УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

СУДАЛГААНЫ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)

ТОЙМ АГУУЛГА

- ◊ **Эдийн засгийн бодлого**
- ◊ **Эрдэс баялаг, уул уурхайн салбарын болон байгаль орчны асуудал**
- ◊ **Нийгмийн бодлогын асуудал**
- ◊ **Хууль, эрхзүйн асуудал**
- ◊ **Төрийн байгуулал, парламент судлалын асуудал**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР, 2013

DDC
658. 4012 - 015
Б - 533

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (XIV боть, 2013)
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун, Ө. Мөнхтунгалаг

ISBN 978-99962-1-743-2

ГАРЧИГ

Судалгааны эмхтгэл - XIV боть

УИХ -ЫН 2012 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

- **ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД** 9

Ц. Норовдондог (УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Ph.D)

1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

1.1. **Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин: Бусад орнуудын туршлага ба Монгол Улсын эрх зүйн орчны өнөөгийн байдал** (Харьцуулсан судалгаа) 20

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн (LL.M), Г. Билгээ, Д. Байгалмаа, Ц. Батдорж, Г. Гэрэл, Ч. Онончимэг

1.2. **Гадаадын зарим орны шатахууны жижиглэнгийн үнэ, түүний бүтэц** (Харьцуулсан судалгаа) 46

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Д. Байгалмаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг

1.3. **Монгол Улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт ба үнэлгээ** (Дүн шинжилгээ) 56

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Д. Байгалмаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг

1.4. **Тендерт оролцогч үндэсний аж ахуйн нэгжүүлэд хөнгөлөлт, давуу тал олгодог эсэх талаархи бусад орнуудын туршлага** (Харьцуулсан судалгаа) 103

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг, Б. Хатантуул

1.5. **Зарим орнуудын нэг хүнд ногдох ДНБ ба цалингийн дундаж хэмжээний харьцаа, харилцан хамаарлын шинжилгээ** (Дүн шинжилгээ) 109

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Г. Гэрэл, Ч. Онончимэг

1.6. **АНУ -ын төсөв зохиох, батлах, хуваарилах үйл явцын тойм судалгаа** 119

Ц. Норовдондог (Ph.D), Б. Дуламсүрэн

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2. ЭРДЭС БАЯЛАГ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ

2.1. **Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хууль зүйн тодорхойлолт, ашигт малтмалын төрөл зүйлийн талаархи бусад орнуудын туршлага** (Харьцуулсан судалгаа) 132

Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг

2.2. **БНХАУ -ын байгаль орчин, уул уурхайн салбар дахь байгаль орчны талаархи хууль эрх зүйн бодлогын шинэчлэл, зохицуулалтын талаархи лавлагаа мэдээлэл** 143

Г. Алтан - Оч (Ph.D)

2.3. **Цэнгэг нуурын хамгаалалтыг талаархи гадаадын улс орны эрхзүйн зарим зохицуулалт** 146

Г. Алтан - Оч (Ph.D), Г. Чулуун

2.4. **Гүний усны ашиглалт хамгаалалтын эрхзүйн зохицуулалт, гадаадын туршлага** 165

Г. Алтан - Оч (Ph.D), Г. Чулуун

2.5. **Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний үр дүн, хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал** (Дүн шинжилгээ) 179

Ө. Мөнхтунгалаг

2.6. **Ашигт малтмалын нөөц ашигласаны төлбөр** (роялти) **ба менежментийн төлбөр** 191

Ц. Норовдондог (Ph.D), Г. Алтан - Оч (Ph.D) Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Д. Байгалмаа Г. Гэрэл, Ч. Онончимэг, Г. Билгээ

2.7. **Мэнэжментийн төлбөр** (Хавсралт судалгаа) 198

Г. Алтан - Оч (Ph.D)

2.8. **Өсөн нэмэгдэх нөөц ашигласаны төлбөр, дэлхийн улсуудын жишиг (Харьцуулсан судалгаа)** 201

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн Г. Гэрэл, Ч. Онончимэг

3. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДЛААР

3.1. **Тэтгэвэрийн гэр бүлийн гишүүдэд нь өвлүүлэх нөхцөл, журмын талаархи бусад орнуудын зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 212

Ц. Товуусүрэн, А. Пагма, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл

3.2. **Хүүхэд асарсны тэтгэмж олгохтой холбогдсон статистик мэдээлэл, гадаадын зарим улс орны эрх зүйн орчин** (Харьцуулсан судалгаа) 225

Ц. Товуусүрэн, А. Пагма, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл

4. ХУУЛЬ ЭРХЗҮЙН АСУУДЛААР

4.1. **Нийтийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх зарим зохицуулалтын талаар** (Лавлагаа мэдээлэл) 238

Р. Хатанбаатар

4.2. **Үндэсний хэлээ төрийн албан ёсны хэл болгон ашиглах талаар Монгол Улс болоэ бусад орны баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 242

Д. Жигваагүнсэл

4.3. **Лобби бүлгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 266

П. Амаржаргал, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр

4.4. **Монгол Улсын хилийн боомт, түүний дэглэмийн өнөөгийн байдал, бусад орнуудын эрхзүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 274

Ц. Товуусүрэн, Ө. Мөнхтунгалаг

4.5. **Дэлхийн зарим улс орны хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагууд, тэдгээрийн харъяалал** (Лавлагаа мэдээлэл) 298

Ц. Товуусүрэн, Ө. Мөнхтунгала

4.6. **Гадаадын зарим орны хот байгуулалтын эрхзүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа** 300

Р. Хатанбаатар, А. Пагма, Г. Гэрэл

4.7. **Олигархижсан улстөрийн бүтцийг хязгаарлах тухай бусад орны туршлага** (Харьцуулсан судалгаа) 314

Д. Мягмарцэрэн, П. Амаржаргал, Г. Билгээ, Г. Гэрэл, Ч. Онончимэг

4.8. **Гадаадын зарим орны үндсэний аюулгүй байдлын зөвлөлийн гүшүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалт, эрх үүргийн талаархи харьцуулсан судалгаа** 335

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

4.9. **Төрийн өндөр албан тушаалтны эрхийг хязгаарлах зарим асуудал** 345

Г. Чулуун

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4.10. **Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд тавих хяналт хариуцлага** 354

Б. Нарантуяа

4.11. **Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байрны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт ба гадаадын зарим орны туршлага** (Лавлагаа мэдээлэл) 365

Ц. Норовдондог (Ph.D), Г. Чулуун, Ц. Батдорж

4.12. **Цэргийн алба хаах хугацааны талаархи гадаадын улс орны эрх зүйн зохицуулалт** 391

Р. Хатанбаатар, Г. Чулуун

4.13. **Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хуулийн агуулгад холбогдох зарим лавлагаа** 397

Р. Хатанбаатар, Г. Чулуун

4.14. **Сонгуулийн сурталчилгааны зардлын санхүүжилт, гадаадын зарим орны эрхзүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 407

Ц. Товуусүрэн, Б. Хатантуул

4.15. **“Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг” -ийг гадаад улсад хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал, Олон улсын гэрээ конвенцийн эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 417

П. Амаржаргал

5. ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ПАРЛАМЕНТ СУДЛАЛЫН АСУУДЛААР

5.1. **Төрийн албаны тогтолцоо, шинэтгэлийн талаархи бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал** (Харьцуулсан судалгаа) 422

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, Ц. Болормаа, Ө. Мөнхтунгалаг, Б. Нарантуяа

5.2. **Хуулиар тогтоосон Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээ ба бусад орны парламентын дотоод ажил хариуцсан байнгын хорооны эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 463

П. Амаржаргал

5.3. **Гадаадын зарим орны парламентын өргөдлийн хорооны талаархи харьцуулсан судалгаа** 477

Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), А. Пагма, Ө. Мөнхтунгалаг, Б. Нарантуяа

5.4. **Парламентын Тамгын газрын бүтэц дэх Байнгын хороодын ажлын алба** (Харьцуулсан судалгаа) 504

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

5.5. **БНСУ -ын Үндэсний ассамблейн ажлын албадын тухай** (Лавлагаа мэдээлэл) 516

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

5.6. **Парламент дахь намын бүлэг удаа дараа ирц бүрдүүлээгүй тохиолдолд намын бүлгийг тараах асуудлаар бусад орны туршлага** (Лавлагаа, мэдээлэл) 528

Р. Хатанбаатар, Б. Хатантуул

5.7. **Парламентыг үл хүндэтгэх үйлдэл: Агуулга, эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 530

Р. Хатанбаатар, А. Пагма

5.8. **Парламентын нээлттэй сонсголд оролцогчдын үүрэг, хариуцлага** (Лавлагаа, мэдээлэл) 539

Ц. Болормаа

5.9 **ХБНГУ -ын эрүүгийн хуулийн харьцуулалт үүрэг, хариуцлага** (Лавлагаа, мэдээлэл) 545

Г. Алтан - Оч (Ph.D)

5.10. **Парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудлын эрх зүйн зохицуулалт** (Харьцуулсан судалгаа) 547

Р. Хатанбаатар, А. Пагма, Д. Жигваагүнсэл

5.11. **Парламентын танхимд гишүүдийг суулгах дараалал болон түүнтэй холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэх талаарх бусад орны туршлага** (Харьцуулсан судалгаа) 554

Р. Хатанбаатар, Б. Хатантуул

5.12. **Парламентч - эмэгтэйчүүдийн бүлгийн талаарх товч мэдээлэл** 558

Ц. Товуусүрэн, А. Пагма

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Ц. Норовдондог - УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, доктор (Ph. D)

1. Хууль тогтоох байгууллагын судалгааны нэгжийн төлөвшил, хөгжил

2002 онд НҮБ -ийн хөгжлийн хөтөлбөр (UNDP) -өөс УИХ -ын Тамгын газарт “Ардчилсан парламентын засаглалыг бэхжүүлэх” хамтарсан төсөл хэрэгжүүлж УИХ болон УИХ -ын Тамгын газрын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргасан. Зөвлөмжид тусгасан гол шүүмж нь “УИХ-аар батлан гаргаж буй хууль, тогтоомж, бодлогын шийдвэрийн онолын болон практик үндэслэлийг сайжруулах, судалгаа тооцооны үндсэн дээр олон нийтийн санаа бодлыг өргөнөөр тусгасан нийгэм, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцсэн “сайн” хуулийг УИХ-аар батлан гаргах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах албыг байгуулах нь зүйтэй” гэсэн санаа байв.

Түүх сөхвөл,

- Монгол улс ардчилсан парламентын засаглалтай болсон даруйдаа анх 1991 онд Улсын Бага хурлын дэргэд Төр нийгэм - судлалын академи байгуулсан.
- 1994 онд уг академийг УИХ -ын харьяа болгосон боловч 2 жилийн дараа буюу 1996 оны сонгуулийн дараа татан буулгаж УИХ -ын Тамгын газрын Хуулийн хэлтсийн харьяа Судалгаа мэдээлэл, лавламжийн алба болгон өөрчилсөн.
- 2000 оны сонгуулийн дараа буюу 2001 онд тус албыг Мэдээлэл, судалгааны хэлтэс болгон өөрчилсөн боловч 4 сарын дараа татан буулгаж, Номын санг Захиргаа боловсон хүчний хэлтэст харьяалуулан ердөө 2 ажилтан мэдээлэл, лавлагаа хариуцаж байв. Энэ үед УИХ -ын хэрэгцээт судалгааг бусад эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар төлбөртэй хийлгэхээр шийдвэрлэсэн боловч 2002 оноос 2005 оны хооронд Байнгын хороодын захиалгаар ердөө 7 судалгааны ажлыг гадны байгууллагуудаар төлбөртэй гүйцэтгүүлсэн байна.

  Бусад судалгааны байгууллагууд захиалгат судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дор хаяж 6 сар, бүр 2 - 3 жилийн хугацаа зарцуулах ч үе байв. Байнгын хороодын хувьд судалгаанд хөрөнгө мөнгө зарцуулах сонирхол, боломж бага байсан бөгөөд нөгөө талаас, урт хугацаанд хийсэн онолын шинжтэй суурь судалгаа нь УИХ -ын хэрэгцээнд нийцэхгүй байх, цаг хугацааны хувьд ач холбогдолоо алдах зэрэг хүндрэлүүд гарч байсан байна.

- 2003 онд Улсын Их Хурал өөрийн гэсэн судалгааны албатай болох шийдвэр гаргаж дэргэдээ Бодлогын шинжилгээний төв байгуулан ажиллуулсан. Тус төв нь Байнгын хороодын захиалгаар томоохон хэмжээний бодлогын болон суурь судалгаануудыг гүйцэтгэж байсан ба Тамгын газарт газарт лавлагаа , мэдээлэл хариуцсан 2 - 3 ажилтан байв. Төвийн үйл ажиллагааг Улсын Их Хуралтай нягт уялдуулж , уян хатан ажиллуулах боломж хязгаарлагдмал байсан бөгөөд төсөв, санхүүгийн хувьд ч зарим хүндрэлүүд гарч байжээ.
- 2008 оны сонгуулийн дараа Улсын Их Хурлын судалгаа, мэдээллийн эрэлт хэрэгцээг уян хатан, шуурхай хангах мэргэшсэн албыг Тамгын газрын бүтцэд байгуулахаар шийдвэрлэж Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төвийг өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулахаар зохион байгуулсан боловч олон нийттэй харилцах, хяналт шалгалтын чиг үүргийг Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд шилжүүлж, одоо Судалгааны төв нэртэйгээр Улсын Их Хурлын судалгаа , мэдээлэлийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр дагнан ажиллаж байна.

2. УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн үйл ажиллагаа

Бүтцийн хувьд Судалгааны төв нь судалгааны үндсэн 4 хэсэг болон мэдээллийн үйлчилгээний хэсэгтэй. Үүнд: Макро эдийн засгийн судалгааны хэсэг, Эдийн засгийн бодит салбар, хөгжлийн бодлогын судалгааны хэсэг, Нийгмийн бодлогын судалгааны хэсэг, Эрх зүй төрийн байгуулал, гадаад бодлогын судалгааны хэсэг болон УИХ -ын Номын сантай.

УИХ -ын хууль тогтоох үйл ажиллагаанд Судалгааны төв иж бүрэн үйлчилгээ үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, гишүүдийн санаачилсан хуулийн төсөл боловсруулах болон хуулийн төслийг хэлэлцэн батлах үндсэн 2 үе шатанд аль алинд нь судалгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болдог. Хуулийн төсөл боловсруулах шатанд урт хугацаа шаардсан бодлогын шинжтэй судалгаанууд хийгддэг бол хэлэлцэн батлах шатанд шуурхай судалгаа, мэдээлэл гаргаж өгч байна.

УИХ -ын 76 гишүүн тус бүрдээ хууль санаачлагч учраас шаардлагатай зарим асуудлаар хуулийн төсөлд холбогдолтой харьцуулсан болон бодлогын судалгааг хийлгэх хүсэлт гаргах нь олон байдаг. Зөвхөн 2008 - 2012 онд гэхэд Судалгааны төв нь хууль тогтоох үйл ажиллагаанд зориулан 400 гаруй судалгааны бүтээгдэхүүн, ном товхимол, эмхэтгэл, гарын авлага гаргаж судалгааны мэдээллийн сан бүрдүүлсэнээс, 70,3% -ийг УИХ -ын гишүүд, Байнгын хороодын захиалгаар, 29,7% -ийг Тамгын газар болон Судалгааны төвийн санаачлагаар гүйцэтгэжээ.

Статистикаас үзэхэд, эдгээр судалгааны ажлуудын 20% орчим нь бодлогын судалгаа, 50% гаруй нь харьцуулсан судалгаа, лавлагаа мэдээлэл, 30% орчим нь ном товхимол, гарын авлага байна. Тамгын газраас өнгөрсөн хугацаанд хууль тогтоох үйл ажиллагаанд судалгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх арга барилыг төлөвшүүлэх, судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, судлаач, шинжээчдийг дадлага туршлагатай болгох тал дээр тодорхой ахиц дэвшил гаргаж ажилласан боловч бусад өндөр хөгжилтэй орнуудын парламентын судалгааны албатай харьцуулахад хүчин чадал, нөөц боломжийн хувьд хязгаарлагдмал юм.

Судалгааны төвийг анхнаас нь бусад орнуудын парламентын судалгааны албадын жишгээр ажиллуулж, стандарт үйлчилгээ үзүүлэхийг зорьсон, нөгөө талаас өмнөх жилүүдэд судалгааны нэгжийн нэр хүнд, үнэлэмж доогуур байсан нь Төвийг ийнхүү илүү их ачаалалтай ажиллуулахад хүргэсэн байна. Энэ бол төвийн өнгөрсөн хугацааны ажлын бодит үр дүн юм. Мөн, эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зохион байгуулах, судалгааны нийтлэл бичиж илтгэл тавих, олон нийтийн санал асуулга зохион байгуулах зэрэг идэвхтэй үйл ажиллагааг тасралтгүй явуулсаар байна

УИХ -д зориулан гаргаж өгч буй судалгаа нь онолын, суурь судалгаанд хамаарахгүй бөгөөд хууль тогтоох институцид шийдвэр гаргахад туслах зорилготой бодлогын (хэрэглээний) судалгаа, мэдээлэл лавлагаа, харьцуулсан судалгаа зонхилдог юм. Төвийн гаргаж байгаа судалгааны ихэнх нь бодлогын судалгаа, харьцуулсан судалгаа,шуурхай мэдээлэл лавлагаа болон хуулийн төслийн шинжилгээ байдаг.

Судалгааны төв нь УИХ -ын ээлжит чуулганы статистик эмхэтгэл, парламентын 4 жилийн нэгдсэн тайлан, УИХ -ын түүхэн товчоон эмхэтгэлүүдийг боловсруулах, ном, товхимол, гарын авлага, мэдээ тайланг нэгтгэн гаргаж байна. Мөн олон нийтэд зориулсан хэлбаршуулсан гарын авлага, арга зүйн зөвлөмж гаргах, эрдэм шинжилгээ-онол практикийн хурал зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд судлаач, шинжээчид хуулийн ажлын хэсэгт орж ажиллах, бодлогын зөвлөмж гаргах, хуулийн төслийг олон нийтэд сурталчлах, анкетын санал асуулга явуулах зэргээр сургалт, судалгаатай холбоотой бүх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн хугацаанд тус төвөөс Парламент судлалд үнэтэй хувь нэмэр оруулсан хэд хэдэн дорвитой бүтээлүүдийг гаргасан. Тухайлбал, “Дэлхийн улс орнуудын парламент” (198 орныг харьцуулсан), “Дэлхийн улс орнуудын парламентын Ажлын албад” (50 орныг харьцуулсан) номыг хэвлүүлэн гаргасан нь ховор бүтээлд тооцогдоно.

Мэдээллийн сангийн хувьд, 2010 онд Дэлхийн банкны дэмжлэгээр Хөгжлийн мэдээллийн төв байгуулсан /20 мянга орчим ам. доллар/. 2011 онд БНСУ -ын Засгийн газрын хөгжлийн агентлаг (KOIKA) -гийн тусламжтайгаар 1,0 сая орчим ам долларын өртөгтэй “Цахим архив” төсөл хэрэгжүүлсэн. 2012 онд Туркийн Хөгжлийн агентлаг (TIIKA)-гийн тусламжаар 800,0 орчим ам долларын өртөгтэй “Цахим номын сан” төсөл хэрэгжүүлж байна. Мөн УИХ -ын хэвлэх цехийн тоног төхөөрөмжийг өнгөт хэвлэлийн тоног төхөөрөмжөөр шинэчилж байна. Эдгээр буцалтгүй тусламжийн үр дүнд Тамгын газар болон УИХ -ын мэдээллийн бааз бүрэн цахим хэлбэрт шилжих бэлтгэл хангагдаж байгаа бөгөөд энэ хэмжээгээр судалгааны бүтээгдэхүүний чанар сайжрах юм.

УИХ -ын Судалгааны төвийн хүчин чадал, үйл ажиллагааны мэргэшсэн байдлаас парламентын чадавхи шалтгаалах учраас УИХ -ын гишүүдтэй аль болох ойр, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн уян хатан ажиллах шаардлагатай болдог. Одоогийн бүтэц зохион байгуулалт, ажлын арга барил, байршил болон төрийн холбоо, дотоод сүлжээ, интернетэд холбогдсон байдал зэрэг нь УИХ -аар асуудлыг хэлэлцэх үе шат бүхэнд судалгаа мэдээллийг шуурхай гаргаж өгөх боломжийг бүрдүүлж байна.

Төрийн институцийн өөрийнх нь бүтцэд ажилладаг мэргэшсэн судалгааны албадыг бэхжүүлэх асуудал сүүлийн үед чухлаар тавигдаж байна. Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд УИХ болон Засгийн газрын түвшинд асуудалд шинжлэх ухааны биш, судалгаа тооцоогүй хандаж ирсэн гэсэн шүүмжлэл нэлээд гарах боллоо. Бодлого судлалын салбар нь хууль тогтоох, бодлого боловсруулах эрх бүхий байгууллагын өөрсдийнх нь эрэлт хэрэгцээнээс үүдэн бий болсон харьцангуй залуу салбар бөгөөд сүүлийн үед дэлхий дахинаа бодлогын шинжилгээний нийтлэг арга зүй, үйл ажиллагааны стандарт төлөвшин хөгжиж байна.

Тамгын газрын бүтцийн нэгж учраас парламент хоорондын болон парламентын Тамгын газар хоорондын харилцааны шугамаар бусад орнуудын ижил түвшний судалгааны албадуудтай харилцаа холбоо тогтоох, тусламж дэмжлэг авах, хамтран ажиллах таатай нөхцөл бүрдсэн. АНУ -ын Конгрессийн Судалгааны алба (CRS), БНСУ -ын Үндэсний Ассамблейн судалгааны алба (NARS) -тай нягт хамтын ажиллагаа тогтоож, Австрали, Франц, Польш, Турк, БНСВУ, Филипин, Лаос зэрэг орнуудын Парламентын судалгааны албадын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж туршлага судалсан.

Дэлхийн банк, Бүгд найрамдахчуудын Олон улсын Хүрээлэнтэй Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна. Монголын ажил олгогч эздийн холбоо, Шинжлэх ухаааны академи, МУИС-ийн ХЗДС зэрэг ТББ-уудтай Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж байна. Дэлхийн 50 гаруй орны парламентын Тамгын газар, Судалгааны албадуудын туршлагыг харьцуулан судалж харьцуулсан судалгааны ном гаргасан. Мөн Олон Улсын Парламентын Номын сангуудын холбоо (IFLA)-д гишүүнчлэлээ сэргээж дахин элссэн.

3. Парламентын судалгааны онцлог ба бодлогын шинжилгээ

УИХ -ын Судалгааны төв нь төрийн албаны статустай учраас үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөл бүрдсэн. Олон намын төлөөлөл бүхий парламентын гишүүдэд тэгш, шударга үйлчилгээ үзүүлэх, улс төрөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх нь парламентын судалгааны албаны онцлог юм. Хууль тогтоох байгууллагад зориулсан бодлогын шинжилгээ, судалгаа нь хэлэлцүүлгийн үе шат бүхэнд үнэн зөв мэдээлэлд суурилсан, бодитой, тэнцвэртэй мэдээллийг уян хатан шуурхай гаргаж өгөх, хууль

санаачлагчаас өргөн барьсан төсөлд тусгасан бодлогын шийдлийн хувилбарыг задлан шинжилж, асуудлыг шийдвэрлэх бодлогын альтернатив хувилбарыг боловруулсан гаргах, хувилбар тус бүрийн эерэг, сөрөг нөлөөг үнэлэн гаргахад парламентад туслах зорилготой.

Хууль тогтоох засаглал болон гүйцэтгэх засаглал хоорондын харилцааны мөн чанарыг өөрчлөх, Засгийн газрын үйл ажиллагаанд бодитой хяналт тавих, олон нийтийн эрх ашигт нийцсэн практик ач холбогдол бүхий хууль, тогтоомжуудыг парламентаар батлан гаргахад бодлогын шинжилгээ, судалгаа чухал бөгөөд энэ нь нэг ёсондоо тухайн парламентын чадавхийн илэрхийлэл юм.

Үндсэн зарчмууд:

- Ардчилал ба сайн засаглалын үндэс нь сайн хууль тогтоох байгууллага
- Сайн хууль тогтоох байгууллагын үндэс нь мэдлэг ба мэдээлэл
  - ярвигтай бэрхшээлтэй асуудлыг оновчтой аргаар шийдэхийн тулд
  - улс орныг удирдан чиглүүлэхэд илүү үүрэг гүйцэтгэхийн тулд

Практик шалтгаан:

- Гүйцэтгэх засаглал мэдээллийг монополь эрхтэйгээр эзэмшдэг учир мэдээллийн хяналтыг тэнцвэржүүлэх шаардлагатай.
- Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын мэдээллийг авах, хуваалцах арга барил нь эрс ялгаатай. Гүйцэтгэх засаглал нь мэдээллийг өөрийн харьяа хүчирхэг бүтцээр (яамд, агентлаг) дамжуулан босоо тогтолцоогоор авдаг бол, хууль тогтоох байгууллага нь аль болох иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан мэдээлэл авах сонирхолтой байдаг.
- Илүү ардчилсан, бодит байдалд нийцсэн бодлого боловсруулах, бодлогын олон хувилбаруудыг гаргаж оновчтой шийдэл гаргах
- Гүйцэтгэх засаглал нь өөртөө “ашигтай” хөтөлбөрүүдийг хууль тогтоох байгууллагад тулган батлуулах сонирхолтой
- Хууль тогтоогчид гүйцэтгэх засаглалын байгууллагуудад зөв асуултуудыг тавих
- Засаглал хоорондын харилцааны мөн чанарыг өөрчлөх

a. Хууль тогтоох байгууллагын судалгаа нь хэрэглээний судалгаа юм.

Үндсэндээ 2 түвшинд мэдлэг буй болж байдаг. Онолын судалгаа ба бодлогын (хэрэглээний) судалгааны зааг ялгаа нь дараахь шинжээр тодорхойлогдоно.

Хэмжүүрүүд	Онолын судалгаа	Хэрэглээний судалгаа
Зорилго	Эцсийн үнэн	Асуудлыг шийдэх
Хамрах хүрээ	Нэг салбараар мэргэших	Олон салбарыг хамрах
Хугацаа	Нээлт хийх хүртэл	**Шаардлага** гарсан үед
Хэлбэр	Мэргэжлийн хэлээр	Товч, тодорхой, арга замыг тодорхойлсон
Орчин	Ганцаараа	Багаар

b. Хууль тогтоох байгууллагын судалгааны алба нь **“**мэдээллийн зуучлагч**”** юм.

Парламентын судалгааны алба нь үйл ажиллагааны онцлогоосоо шалтгаалан бусдын

судалгаа шинжилгээний ажлыг “зээлэх” буюу тэдгээрт тулгуурлан шуурхай байдлаар мэдээллийг дамжуулах үүрэг хүлээнэ.

“Зуучлагч” -ийн үүрэг зайлшгүй болох нь:

- Онолын болон нарийн мэргэжлийн концепци, хэллэгийг илүү ойлгомжтой хэлбэрт оруулах
- Онолын концепцийг хэрэгтэй бөгөөд хэрэгжүүлж болохуйц санаа болгож бодлогын үйл явцад тусгах
- Нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ямар үүрэгтэй оролцож болохыг харуулах
- Эрдэмтэн судлаачид ба хууль тогтоогчдын хооронд хэлэлцүүлэг өрнүүлэх

Мэдлэгтэн ба эрх мэдэлтний ертөнц буюу шинжлэх ухаан ба хууль тогтоох байгууллагуудын хооронд том ангал байдаг. Хууль тогтоох байгууллагын судлаач шинжээч нар нь дээрх хоёр ертөнцийг холбох гүүр буюу зуучлагч юм.

3. Хууль тогтоох байгууллагын судалгаа нь өөрийн онцлогтой

   Үндсэн шинж чанар:

   - Обьектив, төвийг сахисан байх.
   - Зөвлөмж өгөхөөс зайлсхийх.
   - Аливаа асуудалд хариулахад бэлэн байх.
   - Хамгийн сайн мэдлэг, ур чадвар дээр түшиглэх.
   - Нууцыг хадгалах.
   - Улс төрийн зөв дүгнэлт, үнэлэмжтэй байх.
   - Цаг хугацаандаа багтсан байх.
   - Парламентын зорилгыг биелүүлэхийн төлөө ажиллах.

Олон зуун жилийн турш мэдлэг ба эрх мэдэлтний ертөнцийг тусгаарласан асар том ангал оршин байсаар байдаг тул эрдэмтэн, судлаачид болон хууль тогтоогчдыг ойртуулах, мэдлэгт суурилсан шийдвэрийг хууль тогтоох байгууллагаар гаргуулахад парламентын судалгааны алба үйл ажиллагаагаа чиглүүлж байдаг.

Үл ойлголцол яагаад үүсдэг вэ?

- Эрдэмтэн, судлаач нар хууль тогтоогчдын гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл, тэдэнд байгаа мэдээллийн чанарт сэтгэл хангалуун бус байдаг. “Хууль тогтоогчид хуучирсан, үеэ өнгөрөөсөн онол, мэдээллийг үндэслэж шийдвэр гаргадаг.” гэж тэд үздэг.
- Эрдэмтэн, судлаачид санаа бодлоо ойлгомжтой илэрхийлдэггүй, практик асуудлыг цагт нь шийдвэрлэж чаддаггүй гэж хууль тогтоогчид үздэг. “Эрдэмтдэд найдаад хэрэггүй. Тэд онолдохоос өөр юм мэдэхгүй, хэтэрхий их ярьдаг. Тэд сурах бичгийн хэлээр ярьдаг.” *гэж улс төрчид үздэг.*

Яагаад гишүүнд мэдээлэл хэрэгтэй болдог вэ?

a. Асуудлыг ойлгохын тулд
b. Парламент, Байнгын хороо, эсвэл бүлэг дээр судлах асуудал гарч ирдэг
   - Гишүүн асуудлыг ойлгож аваад хэлэлцүүлэгт бэлтгэлтэй оролцохыг хүсдэг.

- Санал өгөх
- Саналаа бодож боловсруулаагүй байдаг, тиймээс бодит дүн шинжилгээ хэрэгтэй болдог.

c. Бодлого эсвэл гишүүний хуулийн төслийг боловсруулах
d. Сонгогчид, сонирхлын бүлэг, компанийн удирдлага, лоббистуудтай хийх уулзалтад бэлтгэх
e. Сонгогчийн асуултад хариулах
f. Үг хэлэх
g. Өөрийн саналаа бусад гишүүдэд ойлгуулах

Яагаад бодит байдлыг харуулж, санал бодлыг тал бүрээс нь харгалзан үзэх хэрэгтэй вэ?

- Төрийн албан хаагчид (улс төрийн бус албан тушаалд томилогдсон этгээдүүд) бодитой бөгөөд санал бодлыг тал бүрээс нь харгалзан үзсэн судалгааг хийх хэрэгтэй. Судлаачид тодорхой байр суурь баримталбал бусад бүх санал бодлын өшөөтнүүдийг бий болгож, хайхрагдахгүй орхигдох эсвэл шийтгүүлэх эрсдэлд орно

Бусад орнуудын парламентын судалгааны албадын туршлага

Дэлхий нийтийн хандлагаас үзэхэд, сүүлийн жилүүдэд хууль тогтоох байгууллагын судалгаа, мэдээллийн үйлчилгээнд ихээхэн ахиц дэвшил гарч албан ёсны статус бүхий парламентын судалгааны албадын үйл ажиллагааны нийтлэг стандарт, бүтээгдэхүүн үйлчилгээ, бодлогын шинжилгээний арга зүй улам бүр тодорхой болж байна. АНУ, Австрали, БНСУ зэрэг өндөр хөгжилтэй орнууд энэ чиглэлээр жишиг болохуйц үйлчилгээг нэвтрүүлсээр байна. Ялангуяа АНУ -ын Конгрессийн Судалгааны албa (CRS) -ны туршлага энэ салбарт загвар болж байгаа юм.

2009 онд УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс дэлхийн 50 орны парламентын Ажлын албадын үйл ажиллагааны талаар харьцуулсан судалгаа хийсэн. Судалгаанд хамрагдсан 50 орны 92 хувь нь парламентын судалгааны нэгжтэй байна.

Бүтцийн хувьд парламентын судалгааны албa нь парламендаа шууд үйлчилдэг бүтцийн нэгж байна. Үүнээс:

- Парламентын ажлын албаны дотоод бүтцэд байх – 83 хувь
- Парламентын ажлын албатай ижил статустай – 17 хувь

Жишээ болгон АНУ -ын Конгрессийн судалгааны албаны үйл ажиллагааны зарим онцлогийг танилцуулж байна.

АНУ -ын Конгрессийн Судалгааны албаны туршлага

АНУ -ын Конгресс нь жилд 50 мянга гаруй удаа Конгрессийн Судалгааны албa /КСА/ -нд аливаа нэг асуудлаар мэдээлэл авах зорилгоор хандаж туслалцаа авдаг. Тус албанд одоогоор 700 орчим хүн ажиллаж байгаагаас 450 нь өндөр түвшний бодлогын судлаач, хуульч болон салбарын мэргэжилтнүүд, 350 нь мэдээллийн мэргэжилтнүүд байдаг. КСА нь Конгрессийн Номын сантай нэгдмэл бөгөөд Конгресс болон Сенатад Америкийн иргэдийн эрх ашигт нийцсэн, төвийг сахисан, цагаа олсон судалгаа, дүн шинжилгээ хийж ,мэдээллээр хангах үүрэгтэй.

Конгресс нь доорх үндсэн чиглэлээр КСА -наас үйлчилгээ авна. Үүнд:

- Бодлого, эрх зүйн болон процедурын иж бүрэн шинжилгээ хийлгэх
- Бодлогын альтернатив хувилбаруудыг нээн илрүүлэх, үнэлэх, тэдгээр хувилбаруудын үр дүн, үр дагаварыг тооцох
- Хуулийн төсөл боловсруулахад анхан шатны дэмжлэг авах
- Сүүлийн үеийн судалгааны арга, аргачлалыг ашиглан тодорхой асуудлаар тооны мэдээллийн сан бий болгох, дүн шинжилгээ хийлгэх
- Судалгааны шинэ үр дүн, мэдээ ба мэдээллийн эх сурвалжийг олж авах, тодорхойлолт гаргуулах
- Конгрессийн Байнгын хороодод шинжээчийн дүгнэлтийг сонсгох
- Хууль тогтоох байгууллагын анхаарлын төвд байгаа асуудлаар сургалт, семинар авах

Конгрессийн судалгааны албаны үнэт зүйлс ба үүрэг нь

- Хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн хэсэг
- Конгрессийн Номын сангийн нэг хэлтэс

> Сенатч Жеймс Инхофе:
>
> - “КСА -ыг би энд дурдах нь чухал гэж бодож байна. Учир нь бид тэдний хийж буй ажлыг хүндэтгэдэг.”
>
> Сенатч Диана Файнштайн:
>
> - “КСА хэмээх судалгааны нэгж бидэнд үйлчилдэг. Энэ албa нь төвийг сахисан, итгэлтэй бөгөөд төлөөлөгчдийн танхим болон сенатад бидний хийдэг ажлын нэг хэсэг юм.”

КСА -ны эрхэм зорилго

> “КСА нь хууль тогтоох бүхий л үйл явцын туршид Конгрессийн иж бүрэн, үнэн зөв дүн шинжилгээ, судалгаагаар хангаж ажиллна. КСА-ны үйлчилгээ нь төвийг сахисан, цагаа олсон, нууцыг чандлан хадгалсан байна.”

Конгрессийн уламжлал

- КСА нь Конгрессийн ажилтнуудын ажлыг дэмжих үүрэгтэй.
- КСА нь Конгрессийн гишүүд болон бүх Байнгын хороонд үйлчлэх үүрэгтэй.
- КСА нь олон нийтэд бус, зөвхөн конгресст үйлчилнэ.

КСА -ны үнэт зүйлс

- Судалгааны бүх үе шатанд нууцыг хадгалах
- Төвийг сахисан, нөлөөнд үл автсан дэмжлэг үзүүлэх
- Тэнцвэртэй, бодитой дүн шинжилгээ хийх
- Мэдлэг, мэдээллийг хадгалах, уламжлан дамжуулах
- Салбарын асуудлаар мэргэшсэн нэрт судлаач, шинжээч ажиллуулах

КСА -ны үйлчилгээний хэлбэр

- Зөвлөгөө өгөх, мэдээлэл хийх
- Нууц танилцуулга
- Шинжээчдийн мэдүүлэг
- Цахим хуудасны үйлчилгээ
- Конгрессээр дамжуулж олон нийтэд дамжуулах мэдээ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Сургалт, семинар
- Ерөнхий мэдээлэл
- Уншлагын танхим ба судалгааны төвүүд

КСА -ны тайлан

Хэлэлцэх хуулийн төслийн жагсаалттай уялдуулж гаргана. КСА-ны цахим хуудаснаас 7 хоногийн өдөр бүр 24 цагийн турш үзэх боломжтой. Зохиогчийн эрх байхгүй, Конгрессийн зөвшөөрлөөр ашиглана.

Мэдээллийн үйлчилгээ

- Биечлэн гишүүний өрөөнд эсвэл КСА -ны байранд /Сенатын судалгааны төв, Rayburn барилгын судалгааны төв/
- Утсаар, теле хурал эсвэл онлайн ярилцлага
- Хууль тогтоомжийн тойм бэлтгэх
- Ирээдүйн хууль тогтоомжийн хувилбаруудыг судлах

Зуучлах үйлчилгээ

- Мэргэшсэн мэдээллийн ажилтнууд
- Мэдээллийн баазаас сэдэвчилсэн хайлт хийх
- Конгрессийн өмнөөс бусад байгууллагуудтай холбоо барих

Сонсголын бэлтгэл хангах

- КСА -ны шинжээчид мэдээлэл өгөх боломжтой.
- Гэхдээ тухайн асуудлын нөлөөллийн бус, аспектаар сонсголд оролцож мэдээлэл өгдөг.
- Мэдээлэл нь тухайн шинжээчийн мэдлэгийн цар хүрээгээр хязгаарлагдана.
- Сонсголд оролцох гэрчийн жагсаалтыг бэлтгэх
- Сонсголын асуултуудыг бэлтгэх
- Сонсголын нээлтийн үг, илтгэлийг бэлтгэхэд туслах
- Шаардлагатай үед газар дээр нь мэдээлэл өгөх зорилгоор сонсголд оролцох

Хуулиар хориглосон үйлчилгээ

- Туйлширсан, төвийг үл сахисан үйлчилгээ үзүүлэх
- Конгрессийн нэг гишүүний талаарх мэдээллийг нөгөө гишүүнд өгөх
- Хуулийн төсөл бичих болон хуультай холбоотой албан ёсны төсөл тооцоо гаргах

АНУ -ын Конгрессийн судалгааны албаны 650 ажилтан хууль тогтоох үечлэлээр ажилладаг. Засгийн газрыг хянах байгууллагын 3350 ажилтан урт хугацааны судалгаа хийдэг, шинэчлэлийн төлөө ажилладаг. Конгрессийн төсвийн нэгжийн 250 ажилтан төсвийн болон эдийн засгийн асуудлыг хариуцдаг.

УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн хувьд, 2008 онд байгуулагдсан цагаасаа эхлэн АНУ -ын КСА -ны үйл ажиллагааны арга барил, ерөнхий зарчмыг удирдлага болгон ажиллаж байгаа боловч цаашид хүчин чадлаа бэхжүүлэх, судлаач шинжээчдийг мэргэшүүлэх тал дээр анхаарах шаардлага бий. Хууль тогтоох байгууллагын судалгааны эрэлт хэрэгцээ улам их болж байна.

Манай Судалгааны төвийн хурдтай шуурхай үйл ажиллагаанд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь:

- Төрийн албаны статус (Тамгын газрын харьяанд)
- Мэдээллийн баазад ойр (Номын сан, архив, дотоод сүлжээ гэх мэт)
- Захиалагч, хэрэглэгчтэй ойр (УИХ-ын гишүүд, Байнгын хороод, Тамгын газар)
- Бусад төрийн болон ТББ-уудаас албан ёсны мэдээлэл гаргуулж авах боломж
- Гадаад, дотоод харилцаа хөгжүүлэх, мэдээллийн зуучлагч хийх боломж
- УИХ болон Тамгын газрын дэмжлэг
- Багаар ажиллах чадвар

5. Хууль тогтоох байгууллагын судалгааны тулгамдсан асуудлууд, санал зөвлөмж

A. Хууль тогтоох үйл ажиллагааны цикл тус бүрт иж бүрэн үйлчилгээ үзүүлж байхаар судалгаа шинжилгээний мэргэшсэн албадыг зүй зохистой ажиллуулах шаардлага байна. Хуулийн төсөл боловсруулах болон хэлэлцэн батлах үндсэн 2 үе шатанд аль алинд нь судалгаа, мэдээллийн эрэлт хэрэгцээ их байна.

B. Хууль санаачлах эрх бүхий субьект тус бүрт (Ерөнхийлөгч, УИХ, ЗГ) хуулийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх судалгаа, мэдээллийн үйлчилгээний бүтэц байгаа боловч төдийлөн үр ашигтай ажиллуулж чадахгүй байна. Ялангуяа Засгийн газрын харьяанд яам, агентлаг, судалгааны хүрээлэнгүүд гэх мэт олон байгууллагууд байх боловч салбарын мэргэжилтнүүд, судлаачид, экспертүүдээр хуулийн төсөл боловсруулах шатанд судалгаа, тооцоо хийлгэх тал дээр төдийлөн санаачлага гаргахгүй байна.

Төр хүчтэй байхын тулд төрийн институцид үйлчилдэг мэргэшсэн судалгааны албад нь хүчирхэг байх ёстой. Эдгээр судалгааны албад нь ард түмний нэрийн өмнөөс итгэмжлэгдэж шат шатандаа үйлчилгээ үзүүлдэг, нөлөөнд үл автах, хараат бус, мэргэшсэн албад байдаг. Төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх сонирхол бүхий гадаад дотоодын байгууллага, ашиг сонирхолын бүлгүүд ямагт байдаг учраас төрийн албаны статустай эдгээр албад нь аль болох төвийг сахисан байдлаар бодлогын хувилбар боловсруулж шийдвэр гаргагчдад тусалж байх үүрэгтэй.

C. Монгол улсад бодлого судлалын салбарыг судалгааны нэг чухал салбар болгон хөгжүүлэх асуудалд анхаарах цаг болжээ. Бодлогын судалгаа, шинжилгээний салбар нь шийдвэр гаргагчдын эрэлт хэрэгцээнээс үүдэн харьцангуй сүүлд бий болсон боловч судалганы арга зүй, үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэрийн хувьд бүхэл бүтэн шинжлэх ухааны салбар болон хөгжжээ.

Тухайлбал, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалд үйлчилж байгаа судалгааны албадын хувьд ажлын арга барилын хувьд ялгаа зааг бий. Хэзээ, хаана, хэнд зориулж, ямар зорилгоор гэдгээсээ хамааран үйл ажиллагааны зохион байгуулалт нь өөр байж болох ч бодлогын шинжилгээний арга зүй нийтлэг юм. Иймд судлаач, шинжээчдийн бодлогын шинжилгээний арга зүйг дээшлүүлэх шаардлага байна.

D. Суурь судалгаа, бодлогын судалгааны салбарыг жигд хөгжүүлэх шаардлага байна. Ялангуяа эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиудын онолын болон академик судалгааны чадавхийг сайжруулах, судалгааны хүрээлэнгүүд чиглэл чиглэлээрээ төрөлжин ажиллах шаардлага байна. Суурь судалгааны бааз суурь өргөжихийн хэрээр бодлогын судалгааны чанар, үр өгөөж, шуурхай байдал сайжирна.

E. Хууль зүйн суурь, хавсарга, бодлогын судалгааны салбаруудыг жигд хөгжүүлэх, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалд үйлчилж буй зорилгоос нь хамааруулан үр ашигтай ажиллуулах талаар эрх бүхий байгууллагуудын зүгээс санаачлага гаргаж дэмжих шаардлагатай. Эдгээр судалгааны албадын хараат бус, тогтвортой ажиллах хэвийн орчинг бүрдүүлэх шаардлагатай.

F. Бодлого судлалаар мэргэшсэн судлаач шинжээчдийг бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх чиглэлээр арга зүйн сургалтууд явуулах, өндөр түвшний эксперт шинжээчдийг сонгон шалгаруулах, тогтвортой ажиллуулах, цалин урамшууллыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүний нөөцийн бодлого шаардлагатай байна.

G. УИХ-ын Судалгааны төвийн хувьд, УИХ-ын хэлэлцүүлгийн үе шат бүхэнд шуурхай үйлчилгээ үзүүлэхэд байршил болон мэдээллийн бааз суурь чухал ач холбогдолтой. Сүүлийн жилүүдэд судалгааны захиалга, мэдээллийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа учраас хүний нөөц, чадавхийг сайжруулахад анхаарах шаардлага бий. Өмнөх жилүүдийн практикаас үзэхэд, шийдвэр гаргагчдын нөлөөгөөр тогтвортой ажиллуулж чадаагүй бөгөөд шаардлагатай нөхцөл бүрдсэн тохиолдолд бусад орнуудын парламентын судалгааны албадын жишгээр ажиллах бүрэн боломжтой.

2012.8.25

1
БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Нороводондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Г. Билгээ,
Д. Байгалмаа, Ц. Батдорж, Г. Гэрэл, Ч.Онончимэг

Агуулга

Оршил хэсэг

Судалгааны үр дүн

Нэг. Бусад орнуудын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, туршлага

1. Вьетнам улс
2. Индонези улс
3. Казахстан улс
4. ОХУ
5. Бразил улс
6. Чили улс
7. Өмнөд Америкийн орнууд

Хоёр. Монгол улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, өнөөгийн байдал

Хавсралт 1.

- Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн, 1990 - 2011, салбараар

Хавсралт 2.

- Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо 1990 - 2011 он

Хавсралт 3.

- Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн 1990 - 2011, улсаар

Хавсралт 4.

- Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалттай компанийн тоо – улсаар 1990 - 2011 он

Хавсралт 5.

- Татварын ерөнхий хуулиар тогтоосон татварын төрлүүд болон тэдгээрийн хувь хэмжээний лавлагаа

* * *

ОРШИЛ ХЭСЭГ

УИХ -ын гишүүн Л. Энх - Амгалан нарын 5 гишүүнээс 2012 оны 9 -р сарын 10 -ний өдрийн 10/1461 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу “Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин: Бусад орнуудын туршлага ба Монгол улсын эрх зүйн орчны өнөөгийн байдал” сэдэвт харьцуулсан судалгааг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачид гүйцэтгэв. Судалгаанд захиалгад ирүүлсэн хүсэлтийн дагуу гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг нийтлэг байдлаар зохицуулсан Вьетнам, Индонези, Казахстан, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг тусад нь салбар хуулиар зохицуулсан Бразиль, Чили,

ОХУ зэрэг орнуудын туршлагыг авч үзэв. Гадаадын хөрөнгө оруулалтаар эдийн засгаа амжилттай хөгжүүлсэн туршлага бүхий орнууд, эдийн засгийн өсөлт, хөгжлөөр манай улстай ойролцоо улс орнууд гэсэн шалгуурыг үндэслэн судалгаанд хамрагдсан орнуудыг сонгосон болно.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд дараахь асуудлуудаар мэдээллийн хайлт хийж, олдсон мэдээллүдийг харьцуулан судалсан болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдлын талаархи тоон мэдээлэл;
- Хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын орчны талаарх мэдээлэл;
- Хөрөнгө оруулалтын талаар баримталж буй бодлого, зарчим
- Хөрөнгө оруулалтын тогтвортой байдлын нөхцөл, татварын болон бусад хөнгөлөлт, хөрөнгө оруулалтыг хамгаалах, баталгаажуулах
- Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчдад хандах хандлага, тэгш боломж
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын бүртгэл, хяналт
- Хөрөнгө оруулалтыг хязгаарлах, хориглох хүрээ
- Хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, урамшуулал болон бусад зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзсэн.

Судалгаанд, Монгол Улсын гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын талаарх тоон мэдээллийг 1990 - 2011 онуудын хооронд дахь тоон үзүүлэлтээр авч үзэн, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны нөхцөл, татварын орчныг одоо мөрдөж байгаа хууль, тогтоомжийн хүрээнд судалсан болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанаас үзэхэд, аль ч улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихийн зэрэгцээ дотоодын хөрөнгө оруулалт, дотоодоос гадаад улс руу хийх хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг тэнцвэртэй баримталж байна. Үүний зэрэгцээ гадаадаас оруулах хөрөнгө оруулалтанд тодорхой хязгаарлалт тогтоох, тухайн улс орны хөгжилд түлхэц болохуйц салбарыг дэмжих үүднээс хөрөнгө оруулалтын давуу эрх, дэмжлэг урамшуулал олгох зэрэг асуудлыг улс орон бүр өөрийн хууль эрх зүйн орчиндоо тусгасан байна.

Судалгааны ажлыг гүйцэтгэх явцад зарим улсын хувьд захиалагчаас ирүүлсэн хүсэлтэд нийцсэн баримт бичиг, эрх зүйн актууд олдоогүй тул нарийвчилсан мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байлаа. Судалгаанаас үзэхэд:

1. Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг дотоодын болон гадаадын гэж ангилахгүйгээр, ижил тэгш боломжтой байхаар зохицуулсан орнуудын хувьд дараахь нийтлэг хандлага ажиглагдаж байна. Тухайлбал,
   - Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад хуулийн хүрээнд эрх тэгш хандах бөгөөд хөрөнгө оруулалтын давуу эрх болон хөнгөлөлт урамшуулалыг нэгэн адил эдлүүлэх;
   - Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиуд нь ерөнхийдөө гадаадын хөрөнгө оруулалтыг хянах, дэмжин зохицуулахад чиглэгдэх ба дараахь шинжийг агуулсан байна. Үүнд:
     - ✓ Хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжсэн, элдэв хязгаарлалтыг аль болох бага байлгахад чиглэсэн байх
     - ✓ Хөрөнгө оруулалтыг төрөл бүрийн арга механизмаар дэмжих ч, дотоодын оролцоог илүү чухалчлах хандлагатай, квот тогтоох зохицуулалтыг агуулсан

ШИНЖЛЭХ УХААНЫ САН

- ✓ Гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрч байгаа боловч дотоодын хяналтанд байлгах бодлого

2. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах орчин болон татварын орчин, тогтвортой байдлын гэрээний тухайд:

- Хөрөнгө оруулалтыг тодорхой нэг салбарт чиглүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийхэд хандуулахад зориулан гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт татварын хөнгөлөлт үзүүлэх, давуу эрх олгохоор зохицуулсан;
- Хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт эдлүүлэх, газар ашиглах талаар дэмжлэг үзүүлэх болон хуульд заасан бусад үндэслэлээр татварын хөнгөлөлтийг олгох. Тухайлбал, тодорхой хөрөнгө оруулах шаардлагатай салбарын тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийг импортын татвараас чөлөөлөх, газар ашиглалтын татвар, түрээс зэргээс чөлөөлөх, ашиглах хугацааны хувьд хөнгөлөлт эдлүүлэх талаарх хуулийн зохицуулалтууд байна.
- Гадаадаас урт хугацаанд оруулах хөрөнгө оруулалтыг тогтвортой байлгах үүднээс тогтвортой байдлын гэрээ эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломжтой. Ингэхдээ
  - ✓ Тухайн гэрээний зүйл /Тухайлбал байгалийн баялаг/-ийг эзэмших эрх нь төсөл хэрэгжүүлэгчид шилжих
  - ✓ Гэрээний үргэлжлэх хугацаа нь 30-40 жил байх.
  - ✓ Төсөл хэрэгжүүлэгч нь бүх эрсдэлийг хүлээхийн зэрэгцээ ашгийн мөн дийлэнх хэсгийг авах.
  - ✓ Төсөл хэрэгжүүлэгчид урт хугацааны татварын тогтвортой байдлыг бий болгох зэрэг нөхцөлүүдийг тусгахаар заасан байна.

3. Дотоодын хөрөнгө оруулагчийн эрх зүйн орчин, татварын зохицуулалт:

- Дийлэнх орны хувьд гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд хуулийн зохицуулалт, эрх зүйн боломж ижил тэгш байна.
- Вьетнамын хөрөнгө оруулалтын хуулиар Дотоодын хөрөнгө оруулалтын бүртгэлийг хуульчилан тогтоож өгсөн. Өөрөөр хэлбэл тухайн улс оронд улсын төсвийн хөрөнгөөр болон хувийн хэвшлийн хөрөнгөөр оруулсан хөрөнгө оруулалтыг хуульд заасан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд бүртгүүлэхийг хуульчилан тогтоож өгсөн.

4. Улс орны стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулалтыг чиглүүлэх талаарх эрх зүйн зохицуулалт: Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудын хувьд энэ талаар нарийвчлан зохицуулсан эрх зүйн актууд олдсонгүй. Вьетнамын хуульд Аж үйлдвэрийн парк, экспортын бүс, өндөр технологийн парк, эсвэл эдийн засгийн бүс нутгуудад хөрөнгө оруулалт хийж буй хөрөнгө оруулагчдад давуу эрх олгох талаар хуульчлан зохицуулсан байна. ОХУ-ын хувьд стратегийн салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах, зохицуулах тухай асуудлыг бие даасан хуулиар болон салбарын хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Энэ талаар 2009 онд Судалгааны төв тусгайлсан судалгаа, мэдээллийг УИХ-ын гишүүдэд гаргаж өгсөн болно.

5. Хөрөнгө оруулалтын хязгаарлалтын талаар:

Аль ч орны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой бодлогын хүрээнд дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл олгоход анхаарч байдаг боловч зарим тодорхой хязгаарлалтыг хууль эрх зүйн орчноороо дамжуулан тавьдаг байна. Эдгээр

хязгаарлалтууд нь нийтлэг агуулгаараа үндэсний аюулгүй байдлаа хамгаалахад чиглэгдэж байгаа бол хөгжингүй орнуудын хувьд дотоодын эдийн засгаа хамгаалах үүднээс тодорхой салбаруудад шууд болон шууд бус байдлаар хязгаарлалт, хориглолт тавьдаг байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах арга хэлбэрүүдийн хувьд:

- Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах хамгийн түгээмэл арга бол хөрөнгө оруулалтын хувь хэмжээнд хязгаарлалт тогтоох явдал юм. Тухайлбал: БНХАУ -д хөрөнгө оруулалтын 51%, Энэтхэгт 40%, Солонгост 50%, Мексикт 49% хүртэлх хувь нь тухайн улс үндэстний өөрийн хөрөнгө оруулалт байхыг зөвшөөрсөн байдаг.
- Хөрөнгө оруулалтын хувь хэмжээнээс гадна эдийн засгийн тодорхой нэг салбарын хувьд хязгаарлалт хийж болох бөгөөд ингэхдээ
  - ✓ Зөвхөн тухайн улс эсвэл дотоодын компани л хөрөнгө оруулах эрхтэй эдийн засгийн салбар /тухайн улсад харьцангуй өндөр түвшинд хөгжчихсөн салбар, дотоодын үйлдвэрлэгчийн хөрөнгө оруулж чадах жижиг дунд үйлдвэрийн салбаруудад ихэвчлэн энэ хязгаарлалтыг тогтоодог. Тухайбал: Франц улсад мэдээллийн хэрэгсэл, шуудан холбоо харилцаа, төмөр зам, цахилгаан, газ зэрэг салбар зөвхөн төрийн эсвэл төрийн өмчийн компаниудад нээлттэй байдаг бол ОХУ-д даатгалын салбар, үнэт цаасны арилжааны салбарт гадны хөрөнгө оруулахыг хорьсон.
  - ✓ Тоотой хэдэн гадаадын хөрөнгө оруулагчид л хөрөнгө оруулах эрхтэй аль нэг тодорхой салбар /гадаадын хөрөнгө оруулалтад тодорхой хэмжээний хязгаарлалт бүхий салбаруудыг тухайн улс янз бүрийн шалтгаанаар хязгаарладаг. Тухайлбал: Өмнөд Солонгост ажлын хүчийг ихээр шаарддаг салбар, түүхий эд боловсруулалт, дотоодын зах зээл рүү чиглэсэн салбаруудыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байдаг. Австрали улсад радио, телевиз, мэдээллийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг 20% хүртэл хязгаарласан байна./
  - ✓ Гадаадын хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжих салбар /гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бүрэн нээлттэй салбар нь ихэвчлэн дотоодын хүчин чадал, нөөц багатай, дотоодын ажилгүйдлийг багасгах, гадаад худалдааны экспортын хэмжээг ихэсгэхэд чиглэгдсэн салбарууд/ гэж байна.

Монгол улсын хувьд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”, “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай”, “Концессийн тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль” болон Татварын багц хуулиуд зэрэг хууль эрх зүйн актуудаар хөрөнгө оруулалтын орчныг зохицуулж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд ихэвчилэн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хөнгөлөлт болон давуу эрх олгох асуудлыг түлхүү зохицуулсан байна. Дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтад тэгш боломж олгох, хөнгөлөлт эдлүүлэх, тогтвортой байдлын гэрээ хийх зэрэг асуудлыг тодорхой хуульчилсан, нарийвчлан зохицуулсан байдал хангалтгүй байна.

* * *

UIH MN
СУДАЛГААНЫ

НЭГ. БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1. ВЬЕТНАМ

❖ Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Вьетнам улсын эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа ба сүүлийн 10 жилд эдийн засгийн өсөлт дунджаар 7,5 хувьтай байна[1]. Вьетнам улсын гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2010 онд 18,6 тэрбум ам.долл -т хүрсэн бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 74.2% -ийг дотоодын шууд хөрөнгө оруулалт, 25.8 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт эзэлсэн байна. Вьетнам улсын гол хөрөнгө оруулагчдад Малайз, Япон, Тайвань, Канад улсууд бөгөөд Канад улсын хувьд хөрөнгө оруулалт хийдэг гол салбарт уул уурхай, газрын тос, байгалийн хий, боловсрол, үл хөдлөх хөрөнгө болон санхүү, даатгалын үйлчилгээ зэрэг орно.

Одоогоор Канадын компани 99 төсөлд 4,7 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийж, гадаадын хөрөнгө оруулагчдаас 13-р байрт жагссан байна. Вьетнамын хамгийн их экспортолдог бараа бүтээгдэхүүний төрөлд будаа, кофе, самар, нэхмэл эдлэл, электрон бараа, компьютер, далайн хоол, модон бараа бүтээгдэхүүн зэрэг ордог.

❖ Хөрөнгө оруулалтын орчин:

1	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин	Вьетнам улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулдаг олон хууль байдаг ба доорх хуулиудаар гол үйл ажиллагааг зохицуулна. 1. Хөрөнгө оруулалтын тухай хууль /Law on Investment, Law No.59/2005/Qh11/ 2. Газрын тухай хууль 3. Барилга байгууламжын тухай хууль Хөрөнгө оруулалтын тухай хуулиар бизнесийн зорилготой ХО-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчдын эрх үүрэг, ашиг сонирхол болон хууль ёсны эрхийг хангах, ХО-ыг дэмжих болон давуу эрх олгох, тус улсын хөрөнгө оруулалтын төрийн зохицуулалт болон Вьетнам улсаас гадаадад хийх хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулна. Энэхүү хууль нь 2006 оны 7 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа.
2	Хөрөнгө оруулалтын бодлого	- Хөрөнгө оруулагчид хуулиар хориглоогүй хүрээ, салбар, худалдаанд хөрөнгө оруулалт хийж болно. Түүнчлэн Вьетнам улсын хуулинд заасны дагуу өөрсдийн эрхэлж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд шийдвэр гаргах эрхтэй. - Эдийн засгийн бүх салбарт хөрөнгө оруулалт хийж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад улсаас хуулийн дагуу тэгш хандана. - Хөрөнгө оруулагчийн эзэмших хөрөнгө, мөнгө, орлого түүнчлэн хуулийн дагуух эрх ашигийг улсаас хамгаална. - Хөрөнгө оруулалт хийх хүрээ, нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийж буй хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын давуу эрх олгох бодлогыг улсаас батлан гаргана.

[1] Вьетнам улс нь Дэлхийн банкнаас гаргадаг “2011 оны Бизнесс Эрхлэх жагсаалт” -ын 78 дугаар байрт жагсаж, бизнесс эрхлэхэд таатай улс орнуудын тоонд ордог.

3	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын бүртгэлийн үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 45-р зүйл Дотоодын хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгө оруулалтын бүртгэл: 1. Дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ тус бүр нь 15 тэрбум Вьетнам доноос бага, мөн түүнчлэн хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүрээний жагсаалтанд ороогүй төсөл бол, хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын бүртгэлийг хийх шаардлагагүй. 2. Дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ тус бүр нь 15 тэрбум Вьетнам доноос их ба 300 тэрбум Вьетнам доноос бага, мөн түүнчлэн хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүрээний жагсаалтанд ороогүй төсөл бол, хөрөнгө оруулагч нь Мужийн Хөрөнгө Оруулалтын Асуудал Эрхэлсэн Улсын Захиргааны Байгууллагын тогтоосон хэв журмын дагуу хөрөнгө оруулалтын бүртгэлийг хийнэ. 3. Хөрөнгө оруулагчын хөрөнгө оруулалтын гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан Мужийн Хөрөнгө Оруулалтын Асуудал Эрхэлсэн Улсын Захиргааны Байгууллага нь хөрөнгө оруулалтын гэрчилгээг олгоно. Гадаадын хөрөнгө оруулалтын төслийн хөрөнгө оруулалтын бүртгэл /46-р зүйл/ 1. Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ тус бүр нь 300 тэрбум Вьетнам доноос бага бол, мөн түүнчлэн хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүрээний жагсаалтанд ороогүй төсөл бол, хөрөнгө оруулагч нь Мужийн Хөрөнгө Оруулалтын Асуудал Эрхэлсэн Улсын Захиргааны Байгууллагын тогтоосон хэв журмын дагуу хөрөнгө оруулалтын бүртгэлийн процедурыг хийж хөрөнгө оруулалтын гэрчилгээгээ авна. Хөрөнгө оруулалтын төслийн хяналт шалгалт /47-р зүйл / 1. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ тус бүр нь 300 тэрбум Вьетнам донтой тэнцэх буюу түүнээс их бол, мөн тухайн төсөл нь хөрөнгө оруулалтыг хязгаарлах төслийн жагсаалтанд орсон бол, хөрөнгө оруулалтын гэрчилгээг авахдаа хяналт шалгалтыг хийнэ. 2. Хөрөнгө оруулалтын хяналт шалгалтын хугацаа нь бүрэн бүтэн, хүчин төгөлдөр материалыг хүлээн авснаас хойш 30 өдрөөс хэтрэхгүй байна. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг сунгаж болох ба 45 өдрөөс хэтрэхгүй байна.
5	Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчдын хандлагын ялгаа	Хуулинд зааснаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хуулийн өмнө тэгш эрхтэй байх бөгөөд давуу эрхийн баталгааг нэгэн адил олгоно.
6	Хөрөнгө оруулалтын хориглолт, хязгаарлалт	Хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүрээнд: - Үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдал, нийгмийн хэв журам, аюулгүй байдалд нөлөөлөх салбар - Банк санхүүгийн салбар - Олон нийтийн эрүүл мэндэд нөлөөлөх салбар - Соёл, мэдээ мэдээлэл, хэвлэл мэдээллийн салбар - Үзвэр үйлчилгээ - Үл хөдлөх хөрөнгийн бизнесс - Байгалийн баялаг, уул уурхайн судалгаа, нээлт хийх болон экологи байгаль орчин - Боловсрол сургалт - Хуульд заасан бусад салбарууд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

7	Хөрөнгө оруулалтанд олгох давуу эрх /татвар, газар болон бусад/	Давуу эрх эдлэх хөрөнгө оруулалтын хүрээнд /27-р зүйл/ 1. Шинэ материал, бүтээгдэхүүн, шинэ эрчим хүч, өндөр технологи, био технологи, мэдээлэл технологи, механик инженерийн бүтээгдэхүүн үйлдвэр 2. Фирм, газар тариалан, ойн болон усан бүтээгдэхүүн, давс, нийлмэл материал үржүүлэх, ургамлын шинэ төрөл эсвэл амьтан үржүүлэг 3. Өндөр технологи, орчин үеийн техникийн хэрэглээ, байгаль орчны хамгаалалт, өндөр технологийн хөгжил, судалгаа 4. Их хэмжээний хөдөлмөрийн хүч, ажиллах хүч 5. Дэд бүтцийг хөгжүүлэх болон барих, том хэмжээний чухал төслүүд 6. Боловсрол, сургалт, эрүүл мэнд, биеийн тамир, спорт болон үндэсний соёлыг хөгжүүлэх 7. Үндэсний гар урлал, аж үйлдвэрийн хөгжил 8. Бусад дэмжлэг хэрэгтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ Хөрөнгө оруулалтын давуу эрх эдлэх нутаг дэвсгэрт /28-р зүйл/ 1. Нийгэм эдийн засгийн маш хүнд нөхцөл байдалтай нутаг дэвсгэр 2. Аж үйлдвэрийн парк, экспортын бүс нутаг, өндөр технологийн парк, эдийн засгийн бүс нутаг. Хөрөнгө оруулалтын давуу эрх эдлэх, хөрөнгө оруулалтыг хязгаарлах хүрээ болон нутаг дэвсгэрүүдийн жагсаалтыг нийтлэн гаргана /31-р зүйл/. Хөрөнгө оруулалтын давуу эрхийг эдлэх хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага /32-р зүйл/ 1. ХО-ын давуу эрх эдлэх хөрөнгө оруулагч нь уг хуулийн 27, 28-р зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөлтэй байх ёстой. Энэ шаардлагыг хангасан хөрөнгө оруулагч нь энэ хууль болон холбогдох бусад хуулинд заасан давуу эрхүүдийг эдэлж болно. 2. ХО-ын давуу эрхийг эдлэх этгээд нь шинэ хөрөнгө оруулалтын төсөл, хөрөнгө оруулалтын төслийн хүрээг өргөтгөх, үйл ажиллагааны чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, байгаль орчны бохирдлыг бууруулах зэрэг шаардлагыг хангасан байх ёстой. Татварын давуу эрх /33-р зүйл/ - ХО-тын төсөлтэй хөрөнгө оруулагчид нь татварын хуулинд заасны дагуу татварын хөнгөлөлттэй хувь хэмжээ, татварын хөнгөлөлттэй хувь хэмжээг эдлэх хугацаа, татварын хөнгөлөлт, татвараас чөлөөлөх зэрэг давуу эрхүүдийг эдэлнэ. - Вьетнам улсын импорт экспортын татварын хуулинд заасны дагуу ХО-тын төслийн гүйцэтгэлийн тоног төхөөрөмж, материалыг импортлоход импортын татвараас чөлөөлнө. - Татварын хуулинд заасны дагуу хөрөнгө оруулалтын давуу эрх эдлэх төслийн технологийн шилжүүлэлтийн орлогоос орлогын албан татварыг чөлөөлнө. Газар ашиглалтад эдлэх давуу эрх /36-р зүйл/ 1. Хөрөнгө оруулалтын төслийн газар ашиглалтын хугацаа 50 жилээс хэтрэхгүй байна. Хууль заасан шаардлагатай тохиолдолд газрын түрээсийн хугацааг 70 жилээс ихгүйгээр олгож болно. 2. Газар ашиглалтын хугацаа дууссаны дараа, хэрэв хөрөнгө оруулагчид газрын хуулийг сахин биелүүлж байсан бөгөөд үргэлжлүүлэн газар ашиглах хүсэлтэй бол холбогдох зөвшөөрлийг олгоно. 3. ХО-ын хийж буй хөрөнгө оруулалтын төсөл нь хөрөнгө оруулалтын давуу эрх эдлэх хүрээ эсвэл нутаг дэвсгэрт тохирч байвал, холбогдох хуулийн дагуу газрын түрээс болон газар ашиглалтын татварын хөнгөлөлт эдлэх эсвэл татвараас чөлөөлүүлж болно. Аж үйлдвэрийн парк, экспортын бүс, өндөр технологийн парк, эсвэл эдийн засгийн бүс нутгуудад хөрөнгө оруулалт хийж буй хөрөнгө оруулагчдын эдлэх давуу эрх /37-р зүйл/

8	Хөрөнгө оруулалтын давуу эрхийн гэрчилгээний өргөдөл гаргах нь	1. ХО-д хөрөнгө оруулалтын давуу эрхийн гэрчилгээний өргөдөл гаргахдаа хөрөнгө оруулалтын бүртгэлийн процдурыг гүйцэтгэнэ. 2. ХО-ын хяналт шалгалтанд орсон, давуу эрхийг эдлэх нөхцлийг хангасан дотоодын ХО-ын төслүүд эдлэх хөрөнгө оруулалтын давуу эрхийг тэдний хөрөнгө оруулалтын гэрчилгээнд бичиж өгнө. 3. Давуу эрх эдлэх нөхцлийг хангасан ГХО-ын төслүүдэд, хөрөнгө оруулалтын давуу эрхийг тэдний хөрөнгө оруулалтын гэрчилгээнд бичиж өгнө.
9	Гадаадад хийх хөрөнгө оруулалт	Гадаадад хийх хөрөнгө оруулалт /74-р зүйл/ 1. Гадаадад хийх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тааламжтай нөхцөл бүрдүүлэх болон гадаадад хөрөнгө оруулалт хийж буй Вьетнамын хөрөнгө оруулагчийн хуулийн ашиг сонирхлыг Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай хэлэлцээр хийсэн талын хэлэлцээрийн дагуу хамгаална. Гадаадад хийх хөрөнгө оруулалтыг дэмжих ба хориглох хүрээ /75-р зүйл/ 1. Вьетнам улс нь гадаадад хөдөлмөр экспортлох, Вьетнамын үндэсний гар урлал болон аж үйлдвэрийг үр дүнтэй дэмжих, зах зээл өргөтгөх, мөн хөрөнгө оруулалт хийх улсад байгалийн баялагийг нээх гэсэн салбаруудад хөрөнгө оруулалт хийж буй бүхий л эдийн засгийн байгууллага, хуулийн этгээдийг дэмжинэ. 2. Вьетнам улс нь улсын нууц, аюулгүй байдал, батлан хамгаалах, түүх, соёл уламжлалд хохирол учруулж болох холбогдох хөрөнгө оруулалтын төсөлд гадаадад хийх хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгохыг хориглоно.

* * *

2. ИНДОНЕЗИ

❖ Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Индонези улс нь хурдацтай хөгжиж буй тэнцвэртэй эдийн засагтай улс юм. Газар тариалангийн салбар нь түүхэнд голлох үүрэг гүйцэтгэдэг байсан бол сүүлийн 40 жилийн турш уул уурхайн салбар нь эдийн засагт чухал байр суурийг эзэлж байна. Хамгийн их экспортолдог бараа бүтээгдэхүүний төрөлд газрын тос, байгалийн хий, нүүрс болон бусад уул уурхайн бүтээгдэхүүн, газар тариалангийн бүтээгдэхүүн, электрон машин, тоног төхөөрөмж, загас зэрэг ордог.[2]

Зураг 1.



1995 - 2011 оны хооронд Индонези улсад хийгдсэн хөрөнгө оруулалтын дүн болон төслийн тоо

[2] 2011 онд Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Дэлхийн Өрсөлдөх Чадварын тайланд 139 орноос 44 дүгээр байрт жагссан үзүүлэлт нь хөрөнгө оруулалт хийхэд таатай улсуудын тоонд орсон байна.

Статистик мэдээллээс харахад 2012 оны 3-р улирлын байдлаар Индонези улсын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 31 хувийг дотоодын шууд хөрөнгө оруулалт, 69 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

2012 оны 3 -р улирлын байдлаар Индонези улсад хийж буй гадаадын хөрөнгө оруулалтын гол салбаруудад: машин, бусад тээврийн үйлдвэр 0,5 тэр бум ам.долл, цаас, хэвлэх үйлдвэр 0,7 тэр бум ам.долл, тээвэр харилцаа холбоо 0,8 тэрбум ам.долл, уул уурхай 1,1 тэрбум ам.долл, хими, эм үйлдвэрлэл 1,1 тэрбум.ам долл бусад салбар 2,1 тэрбум ам.долл байна. Хөрөнгө Оруулалтын Зохицуулах Зөвлөл нь /Indonesia Investment Coordinating Board/ Индонезийн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын ихэнх төсөлд зөвшөөрөл олгох ба харин Засгийн газрын агентлаг, яамдууд нь газрын тос, байгалийн хий, банк, даатгалын салбарын хөрөнгө оруулалтыг хариуцна.

❖ Хөрөнгө оруулалтын орчин:

1	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин	Бүгд Найрамдах Индонези улсын Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2007-25 /Law of The Republic of Indonesia, Concerning Investment, Number: 25 Of 2007/ Хөрөнгө оруулалт гэж Бүгд Найрамдах Индонези улсын нутаг дэвсгэрт бизнесс эрхэлж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын аливаа бүх төрлүүдийг хэлнэ.
2	Хөрөнгө оруулалтын зарчим	1. Засгийн газар хөрөнгө оруулалтын үндсэн бодлогыг тодорхойлохдоо: - Үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор үндэсний үр ашигтай бизнессийн хөрөнгө оруулалтын орчинг бүрдүүлэх - Хөрөнгө оруулалтын хэмжээг ихэсгэх зорилготой. 2. Дээрх үндсэн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар нь Үндэсний эрх ашигт үндэслэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ижил тааламжтай нөхцөл олгоно.
3	Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчдын хандлагын ялгаа	Уг хуульд зааснаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад эрх зүйн баталгааг нэгэн адил олгох бөгөөд уг хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих.

4	Хөрөнгө оруулалтын тааламжтай нөхцөл	Уг хуулиар хөрөнгө оруулагчид нэн тааламжтай нөхцөлийг бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөж буй хөрөнгө оруулагчидад болон шинээр бизнес эрхэлж буй хөрөнгө оруулагчид олгоно. Уг тааламжтай нөхцөлийг олгохдоо хуулийн 18-р зүйлд тухайн хөрөнгө оруулагчид тавигдах шаардагуудыг хуульчилан тогтоож өгсөн байдаг. Шалгуурыг хангасан хөрөнгө оруулагчидад дараах хөнгөлөлтийг олгоно. - Тодорхой заасан хугацаанд хийсэн хөрөнгө оруулалтын тодорхой заасан түвшинд хүртэлх орлогын албан татварын суутгал хийх; - Дотоодод үйлдвэрлэх боломжгүй үйлдвэрийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, машин импортлоход, импортын татварын хөнгөлөлт эдлэх эсвэл импортын татвараас чөлөөлөх - Тодорхой заасан хугацаанд тодорхой нөхцөлтэйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түүний түүхий эдийг эсвэл туслах материалыг импортлоход, импортын татварын хөнгөлөлт эдлэх эсвэл импортын татвараас чөлөөлөх - Тодорхой заасан хугацаанд дотоодод үйлдвэрлэх боломжгүй үйлдвэрийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, машин импортлоход нэмэгдсэн өртгийн албаны татварын хөнгөлөлт эсвэл татвар төлөх хугацааг хойшлуулах - Тодорхой заасан нутаг дэвсгэрт, тодорхой заасан бизнессийн салбарт үл хөдлөх хөрөнгийн татварын хөнгөлөлт эдлэх Хууль заасан тааламжтай нөхцөл, давуу байдлыг Засгийн газраас тодорхойлсон Үндэсний аж үйлдвэрийн бодлогын баримт бичигт тулгуурлан олгодог байна. Мөн түүнчлэн Засгийн газраас доор заасан үйлчилгээ болон лицензийн тааламжтай нөхцлийг хөрөнгө оруулалтын компаниудад олгоно: 1) Газрын эрх 2) Цагаачлалын албаны үйлчилгээний тааламжтай нөхцөл 3) Импортын лицензийн тааламжтай нөхцөл Дээр дурьдсан үйлчилгээ болон газрын эрхийн зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн хүсэлтийн дагуу доор заасан хэлбэрээр сунгаж, үргэлжлүүлэн сунгаж, шинэчлэж болно: 1) Түрээсийг 95 жилээр олгох ба 60 жилээр үргэлжлүүлэн сунгаж болох ба мөн цаашид 35 жилээр шинэчилж болно. 2) Барилгын эрхийг 80 жилээр олгох ба 50 жилээр үргэлжлүүлэн сунгаж болох ба мөн цаашид 30 жилээр шинэчилж болно. 3) Хэрэглээний эрхийг 70 жилээр олгох ба 45 жилээр үргэлжлүүлэн сунгаж болох ба мөн цаашид 25 жилээр шинэчилж болно. Импортын лицензийн хөнгөлөлтийг олгох бүтээгдэхүүн нь: 1) Худалдааны зохицуулах хуулийг зөрчөөгүй аливаа бүтээгдэхүүн. 2) Үндэсний аюулгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин болон ёс заншилд сөрөг нөлөө үзүүлэхгүй аливаа бүтээгдэхүүн. 3) Гадаадаас Индонези улсад шилжүүлсэн үйлдвэрийн аливаа бүтээгдэхүүн. 4) Өөрсдийн бүтээгдэхүүний хэрэгцээнд зориулан материал эсвэл үйлдвэрлэлийн хэрэгсэл, тоног төхөөрөмж байна.

UHF.MN
ЭЭЛЖИЙН САНАЛ САН

3. КАЗАХСТАН

Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

2010 оны байдлаар тус улсын нийт хөрөнгө оруулалтын 48%-ийг хувийн хөрөнгө оруулалт, 30%-ийг гадаадын хөрөнгө оруулалт, үлдсэн 22% -ийг улсын төсвийн хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна. Энэ үзүүлэлтүүдийг 2006 оныхтой харьцуулахад хувийн хөрөнгө оруулалт 1,3 дахин, гадаадын хөрөнгө оруулалт 1,8 дахин, улсын хөрөнгө оруулалт 2,7 дахин тус тус өссөн байна. Казахстан улсын 2011 оны нийт хөрөнгө оруулалтын үзүүлэлтийг 2007 оныхтой харьцуулахад 47 хувиар, нэг хүнд ногдох хөрөнгө оруулалт 39 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1. **Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, сая тенге**

	2006	2007	2008	2009	2010
Нийт хөрөнгө оруулалт	2 824 523	3 392 122	4 210 878	4 585 298	4 653 528
Үүнээс:					
• улсын	385 686	555 830	813 337	851 452	1 036 774
• хувийн	1 687 784	1 933 319	2 302 592	2 307 747	2 239 306
• гадаадын	751 053	902 973	1 094 949	1 426 099	1 377 448

2006 онд нийт хөрөнгө оруулалтын 47 хувийг аж үйлдвэрийн салбарт оруулж байсан бол 2010 онд 55% болж өссөн бөгөөд энэ хугацаанд аж үйлдвэрийн салбарт оруулж байсан хөрөнгө оруулалтын 65-68 хувь нь уул уурхайн салбарт орсон байна.[3]

❖ Хөрөнгө оруулалтын орчин:

1	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин	Хөрөнгө оруулалтын тухай хуулиар /2003/ Казахстан улсад хөрөнгө оруулалтын эрх зүйн болон эдийн засгийн үндэс, тус улсад хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, хөрөнгө оруулалтад үзүүлэх төрийн дэмжлэг, хөрөнгө оруулагч талуудын хооронд үүссэн маргааныг зохицуулах журам зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Уг хуулиар гадаадын төдийгүй дотоодын хөрөнгө оруулагчдад ялгаварлахгүйгээр зохицуулж өгсөн байна. Хөрөнгө оруулалт гэдэг нь хуулийн этгээдийн дүрмийн санд, эсхүл үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах тогтсон активыг нэмэгдүүлэх зорилгоор оруулж буй бүх төрлийн /хувийн хэрэгцээний бараа, бүтээгдэхүүнээс бусад нь/ хөрөнгийг, үүнд лизингийн гэрээ байгуулсан үеэс эхлэн санхүүгийн лизингийн зүйл болон эдгээр бүх хөрөнгөд хамаарах эрхийг хэлнэ хэмээн тусгажээ. Хөрөнгө оруулагч гэдэг нь Казахстан улсад хөрөнгө оруулалт хийж буй хувь хүн, хуулийн этгээд хэмээн тодорхойлсон байна. Төсвийн хөрөнгөөр, мөн түүнчлэн боловсрол, халамж, эрдэм шинжилгээ, эсхүл шашны үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллагад хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой харилцааг уг хуулиар зохицуулахгүй.

[3] Казахстан в 2010 году (статистический ежегодник). Эх сурвалж: http://www.stat.kz/

2	Хөрөнгө оруулагчийн эрх зүйн баталгаа	Хөрөнгө оруулагчидад эрх зүйн баталгааг олгох бөгөөд үүнд төрийн байгууллагын зүгээс Казахстан улсын хуультай харьшилдах эрх зүйн акт шинээр гаргасан, эсхүл тийм байгууллагын албан тушаалтан хууль бус үйлдэл хийснээс хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд тус улсын Иргэний хуулиар зохицуулсаны дагуу хохирлоо барагдуулна. Уг хуулиар тогтвортой байдлын баталгаа хэмээн ойлголт үүсэж байгаа бөгөөд энэ нь хөрөнгө оруулагч, төрийн байгууллагын хооронд хийсэн гэрээний, талуудын харилцан тохиролцож хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс бусад нөхцөлийг уг баталгаагаар хангах ба дараах тохиолдолд хэрэгжихгүй: • онцгой албан татварт барааны импорт, үйлдвэрлэл, борлуулах журам болон нөхцөлийг өөрчилж байдаг Бүгд Найрамдах Казакстан Улсын хууль тогтоомж өөрчлөгдсөн, эсхүл Бүгд Найрамдах Казакстан Улсын олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон ба өөрчлөгдсөн бол • үндэсний болон экологийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах үүднээс Казакстан улсын хууль тогтоомжид нэмэлт, өөрлөлт орж буй бол
3	Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт	Төрөөс үзүүлж буй дэмжлэг болох хөрөнгө оруулалтын преференц буюу хөнгөлөлт бөгөөд энэ нь хуулийн 1-т зааснаар Казакстан улсад хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлж буй Казахстан улсын хуулийн этгээдэд хамаарна. Энэхүү дэмжлэгийн зорилго нь хөрөнгө оруулалтын орчныг таатай болгох, мөн түүнчлэн орчин үеийн технологийг ашиглах, казахстаны боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлдвэрлэлийг байгуулах, өргөтгөх, шинэчлэх хөрөнгө оруулалтыг урамшуулах зорилготой. Хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг Засгийн газраас батлан гаргасан эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн ангилалтын түвшинд, эсхүл хөрөнгө оруулалтын стратегийн ач холбогдолтой төслийн жагсаалтад тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд олгоно. Эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсанаар дараах хөрөнгө оруулалтын хөнгөлөлтийг эдэлнэ: • Гаалийн албан татвараас чөлөөлөх - Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүний сэлбэг, түүхий эд /Гаалийн холбоо болон Казахстан улсын хууль тогтоомжид нийцсэн/, импортлоход гаалийн албан татвараас чөлөөлөгдөнө. - Энэ нь хөрөнгө оруулалтын гэрээ бүртгэгдсэнээс хойш 5 жил хүчинтэй байна. - Төрөөс олгох урамшуулал гэдэг нь хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд зориулж Казахстан улсын хуулийн этгээдэд Казакстан улсын өмчлөлд буй хөрөнгийг түр хугацаагаар, төлбөргүйгээр ашиглуулах, эсхүл түр хугацаагаар, төлбөргүйгээр газар ашиглуулахыг хэлнэ. - Төрөөс олгох урамшуулалд газар, байшин барилга, байгууламж, автомашин, тоног төхөөрөмж, тооцоолох техник, хэмжигч болон тохируулагч багаж, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн болон ахуйн багаж гм. - Төрөөс олгох урамшуулал нь хөрөнгө оруулалтын 30-аас илүүгүй хувь байх ба урамшуулалыг хууль тогтоомжийн дагуу зах зээлийн үнээр үнэлнэ. • Газрын болон хөрөнгийн татварын хөнгөлөлт - Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд Казахстан улсын татварын хууль тогтоомжид заасан журмын дагуу газрын болон хөрөнгийн татварын хөнгөлөлт үзүүлнэ болно. • Үйлдвэрлэлийн хөнгөлөлт - Нийгэм-эдийн засгийн хөгжил доогуур суурин газарт хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдэд хий, цахилгаан хэрэглэх, газар болон байшин барилга, байгууламж эзэмшихэд зэрэгт хөнгөлөлт үзүүлнэ.
4	Бүртгэлийн үйл ажиллагаа	Бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг хуулиар тогтоож өгсөн бөгөөд эрх бүхий байгууллага тэдгээрийг хүлээн авч 10 хоногийн дотор судлан үзнэ. Бүртгэх тухай шийдвэр гарсанаас хойш 10 хоногийн дотор гэрээ байгуулж, түүнээс хойш 5 хоногийн дотор бүртгэнэ. Бүртгэл хийгдсэн өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно

UIH.MN
ЭЗЭМШИГЧИЙН ХАНЫСАН

5	Хөрөнгө оруулалтын гэрээний биелэлтийн хяналт	• Эрх бүхий байгууллагын зүгээс хөрөнгө оруулалтын гэрээний биелэлтийн объект дээр үзлэг хийх, тайланг судлах зэргээр хяналтыг хэрэгжүүлнэ. • Гэрээ байгуулсан хуулийн этгээд нь тогтоосон маягтын дагуу тайланг гаргаж, холбогдох баримт бичгийн хамт хагас жил тутамд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. • Үйл ажиллагааны хөтөлбөр дууссан нөхцөлд гэрээний дуусахаас 3 сарын өмнө хөрөнгө оруулагч талын объект дээр үзлэг хийнэ. • Үйл ажиллагааны хөтөлбөрийг биелүүлээгүй хуулийн этгээдэд эрх бүхий байгууллагаас 2 сарын хугацаанд зөрчлийг арилгахыг сануулсан албан бичгийг явуулна. \ • Гэрээ байгуулсан хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд үйл ажиллагааны зорилго, мөн түүнчлэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон хөрөнгө зэргийг өөрчлөх эрхгүй

4. ОРОС

❖ Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

2010 оны байдлаар ОХУ-ын нийт хөрөнгө оруулалтын 87,1 хувийг ОХУ-ын хөрөнгө оруулалт, 7,6 хувийг орос болон гадаадын хамтарсан хөрөнгө оруулалт, үлдсэн 8,2 хувийг гадаадын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг 2005 оныхтой харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалт 2,9 хувиар, орос болон гадаадын хамтарсан хөрөнгө оруулалт 3,6 хувиар тус тус буурсан байхад дотоодын хөрөнгө оруулалт нь 6,5 хувиар өссөн байна. ОХУ-ын 2010 оны нийт хөрөнгө оруулалтын үзүүлэлт болон нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтыг 2005 оныхтой харьцуулахад тус тус 3 дахин нэмэгдсэн байна. ОХУ-ын нийт хөрөнгө оруулалтын 59,4 хувийг хувийн хөрөнгө оруулалт, 16,7 хувийг улсын хөрөнгө оруулалт, 7,0 хувийг оросын холимог хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна. Эдгээрээс 2005-2010 оны хооронд хувийн хөрөнгө оруулалт тогтмол дунджаар 2,9 хувиар өсөж ирсэн байна.

Хүснэгт 2. ОХУ -д орох хөрөнгө оруулалтын эх үүсвэр, тэрбум рубль[4]

	2005	2006	2007	2008	2009	2010
Нийт хөрөнгө оруулалт	3611,1	4730,0	6716,2	8781,6	7976,0	9151,4
Үүнээс:						
ОХУ	2909,0	3861,3	5580,7	7358,9	6795,6	7968,3
Үүнээс:						
- улсын	677,7	828,3	1190,8	1589,6	1537,3	1525,8
- орон нутаг	137,6	197,5	298,1	380,1	288,9	270,9
- хувийн	1623,1	2249,6	3336,9	4490,6	4405,4	5440,3
- оросын холимог	465,6	579,5	746,1	887,6	556,2	641,4
- бусад	5,0	6,4	8,8	11,0	7,8	7,1
Гадаадын	298,4	367,3	476,8	655,7	545,0	486,7
Оросын болон гадаадын хамтарсан	403,7	501,4	658,7	767,0	635,4	696,4

[4] Федеральной службы государственной статистики. Эх сурвалж: http://www.gks.ru/

2010 оны байдлаар ОХУ -д гадаадын нийт хөрөнгө оруулалтын 33,1 хувийг санхүүгийн үйл ажиллагаа, 28,9 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 12,1 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг 2005 оныхтой харьцуулахад боловсруулах үйлдвэрлэл 4,6 хувиар буурсан бол ашигт малтмалын олборлолт 0,9 хувиар өссөн, харин санхүүгийн үйл ажиллагаа бүр 29,7 хувиар өссөн байна.

Хөрөнгө оруулалтын орчин:

1	Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин	ОХУ дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль[1] /1999 он/ - ОХУ дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн баталсан нь гадаадын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах, тэдний үйл ажиллагааг дэмжихэд илүү анхаарсан байна. Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хууль[2] /2008 он/ - 2008 онд батлагдсан Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулиар гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдийн хувьцааг эзэмших тухай, эсхүл энэ төрлийн ААН-үүдэд хяналт тогтоох тухай хэлцлийг хязгаарлах, тэдгээрийнүйл ажиллагааг тодорхой болгох, ААН-үүдийн хөрөнгө оруулах өргөдлийг хянаж үзэх процедур, хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага зэрэг асуудлыг зохицуулсан байна.[3] ОХУ-д капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй үйл ажиллагааны тухай хууль[4] /1998 он/ - ОХУ-д капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй үйл ажиллагааны тухай хуулиар ОХУ-ын нутаг дэвсгэр дээр капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны эрх зүйн болон эдийн засгийн үндэсийг тогтоосон, мөн түүнчлэн хуулийн этгээлийн хэлбэрийг үл хамааран капитал хэлбэрээр хөрөнгө оруулж буй субъектын эрх, сонирхлыг тэгш хамгаалах баталгааг тогтоосон байна. АДМИНИСТРАТИВНЫЙ РЕГЛАМЕНТ Федеральной антимонопольной службы по исполнению государственной функции по рассмотрению уведомлений о приобретении иностранным инвестором или группой лиц, в которую входит иностранный инвестор, пяти и более процентов акций (долей), составляющих уставные капиталы хозяйственных обществ, имеющих стратегическое значение для обеспечения обороны страны и безопасности государства

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2	Хөрөнгө оруулагчид үзүүлэх баталгаа буюу тогтворжуулалт	Гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлэх нийт 13 төрлийн үндсэн баталгаануудыг хуулийн 5-17-р зүйлүүдэд оруулсан байна. Тухайлбал, • үйл ажиллагааны эрх зүйн хамгаалалт /5-р зүйл/ • хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг хэрэгжүүлэх /6-р зүйл/ • эрх, үүргийг нь өөр этгээдэд шилжүүлэх баталгаа /7-р зүйл/ • гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн эд хөрөнгийн улсад хураах, улсын болгоход нөхөн олговор олгох /8-р зүйл/ • гадаадын хөрөнгө оруулагч, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай ААН-н хувьд ОХУ-ын хууль тогтоомжинд таагүй өөрлөлт орохоос сэргийлэх /9-р зүйл/ • хөрөнгө оруулалт оруулах, аж ахуйн үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор үүсэх маргааныг зохих ёсоор шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх /10-р зүйл/ • ОХУ-ын нутаг дэвсгэрт олсон орлого, бусад хууль ёсоор олсон мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах, өөр улс руу шилжүүлэх /11-р зүйл/ • ОХУ-ын нутаг дэвсгэрт анхлан гадаадын хөрөнгө оруулалтын хэлбэрээр зөөвөрлөн оруулсан эд хөрөнгө, баримт бичиг, эсхүл цахим зөөврийн хэрэгсэлд агуулах мэдээлэлийг ОХУ-аас саадгүй зөөвөрлөн гаргах эрх /12-р зүйл/ • үнэт цаас олж авах эрх /13-р зүйл/ • хувьчлалд оролцох эрх /14-р зүйл/ • гадаадын хөрөнгө оруулагчид газар, бусад байгалийн баялаг, барилга байгууламж болон бусад үл хөдлөх эд хөрөнгө олж авах эрх /15-р зүйл/ • гаалийн албан татвараас хөнгөлөх /16-р зүйл/ • ОХУ-ын субъектууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үзүүлэх хөнгөлөлт /17-р зүйл/ Гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлэх нь Холбооны улсын татварын тухай хуулиар нарийвчлан зохицуулагдана. ОХУ-ын субъектууд болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын өөрсдийн эрх мэдлийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжидэл татварын хөнгөлөлт үзүүлэх, баталгаа гаргах, санхүүжилт хийх болон гадаадын хөрөнгө оруулагчийн хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөлд бусад хэлбэрийн дэмжлэгийг үзүүлж болно.

* * *

5. БРАЗИЛЬ

❖ Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Бразиль нь эдийн засгийн хөгжлөөрөө Латин Америкийн орнууддаа тэдийгүй дэлхийд тэргүүлдэг улсын нэг юм. ДНБ -ний жилийн өсөлт нь 7,5 хувьтай, гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татаж чадсан улс. 2005-2010 онуудад ГХО-ын өсөлт хамгийн өндөр байсан ба ихэнх хэсэг нь санхүү, газрын тос, хий, харилцаа холбооны салбаруудад АНУ, Испани, Португал, Нидерланд, Франц зэрэг орнуудаас хийгджээ.

Бразилийн хөрөнгө оруулалтын орчинг судлан үзэхэд дотоод, гадаад хөрөнгө оруулалтыг нийтлэг байдлаар зохицуулсан хууль гаргаагүй ба дотоодоос гадагшлах хөрөнгийн урсгал нь 2010 онд 11.5 тэрбум ам.доллар байсан бол 2011 онд сөрөг утгатай болж, хөрөнгө оруулалтын урсгал гадагшлаагүй гэсэн тоо баримт байна. Энэ нь нэг талаар тус улсын

эдийн засаг тогтвортой байгааг харуулж байна.[5] Бразилийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг ч тодорхой салбарт хязгаарлалтыг хийх бодлого баримталдаг улс бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалттай холбоотой мэдээллийг доор хүснэгтээр харуулав.

❖ Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин:

1	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин	Ерөнхийдөө доорх 3 төрлийн эрх зүйн баримт бичигт захирагдан гадаадын хөрөнгө оруулалт хийгддэг. Үүнд: 1. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль- Law No4131/62 2. Засгийн газрын шийдвэр - 4390/64. /Зарлиг N55762/65/- Энэ хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулалтын ерөнхий эрх зүйн орчинг зааж өгсөн. Бразилийн төв банкнаас гаргасан дүрэм зааврууд нь энэ баримт бичгийн бүрэлдэхүүн болдог. 3. Онцгойлсон бизнест хийх хөрөнгө оруулалтыг үндсэн хууль болон зарим тусгай хуулиар хязгаарлалт хийдэг.
2	Гадаадын хөрөнгө оруулалтын зарчим	Гадаадын хөрөнгө оруулалт нь үндсэн 2 хэлбэрээр хийгдэнэ. 1. Бэлэн мөнгөөрх хөрөнгө оруулалт 2. Зээл болон бараа бүтээгдэхүүнээр хөрөнгө оруулалт Бараа бүтээгдэхүүнээр хийж байгаа хөрөнгө оруулалтанд тодорхой хязгаар тавьдаг. Үүнд: - Зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн бараа бүтээгдэхүүн байна. - Дотоодод үйлдвэрлээгүй, баталгаатай байх ба улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгахад хувь нэмрээ оруулсан бараа бүтээгдэхүүн байна.
3	Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчдын хандлагын ялгаа	Бразильд оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтанд үйлчлэх хуулийн хүрээ нь дотоодын хөрөнгө оруулалттай адил байна. Хуулиар зөвшөөрөгдөөгүй ямар нэг онцлог зүйлийг хориглосон байдаг. Гадаадын компаниуд нь Бразильд 6-аас дээш жилийн хугацаанд хөрөнгө оруулсан нөхцөлд дотоодын өмч хувьчлалд оролцох боломжтой.
4	Гадаадын хөрөнгө оруулалтын хориглолт, хязгаарлалт	-Гадаадын хөрөнгө оруулалтын оролцоог хориглох нь: Олон талт цөмийн энергийн үйл ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ, шуудан харилцаа холбооны үйлчилгээ, агаарын нислэг, сансарын хөлгийн үйлдвэрлэлд гадаадын хөрөнгө оруулалт хийхийг хориглодог. -Гадаадын хөрөнгө оруулалтын оролцоог хязгаарлах нь: Хөдөөгийн бүс нутгийн болон хил хязгаарын бүс дэх газарт үйл ажиллагаа явуулах, түрээслэх, худалдан авах, сонин телевиз радио сүлжээний менежемент хийх болон эзэмшүүлэх, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулах, санхүүгийн салбар /банк, даатгал/-т хөрөнгө оруулалт хийхэд тус тус нь хязгаарлалт хийдэг.

[5] Дэлхийн банк болон Олон улсын санхүүгийн корпорациас улс орнуудын хөрөнгө оруулалтын орчинг үнэлдэг “doing bussines-2013” тайлангаар нийт 185 орноос тус улс нь бизнесийн таатай орчны үзүүлэлтээр 130 дугаар байрт, хөрөнгө оруулалтыг хамгаалах үзүүлэлтээр 82 дугаар байрт оржээ.

UIS.MN
СУДАЛГААНЫ САН

5	Хөрөнгө оруулагч ашгаа шилжүүлж авах болон капитал хөрөнгөө буцаан татахад тус улсын хандлага	Гадаадын хөрөнгө оруулагч нь хуулийн дагуу Бразилийн төв банкинд бүртгэл хийлгэсэн тохиолдолд капиталаа буцаан татах, ашгаа шилжүүлэн авахад хязгаарлалт, зөвшөөрөл шаарддаггүй. Төлбөрийн балансын хямралаас шалтгаалан түр зуурын хязгаарлалт байж болдог. 1996 оноос хойш гадаадын хөрөнгө оруулагч нь ашгаа шилжүүлж авах болон капиталаа буцаан татахад авах орлогын татварыг хөнгөлсөнГадаадын хөрөнгө оруулагч нь капиталаа буцаан татах онцгой нөхцөлд Төв банк нь тухайн хөрөнгө компанийн бүртгэлд тусгагдсан эсэхийг балансаар нь шалгах ба хэрвээ тусгагдаагүй бол хөрөнгө оруулалтыг бууруулж бүртгэх, эсвэл балансад тусгагдаагүй хөрөнгийн хэмжээгээр капиталын буцаалтыг бууруулж зөвшөөрлийг олгох арга хэмжээнүүдийг авч болно.
6	Гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах талаар	Холбооны Засгийн газрын бодлогод гадаадын хөрөнгө оруулалтанд онцгой тэтгэлэг, урамшуулал байдаггүй. Гэхдээ нэг тогтсон дүрэм нь үйлдвэрлэлд оруулж байгаа капиталаарх гадаадын хөрөнгө оруулалтыг импортоор оруулахдаа гаалийн албан татварын хувь хэмжээнд нь хөнгөлөлт үзүүлдэг.
7	Татварын орчин	Ажил эрхлэлтийн татвар – Цалингаас 3 төрлийн татвар тооцдог. - Ажил олгогчийн нийгмийн хариуцлагын татвар 27/29%, Ажил огогчдын нийгмийн хамгаалалд нийт цалингийн 20 хувийн татвар төлдөг. Энэ нь цааш өсч гэнэтийн ослын даатгал болон бусад татварууд нэмэгдээд 27-29 хувь болдог. - Ажилтны нийгмийн хариуцлагын татвар 8/11% - Ажил олгогчийн цалингийн татвар 8% - Ажил олгогч нь сар бүр ажилтны тэтгэврийн санд мөнгө төлдөг.
		Шууд бус татвар - НӨАТ - 7/19% - Орон нутгийн татвар 2-5% - Онцгой татвар /олон төрлийн/ - Импортын татвар /олон төрлийн/
		Ашиг орлогын татвар /withholding tax/-үйлчилгээ үзүүлж байгаа болон хөрөнгө оруулалтаас орж буй санхүүгийн орлогод татвар ноогдуулдаг. - Ерөнхий ашиг орлогын татвар /general withholding tax/- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, үйлчилгээний төлбөр хураамж, хөрөнгийн орлогын, хүүгийн, ноогдол ашгийн болон бусад татварууд орно. Татварын түвшин нь 15-25%. - Үйлчилгээний ашиг орлогын татвар /withholding tax on services/ - 7,5/25% - Эдийн засгийн интервенцийн татвар CIDE-10%. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хэсэгт, техник, захиргааны үйлчилгээ, техникийн тусламж, хий, газрын тосны импорт борлуулалтанд ногдуулдаг.
		Аж ахуйн нэгжийн татвар-Тус улсад аж ахуйн нэгжийн орлогын 2 төрлийн албан татвар байдаг. Эдгээр нь нийтдээ 34 хувь. - Орлогын албан татвар - 25%. Энэ татварын суурь хэмжээ нь 15 хувь бөгөөд жилийн орлого 240,000 бразиль реалээс дээш бол 10%-ийн нэмэлт татвар төлнө. - Ашгаас нийгмийн халамжийн татвар CSLL-9%

		Бусад - Орон нутгийн шилжүүлгийн татвар- 2/6% - Бэлэглэл өв залгамжлалын татвар- 8% хүртэл - Үл хөдлөх хөрөнгийн татвар /олон төрлийн/ - Оршин суугч бусын капиталын өгөөжийн татвар-15% - Санхүүгийн үйл ажиллагааны татвар /олон төрлийн/
8	Хөрөнгө оруулалтын олон улсын гэрээний талаар	Тус улс нь хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах зорилгоор Франц, Итали, Англи, Швейцари, Чили зэрэг 14 оронтой олон улсын гэрээг байгуулсан байна.

6. ЧИЛИ

❖ Хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Чили улс нь үндсэндээ уул уурхайн, түүний дотор зэс молибден зонхилсон эдийн засагтай орон юм. Уул уурхайн салбар нь тус улсын ДНБ-ий 33%-ийг эзэлдэг, дэлхийн цэвэршүүлсэн зэсийн 17%-ийг үйлдвэрлэдэг. Дэлхийн зэсийн нөөцийн 38 хувь нь Чилид ногддог. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 10.1 мянган ам.доллар бөгөөд ДНБ-д хөрөнгө оруулалт 30 хувийг тус тус эзэлдэг байна.

Тус улс нь 2011 онд 17.3 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалтыг татсан ба түүний 34.1% нь уул уурхайд, 22.4% нь үйлчилгээнд, 18.4% нь цахилгаан, хий, усанд, 11.1% нь тээвэр, харилцаа холбоонд, 10.9% нь үйлдвэрлэлд, 1.7% нь барилга байгууламжид, 1.4% нь хөдөө аж ахуй, загас агнуурт тус тус орсон байна.[6] Чили улсад 60 орны хөрөнгө оруулалт бүхий 3000 гаруй компани үйл ажиллагаа явуулж байгаагаас АНУ, Канад, Испани, Англи зэрэг орнуудаас зонхилох хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

❖ Хөрөнгө оруулалтын орчин:

1	Хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин	Чилид гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн гол хоёр баримт бичиг байна. Үүнд: 1. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль-Decree Law 600, 1974 оноос өнөөг хүртэл мөрдөж байгаа. 2. Төв банкнаас гаргасан валютын журмын 14 дүгээр бүлэг.
2	Гадаадын хөрөнгө оруулалтын зарчим	Гадаадаас Чили руу хөрөнгө шилжүүлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээр хийсэн гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын албан ёсны хаягтай Чилийн байгын оршин суугч нь тус улсын гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн зарчимд нийцүүлнэ.

[6] Дэлхийн банк болон Олон улсын санхүүгийн корпорациас улс орнуудын хөрөнгө оруулалтын орчинг үнэлдэг “doing bussines - 2013” тайлангаар нийт 185 орноос тус улс нь бизнесийн таатай орчны үзүүлэлтээр 37 дугаар байрт, хөрөнгө оруулалтыг хамгаалах үзүүлэлтээр 32 дугаар байрт оржээ.

SUDAL.MN
СУДАЛГААНЫ САН

3	Гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэлийн үйл ажиллагаа	Гадаадын хөрөнгө оруулалт нь зөвшөөрөл, бүртгэл гэсэн 2 үе шатыг дамжина. 1. Хөрөнгө оруулалтын зөвшөөрлийг тус улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Хорооноос олгоно. Дараахь 4 нөхцөл хөрөнгө оруулалтын зөвшөөрөл шаардана. Үүнд: - 5 сая ам.долларoос дээш болон түүнтэй тэнцэх хэмжээний бусад валютаар хөрөнгө оруулалт хийгдэж байгаа бол, - Төрийн өмчийн оролцоотой компаниудад хөрөнгө оруулж байгаа бол, - Хэвлэл мэдээллийн компаниудад хөрөнгө оруулж байгаа бол, - Гадаадын улсын болон төрийн оролцоотой байгууллагаас хөрөнгө оруулалт хийгдэж бол тус тус зөвшөөрөл авах ёстой. 2. Харин хөрөнгө оруулалтын бүртгэлийг Төв банк капитал хөрөнгө орж ирсэн үед нь бүртгэх ба ингэхдээ олон улсын гадаад валютын журмын заалтыг баримтлан 10 мянгаас дээш ам.долларын хөрөнгө оруулвал түүнийгээ төв банкинд бүртгүүлэх ёстой. Мөн тус журмын дагуу бүртгүүлсэн хөрөнгө оруулагч нь татвар төлөлтөө Төв банкинд мэдээлж байх ёстой.
4	Хөрөнгө оруулалтын гэрээ хийх нөхцөл	Хөрөнгө оруулалтын гэрээг тус улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын Хороо, хөрөнгө оруулагч нарын хооронд хийнэ. Гэрээгээр гадаадын хөрөнгө оруулагч нь тус улсад капитал хөрөнгө оруулах ёстой ба үүний хугацаа нь уул уурхайн хөрөнгө оруулалтанд 8-аас доошгүй жил, бусад салбарт 3 жил байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хороо нь уул уурхайн хөрөнгө оруулалтын дээрх хугацааг 12 жил болгон сунгаж болох ба энэ нь хайгуулын ажил хийх шаардлагатай, хайгуулын хугацааг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд сунгана. Үйлдвэрлэлийн салбар болон уул уурхайн олборлолтоос бусад салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалтын хэмжээ 50.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют байвал дээрх хугацааг 8 жил хүртэл сунгаж болно.
5	Гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчдын хандлагын ялгаа	Чилийн хөрөнгө оруулалтын зохицуулалт нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил нөхцлөөр авч үздэг нь гадаадын хөрөнгө оруулагчдад таатай байдаг. Ингэснээр, гадаадын хөрөнгийг эдийн засгийн салбар бүрээр, бүс бүрт жигд байршуулж чаддаг.
6	Гадаадын хөрөнгө оруулалтын хориглолт, хязгаарлалт	Хөрөнгө оруулалтыг хориглосон салбар: Загас агнуур, банк, даатгал, харилцаа холбоо Хөрөнгө оруулалтыг хязгаарласан салбар: цөмийн эрчим хүч, далайн тээвэр, уул уурхай, батлан хамгаалах салбар, үл хөдлөх хөрөнгө

7	Татварын орчин	Чили улс нь татварын сайн системтэй орнуудын тоонд ордог. Чилийн эдийн засгийн бодлого нь гадаадын хөрөнгө оруулалтанд тусгайлсан урамшуулал тооцоод байдаггүй бөгөөд татвараар дамжуулан дараахь байдлаар дэмжлэг үзүүлдэг. - Гадаадын хөрөнгө оруулагч 10 жилийн туршид 42 хувийн татварыг тогтвортой төлөх ёстой. Энэ татварын хэмжээг Засгийн газар 10 жилийн туршид тогтвортой байлгах үүрэг хүлээх ба 50 саяас дээш ам.долларын хөрөнгө оруулсан бол энэ хугацааг 20 хүртэл жил болгож сунгах эрхтэй. - Уул уурхайн салбарт 50-иас дээш сая ам.долларын хөрөнгө оруулалт хийвэл 15 жилийн хугацаанд татварыг өсгөхгүй байх үүргийг Засгийн газар хүлээнэ. - Албан ёсоор зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын төсөлтэй холбоотой гадаадаас оруулж буй капитал, бараа бүтээгдэхүүнийг НӨАТ / VAT=19%/-аас хөнгөлөлт эдлүүлдэг.
8	Хөрөнгө оруулал-тын олон улсын гэрээний талаар	Тус улс нь хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах зорилгоор Франц, Герман, Испани, Хятад, Бразиль, Аргентин зэрэг 45 оронтой олон улсын гэрээг байгуулсан байна.

* * *

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

Манай улс гадаад орчноос шууд хамааралтай, эмзэг эдийн засагтай жижиг улс. Хоёр их гүрний дунд, далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжтай бус нөхцөлд, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн бага эдийн засагтай, хүн ам цөөнтэй орон тул гадаад хүчин зүйлс, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламж, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцөлд шийдвэрлэх үүрэгтэй.

Манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалт нь бүхэлдээ хийгээд бүсчилсэн нутаг дэвсгэр, тодорхой аймаг нийслэл, сум баг, компанийн хөгжил дэвшил, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг улс төр, эдийн засаг, эрх зүйн чухал хүчин зүйл юм. Монгол улсын эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт голлох байр суурийг эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дараахь давуу талууд байна.

Давуу талууд:	Дутагдалтай талууд нь :
• Гадаадын Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн. • Гадаадын Хөрөнгө оруулалттай холбоотой Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан. • Дэлхийн Худалдааны байгууллага, НҮБ болон холбогдох бусад олон улсын байгууллагад гишүүнээр элссэн. • Нээлттэй эдийн засгийн бодлоготой. • Татварын тогтолцоо, хөнгөлөлт, чөлөөлөлтийн систем • Хоёр их гүрний дунд оршдог • Байгалийн томоохон нөөц ордуудтай.	• Хууль эрх зүй, эдийн засгийн тогтворгүй байдал /эмзэг эдийн засагтай жижиг улс/ • Улс төрийн тогтворгүй байдал • Инфляци • Дэд бүтцийн хөгжил сул • Авлига, хүнд суртал • далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл

❖ Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин

Манай улс бусад орнуудтай харьцуулахад дэлхийн гадаадын хөрөнгө оруулалтын урсгалаас өчүүхэн хэсгийг хүртэж байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа хэдий ч хөрөнгө оруулалтыг дэмжих оновчтой бодлого, зөв зохион байгуулалт, эрх зүйн

таатай орчин зэргийг оновчтой бүрдүүлэн хөгжүүлж чадвал зохих үр шимийг хүртэх бүрэн боломжтой юм. Монгол улс нь Дэлхийн Банкны Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлагийн гишүүн бөгөөд 1965 оны Вашингтоны конвенцид Олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх асуудлаар 1996 онд, 1985 оны Сөүлийн конвенцид хөрөнгө оруулалтын даатгалын асуудлаар 1999 онд тус тус элсэн орсон.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг 1993 оны 5 дугаар сарын 10 -нд шинээр баталсан бөгөөд энэ хуульд 1998, 2001, 2002, 2008, 2011, 2012 онуудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ хуульд “Гадаадын хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ” гэж хөрөнгө оруулалтын үндсэн ойлголтыг тодорхойлсон.

Монгол Улсад оруулах гадаадын хөрөнгө оруулалт нь эрх зүйн хувьд: а/ чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнг төгрөгөөр олсон орлого; б/ хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх; в/ оюуны өмчийн эрх гэсэн гурван үндсэн төрөлтэй байхаас гадна гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийж болохыг хуулиар тодорхойлсон бөгөөд татварын нөхцөл, хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгаа, хөрөнгө оруулагчид олгох нөхцөл зэргийг зохицуулсан юм.

Энэхүү хуулиар болон бусад холбогдох салбарын хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулагчид таатай нөхцөлийг олгосон бөгөөд тухайлбал;

- Юуны өмнө гадаадын хөрөнгө оруулалтыг хууль бусаар хураан авахыг хориглосон байна. Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс, зөвхөн хуульд заасан журмын дагуу, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцлөөр дайчлан гаргуулж болно. /ГХО тухай хуулийн 8.1-8.5 зүйл/
- Эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, түүний дотор аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөнд хувь хөрөнгө болгон оруулсан эд хөрөнгөө гадаадад буцаан гаргах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох, бусад этгээдэд эрх, үүргээ шилжүүлэх нь Монгол Улсын хуулиар гадаадын хөрөнгө оруулагчдад олгосон өргөн эрх юм. /ГХО тухай хуулийн 10.1 зүйл/
- Монгол Улсын зах зээлд хөрөнгө оруулагчийг татах эрх зүйн нэг чухал хэлбэр нь “Тогтвортой байдлын гэрээ” юм. Монгол Улсад 20 сая ам.доллараас доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг 10 жил, 50 сая ам.доллараас дээш бол 15 жилээр гэрээ байгуулна. /ГХО тухай хуулийн 19 дүгээр зүйл/
- Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын нэг чухал асуудал бол газрын харилцаа юм. Гадаадын хөрөнгө оруулагчид газрыг төлбөртэйгээр, гэрээний үндсэн дээр ашиглуулах бөгөөд газар ашиглах гэрээний үндсэн хугацаа эхний ээлжинд 60 жил, дараагийн удаа 40 жилээр сунгаж болно. /ГХО тухай хуулийн 21.5 зүйл/

Хэдийгээр манай улсын холбогдох хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж болох бөгөөд цаашид тэдгээрийг цаг үеийн шаардлага, өнөөгийн эрчимтэй хөгжиж байгаа нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн сайжруулах, мэдээлэл, технологи, татвар, үйлдвэрлэлийн чиглэлээр эрх зүйн орчинг шинэчлэн зохицуулах шаардлагатай юм. Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгохдоо зах зээлд чиглэсэн (market-seeking), ашигт

малтмалд чиглэсэн (resource - seeking), үйлдвэрлэлийн бүтээмжид чиглэсэн (efficiency -seeking), стратегийн нөөц баялаг болон чадварт чиглэсэн (strategic asset or capability-seeking) хөрөнгө оруулалтын алинд нь түлхүү анхаарал тавих, алийг нь илүү дэмжих, ямар хөнгөлөлт үзүүлэх бодлогыг сайтар тодорхойлох хэрэгтэй юм.

Учир нь гадаадын хөрөнгө оруулалтын шийдвэрлэгч хүчин зүйлст эдийн засгийн хүчин зүйлсээс гадна манай орны гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын тогтолцоо (policy framework) болон бизнесийн тав тухтай орчин (business facilitation), эрх зүйн таатай орчин (favorable legal environment) хамаарах бөгөөд үүнд төрийн тодорхой үйл ажиллагаа бодлого үгүйлэгдэж байна.

❖ Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Гадаадын хөрөнгө оруулалт тухай улс орны хувьд эдийн засаг, нийгэмд эерэг үр дагварыг гаргадаг хэдий ч эдийн засгийг гадаадаас хамааралтай болгох, байгаль орчныг сүйтгэх, импортыг хэт нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавар бий болгодог. 1990 оноос өнөөг хүртэл Монгол Улсад 110 улс орон, тусгай статустай бүс нутгуудаас 11642 гадаадын хамтарсан болон 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бүртгэгдэж, нийт 9 826,3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 73,7% буюу 7241,9 тэрбум. ам.долларыг геологи, уул уурхайн салбарт, 15,6% буюу 1 534,3 тэрбум ам.долларыг худалдаа нийтийн хоолны салбарт, 1,58% буюу 155,5 сая ам.доллар нь банк санхүүгийн салбарт, 1,10% буюу 108,0 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хөнгөн үйлдвэрийн салбарт, 8,02% -ийг нь бусад салбаруудад оруулсан байна.

Манай улсын хувьд 1990 оноос хойших гадаадын хөрөнгө оруулалтаас зөвхөн уул уурхайн салбарт дахь хөрөнгө оруулалтыг авч үзвэл:

- 1990 - 2004 оны хооронд гадаадын хөрөнгө оруулалт 1 120 894,1 мян ам доллар байсан бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын 493972,74 мян ам доллар нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбарт ноогдож байна.
- Энэхүү гадаадын хөрөнгө оруулалт жил тутам нэмэгдэж байгаа бөгөөд 2011 онд хамгийн их буюу 4 986 034,12 мян ам доллар хүрсэн бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 4 083 218,51 мян ам доллар нь мөн ашигт малтмалын салбарт оруулсан байна.
- Манай улсын хувьд 1990 оноос хойш 2011 он хүртэл нийт 9 826 352,76 мян ам долларын гадаадаас хөрөнгө оруулалт хийгдсэн бол үүний 7 241 934,93 мян ам.доллар нь ашигт малтмалын салбарт оруулсан хөрөнгө оруулалт байлаа.



Зураг 2.1 Нийт хөрөнгө оруулалт болон ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулалт 1990 - 2011, /Сая ам доллар/

UIHAMN СУДАЛГААНЫ САН

Монгол Улсад 110 орчим орны хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд эдгээрээс Монгол Улс 40 орчим улстай хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай хоёр талын хэлэлцээр байгуулжээ.



Зураг 2.2.
Монгол д бүртгэгдсэн Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл 1990 - 2011

Монгол Улсад хөрөнгө оруулсан байдлыг улсаар нь авч үзэхэд дийлэнх буюу 35% -ийг БНХАУ -аас, 21,5% -ийг Нидерланд улсаас 9% -ийг Виржуини арлуудаас тус тус хөрөнгө оруулсан байна. Монгол Улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгсэн улсуудын талаар Хүснэгт 1-4-т дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно.

❖ Дотоодын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал:

Төрийн зүгээс ямар нэг салбарыг дэмжих үүднээс дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлогыг барьж байгаа тохиолдолд тухайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласнаар үндэснийхээ бизнесийн салбарыг хөгжүүлэх бодлого барих шаардлагатай юм. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагч компаниудыг дотоодын зах зээл дээр монополь тогтоохоос хязгаарлаж улмаар дотоодын компанийг өсөж хөгжих нөхцөл бололцоогоор хангаж байгаа явдал юм.

Тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах бодлого нь түр зуурын шинжтэй байх ба үүнийг дэлхийн олон улс орнууд өргөнөөр хэрэглэж байна. Хэдийгээр иймэрхүү хязгаарлалт тогтоох практик нь Олон улсын худалдааны байгууллагын тогтоосон де-факто буюу олон улсын худалдаа хийхэд ямар нэгэн саад тотгор үзүүлж буй ялгаварласан асуудал болох боловч ОУХБ нь эдийн засгийн тодорхой салбарт хязгаарлалт, хориг тавихыг зөвшөөрдөг. Ингэхдээ тухайн улс орон тодорхой хугацааны дараа энэхүү хориг, саадыг өөрчлөх үүрэг хүлээх ёстой гэсэн нөхцөл тавьдаг.

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тэргүүлэх чиглэлийнхээ нэг болгох зорилтоо дэвшүүлсэн. Тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007 - 2015 онд, 2016 - 2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шаттайгаар авч үзжээ. Тус бодлогын 5.1.2 -т “Татварын бодлого” гэсэн хэсэгт ”Татварын бодлогоор экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.” гээд уг хэсгийн стратеги зорилт 1-д “дотоодын болон олон улсад нэр хүнд бүхий гадаадын хөрөнгө оруулагчдыг” дэмжих гэж заажээ.

Сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжин хөгжиж үйл ажиллагааных нь цар хүрээ тэлж байгаа нөхцөлд дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт бодитойгоор нэмэгдэж байна. Гэвч адил нөхцөлд, адил бизнес, үйлдвэрлэл явуулж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгаатай хууль дүрэм үйлчилж гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй хөнгөлөлт, чөлөөлөлт, дотоодын оруулагчдад үл үйлчилж буйгаас шударгаар өрсөлдөх нөхцөлгүй болж байна.

Монгол Улсын үндсэн хөрөнгийн болон үнэт зүйлсийн хуримтлал материаллаг нөөцийн хуримтлалын томоохон бүрэлдэхүүн хэсэг болох хөрөнгө оруулалтын 70 хувийг гадаад, 30 хувийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Дотоодын эх үүсвэрийн 14.5 хувийг банкны зээл болон өөрийн хөрөнгө, 15.5 хувийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлжээ.[7] Хөрөнгө оруулалтын 65,1 хувийг тоног төхөөрөмж, 11,4 хувийг барилга угсралт, 23,5 хувийг бусад зүйлд зарцуулж байна.

Хүснэгт 2.1. **Улсын төсвийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын дүн, /1991-2011 оны гүйцэтгэлээр/**

Он	Улсын төсвийн хөрөнгийн зардлын хөрөнгө оруулалт	Хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хувь
2011		
2010	579 791,9	8,1
2009	423 244,9	7,6
2008	482 660,3	7,9
2007	239 315,5	4,4
2006	145 776,0	3,9
2005	66 946,1	3,0
2004	69 021,7	3,6
2003	56 890,0	3,9
2002	39 875,9	3,2
2001	39 558,4	3,5
2000	33 693,3	3,3
1999	23 187,5	2,5
1998	33 967,8	4,2
1997	29 411,5	3,5
1996	26 312,1	4,1
1995	26 659,4	4,8
1994	10 427,8	3,7
1993	8 269,9	5,0
1992	1 377,3	2,9
1991	1 293,6	6,8

UIH.MN

Дотоодын хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгаа бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зардлын хэмжээ 2010 онд 664,3 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 38 хувиар өсчээ. Харин 2011 онд хөрөнгийн зардлын хэмжээ өмнөх онтой нь харьцуулахад бага зэрэг буурсан буюу 627,7 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зардлыг тухайн оны гүйцэтгэлээр нь авч үзвэл 1991 онд ДНБ-ний 6,8 хувь, 2000-2007 оны хооронд ДНБ-ний 3,3 - 4,4 орчим хувийг эзлэж байсан бол сүүлийн жилүүдэд энэхүү үзүүлэлт нэмэгдэж дунджаар 7,9-8,1 орчим хувьтай болсон байна. Энэ үзүүлэлтээс харахад манай улсын

[7] Статистикийн эмхтгэл 2011 он УСХ

хувьд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх дотоодын хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа бөгөөд дотоодын үйлдвэрлэгч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт ч мөн нэмэгдэх хандлагатай байна.

❖ Хөрөнгө оруулалтын татварын эрх зүйн орчны талаар:

Төр засгийн зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсыг хөгжүүлэх нэг чухал хөшүүрэг гэж үзэн, гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад ихээхэн ач холбогдол өгсөөр ирсэн. Гадаадын хөрөнгө оруулагч нарыг татварын бодлогоор татахын тулд илүү хөнгөлөлттэй нөхцөл эдлүүлдэг байсан бөгөөд хөрөнгө оруулалтын баталгаат орчин, татварын тогтвортой байдлаар татахыг тулд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлд Тогтортой байдлын гэрээ байгуулахаар хуульчилсан.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулагч нарт Монголын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй нөхцөл өгдөг бөгөөд манай улсад аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хувь хэмжээ 10 ба 25%, нэмүү өртгийн албан татварын хувь хэмжээ 10% байгаа нь бүс нутагтаа хамгийн бага хувь хэмжээнд тооцогдоно.

Түүнчлэн манай улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар 2008 онд шинэчлэн баталсан бөгөөд тэргүүлэх салбарт оруулсан хөрөнгө оруулалтад Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу оруулсан хөрөнгийн 10 хувьтай тэнцэх албан татварын хөнгөлөлт эдлүүлдэг. Мөн үр тариа, хүнсний ногоо, сүү, жимс жимсгэнэ, тэжээлийн ургамлын бүтээгдэхүүн тариалсан аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар хөнгөлдөг.

/Хөрөнгө оруулалтын хүрээнд Монгол Улсын Татварын ерөнхий хууль болон татварын бусад холбогдох хууль тогтоомжоор авч буй татварын хувь хэмжээний дэлгэрэнгүйг хавсралт 5 -аас үзнэ үү

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Монгол Улсын хуулиуд. Эх сурвалж: www.legalinfo.mn
- Decree Law №600, of 1974, Foreign Investment Statute /Чили улсын Гадаадын хөрөнгө оруулалтын хууль/
- Чили улсын Төв банкны валютын журмын 14-р бүлэг
- Lei №4131/62 /Бразиль улсын Гадаадын хөрөнгө оруулалтын хууль/
- Закон Республики Казахстан “Об инвестициях” от 8 января 2003 года.
- Федеральный закон от 25 февраля 1999 N 39-ФЗ “Об инвестиционной деятельности в Российской Федерации, осуществляемой в форме капитальных вложений”
- Федеральный закон от 29 апреля 2008 года N 57-ФЗ “О порядке осуществления иностранных инвестиций в хозяйственные общества, имеющие стратегическое значение для обеспечения обороны страны и безопасности государства”
- Федеральный закон от 9 июля 1999 года N 160-ФЗ “Об иностранных инвестициях в Российской Федерации”
- “Бизнесийн эрх зүй- хуульчдад зориулсан гарын авлага”. УБ., 2003 он
- “Дотоод хөрөнгө оруулалтын чуулган - санал асуулгын дүн”. УБ., 2005 он
- “Орчуулгын түүвэр” . Бээжин хот., 2009 он
- “Өрнөн хөгжиж буй Өвөр Монгол” Хөх хот., 2009 он
- “Үндэсний аюулгүй байдлыг хангахад Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн төслийн шинжилгээ, гадаад орнуудын туршлага”. Харьцуулсан бодлогын судалгаа (СТ-11/203). УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. 2011 он.
- З. Бороо. “Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгч хүчин зүйлс”. УБ., 2005 он
- Рек. Д. Баянбилэг. “Гадаадын хөрөнгө оруулалт, чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт”. УБ., 2009 он
- Рек. Ж.Амарсанаа. “Гадаадын хөрөнгө оруулалт” . УБ., 2009 он
- Ц.Түвшинзаяа. “БНХАУ-ын хуулийн эмхтгэл” .УБ., 2008 он\
- www.baidu.cn
- www.sina.cn
- www.foreigninvestment.cl
- www.bcentral.cl
- http://www.bcb.gov.br
- www.mongolianminingjournal.com
- www.unctadstat.unctad.org
- Бразильд хөрөнгө оруулагчдад зориулсан хуулийн хөтөч
- Казахстан в 2010 году (статистический ежегодник). Эх сурвалж: http://www.stat.kz/
- Агентство Республики Казахстан по статистике. Эх сурвалж: http://www.stat.kz/
- Федеральная служба государственной статистики. Эх сурвалж: http://www.gks.ru/

(Footnotes)

[1] ФЗ от 9 июля 1999 года N 160-ФЗ “Об иностранных инвестициях в Российской Федерации”

[2] ФЗ от 29 апреля 2008 года N 57-ФЗ “О порядке осуществления иностранных инвестиций в хозяйственные общества, имеющие стратегическое значение для обеспечения обороны страны и безопасности государства”

[3] “Үндэсний аюулгүй байдлыг хангахад Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн төслийн шинжилгээ, гадаад орнуудын туршлага”. Харьцуулсан бодлогын судалгаа (СТ-11/203). УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. 2011 он.

[4] ФЗ от 25 февраля 1999 N 39-ФЗ “Об инвестиционной деятельности в Российской Федерации, осуществляемой в форме капитальных вложений”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ҮНЭ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа
Д. Байгалмаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг

ОРШИЛ

УИХ -ын гишүүн Д. Ганхуягийн 12/3328 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Судалгааны төвийн эдийн засгийн судалгааны баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Захиалагчийн хүсэлтийн дагуу гадаадын нефть импортлогч улс орнууд дахь шатахууны үнэ бүрдэлт буюу жижиглэнгийн үнийн бүтцийн бүрдүүлбэрийг тодруулахыг зорьсон болно.

Хамрах хүрээ:

Судалгаанд нийт 97 оронд борлуулагдаж буй 4 төрлийн шатахууны /АИ - 92, АИ - 95, АИ - 98 болон ДТ/ жижиглэнгийн үнийг 2012 оны эцсийн байдлаар харьцуулан гаргасан бөгөөд үүнээс 36 улсад шатахууны жижиглэнгийн үнэ 2 ам.долларааc дээш /2-оос 2.5 долларын хооронд/ байх ба үлдсэн 61 орон нь 2 ам.долларааc доош өртөгтэй байгаа нь харагдаж байна.

Литр тутам нь 2-оос 2.5 ам доллар хүртэлх улс нь ихэвчлэн Европын өндөр хөгжилтэй буюу хөгжингүй орнууд байгаа бол 2 ба түүнээс доош үнэ бүхий улс орнуудад томоохон нефть импортлогч болон нефть үйлдвэрлэгч, хөгжилтэй улс орнууд багтсан байна. Тухайлбал, дэлхийн хамгийн том нефть импортлогч болох АНУ -д 30 рубль буюу 1 ам.долларааp борлуулагдаж байгаа бол нефть үйлдвэрлэгч улс болох ОХУ-д литр тутмыг 0.9 ам доллар буюу 27 рублиэр борлуулж байна. Харин Венесуэл, Саудын араб зэрэг улс оронд 4 рублээр худалдан борлуулж байна.

Жижиглэнгийн үнэ нь 2 ам.доллар ба түүнээс дээш борлуулж буй улс оронд Австри, Австрали, ХБНГУ, Голланд, Бельги, Итали, Норвеги, Люксенбург гэх мэт Европын өндөр хөгжилтэй орнууд багтаж байна. Судалгаанд хамруулсан 97 орноос АНУ, Англи, Япон, Канад, Норвеги, Франц, Итали зэрэг улсуудын жижиглэнгийн үнийн бүтцэд задлан шинжилгээ хийн, жижиглэнгийн үнийн бүрдүүлэлт, түүний бүтцийн ерөнхий зураглалыг гаргасан болно.

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Жижиглэнгийн үнийн задаргаа, үнэ бүрдүүлэлтийг нарийвчлан судлахаар сонгон авсан 7 орны хувьд ихэвчлэн нефть импортлогч улсууд байх ба шатахуун борлуулалтын жижиглэнгийн үнэ нь 2 ам.долларааc дээш /ХБНГУ, Итали, Франц, Япон / буюу доош байгаа улс орнуудаас /АНУ, Англи, Канад/ түүвэрлэн судалгаанд хамруулсан болно.

Ийнхүү судлахад Англи, ХБНГУ, Итали, Франц улсын хувьд жижиглэнгийн үнийн 50-иас дээш хувийг татварууд эзлэж байгаа бол АНУ-д 13 хувь, Канадад 29 хувь, Японд 37 хувийг тус тус эзэлж байна. Харин дээрх долоон орны хувьд жижиглэнгийн үнэ дэхь түүхий нефтийн үнэ 6 орны хувьд яг адилхан байсан бол АНУ-ын хувьд бусад орноос хямд хэдий ч үнийн бүрдүүлэлтийн ихэнхи хувийг түүхий нефтийн үнэ эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл, дээрх улсуудын жижиглэнгийн үнийн ойролцоогоор 34-36 орчим хувийг түүхий нефтийн үнэ эзэлж байгаа бол жижиглэнгийн үнэ бүрдүүлэлтэд түүхий нефтийн үнэ хамгийн

өндөр хувьтай буюу үнийн 42 хувийг эзэлж байгаа улс нь АНУ юм. Харин үйлдвэрлэлийн зардал /тээвэр, даатгал болон бусад зардал/ нь жижиглэнгийн үнийн үлдсэн хэсгийг буюу ойролцоогоор 14 орчим хувийг эзэлж байна. Эдгээр 7 орноос үйлдвэрлэлийн зардал хамгийн өндөр буюу 29 хувийг эзэлж байгаа улс нь Япон улс бол АНУ -ын жижиглэнгийн үнийн 28 хувийг үйлдвэрлэлийн зардал буюу тээвэрлэлт, маркетингийн үнэ даатгал болон бусад зардал эзэлж байна.

Судалгааны үр дүнгээс харахад жижиглэнгийн үнийн дүнд хамгийн ихээр нөлөөлж байгаа нь татвар гэдэг нь эндээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл, түүхий нефтийн хувьд бараг бүх оронд ижил дүнтэй байгаа бол жижиглэнгийн үнийг бүрдүүлж байгаа татварын хэмжээ л жижиглэнгийн үнэд хамгийн их нөлөөлж байгаа орц гэдэг нь харагдаж байна. Эдгээр орны хувьд яригдаж байгаа үйлдвэрлэлийн зардал гэдгийг тээвэрлэлт, даатгал болон бусад зардал бүрдүүлж байгаа гэдгийн анхаарах нь зүйтэй юм. Судалгааны дэлгэрэнгүйг тайлангаас үзнэ үү.

1. Шатахууны өртөг тооцох ерөнхий бүтэц, зарим улсын шатахууны жижиглэнгийн үнийг тооцсон задаргаа

а) Жижиглэнгийн үнийн харьцуулалт

Юуны өмнө захиалагчийн хүсэлтийн дагуу дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжингүй улс орнуудын шатахууны жижиглэнгийн үнийг шатахууны 4 төрлөөр хүснэгтлэн харьцуулан үзүүлэв. Ингэхдээ нефть, импортлогч болон үйлдвэрлэгч, хэрэглэгч 97 орныг хамруулсан бөгөөд үнийг 2012 оны эцсийн байдлаар гаргасан болно. Түүнчлэн эдгээр орноос 2 ам.долларааc дээш болон доош үнэ бүхий зарим орныг сонгон жижиглэнгийн үнийн задаргаанд анализ хийн үнийн бүтцийн ерөнхий зураглалыг гаргахыг зорив.

Зарим орны шатахууны жижиглэнгийн үнэ, Хүснэгт -1

/2012 оны IV сарын байдлаар, ОХУ -ын рублиэр/

	Улс	Шатахууны төрөл			
		АИ - 92	АИ - 95	АИ - 98	ДТ
1.	Авсртали	57.97	57.97	76.77	42.70
2.	Австри	56.41	57.58	65.02	55.23
3.	Азербайджан	12.53	13.32	14.10	12.14
4.	Алжир	8.23	-	8.62	5.48
5.	Англи	18.80	-	-	-
6.	АНУ	30.40	31.50	32.52	32.26
7.	Аргентин	27.42	41.13	-	30.16
8.	Армен	27.81	-	-	30.55
9.	Араб	-	37.21	-	36.43
10.	Афганистан	17.63	59.93	70.51	12.53
11.	Беларусь	21.80	23.44	-	23.98
12.	Бельги	68.16	63.85	65.02	60.71

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

13.	Болгар	52.49	53.66	48.57	53.27
14.	Боливи	14.49	16.84	-	14.49
15.	Босни-Герцеговин	-	48.96	48.18	50.92
16.	Ботсван	23.50	-	-	25.85
17.	Бразил	44.65	51.31	-	31.34
18.	Бруней	9.79	10.58	-	5.88
19.	Венесуэл	4.70	6.27	-	-
20.	Вьетнам	25.85	59.93	-	-
21.	Габон	-	53.27	-	32.51
22.	Гайана	26.24	-	-	27.03
23.	Гамби	28.59	59.93	-	31.34
24.	Герман	61.50	65.42	58.76	60.32
25.	Голланд	72.47	72.07	75.21	59.15
26.	Грек	68.55	71.29	72.47	62.28
27.	Дани	56.41	72.07	-	64.24
28.	Доминиканы БНУ	62.67	66.59	70.12	59.54
29.	Египет	7.83	9.01	-	5.09
30.	Замби	66.98	-	-	41.91
31.	Израль	54.84	57.19	-	-
32.	Индонез	-	13.32	19.59	12.53
33.	Ирак	10.18	10.58	-	-
34.	Иран	25.46	17.63	-	-
35.	Ирланд	61.11	64.63	58.54	61.50
36.	Исланд	61.11	65.02	-	61.89
37,	Испани	58.76	58.76	58.76	54.06
38,	Итали	67.77	72.86	72.86	67.77
39.	Казахстан	21.02	27.57	31.39	17.85
40.	Канад	39.13	40.90	42.96	39.72
41.	Катар	-	6.27	-	7.83
42.	Кени	36.04	-	-	28.20
43.	Кипр	-	54.06	49.36	54.06
44.	Колумб	30.55	-	-	21.54

45.	Коста-Рика	28.59	27.42	-	26.24
46.	Латви	44.65	56.01	46.22	54.06
47.	Лесото	28.59	-	-	31.34
48.	Литва	51.71	56.01	49.75	52.88
49.	Люксембург	56.41	56.01	57.19	50.53
50.	Малайз	-	17.63	-	-
51.	Мальта	52.49	56.80	53.66	53.27
52.	Марокко	36.82	-	-	21.15
53.	Мексик	21.94	23.11	-	-
54.	Мозамбик	35.25	-	-	32.90
55.	Монако	-	50.92	59.45	43.48
56.	Монгол	41.52	24.29	-	38.39
57.	Намби	36.04	37.60	-	39.56
58.	Норвеги	67.77	77.56	74.42	59.54
59.	ОХУ	27.37	29.17	31.96	28.02
60.	Пакистан	-	-	34.47	33.30
61.	Парагвай	39.95	41.13	-	30.55
62.	Перу	33.69	-	-	25.85
63.	Польш	57.19	58.36	57.58	53.27
64.	Португал	61.89	68.16	68.55	59.54
65.	Румын	49.36	50.92	52.10	52.49
66.	Саудын Араб	4.31	4.31	-	2.35
67.	Сенегал	41.91	43.87	-	39.95
68.	Серби	43.09	51.71	56.01	52.88
69.	Сингапур	38.39	39.56	-	-
70.	Сири	23.50	-	-	12.53
71.	Словак	48.96	60.71	54.84	57.19
72.	Словени	49.36	58.36	52.10	53.27
73.	Тайвань	-	23.50	-	-
74.	Тайланд	43.09	35.25	37.21	20.76
75.	Танзани	30.16	-	-	45.44
76.	Тунис	-	26.64	28.59	19.59
77.	Турк	75.60	67.77	76.38	65.42

UB.MN
ӨДЛӨГААНЫ САН

78.	Украйн	38.67	40.86	-	36.84
79.	Уругвай	48.18	48.18	47.00	52.49
80.	Фижи	36.43	61.11	-	-
81.	Филиппин	-	38.39	-	16.45
82.	Финлянд	66.20	66.20	68.55	61.11
83.	Франц	59.93	67.37	65.81	60.32
84.	Хорват	52.88	57.19	51.31	54.06
85.	Хонг-Конг	-	62.28	63.85	45.44
86.	Хятад	16.06	33.30	-	21.15
87.	Чех	55.23	58.36	60.71	58.76
88.	Чили	35.25	42.30	-	38.00
90.	Шинэ Зеланд	47.79	48.57	-	33.30
91.	Швейцари	61.50	60.71	63.85	63.85
92.	Швед	64.63	69.33	67.77	66.98
93.	Шри Ланки	30.94	39.95	-	-
94.	Эквадор	11.36	-	-	29.38
95.	Эстон	53.66	54.45	-	55.23
96.	Этиоп	25.46	-	-	30.16
97.	Энэтхэг	34.08	-	-	27.03
98.	Япон	57.58	59.54	62.67	58.36

Эх сурвалж: http://au95.org/price/

Дээрх хүснэгт дэх 97 улсын шатахууны үнийг руб-ээр тооцсон дүнг авсан бөгөөд эдгээрээс 1 л шатахууны үнэ 2 ам доллар -аас илүү орнуудыг өнгөөр тодруулсан болно. Хүснэгтээс харахад жижиглэнгийн үнийн судалгаанд хамрагдсан нийт 97 орны 36 нь 2 ам доллараас дээш үнэтэй үлдсэн 61 орон нь 2 ам доллараас доош үнэтэй байна.

b) Жижиглэнгийн үнийн бүрдүүлэлт

Шатахууны жижиглэнгийн үнийн өртөг зардлыг тооцоход тус үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үндсэн мэдээллүүдээс гадна нарийвчилсан тоон мэдээллүүд шаардлагтай ба энэхүү мэдээлэл нь хязгаарлагдмал зэрэг нөхцөл байдлаас хамааруулан нийтэд мэдээлэгдэж байдаг статистик мэдээллүүдэд үндэслэн жижиглэнгийн үнийг ерөнхий бүтцээр нь харьцуулан судаллаа.

Шатахууны үнэ бүрдэлтийг тоймлон харахад:

- Түүхий эдийн үнэ
- Боловсруулалтын үе шатны үнэ
- Борлуулалтын үнэ гэсэн ерөнхий бүтэцтэй байх ба борлуулалтын үнэ нь нийлүүлэлт, худалдан авалтын хэлбэр, шат дамжлагаас хамааруулан бөөний болон жижиглэнгийн үнэ тогтдог.

АНУ -ын Эрчим хүчний мэдээллийн удирлагын газраас шатахууны 1 галлон тутмын

жижиглэнгийн үнийн бүтцийг доорх үзүүлэлтүүдээр олон нийтэд мэдээлдэг. /2012 оны 11 сарын байдлаар/

Шатахууны орц	Бензин	Дизель
Жижиглэнгийн үнэ $/галлон	3.45$	4.00$
- Түүхий нефть	67%	58%
- Боловсруулалт	9%	13%
- Нийлүүлэлт, маркетинг	12%	17%
- Татварууд	12%	12%

Бензин болон дизелийн түлшний жижиглэнгийн үнэд орцууд нь 1 галлоны үнэд эзлэх хувиар илэрхийлэгдсэн ба доорх аргачлалаар тодорхойлдог.

Түүхий нефть /crude oil/ - нефть боловсруулагчдын худалдан авалтын зардлын сарын дундаж буюу үйлдвэрлэгчдийн түүхий нефтийг боловсруулахаар худалдан авсан дундаж үнэ

Боловсруулалтын зардал болон ашиг /refining costs & profit/ - бензин, дизель түлшний спот үнийн сарын дундаж болон үйлдвэрлэгчдийн түүхий нефтийг боловсруулахаар худалдан авсан дундаж үнийн хоорондын зөрүү

Нийлүүлэлтийн болон маркетингийн зардал болон ашиг – EIA -аас 7 хоногоор тоймлон тооцсон жижиглэнгийн үнийн дундаж болон дээрх орцын зөрүү

Татварууд – Холбооны дотоодын сарын дундаж болон шатахуун, түлшинд ноогдуулсан улсын татварууд

Дээрх орцуудаас 2, 3 дугаар орцууд нь өмнөх орцын үнээс хамаарч цаг хугацааны хоцрогдолтойгоор хувьсан өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл, спот үнийн өөрчлөлт жижиглэнгийн үнэд нөлөөлнө. Түүвэрлэн судалсан улс орнуудаас харахад 2 ам.долларооос дээш буюу үнэ өндөр тогтсон ихэвчлэн Европын холбооны гишүүн орнуудын шатахууны жижиглэнгийн үнийн бүтцэд нөлөөлж буй голлох хүчин зүйл нь татварын хувь хэмжээ юм.

Хүснэгт 2

Улс орнууд	мэдээллийн хугацаа	Жижигл-энгийн үнэ $/litre	Түүхий нефть $/ litre-т эзлэх хувь	Боловср-уулалт $/litre-т эзлэх хувь	Нийлүүлэлт, маркетинг $/ litre-т эзлэх хувь	Татварууд $/litre-т эзлэх хувь					Нийт $/litre-т эзлэх хувь
						CO2	OAT	Гаалийн	НӨАТ	татварын дүн	
АНУ	2012.11	0.91	67.0	9.0	12.0		12.0			12.0	100
Англи	2011.10	2.11	33.7	1.1	5.3			43.2	16.7	59.9	100
Норвеги	2010.05	2.8	28.0	14.0		6.0	32.0		20.0	58.0	100

Дээрх хүснэгтээр харагдаж буй мэдээллүүдийг хялбар харагдах байдлаар Зураг 1 - ээр үзүүлэв. Зураг 1 -т АНУ, Англи болон Норвеги улсын шатахууны жижиглэнгийн үнийн бүтцийг харьцуулан харуулсан бөгөөд Англи улсад жижиглэнгийн үнэ 18,80 рубль буюу 0,6 ам.доллар байх бөгөөд энэ үнийн 59,9 хувь нь татвар, 33,7 хувь нь түүхий нефтийн үнэ байгаа бол боловсруулалт болон нийлүүлэлт, маркетингийн зардал нь үлдсэн 6,4 хувийг эзлэж байгаа нь харагдаж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ

Англи улсын жижиглэнгийн үнийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй татварын задаргааг үзвэл гаалийн татвар 43,2 хувь, НӨАТ 16,7 хувийг тус тус эзэлж байна. АНУ-ын хувьд 1 литр шатахууны жижиглэнгийн үнэ 0,9 ам.доллар бөгөөд үүний 12 хувийг татвар, мөн 12 хувийг нийлүүлэлт, маркетингийн зардал болон жижиглэнгийн үнийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж байгаа орц нь түүхий нефтийн үнэ байх ба энэ нь 67 хувийг эзэлж байна

Норвеги улсын хувьд 1 литр шатахууны жижиглэнгийн үнэ 2,67 ам.доллар байх ба үүнээс 1,62 ам.доллар буюу нийт үнийн 58 хувийг татвар эзэлж байна. Тус 58 хувийн татварын нарийвчилсан задаргааг дээрх хүснэгтэд харуулсан бөгөөд үүнээс агаарын бохирдлын татвар 6 хувь, онцгой албан татвар 32 хувь, НӨАТ 20 хувийг тус тус эзэлж байна. Норвеги улс нь дэлхийд 7 дахь том газрын тосны экспортлогч, 14 дэх томоохон газрын тос үйлдвэрлэгч орон боловч шатахууны үнэ өндөр байдаг улс юм. Өөрөөр хэлбэл, 1 литр шатахууны үнэ 2,67 ам.доллар болж байна.

Тус улсын иргэдийн өдрийн дундаж орлого 272 ам.доллар ба үүний ердөө 3,7 хувийг шатахуунд зарцуулдаг байна. Тус улсын хувьд шатахууны үнэ өндөр байгаагийн гол шалтгаан нь холбогдох татвар хураамжийн хувь хэмжээтэй холбоотой ч өрхийн орлоготой харьцуулахад иргэдийн нуруунд дарамт болохооргүй байгаа юм. Зураг 1 -ийг үзнэ үү.



Зураг-1

Европын өндөр хөгжилтэй импортлогч орнуудад жижиглэнгийн шатахууны үнэ 2 ам.доллар байгаа нь хүснэгтээс харагдсан. Үүний 50-60 хувь татвар эзэлж байгаа юм. Тухайн орнуудын хувьд татварын энэхүү өндөр бүтцээр шатахууны үнийн огцом өсөлтөөс хамгаалдаг гэж тайлбарласан байдаг. Өөр нэг чухал шалтгаан нь сүүлийн дөрвөн сарыг нэгтгэж авч үзэхэд дэлхийн зах зээл дээр түүхий нефтийн үнэ тогтвортой буюу хэлбэлзэл маш бага байхад, түүнчлэн ОХУ-ын нефтийн бүтээгдэхүүний экспортын татвар ч хэлбэлзэлгүй шахам, бага зэрэг буурсан байхад, хилийн үнэ А80 болон А92 дээр дунджаар 85 ам.доллар, дизел 260 ам.долларааp тус тус нэмэгдсэн.

Одоо нэг баррель түүхий нефтийн үнэ дэлхийн зах зээл дээр 100 орчим доллар байхад Оросууд литр нефть тутмаас 0.40 доллар буюу 560 орчим төгрөгийг экспортын татвар хэлбэрээр авч байна. Ингэж тооцоход импортоор орж ирж буй нэг литр нефтийн хилийн

үнэ 1440 орчим төгрөг болох ба үүний 560 төгрөгийг татвар үлдсэн 880 төгрөгийг түүний нефть болон боловсруулалт, тээвэр, хадгалалт болон холбогдох бусад зардлыг нэмбэл өнөөгийн үнийн ойролцоо дүн гарч байна.

Энд анхаарал татсан гол асуудал нь шатахууны хилийн үнийн 60 гаруй хувийг эзэлж байгаа ОХУ-ын экспортын татвар юм. Энэ асуудлыг зөвхөн Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үр дүнд ОХУ-ын хууль тогтоомжинд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж судлаачид үздэг байна. Харин бусад орны хувьд шатахууны жижиглэнгийн үнийн хэдэн хувийг татвар эзэлж хэдэн хувийг нефтийн өөрийн үнэ болон бусад зардал эзэлж байгаа Зураг 2 -оор харуулъя.

Зураг 2 -т 2011 оны байдлаар Дэлхийн Их долоон улсуудын хувьд 1 литр газрын тос ямар үнэтэй байгааг харуулж байгаа бөгөөд, эдгээр жижиглэнгийн үнийн харилцан адилгүй байгаа нь түүхий газрын тосны үнийн өртөг өөр байгаагаас шалтгаалаагүй ба харин эдгээр газрын тосны хэрэглэгч орнуудын газрын тосны татварын түвшин өөр байгаатай холбоотой байгааг зургаас харж болно.

Эдгээр татварын хэмжээ АНУ болон Канад улсад харьцангуй бага байх боловч, Европ болон Ази Номхон далайн орнуудад маш өндөр түвшинд байна. Жишээлбэл, Англи улсын засгийн газар 2011 онд хэрэглэгчдэд худалдсан нэг литр шатахуун бүрийн үнийн 59 орчим хувийг /1,30 ам.доллар орчим/ татвар болгон авсан бол АНУ-ын улсын хувьд 1 литр шатахуун бүрийн үнийн ердөө 14 хувийг татвараас бүрдүүлсэн байгаа нь харагдаж байна. Тиймээс ч дэлхийн хамгийн том импортлогч болох АНУ улсын хувьд шатахууны жижиглэнгийн үнэ нэг ам.долларт ч хүрэхгүй байна. Харин газрын тос үйлдвэрлэгч орнууд (OPEC /Газрын тос экспортлогч орнуудын байгууллага/ оролцуулан) зөвхөн нийт шатахууны үнийн 32 орчим хувь болох 0,71 ам.долларын орлого олсон байна.



Зураг 2 (Ам.доллар/литр) Эх сурвалж: OPEC database

Тайлбар: Зураг дээрх үнийг 2011 оны байдлаар литр бүрийн үнийг ам.долларaар тооцсон үнэ болно. Үйлдвэрт тээвэр, даатгал болон бусад зардал орно. Түүхий газрын тосны FOB үнэд бүтээгдэхүүний зардал болон бусад холбогдох зардал багтана. Зураг 3 -т түүхий газрын тосны худалдаанаас улс орнуудын олох орлого болон газрын тосны татвараас олох орлогын зөрүү хэмжээг үзүүлсэн байна. 2007-2011 оны хооронд OECD -ын /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/ гишүүн орнууд газрын тосны татвараас нийт 5,547 тэрбум ам.долларын орлого олсон. Харин OPEC-ын гишүүн орнууд энэхүү

UHMN
СУДАЛГААНЫ САН

ижил хугацаанд 4,162 тэрбум ам.долларын орлого олсон нь OECD-ын гишүүн орнуудын засгийн газрын олж буй орлогоос ойролцоогоор 1,390 тэрбум ам.доллараар бага байна.



Зураг 3. Татвар болон орлого (Эх сурвалж: OPEC database)

OECD -ын гишүүн орнуудын газрын тосны татвараас олсон орлого нь тухайн орны Үндэсний засгийн газрын цэвэр орлого болох юм. Гэтэл OPEC-ын гишүүн орнуудын түүхий газрын тосны худалдаанаас олж буй орлогод олборлолт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, тээвэрлэлт зэрэг өндөр зардал багтсан байна. Энэ бүхнээс үзэхэд газрын тос худалдаалж буй улс орнууд газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй улс орнуудаас илүү их ашиг олдог байна. Жишээлбэл, Англи улсын засгийн газар 2011 оны байдлаар газрын тосны худалдаанаас OPEC-ын гишүүн орнуудаас 1,8 дахин их орлого олсон байна. Зураг 4-т OECD улсуудын 2007-2011 оны хооронд баррель газрын тос бүрийн өртөг зардлын задаргааг улс орон тус бүрээр үзүүлсэн бөгөөд 7 орныг хамруулсан доорх зургаас шатахууны үнэ 2011 онд жижиглэнгийн үнэд эзлэх татварын хувь хэмжээнээс хамаарч хэрхэн өссөнийг үзүүлж байна.



Зураг 4 (Баррель/ам.доллараар) 1 баррель = 42 америк галлон буюу 159 литр

ОХУ -ын хувьд 2011 - 02 -11 ны байдлаар 1л бензиний үнийн өртөг дараах бүтэцтэй байна:
1 литр АИ - 92 бензиний жижиглэнгийн үнийн бүтэц (**1** л= **24,3** рубль):

Орц	Эзэлж буй хувь	Үнэ /руб/
Олборлолтын өртөг	9,5%	2,3
Тээвэрлэлтийн зардал	1,2%	0,2
Дахин боловсруулах зардал	6%	1,4
Жижиглэн хэрэглээ	11%	2,6
Ашгийн татвар	18%	1,16
Акциз	12%	2,9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	15,3%	3,7
Нөөц ашигласаны татвар	16,9%	4,1
Нийт ашиг	23,3%	5,6

ОХУ -ын жижиглэнгийн үнийн өмнө өгүүлсэн бүтцийг доорхи харуулав.

ШИНЭ МЭДЭЭ
СУДАЛГААНЫ САН

Ашигласан материал

1. http://www.eia.gov/petroleum/gasdiesel/
2. http://chartsbin.com/view/1115
3. http://www.opec.org/opec_web/en/data_graphs/333.htm
4. http://au95.org/price/
5. OPEC database

* * *

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ БА ҮНЭЛГЭЭ

(ДҮН ШИНЖИЛГЭЭ)

Ц. Нороводондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Д. Байгалмаа,Г. Гэрэл, Ч. Онончимэг

Сэдвийн агуулга

Нэг. Дүн шинжилгээний хэсэг

1.1 Эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт, судлагдсан байдал

1.2 Эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд ба үнэлгээний индикаторууд

1.3 Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын өнөөгийн байдал

1.4 Эдийн засгийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүд

Хоёр. Судалгааны хэсэг

2.1 Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох зорилтын өнөөгийн байдал

2.2 Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого ба өнөөгийн байдал

2.3 Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлын эрсдэл

2.4 Эрчим хүч, эрдэс баялгын салбарын бодлого

2.5 Гадаад худалдаа, интеграцийн бодлогын хэрэгжилт эрсдэл

Ашигласан материал

* * *

Монгол улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт ба үнэлгээ

1.1 Эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт, судлагдсан байдал

Эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт нь “төрт ёсны харилцаа” бий болсон цагаас хойш 200 гаруй жилийн туршид хөгжиж шинжлэх ухааны түвшинд судлагдсаар ирсэн боловч төдийлөн “нээлттэй“ сэдэв байгаагүй. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан үйл явдлууд, глобалчлалын нөлөөгөөр энэ асуудал нь тусгаар улс бүрийн амин чухал асуудал болоод байна.

Улс орны дотоод болон гадаад эдийн засгийн аюулгүй байдлын түвшинг үнэлэх онол, арга зүйд ахиц гарч дэлхийн нэр хүнд бүхий эрдэмтэд, судалгаа шинжилгээний байгууллагууд шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээний арга, аргачлалыг боловсруулж байна. Улс орон бүр өөрийн эдийн засгийн аюулгүй байдлаа үнэлэх тоон болон харьцуулсан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тогтоож үндэсний болон олон улсын түвшинд харьцуулсан ажиглалт, дүн шинжилгээ хийж байна.

Харин Монгол улсад харьцангуй бага судлагдсан салбар болох нь судалгааны явцад ажиглагдлаа. Сүүлийн жилүүдэд энэ сэдвээр хэд хэдэн удаа хэлэлцүүлэг, эрдэм

шинжилгээний хурал зохион байгуулагдсаныг эс тооцвол эдийн засгийн аюулгүй байдлын тухай ойлголт, эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд болон тэдгээрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд /индикатор/, тооцох аргачлалыг боловсруулах тал дээр төдийлөн ахиц дэвшил гараагүй байна.

ҮАБЗ болон төрийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргах субьектуудын хувьд энэ бол гарцаагүй анхаарал хандуулах шаардлагатай тулгамдсан асуудал мөн. Доорхи хурал, семинарын материалууд болон зөвлөмжийг тухай бүр ҮАБЗ-д хүргүүлсэн гэж найдаж байна. Тухайлбал:

- Стратеги судлалын хүрээлэн “Эдийн засгийн аюулгүй байдалд учирч буй эрсдэлүүд”, /2012.04.18/
- УИХ-ын АБГБ -ын Байнгын хороо, Конрад Аденаурын сан “Эдийн засгийн аюулгүй байдал” /2012.04.27/
- Стратеги судлалын хүрээлэн “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд өгөх үнэлгээ” / 2012.12.10/

2010 онд шинэчлэн батлагдсан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т заасан ”Эдийн засгийн аюулгүй байдал” бүлэгт дараахь 5 багц асуудлын хүрээнд эдийн засгийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлсэнээр Монгол улс эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгоно хэмээн зорилтоо тодорхойлсон. Үүнд:

- Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох
- Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого баримтлах
- Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангах
- Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого хэрэгжүүлэх
- Гадаад худалдаа, интеграцийн бодлого хэрэгжүүлэх

Монгол улсын Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын зорилтууд:

1. Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох хүрээнд
    - Олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох;
    - Стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл харилцаа холбоо, санхүүгийн салбарыг Европын холбооны стандартад нийцүүлэх;
    - Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгын салбарыг хөгжүүлэх;
    - Дэд бүтцийн салбарыг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг харгалзан хөрөнгө оруулалт хийх;
    - Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, агаарын тээвэр, мэдээллийн технологи ачишлаг экспортлох боломжтой, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;
    - Боловсролын салбарт ОУ-ын стандартыг мөрдүүлж, ИДС болон ЭҮСБ -уудын уялдаа холбоог хангаж, хүний хөгжлийг дээшлүүлэх;
    - Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
    - Өндөр технологи, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл харилцааны

салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалж, иргэдийг ажлын байраар хангах, ядуурлыг бууруулах

2. Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах хүрээнд

- Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь хэмжээг нэмэгдүүлэх, хамгаалах;
- Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтнийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байх, гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орнууд, өндөр хөгжилтэй орнуудын оруулах хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй байлгах;\
- Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд борлуулахдаа бодлогын зарчмыг хадгалж эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөгжлийн үндсийг тавих хөшүүрэг, арга хэрэгсэл болгох;
- Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн хараат бус нөхцөлийг бууруулж, тээврийн салбарт хөрш орнуудтай 2 болон 3 талт урт хугацааны харилцан ашигтай хэлэлцээр байгуулах. Далайд гарах гарцыг эрэлхийлэх;

3. Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангах хүрээнд

- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлэх;
- Засгийн газрын авах зээл нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан зохистой харьцаанд байх ба бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх;
- Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын 1 жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгах;
- Үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж тогтворжуулах, дотоодын гүйлгээнд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын зах зээлд эзлэх хувь хэмжээг зохистой байлгах;
- Банк дундын эрсдэлийн сан байгуулж, санхүүгийн салбарын эрсдэлээс үүссэн хохирлыг төр хариуцах зарчмаас татгалзах;
- Гадаад, дотоодын томоохон төлбөр тооцоо, зээл, аккредитивд хяналт тавих, санхүүгийн гэмт хэргийг илрүүлж шалгаж шийдвэрлэх тогтолцоо бий болгох;

4. Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлогын хүрээнд

- Эрдэс баялгийн салбарыг үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа болгож түүхий эдийн хавсарга, гадаад дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхолын сөргөлдөөнөөс ангид байлгах, байгаль орчныг доройтуулахгүй байх;
- Уул уурхайн ил тод хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулах;
- Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импорт орлох, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор өргөнөөр ашиглах;
- Байглаь орчинд хор нөлөө багатай хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж 2020 он гэхэд түлш эрчим хүчний хэрэгцээг нүүрс болон бусад дотоодын эх үүсвэрээр бүрэн хангах;
- Газрын тосны бүтээгдэхүүнээр 1 орноос шууд хараат байдлыг багасгаж 2020 он

гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангах, улсын нөөцийг түүхий нефтээр зургаан сараас доошгүй хэмжээнд байлгах;
- Цөмийн эрчим хүчийг үндэсний ашиг сонрхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлэх, Цөмийн цикдийг хөгжүүлж цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгох, бэхжүүлэх;

5. Гадаад худалдаа, интеграцийн бодлогын хүрээнд

- Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах;
- Гадаад худалдааны алдагдалыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгсэлүүдийг зохистой хэрэглэх;
- Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгаайлахаас сэргийлэх, үнийн зохиомол хэлбэзэл, монополь, үударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах;
- Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр хийхдээ эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан судалгаа тооцоотой, шат дараалалтай, сонголт хийх зарчим баримтлах;

“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д дэвшүүлсэн зорилтуудыг хангах хүрээнд хийгдэж байгаа ажлууд, төрийн бодлогын уялдаа холбоо, эцсийн үр дүн тодорхой биш байна. Үзэл баримтлал цаасан дээр батлагдсан боловч хэрэгжүүлэх механизм нь тодорхойгүй, асуудлыг хариуцах ёстой Засгийн газрын болон УИХ-ын байгууллагууд үүрэг хариуцлага хүлээдэггүй, энэ талаар албан ёсны статистик мэдээлэлийг тогтмол гаргаж тайлагнахгүй явсаар иржээ. Эрдэмтэн судлаачид, иргэдийн зүгээс энэ асуудалд шүүмжлэлтэй хандаж тодорхой санал дэвшүүлж байгаагаас үзэхэд асуудлыг системтэй авч үзэх шаардлага бий болсоныг харуулж байна. Үүнээс үүдэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд болон тэдгээрийг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд /индикатор/-ийг тогтоож, үнэлэх аргачлалыг боловсруулах, тогтмол мониторинг үнэлгээ хийх талаар холбогдох байгууллагуудад үүрэг өгөх
2. ҮАБЗ болон УИХ -ын түвшинд энэ асуудлыг тогтмол хэлэлцдэг болох
3. Төрөөс явуулж байгаа бодлого, шийдвэрийг ҮАБ-ын үзэл баримтлалд нийцүүлэх, бодлогын уялдаа холбоог хангах чиглэлээр УИХ болон ЗГ-т үүрэг өгөх

1.2 ЭЗАБ -ын үзүүлэлтүүд ба үнэлгээний индикаторууд

Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын зорилго, зорилтуудаа улс орон бүр өөрийн орны өвөрмөц нөхцөл байдалд тохируулан тодорхойлдог. Гэхдээ эдийн засгийн аюулгүй байдлын асуудал нь улс төр, эдийн засаг, эрх зүй болон гадаад харилцааны салбарт явуулж байгаа бодлогын үр дүн юм.

Эдийн засгийн аюулгүй байдлыг тооцох үзүүлэлтүүд, үнэлгээний аргачлалуудыг судалж үзлээ. Олон улсын түвшинд ч тухайлсан орны хувьд ч ийм арга, аргачлалууд байна. Эдгээрээс ОХУ-ын нэрт эрдэмтэн С.Глазьевийн боловсруулсан Эдийн засгийн аюулгүй байдлын индекс тооцох аргачлал нь дэлхийн хэмжээнд хэрэглэгдэж байгаа жишиг болохуйц аргачлал болох нь харагдаж байна. Иймд уг эрдэмтэний хийсэн судалгаа,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

аргачлалыг ашиглан Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын түвшин ямар байгаа талаар тойм төдий мэдээлэл өгөх, дүгнэлт гаргахыг оролдов. /Хугацаа бага, мэдээлэл хомс байсныг дашрамд дурдья. Цааш лавшруулан судлах боломжтой./

С.Глазьев нь анх 1996 онд энэхүү аргачлалыг боловсруулж дэлхийн 209 орны хэмжээнд харьцуулсан судалгаа хийсэн байна. Үүнээс хойш ийм хэмжээний томоохон судалгаа хийгдсэн эсэх нь тодорхойгүй. ОХУ-д С.Глазьевийн боловсруулсан 20 үзүүлэлтийг Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг тооцох үзүүлэлтүүд болгон баталгажуулж албан ёсны хэрэгцээнд ашиглаж байна.

1996 онд хийсэн судалгаагаар, эдгээр 20 үзүүлэлтээс 3 шалгуур хангасан 23 орон байсны дотор Монгол улс байна. Эдгээр бүлэг орнууд нь дэлхийн нийт орны 11%, дэлхийн нийт хүн амын 3,1%-ийг бүрдүүлж байсан байна. Тухайн үед дэлхийн хэмжээнд 20 үзүүлэлтийг хангасан орон байгаагүй бөгөөд хамгийн дээд тал нь Япон-15, АНУ, Франц-14, БНСУ, Сингапур-13, ОХУ-7, БНХАУ-1 үзүүлэлтийг хангаж байсан байна. Цаашид энэ үзүүлэлт хэрхэн өөрчлөгдсөнийг ядаж одоо байгаа нөхцөл байдлын хүрээнд тайлбарлах нь зүйтэй гэж үзлээ.

Количество критериев, которым соответствует страна	Количество стран, удовлетво ряющих этому числу критериев	Страны и территории	Удельный вес в общем числе стран мира, %		Удельный вес в мировом населении, %	
			по груп-пам	нараста-ющим итогом	по груп-пам	нараста-ющим итогом
3	23	Афганистин, Белиз, Гамбия, Грузия, Джибути, Доминика, Кабо-Верде, Кения, Кирибати, Либерия, Македония, Малави, Мали, Монголия, Непал, Нормандские о-ва, Сан-Марино, Соломоновы о-ва, Сомали, Танзания, Узбекистан, Чад, Экваториальная Гвинея	11,0	74,2	3,1	95,8

Источники: расчеты ИЭА по данным ООН, МВФ, Всемирного банка, МОТ, ЮНЕСКО

1.3 Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын өнөөгийн байдал

Монгол улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдал ямар түвшинд байгааг судалгаанд ашигласан мэдээлэл, аргачлалуудыг ашиглан дараахь үзүүлэлтүүдээр тоймлон дүгнэж болох юм. Үүнд :

№	Үзүүлэлтүүд	Босго үнэлгээ 1996	Бодит үзүүлэлт			
			2008	2010	2011	2012-XI
1	ДНБ-ний өсөлтийн хувь	5%	8.9	6.4	17.3	12.4

2	1 хүнд ногдох ДНБ /МХХ, Монгол улс/ Дэлхийн босго -11505	2015 онд 5000 $	2465.1	3025.9	3521.0	3462.3 /3-р ул/
3	Аж үйлдвэрлэлийн салбар дахь боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	70%	16.7	21.5	22.2	32.4
4	Аж үйлдвэрлэлийн салбар дахь машин үйлдвэрлэлийн эзлэх хувь	20%	0	0	0	0
5	ДНБ-д Хөрөнгө оруулалтын эзлэх хувь	25%	27.2	45.7	60.4	
6	ДНБ-д Шинжлэх ухааны зардлын эзлэх хувь	2%	0.2	0.3		
7	Машин үйлдвэрлэлд шинэ бүтээгдэхүүний эзлэх хувь	6 %	0	0	0	0
8	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь	7%	35.2	39.2	41.9	
9	Хүн амын дундаж наслалт	70	67.2	68.5	68.3	68.3
10	Гэмт хэргийн түвшин (100 мян хүнд ногдох гэмт хэргийн тоо)	5 тыс.	124	111	104	118
11	МОТ-ийн аргачлалаар тооцсон ажилгүйдлийн түвшин	7 %	9.2	9.9	7.7	6.3
12	Инфляцийн жилийн дундаж түвшин	20%	22.1	13.0	10.2	14.4
13	ДНБ-д эзлэх дотоод өрийн хувь хэмжээ	20%	3.4	16.3	25.6	27.4
14	Төсөвт орох татварын орлогоос дотоод өр ба түүний хүүгийн төлбөрт зарцуулах хувь	25%	1.1	7.4	15.3	0.4
15	ДНБ- д эзлэх гадаад өрийн хувь хэмжээ	25%	24.0	20.3	28.3	29.4
16	Төсвийн алдагдлын санхүүжүүлтэнд гадаад өрийн хувь хэмжээ	30%	38.8	13	25.9	8.6
17	ДНБ дэх төсвийн алдагдалын хувь	5%	-0.5	-5.6	-7.1	
18	ДНБ-д Мөнгөний масс(М2) – ын эзлэх хувь	50%	34.6	56.7	59.2	71.7
19	ДНБ-д импортын эзлэх хувь	30%	61.9	84	52	45
20	Үүнээс хүнсний бүтээгдэхүүний импорт	25%	41.1	49.2	65.0	5.8

Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхэтгэл 2009 ,2010, 2011, 2012 оны 3 улирал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1.4 Эдийн засгийн аюулгүй байдлын болзошгүй эрсдэлүүд

2008-2012 оны статистик мэдээллээс тоймлон дараахь байдлаар Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын нөхцөл, эрсдэлүүдийг тоймлон харуулж байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	Бодит байдал	Болзошгүй эрсдэл
Эдийн засгийн өсөлтийн хувь 5%-иас доошгүй байх	Статистикаас үзэхэд Монгол улс 2008 оноос хойш эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж ирсэн боловч энэхүү өсөлт нь уул уурхайн салбарын нөлөөгөөр бий болсон бодит бус өсөлт гэж үздэг.	- Эдийн засгийн бүтэц алдагдах - Уул уурхайн салбараас хамааралтай эмзэг эдийн засаг - Гадаадын хөрөнгө оруулагчаас хамааралтай болох - Голланд өвчин
1 хүнд ногдох ДНБ-ны дэлхийн дундаж 11505$, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод зааснаар 5000$ -с доошгүй байх	Монгол улсын 1 хүнд ногдох ДНБ 2008 онд 2465,1 ам доллар байсан бол 2011 онд 3521,3 ам доллар болж өсчээ. Нийт хүн амын дунджаар ийм байгаа боловч баян, ядуугийн ялгаа маш өндөр /20 дахин/ гэж судлаачид үзэж байна.	- Орлогын тэгш бус байдал - Ядуурал
Аж үйлдвэрлэлийн салбарт боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 70%-иас доошгүй байх	Монгол улсад энэ үзүүлэлт 2008 оноос хойш дунджаар 20% байна.	- Өөрөө өөрийгөө тэтгэх эдийн засгийн бодлого алдагдах - Импортоос хараат болох
ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх хувь 25%-аас доошгүй байх	2009 оноос Оюу толгой төсөл хэрэгжиж эхэлсэнээр хөрөнгө оруулалтын дүн өсөж байна. Гадаадын хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл олгосноор гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын 85% орчим нь уул уурхайн салбарт орсон бол нийт экспортын 95% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.	- Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгавартай хандах нь үндэсний хөрөнгө оруулалтыг бууруулах - Нийт эдийн засгийн чадавхи суларч санхүүжилтийн боломж хумигдаж байгаагаас хөрөнгө оруулалтын эх үүсвэр дутагдах - Гадаадын хөрөнгө оруулалт, экспортоос хамааралтай болох
ДНБ-д шинжлэх ухааны зардлын эзлэх хувь 2%-иас доошгүй байх	2008 оноос хойш энэ үзүүлэлт дунджаар 02% байна. Монгол улс шинжлэх ухааны салбартаа хөрөнгө зарцуулж шинэ техник, технологи нэвтрүүлэх, хөгжилд чиглэсэн бодлого явуулахгүй байна	- Хөгжлийн бодлого алдагдах - Техник, технологи, суурь судалгааны хоцрогдол
Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой хүн амын нийт хүн амд эзлэх хувь 7%-иас хэтрэхгүй байх	Монгол улсад энэ хувь 2008 оноос хойш бүр өсч 41,9%д хүрсэн ба дунджаар 38,7 %, байна. Нийт хүн амын 40% гаруй нь ядуу байна	- Ядуурал, ажилгүйдэл хэтэрхий их өссөн нь нийгэм, эдийн засгийн маш олон эрсдэл
Хүн амын дундаж наслалт 70 байх	Монгол улсын хүн амын дундаж наслалт 2008 оноос хойг бага зэрэг өсч 2011 онд 68,3 болсон байна. Гэвч дэлхийн дунджид хүрээгүй.	- Хүн амын өсөлт ба хөгжлийн бодлого алдагдах - Эрүүл мэндийн салбарын бодлого - Нийгмийн халамж, даатгалын бодлого

Хүн амын хамгийн их болон бага орлоготой 10%-ийн хоорондын орлогын зөрүүний ялгаа 8 дахин-аас хэтрэхгүй байх	МУ-ын нийт хадгаламжийн дүнг авч үзвэл, 715000 өрхийн дундаж хадгаламж 20,5 сая байхад, 27000 өрхийн д/ хадгаламж 57 сая төгрөг. Нийтээр нь авч үзвэл 22 дахин зөрүүтэй. Сүүлийн жилүүдэд дундаж орлоготой иргэдийн тоо буурч, бага орлоготой иргэдийн тооөссөн. Монголын нийт актив хөрөнгийн дийлэнхийг өндөр орлоготой иргэд эзэмшиж байна. дэлхийн жишгээс үзэхэд дундаж орлоготой иргэдийн тоо нийт хүн амын 60%-иас доошгүй байх ёстой	- Хүн амын орлогын зөрүү, баян хоосны хэт ялгаа - Авилгал - Улс төржилт - Эдийн засаг дахь төрийн оролцоо хэт их байгаа нь авилгал, хууль бус хөрөнгөжих явдлыг өөгшүүлж байна. - Зах зээлийн жам ёсны тогтолцоо алдагдаж байна.
100000 хүнд ногдох гэмт хэргийн гаралт 5000-аас хэтрэхгүй байх	Гэмт хэргийн гаралт сүүлийн үед нэмэгдэж үйлдэж байгаа арга хэлбэр, шалтгаан нь улам бүр эмзэглүүлж байна. Ядуурал, ажилгүйдэл, ёс суртахууны доройтол, хууль эрх зүйн уян хатан бус байдал нөлөөлж байна.	- Нийгмийн сэтгэл зүй гажих - Хүмүүжил, ёс суртахууны доройтол - Ажилгүйдэл, ядуурал - Хуулийн хатуу чанга байдал
Ажилгүйдлийн түвшин хөдөлмөрийн насны хүн амын 7%-иас хэтрэхгүй байх	МУ-д энэ үзүүлэлт 2008 онд 9,2% байсан бол 2011 онд 7,7% байна. Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжсэнээр ажлын байр бий болж байна.	- Ядуурал - Гэмт хэргийн гаралт - Боловсон хүчний дутагдал
Инфляцийн жилийн дундаж түвшин 20%-аас хэтрэхгүй байх	2008 онд 22,1% байсан бол 2011 онд 10,2% болсон байна. Инфляцийг онилсон мөнгөний хатуу бодлогыг явуулсаар байгаа нь эдийн засгийн хөгжлийг боомилж эцсийн дүндээ үндэсний эдийн засгийг сөхрүүлж байна гэж судлаачид үздэг. Мөнгөний бодлогыг Төв банк дангаар хараат бусаар явуулах боломжгүй улс төрөөс хараат байна	- Төв банк нийт эдийн засгийг дэмжсэн бодлогыг бие даасан байдлаар явуулж чадахгүй байгаа нь эцсийн дүнд эдийн засгийн хөгжлийг боомилж хямрал үүсгэж болзошгүй. - Төв банкыг улс төрөс хараат байлгах нь бие даасан, мэргэшсэн байдлаар ажиллах боломжийг үгүйсгэж байна. - Тусгай зөвшөөрөлтэй монополь үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд суурь үнэд нөлөөлөх эрсдэл
ДНБ-д эзлэх дотоод өрийн хувь хэмжээ 20%-иас хэтрэхгүй байх	Сүүлийн жилүүдэд дотоод өрийн хэмжээ өсч байна. 2008 онд 3,4% байсан бол 2011 онд 25,6% болж өссөн байна.	- Зээлдэгчдийн төлбөрийн чадвар муудах - Найдваргүй зээл өсөх - Банк санхүүгийн салбарын хямрал - Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх, инфляци
ДНБ-д эзлэх гадаад өрийн эзлэх хувь 25%-иас хэтрэхгүй байх	Гадаад өр харьцангуй тогтвортой байгаа боловч сүүлийн жилүүдэд өсч байна. 2008 онд 24% байсан бол 2011 онд 28,3% болж өссөн байна.	- Засгийн газрын төлбөрийн чадвар муудах - Төсвийн хямрал

UB.MN
СОЁЛОГ ААНЫ САН

Төсөвт орох татварын орлогоос дотоод өр ба хүүгийн төлбөрт зарцуулах хувь 25-иас доошгүй байх.	Монгол улсад энэ үзүүлэлт хангалтгүй байна. 2008 онд 1,1% байсан бол 2011 онд 15,3% болж өссөн нь төсвийн тэлэлттэй холбоотой. Гэвч 2012 оны сүүлчээр авсан ЗГ-ын бондын төлбөр нь төсөвт дарамт үүсгэнэ.	- ЗГ-ын төлбөрийн чадамж буурах - Эдийн засгийн хямрал - Төсвийн орлого, санхүүжилтийн саатал
Төсвийн алдагдалын санхүүжилтэнд гадаад өрийн хувь хэмжээ 30% -аас хэтрэхгүй байх	2008 онд -38,8% байсан бол 2011 онд 25,9% байна. Төсвийн алдагдалыг гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх	- Гадаад эх үүсвэрийг эргэн төлөх эх үүсвэр дутагдах - Засгийн газрын өр нэмэгдэх
ДНБ-д төсвийн алдагдалын хувь 5%-иас хэтрэхгүй байх	2008 онд 0,5% байсан бол 2011 онд 7,1% болж өсчээ. Энэ нь анхаарах ёстой үзүүлэлт болж байна. “Төсвийн тогтвортой байдлын тухай“ хуулиар 2013 оноос эхлэн 2%-иас хэтрэхгүй байх ёстой.	- Төсвийн алдагдалын зохистой харьцаа алдагдах
ДНБ-д мөнгөний масс(М2) –ын эзлэх хувь 50% -иас хэтрэхгүй байх	2008 онд 34,6 % байсан бол 2011 онд 59,2% болж өсчээ.	- Инфляци өсөх
ДНБ-д импортын эзлэх хувь 30%-иас хэтрэхгүй	2008 онд 61,9% байсан бол 2010 онд 84%, 2011 онд 52% болсон байна. Эдийн засаг бүхэлдээ импортоос хамааралтай байна.	- Импортын хэт их хамаарал
Үүнээс хүнсний бүтээгдэхүүний импортын хувь хэмжээ 25%-иас хэтрэхгүй байх	Монгол улсын хэмжээнд нийт импортын бүтээгдэүүнд хүнсний бүтээгдэхүүний импорт 2008 онд 41,1% байсан бол 2011 онд 65% болж өссөн байна.	- Хүнсний аюулгүй байдал алдагдах - Үндэсний үйлдвэрлэл мөхөх - Зайлшгүй нөхцөлд ард түмний эн тэргүүний хэрэгцээт хоол хүнсийг үйлдвэрлэх чадваргүй болох

Нийт 20 шалгуур үзүүлэлтийг зэрэгцүүлж үзвэл, Монгол улс эдгээр үзүүлэлтээс үндсэндээ 3 шалгуурыг хангаж, 16 шалгуурыг хангахгүй байна гэж дүгнэж болохоор байна. Шалгуур хангаж буй 3 үзүүлэлт нь:

- ДНБ-ны өсөлтийн хувь
- ДНБ-д хөрөнгө оруулалтын эзлэх %
- Инфляцийн жилийн дундаж түвшин гэсэн 3 үзүүлэлт байна.

Гэвч бодит байдал дээр дээрхи 3 шалгуур тус бүр олон нийт, судлаачдын зүгээс тодорхой шүүмж дагуулж байна. Жишээ нь, ДНБ-ын өсөлтийн % хэмжээ нь дэлхийд бараг байхгүй өндөр өсөлт боловч зөвхөн уул уурхайн салбарын өсөлтөөс бий болсон бодит бус өсөлт гэж үздэг. Мөн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн нь Оюу толгой төсөл гэх мэтийн томоохон төсөлд холбогдох цаг зуурын томоохон хөрөнгө оруулалт юм. Инфляцийн түвшний хувьд энэ нь мөнгөний хатуу бодлого баримтлаж ирсэний үр дүн боловч эцсийн дүндээ бодит эдийн засгийн санхүүжилт хумигдсанаар эдийн засгийн хямрал нүүрлэх, үндэсний аж ахуйн нэгжүүд санхүүгийн дутагдалд орох магадлалтай гэж үздэг.

Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын эрсдэлийг бүхэлд нь дараахь уялдаа холбоо бүхий бодлогын аспектуудын хүрээнд бүлэглэн авч үзэж болох юм. Үүнд:

1. Улс төрийн эрсдэл
- Эдийн засаг дахь төрийн оролцоо хэт их
- Улс төрчдийн эдийн засгийн ашиг сонирхол
- Авилгал
- Төрийн бодлого, концепци тодорхойгүй
- Эрх зүйн орчин, бодлого хөтөлбөрийн уялдаа холбоо алдагдсан
- Эрх зүйн орчин тогтворгүй
- Улс төрчдийн лобби
- Хэт улс төржилт, намчирхал
- Ашиг сонирхолын зөрчил
- УИХ болон Засгийн газар, бусад төрийн байгууллагуудын чадавхи, ажлын уялдаа холбоо муу

2. Эрх зүйн орчны эрсдэл
- Хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал
- Үндсэн хууль болон бусад хууль хоорондын нийцэл алдагдах
- Салбарын болон оргник хуулиудын хоорондын зөрчил, хуулийн цоорхой
- Хуулийн төслийн концеци, боловсруулалт, үндэслэл тооцоо судалгаа муутай
- Хууль тогтоомжийн хэрэгжилт
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үнэлгээ хийх нэгдсэн систем

3. Гадаад харилцааны эрсдэл
- Геополитик
- Гадаад эдийн засаг, худалдаа
- Гадаадын хөрөнгө оруулалт гэх мэт

4. Эдийн засгийн эрсдэл (Үүнийг дээр хүснэгтээр тайлбарласан болно)

Дээрхи асуудлуудын хүрээнд УИХ, Засгийн газар, Сангийн яам, Хөгжлийн яам, Монгол банк, Статистикийн үндэсний хороо, СЗХ зэрэг төрийн байгууллагууд, Стратеги судлалын хүрээлэн, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Тагнуулын ерөнхий газар болон бусад эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд гүнзгийрүүлэн судлах, тоо мэдээллийг нарийвчлах буй за. Зөвхөн санаа сэдэл өгөх үүднээс энэхүү мэдээллийг богино хугацаанд тоймлон гаргаж хүргүүлсэн тул хүлцэл өчье. [Боловсруулсан - Ц. Норовдондог (Ph.D)

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

(ХАВСРАЛТ СУДАЛГАА)

Энэхүү судалгааны ажил нь “Монгол улсын үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын хэрэгжилт ба үнэлгээ” сэдэвт судалгааны ажлын хавсралт судалгаа юм. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурьдсан Эдийн засгийн аюулгүй байдлын зорилтууд болон тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор судалгаанд статистик мэдээллүүд, холбогдох яам газруудын гаргасан мэдээлэл, Засгийн газрын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаархи мэдээлэл болон бусад судалгааны мэдээллүүдийг энэхүү судалгаанд ашигласан болно.

Судалгааны үр дүнг тоймлон дүгнэхэд Монгол улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд ерөнхийдөө хангалтгүй байгаа нь харагдаж байна. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” дахь Эдийн засгийн аюулгүй байдлын зорилтуудад холбогдох заалт бүрийг нэгбүрчлэн авч үзвэл нааштай үзүүлэлт тодийлөн харагдахгүй байна. Зарим нэг заалтын хувьд одоогоор хэрэгжих цаг хугацаа нь болоогүй, өнөөгийн нөхцөлд шууд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зэрэг бэрхшээл асуудлууд ч байна. Тиймээс судалгааны үр дүнг нэгтгэн харуулахдаа сөрөг үр дүн бүхий заалтуудыг салбар бүрээр нь тодруулан авч үзлээ. Үүнд:

Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох

- Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн төрөлжилт нь уул уурхайн салбараас хамааралд хумигдах хандлагатай болсон. Олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох талаар хэдийгээр төрөөс баримтлах бодлого, баримт бичгүүдэд тусгасан хэдий ч үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого тодорхойгүй хэвээр байна. Уул уурхайн үйлдвэрлэл өсөхийн хэрээр үйлчилгээний салбарт эрчимтэй өсөлт гарсан хэдий ч аялал жуучлал, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт дорвитой өсөлт ажиглагдсангүй.

- Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна.

Уул уурхайн салбарын хөгжлөөс хамаарч, эдийн засаг өсөлттэй, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ өндөр байгаа хэдий ч зөвхөн түүхий эдийн экспортод түшиглэсэн, үнийн өөрчлөлтөд эмзэг эдийн засгийн өрөөсгөл, цөөн орны зах зээл, дамжин өнгөрөх тээврээс хараат байна. Олборлох салбараас бий болсон орлогын хувьд дээрх зорилтод дурьдсанчлан хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлд зарцуулахаас илүүтэйгээр нийгмийн халамжийн салбарт түлхүү зарцуулсан байна.

- Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн өсөлт өндөр байхын хэрээр хүн амын ядуурлын түвшин багасах хэдий ч 2002 оноос хойш ядуурлыг түвшин тогтмол байдлаар өссөн байхад эдийн засгийн өсөлтийн хувьд харьцангуй өөрчлөлттэй байсан байна. Эндээс манай улсын хувьд эдийн

засгийн өсөлтийн хувь нь хэдийгээр өссөн ч хүн амын ядуурлын түвшин буурахгүй тогтмол өсөлттэй байна.

Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого

- Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

Хөрөнгө оруулалтын бүтцийг үзвэл гадаадын хөрөнгө оруулалт дотоод өрсөлдөөнийг эрчимжүүлж, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн зүйл ажиглагдахгүй байна. Гадаадын хөрөнгө оруулалт үндэсний үйлдвэрийн бааз суурийг дэмжихгүй байгаа явдал алсдаа манай эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалтаас шууд хараат болох хандлага руу хөтөлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын дүнг дотоодын хөрөнгө оруулалтын дүнд харьцуулсан харьцаанаас харахад гадаадын хөрөнгө оруулалт дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хоёр дахин их байгаа нь ямар нэгэн шалтгаанаар гадны хөрөнгө оруулалт зогсвол манай улс эдийн засгийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах чадваргүй болж болохыг харуулж байгаа юм.

- Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

Стратегийн ач холбогдолтой салбаруудыг нарийвчлан тогтоосон, үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд нийцүүлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэрт байдал, стратегийн ач холбогдол бүхий салбарт баримтлах хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон тодорхой хуулийн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм хангалттай биш байгаагаас зарим нэг улсын хөрөнгө оруулалтын хэмжээ хэт давамгайлах, тодорхой нэг салбарт хөрөнгө оруулалт төвлөрөх зэрэг сөрөг хандлагууд гарч байна.

Монгол улсын эдийн засгийн эмзэг бүтэц, гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, тодорхой салбарт чиглэгдэж байгаа байдал, хөрөнгө оруулалт хийж буй арга механизм, ирээдүйд гарч болзошгүй үр дагаврыг харгалзан үндэсний аюулгүй байдалд хамааралтай зарим салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг татахдаа дэлхий нийтээр дагаж мөрдөж байгаа хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэлтийн гэрээний стандарт, шууд бус хязгаарлалтын арга хэрэгсэлүүдийг ашиглах, илүү нээлттэй, хяналттай хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх шаардлагтай болох нь судалгаанаас харагдаж байна.

- Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно.

Хөрөнгө оруулалтын үр ашиг бууралд байгаа нь аль болох өгөөжөө өгөх салбарт чиглэгдэхгүй, мөн тухайн хөрөнгө оруулалт төдийлөн үр ашигтай байж чадахгүй байгааг харуулж байна. Судалгааны үр дүнгээс харахад гадаадын хөрөнгө оруулалт орж буй салбарын хувьд нэлээд өрөөсгөл байгаа нь харагдаж байна. Иймд өөрийн орны нөөц, боломжид тулгуурлан хөрөнгө оруулалтыг /ялангуяа дотоодын хөрөнгө оруулалтыг/ үр ашигтай хуваарилах, тэрхүү нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй ба боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх нь чухал байна.

UIH.MN
СУДАЛ АЛБАГСАН

Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал

- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ.

Манай улсын төсөв, санхүүгийн салбарын тогтвортой байдал нь хуулийн хүрээнд тавьж байгаа тоон шалгуурыг хангаж байгаа хэдий ч түүнд нөлөөлж байгаа гол үзүүлэлтүүдээр нь харахад системийг бүхэлд нь тогтворгүй болгох эрсдлүүдийг үүсгээд байна.

Өнгөрсөн хугацааны Монгол улсын төсөв нь уул уурхайн орлогоос хэт хамааралтай байж, түүнд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал ихээр нөлөөлж байсан. Гадаад эдийн засгийн таатай үед бодит үйлдвэрлэлийн хэмжээгээр бус үнийн өсөлтөөр огцом өссөн манай улсын төсвийн орлого гадаад зах зээл таагүй болох үед эрс буурч, төсвийн зарлагын хэт тэлэлтийг хумихад төвөгтэй болж, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд бэрхшээл үүсгэж байна. Нөгөө талаар, нийгмийн халамж, амлалтыг санхүүжүүлсэн нь төсөвт асар дарамт учруулж, бодит салбарын хөгжлийг сааруулах, эдийн засгийн өсөлтийг удаашруулахад гол нөлөө үзүүлсэн ба дээрх шалтгаанууд нь төсвийн тогтворгүй байдлыг үүсгэсэн. Ирж буй оны буюу 2013 оны төсвийн төлөвлөлтөөс харахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг тоон үзүүлэлтийн хувьд хангасан онцлогтой төсөв болсон боловч төсвийн орлогыг хэт өөдрөг төлөвлөсөн нь бодит эрсдэл юм. Энэхүү төлөвлөлтийг биелэлт нь гүйцэхгүй бол төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр тэр хэмжээгээр дутагдах, түүнчлэн төлөвлөсөн зардлуудыг хязгаарлах шаардлага гарч, энэ нь эргээд бодит эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалт багасах зэрэг нөлөөтэй.

Нөгөө талаар, орлого бүрдүүлэгч эх үүсвэр нь зөвхөн татвараар бүрдэж байгаа, түүнчлэн тэдгээр таварыг бүрдүүлэгч эх үүсвэрт дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн үнийн хэлбэлзэл зэрэг гадаад нөлөөлөл их тул цаашид орлогын бусад эх үүсвэрүүдийг эрэлхийлэх шаардлагатай байна.

Санхүүгийн салбарын тогтвортой байдал нь салбарыг хянаж байгаа шалгуурын хүрээнд хэвийн байгаа харагдавч задлан харахад үүсч болзошгүй эрсдлүүд байсаар байна. Үүнд, зээлийн төвлөрөл болон эх үүсвэрийн төвлөрөл, өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдлүүд байна.

- Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна.

Сүүлийн жилүүдийн гадаад өрийн ашиглалтаас харахад дэд бүтэц /52%/, эдийн засгийн салбаруудад /41%/ дийлэнх хэсгийг оруулж байгаа боловч тэдгээр нь чанар стандартын шаардлага хангахгүй, эдийн засгийн бодит үр өгөөж нь муу байна.

Монгол улсын гадаад өрийн ДНБ -д эзлэх хувь хэмжээ 2011 оны байдлаар 28.3 хувь байгаа нь шалгуурыг 3.3 пунктээр давж байгаа ба 2012 оны эцэст 1,5 тэрбум ам.долларын Засгийн газрын бонд гаргасныг оруулж тооцоход зөвхөн гадаад өр нь ДНБ-ний 50 орчим хувийг эзлэх хандлагатай болоод байна. Шинээр гаргасан энэхүү хөрөнгийг бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдэд зарцуулна гэж Засгийн Газраас мэдэгдэж байгаа ба хэрвээ зүй зохистой ашиглаж чадахгүй бол энэ нь их өрийн асуудал үүсэх төдийгүй үндэсний аюулгүй байдалд цаашилбал, манай улсын тусгаар тогтнолд нөлөөлөх эрсдэл үүснэ.

Эрчим хүч, эрдэс баялагын салбарын бодлого

- Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг ханга-хыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг

сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.

Үзэл баримтлалын тус заалтын дагуу 2012 оны 1 сард УИХ-аас “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” батласан боловч бодит байдал дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй бшх шатны байгууллагын томилгоо, тэдгээрээс хариуцан хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд ашиг сонирхолын зөрчил-тэйгээр хандаж бүтээн байгуулалтын томоохон ажлыг удаашруулах, үргүйдүүлэх болон бусад зөрчилүүд байгаа нь ил байна.

Мөн уул уурхайн ил тод байдал, орлогын хяналтын талаар “2012-2016 онд хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд эрх зүйн орчин бий болгоно хэмээн зорилт тавин шат дараалал бүхий үйл ажиллагааг хийхээр төлөвлөжээ. Анхаарвал зохих хамгийн том асуудал нь дан ганц хууль болон бусад шаардагдах эрх зүйн акт батлан гаргах нь хангалттай биш харин тэдгээрийг ягштал хэрэгжүүлэх арга зам, тогтолцоо, хариуцах эзэн нь туйлын тодорхой байж тус ажилдаа сэтгэл гарган ажиллах нь нэн шаардлагатай асуудал болсон байна.

- Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.

Энэ зорилтын хүрээнд өнөөгийн байдлаар Эрчим хүчний яаманд Засгийн газраас баталсан 3 Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тус яаман дээр гадаадын болон ОУ-ын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжүүлсэн болон танилцуулагдсан 8 төсөл байна. Түүнчлэн байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих зорилготой өөр жижиг төслүүд ТББ болон ОУ-ын байгууллагуудын санхүүжилт, тусламж дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна.

Гэвч Засгийн Хэрэг Эрхлэх газрын мэдээлсэнээр тус салбарын хамгийн гол хөтөлбөр болох “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт удааширалттай буюу тасарч байгаад шат шатны удирдлагууд анхаарах шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна. Мөн гадаадын болон ОУ-ын байгууллагын санхүүжилтээр хэрэгжсэн 6 төсөл нь хэрэгжээд дууссан ч эрчим хүчний дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж дийлэхгүй байгаа байдал үргэлжилсээр байна. “Дулааны цахилгаан станц-5” төслийн явц дэндүү удаашралтай байна.

Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.

Тус зорилтын хүрээнд “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хөтөлбөр” болон түүнийг дагаж гарсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 2016 он гэхэд дотоодын газрын тосны үйлдвэр бариж ашиглалтад оруулсан байна гэсэн зорилт дэвшүүлсэн байна. Түүнчлэн нефт импортлогч компаниудтай хамтран ажиллаж нөөцийг 6 сараас доошгүй хэмжээнд байлгана гэсэн зорилт тавьжээ. Энэ зорилтын хүрээнд Уул уурхайн яамнаас Засгийн газрын бондоор санхүүжих “Газрын тосны үйлдвэр” барих тухай төсөлөө Засгийн газарт хүргүүлжээ.

Гэвч тус төсөлд баримталж буй хариуцсан яамны бодлогод анхаарлаа хандуулах

ҮНЭМЛЭН СУДАЛГААНЫ

шаардлагатай байна. Тухайлбал тус яамны албан ёсны цахим хуудсанд тус үйлдвэр түүхий эд ОХУ-аас авахаар тохирсон тухай мэдээлэл тавигдсан байна. Гэтэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 98-р зорилтод “Олборлож буй газрын тосыг дотоодын үйлдвэрт эхний ээлжинд нийлүүлэх арга хэмжээ авна” гэсэн зорилт дэвшүүлсэнтэй зөрчилдөж байна. Мөн дотоодод түүхий эдийн нөөц орд газрууд байсаар байтал түүхий эдийг заавал гадаад орноос импортлох нь эдийн засгийн үр ашгийн хувьд аль нь илүү байх вэ гэдэгт тусгай мэргэжилтнүүдийн ашиг сонирхолын зөрчилгүй нарийвчилсан судалгаа шаардлагатай гэж үзэж байна.

Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ. Тус зорилтын шинэчлэлийн Засгийн газар олон нийтийн хүсэлтээр ойрын ирээдүйд “цацраг идэвхит ашигт малтмалыг ашиглахгүй” гэсэн шийдвэр гаргасан.

Гадаад худалдаа, интеграцийн бодлого

- Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.

Сүүлийн жилүүдэд манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ эрчимтэй өсч, дэлхийн 130 гаруй улс оронтой гадаад худалдаа хийж байгаа нь манай улсын эдийн засагт чухал ач холбогдолтой хэдий ч монгол улсын үндэсний эдийн засгийн гадаад худалдааны аюулгүй байдлын бүрэн хангаж чадахгүй байсаар байна. Импортын бараа бүтээгдэхүүний хувьд дэлхийн 100 гаруй улс орноос эрдэс бүтээгдэхүүн болон тээврийн хэрэгсэл, машин, механик төхөөрөмж, сэлбэг, эд анги зэрэг бараа ихэнх импортын барааны хувийг эзэлж байгаа нь манай улс дотооддоо үйлдвэрлэх боломжгүй бүтээгдэхүүн юм.

Харин экспортын бараа бүтээгдэхүүний төрлийн хувьд эрдэс бүтээгдэхүүн нийт экспортын барааны 90 орчим хувийг эзэлж байгаа нь манай улсын экспортын бараа бүтээгдэхүүний маш цөөн нэр төрөлтэй байгааг илтгэж байна. Мөн түүнчлэн экспортын бүтээгдэхүүний 90-ээс дээш хувийг зөвхөн БНХАУ -руу экспортолж байгаа нь манай улсын гадаад худалдаа БНХАУ-аас шууд хамааралтай болж буйг харуулж байна.

- Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Манай улсын гадаад худалдааны алдагдал сүүлийн жилүүдэд улам өссөөр байгаа ба энэ нь манай орны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох боловсруулаагүй болон хагас боловсруулсан түүхий эд, зэс, алтны экспорт голлосон хүнс, өргөн хэрэглээний барааны импортоос хамаарсан хэвээр байгаа нь нөлөөлж байна. Тиймээс энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байгаагаас хамааран үндэсний үйлдвэрлэл хөгжихөд саад учирж хүнд байдалд орох эрсдэлтэй.

2.1 Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох зорилтын өнөөгийн байдал

Эдийн засгийн олон тулгуурт бүтцийг бий болгох гэдэг нь нэгдүгээрт, эдийн засгийн системд байх ёстой гол бүрдэл хэсгүүдийг нь бий болгох, тэдгээрийн хоорондын харилцаа, хоршил, баланс, уялдаа, харилцан үйлчлэлийг хангах, хоёрдугаарт, эрсдэлийг хуваарилах, дотоод нөөц, бололцоогоо дайчилж, өөрийгөө тэтгэх, тэнцвэржүүлж (self

sustainability) чадах, бие даасан байдлыг хангах, гуравдугаарт, нийгмийн өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангаж чадахуйц өргөтгөсөн үйлдвэрлэл явуулж тогтвортой өсөн тэлж чадах, дөрөвдүгээрт, газар зүйн түгжигдмэл байдлыг арилгаж давуулан тээвэрлэх боломжтой салбаруудыг бий болгох, тавдугаарт, бүтээмж, өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх өргөн хүрээтэй шаардлагатай арга, механизмыг онцолж байгаа юм.[8]

Эдийн засгийн бүтэц нь системийн онолын үүднээс юуны өмнө тэнцвэртэй байх, түргэн өсөж, тэлж чадах, дотоод бүтэц, зохион байгуулалт, харилцан үйлчлэл нь уян хатан байх ёстой. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам нь эдийн засгийн гадаад харилцаа, гадаад зээл, өр, төлбөрийн асуудал, төсөв, мөнгөний болон шинжлэх ухаан-технологи, мэдээллийн бодлого зэрэг чиглэлээр төрийн нэгдсэн бодлоготой байх явдал юм.
Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал ямар түвшинд хангагдаж байгааг авч үзвэл иргэдийн орлого, суурь хэрэгцээг хангах хэмжээнд хараахан хүрэхгүй байгаа, хүн амын дийлэнх хэсэг ядууралд өртсөн, баян хоосны ялгаа хэт ихэссэн, эдийн засгийн цөөн бүтэцтэй, тодорхой хэдэн салбарууд хөгжсөн, дэлхийн зах зээлийн үнэ, ханш, импортоос хэт хамааралтай, гадаадын хөрөнгө оруулалт цөөн хэдэн орноос хамааралтай зэргийг тодорхой тоон мэдээлэлд тулгуурлан авч үзлээ.

- Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

Энэ зорилтын өнөөгийн байдал: Сүүлийн жилүүдэд манай улсын эдийн засгийн төрөлжилт нь уул уурхайн салбараас хамааралд хумигдах хандлагатай болсон. Өөрөөр хэлбэл уул уурхайгаас төсвийн орлого хэт хамааралтай болсон төдийгүй эдийн засгийн өсөлт дундаас доош түвшинд хүрч чадахгүй, харин ч эсрэгээр хүнд ачаа болж байна. Олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох талаар хэдийгээр төрөөс баримтлах бодлого, баримт бичгүүдэд тусгасан хэдий ч үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого тодорхойгүй хэвээр байна.

2011 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ гурван мянга ам.долларт, 2012 оны урьдчилсан байдлаар гурван мянга таван зуу орчим ам долларт хүрсэн байна. Гэвч энэхүү өсөлт нь шууд мэдрэгдэж чадахгүй хэвээр байна. Мэдээж уул уурхайн үйлдвэрлэл өсөхийн хэрээр үйлчилгээний салбарт эрчимтэй өсөлт гарсан хэдий ч аялал жуучлал, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт дорвитой өсөлт ажиглагдсангүй. Ажлын байр уул уурхайн салбарт өсөж байгаагаас бусад салбарт ахиц гарсангүй.

Хүснэгт: 3.1 **Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ**
сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2008	2009	2010	2011	2012-III
Нийт дүн	2 862 573,2	2 975 639,9	4 086 625,0	5 027 752,0	4 072 40366
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1 847 547,4	1 947 227,0	2 835 149,7	3 500 745,8	2 744 978.3
Боловсруулах аж үйлдвэр	759 176,2	734 561,4	878 367,9	1 118 357,2	1 004 454.2

[8] “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд” Ц. Даваадорж /Ph.D/)

Үүнээс: Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	284 993,0	356 222,1	454 437,7	503 476,2	409 051.6
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	198,2	169,9	211,4	31 008,5	65 231.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	59 278,9	47 342,7	61 648,0	86 593,7	85 383.6
Төмрийн үйлдвэрлэл	165 008,2	65 751,0	87 961,9	104 649,0	124 407.0
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	7 422,2	5 906,1	15 383,7	22 083,3	20 479.1
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	2 869,6	2 642,9	1 524,1	2 493,5	5 761.4
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	8 107,2	6 429,9	9 149,3	11 868,3	10 441.4
Цахилгаан, дулаан эрчим хүчний үйлдвэрлэл	255 849,6	293 851,4	373 107,4	408 649,1	322 971.1

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн дийлэнх хувь буюу 69 орчим хувийг уул уурхай, олборлох салбарын бүтээгдэхүүн, боловсруулах аж үйлдвэрийн салбар нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 22 орчим хувийг эзлэж байгаагаас харахад манай улсын хувьд олон тулгуурт эдийн засгийг бүтцийг бий болгох шаардлагатай байгаа харуулж байна.

Цаашид эдийн засгаа дархлаажуулах, боловсруулах үйлдвэрлэлийн салбар, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг бусад салбарыг хөгжүүлэх талаар төрөөс тодорхой бодлогыг хэрэгжүүлэх, уул уурхайн салбараас хэт хараат байгаа өнөөгийн нөхцөлөөс аажим аажимаар гарах алхамуудыг хийх нь олон тулгуурт эдийн засаг хөгжих нэг хөшүүрэг юм.

Хүснэгт 3.2 Эдийн засгийн өсөлт

	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012
ДНБ оны үнээр /тэрбум төг/	6555.6	6590.6	8414.5	10829.7	13 944.2
ДНБ-ны өсөлт	8.9	- 1.3	6.4	17.3	12.3



(Зураг 3.1. Эдийн засгийн өсөлтийг 2000 - 2012 оны хооронд авч үзвэл)

- Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна.

Манай улсын хувьд эдийн засгийн бие даасан байдлыг бий болгох, хамгаалах зайлшгүй шаардлагатай хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эд, түлш, эрчим хүчээр өөрийн хэрэгцээг хангаж чадаагүй, импортоосоо хамаарсан хэвээр байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд манай улсын хувьд уул уурхайн салбарын хөгжлөөс хамаарч, эдийн засаг өсөлттэй, нэг хүнд ногдох ДНБ -ний хэмжээ өндөр байгаа хэдий ч зөвхөн түүхий эдийн экспортод түшиглэсэн, үнийн өөрчлөлтөд эмзэг эдийн засгийн өрөөсгөл, цөөн орны зах зээл, дамжин өнгөрөх тээврээс хараат байна.

2010 онд экспортын бүтээгдэхүүний 81.3 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлсэн, экспортын 70 гаруй хувь нь БНХАУ-д гарсан бол 2011 оны байдлаар экспортын бүтээгдэхүүний 89.2 %-ийг, 2012 оны эхний 11 сарын байдлаар 90 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн тус тус эзлэж байна. Статистик мэдээллээс харахад экспортод гарсан нийт уул уурхайн бүтээгдэхүүний 92%-ийг нь БНХАУ-д экспортлосон байна.

Зураг 3.2 Экспортод гарч буй эрдэс бүтээгдэхүүн
(2009 - 2012 оны XI сарын байдлаар, сая.ам.долл)

Гэвч уул уурхай, олборлох салбараас бий болсон орлогын хувьд дээрх зорилтод дурьдсанчлан хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлд зарцуулахаас илүүтэйгээр нийгмийн халамжийн салбарт түлхүү зарцуулсан болно. Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд, түүний дотор хэрэглээний үнийн индекс, инфляц нь түүхий эдийн экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэн худалдааны үнээс хамааралтай, бизнесийн орчин таатай бус, үнийн зохиомол өсөлт бий болгож байгаа нь тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг агуулж байна.

- Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас ядуурлын үнэлгээ дээр үндэслэн ядууст чиглэсэн чиг баримжаатайгаар эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах бодлогын шинэчлэлүүдийг дэс дараатай хэрэгжүүлж байна. Цаашид ч Засгийн газар хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг түргэтгэж улмаар хүн амын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор макро эдийн засгийг тогтворжуулж, инфляцийг тогтвортой бөгөөд доогуур түвшинд байлгах, зах зээлийн шударга өрсөлдөөнийг хөгжүүлэх, мөнгө зээл, татварын механизмыг оновчтой ашиглах бодлогыг хэрэгжүүлж байна.

Эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон баялгийг хүн амын дунд зохистой хуваарилах, ялангуяа ядууст чиглүүлэх нь ядуурлыг бууруулах стратегийн үндсэн зорилтын нэг юм. Гэхдээ энэхүү хуваарилалт нь ядуучуудад хөрөнгийг шууд хуваарилах арга замаар бус ядуучууд, ядуурлын ирмэгт ойрхон байгаа хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, тэдгээрийн өөрсдийнх нь идэвхи санаачлагыг дэмжих замаар амьжиргааны түвшинг нь дээшлүүлэхэд чиглэгдэнэ. Иймд 3.2.1.9 -д дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ гэж заасан байгаа. Хөдөлмөрийн орлого нь амьдралын гол эх үүсвэр байхаас гадна, иргэдээ санхүүгийн зах зээлд оролцуулж хөрөнгийн болон, арилжааны нэмэгдэл орлоготой болгох явдал чухал.

Зураг 3.3 Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилтын хүрээнд

Зураг 3.3-с үзэхэд эдийн засгийн өсөлт өндөр байхын хэрээр хүн амын ядуурлын түвшин багасах хэдий ч 2002 оноос хойш ядуурлыг түвшин тогтмол байдлаар өссөн байхаад эдийн засгийн өсөлтийн хувьд харьцангуй өөрчлөлттэй басйан байна. Эндээс манай улсын хувьд эдийн засгийн өсөлтийн хувь нь хэдийгээр өссөн ч хүн амын ядуурлын түвшин буурахгүй тогтмол өссөлттэй байна. Улс төр, нийгмийн салбарын хүрээнд бүтцийн өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлсэн нь эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн хүчин зүйл болсон төдийгүй эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих бас нэг хүчин зүйл юм.

Хувийн хэвшлийн идэвхитэй оролцоо болон экспортод чиглэгдсэн гадаад худалдааны бодлогод тулгуурлан эдийн засгийн өндөр өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулахыг Засгийн газар зорьж байна. Эдийн засгийн өсөлтийг бүсчилсэн хөгжил болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан хэрэгжүүлнэ. Мөн эдийн засгийн өсөлт, хүний тогтвортой хөгжлийг хангахад макро эдийн засгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалт, хүний хүчин зүйлийн хөгжил чухал үүрэг гүйцэтгэнэ.

2.2. Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого

Манай орны хөрөнгийн хомсдолтой эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй хэвээр байна. Төр засгаас эрчимтэй бодлого явуулсны үрээр манай улсад хийгдэж буй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд их өсчээ. 1990-2012 он хүртэл дэлхийн 110 орны 11642 гадаадын хөрөнгө оруулалттай компани бүртгэгдсэн байна. Эдгээр компаниуд 2011 оны байдлаар 4,986 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн ба үүний 80%-ийг 2006 - 2010 онд хийжээ[9]. 2009 онд гадаадын 613 компани 801 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж байсан бол энэ тоо 2010 онд 1,025 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гэвч орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалтыг манай улс үр өгөөжтэй ашиглаж чадаж байна уу, “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан эдийн засгийн аюулгүй байдлын зорилтуудыг хангаж чадаж байгаа юу гэдэг дээр шүүмжлэлтэй асуудлууд гарсаар байна. Иймээс гадаадын хөрөнгө оруулалтад холбогдох заалтуудын хүрээнд дараах асуудлуудыг тодруулан авч үзлээ.

- Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалт нь шинэ технологийг нэвтрүүлэх чухал арга болсоор иржээ. Олон улсын корпорациуд нь ихэвчлэн дэвшилтэт технологийн уурхай байдаг бөгөөд тэд хөгжилтэй орноос буурай орнууд руу ноу-хауг нэвтрүүлж, ингэснээр тухайн орны дотоодын үйлдвэрлэл технологийн дэвшилд түлхэц өгч, өрсөлдөөнийг идэвхижүүлэх гол хүчин болдог байна. Иймд гадаадын хөрөнгө оруулалтын үр ашгийн нэг чухал асуудал нь түүний дотоодын хөрөнгө оруулалтыг хэр идэвхижүүлж, өрсөлдөөнийг бий болгож буйгаар нь тодорхойлогдоно. Харин манай оронд энэхүү үр ашиг төдийлэн биелэлээ олж чадахгүй байна.

2005 - 2010 оны дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын дүн, тэдгээрийн харьцааг хүснэгт 1-д авч үзвэл:

Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрээр, оны үнээр

	Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг					
	2005	2006	2007	2008	2009	2010
Дотоод	321,8	417	778,5	950,5	843,2	1038,5
Гадаад	394,5	464,3	474,3	834,6	1303	2332,2
Хөрөнгө оруулалтын харьцаа	8,2	9	16,4	11,3	6,4	44,5

2005 - 2010 онд дотоодын хөрөнгө оруулалт жилд дунджаар 12,6 хувиар гадаадын

[9] http://investmongolia.com/fiftanew/contents/inc.googledocviewer.php?file

хөрөнгө оруулалт 14,2 хувийн өсөлттэй байгаа ба 2005-2008 он хүртэл дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх онуудаас өссөн, харин 2009 онд 2008 онтой харьцуулахад 18 хувийн бууралттай байна. Энэ бууралт 2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас болгоомжлон манай иргэдийн хадгаламжийн болон хөрөнгө оруулалтын сонирхол буурснаас үүдэлтэй байж болох юм. Харин 2010 онд өмнөх оноос 23 хувиар, 2008 оноос 9,3 хувиар өссөн нь Монгол оронд яригдаж байгаа томоохон төслүүдтэй холбоотой байж болох юм. Үүнийг нотлохын тулд хөрөнгө оруулалтын бүтцийн өөрчлөлтийг графикаар харуулав.

Доорхи графикаас харахад Монгол улсын хөрөнгө оруулалтын санхүүжилтийн бүтэц нь 2008 онд дотоодын эх үүсвэр давамгайлж (нийт хөрөнгө оруулалтад эзлэх дотоодын хөрөнгө оруулалтын 53,2 хувь) байсан бол түүнээс хойш гадаадын хөрөнгө оруулалтын хувийн жин ямагт нэмэгдэж ирсэн байна. Энэ нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ ижил түвшинд, харилцан өрсөлдөхүйц хэмжээнд байж чадахгүй байгааг харуулж байна. Хөрөнгө оруулалтын бүтцийг үзвэл гадаадын хөрөнгө оруулалт дотоод өрсөлдөөнийг эрчимжүүлж, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн зүйл ажиглагдахгүй байна.



Гадаадын хөрөнгө оруулалт үндэсний үйлдвэрийн бааз суурийг дэмжихгүй байгаа явдал алсдаа манай эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалтаас шууд хараат болох хандлага руу хөтөлж байна. 2010 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулалт дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хоёр дахин их буюу хүснэгт 1 -д харуулсан хөрөнгө оруулалтын харьцаа /Гадаадын хөрөнгө оруулалтын дүнг дотоодын хөрөнгө оруулалтын дүнд харьцуулсан харьцаа/-аас харахад тус онд дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ гадаадын хөрөнгө оруулалтын 44,5 хувьтай тэнцэж байна. Дээрхээс харахад ямар нэгэн шалтгаанаар гадны хөрөнгө оруулалт зогсвол манай улс эдийн засгийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах чадваргүй байгаа нь харагдаж байгаа юм.

Үзэл баримтлалд «Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн» гэжээ.

Эдийн засгийн бие даасан байдал гэдэг нь хөрөнгө оруулалтын талаас авч үзвэл ирээдүйд илүү их ашигтай ажиллахын тулд, мөн эрхэлж буй үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахын тулд оруулж буй томоохон хөрөнгө оруулалт нь гадны оруулах хөрөнгөнөөс хамааралтай бус зөвхөн дотоодын оруулж буй хөрөнгө оруулалтаар хэмжигдэх асуудал гэж ойлгож болох юм. Хүснэгт 1-ээс харахад хөрөнгө оруулалтын харьцаа /гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг дотоодын хөрөнгө оруулалтад харьцуулсан харьцааг хөрөнгө оруулалтын харьцаа гэж тодорхойлов/

2007 онд 164,1 хувь буюу дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ гадаадын хөрөнгө оруулалтаас 1,6 дахин их, 2008 онд 1,1 дахин их, бусад онуудад 100 хувиас бага байна. Энэ үзүүлэлт 2010 оны байдлаар 44,5 хувь буюу дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ гадаадын хөрөнгө оруулалтын дөнгөж 44,5 хувьтай тэнцэж буйг илтгэж байна. Нэг ёсондоо хөрөнгө оруулалт гадныхнаас хамааралтай болж байгааг харуулж байна. Энэ хүрээнд дараах асуудлыг харгалзан үзэхийг зөвлөмж болгож байна.

1. Эдийн засгийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын шалгуур үзүүлэлтэд хөрөнгө оруулалтын харьцаа /дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнд харьцуулж хувиар тооцсон тооцоо/-г оруулах хэрэгтэй. Энэ харьцаа 100 хувиас хэтрэхгүй байх бодлого барих нь зүйтэй.

2. Зөвхөн гадаадын хөрөнгө оруулалт хэмээн туйлшрахгүйгээр хөрөнгө оруулалтын асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна. Энэ нь хууль эрхзүйн хүрээнд зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль бус Монгол Улсын хөрөнгө оруулалтын тухай хууль гэсэн нэгдсэн хуультай болохыг шаардаж байна.

- Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

Судалгаанаас үзэхэд 2010 онд шинэчлэн баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3-р бүлэгт эдийн засгийн аюулгүй байдал, бие даасан байдлаа хангаж хөгжих, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах гэх мэтийн үзэл баримтлалуудыг тодорхойлсон боловч стратегийн ач холбогдолтой салбаруудыг нарийвчлан тогтоосон, үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд нийцүүлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэрт байдал, стратегийн ач холбогдол бүхий салбарт баримтлах хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон тодорхой хуулийн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм хангалттай биш байна.

Монгол улсын эдийн засгийн эмзэг бүтэц, гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, тодорхой салбарт чиглэгдэж байгаа байдал, хөрөнгө оруулалт хийж буй арга механизм, ирээдүйд гарч болзошгүй үр дагаврыг харгалзан үндэсний аюулгүй байдалд хамааралтай зарим салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг татахдаа дэлхий нийтээр дагаж мөрдөж байгаа хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэлтийн гэрээний стандарт, шууд бус хязгаарлалтын арга хэрэгсэлүүдийг ашиглах, илүү нээлттэй, хяналттай хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх шаардлагтай болох нь судалгаанаас харагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох, хязгаарлахдаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах эерэг, тааламжтай нөхцөлийг алдагдуулахгүй байх, Монгол улсын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эерэг үнэлэмжийг бууруулахгүй байхаар тооцож зохицуулалт хийх шаардлагатай байна.

Манай улсын хувьд уул уурхайн салбар нь стратегийн ач холбогдолтой байдаг бөгөөд уул уурхайн салбар дахь аливаа эрсдэлүүд үндэсний аюулгүй байдал шууд нөлөөлөх хандлагатай байна. Иймээс стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай хууль гаргасан. Гэвч хуулийг хэн, хэрхэн хэрэгжүүлэх, шийдвэр гаргах горимын талаарх асуудлууд анхаарлыг ихэд татаж байгаа. Учир нь хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зөрчил үүсгэж болзошгүй

заалтууд нэлээд орсон байгаа. Тухайлбал,

1. Хэрэгжүүлэлт, зохион байгуулалт тухайд Монголын аж ахуйн нэгжийн гуравны нэгт хүргэж болзошгүй аливаа хэлцэл Засгийн газраар шийдүүлэх шаардлагтай гэж тооцвол маш их ажиллагаа орно. Үүнд төрийн захиргааны байгуулагын хүн хүчний хүрэлцээний асуудал гарч ирнэ. Мөн Засгийн газар гэдэг нь асуудал эрхэлсэн чиглэлийн байгууллага уу, эсхүл засгийн газрын бүрэлдэхүүн үү, гэх мэт яг шийдвэр гаргах субъект нь тодорхойгүй байгаа юм.
2. Шийдвэр гаргах шалгуурууд хэмжигдэхүйц бус, барьцгүй байгаа тул үзэмжээр шийдэх боломж олгож байгаа нь гадныхны хувьд бүрхэг орчин үүсгэж хөрөнгө оруулалт, тоглоомыг дүрмийг тодорхойгүй болгож байна.
3. Хуулинд татвар хураалтын талаар заалт орсон байгаа нь нэгт, эрх зүйн үүднээс татварын багц хуулинд тусгагдаж байж хүчин төгөлдөр болно, хоёрт, Монголын нутаг дэвсгэрт бүртгэлгүй хуулийн этгээд монголын татварын хуульд захирагдан Монголд татвар төлөх олон улсын эрх зүйн үндэслэл байхгүй.
4. Гадаадад гадаад субъектууд хооронд хэлцэл хийж байхад Монголоос хяналт тавих боломж хомс. Тухайлбал, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа компани нь зөвхөн шууд хөрөнгө оруулсан толгой компанийн өмнөөс тодорхой хэмжээний хариуцлага хүлээж болохоос толгой компанид нь дээш хэд хэдэн шат дамжсан хөрөнгө оруулагчдын өмнөөс хариуцлага хүлээх боломж байхгүй.
5. Стратегийн гэгдэж байгаа салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын дийлэнх нь олон улсын бирж дээр нээлттэй арилжаалагдаж байгаа компаниуд байдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын сангуудаар дамжин хувьцаа эзэмших эцсийн этгээд нь тархай бутархай иргэд байх боломжтой, өдөр тутам хэдэн мянгаар хийгдэж байгаа арилжаанд хяналт тавих боломжгүй юм.
6. Бас нэг анхаарах зүйл бол том хувьцаа эзэмшигч нь хуулийг дагаж мөрдөөгүйгээс болж Монголд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход ямар ч гэм буруугүй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх болно. Үүнээс үүдэн Монголын засгийн газрыг шүүхэд өгөх тохиолдол олноор гарах боломжтой.

Гарч болзошгүй сөрөг үр дагавар

Хуулийг хэрэгжүүлэхдээ дээрх дурдсан зүйлсийг харгалзан үзэж шийдвэрлэхгүй бол анх зорьсон үр дүн бус харин сөрөг үр дагавар давамгайлах боломж бүрдэнэ. Тухайлбал,

- Тодорхойгүй учир эрсдэл нэмэгдэнэ, улмаар стратегийн салбар луу орох хөрөнгө оруулалтын хэмжээ буурч улмаар санхүүжилтийн өртөг өснө.
- Жижиг бөгөөд анхан шатны уурхайн төслүүд санхүүжилт олдохгүй байх магадлал нэмэгдэнэ, учир нь Монголын дотоодын санхүүгийн зах зээл банк давамгайлсан, уул уурхайн салбарт гаргах зээлийн хэмжээ хязгаарлагдмал, мөн баталгаа хөрөнгө, барьцаа байдаггүй тул хайгуулын шатны төслүүдийг банкнаас санхүүжүүлэх боломжгүй байдаг.
- Олон улсын уурхайн бизнесийн хөгжлийн үе шатыг судлаж үзвэл хайгуулын шатанд эрсдэл даах чадвартай, энэ талын туршлага ихтэй нарийн чиглэлийн компаниуд анхны хөрөнгө оруулалт хийж хайгуул явуулдаг бөгөөд нэгэнт нөөц нь тогтоогдоод олборлолт явуулах боломжтой болоход өөрсдөө гарч, олборлох үйл ажиллагаагаар дагнасан талд худалдах замаар хөрөнгө оруулалтынхаа ашгийг хэрэгжүүлдэг. Энэ шат дамжлага дээр төрийн зүгээс хориг, хязгаарлалт тавигдах нь анхны хөрөнгө оруулагч нарт гарцыг нь хумиж байгаа тул хөрөнгө оруулахгүй байх магадлал нэмэгдэж байгаа юм.

Эдгээр асуудлыг хуулийг хэрэгжүүлэх шатандаа анхаарч зөв шийдвэрлэж байж стратегийн ашиг сонирхолоо хамгаалахын зэрэгцээ эдийн засгийнхаа хөгжлийг авч үлдэх боломжтой болох нь. Манай улсын хувьд энэ хуулиар Гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж, хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлсэн боловч өнөөдрийн байдлаар эдийн засагт хангалттай хэмжээний өсөлтийг бий болгож чадахгүй байна.

Улсын хэмжээнд 60 гаруй хувийг эзэлж буй гадаадын хөрөнгө оруулалт нь чухам аль салбарт орж байна вэ. эдийн засагт үр өгөөжөө өгөх, дотоодын хөрөнгө оруулагчдад өрсөлдөөнийг бий болгохуйц чиглэлд хийгдэж чадаж байна уу гэдэг асуудал хөндөгдөж байна. Монгол Улсын ҮАБ-ын Үзэл баримтлалд тусгаснаар «Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно» гэжээ.

Алсдаа улс орны хөгжил бий болох үндэс нь дотоодын түүхий эдээ экспортлох бус түүнийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бэлэн бүтээгдэхүүн болгох. өөрөөр хэлбэл, боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх явдал юм. Гэтэл манай оронд хийгдэж буй гадаадын хөрөнгө оруулалт зарим талаар өрөөсгөл байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/ -ын хичнээн хувь нь аль салбарт орж байгааг хавсралтад байгаа хүснэгтээр харууллаа.

2011 оны байдлаар Монгол Улсад гадаадаас орж ирж буй нийт хөрөнгө оруулалтын 74 хувь нь уул уурхайн салбарт оржээ. Эдийн засгийн үндсэн салбаруудаа гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нь түүнийг татах нэгэн чухал асуудал боловч манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох, эрсдэлийг тооцох, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан цогцоор авч үзэхэд анхаарах нь зүйтэй байна.



Графикаас харахад манай улсын хөгжлийн үндэс болох салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийгдэж чадахгүй байна. Аливаа улс орон, гадаадын байгууллага манай улсад хөрөнгө оруулалт хийж байна гэдэг бол манай оронд ашигтай гэдэгт онцолж бус зөвхөн хувийн эрх ашгийн үүднээс хандаж байгаа нь ойлгомжтой. Харин манай улс тэрхүү ашиг сонирхолд нь дөрөөлж өөртөө өгөөжийг нь хүртэх явдал чухал юм.

Манай улсад 1990 оноос одоог хүртэл хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн эхний улсыг оруулсан хөрөнгийнх нь нийт гадаадын хөрөнгө оруулалтад эзлэх хувиар нь хүснэгтээр харуулбал:

№	Улсын нэр	%	Total	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
1	БНХАУ	49.28	5,737	1,534	532	827	876	859	299	376	434
2	БНСУ	18.00	2,095	632	203	274	332	302	113	117	122
3	ОХУ	6.90	803	433	54	105	72	51	37	17	34
4	Япон	4.17	486	190	29	56	60	58	35	23	35
5	АНУ	2.38	277	98	19	28	27	44	11	14	36
6	Виржини арлууд (UK)	1.87	218	27	9	12	26	17	23	37	67
7	Герман	1.55	180	102	10	18	13	13	8	7	9
8	Сингапур	1.32	154	52	9	5	10	21	4	22	31
9	Вьетнам	1.32	154	25	14	34	46	21	3	8	3
10	БНХАУ / Гонконг/	1.28	149	54	9	5	10	14	10	27	20

Эдгээр улсуудын манай оронд оруулах гадаадын хөрөнгө оруулалтын урсгал жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2007 онд 36,4 хувь, 2008 онд 41,8 хувь, 2009 онд 13,0 хувь, 2010 онд 26,3 хувиар тус тус өмнөх оныхоос өссөн байна.

(Гадаадын хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь хэмжээ)

2010 онд бүртгэгдсэн хөрөнгө оруулалтыг улс орноор авч үзвэл Нидерланд улсаас 233,0 сая, БНХАУ-аас 173,3 сая, Канадаас 147,8 сая, Бермудаас 114,5 сая, Их Британийн Виржин арлуудаас 101,7 сая, Хонгконгоос 79,6 сая, БНСУ-аас 38,7 сая, Сингапураас 31,0 сая, Люксембургаас 25,6 сая ам.долларын хөрөнгө оруулалт гэх зэрэг нийт 59 орноос 1011,6 ам долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна. 2010 онд бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өмнөх оны жилийн эцсийнхээс 26,3 хувиар өссөн ба сүүлийн 5 жилийн дунджаас 1,9 дахин, 1990-2009 онуудад бүртгэгдсэн нийт хөрөнгө оруулалтын дунджаас 5 дахин буюу 530 хувиар өссөн байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дотоодын 67 мянган боловсон хүчнийг ажлын байраар хангасан бөгөөд 2500 гаруй гадаадын мэргэжилтнүүд Монгол улсад ажиллаж удирдлагын шинэ шинэ арга технологийг нэвтрүүлсэн нь маш том оюуны хөрөнгө оруулалт юм. Caterpillar, Samsung, Sumitomo, Coca Cola, Itochu, Komatsu, Hyundai, Procter & Gamble, Ford, Mercedes-Benz болон бусад дэлхий дахинд алдаршсан томоохон корпорациуд Монголд үйл ажиллагаа явуулж байна. Уул уурхай, аялал жуулчлал, дэд бүтэц болон газар тариалан зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтын томоохон салбарууд болоод байна. Төр засгаас 2002 оныг “Хөрөнгө оруулалтыг сурталчлах жил” болгон зарласан бөгөөд үүний зорилго нь уул уурхай, газар тариалангийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах, аялал жуулчлал болон мэдээллийн технологийн зэрэг голлох салбаруудад хийгдэх хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд оршиж байв.

Эдгээрийг нэгтгэж товчлон дүгнэхэд манай улсын эдийн засгийн нөхцөл байдалд дараах дүр зураг харагдаж байна.

- Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортоос хамааралтай. Түүхий эдийн экспорт голлосон.
- Байгалийн баялаг, гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналт алдагдсан. Үндэсний үйлдвэрлэл, хөлөдмөрийн нөөц доройтсон. Үнийн өсөлтөд өртөмтгий, хэт өрөөсгөл бүтэцтэй
- Эдийн засгийн бие даасан байдал хангагдаагүй, стратегийн хүнс бараагаар өөрийгөө хангаж чадахгүй. Гадаад зах зээл хөрш орнуудаасаа хэт хамааралтай.
- Геопоилтитикийн эрсдэлтэй. Байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөний талбар болсон.
- Монгол Улсын үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд борлуулахдаа гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлээр баримтлах бодлогын зарчим алдагдахгүй байх эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

Энэ талаар хийгдэх ёстой ажлууд дөнгөж эхлэлийн шатандаа явж байгаа тул одоогоор ямар нэг үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна. Гэхдээ үүнд холбогдох эрхзүйн орчноо бүрдүүлэхээс өмнө улс төрийн шинж чанартай алхамууд хийж эхлэсэн нь цаашид хүндрэл үүсгэж болзошгүй байна. Үүнд жишээ болгон Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах хэтийн зорилго төлөвлөгөө болон тус ордтой холбоотойгоор эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг дурьдаж болох юм.

Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно. Хөрөнгө оруулалт нь хөгжлийн зардал болж байдаг тул өсөн нэмэгдэж буй гадаадын хөрөнгө оруулалт нь манай орны нэмүү өртөг бүтээх үйл явцад маш чухал хувь нэмэр оруулж байх учиртай. Энэ үүднээс хөрөнгө оруулалтын өгөөжийг илэрхийлэх үзүүлэлтийг гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг ДНБ-д харьцуулсан харьцаагаар тооцож үзэв.

ГШХО-ын өгөөж /ДНБ болон ГШХО- ын харьцаа/ -г авч үзэв. Хүснэгт 2-т тооцоолсноор гадаадын хөрөнгө оруулалтын өгөөж 2008, 2009, 2010 онд өмнөх онуудаас буурсан ба 2010 оны байдлаар гадаадын нэг төгрөгийн шууд хөрөнгө оруулалтын үр дүнд ойролцоогоор гурван төгрөгийн нэмэгдэл өртөг бий болсон байна. Энд анхаарал татсан нэг асуудал нь 2005-2010 оны хооронд ДНБ жилд дунджаар 121,15 хувийн хурдтай өссөн байхад ГШХО илүү их хурдтайгаар буюу жилд дунджаар 157,56 хувиар өсчээ. Ийм байхад өгөөж нь буураад байгаа нь ГШХО их хэмжээгээр орж ирсэн ч үр дүн муутай буюу нэмүү өртөг үйлдвэрлэх салбарт орж чадахгүй байгааг харуулж байна.

SUDALGAANY SAN

Үр дүнтэй ашиглахын тулд аль салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих вэ? Хэтдээ хөгжлийг бий болгох /боловсруулах аж үйлдвэр/ салбарт түлхүү чиглүүлэх нь зүйтэй. ҮАБ-ын Үзэл баримтлалд эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжихийг чухалчилж үзсэн байна. Энэ нь эцсийн дүндээ боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж дотооддоо хэрэглээгээ хангаад зогсохгүй дэлхийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахын нэр юм.Хөрөнгө оруулалт их хэмжээгээр орж ирсэн сүүлийн таван жилийн хугацаанд манай орны боловсруулах аж үйлдвэрлэлийн ДНБ -д эзлэх хувийн жинд өөрчлөлт ороогүй, 5-6 хувьтай хэвээр байна. Эндээс үзэхэд боловсруулах аж үйлдвэрийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт чиглэгдэхгүй байгаа нь харагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн үр өгөөжтэй салбарт ашиглахын зэрэгцээ дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, энэ салбарын хөгжилд гол үүрэг гүйцэтгүүлэхэд төр засгийн зүгээс чухлаар анхаарч. үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нөхцөл байдлыг бий болгох. зуучлагчийн үүрэг /тоног төхөөрөмж, шаардлагатай үр тариа гэх мэтийн биет хөрөнгийг бусад улс орноос дотоодын үйлдвэрлэгчиддээ хангаж өгөх/-ийг гүйцэтгэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.
ГШХО -ийн өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төр засгийн зүгээс гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа үр дүнтэй ашиглах явдал маш чухал. Манай улс эдүгээ 150 оронтой дипломат харилцаатай, олон улсын засгийн газар хоорондын 54 байгууллагын гишүүн, олон талт 240 орчим гэрээ, конвенцэд нэгдээд байна. Өнөөгийн байдлаар манай улс бусад улс оронтой 3000 орчим хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулжээ. Монгол улс хоёр талын шугамаар 34 улстай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр байгуулан ажиллаж байна.

Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хамгаалах зорилгын-хоо хүрээнд дэлхийн болон бүс нутгийн зарим гүрэнтэй ойр дотно түншлэлийн харилцаа хөгжүүлж ирлээ. Сүүлийн жилүүдэд гадаад улстай байгуулсан ийм төрлийн хамтын ажиллагааг дурдвал:

- Гадаад бодлогын дээрх зорилт биеллээ олбол манай эдийн засгийн гадаад нөхцөл улам ч сайжрах нь лавтай. Энэ боломжийг ашиглан алсдаа хөгжлийг бий болгох чиглэлд түлхүү харилцан, хамтран ажиллаж, дотоодын хөрөнгө оруулагчдыг үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай материаллаг болон материаллаг бус эд зүйлээр хангаж өгөх нь төрийн үүрэг юм.

- Хөрөнгө оруулалтын үр ашиг буураад байгаа нь аль болох өгөөжөө өгөх салбарт чиглэгдэхгүй, мөн тухайн хөрөнгө оруулалт төдийлөн үр ашигтай байж чадахгүй байгааг харуулж байна. Гадаад улс орнуудтай хамтын ажиллагаатай ажиллахын чухал шаардлага нь тэдгээр улстай харилцан хамтарч Монгол орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах билээ. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй байлгахын тулд гадаад харилцаандаа түшиглэн улс орнуудтай тодорхой чиглэлд хөрөнгө оруулж, хөгжүүлэх бодлого баривал сайн.

Судалгааны үр дүнгээс харахад гадаадын хөрөнгө оруулалт орж буй салбарын хувьд нэлээд өрөөсгөл байгаа нь харагдаж байна. Иймд өөрийн орны нөөц, боломжид тулгуурлан хөрөнгө оруулалтыг /ялангуяа дотоодын хөрөнгө оруулалтыг/ үр ашигтай хуваарилах, тэрхүү нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй ба боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх нь чухал байна. Боловсруулах үйлдвэрийн салбар нь ажиллах хүчийг нэлээд их хэмжээгээр шаарддаг төдийгүй бодлогоо чанартай, зөв хэрэгжүүлж чадвал давхар ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэх боломж байгаа юм.

№	Салбарын нэр	%	Total	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	73.7	7,241,934.93	493,972.74	183,961.91	195,390.34	336,985.65	485,189.08	643,454.56	819,762.15	4,083,218.51
2	Худалдаа, нийтийн хоол	15.6	1,534,269.95	162,764.31	53,376.62	103,388.43	111528.37	187,447.85	132,636.45	162,560.01	620,567.90
3	Бусад	4.47	439,002.33	92,880.36	52,884.35	47,739.57	13,882.50	6,875.86	3,510.34	14,012.70	207,216.65
4	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	1.58	155,514.91	67,105.46	9,671.09	11,982.63	21,936.52	4,495.96	3,219.31	12,979.37	24,124.58
5	Хөнгөн үйлдвэр	1.10	108,007.40	85,001.91	1,792.13	1,454.22	1,205.34	18,208.00	92.82	153.75	99.24
6	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	0.81	79,494.74	55,237.94	772.73	1,791.75	4,273.45	1,894.74	9,366.55	980.10	5,177.47
7	Мэдээлэл, холбооны технологи	0.46	45,080.42	19,623.03	6,267.60	480.86	6,916.70	1,442.57	1,252.80	125.00	8,971.86
8	Аялал жуулчлал	0.42	41,022.85	13,028.04	1,490.23	1,637.36	486.70	1,365.63	491.34	371.40	22,152.15
9	Тээвэр	0.36	35,413.79	20,951.90	933.33	24.60	657.15	174.13	2,406.20	2,892.00	7,374.49
10	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	0.27	26,571.47	15,297.57	303.96	1,424.37	710.00	100.50	298.08	3,850.00	4,586.98
11	ХАА, газар тариалан, МАА	0.16	15,367.78	9,305.76	2,787.10	362.60	208.43	1,242.38	504.15	403.36	554.00
12	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	0.15	15,099.45	10,656.24	12.99	391.47	67.00		3,495.61	60.48	415.65

UHAM
СУДАЛГААНЫ САН

13	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	0.14	13,396.95	4,011.72	56.30	5.25	395.00	101.00	430.12	7,492.00	905.55

2.3. Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлын эрсдэл

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын энэ бүрэлдэхүүн хэсгийг хангахад 5 заалтыг тусгасан ба эдгээр заалтуудын хүрээнд төсөв, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, цаашид үүсч болзошгүй эрсдлийг тодорхойлохыг зорилоо. Энэхүү үнэлгээг хийхдээ тус судалгааны үндсэн үнэлгээний индикаторууд /Глазьевийн аргачлал/ дээр нэмж манай улсын хууль, журам заавар, бодлогын хүрээнд санхүүгийн салбарын тогтвортой байдал болон төсвийн тогтвортой байдалд тавьж байгаа шалгууруудаар тооцлоо.

Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд

Аливаа улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь тухайн улс орны хөгжлийн гол үзүүлэлтийн нэг байдаг. Санхүүгийн тогтвортой байдал гэдэг нь үнэ тогтоох, нөөц хуваарилах, санхүүгийн эрсдэлийг удирдах зэрэг эдийн засгийн тогтолцоонууд нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн байхаас гадна зах зээлийн гэнэтийн таагүй нөлөөлөл, хямралын үед мөн адил ажиллах чадвартай байхыг хэлэх бөгөөд ерөнхийдөө тухайн улсын санхүүгийн системийн найдвартай байдлыг санхүүгийн тогтвортой байдал гэж ойлгож болох юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, урт хугацааны өсөлт хөгжлийг дэмжих эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ” гэж заасан ба энэ заалт хэрхэн хангагдаж байгааг санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдээр үнэлэв.

Өнгөрсөн хугацаанд гарч байсан олон улсын банк, санхүү, эдийн засгийн хямралууд нь санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцоолох шаардлагыг бий болгосон бөгөөд ОУВС-аас санхүүгийн системийн тогтвортой байдал, түүнийг хүчирхэгжүүлж хяналт тавих, үнэлгээ хийхэд туслах зорилгоор санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тооцдог аргачлалыг боловсруулан гаргасан. Энэ аргачлалаар санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь:

1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
2. Хөрөнгийн чанар
3. Ашигт ажиллагаа
4. Хөрвөх чадвар
5. Зах зээлийн эрсдэлийн мэдрэмж гэсэн үндсэн 5 бүлгээс бүрдэнэ.

Түүнчлэн, төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд явуулах бодлогын ажлуудыг тодорхойлон гаргаж байгаа ба 2012 оны бодлогын баримтанд тусгагдсан зорилтын хэрэгжилтүүдийг доор холбогдох заалтад нь хамруулан тайлбарыг оруулсан болно. Монгол улсын хувьд санхүүгийн зах зээлийн 95.3 хувийг банкны салбар эзэлдэг тул санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтийг харахад тус салбараар төлөөлүүлэн авах боломжтой юм. 2012 оны 8 дугаар сарын байдлаар нийт 14 банк, тэдгээрийн 1371 салбар нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ба дээрх тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг банкны салбарын тоон мэдээлэлд үндэслэн харвал:

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохист харьцааны үзүүлэлт. Монголын арилжааны

банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохист харьцаа нь холбогдох журмын дагуу 12 хувиас дээш байх ёстой ба 2012 оны 8 дугаар сарын байдлаар 15.2 хувь байгаа нь шалгуурыг хангаж байна. Монголбанкны мэдээллээс үзэхэд, энэхүү үзүүлэлт нь сүүлийн 9 жилийн дунджаар 14.8 хувь байгаа ба 2009 онд хамгийн доод түвшинд буюу 5.5 хувьд хүрч байсан байна. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг бусад орнуудтай харьцуулан харахад:

* WHD – өмнөд ба хойд америк тивийн орнууд (Western hemisphere countries), ED – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд (emerging and developing economies), OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд(organization for economic cooperation and development), G20 их 20 орнууд (group of 20 countries), EUR-европын орнууд (European countries), APD –ази, далайн орнууд(asian and pacific countries)

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлдог үнэлгээ тул Монгол улсын банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь тавьж буй шалгуурыг хангаж байгаа боловч ОУВС-ийн гишүүн орнуудын дундаж /15.8/-тай харьцуулахад доогуур түвшинд байгаа нь эрсдэл даах чадвар тийм ч сайн биш байгааг илэрхийлж байна. Хөрөнгийн чанарын үзүүлэлтийг тодорхойлохдоо зээл, түүнтэй адилтган тооцох актив хөрөнгийн төвлөрөл болон зээлийн чанарын үзүүлэлтээр тооцдог. Зээлжүүлэлт нь санхүүгийн секторын үндсэн бизнес байдаг тул түүнээс хүлээж болзошгүй эрсдэл нь тухайн салбарын хамгийн том эрсдлийн нэг юм.

Сүүлийн жилүүдэд арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл байнга өсөж, 2012 оны III улирлын байдлаар 6,9 их наяд төгрөгт хүрсэн нь гаднаас хямд эх үүсвэрийг их хэмжээгээр татсантай холбон тайлбарлаж байна. Энэхүү зээлийн үлдэгдэлд эзэлж буй чанаргүй зээлийн хувь хэмжээ буурсаар байгаа нь сайн хэдий ч чанаргүй зээлийн бууралтын хувь хэмжээнээс зээлийн өсөлтийн хурд 21,3 хувиар илүү байгаа нь зээлийн чанар тийм ч дорвитой буурахгүй байгааг илэрхийлж байна. Түүнчлэн, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нь өмнөх оны мөн үеэс 117.0 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин нэмэгдсэн ба үүний тодорхой хэсэг нь чанаргүй зээлийн ангилалд нэмж шилжих нь зайлшгүй.

UNDP.MN
СУДАЛГААНЫ САН

Зээлийн төвлөрлийн эрсдэл гэдэг цөөн хэдэн зээдэгчид хөрөнгө төвлөрөх, хэт нэг салбарт зээл байрших зэрэг эрсдлүүд юм. Өөрөөр хэлбэл, банк санхүүгийн салбар дахь томоохон зээлүүд цөөн хэдэн зээлдэгчид төвлөрч, тэр нь янз бүрийн хүчин зүйлээс хамааарч төлөгдөхгүйд хүрвэл тухайн банк санхүүгийн байгууллагадаа төдийгүй санхүүгийн системийн тогтворгүй байдлыг бий болгох сөрөг нөлөөтэй. Үүний тод жишээ нь Анод банк, Зоос банкны дампуурал юм. Манай улсын хувьд “Банкны тухай хууль”-д заасны дагуу “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-аар зээлийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтийг тооцохдоо

- Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь ≤ 20%
- Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл:
  - Нийлбэр нь өөрийн хөрөнгөнд эзлэх хувь ≤ 20%
  - Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөнд эзлэх хувь ≤ 5% байх шалгуурыг тавьдаг. Үүнийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод тайлан, тэнцлээр нь хяналт тавин ажилладаг.

Харин зээлийг ашигтай салбар хэмээн нэг салбарт хэт их зээл олгох нь зээл шингээх чадвараас зээлийн хэмжээ давж, энэ нь эргээд эрсдэл үүсгэдэг. Үүнийг зохицуулсан хязгаарлалт байхгүй бөгөөд үүнийг макро, микро орчны нөхцөл байдлаас хамааруулан бодлогоор зохицуулдаг, эсвэл судалгаа шинжилгээний үндэслэлтэй загварчлал, заавар зөвлөмжүүдийг банк санхүүгийн байгууллагуудад өгч байх нь зүйтэй юм.



Эдийн засгийн салбаруудаар зээлийн төвлөрлийг харахад ерөнхийдөө жигд тархалттай харагдах боловч үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбаруудад олгогдож байгаа зээлийн нэг нь үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулагдаж байгаа, нөгөө нь барилга барихад зориулагдаж байгаа гэсэн утгаараа 1 салбарт орж байна гэж үзвэл нийт зээлийн 26 хувь нь барилгын салбарын зээл юм. Харин ХАА -н салбарт нийт зээлийн 2 хувь буюу хамгийн бага зээл олгогдож байна.

Эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн чанарыг авч үзэхэд уул уурхайн салбар дахь зээл 107.3 тэрбум төгрөгт хүрч, нийт банкны салбарын чанаргүй зээлийн 35 хувийг дангаар эзэлж байна. Энэ нь тухайн салбар дахь эрсдлийн хэмжээ өндөр байгааг харуулж байгаа ба уул уурхайн экспортын бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурах зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч энэ салбарын орлого буурахад чанаргүй зээлийн хэмжээ улам нэмэгдэх магадлал өндөр юм. Гэхдээ нийт зээлийн үлдэгдэлд эзлэх уул уурхайн салбарын зээлийн хэмжээ нь 13 хувийг эзэлж байгаад энэ хэмжээний чанаргүй зээлийн эрсдлийг банкууд эрсдлийн сангаараа даагаад гарах чадвар байгаа ч эдийн засгийн аюулгүй байдалд шууд бус байдлаар нөлөөлөх нөлөөллийг уул уурхайн салбарт гаргах бодлого шийдвэрийн хүрээнд харгалзаж байх нь зүйтэй болов уу.

Ашигт ажиллагаа нь аливаа бизнесийн оршин тогтнох үндэс бөгөөд Монголын банкуудын ашигт ажиллагаа сайжирсаар байна. 2012 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын цэвэр ашиг 123,5 тэрбум төгрөгт хүрч өмнөх үеийн мөн үеэс 23,1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Ашгийн энэхүү өсөлтөнд голлох нөлөөг хүүгийн орлого үзүүлж байгаа ба нэг талаар, ашигтай ажиллаж байгаа нь сайн хэдий ч манай орны ихэнх банк санхүүгийн байгууллагууд нь гадаад эзэнтэй тул үр өгөөжийг нь монголчууд хүртэхээс илүүтэйгээр гадаадыхан хүртэх боломжтой юм.

2000 оны байдлаар Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалттай банк байдаггүй байсан бол 2004 онд гадаадын хөрөнгө оруулалттай банкууд банкны зах зээлийн 40 хувийг, 2009 оноос 65 хувийг тус тус эзлэх болсон байна. Активын өгөөжийн үзүүлэлт, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтийг бусад орнуудтай харьцуулсан байдлаар доор зургаар харуулав.

СУДАЛГААНЫ САН



Хөрвөх чадварын үнэлгээ: Санхүүгийн салбарын хөрвөх активын хэмжээ сүүлийн саруудад буурах хандлагатай байгаа ба урт хугацаанд байнга өсөн нэмэгдсээр ирсэн. Хөрвөх чадварын зохистой харьцаа нь хамгийн багадаа 18 хувь байсан ба 2011 оны 11 сараас Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар 25 хувьд хүргэсэн. 2012 оны 8 сарын байдлаар нийт 2,8 их наяд төгрөгийг төлбөр түргэн гүйцэтгэх зориулалтаар хөрвөх активт байршуулж, 30,5 хувь байгаа нь шалгуурыг хангаж байна. Харин бүс нутгийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн бага түшинд байна.

Болзошгүй эрсдлүүд:

Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдээс харахад манай улсын санхүүгийн салбарын үзүүлэлтүүд ерөнхийдөө шалгуурын хүрээнд хэвийн байгаа харагдавч задлан харахад үүсч болзошгүй эрсдлүүд байсаар байна. Үүнд, зээлийн төвлөрөл болон эх үүсвэрийн төвлөрөл, өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдлүүд байна. Монголбанкнаас санхүүгийн салбарын эмзэг байдлыг “дунд”-аас “өндөр” төлөв рүү шилжих эрсдэлтэй хэмээн тооцсон байна. 2008-2009 оны нөхцөл байдалтай харьцуулахад өнөөгийн санхүүгийн салбарын үзүүлэлтүүд сайжирч байгаа ба санхүүгийн салбар нь өөрөө эмзэг, мэдрэмтгий учраас банкны сайн засаглалыг бэхжүүлэх, банк санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны хяналт шалгалтыг сайжруулах, олон улсын зохицуулалтын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх шаардлага урган гарч байна.

Төсвийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд

Эдийн засгийн аюулгүй байдлыг үнэлэхэд төсвийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдээр хэмжих болсон шалтгаан нь төсвийн тоон өгөгдлүүдийг хэмжиж болохуйц бөгөөд энэхүү хэм хэмжээний эрх зүйн орчин /Төсвийн тогтвортой байдлын тухай хууль/ нь тогтоогдсонд оршино. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсөвт 4 тусгай шаардлагуудыг тавьсантай холбоотойгоор тойм шинжилгээ хийн, түүнээс үүсч болох эрсдлийг тодорхойллоо.

Төсвийн тогтвортой байдлын хуулийн шаардалга	Өнөөгийн байдал	Болзошгүй эрсдэл
Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;	Төсвийн орлогыг 2011 оноос тэнцвэржүүлсэн журмаар тооцож эхэлсэн бөгөөд 2004-2011 онуудын дундажаар төсвийн орлого ДНБ-ний 33.7 хувийг эзэлж байсан ба 2013 оны төсвийн орлогыг ДНБ-ний 40.2 хувьд төлөвлөсөн. Төсвийн орлого нь - уул уурхайн орлогоос хамааралтай, - төсвийн орлого нь дэлхийн зах зээлийг дагаж хэлбэлздэг, - өөдрөг төлөвлөлттэй, орлогыг хэт нэмэгдүүлж тооцсон, - нийт төсвийн орлогын 91,2% нь татварын орлогоос бүрдэж байна.	- өндөр төлөвлөсөн орлогын гүйцэтгэл тасалдах нь бодит эрсдлийг үүсгэнэ. - Орлогын өсөлтийг дагаад зардал өснө. - Орлого 1 салбараас хамаарч байгаа нь дэлхийн санхүүгийн хямралд өртөх магадлал өндөр
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх	2004-2011 онуудад эдийн засгийн бодит дундаж өсөлт жилд 9,5%, инфляцийн дундаж өсөлт жилд 10,4% байхад төсвийн зардлын дундаж өсөлт жилд 31% байжээ. Харин 2013 оны төсөв нь шинээр хэрэгжүүлж эхэлж байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлж байгаа тул зарлагын өсөлт нь өмнөх 12 жилийн дундаж болон энэ оны эрдэс баялагийн бус ДНБ-ний өсөлтийн аль ихээс хэтрэхгүй байх ёстой гэсэн шаардлагын дагуу төсвийн зардлыг 18 хувиар нэмэгдүүлж тооцсон байна.	- орлогын гүйцэтгэл тасалдсан тохиолдолд төсвийн зардал хумигдаж бодит эдийн засгийн хөгжил саарна.
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсвэл ашигтай байх. /Глазьевийн шалгууруар төсвийн алдагдал нь ДНБ-ний 5%-иас дээшгүй/	2008-2011 онуудын дундажаар төсвийн алдагдал ДНБ-ний 4,1 хувийг эзэлж байсан ба 2011 онд хамгийн өндөр хувь буюу 7,1 хувьд хүрсэн байна. Харин 2013 оны төсвийн алдагдал нь хуулийн заалтыг ханган ДНБ-ний 2 хувь байхаар тооцжээ. Үүнд нөлөөлж буй үзүүлэлт нь орлогын өндөр төлөвлөлтөөс гадна ДНБ-ийг мөн өндөр өсөлттэйгөөр тооцсон. /оны үнээр 30%-ийн өсөлттэй/	-орлогын гүйцэтгэл тасалдах тохиолдолд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдана. -ДНБ төлөвлөсөн хэмжээ /17,6 их наяд төгрөг/-нд хүрэхгүй тохиолдолд харьцаа алдагдана.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй. Глазьевийн шалгуураар: -ДНБ-д эзлэх дотоод өр 20%-иас хэтрэхгүй - ДНБ-д эзлэх гадаад өр 25%-иас хэтрэхгүй -Төсвийн алдагдлын санхүүжилтэнд гадаад өрийн хувь хэмжээ 30%-иас хэтрэхгүй	Монгол улсын өрийн үлдэгдэл 2013 онд 9,369.8тэрбум төгрөг буюу өнөөгийн үнэ цэнээр илэрхийлбэл 8,114.9 тэрбум төгрөгт хүрэхээр байна. ДНБ-д эзлэх Улсын өрийн хэмжээ 2013 онд (өнөөгийн үнэ цэнээр) 46.1 хувь болж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Өрийн дээд хязгаар болох 50 хувиас 3.9 пунктээр бага буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтын хүрээнд тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Сүүлийн жилүүдэд дотоод өр өсч 2008 онд ДНБ-ний 3,4% байсан бол 2011 онд 25,6% болсон байна. Гадаад өр 2008 онд ДНБ-ний 24%-ийг эзэлж бол 2011 онд 28,3 хувь болж өсчээ. 2012 оны эцэст авсан 1,5 тэрбум ам.долларыг нэмж тооцвол ДНБ-ний 50 орчим хувийг гадаад өр эзлэх хандлагатай байна.	Гадаад өрийг ашиггүй зарцуулсан тохиолдолд - ЗГ-ын төлбөрийн чадвар муудах - төсвийн хямрал нүүрлэх - үндэсний тусгаар тогтнолын асуудал хөндөгдөх

Төсвийн өнөөгийн байдлын дэлгэрэнгүй тайлбарыг доор оруулав.

2013 оны төсөв нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиудын удирдлага, зарчмыг бүрэн тусгаж, хуулиар тогтоосон тусгай шаардлагуудад нийцснээрээ өмнөх онуудын төсвөөс онцлогтой гэдгийг Засгийн газраас мэдэгдсэн байгаа. Монгол улсын 2013 оны батлагдсан төсвөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 7,088.3 тэрбум төгрөг буюу ДНБ -ий 40.2 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 7,444.6 тэрбум буюу ДНБ-ий 42.2 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 356.3 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар тооцжээ.

Төсвийн орлогыг өмнөх оны төсвийн тодотголоос 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон ба бүтцийх нь хувьд харахад дээрх 7,088.3 тэрбум төгрөг нь 100 хувь урсгал орлогоос бүрдэж байна. Үүний 91,2 хувийг татварын орлого, 8,8 хувийг татварын бус орлого эзэлж байгаа ба өмнөх онуудын төлөвлөгөө, гүйцэтгэлээс харахад төсвийн орлого ерөнхийдөө иймэрхүү бүтэцтэй байсаар ирсэн.

2013 оны төсвийн онцлог нь бусад татвараар 1,296.3 тэрбум төгрөгийн орлого олно гэж төлөвлөсөн нь өмнөх оноос 633,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон ба үүнийг дотор нь задлан харахад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өмнөх оноос 75,7 тэрбум төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийг өмнөх оноос 40 тэрбум төгрөгөөр, бусад татварыг өмнөх оноос 516,3 тэрбум төгрөгөөр нь тус тус нэмэгдүүлсэн байна. Үүний 516,3 тэрбум төгрөг нь юунаас орох орлого вэ гэдэг нь тодорхойгүй байна.

Орлогын эх үүсвэр ийнхүү зөвхөн татвараас бүрдэж, бусад эх үүсвэрүүдийн оролцоо бага байгаа нь төсвийн орлогыг тогтворгүй болгож байна. Үүнийг бид амьдрал дээр /уул уурхайн экспорт болон үнийн өөрчлөлттэй холбоотой төсвийн орлого тасалдсан/ харж байгаа билээ. Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагын (OECD) гишүүн орнуудад татварын орлого нь дунджаар төсвийн орлогын 62 хувь байгаатай харьцуулахад манай улсын төсвийн орлого энэ тал дээр маш эмзэг байна.

Төсвийн орлого	2013 оны төлөвлөгөө	
	хэмжээ /сая төгрөг/	эзлэх хувь
1. Урсгал орлого	7,087,518.1	99.99
Татварын орлого	6,461,531.6	91.16
Татварын бус орлого	625,986.5	8.83
2. Хөрөнгийн орлого	815.6	0.01
3. Тусламжийн орлого	0.0	0.00
Нийт тэнцвэржүүлсэн орлого	7,088,333.7	100.0

Нөгөө талаар, нэгдсэн төсвийн орлого 2012 оны 11 сарын гүйцэтгэлээр 4,322.0 тэрбум төгрөг байхад 2013 онд 7,088.3 тэрбум төгрөгийн орлого орно гэж өмнөх оны гүйцэтгэлээс 2,8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь төсвийн алдагдлыг бууруулж, ДНБ-ний 2 хувьд хүрэхэд нөлөөлж байгаа ба энэ нь хуулийн хүрээнд байгаа мэт харагдавч хэрвээ орлого төлөвлөсөн хэмжээнд хүрч төвлөрөхгүй тохиолдолд харьцаа яаж өөрчлөгдөх нь тодорхой юм. Нэгдсэн төсвийн орлогын 2008 оноос хойших хугацааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг доор хүснэгтээр оруулав.

хугацаа	нэгдсэн төсвийн орлого /тэрбум төгрөг/		
	төлөвлөлт	гүйцэтгэл	Зөрүү
2008	2,496.9	2,170.4	-326.5
2009	2,054.7	1,993.9	-60.8
2010	2,645.7	3,122.5	476.8
2011	4,281.8	4,468.2	186.4
2012	5,508.8	4,322.0	-1,186.8
2013	7,088.3		

2008-2012 онуудад өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан төсвийн төлөвлөлтийн өсөлтийн дундаж нь 21,9 байсан бол 2013 онд өсөлт нь 64 хувь байна. Төсвийн зарлагын өсөлт нь сүүлийн жилүүдэд тухайн жилийнхээ эдийн засгийн бодит өсөлт болон инфляцийн өсөлтөөс илүү хурдтай байсан байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн бодит дундаж өсөлт жилд 9,5 хувь, инфляцийн дундаж өсөлт жилд 10,4 хувь байхад төсвийн зардлын дундаж өсөлт жилд 31 хувь байжээ. Харин 2013 оны төсөв нь шинээр хэрэгжүүлж эхэлж байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлж байгаа тул зарлагын өсөлт нь өмнөх 12 жилийн дундаж болон энэ оны эрдэс баялагийн бус ДНБ-ний өсөлтийн аль ихээс хэтрэхгүй байх ёстой гэсэн шаардлагын дагуу төсвийн зардлыг 18 хувиар нэмэгдүүлж тооцжээ.

Төсвийн зарлагын төлөвлөлт 7,444,6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны төлөвлөлтөөс 1,132.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба үүнд, урсгал зардал 299,8 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 769,1 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 63,5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Энэхүү зарлагын төлөвлөлтийн сайшаалтай тал нь урсгал шилжүүлэгийг бууруулж, бодит эдийн засагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээрээ давуу юм.

Өнгөрсөн хугацааны төсвийн байдлаас харахад, уул уурхайн орлогоос хэт хамааралтай, тогтворжуулалтын сандаа хангалттай хуримтлал үүсгэж чадаагүй манай улсын төсөвт дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал ихээр нөлөөлж байна. Гадаад эдийн засгийн таатай үед бодит үйлдвэрлэлийн хэмжээгээр бус үнийн өсөлтөөр огцом өссөн манай улсын төсвийн орлого гадаад зах зээл таагүй болох үед эрс буурч, төсвийн зарлагын хэт тэлэлтийг хумихад төвөгтэй болж, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд бэрхшээл үүсгэж байна. Нөгөө талаар, нийгмийн халамж, амлалтыг санхүүжүүлсэн нь төсөвт асар дарамт учруулж, бодит салбарын хөгжлийг сааруулах, эдийн засгийн өсөлтийг удаашруулахад гол нөлөө үзүүлсэн ба дээрх шалтгаанууд нь төсвийн тогтворгүй байдлыг үүсгэсэн.

Ирж буй оны буюу 2013 оны төсвийн төлөвлөлтөөс харахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг тоон үзүүлэлтийн хувьд хангасан онцлогтой төсөв болсон боловч тухайн тоог илэрхийлж байгаа утгаар нь харахад төсвийн орлогыг хэт өөдрөг төлөвлөсөн нь тэр хэмжээгээр зардлыг нэмэгдүүлж төлөвлөх үндэслэлийг бий болгож байгаа ба орлогын төлөвлөлт тасалдсан тохиолдолд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр тэр хэмжээгээр дутагдах, түүнчлэн орлогын эх үүсвэр бодит нөхцөлд хүрэлцэхгүй тохиолдолд төлөвлөсөн зардлуудыг хязгаарлах шаардлага гарч, энэ нь эргээд бодит эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалт багасах зэрэг сөрөг нөлөөтэй.

Нөгөө талаар, орлого бүрдүүлэгч эх үүсвэр нь зөвхөн татвараар бүрдэж байгаа, түүнчлэн тэдгээр таварыг бүрдүүлэгч эх үүсвэрт дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн үнийн хэлбэлзэл зэрэг гадаад нөлөөлөл их тул цаашид орлогын бусад эх үүсвэрүүдийг эрэлхийлэх шаардлагатай байна.

Дээрх нөхцөл байдлуудаас харахад 2013 оны төсөв нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг тоон үзүүлэлтийн хувьд хангаж байгаа хэдий ч тухайн тоог илэрхийлж байгаа бодит утгаар нь харахад эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Өөрөөр хэлбэл, төсвийн орлогын хэт өөдрөг төлөвлөлтийг биелэлт нь гүйцэхгүй бол төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр тэр хэмжээгээр дутагдах, түүнчлэн төлөвлөсөн зардлуудыг хязгаарлах шаардлага гарч, энэ нь эргээд бодит эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалт багасах зэрэг нөлөөтэй.

Нөгөө талаар, орлого бүрдүүлэгч эх үүсвэр нь зөвхөн татвараар бүрдэж байгаа, түүнчлэн тэдгээр таварыг бүрдүүлэгч эх үүсвэрт дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн үнийн хэлбэлзэл зэрэг гадаад нөлөөлөл их тул цаашид орлогын бусад эх үүсвэрүүдийг эрэлхийлэх шаардлагатай байна.

Засгийн газрын авах зээл нь бодит эдийн засгийн салбарт чиглэгдэх бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг хангасан, зохистой харьцаанд байна. /УАБ-ын үзэл баримтлалын 3.2.3.2 /Монгол улсын өрийн үлдэгдэл 2013 онд 9,369.8тэрбум төгрөг буюу өнөөгийн үнэ цэнээр илэрхийлбэл 8,114.9 тэрбум төгрөгт хүрэхээр байна. ДНБ-д эзлэх Улсын өрийн хэмжээ 2013 онд (өнөөгийн үнэ цэнээр) 46.1 хувь болж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан энэ оны өрийн дээд хязгаар болох 50 хувиас 3.9 пунктээр бага буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтын хүрээнд тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

Харин Глазьевийн аргачлал дахь дотоод, гадаад өрийн шалгуурууд нь улсын нийт өр доторх Засгийн газрын өрийн байх ёстой түвшин гэж ойлгож байгаа тул энэ харьцаа эрсдлийн босгыг давж байгаа юм.

Үзүүлэлт	2007	2008	2009	2011
Гадаад өр[1]	1,788.4	2,028.5	2,604.9	2,669.3
ДНБ-д эзлэх хувь	24.5%	24.0%	29.6%	28.3%

Түүнчлэн, Монгол улс анх удаа Засгийн газрын 1,5 тэрбум ам.долларын бондыг дэлхийн зах зээлд арилжаалж, энэхүү хөрөнгө нь Монгол улсын дансанд орж бүртгэгдсэн гэдгийг албаны эх сурвалжуудаар мэдээлсэн. Энэ нь 2012 оны 12 дугаар сарын дундаж ханш /1$=1396₮/ -аар тооцоход 2,094,0 тэрбум төгрөг болж ДНБ -ний 21.1 хувийг эзэлж байна.

Энэ хөрөнгийг Шинэчлэлийн Засгийн газрын ойрын жилүүдэд хийх томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилготой байгаа ба бондын зарцуулалт тодорхой бус, нээлттэй биш байгаа нь олон нийтийн анхаарлыг татахаас гадна үр ашигтай ашиглаж чадвал энэ нь ирээдүйн их хөгжлийг авчрах, хэрвээ ашиглаж чадахгүй бол энэ нь их өрийн асуудал үүсэх төдийгүй үндэсний аюулгүй байдалд цаашилбал, манай улсын тусгаар тогтнолд нөлөөлөх асуудал болж хувирна. Иймээс бондоорх хөрөнгийг эдийн засгийн үр ашгийн тооцоо судалгаатай, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн дэд бүтэц, үйлдвэрлэлийг бүтээн байгуулах, хөгжүүлэхэд зориулагдах ёстой.

Чингис бондыг ашиглах хугацааны хүү, үндсэн төлбөрийн мэдээлэлд үндэслэн тооцоход хүүгийн төлбөрт 0,6 тэрбум ам.доллар, үндсэн төлбөрт 1,5 тэрбум ам.доллар, нийтдээ 2,1 тэрбум ам.долларыг эргүүлэн төлөх буюу тус хөрөнгийн ашиглалт нь жилд хамгийн багадаа 17,5 хувийн өгөөжтэй байж эрсдэлгүйгээр бондыг хугацаанд нь эргэн төлөх боломжтой. Өөрөөр хэлбэл, тус хөрөнгийн 100 төгрөг тутмаас 17,5 төгрөгийн ашигтай байх төсөл хөтөлбөрт зарцуулах шаардлага гарч байгаа юм.

2.4. Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар бүлэгт заасан Эдийн засгийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох Эрчим хүч, эрдэс баялагийн салбарт үндэсний аюулгүй байдлыг хангахаар дараах заалтуудыг тусгасан байна. Үүнд:

- 3.2.4.1. Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.
- 3.2.4.2. Эрчим хүчний дотоодын гол эх үүсвэр болох нүүрсийг импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байраар хангах зорилгоор өргөнөөр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.
- 3.2.4.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана.
- 3.2.4.4. Цөмийн эрчим хүчний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.[2]

Дээр иш татсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” -ыг 2010 онд

шинэчлэн баталсан бөгөөд түүнээс хойшхи 2 жилийн хугацаа нь эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулахад хангалттай хугацаа биш хэдий ч энэ хугацаанд Засгийн газраас тус үзэл баримтлалд үйл ажиллагааныхаа төлөвлөгөө болон, яам, агентлагуудын хариуцан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь хэрхэн нийцэн гарсан нь бас нэг үзүүлэлт болох нь тодорхой. Тиймээс 2 жилийн хугацаанд гарсан үр дүнг үнэлэхээс илүүтэйгээр тухайн салбарт баримталж буй бодлогод үзэл баримтлалтай нийцэгүй болон зөрчилдөж байгаа зүйл байгаа эсэхийг тодорхойлох нь эхний алхам болох юм.

1994 онд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” батлагдсанаас эхлэн тус үзэл баримтлал дахь эдийн засгийн салбарын аюулгүй байдлыг үнэлэх болон холбогдох судалгаа, шинжилгээний ажлууд тогтмол хийгдэж байсан байдаг. 1996 оноос хойш 2009 оныг хүртэл хийгдэж байсан судалгааны ажлын гол хэрэглэгдэхүүн нь ОХУ -ын стратеги судлалын хүрээлэнгээс боловсруулсан шалгуур үзүүлэлтэд үндэслэн гаргасан 15 шалгуур үзүүлэлт байгаа нь ихэнхи судалгааны тайлан, холбогдох ном, эмхэтгэлүүдэд дурьдагсан байна. Өөрөөр хэлбэл, үнэлгээний гол хэрэглэгдэхүүн нь дээрх 15 шалгуур үзүүлэлт.

Шалгууруар үнэлсэн үнэлгээний үр дүн нь ихэнхи тохиолдолд адилхан гарсан байна. Тухайлбал, “...15 шалгуур үзүүлэлтээс 12-13 шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн үзүүлэлтүүд нь шаардлага хангахгүй байгаа бөгөөд энэ байдал удаан үргэлжилбэл манай улсын эдийг засгийн аюулгүй байдал алдагдаж, гадаад улс орон, бүлэглэлүүдээс хараат байдалд орох ... магадлалтай”[10] гэсэн дүгнэлтүүдийг гаргасан байдаг. Харин судлаач миний зүгээс олон жилийн туршид гарч байсан дээрх судалгааны дүгнэлтийг үгүйсгэх гээгүй бөгөөд тус дүгнэлтийн шалтгааныг өөрөөр харж байна.

Өөрөөр хэлбэл, эдийн засгийн аюулгүй байдлыг бодитоор үнэлэх шалгуур үзүүлэлт нь өөрөө үнэлгээний шаардлага хангахгүй байгаад гол учир нь байна. Өдий хүртэл хийж ирсэн, шинжилгээ, судалгаа, үнэлгээний гол хэрэглэгдэхүүн болох оросын эрдэмтэд болон НҮБ, ОХУ-ын стратеги судалгааны хүрээлэнгээс боловсруулсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Монголын эрдэмтдийн боловсруулан гаргасан 15 шалгуур үзүүлэлт нь эдийн засгийн аюулгүй байдлыг бодитоор үнэлэх боломжгүй бөгөөд салбарын гол үзүүлэлтүүдийг гаргаж чадаагүй гэж үзэж байна. Учир нь:

- Судалгаа, шинжилгээндээ хэрэглэж байсан гол шалгуур үзүүлэлтүүд нь “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” дахь эдийн засгийн аюулгүй байдлын үзэл баримтлал болгон дэвшүүлсэн зорилтуудыг үнэлэхэд чиглэгдсэн шалгуур үзүүлэлтүүд болж чадаагүй. Өөрөөр хэлбэл байгаа оноогүй,
- Эдийн засгийн аюулгүй байдлыг үнэлэхэд шаардагдах үзүүлэлтүүд дутуу. Тодруулбал, статистик үзүүлэлтээр гараад байгаа эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн үзүүлэлтүүд, мөн эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх үзүүлэлтүүд дутуу дулимаг,
- Үзэл баримтлалд тусгагдсан эдийн засгийн салбарын үзүүлэлтээ бүрэн тодорхойлоогүй. Тухайлбал, эрдэс баялаг, эрчим хүчний салбарын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний үзүүлэлт байхгүй,

гэх зэрэг нь шалгуур үзүүлэлттэй холбоотой асуудлууд байгаа юм. Тухайлбал эдгээр шалгуур үзүүлэлт эрчим хүч, уул уурхайн салбарын аюулгүй байдлыг үнэлэх үзүүлэлт нэг ч байхгүй. Мөн тус шалгуур үзүүлэлтүүд нь юу нь, яаж буруудсанаас эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгааг тодорхой харуулж чадахгүй байгаа юм. Тиймээс энэ шалгууруар гарсан үр дүнгүүд бодитой эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Гэвч эдийн засгийн аюулгүй байдал хангагдахгүй байгаа нь бодит үнэн. Үүнийг өнөөдрийн амьдралын чанар харуулж байна. Иймд гол алдаа нь хаана байна, яагаад эдийн засгийн аюулгүй байдал хангагдахгүй байна вэ гэдэг асуудал тулгарч байна. Өөрөөр хэлбэл “define the problem” буюу “асуудлыг тодорхойлох” бодлогын шинжилгээний алхам нэн тэргүүнд

[10] “Үндэсний аюулгүй байдал хийгээд эдийн засгийн аюулгүй байдал”, Стратеги судлал сэтгүүд, Р. Батмэнд

хийгдэх шаардлагатай болоод байна. Үүнийг тодорхойлж, судалгаагаар шалгасны дараа үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үнэн зөвөөр боловсруулах алхам хийх нь үр дүнтэй байх болов уу. Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах явцад эдийн засгийн аюулгүй байдлыг аюултай түвшинд хүргэж буй гол асуудал нь бодлого боловсруулах шатанд байх магадлалтай нь харагдаж байна.

Түүний хажуугаар хууль болон Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүд, томоохон төслүүдийн хэрэгжилтийн механизм нь, хэрэгжүүлж буй арга зам, түүнд тавих хяналт үгүй зэрэг нь удаах нөлөөллийн хүчин зүйл болж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл цаасан дээр боловсруулан батлан гаргасан бодлогын баримт бичгүүд түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь ерөнхий байдлаараа ҮАБ-ын үзэл баримтлалтай нийцэж байгаа боловч эрхэлсэн яамдуудын тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдэж буй нарийвчилсан төслүүд дээр зарим талын зөрчилүүд харагдаж байна. Үүнийг тодорхой харуулахын тулд Эрчим хүч, эрдэс баялагын салбарт баримтлах аюулгүй байдлын үзэл баримтлалыг зорилт нэг бүрээр нь авч үзэж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан нарийвчилсан суурь судалгаа хийж нөхцөл байдлыг нарийн тодорхой болгох шаардлага байгаа нь харагдаж байна.

Эрчим хүч, эрдэс баялагийн салбарын аюулгүй байдлын үзэл баримтлалын зорилтыг нэг бүрчлэн авч үзвэл дараах байдалтай байна.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт баримтлах аюулгүй байдлын зорилтууд

Эрчим хүч	Уул уурхай	Байгаль орчин
• Нүүрсний импортыг орлох • Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх • Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх • 2020 он гэхэд түлш, Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрээр бүрэн хангах • Цөмийн эрчим хүчний салбарыг хөгжүүлэх • Цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгох	• Эрдэс баялагийн салбарыг улс төр, бизнесийн ашиг сонирхлын зөрчилдөөнөөс ангид байлгах / зөрчилдөөний талбар болохоос сэргийлэх/ • Уул уурхайн ил тод • Уул уурхайн орлогод хяналт тавих • Орон нутагт үйлдвэрлэлийг дэмжиж • Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос хараат байдлыг багасгах • 2020 онд дотоодын үйлдвэрлэлээр газрын тосны хэрэгцээгээ бүрэн хангах • Үнийн хэт хэлбэлзэлд өртөхөөс сэргийлэх • Улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгах • Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалтыг бий болгох	• Байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Дээрх 16 зорилт тус бүрт Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Газрын тосны газар, Ашигт малтмалын газар гэсэн 5 байгууллагын вэб сайтад мэдээлэл авахаар хандсан ч Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас бусад байгууллагын сайтад байршуулсан мэдээлэл шаардлага хангахгүй байв.

Байгаль орчин: Байгаль орчин ногоон хөгжлийн яам нь үзэл баримтлалын 3.2.4.1-д заасан байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх бодлогыг ханган ажиллах бөгөөд одоогийн байдлаар тус яаманд нийт 25 Үндэсний хөтөлбөр харъяалагдаж байгаа бөгөөд үүнээс 12 хөтөлбөр нь хэрэгжээд дууссан байна. Эдгээр 25 хөтөлбөрөөс яг уул уурхайн

хайгуулын болон олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн хүчин зүйлээс байгаль орчныг доройтуулахаас сэргийлэхэд чиглэсэн “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр” гэсэн хөтөлбөр байсан бөгөөд энэ нь 2010 онд дуусгавар болсон байна. Хэрэгжилтийн байдал, үр дүнгийн талаарх тодорхой мэдээлэл судалгаа алга байна.

2015 он хүртэд хэрэгжих “Цагаан тоос”, 2035 он хүртэл хэрэгжих “Ногоон хэрэм”, 2015 он болон түүнээс цаашид хэрэгжих “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүдийн хамруулан авч үзэж болох юм. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын мэдээлж байгаагаар Байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа дээрх хөтөлбөрүүдээс 7 хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, удааширалттай, зарим заалт нь тасарч байгаа бөгөөд хэрэгжилтийн хяналтыг тогтмолжуулж, биелэлтийг бүрэн гаргахад анхаарах шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарчээ. Ийм дүгнэлт бүхий хөтөлбөрт “Ногоон хэрэм” хөтөлбөр багтсан байна.

Эрдэс баялаг, Эрчим хүч: Хуучнаар Эрдэс баялаг, Эрчим Хүчний Яам одоогоор Уул уурхайн яам, Эрчим хүчний яаманд нийтдээ Үндэсний хөтөлбөр 5, Хэрэгжүүлж байгаа 12 төсөл байна гэсэн мэдээ 2012 оны эхний хагас жилийн байдлаар гарсан байна. Тус салбарт Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сэргээгдэх эрчим хүч”, “Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем”, “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх”, “Монгол улсыг аж үйлдвэржүүлэх”, “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх” гэсэн 5 хөтөлбөр байгаагаас “Сэргээгдэх эрчим хүч”, “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх” гэсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашралттай буюу тасарч байгаа гэсэн дүгнэлт хийжээ. Бусад хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нарийн тодорхой мэдээлэл байхгүй.

УАБ -ын эдийн засгийн салбарын Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын дээрх 16 зорилтын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөө хэрхэн нийцэж байгаа талаар авч үзвэл дараах байдалтай байна.

- “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх, үйл ажиллагааны хөтөлбөр”-т эрдэс баялаг уул уурхайн салбарын бодлоготой хамаарал бүхий 19 чиглэлийн зорилтыг эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлийн зорилт болгон тавьсан байна. Үүнийхээ хүрээнд эдийн засгийг солонгоруулах долоон чиглэлийн бодлого бодлого явуулахаар төлөвлөсөн байна. Үүнээс “Үйлдвэржүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого”, “Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого” гэсэн 2 чиглэлийн бодлогын зарим заалтууд нь эрдэс баялаг, эрчим хүчний салбарын бодлоготой хамаарал бүхий бодлогууд байгаа юм. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бодлого тус бүрийн дагуу үйл ажиллагааны зорилт тавин төлөвлөгөө боловсруулсан байна.
- “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөн”-д нийт 319 зорилт тусгагдсанаас Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хамаарах 41 зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан заажээ.

Өөрөөр хэлбэл салбарын аюулгүй байдлын үзэл баримтлалд дэвшүүлсэн 16 зорилтод нийцүүлэн Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөртөө нийт 41 зорилт, 140 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Үүнээс цөмийн эрчим хүчний хэрэглээтэй холбоотой аливаа бодлого хэрэгжүүлэхгүй гэдгээ Ерөнхий сайдын зүгээс амалсан байна. Мөн Эрдэс баялагийн салбарыг улс төр, бизнесийн ашиг сонирхлын зөрчилдөөнөөс ангид байлгах зорилтын хувьд хэдийгээр 2012 онд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” батлагдсан ч төдийлөн хэрэгжихгүй байгаа бөгөөд хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөрүүд ашиг сонирхолын зөрчилтэй байна гэсэн шүүмжлэл дагуулж байна. Мөн УАБҮЗ -ын 3.2.4.3-д заасан зорилтуудын хүрээнд эрхэлсэн яамнаас нь Газрын тосны үйлдвэр

барих тухай төслийг Засгийн газарт хүргүүлсэн ч энэ төслөөр тус үйлдвэр нь түүхий эдээ ОХУ -аас авах болсон нь мөн УАБҮЗ -ын үндсэн бодлого, Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 98.1- т заасан “Боловсруулах үйлдвэр байгуулан Монгол Улсад олборлож байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрт эхний ээлжинд нийлүүлдэг болох” гэсэн зорилтуудтай зөрчилдөж байна.

Мөн цаашид баримталахаар болсон татварын хөнгөлөлтийн бодлого нь үзэл баримтлалтай шууд бусаар зарчилдөж байна гэж үзэж болохоор байна. Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1. -т “Уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи үйлдвэрлэх зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжийн төсөвт төлсөн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох чиглэлээр Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль...-д нэмэлт өөрчлөлт оруулна” гэсэн нь үзэл баримтлалыг даган гарсан мэргэжилтнүүдийн дүгнэлттэй зөрчилдөж байна. Энэ мэт шууд бусаар зөрчилдөж байгаа болон тодорхойгүй зорилтууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан байна.

Стратеги судлалын салбарын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Эрчим хүч, эрдэс баялгийн салбарт тулгамдаж буй асуудал нь дараах байдалтай байна:

- ✓ Эрдэс, баяжмалын нөөц, агуулгыг бүрэн тооцохгүй,
- ✓ Татвар, шимтгэлийг бүрэн авахгүй,
- ✓ Тусгай зөвшөөрөл, химийн хортой бодисын хэрэглээнд тавих төрийн хяналт сул,
- ✓ Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар олон төсөл, саналууд ирүүлсэн байдаг боловч үйлдвэр байгуулах хөрөнгө, санхүүжилтийн асуудал нь тодорхой бус, техник технологийн сонголт бүрэн хийгдээгүй, ажил хэрэг болгохгүй орхигдуулсаар байна.
- ✓ Монгол Улсаас уул уурхайн бүтээгдэхүүн экспортолж буй аж ахуйн нэгжүүд орлогоо нууж, татвараас зайлсхийсээр байна. Тэдний борлуулалтыг дэлхийн зах зээлийн үнээр борлуулах хуулийн заалтыг тууштай хэрэгжүүлэхгүй, нөөц ашигласны төлбөр, татварын хэмжээг бодитой тогтоож чадахгүй орлого алдсан хэвээр байна.
- ✓ Цахилгаан, дулааны шугам сүлжээ хуучирсан, нийгмийн салбарын хэрэгцээг харгалзан үнийг төрөөс бага тогтоож нөгөө талаас эрчим хүчний салбарын үр ашиггүй, үрэлгэн үйл ажиллагаанаас эдийн засгийн сөрөг цикл үүсээд байна. Шатахууны хангамж, бөөний болон, жижиглэн худалдаа дэлхийн зах зээлийн үнийн савалгаа, нэг улсын экспорт, тээврийн тарифын нөлөөнд байна. Үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн хэрэглээний бүх салбарт цахилгаан, дулаан, шатахууны зохистой хэрэглээ, хэмнэлтийн горим, ухамсар, соёл тогтоогүй нь макро эдийн засгийн ихээхэн алдагдалд хүргээд байна
- ✓ Уул уурхайн салбарт химийн хорт бодисыг технологийн дагуу хэрэглэх ёстой боловч хяналт сул байгааг ашиглан гар аргаар алт олборлож байгаа иргэд хууль бусаар, технологийн горимгүй хэрэглэж байгаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг хордуулах үндсэн шалтгаан болж байна.
- ✓ Түлш, шатахууны салбар 100 хувь гадны импорт, үнийн хэлбэлзлээс хамааралтай бөгөөд жилд нэг их наяд төгрөгөөс их үнээр түлш, шатахууныг нэг улсаас худалдан авч байгаа бөгөөд энэ нь гадаад худалдааны алдагдлын гол шалтгаан болж байна.

ЗӨВЛӨЛГӨӨ ХАМГААЛАГДСАН

- ✓ Манай улсын эдийн засгийн үндсэн активууд болон улсын төсвөөр хийгдсэн геологи хайгуулын судалгааны үр дүнд нээгдсэн ордуудыг үнэ төлбөргүй шахуу тарааж, лицензийн олголтыг хяналтаас гаргасан. Энэ салбарт төрийн бодлого алдагдсан бөгөөд уул уурхайн салбараас орох орлого татвараас чөлөөлөгдсөн хэвээр байна.
- ✓ Хууль бус ашигт малтмал олборлогчдыг хязгаарлаж бусад салбарт ажлын байраар хангаж чадахгүй, байгаль орчныг ихээхэн сүйтгэж байгаа зэрэг нь тус салбарын олон жил үргэлжилсэн хүндрэлүүд болоод байна. Эрдэс бүтээгдэхүүний экспортод тавих төрийн хяналт алдагдаж бүтээгдэхүүний хэмжээ, үндсэн болон дагалдах элементийн агуулгыг бүрэн тодорхойлж чадахгүй төсвийн орлогын бүрдүүлэлтэд алдагдал учруулж байна[11] гэж дүгнэсэн байдаг.

2.5 Гадаад худалдаа, интеграцийн бодлогын хэрэгжилт, эрсдэл

Монгол улсын Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал ямар хэмжээнд хангагдаж байгааг үнэлэх зорилгоор гадаад худалдаа, интеграцийн бодлогын өнөөгийн байдал нь "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" -ын 3.2.5 -д заасан Гадаад худалдаа, интеграцийн бодлогын зааллтын зорилтыг хангаж чадаж буй эсэхийг үнэлэн дүгнэж, энэхүү зааллтын хэрэгжилт хангалтгүй байснаар үүсч болох эрсдэлүүдийг гарган ирэхийг зорив.

Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд элсэж, гадаад эдийн засгийн нээлттэй бодлого явуулж ирсэн бөгөөд 2012 оны эхний 11 сард дэлхийн 137 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10298.9 сая ам.долл, үүнээс экспорт 4029.9 сая ам.долл, импорт 6269.1 сая ам.долларт хүрчээ (Зураг 1). Доорх зургаас харахад сүүлийн жилүүдэд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ жил бүр өссөнөөр гадаад худалдаа хөгжиж байгаа хэдий ч гадаад худалдааны алдагдал эрчимтэй өссөөр байна.



Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, сая ам. долл.

Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхэтгэл , 2012 оны 11 сарын танилцуулга

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 11 сард 2239.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 534.5 сая ам.долл буюу 31.4 хувиар өсчээ. Харин 2012 оны эхний 11 сарын үеийн гадаад худалдааны алдагдлыг 2010 оны мөн үеийн 320.5 сая ам.долларын алдагдалтай харьцуулбал 1918.7 сая ам.долл өссөн үзүүлэлттэй

[11] http://www.nsc.gov.mn/?q=mn/node/130

байна. Гадаад худалдааны алдагдал өсөхөд манай орны экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох боловсруулаагүй болон хагас боловсруулсан түүхий эд, зэс, алтны экспорт голлосон хүнс, өргөн хэрэглээний барааны импортоос хамаарсан хэвээр байгаа нь нөлөөлж байна.

Энэ байдлаас харахад "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.2.5.2-т заасан "Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ" гэсэн зорилтын Гадаад худалдааны алдагдлыг багасгах хэрэгжилт маш хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Гаалийн албан татварын хэмжээ нь гаалийн үнэ, тоо хэмжээ, татварын төрөл, хэлбэр, тарифын хувь хэмжээ зэргээс хамаарч өөр өөр байх бөгөөд 2002 оноос дийлэнх үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын барааны гаалийн татварын хэмжээг 5 хувь, Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) -ын хувь хэмжээг 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс 10 хувиар ногдуулж байгаа бөгөөд тодорхой зарим нэр төрлийн барааны улирлын чанартайгаар өөрчлөгддөг. Төмс, сонгино, байцаа, шар лууван, шар манжин, гурил зэрэг бараа бүтээгдэхүүний хувьд жил бүрийн 8 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл 15%, бусад улиралд 5%-ийн татвар ногдуулахаар заасан байна.

Үүнээс харахад тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэх, Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлэх тал дээр анхааран улсаас дээрх гаалийн татварын зохицуулалт хийгдэж байна.

Энэ зорилт нь үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд чухал ач холбогдолтой ба хэрэв энэ зааллтын хэрэгжилт хангалтгүй байвал үндэсний үйлдвэрлэл хөгжихөд саад учирж хүнд байдалд орох эрсдэлтэй. Манай улс 2012 оны эхний 11 сард нийт 55 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 92.8 хувь, Канад улсад 2.4 хувь, ОХУ-д 1.8 хувь ногдож байгаа нь нийт экспортын 97.0 хувийг эзэлж байна.

Экспортын бүтэц, голлох улсаар, 2012 оны эхний 11 сарын байдлаар,
(эх сурвалж: МУ -ын статистикийн эмхэтгэл , 2012 оны 11 сарын танилцуулга)

Экспортын 98.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн эзэлж байна.

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, хувиар

UB.MN
СУДАЛГААНЫ САН

	2010 I-XI	2011 I-XI	2012 I-XI
Нийт	100.0	100.0	100.0
Эрдэс бүтээгдэхүүн	80.2	88.8	89.3
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	8.1	5.4	5.7
Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	6.5	2.5	2.5
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	1.2	1.1	0.6
Бусад	4.0	2.2	1.9

Эх сурвалж: МУ-ын статистикийн эмхэтгэл , 2012 оны 11 сарын танилцуулга

Дээрх статистик мэдээллээс харахад “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.5.1 -т заасан “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь хөрш орнуудад гаргах экспортын нэр төрөл цөөн, боловсруулаагүй түүхий эд голлож тарифын болон тарифын бус саад, хоригтой байна. Энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан эдийн засаг экспорт импортоос хэт их хамааралтай болох, үндэсний үйлдвэрлэл мөхөх, хүнсний аюулгүй байдал алдагдах зэрэг эрсдэл үүсэх боломжтой.

Манай улс 2012 оны эхний 11 сард нийт 134 оронтой импортын худалдаа хийсний 28.2 хувийг БНХАУ -тай, 26.9 хувийг ОХУ-тай, 8.1 хувийг АНУ-тай, 7.5 хувийг Япон улстай, 7.0 хувийг БНСУ-тай, 3.6 хувийг ХБНГУ-тай хийсэн нь нийт дүнгийн 81.4 хувийг эзэлж байна.



Импортын бүтэц, голлох улсаар,
2012 оны эхний 11 сарын байдлаар

Импортын хэмжээ 2012 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеийнхээс 301.8 сая ам.долл буюу 5.1 хувиар нэмэгдсэн байна. Нийт импортод машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг 24.6 хувь, эрдэс бүтээгдэхүүн 22.9 хувь, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 19.4 хувь, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.8 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 5.8 хувийг эзэлж, үлдсэн 18.5 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, хувиар

Энэхүү статистик мэдээллээс харахад “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.5.3-т заасан “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална” гэсэн заалтын биелэлт хангагдаж байна. Учир нь манай улс дэлхийн олон орны зах зээлээс олон төрлийн бараа бүтээгдэхүүн импортолж байгааг дээр дурдсан. Хэрэв энэ заалтын биелэлт хангалтгүй байвал манай улсын баримталж буй гадаад худалдааны салбарт олон тулгуурт гадаад бодлогын зарчим алдагдах эрсдэл учирж болзошгүй.

* * *

Ашигласан ном, материалын жагсаалт

1. Ашигт малтмалын газар, Ашигт малтмал, газрын тосны салбарын мэдээлэл- /www.mram.gov.mn/
2. Банкны тухай хууль 2010 он
3. Глазьев.С “Методика расчета основных показателей экономической безопасности РФ”, 1996
4. Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Гадаадын хөрөнгө оруулалтын мэдээлэл, /www.investmongolia.com/
5. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль 1993-05-10
6. Даваадорж.Ц “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд”, Стратеги судлал сэтгүүл, 2011.№53
7. Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам - http://mne.mn/v3/
8. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
9. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоол, 2011-07-09 №39
10. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай, УИХ-ын тогтоол, 2012.05.18 №37
11. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай 2012 он
12. Монгол Улсын Статисикийн эмхтгэл УСХ, 2011 он
13. Статистикийн бюллетень 2009 №12, 2010 №12, 2011 №12, 2012 №13 УСХ
14. Страны с переходной экономикой Дэлхийн банк OED Вашингтон 2004 он

ШУА MN
СУДАЛГААНЫ САН

15. Тунгалаг.Д Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал УБ.2009 он
16. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010.06.24
17. Цэцгээ.С Даяаршлын нөхцөл дэх үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, түүнийг хангах механизмыг боловсронгуй болгох нь. Адмон. 2008
18. Цогтоо.М Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудалд. Мэдээлэл сэтгүүл 1993 №1
19. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл ба төсвийн уялдаа холбоо /судалгааны тайлан/ Сангийн яам, UNDP УБ 2005 он
20. www.legalinfo.mn
21. www.mof.gov.mn
22. www.pmis.gov.mn

(Footnotes)

[1] http://www.mof.gov.mn/res/resource/resource/0726_112.pdf

[2] Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010;

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХӨНГӨЛӨЛТ, ДАВУУ ТАЛ ОЛГОДОГ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Г. Билгээ, Г. Гэрэл, Ч. Онончимэг, Б. Хатантуул

ОРШИЛ

УИХ-ын гишүүн Д.Ганхуягийн 2012 оны 7 -р сарын 27 -ны өдрийн 326 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу дэлхийн улс орнууд тендерт оролцож буй үндэсний аж ахуй нэгжүүддээ ямар хэлбэрээр хөнгөлөлт үзүүлдэг талаар туршлагыг харьцуулсан судалсан бөгөөд судалгааг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн эдийн засгийн багийнн судлаачид хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүн

Хөгжиж буй болон ядуу буурай орнуудын хувьд хувийн секторын борлуулалт хийх томоохон зах зээл буюу худалдан авагч нь ихэвчлэн тухайн улсын Засгийн газар, төрийн байгууллагууд байдаг байна. Харин өндөр хөгжилтэй орнуудын хувьд тухайн улсын ААН-үүд нь ихэвчлэн олон улсад нэр хүнд бүхий томоохон компани, корпорациуд байх ба жижиг дунд ААН-үүд бизнес эрхлэхэд таатай зах зээлийн харилцаа үйлчилж байдаг тул олон улсын болон дотоодын зах зээл дээр бараа, ажил, үйлчилгээгээ амжилттай борлуулах боломжтой байдаг байна. Ийм учраас төрөөс худалдан авалт хийх замаар дэмжлэг үзүүлэх шаардлага харьцангуй бага байдаг байна.

Хөгжиж буй болон ядуу буурай орнуудын хувьд, төрөөс үндэсний үйлдвэрлэл, дотоодын зах зээлээ дэмжих, улмаар ядуурлыг бууруулах зэрэг үндсэн зорилгуудын хүрээнд тендер шалгаруулалтанд онцгой анхаарч холбогдох дүрэм журмуудыг нарийвчлан зохицуулж өгсөн байна. Ингэхдээ тендерт оролцогчдод тодорхой шалгуур тавих, хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг. Мөн тендерт оролцогчид нь ихэнхдээ хувийн хэвшлийн байгууллагууд байдаг хэдий ч төрийн өмчит үйлдвэрийн газрууд ч бас тендер шалгаруулалтанд оролцож, ашиг орлого олох боломжтой байдаг.

Хөгжингүй орнуудын хувьд тендерт оролцогчдыг өрсөлдөх тэгш боломжоор ханган, хамгийн сайн, нийгэм эдийн засгийн хувьд үр ашиг, хэмнэлт бүхий санал ирүүлсэн нийлүүлэгч, гүйцэтгэгч нарыг сонгон гэрээ байгуулдаг үндсэн зарчмыг л баримталдаг тул тендерт оролцохоор саналаа ирүүлсэн аль нэг этгээдэд давуу эрх олгодоггүй байна. Тухайлбал, Швед Улсын Төрийн худалдан авалтын тухай актын[12] 9 дүгээр зүйлийн Төрийн худалдан авалтын үндсэн зарчимд “гэрээлэгч талын удирдлагууд нийлүүлэгч талуудтай эн тэнцүү, үл ялгаварлах болон ил тод хэлбэрээр худалдан авах тендерийг удирдан явуулна” гэж заажээ. Мөн түүнчлэн Серби Улсын Төрийн худалдан авалтын тухай хуулийн[13] 8 дугаар зүйл дэх Худалдаанд оролцогч талуудын эрх тэгшийн зарчимд “худалдан авах тендерийг зохион байгуулагч тал тендерт оролцогч талуудыг үл ялгаварлах, ямарваа нэг нөхцөлийг тулгахгүй” гэжээ. БНХАУ -ын Төрийн худалдан авалтын тухай хуульд тендерт оролцогчийг дотоодын болоод гадаадын гэж онцлон ангилсан зүйл байдаггүй[14].Тэгвэл зах

[12] http://www.cleanvehicle.eu/fileadmin/downloads/sweden/Swedish_Public_Procurement_Act_4.pdf

[13] http://www.oecd.org/countries/serbia/40511974.pdf

[14] The Government Procurement Law of the People’s Republic of China (Adopted at the 28th Meeting of the Standing Committee of the Ninth National People’s Congress on June 29, 2002)

зээлийн хөгжил муу, эрүүл өрсөлдөөн байхгүй ядуу буурай улс орнуудад төрөөс тендерт оролцогчдын аль нэг хэсгийг дэмжих зорилгоор давуу нөхцөл олгох зэргээр ялгаварлан гадуурхаж эхлэх үед төр, засгийн хуваарилалтаас хувь хүртдэг хэсгийнхэн энэ чиглэлээрээ харьцангуй томорч, үйл ажиллагаагаа тендерт оролцох чиглэлээр түлхүү явуулах болдог. Үүний улмаас зөвхөн тендерээс ашиг орлогоо олдог, хувь хүртдэг, бараа үйлчилгээгээ зөвхөн төрийн байгууллагад нийлүүлдэг компаниуд бий болох ба бусад компаниуд энэ давуу эрхийг олж авахын төлөө зүтгэн тухайн улсын эдийн засаг бизнесийн орчин зах зээлийн эрэлт, хэрэгцээн дээр менежмент хийдэг жам ёсны хэлбэрээс гажууддаг байна.

Тиймээс судалгааны явцад цугласан мэдээллүүд үндсэндээ хөгжиж буй болон ядуу буурай орнуудын жишээ баримтууд байгаа болно. Эдгээрээс харахад улс орнууд үндэсний ААН-дээ дараах байдлаар давуу эрх олгодог байна.

1. Эрх бүхий байгууллагаас гадаад улсаас гаралтай бараа, ажил, үйлчилгээг улсын аюулгүй байдал, батлан хамгаалах асуудалтай холбоотойгоор тухайн сонгон шалгаруулалтад орох эрхийг хасах, эсвэл хязгаарлах,
2. Нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн тухайн улсад үйлдвэрлэгдсэн байх ёстой болон тухайн бараа үйлчилгээний агууламжийн 50 -иас доошгүй хувь нь үндэсний гарал үүсэлтэй байхыг шаардах,
3. Тендерт оролцогчдод технологи дамжуулах ба дотоодын хөрөнгө оруулалттай байх, дотоодын экспортыг дэмжсэн байх зэрэг шаардлагуудыг тавьж болно. Мөн түүнчлэн эдгээр тавьсан шаардлагуудыг тендерийн үнэлгээнд оруулан тооцох ба энэ нь үнэлгээний гуравны нэгээс их байж болохгүй.

Харин гадаад улсын ААН тендерт оролцохыг зөвшөөрөх нөхцөлүүд нь:

1. Дотооддоо үйлдвэрлэх боломжгүй байгаа худалдан авах тендерийн төсөл
2. Тендерын зарласан шаардлагыг хангах дотоодын оролцогчид байхгүй, эсвэл тендер шалгаруулалт явагдсан боловч дотоодын оролцогч ялагч болоогүй бол

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ХӨНГӨЛӨЛТ, ДАВУУ ТАЛ ОЛГОДОГ ЭСЭХ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Улсын нэр	Тендерийг зохицуулдаг эрх зүйн актууд /огноо/	Зохицуулалтууд
1. ОХУ	Төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай N94-ФЗ тоот холбооны хууль	Тус хуулийн 13 дугаар зүйлийн 1-д “Дотоодын хэрэгцээнд гадаадын улс, гадаадын бүлэг улсаас гаралтай эд зүйл, түүнчлэн гадаадын хүний хийх ажил, үзүүлэх үйлчилгээ нь бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтын зорилгод нийцсэн, ОХУ-аас гаралтай бараа, ажил, үйлчилгээтэй адил нөхцөлд төр болон орон нутгийн хэрэгцээнд нийцэж байвал ОХУ-ын байгуулсан олон улсын гэрээ, бусад Холбооны хууль болон энэ хуульд өөрөөр заагаагүй бол хэрэглэж болно”. Мөн тус хуульд зааснаар эрх бүхий байгууллагаас гадаад улсаас гаралтай бараа, ажил, үйлчилгээг улсын аюулгүй байдал, батлан хамгаалах асуудалтай холбоотойгоор тухайн сонгон шалгаруулалтад орох эрхийг хасах, эсвэл хязгаарлах тухай заасан байна. Харин дотоодын сонгон шалгаруулалтад оролцогчид давуу эрх олгох тухай тусгаагүй байна. Төрийн болон орон нутгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын талаар эрх зүйн үндсэн зохицуулалт бол 94 тоот Холбооны хууль бөгөөд уг хуульд захиалга авах субъект нь зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран шаардлага хангасан ямар ч хуулийн этгээд байж болохыг заасан байна.

2. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	Тендерийн тухай хууль. 2005 National Assembly of the Socialist Republic of Vietnam Legislature XI, Session 8 (from 18 October until 29 November 2005)	13 дугаар зүйл. Олон улсын тендер[1] 1. Дараахь тохиолдолд олон улсын тендерийг зохион байгуулна. a. Олон улсын тендер явуулна гэж донор заасан ОДА-г хэрэглэх төсөл b. Хараахан дотооддоо үйлдвэрлэх боломжгүй байгаа худалдан авах тендерийн төсөл c. Тендерын зарласан шаардлагыг хангах дотоодын оролцогчид байхгүй, эсвэл тендер шалгаруулалт явагдсан боловч дотоодын оролцогч ялагч болоогүй бол 2. Тендерт ялсан гадаадын оролцогч хамтран ажиллах хэлцлийн дагуу үүргээ зүй ёсоор биелүүлээгүй эсхүл тендерт заасанчлан Вьетнам гэрээлэгч талд даалгасан ажлын хэмжээ, үнэ цэнийг биелүүлэх Вьетнам гэрээлэгчийг хөлслөөгүй бол тухайн оролцогчийг цуцлана. 3. Вьетнамын тендерийн төслийг гүйцэтгэхээр тендерт ялсан аливаа гадаад тендерт оролцогч нь гадаадын гэрээлэгчдийн менежментийн тухай Вьетнамын Засгийн газраас гаргасан хэм хэмжээг дагаж мөрдөнө.
3. Бүгд Найрамдах Гамби Улс	Төрийн худалдан авалтын тухай Акт. 2001. (The Gambia Public Procurement Act-2001) Төрийн худалдан авалтын тухай журам. 2003. (The Gambia Public Procurement Regulations-2003)	Олон Улсын Тендер зарлах нөхцөл 1. Тооцоолсон өртөг нь эрх мэдэл бүхий байгууллагаас тогтоосон үнийн дүнгээс давсан тохиолдолд 2. Өрсөлдөх үнэ болон нөхцөлд тухайн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэх Гамба улсын гурваас доошгүй нийлүүлэгч байхгүй тохиолдолд 3. Үндэсний хэмжээнд тендер зарлахад нийлүүлэгч шалгараагүй тохиолдолд
4. Бүгд Найрамдах Унгар Улс	Төрийн худалдан авалтын тухай Акт. 2011. (Hungarian Public Procurement Act-2011)	Жилийн цэвэр орлого нь 100 сая форинт[2]-с илүүгүй үндэсний аж ахуй нэгжийг бараа үйлчилгээ худалдан авагч тал тендерт оролцуулах эрх олгох
5. Мексик Улс	Төрийн худалдан авалтын тухай багц хуулиуд	Төрийн худалдан авалтын тухай багц хуулинд зааснаар Мексикийн Нэгдсэн Улсад 3 төрлийн тендер байдаг. 1. Үндэсний Төрийн тендер-зөвхөн Мексикийн үндэсний АА нэгжүүд оролцоно. Нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн Мексикийн Нэгдсэн Улсад үйлдвэрлэгдсэн байх ёстой болон тухайн бараа бүтээгдэхүүний агууламжийн 50-иас доошгүй хувь нь үндэсний гарал үүсэлтэй байна. 2. Олон Улсын тендер зарлах- зөвхөн Мексик улстай Олон Улсын чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зурсан талууд болон дотоодын оролцогчид Үндэсний тендер хүчингүй болсон тохиолдолд 3. Олон Улсын нээлттэй тендер зарлах- Дотоодын болон гадаадын орны оролцогчид 2-т заасан тендер хүчингүй болсон тохиолдолд

UB.MN
СУДАЛГААНЫ САН

6. Тайвань	Тайваний Засгийн газрын худалдан авалтын тухай хууль, 1998 (Government Procurement Act, 1998)	43-р зүйл Манай улсын нутаг дэвсгэрт үйлчлэх бусад гэрээ хэлэлцээрт хориглосон заалт байхгүй бол захиалагч тал нь дараах аль нэг аргыг сонгон хэрэглэж болох ба тендерийн баримт бичигт тодорхой заана. 1. Тендерт оролцогчдод дотоодын бараа бүтээгдэхүүн худалдан авах хувь хэмжээг заах, технологи дамжуулах ба дотоодын хөрөнгө оруулалттай байх, дотоодын экспортыг дэмжсэн байх зэрэг шаардлагуудыг тавьж болно. Мөн түүнчлэн эдгээр тавьсан шаардлагуудыг тендерийн үнэлгээнд оруулан тооцох ба энэ нь үнэлгээний гуравны нэгээс их байж болохгүй. 2. Энэхүү хуулийн 52-р зүйлд заасны дагуу шаардлагыг хангасан гадаадын оролцогчын тендер нь хамгийн доод оноотой тендер байвал дотоодын оролцогчид тухайн тендерийн үнийн давуу эрхийг олгож болно.
7. Бүгд Найрамдах Гана Улс	Төрийн худалдан авалтын тухай хууль, 2003 (Public Procurement Act, 2003)	60-р зүйл. Давуу эрх олгох 1- Захиалагч тал нь дотоодын нийлүүлэгчдэд ажил гүйцэтгэх тендерт, дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тендерт, мөн үйлчилгээ үзүүлэх тендерт оролцоход давуу эрх олгож болно. 2- Давуу эрх олгох хэмжээг худалдан авах дүрэм журамд заасны дагуух аргачлалаар бодох ба худалдан авах үйл ажиллагааны тэмдэглэлд тодорхой заана. 3- Зөвлөлөөс давуу эрхийн зөвшөөрлийг өгч, давуу эрхийг олгоно. Хавсралт 3 Төрийн худалдан авах тендерийн босго үнэ 1-2 Олон улсын тендерийн босго үнэ - Бараа нийлүүлэх тендер 15 тэрбумаас дээш - Ажил гүйцэтгэх тендер 20 тэрбумаас дээш - Техникийн үйлчилгээ үзүүлэх тендер 2 тэрбумаас дээш 1-3 Үндэсний тендерийн босго үнэ - Бараа нийлүүлэх тендер 200 сая аас 2 тэрбум хүртэлх - Ажил гүйцэтгэх тендер 500 сая аас 15 тэрбум хүртэлх - Техникийн үйлчилгээ үзүүлэх тендер 200 сая аас 2 тэрбум хүртэлх

8. Бүгд Найрамдах Кени Улс	Төрийн худалдан авалтын тухай хууль, 2005 (Public Procurement and Disposal Act 2005)	39-р зүйл Төрийн худалдан авах үйл ажиллагаанд оролцох 2- Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүчин зүйлүүдээс хамааран 8-р дэд хэсэгт заасан хуулийн этгээдэд төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд оролцоход нь сайдаас давуу эрх олгох шийдвэрийг гаргаж болно. 4- Давуу эрхийг дараах этгээдэд олгоно : 1) жижиг, дунд үйлдвэрүүдэд 2) ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, бараа нийлүүлэх этгээдэд 3) зарим бүс нутгуудад 8- Энэхүү хэсэгт заасан давуу эрхийг дараах этгээдүүд эдэлж болно: 1) Илүү давуу эрхийг Кени улсын иргэдэд олгох ба үүнд: I. Кенийн засгийн газрын 100 хувийн хөрөнгө оруулалттай болон Кени улсын байгууллага орно. II. Тогтоосон давуу эрхийг доор заасан этгээдэд олгоно: - Тендерт Кени улсад ургасан, олборлосон эсвэл үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг санал болгож буй оролцогчдод - Дотоодын хувь эзэмшигчдийн хэмжээнээс хамааран ажил, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тендерийн оролцогчдод давуу эрх олгож болно. 28-р зүйл 1. Энэхүү хуулийн 39-р зүйлийн 8-р дэд хэсэгт заасны дагуу Кени улсын иргэнд дараах давуу эрхүүдийг олгож хөнгөлөлт үзүүлж болно: 1) Бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний нийлүүлэлтэнд 50 сая шилинг 2) Ажил гүйцэтгэлд 200 сая шилинг 3) Энэ хуулийн 39-8-1-1 хэсэгт заасанд тендерийн үнэлгээний үнийн 15 хувь 4) Энэ хуулийн 39-8-1-2 хэсэгт зааснаар – - 20 хувиас доош дотоодын хувьцаа эзэмшигчтэй этгээд бол тендерийн үнэлгээний үнийн 6 хувь - 20 хувиас дээш ба 50 хувиас доош дотоодын хувьцаа эзэмшигчтэй этгээд бол тендерийн үнэлгээний үнийн 8 хувь
9. Кыргыз	Төрийн худалдан авалтын тухай хууль /2004/ Закон Кыргызской Республики “О государственных закупках” от 24 мая 2004 года № 69	Дотоодын нийлүүлэгчидэд үзүүлэх хөнгөлөлтийг хуулийн 3-р зүйлээр зохицуулна. 3.1-д зааснаар төрийн байгууллагын зөвшөөрсний дагуу захиалагчийн зүгээс тендерийн захиалгын дүнгээс хамаарч КБНУ-ын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн барааны санал болгосон үнийн дүнгийн 20 хүртэлхи хувийн хөнгөлөлт, мөн ажил гүйцэтгэх дотоодын аж ахуй нэгжид 10 хувийн хөнгөлөлт тус тус үзүүлнэ. 3.2-д зааснаар хэрэв КБНУ-ын нутаг дэвсгэрт хийгдэж байгаа ажил гүйцэтгэгч нь тухайн орон нутгаас ажиллах хүч авсан, мөн 30-аас багагүй хувийн түүхийн эд, материал хэрэглэж байгаа бол захиалагч хөнгөлөлт үзүүлэнэ. Хуулийн 3.1, 3.2-д зааснаас бусад тохиолдолд худалдан авах үйл явцад дотоод, гадаадын нийлүүлэгчидэд тэгш боломж олгоно.
Болгар	Төрийн худалдан авалтын тухай хууль Law on Public Procurement state gazette, no. 56/22.06.1999	Дотоодын нийлүүлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх боловч ямар хөнгөлөлт үзүүлэхийг Тендерийн Хороо шийднэ.

ШҮҮХИЙН ЭРХЭЛ ХАМГААЛАГДСАН

Мавритан	Төрийн худалдан авалтын тухай хууль The public procurement act 2006	Дотоодын нийлүүлэгчид үзүүлэх хөнгөлөлтийг хуулийн 17-18-р зүйлээр зохицуулсан бөгөөд нарийн зохицуулалтыг өмнөх практиктаас ишлэн зохицуулж болно. 17. Нээлттэй үндэсний тендер Төсвийн байгууллага нь нээлттэй сурталчилгаат тендерт оролцогсдыг зөвхөн Мавритан улсын иргэд, аж ахуйн нэгжээр хязгаарлаж болно. 18. Нээлттэй олон улсын тендер (1) Нээлттэй олон улсын тендерийг дараах үед зарлана. (а) Худалдан авалтын үнийн дүн нь тодорхойлогдсон босго дүнгээс илүү үед (б) Нийлүүлэх гэж буй бараа, ажил үйлчилгээ нь Мавритан Улсын 1-с илүү нийлүүлэгчээс өрсөлдөөнт үнэ болон бусад шаардлагатай нөхцлүүдээр авах боломжгүй, (в) Нээлттэй үндэсний тендер зарлахад санал ирээгүй үед шаардлагатай бараа, ажил үйлчилгээг олон улсын нийлүүлэгчдээс нийлүүлнэ. (2) Төсвийн байгууллага нь нээлттэй олон улсын тендер зарласан тохиолдолд үндэсний болон бүс нутгийн бараа бүтээгдэхүүн болон үндэсний үйлдвэрлэгч, оролцогчдыг хуулийн хүрээнд гадаадын оролцогчдоос эрхэмлэн үзэж болно.
Нигер	Төрийн худалдан авалтын тухай хууль Public procurement act, 2007	6-р бүлэг. 34-р зүйл (1) Бараа, ажил үйлчилгээ худалдан авч буй байгууллага нь тендерийг үнэлэх явцдаа дотоодын нийлүүлэгчийг гадаадын нийлүүлэгчээс, эсхүл дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг гадаадад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээс давуу үзэж болно. (2) Дотоодын аж ахуйн нэгж, оролцогчид аливаа давуу эрх олгох тохиолдолд ямар хэлбэрийн давуу эрх олгохыг, энэ эрхийг эдлэхийн тулд ямар нөхцлийг хангасан байхын тендерийн материал дээр тодорхой заах. (3) Зөвхөн олон улсын өрсөлдөөнт тендерийн үед давуу эрх олгож болно. (4) Хороо нь дээрх давуу эрхийн хязгаар, хэм хэмжээ болон ямар бараа, ажил үйлчилгээнд хамаарах зэргийг үе үе тодорхойлно.

(Footnotes)

[1] Вьетнамын Улсын Тендерийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6. Олон улсын тендер гэж гадаадын болон дотоодын байгууллага аль аль нь оролцож байгаа тухайн тендерийн шаардлагыг хангасан гэрээлэгчийг сонгон шалгаруулах процессийг хэлнэ.

[2] Унгар улсын мөнгөний нэгж. Ойролцоогоор 1 ам.доллар = 225 форинт

[3] http://www.ua-tenders.com/legislation/kr/

ЗАРИМ ОРНУУДЫН НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА ЦАЛИНГИЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦАА, ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ

(ДҮН ШИНЖИЛГЭЭ)

Ц.Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Г. Гэрэл, Ч. Онончимэг

Оршил

УИХ -ын гишүүн Д.Ганхуягийн 2013 оны 01 дүгээр сарын 29 -ний өдрийн 12/777 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу тус судалгааг гүйцэтгэлээ. Судалгаанд авагдах орнуудыг захиалагчийн хүсэлтийн дагуу түүвэрлэхдээ Дэлхийн банкнаас гаргасан “Улс орнуудын орлогын түвшингийн ангилал”[15] болон НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ILO/-аас хийгдсэн судалгаа[16]-г гол шалгуур болгон авсан болно.

Судалгаанд хөгжлийн түвшингийн хувьд ялгаатай улс орнуудаас дор дурьдсан орнуудыг сонгон хөдөлмөрийн хөлсний дундаж үзүүлэлт болон нэг хүнд ногдох ДНБ-ний хоорондын харьцаа, хамаарлыг зэрэгцүүлэн судаллаа. “Улс орнуудын орлогын түвшингийн ангилал”-аар орлогын түвшин нэг хүнд ногдох ДНБ -ний хувьд:

a) Бага орлоготой (1,005$ буюу түүнээс доош): Тажикстан, Пакистан, Кыргызстан.
b) Дунд орлоготой (1,006 – 3,975 $): Украйн, Гүрж, Монгол, Армян, Филлиппин.
c) Дундаас дээш орлоготой (3,976 – 12,275 $): Хятад, Турк, Босни-Герцеговин, Аргентин, Малайз.
d) Өндөр орлоготой (12,276$ буюу түүнээс дээш): Люксембург, АНУ, Швед, Канад, Австрали зэрэг болно.

Судалгааны зорилго

Улс орны хүн амын дундаж цалин хөлс нь тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын амьжиргааны түвшингээс авахуулан эдийн засаг, нийгмийн олон чухал үзүүлэлтийг илэрхийлж байдаг. Онолын хувьд, хөдөлмөр бол онцлог шинжтэй таваар бөгөөд үнэ нь цалин хөлсний хэлбэрээр илэрхийлдэг. Хүн амын орлогын дийлэнх хэсэг нь цалин хөлсний орлого байдаг бөгөөд үүнээс шалтгаалан хэрэглээний барааны эргэлт, түүний үнийн түвшин, хэлбэлзэл нь цалин хөлсний түвшнээс хамааралтай байдаг.

Энэхүү судалгааны үр дүнд дэлхийн бусад орнуудын /72 орноор/ эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ болон цалин хөлсний дундаж үзүүлэлтийн талаарх лавлагаа мэдээлэл гаргаснаас гадна эдгээр үзүүлэлтүүдийн хоорондын харьцаа, уялдааг холбоог эдийн засгийн эконометрик шинжилгээний аргаар 18 орны хувьд тооцоолж, уялдаа холбоог харуулахыг зорьсон болно.

Судалгааны агуулга, үр дүн

Судалгаанаас үзэхэд, улс орнуудын хувьд нэг хүнд ногдох ДНБ хэмжээ өндөр байх тутам тухайн улсын хүн амын дундаж цалингийн хэмжээ нэмэгдэж байна. Гэвч тухайн орнуудын хувьд дундаж цалингийн хэмжээг нарийвчлан тодорхой гаргасан эсэх нь эргэлзээтэй байгаа юм. Тухайлбал: Өндөр орлоготой болон дундаас дээш орлоготой улс орнуудын

[15] http://data.worldbank.org/about/country-classifications/country-and-lending-groups

[16] http://www.bbc.co.uk/news/magazine-17543356

хувьд нийт хүн амын 80 - 90 орчим хувь нь ажил эрхлэн, тогтмол цалин хөлс авдаг бол дунд ба дундаас доош орлоготой Зүүн Азийн орнуудын хувьд хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 25 хувь нь л тогтмол цалин авдаг байна/

- Судалгааны эхний хэсэгт лавлагаа мэдээллийг бэлтгэх зорилгоор нийт 72 орны нэг хүнд ногдох ДНБ болон дундаж цалингийн хэмжээг тухайн улсын эдийн засгийн өсөлтийн хэмжээтэй харьцуулан хүснэгтээр гаргав. /Хавсралт/ -д зарим улсын дундаж цалинг ажил мэргэжлийн салбараар нь ангилан гаргасан/.

  Судалгаанаас үзэхэд, хамгийн өндөр цалин хөлсний түвшинд /4089 ам доллар/ байгаа Люксембургт ажил хөдөлмөр эрхэлдэг хүн хамгийн бага түвшинд /227ам доллар/ байгаа Тажикстанд хөдөлмөр эрхэлдэг хүнээс даруй 18 дахин өндөр цалин авдаг байна.

  Монгол улсын хувьд дундаж цалингийн хэмжээ 415 ам.доллар байна хэмээн Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас тооцсон байна. Энэ үзүүлэлтээр Монгол улс жагсаалтад багтсан 72 орны 66-д багтсан бөгөөд 415 ам.доллар гэдэг бол дэлхийн дундаж цалин /1500 ам доллар/ -аас 3.5 дахин бага гэж ойролцоогоор тооцож байна. Үүнийг Люксембургтэй харьцуулвал 9, АНУ -тай харьцуулбал 7 дахин бага байна. Мөн Монгол улсын цалин хөлсний дунджаас БНСУ-6, Швед 7, Чех 4 дахин өндөр цалин хөлстэй байна.

- Судалгааны хоёр дах хэсэгт хөгжлийн түвшингээр ялгаатай нийт 18 улсыг сонгон, тэдгээрийн дундаж цалин болон нэг хүнд ногдох ДНБ хэмжээний хоорондын хамаарлыг эконометрикийн регрессийн шинжилгээний аргаар тооцсон болно. Шинжилгээний дүнгээс үзэхэд, нэг хүнд ногдох ДНБ-нээс дундаж цалингийн хэмжээ хүчтэй хамааралтай бөгөөд нэг хүнд ногдох ДНБ-ны хэмжээ 100 ам.доллараар нэмэгдэхэд дундаж цалин 10.6 ам.доллараар нэмэгдэж байна гэсэн тооцоо гарч байна. Тооцооны эхний шатанд сонгосон 18 орноор хамаарлын шинжилгээ хийсэн бөгөөд утгын алдааг засахдаа өндөр орлоготой 5 орныг хасаж, бага, дунд, дундаас дээш орлоготой үлдсэн 13 орны дундажийг авч үзэхэд дээрх тооцоо гарсан болно.

* * *

1. Зарим орнуудын дундаж цалин хөлс болон нэг хүнд ногдох ДНБ хэмжээний талаархи лавлагаа, мэдээлэл

НҮБ -ын Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ILO/-аас 2012 оны байдлаар дэлхийн 72 орны хөдөлмөрийн хөлсний судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд дэлхийн хэмжээнд хүн амын дундаж цалин 1500 орчим ам.доллар бөгөөд улс орны эдийн засаг, амьжиргааны түвшин зэргийн нөлөөлөөс шалтгаалан харилцан адилгүй байна. Гэвч ILO нь энэхүү судалгаандаа хүн амын цалин хөлсний хэмжээг бүрэн тооцох боломжгүй, өнөөгийн хөгжиж буй ихэнх улс орны иргэдийн хувьд дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэдэг учир цалин хөлсний хэмжээ харилцан адилгүй, тооцох боломжгүй байгаа талаар дурьдсан байна.

Судалгааны энэхүү хэсэгт дэлхийн улс орнуудын цалингийн дундаж ба тухайн улсын нэг хүнд ногдох ДНБ, эдийн засгийн өсөлтийг хүснэгтээр харьцуулан гаргалаа.

Хүснэгт 1.

- Дэлхийн улс орнуудын дундаж цалин ба нэг хүнд ногдох ДНБ /ам долл -р/ лавлагаа /2011 - 2012 оны байдлаар/

№	Улс	Дундаж цалин /ам.долл/[1]	Нэг хүнд ногдох ДНБ хэмжээ[2] ам.долл	Эдийн засгийн өсөлт[3] %
1	Люксембург	4089	114 508	1.7
2	Норвеги	3678	98 102	1.4
3	Австри	3437	49 609	2.7
4	АНУ	3263	48 112	1.7
5	Их Британи	3065	39 038	0.8
6	Бельги	3035	46 663	1.8
7	Швед	3023	57 091	3.9
8	Ирланд	2997	48 423	0.7
9	Финлянд	2925	48 823	2.7
10	БНСУ	2903	22 424	3.6
11	Франц	2886	42 377	1.7
12	Канад	2724	50 345	2.5
13	Герман	2720	44 060	3.0
14	Сингапур	2616	46 241	4.9
15	Австрали	2610	60 979	1.9
16	Кипр	2605	30 670	0.5
17	Япон	2522	45 903	-0.7
18	Итали	2445	36 103	0.4
19	Исланд	2431	43 969	0.7
20	Испани	2352	-	-
21	Грек	2300	25 622	-7.1
22	Шинэ Зеланд	2283	36 254	1.0
23	Өмнөд Африк	1838	8 070	3.1
24	Мальт	1808	21 209	2.1
25	Израиль	1804	31 282	4.7
26	Чех	1786	20 579	1.9
27	Хорват	1756	14 180	-0.0
28	Турк	1731	10 524	8.5
29	Катар	1690	92 501	18.8
30	Хонконг	1545	35 156	4.9
31	Польш	1536	13 463	4.3
32	Словак	1385	17 646	3.3
33	Унгар	1374	13 866	1.7
34	Македон	1345	-	-
35	Босни-Герцеговин	1338	4 821	1.7
36	Эстони	1267	16 533	8.3
37	Орос	1215	13 089	4.3
38	Ямайка	1135	5 330	-
39	Литва	1109	13 339	5.5

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

40	Аргентин	1108	10 942	8.9
41	Латви	1098	12 726	5.9
42	Серби	1058	6 310	2.0
43	Чили	1021	14 394	6.0
44	Ботсван	996	8 533	5.7
45	Малайз	961	9 977	5.1
46	Беларус	959	5 820	5.3
47	Румын	954	8 405	-0.4
48	Бахрейн	917		-
49	Панам	831	7 498	10.6
50	Маврикий	783	8 755	4.1
51	Бразил	778	12 594	2.7
52	Макао	758	65 550	20.7
53	Казахстан	753	11 357	7.5
54	Болгар	750	7 158	1.7
55	Колумб	692	7 104	5.9
56	Украйн	686	3 615	5.2
57	Хятад	656	5 445	9.3
58	Мексик	609	10 047	3.9
59	Гүрж	603	3 203	7.0
60	Азарбайжан	596	6 916	1.0
61	Египет	548	2 781	1.8
62	Тайланд	489	4 972	0.1
63	Армян	471	3 305	4.6
64	Доминикан	462	5 530	4.5
65	Молдав	438	1 967	6.4
66	Монгол	415	3 129	17.5
67	Сири	364		-
68	Кыргызстан	336	1 075	5.7
69	Энэтхэг	295	1 489	6.9
70	Филиппин	279	2 370	3.9
71	Пакистан	255	1 189	3.0
72	Тажикистан	227	935	7.4

Дээрх 72 улсаас захиалагчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу улс орны хөгжлийн түвшинээс шалтгаалан 18 улсыг сонгон дундаж цалин ба нэг хүнд ногдох ДНБ-ний хоорондын хамаарлыг нарийвчлан судалсан болно.

* * *

Хүснэгт 2.

- Судалгаанд авагдсан хөгжлийн түвшингээр ялгаатай зарим орны нэг хүнд ногдох ДНБ ба дундаж цалин хөлсний хэмжээ /ам долл/ /2011 - 2012 оны байдлаар/

№	Орнууд	1 хүнд ногдох ДНБ	Дундаж цалин хөлс
Бага орлоготой орнууд (1,005 $ буюу түүнээс доош)			
1	Тажикстан	935	227
2	Пакистан	1089	255
3	Кыргызстан	1 075	336
Дунд орлоготой орнууд (1,006 – 3,975 $)			
4	Украйн	3 615	686
5	Гүрж	3 203	603
6	Монгол	3 129	415
7	Армян	3 305	471
8	Филиппин	2 370	279
Дундаас дээш орлоготой орнууд (3,976 – 12,275 $)			
9	Хятад	5 445	656
10	Турк	10 524	1731
11	Босни-Герцеговин	4 821	1338
12	Аргентин	10 942	1108
13	Малайз	9 977	961
Өндөр орлоготой орнууд (12,276 $ буюу түүнээс дээш)			
14	Люксембург	114 508	4089
15	АНУ	48 112	3263
16	Швед	57 091	3023
17	Канад	50 345	2724
18	Австрали	60 979	2610



Зураг 1. Дэлхийн дундаж цалин ба орнуудын дундаж цалингийн хэмжээ

Хавсралт: Зарим орнуудын дундаж цалинг салбараар ангилбал

1/ Филиппин

Салбар	Дундаж цалин /песо/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Санхүү	29,075	715.24	21
Газ- Эрчим хүч- Ус	21,163	520.60	18
Тээвэр харилцаа	15,907	391.31	14
Уул уурхай-ашигт малтмал	13,298	327.13	13
Бүх салбарын дундаж орлого	10,719	263.68	11
Үйлдвэрлэл	11,166	274.68	11
Үл хөдлөх хөрөнгө	9,770	240.34	11
Боловсрол	9,641	237.17	11
Барилга байгуулалт	7,438	182.97	9
Зочид буудал- Ресторан	6,685	164.45	8

2/ Хятад

Салбар	Дундаж цалин /юань/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Санхүү	2,249	360.09	8
Газ- Эрчим хүч- Ус	1,817	290.92	8
Үл хөдлөх хөрөнгө	1,559	249.61	8
Тээвэр харилцаа	1,532	245.29	8
Уул уурхай-ашигт малтмал	1,406	225.12	8
Боловсрол	1,356	217.11	8
Бүх салбарын дундаж орлого	1,335	213.75	8
Үйлдвэрлэл	1,169	187.17	8
Барилга байгуулалт	1,064	170.36	8

3/ АНУ

Салбар	Дундаж цалин / ам.доллар/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Газ- Эрчим хүч- Ус	4,732	4,732	22
Уул уурхай-ашигт малтмал	3,748	3,748	21
Барилга байгуулалт	3,230	3,230	20
Үйлдвэрлэл	2,928	2,928	19

Бүх салбарын дундаж орлого	2,821	2,821	18

4/ Канад

Салбар	Дундаж цалин /Канад доллар/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Уул уурхай-ашигт малтмал	5,677	5,610.79	37
Газ- Эрчим хүч- Ус	4,615	4,561.18	35
Санхүү	4,053	4,005.73	32
Үйлдвэрлэл	3,834	3,789.29	31
Барилга байгуулалт	3,816	3,771.50	31
Боловсрол	3,491	3,450.29	29
Тээвэр харилцаа	3,484	3,443.37	29
Үл хөдлөх хөрөнгө	3,306	3,267.44	29
Бүх салбарын дундаж орлого	3,156	3,119.19	28

5/ Швед

Салбар	Дундаж цалин / крона/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Уул уурхай-ашигт малтмал	27,893	4,419.10	34
Газ- Эрчим хүч- Ус	23,673	3,750.53	32
Барилга байгуулалт	22,684	3,593.84	32
Үйлдвэрлэл	21,052	3,335.28	31
Тээвэр харилцаа	20,199	3,200.14	31
Бүх салбарын дундаж орлого	19,237	3,047.73	30
Үл хөдлөх хөрөнгө	18,325	2,903.24	30
Боловсрол	17,326	2,744.97	30
Зочид буудал- Ресторан	13,700	2,170.50	29

6/ Австрали

Салбар	Дундаж цалин / Автрали доллар/	Дундаж цалин / ам.доллар/	Татварын суутгал
Уул уурхай-ашигт малтмал	6,144	6,358.96	26
Газ- Эрчим хүч- Ус	4,769	4,935.85	23
Санхүү	4,591	4,751.63	22
Боловсрол	4,136	4,280.71	20

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Тээвэр харилцаа	4,081	4,223.78	20
Үйлдвэрлэл	4,065	4,207.22	20
Барилга байгуулалт	4,056	4,197.91	20
Үл хөдлөх хөрөнгө	3,904	4,040.59	20
Бүх салбарын дундаж орлого	3,848	3,982.63	20
Зочид буудал- Ресторан	2,935	3,037.69	18

Эх сурвалж: http://www.worldsalaries.org/

2. Нэг хүнд ногдох ДНБ ба дундаж цалингийн хоорондын хамаарлын шинжилгээ

Хүснэгт 2 -с үзэхэд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ хэдий чинээ өндөр байна тухайн улсын хүн амын дундаж цалин өндөр байна гэсэн ерөнхий дүгнэлт гарч байна. Гэвч энэхүү дүгнэлт нь харьцангуй өрөөсгөл бөгөөд эдийн засгийн аргаар тооцож буй дундаж цалин болон 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ нь төдийлөн бодитой бус гэдгийг дурьдах нь зүйтэй болов уу.

Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг доорхи томьёолоор тодорхойлдог.

X= GDP / N = нэг хүнд ногдох GDP

Х буюу нэг хүнд ногдох ДНБ -ний хэмжээг орлогын аргаар тооцсон тохиолдолд компаний ашиг, татвар, элэгдэл, Рент, цалин зэргээр задрах бөгөөд тухайн орны хөгжлийн түвшин, GDP-д эзлэх салбарын бүтэц, салбар хоорондын тэнцэл, төрийн оролцоо зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан цалингийн эзлэх хувь харилцан адилгүй байна. Судалгааны энэ хэсэгт нэг хүнд ногдох ДНБ болон дундаж цалингийн хооронд ямар хамааралтайг болон нэг хүнд ногдох ДНБ хэмжээ өсөхөд дундаж цалин хөлст ямар хувиар нөлөөлж болох эсэхийг батлах зорилгоор Хүснэгт 2 -т дурьдсан орнуудын мэдээлэл дээр үндэслэн статистик шинжилгээний судалгааны багц программ Eviews 3.1 дээр регрессийн шинжилгээг хийхэд үр дүн нь дараах байдалтай гарч байна.

Dependent Variable: Y				
Method: Least Squares				
Date: 02/21/13 Time: 12:07				
Sample: 1 18				
Included observations: 18				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	584.4268	128.9462	4.532331	0.0003
X	0.036415	0.003434	10.60334	0.0000
R-squared	0.875419	Mean dependent var		1376.389
Adjusted R-squared	0.867633	S.D. dependent var		1225.742
S.E. of regression	445.9527	Akaike info criterion		15.14274
Sum squared resid	3181981.	Schwarz criterion		15.24167
Log likelihood	-134.2847	Hannan-Quinn criter.		15.15638
F-statistic	112.4309	Durbin-Watson stat		1.516065
Prob(F-statistic)	0.000000			

Хүснэгт 2 -т дурьдсан нийт 18 улсын хувьд хэрэв нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 100 ам.долл-р нэмэгдэхэд дундаж цалин 3.6 ам.долл-р нэмэгдэх дүн гарч байна. Регрессийн

утгын алдааг тооцон хамгийн өндөр орлоготой улс орнуудыг хасч дундаас дээш орлоготой 13 улсаар дахин шинжилгээ хийхэд:

Dependent Variable: Y				
Method: Least Squares				
Date: 02/21/13 Time: 12:19				
Sample: 1 13				
Included observations: 13				
Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	199.5531	125.8389	1.585782	0.1411
X	0.107096	0.021735	4.927464	0.0005
R-squared	0.688208	Mean dependent var		697.3846
Adjusted R-squared	0.659863	S.D. dependent var		463.7887
S.E. of regression	270.4874	Akaike info criterion		14.17897
Sum squared resid	804797.8	Schwarz criterion		14.26588
Log likelihood	-90.16328	Hannan-Quinn criter.		14.16110
F-statistic	24.27990	Durbin-Watson stat		1.459465
Prob(F-statistic)	0.000451			



Эндээс үзэхэд дээр дурьдсан 13 улсын хувьд **С буюу хамгийн бага утга** /цалин хөлсний доод хэмжээ/ 199.5 ам доллар байх бөгөөд нэг хүнд ногдох ДНБ хэмжээ 100 ам долл-р нэмэгдэхэд **Х утга** нь 10.7 ам долл-р нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл дээрх улс орнуудын хувьд дундаж цалин доод түвшин нь 200 орчим ам.долл байх бөгөөд нэг хүнд ногдох ДНБ хэмжээ нь 100 ам.долл-р нэмэгдэхэд дундаж цалингийн хэмжээ нь 10.7 ам долл-р нэмэгдэж байна гэсэн үг юм.

Эндээс корреляцийн шинжилгээгээр дундаж цалин болон нэг хүнд ногдох ДНБ хоорондын хамаарлыг бодвол:

R_{xy} - Корреляцийн утга

$0 < /R_{xy}/ < 0,5$	• Дээрх үзүүлэлтүүд нь сул хамааралтай
$0,5 < /R_{xy}/ < 0,75$	• Мэдэгдэхүйц хамааралтай
$0,75 < /R_{xy}/ < 0,9$	• Хүчтэй хамааралтай
$0,9 < /R_{xy}/ < 0,99$	• Төгс хамааралтай

UTH.MN
СУДАЛГААНЫ САН

Хэрэв 0,75 -аас дээш хамааралтай тохиолдолд нэг хүнд ногдох ДНБ орлогоор тухайн улсын түвшин тодорхойлогддог.

Covariance Analysis: Ordinary			
Date: 02/21/13 Time: 12:20			
Sample (adjusted): 1 13			
Included observations: 13 after adjustments			
Covariance			
Correlation	X	Y	
X	11913829		
	1.000000		
Y	1275923.	198553.8	
	0.829583	1.000000	

Корелляцийн шинжилгээгээр хамаарлыг тооцоход $0 < /R_{xy}/ < 0,82$ буюу 1 хүнд ногдох ДНБ хэмжээ дундаж цалинтай хүчтэй хамааралтай байна.

* * *

Ашигласан материал

- http://data.worldbank.org/about/country-classifications/country-and-lending-groups
- http://www.bbc.co.uk/news/magazine-17543356
- http://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD/countries
- http://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG/countries
- http://www.worldsalaries.org/

- http://www.bbc.co.uk/news/magazine-17543356
- http://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD/countries
- http://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.KD.ZG/countries

АНУ –ЫН ТӨСӨВ ЗОХИОХ, БАТЛАХ, ХУВИАРЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ТОЙМ СУДАЛГАА

Ц. Норовдондог (Ph.D), Б. Дуламсүрэн

Гарчиг

1. АНУ -ын Холбооны засгийн газрын төсвийг зохиох, батлах үйл явцын тойм
   - 1.1 Төсвийн харилцааны эрх зүйн орчин
   - 1.2 Төсвийг зохиох, батлах үйл явцад оролцогч талууд ба тэдгээрийн үүрэг
   - 1.3 Ерөнхийлөгчийн жилийн төсвийг өргөн барих
   - 1.4 Төсвийн тухай Конгрессийн тогтоол
   - 1.5 Төсвийг тохируулах үйл явц
   - 1.6 Төсвийн тухай хууль, тогтоомжийн төрлүүд
2. АНУ-ын Холбооны Засгийн газрын зөвшөөрөл өгөх, төсөв хуваарилах үйл явц
   - 2.1. Зөвшөөрөл - Төсөв хувиарлах үйл явц
   - 2.2. Төсөв хуваарилах тухай хуулийн төсөл
   - 2.3. Төсвийг хэрэгжүүлэх

Ашигласан материал, эх сурвалж

Хавсралт 1. АНУ -ын төсвийн үе шатны схем
Хавсралт 2. АНУ -ын КонгрессийнТөсвийг зохиох, батлах хуваарь

* * *

Аливаа улсын төсөв гэдэг нь зөвхөн тодорхой хэмжээний хөрөнгийг төрийн мэдэлд хуримтлуулж зарцуулахдаа биш, тухайн улс орны хөгжлийн цаашдын урт хугацааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх гол хэрэгсэл байх ёстой. Энэ үүднээс манай улсын хувьд төсвийг үрэлгэн зардалд биш, бэлэнчлэх сэтгэлгээний нийгэмд биш, тодорхой бүтээн байгуулалт, үйлдвэрлэлд чиглүүлж улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэх үүднээс төсөв хэлэлцэх чадавхийг сайжруулахад анхаарч, төсвийн үйл явцад гадаад улс орнуудын “сайн” туршлагыг судлан үзэх нь чухал юм. Тус судалгаанд АНУ-ын Холбооны засгийн газрын төсвийн харилцааны эрх зүйн зохицуулалт, төсөв зохиох, хянах, судалгаа дүгнэлт гаргах, батлах процессын талаар авч үзлээ.

1. АНУ -ын Холбооны засгийн газрын төсвийг зохиох, батлах үйл явцын тойм

1.1 Төсвийн харилцааны эрх зүйн орчин

АНУ-ын төсвийн төсөл боловсруулах үйл явцыг ил тод хэрэгжүүлэх зарчимтай бөгөөд Төсвийн төсөл боловсруулах, түүнийг батлах үйл явц нь Үндсэн хууль, Холбогдох хууль тогтоомж, Төлөөлөгчдийн танхим ба Сенатын дүрэм журам, эрх зүйн орчинд нийцсэн байна. АНУ-ын төсвийн харилцааны эрх зүйн үндсэн акт бол“ Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай“ (Congressional budget and Inpoundment Control Act.1974) хууль юм.

Одоогоос 30 гаруй жилийн өмнө энэхүү эрх зүйн актыг батлан гаргахаас өмнө төсвийн үйл

SHT.MN
СУДАЛГААНЫ САН

явцад Ерөнхийлөгч давуу эрхтэй байж хууль тогтоох засаглал болон гүйцэтгэх засаглалын хооронд төсвийн тэргүүлэх чиглэл, үзэл баримтлал, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар зөрчил, үл ойлголцол гарч байсан байна. Өөрөөр хэлбэл Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөвт Конгресс өөрийн зүгээс өөрчлөлт оруулах, Засгийн газрын зарлагад хяналт тавих, Конгрессийн 2 танхим санал бодлоо оруулах шаардлагатай байсан.

1974 онд Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хууль батлагдсанаар төсвийн харилцаатай холбоотой олон асуудлуудыг Конгресс засгийн газраасаа хараат бусаар шийдвэрлэх бололцоотой болжээ. Мөн төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, Засгийн газраас хараат бус, төвийн сахисан, үнэн зөв, шинжлэх ухааны үндэслэл, тооцоо бүхий судалгаа, шинжилгээ хийдэг, Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод төсөвтэй холбоотой мэдээ, мэдээлэл гаргаж өгдөг хүчирхэг нэгж шаардлагатай гэж үзсэн тул Конгрессийн дэргэд төсвийн шинжилгээ, судалгаагаар мэргэшсэн аппарат хараат бус Конгрессийн ажлын албатай эн зэрэгцэх статус бүхий, дараах нэгжүүдийг ажиллуулахаар хуульчилсан байна.

1. Конгрессийн төсвийн алба
2. Конгрессийн номын сангийн Судалгааны алба
3. Конгрессийн төрийн хариуцлагын алба
4. Конгрессийн төсвийн алба (CBO – Congresional budget office)

Бүтэц:

Энэхүү холбооны агентлаг нь 1974 онд Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хуулийн дагуу байгуулагдсан. 250 гаруй ажилтантай, тэдгээрийн 70 хувь нь эрдмийн зэрэг цолтой төсвийн мэргэжлийн шинжээч, эдийн засагчид болон нийгмийн бодлогын шинжээчид ажилладаг Тус алба нь дараахь хэлтэст хуваагдана:

- Төсвийн анализийн хэлтэс
- Эдийн засгийн анализийн хэлтэс
- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хэлтэс
- Макро эдийн засгийн хэлтэс
- Менежмент, бизнес, мэдээллийн үйлчилгээний хэлтэс
- Микро эдийн засгийн судалгааны хэлтэс
- Үндэсний аюулгүй байдлын хэлтэс
- Татварын анализийн хэлтэс

Сенатын ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын спикер нар Конгрессийн төсвийн албаны даргыг 4 жилийн хугацаатай хамтран томилдог ба аль ч танхим түүнийг тогтоолоор өөрчилж болдог. Чиг үүрэг: Конгрессийн хоёр танхимаас нилээд хэдэн жилийн нэгдсэн төсвийг батлах бөгөөд энэ нь хууль болж ёсчлогдохгүй, зөвхөн орлого, зарлагатай холбоотой хууль батлах үйл ажиллагаанд гарын авлага болно. Үүнд Конгрессийн төсвийн алба нь Конгресс болон Сенат, Танхимын Төсвийн хороонд судалгаа, шинжилгээ хийж өгөх бөгөөд ингэхдээ улс төрийн ямар нэгэн зөвлөмжийг баримтлахгүй.

Алба нь жил бүрийн 1-р сарын сүүлээр хуульд заасны дагуу дараагийн 10 жилийн орлого, зарлагын тооцоог багтаасан төсөв, эдийн засгийн төлөв байдлыг гаргаж өгдөг. Мөн Ерөнхийлөгчийг АНУ -ын нэгдсэн төсвийг Конгресст өргөн барьснаас хойш нэг сарын хугацаанд уг төсөвт бие даасан, хараат бус шинжилгээ тооцоолол хийж төсвийн асуудал хариуцсан байнгын хороодод хүргүүлдэг. Үүний зэрэгцээ Конгрессийн санал болгосон төсвийн төсөлд ч үнэлгээ тооцоолол хийнэ. Конгрессын хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тооцооллыг боловсруулж, хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрүүдийн явцын

үнэлгээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх зэргийг хийж сонирхогч талуудад хүргүүлдэг.

Төсвийг зохиох, батлах үйл явцад оролцогч талууд ба тэдгээрийн үүрэг:

АНУ -ын Төсөвийн зардлыг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. шууд гарах зардал,
2. эрх мэдлийн хүрээнд гарах зардал

Шууд гаргах зардал. Хууль тогтоомжид заагдсан уламжлалт зардлууд /тэтгэвэр тэтгэмж, халамж үйлчилгээ гэх мэт/ орно. Шууд гаргах зардал нь тухайн жилд Конгресс эсвэл Ерөнхийлөгчөөс ямар нэгэн хяналт, саналгүйгээр эрх зүйн актуудын дагуу шууд төсөвлөгддөг. Хөрөнгө нь шаардлага хангах шалгуур үзүүлэлт, төлбөрийн аргачлал дээр үндэслэгдэнэ. Хэрэв төсөвт зардалаас урьдчилан төлөвлөсөн зардал давах хандлагатай бол энэ талын тэтгэмжинд хамрагдах иргэдийн шалгуур үзүүлэлтийг нь өндөрсгөх замаар зохицуулалт хийдэг. /Сүүлийн жилүүдэд зардлын 55 орчим хувийг эзэлж байгаа/.

Эрх мэдлийн хүрээнд гаргах зардал**:** Төсөв хувиарлах эрх зүйн актуудад заагдсан бөгөөд тухайн жилд хөрөнгө оруулах шаардлагатай салбаруудад Конгрессийн шийдвэрийн дагуу төсөвлөх зардлууд багтдаг. Хэрэв тухайн салбар тухайн жилд төсөвлөсөн зардлаар зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд зардлыг буцаан татах замаар хяналт тавина. /Сүүлийн жилүүдэд зардлын 40 орчим хувийг эзэлж байна/

Төсвийг зохиох, батлах үйл явцад оролцогч талууд:

1. Удирдлага, төсөв эрхлэх газар (УТГ) нь дараах хоёр хэсэгтэй.
   - Ерөнхийлөгчид төсөв, холбогдох бусад асуудлаар туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий алба
   - Төсвийн гүйцэтгэлийн тогтолцоог удирддаг парламентийн төсвийн газар
2. Конгрессийн төсвийн алба (КТА**)** нь Конгрессийг эдийн засгийн мэдээллээр хангах үүрэг хүлээнэ. 1974 оны Конгрессийн төсөв ба зарцуулалтыг хянах актын дагуу байгуулагдсан. Тус газрын гол үүрэг нь холбооны төсөвтэй холбоотой шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл, шинжилгээ, үндсэн мэдээллээр хангах, төсвийн байнгын хороодод конгрессийн төсөв, төсөвтэй холбоотой асуудлаар туслалцаа үзүүлэх, төсвийн тухай бие даасан мэдээлэл, шинжилгээгээр хангах, хууль тогтоомжийн төслийн зардлын тооцоог гаргах явдал юм.
3. Төлөөлөгчдийн танхим, Сенатын төсвийн байнгын хороод
   - Төсвийн тухай тогтоолыг хариуцдаг
   - Төсвийн хэрэгжилтийг хариуцан хянах конгрессийн албан ёсны шинжээчид
   - Төсвийг тохируулах тухай багц хуулийн төсөл гаргах (хэрэв шаардлагатай бол)
4. Төлөөлөгчдийн танхим, Сенатын зөвшөөрөл өгөх болон хууль тогтоох байнгын хороод
   - Эрх мэдлийн хүрээнд гаргах зардалтай холбоотой хөтөлбөрүүдэд зөвшөөрөл өгөх асуудлыг хариуцдаг
   - Шууд гаргах зардлын тухай хууль тогтоомжийг хариуцдаг
5. Төлөөлөгчдийн танхим, Сенатын төсөв хуваарилах байнгын хороод

UIH.MN
ҮЗЭЖ АЖЛЫГ САН

- Эрх мэдлийн хүрээнд гаргах зардлын тухай бүх хууль тогтоомжийг хариуцдаг (байнгын, нэмэлт, зарцуулж буй төсвийн хуваарилалт)

6. Төлөөлөгчдийн танхимын татвар, хураамж, Сенатын санхүүгийн байнгын хороод
   - Орлогын тухай хууль тогтоомжийг хариуцдаг бөгөөд татварыг нэмэх, хасах гэх мэт орлоготой холбоотой бүхий л өөрчлөлт, тогтоолуудыг хариуцан гаргана.
   - Мөн зайлшгүй гаргах зардлын тухай хууль тогтоомжийг хариуцдаг.

Ерөнхийлөгчийн жилийн төсвийг өргөн барих

Ерөнхийлөгчийн төсөв
- Холбооны засгийн газрын зарлага, орлого.
- Ерөнхийлөгчийн ирэх жилийн төсөвт оруулах саналууд
- 1 дүгээр сарын эхний даваа гаригаас 2 дугаар сарын эхний даваа гаригийн хооронд өргөн барьдаг.

АНУ -д Ерөнхийлөгчөөс Конгресст өргөн барьсан төсвийг хянах, судалгаа дүгнэлт хийх, хянах, батлах процесс нь маш нарийн процесс юм. Ерөнхийлөгчийн төсвийн удирдлагын газар нь Холбооны улсын хэмжээний нэгдсэн төсвийг боловсруулан Конгресст 2-р сарын эхний Даваа гарагт өргөн барина. Конгресст өргөн барьсан төсвийг хянах, батлах ажиллагаа нь нүсэр зохион байгуулалт, бүтэцтэй бөгөөд энэхүү үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг Конгрессийн судалгааны алба, Конгрессийн төсвийн алба, Төрийн хариуцлагын алба гэсэн үндсэн 3 алба байна.

Төсвийн тухай Конгрессийн тогтоол

Конгрессийн төсөв зохиох, батлах үйл явцын гол хэсэг нь
- Төлөөлөгчдийн танхим, Сенат хэлэлцэн тохиролцох;
- Бүх төсвийн тухай хууль тогтоомжид шалгуур үзүүлэлт тогтоох; конгрессийн төсвийн тэргүүлэх чиглэлүүдийг тоймлох;
- Ерөнхийлөгч гарын үсэг зурах шаардлагагүй бөгөөд хууль тогтоомж болж гардаггүй;
- Төлөөлөгчдийн танхим, Сенатын хэлэлцэн тохиролцох хугацаа 4 дүгээр сарын 15 байдаг.

Төсвийн тухай тогтоолд зайлшгүй тусгах шаардлагатай агуулга:
- Зарлага, орлого, алдагдал/үлдэгдэл, өрийн нийт хэмжээ
- Бүх үндсэн үйл ажиллагааны төрөл зүйлийн зарлагын хэмжээ
- Байнгын хороодын зарлагын хэмжээ

Төсвийн тухай тогтоолд сонгож хэрэглэх агуулга:
- Төсвийг тохируулах тухай заавар чиглэл
- Дүрэм журмын заалтууд

Төсвийн тухай тогтоолд хуралдааны дэгээр хэрэгжүүлэх:
- Зарлагын дээд хязгаар ба орлогын доод хязгаар
- Байнгын хороодод хуваарилах хөрөнгө

* Сенат дээр эдгээр хуралдааны дэгээс татгалзах горимын саналд тавны гуравын санал шаардлагатай

1.5 Төсвийг тохируулах үйл явц

Зорилго нь төсвийн тухай тогтоолд заасан шууд гаргах зарлага, орлогын бодлогыг хэрэгжүүлэх явдал юм. Хоёр шатлалтай үйл явц:

1. Төсвийг тохируулах заавар чиглэлийг төсвийн тухай тогтоолд тусгадаг.
2. Хууль тогтоох байгын хороод үйлчилж буй хуульд өөрчлөлт оруулахыг зөвлөдөг. Тусгай дүрэм журмын дагуу авч хэлэлцдэг

Төсвийн тухай тогтоолд заасан зарлагын хэмжээний жишээ (16) Эрх зүйн газар (750):

2009 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $55,783,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $49,853,000,000.

2010 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $53,400,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $52,043,000,000.

2011 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $53,892,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $55,589,000,000.

2012 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $53,738,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $55,468,000,000.

2013 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $53,569,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $54,537,000,000.

2014 оны төсвийн жил:

(A) Төсвийн шинэ эрх мэдэл, $54,247,000,000.
(B) Зарцуулах хөрөнгө, $54,058,000,000.

Төсвийн тухай тогтоолд заасан зарлагын хэмжээний жишээ:

1) ХОЛБООНЫ ЗАСГИЙН ГАЗРЫН ОРЛОГО – Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор:

(A) Холбооны засгийн газрын орлогын зөвлөж буй хэмжээ:

2009 оны төсвийн жил: $1,532,571,000,000.
2010 оны төсвийн жил: $1,653,682,000,000.
2011 оны төсвийн жил: $1,929,625,000,000.
2012 оны төсвийн жил: $2,129,601,000,000.
2013 оны төсвийн жил: $2,291,120,000,000.
2014 оны төсвийн жил: $2,495,781,000,000.

(B) Холбооны засгийн газрын орлогын нийт хэмжээ өөрчлөгдөх нөлөө үзүүлэх тоо хэмжээ:

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2009 оны төсвийн жил: $0.

2010 оны төсвийн жил: -$12,304,000,000.

2011 оны төсвийн жил: -$159,006,000,000.

2012 оны төсвийн жил: -$230,792,000,000.

2013 оны төсвийн жил: -$224,217,000,000.

2014 оны төсвийн жил: -$137,877,000,000.

1.6 Төсвийн тухай хууль, тогтоомжийн төрлүүд:

Холбооны засгийн газрын зарлага, орлогод үзүүлэх шууд бус нөлөө

- Төсвийн тухай Конгрессийн тогтоол
- Эрх мэдлийн хүрээнд гаргах зардалд өгөх зөвшөөрөл

Холбооны засгийн газрын зарлага, орлогод үзүүлэх шууд нөлөө

- Төслийг тохируулах тухай хууль тогтоомж
- Орлогын тухай хууль тогтоомж
- Шууд гаргах зардлын тухай хууль, тогтоомж
- Төсөв хуваарилах тухай хууль тогтоомжийн төсөл (эрх мэдлийн хүрээнд гаргах зардлын тухай хууль тогтоомж)

2. АНУ-ын Холбооны Засгийн газрын зөвшөөрөл өгөх, төсөв хуваарилах үйл явц

2.1 Зөвшөөрөл- Төсөв хувиарлах үйл явц

Зөвшөөрөл нь - Холбооны засгийн газар, үйл ажиллагаа эсвэл хөтөлбөрийг эхлүүлэж эсвэл үргэлжлүүлж буй хуулийн заалт.

Төсөв хувиарлах – Хөтөлбөрт гол төлөв тодорхой хугацааны туршид хөрөнгө гаргахыг заадаг хуулийн хэллэг.

- Зөвшөөрсөн Төлөөлөгчдийн танхим, Сенатын дүрэм журам шаардлагатай
- Зөвшөөрөгдөөгүй төсвийн хувиарлалтыг хориглодог
- Төсөв хуваарилах тухай хуулийн төсөлд тусгасан хуулийн заалтуудыг хориглодог (гэхдээ хязгаарлах заалтуудыг оруулж болно)

Зөвшөөрөл өгөхөд хэрэглэх үг хэллэг

ХАА -тай холбоотой ашигтай мэдээллийг олж авах, АНУ-ын ард түмний дунд тухайн үгийн хамгийн ерөнхий, төгс төгөлдөр утгаар нь түгээх, шинэ, чухал үр, ургамлыг худалдан авах, тарьж ургуулах, ард түмэнд хуваарилах ерөнхий чиг үүрэгтэй ХАА-н яамыг ... үүгээр байгуулав. Тус байгууллага нь өөрийн сансар, онгоц зохион бүтээж турших үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой суурь ба хэрэглээний судалгаа шинжилгээ, технологийн хөгжил, шинэ загварын туршилтын чиглэлийн шинэ бүтээлийг дэмжих зорилгоор өрсөлдүүлж бэлэн мөнгөөр шагнал олгох хөтөлбөр хэрэгжүүлж болно. Тус байгууллага нь зөвхөн энэхүү заалтын дагуу шагнал олгох зорилгоор хөтөлбөр хэрэгжүүлж болно.

2011 оны төсвийн жилд эрэг орчмын харуулд шаардагдах зардалд хуваарилахыг зөвшөөрсөн хөрөнгө:

1. Эрэг орчмын харуулын үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд, $ 24,500,000 -оос $

6,970,681,000 -ыг 1990 оны Газрын тосны бохирдлын тухай хууль (33 U.S.C. 2712(a)(5)) -ийн 1012 дугаар зүйлийн (a) (5) -д заасан зорилгыг хангах зорилгоор Газрын тосны бохирдлыг арилгах итгэмжлэгдсэн хөрөнгийн сангаас гаргахыг зөвшөөрөв.

2. Хөлөг жолоодоход туслах эд хөрөнгө, хилийн ба хилийн чанад дахь барилга байгууламж, холбогдох тоног төхөөрөмж зэрэг усан онгоц, нисэх онгоц худалдан авах, барьж байгуулах, сэргээх, сайжруулахад $1,640,000,000 -оос (A) $20,000,000 -ыг 1990 оны Газрын тосны бохирдлын тухай хуулийн 1012 дугаар зүйлийн (a)(5)-д заасан зорилгыг хангах зорилгоор зарцуулж дуусах хүртэл хүрэлцээтэй байлгахын тулд Газрын тосны бохирдлыг арилгах итгэмжлэгдсэн хөрөнгийн сангаас гаргана; (B) $1,233,502,000 -ыг Гүний усны нэгдсэн тогтолцооны хөтөлбөрт хуваарилахыг зөвшөөрөв; (C) $100,000,000-ыг хөлөг жолоодох хилийн барилга байгууламж, туслах эд хөрөнгөд хуваарилахыг зөвшөөрөв. Энэхүү эрх зүйн актын зорилгыг хангахад шаардлагатай хөрөнгийг хуваарилахыг зөвшөөрөв.

2.2 Төсөв хуваарилах тухай хуулийн төсөл

Төсвийг хуваарилах гурван төрлийн арга хэмжээ байна. Үүнд:

- Байнгын төсвийн хуваарилалт: ирэх төсвийн жилийн хөрөнгө (жилийн төсвийг хуваарилах 12 арга хэмжээ)
- Зарцуулж буй төсвийн хуваарилалт: байнгын төсвийн хуваарилалтыг хуульчлах хүртэл хуваарилах төсвийн жилийн эхэн үеийн түр зуурын хөрөнгө
- Нэмэлт төсвийн хуваарилалт: төсвийн жилийн нэмэлт хөрөнгө; гол төлөв “онц байдал”-ын гэж тодорхойлдог.

Төсөв хувиарлах, төсөв дахин хувиарлах үйл явц зарлагын хязгаарыг бий болгодог.

- Төсөв хувиарлах байнгын хороод төсвийн тухай тогтоолоор хувиарласан хөрөнгийг хүлээн авдаг бөгөөд энэ нь эрх мэдлийн хүрээнд гаргах нийт зарлагад тавигдах хязгаар болдог.
- Түүний дараа Төсөв хувиарлах байнгын хороод энэхүү хөрөнгийг 12 дэд хороонд дахин хувиарладаг бөгөөд энэ нь төсөв хувиарлах хуулийн төсөл бүрт тавигдах хязгаар болдог
- Тухайн чуулганы явцад эдгээр дэд хорооны зарлагын хэмжээг өөрчилж болно

* /Сенат дээр эдгээр хэмжээнээс татгалзах горимын саналд тавны гурвын санал шаардлагатай/

Төсөв хувиарлах 12 дэд хороод

- ХАА, хөдөөгийн хөгжил
- Худалдаа, хууль зүй, шинжлэх ухаан
- Батлан хамгаалах
- Эрчим хүч ба усны асуудал
- Санхүүгийн үйлчилгээ, засгийн газар
- Дотоодын аюулгүй байдал
- Дотоод хэрэг, байгаль орчин
- Хөдөлмөр, эрүүл мэнд, хүн амын үйлчилгээ, боловсрол
- Хууль тогтоох засаглал
- Цэргийн барилга байгууламж, ахмад дайчдын асуудал
- Улс төр, гадаад үйл ажиллагаа
- Тээвэр, орон сууц, хот байгуулалт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Төсөв хувиарлах үйл явц дахь Байнгын хороодын үйл ажиллагаа:

- Төсөв хувиарлах дэд хороод Ерөнхийлөгчөөс төсвийн талаар гаргасан хүсэлтийг хэлэлцдэг.
- Төсөв хувиарлах дэд хороо бүр байнгын төсөв хувиарлах тухай хуулийн төслийг эцэслэх бөгөөд дагалдах тайлан (байнгын хорооны тайлан)-гийн төслийг боловсруулдаг.
- Төсөв хувиарлах хороо нь гол төлөв тухайн дэд хорооны боловсруулж цөөн хэдэн өөрчлөлт оруулан баталж байнгын төсвийн хуваарилалтын тухай хуулийн төсөл, дагалдах тайланг танилцуулахын өмнө эцэслэж болно.

Төсөв хуваарилах тухай хуулийн төсөл:

Төсөв хуваарилах гурван төрлийн арга хэмжээ:

- Байнгын төсвийн хуваарилалт: ирэх төсвийн жилийн хөрөнгө (жилийн төсөв хуваарилах 12 арга хэмжээ)
- Зарцуулж буй төсвийн хуваарилалт: төсвийн байнгын хуваарилалтыг хуульчлах хүртэл хувиарлах төсвийн жилийн эхэн үеийн түр зуурын хөрөнгө
- Нэмэлт төсвийн хуваарилалт: төсвийн жилийн нэмэлт хөрөнгө; гол төлөв “онц байдал”-ын гэж тодорхойлдог

Төсөв хувиарлах хуулийн төсөлд хэрэглэх үг хэллэг:

Армийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ

Өөрөөр заагаагүй, армийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд шаардлагатай, хуулийн дагуу зөвшөөрсөн зардал $12,478,000 -оос хэтрэхгүй. Батлан хамгаалахын сайдын зөвшөөрлөөр зарцуулах хөрөнгийг онц байдал, онцгой тохиолдлын зардалд ашиглаж болох бөгөөд төлбөрийг сайд цэргийн нууц зорилгод хэрэгцээтэй болохыг баталсан тохиолдолд хийж болно, $30,454,152,000.

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн газар

Холбооны засгийн газрын захиргааны зардал зэрэг 1998 оны Ажиллах хүчний хөрөнгө оруулалтын тухай I зүйлийн C -г хэрэгжүүлэх зорилгоор Ажиллах хүчний хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу зорчигч тээврийн хэрэгсэл худалдан авах, хөлслөх, барилга, бусад барилга байгууламжийг барьж байгуулах, өөрчлөх, засварлах, сургалтын төвүүдийн үл хөдлөх хөрөнгө худалдан авах; $1,705,320,000, түүнчлэн зардлыг нөхөн төлөх:

(1) Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагаанд $1,576,130,000, үүнээс $985,130,000 2010 оны 7 дугаар сарын 1 -нээс 2011 оны 6 дугаар сарын 30 -ныг хүртэл хугацаанд гүйцэтгэх ажилд, $591,000,000 2010 оны 10 дугаар сарын 1 -нээс 2011 оны 6 дугаар сарын 30-ныг хүртэл хугацаанд гүйцэтгэх ажилд зарцуулахад бэлэн байна;

(2) $100,000,000 2010 оны 10 дугаар сарын 1-нээс 2013 оны 6 дугаар сарын 30 -ныг хүртэл хугацаанд Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн төвүүдийг барьж байгуулах, сэргээн засварлах, худалдан худалдан авах ажилд зарцуулахад бэлэн байна;

(3) Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн газарт шаардлагатай зардалд зориулсан $29,190,000 2009 оны 10 дугаар сарын 1-нээс 2010 оны 9 дүгээр сарын 30-ныг хүртэл хугацаанд гүйцэтгэх ажилд зарцуулахад бэлэн байна:

Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн газар гүйцэтгэгч байгууллагатай байх тохиолдолд аливаа бусад хуваарилалтаас ямар ч хөрөнгийг Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн төвүүдэд хоолны үйлчилгээ үзүүлэхэд ашиглахгүй тохиолдолд.

Төсөв хуваарилах үйл явц:

1. Байнгын хорооны тайланд конгрессийн зорилгыг илэрхийлэх илүү дэлгэрэнгүй мэдээлэл хамаардаг. Гэхдээ ийм дэлгэрэнгүй мэдээллийг хууль ёсоор заавал дагаж мөрдөхгүй.
2. Хуулийн төсөл, тайланд хэрэглэх үг хэллэгт (өөрөөр хэлбэл, тодорхой зорилго, хэрэглэгээ, эсвэл хүлээн авагчид зориулсан хөрөнгө) тусгай зориулалтын хөрөнгө хамаарч болно.

Төсөв хуваарилах тайланд хэрэглэх үг хэллэг:

Түншлэл. Тус байнгын хороо Хүн амын тооллогын хэрэг эрхлэх газраас ахмадууд, хотын хүн ам, цөөнх зэрэг хүн амыг тоолоход хамгийн их бэрхшээлтэй зайлшгүй тулгарах тул санаа зовж байна. Тиймээс тус байнгын хороо Хүн амын тооллогын хэрэг эрхлэх газраас төрөл бүрийн орон нутгийн ажил эрхлэгчдийг түр хугацаанд хөлсөлж ажиллуулахыг үүрэг болгож байна. Эдгээр орон нутгийн ажил эрхлэгч нар нь илүү олон хүмүүст хүрэх, тооллогыг илүү үнэн зөв явуулах, хэлний ур чадвар, соёлын тухай мэдлэгтэй байх болно.

Ерөнхий байцаагчийн зөвлөмж. Тус хороо Ерөнхий байцаагчийн газар [ЕБГ]-аас хаягийн жагсаалтыг үнэн зөв болгох, зардлыг бууруулах талаар 3 зөвлөмж гаргасныг тэмдэглэж байна. Тус байнгын хороо нь Хүн амын тооллогын хэрэг эрхлэх газар эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд санаа зовж байна. Тус байнгын хороо Хүн амын тооллогын хэрэг эрхлэх газарт энэхүү эрх зүйн актыг баталснаас хойш 60 хоногийн дотор ЕБГ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээний талаар танилцуулахыг үүрэг болгож байна.

Тус байнгын хороо Засгийн газраас 2010 онд болох 10 жилийн арга хэмжээнд анхаарахгүй байх, яамнаас шүүмжлэлтэй хандаж хяналт тавихгүй байх, хөрөнгө гаргуулах хүсэлтийг цаг тухайд нь гаргахгүй байх асуудал үүсч улмаар үндсэн хуулийн дагуу гүйцэтгэх эрх олгосон энэхүү ажил хийгдэхгүй болох эрсдэл нүүрлэж байгааг сэтгэл дундуур тэмдэглэж байна. Тус байнгын хороо шаардлагатай хөрөнгийг гаргах үүрэг хүлээдэг бөгөөд Засгийн газарт 10 жилийн арга хэмжээг амжилттай болгох нөхцлийг бүрдүүлэхэд зохих хяналт тавьж ажиллахыг үүрэг болгож байна.

Бага хурлын гэрээний дагуу Цөмийн зэвсгийн зөвлөлд Цөмийн төлөв байдлын үнэлгээ гарснаас хойш 60 хоногийн дотор Эрчим хүчний сайдтай хамтран Үндэсний шинжлэх ухааны академитай цөмийн аллага хядлагын эрсдэл, цэргийн аюул заналыг харгалзан үзэж үндэсний аюулгүй байдал, стратеги, тактикийн зориулалттай B61 -ийн нэмэгдүүлсэн хамгаалах хүчин чадлыг судлах судалгаа хийх гэрээ байгуулахыг үүрэг болгож байна. Бага хурлын гэрээний дагуу Цөмийн зэвсгийн зөвлөлд Цөмийн төлөв байдлын үнэлгээ гарснаас хойш 90 хоногийн дотор ... тус судалгааг хийлгүүлснээс хойш 180 -аас доошгүй хоногийн дотор Эрчим хүчний сайдтай хамтран цаашдын судалгааг хийлгүүлэхийг үүрэг болгож байна.

Конгрессийн заавар чиглэлээр гаргах зарлага “Тусгай зориулалтын хөрөнгө”

- Ерөнхий нэр томъёоны тодорхойлолт: Конгрессийн гишүүний заавар чиглэлийн дагуу тодорхой анхаарах хүмүүст хөрөнгө хуваарилах
- Төлөөлөгчдийн танхим, Сенатын тусгай зориулалтын хөрөнгийн тухай дүрэм журам нь:

- зарлага, тодорхой хязгаартай татварын орлого, эсвэл хязгаартай импорт, экспортын татварын орлого
- хууль эсвэл тайланд хэрэглэдэг үл хэллэгтэй заалтуудад тус тус үйлчилдэг

➢ Байнгын хорооны тайланд хэрэглэдэг үг хэллэгээр дэлгэрэнгүй жагсаалт эсвэл тайлан гаргахыг шаарддаг.

АНУ -ын Төсвийн үе шатын схем



Эрх мэдлийн хүрээнд гаргах зарлагад үзүүлэх хуулийн хязгаар

➢ 10 жилийн хугацаа (2012 - 2021) -ны жил бүрийн эрх мэдлийн хүрээнд гаргах зарлагад үзүүлэх хуулийн хязгаар
  - 2012, 2013 оны төсвийн жилд аюулгүй байдал, аюулгүй байдлын бус төрөл зүйлийн хязгаар
➢ Тодорхой зорилгоор хязгаарыг зохицуулж болно
➢ Конгресс эсвэл Ерөнхийлөгч төсвийг заасан хязгаараас хэтрүүлэн хуваарилах тохиолдолд зарлагыг Конгрессийн чуулган дуусахаас өмнө шууд хасдаг.

2.3 Төсвийг хэрэгжүүлэх

Ерөнхийлөгчийн Удирдлага, төсвийн хэрэг эрхлэх газраас байгууллагуудыг жилийн эцсээс өмнө хөрөнгөгүй болохоос урьдчилан сэргийлэхийн тулд гол төлөв тухайн хөрөнгийг

улирал тутамд эсвэл төсөлд хувиарладаг.

➢ Хөрөнгийн хэрэглэгээний хязгаар нь дараах үндэслэлээр явагдана. Үүнд:

Өөрөөр зохицуулах: данс хооронд хөрөнгө шилжүүлэхэд ихэнхдээ зөвхөн конгрессийн мэдэгдэл шаардлагатай байдаг.

Шилжүүлэх: данс хооронд шилжүүлэх асуудлыг хуульчлах ёстой

➢ Хуваарилсан хөрөнгийг зарцуулахаас татгалзах

Хойшлуулах: захиргааны шалтгаанаар зардлыг хойшлуулах; гагцхүү конгрессийн мэдэгдэл шаардлагатай.

Цуцлах: зарлагыг цуцлах; хуульчлах ёстой.

* * *

Ашигласан материал, эх сурвалж

АНУ

- Senate Budget Committee. Эх сурвалж: budget.senate.gov/
- House Committee on the Budget. Эх сурвалж: budget.house.gov/
- Congressional Budget Office. Эх сурвалж: www.cbo.gov/
- УИХ -ын тамгын газар, БНОУХүрээлэнгээс хатран зохион байгуулсан
- “УИХ-ын судалгаа шинжилгээний чадавхыг дэмжих нь“ сургалт семинар

* * *

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2
БҮЛЭГ

ЭРДЭС БАЯЛАГ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРД”-ЫН ХУУЛЬ ЗҮЙН ТОДОРХОЙЛОЛТ, АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРӨЛ, ЗҮЙЛИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг

ОРШИЛ

УИХ-ын гишүүн Д. Ганхуягийн 2012 оны 11 -р сарын 01 -ний өдрийн 12/2904 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу гадаадын зарим орны Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын хууль зүйн тодорхойлолт, ашигт малтмалын төрөл зүйлийн талаар харьцуулсан судалсан бөгөөд судалгааг УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн Эдийн засгийн багийн судлаачид гүйцэтгэв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны явцад дараахь улс орнуудын ашигт малтмалын хуулиудыг харьцуулан судалсан болно. Үүнд:

- АНУ-ын “Үндэсний стратегийн болон хязгаарлагдмал нөөцтэй ашигт малтмалын үйлдвэрлэлийн тухай хууль”, 2012
- Беларусийн Газрын хэвлийн тухай хууль, 2008
- “БНХАУ-ын Ашигт малтмалын тухай хууль”, БНХАУ-ын 1994 оны Засгийн газрын 152-р тогтоолоор батлагдсан “БНХАУ-ын Ашигт малтмалын хуулийг дагаж мөрдөх тухай журам
- Индонезийн “Бүгд Найрамдах Индонези улсын Ашигт малтмал, нүүрсний тухай хууль, 4/2009”, Индонези улсын Уул уурхайн салбар дахь тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх тухай журам,
- Казахстан улсын “Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль”, Стратегийн ач холбогдол бүхий баялагтай газрууд болон ордуудын жагсаалтыг батлах тухай**, Засгийн газрын тогтоол,**
- Канад улсын “Уул уурхайн тухай акт”,
- ОХУ-ын “Газрын хэвлийн тухай хууль”, Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын үндсэн төрлүүдийн жагсаалт, Засгийн газрын тогтоол, 1996
- Энэтхэг улсын “Ашигт малтмалын тухай хууль”, “Газрын баялагийн тухай хууль” болон бусад холбогдох эрх зүйн

Судалгаанд дээрхи орнуудаас гадна хэд хэдэн орны хуулийг авч үзсэн боловч “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар” гэсэн нарийвчилсан хуулийн тодорхойлолт тодийлөн олдоогүй тул нэр бүхий орнуудаар судалгааны хүрээг хязгаарлав. Судалгаанд авагдсан орнуудын стратегийн ашигт малтмалын ордын тодорхойлолт, зарим орнуудын ашигт малтмалын төрөл зүйлийн ангилалыг судалгаагаар харуулав. /Хүснэгт үзнэ үү./

“Стратегийн Шинжтэй Орд” гэдэг нь тухайн улсын эрдэс баялгийн хөгжлийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөнд хамрагдсан, хөгжлийн хэтийн төлөвлөгөөнийх нь зайлшгүй нэг хэсэг нь болж уялдсан, тухайн эзэн орны нутаг дэвсгэр дээрх орд юм гэсэн нийтлэг ойлголт байдаг.

Стратегийн болон онцлох шинж чанартай орд гэдгийг улс орон бүр өөр өөрөөр авч

үзэж болох боловч ихэвчлэн улсын мөнгөний бодлого, валют, үнэт металын нөөцийн бодлоготой уялдаатай тул нөөц ихтэй алтны үндсэн ордуудыг; эрчим хүчний эх үүсвэр болон гангийн болон химийн үйлдвэрлэлийн амин сүнс гэдэг үүднээсээ баялаг нөөцтэй коксжих чулуун нүүрсний ордуудыг; хүний амьдралд хамгийн түгээмэл хэрэглэгддэг, энэ чанараараа эрэлтийн хувьд үнэмлэхүй давуу шинжтэй, баялаг арвин нөөцтэй суурь металлын ордуудыг стратегийн шинж чанартай гэсэн ангилалд хамааруулж байна.

Олон улсын хэмжээнд “Strategic mineral” буюу “Стратегийн ашигт малтмал” –ыг хэд хэдэн хүчин зүйлээр тодорхойлдог.

- Нэгдүгээрт, хөгжилтэй орнуудын хувьд цэргийн, аж үйлдвэрлэлийн эсхүл арилжааны зэрэг эдийн засгийн нэн чухал ач холбогдолыг нь харгалзан стратегийн ашигт малтмалын төрөл зүйлээ тогтоодог. Жишээ нь батлах хамгаалах, анагаах ухаан, харилцаа холбоо, зам тээвэр, эрчим хүч гэх мэтийн стратегийн салбаруудынхаа хэрэгцээг эхний ээлжинд харгалзан үздэг.
- Хоёрдугаарт, Үндэсний ашиг сонирхолыг хангахад зайлшгүй хэрэгцээтэй, ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөцгүй улс орон бусад орноос импортлох шаардлагатай болдог бөгөөд энэ шалтгааны улмаас тухайн ашигт малтмалыг стратегийн ач холбогдолтой хэмээн үздэг байна. Тухайлбал, Америк, Япон, Европын зарим орнууд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалаа бусад орноос худалдан авч байгаа бөгөөд дэлхийн зах зээлд тэдгээрийн хооронд өрсөлдөөн нэмэгдсээр байна.

Худалдаа арилжааны болон аюулгүй байдлын ашиг сонирхолын аль аль нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц болон хэрэгцээг бүрэн тодорхойлохгүй бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдал зэрэг олон шалтгаантай холбоотой.

Монгол улсын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.12-т ”Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг” хэлнэ гэж тодорхойлсон байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, ордын талаархи тодорхойлолтууд, төрлүүд

Гадаадын улс орны хууль, эрх зүйн орчин	Тодорхойлолт	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын төрөл
АНУ Үндэсний Стратегийн болон хязгаарлагдмал нөөцтэй ашигт малтмалын үйлдвэрлэлийн тухай хууль, 2012 “National Strategic and Critical Minerals Production Act of 2012”[1]	(1) “Стратегийн болон хязгаарлагдмал ашигт малтмал” гэдэгт дараах чухал ач холбогдол бүхий ашигт малтмалыг ойлгоно. Үүнд: (A) Үндэсний батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай ашигт малтмалууд, (B)Үндэсний эрчим хүчний дэд бүтэц, түүнд багтах дамжуулах хоолой, цэвэршүүлэх чадамж, Цахилгаан эрчим хүчний үүсгүүр болон дамжуулагч, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлд шаардагдах ашигт малтмалууд, (C) Дотоодын аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, орон сууцны барилга барих, харилцаа холбоо, эрүүл мэнд, тээвэр дэд бүтцэд шаардагдах ашигт малтмалууд, (D) Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал болон худалдааны тэнцвэрт байдлыг хангахад шаардагдах ашигт малтмалууд	Төрөл: -Цахилгаан/электрон: Хүнцэл /arsenic/, галий /gallium/, индий / indium/, sheet mice, платины бүлгийн ашигт малтмалууд /platinum group/, germanium, цагаан тугалга /tin/, мөнгө, газрын ховор элементүүд, теллур /tellurium/, ванади / vanadium/, -Тээвэр: Хөнгөн цагаан, сурьма /antimony/, графит /graphite/, платины бүлгийн ашигт малтмалууд /platinum group/, марганц, никель -Барилга байгууламж: Титан, хөнгөн цагаан, марганц, ванади -Эрчим хүч: Кобальт, литий, никель, газрын ховор элемент, vanadium, galium, indium, germanium, селен, мөнгө, теллур, barium, cesium, хөнгөн цагаан, молибден, платины төрлийн ашигт малтмал -Боловсруулах аж үйлдвэрлэл: Фтор, графит, Indium graphitem, магни, никель, сурьма, литий, хөнгөн цагаан, кобальт, manganese -Батлан хамгаалах/нисэх хүчний үйлдвэрлэл: Кобальт, никель, niobium, газрын ховор элемент, rhemiun, vanadium -Эмчилгээний болон Химийн: Хүнцэл агуулсан ашигт малтмал, барий, cesium, titanium, сурьма, фтор, магни, никель, rhenium, платины бүлгийн ашигт малтмал

Беларусь Газрын хэвлийн тухай хууль, 2008 Кодекс РБ О недрах от 14 июля 2008 г. № 406-З	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал – Бүгд Найрамдах Беларусь улсын нийгэм-эдийн засгийн хөгжил болон үндэсний аюулгүй байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий ашигт малтмалыг хэлнэ. /1.40/	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын төрөл /22.1/: 1. шатамхай ашигт малтмалууд: • нефть, хийн конденсат; • байгалийн хий;\ • хүрэн нүүрс; • шатамхай занар; 2. хүдрийн ашигт малтмалууд: • төмрийн хүдэр, боксит, уран, титан, зэс,молибден, цирконий, тантал, ниобий, бериллий, литий; • ховор элементийн хүдэр (гадолиний, гольмий, диспрозий, европий, иттербий, лантан, лютеций, неодим, празеодим, прометий, самарий, тербий, тулий, церий, эрбий); • үнэт металл (алт, мөнгө, платин, палладий); 3. хүдрийн бус ашигт малтмалууд: • калийн давс; • үнэт болон хиймэл чулуу (алмаз, бадмараг, хосгүй хуван бүрэлдсэн зүйл); • маш цэвэр өөхөн чулуу болон уулын болор; • давсонит; • шохой, мергель, трепел, цементын үйлдвэрлэлд ашигладаг шавар. Хуулиар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалд бусад ашигт малтмалыг оруулж болно. /22.2/
БНХАУ “БНХАУ-ын Ашигт малтмалын хуулийг дагаж мөрдөх тухай журам, 1994”, Засгийн газрын 152-р тогтоол “БНХАУ-ын Ашигт малтмалын тухай хууль, 1986” Rules For Implementation of the Mineral Resources Law of the People’s Republic of China Law of the People’s Republic of China on Mineral Resources, 1986	“БНХАУ-ын Ашигт малтмалын хуулийг дагаж мөрдөх тухай журам, 1994”-ын 6-р зүйлд зааснаар: “Ард түмний эдийн засагт чухал ач холбогдолтой олборлолт явуулах газар” гэж улсын бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд ороогүй ч гэсэн ард түмний эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг үндэслэн улсаас тогтоосон ашигт малтмалын их хэмжээний нөөцтэй, сайн чанартай, хамгаалалтанд авсан газрыг хэлнэ. Тайлбар: “Ард түмний эдийн засагт чухал ач холбогдолтой олборлолт явуулах газар” нь эдийн засгийн ач холбогдол өндөр эсвэл эдийн засгийн үр ашиг их, улсын эдийн засгийн бүтээн байгуулалтанд стратегийн чухал ач холбогдолтой олборлолт явуулах газар юм. “БНХАУ-ын Ашигт малтмалын тухай хууль, 1986”-ын 17-р зүйлд зааснаар: “Улсын төлөвлөгөөний дагуу олборлолт явуулах газар”, “Ард түмний эдийн засагт чухал ач холбогдолтой олборлолт явуулах газар”, болон “Улсаас хамгаалалтанд авч олборлохоор тогтоосон тусгай төрлийн ашигт малтмал”-ыг зөвхөн улсын төлөвлөгөөний дагуу олборлолт явуулах ба Засгийн газрын холбогдох яамны зөвшөөрөлгүйгээр аливаа байгууллага, хувь хүн олборлолт явуулахыг хориглоно.	“Улсаас хамгаалалтанд авч олборлохоор тогтоосон тусгай төрлийн ашигт малтмал” гэж ард түмний эдийн засгийн бүтээн байгуулалт, технологийн өндөр хөгжлийн хэрэгцээнд үндэслэн, мөн ашигт малтмалын үнэ цэнэ болон ховордсон байдалд үндэслэн засгийн газраас тогтоосон, улсын төлөвлөгөөний дагуу засгийн газрын холбогдох яамны зөвшөөрөлтэйгөөр олборлодог ашигт малтмалыг хэлнэ. “Улсаас хамгаалалтанд авч олборлохоор тогтоосон тусгай төрлийн ашигт малтмал”-ын төрөлд: 1. Газрын тос, байгалийн хий, метан /Coalbed Methane/, цацраг идэвхит ашигт малтмал 2. Алт 3. Вольфрам /tungsten/, тугалга /tin/, сурьма /antimony/, ионы газрын ховор ашигт малтмал /rare earth ionic mineral/ орно.

ULAANBAATAR
СУДАЛГААНЫ САН

Индонези “Бүгд Найрамдах Индонези улсын Ашигт малтмал, нүүрсний тухай хууль, 4/2009” Индонези улсын уул уурхайн газрын тодорхойлолтын дагаж мөрдөх тухай журам, 2008 Mineral and Coal Mining Law of the Republic of Indonesia, Number 4 of 2009 Implementing Regulation on Mining Area Determination for Indonesia’s 2008	“Бүгд Найрамдах Индонези улсын Ашигт малтмал, нүүрсний тухай хууль, 4/2009”-ын 1-р зүйлд зааснаар: “Улсын нөөц газар” гэж үндэсний стратегийн ач холбогдолтой нөөц газартай олборлолт явуулах бүс газрыг хэлнэ. 27-р зүйлд зааснаар: 1. Бүгд Найрамдах Индонези улсын Төлөөлөгчдийн Танхимын зөвшөөрлийн дагуу, Засгийн газар үндэсний стратегийн ач холбогдол бүхий экосистем болон байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах зорилгоор тусгай бүтээгдэхүүний нөөцтэй газрыг Улсын нөөц газар хэмээн тодорхойлно. Тайлбар: Үндэсний ач холбогдол бүхий улсын нөөц газрыг үндэсний эдийн засгийн өсөлт, үндэсний стратегийн эрчим хүч мөн аж үйлдвэрийн уян хатан чанар болон үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд ашиглана. 2. Бүгд Найрамдах Индонези улсын Төлөөлөгчдийн Танхимын зөвшөөрөл авснаар өмнөх 27-1-т заасан Улсын нөөц газарт тодорхойлсон тусгай төрлийн бүтээгдэхүүний олборлолт явуулахаар улсын нөөц газрын зарим хэсгийг ашиглаж болно. Индонези улсын уул уурхайн газрын тодорхойлолтын дагаж мөрдөх тухай журамд зааснаар: Улсын нөөц газарт тавигдах шалгуур: - Геологийн газрын зураг, мэдээлэлд суурилсан цацраг идэвхит ашигт малтмал, металл ашигт малтмал болон нүүрсний нөөцтэй чулуун гадаргаас бүрдэх - Геологийн газрын зураг болон мэдээлэлд суурилсан цацраг идэвхит ашигт малтмал, металл ашигт малтмал болон нүүрсний геологийн илэрцээс бүрдэх - Нүүрс болон ашигт малтмалын нөөцтэй байх - Уул уурхайн бүтээгдэхүүн хадгалан хамгаалах зорилготой байх - Бусад улстай хиллэсэн газар болон арлууд - Хамгаалалтанд авсан газар - Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын дагуу дээд тал нь 2000 км кв-тай жижиг арал дээр байршилтай байх.	Тусгай төрлийн бүтээгдэхүүнд зэс, хар тугалга /lead/, алт, төмөр, никель, хөнгөн цагааны хүдэр /bauxite/, нүүрс орно.

Казахстан Газрын хэвлий, газрын хэвлийг ашиглах тухай хууль, 2012 Стратегийн ач холбогдол бүхий баялагтай газрууд болон ордуудын жагсаалтыг батлах тухай, Засгийн газрын тогтоол, 2011 Закон РК от 13.01.12 г. № 542-IV “О недрах и недропользо-вании” Постановление Правительства РК от 4.10.2011 года № 1137 “Об утверждении перечня участков недр, месторождений, имеющих стратегическое значение”	Стратегийн ач холбогдол бүхий баялагтай газрууд болон ордууд – Бүгд Найрамдах Казахстан улсын Засгийн газраас баталсан жагсаалтад хамрагдсан, Бүгд Найрамдах Казахстан улсын тогтвортой хөгжилийг хангахад нийгэм-эдийн засгийн ач холбогдол бүхий баялагтай газар болон ордуудыг хэлнэ. /1.85/ Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал – Бүгд Найрамдах Казахстан улсын тогтвортой хөгжлийг хангахад стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалыг хэлнэ. /1.86/	Хуулийн 1.85 заасны дагуу Стратегийн ач холбогдол бүхий баялагтай газрууд болон ордуудын жагсаалтыг Казахстаны Засгийн газар батлана. Жагсалтаар нийт 361 орд батлагсан ба үүнд Кумдыколькийн алмазны орд, 7 алтны орд, 50 гаруй ураны орд, 40 гаруй нүүрс ус төрөгчийн орд болон 150 орчим газрын гүнийн цэвэр устай газрууд багтсан байна.
Канад Уул уурхайн тухай акт, 1990 Mining Act, 1990	Уул уурхайн тухай акт, 1990-ын 1-р зүйлд зааснаар: “Чухал ач холбогдолтой ашигт малтмалын газар” гэж шохойн чулуу / limestone/, гантиг /marble/, шавар / clay/, сэвх чулуу /marl/, хүлэр /peat/ болон барилгын чулуу /building stone/ зэргээс бусад төрлийн ашигт малтмалын хуримтлал илэрсэн, байгалийн байдлаараа байгаа, уул уурхайн олборлолт хийн хөгжүүлж ашиглах боломжтой ашигт малтмалын судал, хүдрийн давхарга болон орд газрыг хэлнэ.	“Чухал ач холбогдолтой ашигт малтмалын газар” гэж шохойн чулуу /limestone/, гантиг / marble/, шавар /clay/, сэвх чулуу /marl/, хүлэр /peat/ болон барилгын чулуу /building stone/ зэргээс бусад төрлийн ашигт малтмал
Орос Газрын баялагийн тухай хууль, 1992 Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын үндсэн төрлүүдийн жагсаалт, Засгийн газрын тогтоол, 1996 Закон РФ от 21 февраля 1992 г. N 2395-1 “О недрах” Перечень основных видов стратегичес-кого минерального сырья (утв. распоряжением Правительства РФ от 16.01.1996 г. N 50-р)	Холбооны ач холбогдол бүхий баялагтай газар – улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай баялагтай газрыг хамааруулна. /2.1/	Холбооны ач холбогдол бүхий баялагтай газарт дараах газрууд хамаарна /2.1/: 1. уран, алмаз, маш цэвэр өөхөн чулуун түүхий эд, иттрийн төрлийн ховор газар, никел, кобальта, тантала, ниобия, бериллия, лития, платинийн төрлийн металлын орд болон илэрсэн газар; 2. ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа болон 2006 оны 1-р сарын 1-ээс эхлэн ашигт малтмалын улсын балансын баримтад үндэслэсэн дараах ашигт малмалууд: • 70 сая тонн-оос дээш нефтийн нөөц; • 50 тэрбум м³-ээс дээш хийн нөөц; • 50 тонн-оос дээш алтны судлын нөөц; • 500 мянган тонн-оос дээш зэсний нөөц; ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн яамнаас боловсруулсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын үндсэн төрөлд дараах төрлийн ашигт малтмалуудыг хамруулсан байна: нефть, байгалийн хий, уран, марганец, хром, титан, боксит, зэс, никель, хар тугалга, молибден, вольфрам, цагаан тугалга, циркони, тантал, ниобий, кобальт, кандий, бериллий, сурьма, литий, германий, рений, иттрийн төрлийн ховор газар, алт, мөнгө, платиноид, алмаз, маш цэвэр өөхөн чулуун түүхий эд.

Энэтхэг Mines and Minerals (Development and Regulation) Act, 1957, -Mines Act, 1952 -National Mineral Policy	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалд байлдааны зэр зэвсэгт ашиглагдах материалд шаардлагатай бүх ашигт малтмалын түүхий эд, материал, батлан хамгаалах аль нэг үйлдвэрлэлд зайлшгүй хэрэгцээтэй, хүрэлцээтэй байх, бэлэн байх ёстой тэдгээр ашигт малтмалыг хамааруулан ойлгоно.	Энэтхэгт хязгаарлагдмал байдаг, нийлүүлэлт багатай ашигт малтмалууд: Petroleum, petroleum products, sulphur, base metals, lead, zinc, copper, nickel,tin, mercury and platinum and mineralsindustrial diamonds, graphite,alkalis, potash, cryolite, selenium Дэлхийд чухал хэрэгцээтэй Энэтхэгийн нөөцүүд : Abundant, rich iron ores, ores of manganese, titanium, thorium, of the light alloy metals, aluminium, magnesium Дайны үед амин чухал хэрэгцээтэй метал болон ашигт малтмал: Aluminium, Nickel, Antimony, Petroleum, Coal, Platinum,Chromium, Potash, Columbium, Sulphur, Copper, Tantalum, Iron, Tin, Lead, Tungsten, Manganese, Uranium, Meroury, Vanadium, Molybdenum, Zinc, Mica Энэтхэг улсад хомсдолтой байгаа ашигт малтмалууд: Sulphur, Lead, Petroleum, Zinc, Mercury, Platinum, Nickel, Graphite, Tin, Ferro-Tungestan,

Жишээ болгон ОХУ-ын “ Газрын хэвлийн тухай” хууль болон ОХУ-ын Засгийн газрын 1996 оны 50-р тогтоолоор батлагдсан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нэр төрлүүдийн жагсаалт”-ыг хавсаргав. /Хавсралт үзнэ үү/ ОХУ нь зах зээлийн эдийн засагт шилжээд удаагүй ч гэлээ байгалийн баялгийн арвин нөөцтэй том гүрний хувьд ашигт малтмалын салбарын эрх зүйн орчноо алсын хараатай зөв бүрдүүлсэн орны тоонд зүй ёсоор орно. Ялангуяа ОХУ-ын “Газрын хэвлийн тухай” хуулийг нарийвчлан судлах, Монгол улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн хүрээнд зохицуулагдаагүй олон асуудлуудыг шинээр зохицуулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна гэж үзэж байна.

- ОХУ-ын хувьд, “ Газрын хэвлийн тухай “хуулийн 12-р бүлэгт зааснаар, улсын хэмжээний ашигт малтмалын нөөцийг төрийн хяналтанд байлгах, үр ашигтай зохицуулах үүднээс Ашигт малтмалын нөөцийн улсын балансыг гаргаж байхаар заасан. Улсын нөөцийн баланс нь ашигт малтмалын нэр төрөл бүрээр /үйлдвэрлэлийн зориулалттай орд газар/ тухайн нөөцийн тоо хэмжээ, чанар, судлагдсан байдал, олборлолтийн хэмжээ, норматив алдагдал зэрэг мэдээллийг агуулах бөгөөд ашигт малтмалын нэр төрөл тус бүрээр хайгуул хийгдсэн, үйлдвэрлэл явуулсан, олборлолт хийгдсэн, үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглагдсан гэх мэтээр ангилан тогтмол баланс гаргаж байдаг байна. Ашигт малтмалын улсын нөөцийн балансыг ОХУ-ын Засгийн газрын эрх бүхий гүйцэтгэх засаглалын байгууллагууд ЗГ-аас тогтоосон журмын дагуу Улсын экспертизийн дүгнэлтээр баталгаажсан геологийн мэдээллийг үндэслэн гаргана. Улсын нөөцийн балансад ашигт малтмалын нөөцийг бүртгэх, бүртгэлээс хасахад мөн улсын экспертиз хийгдсэн геологийн болон тухайн орд газартай холбоотой албан ёсны бусад мэдээллийг үндэслэнэ.

- ОХУ-ын “Газрын хэвлийн тухай” хуулийн 13-р бүлэгт заасан бас нэг чухал асуудал бол орд газрын “Геологи-эдийн засгийн болон өртгийн үнэлгээ”-г зайлшгүй хийх тухай асуудал юм. Байгалийн баялгийг олборлох, хайгуул хийх, боловсруулахын тулд зайлшгүй байдлаар геологи, технологи, экологи, эдийн засгийн болон бусад тооцоо судалгааг иж бүрэн хийж байхаар хуульчилсан байна. Учир нь ашигт малтмалын ордын нөөцийг илрүүлж тогтоосны дараа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах шаардлага байна уу үгүй юу гэдэг

шийдвэрийг эдийн засаг, үндэсний аюулгүй байдал талаас нь геологи-эдийн засгийн тооцоо судалгаа, үнэлгээг үндэслэн гаргадаг. Үүний үр дүнд тухайн ордын нөөцийн хэмжээ, чанарыг тооцон ашиглалт явуулсанаар эдийн засгийн үр ашиг гарах эсэх, олборлолт хийх боломж, тээвэр, дэд бүтэц, боловсруулалтын зардал зэргийг тооцсон өртөгийн үнэлгээг гаргаж, татвар шингэсэн борлуулалтын үнийг бодитойгоор тооцон гаргадаг байна. Ашигт малтмалын геологи-эдийн засгийн тооцоо болон өртгийн үнэлгээ хийх аргачлалыг ОХУ-ын Засгийн газрын холбогдох байгууллага баталдаг. /Хууль үзнэ үү/

- ОХУ-ын Ашигт малтмалын нөөцийн ангилал

  ОХУ-д тодорхой төрлийн ашигт малтмалын геологийн нөөцийн судлагдсан байдал, эдийн засгийн ашигт байдал, үйлдвэрлэлд оруулах боломж зэргийг харгалзан улсын экспертизийн гаргасан албан ёсны дүгнэлтийн дагуу геологийн болон холбогдох бусад мэдээлэлд суурилсан тооцоо судалгааг үндэслэн ашигт малтмалын ордын нөөцийн ангилалыг тогтооно. ОХУ-ын Засгийн газрын 1996 оны 01 сарын 16-ны өдрийн 50 тоот тогтоолоор “ Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нэр төрлийн жагсаалт”-ыг баталсан. /хавсралт үзнэ үү/

- “Газрын хэвлийн тухай” хуулийн 15-р зүйлд зааснаар дараахь төрлийн ашигт малтмалыг нийтлэг тархалттай ашигт малтмалууд гэж үзнэ. Үүнд:

  1. алевролиты, аргиллиты;
  2. ангидрит;
  3. битумы и битуминозные породы;
  4. брекчии, конгломераты;
  5. магматические и метаморфические породы;
  6. галька, гравий, валуны;
  7. гипс;
  8. глины (кроме бентонитовых, палыгорскитовых, огнеупорных, кислотоупорных, каолина);
  9. диатомит, трепел, опока;
  10. доломиты;
  11. известковый туф, гажа;
  12. известняки;
  13. кварцит (кроме динасового, флюсового, железистого, абразивного);
  14. мел;
  15. мергель;
  16. облицовочные камни (кроме высокодекоративных);
  17. пески (кроме формовочного, стекольного, абразивного, содержащего рудные минералы в промышленных концентрациях);
  18. песчаники (кроме динасовых, флюсовых);
  19. песчано-гравийные, гравийно-песчаные, валунно-гравийно-песчаные, валунно-глыбовые породы;
  20. ракушка;
  21. сапропель;
  22. сланцы (кроме горючих);
  23. суглинки;
  24. торф.

- ОХУ -ын Засгийн газрын 1996 оны 50-р тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу дараахь ашигт малтмалуудыг стратегийн ач холбогдолтой ашигт малтмал гэж үзнэ. Үүнд:

  1) Нефть
  2) Природный газ
  3) Уран
  4) Марганец

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5) Хром
6) Титан
7) Бокситы
8) Медь
9) Никель
10) Свинец
11) Молибден
12) Вольфрам
13) Олово
14) Цирконий
15) Тантал
16) Ниобий
17) Кобальт
18) Скандий
19) Бериллий
20) Сурьма
21) Литий
22) Германий
23) Рений
24) Редкие земли иттриевой группы
25) Золото
26) Серебро
27) Платиноиды
28) Алмазы
29) Особо чистое кварцевое сырье

- Холбооны улсын Ашигт малтмалын нөөцийн фонд

ОХУ нь ирээдүйн хэрэглээгээ хангах, стратегийн болон ховордсон ашигт малтмалын нөөцийг бүрдүүлэх зорилгоор ашиглагдаагүй байгаа газрын хэвлий дэх байгалийн баялгийн нөөцөөрөө Холбооны Улсын нөөцийн фондыг бүрдүүлж байдаг. Нөөцийн фондод ордыг бүртгэх асуудлыг ОХУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.

Холбооны улсын фондод орд газрыг бүртгэхдээ орд эзэмшигчийн өөрийн хөрөнгөөр хайгуул хийсэн эсэхээс хамааруулан хуульд заасан журмын дагуу бүртгэнэ. Мөн ордыг Холбооны улсын өмчид бүртгэхдээ геологийн болон холбогдох бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу улсын мэдээллийн санд авна. Холбооны улсын нөөцийн бүртгэлд авсан орд газруудыг холбогдох хуулийн дагуу эргэлтэнд оруулах, ашиглах асуудлыг шийдвэрлэнэ. /Хуулийн 19-р зүйл/

Хавсралт.

Согласование технического проекта пользования недрами	ст. 7 Закона Российской Федерации «О недрах»
Согласование решений о предоставлении недр в пользование для целей строительства и эксплуатации подземных сооружений, не связанных с добычей полезных ископаемых	ст. 10.1 Закона Российской Федерации «О недрах»
Согласование условий лицензий на пользование недрами	ст. 16 Закона Российской Федерации «О недрах»

Государственное нормативное регулирование вопросов безопасности работ, связанных с пользованием недрами, включая вопросы соблюдения всеми пользователями недр законодательства, утвержденных в установленном порядке стандартов (норм, правил) по охране недр, предупреждению и устранению вредного влияния горных работ на население, окружающую природную среду, здания и сооружения, проведение комплекса геологических, маркшейдерских и иных наблюдений	ст. 24, 38 Закона Российской Федерации «О недрах»
Выдача разрешений на застройку площадей залегания полезных ископаемых	ст. 25 Закона Российской Федерации «О недрах»
Подписание актов о ликвидации и консервации предприятий по добыче полезных ископаемых или подземного сооружения, не связанного с добычей полезных ископаемых, согласование порядка постановки запасов полезных ископаемых на государственный баланс и их списание с государственного баланса	ст. 26 Закона Российской Федерации «О недрах»
Государственное управление отношениями недропользования	ст. 36 Закона Российской Федерации «О недрах»
Государственный контроль за геологическим изучением, рациональным использованием и охраной недр	ст. 37 Закона Российской Федерации «О недрах»
Государственный надзор за безопасным ведением работ, связанных с пользованием недрами, включая вопросы обеспечения всеми пользователями недр законодательства, утвержденных в установленном порядке стандартов (норм, правил) по безопасному ведению работ, предупреждению и устранению их вредного влияния на население, окружающую природную среду, здания и сооружения, а также по охране недр	ст. 38 Закона Российской Федерации «О недрах»
Согласование разрешений на захоронение отходов и других материалов на континентальном шельфе	ст. 34 Федерального закона «О континентальном шельфе Российской Федерации»
Контроль за соблюдением установленного порядка представления государственной отчетности предприятиями, осуществляющими разведку месторождений полезных ископаемых и их добычу	Постановление Правительства Российской Федерации от 28.02.96 N 215
Согласование проектов округов горно - санитарной охраны	ст. 3 Положения об округах санитарной и горно - санитарной охраны лечебно - оздоровительных местностей и курортов федерального значения, утвержденного Постановлением Правительства Российской Федерации от 07.12.96 N 1425

СУДАЛГААНЫ САН

Надзор за разработкой природных лечебных ресурсов, отнесенных к категории полезных ископаемых	ст. 22 Положения об округах санитарной и горно - санитарной охраны лечебно - оздоровительных местностей и курортов федерального значения, утвержденного Постановлением Правительства Российской Федерации от 07.12.96 N 1425
Государственный контроль за изучением, использованием и охраной подземных водных объектов, содержащих природные лечебные ресурсы	ст. 6 Положения об осуществлении государственного контроля за использованием и охраной водных объектов, утвержденного Постановлением Правительства Российской Федерации от 16.06.97 N 716
Государственный контроль за использованием и охраной водных объектов по вопросам соблюдения установленного законодательством порядка при использовании водных объектов и их дна для добычи полезных ископаемых, торфа, сапропеля; проведение буровых работ, строительства подземных сооружений, прокладки трубопроводов, буровзрывных и иных работ	ст. 7 Положения об осуществлении государственного контроля за использованием и охраной водных объектов, утвержденного Постановлением Правительства Российской Федерации от 16.06.97 N 716
Координация развития и функционирования подсистем мониторинга геологической среды, связанных с использованием ресурсов недр на предприятиях добывающих отраслей промышленности	Постановление Совета Министров - Правительства Российской Федерации от 24.11.93 N 1229
Подготовка заключений на градостроительную и проектную документацию	ст. 29 Гражданского кодекса Российской Федерации

(Footnotes)

[1] http://thomas.loc.gov/home/gpoxmlc112/h4402_eh.xml

БНХАУ -ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХЗҮЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ

Захиалагч: Г. Баярсайхан, УИХ -ын гишүүн бөгөөд БОХХААБХ -ны дарга
Судлаач: Д-р Г. Алтан - Оч
Судалсан хугацаа: 2012.10.05 - 11.30

НЭГ. БНХАУ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ[17]

Уг хуулийг 1989.12.26-ны өдөр баталсан. 6 бүлэг, 47 заалттай.

1-р зүйл: Ерөнхий зүйл; 2-р бүлэг: Байгаль орчны хяналт шалгалт, удирдлага; 3-р бүлэг: Байгаль орчныг хамгаалах, сайжруулах; 4-р бүлэг: Байгаль орчны бохирдол болон бусад нийтийг хамарсан аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих; 5-р Эрхзүйн хариуцлага; 6-р бүлэг: Бусад гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Хуулийн 5-р зүйлд, байгаль орчныг хамгаалах чиглэлийн шинжлэх ухааны боловсролыг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээг эрчимжүүлэх, түүний төвшнийг нэмэгдүүлэх, шинжлэх ухааны мэдлэгийг нийтийн хүртээл болгохыг төр хөхиүлэн дэмжинэ гэж заажээ. 6-р зүйлд, бүх байгууллага, хувь хүн байгаль орчныг хамгаалах үүрэгтэй бөгөөд байгаль орчин бохирдуулсан буюу түүнд хохирол учруулсан байгууллага, хувь хүний эсрэг зарга мэдүүлэх эрхтэй гэж заасан байдаг.

Төрийн зөвлөлийн дэргэдэх байгаль орчны хамгаалалтын захиргааны эрх бүхий газар нь байгаль орчны чанарын үндэсний стандартыг бий болгоно. Төв засгийн газрын шууд удирдлага дор байх муж, автономит бүс, хотын захиргааны ардын засгийн газар нь үндэсний стандартад тусгагдаагүй асуудлаар өөрийн стандартыг тогтоож болох ба үүнийгээ дээрх байгууллагад тайлагнах үүрэг хүлээнэ. Мөн дээрх газар нь хяналтын системийг бий болгож, хяналтын нормативыг тогтоохоос гадна холбогдох газартай хамтран хяналтын сүлжээг зохион байгуулж, байгаль орчны хяналтын удирдлагыг боловсронгуй болгоно. Уг газар болон засгийн газрууд байгаль орчны нөхцөл байдлын талаар тогтмол тайлан мэдээлэл гаргаж байна.

Байгаль орчныг бохирдуулахуйц барилгын төслийн нэгжүүд нь байгаль орчин хамгаалах хууль тогтоомжуудыг мөрдөх шаардлагатай. Төлөвлөлтийн газар нь барилгын төслийн байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийгдэж зөвшөөрөл авах хүртэл барилгын төслийн зохион бүтээлтийн нарийвчилсан төлөвлөгөөг батлахгүй.

Төрөл бүрийн төвшний ардын засгийн газрууд нь өөрийн харъяалах нутгийн байгаль орчныг чанарыг хариуцах ба сайжруулах арга хэмжээ авах үүрэгтэй. Эдгээр засгийн газрууд нь байгаль экологийн төрөл бүрийн систем бүхий бүс нутаг, ховор болон устаж буй зэрлэг амьтан, ургамал бүхий бүс нутаг, усны үндсэн эх үүсвэрийг хадгалсан бүс нутаг, шинжлэх ухаан, соёлын хувьд үнэ цэнэ бүхий геологийн тогтоц, алдартай агуй, органик биетийн чулуужсан үлдэгдэл бүхий бүс нутаг, мөсөн гол, галт уул, халуун рашаан, хүн төрөлхтний түүхэн ул мөр, эртний болон ховор модыг тус тус хамгаалах үүрэгтэй. Дээрх зүйлүүдийг гэмтээхийг хатуу хориглоно.

[17] http://www.china.org.cn/english/environment/34356.htm

Байгалийн үзэсгэлэнт, эсвэл түүхт газар, дархан цаазат болон бусад Төрийн зөвлөл болон түүний дэргэдэх эрх бүхий газар, цаашилбал, муж, автономит бүс нутаг болон Төв засгийн газарт шууд харъяалагдах хотын захиргааны ардын засгийн газрын тогтоосон хамгаалалт шаардлагатай бүсийн дотор байгаль орчин бохирдуулахуйц үйлдвэрлэлийн байгууламж барьж болохгүй; тогтоосон бохирдлын стандартаас хэтрэхгүй бол бусад байгууламж барьж болно. Нэгэнт баригдсан байгууламжийн ялгаруулах бохирдол стандартын хэмжээнээс давбал түүнийг тодорхой хугацааны дотор арилгах буюу хянаж байх шаардлагатай. Хэрэв байгалийн баялаг боловсруулах буюу олборлож байгаа бол байгаль орчны экологийг хамгаалах үүднээс зохих арга хэмжээнүүдийг авсан байвал зохилтой.

Бүх төвшний ардын засгийн газар нь хөрсний бохирдол, газар цөлжилт болон шүлтжилт, хөрсийг сайжруулах, газрын намагжин доройтолт, хөрсний гулгалт, ургамлын гэмтэл, хөрсний эвдрэл, усны нөөцийн хаталт, төрөл зүйлийн мөхөл болон бусад экологийн тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх буюу хянах замаар, ургамлын өвчин, хортон шавьжийг бүр мөсөн урьдчилан сэргийлэх буюу хянах замаар, химийн бордоо, пестицид болон ургац нэмэгдүүлэх гормоныг үр ашигтай хэрэглэх замаар тариалангийн байгаль орчныг илүү сайн хамгаалах үүрэгтэй.

Хотод болон орон нутагт барилга байгууламж барихдаа ургамал, ус, байгалийн ландшафтыг хамгаалах бөгөөд тухайн байгаль орчны онцлогт тохирсон цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс болон түүхт газар, байгалийн үзэсгэлэнт газар байгуулахад анхаарна.

Байгаль орчны бохирдол болон нийтийг хамарсан аюул эрсдэл үүсгэх бүх байгууллага нь үйлдвэрлэл явуулах, барилга байгууламж барих болон бусад үйл ажиллагааны улмаас үүсэх бохир хий, бохир ус, бохир хаягдал, тоос, өмхий хий, цацраг идэвхт бодис, шуугиан, чичиргээ, цахилгаан соронзон цацрагийн нөлөөгөөр байгаль орчинд учрах бохирдол, хохирлоос урьдчилан сэргийлэх буюу хянах үр дүнтэй арга хэмжээ авч, байгаль орчны хамгааллын хариуцлагын системийг бий болгож, байгаль орчныг хамгаалах асуудлыг төлөвлөгөөндөө тусгаж ажиллах үүрэгтэй.

Шинээр байгуулах үйлдвэр болон оршин байгаа үйлдвэрийн газарт технологи дамжуулахдаа түүхий эдийг дээд зэргээр ашигладаг, байгаль орчинд хамгийн бага хор хөнөөлтэй тоног төхөөрөмж, технологийн процессыг ашиглах ба хаягдал материалыг бүр мөсөн ашигладаг, бохирдлыг цэвэршүүлдэг эдийн засгийн үр ашигтай, хэмнэлттэй технологийг ашиглах үүрэгтэй.

Үндэсний болон орон нутгийн байгаль орчны бохирдлын стандартын шаардлагаас хэтрүүлэн бохирдуулсан бүх үйлдвэр, байгууллага нь тогтоосон хэмжээний татвар төлөх ба бохирдлыг арилгах болон хянахад хариуцлага хүлээнэ. Хэрэв шаардлагатай бол Усны бохирдлоос урьдчилан сэргийлэх болон түүнийг хянах тухай хуулийг ч хослуулан мөрдөнө. Бохирдол ялгаруулалтын стандартыг хэтрүүлсэнээс орох татварын орлогыг зөвхөн бохирдлоос урьдчилан сэргийлэх болон хянах зорилгоор ашиглах ба бусад ямар ч зорилгоор үрэхгүй. Энэ тухайд Төрийн зөвлөлөөс тусгайлан арга хэмжээ авна.

Байгаль орчны хамгаалалтын журамд тусгасан шаардлагыг хангахгүй технологи, тоног төхөөрөмжийг импортлоход торгууль ногдуулна.

Цацраг идэвхт бодис агуулсан хортой химийн бодис болон материал үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах болон хэрэглэхэд холбогдох төрийн хууль тогтоомжийг хослуулан мөрдүүлнэ.

Бохирдлыг нь урьдчилан сэргийлэх буюу хянах боломжгүй, түүнийг хэрэглэснээр асар их бохирдол гаргадаг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэг этгээдээс нөгөөд шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.

ХОЁР. БНХАУ-ЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ[18]

Уг хууль нь 1986.10.01 -ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, 1996 онд өөрчлөлт оруулсан. Нийт 7 бүлэг, 53 зүйлтэй. Ашигт малтмалын хайгуулын бүртгэл ба уул уурхайн зөвшөөрөл; Ашигт малтмалын хайгуул; Уул уурхайн ашиглалт; Хамтын хүчээр олборлох байгууллага ба хувь хүний олборлолт зэрэг үндсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Хуулийн 4 дэх зүйлд, Төрийн өмчит уурхай нь ашигт малтмал олборлох гол этгээд мөн. Төр нь төрийн өмчит уурхайн бэхжил, дэвшлийг батлан даана гэж заажээ.

5 дахь зүйлээр, Төр нь хайгуул болон олборлолт явуулах эрхийг худалдан авах зарчимд тулгуурласан системийг нэвтрүүлнэ; гэвч тухайн нөхцөл байдалд тохируулан татварыг бууруулах, эсвэл авахгүй байхаар шийдвэрлэж болохоор зохицуулжээ. Уурхай бүр холбогдох төрийн зохицуулалтын дагуу нөөцийн татвар болон нөөцийн нөхөн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

Хуулийн 20-р зүйлд, Төрийн зөвлөлийн холбогдох эрх бүхий газар зөвшөөрөөгүй бол доорх газруудад ашигт малтмал олборлохгүй:

1. Боомт, нисэх буудал болон батлан хамгаалах объектын дотор;
2. Чухал үйлдвэрлэлийн бүсээс тодорхой зай хүртэлх, том хэмжээний ус нөөцлөх төсөл, байгууламж, хотын инженерийн байгууламжийн дотор;
3. Төмөр зам, чухал хурдны авто замаас тодорхой зайнд;
4. Гол мөрөн, чухал суваг шуудуунаас тодорхой зайнд;
5. Төрийн хамгаалалттай дархан цаазат нутаг, гол байгалийн үзэсгэлэнт газар, түүхэн шүтээнт газар, үл хөдлөх түүхийн үнэ цэнэтэй газар;
6. Төрөөс өмнө нь зөвшөөрөгдсөн уурхайн газар.

22-р зүйлд, Ашигт малтмалын хайгуул болон олборлолт явуулж буй хэн боловч геологийн ховор олдвор, эсвэл шинжлэх ухаан, соёлын илэрхий үнэ цэнэ бүхий соёлын шүтээн олбол түүнийг хамгаалалтанд авах ба холбогдох газарт цаг алдалгүй мэдэгдэнэ гэж заажээ.
32-р зүйлд, Уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүн бүр байгаль орчныг хамгаалах болон байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг сахиж мөрдөх үүрэгтэй гэж заасан.

Хүн бүр газрыг арвич хямгач ашиглана. Уулын ажлын үр дүнд тариалангийн талбай, бэлчээр, эсвэл ой мод гэмтсэн бол холбогдох байгууллага нь мод тарих, өвс суулгах, эсвэл бусад аргаар тухайн газрыг сэргээх үүрэгтэй.

Ашигт малтмалын олборлолтоос үүдэн бусдын үйлдвэрлэл болон амьдралд хохирол учруулсан хүн бүр нөхөн олговор олгох хариуцлага хүлээх буюу сэргээн засварлах үүрэг хүлээнэ.

33-р зүйлд, Төмөр зам, үйлдвэр, нөөц хадгалах байгууламж, нефтийн хоолой, өндөр хүчдэлийн шугам, эсвэл том хэмжээний барилга байгууламж барихаас өмнө барилга угсралтын байгууллага нь геологи, эрдэс баялаг хариуцсан эрх бүхий газраас эрдэс баялгийн тархалт, олборлолтын талаар мэдээлэл авсан байх шаардлагатай гэж тусгажээ. Эрх бүхий газраас зөвшөөрөл аваагүй бол ийм барилга байгууламж нь чухал орд газрыг хамарч болохгүй.

[18] http://www.lehmanlaw.com/resource-centre/laws-and-regulations/environment/law-of-the-peoples-republic-of-china-on-mineral-resources-1986.html

ЦЭНГЭГ НУУРЫН ХАМГААЛАЛТЫН ТАЛААРХИ ГАДААДЫН УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН [ЗАРИМ] ЗОХИЦУУЛАЛТ

Г. Алтан - Оч (Ph.D), Г. Чулуун

Өмнөтгөл

УИХ –ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооноос[19] гарчигт дурдсан сэдвийн хүрээнд гадаадын туршлага, түүнд холбогдох мэдээлэл гаргуулахаар ирүүлсэн захиалгын дагуу доорхи лавлагааг бэлтгэв.

Нуур хамгаалах асуудал бол угтаа байгаль хамгаалах, мөн, усны тухай .. гэзд ерөнхий, багц [олон] хуулиар нэгэнт зохицуулагдчихсан байдаг нэг онцлогтой. Асуудлыг улам нарийсган, голуудыг, нууруудыг, эсхүл цэнгэг уст нууруудыг тухайлан авч үзэх нь аливаа улс орны өөрийн онцлогтой уялдан гарч ирдэг. Нуурын, цэнгэг нуурын тухай асуудал, мөн, дан гагц байгаль хамгаалах явцуу асуудал ч биш, эдийн засгийн .. бусад өргөн агуулгатай.

Нуурын тухай ойлголтыг жигдлэх үүднээс танин мэдэхүйн зарим элементар ухагдахууныг цухас ч болов хөндөх шаардлага тулгарч байна. Тэдгээрээс заримыг нь товчхон (2 абзацад багтаан) дурдвал,

- Нуур нь гадаргуугийн усны нэг төрөл, хонхорт хашигдаж хуримтлагдсан ус юм. Нуур амьд биетийн экологийн орчин болж өгдөг. Нуурын хэмжээ янз бүр. Аварга том нуурыг тэнгис далай гэж нэрлэх нь ч бий. Жишээ нь, Каспийн тэнгис (394299 км^2) тодорхойломжоороо [бол] нуурт тоологдох боломжтой. Гэхдээ, Каспийг заавал “нуур эсхүл далай” гэж яг таг ангилах нь олон улсын, ихээхэн маргаантай “том” асуудал байдаг аж. Баргын далай нь далай нэрт нуур юм.
- Нуурыг урсгал ба тогтмол гэж ангилахаас гадна, эрдэсжилтээр нь, цэнгэг, давст, шорвог гэж хуваана. Томоохон нуурын нэг хэсэг нь цэнгэг, нөгөө хэсэг нь давстай [эсхүл, бүр шорвог] байх явдал элбэг. Хагас цэнгэг нуур ч олон Нуурын ус хугацааны уртад багасах, улмаар, давсжих шорвогжих нь бий. Нуурыг бас үүсэл гарвалаар нь, усан балансаар нь, биологийн чанараар нь гэзд олон шинжээр ангилж болдог. Энэ бүхэн дээхнэ үеийн “түмэн бодис” –ын сурах бичигт туссан [байдаг] хамгийн энгийн танин мэдэхүйн анхдагч ойлголтууд юм. 1 литр ус 1 гр. хүрэхгүй (бага) эрдэсжилттэй байвал түүнийг “цэнгэг ус” хэмээнэ.

Бид энд [захиалгын дагуу] цэнгэг уст нуурыг тухайлан сонирхож байгаа болно. Тэгэхээр, нуурыг эрдэсжилтээр нь ангилах нь онолын хувьд [зарим талаар] барьцгүй зүйл мэт. Улс орнуудын холбогдох хууль тогтоомжид “нуурын цэнгэгийг нь илүү түлхүү хамгаалах, цэнгэг бишийг нь дутуу дулимаг хамгаалах гаргуунд нь хаях” үзэл санаа тусаагүй, тусах ч үндэсгүй; юм.

> Дэлхийн бүх нуурын толин мандлын нийт талбай 2.7 сая км^2, усан багтаамж ~230000 км^3 бөгөөд энэ нь бөмбөрцгийн хуурай газрын 1.8% -тэй тэнцэнэ. Нуурын усны түвшин “улирлын буюу бага” ба “олон жилийн буюу харьцангуй том”] хэлбэлзэлд оршдог. Нуурын дүрс зүйн тодорхойломж их төлөв түүний усан балансаас хамаарна.

Амьд байгаль, хүрээлэн байгаа орчин, уул ус, гол мөрөн, нуур цөөрөм, усан объектийг хамгаалах тухай [ерөнхий] хууль тогтоомж энд тэндгүй нийтлэгдүү төрхтэй байдаг ч ч байгалийн давтагдашгүй өвийг улс орнууд дангааараа болон хамтын хүчээр “хүчлэн хамгаалсан” жишээ бас цөөнгүй. Энэ тал дээр, олон улсын түгээмэл зохицуулалтын

[*] УИХ –ын Байгаль орчин хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г. Баярсайхан, албан бичиг №6/3934, 2012.12.14;

чанартай эрхзүйн баримт бичгүүд ч бий. Жишээ нь, (баримт бичгийн нэрийг энд утгачилж авав)

1. Аюултай ачааг төмөр замаар, автомашинаар, дотоодын усан замаар зөөх тээвэрлэх явцад учруулсан хохирлын [иргэний] хариуцлагын тухай Конвенци, Женева, 1989.X сар;
2. Цэрэг дайны болон өөр бусад хэлбэрийн дайсагнасан зорилгод хүрээлэн буй орчныг [зориуд санаатайгаар] халтайгаар ашиглахыг хориглох Конвенци, 1976.12.10;
3. Хил дамнасан хорт нөлөө бүхий үйлдвэрлэлийн [том] осол гамшгийн тухай Конвенци, Хэльсинк, 1992.3.17;
4. Хилийн ус, олон улсын [харъяалал бүхий] нуурыг ашиглах хамгаалах Конвенц (1992) -ийн ус ба эрүүл мэндийн асуудлаархи Протокол, Лондон, 1999.6.17;
5. Хилийн бүс нутгийн үйлдвэрлэлийн осол гамшгийн хилийн усанд учруулсан хохирлын нөхөн төлбөр, иргэний хариуцлагын тухай Протокол, Киев, 2003.5.21;
6. [Байгалийн цэвэршилтэд мэдрэмжгүй] үл арилагч органик бохирдуулагч [хаягдал] –ийн тухай Конвенц, Стокгольм, 2001.5.22;
7. Бусад;

Олон улсын гол нуурын эрхзүйн дэглэм (правой режим рек и озёр) –ийн үүсэл түүх XVII зуунаас эхтэй юм. Улс гүрнүүд 2 ба түүнээс дээш улсын харъяалалтай гол нуурыг гадаад харилцааны маргаангүй ашиглах горимыг эртнээс эрэлхийлж ирсэн. Тийм “дэглэм” хилийн усны зохицуулалтын байдаг агуулгатай бөгөөд нуур, тэр тусмаа цэнгэг нуурын хамгаалалтын асуудалд хамаатахгүй. Ер нь, нуурыг ундны усны нөөц, эсхүл, цэнгэг устай, цэвэр тунгалаг нь гайхалтай учраас хамгаалах гэзд байдаггүй, харин асуудлыг, тухайн нэр бүхий усан объекийн ашиглалтын үр нөлөөг дээшлүүлэх, эх байгалийг хамгаалах, бүс нутгийн хүн зоны амжиргааны эх үүсвэр талаас .. нь буюу илүү өргөн агуулгаар харж зохицуулдаг байна.

Усны нөөц [сан] бүхий үзэсгэлэн төгөлдөр нутгийг хуулиар хамгаалах туршлага гадаадын улс орнуудад бий. АНУ –д Үзэсгэлэнт онгон гол мөрний тухай хууль (Закон о диких и красивых реках, 1968), ОХУ –д “Байгаль нуурыг хамгаалах тухай хууль (1992) .. зэргийн жишээлэн хэлж болно.

1. Ундны усны проблем (дэлхий дахинд)

Дэлхийн улс орнуудад нуур хамгаалах асуудал их төлөв (байгаль хамгаалах хууль, усны тухай хууль, хилийн усны гэрээ хэлэлцээр ... г. м.) ерөнхий хуулиудаараа зохицуулагддаг. Нэг ба нэг хэсэг нуурт зориулсан тусгай хууль ховор юм. Тэр тусмаа, нуур хамгаалах асуудлыг байгаль, хүрээлэн байгаа орчныг хамгаалах өргөн агуулгаар нь авч үзсээр ирсэн ба тухайн холбогдох хууль тогтоомжийг ундны усны, эсхүл цэвэр усны нөөц гэдэг талаас нь харж зохицуулж байгаа байдал төдийлэн тодорч харагдсангүй. Нуурыг цэнгэг учраас нэн тэргүүнд хамгаална гэхчилэн сэтгэх нь [одоохондоо] улс орнуудад нийтлэг хандлага биш ажээ. Байдал манайд ч тийм байгаа. Монголчууд [цэнгэг уст Хөвсгөл нуурыг бус, харин] Увс[20] нууруаа дэлхийн байгалийн өвд бүртгүүлсэн.[18]

Байгалийн цэнгэг усны экосистемд хүний үйл ажиллагаа байнга сөргөөр нөлөөлж иржээ. Үргэлж өсөн нэмэгдэж байгаа хүн зоныг цэнгэг ус, хоол хүнсээр хангахын тулд усжуулалттай газар тариалан хөгжиж, олон тооны усан сан, далан баригдаж, цэнгэг усны хэрэглээ эрс нэмэгдсэний улмаас эдүгээ дэлхийн хүн амын 40% нь цэнгэг усны дутагдалтай нөхцөлд амьдарч байна. Цаашид, энэ байдал улам дордож, 2025 он гэхэд дэлхийн хүн амын $^2/_3$ нь ийм цэнгэг усны гачаалд орно гэсэн таамаг ч буй аж. (WWF, 2002, Living Waters)

Азид усны хомсдол, сүүлийн жилүүдийн өөрчлөлтийн зургаараар хэдийнэ аюултай

[20] ОХУ –тай хамтарч;

гэж тодорхойлохуйц байдалд хүрсэн тухай НҮБ -ын судалгаанд дурдагдсан. Өнөөдөр, африкийн ундны усны нөөцийн байдал ч мөн хүнд байгаа юм. Дахиад 30 жил өнгөрөхөд, африкт жишээ нь, байдлыг хянах боломжгүй тийм нөхцөл байдал үүсэх магадлалтай гэж үздэг аж. Усаар дамжин хүнд халдварлах өвчний тоо сүүлийн 10 жилийн дотор 30% өссөн тухай мэдээлэл ч байна. Ямар ч байсан дэлхийн цөөнгүй бүс нутагт усны хомсдол бодитойгоор нүүрлээд байна гэж зарим судалгааны тайланд туссаныг дурдъя.

Дэлхийн буурай хөгжилтэй орнуудад цэнгэг усны хомсдол нь хүний өвчлөл болон нас баралтанд нөлөөлөгч үндсэн шалтгааны болсоор байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO) –ын судалгаагаар, жил тутам 15 сая хүүхэд ундын усны гачаалаас үүдсэн шалтгаанаа эндэх боломж бүхий тооцоо хүртэл гарчээ.

Байдал ийм байгаа болохоор, цаашид нүүрлэх усны хомсдол болон нийгмийн тогтвортой хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд экосистемийг хамгаалах зарчимд тулгуурласан урт хугацааны арга хэмжээ авч хэргэжүүлэхийг дэлхий нийт эрмэлзэж байна Усаа үргэлж цэврээр нь байлгахын тулд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) дараах 2 чиглэлийг баримталж байгаа болно. Үүнд:

- Нуур, ус, намгархаг газрын хамгаалалтыг нэмэгдүүлж түүний ашиглалт болон менежментийг эрс сайжруулах;
- Газар, ус, экосистем хоорондын нарийн уялдаа холбоог харгалзан нуур, гол мөрнийг илүү өгөөжтэй ашиглах; явдлыг чухалчилж байна (WWF, 2002, Living Waters).

2. Байгаль нуурыг хамгаалж буй ОХУ –ын туршлага

Байгаль нуурыг хамгаалах асуудал ОХУ –ын төр засгийн холбогдох дээд байгууллагуудын анхаарлын төв оршсоор ирсэн. Нуурыг хамгаалах тухай тусгай бие даасан хууль Б.Ельциний үед гарсан, мөн, удаа дараа уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь үүний нэг нотолгоо юм. [Байгаль нуурыг хамгаалах тухай хуулийг, эх хэлээр нь, ард хавсаргав. [Хавсралт - 1]

1996 онд Байгаль нуурыг ЮНЕСКО дэлхийн байгалийн өвийн жагсаалтад бүртгэсэн. Орост, Байгаль нуурыг хамгаалах, нуурын бүс нутгийн нийгэм - эдийн засгийн хөгжлийг 2012 – 2020 онд хангах [улсын төвшний] зорилтот програм, нэгдсэн концепциин дагуу хэрэгжиж эхлээд байна. Уг Концепцийг Оросын Засгийн газар 2011.7.20 –нд (Распоряжение №1274) баталжээ. Засгийн газрын энэ шийдвэр нь Байгал нуурын хамгаалалтын тухай хууль, мөн, ОХУ –ын Ерөнхийлэгчээс тухайн чиглэлд өгсөн (Поручение №-ПР2378 от 2009.9.05) үүргийн хэрэгжилттэй давхар холбоотой.

Зорилтот програм 2012 – 2020 оны хооронд 2 үе шаттай хэрэгжинэ. Эхний үе шат 2015 онд дуусна. Хоёрдахь шат 2016 оноос эхэлнэ. Зорилтот програмыг олон аспектаар нарийн тодорхойлогж төлөвлөжээ. Байгал нуурын ай савд оршин буй “суурин бохирдуулагч” нарт ногдох нийлбэр хог хаягдлын хэмжээ байнга өсөн нэмэгдсэн үзүүлттэй явж иржээ. Жишээлж дурдахад, [хог] хаягдлын удирдлагын менежментийг хөтөлбөрт төлөвлөсөн ёсоор хэрэгжүүлж гэмээнэ, өнөөгийн өндөр ба экстемаль түвшинд хүрсэн байгалийн бохирдолыг 80% бууруулах, хог хаягдлыг тусгай төхөөрөмжлөгдсөн полигонд боловсруулах ... зэрэг тодорхой олон үзүүлэлттэй.

Зорилтот програм хэрэгжих хугацаанд, нуурын ай савын нутаг дэвсгэрт, нуурыг хамгаалахад шууд ба дамаар чиглэсэн биет ажил, бодит арга хэмжээний зардалд нийтдээ 57.8 млрд. рубл., үүний 48.5 млрд. рубл. –ийг нь холбооны төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Зөрүүнд гарч байгаа 9.3 млрд. рублийн 6.8 млрд. –ыг нь Холбооны субъект өөрөөсөө, 2.5 млрд. –ыг нь төсвийн гаднах эх үүсвэрээс гаргахаар байгаа болно. ОХУ –ын Сангийн яамнаас оруулсан төсвийн төсөлд Байгаль нуурыг хамгаалах [улсын хэмжээний]

зорилтот хөтөлбөрийг 2013 – 2015 онд санхүүжүүлэхээр 8 млрд. рубль тусгасан нь, орост, Байгаль нуурыг хүрээлэн байгаа орчинтой нь хамт цогцоор бодитойгоор хамгаалахад онцгой анхаарч байгаагийн дам нотолгоо болохоор байна. [http://www.ecoindustry.ru/news/view/33482.html, 18.09.2012]

> Байгаль нуурыг хог хаягдлаас цэвэрлэх хамгаалах эхлэл санаачилгын түр ба дэд төсөл хөтөлбөр олон. НҮБ -ын Хөгжлийн Хөтөлбөрөөс болон Олон улсын сайн дурын “Байгаль нуурыг хамгаалъя” төсөл, “Дэлхийгээ цэвэрлэе”, “Бүх орос даяарын цэвэрлэгээ” –ий кампанит ажил .. г. м. Тусгай санхүүжилттэй нэг удаагийн, түр хэлбэр шинжийн ажил асуудлыг төр засгийн бодлогоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай хольж хутгаж ярих нь, энд [цаана нь хэдийгээр нэг зүйл оршин байгаа ч гэсэн] зохимж багатай гэж үзсэн болно.

Төр засгийн бодлого хөтөлбөр, улсаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний гүйцэтгэл ба [урсгал ажлын] явцад ОХУ –ын Байгаль орчны яам үндсэн захиалагчийнхаа хувиар хяналт тавина, бас, координаторын үүргээ ч давхар гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд үндсэн захиалагчийнхаа хувьд хөндлөнгийн экспертиз, аудит хийлгэх, статистик судалгаа хийх, хийлгүүлэх эрх үүрэгтэй ажилладаг.

Байгаль нуурыг хамгаалах тухай ОХУ –ын хуулийн ач холбогдлын талаар сөрөг үнэлэмжтэй хүмүүс ч цөөнгүй. Буриадын Улан – Удэд саявтарсхан болсон “нуур хамгаалах” хэлэлцүүлэг дээр оросын төрийн думын депутат М. Слипенчук “нуурын тухай хууль нуурыг үл хамгаалаад зогсохгүй, нэмэлт бэрхшээл төвөг удаж, нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. Нуурыг хамгаалах хууль тогтоомж бидэнд ер дутаагүй, бүр эсрэгээр, хангалттай их байна, хэрэгжихгүй л байгаа болохоос биш ...” гэсэн нь зөвхөн нэг жишээ юм. Байгаль нуурыг хамгаалах тухай хуулийн жишгээр, оросын баруунхойд бүс нутагт дахь Ладог нуурын тухай хууль гаргах хэрэгтэй гэсэн санал санаачилга ч гарч байгаа болно.

Байгаль нуурыг хамгаалах тухай хуулийг дагаж гарсан [холбооны түвшний] бусад зарим хууль тогтоомжийн тойм жагсаалтыг харъя. Үүнд:

1. ОХУ –ын Засгийн газрын тогтоол, Постановление Правительства РФ от 30.08.2001 № 643 «Об утверждении видов деятельности запрещенных в центральной экологической зоне Байкальской природной территории»;
2. ОХУ –ын Засгийн газрын 26.03.2001 –ны өдрийн № 234 дугаар тогтоол, «О предельных значениях уровня воды в озере Байкал при осуществлении хозяйственной и иной деятельности»;
3. ОХУ –ын Засгийн газрын 28.01.2002 –ны өдрийн N 67 тогтоол, «Об особенностях охраны, вылова (добычи) эндемичных видов водных животных и сбора эндемичных видов водных растений озера Байкал»;
4. ОХУ –ын Засгийн газрын 06.09.2000 –ны өдрийн № 661 дугаар тогтоол, «Об экологическом зонировании Байкальской природной территории и информировании населения о границах Байкальской природной территории, ее экологических зон и об особенностях режима экологических зон»;
5. ОХУ –ын Байгал орчны сайд (Госком –ын дарга) 05.10.1999 –ны өдрийн “Байгаль нуурын хамгаалах .. хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн эн тэргүүний ажил, арга хэмжээний тухай” № 564 тоот тушаал;
6. ОХУ –ын Байгаль орчны сайдын (Минприрод –ын) 05.03.2010 –ны өдрийн N 63 тоот тушаал, «Об утверждении нормативов предельно допустимых воздействий на уникальную экологическую систему озера Байкал и перечня вредных веществ, в том числе веществ, относящихся к категориям особо опасных, высокоопасных, опасных и умеренно опасных для уникальной экологической системы озера Байкал»;
7. ОХУ –ын загас агнуурын улсын хорооны даргын 08.05.2003 –ны өдрийн «Об утверждении перечня промысловых эндемичных видов водных животных озера Байкал» N 155 тоот тушаал;

Байгаль нуурыг хамгаалах тухай хууль, дээр дурдсан яам газрын тогтоол тушаалаас гадна, бусад холбогдох олон хууль тогтоомжоор Байгаль нуурын ай савыг хамгаалах олон асуудал дамаар зохицуулагдаж байдгийг бас нэмж дурдмаар байна. Байгаль нуурын хамгаалалтын тухай асуудал тухайн нутгийн засаг захиргааны шийдвэрээр буюу нутгийн өөрийн удиирдлагын түвшинд [холбооны субъектийн эрх хэмжээний хүрээнд] гарсан эрх зүйн баримт бичгүүдээр ч зохицуулагдана. Холбооны субъектийн түвшин гарсан мөн чиглэлийн баримт бичгүүдээс заримыг нь энд тухайлан дурдъя. Үүнд:

- Иркутск мужийн дүрэм, Байгалийн [цаад] хязгаарын Дүрэм (Мужийн үндсэн хууль);
- Иркутск мужийн Засгийн газрын 29.12.2009 –ны өдрийн Байгаль нуурын хамгаалалтын албаны тухай N 415/194-пп тоот тогтоол, мөн Комиссийн тухай тогтоол [О комиссии по соблюдению требований к служебному поведению государственных гражданских служащих службы по охране природы и озера Байкал Иркутской области и урегулированию конфликта интересов]
- Закон Иркутской области О ратификации протокола «О продлении на 2001 год действия бассейнового соглашения между Иркутской областью и республикой Бурятия о разделе сумм платы за пользование водными ресурсами озера Байкал»;
- Приказ Службы по охране и использованию животного мира Иркутской области от 14.01.2011 N 3-спр «О распределении между юридическими лицами и индивидуальными предпринимателями квот добычи (вылова) водных биологических ресурсов для осуществления промышленного рыболовства на озере Байкал в пределах Иркутской области с впадающими реками на 2011 год»;

> В настоящее время на областном уровне готовиться около 70 нормативно - правовых актов в области охраны природы. Один из самых важных - разработанный по поручению губернатора проект закона «Об областной государственной охране озера Байкал». Сейчас он находится на согласовании в правоохранительных органах, министерстве юстиции, после будет направлен на обсуждение в Законодательное Собрание региона.

Байгаль нуурын усны чанарыг хэвээр хадгалах нь хамгийн чухал зорилтын нэг мөн. Байгаль нуурын усны чанарыг алдагдуулах чиглэлд хамгийн ихээр муугаар нөлөөлөгч хүчин зүйлийн тоонд [манай] Сэлэнгэ мөрний усны [монголоос үүдэлтэй] бохирдлыг тэнд тэргүүн эзлэжинд нэрлэж байгаа нь анзаарагдсан. Байгаль нуурт цуглах голоос үүсвэртэй усны хэмжээний тэн хагасыг Сэлэнгэ мөрөн гагцаар хангадаг. Оросуудын үзэж байгаагаар Сэлэнгэ мөрний усны гол бохирдуулагч нь, монголд, уул уурхайн “Эрдэнэт” үйлдвэр, орост, Улаан – Үдийн [хотын] цэвэрлэх байгууламжийн хаягдал, мөн Сэлэнгийн сав газар дахь мал аж ахуйн үйлдвэрлэл; -ийг оруулж байна.

Байгаль нуурыг дэлхийн байгалийн өвд бүртгүүлсэнтэй холбогдож “ОХУ –ын [тухайн чиглэлээр] олон улсын өмнө хүлээх үүрэг хариуцлагын тухай асуудал яригддаг. ЮНЕСКО –ийн холбогдох комиссийн товчооноос 2001 оны XII сард ОХУ –д “Дэлхийн өвийн бүртгэл – статустай объектод илрэх ёсгүй зөрчлийн жагсаалт” –ыг хүлээлгэн өгсөн байдаг. Хүлээсэн үүргээн биелүүлээгүй, эсхүл, хангалтгүй биелүүлсэн байдал гарсаар байх ахул, бүртгэгч тал, өмнөх бүртгэлээ өөр зэрэглэлийн буюу “аюулд өртсөн хүн төрөлхтний нийтлэг өв” –ийн жагсаалтад шилжүүлэх боломжтой юм.

3. Канад, АНУ –д Их нуурын бассейныг хамгаалж буй туршлага (түүхэн тойм)

Канад, Америкийн нутагт орших Их нуурын бассейн 5 том нуураас тогтоно. Урсгал цэнгэг устай. Энэ бассейн дэлхийн гадаргуугийн усны 18% -ийг өөртөө агуулдаг. Нуурын ай савд

канадын талаас 10 шахам сая хүн, америкийн талаас 30 гаран сая хүн аж төрдөг. Аль аль талаасаа аж үйлдвэрийн том район. 1950 –аад он хүртэл америк канадын талуудын аль аль нь энэ чухал бөгөөд нэгдмэл том усан объектийг экологийн талаас нь [заавал] хамгаалах учиртайг “сайн ойлголгүй” явж ирсэн гэдэг. Их нууруудаар нуурын тээвэрийн онгоц зорчдог, аж үйлдвэр, аялал жуулчлал хөгжсөн бүс нутаг юм. Их нуурын бассейн зөвхөн нэр бүхий 5 нуур биш, мөн олон тооны гол, жижгэвтэр ба жижиг нуурууд, 35000 шахам араатай.

Америк - Канадын [цэнгэг уст] **Их нуурын бассейн**

Нуурын нэр	Эри нуур	Гурон нуур	Мичиган нуур	Онтарио нуур	Дээд нуур
Гадаргуун толь (км^2)	25 700	59 600	58 000	19 500	82 400
Усан багтаамж (км^3)	480	3540	4900	1640	12 000
Дундач гүн	19 м	59 м	85 м	86 м	147 м
Гүний max	64 м	230 м	281 м	246 м	406 м

Нууруудыг хамгаалж эхлэхээс өмнөх үед цаасны болон өөр бусад үйлдвэрүүдийн хог хаягдал эдгээр нуурт орох хаягдах нь элбэг байв. Бассейны хамгийн их бохирдсон хэсэг нь Эйр нуур байсан бөгөөд тэнд загас жараахай нь илт цөөрөөд ирсэн гэдэг. Хэдий тийм ч Засгийн газрын зүгээс нуурыг аврах цэвэрлэхэд төсөв хөрөнгө гаргасанаар нуурын экологийн байдал улам улмаар сайжирч хуучин хэвэндээ орсон, орсоор байна.

1950 –аад оноос эхлэн канад ба америкийн хоёр тал Их нууруудын бохирдолтой холбогдол бүхий тодорхой хурц асуудлуудыг хамтран шийдэх, [мөн] усны чанарыг сайжруулах 2

UH.MN
СУДАЛГААНЫ САН

талын [дотоод хүрээний] нэгдсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж эхэлжээ. Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн олон бодит арга хэмжээний үр дүнд, хэдхэн жилийн дотор, Их нууруудын их ус илт цэвэршиж ирсэн нь энгийн нүднээ ил болсон гэдэг. Нуурын усан дахь хүнд металлын болон органик элементүүдийн агууламж буурснаар усны шувууд болон загас “хордолтын байдал” –ын түвшин ч буурчээ.

Хөрш зэргэлдээ АНУ – Канад хоёр улсын засгийн газрын нуур хамгаалах энэхүү хөтөлбөрт төвлөрч зангидагдсан хүчин чармайлт бодит үр дүнд хүрсэн [уг] жишээг байгаль хамгаалал, түүний нөөцийн удирдагын улс дамнасан хамтын ажиллагааны нэг жишиг – модель гэж үздэг ажээ. Хамтын хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр тэнд бүх асуудал нэгмөр шийдээгдээд дуусчихсан хэрэг огт биш бөгөөд экологийн олон актуль асуудал өнөө хир мөн оршсоор буйг тэмдэглэх нь зөв биз ээ.

Удаан хугацаанд үл цэвэрших хорт бодисын хөнөөлт аюул Их нууруудын усанд оршин байсаар байгаа нь, тэдгээрийг арилгахад, урсгал биш, урт хугацааны тусгай зорилтот өргөн далайцтай арга ажиллагаа явуулах шаардлагатайг харуулсаар байна. Их нууруудын “эрүүл мэнд” ямар байгааг, тус районы байгаль хамгааллын талаар канадын талаас авч хэрэгжүүлсэн цогц ажлын үр дүнг нэгтгэж илэрхийлсэн тайлан мэдээллүүд харуулдаг. Америкийн талын бодлого хөтөлбөрийн төлөвлөлт хэрэгжилтийг Шикаго хот дахь нуур хамгаалах үндэсний хөтөлбөрийн газрын Хүрээлэн байгаа орчны агентлаг (Агентство охраны окружающей среды по Национальной программе Великих Озер в Чикаго) бас гаргадаг.

Их нуурын бассейны бохирдолтын нэг том асуудал нь цэнгэг уст нуурын усны 1960 оноос эхтэй тэжээлт бодисын баяжуулалтаас үүдэл бүхий нуур ус ургамал ногоондоо эзлэгдэж “өвсөнд баригдах” үйл явц юм. Нуурын усны найрлагад биогенийн элемент ихэдсэнээс болж эвтрофикациин процесс явагдаж, усны чаныг муутгадаг. Эвтрофикацийг нөхцөлдүүлдэг химийн гол хоёр элемент нь азот ба фосфор болно. Энэ байдал канад ба америкийн талуудыг 1972 онд Их нуурын бассейны усны чанарын анхны Хэлэлцээр (GLWQA) -г хийхэд хүргэжээ. Хэлэцээрт тусгалаа олсон холбогдох зүйл заалтаар фосфорт ба азотот хаягдлын хэмжээг хязгаарлав.

Хэлэцээрээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг канадын тал хууль эрх зүйн талаас нь ч баталгаажуулж, бохирдлын голомтуудад тавих хяналтыг чангатгажээ. Чухамхүү 1972 оны хэлэлцээрээр Их нуурууд руу нэвтрэх үйлдвэрийн газруудын химийн хорт хаягдал, механик хог новшийн асуудлыг сөхөж журамласан юм. Канад ба америкийн талууд Их нуурын бассенийг хамгаалах II хэлэцээрээ 6 жилийн дараа буюу 1978 байгуулсан.

Хэлэлцээрүүдийн хэрэгжилийн эерэг үр нөлөө 1980 оны эх гэхэд илээр мэдрэгдэж холбогдох хяналт, судалгаа шинжилгээний байгууллагууд зарим дүгнэлтийг гаргасан байдаг. Үүнд:

1. Хоёр талын хэлэлцээр, хамтын хөтөлбөр програмын үр дүнд талуудын авч хэрэгжүүлсэн бодит багц ажил Их нууруудын бохирдлыг багасгах чиглэлд сайнаар нөлөөлсөн ч тавигдаж байгаа тулгамдсан зорилтуудыг нэгмөр шийдэхэд хүрэлцээтэй бус байна;
2. Их нууруудын экосистемд хохирол учруулагч, нуурын усны бохирдлыг нөхцөлдүүлэгч хорт хаягдлыг хязгаарлах хамгийн үр дүнтэй арга нь тэдгээрийн хэмжээг багасгахад орших бус, харин тэдгээрийг бүрэн хориглох явдал мөн; гэж үзжээ.

Их нуурын бассенийг хамгаалах II хэлэцээрээрийн хүрээнд 1987 онд, талууд, нуурын хүрээлэн байгаа орчныг бохирдлоос ангижруулах ажлаа эрчимжүүлэх үүднээс нэмэлт арга хэмжээ болгож тусгай Протокол –д гарын үсэг зурж, зорилтот ажлын хэрэгжилтийн баталгааг хангах чиглэлд хяналтын арга тогтолцоог өргөжүүлэн чангатгажээ.

4. БНХАУ –ын Засгийн газраас Далай нуурыг хамгаалах чиглэлд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ

Хятадад үйлдвэрлэл хөгжихийн хэрээр тус улсын зүүн хойд болон өмнөд мужуудад экологийн тэнцвэрт байдал алдагдаж, гол ус ширгэх, цөлжилт явагдах ... зэрэг олон сөрөг үр дагавар илэрсээр байна. Тэнд, хамгийн их аюул дагуулж болох нэг асуудлыг ундны усны хомсдол. Фортун сэтгүүлд бичсэнээр, хятадын засаг захиргааны нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад ундны усны хангамж - чанартай холбогдсон багц асуудал багтжээ. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Хятад улс ундны усны хомсдолд “гүн” өртөж байгаа тухай олон улсын судалгааны байгууллагуудын тайлан мэдээнд дурдагдсан байна.

НҮБ -аас явуулсан судалгаагаар ундны усны хэт хомсдолд өртсөн 13 орны тоонд 1347 сая хүнтэй манай урд хөрш орсон. Дэлхийн цэвэр усны нөөцийн зургаан хувь нь л Хятадад хамаатна. Тиймээс үйлдвэрлэл хөгжиж, хүн ам өсөхийн хэрээр ундны усны асуудал тэнд улам бүр стратегийн агуулгатай болсоор ажээ. Хятадад усны хомсдолд өртсөн 300 сая хүн байдаг гэх ба жилд усны хомсдолоос болж 70 орчим мянган хүн нас бардаг гэсэн тойм тооцоо ч байдаг аж.

Хятадын засаг захиргаанаас усны хомсдолыг бууруулах, чанарыг нь сайжруулах ажилд жилд 22 тэрбум доллар төсөвлөдөг. Хятадын хүн ам эрчимтэй өсч байгаа нь усны хомсдолыг улам бүр хүндрүүлсээр байна. Хүн ам нь өнөөгийн хурдцаараа өссөөр байх ахул хятад улс 50 жилийн дараа гаднаас ус импортлох хэмжээнд очно. Ялангуяа хятадын хойд бүс нутагт усны байдал үнэхээр хүнд байгаа” гэж Азийн бүсийн байгалийн байдлыг судлах төвийн мэдээлэд туссан байв.

Хятад улс усны нөөцөө үр нөлөөтэй ашиглах хамгаалах тал дээр далайцтай том програмууд хэрэгжүүлдэг. Хилийн усны хамааралтай тодорхой зарим асуудалд тэд зэргэлдээх хөрштэйгээ нэгмөр тохиролцолгүйгээр барьж байгуулж эхэлсэн төсөл байгууламжуудтай юм. Цэнгэг уст Буйр нуур бол хилийн ус. Буйр нуурт Халхын гол цутгадаг. Халх голын урсацын зарим хэсгийг хятадууд үйлдвэрийн район руугаа татаж, технологийн зориулалтаар ашиглах боломж, бодол төлөвлөгөө бүхийг зарим эх сурвалжид дурдсан байна. (Зураг 1)

БНХАУ -ын Өвөрмонголын өөртөө засах орны Хөлөнбуйр аймгийн нутагт орших Далай нуурт монголын Хэрлэн цутгана. Далай нуур цэнгэг устай, гадаргуун толь томтой, гүехэн (гүн хэсэгтээ эл хэмжээс 8 м.), хамгийн гол нь бүс нутгийнхаа уур амьсгалын онцлогоос хамааранд бусдаас илүү анхаарал шаардахуйц эмзэг байдалд оршдог. Хятадын Засгийн газар Далай нуурыг хамгаалах чиглэлд олон бодитой арга ажиллагаа явуулж ирсэн ба Аргуун голын дээд салаа - Хайлаар голын урсацын тэн хагасыг Далай нуурт цутгадаг байх [тийм] инженерийн шийдлийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газар БНХАУ -ын Засгийн газар хооронд Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай хэлэлцээрийг анх 1994 онд байгуулсан. Монгол - Хятадын хилийн хамтарсан комисс 2 улсын нутаг дэвсгэрт усаар хиллэдэг болон хилийн усны савд хамрагдах гол нуурын газрын байдалтай танилцах, судалгаа хийх, хамтарсан шинжээчдийн хэсгийг байгуулан, түүний ажлын дүрмийг баталж хилийн ус судлалын харуулын сүлжээ байгуулах, усны горимын мэдээ солилцох, Шарилж гол, Буйр нуурын усны горим, нөөцийн талаарх судалгааны үр дүнг солилцох, Буйр нуурын загасны нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар хамтын ажиллагааг өрнүүлж байна. Харин, ОХУ –тай манайх хилийн усны гэрээ холбогдолтой хамтын ажиллагааны эхийг харьцангуй эрт 1974 онд[21] тавьжээ.

[21] Стратегическая оценка природных ресурсов и экологической обстановки в свете Программы

(**Зураг** 1)

5. Монголын цэнгэг усны нөөц, түүний хамгааллын зарим асуудал

Монгол улс нь олон төрлийн экологийн систем бүхий уудам дэлгэр нутагтай, газар нутгийн байршлаараа усны том хагалбаруудын заагт, Ази-Номхон далайн бүс нутгийн хамгийн хур тунадас багатай, хуурайшилт ихтэй хэсэгт оршдог. Монголын усны нөөц жигдбус тархалттай, зарим бүсийн усны чанар муу, эрүүл ахуйн шаардлага хангадаггүй юм.

Монгол орон усны нөөц бага - хязгаарлагдмал орны тоонд ордог. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн талхагдал, уул уурхайн хөгжлийг салбар үйл ажиллагааг дагалдан гарч буй хүрээлэн буй орчны доройтол зэргээс хамаарч байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг байгалийн нөөцийн тогтвортой менежменттэй хослуулах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Возрождения Старых Промышленных Баз Северо-востока, Инженерная Академия КНР, Научное Издательство, Пекин, КНР, 2007;

Монголын нийт усны нөөцийн 83.7% нь нуур, 10.5% нь мөсөн гол, 5.8% нь гол мөрний эзэлнэ. Гадаргын усны нөөцийн 85% нь цэнгэг бөгөөд цэнгэг усны нөөцийн 93.6% -ийг дан гагц Хөвсгөл нуурт хамаарна. Тиймээс, монголын цэнгэг усны нөөц хамгааллын асуудал дотор Хөвсгөл далай, Буйр нуурын талаархи өгүүлэмжийн “эзлэх хувийн жин” бусдаас давамгайлах шинж бүхий юм.

Монгол орон “газрын дундад тэнгисээс байгаль нуур хүртэлх зурвас газрыг хамарсан нуурын бүс” –ийн зүүнзах хэсэгт оршдог. Монголд 0.1 км^2 -ээс дээш талбайтай нуур 3500 орчим бий бөгөөд тэдгээрийн нийт талбай 15640 км^2 буюу нийт нутаг дэвсгэрийн 1% -тай тэнцэнэ. Монголын ихэнх нуур хэт жижиг бөгөөд [тэд] тооны хувьд нийт нуурын 85% -ийг эзэлдэг.

Хөвсгөл нуур, түүний ай савын хамгаалалт

Байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалж үлдсэн, байгалийн бүс бүслүүрийн бүх л хэв шинжийг төлөөлдөг, цэвэр цэнгэг усны сан болсон байгалийн үзэсгэлэнт Хөвсгөл нуур, түүний сав газар, Үүр-Уйлганы хамарсан газар нутгийг хамгаалалх зорилгоор Монгол улсын Засгийн Газрын 1992 оны 31 дүгээр тогтоолоор, тэдгээрийг Байгалийн үндэсний цогцолборт газар гэсэн ангиллаар хамгаалалтанд авч, улмаар, 1995 онд УИХ –ын 26 дугаар тогтоолоор ТХГН –ийн хуульд нийцүүлэн БЦГ –ын ангилалд хамруулсан юм. Хөвсгөл нуурын ус Эгийн гол, Сэлэнгэ мөрнөөр дамжин дэлхийн цэнгэг усны нөөцийн тавны нэгийг агуулдаг Байгаль нуурт цутгадаг болохоор Хөвсгөл нуурыг хамгаалах нь Байгаль нуурыг хамгаалахтай зайлшгүй холбоотой гэж үздэг байна. Иймээс тус цогцолборт газар нь зөвхөн Монгол орны төдийгүй олон улсын ач холбогдолтой нутаг юм.

Нуур усыг[22] тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах талаар

Увс нуур, Монгол Дагуур, Хан Хэнтийн Хагийн Хар нуурыг Дархан цаазат газар, Хөвсгөл, Тэрхийн Цагаан нуур, Хар – Ус нуур (Хар болон Дөргөн нуур), Горхи Тэрэлж (Туул голын зарим хэсэг), Алтайн нурууны нуурууд (Хотон, Хоргон, Даян, Толбо нуур) –ыг Байгалийн цогцолбор газарт, Булган голыг Байгалийн нөөц газарт, Хүйсийн найман нуур, Ганга нуурыг Байгалийн дурсгалт газарт оруулжээ.

Монголын нуур ус Рамсарын жагсаалтад ...

Олон улсын ач холбогдолтой бүхий ус ..газар орчны тухай конвенц буюу “Рамсарын конвенц” –д 2012 оны байдлаар 160 улс орон нэгдэн орсон бөгөөд 193 сая га газрыг хамарсан 2005 (ш.) газар нутгийг бүртгэгдсэн. Конвенцийн үндсэн зорилго нь нуур – усыг хамтран хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг олон улсын хэмжээнд эрхлэн гүйцэтгэх зорилготой юм. Монгол улс энэхүү конвенцид 1998.4.08 –нд ёсоор нэгдэн орсон. “Рамсарын жагсаалт” -д монголын 11 газар нэр зааж орсон. Тэдгээрт, Өгий нуур (1998 он), Монгол Дагуур (1997), Тэрхийн Цагаан нуур (1998), Нууруудын хөндийн нуурууд (1998), Хар-Ус нуур (1999), Айраг нуур (1999), Ачит нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Увс нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд (2004) тус тус бүртгэгджээ.

Японы засгийн газар (Усны нөөцийн салбарын буцалтгүй тусламжаар) Улаанбаатарт “Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” –ийг барьж ашиглалтад хүлээлгэж өгсөн. Төвийг хүлээн авах ёслолын ажиллагаанд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С. Оюун

[22] ус намгархаг газрыг - гэсэн өргөн агуулгатай;

оролцож хэлэхдээ “Байгаль орчны хамгаалал, ногоон хөгжил дэлхий нийтийн амин чухал эрх ашиг, бодит эрэлт хэрэгцээ болж буй өнөөгийн нөхцөлд [энэ] төв монголын төдийгүй зүүн хойд Азийн орнуудын хүрээнд байгаль хамгаалал, ногоон хөгжлийн чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах,олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжлийн чиглэлээр дотоод гадаадын хурал, зөвлөлгөөн, уулзалт зохион байгуулах иж бүрэн байгууламж бүхий түшиц газар болно” гэжээ.

* * *

6. Анхаарах зарим санаа

a) Нуур хамгаалах чиглэлд хэрэгжүүлж ирсэн, хэрэгжүүлж байгаа гадаадын [дээрх дурдсан хэдэн орны] туршлага сэлтээс үзүхүл, тэд, усан объектийн энэ төрлийг “чухамхүү цэнгэг устай учраас” тусгайлан буюу онцлон хамгаалаад байгаа байдал ажиглагдахгүй байна. Энэ нь, доорхи үндэслэл бүхий мэт. Үүнд:

- Гадаадын улс орнууд их төлөв усаар баян, нууруар элбэг юм. Тиймээс, улс орнууд нуур цөөрөмдөө “энэ нь чухал, тэр нь [бол] яахав” гэх маягаар ялгамжтай ханддаггүй, өөрөөр хэлбэл, нэгийг нь буюу нэг-хэсгийг нь тухайлан онцолдоггүй; гэж хэлж болохоор байна. Зарим улс оронд тодорхой усан объектуудыг эрхзүйн талаас нь хууль тогтоомжоор хамгаалсан байдаг ч тэр нь олон биш, нийтлэг биш юм.

  Манай ойрын хөрш, зэргэлдээх казахстанд гэхэд, жишээлбэл, 48262 нуур буй бөгөөд үүний 94% нь эзлэх талбайн хэмжээгээрээ 1 км^2 –ээс том ажээ. Дэлхий бүхэлдээ 1.8 сая [том] нууртайг өмнө дурдсан. ОХУ том жижигтэйгээ нийлсэн 2 сая гаран нууртай. Монгол орны томоохонд тооцогдох нуурын жагсаалтад нэр бүхий 170 гаран нуур байдаг. (Хавсралт – 2)

- Дэлхийн улс орнууд нуур хамгааллын асуудалд ”хожмын цэвэр усны нөөц баялаг” гэсэн “тусгайлсан явцуу агуулгаар” гэхээсээ илүү, нуурыг, бусад олон уул усны нэгэн адил их байгалийн нэг-хэсэг гэж үзэж, байгаль хамгаалах ерөнхий хууль, түүнтэй хамааран уялдах бусад хууль тогтоомжийн хүрээнд хамгаалж ашиглаж иржээ. Нуурыг цэнгэг ба цэнгэг бус [хагас цэнгэг, давстай, шорвог] гэж ялгах, үүнийг хуулиар тодорхойлон баталгаажуулах гэж оролдох нь ээдрээтэй эргэлзээтэй асуудлын нэг юм. Нууран дахь эрдэсийн агууламж амьд байгалийнхаа хуулиар зохицуулагддаг. Зарим онцлог “нуур усыг хамгаалах тухай Рамсарын конвенц” -ийн агуулга ч үүнийг дам нотолдог гэж хэлж болохуйц юм.

b) Байгалийн атар онгон байдлын хэвээр хадгалах, нуур усыг бохирдуулахгүй байх, ус мөрний өгөөжийг нийгмийн хөгжил дэвшлийн болон ард иргэдийн ирээдүйн сайн сайхны төлөө [туйлын] үр нөлөөтэй ашиглах тал дээр дэлхийн улс орнуудын оролдлого туршлага заавал хоорондоо адилхан байх албагүй нь ч харагдаж байна. Улс орнууд энэ чиглэлд юу хүсч төлөвлөсөнөө олон улсын түгээмэл эрхзүйн хэм хэмжээ, хууль тогтоомжийн хүрээнд, дор бүрнээ, өөр өөрийнхөөрөө хийж хэрэгжүүлэх боломж нээлттэй. Амьдрал практик дээрээ ч, ус мөрөн ихтэй улс орны хууль эрхзүйн зохицуулалт, “ус нуургүй шахуу” газар орны холбогдох хууль тогтоомжийн агуулгын цаадах суурь үзэл санаа тэр бүрий хоорондоо ижил байх боломжгүй нь харагддаг.

c) Хилийн усны статустай цэнгэг нуурыг тэтгэгч гол мөрний урсацыг өөрчлөх асуудалд улс орнууд нэг талын ашгийг хэт эрхэмлэн “болгоомжгүй хандах” явдал ойлголт арилахгүй оршсоор байна. Манайханд, хятадын цэнгэг уст Далай нуурыг тэтгэгч Хэрлэн голын урсацыг говиор дайруулан өөрчлөх яриа гарч байсан удаатай ба хятадууд [манай] цэнгэг уст Буйр нуурыг тэтгэгч Халх голын урсацыг нуурын эсрэг чиглэлд татах төсөл хөтөлбөртэй; гэх мэт.

Цэнгэг нуурын хамгаалалтын асуудлыг яг нууран толиогоор нь биш түүний ай савраар [өргөн хүрээнд, бүхэлд нь] авч үздэг юм байна. Цэнгэг уст нуурыг хамгаалахын тулд түүнд цутгагч гол мөрнийг ч хамгаалах учиртай. Энэ мэтээс үүдээд “нуур хамгаалах”, “цэнгэг нуур хамгаалах” асуудал гол мөрнийг хамгаалах асуудалтай арга буюу очоод нийлчихдэг байна.

d) АНУ ба Канадын хилийн ус – Их нуурууд нь, хэрэг дээрээ, нуур ч юм, бас гол мөрөн ч юм. [Хоорондоо бүгд холбоотой. Нэг ус бүгдэнгээр нь дамжаад урсчихдаг гэж хэлж болно] Тиймээс тэнд, нуур хамгаалах асуудал өөрөө усан объектийн хамгаалал гэсэн өргөн агуулгатай.

e) Зарим улс орон нуур усыг хамгаалахдаа засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс төсөв зардал гаргаад биет үйл ажиллагаа, бүтээн байгуулалт өрнүүлэн инженерийн тооцоонд суурилсан гидротехникийн байгууламж барих ... зэргээр “ус ашиглах, байгаль хамгаалах” дорвитой ажил хийдэг, өрнүүлдэг. Мөн, зарим улс орон тухайн усан объектийн тойронд, хүрээлэн байгаа орчныг унаган төрхөөр нь онгон байлгах чиглэлд анхаардаг. Энд тухайн улс орны эдийн засгийн хүчин чадал ч нөлөөлж байгаа нь илт. \

f) Нэг тодорхой усан объекийг, эсхүл цэнгэг уст нэг-нуурыг тухайлан хамгаалсан хууль тогтоол гаргасанаар тухайн асуудал нэгмөр шийдэгдчихдэггүйг зарим орны туршлага харуулж байна; гэж үзнэ. ОХУ –ын Байгаль нуурыг хамгаалах тухай хууль, түүнийг дагаж гарсан засгийн газар, яам агентлагийн тогтоол захирамж, холбооны улсын [дотоод] субъектийн буюу орон нутгийн засаг захиргааны шийдвэр .. эд бүгдийн нийт тоо 100 лавтай хол давахаар байна. Гэтэл тэдгээрийг хэрэгжилт, үр дүнг салбарын мэргэжилтнүүд, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд чамласаар. Гэхдээ, Байгаль нуурыг хамгаалах тухай хууль гарснаар, хүн төрөлхтөний [байгалийн, нийтлэг өв] цэнгэг уст энэ гайхамшигт объектийг хамгаалахад зарцуулах хөрөнгө төсөв урьд урьдынхаас эрс нэмэгдсэнийг тэмдэглэх нь зөв болов уу.

2013.01.10

₪ ₪ ₪

(Хавсралт – 1)

БАЙГАЛЬ НУУРЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ [ОХУ –ын] **ХУУЛЬ**

Федеральный закон РФ от 1 мая 1999 года № 94-ФЗ)

Принят Государственной Думой 2 апреля 1999 г. Одобрен Советом Федерации 22 апреля 1999 года (с изм., внесенными Федеральными законами от 27.12.2000 N 150-ФЗ, от 30.12.2001 N 194-ФЗ, от 24.12.2002 N 176-ФЗ)

Настоящий Федеральный закон определяет правовые основы охраны озера Байкал, являющегося не только уникальной экологической системой Российской Федерации, но и природным объектом всемирного наследия.

Глава I. Основные положения

Статья 1. Правовое регулирование в области охраны озера Байкал

1. Правовое регулирование в области охраны озера Байкал осуществляется настоящим Федеральным законом, другими федеральными законами и иными нормативными правовыми актами Российской Федерации, а также законами и иными нормативными правовыми актами субъектов Российской Федерации. Если международным договором Российской Федерации

установлены иные правила, чем те, которые предусмотрены настоящим Федеральным законом, применяются правила международного договора.

Статья 2. Экологическое зонирование Байкальской природной территории

1. Байкальская природная территория - территория, в состав которой входят озеро Байкал, водоохранная зона, прилегающая к озеру Байкал, его водосборная площадь в пределах территории Российской Федерации, особо охраняемые природные территории, прилегающие к озеру Байкал, а также прилегающая к озеру Байкал территория шириной до 200 километров на запад и северо - запад от него.

2. На Байкальской природной территории выделяются следующие экологические зоны:

   - центральная экологическая зона - территория, которая включает в себя озеро Байкал с островами, прилегающую к озеру Байкал водоохранную зону, а также особо охраняемые природные территории, прилегающие к озеру Байкал;
   - буферная экологическая зона - территория за пределами центральной экологической зоны, включающая в себя водосборную площадь озера Байкал в пределах территории Российской Федерации;
   - экологическая зона атмосферного влияния - территория вне водосборной площади озера Байкал в пределах территории Российской Федерации шириной до 200 километров на запад и северо - запад от него, на которой расположены хозяйственные объекты, деятельность которых оказывает негативное воздействие на уникальную экологическую систему озера Байкал.

3. Экологическое зонирование Байкальской природной территории осуществляется в порядке, установленном Правительством Российской Федерации.

Статья 3. Границы Байкальской природной территории

1. Правительство Российской Федерации по представлениям органов государственной власти Республики Бурятия, органов государственной власти Иркутской области, органов государственной власти Читинской области, органов государственной власти Усть - Ордынского Бурятского автономного округа утверждает границы Байкальской природной территории и экологических зон - центральной экологической зоны, буферной экологической зоны, экологической зоны атмосферного влияния.

2. Органы исполнительной власти Республики Бурятия, органы исполнительной власти Иркутской области, органы исполнительной власти Читинской области и органы исполнительной власти Усть - Ордынского Бурятского автономного округа в порядке, установленном Правительством Российской Федерации, обеспечивают информирование населения Байкальской природной территории о границах Байкальской природной территории, в том числе о границах экологических зон, и об особенностях режима экологических зон.

Статья 4. Договоры о разграничении предметов ведения и полномочий органов государственной власти Российской Федерации и органов государственной власти субъектов Российской Федерации в области охраны озера Байкал

Предметы ведения и полномочия органов государственной власти Российской Федерации и органов государственной власти субъектов Российской Федерации в области охраны озера Байкал в соответствии с Конституцией Российской Федерации и федеральными законами могут определяться договорами о разграничении предметов ведения и полномочий органов государственной власти Российской Федерации и органов государственной власти Республики Бурятия, органов государственной власти Иркутской области, органов государственной власти Читинской области, органов государственной власти Усть - Ордынского Бурятского автономного округа.

Глава II. Режим охраны Байкальской природной территории

Статья 5. Основные принципы охраны Байкальской природной территории

В целях охраны уникальной экологической системы озера Байкал на Байкальской природной территории устанавливается особый режим хозяйственной и иной деятель-ности, осуществляемой в соответствии с принципами:

- приоритета видов деятельности, не приводящих к нарушению уникальной экологической системы озера Байкал и природных ландшафтов его водоохранной зоны;
- учета комплексности воздействия хозяйственной и иной деятельности на уникальную экологическую систему озера Байкал;
- сбалансированности решения социально - экономических задач и задач охраны уникальной экологической системы озера Байкал на принципах устойчивого развития;
- обязательности государственной экологической экспертизы.

Статья 6. Виды деятельности, запрещенные или ограниченные на Байкальской природной территории

1. На Байкальской природной территории запрещаются или ограничиваются виды деятельности, при осуществлении которых оказывается негативное воздействие на уникальную экологическую систему озера Байкал:

   - химическое загрязнение озера Байкал или его части, а также его водосборной площади, связанное со сбросами и с выбросами вредных веществ, использованием пестицидов, агрохимикатов, радиоактивных веществ, эксплуатацией транспорта, размещением отходов производства и потребления;
   - физическое изменение состояния озера Байкал или его части (изменение температурных режимов воды, колебание показателей уровня воды за пределами допустимых значений, изменение стоков в озеро Байкал);
   - биологическое загрязнение озера Байкал, связанное с использованием, разведением или акклиматизацией водных биологических объектов, не свойственных экологической системе озера Байкал, в озере Байкал и водных объектах, имеющих постоянную или временную связь с озером Байкал.

2. На Байкальской природной территории запрещается строительство новых хозяйственных объектов, расширение, реконструкция действующих хозяйственных объектов без поло-жительного заключения государственной экологической экспертизы соответствующих проектов.

3. Перечень видов деятельности, запрещенных в центральной экологической зоне, утверждается Правительством Российской Федерации.

Статья 7. Водный режим озера Байкал

В целях охраны уникальной экологической системы озера Байкал и предотвращения негативного воздействия хозяйственной и иной деятельности на ее состояние устанав-ливаются следующие требования к водному режиму озера Байкал:

- режим наполнения и сработки озера Байкал определяется специально уполномоченным государственным органом управления использованием и охраной водного фонда в порядке, установленном законодательством Российской Федерации;
- запрет на повышение уровня воды в озере Байкал выше максимальных значений и снижение уровня воды в озере Байкал ниже минимальных значений, установленных Правительством Российской Федерации.

  Примечание: Постановлением Правительства РФ от 26.03.2001 N 234 установлены предельные значения уровня воды в озере Байкал при осуществлении хозяйственной и иной деятельности.

Статья 8. Особенности охраны, вылова (добычи) эндемичных видов водных животных и сбора эндемичных видов водных растений

В целях охраны байкальских омуля, нерпы и других видов водных животных, а также видов водных растений, распространенных только в озере Байкал (далее также - эндемичные виды водных

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

животных и растений), за исключением водных животных и растений, занесенных в Красную книгу Российской Федерации, Правительством Российской Федерации или специально уполномоченным им федеральным органом исполнительной власти определяются допустимый объем вылова (добычи) байкальских омуля, нерпы и других эндемичных видов водных животных, сбора эндемичных видов водных растений, сроки вылова байкальского омуля и перечень орудий его вылова, сроки добычи байкальской нерпы и перечень орудий ее добычи, а также сроки сбора эндемичных видов водных растений. Особенности охраны, вылова (добычи) байкальских омуля, нерпы и других эндемичных видов водных животных, а также сбора эндемичных видов водных растений устанавливаются Правительством Российской Федерации.

Статья 9. Территории традиционного природопользования на Байкальской природной территории

1. На Байкальской природной территории в установленном законодательством Российской Федерации порядке определяются территории традиционного природопользования.

2. Отношения, возникающие в связи с использованием земель и других природных ресурсов на территориях традиционного природопользования на Байкальской природной территории, регулируются законодательством Российской Федерации в соответствии с настоящим Федеральным законом.

Статья 10. Особенности пользования земельными ресурсами в центральной экологической и буферной экологической зонах

Пользование земельными ресурсами в центральной экологической и буферной экологи-ческой зонах гражданами и юридическими лицами осуществляется с соблюдением требований настоящего Федерального закона.

Статья 11. Особенности лесопользования в центральной экологической зоне

1. В центральной экологической зоне запрещаются:
   - рубки главного пользования;
   - рубки в кедровых лесах, за исключением рубок ухода за лесом и выборочных санитарных рубок;
   - изъятие земель лесного фонда, занятых лесами первой группы, а также земель лесного фонда, не покрытых лесной растительностью, для их использования в целях, не связанных с ведением лесного хозяйства.

2. При лесоустройстве должен обеспечиваться приоритет восстановления особо цен-ных лесных массивов.

Статья 12. Организация туризма и отдыха в центральной экологической зоне

1. Организация туризма и отдыха в центральной экологической зоне осуществляется в соот-ветствии с правилами, обеспечивающими соблюдение предельно допустимых норм нагрузок на окружающую природную среду в центральной экологической зоне.

2. Правила организации туризма и отдыха в центральной экологической зоне утверждаются органами государственной власти Республики Бурятия, органами государственной власти Иркутской области.

Глава III. Нормативы предельно допустимых вредных воздействий на уникальную экологическую систему озера Байкал

Статья 13. Порядок установления нормативов предельно допустимых вредных воздействий на уникальную экологическую систему озера Байкал

1. Для Байкальской природной территории устанавливаются нормативы предельно допустимых

вредных воздействий на уникальную экологическую систему озера Байкал в порядке, опре-деленном законодательством Российской Федерации в соответствии с настоящим Федеральным законом.

2. Нормативы предельно допустимых вредных воздействий на уникальную экологическую систему озера Байкал, а также методы их определения утверждаются соответствующими специально уполномоченными федеральными органами исполнительной власти и совершенствуются на основании данных научных исследований.

3. Перечень вредных веществ, в том числе веществ, относящихся к категориям особо опасных, высокоопасных, опасных и умеренно опасных для уникальной экологической системы озера Байкал, утверждается специально уполномоченными федеральными органами исполнительной власти.

Статья 14. Предельно допустимый объем сбросов и выбросов вредных веществ, размещения отходов производства и потребления, опасных для уникальной экологической системы озера Байкал

1. Предельно допустимый объем сбросов и выбросов вредных веществ, размещения отходов производства и потребления, опасных для уникальной экологической системы озера Байкал, устанавливается с учетом результатов научных исследований в соответствии с законодательством Российской Федерации и ежегодно подлежит обязательному пересмотру в целях его уменьшения с учетом состояния окружающей природной среды Байкальской природной территории.

2. Количество относящихся к категориям особо опасных и высокоопасных для уникальной экологической системы озера Байкал вредных веществ в сбросах хозяйственных и иных объектов, расположенных в центральной экологической и буферной экологической зонах, не должно превышать такое количество при заборе воды.

3. Концентрации вредных веществ всех категорий опасности для уникальной экологической системы озера Байкал в сбросах и выбросах не должны превышать нормативы предельно допустимых концентраций вредных веществ, установленных для каждой из экологических зон.

Глава IV. Государственное регулирование в области охраны озера Байкал

Статья 15. Федеральный орган исполнительной власти, специально уполномоченный на осуществление государственного регулирования в области охраны озера Байкал

В соответствии с Конституцией Российской Федерации и Федеральным конституционным законом “О Правительстве Российской Федерации” определяется федеральный орган исполнительной власти, специально уполномоченный на осуществление госу-дарственного регулирования в области охраны озера Байкал.

Статья 16. Комплексные схемы охраны и использования природных ресурсов Байкальской природной территории

Основой для осуществления хозяйственной и иной деятельности на Байкальской природной территории являются комплексные схемы охраны и использования ее природных ресурсов, разрабатываемые и утверждаемые в порядке, установленном законодательством Российской Федерации и законодательством субъектов Российской Федерации.

Статья 17. Экологическая паспортизация хозяйственных объектов на Байкальской природной территории

Юридические лица, осуществляющие хозяйственную и иную деятельность на Байкальской природной территории, обязаны иметь экологические паспорта хозяйственных объектов. Особенности ведения экологических паспортов хозяйственных объектов на Байкальской природной территории определяются федеральным органом исполнительной власти, специально уполномоченным на

осуществление государственного регулирования в области охраны озера Байкал.

Статья 18. Ликвидация или перепрофилирование экологически опасных хозяйственных объектов

Ликвидация или перепрофилирование экологически опасных хозяйственных объектов на Байкальской природной территории осуществляется в порядке и в сроки, которые установлены законодательством Российской Федерации.

Статья 19. Государственный экологический контроль в области охраны озера Байкал

Государственный экологический контроль в области охраны озера Байкал осуществляется федеральным органом исполнительной власти, специально уполномоченным на осуществление государственного регулирования в области охраны озера Байкал, иными специально уполномоченными федеральными органами исполнительной власти, а также органами государственной власти Республики Бурятия, органами государственной власти Иркутской области, органами государственной власти Читинской области, органами государственной власти Усть - Ордынского Бурятского автономного округа.

Статья 20. Государственный экологический мониторинг уникальной экологической системы озера Байкал

Государственный экологический мониторинг уникальной экологической системы озера Байкал осуществляют федеральный орган исполнительной власти, специально уполномоченный на осуществление государственного регулирования в области охраны озера Байкал, и иные специально уполномоченные федеральные органы исполнительной власти в рамках единой системы государственного экологического мониторинга.

Статья 21. Финансирование деятельности по охране озера Байкал

1. Финансирование деятельности по охране озера Байкал осуществляется за счет средств федерального бюджета и других источников в соответствии с законодательством Российской Федерации и законодательством субъектов Российской Федерации.

   Действие пункта 2 статьи 21 приостановлено с 1 января по 31 декабря 2003 года Федеральным законом от 24.12.2002 N 176-ФЗ. Действие пункта 2 статьи 21 приостановлено с 1 января по 31 2002 года Федеральным законом от 30.12.2001 N 194-ФЗ. Действие пункта 2 статьи 21 приостановлено с 1 января по 31 декабря 2001 года Федеральным законом от 27.12.2000 N 150-ФЗ.

2. В соответствии с бюджетным законодательством Российской Федерации образуется целевой бюджетный фонд по охране озера Байкал.

Статья 22. Целевые программы в области охраны озера Байкал

1. В целях планирования и осуществления мероприятий по охране озера Байкал осуществляются разработка и реализация федеральных целевых программ и региональных целевых программ в области охраны озера Байкал.

2. Федеральные целевые программы в области охраны озера Байкал формируются Правительством Российской Федерации в порядке, установленном законодательством Российской Федерации. Региональные целевые программы в области охраны озера Байкал разрабатываются и утверждаются в порядке, предусмотренном законами и иными нормативными правовыми актами субъектов Российской Федерации.

Статья 23. Информация в области охраны озера Байкал

В порядке, установленном законодательством Российской Федерации, гражданам и юридическим лицам обеспечивается доступ к информации в области охраны озера Байкал.

Статья 24. Ответственность за нарушение настоящего Федерального закона

Лица, виновные в нарушении настоящего Федерального закона, несут ответственность в соответствии с гражданским, административным, уголовным и иным законодательством Российской Федерации.

Статья 25. Международное сотрудничество Российской Федерации в области охраны озера Байкал

Международное сотрудничество Российской Федерации в области охраны озера Байкал регулируется Конституцией Российской Федерации, международными договорами Российской Федерации, федеральными законами и иными нормативными правовыми актами Российской Федерации.

Статья 26. Вступление в силу настоящего Федерального закона

1. Настоящий Федеральный закон вступает в силу со дня его официального опубликования.

2. Нормативные правовые акты Российской Федерации подлежат приведению в соответствие с настоящим Федеральным законом.

Президент Российской Федерации Б. Ельцин, Москва, Кремль, 1 мая
1999 г.,N 94-ФЗ

* * *

(Хавсралт - 2)

Монголын [том] **нууруд** (Жагсаалтын хэсгээс)

(Хүснэгт -1, Нуурын дүрс зүйн тодорхойлолт, дарааллыг толин гадаргын хэмжээгээр авав, товчилсон)

	Нуурын нэр	Нуурын талбай ($км^2$)	Нуурын урт	Нуурын өргөн (км)		Нуурын гүн (м)		Нуурын эзэлхүүн ($км^3$)
				дундаж	max	дундаж	max	
1	Хөвсгөл (цэнгэг)	2760	136	20,8	36,5	138	262	380,7
2	Увс (давст)	3350	84	40	79	11,9	20	39,6
3	Хар – Ус (цэнгэг)	1852	72,2	26	27	2	4,5	3,432
4	Хяргас (эрдэст)	1407	75	19	31	47	80	66,034
5	Буйр (цэнгэг)	615	40	15	21	6	10,2	3,784
6	Хар нуур (цэнгэг)	575	37	16	24	4,2	7	1,422
7	Дөргөн (давст)	305	24	13	17	14	27	4,367
8	Ачит (цэнгэг)	297	24	12	18	2	5	0,665
9	Бөөнцагаан (давст)	252	24	11	19	10	16	2,355
10	Үүрэг (давст)	239	20	12	18	27	42	6,419
11	Тэлмэн (цэнгэг)	194	28	12	16	13	27	2,671
...	...	...	...	...	...	...	...	...
169	Домбон	2	3,4	0,6	0,8	1	2	0,002

UB.MN
СУДЛАГААНЫ САН

170	Шавхалт	2,1	2,9	0,8	1,2	1,1	2	0,002

* * *

Ашигласан материал

1. [Монгол Улсын] Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний илтгэл, УБ, 2010;
2. Монгол орны нуурын каталоги, УБ, 2000;
3. WHO/UNISEF, Global Water Supply and Sanitation Assessment 2000 Report, 2000. New York: UNISEF,WMO (World Meteorological Organization), 1997, Comprehensive Assessment of the Freshwater Resources of the World, Stockholm, Sweden: WMO and Stockholm Environment Institute. WRI (World Resources Institute), 2002, Earth Trends Website Statistical Database available on line at
4. www.earthtrends.wri.org
5. http://www.panda.org/livingwaters/about.html
6. бусад;

ГҮНИЙ УСНЫ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ТУРШЛАГА

Г. Алтан – Оч (Ph.D), Г. Чулуун

УИХ –ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байгын хорооноос ирсэн захиалгын[23] дагуу бид “гүний усны хамгаалалт, ашиглалтын асуудлыг эрхзүйн талаас нь зохицуулсан гадаадын зарим улс орны туршлага”, түүнд холбогдох бусад мэдээллийг энд нэгтгэв. Гүний ус бол газрын доорхи усны нэг төрөл бөгөөд газрын гидросферийн хүрээндээ, тэрээр, агууламж эзлэхүүнээрээ ч зонхилох хэмжээтэй, үндсэн бүрдэл нь хэсэг юм. Тиймээс бид газрын доорхи усны тухай өгүүлэмж, үндсэндээ [бол] гүний усны тухай асуудал мөн гэсэн бяцхан дөхүүлэлт [авч] хэрэглэлээ.

Манай тохиолдолд, гүний усны ашиглалт - хамгаалалтын асуудлын, ялангуяа хамгаалалтын талын хэсэг нь дотроо дахин задарч яригдах бололцоотой төдийгүй шаардлагатай байгааг юуны өмнө тэмдэглэх нь зүйтэй байх. Гүний усны хамгаалалтын асуудалд,

a) гүний усны ашиглалтын явцад учирах сөрөг нөлөөллийг бууруулах буюу бохирдлоос үйл ажиллагаагаар хамгаалах [ажил үйлчилгээ, техник технологийн чанартай] арга зам;
b) гүний усыг, усан объектийнх нь хувьд эрх зүйн талаас нь хамгаалах арга ажиллагаа;
c) экологийн даатгал;

тус тус хамаарах боломжтой. Энд өгүүлсний b) –д дурдсан, гүний усыг усан объек, мөн, ашигт малтмал болохынх нь хувьд эрхзүйн талаас нь хамгаалах чиглэлийн асуудлыг бид энд тухайлан авч үзэв.

Гүний усны ашиглалт хамгаалалтын асуудал Усны хууль, Газрын хэвлийн тухай, Байгаль хамгаалах ... зэрэг ерөнхий хуулиудаас гадна засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, салбарын яам газар агентлагаас, бусад олон холбогдох хууль тогтоомжтой уялдуулж гаргасан тогтоол шийдвэр, заавар журам, норм нормативаар [олон төвшинд] зохицуулагдана.

Гүний усны эрхзүйн дэглэм (правовой режим подземных водных объектов) –ийн ойлгох тайлбарлахад төвөгтэй зүйлс гол төлөв уг усан ордын хил хязгаарын тодорхойгүй байдал, өмчийн эрхзүйн талтай холбогдож гардаг.

> Отмечалось в юридической литературе, было и остаётся неясным, до каких пределов горные породы, вмещающие в себя подземные воды, могут признаваться предметом права собственности на водные объекты.

Газрын гүний цэнгэг усыг ашиглах чиг сэжим хангалттай олон. Үүнтэй холбогдоод,

- ундны болон ахуйн хэрэглээний [газрын доорхи цэнгэг] усны эрхзүй;
- үйлвэрлэлийн процесст ашиглагдах технологийн зориулалттай газрын гүний усны эрхзүй;

гэсэн хоорондоо төсөөтэй боловч “өрсөлдөөнтэй” гэмээр гүний усны эрхзүйн 2 чиглэл үүсэн хөгжиж байгаа гэдэг.

23 УИХ –ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн Байнгын хорооны даргын 2013.01.10 –ны өдрийн № - $^{6}/_{253}$ тоот албан бичиг;

1. Ерөнхий зарим ойлголтын хүрээнд (товчхон)

Газрын доорхи ус нь нэг талаасаа усан объект, нөгөө талаасаа ашиг малтмалд [давхар] тооцогдоно. Гүний ус урт хугацааны туршид үүсч хуримтлагдаж хадгалагдаж ирсэн, хүний үйл ажиллагааны шууд шууд нөлөөнөөс харьцангуй ангид оршдог, гарвалын хувьд [эртэн цагийн] гадаргын усны нэвчилтээс үүдэлтэй усан объект юм. Газрын доорхи усыг хамгаалах, түүнийг хэмнэлттэй зарцуулах, эдийн засгийн өгөөжтэй ашиглах явдал эдүгээ дэлхийн улс орнуудын энэ цагийн тулгамдсан зорилтын нэг болжээ.

Ус үл нэвтрүүлэгч буюу ус тогтоогч хоёр давхаргын хоорондох ус даралтын орчинд байх ба гүн өрмийн цооног үүсгэмэгц шууд олгойдно. Зурагт олгойдон харагдаж байгаа ус[нууд] бол гүний ч ус юм, артезийн ч ус юм. XII зуунд Францын Артуа тосгонд гүний усны анхны [ийм] худаг гарснаас артезийн худаг, артезийн ус гэх болжээ. Гүний усыг унданд, газар тариалан, үйлдвэрлэлд .. өргөн ашигладаг. Харин, хөрсний ус даралтгүй. Хөрсний усны төвшин хаана байгаа, яаж өөрчлөгдөж байгааг худгийн усны түвшин харуулна.

Гүний ус нь мөрний урсацыг тэтгэх нэг эх үүсвэр юм. (Подземные воды являются одним из источников питания рек) Энэ бол гүний ус гадаргын усны хоорондын харилцан шүтэлцээг тодотгож буй өгүүлэмж. Гүний усны түвшин багасах, дундрах, шавхагдах үед газрын дээд давхарга аяндаа хатаж, ялангуяа говьд унах бага зэргийн хур тундаснаас өөр тэжээлгүй болсон ойр тойрны газар, хүрээлэн буй орчин үхжиж эхэлдэг нь учирч болох магадлал өндөртэй эрсдэлд тооцогддог. Гүний ус 200000 - 1 сая жилд бий болж, нөхөн сэргээгддэг байна.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ) -нд дурдсанаар, жишээ нь, Оюутолгой орчмын газрын гадаргатай ойр бага гүний уст давхарга [тэндэхийн] Гүний хоолойн “гүний усны”уст давхаргын нэвчих хоорондын холбоо маш бага сул юм. Тиймээс, зарим мэргэжилтнүүд Гүний хоолойн гүний усны нөөцийг ашиглахад өнгөн хөрсөн дээр ямар ч сөрөө нөлөө мэдрэгдэхгүй гэж “нотолсон” нь бий. Гэхдээ, “юмыг яаж мэдхэв” гээд ном журмын дагуу олон тооны худагт байнгын ажиглалт хийж байгаа болно.

Монголыг гүний усны нөөц нийт нутаг дэвсгэрийн хувьд жигд бус алаг цоог тархалттай, хойноос урагшлах тусам найрлагын хувьд эрдэсждэг. Монгол орны газар доорх усыг оршиц, тэжээгдэх байдал, эргэлтийн горимоор нь ул хөрсний ба артезийн гэж хоёр хуваана. Нам газарт ул хөрсний усыг уурхайн худгаар хялбархан авч болдог. Ул хөрсний усны эрдэсжилт болон бүрэлдэхүүн нь хотгор гүдгэрийн байдлаас ихээхэн шалтгаална. Монголын тектоникийн хил ба гүний усны ордуудын тархалтын хил ерөнхийдөө давхцдаг.

Монгол усны нөөцөөр хомс орон. Гадаргын усны нийт нөөц 598 км³ бөгөөд түүний 34.6 км³ нь нөхөн сэргэдэг нөөц юм. Нийт нөөц нууруудад (500 км³), мөсөн голд (62.9 км³), гол мөрөнд (34.6 км³/жил) гэсэн харьцаатай орших ба газрын **гүний усны нөөц** - 12.1 км³ гэсэн үнэлгээг байнгын хяналт шинжилгээний үр дүнд үндэслэн Ус цаг уур, орчны шинжилгээний алба тогтоожээ. Манай орны нийт ус ашиглалт, хэрэглээ жилд 0.5 км³ орчим юм.



Гүний усыг чанар ба зориулалтаар нь хэд хэд ангилна. Үүнд:

- ундны ус (цэнгэг)
- техникийн зориулалттай ус (багавтар эрсдэлжилт бүхий)
- рашаан ус (эмчилгээнд ашиглах)
- [аж] үйлдвэрийн зориулалттай ус (агуулга дотроос нь ялгах замаар зарим бодис - бром, йод .. зэрэг химийн элемент олборлох .. г. м.)
- дулааны энэрги агуулсан ус (халуун дулааны хэрэгцээ хангах чадамжтай)

Гадаргын усны хэмжээг барьж экологийн тэнцвэрийг хадгалахад шийдвэрлэх үүрэгтэй монгол орны хөрсний мөнх цэвдгийн хайлалт сүүлийн жилүүдэд байнга өссөөр байгаа дүн мэдээ бий. Энэ байдал **гүний**, хөрсний, гадаргын усны нөөцийн хомсдол, усны экосистемын тогтоц алдагдахад түлхэц өгдөг бөгөөд гадаргын усны ширгэлтийн үндсэн шалтгаануудын нэг юм.

Дэлхийн гидросферийн усны ордууд барагдаж хорогдож байгааг гравитацийн хүчний өөрчлөлтийн мэдээлэлд түшиглэн, сансрын хиймэл дагуулаас (NASA) тодорхойлсон тухай, мөн, газрын доорхи усны хомсдол, гүний усны тураалаас болж дэлхийн зарим томоохон хотуудад бэрхшээл хэдийнэ учирсан тухай мэдээ материал ч таардаг.

2. Гүний усны тулгамдсан хэрэгцээ ба [манай] **хууль тогтоомж**

Байгаль орчны [шинэ] багц хууль 2012.5.17 -нд батлагдаж хэрэгжиж эхэлсэн. Шинэ багц хуулийн агуулга ёсоор “монголын усны нөөц нь стратегийн үнэт баялаг” юм. Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4.1 -т ингэж заасан. Өнгөрсөн жил, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр, монголын өмнийн говийн бүс нутагт өрнөх уул уурхайн бүтээн байгуулалтад шаардагдах усны асуудлыг тухайлан авч хэлэлцсэн.

Ус үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдаж, стратегийн үнэт баялаг хэмээн тодорхойлогдож байгаа нь, түүний үнэ цэнийн илэрхийлэл болж өгч байна.

Байгаа нөөцийнхөө хүрээнд, усыг үр өгөөжтэй хэмнэлттэйгээр ашиглах зарчим у, шинэчилсэн багц хуулийн түлхүүр заалт, гол үзэл санаа юм. Манай улсын хувьд, уул уурхайн салбарт усны хэрэгцээ хамгийн их эрэлттэй байгаа юм. Уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй монголын өмнийн говийн бүс нутагт газрын гүний усны судалгааг нэгдсэн журмаар хийгээгүй. БНМАУ, СССР –ийн үеийн судалгаанаас өөр мэдээлэл хомс, хувийн компаниудын [хийсэн] нэгдмэл-бус мэдээллүүд зонхилдог.

Уул уурхайн болон бусад үйлдвэрлэлийн ус ашиглалт жилд 157.2 сая шоо метр байгаа бөгөөд Тавантолгой, Оюутолгой, Цагаан суварга зэрэг шинээр байгуулагдах уул уурхайн томоохон үйлдвэрүүдийн усны эрэлт хэрэгцээг тооцвол энэ тоо үлэмж хэмжээгээр нэмэгдэх төлөв гарч байна. Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй өсөхийн хэрээр гүний усны эрэлт хэрэгцээ үлэмж ихээр нэмэгдэж, өнөөгийн түвшнээс 10 - 15 дахин магадгүй түүнээс ч илүүгээр өсөх хандлага ажиглагдаж байгааг салбарын мэргэжилтнүүд тооцоолж, сануулсаар иржээ. Уул уурхай салбар, аж үйлдвэрийн паркийн усан хангамжийн эрэлтийн тооцоонд, ирээдүйд энэ салбар чиглэлд технологийн ус хүрэлцэхгүй; гэж гарчээ.

> Өмнийн говийн бүсэд газрын доорх ус ойрын 10 - 12 жилийн хугацаан дахь уул уурхайн үйлдвэрлэлийн хэрэгцээг хангалттай нөхөж чадна, харин түүнээс цаашхи хугацаанд байгаль эхийн он удаан жилд хуримтлуулж хадгалсан нөөц хэр хүрэлцээтэй байхыг одоо тооцоолох аргагүй хэмээн олон улсын судалгааны байгууллага дүгнэжээ.

Монголын **говьд** гадаргын ус бараг байхгүй, тэнд зөвхөн гүний усны хязгаарлагдмал нөөцтэй. Энэ нөөц нь уул уурхай, хүн амын усны хэрэгцээг хангаж чадахгүй учраас гадаргаас ус дамжуулах төслүүдийг мэргэжлийн байгууллагууд ч судалж буй юм. Томоохон гол мөрний урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах шийдвэрийг УИХ гаргах эрхтэй гэсэн заалт шинэ багц хуульд хэвээр үлдсэн. Стратегийн ордын хувьд, тэдний ус ашиглах эрх нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаатайгаа адил 30 жилээр тогтоогдсон.

Балгасын улаан нуурын_гүний ус

Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах гол зангилаа асуудлуудын нэг нь Балгасын улаан нуурын газрын доорх гүний усны орд юм. Уг ордыг ашиглуулах, эс ашиглуулах тал дээр маргаан их өрнөдөг. Балгасын улаан нуурын доорхи гүний ус хамгийн залуу, цэнгэг устай орд болох нь судалгаагаар тогтоогдсон. Нутгийн иргэд ордыг ашиглахыг эрс эсэргүүцэж байгаа бол Засгийн газраас тодорхой хэсгийг нь авч ашиглахаас өөр аргагүй гэдгийг хэлж, тогтоол шийдвэрээ нэгэнт гаргачихсан. Хуулийн §22.7 -д “гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг **улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад** авна гэсэн заалт бол байгаа. Тус ордыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан боловч дээрээс гарсан тушаал шийдвэрийг арга буюу дагах болдог .. г. м.

Өмнийн говь бүс нутагт хэрэгжиж буй уул уурхайн томоохон төслүүдийн хүрээнд шийдвэрлэгдэх учиртай, хүнд бөгөөд том зорилтуудын нэг нь уурхайн технологийн усан хангамжийн асуудал юм. Тус бүс нутагт зэс - молибдений, хүрэн ба чулуун нүүрсний ... зэрэг олон ордод олборлолт явагддаг. Тэдгээрт гүний усыг цооногоор авч, ундны зориулалтаар болон үйлдвэрлэлийн шат дамжлагад ашиглана. Уул уурхайн үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахын тулд говь нутгийн гүний усыг энэ мэтээр ашиглах үзэгдэл хаа сайгүй түгээмэл байгаа ч ус ашиглалт хамгаалалтын гормийг тэр бүрий баримтлахгүй явдал гарсаар байгаа юм.

- Шивээ – Овоогийн уурхайд цооногоор 5 - 13 л/сек. ус авч хэрэглэдэг бөгөөд энэ байдлаар явбал 25 жилийн дараа тус уурхайн орчмын гүний ус шавхагдаж дуусна; гэх тооцоог Дэлхийн банкны мэргэжилтнүүд 2010 онд хийжээ.

- Расход пресной воды в индустрии: для производства одной тонны стали расходуется 150 - 200 м^3 воды, **меди** расходуется[24] – 500м^3 воды.

- Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Мардайн ордын орчимд ч гадаргын ус үгүй. Тэнд, ойролцоох голуудаас 20 км –ийн шугаман хоолой ашиглан хэрэгцээт усаа татаж авч ашиглаж байна. Эдгээр жишээнээс гадна хууль бусаар, далд байдлаар говь тал хээрийн бүс нутагт гүний усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй ашиглах явдал ч бий.

“Усны сав газар” гэж гадаргын ус хурах талбай болон **газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж**, тархалтын талбайг хамарсан орон зайг [бүхэлд нь] хэлдэг. Монгол 29 усны сав газар бий. Харин хууль дахин шинэчлэгдсэнээр сав газрын зөвлөлийн санал дүгнэлт үнэтэй болох юм. Сав газар бүрт захиргаа байх ба түүний эрх үүрэг нь ч тодорхой болсон. Сав газрын захиргааны дэргэд сав газрын зөвлөл бас байна. Захиргаа зөвлөл хоёр бие биенээ харилцан хянаж, хамтран ажиллах юм.

Сав газрын захиргаа багагүй эрхтэй байгаагийн дотроос §17.2 -д “Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиргааны саналыг үндэслэнэ” гэсэн заалт нэлээд анхаарал татаж, бараг хасагдах шахан байж хуульд орсон. Мөн гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах, сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох гэх мэт чухал чухал дүгнэлт гаргах эрх Сав газрын захиргааны гарт бий.

Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ус хэрэглэгч, ашиглагчийн хариуцлага өмнөхөөсөө илүү чангарсан. Гэхдээ энэ хариуцлагыг гадны улс орнуудтай жишихэд харьцангуй (хамаагүй) зөөлөн гэдэг. Уул уурхайн том төслүүд бүрэн хэмжээгээр ашиглалтад орохоос урьтаж [гүний] ус ашиглахад тавигдах шаардлага, босгыг өндөрсгөх нь их ач холбогдолтой гэж үзнэ.

а) Гүний усны ашиглалт хамгаалалтын зарим байдал

Монголчууд бидний .. гүний усаа хэрхэн хайрлан хамгаалж байгааг “сөрөг талаас нь харуулсан доорхи бяцхан түүх, салбарын хэмжээнд мөн чиглэлээр хийгдэж байгаа үр дүнтэй олон сайхан ажил төслийг үгүйсгэхгүй ч, эрхбиш нэгийг бодогдуулах байх. Лавлагаа мэдээллийг гаргахаа бид салбарын зарим мэргэжилтэнтэй холбогдож ажилласан болно.

Хэнтий аймгийн Дархан сумын төвийн артезийн худгийн талаар тухайлан сонирхож байв. Пласт хоорондын их даралтаар, олон метрийн өндөрт байнга тасралтгүй оргилдог [энэ мэт] гүний усны оргилолт “зохиомол” булаг (артезийн худаг) манай орны аль ч хэсэгт бий; ажээ. Ийм худгуудыг байгуулсан цаг хугацаа нь 1970 - 1980 оны хооронд таардаг бөгөөд тэр үед уст цэг гаргах, мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээр усжуулах явдал бол тухайн цагийн намзасгийн нэн тэргүүний чухал зорилтуудын нэг байж. Хэнтийн Дарханы артезийн худгийг Бор - Өндөрийн бүтээн байгуулалтын үед ОХУ -ын гидрогеологчид гаргажээ. Уг нутаг орон нилдээ том хөндий учраас, нэгэнт ус оргилсон бол, ус агууламжийн хангалттай өргөн давхрага байх бүрэн боломжтой юм.

Ном ёсны үүднээс буюу байгаль экологиин талаас нь авч үзвэл эдгээрийг зайлшгүй

[24] Экологическая гидрогеология: Учебное пособие - СПб.: Изд-во С.-Петербургского института, 1996;

буцааж битүүмжлэх шаардлагатай байдаг. Хамгийн сонирхолтой нь, жишээнд дурдсан фонтаныг буцаан битүүмжилсэн тухай мэдээ байдаг ч, артезийн ус өнөөг хүртэл тэртээх 30 – 40 жилийн тэртээх шигээ “тэвэр дүүрэн усаар тэнгэрт тултал” олгойдож байдаг албан бус мэдээ бас байгаа юм. Дархан сумын хэмжээнд гүний, инженерийн, энгийн .. нийт 110 гаруй худаг уст цэг байгаа нь, тэнд артезийн худаг заавал шаардлагүйг харуулах үзүүлэлт юм.

Хэнтий аймаг, Дархан сумын төв, артезийн фонтан 3 км. урсаад хөрсөнд шингэдэг.

Хэнтийн Дархан сумын нутаг дэвсгэрт Дотуур булаг, Шавартай, Бор хужир, Далантүрүү, Бөөрийн булаг, Зараагийн булаг, Гэзэгийн булаг, Ходойн булаг, Бага булаг, Баянбулаг, Ноён булаг, Боонгын булаг, Дэвтээрийн булаг .. зэрэг 31 тооны [нэгэн цагт усархаг байсан] олон булаг шанд байдаг боловч тэдгээр нь жил ирэх тутам ширгэн усгүй болсоор байгаа аж. Мөн, тус сумын хэмжээнд 17 нуур тойром байснаас одоогийн байдлаар дөнгөж 9 нь үлдэж бусад нь ширгэсэн байна. Энэ мэт үзэгдлийн цаад учир шалтгааныг нь, зөвхөн байгаль цаг агаарын хувьсал өөрчлөлттэй холбож үзэх нь эргэлзээт тайлбар гэж үзнэ. Магадгүй энэ нь тэндэхийн газрын гүний усны тураалтай ч холбоотой байж болно.

Байдлыг харьцуулан жиших үүднээс, ОХУ –ын Гүний усыг хамгаалах дүрэм журмын холбогдох заалт – зохицуулалтыг бид сөхөж харсан. Нарийн журамласан байна лэй. Тэр тухай дараагийн дэд гарчгийн дор жич өгүүлэх болно.

3. Оросын холбооны улсад ...

ОХУ –ын усны тухай хууль тогтоомж нь Усны кодекс (1995), мөн [түүнийг дагаж гарсан, усны харилцааг зохицуулсан] янз бүрийн төвшний эрхзүйн холбогдох баримт бусад бичгүүдээс тогтоно. 1992 оны 2 сард батлагдсан ОХУ –ын Газрын хэвлийн тухай хууль ч гүний усны хайгуулийн болон ашиглалт (олборлолт) –той холбогдсон харилцааг зохицуулдаг. Чухамхүү, Газрын хэвлийн тухай хуулинд, ашигт малтмалын ашиглалт хамгаалалтыг нийгмийн тусын тулд, иргэн, нэгж байгууллага (хэрэглэгч) ба улсын аль алинд нь өгөөжтэй [байх] горимоор хэрэгжүүлэх эрхзүйн болон эдийн засгийн зарчмын үндсийг зааж тодорхойлсон[25] гэж үздэг.

[25] Закон о недрах «содержит правовые и экономические основы рационального комплексного

Орос бол газрын доорхи усны нөөцөөр баян [28000 км^3] орон. Тэнд, газрын гүний усны 3367 орд буй бөгөөд тал хувийг нь ашигладаг. Гүний усны нэгдсэн ордуудын ашиглалтын нөөц жилд 28,5 км^3 –д хүрсэн. ОХУ газрын доорхи усны нөөцийн чадамж ихтэй. Газрын доорхи усны нөөц нь ерөнхийдөө бүгд 1990 оноос өмнө, СССР –ийн үед улсын төсвийн хөрөнгөөр санхүүжиж хийгдсэн хайгуулын ажлын үр дүн юм.

Гүний усны ордын “ашиглалтын нөөц” гэх [сая дурдсан] нэр томъёог орост эдүгээ тэр бүр хэрэглэхгүй болж байгаа ба түүнийг эдүгээ, зүгээр л “гүний усны нөөц” гэх болсон. Оросын “Геомониторинг” [улсын төв] –ийн 2007.01.01 –ний байдлаар гаргасан мэдээнд, прогнозын ресурсийг доорхи агуулгаар дурджээ. Үүнд:

- Государственным Центром “Геомониторинг” в России на 1.01.2007 г. учтены прогнозные ресурсы подземных вод в количестве 869,1 млн куб.м/сут (317,2 куб.км/год).
- По результатам оценки обеспеченности населения ресурсами подземных вод для хозяйственно-питьевого водоснабжения, которая выполнена в 1994 - 2000 гг. организациями Министерства природных ресурсов России, общая величина прогнозных ресурсов составляет около 1100 млн куб.м/сут (350 куб.км/год). Однако в связи с тем, что апробация этих прогнозных ресурсов в установленном порядке не была проведена, обе величины носят справочный характер.
- Запасы подземных вод прошедшие государственную экспертизу, на 1.01.2008 г. составили 93,8 млн куб.м/сут на 6371 месторождении (участке), учитываемых в системе государственного мониторинга состояния недр на 1.01.2008 г.

Орост, усан объектийн ашиглалтын асуудлыг зөвшөөрлийн лицензтэй. Хэрэглэгчийн эрх үүрэг, ашиглалтын зорилго чиглэл, хугацаа хэмжээ ... зэрэг нарийссан зүйлсийг, газрын хэвлийн баялигийг лицензээр ашиглах Журам (1992) –аар, мөн, энэ журмыг хэрэглэх Заавар (1994) –аар тодотгосон. ОХУ –ын “Положение о порядке лицензирования пользования недрами” – журам байгаа. Энэ болон, мөн, Гүний усны ордыг ашиглах хамгаалах тухай .. журмууд нь хэдийгээр хугацааны хувьд нилээн “эртний эд” боловчиг эдүгээ хэрэглээнд байгаа нь илт. Интернет ресурсийн зарим мэдээлэлд, заримд нь “2006 оны өөрчлөлт оруулсан текст” гэсэн зүүлт хийсэн байв. Гүний усны ашиглалт хамгаалалт, тураал суултын таалаар дурдсан ерөнхий үндсэн агуулга нь анхааралын хүрээнд байх тийм зүйлүүд гэж үзэв.

Газрын доорхи “усан объектийн хил” хязгаар ОХУ –ын Усны кодексийн 5 дугаар зүйлд зааснаар тодорхологдоно. Харин, Газрын хэвлийн тухай хууль энэ талаар нарийн тодорхойломж ороогүй. Энэ байдлыг ОХУ –ын Засгийн газрын дэргэдэх Харьцуулсан эрхзүй, хууль тогтоомжийн институтийн зарим мэргэжилтэн[26] “гүний ус - ашигт малтмал” учраас тэгсэн; гэдэг. Газрын доорхи баялиг бүхэлдээ “төр” гэсэн ганцхан өмчлөгчтэй учраас энэ байдал [тэнд] одоогоор төвөгтэй байдал үүсгэлгүй явж ирсэн; гэж тайлбарлажээ.

Газрын хэвлий ашиглах чиглэлд зах зээлийн эдийн засгийн харилцаа гүнзгийрэн хөгжихийн хэрээр, газрын гүний зарим объектуудын (ялангуяа, газрын доорхи усан объектуудын хувьд) хилийн тухай ойлголтыг холбооны улсын хуулиар тодорхойлж өгөх хэрэгцээ үүсээд байгаа. Асуудал газрын хэвлийн ба усны тухай гэсэн хуулиудын дундын хамааралтай, гүний өөрөө «А» цэг дээр олборлоход, түүнээс хаа хамаагүй өөр «Б» цэг дээр ч “баялгийн хорогдол” эн тэнцүүхэн явагдаж байдаг онцлогтой юм. ОХУ –ын хууль тогтоомжийн “гүний усны истощение” гэдэг ойлголт ихээхэн анхаарал татах ухагдахуун юм.

использования и их (недр) охраны, обеспечивающих защиту интересов государства и граждан Российской Федерации, а также пользователей»

[26] Сиваков Дмитрий (Ph.D), эксперт, ведущий научный сотрудник отдела аграрного, экологического и природоресурсного законодательства Института законодательства и сравнительного правоведения при Правительстве РФ;

> **Истощение подземных вод** — необратимое уменьшение емкостных запасов подземных вод, связанное с превышением расходования подземных вод над их питанием.
> Истощение нефтяной залежи - уменьшение нач. запасов нефти в продуктивн. пласте, связанное с её добычей.
>
> Орост мөн, гүний усны депрессия гэсэн нэр томъео (геология) – г хэрэглэдэг. Депрессия (лат. depressio — вдавливание, снижение) **Депрессия подземных вод** — снижение напорной поверхности артезианских вод к месту дренажа.

Гүний усны нөөцийг ашиглах - хамгаалах нэг хэрэг, харин, хамгаалдаг тэр объект нь ашигласаар хамгаалсаар байтал “сэхэхгүй” болчих бас нэг ойлголт “аюул” –ын төвшинд бас давхар яригдаад яваад байгаа нь анзаарагддаг. Ашигт малтмалын физик шинж чанараас үүдэлтэй тийм зүйл юм. ОХУ –ын зарим бүс нутагт гүний усны депрессийн царны гүн 90 м. –т хүрсэн тохиолдлууд ажиглагджээ.

ОХУ –ын их хотуудын буюу үйлдвэржсэн зарим районд, гүний ус нөөцийн тураалд өртсөн байна. Ийм бүс нутагт үйлдвэрийн газрууд хаягдал усаа газрын гүн рүү шахах явдал ч гарсаар байгаам. ОХУ –ын Прокурорын газар, мөн Ростехнадзорын газар шүүхийн байгууллагын оролцоотойгоор, ялангуяа аюулын нэгдүгээр зэргийн хорт бодис (мөнгөн ус .. г. м.) бүхий хаягдал хөрсөнд нэвтрэхээс сэргийлэхэд ихээхэн анхаарч байна.

Химийн зарим элементийг дотроос нь ялгаж “үйлдвэрлэх” зориулалт бүхий оросын гүний усны ордын хайгуулын нөөц (разведанные запасы) 327,1 тыс.куб.м/сут. Энэ чиглэлээр 3 том ордод олборлолт явуулж, жилд 200 тн. йод гаргаж авдаг. СССР –ийн үед ийм замаар олборлосон йодын хэмжээ жилд 1200 тн. –д хүрч байсан гэдэг. Бүтээгдэхүүний дутагдлыг эдүгээ гадаадаас импортлох замаар шийдэж байгаа аж. Орост, газрын гүний уснаас бром ялгах үйлдвэрлэх явдал эдүгээ үндсэндээ үгүй болсон байна.

Улс орны усан фондыг хамгаалах, түүний дотор газрын гүний усыг хамгаалахад “ОХУ –ын 2020 он хүртэлх Усны стратеги” чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг. Бодлогын энэ баримт бичиг 2009 оны намар батлагдсан бөгөөд тэнд улсын хэмжээний усны хэрэглээнд, түүний дотор гүний усны ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдлын талаар тоо баримтад суурилсан үнэлгээ дүгнэлт өгчээ. Оросын Холбооны Улсын усны талаар баримтдах бодлогын суурь үзэл санаа, төлбөр тооцооны тал дээр “ус өөрөө өөрийгөө санхүүжүүлнэ (аварна)” гэсэн европын дэвшилтэт зарчимтай дүйж байгаа гэж үздэг аж.

a) Гүний усны ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой зарим дэг

- Орост, гүний ус (орд) –ны нөөцийн үнэлгээг зохих ёсоор хийгээгүй тохиолдолд зөвшөөрлийн лиценз олгох боломжгүй гэж үздэг байна. Ус ашиглах үйлдвэр аж ахуйн газарт гидродинамикийн тооцоолол гаргах орон тооны мэргэжлийн [ерөнхий мэргэжилтэн] гидрогеологч, нэгж алба байхгүй байсан ч гэсэн мэргэжлийн байгууллагад хандаж нөөц тогтоолгосон байх шаардлагатай. Өртөг зардал өндөртэй энэ ажилбарын үргэлжлэх хугацаа – 10 сар;

- Гүний усны ашиглалтын цооногууд тоолууртай, мөн, гүний усны хиймийн найрлагын тодорхойломжтой байх ёстой;
- Гүний усны чанар ундны усны хэрэглээг хангаж чадах эсэхийг эрүүл ахуйн мэргэжлийн [улсын] байгууллага тогтооно;

b) ОХУ –ын Гүний усны хамгаалалтын тухай ЖУРАМ -аас ...

- Гүний усны ашиглалт, хамгаалалтыг хэрэгжүүлэх, **түүнийг депресс, тураалаас сэргийлэх** .. хяналтыг холбооны улсын Геологийн яам эрхэлнэ. Тус яам энэ чиглэлд улсын хэмжээний нэгдмэл ажил үйлчилгээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн шатанд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. Гүний усны ашиглалтын цэгт тавих төрийн хяналт орон нутгийн засаг захиргааныбүтцийн холбогдох байгууллагуудаар дамжин хэрэгжинэ.

- Газрын доорхи усны хамгаалалт гэдэг нь “**гүний усны орд-нөөц бохирдох, турахаас сэргийлэх, мөн түүнчлэн, улс нийгмийн хэрэгцээнд гадын гүнээс нийлүүлэгдэж буй усыг чанар-хэмжээний тогтоосон түвшинд тогтоон барих цогц үйл явц**” мөн.

- Гүний усны орд нөөцийг тураал ба бохирдолд хүргэсэн хариуцлагыг [зөрчил тохиолдол гарсан нөхцөлд] гүний ус ашиглагч үйлдвэр, аж ахуйн болон бусад байгууллага .. хүлээнэ.

- [Гүний] ус ашиглалтын чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь “урьдчилан сэргийлэх ба тусгайлсан” гэсэн зааг ялгамжтай байна. Урьдчилан сэргийлэх төрлийн арга хэмжээ нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

- Гүний усыг хамгаалах чиглэлийн онц шаардлагатай ажил үйлчилгээг, шууд ба шууд бусаар тухайн уст цэгийн үндсэн хэрэглэгч болсон байгууллагууд гүйцэтгэнэ, санхүүжүүлнэ.

- Ашиглалтын цооног өрөмдөх, хайгуулын цооногийг ашиглалтын болгож өөрчлөх .. –ийг холбогдох газрын зөвшөөрөлгүйгээр хийхийг хориглоно. Хаягдалд зориулсан шингээгч цооног өрөмдөх зөвшөөрлийг [тэгэх шаардлагатай онцгой нөхцөл үүссэн тохиолдолд], улсын эрүүл ахуйн ерөнхий мэргэжилтний болон Госгортехнадзорын дүгнэлтийг үндэслэн олгож болно.

- Ундны усны шаардлага хангасан гүний ус, [прежде всего] хүн ардын ахуйн хэрэглээнд зориулагдана. Использование подземных вод питьевого качества для нужд, не связанных с питьевым и бытовым водоснабжением, как правило, не допускается.

- Гүний усны [жин дарах] томоохон хэрэглэгч нар авсан усаа зориулалтын бусаар хэрэглэх эрхгүй.

- Гүний усны хэрэглэгч үйлдвэр аж ахуйн газрууд усны яам газраас баталсан зааврын дагуу урсгал хэрэглээний данс хөтлөнө.

  > Нэгэнт өрөмдсөн цооногоос гүний ус үр ашигүй оргилж асгарахаас сэргийлж, тэдгээрт хаалт тохируулгын механизм, зориулалтын крант, гүний усны давхарга хоорондын даралтыг хэмжих маномерт тавина. Мөн, скважингийн амсар идэгдэх, цооногийн хоолой элэгдэхээс найдвартай сэргийлэх арга хэмжээ авна.

- Гүний усны шинэ хэрэглэгч болох томоохон үйлдвэр аж ахуйн газарыг барьж байгуулж ашигладтад оруулахдаа, тухайн газрын хүн ардын ундны болон ахуйн хэрэглээний хэвийн хамгамжийг тэргүүн ээлжинд шийдвэрлэнэ. (Гүний усны олборлолт нь үйлдвэр аж ахуйн газрын ойр орчмын бичил бүс нутагт усны хангамжийн [хуучин явж ирсэн] нөхцөл байдлыг дордуулахаас ийн сэргийлсэн бололтой)

- Гүний цэнгэг усны ордын ашиглалтын явц дахь өөрчлөлтийн нөхцлийг байнгын байдлаар тандан хянаж холбогдох шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч байх үүднээс төвлөрсөн татуургын бүс, ойр орчны газарт [чанар ба түвшиний] ажиглалтын цооногуудын сүлжээ байгуулна. Байнгын энэхүү ажиглалт ба чанарын шинжилгээний лабораторийн хяналтыг гүний усыг хэрэглэгч тухайн үйлдвэр байгууллага өөрөө хариуцах ба гүний усны эрсдэлжилтийн ихсэлт, хатуулгийн өсөлт, бактерийн болон химийн бохирдлын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд холбогдох газарт даруй мэдээлэх үүрэгтэй.

- Проект наблюдательной сети должен быть составной частью проекта водозаборного сооружения. Создание сети наблюдательных скважин должно быть предусмотрено в проекте строительства промышленного предприятия. Проектирование и устройство наблюдательной сети на промышленных и других объектах, производство наблюдений и лабораторный контроль качества подземных вод выполняются предприятием, загрязняющим подземные воды, под контролем геологической организации.

- Гүний усыг бохирдол ба тураалаас хамгаалах хяналтыг явуулах журмыг ОХУ –ын Геологийн яамнаас баталсан дүрэм зааврaар явуулна.

- Гүний усны ашиглалтын байдалд болон орд газрыг бохирдол тураалаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа, тухайн шалгалт хийгдэж байгаа үйлдвэр албан газрын унаа уншийг хэрэглэх ба зарим шаардлагатай тохиолдолд агаарын тээврийн хэрэгслэлийг ч мөн адил [журмаар] хэрэглэнэ. .. г. . м.

* * *

ОХУ –ын Усны стратегийн бодлогод эдийн засгийн бодит салбарыг усны татвараар [аль болохоор] боомлихгүй байх үзэл санаа суусан. Усыг тэргүүний технологиор, норм нормативын дагуу зөв зохистой ашиглаж байгаа нөхцөлд татвар тариф нэмэгдэхгүй. Харин, эсрэг тохиолдолд усны төлбөр эрс нэмэгдэнэ. Ашиглахгүй сул хаягдаж байгаа гүний усны хэмжээ олборлосон гүний усны нийт хэмжээний 18% орчим байдаг аж. Усны бохирдлын эсрэг арга болгож, тэнд, 2016 оноос усны торгуулийн нэгдсэн хэмжүүр (ставка) тавих төлөвтэй байна.

> Единая штрафная ставка – 120 -кратная стоимость тарифа, который исчисляется из соотношения количества загрязняющих веществ на единицу объёма воды. Единственный способ предотвратить эти убытки – уже сейчас вложить деньги в водоочистные сооружения.

Ус ашиглалтын явцад гардаг эрхзүйн зөрчлийн төрөл зүйлүүд оросын Башкортастаны Усны кодекс (1993.7.13) -ийн 74 дүгээр зүйлд нилээн тодорхой дурдагдсан байдаг ба тэнд, буруутай этгээд захиргааны болоод эрүүгийн хариуцлага хүлээх тухай заажээ. Эрүүгийн хариуцлага яригдаж байгаа болохоор, энэ нь цаагуураа “усны талбарт гардаг гэмт хэрэг” гэж чухам юуг хэлэх вэ гэдгийг дамаар өгүүлж байгаагараа анхаарал татах зохицуулалт байж болно. Усны холбогдолтой хэрэг зөрчилд ногдуулах захиргааны хариуцлагын заалтууд ОХУ –ын Усны кодекс (1995.11.16) –т тодорхой туссан.

Усны тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутэй этгээдэд оросын холбооны улсын Башкортостанд, захиргааны арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэхдээ,

- албан тушаалтанд: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 – 10 дахин нугалсантай тэнцэх хэмжээний;
- иргэнд: хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1 – 10 дахин нугалсантай тэнцэх хэмжээний
- хуулийн этгээдэд: учруулсан хохирлын 30 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний;

торгууль төлбөр ногдуулахаар заажээ. Ингэхдээ, хэрэг зөрчлийн шинж чанар, гэм буруугийн зэрэглэл, хүндрүүлэх ба хөнгөлөх нөхцөл байдал, төлбөрийн чадамж (имущественное положение) зэргийг харгалздаг.

ОХУ –ын хуульд зааснаар, газрын гүний усыг бохирдуулсан, **гүний усны ордыг тураалд оруулах ... зэрэг экологийн гэмт хэрэг зөрчил** гаргасан этгээдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 – 200 тэнцэх хэмжээний рубл. –ээр, эсхүл, 3 сар хүртэл хугацаагаар баривчилах, 1 жил хүртэл хорих ял оноох .. тухай дурдсан байдаг. [Эдүгээ, эдгээр заалтуудад өөрчлөгдсөн байх магадлалтай]

* * *

4. Украйн улсад ...

Газрын доорхи бага гүний усыг ашиглах чиглэл дэх (цооног гаргах, өрөмдлөгийн зөвшөөрөл авах тал дээр) Украйн Улсын холбогдох хууль тогтоомжийн зарим заалт сонирхол татдаг. Украйны Газрын хэвлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд, газар эзэмшигч, газар ашиглагч

нарын гүний цэнгэг ус “ухаж” хэрэглэх эрхийн талаар тодотгосон өгүүлэмж бий. Газар эзэмшигч, газар ашиглагч нар нь зохих журмын дагуу өөрт олгогдсон газрынхаа хил зааг дотор (для своих хозяйственных и бытовых потребностей) хэрэглээний зориулалтаар газрын доорхи усыг авч болно. Гэхдээ, усан зарлагын хэмжээ 1 хоногт 300 м^3 –ээс хэтрэхгүй байна; гэжээ. Энэ нь, лицензгүй, лиценз авахгүйгээр хийж болох ажил-үйлдлийн тухай өгүүлэмж шиг байгаам.

Украйны Ундны усны тухай хуульд, газар эзэмшигч, газар ашиглагч нарт, өмчийн хэлбэрээс нь үл хамааран 20 хүртэл м. –ийн гүнээс ахуйн хэрэглээний зориулалтаар, зөвхөн өрөмдмөл цооногоос, тусгай зөвшөөрөлгүйгээр ус авч ашиглахыг зөвшөөрсөн заалттай. Заагдсан гүний хязгаарыг давах тохиолдолд холбогдох төрийн байгууллагаас ном журмын дагуу [өрөмдлөгийн] зөвшөөрөл авна.

Украйны “Кодекс «Про недра»” –д цооног гаргах үе шатры ажилбаруудыг дарааллаар нь заасан. Тэнд доорхи дарааллыг дурджээ. Үүнд:

1. Проектирование скважины;
2. Согласование проекта;
3. Получение разрешения на бурение;
4. Получение разрешения на спецводо-пользование (шаарлагатай бол);

Газрын доорхи усыг авч ашиглахад шаардагдах баримт бичгийн багц доорхи бүрдэлтэй байна. Үүнд:

- Письмо — заказ (захиалга) на проектирование водозабора;
- Задание (даалгавар) на проектирование водозабора подземных вод;
- Нормативный расчет (тооцоо) водопотребления и водоотвода;
- Генеральный план территории М 1:500;
- Ситуативный план. М 1:10 000;
- Акт выбора, обследования земельного участка для расположения водозаборной скважины.
- Решение (нутгийн захиргааны байгууллагын) совета о согласовании расположения скважины и разрешении на сбор материалов технической документации места расположения водозаборной скважины;
- Государственные акты на право владения землей (аренда);
- Отчет об инженерно-геологических изысканиях, разрезах;

Украйны хууль тогтоомжид, газрын доорхи усны цооногуудыг нэр томъёоны хувьд харилцан ялгамжтай авч үзсэн байна. Тэнд, гүний цооног гэхээрээ артезийн скважинг хэлээд байгаа юм. Бас “гүн-бус цооног” (мелк. скв.) гэж байна. 30 хүртэлх м. –ийн гүнд орших элсэн дэвсгэрт уст давхаргын эх үүсвэрийг энд хамаатуулна. Харин, 20 м. –ээс давсан үзүүлэлт учраас бас л зөвшөөрөл авах болдог; гэнэ. Товчдоо, гүн бус цооногт зөвшөөрөл [бараг] хэрэггүй; тийм зохицуулалттай юм.

Украйнд гүний давхаргын буюу артезийн цооног өрөмдөх нь эрхзүйн талаасаа ихээхэн төвөгтэй процесс байдаг. Гүний цооногоор хүрэх артезийн ус украйнд “**усны стратегийн нөөц**” –д тооцогддог.

> Глубокие водоносные горизонты составляют **государственный стратегический запас воды**. Это объясняет жесткий контроль над их использованием.

Артезийн худаг гаргахын тулд хүсэмжлэгч этгээд эхлээд орон нутгийн холбогдох [усны нөөцийн хяналтын] байгууллагаар явна. Тэнд, тийм хэрэгцээ шаардлага үнэхээр байгаа эсэхийг буюу артезийн худаг гаргах нь, тухайн тохиолдол цорын ганц “зугтах аргагүй гарц” мөн гэдгийг тодорхойлно. Асуудлыг шийдэх өөр гарц байгаа тохиолдолд зөвшөөрөл

олгогдохгүй. Үүний дараа, тухайн уст давхаргад нөөц байгаа эсэхийг ойролцоох бусад цооногуудын бодит мэдээлэлд тулгуурлан үнэлнэ. “Болно” гэсэн тохиолдолд, хүсэмжлэгч этгээд яг хаана өрөмдөхөөс авхуулаад, цооногийн зураг төсөл, өрөмдөх технологи, ашиглах усны хэмжээний талаар нарийн мэдээллийг гаргаж өгнө. Ирсэн өгөгдлүүдийг мэргэжлийн байгууллага судалж үзээд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, бас, цооногийн эзэн гүний усыг бохирдлоос хамгаалах шаардлагуудыг биелүүлж чадна; гэж үзвэл сая зөвшөөрнө; г. м.

> Гүний худаг цооногийг засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагын хяналтад “төрөхөөс нь өмнө” авдаг энэ туршлага чухал мэт. Улаанбаатарын [айлуудын] худгийн бодит бүрэн тоо одоо болтой тодорхой бус байгаа. Бүртгэлд авагдсан 3500 -аад худаг байдаг; гэсэн. Манайхан, жишээ нь, зусландаа худаг гаргаад дээр нь хаусаа барьчихдаг. Нийслэл дэх худгийн тоо 10 мянгаас доошгүй гэсэн таамаг буй. Бас зэрэгцээд 100 мянган бохирдуулагч (зарим эх сурвалжид түүнээс ч их тоо таардаг) жорлон буй. Худаг болгон газрын доорхи усны бохирдлын потенциаль эх сувагт тооцогддог, уст цэгүүдийн эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг заавал шинжилж мэдэх ёстой; гэж үзвэл, газрын доорхи усны хамгаалалтын асуудал манайд тун сул байгаа юм.

* * *

5. Анхаарах зарим саная[25]

1. Монгол Улсын ус ашиглалт, усны хэрэглээний нийт хэмжээ, жилд 500 сая м^3 бөгөөд үүн дотор газрын гүний усны хэрэглээ 90% -ийг нь эзэлдэг. Гэтэл, ном ёсоороо бол чухамхүү гадаргуйн усны хэрэглээ 90% байх ёстой аж. Энэ харьцааг (50 : 50) болгоно; гэсэн нэг боломжгүй “худал” ойрын зорилт дэвшүүлчихээд, амьдрал дээр болохоор, гүний усныхаа хэрэглээг нэмэх чиглэлд ажиллаад байгаа нь анзаарагдав.

2. Гүний усны хязгаарлагдмал нөөцөө усны үнэт баялиг мөн гэдэг талаас нь хайрлан хямгадах, монголчууд бидний онгон байгалиа хамгаалах уламжлалт сэтгэлэг ердийн ухамсрын төвшиндөө хангалттай өндөр байдаг ч, энэ байдал, засаг төрийн үйл ажиллагааны талбарт “түүнтэй дүйх хэмжээний хэрэгжилт” –ийг тэр бүр олохгүй явсаар ирсэн нь бас нэг “зохист-бус уламжлал” –ын хэмжээнд хүрчээ.

3. Усны тухай хууль тогтоомжийн хүрээний баримт бичгүүдийн агуулгад гүний усны ашиглалт ба хамгаалалтын талаар тусгахдаа “гүний усны ордын тураал[27]” (истощение подземных вод), гүний усны орд орчмын “гадаргуйн суулт[28]” (депрессия подземных вод) .. зэрэг сөрөг дагаварт бодит үзэгдлүүдийг зохих ёсоор авч үзээгүй, төдийлэн анхааралагүй явдал байдал ажиглагдаж байна.

4. Манайд, техникийн зориулалтаар хэрэглэх “гүний усыг үйлдвэрлэлийн зориулалттай ус” мэтээр ярьж бичиж заншсан нь усны ангилллын үүднээс зарим талаар оновчтой бус юм. Мөн, (гүний ус, хөрсний ус, газрын доорхи ус), (цэнгэг ус, ундны ус), (ул хөрс, өнгөн хөрс) .. гэхчилэнгийн нарийн яривал хоорондоо утгазүйн ихээхэн ялгамжтай[29] нэр нэршилүүд усны эрхзүйн баримт бичгүүдэд “эмх цэгцгүй, замбараагүй” тусдаг нь тэдгээрийн нийтэд ойлгомжтой байх чанар-байдлыг сулруулсаар байна.

5. Газрын гүний ус ашигт малтмалд тооцогдог хэдий ч тэр бусад ашигт малтмалтай тэр бүр адилгүй юм. Гүний усны орд усан объектийхоо хувьд ашиглалтын

[27] Энд бид зориуд аль болохоор өмнө хэлэгдээгүй шинэ санаа эрэлхийлэхийг хичээсэн болно.

[28] албан бус орчуулга;

[29] мөн адил;

хугацааны явцад нөөцийн хэмжээ болон чанарын үзүүлэлтийн талаасаа динамик өөрчлөлтийн байдалд оршдог. Тиймээс ялангуяа өмнийн говийн бүсийн гүний усны ордуудын төлөв байдлыг улам нарийн тодорхойлох чиглэлд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- дурдсан бүс нутгийн гүний усны томоохон орд газруудын динамик өөрчлөлтийг судлах, өнөөгийн байдалд үнэлгээ гаргах;
- гүний усны илэрсэн тухайлсан нөөцийн хэмжээ түүнийг ашиглах төслийн хэтийн төлөвлөлттэй уялдан нийцэж буй эсэхэд анализ хийх;
- уурхай байгууллагын зүгээс газрын гүний усны ашиглалт – хамгаалалтын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд дүгнэлт өгөх, “бага авч их ашиглах” горимын хэрэгжилт (эффект) –ийг шалгах; .. г. м.

Товчдоо, геологийн түүхийн урт хугацаанд монголын говийн хөрсөнд бий болж “үүцлэгдэж” ирсэн гүний усыг бид нэгмөсөн мөхөөхгүй байх арга замыг үндэслэл бүхий тооцоогоор батлах хэрэгцээ шаардлага тулгамдсан нэг зорилт болж байна.

6. Байгаль орчны багц хуулийн шинэчилсэн өөрчлөлтөөр “байгальд халтай технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулахыг зөвшөөрсөн дүгнэлт гаргахыг хориглох” –оор болсон. Харин, аливаа төсөл хэрэгжүүлэгчийн ашиглах технологи байгальд хэр халтай вэ, ямар шалгуураар дүгнэх вэ гэдэг нь төдийлэн тодорхойгүй байдалтай явж байгаа.

   Хууль тогтоомжийн агуулга дахь энэ “бүрхэг” заалтыг “улсын стандартад нийцээгүй технологитой үйлдвэр аж ахуйн газарт ус ашиглуулахыг хориглоно” гэсэн нь илүү тодорхой, илүү барьцтай заалтаар солих .. замаар асуудлыг улам нарийсган хэрэгжихэд дөхөмтэй болгох боломжтой юм. Үйлдвэрлэлийн процесст ашиглах ус гүний ус байх магадлал өндөр учраас, ийм заалт чухамхүү газрын гүний усыг хамгаалахад үр нөлөөтэй үйлчлэх боломжтой.

7. НҮБ –ын зарим чиглэлийн тайланд дэлхийн дулаарлын нөлөөнд хамгийн их өртөж буй орнуудын нэгээр манай улс “шалгарсан” байна. Тэнд, монголын нийт газар нутгийн 82% нь мал ахуйн бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж, энэ байдал төлөв Төв Азийн хувьд хамгийн томд тооцогдох экологийн доройтлыг үүсгэж, хэтдээ улс орноороо[30] цөлжилтөнд нөлөөнд автана; гэжээ. Тиймээс, Монгол Улсын усны тухай хууль тогтоомжийн агуулгад ундны хэрэглээний чанарын шаардлага хангах гүний усыг технологийн зориулалтаар олборлох - ашиглахыг хориглосон зүйл заалтыг даруй нэмж оруулах шаардлагатай, гэж үзнэ;

8. Эдүгээ, улсын хэмжээнд ус ашиглалт, хэрэглээнд тавих хяналт төдийлөн боловсронгуй бус, энэ талаарх эрх зүйн орчин, нэгдсэн мэдээлэл, хяналтын тогтолцоо сайн бүрдээгүй байна. Гүний усны ашиглалт, хамгаалалт, хэрэглээний мэдээллийг нарийвчлан гаргаж хянах чадахгүй байгаа нь усны нөөцийн менежмент зохих төвшинд хийхэд хүндрэл бэрхшээл үүсгэсээр ...

   Мөн, “усны асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын бүтэц, удирдлага зохион байгуулалт оновчгүй, ажлын нэгдмэл уялдаа холбоо хангалтгүй” байгаа тухай Монгол Улсын Үндэсний аудитын газрын илтгэл (2011) –д ч тэмдэглэгджээ. Монголын Улсын усны бодлого проблемд тулгуурласан, алсыг хараа багатай, нийгмийн амьдралын гүнээс буюу “дороос сурвалжтай” болж төдийлэн чадаагүй,

[30] Грунтовые воды - безнапорные подземные воды, расположенные над поверхностью первого водоупорного слоя; область их питания совпадает с областью распространения. Питьевая вода - вода по своему качеству в естественном состоянии или после подготовки отвечающая гигиеническим нормативам и предназначенная для питьевых и бытовых нужд граждан, либо для производства пищевой продукции. Подземные воды - воды, в т.ч. минеральные, находящиеся в подземных водных объектах.

бүхэлдээ тунхаглалын шинжтэй явж ирсэн нь удирдлага зохион байгуулалт, хяналт, санхүүгийн бэрхшээлтэй холбоотой гэж үздэг; байна.

₪ ₪ ₪

Ашигласан материал

1. [Сүүлийн жилүүдийн] Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
2. Мухина, Э. Н. (Ph.D), Правовое регулирование использования и охраны подземных вод, М., 2011;
3. Г. Даваа, “Усны нөөц ашиглалт, хамгаалалт, уур амьсгалын өөрчлөлтөөс усны горим, нөөцөд үзүүлэх нөлөөлөл”, “Байгаль орчин - 20” сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл, 2008;
4. Интернет мэдээлийн сангийн холбогдор ресурс;
5. World Bank, 2007, World Development Indicators, Mongolia, World Bank, Washington DC;
6. World Bank, 2003, Second Ulaanbaatar Services Improvement Project, Final Feasibility Study, Ulaanbaatar;
7. Сэдэвт холбогдох бусад эх сурвалж;

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

(ДҮН ШИНЖИЛГЭЭ)

Ө. Мөнхтунгалаг

Агуулга

1. Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний үр дүн
   1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал
   1.2. Агаарын бохирдлыг бууруулах талаар 2006 - 2010 онуудад Монгол улсыг хөгжүүлэх сан болон улсын төсөв, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.
   1.3. Агаарын бохирдлыг бууруулах талаар 2011-2012 онд Монгол улсыг хөгжүүлэх сан болон улсын төсөв, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн.

2. Агаарын бохирдол, хүний эрүүл мэндэд нөлөөлж буй байдлыг статистик үзүүлэлтээр
   2.1. Улаанбаатар хотын хүн амын өвчлөл, 2000 - 2011 он
   3.1. Улаанбаатар хотын хүн амын нас баралт, 2000 - 2011 он

* * *

Оршил

Судалгааны зорилго.

Энэхүү судалгааны зорилго нь агаарын бохирдлыг бууруулах, түүнчлэн Улаанбаатар хотыг утаагүй болгох чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн үр дүн, зарцуулсан хөрөнгөнд дүн шинжилгээ хийж, агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй өвчлөл, нас баралтыг статистик тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны зорилтууд.

- Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үр дүнд зарцуулсан хөрөнгөнд дүн шинжилгээ хийх
- Агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй өвчлөл, нас баралтын статистик тоо баримтанд дүн шинжилгээ хийх

Судалгаа мэдээллийн эх сурвалж.

Судалгааны сэдвийн хүрээнд нийслэлийн агаарын чанарын албаны 2006 - 2009 оны агаарын бохирдлыг бууруулах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яамны хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэдээлэл, Нийслэлийн эрүүл мэндийн газрын хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт стстистик үзүүлэлт агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлийн 2013 оны 01 сарын 19 -ний хуралдааны илтгэл, Үндэсний Аудитын газрын агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн төсөлд арга хэмжээний үр дүн, санхүүжилтэнд хийсэн тайлан энэ чиглэлээр явуулсан судалгааны ажлын зарим мэдээллийг эх сурвалж болгон ашиглав.

LAW.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгааны үр дүн

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад 2006-2012 онуудад улсын төсөв, монгол улсыг хөгжүүлэх сан, нийслэлийн төсвийн хөрөнгөөс нийт 12,5 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 2010 оны төсвийн 6,7 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

2007-2009 онд агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой зарцуулсан хөрөнгийн судалгаа хийж үзэхэд зарцуулсан хөрөнгийн санхүүжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх зарцуулах хяналтын тогтолцоонд олон байгууллага зэрэг оролцож агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөгүйгээс, шат дараатай цогц байдлаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байхгүйгээс жилд төсөвлөгдсөн 2-3 тэрбум төгрөг олон төрлийн үр дүн муутай төсөл арга хэмжээнд зарцуулагдаж зарим төрлийн төслүүд нь туршилтын шинж чанартай байгаа нь агаарын бохирдлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулаагүй болохыг холбогдох хяналт шалгалтын байгууллагаас тогтоосон.

2010 оны төсвийн тухай хуулинд 5 тэрбум төгрөгийн төсөл арга, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийсэн боловч төлбөр хийх болон ашиглалтын нөхцөл тодорхойгүй хөрөнгийг зарцуулаагүй байна. 2011 онд Улсын төсвийн тодотголоор 34,0 тэрбум төгрөг батлагдсанаас нийт 17,0 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжсэн байна. Үлдсэн хөрөнгө нь санхүүгийн жил дууссан тул буцаан татагдсан. 2012 онд улсын төсөвт 64,8 тэрбум төгрөг батлагдсанаас 13,5 тэрбум төгрөг сайжруулсан зуух нийлүүлэх ажил зарцуулсан бөгөөд үлдсэн 50,0 гаруй тэрбум дулаан, цахилгааны хангамжийг нэмэгдүүлэх зэрэг төсөл арга хэмжээнд зарцуулагдаж байна. 2011 - 2013 онд Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр 32 сая ам доллар батлагдан мөн тэр хэмжээний зарцуулалт хийгдсэн байна.

2011 - 2012 онд хийгдсэн санхүүжилтээр утаагүй зуух, утаагүй түлш, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын хэрэгсэл зэрэг айл өрхөд чиглэсэн ажил болон нам даралтын зуухуудыг төвлөрсөн халаалтын сүлжээнд холбох, авто тээврийн хэрэгслээс гарах бохирдлыг бууруулах зэрэг багц үйл ажиллагаа явуулсны үр дүнд Улаанбаатар хотод 2012 оны 10-12 дугаар сарууд буюу халаалтын ачаалалтай үед агаарын бохирдол 20 орчим хувиар, бохирдолд агуулагдах хорт бодис 80 хүртэл хувиар буурсан байна.

Эдгээр тоон үзүүлэлтээс гадна агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллах бүтэц тогтолцоо, зохион байгуулалт бий болсон нь цаашид богино хугацаанд үр дүнд хүрэх суурь орчин бүрдүүлснийг холбогдох газрууд тодотгосон. Улаанбаатар хотын агаарын өнөөгийн байдлыг тогтоосон стандартай харьцуулсан байдлаар авч үзэхэд угаарын хий 2-3 дахин, азотын давхар исэл 4,5 дахин, хүхэрлэг хийн агууламж 4 дахин, азоны хий 2 дахин, том ширхэгт тоосонцор 7-18 дахин тогтоосон стандартаас илүү байна.

Агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөөллийн дийлэнх үнэлгээ нь агаарын бохирдлыг амьсгалын замын өвчлөлтэй харьцуулан судалж үзэхэд агаар дахь үндсэн бохирдуулагчид амьсгалын замын өвчлөл, хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжил, дархлаа тогтолцоонд сөргөөр нөлөөлж, зүрх судас, хавдрын өвчлөлд нөлөөлөх хүчин зүйл болохыг судлан тогтоосон .

Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр Улаанбаатар хотод амьсгалын эрхтний өвчлөл нэмэгдэж, нийслэл хотод амьсгалын эрхтний өвчлөл нийт өвчлөлийн 23.4-24.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн өвчлөлийн ерөнхий бүтцэд амьсгалын эрхтний өвчлөл 1-р байр эзэлдэг бөгөөд агаарын бохирдол ихтэй газар түүний эзлэх хувь нэмэгдэж байна.
Улаанбаатар хотын агаар дахь тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж нь хүүхдийн амьсгалын эрхтний өвчлөл, ялангуяа хүүхдийн гуурсан хоолойн цочмог болон архаг үрэвсэл, уушгины үрэвслийн нэг шалтгаан болдог

байна. Мөн Улаанбаатар хотын хүүхдүүд хөдөөгийн хүүхдүүдийг бодвол гуурсан хоолойн үрэвсэл өвчнөөр 5-15 дахин илүү өвчилж байна гэдгийг судалгаар тогтоосон байна. Агаарын бохирдолт нь амьсгалын замын эрхтэний өвчлөлд нөлөөлөхөөс гадна жирэмсэн эмэгтэйчүүдийн 20-27 % нь эрт хожуу хордлоготой, нийт төрсөн хүүхдийн 3,2-3,6% нь хүчилтөрөгчийн дутагдал, амьсгалын замын хямралтай төрж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг сүүлийн 6 жилийн статистик үзүүлэлтээс харахад амьсгалын тогтолцооны өвчин 10.000 хүн амд 2007 онд 732,22 , 2008 онд 864,98, 2009 онд 864,03, 2010 онд 954.82 , 2011 онд 901,04, Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2007 онд 565,5, 2008 онд 669,1, 2009 онд 633,8, 2010 онд 612,8, 2011 онд 640,2 тохиолдолоор бүртгэгдсэн гэсэн үзүүлэлтэй байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөл сүүлийн жилүүдэд тогтмол тэргүүлэх шалтгаан болж нийт өвчлөгчдийн 52,4 хувийг эмэгтэйчүүд, 47,16 хувийг эрэгтэйчүүд эзэлж, өвчлөлийн дийлэнх буюу 48,3 хувийг 0-5 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Амьсгалын тогтолцооны өвчнөөс амьсгалын дээд, доод замын цочмог болон архаг халдварууд, уушгины хатгаа, багтраа бачуурал зэрэг өвчнүүд ихэвчлэн бүртгүүлжээ.

Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2001 оноос хойш байнга нэмэгдэж нийт өвчлөгсдийн 59,7 хувь нь эмэгтэйчүүд 40,3 хувийг эрэгтэйчүүд эзэлж, энэ бүлгийн өвчлөлд цусны даралт ихсэн, зүрхний хэрх, зүрхний цус хомсролт, тархины судасны өвчин зонхилж байгаа ба 45 дээш насныхан ихэвчлэн өвчилсөн байна.

Манай улсын хүн амын нас баралтын шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар болон осол гэмтлийн шалтгаант нас баралт тогтмол эхний байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна. 2006 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас нас барсан тохиолдол 1000 хүн амд 0.9 байсан бол 2011 онд 0,22, болж өссөн байна. Эрүүл мэндийн статистик мэдээлэлд бүртгэгдсэн амьсгалын тогтолцооны өвчлөлд нас, хүйс, улирлын байдал хамааралтай байна. Хаврын улиралд амьсгалын дээд замын цочмог халдвар, архаг бронхит, уушгины хатгалгаа, бусад амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын тохиолдол илүү зонхилж, харин намар уушги тэлэх, энфиземи, өвөл багтраа өвчний улмаас нас барах тохиолдол тус тус илүүтэй тохиолддог нь статистик магадлал бүхий хамааралтай байна.

Нэг. **Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний үр дүн**

1.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн төлөв байдал

Улаанбаатар хот нь далайн түвшнээс дээш 600-700 м өндөрт дөрвөн уулаар хүрээлүүлэн оршдог, салхины дундаж хурд 1-2м/секунд байдаг хийн урсгал хөдөлгөөн харьцангуй тогтуун бүст хамаарагддаг. Салхины чиглэлийн дээд хэсэгт байрлах дулааны цахилгаан станц, үйлдвэрийн газрууд болон дөрвөн уулын бэлээс эхлэн хотын төв хүртлээ тархан байрласан гэр хорооллын айл өрхийн галлагааанаас гарах бохирдуулагч хий нь Улаанбаатарын төв хэсэгт хөдөлгөөнгүй тогтож, агаарын бохирдлыг их хэмжээгээр үүсгэж байна.

Агаарын бохирдлын эх үүсвэрүүд:

Агаарын бохирдлын гол эх үүсвэрүүд нь 2012 оны жилийн эцсийн байдлаар 184 мянган гэр хорооллын айл өрхийн хэрэглэж буй зуух 50%, 306 мянган авто тээврийн хэрэгсэл 20%, бусад эх үүсвэр шороон зам, баригдаж буй барилга байгууламж, хөрсний бохирдол, хог 14%, 1,4 мянган бага болон дунд оврын нам даралтын зуух 14%, 3 дулааны цахилгаан станц 10% эзэлж байна.

Агаарын чанарын төлөв байдал: Агаарын чанарын төлөв байдлыг 2011-2012 оны галлагаатай үе буюу 10-12 саруудад хийсэн хэмжилтийн дүнг тогтоосон стандартай харьцуулан авч үзсэн. Угаарын хий 2-3 дахин, Азотын давхар исэл 4,5 дахин, Хүхэрлэг хийн агууламж 4 дахин, азоны хий 2 дахин, том ширхэгт тоосонцор 7-18 дахин тогтоосон стандартаас илүү байна.

Агаар дахь хүхэрлиг хийн агууламж (2011, 2012 оны 11 - 12 дугаар сар)



Агаар дахь азотын давхар ислийн агууламж (2011, 2012 оны 11 - 12 дугаар сар)



2012 оны галлагаатай үе буюу 10 дугаар сарын агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг 2011 оны мөн үетэй харьцуулахад 13.5% -иар,11 дүгээр сард 25% -иар, 12 дугаар сард 29.2% -иар, агаар дахь азотын давхар ислийн агууламж 2011 оны мөн үетэй харьцуулахад 26%, 11 дүгээр сард 16%-иар ихэссэн бол 12 дугаар сард 29.4% -иар буурсан дүнтэй байна.

Том ширхэгт тоосонцорын сарын дундаж агууламж (2011, 2012)



2012 онд Улаанбаатар хотын хэмжээнд том ширхэглэгт тоосонцорын сарын дундаж агууламж 6, 9 - 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4 - 36.2% -иар буурсан бол 1 - 5, 7 - 8 дугаар саруудад 0.8 - 106.2% -иар ихэссэн байна. Энэ нь дулааны улиралд нийслэл хотод авто зам засвар, барилга зэрэг бүтээн байгуулалтын ажлууд ихээр хийгдсэнтэй холбоотой байна.

1.2. Агаарын бохирдлыг бууруулах талаар 2007 - 2010 онуудад Монгол улсыг хөгжүүлэх сан болон улсын төсөв, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад 2006 - 2009 онуудад улсын төсөв, монгол улсыг хөгжүүлэх сан, нийслэлийн төсвийн хөрөнгөөс нийт 8,7 тэрбум төгрөг төлөвлөгдснээс 2009 оны 11 сарын байдлаар 6,2 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд төслүүдийн хэрэгжилтэнд дүгнэлт хийж үзвэл: 2006 - 2009 онд агаарын бохирдлыг бууруулах талаар монгол улсыг хөгжүүлэх сан болон улсын төсөв, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилт

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Санхүүжилт /гүйцэтгэлээр/
1.	Гэрийн дулаалга, цахилгаан халаагуур, үртсэн болон нүүрсэн шахмал түлшний үйлдвэрүүдийг дэмжих төслүүд	2.402.190.000
2.	2007-2009 онд хэрэгжүүлсэн нам даралтын халаалтын зуухны техник, технологийн шинэчлэлийн төсөл, арга хэмжээ	2.167.700.000
3.	Бусад төсөл арга хэмжээ	1.611.900.000
	Нийт	6.203.790.000

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2007 - 2009 онд агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой зарцуулсан хөрөнгийн судалгаа хийж үзэхэд зарцуулсан хөрөнгийн санхүүжилтийг төлөвлөх, хэрэгжүүлэх зарцуулах хяналтын тогтолцоонд олон байгууллага зэрэг оролцож агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөгүйгээс шат дараатай цогц байдлаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байхгүйгээс жилд төсөвлөгдсөн 2-3 тэрбум төгрөг олон төрлийн үр дүн муутай

төсөл арга хэмжээнд зарцуулагдаж зарим төрлийн төслүүд нь туршилтын шинж чанартай байгаа нь агаарын бохирдлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулаагүй болохыг нийслэлийн аудитын газраас “нийслэлийн агаарын бохирдлыг багасгах талаар холбогдох байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үл нөлөө”-нд гүйцэтгийн аудит хийж дүгнэлт гаргасан байна.

2010 оны төсвийн тухай хуулинд 5 тэрбум төгрөгийн төсөл арга, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ хийсэн боловч төлбөр хийх болон ашиглалтын нөхцөл тодорхойгүй хөрөнгийг зарцуулаагүй байна.

1.3. Агаарын бохирдлыг бууруулах талаар 2011 - 2012 онд монгол улсыг хөгжүүлэх сан болон улсын төсөв, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн.

2011 - 2012 онд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2011 оны 02 сарын 10-нд “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай” хууль батлагдан нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог байгуулсан.

2011 - 2012 онд Үндэсний хорооноос төлөвлөсөн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн ажлуудын биелэлтийг Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллах бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, иргэн, аж ахуй нэгжүүдийг урамшуулах тогтолцоог бий болгох, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрүүдийг шийдвэрлэх, холбогдох журам, стандартуудыг боловсруулан батлах, агаарын бохирдлын эх үүсвэрүүдэд авах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх эхлэлийг тавих, агаарын чанарын мэдээг олон нийтэд мэдээлэх, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллажээ.

- 2011 онд Улсын төсвийн тодотголоор 34,0 тэрбум төгрөг батлагдсанаас нийт 17,0 тэрбум төгрөгийн төсөл хэрэгжсэн байна. Үлдсэн хөрөнгө нь санхүүгийн жил дууссан тул буцаан татагдсан.
- 2012 онд улсын төсөвт 64,8 тэрбум төгрөг батлагдсанаас 13,5 тэрбум төгрөг сайжруулсан зуух нийлүүлэх ажил зарцуулсан бөгөөд үлдсэн 50,0 гаруй тэрбум дулаан, цахилгааны хангамжийг нэмэгдүүлэх зэрэг төсөл арга хэмжээнд зарцуулагдаж байна.
- 2011-2013 онд Мянганы сорилтын сангийн хөрөнгөөр 32 сая ам доллар

2011 - 2012 онд агаарын бохирдлыг бууруулахад чиглсэн томоохон ажлуудын үр дүнг дараах байдлаар авч үзвэл: Агаарын бохирдлыг бууруулахад холбогдох журам, стандартуудыг боловсруулан батлах ажлын хүрээнд

Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан нийт 6 журам, 6 стандартыг боловруулсан. Үүнд:

Журам

- “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам” (Монгол Улсын Засгийн газар)
- “Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам” (Монгол Улсын Засгийн газар)
- “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам” (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал)

- “Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам” (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал)
- ”Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам” (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал)
- “Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам” (Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо

Стандарт

- Ахуйн хэрэглээний зуух
- Хагас коксон түлш
- Шахмал түлш
- Ахуйн зориулалтын шингэрүүлсэн хий диметилийн эфир
- Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- Гэр болон барилга байгууламжийн дулаалгын нэгдсэн стандарт

Агаарын чанарын орон тооны бус байцаагчдыг ажиллуулах ажлын хүрээнд

Нийслэлийн төвийн 6 дүүрэг бүрт Засаг дарга нараар ахлуулсан Үндэсний хорооны салбар хороодыг байгуулан 2012 онд 50 хорооны 484 хэсгийн ахлагч, 2012 онд нийслэлийн төвийн 7 дүүргийн 51 хорооны 654 хэсгийн ахлагчийг “Агаарын чанарын орон тооны бус байцаагч”-аар ажиллуулж эхэлсэн.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг татаастай үнээр нийлүүлэх ажлын хүрээнд:

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн төвийн 6 дүүргийн 172770 мянган өрхийн 77,9 хувь нь 2011-2012 онд татаастай үнээр эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнээр хангасан байна. /Хүснэгт 2/

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхөд 2011 - 2012 онд татаастай үнээр нийлүүлсэн эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний тоо

Хүснэгт 2

Дүүрэг	Зуух		Гэрийн бүрээс		Гонх		Нийт өрхийн тоо	Хамрагдсан өрхийн тоо	Хувь
	2011	2012	2011	2012	2011	2012			
Чингэлтэй дүүрэг	16488	5012	3379	2762	880	622	29133	28259	97%
Баянзүрх дүүрэг	6611	19189	1661	2443	503	379	47661	30786	64.59%
Сүхбаатар дүүрэг	8726	5474	1693	1615	658	462	20227	18728	92.58%
Сонгино-Хайр-хан дүүрэг	8632	23812	2200	1701	614	576	45231	37535	82.98%
Баянгол дүүрэг	0	0	838	983	249	114	12028	2184	18.16%
Хан-Уул дүүрэг	655	12465	71	1421	32	89	18490	14733	79.68%
Нийт бүтээгдэхүүн	41673	66925	9842	10927	2936	2163	172770	134609	77.90%

Авто тээврийн хэрэгслээс гарах бохирдлыг бууруулах чиглэлээр

Нийтийн тээврийн 800 том оврын автобусаас 400 том оврын автобусыг дизель - газын хосолмол болгох ажил явагдаж байгаа бөгөөд 290 автобусны түлшний найрлагыг сайжруулан, утааны бохирдлыг бууруулах зориулалттай төхөөрөмжийг суурилуулсан,15 автобусыг троллейбус болгон өөрчилсөн, 18 троллейбус, дуобус угсарч, 1523 суудлын автомашинд хорт утааны шүүлтүүр суурилах ажил хийгджээ. Том оврын автобуснаас ялгарах утааны тортогжилтын хэмжээ 13,5-36%-иар буурсан дүнтэй байна.

Иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр

Монголын Мянганы сорилтын сан болон “Цэвэр агаарын сан” хамтран сайжруулсан зуух худалдан авсан иргэдэд үнийн дүнгийн 80-90 хувийн хөнгөлөлт, урамшуулал олгож “Цэвэр агаарын сан”-гаас боловсруулсан түлш худалдан авсан иргэдэд үнийн дүнгийн 40 - 47 хувийн хөнгөлөлт олгож нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнийн урамшуулал олгох ажил 2011 оноос эхлэн хэрэгжиж байгаа. Одоогийн байдлаар 118.0 мянга гаруй өрх хөнгөлөлт эдлэх ёстойгоос 53.0 мянган хэрэглэгч хөнгөлөлтөнд хамрагдаад байна.

Ус халаалтын зуухнуудаас үүсэх бохирдлыг бууруулах чиглэлээр

Улаанбаатар хотод байрлах 132 нас даралтын зуухыг татан буулгаж төвлөрсөн халаалтанд холбож 42 нас даралтын зууханд шинэчлэл хийжээ.

2011 - 2012 онд утаагүй зуух, утаагүй түлш, эрчим хүчний хэмнэлттэй халаалт, дулаалгын хэрэгсэл зэрэг айл өрхөд чиглэсэн ажил болон нам даралтын зуухуудыг төвлөрсөн халаалтын сүлжээнд холбох, авто тээврийн хэрэгслээс гарах бохирдлыг бууруулах зэрэг багц үйл ажиллагаа явуулсны үр дүнд Улаанбаатар хотод 2012 оны 10 - 12 дугаар сарууд буюу халаалтын ачаалалтай үед агаарын бохирдол 20 орчим хувиар, бохирдолд агуулагдах хорт бодис 80 хүртэл хувиар буурсан байна. Эдгээр тоон үзүүлэлтээс гадна агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллах бүтэц тогтолцоо, зохион байгуулалт бий болсон нь цаашид богино хугацаанд үр дүнд хүрэх суурь орчин бүрдүүлснийг холбогдох газрууд тодотгосон.

Хоёр. Агаар бохирдол, хүний эрүүл мэндэд нөлөөлж буй байдлыг статистик үзүүлэлтээр
Агаарын бүтэц шинж чанар өөрчлөгдөхийг агаарын бохирдол гэдэг бөгөөд энэ нь хүний эрүүл мэнд, экосистемд таагүй нөлөө үзүүлдэг. Агаарын бохирдолт байгалийн ба хүний гаралтай байж болно.

Байгалийн гаралтай агаарын бохирдол нь байгалийн үйл явцаар үүсэх бөгөөд үүнд галт уул дэлбэрэх, уулын чулуулаг элэгдэх, ургамал хэт их цэцэглэх, ойн болон гал түймрийн утаа гэх мэт хамаарна.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдол нь үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад янз бүрийн хорт бодис агаарт хаягдсанаас үүсдэг. Энэ нь цар хүрээгээрээ байгалийн гаралтай агаарын бохирдолыг давдаг байна. Агаарын бохирдлын улмаас хүн амын дунд амьсгалын замын эмгэг түгээмэл тохиолддог ба бүх насныхан өртдөг нь тодорхой үүний дотор хүүхэд, өндөр настнууд, мөн дархлаа султай өвчлөмтгий хүмүүс архаг хууч өвчтэй хүмүүс илүү өртдөг. Агаарын бохирдлыг хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь хурц ба архаг гэж 2 ангилдаг.

- Хурц нөлөөлөл гэдэг нь агаар бохирдуулж байгаа хорт бодисын хольцууд нь / концентрацаар/ өндөр идэвхээр богино хугацаанд хүн, амьтан, ургамлын амьдрах үйл ажиллагаанд хорт нөлөө үзүүлэхийг хэлнэ.
- Архаг нөлөөлөл гэдэг нь агаар мандалд байгаа хорт бодисууд бага идэвхээр

удаан хугацааны турш хүн, амьтан, ургамлын амьдрах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхийг хэлнэ.
- Архаг нөлөөллийг өвөрмөц ба өвөрмөц бус архаг нөлөөлөл гэж ангилдаг. Өвөрмөц архаг нөлөөлөл гэдэг нь хорт бодис дангаараа тодорхой эрхтэн системийг гэмтээж бие даасан өвчин үүсгэнэ. /тоосжилт/
- Өвөрмөц бус архаг нөлөөлөл нь хорт хольцууд ямар нэг өвчнийг сэдрээх хүчин зүйл болдог.

Олон улсад хийсэн судалгаагаар хүрээлэн буй орчны бохирдол нь оршин суугчдын өвчлөлийг нэмэгдүүлэх, хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжилд сөрөг нөлөөлж, дархлалын түвшинг бууруулдаг болохыг тогтоосон байгаа . Үүнд:

1. Өвчлөлийг нэмэгдүүлэх
   - Амьсгалын эрхтний эмгэг /Цочмог ларингит, Архаг бронхит, тонзиллит, аденойдит, уушги, гуурсан хоолойн бөглөрөлтөт хэлбэрийн архаг үрэвсэл/
   - Харшлын эмгэг (харшлын гаралтай нүд, чих хамрын хоолойн хөндийн үрэвсэл , багтраа, арьсны эмгэг)
   - Зүрх судасны өвчин (Зүрх судасны өвчний тархалт өндөр байх, зүрхний үйл ажиллагааны хямрал, дутагдал, төрөлхийн гажиг, зүрхний ишеми)
   - Удамшлын эмгэг, төрөлхийн гаж хөгжил
   - Хавдар
   - Нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө (үр хөврөл гэмтэх, дутуу төрөх)
2. Бие махбодын өсөлт, хөгжилтөд сөрөг нөлөөлнө
   - Өндөр, жин, цээжний тойргийн хэвийн харьцаа алдагдах
   - Таргалах, турах
   - Биеийн галбир өөрчлөгдөх
3. Бие махбодын физиологийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлнө
   - Уушгины үйл ажиллагаа алдагдана
   - Оюуны ажиллах чадвар
   - Мэдрэхүй-хөдөлгөөний хурд өөрчлөгдөнө
   - Цусны даралт,судасны цохилт өөрчлөгдөнө
4. Дархлалын түвшинг бууруулна
   - Биеийн ерөнхий эсэргүүцлийг сулруулах

Хүний амьсгалын эрхтнүүд нь байгалиасаа өөрийгөө цэвэрлэх, хамгаалах, хоргүйжүүлэх үйл ажиллагаатай тэр хоорондоо нарийн өндөр уялдаатай явагдаж, бие махбодыг бүрэн хамгаалж заясан байдаг. Гэтэл агаарын бохирдол, хүрээлэн буй орчны өөрчлөлтийн нөлөөгөөр дээрх үүргээ гүйцэтгэж чадахгүй болдог байна.

Зүрх судасны өвчин нь тахир дутуу болох, эрт нас барах өндөр эрсдэлтэй бөгөөд эрүүл мэндийн статистикийн мэдээгээр манай улсад зүрх судасны өвчний өвчлөл нь хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж,нас барж буй 3 хүн тутмын нэг нь зүрх судасны өвчний улмаас эндэж байна.

Орчны бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг илтгэх нэг үзүүлэлт бол хүүхдийн зүрх судасны үйл ажиллагааны алдагдлын өөрчлөлт өвчин гэж үздэг байна. Агаарын бохирдол нь хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийн үзүүлэлтүүд, дархлааны

UIH.MN
СУДАЛГААНЫ

байдалд үзүүлэх нөлөөлийг судлаж үзэхэд Улаанбаатар хотод судалгаанд хамрагдсан хүүхдүүдэд өсөлт, хөгжлийн хэвийн харьцаа алдагдаж, өндөр, жин нэмэгдэж, цээжний тойргийн хэмжээ багассан нь тогтоогдсон байна.

Эрүүл мэндийн статистикийн мэдээгээр Улаанбаатар хотод амьсгалын эрхтний өвчлөл жилээс жилд нэмэгдэж, нийслэл хотод амьсгалын эрхтний өвчлөл нийт өвчлөлийн 23.4-24.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн өвчлөлийн ерөнхий бүтцэд амьсгалын эрхтний өвчлөл 1-р байр эзэлдэг бөгөөд агаарын бохирдол ихтэй газар түүний эзлэх хувь нэмэгдэж байна.

Улаанбаатар хотын агаар дахь тоос, хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж нь хүүхдийн амьсгалын эрхтний өвчлөл, тухайлбал хүүхдийн гуурсан хоолойн цочмог болон архаг үрэвсэл, уушгины үрэвслийн нэг шалтгаан болдог байна. Мөн Улаанбаатар хотын хүүхдүүд хөдөөгийн хүүхдүүдийг бодвол гуурсан хоолойн үрэвсэл өвчнөөр 5-15 дахин илүү өвчилж байна гэдгийг судалгаар тогтоосон байна.

Томоохон хотуудын хүн амын өвчлөлд суурьшил ахуйн орчны эрсдэлт хүчин зүйлиин нөлөөллийг судалж үзэхэд агаарын найрлага дахь нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхэрлэг хий, азотын давхар исэл, хөрсний бохирдолтоос үүсэх хар тугалга нь дагнасан буюу хавсарсан байдлаар нөлөөлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байдаг. Агаарын бохирдолт нь амьсгалын замын эрхтэний өвчлөлд нөлөөлөхөөс гадна жирэмсэн эмэгтэйчүүдийн 20 - 27 % нь эрт хожуу хордлоготой, нийт төрсөн хүүхдийн 3,2 - 3,6% нь хүчилтөрөгчийн дутагдал, амьсгалын замын хямралтай төрж байна.

2.1.Улаанбаатар хотын хүн амын өвчлөл, 2000 - 2011 он

Агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөөллийн дийлэнх үнэлгээ нь агаарын бохирдлыг амьсгалын замын өвчлөлтэй харьцуулан судалж, агаар дахь үндсэн бохирдуулагчид сөргөөр нөлөөлж, зүрх судас, хавдрын өвчлөлд нөлөөлөх хүчин зүйл болохыг судлан тогтоосон .

Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг сүүлийн 6 жилийн статистик үзүүлэлтээс харахад амьсгалын тогтолцооны өвчин 10.000 хүн амд 2007 онд 732,22 , 2008 онд 864,98, 2009 онд 864,03, 2010 онд 954.82, 2011 онд 901,04, Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2007 онд 565,5, 2008 онд 669,1, 2009 онд 633,8, 2010 онд 612,8, 2011 онд 640,2 тохиолдолоор бүртгэгдсэн гэсэн үзүүлэлтэй байна.

Амьсгалын тогтолцооны өвчлөл сүүлийн жилүүдэд тогтмол тэргүүлэх шалтгаан болж нийт өвчлөгчдийн 52,4 хувийг эмэгтэйчүүд, 47,16 хувийг эрэгтэйчүүд эзэлж, өвчлөлийн дийлэнх буюу 48,3 хувийг 0-5 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байна. Амьсгалын тогтолцооны өвчнөөс амьсгалын дээд, доод замын цочмог болон архаг халдварууд, уушгины хатгаа, багтраа бачуурал зэрэг өвчнүүд ихэвчлэн бүртгүүлжээ.

Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 2001 оноос хойш байнга нэмэгдэж нийт өвчлөгсдийн 59,7 хувь нь эмэгтэйчүүд 40,3 хувийг эрэгтэйчүүд эзэлж, энэ бүлгийн өвчлөлд цусны даралт ихсэх, зүрхний хэрх, зүрхний цус хомсролт, тархины судасны өвчин зонхилж байгаа ба 45 дээш насныхан ихэвчлэн өвчилсөн байна.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан /10 000 хүн амд/[31]

он	Амьсгалын тогтолцооны өвчин	Бэртэл хордлого, гадны шалтгаант өвчин	Хоол шингээх эрхтний өвчин	Цусны эргэлтийн тогтоцооны өвчин	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин
2000	699,4	745,8	626,1	396,7	456,8
2001	593,2	649,3	524,1	360,9	401,2
2002	634,7	722,3	589,1	427,13	470,6
2003	650,2	742,6	620,3	435,6	490,5
2004	690,7	780,8	728,8	471,8	534,4
2005	678,3	783,6	748,5	462,2	497,1
2006	652,9	748,8	755,9	493,5	587,5
2007	732,22	778,9	797,81	565,5	572,7
2008	864,98	790,68	824,09	640,78	669,1
2009	864,03	766,76	884,03	682,84	633,8
2010	954,82	828,88	849,26	648,06	612,8
2011	901,04	864,24	796,21	681,43	640,2

2.2.Улаанбаатар хотын хүн амын нас баралт, 2001 - 2011 он

Манай улсын хүн амын нас баралтын шалтгаанд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар болон осол гэмтлийн шалтгаант нас баралт тогтмол эхний байруудыг эзэлж жил ирэх тутам эдгээр өвчний улмаас нас барсан хүний тоо нэмэгдсээр байна. Улаанбаатар хотын Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2011 оны статистик судалгаанаас харахад өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааныг сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр гаргасан байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан /1000 хүн амд/[32]

он	Амьсгалын тогтолцооны өвчил	Хавдар	Хоол шингээх эрхтний өвчин	Цусны эргэлтийн тогтоцооны өвчин	Гадны шалтгаант нас баралт
2001	0,33	1,23	0,35	2,18	1,04
2002	0,3	1,47	0,46	2,17	1,35
2003	0,2	1,53	0,47	2,52	1,24
2004	0,23	1,53	0,52	2,38	1,59
2005	0,16	1,24	0,56	2,23	1,82
2006	0,19	1,1	0,72	2,33	1,71
2007	0,18	1,45	0,63	2,12	1,76

[31] Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт 2011, НЭМГ., 2011 он.

[32] Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт 2011, НЭМГ., 2011 он.

UHI.MN
СУДАЛГААНЫ САН

2008	0,19	1,29	0,57	1,86	1,24
2009	0,25	1,26	0,53	1,87	1,17
2010	0,22	1,41	0,58	2,17	1,35
2011	0,22	1,43	0,62	2,18	1,64

Сүүлийн 5 жилийн нийслэл Улаанбаатар хотын тэргүүлэх 5 өвчлөлийн шалтгааныг авч үзвэл амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин, хоол шингээхэрхтэн тогтолцооны өвчин, осол гэмтлийн шалтгаант өвчин тэргүүлж байна. Нийт амьсгалын замын өвчний дийлэнх нь 1-4 насны хүүхдүүд байна. Эрүүл мэндийн статистик мэдээнээс амьсгалын тогтолцооны өвчнийг харахад хатгалгаа хамгийн их бүртгэгддэг байна.

2006 онд амьсгалын тогтолцооны өвчний улмаас нас барсан тохиолдол 1000 хүн амд 0.9 байсан бол 2011 онд 0,22, болж өссөн байна. Эрүүл мэндийн статистик мэдээлэлд бүртгэгдсэн амьсгалын тогтолцооны өвчлөлд нас, хүйс, улирлын байдал хамаараалтай байна. Хаврын улиралд амьсгалын дээд замын цочмог халдвар, архаг бронхит, уушгины хатгалгаа, бусад амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын тохиолдол илүү зонхилж харин намар уушги тэлэх, энфиземи, өвөл багтраа өвчний улмаас нас барах тохиолдол тус тус илүүтэй тохиолддог нь статистик магадлал бүхий хамааралтай байна.

* * *

Ашигласан материал:

1. Нийслэлийн агаарын чанарын албаны 2006 - 2009 оны агаарын бохирдлыг бууруулах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан,
2. Монгол Улсын Үндэсний Аудитын Газрын “Утаа бага гаргах түлш боловсруулах зориулалтаар 2009-2010 онд төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүн” хийсэн гүйцэтгэлийн тайлан,
3. Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яамны хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газрын мэдээлэл,
4. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга П. Цагааны үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01 сарын 19-ний хуралдаанд тавьсан илтгэл,
5. Нийслэлийн эрүүл мэндийн газрын “Хүн амын эрүүл мэндийн статистик үзүүлэлт” 2011 он.

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР (РОЯЛТИ) БА МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛБӨР (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Нороводондог (Ph.D), Г. Алтан - Оч (Ph.D), Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа, Д. Байгалмаа, Г. Гэрэл, Ч. Онончимэг, Г. Билгээ

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР[33] (ROYALTY)**:**

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТөлбөр/ нь ашигт малтмал, эрдсийн нөөцийг ашиглах эрх олгосных нь төлөө тухайн орны Засгийн газарт лицензэзмшигч хуулийн этгээдээс төлж буй төлбөр юм. АМНАТөлбөр нь татварын төрөлд хамаарахгүй бөгөөд ашигт малтмал, эрдэс баялгийн дахин нөхөн сэргээгдэхгүй нөөцийг ашигласны төлөө тухайн улсад төлж буй төлбөр гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл эрдэс баялгийн нөөц үнэ төлбөргүйгээр ашиглагдах ёсгүй гэсэн утгыг илэрхийлж байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг

- Борлуулалтын нийт дүнгээс (борлуулалтад суурилсан);
- Татвар ноогдох ашгаас (ашигт суурилсан) гэсэн хоёр төрлөөр ноогдуулдаг зарчим байна.
- /Олборлолтын хэмжээнээс хамааруулан тогтоох/

Борлуулалтын нийт дүнд ноогдуулдаг АМНАТөлбөрийг аливаа үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлттэй огт хамааралгүйгээр тогтоодог бол ашгаас ноогдуулдаг АМНАТөлбөрийг борлуулалтаас үйлдвэрлэлийн зардлыг хасаад, татварын өмнөх ашгаас ноогдуулдгаараа ялгаатай. Иймд ашигт суурилсан АМНАТөлбөр ноогдох суурь нь бага байх бөгөөд энэ төрлийн АМНАТөлбөрийг төлөх хувь тодорхой норматив, борлуулалтын нийт дүнгээс ноогдуулдаг АМНАТөлбөрийн хувиас илүү өндөр түвшинд тогтоогдох ёстой байдаг байна. (Канад улсын туршлага).

Борлуулалтад суурилсан АМНАТөлбөрийн давуу талуудууд нь :

- Уул уурхайн компаниуд зардлаа зохиомлоор өсгөн мэдээлэх зүй бус явдлыг хязгаарлана;
- Засгийн газарт АМНАТөлбөрийг үйлдвэрлэгчдээс цуглуулах эрсдэл багасана.

Үүний зэрэгцээ борлуулалтад суурилсан АМНАТөлбөртэй холбоотойгоор дараах сөрөг нөлөөллүүд дагалдах магадлалтай. Үүнд:

- АМНАТөлбөр ноогдох суурь энэ тохиолдолд их байх тул АМНАТөлбөрийн хувь хэмжээг хэт өндөр тогтоовол ордын захын агуулгыг сайжруулахад чиглэгдсэн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх;
- Өндөр агуулгатай хүдрийг сорчилж ашиглах зүй бус үзэгдэлд түлхэц өгөх;
- Хэрвээ хүдэр нь олон тооны ашигт эрдсийг агуулсан конгломерат бүтэцтэй, үндсэн болон дагалдах эрдсийг зэрэг агуулсан бол АМНАТөлбөрийн хувь хэмжээг тооцоход хүндрэл гарах магадлалтай. Иймд өндөр агуулгатай хүдрийг сорчилж ашиглахын эсрэг, улсын эрдэс баялгийн нөөцийн баазад сөрөг үр дагавар учруулахгүйн эсрэг хяналтын, зохицуулалтын цогц арга хэмжээг Засгийн газраас авах шаардлагатай болно.

[33] http://boldsandagdorj.blogspot.com/2006/06/blog-post.html С.Болд-Эрдэнэ.

Олон улсын түвшинд борлуулалтад суурилсан АМНАТөлбөр тийм ч өндөр бус, гэхдээ маш ялгавартай тогтоогдсон байдаг. АМНАТөлбөрийн дундаж түвшин дэлхийн бусад орнуудад нийтлэг **3-18%** -д хэлбэлзэж байгаа бөгөөд үүнийг бас үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, тухайн ордын нөөцийн хэмжээний байдал, хүдрийн захын агуулгын хэмжээ, уул геологийн нөхцөл зэргийг харгалзан орд бүрт ихээхэн ялгавартай тогтоодог байна.

Ашигт суурилсан АМНАТөлбөрийн голлох давуу талууд:

- Засгийн газар, хөрөнгө оруулагч аль аль талд эрсдэл адил тэнцүү хуваарилагдах тул үйлдвэрлэгчийн хувийн хөрөнгө оруулалтад үзүүлэх сөрөг нөлөө бага, өөрөөр хэлбэл энэ систем нь үйлдвэрийн санхүүгийн чадавхийг харгалздаг;
- АМНАТөлбөрийн хувийг тооцоход ашигт малтмалын төрөл, агуулга, боловсруулалтын түвшинд үндэслэх шаардлагагүй ба ашигт малтмалын төрөл бүрт ижил хувь, норм хэрэглэж болдог.

Гэсэн ч үүнийг дагалдан дараах эрсдэл үүсч болзошгүй байдаг. Үүнд:

- Засгийн газарт төлөх АМНАТөлбөрийн хэмжээг багасгахын тулд санхүүгийн бүртгэлд зардлаа ихэсгэж мэдээллэх байдлаар манипуляци хийх хандлага үйлдвэрлэгчдэд бий болж болзошгүй;
- Үүний улмаас Засгийн газар ААНОА татварын хуулийн адил АМНАТөлбөрөөс үйлдвэрлэгчид зайлсхийх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авах шаардлагатай;
- АМНАТөлбөрийн хэмжээ үйлдвэрлэгчийн зардал, ашгаас хамааран хэлбэлзэх тул түүнийг цуглуулан хуримтлуулах эрсдэл Засгийн газарт ихэсдэг байна.

АМНАТөлбөрийг (роялти) **төлж буй бусад орны жишиг**

Ашигт суурилсан АМНАТөлбөрийн системтэй орнуудын тоонд Канад, Австралийн хойт бүс нутаг орно. Харин Мексик, Австрали (хойт бүс нутгийг оруулахгүйгээр), Польш, Хятад, Аргентин, Боливи, Бразил, Индонези, Перу, Чили, Узбекистан, ОХУ, Папуа Шинэ Гвиней, Филиппин, Ангол, Гана, Лесото, Малави, Мозамбик, Намиби, Танзани, Зимбабве зэрэг дэлхийн ихэнх улсууд борлуулалтын нийт дүнд АМНА төлбөрийг ноогдуулдаг системтэй байна. Харин Аргентин, Казахстан, Гринланд зэрэг цөөн тооны орнууд АМНА төлбөрийн хувь нормыг хөрөнгө оруулагчтай тохиролцох байдлаар бас тогтоодог байна.

	Улс	Хувь хэмжээ[1]
Ашигт суурилсан нөөц ашигласны төлбөрийн систем		
	Канад	Алт, платинум, алмаз, нүүрс, аж үйлдвэрийн эрдсүүд, төмрийн хүдэр, зэс гэзд бүх ашигт малтмал дээр нөөц ашигласны төлбөрийн хувь ижил түвшинд тогтоогдсон боловч муж бүрээр өөр өөр хувь түвшинтэй. Жишээ нь Кьюбек мужид татварын өмнөх ашгийн 20%, Онтарио мужид 18%, Британ Колумб мужид 15%-иар тус тус нөөц ашигласны төлбөрийг ноогдуулдаг.
	Австралийн хойт бүс нутаг	18% байх ба ашигт малтмалын цэвэр үдэх ашгаас үйдвэрлэлийн болон бусад зардалыг хасна.
Борлуулалтын нийт үнийн дүнд нөөц ашигласны төлбөрийн систем		
	Австрали (хойт бүс нутгийг оруулахгүйгээр)	Баруун Австралид борлуулалтад ноогдуулах АМНА төлбөрийн түвшин экспортолж байгаа - нүүрсэнд 7.5%, - зэсийн баяжмалд 5%, - цэвэршүүлсэн зэсэнд 2.5%, - хээрийн жоншинд 5%, - төмрийн хүдэрт 5-7.5%, - хар тугалганы баяжмалд 5%, - метал хар тугалганд 2.5%, - цайрын баяжмалд 5% гэх мэт ашигт малтмалын төрөл, боловсруулалтын түвшнээс хамаарч 2.5-7.5% байна.
	Ангол	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 2-5%
	Аргентин	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 1-3%
	Боливи	Алт 1-7%, зэс 1%, төмрийн хүдэр 1%
	Ботсвана	Үнэт чулуунд цэвэр орлогын 10%, үнэт металд 5%, бусад эрдэст 3%
	Буркино Фасо	Алт 3%, нүүрс, төмрийн хүдэр 4%
	Гана	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 3-12% Нийт орлогын 3-6%
	Зааны ясан эрэг	Алт 3%, нүүрс, зэс, төмрийн хүдэр 2.5%
	Замби	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 2-5%
	Зимбабве	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 2-10%
	Индонези	Алт 2%, нүүрс 13.5%, зэс, төмрийн хүдэр 2.5%
	Ирланд	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 1.5-4.5%
	Лесото	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 5-10%
	Малави	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 5-10%
	Мексик	Алт, нүүрс, зэс 1.5%
	Мозамбик	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 3-10%
	Намиби	Нүүрс 4%
	ОХУ	Алт 6%, нүүрс 4%, зэс 8%, төмрийн хүдэр 4.8%
	Өмнөд Африк	Алт 3%, нүүрс, зэс, төмрийн хүдэр 2%
	Папуа Шинэ Гвиней	Алт, зэс 2%
	Польш	Алт 10%, нүүрс 2%, зэс 3%
	Танзани	Алт, нүүрс, зэс, төмрийн хүдэр 3%
	Узбекистан	Алт 4%, нүүрс 5.4%, зэс 7.9%, төмрийн хүдэр 3%
	Хятад	Алт 4%, нүүрс 1%, зэс 2%, төмрийн хүдэр 2%
	Филиппин	Алт, зэс, төмрийн хүдэр 2%

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2012 оны 7 сарын байдлаарх зарим орны Роялтийн хувь хэмжээ[34]
/Global mining industry update/

Улс	Хувь хэмжээ
Австрали	30
АНУ	30
Аргентин	21
Бразил	15-25
Гана	10
Герман	15.825
Индонези	20
Их Британи	20
Казахстан	15
Канад	25
БНА Конго улс	14
БН Конго улс	20
Мексик	25
ОХУ	20
Өмнөд Африк	12
Перу	30
Танзани	15
Украин	15
Филиппин	30
Хятад	10
Чили	30
Энэтхэг	10.506

МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛБӨР

“Менежментийн баг”: Хөрөнгө оруулалтын менежмент гэдэг нь хөрөнгө оруулагчдад ашигтай байх тодорхой хөрөнгө оруулалтын зорилтод хүрэхийн тулд хийж буй төрөл бүрийн үнэт цаасны /хувьцаа, бонд болон бусад төрлийн үнэт цааснууд/ болон хөрөнгийн /үл хөдлөх хөрөнгө гэх мэт/ мэргэжлийн менежментийг хэлнэ.

Хөрөнгө оруулагчид нь байгууллага /даатгалын компани, тэтгэвэр тэтгэмжийн сан, корпораци, хандивын байгууллага гэх мэт/ эсвэл хөрөнгө оруулагч хувь хүн байж болно. Менежментийн төлбөр: Хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдахад менежер шаардлагатай ба менежментийн төлбөр нь тухайн менежерийн зарцуулсан цаг хугацаа болон дүн шинжилгээ хийсний нөхөн төлбөр юм. Өөрөөр хэлбэл, Хувь нийлүүлж буй хөрөнгө оруулалтын хувьд менежментийн төлбөр гэдэг нь хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалтын үйл ажилллагаанд зориулсан хөрөнгө оруулалтыг удирдаж буй менежерт төлөх жилийн төлбөр юм. Менежментийн төлбөр нь ерөнхийдөө менежмент хийж байгаа хөрөнгийн хувь хэмжээнд үндэслэн тогтдог[35].

Менежментийн төлбөрийн эдийн засгийн агуулгыг тайлбарлахын тулд эхлээд “менежмент гэж юу вэ” гэдгийг тодорхойлох шаардлага гарна. Менежмент гэдэг нь байгууллагын зорилгод хүрэхийн тулд нөөцүүдийг үр ашигтай, үр дүнтэй арга замаар төлөвлөж

[34] June 2012, “Corporate income taxes, mining royalties and other mining taxes A summary of rates and rules in selected countries”

[35] http://www.investopedia.com/terms/m/managementfee.asp

шийдвэр гаргах, зохион байгуулах, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл юм” гэж тодорхойлсон байдаг. Үүнээс үзэхэд менежментийн багийн зорилго нь тухайн байгууллагын ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ гэж товчхон дүгнэж болох юм. Тэгвэл, менежментийн үйлчилгээ үзүүлсний төлөө төлж байгаа төлбөр нь тухайн байгууллагын орлоготой зайлшгүй холбогдох бөгөөд зөв менежмент явуулснаар ашиг, орлого нэмэгдэх, улмаар үүнд нийцэн менежментийн багийн төлбөр нэмэгдэх зүй тогтол ажиглагдаж байна.

Гэтэл Оюутолгой төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээний 7.4.в -д менежментийн төлбөрийг үндсэн хөрөнгийн зардал болон үйл ажиллагааны зардлаас тооцож байгаа нь менежментийн багийн зорилготойгоо зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, гэрээгээр тогтоосон менежментийн төлбөр тооцох суурь нь компанийн орлогыг нэмэгдүүлэх биш, харин зардлыг нь нэмэгдүүлвэл менежментийн үйлчилгээг үзүүлж байгаа талд ашигтай байхаар тогтоогдсон байгаа нь ойлгомжгүй байна. Гэрээний тусгасан менежментийн төлбөр нь эдийн засгийн агуулгатайгаа нийцэж байгаа эсэх тайлбарыг доор хүснэгтээр харуулав.

Гэрээний заалт	Тайлбар
7.4.в. Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь: • Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 /гурван/ хувь байна.	Үйлдвэрлэл эхлээгүй тул орлого олохгүй гэж үзээд менежментийн төлбөрийг тооцохдоо оруулсан хөрөнгийн хэмжээ, эсвэл үйл ажиллагааны зардлаас тодорхой хувиар тооцож болох талтай.
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойшхи хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 6 /зургаан/ хувь байна.	Үйлдвэрлэл эхэлснээр борлуулалт хийгдэж, орлого орох ёстой. Улмаар ашиг олно. Иймээс менежментийн төлбөрийг зардлаас тооцож болохгүй ба орлогоос тооцох нь зарчмын хувьд нийцтэй.

Гадаадын бусад орнуудад менежментийн үйлчилгээ үзүүлсний төлөө хэдий хэмжээний төлбөр төлдөг талаарх мэдээллийг интернетээс хайлт хийж үзэхэд уул уурхайн салбар болон уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан менежментийн төлбөрийн талаарх мэдээлэл олдоогүй бөгөөд ихэвчлэн санхүүгийн зах зээлд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлдэг компани, хөрөнгө оруулалтын сангуудын менежментийн үйлчилгээний төлбөртэй холбоотой мэдээллүүд олдсон болно.

Менежментийн төлбөр тооцох суурь:

Хамтарсан хөрөнгө оруулалтын сан бүрт менежментийн төлбөрийн хувь хэмжээ харилцан адилгүй байна. Хөрөнгө оруулагчид менежментийн багтайгаа төлбөрийн нөхцөл, хувь хэмжээгээ тохиролцоно. Гэхдээ олон улсад тогтсон дундаж жишгээр хөрөнгө оруулалтын дүнд суурилсан, ашигт суурилсан нөхцлүүдийн аль нэгийг сонгож, 1 - 2% -иар тогтоодог байна. Ихэнх тохиолдолд менежментийн төлбөр нь хамтарсан хувь нийлүүлэлтийн санд хийсэн хөрөнгө оруулалтын нийт дүнд суурилна. Хөрөнгө оруулах эхний үе шат дууссаны дараа /голдуу 4 - 6 жил/ төлбөрийн суурь нь үйл ажиллагааны зардал, ашгаас хамаарч өөрчлөгдөнө. Менежментийн төлбөрийн хувь нь хөрөнгө оруулалтын эхний үе шатанд жилийн 1,0 - 2,0 хувь орчим байх ба сангийн хугацаа дуусах үед анхны хувиас 0,5 - 1,0 хувиар буурна. Хөрөнгө оруулалт байнгын эргэлтэнд орсон үе буюу үйлдвэрлэл эхэлсэнээс хойшхи үйл ажиллагааг удирдах менежментийн төлбөрийг ашиг орлогоос тооцож хувь хэмжээг нь тогтоодог байна.

Латин Америкийн зарим орнуудын Хамтарсан хөрөнгө оруулалтын сангийн менежментийн төлбөрийн хувь хэмжээ:

Орнууд	Төлбөрийн хувь	Тайлбар
Чили	0.89%	Менежментийн төлбөрийг ашгаас тооцсон байна
Колумби	1.66%	
Коста Рика	2.23%	
Эл Сальвадор	1.12%	
Мексико	1.45%	
Перу	1.14%	
Доминикан	3.52%	
Уругвай	0.94%	

Харин хөрөнгө оруулалт оруулж эхлэх үе буюу үйлдвэрлэл эхлэхээс өмнөх үе шатанд менежментийн төлбөрийг нийт оруулсан хөрөнгийн дүнгээс тооцож байна. Жишээ нь: Польш улсын туршлагаас үзэхэд,

Польш улсын Хамтарсан хөрөнгө оруулалтын сангийн менежментийн төлбөрийн хувь хэмжээ /нийт хөрөнгө оруулалтын дүнгээс тооцно/

Он	Нийт төлбөр	Тайлбар
2005	1.44%	Төлбөрийн хувь хэмжээг эргэлтэнд оруулсан нийт хөрөнгөөс суурилан тооцож байгаа бөгөөд жил ирэх тусам төлбөрийн хувь хэмжээ нь буурах шатлалтай байна
2006	1.29%	
2007	1.24%	
2008	1.37%	
2009	1.13%	
2010	0.82%	

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ:

Судалгаанд авч үзсэн “Менежментийн баг”, “Менежментийн төлбөр” зэрэг ойлголтоос Оюу толгой төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан “Менежментийн баг” болон “Менежментийн төлбөр” гэсэн ойлголт зарчмын хувьд ялгаатай байна. Тухайлбал:

1) Гүйцэтгэж байгаа субьектээрээ ялгаатай байна: Олон улсын хэмжээнд Хөрөнгө оруулагчдын төвлөрүүлсэн хөрөнгийг мэргэшсэн удирдлагаар хангах менежментийн баг нь Хөрөнгө оруулагчдын хувьд гуравдагч этгээд байдаг байна. Харин ОТ төслийн хувьд Менежментийн баг нь Хөрөнгө оруулагч нөгөө талын хамааралтай этгээд байхаар Хувь нийлүүлэгчийн гэрээний 7.2-т зааснаас үзэхэд бодит байдал дээр хөрөнгө оруулагч нөгөө тал нь өөрөө менежментийн багийг ажиллуулж байгаа нь харагдаж байна. “Оюу толгой “ төслөөс албан ёсоор гаргасан “Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээний тухай товч танилцуулга”-д “Менежментийн төлбөр нь төслийг удирдаж буй талд төлдөг стандарт төлбөр бөгөөд төслийн менежментийг Рио Тинто компани гүйцэтгэж байна. Уг төлбөр нь

уурхай бүтээн байгуулах, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой томоохон хэмжээний логистикийн болон захиргаа удирдлагын зардал юм.” гэжээ. Үүнээс үзэхэд, Оюу толгой төслийн хувьд “Гүйцэтгэх удирдлага” болон “Менежментийн баг” нь цаад утгаараа нэг субьект байх тул 1 төрлийн үйлчилгээнд 2 давхар зардал гаргаж байна гэж хэлж болохоор байна.

2) Менежментийн төлбөрийн хувь хэмжээгээр ялгагдаж байна. Оюу толгой төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээнд заасан менежментийн төлбөр нь олон улсад тогтсон дундаж жишгээс харьцангүй өндөр байна. Өөрөөр хэлбэл, гэрээнд зааснаар, Үйлдвэрлэл эхлэхээс өмнө үндсэн хөрөнгийн зардал болон үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 хувь, Үйлдвэрлэл эхэлсэнээс хойш 6 хувь байхаар заасан. Гэтэл судалгаанд авагдсан орнуудын хувьд энэхүү зардал нь 0,8-3,5 хувь байх бөгөөд ихэнхи улс оронд 1,1 - 1,4 хувьтай байна. Мөн нөгөө талаас өндөр хөгжилтэй орнуудад менежментийн төлбөрийн хувь хэмжээ бага байхад буурай хөгжилтэй улс оронд энэ хувь хэмжээ өндөр байна. Мөн менежментийн төлбөр нь жил ахих тусам буурах хандлагатай байдаг байна.

3) Менежментийн төлбөр ногдуулах сууриараа ялгаатай байна. Судалгаанаас үзэхэд, менежментийн төлбөрийг хөрөнгө оруулалтын дүнд суурилсан болон ашигт суурилсан гэсэн 2 зарчмыг баримтлан гэрээгээр тогтоодог байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэл ашиглалтанд орох хүртэлх хугацаанд хөрөнгө оруулалтын дүнгээс, ашиглалтанд орсоноос хойших хугацаанд (орлого?) ашгаас тооцож болох талтай. Үүнийг Оюу толгойн Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр үе шаттайгаар ялгавартай тогтоож өгөөгүй байна.

4) Менежментийн баг болон гүйцэтгэх удирдлагын ажлын зааг ялгааг тодорхой болгох шаардлагатай байна. Гэрээнд менежментийн баг нь компанийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад гүйцэтгэх удирдлагад туслалцаа үзүүлэхээр заасан байна. Менежментийн төлбөр нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний төлбөр үү? эсхүл логистикийн болон захиргаа удирдлагын зардал уу? Судалгаанаас үзэхэд, бусад орнуудад менежментийн төлбөрийг хөрөнгө босгох (fund rising), үнэт цаасны багцийг удирдах(mutual, private equity fund, hedge fund), зөвлөх үйлчилгээ(consulting service) зэрэгт төлдөг байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МЭНЭЖМЕНТИЙН ТӨЛБӨР (НЭМЭЛТ СУДАЛГАА)

Захиалагч: Д. Ганхуяг, УИХ -ын гишүүн
Судлаач: Д - р Г. Алтан - Оч, ахлах референт
Огноо: 2013.01.29 - 02.01

Мэнэжментийн төлбөр гэж хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулах болон үнэт цаасны багцын удирдлагын зорилгоор хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалтын сангийн зөвлөгөө өгөгч этгээдэд тодорхой үетэй өгдөг төлбөрийг хэлнэ.[36]

Мэнэжментийн төлбөр хөрөнгө оруулалтын сангийн амьдралын циклийн туршид өөрчлөгдөж болно. Ингэхдээ цаг хугацааны хувьд ерөнхийдөө буурдаг. Яагаад гэвэл, хөрөнгө оруулагчийн анхны амласан хөрөнгө нь цаг хугацааны туршид хөрөнгө оруулалтын өгөөжөөс эргэн төлөгдөж байдаг.

Төлбөрийн хэмжээ багасах үндэслэл нь мэнэжментийн багийн гол хүчин чармайлт сангийн мониторинг, хуваарилалтын үетэй харьцуулахад сангийн эхний 5 - 6 жилд гардагт оршино. Түүнээс гадна, дараагийн хөрөнгө оруулалтын сан босгосноор нэмэлт мэнэжментийн төлбөрийн урсгал орж ирэх учраас мэнэжментийн баг сангийн сүүлийн жилүүдэд мэнэжментийн төлбөр авахаа болих сонирхолтой байдаг.[37]

Хувь тогтоосон энэхүү төлбөрийн системийн альтернатив гэвэл төсөвт суурилсан төлбөр байдаг. Мэнэжментийн багийг ашигтай ажиллуулахуйц (break-even) жилийн төсвийг зөвлөх товчооны тусламжтайгаар хөрөнгө оруулагч, мэнэжментийн баг хамтран боловсруулж батална. Ингэснээр мэнэжментийн баг нь мэнэжментийн төлбөрөөс илүүтэй сангийн ашгаас “үүрэх сонирхол” (carried interest) хүртэх замаар нөхөн олговроо үндсэнд нь авахад тэмүүлэх урамшууллын хөшүүрэг болдог.[38]

ХАМТЫН САН

Хамтын сан (mutual funds)-гийн хувьд, мэнэжментийн төлбөр гэдэгт тухайн сангийн хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөгч буюу түүний харъяа этгээдэд төлөх аливаа зардал, “бусад зардал” -д тусгагдаагүй удирдлагын зардлыг тус тус оруулан тооцно.[39] Зарим хамтын сангийн 2011 оны мэнэжментийн төлбөр нь сангийн дундаж цэвэр хөрөнгийн (fund’s average net assets) 0.625% - 0.69% -тай тэнцүү байна.[40]

ХУВЬЦААТ ХӨРӨНГИЙН САН

Хувьцаат хөрөнгийн сан (private equity funds)-гийн хувьд, тухайн сангийн хязгаарлагдмал хувь нийлүүлэгчдээс хувьцаат компаний хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг

[36] http://en.wikipedia.org/wiki/Management_fee Management fee

[37] http://mba.tuck.dartmouth.edu/pecenter/research/pdfs/LPA.pdf Note on Limited Partnership Agreements

[38] Өмнөхийг үз.

[39] http://www.sec.gov/investor/pubs/inwsmf.htm#factors Invest Wisely: An Introduction to Mutual Funds

[40] https://ww4.janus.com_Management%20Fee_2010-2011_Web_FINAL_12-23-11.pdf 2011 Management Fee Evaluation

санхүүжүүлэх зорилгоор сангийн мэнэжер (өөрөөр хэлбэл хувьцаат хөрөнгийн компани)-т жил тутам төлөх зардлыг мэнэжментийн төлбөр гэнэ.[41]

Хувьцаат хөрөнгийн сан нь төрөл бүрийн хувьцаат хөрөнгийн үнэт цаасанд (өрийн бичиг бараг орохгүй) хөрөнгө оруулах замаар ажилладаг хамтарсан хөрөнгө оруулалтын схем юм. Хувьцаат хөрөнгийн сан нь ихэвчлэн 10 жилийн тогтсон хугацаатай (ихэнхдээ жил жилээр сунгадаг) хязгаарлагдмал түншлэл байдаг.[42] Ихэвчлэн, хөрөнгө оруулсан гэж үзээд хөрөнгө оруулагчийн нийт амласан сан (total investor commitments to the fund)-г (өөрөөр хэлбэл, сангийн хэмжээ) үндэслэн мэнэжментийн төлбөрийг анхлан тогтооно. Амлалтын үе ихэнхдээ 4-6 жилд дуусах (“анхны хөрөнгө оруулалтын үе”) бөгөөд үүний дараа төлбөрийг тооцох суурь нь сангийн зардалд суурилах байдалд шилжинэ. Ингэхдээ хэрэгжүүлсэн бүх хөрөнгө оруулалт буюу хасалт (written-off)-ыг хасаж тооцно.

Мэнэжментийн төлбөр нь анхны хөрөнгө оруулалтын туршид жилд 1.0% - 2.0% байх ба үүний дараагаас санг зогсоох хүртэл ихэвчлэн 0.5%-1.0% болж буурдаг. Өөр нэгэн судалгааны материалд[43], мэнэжментийн төлбөрийг үргэлж амласан хөрөнгийн (committed capital) тодорхой хувиар тогтоох (1%-3%) ба энэ нь хамтын ажиллагааны бүхий л үед хэвээр хадгалагдана, гэж заажээ. Нийтлэг зүйл гэвэл, мэнэжерүүд сангийн амжилтанд суурилсан урамшууллын төлбөр авдаг. Үүнийг “үүрэх сонирхол” (carried interest) гэж нэрлэдэг.[44]

Үүрэх сонирхлыг авахын тулд мэнэжерүүд тодорхой саадын хувийг (hurdle rate) давсан байх ёстой. Саадын хувийг жилийн өгөөж доод тал нь 8%-12% байхаар тогтоодог. Сангийн хөрөнгө оруулалтын ашгаас ихэвчлэн 20% хүртэл урамшуулал болгон мэнэжмент хийсэн компанид өгдөг. Үлдсэн 80%-ийг сангийн хөрөнгө оруулагч авдаг[45].

Европын холбооны 15 улсын хувираа аж ахуй эрхлэгч (enterpreneur) нарын дунд явуулсан судалгааны дүнг үзвэл, хувьцаат хөрөнгийн сангийн удирдлагыг гүйцэтгэж байгаа компани нь хязгааргүй хариуцлага хүлээж байхад хувь нийлүүлэгч зөвхөн гаргасан хөрөнгийн хэмжээгээр хязгаарлагдмал хариуцлага хүлээдэг байна. Хувьцаат хөрөнгийн компани нь дунджаар 6 - 8 мэнэжерээс бүрддэг, ихэвчлэн жижигхэн удирдлагын баг байдаг. Удирдлагын баг нь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд босгосон хөрөнгийн ойролцоогоор 1.5% - 2.0% авахаар мэнэжментийн гэрээ хийсэн байдаг[46].

ХЕЖ САН

Хеж сан (hedge funds) -гийн хувьд, мэнэжментийн төлбөрийг тухайн төлбөр хийгдэх үеийн сангийн өнөөгийн цэвэр өртгийн (net asset value), өөрөөр хэлбэл нийт оруулсан хөрөнгийн тодорхой хувиар тооцно. Төлбөрийн хэмжээ жилд 1%-4% байж болох ба 2%-ийг стандарт гэж үздэг.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[41] http://en.wikipedia.org/wiki/CalPERS Alternative Investment Program

[42] http://en.wikipedia.org/wiki/Private_equity_fund Private equity fund

[43] http://www.dallasfed.org/assets/documents/research/er/1998/er9803c.pdf The Economics of the Private Equity Market

[44] http://en.wikipedia.org/wiki/Carried_interest Carried interest

[45] http://en.wikipedia.org/wiki/Private_equity_fund Private equity fund

[46] http://www.evca.eu/uploadedFiles/Home/Toolbox/Introduction_Tutorial/EVCA_PEVCGUIDE.pdf Guide on Private Equity and Venture Capital for Enterpreneurs

ДҮГНЭЛТ

1. Хамтын сангийн хувьд, мэнэжментийн төлбөрийн хэмжээ дундаж цэвэр хөрөнгийн 0.6% - 0.7% -тай тэнцүү байдаг.
2. Хувьцаат хөрөнгийн компаний хувьд (хувьцаат хөрөнгийн сан), мэнэжментийн төлбөр оруулсан хөрөнгийн 1.0%-2.0%-ийн хооронд (гэхдээ 1% - 3% боломжтой) байдаг.
3. Үнэт цаасны багцын компаний хувьд (Хеж сан), мэнэжментийн төлбөрийг сангийн өнөөгийн цэвэр өртгөөс тооцох бөгөөд арай өндөр буюу 1% - 4% хооронд байдаг. Гэхдээ стандарт хэмжээ нь 2%.
4. Мэнэжментийн төлбөр ихэнхдээ төслийн бүх цаг үед тогтмол байдаг. Гэхдээ анхны хөрөнгө оруулалтын үе буюу эхний 4-6 жилийг дуусгаад цааших бүх хугацаанд 2 дахин багасдаг.

Зөвлөмж:

Оюутолгой компаний хувьд, мэнэжментийн төлбөрийг хувьцаат хөрөнгийн компанитай адилтган тооцох. Ингэхдээ анхны хөрөнгө оруулалтын үед үндсэн хөрөнгийн 2% -иас хэтрүүлэхгүй, хойших үед 1% байхаар (үйл ажиллагааны зардлаас огт тооцохгүй байхаар) тохирох нь зүйтэй.

* * *

Ашигласан материалын жагсаалт

- “Corporate income taxes, mining royalties and other mining taxes”, June 2012, Global mining industry update
- A Global Study of Their Impact on Investors,Government, and Civil Society, The World Bank, 2006
- Heinz P. Rudolph, “Fee structure: does it matter?” World Bank, January 9-11, 2012 “Report: current issues in the chilean mining sector” Sustainable Development Strategies Group
- Shareholders Agreement Among Government Of India And Sterlite Industries (India) Ltd And Bharat Alumunium Company Limited March 2, 2001
- Amended And Restated Shareholders Agreement By And Between La Generale Des Carrieres Et Des Mines And Lundin Holdings Ltd. Tembo Ltd. Faru Ltd. Mboko Ltd. Chui Ltd. Mofia Ltd. , Dated: 28 September 2005
- “Investment Management Fees Survey 2010”Lane Clark & Peacock LLP, 2010
- http://www.investopedia.com/terms/m/managementfee.asp
- http://www.fundlibrary.com/features/columns/page.asp?id=11752
- http://en.wikipedia.org/wiki/Investment_management
- http://www.investopedia.com/terms/m/managementfee.asp
- http://en.wikipedia.org/wiki/Management_fee
- http://blogs.cfainstitute.org/investor/2012/06/28/investment-management-fees-are-much-higher-than-you-think/
- http://boldsandagdorj.blogspot.com/2006/06/blog-post.html С.Болд-Эрдэнэ
- Оюу толгой төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээ /нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон/ 2011.06.08
- “Оюу Толгойн Хөрөнгө Оруулалтын Гэрээний Тухай Товч Танилцуулга”
- http://boldsandagdorj.blogspot.com/2006/06/blog-post.html С. Болд - Эрдэнэ.

* * *

ӨСӨН НЭМЭГДЭХ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, ДЭЛХИЙН УЛСУУДЫН ЖИШИГ
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Д. Мягмарцэрэн, Г. Гэрэл , Ч. Онончимэг

ОРШИЛ

Судалгааг УИХ -ын гишүүн Д. Ганхуягийн 2013 оны 2 -р сарын 06 -ны № 12/1037 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу хийж гүйцэтгэв. Судалгаанд Канад улсын Төрийн санхүүгийн ОУ-ын хүрээлэнгийн ерөнхийлөгч Робин Бродвэй, ОУВС-ын Төсвийн харилцааны газрын туслах захирал Майкл Кийн[47], ШУТИС -ын Геологи, Газрын Тосны Сургуулийн доктор (Ph.D) Б.Оюунчимэг нарын бүтээлийг ашиглав.

Олон улсын хэмжээнд эрдэс баялгийн салбарт түгээмэл хэрэглэгддэг эдийн засгийн ухагдахууны нэг нь “Mining royalty” буюу нөхөн сэргээгдэхгүй эрдсийг олборлож ашигласны төлөө тухайн этгээдээс өмчлөгч төрд төлж буй нөхөн төлбөр юм. Манай улсад уг төлбөрийг Ашигт малтмалын тухай хуульд зааснаар “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” гэж нэрлэдэг.

Энэхүү төлбөрийн тогтолцоог улс орнуудад янз бүрийн нөхцөлөөр хуульчилж уг төлбөрийг тухайн ашигт малтмал өмчлөгч улс орны Засгийн газарт төлөх нөхцөлтэй байх нь нийтлэг юм. Үүний улмаас тухайн улсын төсвийн бүрэлдэхүүнд энэхүү төлбөрийг бүртгэхдээ татварын бус орлогын ангилалд ихэвчлэн оруулдаг. Гэхдээ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (цаашид роялти гэх) нь хөрөнгө оруулагчийн хувьд татвар, эсхүл татварын бус төлбөр гэж нэрлэх нь ач холбогдол багатай бөгөөд түүний нэрнээс үл хамаарч хөрөнгө оруулагчдад тусах татварын дарамт, эдийн засгийн нөлөө нь ижил юм. Гагцхүү эрдэс баялгийн салбарын үйлдвэрлэлийн технологи, зах зээлийн нөхцөл байдал, эдгээрт хамааралтай бусад хүчин зүйлтэй уялдуулж уг татвар буюу төлбөрийн оновчтой түвшинг тогтооход асуудлын гол нь оршдог.

Судалгааны үр дүн:

Судалгаанаас үзэхэд, роялтийн хэмжээ нь тогтмол хувиар тооцогдох, эсхүл тодорхой нөхцлөөс хамаарч өсөн нэмэгдэх хэлбэртэй байна. Төлбөрийг ногдуулахдаа тухайн ашигт малтмалын лиценз эзэмшигч этгээдийн олборлолт явуулж борлуулалт хийсэн орлогоос, эсхүл нийт ашгаас, эсхүл борлуулалт хийсэн эсэхээс үл хамаарч гэрээнд заасан ашигт малтмалын олборлолтод шууд ногдуулдаг зэрэг олон хэлбэрээр үйлчилдэг бөгөөд эрдэс баялгийн салбар дахь татварын нэг гол төрөлд тооцогддог.

1. Эрдсийн тоо хэмжээ болон өртгөөс хамааралтай төлбөрийн давуу тал нь уул уурхайн компаниуд зардлаа зохиомлоор өсгөн мэдээлэх явдлыг хязгаарладаг, төлбөрийг үйлдвэрлэгчдээс цуглуулахад Засгийн газарт учирч болох эрсдэл бага байдагт оршдог.

   Гэхдээ төлбөрийн хувь хэмжээг хэт өндөр тогтоовол ордын захын агуулгыг оновчлоход чиглэгдсэн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, өндөр агуулгатай хүдрийг сорчилж ашиглах зүй бус үзэгдэлд түлхэц өгөх, хүдэр нь олон тооны ашигт эрдсийг агуулсан конгломерат бүтэцтэй, үндсэн болон дагалдах эрдсийг зэрэг агуулсан бол төлбөрийн хувь

[47] http://www.mining.mn/NewsDetails_2959.aspx

хэмжээг тооцоолоход хүндрэл гарах магадлалтай. Иймд эдгээр сөрөг үзэгдлээс хамгаалах цогц арга хэмжээг Засгийн газраас авах шаардлагатай байдаг.

2. Ашгаас хамаарах төлбөрийн давуу тал гэвэл Засгийн газар, хөрөнгө оруулагч эрсдэлээ адил тэнцүү хариуцах тул үйлдвэрлэгчийн хувийн хөрөнгө оруулалтад үзүүлэх сөрөг нөлөө бага, төлбөрийн хувийг тооцоолоход ашигт малтмалын төрөл, агуулга, боловсруулалтын түвшинг үндэслэх шаардлагагүй ба ашигт малтмалын төрөл бүрт ижил хувь тогтоож болдог. Сул тал нь үйлдвэрлэгч төлөх төлбөрийнхөө хэмжээг багасгахын тулд зардлаа зохиомлоор ихэсгэх хандлагатай болж, улмаар төлбөрөөс зайлсхийгчидтэй тэмцэх, төлбөрийг цуглуулах эрсдэл Засгийн газарт тулгардаг.

Нийтлэг ажиглагдаж буй нэг зүй тогтол бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа тохиолдолд роялтийн хувь харьцангуй бага, боловсруулалтын түвшин багатай буюу бүтээгдэхүүнийг түүхийгээр нь экспортолж байгаа тохиолдолд илүү өндөр байгаа явдал юм. Хөгжиж буй улсуудын хувьд өөрийн орны эдийн засагт голлох үүрэгтэй эрдэс баялгийн роялтийн хувь хэмжээг харьцангуй өндөр тогтоосон буюу цаашид ч нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна. Судалгааны хавсралтын хэсэгт эдгээрийг дэлгэрэнгүй хүснэгтээр харуулав.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Ашигт малтмалыг олборлох эсэх шийдэлд хүрэхэд түүнд үйлчлэх татварын тогтолцоо (түүгээр дамжиж ашигт ажиллагааны түвшинг тооцож тогтоох, хайгуулын болон уурхай, эрдэс баялаг олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн урьдчилсан тооцоог гаргах) нэн чухал нөлөөтэй билээ. Энэ төрлийн татвар - төлбөрийн гол нөлөө нь зөвхөн түүний тухайн үеийн түвшин, хэмжээ тодийгүй ирээдүйд үйлчлэх түвшин, нөхцөл, төлбөрийн горимоос хамаардаг. Тухайлбал, ашигт малтмалыг одоо олборлоод төлбөрийг мөн “өнөөдрийн нөхцөл”-өөр тооцож гүйцэтгэх, эсхүл олборлолтыг дараа явуулж түүнийг ирээдүйд ашиглахад ногдуулах төлбөрийг “өнөөдрийн нөхцөл”-өөр гүйцэтгэх зэрэг хувилбарууд бол эдийн засгийн агуулгаар эрс тэс ялгаатай бөгөөд “өнөөдрийн төлбөр”-ийн “маргааш”-ийн үнэ цэнэ нь ирээдүйнхээс өндөр, эсхүл доогуур болохыг нарийн тооцох шаардлага тулгардаг.

Эрдэс баялгийн салбар хөгжсөн болон хөгжиж байгаа улсуудын туршлагаас үзэхэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг олборлож ашиглаж буй эрдсийн тоо хэмжээ болон өртгөөс хамааралтай, ашгаас хамааралтай, хосолсон гэсэн 4 төрөлд хуваж болохоор байна.

1. Эрдсийн тоо хэмжээнээс хамааралтай төлбөр

Эрдсийн тоо хэмжээнээс хамааралтай төлбөрийг ихэвчлэн бага үнэ цэнэтэй барилгын материал олборлож ашиглах үед ногдуулдаг. Төлбөрийн дүнг тооцоолохдоо олборлож ашигласан барилгын материалын тонн тутамд төлөх (тухайн улсын валютаар тогтоосон) хэмжээг үндэслэнэ. Энэ хэмжээг металл бус эрдсийн үнийн индексийг харгалзан тогтмол шинэчилж байх шаардлагатай байдаг байна. Жишээлбэл, Австрали барилгын материал олборлож ашиглах үед ногдуулдаг төлбөрийнхөө хэмжээ (барилгын материалын зориулалтаар ашиглаж байгаа бол тонн тутамд 30 цент, металлургийн зориулалтаар бол 50 цент байсан)-г металл бус эрдсийн үнийн 1983-2003 оны индексийг харгалзан 2004 оноос жил бүр 8-10 орчим хувиар индексжүүлэн нэмэгдүүлсэн байна.

Австрали барилгын материалын эрдсийг ямар зориулалтаар олборлож ашиглаж байгаагаас нь шууд хамааруулан төлбөрийн хэмжээг ялгаатай тогтоосныг энд анхааралдаа авах хэрэгтэй юм. Хэрвээ эрдсийг барилгын материалын зориулалтаар ашиглах бол тонн тутамд 30 цент, металлургийн зориулалтаар ашиглах бол 50 центээр тогтоосноос үзэхэд металлургийн зориулалттай эрдсийн төлбөр 67 хувиар өндөр байна. Хэрэв хөрөнгө оруулагчдад ногдуулах роялтийн хэмжээг олборлох бүтээгдэхүүний нэгжид тооцож тогтоосон бол уг олборлолтод тухайн төрлийн төлбөр тодийлөн нөлөөтэй бус байх болно. Жишээ нь: олборлолт явуулсны дараах хугацаанд төлсөн роялтийн үнэ цэнэ нь уг олборлолтын цаг хугацааны нөхцөлд илүү тохиромжтой гэж үздэг. Харин тухайн ашигт малтмалын олборлолтын өмнөх “бараг цэвэр орлого” бүтээлтийн үе шатанд олсон орлогод ногдуулах татвар-төлбөр нь хэрэв зохистой түвшинд бол уг олборлолтын дараагийн үе шатанд тодийлөн сөрөг нөлөөлдөггүй.

Цөөн тохиолдолд роялтийн төлбөр ногдуулалт, хураалтын дээрх горимууд үйлчилдэг. Жишээ нь: роялтийг олборлолтын хэмжээнд тусгайлсан хязгаарлалт тогтоож, түүнд тогтмол түвшинт хэлбэрээр татвар буюу энэхүү төлбөрийг ногдуулах нөхцөлд олборлолтын хэмжээг урьдчилж тогтоолгох сонирхол олборлогчдод төрдөг. Энэ нь өнөөгийн нөхцөлөөр роялтийг төлөх нь ирээдүйн олборлолтын төлөө төлөх төлбөрийн өнөөгийн цэвэр үнэ цэнээс ихэвчлэн хямд тусах тал байгааг олборлогч мэдэрдэг. Нөгөө талаас, роялтийг өсөн нэмэгдүүлэх хэлбэрээр (борлуулалтын түвшнээс хамааруулж) тогтоох хууль тогтоомж үйлчилж байгаа нөхцөлд хэрэв зах зээлд тухайн төрлийн ашигт малтмалын үнийн өсөлт нь хүүгийн түвшнээс өндөр байгаа бол олборлолтыг хөрөнгө оруулагчид түргэтгэх хандлагатай байдаг.

Роялтийн дээрх нөхцөлүүд нь гол төлөв олборлолтыг түргэтгэж, уурхайг аль болох богино хугацаанд ажиллуулж тогтоосон хугацаанаас өмнө хаах сонирхлыг төрүүлсэн шинж агуулдаг. Нийгмийн хүлээлт бол тухайн олборлолтын ахиуц зардлыг богино хугацаанд нөхөхөд чиглэсэн байдаг атал хувийн салбарын хувьд олборлолтыг богино хугацаанд зогсоох бус, харин олборлолтын зардлыг ашигт малтмал ашигласны төлөө төлөх төлбөрийн хамт нөхөхүйцээр тухайн ашигт малтмалын үнэ зах зээлд өсөх хандлагыг ажиглаж хүлээлтийн байдлаар үйл ажиллагаа явуулах тал ч бий. Энэ практик үнэнийг уул уурхайн үйлдвэрлэлийн харилцааг зохицуулахтай холбогдсон аливаа орны хууль тогтоомжид харгалзан үздэггүй бөгөөд зарим тохиолдолд хэрэв олборлолт ашиггүй байдалд хүрвэл роялтийг халах, эсхүл түүнийг төлөх хугацааг сунгаж хойшлуулах заалтууд туссан байдаг тухай Отто нар (2006) судалгаандаа дурдсан байна.

2. Эрдсийн өртгөөс хамааралтай төлбөр

Энэ тогтолцоог дэлхийн олон улсад хэрэглэдэг. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг олборлож ашиглаж буй эрдсийн өртгөөс хамааруулан ногдуулах үед олборлож ашиглаж буй эрдсийн мөнгөөр илэрхийлсэн дүнд эзлэх хувь хэлбэрээр төлбөрийн хэмжээг тогтооно. Олборлож ашиглаж буй эрдсийн борлуулалтын хэмжээг уг эрдсийн олон улсын эсвэл холбогдох бусад зах зээлийн үнээр үржүүлж мөнгөн дүнг тооцоолно. Мөнгөн дүнг тухайн улс өөрийн валютад шилжүүлэхдээ Үндэсний төв банкныхаа тухайн үеийн ханшийг ашиглана. Төлбөрийн хувийг дэлхийн улс орнууд өвөрмөц онцлогт нийцүүлэн эрдсийн төрөл, баяжмал, металлаар гэх мэт ялгаатай тогтоодог байна. Жишээ нь: ӨБНАУ-д “Эрдэс баялаг, газрын тосны баялагийн төлбөрийн тухай” хуулийг 2010 оны 3 дугаар сарын 1-нээс дагаж мөрдөж эхэлсэн байна.

Энэ хуулийн дагуу эрдэс баялагийн хоёр жагсаалтыг үндэслэн төлбөрийн хувийг тусгай томьёогоор тооцох болжээ. Эхний жагсаалтад нь цэвэр металлуудыг оруулсан бөгөөд тэдгээрийн хувьд төлбөрийн хэмжээ нь 5 хувиас, харин хоёрдугаар жагсаалтад оруулсан төрөл бүрийн хүдрийн хувьд төлбөрийн хэмжээ 7 хувиас хэтрэх ёсгүй ажээ. Тайландад зэсийн хүдрийнх 10 хувь, кварц, каолинит, фосфат зэрэг эрдсийнх 4 хувь, цэвэр зэс, цайрынх 2,5 хувь гэх мэтээр ялгаатай тогтоосон байна. Казахстанд газрын тосных 2-6 хувь, гүний усных 10 хувь, барилгын материалынх 1-4,5 хувь байна.

3. Ашгаас хамааралтай төлбөр

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг уул уурхайн компанийн цэвэр ашгийн хувь хэлбэрээр тогтоосон бол ашгаас хамааралтай төлбөр гэнэ. Төлбөрийн ийм тогтолцоотой орнуудын тоонд Канад, Австралийн хойт бүс нутаг орно. Австралийн хойт бүс нутагт ашгаас хамааралтай төлбөрийн хэмжээ 18 хувь байдаг бол Канад улсад муж бүрээр ялгаатай байна. Жишээлбэл, Канадын Квебек мужид 20 хувь, Онтарио мужид 18 хувь, Британш Колумб мужид 15 хувь байдаг.

Роялтийг ашигт суурилж тогтоосон аргыг боловсронгуй болгоход Засгийн газарт дараах гурван давуу байдлыг хадгалах ёстой гэж үздэг. Нэгд, юуны өмнө ашигт малтмалын төлбөр ногдуулах, хураах тогтолцоо, горим энгийн бөгөөд хялбар ойлгомжтой байх хэрэгтэй. Жишээ нь: газрын тос, байгалийн хий олборлох, үйлдвэрлэхэд ногдуулах төлбөрийг оновчтой тодорхойлохын тулд тэдгээр бүтээгдэхүүнийг хэмжих хэмжүүрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэж, энэ талаар урьдаас бэлтгэл хангасан байх шаардлага тавигддаг. Эрдэс баялгийн бусад төрөлд бол тоо хэмжээ болон үнэлгээг тогтоож хэмжих ажиллагаа үүнээс хялбар дөхөм байх талтай. Ашигт малтмалын төлбөрийн тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах нь чухал.

Хоёрт, роялтинаас бүрдэх орлогын өгөөжийг тухайн олборлолт, үйлдвэрлэлийн анхны үе шатнаас нь эхэлж тооцох нь зүйтэй. Мэдээж, үйлдвэрлэгчийн зүгээс Засгийн газарт энэ төлбөрөөр оруулах орлого нь эхний шатанд харьцангуй өндөр санагдаж, үйлдвэрлэлийн зардлын зохих хэсгийг эзлэх боловч хожим төлөлт хийх үед түүний өнөөгийн үнэ цэнэ нь ямар түвшинд байх судалгаа, ирээдүйд хүлээгдэх харьцангуй өгөөж ба алдагдлын тооцоог мэргэжлийн үүднээс хийх ёстой. Ашигт малтмал олборлогч гадаадын этгээд төсөвт ямар нэг төлбөр урьдчилж төлөхгүйгээр мөн ямар нэг олборлолт явуулж эхлэх ёсгүй гэсэн улс төрийн бодлого үйлчилж байж болно.

Гуравт, роялти нь зарим тохиолдолд тогтвортой бөгөөд төсвийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн татварын өмнөтгөл суурь болж байх. Гэхдээ ашигт малтмал ашиглалтын төлбөрийг олборлолтын үе шатуудын явц дунд өөрөөр хэлбэл, “бараг цэвэр орлого”-ын гэж нэрлэгддэг хайгуулын ба уурхай барьж байгуулах үе шатыг бүхэлд нь хамруулж үйлчилдэг талаас нь авч үзвэл эрдэс баялаг олборлолтын шийдэл гаргахад ямар ч тохиолдолд энэ нь хөрөнгө оруулагч, олборлогчид давуутай тал, дэвшилттэй нөхцөлийг бүрдүүлдэггүй гэж судлаачид үздэг.

4. Хосолсон төлбөр

Австрали улсад алмазын нөөц ашигласны төлбөр ногдуулахад эрдсийн өртгөөс болон компанийн ашгаас хамааралтай төлбөрийн хоёр өөр тогтолцоог хослуулан хэрэглэдэг нь эрдэс баялгаас хүртэх улсынхаа хувийг баталгаажуулахад чиглэгдсэн Засгийн газрын хамгаалалтын арга хэмжээ юм. Энэ хосолсон тогтолцоо ёсоор алмаз олборлох төсөл хэрэгжих нийт хугацаанд олох ашгаас 22,5 хувийн төлбөр авах бөгөөд жил тутам ногдуулах төлбөрийн хэмжээ нь 7.5 хувиас бага байх ёсгүй.

Дээр дурдсан дөрвөн тогтолцооноос гадна гэрээгээр тохиролцож тогтоох аргыг бас хэрэглэдэг. Жишээлбэл, Аргентин, Казахстан, Гренланд зэрэг улс зарим ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээгээр тохиролцож тогтоодог байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тогтолцооны давуу ба сул тал, чиг хандлага

Роялтийн гол чиг үүрэг нь юу вэ? тэрхүү төлбөрийг бүтээгдэхүүнд нь үү, эсхүл түүний үнэ цэнд нь тохируулж ногдуулж байна уу? ашигт малтмалд ногдуулах татварын сайн жишгийг хэрхэн бий болгох вэ? Роялти нь зарим тохиолдолд үр ашигтай хэрэглээг зохицуулах хэрэгсэл болж байдаг. Жишээ нь: хөрөнгө оруулагч талд энэ төлбөрийн түвшин оновчгүй гэж үзвэл түүнд зохих хямдруулалт тогтоох нөхцөл үйлчилж болно. Гэтэл энэхүү хөнгөлөлтийн түвшинг үндэслэлгүй өндөр тогтоовол хөрөнгө оруулагч тал уг ашигт малтмалын нөөцийг аль болох богино хугацаанд олборлож шавхахыг хичээх тал гарна.

Иймд хөрөнгө оруулагч-олборлогч талууд роялтийг өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний түвшинг хадгалж, аль болох доогуур тогтоолгох арга замыг сүвэгчилж янз бүрийн шалтгаан дурдах нь түгээмэл үзэгдэл болов. Ерөөс роялти тогтоолт нь ихээхэн эмзэг, мэдрэмж дагуулсан асуудал бөгөөд хэрэв түүнийг буруу (хэт доогуур, эсхүл үл хувьсах нэг түвшинт буюу тогтмол дүнгээр) тогтоовол олборлогч тал тухайн эрдэс баялаг олборлолтын эрхийг ашиглаж хязгаргүй хэмжээнд сорчилж, эсхүл өөрийн бүх хүч чадлаас давуулж олборлолт явуулснаар ашигт малтмалын үнэ нь түүний олборлолтод ногдох ахиуц зардлыг хаах төдий хэмжээнд нэрлэсэн үнэлгээгээр илэрхийлэгдэх нөхцөл байдал үүсч, үүний улмаас роялти төлөх боломжгүйд хүрэх, эцэст нь уг төлбөрийг төлөхөөс зайлсхийх, эсхүл түүний ирээдүйд тогтох өнөөгийн цэвэр үнэ цэнийг үл хайхарч олборлуулагч талд бодит алдагдал үүсгэх нөхцөл байдал үүсдэг.

Ийнхүү богино хугацаанд “амжуулах” сэтгэхүйд хөтлөгдөж илүүдэл олборлолт явуулсны улмаас ашигт малтмалын ирээдүйн олборлолтын боломжит зардлын төвшний өнөөгийн үнэ цэнээр тооцсон хэмжээг өндөрсгөхөд хүргэдэг. Иймд ашигт малтмал олборлолтыг тогтвортой түвшинд жигд байлгах нь гэрээний хугацаанд олборлолт, боловсруулалтын үе шатыг дэс дараатай, мөн тогтвортой явуулах, эрдэс баялгийн үнийн түвшинг харьцангуй тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлэхийн сацуу олборлогч тал нь үйлчилж байгаа гэрээг дуусгавар болгох төгсгөлийн шатанд ирээдүйн олборлолтын аргын талаар анхаарч урьдчилсан зэхэлт хийх боломжийг олгодог.

Ашигт малтмал олборлолтыг илүү үр ашигтай болгох арга замыг хайхдаа олборлолтын гэрээний төгсгөлийн хугацаанд тухайн ашигт малтмалын олборлох нөөц шавхагдах төгсгөлийн үе шат ойртох тутам уг эрдэс баялгийн үлдэж байгаа хэсгийн ахиуц үнэ цэнэ нь гэрээний нөхцөлийн дагуу нэмэгдэж, түүний олборлогдсон нэгж бүрд ногдох татварын ирээдүйн үнэ цэнэ өсөн нэмэгдэх хандлагатай болж ирдэг.

Үүнээс үзвэл роялтийн эдийн засгийн агуулга, түүний өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь тухайн хөрөнгө оруулагчийн аль хир урт хугацаанд олборлолт явуулах нөхцөлөөс хамаардаг нь харагдана. Хэрэв гэрээт хугацаанд олборлохоор уг талбайд тогтоосон нөөцийг гэрээний дагуу олборлож дуусаагүй бол тэрхүү нөөцийн үлдэх хэсгийг олборлолтын өнөөгийн боломжит үнээр нь тооцож худалдан борлуулах нөхцөлийг гэрээнд тусгасан байж болно. Энэ тохиолдолд өмнөх хөрөнгө оруулагч-олборлогчтой байгуулсан гэрээнд заасан роялтийн түвшинд өөрчлөлт оруулахгүйгээр тухайн гэрээгээр үйлчилж ирсэн нөхцөлийг хадгалах нь зохистой гэж үздэг.

Ашигт малтмал ашиглалтын төлбөр нь улс орон бүрийн практикт өөр өөр агуулгатай байх ба тухайлбал: Чили болон ӨАБНУ-д уул уурхайн ашигт малтмалын олборлолтод ногдуулах төлбөр нь (гол төлөв олох ашигтай уялдсан байх жишээтэй) хатуу нөхцөл заасан бус агуулгатай байхад Дани улсад газрын тос, байгалийн хий олборлолтод, эсхүл Англид (2002 оноос эхэлж) мөн газрын тосны олборлолт, үйлдвэрлэлд гол төлөв тухайн ашигт малтмалын үйл ажиллагаа хэрхэн явагддагтай шууд холбогдолгүй байдлаар роялти ногдуулалт, хураалтын тогтолцоо үйлчилдэг байна.

Эдгээрийн эерэг ба сөрөг нөлөөллийг авч үзвэл:

- Роялтийн өсөн нэмэгдүүлэх горим бүхий болон тусгай нөхцөлт хэлбэрүүд нь цаг хугацааны ялгаатай нөхцөлүүдэд ч мөнгөний үнэ цэнэ талаасаа гол төлөв тэнцүү шинж чанар агуулж байдаг.
- Үнэ тогтоох суурь нь өөр өөр байх нь роялтийг уурхайн хүдрийн үнэ цэнд, эсхүл хайлуулалтын цэвэр орлого (үйлдвэрлэлийн өртөгт түүхий эдийн цэвэршүүлэлт болон хольцоос ялгаж цэвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ цэнэ)-д, эсхүл экспортын нөхцөлд гарах тээврийн болон холбогдох бусад зардлыг тооцсон үнэ цэнд суурилж тогтооход хүргэдэг. Отто нар (2006) ашигт суурилсан бус нөхцөлөөр тооцсон ашигт малтмалын төлбөрийн түвшин нь нийт татварт эзлэх хувийн жингээр 2.75 - 3.45 хувь хооронд хэлбэлздэг бөгөөд энэ нь татварын суурийг хэрхэн тогтоосноос хамаардаг тухай тэмдэглэжээ.
- Роялтийн түвшний ийнхүү ялгаварт байдал ба хэлбэлзэл нь мөн өөрийн өвөрмөц төрх байдал, тэдгээрийн үйлчлэлийн үр дагавартай холбоотой байдаг. Жишээ нь: цэвэршүүлсэн уул уурхайн бүтээгдэхүүнд ногдуулах тусгай татвар нь олборлогдож байгаа ашигт малтмалын ашигтай агуулгын зэргээс хамаардаг (учир нь ашигт элементийн агуулга өндөртэй хүдрийн олборлолтод ногдуулах төлбөр нь энгийн буюу түүнээс доогуур агуулга бүхий хүдрийнхээс харьцангуй өндөр байх шаардлагатай) нөхцөлийг эвдэхгүй бөгөөд жишээ нь энэ нөхцөл газрын түүхий тосонд хамаарахгүй (учир нь газрын түүхий тосны хувьд хүдрийн агуулга, чанараас ашигт малтмал олборлосны төлбөрийн түвшин тогтоолтын арга энд холбогдолгүй) байж болно.
- Роялти тогтоолтод нөлөөлөх хүчин зүйлийн бүтэц бүрэлдэхүүн нь өөр хоорондоо шугаман бус хамааралтай байх ба уг төлбөрийн түвшин, хэмжээ нь харин гол төлөв олборлолтын тоо хэмжээ, тухайн олборлогдож байгаа эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнээс хамааралтай бөгөөд цаг хугацааны зарим мөчлөгт тэдгээрийн үнэ огцом унаж, олборлолт, үйлдвэрлэлд цочрол өгдөг тул төсвийн бүтэцчилсэн болон эдийн засгийн төлжилтийн үнэлгээ хийх замаар тогтвортой байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь Засгийн газруудын бодлогын нэг томоохон хэсэг байдаг.
- Эрдэс баялгийн төрөлд ногдуулах роялтийг нэгэн түвшнээр, эсхүл тухайн эрдэс баялгийн нэр төрөл ба түүний агуулгаас хамааруулж ялгаатай тогтоох практик бий. Энэ нь төлбөр ногдуулалт, хураалтыг хялбаршуулах захиргаа удирдлагын талаас хийгээд улс төрийн бодлого, Засгийн газрын ба улс төрчдийн тусгайлсан зорилт, амлалтыг хэрэгжүүлэх нөхцөл байдлын нөлөө зэргээс ч хамаардаг.

  Гэхдээ ашигт малтмал ашиглалтын төлбөрийг ийнхүү ялгавартай тогтоох үндэслэл нь өнөөг хүртэл нэлээд бүрхэг асуудал хэвээр байна. Хэрэв ашигт малтмал ашиглалтын төлбөрийг дэлхийн зах зээлийн үнийн түвшнээс гол төлөв хамааруулж тогтоож байгаа бол энэ нь тэдгээр төрлийн ашигт малтмалын эрэлт нийлүүлэлтэд түлхүү тулгуурлаж, уг төлбөрийг тогтоох эдийн засгийн үндсэн шинж чанарыг харуулж, тухайн бүтээгдэхүүнд эрдэс баялаг олборлох төлбөрийн түвшинг өөр өөрөөр тогтоох гол үндэслэл нь гэж үзэж болох юм. Гэхдээ дээрх төлбөрийг эрэлт нийлүүлэлтэд үндэслэх зорилго агуулсан ийм хандлага нь тун ховор тохиолддог.

  Хэрэв роялтийг ирээдүйн татварын төлбөрийн агуулгаар авч үзвэл бүтээгдэхүүн гаргах, ашигт ажиллагааны түвшний цаг хугацааны үечлэлтэй уялдуулах хэрэгтэй бөгөөд энэ нь эцсийн дүнд тухайн эрдэс баялгийн нэр төрөл, агуулга, ордын тогтоц ба уул геологийн нөхцөлөөс хамаарах ёстой болно.

  Роялтийг ялгавартай өндөр түвшинд тогтоох практик ихэвчлэн эрдэнийн чулууны хамгийн гол төрөл болох бадмааранг үнэт чулуунд нийтлэг хэрэглэгддэг бөгөөд олборлолтын үлдэц цэвэр орлогын татварын төрөл үйлчилдэг. Хэрэв ашигт малтмал ашигласны ялгаварт төлбөрийг тогтоохдоо алдаатай буруу тооцоолол хийвэл тэгш түвшинт төлбөрийн чиг үүргийг үгүйсгэхийн сацуу ялгаварт татварын үйлчлэлийг сулруулах болно.
- Роялтийн түвшинг хэрэв ашигт суурилсан нөхцөлөөр тогтоовол орлого нь зарим төрлийн зардлын түвшнээс доогуур байх практик гарах тохиолдолд нийт борлуулалтын дүнд орлогын эзлэх хувийг харьцуулж уг төлбөрийг өсгөн нэмэгдүүлсэн аргад үндэслэн тооцох зарчим үйлчилнэ.

  Энэ нь тухайн төлбөрийг бүтээгдэхүүнд суурилсан нөхцөлөөр тогтоох аргатай ижил төстэй бөгөөд нэг талаас Засгийн газар татварын тогтвортой байдлыг хадгалах, нөгөө талаас, хөрөнгө оруулагчийн зүгээс төсвийн орлого бүрдүүлэлтийн хооронд итгэлцлийг бэхжүүлэхэд тийм ч сайн нөлөө үзүүлдэггүй. Ашигт малтмалын төлбөрийн түвшинг ашигт суурилан тогтоох арга нь хөрөнгө оруулагчдын өнөөгийн практикт бусад аргаас илүү зохистой хэлбэрт тооцогддог.

* * *

(Хавсралт хүснэгт)

Хөгжиж буй улсуудын хувьд өөрийн орны эдийн засагт голлох үүрэгтэй эрдэс баялгийн хувьд төлбөрийн хувь хэмжээг харьцангуй өндөр тогтоох хандлага ажиглагдаж байна.

Д/д	Улс	Эрдэс баялаг	Хувь хэмжээ
1	Ботсвана	Үнэт чулуу	10 %
		Нүүрс ба үнэт металл	5 %
		Бусад	3%
2	Мозамбик	Алмаз	10-12%
		Нүүрс болон бусад	3-8%
3	Сьерра Леон (2009 онд Ашигт малтмалын хуулиа өөрчлөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн)	Алмаз	5%-иас 6,5%
		Алт болон бусад	4% -иас 5%
4	Энэтхэг (2009 онд төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэн)	Төмрийн хүдэр	тонн бүрт 27 хүртэл рупий төлдөг байсныг 10 %
		Цайрын хүдэр	6.6 %-иас 8 %
		Зэсийн хүдэр	3.2 %-иас 4.2 %
		Хар тугалга	5 %-иас 7 %

Төлбөрийн хэмжээ тодорхой эрдсийн хувьд ямар хэлбэлзэлтэй байгааг зэс ба нүүрсний хувьд авч үзье.

UNAM
СУДАЛГААНЫ САН

Зэс:

Борлуулалт бүүр өртгөөс хамаарууллан ногдуулдаг улсууд	ОХУ	Австрали	Узбекистан	Ботсвана	Мозамбик	Лесото	Малави	Зимбабве	Гана
роялти	8%	5-7,5%	7,9%	3-10%	3-10%	5-10%	5-10%	2-10%	3-12%

ашгаас хамааралтай төлбөр ногдуулдаг Канадын мужууд	Квебек	Онтарио	Бритиш Колумб
роялти	20%	18%	15%

Нүүрс:

Улс орнууд	Австралийн Квийнсланд	Австралийн Өмнөд Шинэ Уэлс	ОХУ	Ботсвана	Тайланд	ӨАБНУ	Индонези
роялти	100 австрали доллар/ тонноос бага бол 7 %, 100 австрали доллар/ тонн-оос давсан хэсэгт 10 %,	ил уурхай бол 8,2 %, далд уурхай бол 7,2 %, их гүний далд уурхай бол 6,2 %	4 %	5%	4 %	7 %	13,5 %

Зэс ба нүүрсний хувьд төлбөрийн хувь хэмжээ ийнхүү янз бүр байгаа бөгөөд тухайн улсын эдийн засагт гүйцэтгэж байгаа үүрэг нь харьцангуй их улсуудад уг төлбөрийн хувь хэмжээ харьцангуй өндөр, түүний хувь хэмжээг нэмэгдүүлэх хандлага ажиглагдаж байна. 2012 оны 6-р сард www.pwc.com дэлхийн улс орнуудын уул уурхайн татварын хувь хэмжээнүүдийг шинэчлэн оруулсан хүснэгтийг англи хэл дээр хавсаргав.

Level	Mineral tax name	country
Provincial	Provincial mining royalties	Argentina
1: State 2:Federal	1:State Royalties 2: Minerals Resource Rent Tax (“MRRT”)	Australia
Federal	Specific Mining Tax	Chile
1:Federal 2:Federal 3:Federal	1:Resource Tax 2:Compensation For Mineral Resource 3:Royalty fee of Exploration Right	China
1:State 2:State	1:Royalty 2:Deadrent	India
1: Regional Government 2:Central Government 3:Central Government	1:Mining Royalty 2:Special Mining Tax 3:Special Mining Contribution	Peru
3:Federal 4:Federal 5:Federal	3:Excise tax 4:Royalties to mineral reservations 5:Royalties to indigenous cultural communities	Philippines
Federal	Mining and Petroleum Resources Royalty (“MPRD”)	South Africa
1:Federal 2:Federal	1:Charge for use of subsoil 2:Pollution tax	Ukraine
3:Federal 4:State 5:State	3:Federal Land Royalty 4:Nevada Net Proceeds Tax 5:Other State Severance Taxes	United States

Rates				Basis
Coal	Iron ore	Gold	Copper	
3.0%	3.0%	3.0%	3.0%	Mine head value
1:7.0% - 10.0% 2:22.5%	1:6.5% - 7.5% 2:22.5%	1: 0% - 2.5% 2: N/A	1: 2.7% -3.5% 2: N/A	Volume of minerals extracted 2: Mining profi t
0% - 14.0%	0% - 14.0%	0% - 14.0%	0% - 14.0%	Adjusted PBT
1:RMB 2 -RMB 8 per tonne 2:0.5%-4.0% 3:	1:RMB 10-RMB 25 per tonne 2:0.5%-4.0% 3:	1:RMB 1.5 -RMB 7 per tonne 2:0.5%-4.0% 3:	1:RMB 5 -RMB 7 pertonne 2:0.5% -4.0% 3:	1:Units produced (weight) 2:Revenues (Turnover) 3:Mining area
1:INR55 +5.0%(P) -INR 130 +5.0%(P) 2:INR 1,000/ Ha	1:10.0% 2:INR 1,000/Ha	1:2.0% 2:INR 4,000/Ha	1:4.2% 2:INR 3,000/Ha	1:Units produced 2:Area of mine
1:1.0% -12.0% 2:N/A 3:N/A	1:1.0% -12.0% 2:2.0% -8.4% 3:4.0% -13.12%	1:1.0% -12.0% 2:2.0% -8.4% 3:4.0% -13.12%	1:1.0% -12.0% 2:2.0% -8.4% 3:4.0% -13.12%	1:PBT 211 2:PBT 211 3:PBT 211
3:PhP 10.00/ metric tonne 4:min. 5.0% 5:as agreed	3:2.0% 4:min. 5.0% 5:as agreed	3:2.0% 4:min. 5.0% 5:as agreed	3:2.0% 4:min. 5.0% 5:as agreed	3:Market Value 4:Market Value 5:As agreed; min of 1% gross output
0.5% - 7.0%	0.5% - 7.0%	0.5% -5.0%	0.5% - 7.0%	Adjusted revenues
UAH 0.57 -5.33/ tonne depending on quality of ore	UAH 0.89 -11.45/ tonne depending on quality of ore	UAH 15.98/ tonne extracted	According to rate of a main material	1:Units produced 2:Units produced
3:8.0 %-12.5% 4:2.0% - 5.0% 5:2.0% - 5.0%	3:0% 4:2.0% - 5.0% 5:2.0% - 5.0%»	3:0% 4:2.0% - 5.0% 5:2.0% - 5.0%	3:0% 4:2.0% - 5.0% 5:2.0% - 5.0%	3:Revenues (Turnover) 4:Adjusted PBT 5:Adjusted PBT

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3
БҮЛЭГ

НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТЭТГЭВРИЙГ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НЬ ӨВЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРМЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЗОХИЦУУЛАЛТ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Товуусүрэн, А. Пагма, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн С. Эрдэнийн захиалгаар Тэтгэврийг гэр бүлийн гишүүдэд нь өвлүүлэх нөхцөл, журмын талаарх бусад орнуудын зохицуулалт харьцуулсан судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын гэр бүлийн болон түүний дотор 10-аас дээш жил хамтран амьдарсан гэр бүлийн тоог статистик бүртгэлийн материалд үндэслэн тооцож гаргах, гадаадын зарим улс орнуудад тэтгэврийг өвлүүлдэг туршлагыг харьцуулан дүн шинжилгээ хийж, цаашид энэ талаар бодлого боловсруулахад баримтлах чиглэлийг тодруулахад оршино.

Судалгааны зорилтууд.

- Монгол Улсын гэр бүлийн статистик, түүний дотор 10-аас дээш жил хамтран тогтвортой амьдарсан гэр бүлийн тоог тооцон гаргах.
- Гадаадын зарим орнуудад өндөр насны тэтгэврийг гэр бүлийн гишүүдэд нь өвлүүлдэг туршлага, нөхцөл, журмыг судлах, харьцуулан дүн шинжилгээ хийх

Судалгааны аргачлал.

- Гэр бүлийн статистик тоо баримтыг үндэслэн 10-аас дээш жил хамтран тогтвортой амьдарсан гэр бүлийн тоог тооцож гаргах
- Гадаадын зарим орнуудад тэтгэврийг өвлүүлдэг нөхцөл журмын талаарх материалыг нэгтгэн харьцуулалт, дүн шинжилгээ хийх

Судалгааны үр дүн

- Монгол Улсын гэр бүлийн статистик тоо баримтыг Улсын бүртгэлийн газар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан баримтат тулгуурлан гаргаж, боловсруулалт хийж, 10-аас дээш жил хамтран тогтвортой амьдарсан нийт гэр бүлийн тоо, бэлбэсэн гэр бүлийн тоог гаргах\
- Өндөр насны тэтгэврийг өвлүүлдэг гадаадын улс орнуудын туршлагыг судалснаар тэтгэврийн тогтолцоог шинэчлэх бодлогыг тодорхойлоход анхаарвал зохих асуудлыг тодруулах

Судалгааны дүгнэлт.

- Гадаадын зарим улс орнуудын тэтгэврийн тогтолцоог судалж үзэхэд тэтгэврийг өвлүүлэх асуудал хэд хэдэн хүчин зүйлээс хамаардаг байна. Үүнд:
  - Тэтгэврийн тогтолцоо хуримтлалынх уу, хуваарилалтынх уу, хуримтлал, хуваарилалт хосолсон уу
  - Тэтгэврийг нэг удаа бөөнөөр нь олгох уу, амьд байх хугацаанд нь олгох уу, төлөвлөгөөт хасалт хийж олгох уу

Эх газрын буюу хуваарилалт /Бисмаркын/ -ын тогтолцоотой улс орнуудаас Италид тэтгэврийг өв залгамжлуулдаг боловч, улс орны эдийн засгийн хямрал, өндөр настан

хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь нэмэгдэж, нэг ажиллагчид ногдох тэтгэврийн хүний тоо 3 -д хүрсэн зэргээс шалтгаалан тэтгэврийн сан хүрэлцэхгүй хямралт байдалд орсон байна. Цэвэр хуримтлалын тогтолцоотой болон хуримтлал, хуваарилалт хосолсон тогтолцоо бүхий улс орнуудад ихэвчлэн тэтгэврийн сангийн хуримтлалын хэсгээс олгогдоогүй үлдсэн мөнгийг өв залгамжлуулах эрх үүсч, иргэний болон бусад хуулийн дагуу түүнчлэн даатгагч, даатгуулагчийн хооронд байгуулсан гэрээгээр мөн гэрээслэлээр зохицуулдаг байна.

Тэтгэврийг тавьж олгох хэлбэрээс шалтгаалан бөөнөөр нь буюу бүх насаар нь тэтгэвэр тавьж олгох хэлбэрийг хэрэглэж байгаа тохиолдолд тэтгэврийг өвлүүлэхгүй байх, харин тэтгэврийг төлөвлөгөөт хасалтын аргаар тавьж олгож байгаа тохиолдолд тэтгэврийн олгогдоогүй үлдэгдлийг өвлүүлэх эрх үүсэх нь зөв гэж үздэг байна.

Нэг. Гэр бүлийн талаарх мэдээлэл.

Хүн ам зүйн шинжлэх ухаанд гэр бүл гэдэг нь гэр бүл болох, салах, бэлэвсрэх, тусгаарлах, дахин гэр бүл болох гэсэн ухагдахууныг цогцоор илэрхийлдэг ойлголт юм. Эдгээр үзүүлэлт гэрлэлт гэсэн ойлголтыг тал бүрээс нь тодорхойлон гаргадаг. Монгол Улсын 1999 оны 6 дугаар сарын 11 -ний өдөр батлагдсан “Гэр бүлийн тухай” хуульд “Гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрх, үүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дүнд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм” гэсэн байна. Гэр бүл болох нь хүмүүс гэр бүлээ албан ёсоор бүртгүүлэх явдлаар илэрнэ.

1960-аад оноос эхлэн төрөөс хүн ам, нийгэм эдийн засгийн талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гэр бүлгүй хүн амын тоо багасаж, хүйсийн харьцаа тодорхой хэмжээгээр тогтворжих хандлага ажиглагдаж эхэлсэн байна. Судалгааны сэдвийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, хүн ам орон сууцны 2000, 2010 оны улсын тооллогын дүн, МУИС -ийн ЭЗС -ийн Статистикийн тэнхимийн судалгааны ажлыг судалгаа мэдээллийн эх сурвалж болгон ашиглав. 1979 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 65.4 хувь нь гэр бүлтэй байсан бол 1989 онд 65.8 хувь, 2000 онд 57.8 хувь, 2010 онд 60.1 хувь болжээ.

2010 оны тооллогын дүнгээс харахад Монгол Улсын нийт хүн амын 69.2 хувь **(1905969 хүн**) арван тав, түүнээс дээш насны хүн ам байна. Эдгээр хүмүүсийн **31.3** хувь нь огт гэр бүл болоогүй, **60.1** хувь нь гэр бүлтэй (батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийг оруулсан), **3.1** хувь нь салсан (гэр бүлээ цуцалсан болон тусгаарласан хүмүүсийг оруулсан), **5.5** хувь нь бэлбэсэн байна. Арван тав, түүнээс дээш насны нийт хүн амд эзлэх батлуулсан, батлуулаагүй гэр бүлийн хүн амын хувийн жин 2000 онд 57,8 хувиас сүүлийн 2010 оны тооллогоор 60,1 хувь болж өссөн байна.

Хүн амын тооллогын статистик мэдээлэлд өрхийн тоон мэдээлэл гардаг ч энэ нь:

1. Ганц бие өрх
2. Ам бүлээрээ өрх
3. Нийлмэл өрх
4. Холимог өрх –ийг хамруулсан байдаг учраас гэр бүлийн тоон үзүүлэлт болж чадахгүй байна.

Иймээс /хүснэгт 1/ -т тусгагдсан гэр бүлээ батлуулсан болон батлуулаагүй эрэгтэй эмэгтэйн тооны аль ихийг нийт гэр бүлийн тоонд тооцож үзвэл 2000 онд 442229 батлуулсан болон батлуулаагүй гэр бүл байна. 2000 оны хүн амын тоологоор бүртгэгдсэн гэр бүлийн нийт тоо нь 10-аас дээш жил хамтран амьдарсан нийт гэр бүлийн тоог ерөнхийд нь илэрхийлэх боломжтой бөгөөд 10 -аас дээш жил хамтран амьдарсан гэр бүлийн тоог нарийвчлан гаргая гэвэл үүнд багагүй цаг хугацаа шаардагдах бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

газарт тусгайлан үүрэг даалгавар өгч, иргэний регистрийн дугаараар хөөж гаргуулах хэрэгтэй гэсэн саналыг тус газрын мэргэжлийн хүмүүс нь тавьж байна.

Харин тэтгэврийг өвлүүлэхэд хамаарах нийт 104897 гэр бүл 2010 оны тооллогоор тоологджээ. Үүнээс эрэгтэй 20620, эмэгтэй 84277 гэр бүл байна. Нийт 104897 гэр бүлээс 10-аас дээш жил хамтран амьдарсан гэр бүл хэд байгааг мөн регистрийн дугаараар хөөж нарийвчлан гаргах шаардлагатай. Харин тэтгэврийг өвлүүлэх талаар шийдвэр гаргасан тохиолдолд гэр бүл болсноо хугацаа алдахгүй бүртгүүлэх, гэр бүл тогтвортой байх хөшүүрэг болж чадахаар байна.

(Хүснэгт 1)

- **Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг хувиар, 2000, 2010 он.**

Насны бүлэг 15+	Бүгд		Гэр бүлийн байдал							
	Тоо	Хувь	Огт гэр бүл болоогүй		Батлуулсан, батлуулаагүй гэр бүлтэй		Цуцалсан, Тусгаарласан		Бэлбэсэн	
• 2000 он										
Эрэгтэй	749890	100	36,6	274460	58,5	438686	2,1	15748	2,8	20997
Эмэгтэй	774482	100	29,7	230021	57,1	442229	3,3	25558	9,9	76674
• 2010 он										
Эрэгтэй	937271	100	34,4	322421	60,7	568923	2,7	25307	2,2	20620
Эмэгтэй	968698	100	28,2	273173	59,6	577344	3,5	33904	8,7	84277

* * *

Хоёр. Гадаадын зарим улсын тэтгэврийн тогтолцооны шинэчлэл.

Судалгааны явцад дэлхийн олон улс оронд ялангуяа уламжлалт хуваарилалтын тогтолцоотой улс орнуудад 1990-ээд оноос эхлэн хүн амын хөгшрөлтийн явц түргэсч, нэг ажиллагчид ногдох тэтгэвэр авагчдын тоо хурдацтай өсөх хандлага хүчтэй болсон.

Дэлхийн банкнаас 1994 онд “Дэлхийн хөгшрөлтын хямралаас сэргийлэх нь” (AVERTING THE OLD AGE CRISIS) сэдэвт илтгэлийг нийтлүүлснээр энэ талаар өргөн хэлэлцүүлэг эхэлжээ. Энэхүү илтгэлд олонх улс орнуудад тэтгэвэрийнхний насжилт уртасч, үе дамжуулан санхүүжих хуваарилалтын зарчимд суурилсан тэгэврийн тогтолцоо (эв санааны нэгдлийн тогтолцоо Pay-As-You-Go)-ны санжүүжилт хүндрэхээр байгааг тэмдэглэсэн байна.

Дэлхийн банкны төлөөлөгчид үндэсний тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд албан журмын хуримтлалын тогтолцооны элементийг оруулахыг санал болгосон байна. Олон жилийн туршид Дэлхийн банк (Worldbank), Олон улсын хөдөлмөрийн байгууллага труда (MOT - ILO), Олон улсын нийгмийн хангамжийн байгууллага (ISSA)-ын төлөөлөгчид тэтгэврийн тогтолцоонд хуваарилалт, хуримтлалын харьцаа ямар байх талаар маргалдсаар ирсэн байна. Өнөөдрийн байдлаар хүрсэн улс төрийн зөвшилцөл нь бүгдэд нь тохирох нэгдсэн жор байхгүй бөгөөд үндэсний онцлог, эдийн засгийн хөгжлийн түвшиндээ тохирсон өөрийн гэсэн загварыг сонгох нь зүйтэй гэсэн саналд нэгдэхэд хүргэсэн байна.

Хүн амын хөгшрөл хурдацтай нэмэгдэж байгаа Европын болон өмнөд америкийн олон орнуудад тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлсэн байна. Зүүн европ, Скандинавын орнууд, Польш, Казахстанд гурван түвшинт тэтгэврийн тогтолцоонд, өмнөд америкийн Чили, Аргентин, Перу, Колумби зэрэг улсад цэвэр хуримтлалын тогтолцоонд шилжих алхамуудыг амжилттай хэрэгжүүлж байна.

Чили Улс

1981 оноос тэтгэврийн даатгалын бүрэн хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн. Хувийн тэтгэврийн сангуудад даатгуулагчдын нэрийн дансанд мөнгөн хэлбэрээр шилжиж, төлсөн шимтгэл нь хөрөнгө оруултад ашиглагддаг болсон.

Чили Улс бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжихдээ залуучуудыг заавал хамруулах, хуваарилалтын дансанд шимтгэл төлөөд эхэлсэн хүмүүст аль нэгийг нь сонгох боломж олгож, хуучин хуваарилалтын тогтолцоондоо үлдсэн хүмүүс улсын төсвөөс хуучин журмаар тэтгэврээ авч, шинэ тогтолцоонд шилжсэн хүмүүст төлсөн шимтгэлтэй нь дүйцэхүйц төрийн облигаци олгосон байна. Энэхүү облигаци нь жил бүр 4 хувиар нэмэгдэж, хожим ажилтан тэтгэврээ тогтоолгох үед төр облигациа нэмэгдсэн хэмжээгээр нь худалдан авах журамтай байсан.

Хуримтлалын шинэ тогтолцоонд шилжих үед Засгийн газрын хүлээсэн үүргийн нийлбэр нь дотоодын нийт бүтээгдэхүүний 80-100 хувьтай тэнцэж байсан бөгөөд үүнийг төсвийн зардлаас давсан орлого, өмч хувьчлалын орлогоос санхүүжүүлж байсан.1992 - 1995 онд хуримтлалаас тогтоолгосон тэтгэвэр, хуваарилтын хуучин тогтолцоогоор тогтоолгосон тэтгэврээс 40 - 50 хувь илүү байсан ба даатгалын шимтгэл нь 19 хувиас 10 хувь /амь даатгал, тахир дутуугийн даатгалын шимтгэлийг оруулбал 13 хувь/ болж буурсан учир хуучин тогтолцоондоо үлдсэн хүмүүсийн 90 - 95 хувь нь түүнийг орхиж шинэ тогтолцоо руу шилжсэн.

Түүнчлэн дотоодын нийт бүтээгдэхүүний 0,2-0,5 хувиар тооцож улсын төсөвт суулгасан тэтгэврийн нөөц сангаас санхүүждэг төрийн доод хэмжээний тэтгэврийг олгодог. Чили Улсад тэтгэврийг тавьж олгохдоо насан туршдаа тэтгэвэр авах, хуримтлагдсан нийт мөнгөнөөс төлөвлөгөөтэйгөөр хасалт хийж авахын аль нэгийг сонгох эрх олгодог бөгөөд төлөвлөгөөтэйгөөр хасалт хийж авах хувилбарыг сонгосон тохиолдолд, даатгуулагч болон тэтгэвэр авагч нас барвал хуримтлалын дансанд үлдсэн хэсгийг нь өвлүүлэх журамтай.

Швед Улс.

Швед Улсын тэтгэврийн тогтолцоо 1990-ээд он хүртэл эв санааны нэгдлийн тогтолцоонд суурилсан, 30-аас дээш жил ажилласан ажилтан улсын хэмжээний дундаж цалингийн 60 хувиар тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байв. Тус улсад хүн ам зүйн нөхцөл байдлын нөлөөнөөс хамаарч тэтгэврийн тогтолцооны өөрчлөн байгуулалтын асуудлыг 1998 онд парламент шийдвэрлэж, 2013 онд шинэ тогтолцоонд бүрэн шилжсэн байна.

Тэтгэврийн шинэ тогтолцоонд 1938 оноос хойш төрсөн иргэдийг хамааруулж, нөхцөлт хуримтлалын, хуримтлалын, сайн дурын гэсэн гурван түвшинд авч үзсэн байна. 1938-1953 оны хооронд төрсөн иргэний тэтгэврийн зарим хэсэг нь хуучин тогтолцоогоор тооцогдох журам тогтоожээ. Нөхцөлт хуримтлалын хэсэг (Inkomstpension)

Нөхцөлт хуримтлал /бодит мөнгөөр бус тооцоогоор хуримтлагдсан/ -ын тэтгэвэр нь үндсэндээ хуваарилалтын зарчим дээр үндэслэдэг (Pay as You Go) Иргэний эх орондоо олсон бүх орлогоосоо төлсөн 16 хувийн шимтгэлээс эх үүсвэр нь бүрддэг байна. Энэ бол нөхцөлт тэтгэврийн үүрэг бөгөөд улсын хэмжээний макро эдийн засгийн үзүүлэлтээс хамаарч индексчлэгддэг байна. Иргэний үндсэн тэтгэврийн хэмжээ нь энэхүү

нөхцөлт хуримтлалын хэмжээг түүний цаашид амьдрах жилийн тоонд хуваах замаар тодорхойлогддог байна.

Хувь хүний нэрийн хуримтлалын хэсэг (Premiepension)

Тэтгэврийн хувь хүний нэр дээрх хуримтлал нь түүний хөдөлмөрийн хөлсний 2,5 хувийн шимтгэлээс бүрдэх бөгөөд бодит мөнгөн хэлбэрээр тэтгэврийн санг эрхлэх газрын дансанд шилжин зах зээлийн механизмээр хөрөнгө оруулалтад ашиглагддаг байна. Түүнийг нөхцөлт хуримтлалын нэгэн адил 61 наснаас олгож эхэлдэг.

Сайн дурын хэсэг

Үндэсний эдийн засагт ажиллагчдын 90 хувийг хамрах ажиллагчид болон ажил олгогчдын хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу сайн дурын үндсэн дээр бүрдүүлдэг тэтгэврийн хэсэг юм. Хэмжээ нь дунджаар тэтгэвэрт гарахын өмнөх цалин хөлсний 10 орчим хувиас бүрддэг байна.

Төсвөөс олгох баталгаат тэтгэвэр /garantipens/

Нөхцөлт хуримтлалаас хэт бага тэтгэвэр авдаг буюу ямар нэг тэтгэвэр авдаггүй хүмүүст улсын төсвөөс баталгаат тэтгэвэрийг олгодог. Түүнийг 65 наснаас эхэлж, Швед Улсад 3-аас доошгүй жил амьдарсан хүмүүст олгох бөгөөд 40 буюу түүнээс дээш жил амьдарсан хүмүүст бүрэн хэмжээгээр олгоно. 40 жилээс дутуу жил тутамд түүний 1/40-тэй тэнцэх хэмжээний мөнгийг хасч тооцно. Баталгаат бүрэн тэтгэврийн хэмжээ нь амьжиргааны баталгаат түвшинг 2,13 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

Тэтгэврийн сангийн захиргааны зардал.

Тэтгэврийн тогтолцооны захиргааны аппаратын зардалд иргэний Хувь хүний нэрийн хуримтлалын дүнгээс 0,46 хувь, нөхцөлт хуримтлалын дүнгээс 0,5 хувиар хатуу тогтоож, хуваарилдаг байна.

Өв залгамжлал

Швед Улсад тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалд байгаа үлдэгдлийг өв залгамжлуулах журамтай. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хуримтлалын хэсгийн үлдэгдлийг өвлүүлэхдээ түүний нас чацуу, тэтгэврийн насанд хүрсэн иргэдэд тараах хуваарилдаг бөгөөд энэ нь тэдгээрийн авах тэтгэврийн хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг байна.

Итали Улс.

(Тэтгэврийн тогтолцоо) Италид Тэтгэврийн даатгалын хуваарилалтын тогтолцоо үйлчилдэг. Эрэгтэйчүүд 65 /2012 оноос 66/, эмэгтэйчүүд 60 /2012 оноос 62/ нас хүрч 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд бүрэн тэтгэвэр авах эрх үүсдэг байна. Удаан жил ажилласны тэтгэврийг 35 жил шимтгэл төлсөн 57 насанд хүрсэн, эсвэл 38 жил шимтгэл төлсөн 57 нас хүрээгүй иргэн тогтоолгон авах эрхтэй.

Өв залгамжлуулах журам

Италид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгчдийн тэтгэврийг эхнэр /нөхөр/, гэр бүлийн гишүүдэд өв залгамжлуулахдаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байсан иргэн, тэтгэвэр авагчдын гэсэн онцлогийг харгалзан зохицуулдаг байна.

- Нас барсан тэтгэвэр авагчдын тэтгэврийг өв залгамжлагчид шилжүүлэх
- Ажиллаж байсан шимтгэл төлөгч нас барсан тохиолдолд шууд бус тэтгэвэр авах эрхтэй бөгөөд шимтгэл төлсөн хугацаа нь 15-аас дээш жил, сүүлийн 5 жилийн дотор 3 жилд нь шимтгэл төлсөн байх болзолтой байна.

Нас барсан этгээд Италийн иргэн бол түүний эхнэр /нөхөр/ иргэний харъяаллыг үл харгалзан тэтгэврийг нь өвлөн авах эрх үүснэ. Өвлөгдөх тэтгэврийн хэмжээг хуулиар тогтооно. Нас барсан даатгуулагч нэгээс дээш удаа гэрлэсэн бол тэдний хамтран амьдарсан хугацаанаас нь хамааруулж өвлөгдөх тэтгэврийг нь хуваах журамтай. Нас барсан этгээд гэрлэлт цуцлуулснаас хойш дахин гэрлээгүй бөгөөд түүнээс тэтгэмж авах эрхтэй салсан гэр бүлийнхний амьжиргааны байдал нь хүнд байгаа бол тэтгэврийг тэдэнд өвлүүлэх эсэх асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэх журамтай.

Нас барсан даатгуулагч эхнэр /нөхөр/ үгүй бол тэтгэврийг өв залгамжлах эрх эхлээд хүүхдэд дараа нь хамгийн ойрын ах дүү, төрөл төрөгсдөд шилжинэ. Италид тэгэврийн таатай нөхцөл бүрдсэн бөгөөд нийгмийн хангамжийн зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 15,4 хувь /европын орнуудын дундаж 11,9 хувь/ -ийг эзэлж байна. Италийн эдийн засгийн хямралтай байдал нь нийгмийн хангамжийн бодлогоо эргэн харахыг шаардаж байгаа бөгөөд 1990-ээд оноос хойш үе шаттайгаар өөрчилсөөр ирсэн байна.

Оросын Холбооны Улс

ОХУ нь 1990 оноос хойш тэтгэврийн тогтолцоогоо олон үе шаттайгаар шинэчлэж байгаа ба 2002 оноос орос оронд тэтгэвэр нь суурь, даатгалын, хуримтлалын гэсэн 3 хэсгээс бүрдэх болсон. Хууль, тогтоомжийн дагуу тэтгэврийн хуримтлалын хэсгийг төрийн удирдах компаний (ОХУ -ын Тэтгэвэрийн сан) мэдэлд үлдээх, аль нэг хувийн удирдах компани (УК), аль эсхүл төрийн бус тэтгэврийн сангийн (УК) мэдэлд хөрөнгө оруулалтын зорилгоор шилжүүлэх боломжийг олгожээ.

2001 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын тэтгэврийн тухай” хуульд тэтгэвэр авагч иргэн нас нөхчсөн тохиолдолд түүний тэтгэврийг өвлүүлэх талаар хуульчилсан. Тэтгэвэр авагч иргэн нас нөхчсөн тохиолдолд тэтгэврийн дараах төрлүүдийг түүний өв залгамжлагчдад өвлүүлдэг байна. Үүнд:

- Тэтгэвэр авагч амьд ахуйдаа авч амжаагүй улсаас тогтоосон тэтгэврийн үлдэгдэл мөнгө (тэтгэврийн төрлөөс үл хамаарна)
- Тэтгэврийн хуримтлалын хэсэг
- Төрийн бус тэтгэврийн санд сайн дурааараа хуримтлуулсан хуримтлал зэрэг болно.

Тэтгэврийн нийт шимтгэл нь шимтгэл төлөгчийн нэрийн дансанд хуримтлагдаж, тус дансанд ямар хэмжээний мөнгө хуримтлагдсан талаар ОХУ -ын Тэтгэвэрийн сангаас ирээдүйн тэтгэвэр авагчид жил бүр “аз жаргалын захидал” илгээн мэдээлдэг байна. Тэтгэврийн шимтгэл төлөгч нь өөрийн нэрийн дансан дахь хуримтлалаа зөвхөн тэтгэвэрт гарсныхаа дараа ашиглах боломжтой ба харин хуульд зааснаар шимтгэл төлөгч иргэн тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө нас нөхчсөн тохиолдолд түүний нэрийн дансанд хуримтлагдсан мөнгийг өв залгамжлагчид нь өвлөх эрхтэй.

ОХУ -д тэтгэврийн хуримтлалыг гэрээслэх, өвлөх эрхийг “Төрийн бус тэтгэврийн сангийн тухай” болон “Тэтгэврийн хуримтлалын хэсгийг хөрөнгө оруулалтаар эргэлтэнд оруулах тухай” зэрэг хуулиудад хуульчилжээ. Тухайлбал, “Төрийн бус тэтгэврийн сангийн тухай” хуульд хэрэв даатгуулсан иргэн тэтгэврийн хуримтлалын хэсэг болон нэмэлт хуримтлалыг түүнд тэтгэвэр болгон тогтоохоос өмнө нас нөхчсөн тохиолдолд “түүний тэтгэврийн хуримтлалын хэсгийн дансанд байгаа мөнгөн хуримтлал нь даатгуулагчийн санд гаргасан өргөдөлд заасан өв залгамжлагчдад олгогдоно” гэж заажээ.

“Тэтгэврийн хуримтлалын хэсгийг хөрөнгө оруулалтаар эргэлтэнд оруулах тухай” хуульд “Өв залгамжлагчид нь даатгуулагч нас нөхчсөн өдрөөс хойш 6 сарын дотор ОХУ -ын Тэтгэврийн санд хандсан тохиолдолд төлбөр олгогдоно” гэж заасан. Тэтгэврийн

хуримтлалын өв залгамжлал нь гэрээслэлээр, хуулийн дагуу гэсэн 2 хэлбэрээр өвлөгдөж байна. Даатгуулагчийн тэтгэврийн хуримтлалын хэсэг нь ОХУ-ын Тэтгэврийн санд байгаа тохиолдолд даатгуулагч нь тус санд ирж тусгай өргөдлийн маягтын дагуу гэрээслэлийн өргөдлөө гарган тодорхой өв залгамжлагчид гэрээслэнэ. Гэрээслэлгүй тохиолдолд тэтгэврийн хуримтлалын хэсгийг “Оросын Холбооны Улсын тэтгэврийн тухай” хуулийн 12 дахь хэсгийн 16 дугаар зүйлд заасан хүмүүст болон “Оросын Холбооны Улсын иргэний хууль”-ийн 3 дахь хэсгийн 1183 дугаар зүйлийн дагуу өвлүүлэхээр эрх зүйн зохицуулалт хийсэн байна.

ОХУ-ын төрийн сан болох ОХУ-ын Тэтгэвэрийн санд нэрийн данстай даатгуулагчийн тэтгэврийн хуримтлалын хэсгийн өв залгамжлалын хувьд нэг ялгаа бий ба тухайн даатгуулагч нэрийн данс дахь хуримтлалаа авах насанд хүрэхээс өмнө нас нөхчсөн тохиолдолд түүний хуримтлалыг өвлөх эрх үүсдэг. Хэрэв тухайн даатгуулагч өөрийн тэтгэврийн хуримтлалын хэсгээс нэг удаа л тэтгэвэр авсан тохиолдолд өвлөх эрх огт үүсдэггүй байна.

Төрийн бус тэтгэврийн сангуудад сайн дурааараа даатгуулсан даатгуулагчийн тэтгэвэрийг өвлүүлэх асуудлын хувьд энэ асуудлыг төрийн бус тэтгэврийн сангийн дүрэмд нарийн заасан байдаг ба гэрээ байгуулах үед тодорхой тусгадаг. Сан тус бүрийн дүрэмд янз бүрээр зохицуулсан байж болох боловч зарим зүйл нь ижил байдаг, тухайлбал, даатгуулагч тэтгэврээ 2 янзын схемээр хуримтлуулж болно. Үүнд:

1. Насан туршийн схем - энэ нь даатгуулагч тэтгэвэрт гараҳдаа тэтгэвэрээ үлдсэн амьдралынхаа туршид авах юм. Өвлөх харилцаа нь энд тэтгэврийн хуримтлалын хэсэгтэй ижил, даатгуулагч данс дахь хуримтлалаа авах насанд хүрэхээс өмнө нас нөхчсөн тохиолдолд түүний хуримтлалыг өвлөх эрх үүсдэг. Хэрэв тухайн даатгуулагч өөрийн тэтгэврийн хуримтлалын хэсгээс нэг удаа л тэтгэвэр авсан тохиолдолд өвлөх эрх үүсдэггүй байна.

2. Хугацаатай схем- даатгуулагч тэтгэвэрт гарахдаа тэтгэвэрээ тодорхой хэдэн жилийн хугацаанд авахаар гэрээ байгуулна. Уг хугацаа нь тухайн сангаас заасан тодорхой хугацаанаас (жишээ нь 5 жилээс доошгүй, 15 жилээс дээшгүй) ба даатгуулагчийн хүсэлтээс (жишээ нь, 7 жил) хамаарна. Энэ тохиолдолд даатгуулагч данс дахь хуримтлалаа авах насанд хүрэхээс өмнө нас нөхчсөн, эсхүл сонгосон хугацаанаасаа өмнө нас нөхчсөн бол өв залгамжлагч нь түүний данс дахь бүх мөнгийг өвлөх эрхтэй.

АНУ

АНУ -д тэтгэвэр ба тэтгэвэр өвлөн авах зэрэг бүх харилцаа нь 2006 оны 8-р сарын 17 -ны “2006 оны Тэтгэвэр Хамгаалах Хууль” (The Pension Protection Act of 2006) -иар зохицуулагддаг байна. Гэхдээ АНУ -ын муж улс бүр өөр өөрийн хуультай. АНУ -д Нийгмийн Хамгаалал гэдэг нь Өндөр насны, Тэжээгчээ алдсаны, Хөдөлмөрийн чадвар алдсаны даатгал (Social Security refers to the Old-Age, Survivors, and Disability Insurance (OASDI)) хэмээх Холбооны Засгийн Газрын Хөтөлбөрийг хэлдэг байна.

Тэтгэвэр өвлөх эрх үүсэх:

АНУ -ын тэтгэврийн тогтолцоогоор хүн бүр өөрийн Тэтгэврийн Данс (Individual Retirement Account - IRA)-тай байдаг. Засгийн газрын болон орон нутгийн, сайн дурын тэтгэврийн сангуудтай. АНУ-ын “Тэтгэвэр хамгаалах” хуулинд зааснаар гэр бүлийн эхнэр нөхрийн аль нэг нь нас барахад тухайн цаг үеийнх нь эхнэр эсвэл нөхөрт түүний тэтгэврийг нь өвлөн авах эрх шууд үүсдэг байна. Ингэхийн тулд нөхөр буюу эхнэр нь тэтгэвэрт гарах үедээ тэтгэврийн төлөвлөгөөний данс нээлгэхдээ хамтран эзэмшигчийн нэрийг

бүртгүүлсэн байх шаардлагатай. Энэ нь тухайн хүн тэтгэвэрт гарах үедээ Өндөр насны тэтгэврийн төлөвлөгөөгөө гаргаж данс нээх маягт дээр нэг гэр бүлийн хүмүүс ихэвчлэн эхнэр, нөхрийнхөө нэрийг үндсэн хүлээн авагчаар, бас хүүхдийнхээ нэрийг хоёрдогч хүлээн авагчаар бичсэнээр нас барсан үедээ гэр бүлийн гишүүддээ өөрийн тэтгэврийг өвлүүлэн үлдээх эрхийг баталгаажуулдаг. Энэ мэтчилэн тэтгэвэр өвлөн хүлээн авагчаар хичнээн хүнийг нэрлэн бичих нь тухайн хүний эрхийн асуудал бөгөөд хувь хэмжээг ч тодорхой бичих боломжтой байдаг.

Ингээд тэтгэвэр өвлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэтгэврийг өвлөх хүлээн авагч нь бас хүлээн авагчийн маягт[48] -ыг бөглөж хүсэлт гаргадаг. Ийнхүү тэтгэврийн данснаа үндсэн (primary beneficiary) хүлээн авагчаас гадна удаах хоёрдох (alternate beneficiary) хүлээн авагчийг нэрлэх нь тухайн нэг хүнийг нас барсаны дараа гэр бүлийнхэнд нь илүү уян хатан боломж олгодог байна. Тухайлбал, үндсэн хүлээн авагч нь өөрийн өвийг авахгүй хэмээн чөлөөтэй шийдвэрлэх боломжтой, ингэснээр хоёрдох хүлээн авагч руу шилжүүлэх боломжтой болж байгаа юм. Мөн дээр дурьдсан тохиолдлоос гадна тэтгэвэр өвлүүлэх тухай гэрээслэлийг үндэслэн тэтгэврийг өвлүүлж болдог байна. /Жишээ нь: Франсес банкны ажилтнаас авсан маягт дээр өөрийн нөхөр Шоныг тэтгэврийн данснаа үндсэн хүлээн авагчаар нэрлэжээ.

Гэхдээ тэр үед тэрээр хоёрдогч хүлээн авагчийг нэрлэж бичээгүй байдаг. Гэтэл хэдхэн жилийн дараа тухайн үедээ 80-аад настай байсан Шоон нас барж, төд удалгүй Франсес өөрөө данснаа хүлээн авагчийн нэрийг өөрчлөж амжилгүйгээр нас барсан байна. Ингээд тэрхүү тэтгэврийн данс нэрлэсэн тодорхой хүлээн авагчгүй байсан тул мөнгийг нь түүний гэрээслэлийг үндэс болгон хүү Колинд шилжүүлсэн аж. Гэхдээ Колин энэ мөнгийг заавал 5 жилийн дотор гарган авах ёстой болж байгаа юм. (Торгууль төлнө гэсэн үг) Хэрвээ Колины нэр хоёрдогч хүлээн авагчаар бичигдсэн байсан бол тэр мөнгийг 40-с илүү жилийн хугацааны туршид насан туршдаа гарган авч хэрэглэж болох байв /

Тэтгэвэр өвлөн авах хэлбэр:

Тэтгэвэр өвлөн авах нөхцөл байдал болон эрх үүссэн тохиолдолд нас барагчийн эхнэр, нөхөр нь өөрөө тэтгэврийн насанд хүрсэн байвал ямар ч татвар шимтгэлгүйгээр өөрийн тэтгэврийн дансанд шилжүүлэн авч хэрэглэж болно. Харин өөрөө тэтгэврийн насанд хүрээгүй бол:

1) Тэтгэврийн насанд хүртлээ нас барагчийн нэр дээр хэвээр нь байлгаж болно. Тэгээд хожим тэтгэврийн насанд хүрэхээрээ өөрийн тэтгэврийн данс руу ямар ч торгуульгүйгээр шилжүүлэн авч хэрэглэж болно.
2) Шууд өөрийн тэтгэврийн данс руу шилжүүлэн авааД тодорхой хэмжээний мөнгө гарган авч хэрэглэж болно. Гэхдээ энэ нь дээр дурдсан хуулиар эрт хэрэглэсний 10% -ийн шимтгэл төлдөг байна. /Жишээ нь: Энни нөхрийгөө нас барах үед 45 настай, 2 хүүхдээ гэртээ хардаг байв. Тэрээр нөхрийнхөө Тэтгэвэрт гарах төлөвлөгөөний (401(k) plan) дансан дахь мөнгийг өвлөн авчээ. Түүнд энэ данснаас хэдэн жилдээ л мөнгө гарган авч хэрэглэх шаардлага бий. Хэрвээ тэрээр тухайн данс дахь бүх мөнгийг өөрийн тэтгэврийн данс руу шилжүүлээд, 59S нас хүрэхээсээ өмнө зохих хэмжээний мөнгө гарган хэрэглэх аваас эрт авч хэрэглэсэний 10% шимтгэл төлөх болно. Түүний оронд энэ дансыг нас барсан нөхрийнхөө нэр дээр хэвээр нь хадгалвал өөрөө тэтгэврийн насанд хүрч, шилжүүлэн авах хүртлээ хүү ашиг тооцуулан, цаашид торгуульгүйгээр хэрэглэх боломжтой болно./

Мөн түүнд салсан буюу урдын эхнэр нөхрүүд байгаа бол тэд нар нь наанадаж 10 жил хамт

[48] «О негосударственных пенсионных фондах» (№75 - ФЗ от 7.05.1998)

амьдарсан байвал мөн “Хань ижлийн” (spouse’s benefit) тэтгэмж авах эрх үүсдэг байна. Харин OASDI буюу Нийгмийн хамгаалалд ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй тул Хань ижлийн тэтгэмжинд хамруулдаггүй. Учир нь хэдийгээр цөөн хэдэн муж улсад нь ийм гэрлэлтийг зөвшөөрдөг ч Холбооны засгийн газар ба хуулийн хүрээнд зөвшөөрдөггүй ажээ.

АНУ-ын хувьд өндөр насны тэтгэврийг өвлүүлэх тогтолцоо нь илүү уян хатан байдаг бөгөөд хэнд өвлүүлэн үлдээх нь хүний эрхийн асуудал юм. Учир нь тэтгэврийг өвлүүлэн шилжүүлэхэд тэтгэврийн дансны маягт болон гэрээслэл зэргийг үндэслэдэг бөгөөд хань ижлийнхээ тэтгэврийг өвлөн авах нь хуулиар зөвшөөрөгдсөн байдаг байна.

ИХ БРИТАНИ УЛС[49]

Англи улсын хувьд өндөр насны тэтгэвэр өвлөх асуудлаар ихээхэн боловсронгуй тогтолцоо, хууль эрх зүйн орчинтой орон юм. Тэтгэвэр өвлөх тухай асуудлыг “Нийгмийн хамгааллын тэтгэврийн тухай хууль” /Social Security Pensions Act/ “Тэтгэврийн тухай хууль” /Pension act 2008, 2011/, Тэтгэврийг хамгаалах тухай хууль” /The Pension Protection Act/, “Нийгмийн хамгааллын шимтгэл ба тэтгэмжийн тухай хууль” /Social Security Contributions and Benefits Act 1992/ -уудаар зохицуулдаг байна.

Төрөөс олгож буй өндөр насны Тэтгэврийн схемийг (The State Earnings Related Pension Scheme (SERPS)) 1978 онд Хөдөлмөрийн Намын Засгийн Газар анх нэвтрүүлсэн бөгөөд бэлэвсрэн үлдэгсэд нөхрийнхөө тэтгэврийг (SERPS) 100% өвлөн авах эрхтэй байхаар зохицуулжээ. Харин 1986 оноос Консерватив Намын Засгийн Газар улам бүр өсөн нэмэгдэж байгаа тэтгэврийн өртөгийг анхааран үзэж, төрийн тэтгэврийн схемийг хэзээ нас барснаас нь хамаарч 100%-50% хүртэл хэмжээгээр хувь тооцон өвлүүлэхээр өөрчилжээ.

Өндөр насны тэтгэвэр нь тухайн хүний хөдөлмөрлөж олсон хөлснөөс хуримтлуулсан нийгмийн даатгалын шимтгэлийг үндэслэн олгодог тэтгэврийг хэлдэг. Энэ төрлийн тэтгэврийг “Төрийн тэтгэвэр” гэх ба энэ нь 2 хэсэгтэй[50] байдаг байна. Үүнд:

- Төрийн суурь тэтгэвэр (The Basic State Pension (BSP)- Энэ нь бүх хүмүүст олгогдох суурь тэтгэвэр юм. Мөн Үндэсний даатгалын шимтгэлийн (National Insurance Contributions (NICs)) бүрэн тэмдэглэл хийлгэсэн хүмүүс Төрийн тэтгэвэрт хамрагдах насанд хүрэх үедээ энэхүү Төрийн суурь тэтгэвэр (BSP)-ийг авах эрх үүснэ. Тэтгэврийн хэмжээ нь 2012-2013 онд J107,45 байна.
- Төрийн нэмэлт тэтгэвэр- (The Additional State Pension (ASP)-2002 оны 4-р сард төрийн нэмэлт тэтгэвэр нь Төрийн хоёр дахь тэтгэвэр болж өөрчлөгдсөн. Төрийн хоёр дахь тэтгэвэр нь бага болон дунд орлоготой хүмүүс, зарим бусдыг асардаг ба удаан хугацаагаар өвчтэй байсан, хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүст илүү их таатай тэтгэвэр юм.

Их Британид “Гэр бүлийн тухай “хуулиар хууль ёсны гэр бүлийн эхнэр нөхрийн хэн нэг нь нас барсан тохиолдолд нөгөө нь тэтгэврийг нь өвлөн авах эрхтэй байдаг байна.

Тэтгэвэр (SERPS) өвлөн авах:

Хууль ёсны гэр бүлийн эхнэр болон нөхрийн аль нэг нь нас барсан тохиолдолд Бэлэвсэн

[49] “Об инвестировании средств для финансирования накопительной части трудовой пенсии в Российской Федерации”2002 N 111-ФЗ

[50] The Pension Protection Act of 2006, Pub.L.109–280) http://www.nolo.com/legal-encyclopedia/free-books/avoidprobate-book/chapter2-2.html

үлдсэн эхнэр ба нөхөр, үлдэж хоцорсон хамтран амьдрагч /(Civil partnerships) гэдэг нь Их Британы Вант Улсад 2004 оны “Иргэний Хамтын Амьдралын тухай Хууль” (Civil Partnership Act 2004) -аар ижил хүйстэн хосуудыг хууль ёсны гэр бүлийн адил эрх, үүрэгтэй болгосныг хэлж байгаа юм. Энэ хуулиар тэд хууль ёсны гэр бүлийн адил эд хөрөнгийн эрхтэй, татвар, нийгмийн хамгаалал ба тэтгэвэр өвлөн авах эрхтэй, тэр бүү хэл эцэг эхийн гэх мэт эрх үүргүүдтэй, бас хууль ёсоор салах процесс бүхий байдаг байна. Түүнээс биш ерийн нэг хамт амьдардаг төдийгөөр тэтгэвэр өвлөн авах зэрэг ямар нэг хууль ёсны эрх үүсэхгүй./ нь хань ижлийнхээ хурааж хуримтлуулсан Орлогоос Хамааралтай Төрийн Тэтгэврийн схемийг /SERSP/ өвлөн авах эрхтэй.

Энэ нь (Category B pension) Төрийн суурь тэтгэвэр ба, эсвэл Төрийн нэмэлт тэтгэврийг 50 хувиас эхлэн 100 хувь хүртэл бүтнээр нь өвлөн авахыг хэлнэ. Өвлөж авах тэтгэврийн хувь хэмжээ нь:

- ✓ тухайн өвлөн авах гэж буй хүн яг хэзээ бэлэвсэн болсон
- ✓ нас барсан хүн нь хэзээ тэтгэврийн насанд хүрсэн зэргээс хамаардаг.

Үүнийг дараах хүснэгтээс тодорхой харж болно. /Хүснэгт1, 2/

Эхнэрийн эсвэл хамтран амьдрагчийн өвлөн авч болох SERPS тэтгэврийн хамгийн дээд хэмжээ[51]

Хүснэгт 1

Эрэгтэй хүний төрсөн өдөр	Түүний эхнэр эсвэл хамтран амьдрагчийн өвлөн авч болох SERPS тэтгэврийн хамгийн өндөр хувь
• 1937 оны 10 сарын 5 ба түүнээс өмнө	100%
• 1937 оны 10 сарын 6 ба 1939 оны 10 сарын 5-ны хооронд	90%
• 1939 оны 10 сарын 6 ба 1941 оны 10 сарын 5 -ны хооронд	80%
• 1941 оны 10 сарын 6 ба 1943 оны 10 сарын 5-ны хооронд	70%
• 1943 оны 10 сарын 6 ба 1945 оны 10 сарын 5 -ны хооронд	60%
• 1945 оны 10 сарын 6 ба түүнээс хойш	50%

Нөхрийн эсвэл хамтран амьдрагчийн өвлөн авч болох SERPS тэтгэвэрийн хамгийн дээд хувь

Хүснэгт 2

Эмэгтэйн төрсөн өдөр	Нөхрийн эсвэл хамтран амьдрагчийн өвлөн авч болох SERPS тэтгэврийн хамгийн дээд хувь хэмжээ
• 1942 оны 10 сарын 5 ба түүнээс өмнө	100%
• 1942 оны 10 сарын 6 ба 1944 оны 10 сарын 5-ны хооронд	90%

[51] Inheriting a SERPS pension, SERPSL1, December 2007; www.is4profit.com/pdf/pm2sep06.pdf - United Kingdom

UIH.MN
СУДАЛГААНЫ ТӨВ

• 1944 оны 10 сарын 6 ба 1946 оны 10 сарын 5-ны хооронд	80%
• 1946 оны 10 сарын 6 ба 1948 оны 10 сарын 5-ны хооронд	70%
• 1948 оны 10 сарын 6 ба 1950 оны 7 сарын 5-ны хооронд	60%
• 1950 оны 7 сарын 6 ба түүнээс хойш	50%

Харин тэтгэвэр өвлөх хэлбэр нь:

- ✓ Хэрвээ гэрлэсэн бэлэвсэн эмэгтэйн нөхөр нь нас барсан тохиолдолд түүний тэтгэврийг өвлөн авах эрхтэй ба хэрвээ тэтгэврийн насанд хүрсэн бол шууд өвлөн авна.
- ✓ Харин тэтгэврийн насанд хүрээгүй бол Бэлэвсэний Тэтгэмж авах боломжтой. Бэлэвсэний Тэтгэмжийг тэтгэврийн насанд хүрээгүй байсан ч авах ба, хэн нэгэн өөр хүнтэй гэр бүл болсон ба хууль ёсоор хамтран амьдрах болсноор энэ тэтгэмжийг авах эрх дуусгавар болно. Мөн тэтгэврийн насанд хүрээгүй бол хүрэх хүртлээ Хүнд Гарз Хохирлын Тэтгэмжийг бас авч болно. Ингээд тэтгэврийн насанд хүрэх үедээ дахин гэрлээгүй, өөр хэн нэгэнтэй хамтран амьдрах хууль ёсны харилцаа тогтоогоогүй байх тохиолдолд нөхрийнхөө тэтгэврийг өвлөн авах эрх үүсэх юм.

Төрийн хоёр дахь Тэтгэвэр буюу нэмэлт тэтгэвэр[52]-ийг Бэлэвсэн үлдсэн эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагч нь өөрийн гэр бүлийн хүнийнхээ Төрийн хоёр дахь тэтгэврийн 50 хүртэл хувийг өвлөн авч болно. Төрийн нэмэлт тэтгэврийн авч болох хамгийн их дүн хэмжээ нь тухайн тэтгэвэр өвлөгчийн өөрийн нэмэлт тэтгэвэр ба бусад өвлөн авсан нэмэлт тэтгэвэрийн нийлбэр юм. Энэхүү хамгийн их хэмжээ нь жил бүр шинэчлэгдэх ба үүнийг жил бүрийн нэмэлт тэтгэвэр өвлөн авах эрх анх үүссэн тэр өдөртөө өргөдөл гаргаж тогтоолгоно. 2012 оны 4 дүгээр сар ба 2013 оны 4 дүгээр сарын хоорондох хамгийн их Төрийн нэмэлт тэтгэврийн дүн хэмжээ нь долоо хоног тутамд J161.94 байдаг байна.

Их Британи улсын хувьд өндөр насны тэтгэврийг өвлөх өвлүүлэх харилцааг хуулиар зохицуулсан байдаг бөгөөд хууль ёсны гэр бүлийн эхнэр болон нөхөр, хамтран амьдрагчийн аль нэг нь нас барсан тохиолдолд нэгнийхээ тэтгэврийг нь өвлөн авч болдог байна.

* * *

Ашигласан материал:

1. «О негосударственных пенсионных фондах» (№75-ФЗ от 7.05.1998)
2. “Об инвестировании средств для финансирования накопительной части трудовой пенсии в Российской Федерации”2002 N 111-ФЗ
3. The Pension Protection Act of 2006, Pub.L.109–280) http://www.nolo.com/legal-encyclopedia/free-books/avoid - probate-book/chapter2-2.html
4. IRA application https://content.etrade.com/etrade/estation/pdf/IRA_App5.pdf
5. Beneficiary IRA application https://content.etrade.com/etrade/estation/pdf/Beneficiary_IRA.pdf
6. Inherit SERPS www.parliament.uk/briefing-papers/sn00706.pdf
7. Нийгмийн Хамгаалал Тэтгэврийн Хууль 1975 он) www.legislation.gov.uk/ukpga/1975/.../content
8. Inheriting a SERPS pension, SERPSL1, December 2007; www.is4profit.com/pdf/pm2sep06.pdf - United Kingdom
9. SERPS and the State Second Pension and in the following leaflets http://www.legislation.gov.uk/

[52] SERPS and the State Second Pension and in the following leaflets http://www.legislation.gov.uk/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮҮХЭД АСАРСНЫ ТЭТГЭМЖ ОЛГОХТОЙ ХОЛБОГДСОН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Товуусүрэн, А. Пагма, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл

АГУУЛГА

УДИРТГАЛ

- Судалгааны зорилго
- Судалгааны зорилт
- Судалгааны аргачлал
- Судалгааны үр дүн
- Судалгааны дүгнэлт

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Монгол улсын хүүхэд асарсны тэтгэмж олгохтой холбогдсон статистик тоо баримт, Хүүхэд асарсны тэтгэмжийг 2 нас хүртэл олгох тохиолдолд улсын төсөвт нөлөөлөх нөлөөлөл.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Гадаадын зарим улс орны хүүхэд асрах тэтгэмж олгохтой холбогдсон харилцаа

- Оросын холбооны улс
- Бүгд Найрамдах Узбекистан Улс
- Нидерландын Вант Улс
- Бүгд Найрамдах Чех Улс

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

* * *

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын захиалгаар “Хүүхэд асарсны тэтгэмж олгохтой холбогдсон статистик тоо баримт, гадаадын зарим улс орны эрх зүйн орчин”сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго.

Энэхүү судалгааны зорилго нь сүүлийн 10 жилийн хугацаанд 0-2 насны хүүхдийн тоог статистикийн албан ёсны мэдээллээс тооцон гаргах, 0-2 насны хүүхдийн цэцэрлэг яслийн хүрэлцээ, сүүлийн 10 жилд жил тутам амаржсан эхийн тоо, нялхасын эндэгдэл, 0-2 насны хүүхдээ асарч байгаа эх/өрх толгойлсон эцэг/-ийн тоо, 0-2 насны хүүхдээ асарч байгаа эх/өрх толгойлсон эцэг/-д хүүхэд асарсны тэтгэмж олгоход төсөвт нэмэгдэх зардлыг тооцон гаргах, энэ талаар гадаадын зарим улс орны эрх зүйн орчинг судлаж, дүгнэлт гаргахад чиглэгдэнэ.

Судалгааны зорилт.

- Сүүлийн 10 жилийн 0 - 2 насны хүүхдийн тоог статистикийн мэдээлэлд тулгуурлан тооцон гаргах

- 0 - 2 насны хүүхэдтэй эх/өрх толгойлсон эцэг/-ийн тоог тооцож гаргах;
- Хүүхдийг 2 нас хүртэл тэтгэмж олгоход улсын төсвийн зардлын өсөлтийг тооцох;
- Гадаадын улс орнуудад хүүхэд асарсны тэтгэмж олгодог эрх зүйн орчныг харьцуулан судлах;
- Судалгааны дүгнэлт гаргах;

Судалгааны аргачлал.

- Статистикийн албан ёсны мэдээлэлд тулгуурлан 0 - 2 насны хүүхдийн тоо, мөн насны хүүхэдтэй эх/өрх толгойлсон эцэг/ -ийн тоог сүүлийн 10 жилээр тооцон гаргаж, тоон мэдээллийн эх сурвалжийг бэлтгэх;
- Хүүхэд асарсны тэтгэмжийг гадаадын зарим улс орнуудад хэрхэн зохицуулж байгаа талаар харьцуулан судлах;
- Монгол Улсад хүүхдийг 2 нас хүртэл эх/өрх толгойлсон эцэг/-д тэтгэмж олгоход улсын төсвийн зардалд нөлөөлөх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах:

Судалгааны үр дүн.

Хүүхэд асарсны тэтгэмж олгох талаар шийдвэр гаргахад 0 - 2 насны хүүхэдтэй эх/өрх толгойлсон эцэг/ -ийн тоо, мөн ийм насны хүүхдийн тоон мэдээллээр хангах;

- Хүүхэд асарсны тэтгэмж олгох шийдвэр гаргахад улсын төсвийн зардалд нөлөөлөх нөлөөллийн мэдээллээр хангах;
- Хүүхэд асарсны тэтгэмж олгодог гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулалтаар холбогдох дүгнэлт хийх боломж олгох;

Судалгааны дүгнэлт.

1. 0 - 2 насны хүүхэд асарсны тэтгэмж олгох нь эх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхэд гэр бүлийн халуун дулаан уур амьсгалд эрүүл өсөж торниход чиглэгдсэн чухал арга хэмжээ юм.
2. Хүүхэд асарсны тэтгэмж олгоход улсын төсөвт багагүй ачаалал нэмэгдэхээр байгаа ч гадаадын зарим улс орны жишгийг харгалзан тэтгэмжийн хэмжээ, хамрагдах хүүхдийн насны хязгаарыг 2 нас хүртэл аажмаар өсгөх замаар эдийн засгийн өсөлттэй уялдуулан шийдвэрлэж болох юм.
3. Энэ чиглэлээр хууль батлагдсан тохиолдолд нийгмийн халамжийн зарим тэтгэмжид зохицуулалт хийх.

* * *

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Монгол улсын хүүхэд асарсны тэтгэмж олгохтой холбогдсон статистик тоо баримт, Хүүхэд асарсны тэтгэмжийг 2 нас хүртэл олгох тохиолдолд улсын төсөвт нөлөөлөх нөлөөлөл.

1. Улсын хэмжээнд 2002 - 2012 онд төрсөн хүүхэд, амаржсан эх, яслид хамрагдсан хүүхдийн тоо

Уг сэдвийн хүрээнд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны Статистикийн 2003-2011 оны эмхтгэл, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Статистик блютень 2012, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Улсын нийгмийн даатгалын газрын мэдээллээс гаргасан албан ёсны эх сурвалжийг лавлагаа мэдээллийн эх сурвалж болгон ашиглав.

Улсын хэмжээнд 2002 - 2012 онд нийт 626576 мянган хүүхэд төрсөнөөс 0 - 1 насандаа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

12486 хүүхэд эндсэн тохиолдол бүртгэгджээ. Сүүлийн 10 жилд улсын хэмжээнд 0 - 2 настай хүүхдийн тоог гаргахдаа тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тооноос 0 - 1 насандаа эндсэн хүүхдийн тоог хасч тооцсон болно. 2002 - 2012 онд төрсөн 0 - 2 настай яслийн насны нийт 614090 хүүхдүүдийн 45262 буюу 7,4 хувь нь хамрагджээ.

Улсын хэмжээнд сүүлийн 10 жилд төрсөн хүүхэд, амаржсан эх, яслид хамрагдсан хүүхдийн тоо

Хүснэгт 1

Он	Амьд төрсөн хүүхдийн тоо /хүйсээр/		Нялхсын эндэгдэл /0-1 хүртэлх насандаа/	Тухайн жилд төрсөн хүүхдийн тоо	0-2 настай хүүхдийн яслид хамрагдсан тоо	Амаржсан эхийн тоо
	1	2	3	4	5	6
2002	эрэгтэй	23092	799	22293	4383	46691
	эмэгтэй	22631	591	22040		
2003	эрэгтэй	23113	602	22511	3748	45592
	эмэгтэй	21631	449	21182		
2004	эрэгтэй	22686	588	22098	3385	45380
	эмэгтэй	21835	428	21407		
2005	эрэгтэй	23269	530	22739	3663	45146
	эмэгтэй	21902	408	21494		
2006	эрэгтэй	24396	901	46475	4370	48880
	эмэгтэй	22980				
2007	эрэгтэй	28483	547	27936	4938	56411
	эмэгтэй	27291	447	26844		
2008	эрэгтэй	32623	731	31892	4754	63451
	эмэгтэй	30639	509	30130		
2009	эрэгтэй	35241	795	34446	4400	68735
	эмэгтэй	33521	591	32930		
2010	эрэгтэй	33810	721	33089	4353	62942
	эмэгтэй	32079	554	31525		
2011	эрэгтэй	36288	1152	69424	3621	69155
	эмэгтэй	34288				
2012	эрэгтэй	74778	1143	73635	3647	74474
	эмэгтэй					
Нийт дүн		626576	12486	614090	45262	626857

Нялхсын эндэгдлийн шалтгааныг дурьдвал, 2011 оны байдлаар нийслэлийн эрүүл мэндийн газрын хийсэн судалгаагаар 54,8 хувь нь нярайн эрт үед, 9,5 хувь нь нярайн хожуу үед 35,53 хувь нь 29 - 365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна. Нэг хүртэлх насны

хүүхдийн эндэгдлийн перинаталь үед үүссэн эмгэгийн дотор нярайн тархитай холбоотой бусад хямрал 34,2 хувийг, төрөхөд ураг бүтэх 21,05 хувь, нярайн амьсгалын гачаал 14,82 хувийг эзэлж байна. Амьсгалын тогтолцооны өвчлөлөөс шалтгаалсан эндэгдэл дотор уушгины хатгаагаар 98,7 хувь, Төрөлхийн гажгаас 53,1 хувийг зүрхний төрөлхийн гажиг, 12,5 хувийг улаан хоолойн төрөлхийн гажиг, 34,4 хувийг бусад эрхтэний төрөлхийн гажиг тус тус эзэлж байна. /Хүснэгт 2/[53]

Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан

Хүснэгт 2

Шалтгаан	01- хүртэлх насны	5 хүртэлх насны
Перинаталь үүссэн зарим эмгэг	54,28	44,70
Амьсгалын замын өвчин	17,42	18,11
Төрөлхийн гажиг, гаж хөгжил	16,00	15,05
Гадны шалтгаант өвчлөл	3,42	10,58
Мэдрэлийн тогтолцооны өвчлөл	3,14	4,47

2. Улсын хэмжээнд 2002 - 2012 онд хүүхэд асарсны тэтгэмжид хамрагдсан эх, эцэг асран хамгаалагчдын тоо, хэмжээ

2002 - 2006 онуудад нийгмийн халамжийн хүүхэд асарсны тэтгэмж авах, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан байдлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан 1995 онд батлагдсан нийгмийн халамжийн тухай хуулиар “төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 1 нас /ихэр бол 3 нас/ хүртэл асарч байгаа эх /эцэг, асран хамгаалагч/ амаржсаны тэтгэмжээ авсаны дараа хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй байсан байна. Тус хуулиар хvvхэд асарсны тэтгэмж авч байх хугацаандаа хvvхэд дахин төрvvлсэн болон урчлэн авсан эхийн тvрvччийн хvvхэд асарсны тэтгэмжийг зогсоож, дараагийн хvvхдээ асрахад нь зориулан тvvнд хvvхэд асарсны тэтгэмж олгоно. Уг тэтгэмж нь эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлтийн хугацаанд хамаарч тэтгэмжийн хэмжээг тухайн үеийн амьжиргааны доод түвшинг харгалзан засгийн газар тогтоож байжээ. 2002-2007 онд давхардсан тоогоор 295.1 мянган хүн 410,9 сая төгрөгийн тэтгэмж авсан байна.

Нярай хvvхдийн арчилгааны тэтгэмжид нэн ядуу өрхийн эх хvvхдээ төрvvлснээс хойш 3 сарын дотор нэг удаа нярай хvvхдийн арчилгааны тэтгэмж авч байсан бөгөөд тэтгэмжийн хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцvv хэмжээтэй байжээ. 2002-2007 онд 28 мянган хүн 692,9 сая төгрөгийн тэтгэмж олгоджээ.

Ихэр хvvхдийн тэтгэмжинд ихэр хvvхэд төрvvлж, эсэн мэнд өсгөж байгаа эхийн төрснөөс хойш 3 сарын дараа хvvхэд тус бvрд 20000 төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгосон бөгөөд 2002-2006 онд 1,5 мянган эхэд 54,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжинд тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн

[53] Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт, УБ хот., 2011 он. Нийслэлийн эрүүл мэндийн газар

бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсч тэтгэмжийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг болон төрийн албан хаагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгогджээ. 2002 - 2006 онд 238800 эхэд 19829,1 сая төгрөгийн тэтгэмж зарцуулжээ.

Өнчин хүүхэд үрчлэн авсны тэтгэмжинд бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөн хүмүүжүүлж байгаа эх /эцэг/ үрчлэн авсан хүүхдээ 16 нас хүртэл нь тэтгэмж авах эрх үүсч тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байх бөгөөд улирал тутам олгосон байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаарх холбогдох хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу хүүхэд асарсны, ихэр хүүхдийн, нярай хүүхдийн арчилгааны жирэмсэн болон амаржсаны, өнчин хүүхэд үрчлэн авсаны тэтгэмжүүд 2006 оны 07 сарын 01 -нээс олгогдохгүй болсон байна.

Улсын хэмжээнд 2002 - 2007 онд хүүхэд асарсны тэтгэмжид хамрагдсан эх, эцэг асран хамгаалагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн дүн

Хүснэгт 3

Он	Хүүхэд асарсны		Ихэр хүүхдийн		Өнчин хүүхэд үрчлэн авсны		Нярай хүүхдийн арчилгааны		Жирэмсэн болон амаржсаны	
	Тоо Мянга.хүн	Дүн Сая,төг	Тоо Мянга. хүн	Дүн Сая,төг	Тоо Мянга. хүн	Дүн Сая,төг	Тоо Мянга. хүн	Дүн Сая,төг	Тоо Мянга.хүн	Дүн Сая,төг
2002	57.100	43.437	300	13,0	500	76,0	4600	112,0	49300	4254,1
2003	58.400	48.074	300	11,9	600	96,7	5900	146,0	51500	4189,6
2004	59.100	57.058	300	11,5	600	111,6	7500	186,3	54500	4294,4
2005	53.900	57.369	400	12,6	700	112,2	6700	166,0	45600	4134,9
2006	44.300	56.455	200	5,8	400	92,4	3300	82,6	37900	2956,1
2007	22.300	148.46	-	-	400	68,8	-	-	-	-
Дүн	295,1	410,9	1500	54,8	3200	577,7	28000	692,9	238800	19829,1

2006 - 2012 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаарх холбогдох хуулиудад хэд хэдэн удаа өөрчлөлт орсон бөгөөд 0-2 настай хүүхдээ харж асарч байгаа эцэг эх асран хамгаалагчдад дараахь тэтгэмжүүдийг олгожээ.

Улсын хэмжээнд 2006 - 2012 онд хүүхэд асарсны зарим тэтгэмжид хамрагдсан эх, эцэг асран хамгаалагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн дүн

Хүснэгт 4

Он	Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн		Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж		3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд 1 удаа	
	Тоо Мянга.хүн	Дүн Сая,төг	Тоо Мянга.хүн	ДүнСая,төг	Тоо Мянга.хүн	Дүн Сая,төг
2006	20200	901,2	-	-	-	-
2007	77500	12732,9	-	-	-	-
2008	-	-	91200	15,753,6	1400	90,2
2009	-	-	91700	16,184,9	2300	165,1

2010	-	-	87766	17,202,4	2100	258,2
2011	-	-	85200	20,746,9	1800	186,7
2012	-	-	89871	32,358,9		
Дүн	97700	13634,1	445737	102,2	7600	700,2

Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн тэтгэмжийг 2006 оны 7 сарын нэгнээс шинээр олгож эхэлсэн бөгөөд 2006 - 2007 онд 97700 эхэд 13634,1 сая төгрөгийн тэтгэмж олгожээ. 2007 оны 01 сарын 04 -ний өдрөөс хууль нэмэлт өөрчлөлт орж энэ тэтгэмжийг түр зогсоосон. 2010 оны 01 сарын 1 -нээс хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж,шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжуудыг зогсоож жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжийг нөхцөлт мөнгөн тэтгэмжийн зардлаас олгож эхэлжээ. Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж, 3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд 1 удаа олгох тэтгэмжийг 2008 оны 02 сарын 24 -нөөс шинээр олгож эхэлсэн.

Хүүхэд асарсны тэтгэмжийг 2 нас хүртэл олгох тохиолдолд улсын төсөвт нөлөөлөх нөлөөлөл.

Монгол Улсын Үндэсний статстикийн хорооны “Статистикийн бюллетень”-д хүн амын тоо 2012 оны жилийн эцэст урьдчилсан дүнгээр 2869.5 мянга, үүнээс Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо 2762.4 мянга болж, оны эхнээс 57.9 мянган хүн буюу 2.1 хувиар өслөө. Улсын хэмжээнд 2012 онд 74474 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 74778 болж, өмнөх оныхоос амаржсан эхийн тоо 4146 эхээр буюу 5.9 хувь, хүүхдийн тоо 4202 хүүхдээр буюу 6.0 хувиар өссөн байна гэжээ.

Улсын хэмжээгээр 2012 онд нялхсын эндэгдэл 1143 болж, өмнөх оныхоос 9 хүүхэд буюу 0.8 хувь, 1-5 хүртэлх насандаа 253 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 5 хүүхэд буюу 1.9 хувиар буурсан байна. Үндэсний статистикийн хорооноос гаргадаг улсын нийгэм эдийн засгийн тогтмол мэдээлэл дэх хүн амын статистик мэдээний ангилалд 0 - 5 насны ангилал байхаас бус 0-2 насны ангилал байдаггүй учраас уг мэдээллийг албан ёсоор гаргуулахад багагүй цаг хугацаа шаардагдах болсон юм. Иймд судалгааг шуурхай гаргах үүднээс 2012 оны төрөлтийн статистик дээр үндэслэн 2 нас хүртэл хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцгийн нийлбэр тоог тооцов. Шаардлагатай гэж үзвэл 2 нас хүртэл хүүхэдтэй эх/өрх толгойлсон эцэг/-ийн нарийвчилсан тоог Улсын Их Хурлын гишүүний албан тоотоор Үндэсний Статистикийн хороогоор гаргуулж болох юм.

Хүүхдийг 2 нас хүртэл асрах эхийн тоог гаргахын тулд 2011 - 2012 онд амаржсан эхийн тоог үндэс болгов. 2011-2012 онд амаржсан эхийн тоо 70128+74474 =140602 эх байна. Мөн энэ хугацаанд нялхсын эндэгдэл 1152+1143= 2295 байсан байна. Эндээс 140602-2295=138307 эх, өрх толгойлсон эцэг байна гэж үзэж болох юм.

Дэлхийн зарим улс орны нийгмийн халамжийн практикаас авч үзэхэд хүүхдээ асарсны тэтгэмжийн сард олгох хэмжээг дор дурдсанаар тогтоодог байна. Үүнд:

- Сарын үндсэн цалин, хөлс
- Сарын дундаж цалин хөлс
- Улсын хэмжээний цалин хөлсний доод хэмжээ
- Амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ
- Гэр бүлийн сарын нийт орлогын тодорхой хувиар гэх мэт хувилбарууд байгаа юм.

ТӨР MN СУДАЛГААНЫ САН

Цаашилбал ажил эрхэлдэг, эрхэлдэггүй ялгаагүй бүх эхчүүдэд ялгаагүй олгох бол улсын хэмжээний дундаж цалингийн хэмжээгээр, мөн ийм цалингийн тодорхой хувиар, баталгаат доод цалин, амжиргааны баталгаажих доод түвшингийн тодорхой хувь хэмжээгээр гэх мэтчилэн олон хувилбар байж болох юм.

Монгол Улсын “Нийгмийн халамжийн тухай” хууль, Засгийн газрын 2012 оны 81 дүгээр тогтоолын дагуу жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн хэмжээ сард 48000 төгрөг, хамрагдаж байгаа эх/өрх толгойлсон эцэг/ -ийн тоо 90 шахам мянга байгаа бөгөөд үүнд жилд ойролцоогоор 4,3 тэрбум төгрөг /өнгөрсөн онд YII сарын 1-нээс энэ хэмжээг мөрдсөн учир гүйцэтгэл нь нийт мөнгөн дүнг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа/ зарцуулахаар байна. Энэ тэтгэмжийн оронд хүүхэд асарсны тэтгэмжийг олгоно гэж үзээд дээр дурдсан зарим хувилбаруудаас манайд авч болох хувилбаруудаар тэтгэмжийн хэмжээг улсын дүнгээр тооцоход улсын төсөвт ямар ачаалал нэмэгдэхийг авч үзвэл:

1. Сарын цалин хөлсний улсын дундажаар олгоно гэж үзвэл:

ХАТ = 12 х ДЦ х N

ХАТ - хүүхэд асарсны тэтгэмж;

ДЦ - улсын хэмжээний сарын дундаж цалин /401344,7 2012 оны III улирлын/;
N- тэтгэмжид хамрагдах эх/ өрх толгойлсон эцэг/-ийн тоо:

а/ 2 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 401344,7 х 138307 = 666 105 377 074.8 ₮ буюу 666,1 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **661,8** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

б/ 1 нас 6 сар хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 401344,7 х 92205 = 444 071 856 762₮ буюу 444,1 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **439,8** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

в/ 1 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 401344,7 х 74474 = 358 676 942 253,6 буюу 358,7 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **354,3** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

2. Цалингийн доод хэмжээгээр олгоно гэж үзвэл:

ХАТ = 12 х ЦБТ х N

ЦДХ - сарын баталгаат цалингийн түвшин/140400₮/

а/ 2 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 140400 х 138307 = 233 019 633 600 ₮ буюу 233,0 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **228,7** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

б/ 1 нас 6 сар хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 140400х92205 = 155 346 984 000₮ буюу 155,3 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн

4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **151,0** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

в/ 1 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ= 12 х 140400 х 74474 = 125 473 795 200₮ буюу 125.5 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **121.2** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

3. Амьжиргааны баталгаажих доод түвшингээр олгоно гэж үзвэл:

ХАТ= 12 х АБДТ х N;

АБДТ-амьжиргааны баталгаажих доод түвшин/108000₮/

а/ 2 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ= 12х108000х 138307 = 179 245 872 000 ₮ буюу 179,2 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **174,9** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

б/ 1 нас 6 сар хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х1 08000 х 92205 = 119 497 680 000₮ буюу 119,5 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **115,2** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

в/ 1 нас хүртэл тэтгэмж олгоход;

ХАТ = 12 х 108000 х 74474 = 96 518 304 000₮ буюу 96,5 тэрбум төгрөг болж байна. Үүнээс жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд олгодог тэтгэмжийн 4,3 тэрбум төгрөгийг хасч тооцвол **92,2** тэрбум төгрөгөөр төсвийн ачаалал нэмэгдэхээр байна.

Түүнчлэн 2 болон түүнээс дээш ихэр хүүхэд асарсны тэтгэмжийг ялгавартай тооцдог аргачлал байж болно. Гэхдээ манай улсын хувьд ихэр хүүхдийн тэтгэмжийг тусгайлан тогтоосон. Тэтгэмжийг хугацааны хувьд заавал шууд 2 нас хүртэл гэхгүйгээр 1 нас, 1нас 6 сар, 2 нас гэсэн үе шаттай шилжих хувилбар ч байж болох юм.

* * *

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Гадаадын зарим улс орны хүүхэд асрах тэтгэмж олгохтой холбогдсон харилцаа

Дэлхийн улс орнууд хүүхэд асрах тэтгэмжийн талаар өөр өөрсдийн бодлого, хууль эрх зүйг боловсруулан хэрэгжүүлдэг байна.

1. Оросын Холбооны Улс

Тус улсад 1995 онд “Хүүхэдтэй иргэдэд үзүүлэх төрийн тэтгэмжийн тухай” Холбооны хуулийг баталсан ба энэхүү хуулийн дагуу дараах тэтгэмжүүдийг тогтоон олгож байна[54]. Үүнд:

[54] http://base.consultant.ru

UIH.MN
СЭДАЛГААНЫ

Тэтгэмжийн төрөл	Тэтгэмжийн хэмжээ (2012 оны 1дүгээр сарын 1-ээс)	Тэтгэмжийн хэмжээ (2013 оны 1дүгээр сарын 1-ээс 1.055 коэффициентоор индекжүүлсэн байдлаар)
Хүүхэд төрөхөд олгодог нэг удаагийн тэтгэмж	12 405.32 руб.	13 087. 61 руб.
Хүүхдээ 1.5 нас хүртэл нь асарсан заавал даатгалд хамрагдсан болон ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдэд олгодог сар бүрийн тэтгэмж	Анхны хүүхэд -2 326 руб. Хоёр дахь болон дараагийн - 4 651.99 руб.	Анхны хүүхэд - 2 453.93 руб. Хоёр дахь болон дараагийн - 4 907.85 руб.
Хугацаат цэргийн албан хаагчийн жирэмсэн эхнэрт олгодог нэг удаагийн тэтгэмж	19 645.12 руб.	20 725.60 руб.
Хугацаат цэргийн албан хаагчийн хүүхдэд олгодог сар бүрийн тэтгэмж.	8419,34 руб.	1.40 руб.

“Хүүхэдтэй иргэдэд үзүүлэх төрийн тэтгэмжийн тухай” Холбооны хуулийн дагуу олгогдох дээрх тэтгэмжүүдтэй холбоотой ОХУ-ын Засгийн газрын 2009 оны 1100 дугаар Тогтоол[55], ОХУ -ын Эрүүлийг хамгаалах, нийгмийн хөгжлийн яамны сайдын 2009 оны 1012 дугаар тушаал зэрэг эрх зүйн баримт бичгүүд үйлчилж байна[56]. Хүүхдийг асарсан тэтгэмжийн хувьд ОХУ-д дээр дурдсан хуулийн дагуу 1.5 жил хүртэл асарсны тэтгэмжийг яг биечлэн асарч буй хүнд нь ажил эрхэлсэн эсэх, суралцаж байгаа эсэхээс үл хамааран олгодог байна.

Хүүхэд төрөхөд нэг удаа олгодог тэтгэмжийг мөн адил бүх эмэгтэйчүүд, эхчүүдэд олгодог. ОХУ-ын Хөдөлмөрийн хуулийн дагуу хүүхэд төрүүлсэн эх хүсэлт гарган хүүхдээ 3 нас хүртэл нь асарч болох ба үүнээс 1.5 жилд нь “Хүүхэдтэй иргэдэд үзүүлэх төрийн тэтгэмжийн тухай” Холбооны хуульд заасан тэтгэмжийг олгоно. Харин 3 нас хүртэл нь асрах тохиолдолд үлдсэн 1.5 жилд нь сар бүр 50 рублийн нөхөн олговор олгодог. 2011 оноос 6 сараас ОХУ-ын Төрийн Думд хүүхэд асарсны тэтгэмжийг 1.5 нас хүртэл байсныг 3 нас хүртэл нь олгохоор өөрчлөх зорилготой хуулийн төсөл өргөн баригдсан ба одоогоор 2013 оны Төрийн Думын хэлэлцэх хуулийн төслийн жагсаалтанд оруулах шийдвэр гарсан байна.

2. Бүгд Найрамдах Узбекистан Улс

Узбекистан улсын Ерөнхийлөгчийн 2002 оны “Нийгмийн эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх зорилтот тусламжийг нэмэгдүүлэх тухай”[57] Зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор БНУзУ-ын Хөдөлмөр, Хүн амын нийгмийн хамгааллын яамнаас 2002 онд “Ажил эрхэлж байгаа эхэд

[55] Постановление Правительства РФ от 29.12.2009 № 1100 «Об утверждении Положения об исчислении среднего заработка (дохода, денежного довольствия) при назначении пособия по беременности и родам и ежемесячного пособия по уходу за ребенком отдельным категориям граждан»

[56] Министерство здравоохранения и социального развития РФ, Приказ от 23 декабря 2009г. №1012 “Об утверждении порядка и условий назначения и выплаты государственных пособий гражданам, имеющим детей”.

[57] Указ Президента Республики Узбекистан от 25 января 2002 года № УП-3017 «Об усилении адресной поддержки социально уязвимых слоев населения»

хүүхдээ хоёр нас хүртэл нь асарсны сар бүрийн тэтгэмж тогтоож, олгох тухай Журам”[58], мөн “Ажил эрхлэхгүй байгаа эхэд хүүхдээ хоёр нас хүртэл нь асарсны сар бүрийн тэтгэмж тогтоож, олгох тухай Журам”[59]-ыг тус тус батлан гаргажээ. “Ажил эрхэлж байгаа эхэд хүүхдээ хоёр нас хүртэл нь асарсны сар бүрийн тэтгэмж тогтоож, олгох тухай Журам”-ын дагуу хүүхэд асарсны сар бүрийн тэтгэмжийг хүүхдийг хоёр нас хүртэл нь түүнийг биечлэн асарсан эх, эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх/эцэг/ -д олгоно.

Хүүхэд асарсны сар бүрийн тэтгэмжийг хэдэн хүүхэд асарч байгаа, тэтгэмж авч байгаа хүний ажилласан жилээс үл хамааран Узбекистан улсад тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. Ажил эрхэлдэг (суралцдаг, цэргийн албаа хааж буй) эхчүүдэд сар бүрийн тэтгэмжийг ажлын газар нь (сургууль, цэргийн албаа хааж буй газар) захиргааны шийдвэрийг үндэслэн тогтооно.

Ажил эрхэлдэг эх (эхийг орлох хүмүүс) хүүхэд асарсны тэтгэмжийг сар бүр авахын зэрэгцээ бүрэн бус ажлын цагаар болон гэрээгээр хөдөлмөр эрхлэх эрхтэй ажээ. “Ажил эрхлэхгүй байгаа эхэд хүүхдээ хоёр нас хүртэл нь асарсны сар бүрийн тэтгэмж тогтоож, олгох тухай журам”-ын дагуу хүүхэд асарсны сар бүрийн тэтгэмжийг хүүхдийг 2 нас хүртэл нь түүнийг биечлэн асарсан эх, эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, үрчилж авсан эх/эцэг/, сургуульд төлбөртэй суралцдаг эхчүүд (эхийг орлох хүмүүс), хуулийн этгээд байгуулаагүйгээр худалдаа эрхэлж байгаа эхэд (эхийг орлох хүмүүс) тосгон, хот айлын иргэдийн хурал, цуглааны шийдвэрийг үндэслэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас тогтооно.

Хүүхэд асарсны сар бүрийн тэтгэмжийг хэдэн хүүхэд асарч байгаа, тэтгэмж авч байгаа хүний ажилласан жилээс үл хамааран Узбекистан улсад тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. Хүүхэд асарсны тэтгэмж тогтоолгохын тулд сүүлийн 3 сарын гэр бүлийн орлогын тухай лавлагааг гаргаж өгнө. Түүнчлэн ажил эрхлээгүй эхчүүд хүүхэд асарсны тэтгэмжид хамрагдахын тулд тодорхой нөхцөл буюу тухайн гэр бүлд ийм тэтгэмж хэрэгтэй байгааг илэрхийлсэн тодорхойлолт шаардлагатай. Өөрөөр хэлбэл тухайн гэр бүлийн нэг гишүүнд ногдох өрхийн орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлснээс их байж болохгүй гэсэн нөхцөл бий.

3. Бүгд Найрамдах Чех улс[60]

Олон улсад хуулиараа хүүхдийн асаргааны урт хугацааны чөлөөтэй тэтгэмж олгодог орнууд бол Төв Европын орнууд байдаг байна. Үүний нэг нь Чех улс юм. Хүүхэд асаргааны тэтгэмжийн асуудлыг “Хөдөлмөрийн тухай хууль” /Labour Law in Czekh Republic/ болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг. Тус улсад эхчүүд хүүхдээ төрүүлсний дараа 3 жил чөлөөлөгдөн гэртээ хүүхдээ асардаг нь тогтсон стандарт бөгөөд энэ нь хүүхдийн тооноос хамааран илүү урт ч байж болдог байна.

Эхчүүд хүүхэд асрах чөлөөгөө 2, 3 эсвэл 4 жилээр авах уу гэдгээ сонгодог. Энэчлэн хэдийгээр энэ нь практик амьдрал дээр нэг их өргөн дэлгэр биш боловч аавууд эхийн оронд хүүхэд асаргааны чөлөө авах боломжтой байдаг байна. Ийнхүү чөлөө авсан бүх хугацаанд эхчүүд төрийн халамж дэмжлэгийг хүртэж байдаг байна.

[58] Положение “О порядке назначения и выплаты работающим матерям ежемесячного пособия по уходу за ребенком до достижения им возраста двух лет”

[59] Положение “О порядке назначения и выплаты неработающим матерям ежемесячного пособия по уходу за ребенком до достижения им возраста двух лет”

[60] Haas, Elizabeth. “Maternity Leave in the Czech Republic”. Retrieved 5 December 2012. http://en.wikipedia.org/wiki/Parental_leave

Үүнийг Чехийн Хөдөлмөрийн хуулийн (Labour Law in Czekh Republic) 195[61]-р зүйлд Эцэг эхийн хүүхэд асаргааны чөлөөний тухай:

- ✓ Эх хүүхдээ төрүүлэх болон түүнийг асрахад 28 долоо хоногийн буюу 196 хоногийн тэтгэмжит чөлөө авах эрхтэй. Харин нэг удаад 2 болон түүнээс дээш тооны /ихэр/ хүүхэд төрүүлвэл 37 долоо хоногийн хүүхэд асрах тэтгэмжит чөлөө авах эрхтэй.
- ✓ Хуульд зааснаар эх хүүхэд төрүүлэхээр тооцоологдсон өдрөөс 6 долоо хоногийн өмнө чөлөөг авах эрхтэй ба үлдсэн 22 долоо хоногийн чөлөөг төрснөөс хойш хүүхдээ асрахад зориулан авна. /Харин хугацаанаасаа өмнө төрсөн тохиолдолд төрснөөс хойш 22 долоо хоногийг л авах бөгөөд урьд дутуу эдэлсэн чөлөөний хугацааг нөхөж олгохгүй./ Мөн дээрх чөлөөний хугацаа дууссан тохиолдолд эцэг эх нь хүсвэл хүүхдээ 4 нас хүртэл ажлаасаа чөлөөлөгдөн асрах эрхтэй хэмээн хуульчилжээ.

Чех улсад хүүхэд асаргааны 2 төрлийн тэтгэмж олгодог[62]. Үүнд:

1. Эхийн тэтгэмж /Maternity allowance/- Энэ нь эх хүүхдээ төрүүлэхээс өмнө 6 долоо хоног, хүүхдээ төрүүлсний дараа 22 долоо хоног, нийт 28 долоо хоногийн хүүхэд асрах чөлөөний тэтгэмж юм. Үүнийг зөвхөн эхэд олгох бөгөөд 2009 онд хамгийн дээд хэмжээ нь 28.990 Чех крон /CZK/ буюу 400 доллар байсан ба энэ нь аажмаар өсөх хандлагатай байгаа аж. Эхийн тэтгэмжийг олгохдоо:
   - Ажил эрхэлдэг эх цалин болон орлогын 70 хувиар
   - Хувиараа болон тодорхой орлоггүй эх тэтгэмж авахаасаа өмнө наанадаж 1 жилд 180 өдөр эрүүл мэндийн даатгалыг заавал төлсөн байх шаардлагатай. ЭМД-ийг төлсөн хувь хэмжээнээс шалтгаалан эхийн тэтгэмж олгох хувь хэмжээг тогтооно.
   - Гадаадын иргэн бол энэ тэтгэмжийг авахаасаа өмнө 1 жилд наанадаж 270 өдөр эрүүл мэндийн даатгалыг төлсөн байх ба хөдөлмөрийн гэрээ нь хүчинтэй байгаа тохиолдолд 70 хүртэл хувь тогтоон олгодог байна.

2. Эцэг эхийн тэтгэмж /Parental allowance/ - Энэ нь эхийн хүүхэд асрах 28 долоо хоногийн чөлөөний хугацаа дуусгавар болсны дараа эцэг эхийн хэн нэг нь хүүхдээ асрах бол хүүхдийг 4 нас хүртэл хугацаанд асрах эрх үүсэх юм. Энэ хугацаанд хүүхэд асрах эцэг болон эх нь улсаас хүүхдээ асарсны тэтгэмж авах бөгөөд энэ нь эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдсан, Чех улсад байнгын оршин суух хаягтай байхыг шаарддаг. Нийгмийн халамжийн байгууллагаас олгодог учир өрхийн орлогоос хамаарахгүй хичнээн хугацаанд хүүхдээ асрахаас шалтгаалан тэтгэмжийн дүн хэмжээ өөр байдаг байна. Тухайлбал:
   - 2 жил асрахаар төлөвлөсөн бол 1 сард хамгийн ихдээ 11400 CZK авна.
   - 3 жил асрахаар төлөвлөсөн бол 7600 CZK авна.
   - 4 жил асрахаар төлөвлөсөн бол 3800 CZK авна.

Чех улс нь хүүхэд асаргааны тэтгэмжит чөлөөг хамгийн урт хугацаагаар олгодог орон юм. Мөн бүтэн хугацаагаар ажлаас чөлөөлөгдөн хүүхдээ асрахаас гадна ажлын цагийг хорогдуулсан хэлбэрээр буюу цагаар ажиллаж хүүхдээ асрах зохицуулалт ч байдаг байна.

[61] Labour Law in Czekh Republic хэмээх Google дэхь цахим ном. 2010 он .186 х. www.books.google.mn

[62] Maternity financial support http://www.mpsv.cz/en/1603

4. Нидерландын Вант Улс[63]

Нидерланд улс хүүхэд асаргааны асуудлыг чухалчилан үздэг орнуудын нэг юм. Тус улс нь энэ харилцааг “Хөдөлмөр ба халамжийн Хууль” (Work and Care Act), “Хөдөлмөрийн хууль” (Labour Law), “Нидерландын Иргэний Хууль” (The Civil Code of the Netherlands) хуулиудаар зохицуулдаг байна.

Нидерландын “Хөдөлмөр ба халамжийн хууль” (Work and Care Act)-ийн 3:1-д эхчүүдэд хүүхдээ төрүүлсний дараа 16 долоо хоногийн 100%-ийн цалинтай хүүхэд асаргааны чөлөө олгодог. Үүнээс 4-6 долоо хоногийг нь заавал төрөхийн өмнө авна. Хэдийгээр аавуудад 100%-ийн цалинтай 2-хон өдрийн чөлөө олгодог боловч эцэг эхийн хэн хэн нь ажлаасаа 26 долоо хоног хүртлэх хугацаагаар цалингүй чөлөө авч болдог байна.

Хүүхэд асрах чөлөөг богиносгосон цагаар авбал илүү удаан хугацаагаар авч болно. Ажилчин, албан хаагчдын ажлын цаг ба гэр бүлийн үүрэг хариуцлагаа зохицуулах үндсэн тогтолцоо нь Ажлын Цагийг Зохицуулах Хууль (the Working Time Adjustment Act)-иар ажлын цагаа багасгах арга байдаг байна. Үүнд хэрвээ тухайн нэг компаны ашиг сонирхолтой ноцтой зөрчилдөхгүй нөхцөлд ажилтан, албан хаагч хүсэлт гарган өөрийн ажлын цагийг нэмэх ба багасгах эрхтэй аж.[64]

Хүүхэд төрүүлсэн эх бүр хүүхэд асаргааны тэтгэмжийг 16 долоо хоногт авах ба дараах хувь хэмжээгээр авна. Тухайлбал:

- Ажил эрхэлдэг эх цалингийн 100 хувьтай тэнцэх тэтгэмж
- Хувиараа хөдөлмөр эрхэлдэг бол өмнөх жилийн орлогын хэмжээ болон ажилласан цагаас хамаарна. Хэрэв жилд хамгийн багадаа 1225 цаг буюу 7 сар ажилласан бол үүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний орлого гэж үзэн түүнтэй тэнцэх тэтгэмжийг 100 хувь олгоно[65]
- Хүүхэд асаргааны тэтгэмжийн хувь хэмжээ нь эхийн цалингийн дүн хэмжээнд үндэслэх ба хамгийн ихдээ өдөрт 174.64 евроос хэтрэхгүй.

Нидерланд улс нь хүүхэд асрах чөлөөний тэтгэмжийг олгохдоо эхийн цалингийн орлого болон өрхийн орлогыг харгалзан тэтгэмжийг олгодог бөгөөд хүсвэл 26 долоо хоногоос 8 нас хүртэл нь цалингүй буюу тэтгэмжгүй хүүхдээ асрах чөлөө авч болдог байна

* * *

Ашигласан материал

1. Федеральный закон “О государственных пособиях гражданам, имеющих детей” 1995г. http://base.consultant.ru
2. Постановление Правительства РФ от 29.12.2009 № 1100 «Об утверждении Положения об исчислении среднего заработка (дохода, денежного довольствия) при назначении пособия по беременности и родам и ежемесячного пособия по уходу за ребенком отдельным категориям граждан» .http://base.consultant.ru
3. Министерство здравоохранения и социального развития РФ, Приказ от 23 декабря 2009г. №1012 “Об утверждении порядка и условий назначения и выплаты государственных пособий гражданам, имеющим детей”. http://r51.fss.ru
4. Указ Президента Республики Узбекистан от 25 января 2002 года № УП-3017 «Об усилении

[63] Parential leave http://en.wikipedia.org/wiki/Parental_leave

[64] The Netherlands https://docs.google.com/viewer?a=v&q=cache:DY-

[65] A short survey Social Security the Netherlend . page 19. Maternity for Self-employed persons /ZEZ Scheme/ www.goverment.nl

адресной поддержки социально уязвимых слоев населения». http://www.lex.uz/

5. Положение “О порядке назначения и выплаты работающим матерям ежемесячного пособия по уходу за ребенком до достижения им возраста двух лет”. http://www.lex.uz/
6. Положение “О порядке назначения и выплаты неработающим матерям ежемесячного пособия по уходу за ребенком до достижения им возраста двух лет”. http://www.lex.uz/
7. The Netherlands https://docs.google.com/viewer?a
8. A short survey Social Security the Netherlend . page 19. Maternity for Self-employed persons /ZEZ Scheme/ www.goverment.nl
9. Maternity financial support http://www.mpsv.cz/en/1603
10. Parential leave http://en.wikipedia.org/wiki/Parental_leave
11. Maternity allowance, paternity and parental leave http://www.easyexpat.com/en/guides/netherlands/amsterdam/work/benefits-package.htm
12. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2003
13. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2004
14. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2005
15. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2005
16. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2007
17. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2008
18. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2009
19. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2010
20. Монгол Улсын Статистикийн эмхтгэл 2011
21. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Статистик блютень 2012

4
БҮЛЭГ

ХУУЛЬ, ЭРХЗҮЙН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙТИЙН АЛБАНД АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР (ЛАВЛАГАА - МЭДЭЭЛЭЛ)

Р. Хатанбаатар

I. НҮБ -ын төрөлжсөн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, түүнчлэн АНУ -ын “Олон улсын хөгжлийн агентлаг”, “Муж улсуудын шүүхийн үндэсний төв” зэрэг судалгааны байгууллагаас санхүүжүүлж монголын иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор гүйцэтгэсэн судалгаанууд Монгол дахь авлигын төлөв байдал, авлигын тухай иргэдийн төсөөлөл, хандлагыг бодит байдлаар тодорхойлоход ач холбогдол бүхий хангалттай мэдээлэл агуулсан байна.

Дээрх судалгааны тайлан, мэдээ мэдээллийг бүхэлд нь дүгнэж үзвэл эдүгээ Монгол Улсад төрийн өндөр албан тушаалтны хүрээний авлигын талаар дараах төсөөлөл хийж болохоор байна[66]. Үүнд:

- Авлига төрийн албаны бүхий л салаа мөчирт өргөн тархсаны дотор улс төрийн хүрээнд, ялангуяа улс төрөөр дамжин төрийн өндөр албан тушаалд хүрэгсэд / судалгаанд “Өндөр түвшин”, “Элит” гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна/ -ийн дунд авлига илүү их байна.
- Улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлийн сонирхлын зөрчил, сонгуулийн болон намын санхүүжилт, сонгуулийн тогтолцооны авлигад үзүүлэх нөлөө маш хүчтэй хэвээр байна.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал суларч, улс төрийн намуудаас ихээхэн хараат болсны гадна “төрийн аппарат данхайж”, улсын төсөвт эзлэх зардлын хэмжээ, хувийн жин өсөн нэмэгдсэн ч иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар улам муудаж байна.
- Улс төрийн намын дараа авлигад хамгийн ихээр автсан байгууллагаар цагдаа, газрын алба, шүүх, мэргэжлийн хяналт, татвар зэрэг байгууллагыг олон жил ээлжлэн нэрлэж байна.

АНУ -ын Олон улсын хөгжлийн агентлагийн тайланд авлигатай тэмцэх гол анхаарал өндөр албан тушаалд сонгогдсон болон томилогдсон төрийн албан хаагчдыг хамарсан авлига руу чиглэх ёстой гэж үзжээ:

> Захиргааны авлига нь төрийн үр ашгийг багасгаж, эдийн засгийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг бууруулж байгаа ч Монголд оршиж байгаа хамгийн хүнд шинжийн авлига нь элитийн түвшний авлига юм. Үүний шалтгаан нь элитийн түвшинд захиргааны түвшний авлигаас илүү их хэмжээний мөнгө эргэлддэг болон илүү олон хэлцэл хийгддэгтэй л зөвхөн холбовол учир дутагдалтай.
>
> Эхний шалтгаан нь магадгүй үнэн байх, харин сүүлийн шалтгааныг батлахад хэцүү. Элит түвшний авлига Монголд нэн тулгамдсан асуудал болоод байгааг дараах шалтгаантай холбож үзэх нь зүйтэй.
>
> a. энэ нь захиргааны авлигын өнгө, жишгийг тогтоодог бөгөөд одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр нь хадгалж үлдэх гүн сонирхлыг агуулж байдаг
> b. энэ нь бусад бүх сонирхлыг, түүнийг дотор ардчиллыг бэхжүүлж, өргөн хүрээтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих сонирхлыг шахах магадлал бүхий улс төр, эдийн засгийн тогтолцоог улам бэхжүүлж болзошгүй юм.[67]

II. Авлигалаас урьдчилан сэргийлэх нэг гол нөхцөл нь сонирхлын зөрчлийг хуулиар сайн тодорхойлж зохицуулах явдал юм.

Төрийн өндөр албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн гадаад улсуудад байгаа хөрөнгө, мөнгөний асуудлын талаар гадны бусад орнуудын хууль тогтоомжинд зарим заалтууд тусгагдсан байдаг байна.

1. БНХАУ

БНХАУ -ын 2010 оны 7 дугаар сарын 11 -ний өдрийн Хятадын Коммунист Намын Төв хороо, Засгийн газрын Тамгын газраас гаргасан “Удирдах албан тушаалтнуудын хувийн асуудлыг өргөн мэдүүлэх тухай” /шинэчилсэн/ журмаар албан тушаалтнууд жилд нэг удаа журамд заасан хувийн хөрөнгийг мэдүүлэх үүрэгтэй.

Журмын 2 дугаарт хувийн хөрөнгөө мэдүүлэх албан тушаалтан, 3 дугаарт хувийн орлогоо мэдүүлэгчийн гэрлэлтийн байдлын өөрчлөлт, түүний хүүхдийн харьяалал, эрхэлж буй ажлын байдал, 4 дүгээрт, хувийн хөрөнгө мэдүүлэгчийн орлого, үл хөдлөх хөрөнгийн байдлыг заасан байна.

Удирдах албан тушаалтнууд дараахи тохиолдолд хувийн гэрлэлтийн байдлын өөрчлөлт, түүний үр хүүхдийн гадаадад цагаачилсан байдал, эрхэлж буй ажлыг мэдүүлэх ёстой.

a. албан тушаалтны гэрлэлтийн өөрчлөлт
b. албан тушаалтны хувиараа гадаадад гарсан талаарх бичиг баримтын байдал
c. албан тушаалтны гадаадад зорчсон байдал
d. хүүхэд нь гадаадын иргэн болон харьяалалгүй иргэнтэй гэр бүл болсон байдал
e. хүүхэд нь Хонг Конг, Макао, Тайванийн иргэнтэй гэр бүл болсон байдал
f. гэр бүлийн хүн, хүүхэд нь цагаачилсан байдал
g. гэр бүлийн хүн, хүүхдийн ажлын байдал, үр хүүхдийн гадаадад ажиллаж буй байдал
h. гэр бүлийн хүн, хүүхэд нь хуулийн байгууллагаар мөрдөгдсөн байдал

2. ОХУ

2012 оны 12 дугаар сарын 21 -д Төрийн Дум “ОХУ-ын зарим хууль тогтоомжийн актад өөрчлөлт оруулах тухай” хуулийг батлан гаргасан бөгөөд уг хуулиар төрийн өндөр албан тушаалтнуудын гадаад дахь хөрөнгө, дансны талаар зарим нэмэлт зохицуулалт хийгдсэн юм. Энэ хууль 2013 оны 1 дүгээр сарын 1 -нээс үйлчилж эхэлсэн. Хуулийн гурван заалт нь:

Зүйл 1

Энэ хуулийн нэгдүгээр зүйлээр 2008 онд батлагдсан “Коррупцийн эсрэг хууль“-ийн 11 дүгээр зүйлд дараах агуулгатай 7 дугаар хэсгийг нэмсэн:

> “7. ОХУ -ын төрийн албан тушаалтан, ОХУ -ын субьектийн төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, цэргийн

[66] http://info.worldbank.org/governance/wgi/pdf/c147.pdf

[67] USAID. (2005). Assessment of Corruption in Mongolia, Final Report. Mongolia: Ulaanbaatar. p3.

албан хаагч, дотоод явдлын яам, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагууд, хар тамхины хяналтын байгууллагууд, гаалийн байгууллага, мөрдөн байцаах албаны ажилтнууд, ОХУ -ын прокурорын байгууллагын ажилтнууд, төрийн болон нутгийн захиргааны ажилтнууд, тэдний эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдүүдэд албан үүргээ биелүүлэхэд шаардагдахаас бусад тохиолдолд хориглох зүйлс:

- Гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд хадгаламж, данстай байх, хилийн чанадад үл хөдлөх хөрөнгө эзэмших, гадаадын компанийн үнэт цаас эзэмших
- Гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд хадгаламж, данс нээх, хилийн чанадад үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын компанийн үнэт цаас худалдан авах.

Гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд данстай байх болон данс нээлгэхийг хориглосон заалт нь энэ зүйлд дурдсан албан тушаалтнууд, тэдний эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдүүд эмнэлэгийн үйлчилгээ авах шаардлага гарсан үед үйлчлэхгүй”.

Зүйл 2

Энэ хуулийн хоёрдугаар зүйлээр ОХУ -ын Эрүүгийн хуульд дараах нэмэлт оруулсан:

“Зүйл 289.1. “Гадаад дахь данс болон хөрөнгөтэй холбоотой хуулиар тогтоосон хоригийг зөрчих”

1. ОХУ -ын төрийн албан тушаалтан, ОХУ -ын субьектийн төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, цэргийн албан хаагч, дотоод явдлын яам, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагууд, хар тамхины хяналтын байгууллагууд, гаалийн байгууллага, мөрдөн байцаах албаны ажилтнууд, ОХУ -ын прокурорын байгууллагын ажилтнууд, төрийн болон нутгийн захиргааны ажилтнууд гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд хадгаламж, данстай байх, хилийн чанадад үл хөдлөх хөрөнгө эзэмших, гадаадын компанийн үнэт цаас эзэмших, гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд хадгаламж, данс нээх, хилийн чанадад үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын компанийн үнэт цаас худалдан авахыг хориглосон хуулийн заалтыг зөрчсөн бол таваас арван сая рублээр торгох, эсвэл тав хүртэл жил хорих ял оноож, тодорхой албан тушаалыг гурав хүртэл жил хаших эрхгүй байхаар шийтгэнэ”.

Зүйл 3

1. ОХУ -ын төрийн албан тушаалтан, ОХУ -ын субьектийн төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, цэргийн албан хаагч, дотоод явдлын яам, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагууд, хар тамхины хяналтын байгууллагууд, гаалийн байгууллага, мөрдөн байцаах албаны ажилтнууд, ОХУ -ын прокурорын байгууллагын ажилтнууд, төрийн болон нутгийн захиргааны ажилтнууд Холбооны энэ хууль хүчин төгөлдөр болох өдрийн байдлаар байгаа гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд буй хадгаламж, дансаа хаах, хилийн чанад дахь үл хөдлөх хөрөнгө болон гадаадын компанийн үнэт цаасаа бусдад шилжүүлэх, эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийнхээ гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд буй хадгаламж, дансыг хаах, хилийн чанад дахь үл хөдлөх хөрөнгө болон гадаадын компанийн үнэт цаасаа бусдад шилжүүлэх ажлыг 2013 оны 6 дугаар сарын 1 -ний дотор гүйцэтгэсэн байх үүрэгтэй.

2. Энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт заагдсан хөрөнгө, үнэт цаас өвлөн авсан ОХУ -ын төрийн албан тушаалтан, ОХУ -ын субьектийн төрийн албан тушаалтан, нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, цэргийн албан хаагч, дотоод явдлын яам, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагууд, хар тамхины хяналтын байгууллагууд, гаалийн байгууллага, мөрдөн байцаах албаны ажилтнууд, ОХУ -ын прокурорын байгууллагын ажилтнууд, төрийн болон нутгийн захиргааны ажилтнууд өөрийн хөрөнгө, үнэт цаасаа болон эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийнхээ хөрөнгө, үнэт цаасыг өвлөн авснаас хойш нэг жилийн дотор бусдад шилжүүлэх үүрэгтэй.
3. Энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт заагдсан албан тушаал, ажилд орсон этгээд тухайн албан тушаалд ажиллаж эхэлсэн өдрөөс зургаан сарын дотор энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт заагдсан өөрийн болон эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийн дансыг хаах, хөрөнгө, үнэт цаасыг бусдад шилжүүлэх үүрэгтэй.
4. ОХУ -ын төрийн албан тушаал, ОХУ -ын субьектийн төрийн албан тушаал, нутгийн захиргааны байгууллагын албан тушаал, цэргийн алба, дотоод явдлын яам, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагууд, хар тамхины хяналтын байгууллагууд, гаалийн байгууллага, мөрдөн байцаах алба, ОХУ -ын прокурорын байгууллага, төрийн болон нутгийн захиргаанд ажиллаж байсан хүмүүс, тэдний эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхэд тухайн этгээд төрийн болон нутгийн захиргааны албанаас халагдсан буюу чөлөөлөгдснөөс хойш гурван жилийн хугацаанд гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд хадгаламж, данс нээх, хилийн чанадад үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын компанийн үнэт цаас худалдан авах эрхгүй.

Гадаад улсын нутаг дэвсгэрт гадаадын банканд данстай байх юмуу данс нээхийг хориглосон энэ заалт энэ хэсэгт дурдагдсан этгээд болон тэдний эхнэр(нөхөр), насанд хүрээгүй хүүхэд эмнэлэгийн болон боловсролын үйлчилгээ авах тохиолдолд хамаарахгүй.

Нилээд орнуудын авилгын, эрүүгийн болон ашиг сонирхлын тухай хуулиудыг авч үзэхэд төрийн албан хаагчид мөнгөн болон үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас олж авахад хяналт тавьдаг, бүртгэдэг, хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо бүгдэд нь байгаа боловч тусгайлан гадаад улс, гадаадын банк, гадаадын компанийн тухай заалт цөөн орны хуульд заагдсан байдаг бололтой. Харин төрийн албан хаагч мөрийтэй тоглоомын газраар үйлчлүүлэх тохиолдлыг мөнгө угаах аль нэг хэлбэр байж болзошгүй гэж үзэж шалгах тухай заалт хэд хэдэн орны эрүүгийн хуульд байлаа.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ҮНДЭСНИЙ ХЭЛЭЭ ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛ БОЛГОН АШИГЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛС БОЛОН БУСАД ОРНЫ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Д. Жигваагүнсэл

Агуулга

1. Гадаадын зарим орны төрийн албан ёсны хэлний талаар баримталж байгаа бодлого, эрх зүйн зохицуулалт / харьцуулсан мэдээлэл/
    - 1.1 Хятад улс
    - 1.2 Франц улс
    - 1.3 Казахстан улс
    - 1.4 АНУ
    - 1.5 Монгол улс
2. Монгол улсын төрийн албан ёсны хэлний бодлого, түүхэн уламжлал
3. Монгол улсын төрийн албан ёсны хэлний орчин цагийн бодлого, өнөөгийн байдал.
4. Судалгааны дүгнэлт.
5. Хавсралт

* * *

ҮНДЭСНИЙ ХЭЛЭЭ ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛ БОЛГОН АШИГЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛС БОЛОН БУСАД ОРНЫ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Аливаа улс орны тусгаар тогтнолын нэгэн хүчин зүйл бол үндэсний албан ёсны хэл юм. Тусгаар улс орон, ард түмнүүд оршсоор байх цагт эх хэл бичгийн асуудал байсаар байх нь гарцаагүй зүйл билээ. Дэлхий нийтээр даяаршлын үйл явц эрчимжиж байгаа өнөө үед улс орон бүр үндэсний эх хэлээ хамгаалан хөгжүүлэх, хэлээрээ дамжуулан үндэсний өвөрмөц дүр төрхөө хадгалах талаар дор дороо бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

1. Гадаадын зарим орны төрийн албан ёсны хэлний талаар баримталж байгаа бодлого, эрх зүйн зохицуулалт

Хэл гэдэг бол нийгмийн харилцааны чухал хэрэглүүр бөгөөд улс үндэстний оршин байхуйн үндэс, тусгаар тогтнолын баталгаа, соёлын чухал өв, бусад улсаас ялгарах гол онцлог юм. Улс орон бүр өөрсдийн газар нутаг, хүн ам, үндэстэн ястан, газарзүйн байршил, нийгэм эдийн засгийн байр суурь зэргээсээ шалтгаалан олон янзын хэлтэй байдаг байна. Гэвч тэдгээрээс албан ёсны хэрэглээнд чухам ямар хэлийг сонгох нь тухайн улсын хэлний бодлогоос хамаардаг ажээ.

Тухайлбал, зарим улс орон бүс нутгийн ялгамжтай олон янзын аялгуу хэлтэй байдаг бөгөөд түүнээс зөвхөн нэг хэлийг төрийн албан ёсны хэлээр сонгон хуульчилж, мөрддөг бол зарим улс орон 2 хэлийг зэрэгцүүлэн хос хэлээр албан хэргийг явуулдаг байна. Мөн нэг хэлийг албан ёсны хэлээр хуульчилж, бусад бүс нутгийн хэлийг хуулиар хүлээн зөвшөөрдөг тохиолдол ч байна.

Ихэнх улс орнууд үндэсний хэлээ албан хэрэгцээний харилцаанд хэрэглэхийг” албан ёсны хэл” хэмээх нэршлээр томьёолдог. Зарим тохиолдолд “төрийн хэл” гэж хуулинд томьёолон хэрэглэх нь ч бий. /Тухайлбал: Монгол, Казахстан зэрэг/ Албан ёсны хэл гэдэг нь тодорхой

нэг улс орон, муж улс, эсвэл бусад бүс нутагт тусгайлсан хуулийн статус бүхий хэл юм. Үндсэндээ улс үндэстний албан ёсны хэл бол тухайн улсын шүүх, парламент ба засаг захиргаанд хэрэглэж буй тэр хэл мөн.

Зарим тохиолдолд улс үндэстний харъяалалгүй эс бөгөөс улс үндэстэнээс хэтийдсэн НҮБ ба Европын Холбоо зэрэг байгууллагууд бас албан ёсны хэлтэй байж болдог байна. Албан ёсны хэлний статус нь ихэвчлэн төр улсын тусгаар тогтнол, соёл, үндэсний үзэл гэх зэрэг улс төрийн өргөн асуудлууд ба, үндэстний цөөнх ба уугуул иргэдийн эрх, цагаач иргэдийн асуудлуудтай салшгүй холбоотой байдаг байна. Хэлний бодлогыг ангилан үзэх олон янзын арга зам бий. Энэ тухайд 1999 онд Лавал Их Сургуулийн нийгмийн хэл шинжээч Жэкюс Леклерс (Jacques Leclerc) CIRAL-ын L’amйnagement linguistique dans le monde хэмээх франц хэлт цахим хуудаснаа нийтэлсэн ажилдаа дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.

Өөр өөр хэлний бодлогуудыг цуглуулах, орчуулах, тэдгээрийг ангилах ажлыг 1988 оноос эхлээд 1994 онд Recueil des lйgislations linguistiques dans le monde (vol. I to VI) at Presses de l’Universitй Laval бүтээлийг хэвлүүлжээ. Уг бүтээлд 470 орчим хэлний тухай хууль ба, Office quйbйcois de la langue fransaise -ын зардлаар хэвлэгддэг тэргүүлэх судалгааны бүтээлүүдийг багтаасан байна. Ингээд 2008 оны 4-р сар гэхэд уг цахим хуудас нь 194 улс орны 354 муж буюу өөртөө засах орны хэл шинжлэлийн дүр зураг ба хэлний бодлого зэрэг багтсан байдаг байна. [3] Харин тухайн улсын болон хэлний том жижиг зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж өөр өөрийн онцлогт тохирсон хэлний бодлоготой байдаг байна. Өөрөөр хэлбэл хүн ам, эдийн засгийн хувьд тэргүүлэх улс орнууд өөрийн хэл соёлоо улам түгээн дэлгэрүүлэх, даяаршуулах бодлоготой байдаг бол эсрэгээр хүн ам цөөн, жижиг улс орнууд өөрийн хэл соёлоо даяаршлын энэ их түрлэгээс хамгаалж авч үлдэх зорилготой байдаг байна.

Олон улсад хэлний стандарт тогтоогч байгууллагуудын жагсаалтыг гаргасан байдаг ба хэлний стандарт (standard languages) тогтоогч байгууллагуудыг ихэвчлэн хэлний академи (language academies) гэж нэрлэдэг. Хэлний академууд нь ихэвчлэн хэлний цэвэр ариун байдлыг (linguistic purism) хадгалан хамгаалахад үйл ажиллагаа нь чиглэж байдаг ба, үндсэндээ маш тодорхой толь бичгүүдийг (prescriptive dictionaries) гаргаж түүгээрээ үгсийн утга ба дуудлагыг тодорхойлон албан ёсоор журамлаж байдаг байна. Тухайлбал, Хэлний стандартыг тогтоогч байгууллага нь үгсийг хэрхэн зөв бичих тухай стандартыг тогтоохын (гэхдээ хүчээр тулгахгүй) зэрэгцээ бас тайлбарлан таниулагчийн үүрэг гүйцэтгэж болно. / Жагсаалтыг хавсралт 1-ээс үзнэ үү/

Төрөөс хэлний бодлогыг хэрэгжүүлэхэд Төр, захиргааны байгууллагууд, хороо зөвлөл, хэлний академиуд, судалгаа шинжилгээний байгууллагууд зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг ба тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн уялдаа холбоотой явуулах асуудлыг төрийн бодлогоор зангидаж байдаг байна.

SHI.MN
СУДАЛГААНЫ САН

Гадаадын зарим орнуудын үндэсний хэлээ хэрхэн хэрэглэх тухай хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээлэл

Хүснэгт 1

№	Улсын нэр	Хууль эрх зүйн актууд	Агуулга	Тавигдах шаардлага	Хэрэгжилт
1	БНХАУ	“БНХАУ-ын Үндсэн хууль” 2000.10.31 ний “Стандарт яриа ба бичгийн хятад хэлний тухай БНХАУ-ын хууль” (Ерөнхийлөгчийн Зарлиг №37-аар батласан)	-БНХАУ-ын Үндсэн хуулиараа Путонгхуа / бээжин / хятад хэлийг албан ёсны хэл хэмээн тунхагласан. -Стандарт яриа бичгийн хятад хэлний тухай хуулийн 2.9-д: ... стандарт яриа болон бичгийн Хятад хэл гэдэг нь Путонгхуа (Бээжин аялгуунд үндэслэсэн нийтлэг яриа ба дуудлага) ба стандартчлагдсан хятад ханз үсгүүдийг хэлж байгаа болно. Путонгхуа ба стандарт хятад ханз үсэг нь энэ болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн байгууллагуудын албан ёсны хэл байна. / Хуулийн дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/	“Стандарт яриа ба бичгийн хятад хэлний тухай хууль”-д Стандарт Хятад хэлийг хэрхэн яаж хэрэглэх тухай бүлэг оруулсан байх ба үүнд хэрэглээ, баримтлах стандарт, тавигдах шаардлага зэргийг тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, -Хятад хэлээр хэвлэгдэж байгаа бүх зүйл стандарт яриа бичгийн хэм хэмжээнд нийцсэн байх, -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн , үйлчилгээний бүхий л үйл ажиллагаанд стандарт яриа бичгийн хэл нь үндсэн хэл байна. -Мөн түүнд ажиллагсад Путонгхуа стандарт яриа болон бичгийн хэлийг бүрэн эзэмшсэн байх гэхчилэн шаардлагуудыг хуульчилж өгсөн байна.	Стандарт яриа ба бичгийн хятад хэлний тухай хуулийн 21-р зүйлд: “Стандарт яриа болон бичгийн хятад хэлтэй холбоотой төлөвлөх, хөтлөх, удирдан чиглүүлэх бүх ажлыг Төрийн Консулын дэргэдэх яриа болон бичгийн хэлний ажлыг эрхэлсэн алба хариуцна. □□Төрийн Консулын харъяаны албадууд тус тусын албанд стандарт яриа ба бичгийн хятад хэлийг хэрэглэх явдлыг засаглана.” гэжээ. Энэ нь Хэл бичгийн улсын хороо гэдэг байгууллага байдаг. Эндээс тогтоож өгсөн стандартыг баримтладаг.
2	Казахстан	1993 оны Үндсэн хууль, 1997.07.11-ний №151.1 дугаар бүхий “Казахстаны хэлний тухай хууль”	-Үндсэн хуулиндаа Казах хэлийг төрийн хэл хэмээн тунхагласан байдаг. -“Казахстаны хэлний тухай” хуулийн 4-р зүйлд: “төрийн хэл бол төрийн захиргаа, хууль тогтоох байгууллага, шүүх ажиллагаа, данс тэмдэглэгээ зэрэг тус улсын бүхий л нийгмийн харилцаанд хүчин төгөлдөр хэл юм. Мөн хуулийн 5-р зүйлд: “Орос хэлийг төрийн агентлаг ба тус муж улсын засаг захиргаанд казах хэлтэй адил тэгш хэмжээнд хэрэглэнэ” гэжээ.	15-р зүйл: -Казах хэл нь төрийн хэл байна. -Боловсролын бүхий л үйл ажиллагаа казах хэлээр явагдана -Албан бичиг болон тамга тэмдэг, бараа бүтээгдэхүүний үнэ, шошго, гэрээ хэлэлцээр зэрэг нь казах болон орос хэл дээр хийгдэнэ.	Гэвч Казахстаны хэлний тухай хуулийн 15-р зүйл нь өнөөгийн байдлаар тэдийлэн сайн хэрэгждэггүй. Дийлэнх боловсролын үйл ажиллагаа орос хэл дээр явагддаг ба томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд орос хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг зэрэг олон талаар казах хэл нь тунхаглалын шинж чанартай байдаг байна.

3	Франц	Франц Улсын Үндсэн хууль,	Франц улс 1539 онд Францын хаант улсын засаг захиргааны хэрэглээнд франц хэлийг албан ёсоор хэрэглэхээр хуульчилсан. Франц хэлэнд бүс нутгийн олон янзын хэл байдаг бөгөөд Франц хэлний тухай хуулийн 75.1-д: ”Бүс нутгийн хэл нь Францын өвд хамаарна” хэмээн хуульчилсан байдаг. Мөн Франц улсын нутаг дэвсгэр дээр Франц хэлээр нийгмийн харилцааг зохицуулахаар хуульчилжээ.	-Франц улс албан ёсны бүхий л харилцаанд франц хэл хэрэглэхийг шаарддаг. Ингэхдээ дүрэм болон үгсийн сангийн хэрэглээг зөв хэрэглэхийг шаарддаг. Эдгээрийг хэрэглэхдээ Франц хэлний албан ёсны толь бичгийг баримтлахыг шаарддаг. -Франц хэлэнд нэвтэрч болзошгүй англи хэлний нөлөөллийг бууруулахад анхаарах,	Хуулийн хэрэгжилтэд Франц хэлний академи хяналт тавьж ажилладаг. Франц хэлний академи 1635 онд байгуулагдсан бөгөөд Франц хэлний хэрэглээ, үгсийн сан, дүрэм зэргийг хянан хариуцдаг ба Франц хэлний албан ёсны толь бичгүүдийг хэвлэдэг. Франц улс нь хэлнийхээ байр суурийг хамгаалахад ихээхэн анхаардаг.
4	АНУ	Үндсэн хуулинд нь хэлний талаар ямар нэгэн заалт байдаггүй. Муж улсууд нь хэлний тухай хуультай.	Конгрессийн бараг чуулган бүрт англи хэлийг АНУ-гийн албан ёсны хэл болгон батлах нэмэлт өөрчлөлтийг Үндсэн Хууль-д хийх санал явж байдаг. Мөн АНУ-гийн хуулийн тогтолцоог өөрчлөх замаар арай амар хялбараар англи хэлийг албан ёсны хэл болгох өөр бусад оролдлогууд ч хийгдсээр ирсэн аж. Флоридагийн Дэйд Коунти-д 1980 оноос хойш «Зөвхөн Англиар» гэх хууль хүчин төгөлдөр болсон.	АНУ-нь албан ёсны хэлийг хуульчилаагүй орон бөгөөд энэ нь цөөнхийг эрхийг зөрчсөн зүйл гэж үзэн дэмжлэг авдаггүй байна. Америкийн Иргэний Либериал Эвлэл (the ACLU), нь албан ёсны хэл бүхий болох явдлыг эсэргүүцэгчдийн эгнээнд багтдаг ба, Энэ байгууллагынхан уг материалдаа мөн хууль эрхийн бичгүүдийг зөвхөн англи хэл дээр хэвлэдэг байдал нь англи хэлээр ярьдаггүй хүмүүсийн эрхийг хязгаарласан тэдийгүй, хүн амын англиар ярьдаггүй томоохон хэсгийнхний амьдралыг бэрхшээлтэй болгосон гэж тэмдэглэжээ.	Энэ мэтчилэнгээр АНУ-д албан ёсны хэлийг нэгдсэн байдлаар хуульчилаагүй бөгөөд зарим тохиолдолд муж улсууд өөрсдийн хэлний тухай хуультай байдаг ба түүнийг мужийн захиргаа нь засагладаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5	Монгол улс	Үндсэн хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль	Үндсэн хуулийн 1.8.1:-т “ Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 1.4.1.1.т ““төрийн албан ёсны хэл” гэж орчин цагийн утга зохиолын болон аман ярианы монгол хэлийг” хэлнэ.	-Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 2-р бүлгийн 5-р зүйлд: төрийн албан ёсны үйл ажиллагаа, сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Мөн хуулийн 5.16-д: ...олон нийтэд зориулсан хэвлэл мэдээлэл нь орчин цагийн хэм хэмжээ, нэр томьёог баримтлана.	Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон хариуцан ажиллах алба нь Төрийн хэлний зөвлөл байдаг. Төрийн хэлний зөвлөлийн чиг үүрэг нь төрийн албан ёсны хуулинд дагаж мөрдөх орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тогтоох, баталж мөрдүүлэх, жигдлэн хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, нэр томьёотой холбогдсон асуудлаар дүгнэлт гаргах зэрэг үүрэгтэй болно.

Тайлбар:

- Энэхүү хүснэгтэд гадаадын зарим улс орнууд үндэсний хэлнийхээ хэрэглээг хэрхэн ямар ямар хуулиар зохицуулдаг болохыг харуулахыг зорив

* * *

1.1. Хятад улс

БНХАУ нь хэл соёлын эртний түүхэн уламжлалт орон юм. Хятад улсын хэлний бодлогыг Засгийн газарт Хэл бичгийн улсын хороо, Үндэсний асуудал эрхэлсэн улсын хорооноос удирдан чиглүүлдэг. Хэл, бичгийн улсын хороо нь дотроо Стандартын, Бодлого болон хууль эрх зүйн, Хэл бичиг үсгийг хэрэглэх гэсэн 3 салбартай.

Хятад улс хэлний бодлогынхоо нэн тэргүүнд:

- хэлний бодлогыг хэрэгжүүлэх практик үйл ажиллагаа явуулах шинэ онолыг гаргах,
- бичгийн хэл болон аман ярианы стандартыг тогтоох,
- шинжлэх ухаан техникийн нэр томьёо, үг товчлох зэрэг үгсийн сангийн стандартыг тогтоох
- стандартын үг хэллэгийг дэлгэрүүлж, стандарт бус үг хэллэгийг хэрэглэхийг хянах
- бичгийн хэл түүний хэм хэмжээг стандартчлахыг хүчтэй болгох зорилтуудыг тавьдаг байна.

2000 оны 10 -р сарын 31-ний өдөр хуралдсан Улс Ардын Есдүгээр Чуулганы Тэргүүлэх Хорооны 18 -р хуралдаанаар батласан “Стандарт Яриа ба Бичгийн Хятад Хэлний тухай” бие даасан хуулийг батлан хэрэгжүүлэх болжээ. Дээрх хуулиндаа хятадын төв аялгуу Путонгхуа (Бээжин аялгуунд үндэслэсэн нийтлэг яриа ба дуудлага) стандарт хятад ханз үсэг нь Төрийн байгууллагуудын албан ёсны хэл байх бөгөөд сургалт, боловсролын болон хэвлэл мэдээллийн үндсэн хэл байна гэж заажээ. Мөн Хятад хэлнээ хэвлэгдэж буй бүхэн стандарт яриа болон бичгийн хятад хэлний хэм хэмжээтэй нийцэж байх ёстой ба Хятад хэлт хэвлэлүүдэд гадаад хэл хэрэглэх хэрэгтэй болвоос стандарт хятад хэлээр шаардлагатай тайлбар тэмдэглэлийг хийх хэрэгтэйг хуульчилж өгсөн байдаг байна.

Хятад улс нь хэлний тухай хуулийн хэрэгжилтэд ихээхэн хяналт тавьдаг бөгөөд төрийн албан хаагчид нь эх хэл, бичгийн үлгэр дууриал байх ёстой гэж үзэн, тэдгээрийг жил бүр төрөлх хэлний боловсролоор шалган ажиллуулдаг байна.

1.2. Казахстан улс

Казахстаны үндсэн хуулинд төрийн албан ёсны хэл нь Казах хэл байна гэж заажээ. Казах хэл нь Түрэг хэлний Кепчак /Баруун түрэг/ хэлний салбарт багтдаг ба анхандаа араб үсэгт суурилж хөгжиж байсан боловч 1928 онд ЗХУ -аас латин үсэг рүү шилжүүлжээ. 1940-өөд онд ЗХУ-ын Засгийн газраас кирилл үсгийг хэрэглэхийг тулгасны улмаас казах хэлний зарим нэгэн үгсийг өөрчлөн хялбаршуулсан бөгөөд энэ бичгийн тогтолцоо нь өнөөг хүртэл уламжлагдан иржээ.

1989 оны байдлаар Казах угсаатны 98 хувь нь казах үндэстэн гэсэн баримт байдаг ч казах хэлээ эзэмшсэн түвшин төдийлөн сайнгүй байдаг байна. Учир нь Казахстан улс нь ОХУ-ын муж улс байсан бөгөөд төрийн албан болон сургалт, хэвлэл мэдээллийн үндсэн хэл нь орос хэл байсан ба орос хэлний мэдлэг нь ажлын ур чадварын гол тавигдах шаардлага байсан зэргээс шалтгаалан казах хэлний мэдлэгийн түвшин доогуур харин ихэнх нь орос хэлтэй байдаг байна.

1980-аад оны сүүлчээс “Казах хэлийг сурах аян” өрнүүлж ихээхэн үр дүнд хүрчээ. Улмаар 1989 онд Казахстаны дээд зөвлөлөөс казах хэлийг тус Республикийн албан ёсны хэл болгох анхны хуулийг батлан гаргасан ба энэ нь 1993 оны Үндсэн хуулиар нь албан ёсоор баталгаажсан байдаг. Харин орос хэл нь угсаатан хоорондын харилцааны хэлний үүрэг гүйцэтгэх болсон байна.

Казахстан улсын хувьд хэлний бодлого нь ихээхэн тулгамдсан асуудлуудын нэг болоод байсан бөгөөд 1997.7.11 -ны Дугаар 151.1 “Казахстаны хэлний тухай” шинэ хуулийг батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хуулиараа казах хэлийг Казахстаны “төрийн хэл” хэмээн тунхаглахын сацуу төрийн хэл бол бүхий л нийгмийн харилцаанд хүчин төгөлдөр хэмээн хуульчилжээ. Тус хуулийн 5-р зүйлд орос хэлийг төрийн агентлаг ба тус муж улсын засаг захиргаанд казах хэлтэй адил тэгш хэмжээнд хэрэглэхийг заасан байдаг байна.

Казахстан улсын тухайд казах хэлний бодлогыг тодорхойлсон 1999.1.8 -ны Засгийн газрын 16-р тогтоолоор батлагдсан “Хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” тухай хууль, 2001 онд батлагдсан “Казах хэлийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг нилээд олон тооны хууль эрх зүйн баримт бичгүүдийг гаргасан боловч казах хэлийг хөгжүүлэх тогтолцоо нь төдийлөн хангалттай бус байдаг байна. Тухайлбал, Казах хэлний хэрэглээ нь хөдөө орон нутаг зэрэг алслагдсан нутгийнхны дунд өргөн хэрэглэгддэг бөгөөд зарим сургуулиудын сургалт орос хэлээр явагдсаар байгаа нь төрийн хэлний бодлогын хэрэгжилт зарим талаар сайн хэрэгжихгүй байгааг илтгэж байна.

1.3. Франц улс

Франц улс нь хэлний бодлогын талаар эртнээс анхаарч ирсэн бөгөөд Франц хэлийг 1539 онд Хаант засаг захиргааны хэрэглээнд албан ёсоор хэрэглэхийг хуульчилсан орон юм. Францын хэлний бодлогыг хэрэгжүүлэхэд Франц хэлний академи, Франц хэлний дээд хороо, Францын Засгийн газрын яам дундын хороо, Францын үндэсний хурал дахь Боловсрол, соёлын комисс зэрэг байгууллагууд ихээхэн чухал үүрэгтэй.

Франц хэлний академи нь 1635 онд анх байгуулагдсан, франц хэлний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хэлний цэвэр ариун байдлыг хангах, шинээр хэрэглэх нэр томьёог хэрэглээнд оруулах, хэлийг зөв хэм хэмжээний дагуу хэрэглэхэд дадуулах зэрэг ажлыг хийдэг. 1984 онд Франц хэлийг хэрэглэх, түгээх зорилготой “**Франц хэлний Зөвлөх хороо**”, засаг захиргаа, улсын хувийн бүхий л байгууллагын үйл ажиллагааг нэгтгэх зорилготой “**Франц хэлний Комиссарын газар**”-уудыг байгуулж байжээ. 1989 онд Франц хэлний Зөвлөх хорооны үйл ажиллагааг залгамжилсан Франц хэлний Дээд хороог байгуулсан бөгөөд энэ нь франц хэлийг дотооддоо болон хилийн чанадад түгээн дэлгэрүүлэх, францын

ерөнхийлөгч болон засгийн газраас гаргасан бодлогын үндсэн чиглэлтэй нийцүүлэн гадаад хэлний бодлогыг боловсруулдаг аж.

Францын ерөнхийлөгч Жорж Помидугийн санаачлагаар шинжлэх ухаан техникийн салбарын нэр томьёог үүсгэх, гадаад үг хэллэгээс зайлсхийх зорилгоор Францад Нэр Томьёоны Комисс 1970 онд байгуулсан ба 1972 онд яам болгонд Мэргэжлийн Нэр Томьёоны хороо ажиллуулж эхэлсэн ба одоогоор нэр томьёоны төрөлжсөн 20 комисс ажиллаж байна. Франц Хэлний Ерөнхий Төлөөлөгчийн газар нь жил бүр парламентад “Франц хэлний тухай” хууль /Тубоны хууль/-ийн хэрэгжилт болон франц хэлний олон улсын байгууллагад эзэлж буй байр суурийн талаар тайлан гаргаж Франц хэлний дээд хороонд танилцуулдаг байна.

Энэ мэтчилэн Францын Засгийн газраас Франц хэлний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санаачилга, ивээл дор нэгдсэн томоохон бүрэлдэхүүн бүхий хороо газруудаар дамжуулан явуулдаг бөгөөд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бий болгож чадсанаараа Франц хэлний цэвэр ариун байдлыг хадгалсан, зөв зохистой хэрэглээг нэвтрүүлсээр иржээ.

1.4. АНУ

Ардчиллын өлгий нутаг АНУ нь олон муж улсуудаас бүрддэг бөгөөд хэлний асуудалд чөлөөтэй ханддаг улс олон жилийн хүчин чармайлтуудыг эс тооцвол өдгөөг хүртэл албан ёсны хэлийг хуульчлаагүй орон мөн. Энэ асуудал дээр АНУ-ын эрх баригчид олон янзын үзэл бодолтой байдаг байна.

Конгрессийн бараг чуулган бүрт англи хэлийг АНУ-гийн албан ёсны хэл болгон батлах нэмэлт өөрчлөлтийг Үндсэн хуульд оруулах санал явж байдаг. Мөн АНУ-гийн хуулийн тогтолцоог өөрчлөх замаар арай амар хялбараар англи хэлийг албан ёсны хэл болгох өөр бусад оролдлогууд ч хийгдсээр ирсэн. Гэсэн ч энэ бүх чармайлтууд өнөөг хүртэл амжилтанд хүрээгүй байсаар байна.

Хамгийн сүүлийн үеийн англи хэлийг албан ёсны хэл болгох гэсэн хүчин чармайлтууд нь испани хэлт болон хятад, вьетнам зэрэг азийн улс орнуудаас англиар ярьдаггүй асар их хүний урсгал АНУ-руу ирэх болсонтой холбоотойгоор эрчимжиж байна. 1990 оны судалгаагаар бол АНУ-д оршин суугчдын 13.8 хувь нь гэртээ англи бус хэлээр ярьцгаадаг байна. Харин 2.9 хувь буюу 6.7 сая хүн англиар огт ярьдаггүй аж.

Америкийн Иргэний Либериал Эвлэл (the ACLU), нь албан ёсны хэлтэй болох явдлыг эсэргүүцэгчдийн эгнээнд багтдаг ба, тэдний нийтлүүлсэн материалд ийнхүү эсэргүүцэж буйн учир шалтгаануудыг дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Энэ нь юуны түрүүнд 1780 онд Жон Адамс **Англи хэлний албан ёсны академи** байгуулахыг чармайсан боловч тухайн цаг үедээ ардчилсан бус шинж чанартай хэмээх үндэслэлээр дэмжигдээгүй байдгийг дурджээ. Энэ байгууллагынхан уг материалдаа мөн хууль эрхийн бичгүүдийг зөвхөн англи хэл дээр хэвлэдэг байдал нь англи хэлээр ярьдаггүй хүмүүсийн эрхийг хязгаарласан төдийгүй, хүн амын англиар ярьдаггүй томоохон хэсгийнхний амьдралыг бэрхшээлтэй болгосон гэж тэмдэглэжээ.

Энэ байгууллагын үзэж байгаагаар бол “Зөвхөн Англи хэлээр” хэмээх хуулиуд нь АНУ-гийн Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эрхийг хамгаалах (ялангуяа, шүүх хурлуудад орчуулгын үйлчилгээнд хамрагддаггүй) зүйл заалтыг зөрчих боломжтой юм байна. Зөвхөн Англи хэлээр хэмээхийг баримтлагч U.S. English зэрэг байгууллагууд үүнийг эсэргүүцэхдээ, эдгээр хуулиуд нь ерөнхийдөө нийгмийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн хэрэгцээний тухайд уян хатан зүйлс олонтой гэзэг тэрчлэн, албан бичиг баримт, материаллуудыг зөвхөн нэг хэл дээр хэвлэх болсноор засаг захиргааны байгуллагууд

орчуулга ба хэвлэлийн зардал гэх зэрэгт асар их хөрөнгө мөнгийг хэмнэдэг ба, бас англи хэлээр ярьдаггүй хүн амд англи хэл сурах суртчилгаа болдог гэжээ.

Ийнхүү АНУ нь хэлний талаар баримтлах бодлого дээр төдийлөн нэгдсэн байр сууринд хүрээгүй боловч муж улсууд нь зөвшөөрөгдсөн хэл хэмээн хуульчилсан тохиолдлууд байдаг ч хүний эрхийн асуудал хэмээн нээлттэй ханддаг байна. Гэвч бичигдээгүй хууль ёсоор Англи хэл нийгмийн бүхий л харилцаанд үйлчилсээр байгаа юм байна.

1.5. Монгол улс

Дэлхий нийтээр даяаршлын үйл явц эрчимжиж байгаа өнөө үед улс орон бүр үндэсний эх хэлээ хамгаалан хөгжүүлэх, хэлээрээ дамжуулан үндэсний өвөрмөц дүр төрхөө хадгалах талаар дор дороо бодлого боловсруулан хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд энэ нь тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа юм.

a. Монголын төрийн албан ёсны хэлний бодлого, түүхэн уламжлал

Монголын ард түмэн эртнээс эх хэл, үсэг бичгээ төрийн бодлогын бүрэлдэхүүнд багтаан үзэж, утга зохиолын хэлээ улам баяжуулан төгөлдөржүүлэхийг эрмэлзэн, түүний үгийн сан, хэл зүй, зөв бичих дүрэм, зөв дуудах зүйн хэм хэмжээг боловсронгуй болгоход чиглэсэн олон талын ажил хийж ирснийг түүх шастирт тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Эзэн богд Чингис хааны байгуулсан Их Монгол улсын төр, иргэний аливаа хэргийг монгол бичгээр нэгэнт хэвшин тогтсон зөв бичих зүйг баримтлан бичиж, хөтлөн явуулж байсныг 1224-1225 оны Чингисийн чулууны бичиг, 1246 оны Гүюг хааны захидал дахь тамганы дардас, Ил хаадын захидал тэргүүтэн олон дурсгал, сурвалжууд гэрчилэн үлджээ.

Хубилай сэцэн хаан Их Юань улсыг төвхнүүлэн тунхаглаж Пагва лам Лодойжалцангаар монгол дөрвөлжин бичгийг зохиолгож ”Үүнээс хойногшид тамганы бичиг, тархаах бичгийг монгол хэлээр /дөрвөлжин бичгээр/ бичээд, бус улсын бичгийг хослон бичидхүн”[1] /Ц.Шагдарсүрэн.“Монголчуудын бичиг үсгийн товчоон”/ хэмээн зарлиглажээ. Монгол бичиг нь 13-р зуунаас 1946 он хүртэл 800 гаруй жилийн хугацаанд монгол төрийн албан ёсны бичиг байсан байна. Зая бандида Намхайжамц тод бичгийг 1648 онд, Өндөр гэгээн Занабазар соёмбо бичгийг 1686 онд тус тус зохиож байсан түүхтэй.

XX зууны эхэнд түүхэн цаг үеийн хэрэгцээ шаардлагыг хангахад “ардын ярианы хэлэнд ойр ба сурахад төвөггүй хялбар шинэ дүрэм”[2] бүхий бичиг зохион хэрэглэх юу юунаас чухал байсан тул тухайн үеийн МАХН-ын төв хороо ба СнЗ-өөс 1940 оны 7 -р сарын 26-нд “Латин үсгийг үндэс болгож шинэ монгол үсгийг зохион хэрэглэх” тухай СнЗ -ийн 27 дугаар тогтоол, 1941 оны 2-р сарын 21 нд “Латин үсгийг батлах тухай” МАХН -ын Төв Хороо ба СнЗ-ийн хамтарсан 17/13 дугаар хурлын тогтоол” гарган латин үсгийг үндэслэж боловсон шинэ монгол үсгийг зохион хэрэглэх[3] ажил эхэлсэн боловч монгол үсгийг латинчлахад тэмдэглэгээний дутагдал, хэвлэлийн талын болон техникийн бэрхшээл их зэргээс шалтгаалан дээрх хоёр тогтоолыг хүчингүй болгож 1941 оны 5 дугаар сарын 9-нд “Орос үсэг дээр үндэслэсэн монголын шинэ үсгийг батлах тухай СнЗ, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 25/27 дугаар хурлын тогтоол”, 1942 оны 9-р сарын 3-нд “Казах аймагт шинэ үсгийг тогтоон явуулах тухай СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хамтарсан 40/53 дугаар хурлын тогтоол” гаргаж мөрдүүлсэн байна. /Хүснэгт 1/

1941-1946 онуудад улсын албан хэргийг шинэ үсгээр явуулах бэлтгэл ажлыг хийж 1946 оноос кирилл үсгийн үндсэн дээр зохиогдсон монгол үсэгт бүрэн шилжин оржээ. Ийнхүү 1946 оноос өнөөг хүртэл Монгол улсын албан хэрэглээнд орчин цагийн кирилл монгол хэлийг хэрэглэсээр иржээ. Төрөөс баримталж буй хэлний бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага болон эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайн үед Судар бичгийн хүрээлэнгээс хэлний

бодлогын асуудлыг эрхлэн ажилладаг байсан бөгөөд СНЗ-ийн дэргэд **Улсын Нэр Томьёоны комиссыг** байгуулж шинэ соёл, шинжлэх ухааны дэвшлийг тусгасан үг хэллэг, нэр томьёог оноон тогтоох, жигдрүүлэх, хэвшүүлэх ажлыг явуулдаг байсан боловч 1990 онд энэ байгууллагыг татан буулгаж улмаар 1998 онд Хэл зохиолын хүрээлэнгийн нэгэн сектор болгон сэргээн байгуулсан байна.

b. Монголын төрийн албан ёсны хэлний бодлого, өнөөгийн байдал.

1990 оноос хойш түүхийн өөр цаг үед шилжиж, хуучин социалист нийгмийн тогтолцоог бүхлээр нь өөрчилж байсан тухайн үед дээрх 1941 оны 5 дугаар сарын 9-нд “Орос үсэг дээр үндэслэсэн монголын шинэ үсгийг батлах тухай СнЗ, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 25/27 дугаар хурлын тогтоол”, 1942 оны 9-р сарын 3-нд “Казах аймагт шинэ үсгийг тогтоон явуулах тухай СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хамтарсан 40/53 дугаар хурлын тогтоол”-уудыг МАХН-ын Төв хороо, ЗГ-ын 1990 оны 12 сарын 24-ний 1-р тогтоолоор хүчингүй болгож, мөн онд “Бүх нийтээр монгол бичигт суралцах ажлыг зохион байгуулах тухай” 285-р тогтоол гарган, 1991 онд “БНМАУ-д төрийн албан хэргийг 1994 оноос монгол хэлээр хөтлөн явуулах тухай” 36-р тогтоол гарч монгол бичгийг төрийн албан ёсны бичиг болгох бэлтгэл ажил хийгдэх болжээ.

Монгол бичгийг сурах, сургах ажил эрчимтэй өрнөсний үр дүнд ерөнхий боловсролын сургуульд монгол бичгийн хичээл орж, монгол бичгээр сонин сэтгүүл гарч, эртний сонгодог судар шастируудыг уншиж судлах, кирилл үсэгт хөрвүүлэх зэрэг олон олон дэвшилтүүд гарсан байна. Гэвч орчин цагийн монгол хэл бол төрөөс албан хэрэг хөтлөх хэл бөгөөд боловсрол, соёл, шинжлэх ухаан, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт нийгмийн бүхий л хүрээнд үйлчилсэн хэвээр байна.

Өнөөгийн байдлаар хэл болон хэлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг дараах хуулиудаар голчлон зохицуулдаг байна. Үүнд:

1. МУ-ын Үндсэн хууль /1992 он/
   - Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн /8.1/
   - Дээрх заалт хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө. /8.2/

2. Соёлын тухай хууль /1996 он/
   - Монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх /3.1в/
   - “Соёлын үнэт зүйл” гэдэгт... эх бичиг, бичиг үсэг, аман аялгуу, ардын аман зохиол... хамаарна. /3.2/
   - Монгол улсын иргэн соёлын талаар дараах эрх эдэлнэ. /4.1.4/ Үүнд: эх хэл бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх.
   - Монгол улсын иргэн соёлын талаар дараах үүрэг хүлээнэ. /4.5/ Үүнд:
     - Түүх, соёлын уламжлалыг хамгаалж, хөгжүүлэх
     - Эх хэл, бичиг үсгээ судлах, өвлөх, өвлүүлэх
     - Соёлын үнэт зүйлсийг элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах
   - Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхтэй байна /13.1/ Үүнд: эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3. Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2001 он/

Ард түмний билэг авьяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараах оюуны соёлын үнэт зүйлийг хамааруулна. /1-р бүлэг 4.1/ Эх хэл, түүний хүрээний соёл /4.1.1/

4. Төрийн албан ёсны хэлний тухай хууль /2003 он/
   - Зорилт: Төрийн албан ёсны хэл болох монгол хэлний хэм хэмжээ нэр томьёог төрийн албан хэрэг хөтлөх, төрийн албан ёсны үйл ажиллагаанд хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах болон Монгол улсын нэгдмэл байдлыг хангахад оршино. /1.1.1/
   - Төрийн албан ёсны хэл гэж орчин цагийн утга зохиолын болон аман ярианы монгол хэлийг /4.1.1/
   - “төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ” гэж орчин цагийн монгол утга зохиолын хэлний зүй тогтол, хэл бичгийн дүрмийг хэлнэ. /4.1.2/

Манай улс албан ёсны хэлний бодлогыг зохицуулах бие даасан хуулийг 2003 онд боловсруулан батлаж, хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албан ёсны хэлэнд дагаж мөрдөх орчин цагийн хэлний хэм, хэмжээ, нэр томьёог шинжлэх ухааны үндэстэй оноон тогтоох, баталж мөрдүүлэх, жигдлэн хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, нэр томьёотой холбогдсон асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Төрийн хэлний зөвлөлийг байгуулж эрх, үүрэг ажлын чиг үүргийг тодорхой хуульчилсан. Төрийн хэлний зөвлөлийн дарга нь Засгийн газрын гишүүн байна гэж хууль, дүрмэндээ заасан хэдий ч одоогоор Соёлын яамны харьяанд шилжүүлсэн байна.

Төрийн хэлний зөвлөлийн ажлын алба нь ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн байдаг бөгөөд өнөөгийн байдлаар Хэлний стандарт тогтоосон 700 үг, Зөв бичих дүрмийн толь, тайлбар толиудыг цуврал байдлаар ботилон гаргаж олон нийтэд түгээн дэлгэрүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 105-р зарлигаар жил бүрийн 5-р сарын эхний ням гарагийг “Монгол үндэсний хэл, үсэг бичиг”-ийн баярын өдөр болгож, үндэсний хэл,бичиг түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлалт өвийг судлан сурталчлах, үндэсний бичгээ эзэмших, үр хүүхэддээ зааж өвлүүлэх талаар өргөн олонд хүртээлтэй ажил зохиохыг заажээ.

“Олон улсын эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан 2007 оны II сарын 21 өдөр ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Койчиро Мацүүрагаас ирүүлсэн илгээлт бичигт “Эх хэл бол бид бүхний эрхэм нандин зүйлийн нэг мөн. Эх хэлээрээ бид анхныхаа үгийг хэлж, өөрийн санаа бодлоо хамгийн зөвөөр илэрхийлдэг.ЮНЕСКО-гоос олон хэлний тогтолцоог дэмжих талаар ихээхэн хүчин чармайлт тавьж байна. Ингэхдээ ялангуяа боловсролын системд “эх хэл”, “үндэсний хэл”, “харилцааны хэл” гэсэн хүн бүрийн эзэмшвэл зохих дор хаяж хэлний 3 төвшнийг эзэмшсэн байх ёстой гэж үздэг.

Олон улсын Эх хэлний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан дэлхийн бүх хэлний зохистой орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үндэсний болоод бүс нутгийн хэлний стратеги бодлогыг боловсруулан хэрэгжүүлж эхлэхийг би уриалж байна” гэжээ. Энэ өдрөөр манай улс эх хэлээ хайрлан хамгаалах, хөгжүүлэх, бүтээлч ажил хэрэг болгох талаар эрдэмтэд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж түүнээс гарсан шийдвэр зөвлөмжийг бодлого боловсруулагч нарт хүргүүлэх ажлыг хийж иржээ

UHLDSN
СОЗДАН АНАЛИЗАН

Монгол хэлний холбогдох хууль эрх зүйн баримтууд

Хүснэгт 2

№	Эрх зүйн актын нэр	Огноо	Холбогдох зүйл заалт	Тайлбар
2	МАХН-ын Төв хорооны 2-р бүгд хурлын тогтоол	1929.5.27	Намын бусад асуудлын тухай тогтоолын Суртлын тухай хэсгийн нэгд: ...сургуулийн хэргийг сайжруулах хийгээд... бичиг үсэгт сургах явдыг нэн шаламгайлан чанартай явуулахын хамт дацан хийдэд суух багачууд банди нарын зэрэг этгээдэд монгол бичиг үсэг заах, сургах хэргийг үүсгэл болгон явуулах	Ард нийтийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах ажил ихээхэн эрчимтэй явагдаж, улмаар 1932 он гэхэд бичиг үсэгт сургах бүлгэм, дугуйлан тогтмол ажиллуулах болжээ.
3	МАХН-ын 8-р Их хурлын тогтоол	1930.04.02	Нам ба улс төрийн дотоодын тухай хэсэгт: ... монгол үсгийг халж боловсон соёлыг дэлгэрүүлэхэд дөхөмтэй латин үсгийг өөрийн монгол хэлэн дээр зохиолдуулсан үндсэн хэлний үсэг болгож хэрэглэх явдлыг богино хугацаанд гүйцэтгүүлэх... Бэлтгэл ажлыг явуулж таван жилийн төлөвлөгөөний эхний жилүүдэд гүйцэлдүүлэх	Монгол бичгийг халах хэд хэдэн шалтгаан байна гэж үзсэн. -сурах, сургахад хялбар бус -математик, физик зэрэг шинэ үеийн ш.у-ны нэр томъёо тэмдэглэгээнд хэрэглэхэд хүндрэлтэй -яриа болон бичгийн хооронд зохилдохгүй
4	Шинэ латин үсгийг батлах тухай МАХН-ын Төв хороо ба СнЗ-ийн хамтарсан 17/13 дугаар хурлын тогтоол	1941.02.21	Уг тогтоолд: Хүн ардыг 1932 он хүртэл албан ёсоор латин монгол үсэгт сургах, 1933 оноос албан хэргийг латин монгол үсгээр хөтлөхөөр тогтоожээ.	-Латин үсгийг үндэс болгож шинэ монгол үсгийг зохион хэрэглэх тухай 1940.07.21-ний СнЗ-ийн 27-р тогтоолыг гаргаж, улмаар батлан 10-аад жил хэрэглэсэн ч монгол хэлэнд хэрэглэхэд тэмдэг дутагдалтай, хэвлэлийн болоод техникийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлүүдээр халах болсон байна.
6	“Орос үсэг дээр үндэслэсэн монголын шинэ үсгийг батлах тухай СнЗ, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 22/27 дугаар хурлын тогтоол”	1941.3.25	1.Монгол бичгийг шинэ орос үсэг дээр шилжүүлэн хэрэглэх нь зүйтэй. 2.Латин үсгийн хэрэглээг зогсоосугай 3.Шинэ орос үсгийг ард нийтэд зарлан хэлэлцүүлж 1 сарын дотор саналыг НТХ ба ЗГ-т оруулж ирэхийг даалгасугай,	
7	“Казах аймагт шинэ үсгийг тогтоон явуулах тухай СнЗ, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хамтарсан 40/53 дугаар хурлын тогтоол”	1942.9.3	1. Казах аймаг хэрэглэж буй латин үсгийн оронд шинэ орос үсгийг тогтоон явуулсугай. 2. СССР-ийн Казах улсад хэрэглэж буй орос үсгийг бүрэн хэрэглэж явуулсугай.	
8	МАХН-ын Төв хороо, ЗГ-ын 1-р тогтоол	1990.12.24	Уг тогтоолоор СнЗ, МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 22/27 дугаар хурлын тогтоол”-ыг хүчингүй болгосон	
9	“Бүх нийтээр монгол бичигт суралцах ажлыг зохион байгуулах тухай” 285-р тогтоол	1990 он	Бүх нийтээр монгол бичиг сурах аяныг өрнүүлэх тухай	

10	“БНМАУ-д төрийн албан хэргийг 1994 оноос монгол хэлээр хөтлөн явуулах тухай” УБХ-ын 36-р тогтоол	1991 он	Төрийн албан хэргийг монгол бичгээр явуулах бэлтгэл ажлыг хангах тухай	
11	УБХ-ын 1991 оны 36 дугаар тогтоолын биелэлтийг хэлэлцсэн тухай УИХ-ын 66-р тогтоол	1994.7.8	1.Монгол улсад албан хэргийг кирилл монгол бичгээр үргэлжлүүлэн хөтөлж явуулсугай. 2.1994-1995 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг албан хэрэг хөтөлж байгаа бичгээр явуулах нь зүйтэй гэж үзсүгэй.	Уг тогтоолыг үндэслэн 1995.06.23-ны УИХ-ын 43-р тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна.
12	Монгол бичгийн үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын 43-р тогтоол	1995.6.23	Үндэсний баялаг өвийг мэдэх, судлан дэлгэрүүлэх, ардын заншлыг уламжлуулах нэг нөхцөл нь монгол бичиг учир сургах, хэрэглэх орчныг бий болгох зорилготой.	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газар хариуцан зохион байгуулна.
13	Латин үсгийн үндэсний хөтөлбөр батлах тухай УИХ-ын 31-р тогтоол	2003.06.19	Орчин үеийн хэрэгцээ шаардлагыг харгалзан монгол кирилл үсгийг латин үсэгтэй хослуулан хэрэглэх.	
14	Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай ЗГ-ын 244-р тогтоол	2004.12.22	4.3.5.эх хэл, бичиг, түүхээ үндэс язгуураар нь судалж сургах, хадгалж хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох; 4.3.6.төр, иргэний харилцаанд эх хэлний эзлэх байр суурь, халдашгүй дархан байдлыг хуульчлан баталгаажуулж, хүүхдийг эх хэл, бичгээ бүрэн төгс эзэмших, монгол үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох ажлыг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох	
15	“Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх тухай” Ерөнхийлөгчийн 155 дугаар зарлиг	2010.07.10	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдээс гадаад улсын адилтгах төвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг монгол бичгээр үйлдэж, орчуулгыг тухайн улсын эсвэл НҮБ-ын албан ёсны аль нэг хэлээр хавсарган илгээж байхаар тогтоосугай.	

* * *

Судалгааны дүгнэлт

Аливаа улсын төрийн хэлний бодлого нь төрийн үндэсний бодлогын салшгүй хэсэг бөгөөд Ерөнхийлөгч, ерөнхий сайдын ивээл дор үүнийг Засгийн газраас хэрэгжүүлдэг байна.

Төрөөс хэлний бодлогыг хэрэгжүүлэхэд төр захиргааны байгууллагууд, хороо зөвлөл, хэлний академиуд, судалгаа шинжилгээний байгууллагууд зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд чухал үүрэгтэй бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн уялдаа холбоотой явуулах асуудлыг төрийн бодлогоор зохицуулдаг байна. Эх хэл, бичиг үсгийн бодлогыг урт болон богино хугацааны хөтөлбөр төлөвлөгөө, тусгайлсан хуулиар хэрэгжүүлдэг ажээ.

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

Судалгаанд хамрагдсан улс орнууд нь өөрсдийн хэлний бодлогыг ихээхэн анхаардаг бөгөөд бүгд албан ёсны хэлний бие даасан хуультайгаас гадна Үндсэн хуулиараа албан ёсны хэлээ хуульчлан тунхагласан байдаг байна. Тухайлбал, **Франц** улс гэхэд одоогоос 400 жилийн тэртээ 1-р Франсуа хаан үед “хууль эрх зүйн акт, албан бичиг хэргийг гагцхүү франц хэл дээр хөтөлнө” гэж тунхагласнаар франц хэлний талаарх Францын төрийн хэлний бодлого хэрэгжиж эхэлсэн бөгөөд өнөөдрийн даяаршлын эрин үед уг бодлого улам бүр лавшран хэл, соёлоо хамгаалахаас гадна дэлхий дахинд соёлын олон төрлийн зүйлийг хадгалж хамгаалах хүртлээ хөгжиж ирсэн байна.

Энэ мэтчилэн зарим улс орон бүс нутгийн ялгамжтай олон янзын аялгуу бүхий хэлтэй байдаг бөгөөд түүнээс зөвхөн нэг нийтлэг хэлийг төрийн албан ёсны хэлээр сонгон хуульчилж мөрддөг бол зарим улс орон 2 хэлийг зэрэгцүүлэн хос хэлээр албан хэргийг явуулдаг байна. Ихэнх улс орнууд “Албан ёсны хэлний тухай” хуулиараа үндэсний эв нэгдлийг хангах, өөрсдийн албан ёсны хэлний хэм, хэмжээ, цэвэр ариун байдлыг хадгалах, зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, хэлний дархлааг сайжруулах, бодлогыг зохицуулдаг байна.

Хятад улсын туршлагаас харахад хэлний тухай хуулиндаа хэлний дагаж мөрдөх хэм хэмжээ, тавигдах шаардлагыг тодорхой нарийвчлан зааж өгсөн байна. Тухайлбал, Хятад хэлнээ хэвлэгдэж буй бүхэн стандарт яриа болон бичгийн хятад хэлний хэм хэмжээтэй нийцэж байх ёстой ба Хятад хэлт хэвлэлүүдэд гадаад хэл хэрэглэх хэрэгтэй болвоос стандарт хятад хэлээр шаардлагатай тайлбар тэмдэглэлийг хийх хэрэгтэйг хуульчилж өгсөн байдаг байна. Хятад улс нь хэлний тухай хуулийн хэрэгжилтэд ихээхэн хяналт тавьдаг бөгөөд төрийн албан хаагчид нь эх хэл, бичгийн үлгэр дууриал байх ёстой гэж үзэн, тэдгээрийг жил бүр төрөлх хэлний боловсролоор шалган ажиллуулдаг байна.

Албан ёсны хэлний тухай хуулийг хэрэгжүүлэгч газар нь ихэвчлэн Төрийн нэгжийн байгууллага байх ба стандарт тогтоон түүнд хяналт тавьж, шинэ үг хэллэгийг зохион нэвтрүүлэх зэрэг холбогдох ажлуудыг ШУА нь хариуцан ажилладаг байна.

Монгол улсын хувьд, монгол хэл бичгийн өнө эртний түүхэн уламжлалтай орон юм. Хэл бичгийн уламжлалт түүхэн хөгжлөөс эргэн харвал манай улс түүхэн цаг үе бүрдээ төрийн албан ёсны бичигтэй, түүгээрээ нийгмийн бүхий л харилцааг илэрхийлэн явуулдаг байжээ. Түүхэндээ монгол бичиг нь 13-р зуунаас 1946 оныг хүртэл 800 жилийн турш төрийн албан ёсны хэл бичиг байсан бөгөөд энэ завсар дөрвөлжин бичиг, соёмбо үсэг, тод үсэг, латин үсэг зэргээр төрийн албан хэргийг хөтлөж байсан удаатай. Гэвч эдгээр нь он цагийн шалгууруар төдийлөн урт хугацаанд хэрэглэгдээгүй байна.

Монгол бичгийн хэрэглээг 1941-1946 онд халж, орос үсэгт суурилсан кирилл орчин цагийн монгол хэл бичгийг зохион хэрэглэж төрийн хэргийг хөтлөн явуулахын сацуу ард олныг шинэ бичиг үсэгт богино хугацаанд эрчимтэй сургаж, кирилл монгол хэлний хэрэглээг төлөвшүүлжээ.

Орчин цагийн монгол хэл, бичгийг 1941 оноос 1990 он хүртэл төрийн албан ёсны хэл хэмээн тунхаглан нийгмийн бүхий л харилцаанд хэрэглэсээр ирсэн ч 1990 оны ардчилалсан хувьсгалын дараагаар үндэсний үзэл, бичиг үсгээ сэргээн хэрэглэх зорилгоор дахин Монгол бичгийг төрийн албан харилцаанд нэвтрүүлэх шийдвэр гарч, тодорхой хугацаанд эрчимтэй ажилласан ч бэлтгэл ажил хангалттай хийгдээгүй учир төрийн харилцаа, сургалтад хэрэглэх боломжгүй гэж үзээд орчин цагийн монгол хэл бичгийг үргэлжлүүлэн төрийн албан хэрэг болон сургалт, мэдээллийн харилцаанд хэрэглэх тогтоол гаргасан байна.

Өнөөгийн байдлаар Монгол хэлний бодлогыг зохицуулах эрх зүйн хүрээнд Үндсэн хууль, Хэлний тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль

гэсэн үндсэн 4 хууль, хэд хэдэн үндэсний хөтөлбөр, бодлогын баримт бичгүүд, зарим тогтоол шийдвэрүүд гарсан ч түүний хэрэгжилтэд хяналт тавих механизм нь сул, хэлний холбогдох байгууллагуудын харилцан уялдаагүй ажиллагаа, хууль тогтоомжуудын зөрчилтэй хэрэгжих боломжгүй заалт зэргээс шалтгаалан хэлний бодлого төдийлөн сайн хэрэгжихгүй байна.

Тиймээс хэлний бодлогыг цогцоор нь авч үзэж, хууль дүрэм журмын уялдаа холбоо, бодит амьдралын хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх, хэрэгжүүлэгч байгууллагын статус зэргийг эргэж нэг харах нь зүйтэй гэж эрдэмтэд үзэж байна. Тухайлбал:

- 1990 онд МАХН-ын Төв хороо, Засгийн газрын хамтарсан 1-р тогтоолоор кирилл бичгийг халж хуучин монгол бичгийг төрийн албан хэл болгох тухай шийдвэр гаргасан.
- 1994 онд Улсын Их хурал дээрх тогтоолыг хэлэлцээд төрийн албан хэргийг хуучин монгол бичгээр явуулах бэлтгэл хангагдаагүй гэж үзээд Монгол улсад албан хэргийг цаашид кирилл монгол үсгээр явуулах нь зүйтэй гэж шийдсэн.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 07 сарын 10-ны өдрийн 155 дугаар зарлигаар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс гадаад улсын адилтгах түвшний албан тушаалтанд илгээх албан бичиг, захидлыг монгол бичгээр үйлдэж орчуулгыг тухайн улсын болон НҮБ-ийн албан ёсны аль нэг хэлээр хавсарган илгээж байхаар тогтоосон байна.

Энэ мэтчилэнгээр хуучин монгол бичгийг төрийн албан ёсны харилцаанд ашиглах, хэл соёлоо хадгалах, хэрэглээг нэмэгдүүлэх үндэсний үзэл, сонирхол төрийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсаар байгаа хэдий ч одоогийн байдлаар практикт 70 гаруй жил хэрэглэгдэж хэвшил болсон кирилл монгол үсэг төрийн албан ёсны хэрэглээнд хэрэглэгдсээр байна. Нийгмийн хөгжлийн чиг хандлага, хүмүүсийн аж байдал, соёлын өөрчлөлтийг дагаж үндэсний хэл, соёл нь улам бүр боловсронгуй болон хөгжиж байдаг билээ.

* * *

Хавсралт 1

Хэлний стандартыг тогтоогч байгууллагууд

Хэл	Нутаг дэвсгэр	Стандарт тогтоогч (ид)
Африка	Өмнөд Африк	Die Taalkommissie
Акан	Гана	(AOC) Акан Ортографикийн Хороо
Албани	Албани	Тирана, Албанийн Шинжлэх Ухааны Академи
Араб	Алжир Сир Египет Йордан Мороко Ирак Тунис Судан Израйл Сомали	Араб Хэлний Академи (مجمع اللغة العربية) Алжир, Сир, Египет, Йордан, Мороко, Ирак, Тунис, Судан, Израйл
Арагон	Арагон	Арагоны Академи, Арагон, Испани
Армен	Армен	Армен Улсын Шинжлэх Ухааны Академи
Астури Asturian	Астури	Астурийн Хэлний Академи (Academia de la Llingua Asturiana)

UHH.MN
СУДАЛГААНЫ САН

Азербажан	Азербажан	Азербажан Улсын Шинжлэх Ухааны Академи
Бенгали / Бангла	Бангладеш	Дака, Бангла Академи
	Баруун Бенгал	Баруун Бенгал, Колката, Пасчимбанга Бангла Академи
Баск	Баск Улс	Euskaltzaindia, Баск хэлний Язгуурын Академи
Белорус	Белорус	Белорус Үндэстний Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх Якоб ба Жанка Купалагийн нэрэмжит Хэл, Утга зохиолын Институт National Academy of Sciences of Belarus
Бербер буюу Тамазайт	Мороко	IRCAM
	Алжир	HCA
Болгар	Болгар	Болгарын Шинжлэх Ухааны Академи -н дэргэдэх Болгарын Хэлний Институт
Бирм	Мъянмар	Мъянмарын Хэлний Коммис
Каталан	Каталон	Каталан Судлалын Институт (Institut d'Estudis Catalans)
	Валенцийн Нийгэм	Acadimia Valenciana de la Llengua (Валенц хэлний стандартыг тогтоох тухайд)
Себуано	Филипин	Урлаг, Бичиг Үсгийн Висаяан Академи
Мандарин Хятад	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Төрийн Хэл ба Бичиг Үсгийн Хороо
	Хятад Улс (Тайвань)	Үндэсний Хэлний Хороо
	Сингапур	Мандарин хэлийг Сурталчилах Консул
	Малайз	Малайзын Хятад Хэлний Стандартын Консул
Корниш	Корнвелл	Корниш Хэлний Хамтын Нөхөрлөл (Keskowethyans an Taves Kernewek)
Хорват	Хорват	Хорватын Хэл ба Хэл Шинжлэлийн Институт (Institut za hrvatski jezik i jezikoslovlje)-ийн дэргэдэх Стандарт Хорват Хэлний Дүрмийн Консул (Vijeće za normu hrvatskoga standardnog jezika)
Чех	Чех Улс	Чех Хэлний Институт (Ъstav pro jazyk českэ Akademie věd Českй republiky)
Дани	Денмарк	Dansk Sprognжvn (Данийн Хэлний Консул)
Далекарл	Даларна коунти	Ulum Dalska
Дари	Афганистан	Афганистаны Шинжлэх Ухааны Академи
Дач	Недерланд Бельги Суринэйм	Nederlandse Taalunie (Дач Хэлний Эвлэл)
Зонха	Бутан	Зонха Хэлний Хөгжлийн Коммис (үндсэндээ төвд үсэг юм.)
Эстон	Эстон	Emakeele Seltsi keeletoimkond (Эх хэлний Нийгэмлэгийн Хэлний Удирдах зөвлөл) нь дүрэм ба стандартыг тогтоодог ба, албан ёсны зөвөлгөөг Эстон Хэлний Институт (Eesti Keele Instituut) нь өгдөг байна.
Фароесе	Фарое Арлууд	Фароес Хэлний Удирдах Зөвлөл (Fшroyska mбlnevndin)
Филипино	Филипин	Филипино Хэлний Коммис
Финланд	Финланд	Финландын Хэлний Судалгааны Институт

Франц	Франц	Acadйmie fransaise (Франц хэлний академи)
	Кюбек	Office quйbйcois de la langue fransaise (Франц хэлний Кюбек Алба)
Фриули	Фриули-Венец Гиулия	Фриули хэлний бүс нутгийн агентлаг (Agjenzie Regjonвl pe Lenghe Furlane)
Галици	Галици	Галицийн язгуурын академи
Герман	Герман Австри Швейцар Өмнөд Турол Бельги Лечтенштейн	Герман Ортографийн Консул (Rat fьr deutsche Rechtschreibung)
Грийнланд	Грийнланд	Грийнландын хэлний тамгын газар (Oqaasileriffik)
Грек	Грек Кипр	Грек Хэлний Төв (Κέντρον Ελληνικής Γλώσσας)
Гайтын Греоле	Гайти	Ministиre de l'йducation nationale et de la formation professionnelle (Гайтийн боловсролын алба)[citation needed]
Еврей	Израйл	Еврей Хэлний Академи (תירבעה ושלל הימדקאה)
Хинди	Энэтхэг	Хинди хэлний төв зөвлөл (Энэтхэгт Деванагари үсэг хэрэглэх ба Хинди үг, үсгийн дүрмийг тогтоодог)
Хмар	Энэтхэг	Хмар Утга зохиолын нийгэмлэг (Манипур, Энэтхэг) (энэ нь үндсэндээ Төвд үсэг юм билээ)
Унгар	Унгар	Унгарын Шинжлэх Ухааны Академийн Хэл Шинжлэлийн судалгааны институт (Magyar Tudomбnyos Akadйmia Nyelvtudomбnyi Intйzete)
Исланд	Исланд	Бrni Magnъsson Исланд Судлалын Институт
Игбо	Нигер	Игбо Хэл, Соёлыг Суртчилах Нийгэмлэг
Индонез	Индонез	Badan Pengembangan dan Pembinaan Bahasa
Ирланд	Ирланд Умард Ирланд	Foras na Gaeilge
Итал	Итал	Accademia della Crusca (Браны Академи)
Япон	Япон	Албан ёсны төвлөрсөн зохицуулалт үгүй боловч Японы Боловсролын Яамны дэргэдэх Соёлын Хэргийн Агентлаг de facto дүрэм журмаар зохицуулагддаг.
Каннада	Карнатака	Канатака Засгийн Газар ба бусад олон агентлагууд
Кашуби	Польш	Кашуби хэлний коммис (Radzlzna Kaszlbsczйgt Jrzlka)
Казак	Казакстан	Казакстаны Соёлын Яам
Солонгос	Өмнөд Солонгос	Солонгос хэлний Үндэсний Институт
Куен	Норвег	Kainun institutti – kvensk institutt
Ладино	Израйл	Autoridad Nasionala del Ladino (Ладиногийн Үндэсний Захиргаа) [1]

ШУТИС
СУДАЛГААНЫ САН

Латин	Ариун Сий	Латинатас Сан (Opus Fundatum Latinitas) (Ромын Каталик Сүм дэх)[3]
		Ботаникийн нэрийн тухай Олон улсын код (of the International Association for Plant Taxonomy: Ботаникийн ухаан дахь Латин)
		Амьтан судлалын нэрийн тухай олон улсын код (of the International Commission on Zoological Nomenclature: Амьтан судлалын Латин)
Латви	Латви	Latvian State Language Center (Valsts Valodas Centrs)
Lithuanian	Lithuania	Commission of the Lithuanian Language (Valstybinė lietuvių kalbos komisija)
Lusoga	Uganda	Lusoga Language Authority (LULA)
Macedonian	Macedonia	Macedonian Language Institute «Krste Misirkov» (Институт за македонски јазик „Крсте Мисирков“,Institut za makedonski jazik „Krste Misirkov“)
Malay	Malaysia Brunei	Dewan Bahasa dan Pustaka (The Institute of Language and Literature)
Malayalam	Kerala	Kerala Sahitya Akademi and Government of Kerala
Maltese	Malta	National Council for the Maltese Language (www.kunsilltalmalti.gov.mt)
Manx	Isle of Man	Coonceil ny Gaelgey
Māori	New Zealand	Māori Language Commission
Mirandese	Portugal	Anstituto de la Lhĭngua Mirandesa (Institute of the Mirandese Language)
Mixtec	Mexico	Academy of the Mixtec Language (Ve’e Tu’un Sɓvi)
Mongolian	Mongolia	Council of the official state language (Төрийн хэлний зөвлөл). Decisions have to be confirmed by the Mongolian government. [2]
Nepali	Nepal	Language Academy of Nepal
Norwegian (Bokmel and Nynorsk)	Norway	Norwegian Language Council
Occitan	France Spain Monaco Italy	Associacion de Prefiguracion de l’Entitat de Regulacion de la Lenga Occitana. [3]
Pashto	Afghanistan Pakistan	Academy of Sciences of Afghanistan Pashto Academy at the University of Peshawar
Persian	Iran Tajikistan Afghanistan Uzbekistan	Academy of Persian Language and Literature (فرهنگستان زبان و ادبیات ایران)
Polish	Poland	Polish Language Council (Rada Języka Polskiego)
Portuguese	Brazil	Academia Brasileira de Letras (Brazilian Literary Academy)
	Portugal	Academia das Cікncias de Lisboa, Classe de Letras
Quechua	Peru	High Academy of the Quechua Language (Qheswa simi hamut’ana kuraq suntur)

Romanian	Romania	Institutul de Lingvistică al Academiei Romвne (Institute for Linguistics of the Romanian Academy)
	Moldova	Academia de Ştiinţe a Moldovei
Russian	Russian Empire	Russian Academy (1783–1841)
	Russia	Russian Language Institute of the Russian Academy of Sciences (since 1944)
Scots	Scotland	The Scots language Centre supports the Scots language. Scottish Language Dictionaries record and analyse the language as it is spoken and written throughout Scotland today.[
Scottish Gaelic	Scotland	Bтrd na Gaidhlig maintains the national plan for Gaelic, to promote its use and make Gaelic culture accessible
Secwepemctsнn	Canada	Stk’wemiple7s re Secwepemctsin, are the group of people supported by the Secwepemc Cultural Education Society who develop new words.
Serbian	Serbia Montenegro (B & H)	Board for Standardization of the Serbian Language
Sindhi	Pakistan	Sindhi Language Authority [4]
Sinhala	Sri Lanka	Hela Havula
Slovak	Slovakia	Ľudovнt ЉtЂг Institute of Linguistics (Jazykovednə ъstav Ľudovнta ЉtЂгa) at Slovak Academy of Sciences (Slovenskб akadйmia vied)
Slovene	Slovenia	Slovenian Academy of Sciences and Arts
Sorbian	Germany	Serbski institut [5]
Spanish	Spain Colombia Ecuador Mexico El Salvador Venezuela Chile Peru Guatemala Costa Rica Philippines Panama Cuba Paraguay Dominican Republic Bolivia Nicaragua Argentina Uruguay Honduras Puerto Rico	Asociaciyn de Academias de la Lengua Espacola (constituted by the Real Academia Espacola plus 21 other separate national academies in the Spanish-speaking world)
Swahili	Tanzania	Baraza la Kiswahili la Taifa
	Kenya	Chama cha Kiswahili cha Taifa
Swedish	Sweden	Swedish Language Council (semi-official) Swedish Academy
	Finland	Swedish Language Department of the Research Institute for the Languages of Finland (Svenska sprekbyren)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Tamil	Tamil Nadu	Thanjavur Tamil University and Official language Commission of Government of Tamil Nadu
Tatar	Tatarstan	Institute of Language, Literature and Arts of the Academy of Sciences of the Republic of Tatarstan
Telugu	Andhra Pradesh	Telugu Academy and Official Language Commission of Government of Andhra Pradesh
Tetum	Timor-Leste	National Institute of Linguistics at the National University of East Timor
Thai	Thailand	Royal Institute of Thailand
Turkish	Turkey	Turkish Language Association
Ukrainian	Ukraine	National Academy of Sciences of Ukraine
Urdu	Pakistan India	National Language Authority, Pakistan National Council for Promotion of Urdu Language, India
Vxro	Estonia	Vxro Institute
Waray-Waray	Philippines	Sanghiran san Binisaya ha Samar ug Leyte (Academy of the Visayan Language of Samar and Leyte)defunct
Welsh	Wales	— Welsh Language Commissioner (Meri Huws) — The Welsh Government (previously the Welsh Language Board (Bwrdd yr Iaith Gymraeg))
West Frisian	Friesland	Fryske Akademy (Frisian Academy)
Wolof	Senegal	Centre de linguistique appliquйe de Dakar (Center of Applied Linguistics of Dakar at the Cheikh Anta Diop University)
Yiddish	United States Sweden Russia	YIVO [6]
Yoruba	Nigeria	The Yoruba Academy

* * *

Хавсралт 2

Монгол хэл бичиг судлалын салбарын шилдэг эрдэмтдийн мэдээлэл

№	Эрдэмтдийн нэрс	Эрдмийн зэрэг, цол, гавьяа шагнал	Эрхэлдэг албан тушаал	Холбоо барих утас, и-мэйл хаяг
1	Д.Төмөртогоо	Академич, ШУ-ны доктор, профессор, МУ-ын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн	ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал МУИС, Монгол судлалын төвийн захирал	
2	Э.Пүрэвжав	Хэл бичгийн ухааны доктор /Ph.d/	Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	Утас: 98221119, purvee_9@ yahoo.com
3	С.Цэрэнсодном	Академич, ШУ-ны доктор, профессор	ШУА-ын гишүүн, Эх хэлээ хайрлан хамгаалья нийгэмлэгийн тэргүүн	Утас: 330198 /а/
4	Ш.Чоймаа	Төрийн шагналт, Гавьяат багш, ШУ-ны доктор, дэд профессор	МУИС, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхимийн багш	Утас: 88993886

5	С.Мөөмөө	Гавьяат багш, ШУ-ны доктор, профессор	МУИС, МХСС, Монгол хэлшинжлэлийн тэнхимийн багш	
6	н. Өнөрбаян	Гавьяат багш, ШУ-ны доктор, профессор	МУБИС-ын Монгол судлалын сургуулийн захирал	Утас: 99154938
7	Б.Пүрэв-Очир	Гавьяат багш, ШУ-ны доктор, профессор	МУБИС-ын дэд захирал	Утас: 326179, 99834344
8	Ц.Шагдарсүрэн	Төрийн шагналт, Гавьяат багш, ШУ-ны доктор, профессор	МУИС, МХСС, Эхбичиг-Алтай судлалын тэнхимийн багш МУИС, Монгол судлалын төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	
9	Ц.Сүхбаатар	Гавьяат багш, доктор, профессор	МУИС, МХСС, Монгол хэлшинжлэлийн тэнхимийн багш	
10	Б.Чулуундорж	Академич, Ш.У-ны доктор, профессор	Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийн захирал	Утас: 318524
11	М.Базаррагчаа	ШУ-ны тэргүүний ажилтан, ШУ-ны ухааны доктор, проф	МУИС, МХСС, Монгол хэлшинжлэлийн тэнхимийн багш	
12	Ж. Баянсан	Хэл бичгийн ухааны доктор, профессор, Боловсролын тэргүүний ажилтан	Монгол хэл соёлын сургуулийн захирал	Утас: 325435
13	Д.Бадамдорж	Хэл бичгийн шинжлэх ухааны доктор	МУИС, МХСС, Монгол хэлшинжлэлийн тэнхимийн багш	
14	Ч.Зэгиймаа	ШУ-ны доктор, профессор	ХУИС-ийн Хэл соёлын сургуулийн захирал, Хэлний бодлогын үндэстний академийн захирал	Утас: 318524
15	Ж.Бат-Ирээдүй	ШУ-ны ухааны доктор, профессор	-Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрдэмтэн мэргэжилтний зөвлөлийн гишүүн, -Монгол хэл, бичгийн багш нарын үндэсний холбооны тэргүүн -МУИС,МХСС, Монгол хэлний тэнхимийн багш	Утас: 99105206
16	А.Пүрэвжанцан	Хэл бичгийн ухааны доктор	МУИС, Монгол хэлний тэнхимийн эрхлэгч	Утас: Purev_jan@ yahoo.com

* * *

Хавсралт 3

Монгол хэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын жагсаалт

№	Байгууллагын нэр	Хаяг, утас
1	Төрийн хэлний зөвлөл	
2	МУ-ын ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн	БЗД, Офицеруудын ордон, Хүрээлэнгүүдийн нэгдсэн байр, утас: 451436,
3	МҮИС-ын Монгол хэл соёлын сургууль	УБ, СБД, Бага тойруу, Их сургуулийн гудамж-1. ш/х-337. Утас: 77307730, дотуур холбоо-2703
4	Боловсролын Их Сургууль	УБ, СБД, 8-р хороо, Бага тойруу-14. 322296, 326010, 323102, 311547, факс: 976-11-322705 info@msue.edu.mn

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5	Монгол хэлний бичгийн багш нарын үндэсний холбоо	Үндэсний холбооны ерөнхийлөгч Ж.Бат-ирээдүй, утас: 99105206
6	Эх хэлээ хайрлан хамгаалъя нийгэмлэг	ОУС-ын хүрээлэн, ШУА-ын байр, утас: 330198
7	Хэл иргэншлийн дээд сургууль	УБ, СБД, 7-р хороо, 11-р хороолол. УБ-13, ш/х-550, Утас: 350162, 353525, факс: 976-11-353524, www.khel-irgenshil.edu.mn
8	Хэл судлаач дээд сургууль	УБ, ЧД, 13-р хороо, Хайлааст-25, ш/х-24/389, Утас: 357653, 357654, 330175, факс:976-11-357668, www.linguist-edu.mn
9	Хэлний бодлогын үндэстний академи	Улаанбаатар 20/28, Утас:329289

* * *

Хавсралт 4

Стандарт Яриа ба Бичгийн Хятад Хэлний тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хууль

(2000 оны 10-р сарын 31-ний өдөр хуралдсан Улс Ардын Есдүгээр Чуулганы Тэргүүлэх Хорооны 18 -р хуралдаанаар батласан)

Агуулга

1 дүгээр бүлэг. Ерөнхий үндэслэл

2 дугаар бүлэг. Стандарт Яриа ба Бичгийн Хятад хэлийг хэрэглэх

3 дугаар бүлэг. Захиргаа ба Хяналт

4 дүгээр бүлэг. Нэмэлт үндэслэлүүд

Нэгдүгээр бүлэг

Ерөнхий үндэслэл:

Нэгдүгээр зүйл.Энэхүү хууль нь стандарт яриа ба бичгийн хятад хэлийг хэвшүүлэн стандартчилах ба түүнийг дорвитой хөгжүүлэх, улс нийгмийн үйл ажиллагаанд илүү сайн үүрэг гүйцэтгэх ба, Хятадын үндэстэнүүд ба бүс нутгийн хоорондын эдийн засаг, соёлын солилцоог эрчимжүүлэх зорилгоор Үндсэн хуулийг үндэс болгон батлагдсан.

Хоёрдугаар зүйл. Энэ хуулийн зорилгын тухайд, стандарт яриа болон бичгийн Хятад хэл гэдэг нь Путонгхуа (Бээжин аялгуунд үндэслэсэн нийтлэг яриа ба дуудлага) ба стандартчлагдсан хятад ханз үсгүүдийг хэлж байгаа болно.

Гуравдугаар зүйл. Төрөөс Путонгхуа ба стандарт хятад ханз үсгийг дэлгэрүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл.Бүх иргэд стандарт яриа болон бичгийн хятад хэлийг сурах ба хэрэглэх эрхтэй.

Стандарт яриа болон бичгийн хятад хэлийг сурах ба хэрэглэх боломж нөхцлийг Төр хангаж өгнө.

Орон нутгийн засаг захиргаа өөрийн бүх шат түвшин ба харъяалагдах албадууд нь Путонгхуа ба стандарт хятад ханз үсгийг дэлгэрүүлэх арга хэмжээ авах ёстой.

Тавдугаар зүйл. Стандарт яриа болон бичгийн хятад хэлийг төр улсын бүрэн бүтэн байдал ба үндэстний нэр хүндийг хадгалан бэхжүүлэх ба, улс орны эв нэгдэл, үндэстэнтнүүдийн эв нэгдэл ба социализмын материал техникийн баазыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэхийн тухайд хэрэглэх ёстой.

Зургадугаар зүйл.Төр нь яриа болон бичгийн хятад хэлний стандарт хэм хэмжээг тогтоон зохицуулах ба, нийгэм дэх түүний хэрэглээг засаглаж, түүнийг улам бүр хэвшүүлж, баяжуулан хөгжүүлэх үүднээс зааж сургах үйл ажиллагаа, энэхүү хэлээр шинжилгээ судалгааны ажил хийх зэргийг дэмжин тэтгэнэ.

Долдугаар зүйл.Төр нь стандарт яриа болон бичгийн хятад хэлний салбарт гарамгай хувь нэмэр оруулсан байгуулга ба хувь хүмүүсийг шагнаж урамшуулна.

Наймдугаар зүйл.Бүх үндэстэн өөр өөрийн яриа болон бичгийн хэлийг хэрэглэж, хөгжүүлэх эрх чөлөөтэй. Угсаатан үндэстний яриа болон бичгийн хэлийг Үндсэн хууль, Бүс нутгийн үндэстний өөртөө засах ёсны тухай хууль ба бусад хуулиудын дагуу хэрэглэнэ.

Хоёрдугаар бүлэг

Стандарт яриа болон бичгийн хятад хэлийг хэрэглэх тухай:

Есдүгээр зүйл. Путонгхуа ба стандарт хятад ханз үсэг нь энэ болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн байгууллагуудын албан ёсны хэл байна.

Аравдугаар зүйл. Путонгхуа ба стандарт хятад ханз үсэг нь энэ болон бусад хуульд өөрөөр заагаагүй бол сургууль ба боловсролын бусад байгууллагуудад сургалт, боловсролын үндсэн хэл байна. Путонгхуа болон стандарт хятад ханз үсгийг ёургааль ба боловсролын бусад байгууллагуудад хятад хэлний хичээл болгон заана.

Арваннэгдүгээр зүйл. Хятад хэлнээ хэвлэгдэж буй бүхэн стандарт яриа болон бичгийн хятад хэлний хэм хэмжээтэй нийцэж байх ёстой.

Хятад хэлт хэвлэлүүдэд гадаад хэл хэрэглэх хэрэгтэй болвоос стандарт хятад хэлээр шаардлагатай тайлбар тэмдэглэлийг хийх ёстой.

Арванхоёрдугаар зүйл. Путонгхуа нь нийтийн хэвлэл мэдээлэл ба телевизүүдийн хэвлэл мэдээлэлийн үндсэн хэл байна.

Гадаадын хэлийг хэвлэл мэдээлэлийн хэл болгон хэрэглэх хэрэгцээ гарваас энэ тухайд Төрийн Консулын харъяаны хэвлэл мэдээлэл ба телевизийн захиргааны зөвшөөрөлийг авсан байх.

Арвангуравдугаар зүйл. Стандарт хятад ханз үсэг нь худалдаа үйлчилгээний үндсэн үсэг байна. Худалдааны хэрэг зорилгоор зар мэдээний самбар, суртчилгаа, сэтгүүл, шошго тэмдэг гэх зэргийг гадаад ба хятад хэл, хоёулангаар бичих ба, хятад хэлний тухайд заавал стандарт хятад ханз үсгийг хэрэглэнэ.

Худалдаа үйлчилгээнд ажиллаж буй хүмүүс худалдаа үйлчилгээг Путонгхуа хэлээр үйлдвээс зохистой.

Арвандөрөвдүгээр зүйл. Стандарт яриа болон бичгийн хятад хэл нь дараах нөхцөлүүдэд үндсэн яриа ба бичгийн хэл болно:

(1) хэвлэл мэдээлэл, кино ба телевизийн хөтөлбөрүүдийн яриа болон бичгийн хэл;

(2) олон нийтийн газруудын үйлчилгээ, хэрэглэгдэхүүний дээрх бичгийн хэл;

(3) зар мэдээний самбар ба суртчилгааны бичгийн хэл;

(4) бизнессийн болон бусад байгууллагуудын нэр; ба

(5) сав, баглаа боодол ба дотоодын зах зээлд нийлүүлж буй барааны бичиг баримт

Арвантавдугаар зүйл. Мэдээлэл олох ба мэдээлэлийн технологийн бүтээгдэхүүнүүдэд хэрэглэгдэж буй стандарт яриа болон бичгийн хэл нь Төрийн хэм хэмжээтэй нийцэж байх.

Арванзургадугаар зүйл. Энэхүү бүлгийн холбогдох нөхцлүүдийг мөрдлөгө болгохын зэрэгцээ дараах нөхцөлүүдэд орон нутгийн аялгууг хэрэглэж болно:

(1) Төрийн үйл хэрэгт албан үүрэг гүйцэтгэхэд үнэхээр хэрэгцээтэй буй үед;

(2) Төрийн Консулын дэргэдэх хэвлэл мэдээлэл ба телевизийн захиргаа эсвэл муж улсын түвшны

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

мэдээ мэдээлэл ба телевизийн албаны зөвшөөрөлөөр олон нийтийн мэдээлэлд хэрэглэж болно;

(3) уламжлалт дуурь, кино, телевизийн хөтөлбөрүүд ба урлагийн бусад хэлбэрүүдэд хэрэглэх шаардлагатай; ба

(4) тэдгээр нь хэвлэл нийтлэл, сургалт ба судалгааны ажилд үнэхээр хэрэгцээтэй байгаа бол тус тус хэрэглэж болно.

Арвандолдугаар зүйл. Энэхүү бүлгийн холбогдох нөхцөлүүдийг мөрдөхийн зэрэгцээ дараах нөхцөлүүдэд хятадын уг анхны адармаатай ханз буюу өөр хэлбэрүдийг хадгалах буюу хэрэглэж болно:

(1) соёлын өв шүтээн ба түүхэн газруудад;

(2) овог нэрүүдэд;

(3) уран бичлэг ба тамга хагалах зэрэгурлагийн бүтээлүүдэд;

(4) гар бичмэлүүд ба тэмдэг самбаруудад;

(5) хэвлэл нийтлэл, сургалт, судалгаанд тэдгээрийг хэрэглэх шаардлагатай үед; ба

(6) Төрийн Консулын дэргэдэх холбогдох албадаас тэдгээрийг хэрэглэхийг зөвшөөрсөн бусад онцгой нөхцөл байдлуудад.

Арваннаймдугаар зүйл. Стандарт яриа болон бичгийн хятад хэлний хөрвүүлэг ба авиа дуудлагын тэмдэглэгээнд “Хятад дуудлагын үсгийн схем”-ийг баримтлана.

”Хятад дуудлагын үсгийн схем” нь хятад хүмүүсийн болон газрын нэр ба хятад бичиг баримтын нэрийг Ром үсгээр хөрвүүлэхэд зориулж боловсруулсан нэгдсэн хэм хэмжээ мөн бөгөөд хятад ханз хэрэглэхэд зохимжгүй эсвэл хятад ханз хэрэглэх боломжгүй нөхцөлүүдэд хэрэглэнэ.

Хятад дуудлагын үсгийг бага боловсролын шатанд хэрэглэнэ.

Арванесдүгээр зүйл. Путонгхуа нь ажил албаны хэл байх ёстой газрын бүх албан хаагчид Путонгхуа-гаар ярих чадвартай байх ёстой.

Путонгхуа ажил албаны хэл нь болсон мэдээлэлийн ажилтан, теле хөтөлбөрийн хөтлөгч, кино жүжигчин, телевизийн цуврал ба жүжгийн жүжигчин, багш, төрийн албан хаагчид гэх зэрэг хүмүүсийн хэлний мэдлэгийн түвшин Төрөөс тогтоосон зохих стандартыг хангасан байх ёстой; стандарт хангаагүй хүмүүс тохирох түвшний сургалтанд хамрагдах ёстой.

Хорьдугаар зүйл. Хятад хэл сурч буй гадаадын хүмүүст Путонгхуа ба стандарт хятад ханз үсгийг заах ёстой.

Гуравдугаар бүлэг

Захиргаа ба хяналт:

Хорин нэгдүгээр зүйл. Стандарт яриа болон бичгийн хятад хэлтэй холбоотой төлөвлөх, хөтлөх, удирдан чиглүүлэх бүх ажлыг Төрийн Консулын дэргэдэх яриа болон бичгийн хэлний ажлыг эрхэлсэн алба хариуцна.

Төрийн Консулын харъяаны албадууд тус тусын албанд стандарт яриа ба бичгийн хятад хэлийг хэрэглэх явдлыг засаглана.

Хорин хоёрдугаар зүйл. Яриа болон бичгийн хэлтэй холбоотой ажлыг хариуцсан орон нутгийн захигаад ба бусад албадууд нь тус тусын захиргааны нутаг дэвсгэртээ стандарт яриа болон бичгийн Хятад хэлний хэрэглээг захиран удирдана.

Хорин гуравдугаар зүйл. Орон нутгийн Ардын засгийн дэргэдэх эс бөгөөс сумаас дээших шатны захиргааны дэргэдэх аж үйлдвэрлэл ба худалдаа арилжааг хариуцсан захиргааны албадууд нь бизнессийн байгууллагуудын нэр, барааны нэр ба зар сурталчилгаан дахь яриа болон бичгийн хэлний хэрэглээг захиран удирдана.

Хорин дөрөвдүгээр зүйл. Төрийн Консулын харъяаны яриа болон бичгийн хэлтэй холбоотой ажлыг хариуцсан захиргааны алба нь бүх түвшний Путонгхуа хэлний тестийн стандартыг тогтооно.

Хорин тавдугаар зүйл. Гадаад хүний нэр, гадаад газрын нэр, шинжлэх ухааны ба техникийн нэр томъёо зэргийг стандарт яриа болон бичгийн хятад хэлэнд орчуулсан орчуулгыг хянан шалгах ажлыг Төрийн Консулын харъяаны яриа болон бичгийн хэлтэй холбоотой ажлыг хариуцсан алба эсвэл холбогдох бусад албад зохион байгуулна.

Хорин зургадугаар зүйл. Стандарт яриа болон бичгийн хятад хэлний хэм хэмжээтэй нийцэхгүй яриа болон бичгийн хэлний хэрэглээний тухай ба энэ хуулийн Хоёрдугаар бүлгийн холбогдох нөхцөлүүдийг зөрчсөн тухайд ямар ч иргэн шүүмжлэл ба санал хүсэлтээ гаргаж болно.

Энэ хуулийн Арванесдүгээр бүлгийн хоёрдугаар догол мөрт дурдагдсан хүмүүс хэлийг энэ хуулийн Хоёрдугаар бүлгийн холбогдох нөхцөлүүдийг зөрчиж хэрэглэвээс захиргааны холбогдох нэгжүүд, боловсрол олгох хэлбэрээр, шууд хариуцлага хүлээх хүмүүсийг шүүмжлэх ба; үүнийг залруулахаас татгалзсан хэнийг боловч холбогдох захиргааны нэгжүүд арга хэмжээ авна.

Хотуудын олон нийтийн газарт байрлуулсан тоног төхөөрөмж ба тэмдэг тэмдэглээс бүхий самбар дээрх, мөн зар сурталчилгаан дээр энэ хуулийн Хоёрдугаар бүлгийн нөхцөлүүдийг зөрчсөн ханз үсэг зэргийг хэрэглэвээс холбогдох захиргааны албадууд тэдгээрийг засах тушаал гаргана; тэдгээрийг засч залруулахаас татгалзсан хэнд боловч сахилгын сануулга өгч тодорхой хугацааны дотор засч залруулахыг шаардана.

Хорин долдугаар зүйл. Энэ хуулийг зөрчиж, бусад хүмүүсийн стандарт яриа болон бичгийн хэлэнд суралцах ба хэрэглэх үйлэнд саад болсон хэнд боловч холбогдох захиргааны албадуудаас тодорхой хугацааны дотор засч залруулах тушаал ба, сахилгын сануулгыг өгнө.

Дөрөвдүгээр бүлэг, Нэмэлт нөхцөлүүд:

Хорин наймдугаар зүйл. Энэ хууль 2001 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

* * *

Ашигласан материал

1. Базаррагчаа, 1999] - Базаррагчаа.Ц, Хэдэн үеэ бүрэлгэх хэлний гамшиг, МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, № 14/151, УБ 1999. х 200-204
2. [Болд, 2006] - Болд.Л, “Төрийн албан ёсны хэлний тухай хууль”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хэдэн санал, Монгол хэл шинжлэлийн асуудалд, УБ 2006. х 94-96
3. [Адъяа, 2005] - Даяаршил хийгээд монгол хэл бичгийн асуудал (илтгэлийн эмхэтгэл), эмхэтгэсэн О.Адъяа, УБ 2005
4. [Жаргалсайхан, Энхсаруул, 2007] - Монгол улсын ерөнхийлөгч Намбарын Энхбаярын ивээл дор зохион байгуулагдсан “Даяаршил ба төрөөс баримтлах хэлний бодлого” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд, Эмхэтгэсэн О.Жаргалсайхан, Ц.Энхсаруул, УБ 2007
5. [Монгол улсын үндсэн хууль, 1992] - Монгол улсын үндсэн хууль, УБ 1992
6. [Монгол улсын хэлний бодлого, 2006] - Монгол улсын хэлний бодлого, эмхэтгэсэн Б.Ширнэн, У.Сувданцэцэг, УБ 2006
7. [Шагдарсүрэн, 2000] - Ц.Шагдарсүрэн, Хэлний талаарх төрийн бодлого гэж юу вэ?, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, Боть XYI (160) УБ 2000, 13-19-р тал
8. [Төрийн албан ёсны хэлний тухай хууль] -Төрийн албан ёсны хэлний тухай хууль,
9. [Ширнэн, 2005] -Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудлууд (илтгэл, хэлсэн үгийн эмхэтгэл), эмхэтгэсэн Б.Ширнэн, УБ 2005
10. www.wikepedia.com
11. www.unesco.mn
12. www.legalinfo.mn

* * *

UHL.MN
СУДАЛГААНЫСАН

ЛОББИ БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

П. Амаржаргал, Б. Хатантуул, Б. Цолмонбаяр

Лобби бүлгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Улсын Их Хурлын гишүүн Н. Номтойбаярын №6/03 тоот албан бичгийн дагуу “Лобби бүлгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдвээр харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ. Уг судалгааг референт-шинжээч П. Амаржаргал удирдан оршил, дүгнэлт, Япон Улс, Итали Улс, ХБНГУ болон Хавсралт хэсгүүдийг, референт - судлаач Б. Хатантуул Франц, Канад улс гэсэн хэсгүүдийг, референт-судлаач Б. Цолмонбаяр АНУ, Англи улс гэсэн хэсгүүдийг тус тус гүйцэтгэв.

Судалгаанд АНУ, Англи, Герман, Итали, Канад, Франц, Япон зэрэг нийт 7 улсын хувьд лобби болон сонирхлын бүлгүүдийн хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг харьцуулан, онцлог байдлыг авч үзлээ.

Лобби болон тусгай сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой асуудлыг эрх зүйгээр заавал зохицуулах эсэх асуудлаар нэгдсэн жишиг тогтоогүй байна. Өөрөөр хэлбэл улс орон бүрийн онцлог, түүхэн уламжлал, нийгэм, улс төрийн бүлгүүдийн төлөвшил,улс төрийн соёл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан эрх зүйн зохицуулалт, хязгаарлалтын түвшин өөр өөр байгааг улс бүрт товчоор харууллаа.

Япон улс

Япон улсын тухайд хууль тогтоох байгуулага дахь сонирхлын бүлэг болон лобби үйл ажиллагааны талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Улс төрийн өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг сонирхлын бүлгүүдийн талаархи төрийн зүгээс зохицуулалт маш бага байдаг. Нөгөө талаас Японы улс төрд сонирхлын бүлгүүдийн зүгээс мөнгө хандивлахыг хязгаарлан хориглосон ба сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмууд нь ардчилсан улс орнууд дотроо хамгийн хатууд тооцогддог. Үүний үр дүнд Японы сонгуулийн сурталчилгаанд зориулсан хандивын асуудалд хэт хатуу, харин сонирхлын бүлгийн үйл ажиллагаа нь ямар ч зохицуулалтгүй байх эсрэг, тэсрэг дүр зураг байдаг.

Японы сонирхлын бүлгийн гэх АНУ -д байдаг улс төрийн бүх шатны үйл явцад өөр өөрийн асуудал, тактик, стратегитэй оролцдог сонирхлын бүлгүүдтэй адилгүй бөгөөд Европын компаниудын улс төрд нөлөөлөх загварыг илүү дагасан буюу удаан хугацааны, тогтвортой харилцаан дээр үндэслэсэн Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх боломжтой байдаг. Япон Улсад хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаанд ашиг сонирхлын бүлгүүд хэрхэн оролцохыг зохицуулсан зохицуулалт байхгүй, албан ёсны хязгаарлалт байхгүйгээрээ Европын загвараас ялгагддаг.

Итали улс

Италийн Парламент дахь лобби үйл ажиллагааг зохицуулсан нарийн дүрэм, журам байдаггүй. 1980-аад оноос ийм зохицуулалт хийх оролдлого гарч байсан. Тухайлбал, 1983-87 оны Парламентад мэргэжлийн нийтийн албаны үйл ажиллагааг зохицуулсан дөрвөн хуулийн төслийг өргөн барьсан. Ажил олголт ба нийгмийн хамгааллын хорооноос эдгээр

төслүүдийг Доод танхимд хэлэлцэж нэгдсэн төслийг гаргасан байсан боловч Парламент хугацаанаас өмнө тарсан тул энэ ажиллагаа зогссон. 1987, 1989, 1992 онуудад үүнтэй төстэй төслүүдийг өргөн мэдүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй. Сенатын хувьд Үндэсний хэмжээний холбоо болон байгууллагууд Сенатын байранд нэвтрэх зөвшөөрлийн картыг хүсэлт гаргасны үндсэн дээр авч болох боловч тэдгээрийн Парламентын хорооны уулзалтын өрөөнд оруулдаггүй. Шахалтын бүлгүүдийн бүртгэлийг танилцуулах, ийнхүү бүртгэгдсэн бүлгүүд нь өөрсдийн явуулсан үйл ажиллагаа, түүнд зарцуулсан тайланг ил гаргах талаархи шахалт нэмэгдэж байгаа. Сонирхлын болон шахалтын бүлгийг бүртгэх тухай хуулийн төслийг 2001 оны 9 дүгээр сард өргөн мэдүүлсэн боловч батлагдаагүй.

Англи Улс

Лобби бүлгийн үйл ажиллагааг зохицуулсан, лобби бүлгийг бүртгэсэн тусгайлсан акт эрх зүйн баримт бичиг байхгүй бөгөөд лоббист үйл ажиллагаанд оролцогчдыг зохицуулах хандлага илүүтэй байдаг. Судлаач Баггот “улс төрийн аливаа үйл явц нь үндсэндээ шахалтын бүлгийн ямар нэг дарамт, нөлөөллийн үр дагавар байдаг” гэснээс “лоббист” гэдэг ойлголтыг хэрхэн хүлээж авч байгаа нь онцлогтой юм.

1992 онд батлагдаж, 1996 онд шинэчлэгдсэн Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн дүрэмд лобби үйл ажиллагаанд оролцсон парламентын гишүүд тус үйл ажиллагаанд оролцсоноороо ямар нэг шан харамж, бэлэг, нөхөн төлбөр авч байгаа эсэхийг хянах зорилготой зохицуулалт тусгагдсан.

1994 оны 10 -р сард Ерөнхий сайд Жон Майор /John Major/Ноланы хороо /Nolan Committee/ хэмээн нэршсэн Олон нийтийн амьдралд мөрдөх хэм хэмжээ, стандартын хороо /Committee on Standards in Public Life/ -г зарим нэг улс төрчдийн ёс зүйгүй үйл ажиллагааг хянах зорилгоор байгуулсан.

1990-ээд оны үед Англи улсад **“**Cash-for-questions affair” буюу “Асуултны мөнгө” гэж нэршсэн улс төрийн скандал гарсантай холбоотой юм. 1994 оны 10-р сард The Guardian сонин Иан Гриир Нийгэмлэг /Ian Greer Associates/-ийн парламентын алдартай лоббист Иан Гриир Египет эзэнтэй дэлгүүрийн өмнөөс парламентад асуулт тавиулах, бусад арга хамжээг авахуулахаар парламентын 2 гишүүнд авилга өгсөн нь тогтоогдсоноор уг скандалийн эхлэлийг тавьсан. Тус дүрэм нь нийтийн албан хаагчдын худалдаа, санхүүгийн үйл ажиллагааг хянах олон нийтийн ашиг тусын төлөө ажиллуулах зорилготой батлагдсан.

Дээрх дүрмээр “Нийтийн албa” /”public office”/ гэсэн ойлголтыг тодорхойлж, тус ойлголтод Парламентын гишүүд, тэдгээрийн зөвлөхүүд, Засгийн газрын гишүүд, төрийн албан хаагчид, төрийн бус агентууд, эрүүл мэндийн байгууллага, олон нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдсан байгууллагуудын удирдлага болон орон нутгийн эрх баригчид бүгдийг хамруулсан. Тус хороо нь анхны тайлангаараа нийтийн албанд ажиллагчдын үндсэн зарчмуудыг тодорхойлж Сайд нарын Код /Ministerial Code/ -д мөн оруулж өгсөн. Үүнд

- Хувиа хичээхгүй байх – Албан хаагчид нь нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой бөгөөд өөрийн болон гэр бүл, найз нөхдийн ашиг тусын төлөө ажиллах ёсгүй.
- Шударга байдал – Ажил үүргээ гүйцэтгэсний төлөө харилцагчаас ямар нэг санхүүгийн дэмжлэг, хариуцлагыг өөртөө авахгүй байх.
- Үндэслэлтэй байдал– Олон нийтийн ажил хэрэгт оролцох, уулзалт зохион байгуулах, ямар нэг албан тушаал болон шагналд хэн нэгнийг санал болгох зэрэгт бодит үндэслэл, албан ажлын зорилгоор хандах
- Хариуцлагатай байдал – Нийтийн албан хаагчид нь өөрийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаандаа хариуцлага хүлээх үүрэгтэй.
- Нээлттэй байдал- Тэдний ажил үүргийг олон нийт хянахад нээлттэй байлгах ёстой. Олон

нийт шаардсан тохиолдолд тэд гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа үндэслэлийг мэдээлэх үүрэгтэй.

- Үнэнч байх – Нийтийн албан хаагчид нь хувийн сонирхлоо мэдүүлэх ёстой бөгөөд нийтийн ашиг сонирхлыг дагаж ажиллана.
- Манлайлах – Эдгээр зарчмуудыг нийтийн албанд чанд сахиж үлгэр жишээчээр манлайлан биелүүлэх ёстой.

2002 онд энэхүү дүрэмд нэмэлт оруулж “Лобби хийсний төлөө нөхөн төлбөр болон шан харамж авах тухай” бүлгийг нэмж, лобби үйл ажиллагаанд оролцсоны төлөө шан харамж авахгүй байх тухай заасан. Англи улсад гишүүдийн ашиг сонирхлыг бүртгэх мэдүүлэх санал 1975 онд эхэлсэн ч удаан хугацааны дараа биеллээ олсон байдаг. Парламентын гишүүн байсан Нэйл Хамилтон Нийтлэг хэм хэмжээ, эрх мэдлийн хороог 1997 онд байгуулж санхүүгийн үйл ажиллагаагаа ил тод мэдээлэхийг гишүүдээс хүссэн ч амжилтанд хүрээгүй юм.

1994 онд Парламентын Лобби бүлгэмүүд, Мэргэжлийн улс төрийн зөвлөхүүдийн холбоо, Олон нийттэй харилцах институтууд хамтран Лоббистуудыг бүртгэх журам гаргасан боловч Ноланы хороо хүлээн аваагүй.

Тус хороо нь шалтгаанаа “Бид лобби үйл ажиллагааны дараах парламентад гарах нөлөөлөл, үр дагаврыг хянахад гол зорилгоо болгоно. Лоббистуудыг бүртгэх нь бүх лобби бүлгийн үйл ажиллагаа шууд парламентад хандах боломжийг хаах аюултай. Бид тэднийг хатуу чанга хуулиар биш өөрсдийнхөө ёс зүй хэм хэмжээгээр үйл ажиллагаагаа зохицуулахыг дэмжих байр суурьтай байна” гэжээ.

Лордын танхимын хувьд мөн адил тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй. Лоббистууд уулзахыг хүссэн тохиолдолд цаг өгч уулздаг, санал бодлыг нь сонсдог. 1995 онд Журмын хороо /Procedure Committee/ санал болгосноор Лордын танхим гишүүдийн ашиг сонирхлыг бүртгэхийг зөвшөөрсөн. Мөн лордуудын хэн нэгний эрх ашгийн төлөө үг хэлж байгаа эсэх, шан харамж авч байгаа эсэхэд Лордуудын эрх мэдлийн дэд хороо хянах болсон.

Америкийн нэгдсэн улс

АНУ-ын хувьд удаан хугацааны түүхтэй эрх зүйн дүрэм журам бүхий зохицуулалтыг лобби үйл ажиллагаанд тавьдаг. Энэ нь 1946 онд батлагдсан Лобби үйл ажиллагааг зохицуулах нэгдсэн хууль дээр үндэслэдэг. Мөн Хууль тогтоомжийн дахин байгуулалтын акт /Legislative Reorganisation Act/ 1946 онд батлагдсан. Тус хуулиар Конгрессоор хууль батлах бүх түвшинд оролцож байгаа этгээд өөрөө болон хувь хүн, агент, бусад албан тушаалтнаар дамжуулан мөнгө тушааж байгаа болон авч байгаа оролцогч бүгд бүртгүүлэх ёстой. Мөн лобби үйл ажиллагааны санхүүгийн тайланг хуулиар шаарддаг.

Ихэнхи лоббистууд бүртгүүлэхээс татгалздаг, тус хууль нь зөвхөн Конгресст хамаатай байсан учраас тус хуулинд зарчмын 3 өөрчлөлтүүдийг 1995 онд оруулж шинэчилсэн. Үүнд,

1. Зөвхөн Конгресс биш Ерөнхийлөгч, Цагаан ордны төдийгүй засаг захиргааны ажилтнуудад энэ хууль нийтлэг үйлчлэх болсон.
2. Ямар нэг лобби бүлэгтэй холбоо тогтоож тэдэнтэй гэрээ байгуулсан бол 45 хоногийн дотор Төлөөлөгчдийн танхимын нарийн бичгийн даргад мэдэгдэх хуулийн үүрэгтэй болсон.
3. Хагас жил бүр лобби үйл ажиллагаа явуулдаг компаниуд гадны болон дотоодын, Засгийн газарт үйлчилгээ үзүүлсэн талаарх тайлангаа өгөх болсон.

АНУ -ын хувьд лобби бүлгийн үйл ажиллагааг хуульчилж чадсан нь олон нийтийн эрх ашиг хуулинд илүүтэй тусгагдаж батлагдаж байдаг ач холбогдолтой гэж судлаачид үздэг.

Канад Улс

Лоббидох үйл ажиллагааг зохицуулах тухай Холбооны Улсын хуулийг 1988 онд баталсан ба энэ хууль нь эрх мэдлийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг дараах этгээдүүдэд үйлчилдэггүй. Үүнд:

- Муж орон нутгийн засаглалын хууль тогтоох буюу гүйцэтгэх байгууллагын гишүүд
- Гадаад улсуудын сонирхлыг Канадад төлөөлж буй дипломат элчингийн газрын гишүүд
- НҮБ-ын гишүүд, түүнчлэн хуулиар тогтоосон эрх дарх, ямба эдэлдэг бусад олон улсын байгууллагын гишүүд.

Уг хуулийн дагуу дараах зүйлийг лоббидох гэж үзэхгүй:

- Бичгээр илэрхийлэгдсэн хэлбэр нь нийтийн хүртээл болсон бөгөөд тодорхой ажиллагааны явцад хийгдэж байгаа аливаа амаар буюу бичгээр дамжуулан парламентад хандсан хандлага.
- Төлөөлж байгаа бие хүн буюу компаний сонирхолд нийцүүлэн парламентийн аливаа актыг хэрэглэх буюу тайлбар хийх зорилгоор бие хүний зүгээс төрийн албан хаагчид амаар буюу бичгийн хэлбэрээр хандах аливаа хандлага
- Хууль боловсруулахтай холбоотой зөвлөмж буюу тайлбар зөвлөгөө өгөх хүсэлт гарган төрийн албан хаагчийн зүгээс бичгээр ирүүлсэн хүсэлтэд хариу өгөх зорилгоор үйлдэгдсэн төрийн албан хаагчид хандсан аливаа амаар буюу бичгийн хэлбэрээр илэрхийлэгдсэн хандлага, төрийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулсан гэрээ

Лоббич-зөвлөхүүд, Эвлэл нэгдлийн “босоо” лоббичид, Байгууллагын “босоо” лоббичид Лоббичдыг хуульд нийцсэн гэж үзнэ. Лоббич-зөвлөхүүд нь аливаа байгууллага буюу хувь хүний сонирхлыг хөлсөөр хамгаалж, дараахь үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

А) хуулийн төсөл боловсруулах

Б) аливаа хуулийн төсөл буюу бусад хууль эрхийн актуудыг гаргах, өөрчлөх буюу хүчингүй болгох

В) аливаа дотоод дүрэм боловсруулах

Г) төрийн бодлого буюу хөтөлбөр боловсруулах буюу өөрчлөх

Д) төрөөс аливаа мөнгөн тэтгэмж тусламж, баталгаа зэргийг авах.

Тайлагнах. Лоббич-зөвлөхүүд дээрх үйл ажиллааны аль нэгийг эхэлснээс хойш 10 хоногийн дотор бүртгэлийн байгууллагад дараах мэдээллийг илгээх ёстой:

- Өөрийн нэр, ажлын газар
- Ажил олгогчийн нэр ба албан ёсны хаяг
- Ажил олгогч компани, түүнчлэн лоббичийн үйлдлийг сонирхож байгаа аливаа нэг холбогдох компаний зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр
- Ажил олгогч компаний үйл ажиллагааны төрөл
- Лоббичоос төрийн албан хаагчид хандаж тавьсан асуултууд
- Лоббичтай харилцаж байсан төрийн албан хаагчийн ажилладаг төрийн байгууллагууд
- Лоббич болон төрийн албан хаагчдын хоорондын мэдээлэл харилцааны аргууд.

Эвлэл нэгдлийн “босоо” лоббичид гэдэг нь ямар нэг байгууллага буюу хувь хүний хөлсөлөн авсан хүмүүс бөгөөд тэдний чиг үүргийн нилээд хэсгийг (20 ба түүнээс дээш хувь) ажил олгогчийн буюу холбогдох компанийн (хэрвээ ажил олгогч нь бие хүн биш бол) сонирхол,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

эсвэл холбогдох компанийн эрх ашгийн үүднээс төрийн албан хаагчтай дараах асуудлын талаар харьцах ажил эзэлдэг:

- Хуулийн төсөл боловсруулах
- Аливаа хуулийн төсөл буюу өөр бусад хууль эрхийн актуудыг бий болгох, өөрчлөх буюу хүчингүй болгох
- Дотоод дүрэм боловсруулах
- Төрийн бодлого буюу хөтөлбөр боловсруулах буюу өөрчлөх
- Төрөөс аливаа мөнгөн тэтгэмж тусламж, баталгаа зэргийг авах.

Тайлагнах. Эвлэл нэгдлийн “босоо” лоббич бүртгэлийн байгууллагад дараах мэдээллийг хоёр сарын дотор илгээх ёстой:

- Өөрийн нэр, ажлын газар
- Ажил олгогчийн нэр ба албан ёсны хаяг
- Ажил олгогч компани, түүнчлэн лоббичийн үйлдлийг сонирхож байгаа аливаа нэг холбогдох компаний зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр
- Ажил олгогч компаний үйл ажиллагааны төрөл
- Лоббичоос төрийн албан хаагчид хандаж тавьсан асуултууд
- Лоббичтай харилцаж байсан төрийн албан хаагчийн ажилладаг төрийн байгууллагууд
- Лоббич болон төрийн албан хаагчдын хоорондын мэдээлэл харилцааны аргууд.

Байгууллагын “босоо” лоббичид гэдэг нь байгууллагын хамтран зүтгэгчид бөгөөд тэд ажил олгогч компаний сонирхлын үүднээс дараах асуудлаар төрийн албан хаагчтай харьцах харьцаа байдаг:

- Хуулийн төсөл боловсруулах
- Аливаа хуулийн төсөл буюу өөр бусад хууль эрхийн актуудыг бий болгох, өөрчлөх буюу хүчингүй болгох
- Дотоод дүрэм боловсруулах
- Төрийн бодлого буюу хөтөлбөр боловсруулах буюу өөрчлөх
- Төрөөс аливаа мөнгөн тэтгэмж тусламж, баталгаа зэргийг авах.

Тайлагнах. Хэрвээ байгууллагын бүх ажилчид лоббидох үйл ажиллагаа нийт цаг нь байгууллагын бүх ажилчдаас ажил эрхэлбэл зохих нийт цагийн 20 хувиас багагүй хугацааг бүрдүүлж байгаа бол энэ нөхцөлд байгууллагын “босоо” лоббичдын бүртгэлийг ажил олгогч компани хийнэ. Хэрэв уг нөхцөл биеллээ олж байгаа бол ажил олгогч компаниас лоббидох үйл ажиллагаа эрхэлж байгаа өөрийн бүх хамтран зүтгэгчдийн тухай мэдээллийг бүртгэлийн байгууллагад илгээх ёстой (түүнчлэн лоббидох үйл ажиллагаа эрхлэх цаг нь 20 хувиас бага байгаа ажилчдын мэдээллийг ч явуулна).

Канад дахь Лоббичдын бүртгэлийн хүрээлэн. Канад дахь лоббичдыг бүртгэдэг байгууллага нь Канадын бүртгэлийн төв товчоо бөгөөд жил бүр жил эцсийн (үр дүнгийн) тайлангаа нийтлүүлдэг. Лоббидох үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн шаардлагыг дагаж мөрдөх ажлыг тусгай томилогдсон ёс зүйн зөвлөгч гүйцэтгэдэг.

Ёс зүйн зөвлөгч бол “Лоббичийн зан төлвийн багц хууль”-ийг гаргах ажлыг удирддаг. Хэрвээ лоббич нь Лоббидох үйл ажиллагааг зохицуулах тухай журам, эсвэл багц хуулийг зөрчсөн бол ёс зүйн зөвлөгч будлиан зөрчлийг мөрдөх ажиллагааг зохион явуулна. Мөрдөх ажиллагааг дуусган лоббичийн авсан нийт мөнгөн дүн, түүний зарцуулсан

зарлагын талаарх мэдээллийг агуулсан тайлан бичиж Канадын бүртгэлийн төв товчоо болон парламентын танхим /дээд, доод танхим/ бүрт илгээх ба тэд тайлангийн үндсэн дээр дүгнэлт гаргадаг. Лоббидох үйл ажиллагааг зохицуулах Канадын систем нь Америкийн системийг бодвол илүү либераль шинжтэй учир олон түмний зүгээс лоббидох үйл ажиллагаандаа зарцуулсан санхүүжилтийн хэмжээгээ ил болгон задруулах ёсгүй, өндөр албан тушаал хашиж байгаа халагдсан сайд нар эсвэл бусад төрийн албан хаагчдад тавих бизнес эрхлэлтийн хязгаарлалт байхгүй, тендерийн хуваарилах систем ил тод бус, парламентийн гишүүдэд өөрийн сонирхлоо ил тод болгох, бэлэг авах зэргийг хязгаарлахыг албадан үүрэг болгож чаддаг тийм зан байдлын багц хууль байхгүй зэргээр шүүмжлэгдэж байна.

Ийнхүү бүртгэлийн болон багц хуулийн дүрэм журмыг зөрчвөл торгууль оногдуулж болох ч Канад дахь лоббичуудын бүртгэл ерөнхийдөө мэдээлэл өгөх шинжтэй байна.

Франц Улс

Францын Үндэсний Ассамблейн дээд, доод танхимын алинд ч лоббистуудад хамаатай албан ёсны дүрэм, журам байдаггүй байна. Мөн түүнчлэн нөлөөллийн эсвэл сонирхолын ямар нэгэн бүлгийн бүртгэл байхгүй. Доод танхимын депутатууд 79 дүгээр зүйлд заасны дагуу хувийн эрх ашгийг хамгаалсан, орон нутгийн эсвэл мэргэжлийн ашиг сонирхлын бүлэг эсвэл нийгэмлэгт хамаарах болон парламентын үйл ажиллагаатай холбогдуулж аливаа амлалт өгөхийг хориглодог байна. Харин мэргэжлийн бүлэг эсвэл байгууллага Сенаттай холбоо тогтоох тохиолдолд эхэлж Сенатын танхимын тэргүүнд хүсэлт гаргадаг байна.

* * *

Дүгнэлт

Лобби болон сонирхлын бүлгээс хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн талаар эрх зүйн зохицуулалттай улс орнууд нь АНУ /Лоббиг хязгаарлах тухай хууль 1995/, Канад Улс /Лоббистуудын бүртгэлийн тухай хууль 1988/ байх ба бусад улс орнуудын хувьд ийм тусгайлсан эрх зүйн зохицуулалт бүхий хууль байхгүй байна.

Хуулиар тусгайлан зохицуулсан дээрх хоёр улсын энэ талаархи зохицуулалтын гол зорилго нь Лоббистуудыг бүртгэх, бүртгэсний үндсэн дээр санхүүгийн үйл ажиллагаа нь ил тод нээлттэй тайлагнах боломжтой болгоход чиглэгдсэн байх боловч АНУ эрх зүйн зохицуулалтыг илүү хатуу гэж үздэг байна. Зохицуулалтгүй орнуудын хувьд авч үзвэл огт зохицуулалтгүй эсхүл хууль тогтоох байгууллагын өөрийн нь дүрэмд бага зэрэг тусгагдсан гэсэн хоёр зохицуулалтын арга байна. Огт зохицуулалтгүй улсын жишээ нь Япон улс байх боловч лобби бүлгийн үйл ажиллагааг улс төрийн соёл, уламжлал, ёс зүйгээр зохицуулах шинжтэй байна. Итали улсын хувьд лобби үйл ажиллагааны зохицуулалт байхгүй байгаагийн шалтгаан нь Япон улсынхаас өөр байх ба энэ асуудлыг зохицуулсан хуулийн төслүүдийг өргөн мэдүүлж байсан боловч тодорхой улс төрийн шалтгаанаар амжилтгүй болж байсан байна.

Харин Англи улсын хувьд дан ганц эрх зүйн зохицуулалт бол хангалтгүй гэж үздэг ба хуулиар лобби бүлэг гэдгийг хатуу тодорхойлсон нь хэсэг бүлэг лобби бүлгийн үйл ажиллагааг монополь болгох, тэдэнд давамгай эрх олгодог дутагдалтай талтай гэж тайлбарладаг тул лобби үйл ажиллагаа гэхээсээ илүү лобби бүлгийн үйл ажиллагаанд оролцогч субьектэд шууд чиглэсэн, танхимуудын дүрэмд тусгагдсанаараа онцлогтой. Герман улсын хувьд лобби үйл ажиллагааны талаархи эрх зүйн зохицуулалтыг Бундестагийн үйл ажиллагааны дүрэмдээ тусгаснаараа Европын улс орнуудынхаас ялгаатай байна.

СУДАЛГААНЫ

Хавсралт

Гадаад улсад Лобби бүлгийн үйл ажиллагааг зохицуулсан талаархи товч бүдүүвч

	Улсын нэр	Лоббистуудын талаархи дүрэм	Үйл ажиллагаа
1.	Канад улс	Лоббистуудын Бүртгэлийн тухай 1989 оны хуулиар лоббистуудын төрлийг тодорхойлсон. 1996 оноос хойш лоббистуудын бүртгэл олон нийтэд ил тод болсон. Энэхүү бүртгэлийг Үйлдвэрлэлийн яамны харьяаны Лоббистын бүртгэлийн газар хөтөлдөг. Лоббистуудын заавал дагаж мөрдөх ёс зүйн дүрэмтэй.	
2.	Франц улс Үндэсний хурал	Дүрэм, бүртгэл, жагсаалт байхгүй. Товчооны талаархи ерөнхий зааврын 26 дугаар зүйлд Үйл ажиллагааны дүрмийн 23 дугаар зүйл Мөн дүрмийн 79 дүгээр зүйл Үндэсний хурлын Товчооны дэг	Ерөнхийлөгч эсхүл Квастьер зөвшөөрлийг олгох бөгөөд гишүүд лоббистуудын өмнөөс хүсэлт гаргана. Хувийн, орон нутгийн болон мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалсан бүлэг байгуулахыг хориглоно. Ийм бүлэг ордонд уулзаж болохгүй. Ийм бүлэг нь заавал биелүүлэх ёстой зааварчилгаатай бол ийм бүлэгт нэгдэхийг хориглоно. “Судалгааны бүлэг” зөвшөөрөгдсөн, ажилтан нь нарийн бичгийн даргын үйл ажиллагаа явуулж болно. Хязгаартай үйлчилгээ болон хангалтыг зөвшөөрдөг. Захиргааны зардал байхгүй.
	Франц улс Сенатын танхим	Бүртгэл, дүрэм байхгүй. Үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйл 1984 оны Сенатын товчооны тогтоол 84-63	Ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн даргын газраас зөвшөөрлийг олгодог. Хувийн, орон нутгийн болон мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалсан бүлэг байгуулахыг хориглоно. “Судалгааны бүлэг” болон “ажлын хэсэг”-ийг зөвшөөрөх боловч хураамж төлнө. Сенатын ажилтан нарийн бичгийн үйл ажиллагаа хийж болно.
4.	Герман улс Бундестаг	Үйл ажиллагааны дүрмийн 2 дугаар хавсралтаар жил бүр улсын бүртгэл хөтлөхийг шаарддаг.	Хороод болон Бундестаг нь жагсаалтад байхгүй, холбоод болон шинжээчдийг хуралдаа урилгаар оролцуулж болно.
	Герман улс Бундестрат	Дүрэм, бүртгэл байхгүй.	
5.	Итали улс	Дүрэм, бүртгэл байхгүй.	
6.	Япон улс	Дүрэм, бүртгэл байхгүй.	
7.	Их Британийн Нэгдсэн Вант Улс Төлөөлөгчдийн танхим	Дүрэм, бүртгэл байхгүй. Сэтгүүлчид “бүх нам” болон бүртгэлтэй бүлэг, гишүүдийн ажилтнуудын бүртгэл байдаг ба нийтийн танхимын номын санд хадгалагддаг.	
	Их Британийн Нэгдсэн Вант Улс Лордын танхим	Бүртгэл, дүрэм байхгүй.	
8.	Америкийн Нэгдсэн улс	Лоббиг хязгаарлах тухай хууль 1995: Лоббист гэдгийг өргөнөөр тодорхойлсон. Төлөөлөгчдийн танхимын нарийн бичгийн дарга бүртгэлийг хөтөлнө. Хагас жилийн тайлан.	

* * *

Ашигласан материал:

1. Lobby Regulation in the Japanese Diet. By Ronald J.Hrebenar, Akira Nakainura and Akio Nakamura. Parliament Affair (1998) 51 (4) 551-558
2. Regulation of Lobbyists in Developed Countries, Current Rules and Practice (2004)
3. http://www.regulatelobbying.com/
4. Merry Dean. Japanese Legal System. Second edition (2002)
5. Blacks law dictionary. Editor in chief Bryan. A Garner. Eighth edition (2004)
6. Institute of Public Administration Study on the Regulation of Lobbyists in Developed Countries
7. http://per.gov.ie/wp-content/uploads/Public-Relations-Consultants-Association-Ireland.pdf
8. http://en.wikipedia.org/wiki/Ministerial Code
9. www.parliament.uk/commons/lib/research/notes/snpc-01816.pdf
10. www.parliament.uk/commons/lib/research/notes/snpc-01816.pdf
11. http://www.environ.ie/en/LocalGovernment/LocalGovernmentAdministration/StandardsinPublicLife/PublicationsDocuments/FileDownLoad,2048,en.pdf

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТ, ТҮҮНИЙ ДЭГЛЭМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БУСАД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

Ц. Товуусүрэн, Ө. Мөнхтунгалаг

Агуулга

Хилийн дэглэмийн эрх зүйн үндэс

1. МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТ, ТҮҮНИЙ ДЭГЛЭМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтууд

1.2. Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтууд

2. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД

2.1. Европ тивийн улс орнуудын хувьд хамтын ажиллагааны хэлбэрүүд

2.2.Европын холбоонд нэгдэхгүй байх, тодорхой хязгаартай нэгдэх

2.3. Европын холбоонд үл хамаарах

2.4. Шенгений бүс

2.5.Европын холбооны улсуудын визийн ангилал

Хавсралт 1. Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтуудын байршил, ангилал

Хавсралт 2. Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтуудын байршил, ангилал

Хавсралт 3. Европын холбооны улсуудын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж

Ашигласан материал;

* * *

Оршил

“Монгол Улсын Хилийн боомт, түүний дэглэмийн өнөөгийн байдал, бусад орнуудын эрх зүйн эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Судалгааны төвд ирүүлсэн захиалагчийн хүсэлтийн дагуу нэгтгэн бэлтгэв. Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн дэглэмтэй холбоотой материалыг референт-судлаач Ө.Мөнхтунгалаг, Европын холбооны улсуудын хилийн дэглэмтэй холбоотой материалыг ахлах референт Ц.Товуусүрэн нэгтгэн боловсруулав.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгаа нь Монгол Улсын Хилийн боомт, түүний дэглэмийн өнөөгийн нөхцөл байдал, Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн боомтын дэглэмийг зохицуулж байгаа гэрээ, хэлэлцээр, эрх зүйн актууд, дотоодын хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн боомтын эрх зүйн орчин, Европын холбооны улсуудын хилийн дэглэмийг судлахад чиглэгдсэн болно.

Судалгааны зорилт:

Монгол-Орос, Монгол-Хятад, Европын холбооны улсуудын хамтын ажиллагааны хэлбэрүүд, тэдгээрийн зарчим, хилийн дэглэмийн эрх зүйн орчин, тэдгээрийг мөрдөж байгаа практик алхмуудын талаар судлаж, материалыг нэгтгэн бэлтгэх зорилт тавив.

Судалгаа мэдээллийн эх сурвалж:

Судалгааны ажлын хүрээнд Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар, Гадаад Харилцааны Яамны Хөрш орнуудын газар зэрэг хилийн харилцааг зохицуулж буй хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны талаар Судалгааны төвд ирүүлсэн мэдээллээс тоймлон оруулав.

Европ тивийн улс орнуудын хамтын ажиллагааны хэлбэрүүд, Европын холбооны улсуудын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд европын холбоонд нэгдэхгүй байх, тодорхой хязгаартай нэгдэх, холбоонд үл хамаарахтай холбогдсон зохижуулалт, визийн ялгааг онцолж сонгон авч үзсэн болно. Түүнчлэн Европын холбооны хэмжээнд мөрдөгдөж байгаа хилийн зохицуулалттай холбоо бүхий эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалтыг хавсаргав.

Хилийн дэглэмийн эрх зүйн үндэс

Улсын хил бол зөвхөн газарзүйн зурагт тэмдэглэгдсэн зураас бус тухайн улсын бусад улс орнуудтай харилцах төрөл бүрийн үйл ажиллагаа явагддаг геополитикийн орон зай юм. Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг улс орнууд юуны түрүүнд Үндсэн хуулиараа тодорхойлдог. Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байх, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх зарчим нь Үндсэн хуулиас эхтэй улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндэс мөн юм. Хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг тогтоохдоо хилийн орон зай дахь улсын аюулгүй байдлыг хангах, түүний дотор улсын хилийг хамгаалахад чиглэгдэж байх ёстой.

Хилийн дэглэмийн эрх зүйн баримт бичгүүдэд тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж болон улс хоорондын хилийн дэглэмийн гэрээ хэлэлцээрүүд багтана.

Хилийн орон зайн төрөлд хуурай замын, агаарын, усан замын боомтууд багтана. Хилийн дэглэм гэдэг нь дор дурдсан нормчилж тогтоосон дүрэм журмын нэгдэл юм. Үүнд:

- улсын хил дээрх хяналт шалгалтын зориулалт бүхий тоноглол, хилийн тэмдэглэгээ, хил нэвтрэх шугам, зарим шаардлагатай үед хийгдэх хамтарсан шалгалтыг явуулах нөхцлийн дүрэм, журам;
- Улсын хилээр хүн, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх, бараа таваар, ажил үйлчилгээ, амьд амьтныг хилийн тогтоосон авто зам, төмөр зам, усан замын шалган нэвтрүүлэх пунктээр дамжин өнгөрүүлэх, олон улсын нээлттэй нислэг үйлдэж буй агаарын агаарын хөлгийг нэвтрүүлэх дотоодын болон олон улсын нормчлогдсон актууд;
- хил орчмын ус /ихэнхдээ 5 км-ын өргөн/-нд аж ахуй эрхлэх, олборлолт явуулах, хайгуул, судалгааны ажил явуулах, олон нийт, улс төрийн болон бусад арга хэмжээг усан хилийн зэргэлдээ суурингийн дэвсгэр нутагт зохион байгуулахтай холбогдсон журам;
- гадаадын улстай хилийн будлианы талаар хэлэлцээр хийх зөвшөөрөл олгох журам

Хил залгаа улс орнуудын хилийн дэглэм нь тэдгээрийн нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, хоёр улсын хооронд хилийн дэглэмийн талаар байгуулсан гэрээ хэлэлцээр, үндэсний хууль тогтомжоор тогтоосон хэм хэмжээнээс хамаарч өөр өөр байна. Жишээ нь: ОХУ, Латвийн хооронд хилийн дэглэм нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулагдаж байхад ОХУ, Украйны хилийн дэглэм нь ТУХН /Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг/-ийн гэрээгээр зохицуулагдах бөгөөд хилийн хяналт тогтоосон боомтуудад явагддаг байна. Харин Шенгений орнуудад тэдгээр улсын иргэд хилийн аль ч хэсгээр нэвтрэх боломжтой байдаг.

Хилийн дэглэмийн үүсэл, хөгжил /ЗХУ -ын жишээн дээр/

Улс орнуудад хилийн дэглэм тогтоох үйл явц нь хил хамгаалах үйл ажиллагаанаас үүсэлтэй. Эрт үеэс улс орнууд хил залгаа, тэр ч бүү хэл алсын улс орнууд руу дайлаар мордож эзлэн авч байсан нь хил хамгаалах үйл ажиллагааг үүсгэхэд хүргэжээ. Эртний Орос оронд хил залгаа нутаг гадны довтолгоонд байнга өртөж байсан учраас эх орноо гадны довтолгооноос хамгаалах явдал бол нэр төр, алдар гавъяаны хэрэг байв. Эртний Орос орны анхны хилийн баатар бол Илья Муромец байв. Оросын анхны вангуудын үеэс хилээ хамгаалах зорилгоор хот-цайзуудыг байгуулж, хамгаалах байгууламж, утаат болон түүдэг галан холбооны хэрэгслийг буй болгосон байна.

Эртний оросын баруун болон баруун хойт хилийг хамгаалах албыг Новогород, Псков, Полоцк, Старая Ладога, Копорье зэрэг хотууд найдвартай залгуулж байжээ. X-XI зууны үед 100 харуулын хотоос бүрдсэн хил хамгаалалтын нэгдсэн системийг байгуулсан байна. Оросын хилийн анхны хамгаалагчдыг татах зорилгоор тэдэнд хөнгөлөлт, эрх чөлөө, үржил шим бүхий газар олгож байв. Хилийн орчимд суурьшуулсан цэрэг нь хил хамгаалах ажлыг хөдөө аж ахуй гар урлалын ажилтай хослон гүйцэтгэж байжээ.

Татар-Монголын довтолгооны дараах 240 жилийн турш Оросын төрт улсын хөгжлийг тасалжээ. Орос орон Алтан ордын улсын нэгэн хэсэг болж, өөрийн хилийг хамгаалах чадвараа алдсан байна. Жижиг ванлигуудад хуваагдсан Орос орон зөвхөн баруун хилээ Польш, Литви, Немц, Шведийн дайчдаас өөрийн хэр хэмжээнд хамгаалж байжээ. XIY-XY зуунд Москвагийн төрт улс байгуулагдаж, 1360 онд Москвагийн хилийн анхны харуулыг байгуулсан байдаг. Москвагийн анхны хилийн тагнуулын үүргийг гарамгай биелүүлж байсан Дмитрий Донской 1380 онд дайсны хөдөлгөөнийг нэгд нэгэнгүй тагнан илрүүлж байсныг он дараллын бичигт тэмдэглэсэн байна.

XIII зууны эхэн үеэс хилийн цэргийн албаа нь хууль бус наймаатай тэмцэх үүргийг давхар биелүүлдэг болжээ. Энэ үед үйлдвэр, худалдаа хурдацтай хөгжиж, тэдгээрийг гадаадын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөнөөс хамгаалах шаардлага урган гарч, импортын бараанд гаалийн өндөр татвар тогтоож байсан ч хил дамнасан хууль бус наймаа өргөжиж, арга нь нарийсч байжээ. 1754 оноос хил хамгаалах цэргийн албаны зэрэгцээ Сангийн яаманд харъяалагдах сайн дурын гаалийн хяналтыг хэрэгжүүлж эхэлсэн. 1882 оноос хил орчмын мужуудад гаалийн хяналтын онцгой албыг баталж өгчээ.

Хэдэн жилийн дараа тэр үеийн хилийн бэхлэлт, хил хамгаалагч казакууд, гаалийн харуулуудын аль нь ч хил хамгаалах, хил дамнасан хууль бус наймаанаас хамгаалах чадваргүй болсон байна. Ийм учраас Николай I хаан 1827 оны 8 дугаар сарын 5-нд “Европын хил дээр хилийн гаалийн харуул тохинуулан байгуулах дүрэм, орон тоо”-г баталсан байна. Хилийн манаанаы дараа дараагийн жилүүдийн өөрчлөлт нь цэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Кавказ, дундад азийн хязгаарын хамгаалалт XIX зуун хүртэл хуучин янзаараа цэргийн анги, казакуудаар хамгаалсан хэвээр үлдсэн байна.
Зүүн болон алс дорнодын хязгаарт XX зууны 20-иод он хүртэл хилийн тусгай харуулууд байгаагүй юм. Александр III хааны зарлигаар 1893 оны 10 дугаар сарын 15-нд Сангийн яаманд харъяалагдах Хилийн харуулын тусгай корпусыг байгуулсан байдаг.

Оросын эзэнт улсын хилийн харуулууд цэрэгжсэн хэлбэрт шилжсэн. Ялангуяа Кавказын хязгаарт хил дээр ширүүн тулалдаан болдог байв. Бараг өдөр бүр дээрэмчдийн бүлгийн дайралт, цуст мөргөлдөөн, тулгаралт, буудалцаан болж байв. Хил дамнасан хууль бус наймаа хүчтэй зэвсэглэсэн хуягуудаар хамгаалуулж, өөрсдийн барааг хамгаалахын хажуугаар хилчид рүү өөрсдөө довтолдог байжээ.

Хилийн харуулууд XIX зуун, XX зууны эхэн хүртэл тулаанд оролцдог байв. XX зууны эхэн үе, дэлхийн I дайн эхлэх үед хил хамгаалах алба бүхэлдээ цэргийн командлалд шилжин довтолгоон, хамгаалалт, тагнуулын үүргийг биелүүлж байжээ. Дэлхийн I дайны үед хамгийн их тэсвэр хатуужилтай, чадварлаг дайчид нь казакууд, хилийн цэргийн ангиуд байв. 1918 онд Хилийн харуулын тусгай корпусыг татан буулгаснаар хилийн харуулын түүх дуусгавар болсон байна.

Октябрийн хувьсгалын дараа ардын комиссаруудын зөвлөлийн шийдвэрээр хил хамгаалах албыг байгуулсан байна. Хожим нь эхлээд ОХУ-ын дараа нь ЗХУ -ын хуурай замын, усан гадаргын, агаарын улсын хилийн харилцааг зохицуулахтай холбогдсон хууль, тэдгээрийг дагасан хууль тогтоомжийн актууд батлагджээ.

ОХУ-ын Ардын комиссаруудын зөвлөлөөр 1921 оны 1 дүгээр сарын 17-нд “Агаарын тээврийн хөдөлгөөний тухай”, 1925 оны 3 дугаар сарын 10-нд “Оросын төрийн далбаа бүхий хөлөг онгоцонд үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт үйлдлийн тухай”, 1927 оны 6 дугаар сарын 15-нд ЗХУ-ын “Улсын хилийн хамгаалалтын дүрэм”, 1929 оны 6 дугаар сарын 14-нд “Далайн тээврийн худалдааны тухай хууль”, 1930 оны 7 дугаар сарын 3-нд ЗХУ, ОХУ-ын засгийн мэдэлд байдаг “Финийн булангийн усан орон зайн тухай”, 1931 оны 8 дугаар сарын 23-нд “ЗХУ-ын хилийн ариун цэврийн дүрэм”, 1932 оны 4 дүгээр сарын 27-нд “ЗХУ-ын агаарын тухай хууль” зэрэг эрх зүйн актууд батлагдсан байна.

Улсын хилийн дэглэмийн талаарх эрх зүйн үндсэн баримт бичгүүдэд дор дурдсан хууль тогтоомжийн актууд хамаардаг. Үүнд:

- ЗХУ -ын агаарын тухай хууль, ЗХУ болон холбооны улсуудын “Эрүүгийн хууль”, “Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тухай хууль”, холбооны улсуудын “Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль”, 1964 оны ЗХУ-ын Дээд зөвлөлөөс баталсан “Гаалийн тухай хууль”, 1960 оны 8 дугаар сарын 5-нд ЗХУ-ын дээд зөвлөлөөс баталсан “ЗХУ-ын хил хамгаалалтын дүрэм”, 1970 оны 10 дугаар сарын 22-нд ЗХУ-ын Сайд нарын зөвлөлөөс баталсан “ЗХУ-ын хилээр нэвтрэн орох, ЗХУ-ын хилээр гадагш гарах дүрэм”, 1974 оны 8 дугаар сарын 28-нд ЗХУ-ын Сайд нарын зөвлөлөөс баталсан “ЗХУ-ын паспортын тогтолцооны тухай”, 1962 оны 11 дүгээр сарын 21-ний “Гадаадын хөлөг онгоцоор тээвэрлэж байгаа барааны гаалийн хяналтын заавар”, 1973 оны 5 дугаар сарын 31-ний “ЗХУ-ын ариун цэврийн хяналтын дүрэм”, 1967 оны 8 дугаар сарын 5-ны “ЗХУ-ын нутаг дэвсгэрт халдварт өвчний хөл хориотой бүсээс өвчин тараах, нэвтүүлэхээс хамгаалах ариун цэврийн дүрэм”, ЗХУ-ын хилийн ус, зогсоолд гадаадын хөлөг онгоц нэвтрэх заавар болон бусад.

1938 онд хил хамгаалах албанд 30 хилийн отряд шинээр байгуулагдаж, хил хамгаалахад 117000 албан хаагч хамрагдах болжээ. Энэ үед ЗХУ-ын хилийн цэрэг Улсыг аюулаас хамгаалах байгууллагуудтай хамтран Гитлерийн тагнуулын агент, дээрмийн бүлгүүдтэй тэмцэж байв.

Эх орны дайны үеийн хилийн алба.

Хилийн цэргийн хувьд эх орны дайн томоохон шалгуур байсан юм. Баренцийн тэнгисээс Хар далай хүртэл хуурай замын 47, тэнгисийн 6 отряд, тусгай үүрэгтэй 9 команд энэхүү дайнд эх орноо хамгаалахад оролцжээ. Эх орны дайны үед хилийн цэрэгт армийн ар талыг хамгаалах үүрэг ногдуулсан байна. Үүгээр ч зогсохгүй тэргүүн эгнээнд байлдаж дайсанд цохилт өгөхөд томоохон хувь нэмэр оруулжээ. Дайсанд эзлэгдсэн нутаг дэвсгэрт партизаны хөдөлгөөнийг өргөжүүлэн тэлэхэд хилийн цэрэг чухал хувь нэмэр оруулсан байна.

Эх орны дайны дараах хилийн хамгаалалт.

Дайны дараах жилүүдээс хилийн анги нэгтгэлүүд аажмаар тайван цагийн дэглэмд

шилжиж, энэ үйл явц 1948 онд дуусгавар болжээ. 1957 онд ЗХУ-ын Хилийн цэргийн газрыг Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсыг аюулаас хамгаалах газрын харъяанд шилжүүлж, хил хамгаалах үүргийг хариуцуулсан байна. 1960 онд ЗХУ -ын хилийн шинэ дүрмийг батлан хилийн цэргийн эрх зүйн байдал, бодлого, үүргийг шинээр тогтоож, хил тогтоох, хил зөрчигчдийг илрүүлэх, хилийн дэглэм, хилийн зурвас, хилийн бүс, далайн болон хил орчмын гол мөрний сав газрын ашиглалтын журмыг тогтоосон байна.

1970-аад оны эхэнд Байгалийн чанадын , Прибалтикийн, Камчатскийн, Арктикийн хилийн тойруудыг шинээр эмхлэн байгуулжээ. 1982 онд баталсан “Улсын хилийн тухай” хууль нь хилийн цэргийн өөрчлөн байгуулалтыг нэг мөр тусгасан хууль болсон гэж үздэг.

Орчин үеийн хилийн хамгаалалт.

ОХУ -ын хилийн хамгаалалтад 10 бүс нутгийн удирдах газар, тэдгээрийн бүрэлдэхүүн дэх хилийн 80 отряд, 950 гаруй застав, 11 мянга гаруй албан хаагчид ажиллаж байна. ОХУ-ын Гаалийн ерөнхий хорооны албатай хамтарсан 400 орчим хилийн байцаан өнгөрүүлэх алба байна.

ОХУ -ын Хилийн албаны бүрэлдэхүүнд Тажикстаны Хилийн бүлэг, Армян, Киргиз, Казахстан Улс дахь шуурхай ажлын бүлгүүд багтдаг байна. Ерөнхий дүнгээр ОХУ-ын хил дээр 200000 хилчид хил хамгаалах үүрэг гүйцэтгэж байна. ОХУ-ын хуурай замын хилийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа Хилийн албаны анги, нэгтгэлүүдийн зэвсэглэлд орчин үеийн зэвсэг, техник, автомашиныг хэрэглэж байна.

Агаарийн хилийн алба нь улсын хилийг хамгаалахаас гадна эдийн засгийн тусгай бүсүүдийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлдэг. Хилийн алба тэнгисийн хилийн хамгаалалтын албатай харилцан хамтран ажилладаг.

Тэнгисийн хилийн алба нь тэнгисийн хилийн бионөөцийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэн энэ хүрээнд төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна хил дамнасан хууль бус наймаа, хууль бусаар оршин суух явдалтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулж, олон улсын гэмт хэрэг, терроризмтай тэмцэх, далайн дээрмийн асуудлаар гадаадын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахад оролцож байна.

Хилийн албаны өдөр тутмын амьдралд дайн, үймээн гарч байгаа “халуун цэгүүд”-д ажиллах явдал онцгой байр суурь эзэлсээр байна. Террорист халдлагын эсрэг умард Кавказын өргөн хүрээтэй үйл ажиллагаа хил хамгаалах ажиллагааны онцгой анхаарлын төвд байна. Тажикстаны нутаг дэвсгэрт нэвтэрч байрших санаархал бүхий Афганы дайсагнагч бүлэглэлтэй тулгарах явдал бараг өдөр тутам тохиолдож байна.

ЗХУ задарсаны дараа хилийн дэглэмийг тогтоох асуудал хурцардсан юм. Өнөөгийн байдлаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан холбооны улсуудын улс хоорондын хилийн заагийг тогтоох үйл явц дуусгавар болсон ч шинээр үүссэн улсуудын хилийн шугамыг газрын нэрээр тогтоогоогүй бөгөөд зохих хилийн тэмдэглээг хийгээгүй байна.

ОХУ бие даасан тусгаар улсынхаа хувьд түүний хилийн орон зайн эрх зүйн харилцааг зохицуулах үндсэн нормчлогдсон акт бол “ОХУ-ын улсын хилийн тухай” хууль юм. Энэхүү хуулиар хилийн үйл ажиллагааны эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулах бөгөөд ОХУ, түүний субъектуудын төрийн байгууллагуудын бүрэн эрхийг бататгасан байна. Анх удаа улсын хилийг хамгаалах хүрээнд гол зохицуулагч Засгийн газрын байгууллага нь холбооны Хилийн алба байхаар тогтоосон байна.

1993 оны 4 дүгээр сарын 1-ний ОХУ-ын “Улсын хилийн тухай” хуулийн “Улсын хилийн дэглэм” гэсэн 7 дугаар зүйлд:Улсын хилийн дэглэмд дор дурдсан дүрэм, журам багтана.

Үүнд:

- Улсын хилийн агуулга;
- Улсын хилээр иргэн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх:
- Улсын хилээр ачаа, бараа, амьтан шилжиж хөдлөх;
- Улсын хилээр хүн, тээврийн хэрэгсэл, ачаа, бараа, амьтан нэвтрүүлэх;
- Улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт аж ахуй, ажил үйлчилгээ болон бусад ажил эрхлэн явуулах;
- Эдгээр дүрэм журмыг зөрчсөн будлианыг гадаадын улсуудтай хамтран шийдвэрлэх;

Улсын хилийн дэглэмийг хууль бусад холбооны хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрээр тогтооно. Дээр дурдсанаас үзвэл хилийн дэглэм гэж зөвхөн үндэсний, олон нийтийн болон олон улсын харилцааг зохицуулж буй дүрэм журмын нэгдэл төдийгүй, хуулийн /захиргааны, иргэний, сахилгын, эд хөрөнгийн, эрүүгийн/ хариуцлагын түвшин дэх эрх зүйн харилцаа, эрхээ эдлэх, хэрэгжүүлэх журмын нэгдэл юм.

Хилийн дэглэмийн хөгжлийн чиг хандлага

Хилийн дэглэмийг боловсронгуй болгон хөгжүүлэхэд дор дурдсан чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал байна. Үүнд:

1. **Улсын хилийн олон улсын эрх зүйн хэлбэржилтийг боловсронгуй болгох;**
   - Олон улсын эрх зүйн харилцаанд тусгагдаагүй хилийн хэсгийг улс орны эрх ашгийн үүднээс олон улсын эрх зүйн харилцаанд хамруулах;

2. **Улсын хилийн аюулгүй байдлыг хангах;**
   - Хил хамгаалалтын үндэсний эрх зүйн харилцааны зохицуулалт нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцлийг бүрдүүлэх, хилийн байгууллагуудын ажлын уялдаа, шуурхай байдлыг хангахад чиглэгдэх;
   - Эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн дэглэмийг улсын аюулгүй байдлыг хангах бодлогод нийцүүлэн тогтоох;

3. **Хил залгаа орнуудтай хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;**

   Олон улсын хилийн хамтын ажиллагааны хүрээнд тухайн улсын хилийн бодлогын хамгийн чухал зорилтууд тусгалаа олсон байхын тулд:

   - улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлсэн байх;
   - улсын хилийг олон улсын эрх зүйн түвшинд бэхжүүлэн тогтоох;
   - усан хилийн орон зайд улс орныхоо амьдралын хамгийн чухал ашиг сонирхлыг хамгаалсан байх;
   - улсын хилийн орон зай дах олон улсын хамтын ажиллагаанд дайны аюул, хилийн хямрал маргаан гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байх;
   - улс эх орны нэн чухал ашиг сонирхлын үүднээс гадаад орнууд болон улс төр, цэргийн эвслийн зүгээс тусгаарлах бодлого баримтлахад хүргэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх;
   - Улсын хил дээр улс орны аюулгүй байдлын ашиг сонирхлыг хангах;

Терроризмтай тэмцэх чиг хандлага.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн хэмжээнд терроризмтай тэмцэх чиглэлээр дор дурдсан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

олон улсын конвенциууд үйлчилж байна. Үүнд:

- Агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн зарим гэмт хэрэг, түүнтэй төсөөтэй үйлдлийн тухай конвенци /1963/
- Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэгдсэн хууль бус үйлдлүүдтэй тэмцэх тухай конвенци /1971/
- Олон улсын хамгаалалтад байдаг, түүний дотор дипломат эрхтэй этгээдүүдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, ийм гэмт хэрэг үйлдэгсдийг яллан шийтгэх тухай конвенци /1973/
- Хүн барьцаалахтай тэмцэх тухай конвенци /1979/
- Цөмийн материалын нэг бүрчэн хамгаалах тухай конвенци /1980/
- Далай тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенци /1988/
- Тэсрэх бөмбөг бүхий терроризмтай тэмцэх тухай конвенци /1997/
- Пластик тэсрэх бодисыг таньж ялгах зорилгоор марклах тухай конвенци /1999/
- Терроризмыг санхүүжүүлэх явдалтай тэмцэх тухай конвенци /1999/

Терроризмтай тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд программын шинжтэй баримт бичгүүдийг гаргасан байна. Үүнд:

- НҮБ -ын Хүний эрхийн 1993 оны 6 дугаар сарын 25 -ны Венийн бага хурлаар батлагдсан тунхаг бичиг, үйл ажиллагааны хөтөлбөрөөр терроризмын бүхий хэлбэрийн арга зүй, практик үйл ажиллагааг тодорхойлжээ.
- Энэхүү сэдвийг НҮБ -ын Ерөнхий ассамблейн 49 дүгээр чуулганаар үргэлжлүүлэн хэлэлцэж, “Олон улсын терроризмыг улстгах тухай тунхаг”-ийг батлан гаргасан байна.
- Их наймын сайдуудын 1996 оны 6 дугаар сарын 30-ны Парисын зөвлөгөөнөөр терроризмтай тэмцэх талаар хэлэлцэж, эцсийн баримт бичгийг баталгаажуулжээ.
- Энэ асуудлаар улс орнуудын холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг дээрх зөвлөгөөнөөр гаргажээ.

Энэ мэтчилэнгээр олон улсын түвшинд дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг /ТУХН/ -ийн улсууд хамтарч 2000 онд “Терроризмын эсрэг Төв” -ийг байгуулан дүрмийг нь баталж, үндсэн эрх үүрэг, чиг үүрэг, бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсийг нь тогтоосон байна. Энэхүү төв нь байнгын үйл ажиллагаатай тусгай байгууллага бөгөөд олон улсын терроризм, бусад хэт даврагсадтай тэмцэхэд ТУХН-ийн орнуудын холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй ажилладаг. Терроризмтай тэмцэх чиглэлээр улс орнууд үндэсний хууль тогтоох үйл ажиллагаандаа дор дурдсан нийтлэг зүй тогтолыг баримталж байна.

1. Терроризмтай тэмцэх талаарх хууль, тогтоомжийг үр дүнтэй хэрэглэх зорилгоор тэдгээрийг кодлох
2. Улс орны дотоодын эрх зүйн хэм хэмжээ нь олон улсын гэрээнүүдийн өөрчлөлтийг соргогоор мэдэрч эерэг зохицуулалтуудыг цаг алдалгүй авч хэрэглэх
3. Дэлхийн хөгжингүй орнуудын эрх зүйн харилцаагаа ардчилах ерөнхий чиг хандлага гэж хойш тавилгүйгээр улс орнууд үйлдэгдсэн террорист гэмт хэрэг, түүнд оролцсон этгээдүүдэд ногдуулах хариуцлага, шийтгэлийг чангатгах
4. Терроризмын эсрэг эрх зүйн онцгой зохицуулалтаар тусгайлан хамгаалагдсан этгээдтэй холбогдон үйлдэгдсэн хүчирхийллийн шинжтэй үйлдлийг мөрдөн шалгах
5. Улс орныхоо улс төр, олон нийт, эрүүгийн нөхцөл байдалтай уялдсан Терроризмын эсрэг хуульд нийцсэн бусад эрх зүйн актуудыг боловсруулж, батлуулах

Хилийн дэглэмийн хөгжлийн цаашдын чиг хандлага.

Хилийн дэглэм, түүний дотор хилийн шалган нэвтрүүлэх цэгүүдийн үйл ажиллагааг үр өгөөжтэй ажиллуулахын тулд хил залгаа орнуудын холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал чухал гэж үзэх болсон байна. Хөрш зэргэлдээ улсуудын хилээр зэвсэг, байлдааны хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис, хууль бусаар оршин суугчдыг нэвтрүүлэхгүй байх асуудлаар хил дээр хамтарсан тусгай ажиллагаа явуулах нь хил залгаа улс орнуудын хилийн хамтын ажиллагааны хамгийн эерэг хэлбэр гэж судлаачид үзэж байна.

Улсын хилийн дэглэмийн чухал хэсэг болох хилийн шалган нэвтрүүлэх пунктүүдийн паспортын болоод гаалийн хяналт шалгалтын талбайд зэвсэг, байлдааны хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис, хууль бусаар оршин суугчдыг нэвтрүүлэхгүй байхын тулд орчин үеийн тоноглол ашиглах, тэдгээрийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангахад чиглэгдсэн мэргэжлийн боловсон хүчний хангамжийг сайжруулахад улс орнууд ихээхэн анхаарал тавих болсон байна.

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН БООМТ, ТҮҮНИЙ ДЭГЛЭМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ[68]

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын хилийн нийт урт - 8252,658 км бөгөөд хилийн нийт уртын 4709,658 км буюу 57,0 хувийг өмнөд хил, 3543,0 км буюу 43,0 хувийг хойд хил эзэлдэг.[69] Хилийн боомт болон Монгол Улс, ОХУ-ын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээр, Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтын дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн дагуу Монгол, ОХУ-ын хилийн **29** боомт, Монгол-БНХАУ-ын **13** боомт байхаар тогтоосон.

Монгол Улсын хилд агаарын, авто, төмөр замын нийт 46 хилийн шалган нэвтрүүлэх боомт ажиллаж байна. Эдгээр боомтуудаар жилд дунджаар 3 сая гаруй зорчигч, 1,5 сая тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлдэг. Боомтуудыг зориулалт, үйл ажиллагаагаар нь дөрөв ангилдаг. Үүнд:

- Олон Улсын боомт - 14
- Хоёр талын байнгын ажиллагаатай боомт - 10
- Хоёр талын түр ажиллагаатай боомт - 15
- Дамжин өнгөрөх боомт – **7**

Монгол Улс, БНХАУ-ын хилийн 13 боомтуудын талаар ГХЯ -ны Хөрш орнуудын газраас ирүүлсэн мэдээллээс харахад Сүмбэр боомтын цогцолбор болон дэд бүтцийн ажил бүрэн дуусаагүй тул боомт ажиллаагүй, **12** боомт хуваарийн дагуу ажиллаж байгаа боловч хилийн худалдааны дийлэнх хэсгийг нэвтрүүлж байгаа тус боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэг зорчигч, нэгж ачаа тээшийг хянан шалгах ажлын хугацааг богиносгох, үүний тулд орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглох, хяналт шалгалтыг сайжруулах нийтлэг бэрхшээл байгааг дурьджээ.

Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газар хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хангах ГХЯ-ын газрын дарга нарын ээлжит

[68] Гадаад Хэргийн Яамны Хөрш Орнуудын Газрын 2012 оны 10 дугаар сарын 10-ний албан тоотоор ирүүлсэн Монгол Улсын Хилийн боомтуудын талаарх мэдээлэл

[69] http://bpo.gov.mn/contact Хил Хамгаалах Ерөнхий газрын вэб сайт

4 дүгээр уулзалтын протоколоор тохирсон гол гол асуудлуудыг хэрэгжүүлэх чиглэлээр БНХАУ-ын талтай хэлэлцээр хийж байна. Үүнд:

- Гашуунсухайт, Шивээхүрэн боомтыг 2012 оны 08 сарын 01-ний өдрөөс эхлэн олон улсын статустай болгох, 24 цагийн ажиллагаатай болгох, шинээр баригдсан замуудыг богино хугацаанд бүрэн хэмжээгээр ажиллуулж эхлэх,
- Бургастай, Ханги, Баянхошуу, Хавирга боомтуудыг байнгын ажиллагаатай болгох, дэд бүтцийг сайжруулах талаарх тохиролцоог дипломат шугамаар тохирох
- Сүмбэр боомтыг энэ онд багтааж нээх, Бичигт боомтод бараа нэвтрүүлэх тусгай гарц барих талаар хийсэн тохиролцоог хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтарч ажиллах

Монгол Улс, ОХУ-ын хилийн **29** боомтоос **12** боомт нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа, **17** боомтод дэд бүтэц бараг байхгүй, сүүлийн жилүүдэд зорчих хөдөлгөөн багассанаас идэвхтэй ажиллаагүй байна. Эдгээр боомтуудыг 1990 оноос өмнө ЗХУ / хуучин нэрээр/ мал хөлөөр нь нийлүүлэх, оросын талын хил орчмын хамтрал, сангийн аж ахуйгаас манай талд ирж хадлан хадах, орон нутгийн замын байдлаас шалтгаалан аль нэг талынхаа хилийн тодорхой цэгээр дамжин өнгөрөх замаар улсын хилээр гарч, орох зэрэг зорилгоор ажиллуулж байсан.

ОХУ-ын хилийн боомтын тохижилтын асуудал эрхэлсэн **“Росграница”** байгууллагын төлөөлөгчидтэй 2009 оны 12 сард Улаанбаатар хотод уулзалт хийж сүүлийн 10 гаруй жил зорчих хөдөлгөөн хийгдээгүй 14 боомтуудыг хаах үндэслэлийн талаар ОХУ-ын байр суурийг сонсож, санал солилцсон байна. Тус 14 боомтыг хаах эсэх асуудлыг нэгэнт хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр баталгаажуулсан, цаашид боомтыг ашиглах бодит шаардлага гарч болох юм гэсэн үүднээс дээр дурьдсан боомтуудыг хаах асуудлыг түр хүлээх шийдвэрийг Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хурлаас гаргасан байна. Түүнчлэн, Монгол - Оросын хилийн хамтарсан шалгалтыг хамгийн сүүлд хийснээс хойш 17 жил болж байгааг харгалзан улсын хилийн хамтарсан шалгалт хийх хугацааны асуудлаар оросын талтай хэлэлцээ эхлүүлэх, хамтарсан шалгалт хийх асуудлыг тохиролцох зэрэг тулгамдсан асуудлуудыг дурьджээ.

Монгол Улсын хилийн боомт дээр хилийн хяналтын үйл ажилагаа явуулж байгаа Хил хамгаалах байгууллага, Гааль, Мэргэжлийн хяналт, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу явуулж байна.

Хил хамгаалах ерөнхий газар нь Монгол Улсын Хилийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгийг удирдлага болгон 1962 оны Монгол-Хятадын хилийн гэрээ, 2011 оны Монгол-Хятадын хилийн дэглэмийн гэрээ, 1958, 1976 Монгол-Оросын хилийн гэрээ, 2006 оны Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, хилийн асуудлаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм”, “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг.

Хил хамгаалах ерөнхий газар нь Монгол улсын хилийн хамгаалалтыг хилийн болон шалган нэвтрүүлэх отряд, түүний харьяа застав, хангалт үйлчилгээний ангиудын хүч хэрэгслээр төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд, хууль хүчний байгууллагуудтай хамтран ажиллаж, хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугаа ард иргэдийн туслалцаанд түшиглэн зохион байгуулдаг.

Гаалийн Ерөнхий Газар Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нь гаалийн байгууллагын үндсэн ажлын хүрээнд хамаарна. Гаалийн хяналтын зорилго нь гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагаа улс орны Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гаалийн байгууллагын үндсэн үүргийг хангахад чиглэгдэнэ.

2011 онд улсын хилээр нэвтрүүлсэн 7.0 сая зорчигч, 2.7 сая тээврийн хэрэгсэл, 77.8 сая тонн экспорт, импортын, 8.7 сая тонн дамжин өнгөрөх ачаанд бүрдүүлэлт хийж, хяналт шалгалтыг зохион байгуулжээ. Улсын хилээр нэвтэрсэн 23503 зүтгүүр, 24711 суудлын вагон, 732108 ачааны вагон, 10587 онгоц, 813102 суудлын автомашин, 1142327 ачааны автомашинд гаалийн хяналт шалгалт хийжээ. 2011 онд гаалийн хилээр гадаадын 1006825, дотоодын 2490312 зорчигч орж, гадаадын 991307, дотоодын 2527160 зорчигч гарсан байна.

Гадаадын иргэн, харьяатын алба нь гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөх, холбогдсон харилцааг харилцааг зохицуулж байна.

Гадаад харилцааны яамны хил, хилийн боомтын асуудал хариуцсан хэлтэс нь хил орчмын нутаг дэвсгэрт болон хилийн боомтод үндэсний аюулгүй байдлыг хангах, боомтын үйл ажиллагааг сайжруулах, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, боомтоор дамжих бараа эргэлтийг түргэтгэх, хяналт шалгалтыг боловсронгуй болгох, худалдаа арилжаанд аль болох таатай нөхцөл бүрдүүлэх хөрш орнуудтай хилийн харилцааны асуудлаар байгуулсан гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, шинээр үүссэн нөхцөл байдалтай уялдуулан олон улсын гэрээг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хилийн хяналт шалгалтын байгууллагуудтай гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажилладаг байна.

Үүнээс гадна хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын уялдаа холбоог Засгийн газрын 2002 оны 108 дугаар тогтоолоор хилийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын хилийн боомтод зөвхөн хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх алба, хилийн эрүүл ахуй, халдвар судлалын чиглэлийн алба, гаалийн байгууллагыг ажиллуулахаар тогтоожээ.

Монгол Улсын хилийн боомтод хилийн мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа эрхлэж байгаа Эрүүл мэндийн улсын хяналтын алба, Мал эмнэлэг, ариун цэврийн улсын хяналтын алба, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн албад болон тэдгээрийн лабораториудыг нэгтгэн “нэг цэгийн үйлчилгээ”-ний зарчимд шилжүүлэн улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд ногдуулж байгаа татвар, хураамжийг гаалийн байгууллагаар дамжуулан хураахаар зохицуулсан.

1.1. Монгол Улс, БНХАУ -ын хилийн боомтууд

Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтуудын эрх зүйн байдлыг Монгол Улсын Засгийн газар, БНХАУ -ын Засгийн газар хоорондын 2004 оны 07 сарын 05 -ний өдрийн хэлэлцээрээр тодорхойлогддог бөгөөд энэхүү хэлэлцээрийн дагуу **13** боомт ажиллуулахаар тохиролцсон. /Хавсралт №1/

Үүнээс: Олон улсын зорчигч, ачаа тээврийн байнгын ажиллагаатай - 5

Замын - Үүд /авто замын/,

- Замын- Үүд /төмөр -замын/ Тус боомтоор нийт ачаа эргэлтийн 1498128,9 тонн буюу 63,2% нь экспортын ачаа, 872734,4 тонн буюу 36,8% нь импортын ачаа нэвтэрсэн бөгөөд тус боомтоор экспортолсон нийт бүтээгдэхүүний 72,9% нь

UIH.MN

төмрийн баяжмал, 12% молибден, 2% түүхий нефть, 2% нүүрс, 2% хайлуур жонш тус тус эзэлж байна. Тус боомт нь манай улсын хувьд хилийн худалдааны дийлэнх хэсгийг нэвтрүүлж байгаа гол боомт бөгөөд "Говийн бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх" ЗГ-ын 2012 оны 144 дүгээр тогтоолоор хилийн боомтын ачааны автомашин шалган нэвтрүүлэх цогцолбор, зам тайлбайн өргөтгөлийн ажил хийхээр төлөвлөгдсөн.

- Булган боомт: Тус боомт нь 2011 оны 01 дүгээр сараас олон улсын байнгын ажиллагаатай болсон. Тус боомтоор Хөшөөтийн уурхайн нүүрс экспортолдог.
- Бичигт боомт: Тус боомт нь 1992 онд нээгдэж, улирлын шинжтэй ажиллаж байгаад 2004 оны 09 сарын 28-ний өдрөөс эхлэн хэлэлцээрт өөрчлөлт оруулан байнгын ажиллагаатай боомтын ангиллаар ажилуулахаар тохирсон боловч одоогийн байдлаар олон улсын зэрэглэлээр ажиллах асуудлыг хоёр тал эцэслэн шийдээгүй байна.
- Сүмбэр боомт: Тус боомт нь усан хилтэй. Боомтын цогцолборын ажил бүрэн дуусаагүй тул ажилаагүй байна.

Хоёр талын зорчигч ачаа тээврийн байнгын ажиллагаатай 2

- Гашуунсухайт боомт: 1992 оны 07 дугаар сарын 01-нд байгуулагдсан. Хэлэлцээрт байнга ажиллахаар заасан боловч хоёр талын нөхцөл бүрдээгүйгээс 1,3,6,9,12 дугаар сарын 01-20-нд ажилладаг түр ажиллагаатай байгаад 2009 оны 09 сараас байнгын ажиллагаатай болсон. Уг боомтыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн Газрын 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан.
- Шивээхүрэн боомт: 1992 оны 11 дүгээр сарын 01-нд байгуулагдсан. Хэлэлцээрт байнга ажиллахаар заасан боловч хоёр талын нөхцөл бүрдээгүйгээс 1,3,6,9,12 дугаар сарын 01-20-нд ажилладаг түр ажиллагаатай байгаад 2009 оны 1 дүгээр сараас байнгын ажиллагаатай болсон. Уг боомтыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн Газрын 2012 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 104 дүгээр тогтоолоор баталсан.

Хоёр талын зорчигч ачаа тээврийн түр ажиллагаатай 6 боомт байна.

- Даян, Байтаг, Бургастай боомтууд нь /Хавсралт №1/ хуваарийн дагуу ажиллаж байгаа.
- Ханги боомт: Энэхүү боомт нь хэлэлцээрийн дагуу 3,5,8,11 дүгээр сарын 16-31-ний хооронд нээн ажиллуулахаар хуваарьтай боловч 2010 оноос хуваарийн бус үеэр нээн ажиллуулж байгаа. Тус боомтыг БНХАУ-ын хөрөнгөөр тохижуулах ажил хийсэн бөгөөд төмрийн хүдэр, нүүрс экспортолж байна.
- Баян-Хошуу боомт: Энэхүү боомт нь хэлэлцээрийн дагуу 2,5,8,11 дүгээр сарын 01-20-ний хооронд нээн ажиллуулахаар хуваарьтай боловч "Петро Чайна Дачин-Тамсаг" ХХК-ний үйл ажиллагаа өргөжиж байгаатай холбогдуулан хуваарийн бус үеэр нээн ажиллуулж байгаа. Тус боомтыг БНХАУ-ын хөрөнгөөр тохижуулах ажил хийсэн.
- Хавирга боомт: Хэлэлцээр ёсоор жил бүрийн 1 дүгээр сарын 6-25, 4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд нээн ажиллуулдаг бөгөөд хуваарийн дагуу ажиллаж байна.

1.2. Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтууд

Хилийн боомт болон Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээрээр дараах боомтуудыг ажиллуулахаар тохиролцсон. /Хавсралт №2/

Олон улсын зорчигч, ачаа тээврийн байнгын ажиллагаатай 6

- Сүхбаатар, Алтанбулаг, Цагааннуур, Эрээнцав, Боршоо, Ханх боомтууд: Тус боомтууд хуваарийн дагуу хэвийн ажиллаж байгаа бөгөөд 2011 оны байдлаар 290468 хүн зорчсон байна.

Хоёр талын зорчигч ачаа тээврийн байнгын ажиллагаатай 7

- Эрээнцав, Арц суурь, Тэс, Бага-Илэнх, Зэлтэр, Агацын гол, Ульхан боомтуудаар 2011 онд 25466 хүн зорчсон байна. Үүнээс Зэлтэр, Агацын гол, Бага-Илэнх боомтууд албан хаагчдын ажиллах нөхцөл, дэд бүтэц бүрдээгүй гэх үндэслэлээр одоогоор ажиллаагүй байна. Бага-Илэнх боомтоор орон нутгийн хүсэлтээр шаардлагатай үед түр хугацаагаар нээн ажиллуулж ирсэн.

Улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх түр буюу улирлын ажиллагаатай боомтууд 9

- Хилийн боомт болон Монгол, ОХУ-ын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай 1994 оны хэлэлцээрийн дагуу улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх түр буюу улирлын ажиллагаатай Баянзүрх, Хээгт, Шишгэд гол, Бэлдир, Хонгор-Овоо, Цагаан-арал, Хутаг-Өндөр, Хүдэр, Тогтор, Ямалхын гол гэсэн автозамын 9 боомт ажилуулахаар талууд тохиролцсон. Гэвч хоёр талдаа дэд бүтэц бүрдээгүй, эдийн засаг, аж ахуйн ач холбогдол багатай, нээж ажилуулах тогтоол гараагүйн улмаас ихэнх нь хэлэлцээр байгуулагдсанаас хойш ажилаагүй байна.

Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай хоёр талын авто замын боомтууд 7

- Асгатын гол, Бөхмөрөн, Харигийн гол, Тээл-Хандгайт, Тээл-Торгал, Давст, Тэс авто замын 7 боомт ажиллуулахаар талууд тохиролцсон боловч Асгатын гол, Давст, Тэс боомтууд одоогийн байдлаар ажиллаагүй, Бөхмөрөн, Харигийн гол, Тээл-Хандгайт, Тээл-Торгал боомтуудаар 2011 онд 96 хүн зорчсон байна.

Хоёр. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД

2.1. Европ тивийн улс орнуудын хувьд хамтын ажиллагааны хэлбэрүүд

8 хэлбэр байна. Үүнд:

Европын зөвлөлийн бүрэлдэхүүнд нийт 46 улс хамрагддаг байна.

- Европын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс /нийгэмлэг/-ийн бүрэлдэхүүнд Хорват, Босни-Герцоговина, Чрна-Гора, Македон, Серби, Албани, Швейцари, Турк, Ватикан, Сан-Марино, Монако, Андорра болон ЗСБНХУ -ын бүрэлдэхүүнд байсан ОХУ, Украйн, Белорус, Молдов, Гүрж, Армян, Азербайжан зэрэг улсуудаас бусад Европын зөвлөлийн бүрэлдэхүүнд ордог улсууд ордог байна.
- Европын гаалийн холбооны бүрэлдэхүүнд Дани, Исланд, Лихтенштейн, Швейцари, Хорват, Ватикан, Босни-Герцоговина, Чрна-Гора, Македон, Серби, Албани, Андорра болон ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд байсан ОХУ, Украйн, Белорус, Молдов, Гүрж, Армян, Азербайжан зэрэг улсуудаас бусад Европын зөвлөлийн бүрэлдэхүүнд ордог улсууд ордог байна.
- Европын холбооны бүрэлдэхүүнд Хорват, Босни-Герцоговина, Чрна-Гора, Македон, Серби, Албани, Швейцари, Дани, Исланд, Лихтенштейн, Турк, Ватикан, Сан-Марино, Монако, Андорра болон ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд байсан ОХУ, Украйн, Белорус, Молдов, Гүрж, Армян, Азербайжан зэрэг улсуудаас бусад Европын зөвлөлийн бүрэлдэхүүнд ордог улсууд ордог байна.
- Еврогийн бүсийн бүрэлдэхүүнд Австри, Испани, Нидерланд, Бельги, Португали, Итали, Герман, Люксенбург, Словак, Грек, Мальт, Словени, Франц, Финланд, Эстони, Кипр, Ирланд зэрэг 17 улс багтдаг.

- Шенгений бүсийн бүрэлдэхүүнд Кипр, Болгар, Ирланд, Их Британи, Румынээс бусад Европын эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хамрагддаг улсууд болон Швейцари ордог.
- Чөлөөт худалдааны Европын нийгэмлэгийн бүрэлдэхүүнд Исланд, Лихтенштейн, Швейцари, Норвеги ордог.
- Еврог гэрээний дагуу гүйлгээнд хэрэглэдэг орнуудад Ватикан, Сан- Марино, Монако хамрагддаг.

Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгийг үүсгэн байгуулах үеэс бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хүмүүсийг чөлөөтэй дамжуулан өнгөрүүлэх үндсэн зорилготой нэгдмэл зах зээл гэж мэдэгдэж байв. Бараа, үйлчилгээг чөлөөтэй дамжуулан өнгөрүүлэхийн тулд 1958 онд Гаалийн холбоог байгуулж хэд хэдэн хэлэлцээр байгуулсан байна. Гэвч хүмүүс чөлөөтэй нэвтрэлцэх явдал тодорхой хязгаартай хэвээр үлдэж, хэдийгээр Европын холбооны орнуудын хувьд виз шаардлагагүй байсан ч паспортын хяналт хадгалагдаж, паспорт авах, хилээр нэвтрэхэд цаг алдсаар байв.

Хилийн хяналтаас аажмаар татгалзах тухай хэлэлцээрийг Бельги, Люксенбург, Нидерланд, Франц, ХБНГУ -ын хооронд 1985 оны YI сарын 14 -нд Люксенбург, Франц, ХБНГУ -ын хилийн заагт орших Шенген тосгоны ойролцоох эрэгт “Принцесса Мари - Астрид” хөлөг онгоцон дээр байгуулжээ.

1992 оны XII сарын 31 -ний дотор Европын нэгдсэн зах зээлийг байгуулах зорилгоор 1986 онд Европын нэгдсэн актыг батлан гаргажээ. Үүгээр Европын холбоог үүсгэн байгуулах гэрээг боловсруулж эхэлсэн байна. Энэхүү гэрээгээр Европын холбооны иргэншлийн тухай ойлголтыг баталгаажуулж, Европын холбооны иргэд Европын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийг олгожээ.

Европын улс орнуудын хүн амын хөдөлгөөн өсөхийн хэрээр Европын холбооны дотоодын хилийн дэглэмээс аажмаар бүрэн таталзах асуудал тавигдсан. 1990 онд Шенгений хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай конвецид дээр дурдсан 5 улс гарын үсэг зурсан байна. Энэхүү конвенци нь паспортын байнгын хяналт, энгийн паспорт эзэмшигчдийн визийн нэгдсэн журмыг халах, цагдаа, шүүхийн хамтын ажиллагааг тогтоох асуудлыг тусгасан байна. Хэлэлцээр 1995 оноос дээр дурдсан 5 улсаас гадна Испани, Португали зэрэг 7 улсын хэмжээнд хэрэгжиж эхэлжээ.

1999 оны 5 -р сарын 1 -нээс Европын холбооны гэрээнд өөрчлөлт оруулсан Амстрдамын гэрээ хүчин төгөлдөр болсон байна. Шинэчлэгдсэн гэрээний Y хэсэг, Шенгений хэлэлцээрийг дагаж мөрдөж эхлэх тухай конвенцийн заалтын дагуу Европын холбооны хууль тогтоомжийг оруулж өгсөн байна. Европын хууль тогтоомжийн холбогдох хэсэг нь Шенгений хэлэлцээрийг орлох бөгөөд тэдгээрийг Шенгений хууль тогтоомж гэж нэрлэх болжээ.

Европын холбоонд шинээр элсэгч улсууд Шенгений хэлэлцээрт гарын үсэг зурахгүй харин Европын холбоонд элсэн орохын тулд Европын холбооны хууль тогтоомжийн нэг хэсэг болох Шенгений дүрэм журмыг биелүүлэх үүрэг хүлээж, тэдгээрийг бүхэлд нь хүлээн авах ёстой. Шенгений хууль тогтоомжид өөрчлөлт оруулахдаа уг хэлэлцээрт заасан нөхцлийн дагуу бус, Европийн холбооны хууль тогтоох дэг журмыг баримтална.

Европын хамтын ажиллагааны гэрээ болон байгууллагууд дахь улс орнуудын хамаарал



2.2.Европын холбоонд нэгдэхгүй байх, тодорхой хязгаартай нэгдэх

Их Британи, Ирланд Европын холбоонд нэгдэхдээ Европын холбооны гадаад бодлого, аюулгүй байдлын асуудалтай холбоотой ерөнхий бодлогод оролцохгүй байхаар зориуд тэмдэглэсэн учраас Шенгений хууль тогтоомжийн нэлээд хэсгийг хэрэгжүүлдэггүйн дотор өөрсдийн гадаад хил дээр паспортын хяналтыг хадгалж, бие даасан визийн бодлого хэрэгжүүлдэг байна.
\
Их Британи Шенгений хууль тогтоомжид нэгдэхгүй байгаагаа арлын орнуудын паспортын хяналт нь эх газрын хил бүхий орнуудад илүү тохиромжтой цагдаагийн бүртгэл, хувь хүний баримт бичгээс албан бус цагаачлалтай тэмцэх илүү үр дүнтэй, хүндрүүлсэн арга хэрэгсэл болж чадна гэж тайлбарладаг. Ирланд улс энэ бодлогыг хуваалцдаггүй ч өөрийн хувьд илүү чухал гэж үзэж, Их Британитай чөлөөт хилийн дэглэмтэй хэвээр үлдэх үүднээс эдгээр хууль тогтоомжид нэгдэхгүй байх нь дээр гэж үздэг. Ирланд улс Шенгений хууль тогтоомжид нэгдэхгүй байгаа нь Их Британиас хамаарч байгаа болохоор хэзээ нэгэнтээ Их британи Шенгений хууль тогтоомжид нэгдэх аваас Ирланд улс ч нэгдэх шаардлагатай болно.

Их Британи Европын зөвлөлд элсэх хүсэлт 1999 онд гаргахдаа, Шенгений хууль тогтоомжийн цагдаа, шүүхийн хамтын ажиллагаатай холбоо бүхий заалтад хэлбэрийн төдий оролцох боломжийг тооцсон байна. 2000 онд энэхүү хүсэлтийг авч хэлэлцэж зөвшөөрсөн бол 2005 оны 1 дүгээр сарын 1 -нээс хүчин төгөлдөр мөрдөж эхэлжээ. Энэ хамтын ажиллагаа Гибралтарын хувьд хүчинтэй ч далай чанадын бусад титмийн доорх /Хамтын нийгэмлэгт багтах/ нутаг дэвсгэр, цэргийн бие даасан баазуудын хувьд үйлчилдэггүй байна.

Ирланд ийм хүсэлтээ 2002 онд гаргаж тэр дор нь шийдвэрлэсэн ч одоо хүртэл хүчин төгөлдөр мөрдөөгүй байна.

Европын холбоонд хэсэгчлэн нэгдэх

Аливаа улс Европын холбоонд элсэхдээ үндэсний хууль тогтоомжоо Шенгений хууль тогтоомжид нийцүүлэх үүрэг хүлээдэг. Гэхдээ Шенгений хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэхэд юуны түрүүнд холбооны гадаад хилийг бэхжүүлэх чиглэлээр олон төрлийн практик арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Үүнээс улбаалан Европын холбооны зарим гишүүн улс Шенгений хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Үүнд:

ОТГ.MN
СУДАЛГААНЫ САН

- Болгар
- Кипр
- Румын

Эдгээр улсуудын хил дээр урьдын адил гааль, паспортын шалгалт хийгдэж байгаа ба харин тэдний олгодог богино хугацааны /С ангиллын/ виз нь шенгений визэд хамаарахгүй, зөвхөн эдгээр улсуудад зорчих эрхийг олгодог.

Европын холбоонд бүрэн нэгдэх

Европын холбооны ихэнх гишүүн-орнууд Шенгений хууль тогтоомжид бүрэн нэгдсэн байна. Үүнд:

• Австри	• Дани	• Люксембург	• Словак	• Швед
• Бельги	• Испани	• Мальта	• Словени	• Эстони
• Унгар	• Итали	• Нидерланд	• Финланд	
• Герман	• Латви	• Польш	• Франц	
• Грек	• Литви	• Португали	• Чех	

Дани Улс 1997 оны Амстрдамын гэрээнд хавсаргасан Шенгений протоколоор Амстрдамын гэрээнд гарын үсэг зурах үед олгогдсон эрх хэмжээнээс илүү шенгений хамтын ажиллагаанд оролцохгүй байх онцгой эрх хэмжээг эдэлдэг. Түүнээс гадна Европын холбооны өргөтгөсөн гадаад хамтын ажиллагааны механизмаар дамжин Шенгений хууль тогтоомжид нэгдсэн, Европын холбооны гишүүн бус Европын эдийн засгийн бүс /Европын чөлөөт худалдааны ассоциаци/ -ийн гишүүн дор дурдсан орнууд Шенгений хууль тогтоомжийг бүхэлд ашиглах эрхтэй байдаг.

- Исланд
- Лихтенштейн
- Норвеги
- Швейцари

Эдгээр улсуудын хоорондын хил дээр байнгын паспортын хяналт тавьдаггүй /энэ нь тодорхой үеийг сонгож хяналт явуулахыг хориглохгүй/. Эдгээр улсуудаас олгосон богино хугацаатай /С ангиллын/ виз нь шенгенийхэд тооцогдож, Шенгений бүсэд чөлөөтэй зорчих эрхийг олгодог. Лихтенштейн, Швейцари Гаалийн хамтарсан холбоонд хэвээр үлдсэн ч Европын холбооны гаалийн холбоонд хамрагддаггүй учраас тэдгээрийн хил дээр Европын холбооны бусад орнуудын хувьд гаалийн хяналт явуулдаг байна. Энэ нь Шенгений дүрэм, дэг журам Европын холбооны хууль тогтоох үйл явцын хүрээнд боловсруулагдаж, өөрчлөлт орж байдагтай холбоотой байдаг тул эдгээр улсуудын зүгээс уг үйл явцад оролцох боломж туйлын хязгаарлагдмал, үнэндээ Европын холбооноос боловруулсан нөхцлүүдийг эсвэл хүлээн зөвшөөрөх, эсвэл хамтын ажиллагаагаа зогсоход хүрдэг.

Жижиг улсуудын эрх хэмжээ

Ватикан, Монако, Сан - Марино

Европын холбооны гишүүн бус жижиг улсууд Шенгений хууль тогтоомжид нэгдэхгүй бол бүрэн нэгдсэн оролцогч улсуудын талаас хилийн хамгаалалтгүй хамгаалалтгүй үлддэг байна: Ватикан и Сан-Марино Улсууд нь Италийн нутаг дэвсгэрийг алгасаж нэвтрэх агаарын болоод усан боомтгүй

- Монако усан боомттой ч хилийн хяналтын үйлчилгээг Францын зүгээс гүйцэтгэдэг учраас түүгээр нэвтэрсэн бол Францад нэвтэрснээр тооцогддог.

Франц, Монакогийн хооронд гадаад харилцаанд Монакогийн сонирхлыг франц хамгаалсан хэлбэрийн төдийн гэрээтэй учраас Монакогийн Де-юре эрх хэмжээ нь Ватикан, Сан-Мариногийнхаас ялгаатай юм. Гэхдээ улс төрийн талаас нь авч үзвэл эдгээр гурван улс бараг адилхан эрх хэмжээтэй, тэд гаднаас ирэгчдийн хувьд визийн тусгайлсан бодлого баримталдаггүй учраас тэдний иргэд, байнгын оршин суугчид нь Европын холбоо, Европын эдийн засгийн бүсийн нутаг дэвсгэрт чөлөөтэй орших эрхтэй. Итали, Францын талаас эдгээр улсуудад нэвтрэх нь Итали, Францаас гарсанд тооцогддоггүй. Ийм болохоор тэдгээрийн нутаг дэвсгэрт нэвтрэх нь де-факто Шенгений бүсэд нэвтэрч байгаатай агаар нэгэн юм.

Ватикан тухайлбал, Шенгений мэдээллийн системд нэвтрэх асуудлаар Европын холбооны Шенгений үйл ажиллагаанд шууд оролцох хүсэлтээ илэрхийлдэг. Сан-Маринод зорчигчдын хүсэлтээр Улсын аялал жуулчлалын албанаас 5 еврогоор паспортад нь тогтсон загвар бүхий, улсын нэр, төрийн сүлд, олгож байгаа байгууллагын нэр,Vsito turisto буюу San Marino General Trips /англиар/ гэсэн бичвэр бүхий жуулчлалын виз дарж өгдөг байна.

Андорра Улсад Франц, Испаниар дамжихгүйгээр түүний нутаг дэвсгэрт нэвтрэх усан болоод агаарын боомт байдаггүй. Гэхдээ бүх хилийн дагуу хяналтгүй байдаг ч түүний нутаг дэвсгэр Шенгений нутаг дэвсгэрт хамаардаггүй. Андоррагийн нутаг дэвсгэрт нэвтрэх нь Франц, Испаний нутаг дэвсгэрээс болон Шенгений нутаг дэвсгэрээс гарсанд тооцогддог. Өөрийн газар зүйн байршлаас хамааран аль ч улсын иргэдээс виз шаарддаггүй. Мөн Европын холбооны иргэдийг паспортаар болон үндэсний иргэний үнэмлэхээр хил нэвтрүүлдэг байна.

2.3 Европын холбоонд үл хамаарах

Шенгений хууль тогтоомжид нэгдсэн улсуудын зарим нутаг дэвсгэрт тэдгээр хууль тогтоомж бүхэлдээ болон зарим зүйл заалтыг хэрэглэдэггүй . Ихэнх тохиолдолд Европын холбооны улсуудын харьяа алслагдсан нутаг дэвсгэр Шенгений хууль тогтоомжид үл хамаардаг. Эдгээр нутаг дэвсгэрийнхэн газарзүйн байршлаас хамаарч Европод нэвтрэхэд паспортын болон гаалийн хяналтгүй, шууд нэвтрэхэд хүндрэлтэй байдаг байна. Түүнчлэн тэдэнд өөрийн хил залгаа хөршүүдтэй харилцах шаардлагатай байдаг нь эдгээр нутаг дэвсгэр Шенгений бүсийн нэг хэсэг болоход хүндрэл учруулдаг байна.

Нэлээд тохиолдолд Шенгенд үл хамаарах шалтгаан нь Европын холбооны нутаг дэвсгэрт нэвтрэхэд виз шаарддаг үндэстний төлөөлөл байдагтай холбоотой байдаг. Швейцарыг Европын Шенгений бүсэд нэгдэх хүртэл түүний нутаг дэвсгэрт орших Германы дээд Рейний Бюзинген, Италийн Кампионе -д Итали Шенгений бүсэд үл хамаарч байжээ. Эдгээр нутаг дэвсгэрүүд одоо Швейцаритай гаалийн холбоонд нэгдсэн хэвээр байдаг.

Дани

Гренланд, Фарерийн арлууд Европын холбоо, Шенгений бүсэд аль алинд нь ч хамаардаггүй. Гэхдээ Фарерийн арууд Умардын паспортын холбоонд ордог. Энэ холбооны гишүүн орны иргэд Фарерийн арлуудад нэвтрэхдээ өөрийг нь илэрхийлэх аль нэг баримт бичиг/жолооны үнэмлэх/-ийг хөлөг онгоц болон агаарын хөлөгт ороходоо үзүүлдэг байна.Э нэхүү эрхийг гуравдагч улсууд түүний дотор паспорт, биеийн байцаалтаа шалгуулах журам бүхий Европын холбооны гишүүн орнуудын иргэд эдэлдэггүй. Шенгений болон бүр Даниас олгосон богино хугацаатай виз Гренланд, Фарерийн арлуудад хүчингүй байдаг.

Испани

Африкийн хойд хэсэгт хуурай газраар Марокко улсаар хүрээлэгдсэн Испаний Сеута,

Мелилья хотуудад Шенгений хэлэлцээрт нэгдэхээс өмнө ч Тетуан, Надор бүсэд амьдардаг Мароккийн харьяатуудыг визгүйгээр нэвтрүүлдэг байжээ. Түүнчлэн бусад мужийн Мароккийн харьяатуудыг ч зөвхөн Мелилья, Сеутад хүчинтэй хялбаршуулсан тусгай виз олгодог.

Шенгений виз нь Сеута, Мелилья хотод Испаний Европын хэсгээс болон Шенгений бүсийн бусад орнуудаас нэвтрэхэд хүчинтэй бөгөөд паспортын хяналтгүй байдаг. Харин эдгээр хотуудаас буцаад гарахад байнгын паспортын хяналттай байдаг.

Нидерланд

Нидерландын Вант Улсад харьяалагддаг Европ хилийн гадна орших нутаг дэвсгэрүүд нь нутаг дэвсгэрийн алслагдмал байдлаас хамаарч Европын холбоо, Шенгений бүсийн аль алиных нь бүрэлдэхүүнд хамаардаггүй. Эдгээр нутаг дэвсгэрийн хувьд визийн тусгайлсан журам мөрддөг. Гэхдээ Шенгений бүр Нидерландаас олгосон богино хугацаатай виз эдгээр нутаг дэвсгэрт нэврэх эрх олгодоггүй. Нидерландын төлөөлөгчийн газраас далайн чанад дахь эдгээр нутаг дэвсгэрт алинд нь ч нэвтрэх тусгай виз олгодог.

Гэгээн Мартиний арал дээр орших Нидерландын бүрэлдэхүүний Синт-Мартиний өөртөө засах улс, Францын далай чанад дах Сен-Мартений нийгэмлэг хоорондоо хилийн шалгалтгүй зорчдог байна. Ийм учраас Синт-Мартинд зорчихдоо Сен-Мартенд олгосон Францын визээр, эсвэл эсрэгээр нь зорчих эрхтэй байна.

Норвеги

Шпицберген Норвегийн харьяалалд орох асуудлыг Шпицбергийн гэрээгээр тогтоосон бөгөөд энэхүү гэрээнд нэгдэж гарын үсэг зурсан бүх үндэстнүүдийн төлөөлөгчдөөс тэдгээр бүлэг арлуудад чөлөөтэй суурьших, эдийн засгийн эрх чөлөөг хангах үүргийг Норвеги хүлээжээ. Үүний улмаас Шпицберген Шенгений бүсэд ордогүй /Норвегийг тойрч тэдэнд нэвтрэх нь хүндрэлтэй/, Европын эдийн засгийн бүсэд ч бас ордоггүй. Хэдийгээр Шпицберген, Ян-Майен ихэнхдээ нэг бүхэл бүтэнд тооцогддог ч Шпицбергений визгүй нэвтрэх журам Ян-Майенд хамаардаггүй.

Франц

Францын далай чанад дахь Европын холбоонд ордог, ордоггүй нутаг дэвсгэрүүд нь Европоос алслагдсан байдлаасаа хамаарч Шенгений хууль тогтоомжид захирагддаггүй. Эдгээр нутаг дэвсгэрийн хувьд визгүй зорчих дэглэм нь тусгай журмаар ихэнхдээ үндэстнүүдийн төлөөллийн жагсаалтаар Европын холбооноос илүү өргөн хүрээнд зохицуулагддаг.

Шенгений богино хугацаатай визийг Францаас олгосон байсан ч эдгээр нутаг дэвсгэрт нэвтрэхэд хүчингүй байдаг. Францын төлөөлөгчийн газраас далайн чанад дахь нутаг дэвсгэрт нэвтрэхээр олгосон тусгай виз нь Францын далайн чанад дахь аль ч нутаг дэсгэрт нэвтрэх эрх олгодог.

2.4.Шенгений бүс

Шенгений хууль тогтоомжийг Де-факто бүрэн хэрэглэдэг улсуудын нутаг дэвсгэрээс үл хамаарах хэсгийн нутаг дэвсгэрийг нь хассан нийт нутаг дэвсгэрийг Шенгений бүс гэх бөгөөд өөрөөр хэлбэл хүмүүс ямар ч саадгүй, чөлөөтэй, паспортын байнгын хяналтгүйгээр нэвтрэлцэх орон зай юм. Европын холбооны хууль тогтоомжийн дагуу улс орнуудын бие биетэйгээ хиллэдэг аль ч улсын дотоод хилийн хаагуур ч /зөвхөн хилийн заасан боомтоор бус/ чөлөөтэй нэвтрэх боломжтой байдаг.

2.5. Визийн ангилал

“A” ангилал.

Агаарын тээврийн виз нь гишүүн орнуудаар зөвхөн дамжин өнгөрөх эрх олгохоос дотор нь зорчих эрх олгодоггүй. Энэ төрлийн визийг Афганистан, Бангладеш, Гана, Ирак, Иран, Ардилсан Конго, Нигерия, Пакистан, Сомали, Шри-Ланка, Эритрей, Этиопи зэрэг улсын иргэд заавал авсан байхыг шаарддаг. Оролцогч улсууд зарим орны хувьд энэ ангиллын визийг шаардах эрхтэй байдаг. Тухайлбал Азербайжан, Армян, Беларусь, Гүрж, Молдов, Египет, Туркээс шууд нислэгээр Францын олон улсын онгоц буудлаар дамин өнгөрч байгаа ОХУ-ын иргэд ийм визтэй байхыг шаарддаг.

“B” ангилал.

Дамжин өнгөрөх виз нь гишүүн аль нэг орны нутгаар дамжин гуравдагч улс руу нэг, хоёр удаа, онцгой тохиолдолд хэд хэдэн удаа нэвтрэхэд хүчинтэй бөгөөд хугацаа нь 5 хоногоос илүүгүй байна. Энэ төрлийн визийг Шенгений хууль тогтоомжийн оролцогч орнуудад визгүй зорчих эрхтэй улс орны иргэдэд олгогдоно. 2010 оны IY сарын 5-наас “B” ангиллын визийг Шенгений бүсийн тухайд олгогдохгүй болсон ч түүнд үл хамаардаг улс, нутаг дэвсгэрийн хувьд урьдын адил олгож байна.

“C” ангилал.

Шенгений хууль тогтоомжид нэгдсэн оролцогч орнуудын бүхий л нутаг дэвсгэрт хагас жил тутамд 3 сарын хугацаатай нэг болон хэд хэдэн удаа орж гарах эрх бүхий богино хугацаатай виз юм. Энэ төрлийн визийг Шенгений хууль тогтоомжид оролцогч орнуудын нутаг дэвсгэрт визгүй зорчих эрх бүхий улсын иргэнд олгогдоно. Шенгений хууль тогтоомжийг бүрэн хэрэглэдэг /LTV визээс бусад/ аль ч улсаас олгосон энэ ангиллын виз нь Шенгений бүсэд бүхэлд нь зорчих эрх олгодог. Шенгений хууль тогтоомжийг хэсэгчлэн хэрэглэдэг улсаас олгосон “C” ангиллын визээр зөвхөн тэр улсын нутаг дэсгэрт нэвтрэх, тэр улсад зорчих эрх олгодог байна. 2010 оны IY сарын 5-наас Шенгений бүсийн орнуудаас дамжин өнгөрөх зорчигчдод олгодог болжээ.

“D” ангиллын виз.

- 90-ээс дээш хоногийн хугацаатай үндэсний виз. Үндэсний виз болохын хувьд улс бүр өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу олгоно. 2010 оны IY сарын 5-наас Шенгений хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг улсаас олгосон “D” ангиллын виз нь түүнийг олгосон улсын нутаг дэвсгэрт амьдрах эрх олгохоос гадна Шенгений бүсэд хагас жил тутамд 90 хүртэл хоногийн хугацаагаар аялах эрхийг давхар олгодог бөгөөд үүгээрээ өмнө байсан C+D гэсэн нийлмэл ангиллын визийг хүчингүй болгосон байна.
- FMD, FRTD. FTD- авто замын хялбаршуулсан, FRTD- төмөр замын дамжин өнгөрөх баримт бичиг. ОХУ-ын нутаг дэвсгэрээс Калининградын хооронд зорчиход олгодог тусгай ангиллын виз юм.

Хүмүүнлэгийн чанартай онцгой тохиолдолд Шенгений хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлдэг улс ч зөвхөн өөрийн нутаг дэвсгэрт хүчинтэй, Шенгений нутаг дэвсгэрт зорчих эрхгүй “C” ангиллын визийг олгох тохиолдол байдаг. Ийм төрлийн визийг **LTV** / limited territorial validity/ гэж тэмдэглэдэг байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 1

Монгол Улс, БНХАУ -ын хилийн боомтуудын байршил, ангилал

№	Харьяа газар, хороодын нэрс	Боомтын нэр	Боомтын төрөл ангилал	Байршил	Ажиллах хуваарь (Жил бүрийн)	Тайлбар
Нэг. Олон Улсын зорчигч, ачаа тээврийн, боомтууд						
1.	Замын Үүд дэх гаалийн газар	Замын Үүд	Олон улсын шинжтэй, байнгын	Дорноговь аймаг, Замын Үүд сум	Авто замын боомт УБ цагаар 08-18цаг, хятадын цагаар 09-19 цагт	өдөр бүр 9-18 цаг
2.	Замын Үүд дэх гаалийн газар	Замын Үүд	Олон улсын шинжтэй, байнгын	Дорноговь аймаг, Замын Үүд сум	Төмөр замын боомт 24 цагаар	өдөр бүр 9-18 цаг
3.	Ховд аймаг дахь гаалийн газар	Булган	Олон улсын шинжтэй, байнгын	Ховд аймаг, Булган сум	04 сараас 12 сар 15-наас 30	2008 оны 01 дүгээр сараас байнгын ажиллагаатай болсон.
4.	Бичигт дэх ГХ	Бичигт	Олон улсын, байнгын	Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум		Хэлэлцээрээр байнгын ажиллагаатай болсохоор тохиролцсон боловч олон улсын зэрэглэлээр ажиллуулахаар талаар эцэслэн шийдвэрлэгдээгүй.
5.	Дорнод аймаг дахь ГГ Сүмбэр дэх гаалийн салбар	Сүмбэр	Олон улсын шинжтэй, түр	Дорнод аймаг, Халх гол сум	06.11-нээс 06.30 07.16-нээс 07.30 8.16-нээс 9.25	Боомтын цог-цолборын дэд бүтцийн ажил бүрэн дуусаагүй. Ажилаагүй.
2. Хоёр талын зорчигч, ачаа тээврийн байнгын ажиллагаатай боомтууд						
1.	Өмнөговь аймгийн Шивээхүрэн дэх ГХ	Шивээхүрэн	2 талын, байнгын	Өмнөговь аймаг, Гурвантэс сум	/Энэхүү хоёр боомт хоёр талын хууль ёсны баяр, баяр амралтын өдрүүдэд хаах бөгөөд үдийн цайны цаг нь 12-14 цагийн хооронд байна./	
2.	Өмнөговь аймгийн Гашуунсухайт дахь ГХ	Гашуунсухайт	2 талын, байнгын	Өмнөговь аймаг, Ханбогд сум		
3. Хоёр талын зорчигч, ачаа тээврийн түр ажиллагаатай боомтууд						
1.	Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар	Даян	2 талын, түр	Баян-Өлгий аймаг, Сагсай сум	06. 21-ээс 07. 05 08. 01-ээс 08. 20 09. 01-ээс 09. 15	өдөр бүр 10-17 цаг
2.	Ховд аймаг дахь гаалийн газар	Байтаг	2 талын, түр	Ховд аймаг,Булган сум	03.16-наас 03.30 05.16-наас 05.30 09.16-наас 09.30	өдөр бүр 9-18 цаг

3.	Говь-Алтай аймаг дахь гаалийн хороо	Бургастай	2 талын, түр	ГовьАлтай аймаг, Алтай сум	2,4,6,8,10,12 сард 11-аас 30-ны өдрүүдэд	өдөр бүр 9-18 цаг
4.	Дорнод аймаг дахь ГГ Хавирга дахь гаалийн салбар	Хавирга	2 талын, түр	Дорнод аймаг Чойбалсан сум	01.01-01.25 04.01-10.31	өдөр бүр 8-18 цаг
5.	Дорнод аймаг дахь ГГ Баянхошуу дахь гаалийн салбар	Баянхошуу	2 талын, түр	Дорнод аймаг, Халх гол сум	02.01-нээс 02.15 05.01-нээс 05.15 08.01-нээс 08.15 11.01-нээс 11.15	
6.	Сайншанд дахь ГХ	Ханги	2 талын, түр	Дорноговь аймгийн Хатанбулаг сум	03.16-наас 03.30 05.16-наас 05.30 08.16-наас 08.30 11.16-наас 11.30	Даваа-Бямба гаригт хэлэлцээрт заасан нэг өдрийн ажлын цагийн хуваарийн дагуу ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Хавсралт 2

Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтуудын байршил, ангилал

№	Харьяа газар, хороодын нэрс	Боомтын нэр	Боомтын төрөл ангилал	Байршил	Ажиллах хуваарь (Жил бүрийн)	Тайлбар
Нэг. Олон Улсын зорчигч, ачаа тээврийн, боомтууд						
1.	Сэлэнгэ аймаг дахь ГГ	Сүхбаатар	Олон улсын шинжтэй, байнгын	Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум	24 цагаар	
2.	Сэлэнгэ аймаг дахь ГГ, Алтанбулаг дахь гаалийн салбар	Алтанбулаг	Олон улсын шинжтэй, байнгын	Сэлэнгэ аймаг Алтанбулаг сум	өдөр бүр 09-18 цаг	
3.	Баян-Өлгий аймаг дахь ГГ, Цагааннуур дахь гаалийн салбар	Цагааннуур	Олон улсын шинжтэй, байнгын	Баян-Өлгий аймгийн Цагааннуур сум	өдөр бүр 9-18 цаг Бямба,Ням гаригт 09-15	
4.	Дорнод аймаг дахь ГГ, Эрээнцав дахь гаалийн салбар	Эрээнцав авто зам	Олон улсын шинжтэй, байнгын	Дорнот аймаг Чулуунхороот сум	Даваа-Бямба 09-18 цаг Ням: амарна	
5.	Увс аймаг дахь гаалийн хороо, Боршоо дахь гаалийн салбар	Боршоо	Олон улсын шинжтэй, байнгын	Увс аймгийн Давст сум	Өдөр бүр 08-17 цаг Ням: Амарна.	

UHH.MN
ЭРХЛЭГЧ ГААНЫ САН

6.	Хөвсгөл аймаг дахь гаалийн хороо	Ханх	Олон улсын шинжтэй, байнгын	Хөвсгөл аймаг, Ханх сум	Даваа-Баасан 09-18 цаг Бямба,Ням: амарна	
2. Хоёр талын зорчигч, ачаа тээврийн байнгын ажиллагаатай боомтууд						
1.	Дорнод аймаг дахь ГГ, Эрээнцав дахь гаалийн салбар	Эрээнцав төмөр зам	2 талын, байнгын	Дорнот аймаг Чулуунхороот сум	Галт тэрэгний цагийн хуваарийн дагуу ажиллана.	2011 оны байдлаар 5613 хүн зорчсон
2.	Завхан аймгийн Арц суур дахь ГХ	Арцсуурь	2 талын, байнгын	Завхан аймгийн Тэс сум	Өдөр бүр 08-17 цаг Ням: Амарна	2011 оны байдлаар 17321 хүн зорчсон
3.	Увс аймаг дахь гаалийн хороо Тэс дэх гаалийн салбар	Тэс авто замын	2 талын, байнгын	Увс аймгийн Тэс сум	Өдөр бүр 08-17 цаг Ням: Амарна	2011 оны байдлаар 1055 хүн зорчсон
4.	Орхон аймаг дахь ГХ	Бага илэнх /Тэшиг/ Авто замын	2 талын, байнгын	Булган аймгийн Тэшиг сум	-	Одоогоор ажиллаагүй, 2009 ОХУ руу амьд үхэр экспортлосон
5.	Сэлэнгэ аймаг дахь ГГ	Зэлтэр Авто замын	2 талын, байнгын	Сэлэнгэ аймаг, Түшиг сум	-	Сүүлийн 3 жил ажиллаагүй.
6.	Хэнтий аймаг дахь ГГ, Дадал дахь гаалийн салбар	Агацын гол Авто замын	2 талын, байнгын	Хэнтий аймаг Дадал сум	-	Ажилаагүй.
7.	Дорнод аймгийн ГГ, Баян-Уул сумын гаалийн салбар	Ульхан-Дээд Авто замын	2 талын, байнгын	Дорнод аймаг Баян-Уул сум	-	2011 онд 1477 хүн зорчсон.
3. Улсын хилийн хялбарчилсан журмаар нэвтрэх түр буюу улирлын ажиллагаатай боомтууд						

1.	-	Баянзүрх Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	Монгол-ОХУ-ын хилийг хялбаршуулсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар хоорондын 1994 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хэлэлцээрийн дагуу улсын хилийн хялбарчилсан журмаар нэвтрэх түр буюу улирлын ажиллагаатай 9 боомт ажиллуулахаар тохиролцсон боловч хоёр тал дэд бүтэц бүрдээгүй эдийн засаг, аж ахуйн ач холбогдол багатай, нээж ажиллуулах шаардлага гараагүй учраас эдгээр боомтын ихэнх нь хэлэлцээр байгуулагдсанаас хойш ажиллаагүй
2.	-	Хэзэгт Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
3.	-	Шишгэд гол Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
4.	-	Хонгор овоо Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
5.	-	Цагаан арал Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
6.	-	Хутаг-Өндөр Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
7.	-	Хүдэр Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
8.	-	Тогтор Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
9.	-	Ямалхын гол Авто замын	Түр буюу улирлын ажиллагаатай	-	-	
4.Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай хоёр талын авто замын боомтууд						
1.	Баян-Өлгий аймгийн ГГ	Асгатын гол Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Баян-Өлгий аймаг Ногооннуур сум	-	Сүүлийн 3 жил зорчих хөдөлгөөн хийгдээгүй
2.	Увс аймгийн ГГ	Бөхмөрөн Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймгийн Бөхмөрөн сум	-	ОХУ-ын Тыва Улсын Хандгайт, Мугур-Аксы, Кызылхая тосгоны иргэдийг Бөхмөрөн сумын нутгаар дамжин өнгөрүүлэх зориулалттай.
3.	Увс аймгийн хилийн хорооны Сагилын застав	Харигийн гол Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймаг Сагил сум	-	2011 онд 96 хүн зорчсон.
4.	Увс аймгийн хилийн хорооны Давстын сумангийн харуул	Тээл Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймаг Давст сум	-	Мэдээлэлгүй
5.	Увс аймгийн хилийн хорооны Давстын сумангийн харуул	Тээл Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймаг Давст сум	-	Мэдээлэлгүй.

UIHWN СУДАЛГААНЫ САН

6.	Увс аймгийн ГГ	Давст Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймаг Давст сум	-	Зөвхөн хүйтний улиралд ажиллу-улах боломжтой. Хэлэлцээр байгу-улагдсанаас хойш ажиллуулах шаард-лага гараагүй.
7.	Увс аймгийн ГГ	Тэс Авто замын	Дамжин өнгөрөх зориулалттай түр ажиллагаатай	Увс аймаг Тэс сум	-	Зөвхөн хүйтний улиралд ажиллу-улах боломжтой. Хэлэлцээр байгу-улагдсанаас хойш ажиллуулах шаард-лага гараагүй.

* * *

Хавсралт 3

Европын холбооны улсуудын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж

1. Улс орнуудын хилээр хүмүүс нэвтрэх журмын тухай Европын холбооны хууль тогтоомж
2. Шенгений орон зайн улс орнуудын дотоод хилээр болон Европын холбооны гишүүн улсуудын хооронд хилээр нэвтрэх журам
3. Европын холбооны гишүүн улсууд болон Шенгений орон зайн хилийн гаднах гуравдагч улсуудын хооронд хилээр нэвтрэх журам
4. Гуравдагч орнуудын иргэдийг Шенгений орон зайд нэвтрүүлэхээс татгалзах тухай
5. Европын холбооны гишүүн орнуудын хилийг зөрчсөний эрх зүйн үр дагаврын тухай
6. Шенгений орон зайн гадаад хилийн хуурай замын хилийн бичил хөдөлгөөний эрх зүйн дэглэмийн онцлогийн тухай
7. Визийн мэдээллийн систем, Европын холбооны гишүүн улсуудын хилээр хүмүүс нэвтрүүлэх тухай хууль тогтоомжийн шинэчлэл:
    - Хүмүүс хилээр нэвтрэх дэглэм/Шенгений хилийн тухай хууль/-ийн тухай хамтын нийгэмлэгийн хуулиар тогтоосон Европарламент, Европын зөвлөлийн 2006 оны III сарын 15-ны Дэг (EU)№ 562/2006
    - Гишүүн орнуудын гадаад хуурай замын хилийн бичил хөдөлгөөнтэй холбогдох дүрмийг тогтоох, Шенгений конвенцийн заалтыг өөрчлөх тухай Европарламент, Европын зөвлөлийн. 2006 оны XII сарын 20-ны Дэг (EU) №1931/2006
    - Шенгений мэдээллийн систем /SIS II/-ийн хоёр дахь үе шатыг үүсгэн байгуулж ажиллуулах, ашиглах тухай Европарламент, Европын зөвлөлийн 2006 оны XII сарын 20-ны Дэг (EU)№ 1987/2006
    - Визийн /визийн кодекс/ тухай хамтын нийгэмлэгийн хуулиар тогтоосон Европарламент, Европын зөвлөлийн 2009 оны YI сарын 13-ны Дэг (EU) № 810/2009
    - Европын эдийн засгий холбооны (EEU) № 1612/68 Дэгд өөрчлөлт оруулах, 64/221(EEU), 68/360(EEU), 75/35(EEU), 90/364(EEU), 90/365(EEU), 93/96(EEU) тоот удирдамжийг хүчингүй болгож, Гишүүн орнуудын нутаг дэвсгэрт холбооны иргэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн чөлөөтэй амьдрах, зорчих эрхийн тухай Европарламент, Европын зөвлөлийн 2004 оны IY сарын 29-ний Удирдамж 2004/38 (EU)
    - Гишүүн орнуудад гуравдагч орнуудаас хууль бусаар орж ирсэн иргэдийг буцаах тухай хэрэглэж байгаа ерөнхий стандарт дэг журмын тухай Европарламент, Европын зөвлөлийн 2008 оны XII сарын 16-ны Удирдамж 2008/115 (EU)
    - Гравдагч орны өндөр мэргэжилтэй иргэдийг хилээр оруулах, суурьшуулах нөхцлийг тогтоох тухай Европын холбоо, Европын зөвлөлийн 2009 оны Y сарын 25-ны Удирдамж 2009/50(EU)

- Гуравдагч орны иргэнийг хууль бусаар оруулж ажиллуулсан ажил олгогчдод оногдуулах хариуцлагын доод түвшингийн стандартыг тогтоох тухай Европарламент, Европын зөвлөлийн 2009 оны YI сарын 18-ны Удирдамж 2009/52 (EU)

* * *

Ашигласан материал

- Гадаад Хэргийн Яамны Хөрш Орнуудын Газрын 2012 оны 10 дугаар сарын 10-ний албан тоотоор ирүүлсэн Монгол Улсын Хилийн боомтуудын талаарх мэдээлэл
- http://bpo.gov.mn/contact Хил Хамгаалах Ерөнхий газрын вэб сайт
- http://ukr-pravo.at.ua/index/pravovoj_rezhim_peresechenija_ljudmi_vnutrennikh_i_vneshnikh_granic_gosudarstv_chlenov_evropejskogo_sojuza/0-3022
- http://ru.wikipedia.org/
- http://www.kazedu.kz/referat/199429
- http://mk.esimo.ru/documents/files/2_1_4_5.htm
- http://bibliofond.ru/view.aspx?id=443626
- http://old.nasledie.ru/politvne/18_28/article.php?art=18

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНЫ ХИЛИЙН БООМТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЪЯАЛАЛ (ЛАВЛАГАА - МЭДЭЭЛЭЛ)

Ц. Товуусүрэн, Ө. Мөнхтунгалаг

Монгол Улсын Их Хурлын гишүүн М. Батчимэгийн 5/822 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу дэлхийн зарим улс орны хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагууд, тэдгээрийн харьяаллын талаар судалсан.

Хилийн боомтууд дээр ажиллаж байгаа хил хамгаалалт, гаалийн болон мэргэжлийн хяналт, Гадаадын иргэн харъяат, иргэний бүртгэл мэдээллийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, захиргааны удирдлагаар нэгтгэн хангах, хилийн боомтуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулах чиглэлээр олон алхмууд хийгдэж байгаагийн дотор хилийн боомтийн захиргааг байгуулан ажиллуулах явдал тодорхой байр суурь эзэлж байна. Бидэнд олдсон мэдээллээр дэлхийн улс орнууд хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын захиргаа гэсэн боомтуудын үйл ажиллагааг зохицуулах, захиргааны удирдлагаар хангах байгууллагыг буй болгохдоо төр хувийн хэвшлийн түншлэл дээр тулгуурлах хандлага байгаа юм байна.

Дэлхийн зарим улс орны хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагууд, тэдгээрийн харьяалал

№	Улсын нэр	Хилийн боомтын асуудал эрхлэх байгууллагын нэр	Харъяалах яам, газрын нэр	Тайлбар
1	АНУ	Хил хамгаллын алба /United States Border Patrol (USBP)	Дотоодыг хамгаалах департмент	
2	ОХУ	ОХУ-ын хилийн тохижилтын асуудал эрхлэх холбооны агентлаг / Росграница/	ОХУ-ын Засгийн газар	2007 онд хилийн боомтуудын тохижилт, хилийн боомт дээр ажиллаж байгаа байгууллагуудын ажлын уялдаа, холбоог сайжруулах зорилгоор боомтын захиргааны байгууллага хэлбэрээр байгуулсан
3	БНХАУ	Хилийн боомтын хэрэг эрхлэх газар / Chancellery Border Autority of China/	Нийгмийг аюулаас хамгаалах яам	
4	Финланд	“Сенат пропертиз” төрийн удирдлагын компани, Хилийн хамгаалалтын алба /Finnish border guard/	Дотоод хэргийн яам	
5	Канад	Хилийн үйлчигээний агентлаг /Canada Border Services Agency (CBSA)/	Олон нийтийн аюулгүй байдлын сайд	
6	Австрали	Гааль, хил хамгаллын үйлчилгээний алба /,Australian Customs and Border Protection Service /, Цагаачлал иргэний бүртгэлийн алба /Department of Immigration and Citizenship (DIAC)	Дотоод хэргийн сайд	
7	Шинэ Зеланд	Цагаачлалын алба /Immigration New Zealand or INZ, гаалийн алба / Customs Service/	Засгийн газар, Гаалийн сайд	
8	ИБУИНВУ	Хилийн агентлаг /UK Border Agency (UKBA), Хилийн цэрэг /UK Border Force/	Дотоод хэргийн сайд	2008 онд Цагаачлалын болон Визийн агентлагийн нэгтгэн Хилийн агентлагийг байгуулсан
9	Франц	Хилийн цагдаа /Border police/, Гааль, шууд бус татварын ерөнхий газар / Directorate-General of Customs and Indirect Taxes/	Үндэсний цагдаагийн газар, Дотоод хэргийн яам	
10	Гонконг	Цагаачлалын газар /Immigration Department /, Гааль, онцгой татварын удирдах газар /Customs and Excise Department (C&ED)	Засгийн газар	
11	Сингапур	Цагаачлал, хилийн хяналт, шалгалтын газар /Immigration and Checkpoints Authority/	Дотоод хэргийн яам	
12	Макао	Макаогийн цагдаагийн олон нийтийн хамгаалах хүчний газар /Public Security Police Force of Macau/	Цагдаагийн газар	Португалийн колончлолын үеэс эхлэлтэй
13.	Польш	Польшийн хилийн хамгаалалтын газар /Straż Graniczna/	Дотоод хэргийн яам	Хилийн цагдаагийн хэлбэрт шилжсэн

* * *

Ашигласан материал:

- http://ru.wikipedia.org/wiki/_2
- http://www.servat.unibe.ch/icl/au00000_.html
- http://en.wikipedia.org/wiki/Border_checkpoint
- http://en.wikipedia.org/wiki/Immigration_Department_(Hong_Kong)
- http://en.wikipedia.org/wiki/Direction_centrale_de_la_police_aux_fronti%C3%A8res
- http://en.wikipedia.org/wiki/UK_Border_Agency

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Р. Хатанбаатар, А. Пагма, Г. Гэрэл

УДИРТГАЛ

УИХ -ын гишүүн, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн ахлагч Д. Эрдэнэбатын захиалгаар “Гадаадын зарим орны хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны, тухайлбал, БНХАУ, БНМолУ -ын хот байгуулалтын харилцааг зохицуулсан хуулийг Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуультай харьцуулалт хийн, давуу болон сул талыг гаргах, цаашид манай орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлж болох туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулсан дүгнэлт гаргахыг зорив. Мөн зарим өндөр хөгжилтэй орнуудын хот байгуулалтын эрх зүйн орчны талаархи мэдээллийг судалгааны явцад хайлт хийж, олдсон мэдээллүүдийг нэгтгэн нийтлэг асуудал, эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг ерөнхийлөн харуулах зорилго тавьсан болно.

Судалгааны зорилтууд:

- Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтын зарим ерөнхий асуудлыг харьцуулан судлах,
- Гадаадын зарим орны хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн зохицуулалттай харьцуулалт хийн, давуу болон сул талыг гаргах, харьцуулан судлах,
- Судалгаанд хамрагдсан орнуудын хот байгуулалтын хуулийн зохих заалтуудыг Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуультай харьцуулалт хийн, дүгнэлт гаргах зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын тухайлбал, орчин үеийн өндөр хөгжилтэй улсуудын хот байгуулалт, төлөвлөлтийн туршлагыг амжилттай авч хэрэгжүүлж буй БНХАУ-ын Хот, тосгон байгуулалтын тухай хууль /Urban and Rural Planning Law of the People’s Republic of China/, мөн хуучин ЗХУ -ын бүрэлдэхүүнд байсан, тусгаар тогтносон, манай улстай хүн ам, эдийн засгийн хөгжлийн түвшингээр ойролцоо Бүгд Найрамдах Молдов Улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийг Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуультай харьцуулалт хийхээр сонгон авсан болно.
- Гадаадын зарим орнуудын хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтын тодорхой жишээг харьцуулан судлах,
- Судалгааны материалыг харьцуулан нэгтгэн дүгнэх

Хамрах хүрээ:

1. БНХАУ, БНМолУ-ын хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт,
2. ХБНГУ, АНУ, Их Британи, Шведийн хот байгуулалт, түүний үндсэн баримт бичгийн төрөл, ангилал,эрх зүйн зохицуулалт,
3. Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хууль

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн\
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р.Хатанбаатар ахалж, референт - шинжээч А. Пагма, референт - судлаач Г. Гэрэл нар хийж гүйцэтгэв.

Судалгааны дүгнэлт

1. Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн зүйл, заалтуудыг зарим улсын хот байгуулалтын тухай хуулиудтай харьцуулан үзэхэд ерөнхий бүтэц, зохицуулж буй харилцааны хувьд зарчмын ялгаа, зөрүү харьцангуй бага байна. Гэвч зарим нэг тодорхой чухал асуудал, тухайлбал, тухайн хуулиар зохицуулагдаж байгаа хот байгуулалтын үйл ажиллагааны зорилго, үүрэг, функц, тодорхой нөхцөлд хот байгуулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах дэг, журам, олон нийтийн саналыг авах, хот төлөвлөлтийн төрөл, агуулга, хот байгуулалтын үйл ажиллагааны төлөө хүлээх хариуцлагыг хуульчилсан байдлаараа бусад орны хууль илүү тодорхой, нарийвчлан хуульчилсан байдалтай харагдаж байна.

2. Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтанд хот байгуулалтын баримт бичиг, түүний төрөл, агуулга, боловсруулах арга, түүнд тавигдах шаардлага, санхүүжилт зэрэг олон чухал асуудлыг тусган хуульчилдаг ба бидний харьцуулан судалсан хуулиудад уг асуудлыг тусгайлсан бүлэгт авч үзсэн байна. Ерөнхий зарчмын асуудлууд нь ижил хэмжээнд тусгагдан хуульчлагдсан боловч бусад орны хуулиудад хот төлөвлөлтийн хэтийн болон ойрын төлөвлөлтийн хугацаа, зайлшгүй ямар асуудлыг зохицуулсан байх, уг баримт бичигт хэрхэн өөрчлөлт оруулах зэргийг тодорхой хуульчилжээ.

3. Манай улсын хувьд, зайлшгүй тодорхой болгох эрх зүйн зохицуулалтын тухайд жишээ нь, хот байгуулалтын үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээх субъектыг Молдов улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижолтын тухай” хуулийн заалтын нэгэн адилаар хуульчилах боломжтой, бусад улсын хуулиудад ч мөн ийм заалтууд байна.

   Мөн БНХАУ -ын “Хот, тосгоны байгуулалтын тухай” хуульд хот, тосгоны ойрын хугацааны барилга байгуулалтын төлөвлөгөөнд олон нийтийн үйлчилгээний барилга байгууламж, бага дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны барилга байгууламж болон экологи, байгаль орчин хамгаалах гэсэн чухал үндсэн байгууламжуудыг зайлшгүй тусгана гэж хуульчилсан нь манай улсын хувьд анхаарч, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай асуудлын нэг хэмээн үзэж байна.

4. Мөн барилгын зөвшөөрөлгүй барьсан, хууль журам зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгуулах арга хэмжээнд өсгөн нэмэгдүүлэх торгууль тогтоодог улс орнуудын туршлагыг харгалзан үзэх боломжтой юм. Тухайлбал, Орон нутгийн төлөвлөлтийн захиргааны байгууллагаас зөрчил гаргагчид бичгээр сануулга өгөх бөгөөд уг сануулгад гаргасан зөрчлөө арилгах хугацааг заасан байна. Сануулгад заасан зөрчлийг заагдсан хугацаанд арилгаагүй байвал торгууль оногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ хугацаа хэтэрснээс хойш өдөр тутам нэмэгдэнэ.

5. Германд барилга барих зөвшөөрөл авалгүй барьсан юмуу зөвшөөрлийн нөхцөлийг зөрчин барьсан байгууламжийг эзэмшигчийн зардлаар нураах бөгөөд нэмж торгууль оноодог. Францад зөрчил гаргагчийг шоронд хорих хүртэл шийтгэх ба уг зөрчлөөс үүдэн хохирол амссан хөршүүдийнх нь гомдлыг үндэслэн барилга байгууламжийг нураадаг байна.

6. Түүнчлэн хот байгуулалт, төлөвлөлтийн асуудалд иргэд, олон нийтийн оролцоог ерөнхийлөн тусгах бус харин энэ оролцоог бодитой хангах асуудал чухал нь харагдаж байна. Юуны өмнө 1) шийдвэрийг бэлтгэх, гаргах шатанд иргэд, олон нийтийн саналыг заавал тооцох, үүний хамгийн дээд хэлбэр нь хот байгуулалтын бодлоготой холбоотой ерөнхий болон тухайн асуудлаар санал асуулга, референдум явуулах хүртэл хэлбэр байж болно, 2) батлан гаргасан шийдвэрийн талаар гомдол гаргах боломжтой байх, 3) олон нийтийн зүгээс хот байгуулалттай холбоотой асуудлаар тодорхой үйл ажиллагаа явуулах боломжтой байх зохицуулалтыг бидний судалсан улс орнуудын хуульд зохицуулсан байна.

7. Хот байгуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хориглох зүйлүүдийг хуульчилсан нь үндсэндээ ижил төстэй ба манай улсын хуулийн заалтууд нь энэ асуудлаар зарим талаар илүү нарийвчлалтай, инженер, техник, технологийн нөхцөлийг нь тодорхой зааж, хориглох нөхцөлүүдийг нь хуульчилсан боловч эдгээр хуульчлагдсан эрх зүйн зохицуулалтууд амьдрал дээр бүрэн дүүрэн хэрэгждэггүй нь хуулинд хариуцлагын тогтолцоо, хуулийн хэрэгжилтийн хяналтын тогтолцоо ба хэрэжүүлэх журмыг хуульчлан тогтоогүйтэй холбоотой гэж дүгнэж болохоор байна.

* * *

I. Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтын зарим ерөнхий асуудал

- Дэлхийн улс орнуудад хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн ялгаатай статус бүхий баримт бичгүүдээр зохицуулдаг. Тухайлбал, АНУ-д муж улсуудын бүсийн төлөвлөлтийн бүрэн эрхийн тухай хуулиудаар, Францад газрын орон зайн зохион байгуулалтын тухай баримт бичгүүдээр, Германд газар ашиглалтыг журамлах баримт бичгүүдээр тус тус зохицуулдаг. Ер нь аль ч улсад хот байгуулалтын үйл ажиллагааг үл хөдлөх хөрөнгө, түүнийг ашиглах процесстой холбоотойгоор эрх зүйн хувьд зохицуулна.

- Газар ашиглалтын эрх зүйн зохицуулалтаар иргэд, хуулийн этгээд, нутгийн өөрөө удирдах байгууллага болон газар зохион байгуулалт, түүний ашиглалтын асуудлыг эрхэлдэг төрийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх, хариуцлага, үйл ажиллагаагаа уялдуулах журмыг тодорхойлно.

  Газар ашиглалтыг зохицуулах процесст оролцогч этгээдүүдийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дараалыг харгалзах норматив, арга зүй, лавлагаа, зааварчилгааны баримт бичгээр зохицуулна. Эдгээр баримт бичгээр хот байгуулалттай холбоотой архитектур төлөвлөлт, барилга, экологи, эрүүл ахуй, галын аюулаас хамгаалах болон бусад салбарын нормативыг тухайн тодорхой газарт харилцан уялдуулсан хязгаарлалтууд, хот байгуулалтанд оролцогч этгээдүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтооно. Мөн хот байгуулалтын тодорхой төслийг хэрэгжүүлэх үед төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, батлахдаа газар төлөвлөлт, газар ашиглагч бусад сонирхогч этгээдийн байр суурийг тооцож, нэгтгэсэн байх ёстой.

Дээрх баримт бичгүүдийг баталсны дараа тухайн оронд үйлчилдэг газрын мэдээллийг хадгалах системийн (хот байгуулалтын кадастрын систем) дагуу албан ёсоор бүртгүүлнэ, ингэснээр уг баримтууд хуулийн хүчин төгөлдөр болно. Ийнхүү кадастрыг хөтөлснөөр

газар болон бусад үл хөдлөх хөрөнгийг эзэмшигч, ашиглагч, захиран зарцуулагч иргэд болон хуулийн этгээдүүд тогтоосон регламентийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавихад шаардагдах мэдээллийн суурь бий болно. Газар ашиглалтыг зохицуулах орчин үеийн системийг бүрдүүлэх, уг систем зохих ёсоор ажиллаж байхын тулд тодорхой зарчмуудыг баримтлах бөгөөд эдгээр зарчмыг мөрдснөөр дараах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

- хүн амын амьдрах, амрах, ажиллах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хамгаалах,
- үл хөдлөх хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллагад өргөн эрх мэдэл олгох, уг байгууллагын түвшин, өмчийн статусаас үл хамааран газар ашиглагчид гаргасан шийдвэрийг нь заавал биелүүлэх,
- тогтоогдсон процедурыг мөрдөх, газар ашиглахтай холбоотой маргаантай асуудлаар сонирхогч талуудын эрх ашгийг нийцүүлэхэд олон нийтийн болон шүүхийн хатуу хяналттай байх,
- газар ашиглагчид, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны байгууллагуудын хооронд үүсч болох аливаа зөрчлийг арилгахад иргэдийн зүгээс оролцох эрх зүйн боломжууд байх
- төрийн байгууллагаас газар, хот байгуулалттай холбоотой гаргахаар бэлтгэж буй шийдвэрийн агуулгын талаар сонирхогч талууд урьдчилан мэдээлэл авсан байх, ингэснээр хойшдоо гарч болох маргаан, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг болно.

1. Газар төлөвлөлт болон хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийн тухай.

Орон нутаг, хотын түвшинд хот байгуулалтыг төлөвлөх баримт бичгийн хоёр түвшинт систем үйлчилдэг. Эхний түвшин нь газар төлөвлөлтийн баримт бичиг, хоёрдахь нь үл хөдлөх хөрөнгийг ашиглах, өөрчлөх эрхийг тодорхойлох баримт бичиг юм. Эхнийхийг нь газар төлөвлөлтийн баримт бичиг, хоёрдахыг нь хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг гэж нэрлэнэ.

Газар төлөвлөлтийн баримт бичиг нь хот, түүний орчныг хөгжүүлэх бодлогыг тусгасан стратегийн чанартай зарчмын шийдлүүдийг тусгасан байна. Үүнд нийгэм ахуйн болон инженер техникийн системийн ирээдүйн хөгжлийн төлөвлөлт, газар нутгийг тодорхой зориулалтаар хуваарилан ангилахтай холбоотой зарчмын шийдлүүд тусгагдана. Хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг нь илүү нарийвчилан боловсруулж, нутаг дэвсгэрийн бүсүүдийг тогтооно. Бүс бүрийн хувьд тавигдах шаардлага, зааглалт, үл хөдлөх хөрөнгийг ашиглах зөвшөөрөгдсөн хэлбэрүүд, ашиглаж болох газрын хэмжээ, барилгажуулалтын нягтрал зэргийг нарийвчлан боловсруулна.

Эдгээр хоёр түвшний баримт бичгүүд нь шийдвэрлэх зорилгоосоо гадна эрх зүйн статус, хуулийн үйлчлэлээрээ ч ихээхэн ялгаатай. Газар төлөвлөлтийн баримт бичиг нь юуны өмнө хотын захиргаанд хамаарах бөгөөд батлагдан гарснаараа үл хөдлөх хөрөнгө эзэмшигч иргэдэд ямар нэгэн эрх зүйн үр дагавар авчрахгүй байх ёстой. Харин хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг нь нутгийн өөрөө удирдах төлөөллийн байгууллагаар хэлэлцэгдэн батлагдсан, тухайн нутаг дэвсгэртээ хуулийн статустай байх бөгөөд нутгийн захиргааны байгууллагаас гадна үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчид, түрээслэгчид бүгд баримт бичгийн заалтуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

2. Барилга байгуулалтын зөвшөөрөл

Үл хөдлөх хөрөнгийн объектийг өөрчлөн барилга байгуулалт хийх эрх зөвхөн уг үл хөдлөх хөрөнгийн эзэмшигчид байх бөгөөд барилга барих зөвшөөрлийн үндсэн дээр

хийгдэнэ. Гэхдээ зарим бага хэмжээний өөрчлөлт хийхэд зөвшөөрөл авахгүй байж болдог. Зөвшөөрөл авахын тулд нутгийн захиргааны байгууллагад өргөдөл гаргах ба захиргааны байгууллага зөвшөөрөл олгохдоо хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгээс давсан ямар нэгэн эрх зүйн норм тогтоохгүй, энэ нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн эзэмшигчийн барилга байгуулалт хийх сонирхол нь хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгээр тогтоогдсон журамтай нийцэж буйг л баталгаажуулж буй хэрэг юм.

Барилга байгуулалт дууссаны дараа шалгалт хийгдэх бөгөөд энд мөн л шинээр баригдсан объект нь хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгээр тогтоогдсон журам болон аюулгүй байдлын шаардлагад нийцэж буй эсэхийг тогтооно. Харин уг шаардлага биелэгдээгүй тохиолдолд торгууль болон бусад арга хэмжээг авна.

3. Хот төлөвлөлтийн талаарх мэдээлэл

Батлагдан гарсан хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичигт тусгагдсан мэдээлэл иргэдэд нээлттэй, хүртээмжтэй, сонирхсон этгээд нутгийн захиргааны байгууллагад хандан материалтай танилцах боломжтой байх ёстой. Нутгийн өөрөө удирдах төлөөллийн байгууллагаар хэлэлцэгдэн батлагдсан хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг тухайн нутгийн хэвлэлд нийтлэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр болж байхаар хуульчилдаг.

Үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч тухайн үл хөдлөх хөрөнгийн хувьд хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийн шаардлагыг өөрчлөх хүсэлтэй байвал нутгийн захиргааны байгууллагад ийнхүү өөрчлөх гарцаагүй шаардлагатй байгаагаа үндэслэсэн өргөдөл гаргаж болно. Хэрэв уг хүсэлтийг үндэслэлтэй гэж үзээд, хийх өөрчлөлт нь хөршүүдийн сонирхолыг зөрчихгүй, тэдэнд ямар нэгэн хохирол учруулахгүй гэвэл тухайн объектийн хувьд хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийн шаардлагыг өөрчилж болно.

4. Хот төлөвлөлтөнд иргэд оролцох

Үл хөдлөх хөрөнгийг ашиглах, өөрчлөхтэй холбоотой бүсчлэлийн баримт бичгийн шаардлагуудыг тогтооход иргэд, олон нийт оролцох эрхтэй байх ёстой. Хэлбэрийн хувьд шууд болон шууд бусаар оролцох, үе шатны хувьд бүсчлэлийн баримт бичгийг бэлтгэх үед, зөвшилцөх үед эсвэл хэрэгжих үед нь оролцож болдог. Иргэд, олон нийт нутгийн өөрөө удирдах байгууллага юмуу гүйцэтгэх байгууллагад сонгогдсон төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцохыг шууд бус оролцоо гэнэ.

Иргэд, олон нийтийн шууд оролцоо нь тухайн шатны байгуулагын албан ёсны шийдвэр гарахын өмнө ба хойно хэдийд ч байж болох бөгөөд мөн олон нийтийн санаачлага хэлбэртэй байж болно. Энд анхаарал татсан дараах гурван зүйл байна. Үүнд: 1) шийдвэрийг бэлтгэх, гаргах шатанд иргэд, олон нийтийн саналыг заавал тооцох, үүний хамгийн дээд хэлбэр нь хот байгуулалтын бодлоготой холбоотой ерөнхий болон тухайн асуудлаар санал асуулга, референдум явуулах хүртэл байж болно, 2) батлан гаргасан шийдвэрийн талаар гомдол гаргах боломжтой байх, 3) олон нийтийн зүгээс хот байгуулалттай холбоотой асуудлаар тодорхой үйл ажиллагаа явуулах боломжтой байх, жишээлбэл, гол гудамжийг шинэчлэн засварлах, орон нутгийн түүхийн дурсгалыг хамгаалах, хотын өөрийн өвөрмөц дүр төрхийг хадгалах гэх мэт асуудлаар хөтөлбөр гарган үйл ажиллагаа явуулах зэрэг болно.

Хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийн төслийг бэлтгэх шатанд иргэд, олон нийтийн байгууллагууд өөрийн санал бодлоо илэрхийлэх боломжтой байхын тулд уг баримт бичгийн үндсэн санааг орон нутгийн хэвлэлд урьдчилан нийтэлсэн байх шаардлагыг хуульчилсан байх хэрэгтэй. Мөн санал, санаачлага, шүүмжлэлийг нэгтгэн цуглуулах, анализ хийж дүгнэлт гаргах тусгай комиссыг байгуулан ажиллуулах ёстойг болон баримт бичгийн төслийг хэлэлцэх, батлах процесст олон нийтэд нээлттэй сонсгол хийх асуудал зэргийг хуульчлан тогтоосон байх хэрэгтэй байдаг байна.

II. Гадаадын зарим улс орны хот байгуулалтын тухай хууль, Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн харьцуулалт

Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийг БНХАУ -ын “Хот, тосгон байгуулалтын тухай” хууль, Бүгд Найрамдах Молдов улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуультай тус тус харьцуулалт хийсэн болно.

1. БНХАУ -ын Хот, тосгон байгуулалтын тухай хууль /Urban and Rural Planning Law of the People’s Republic of China/

БНХАУ-ын Хот, тосгон байгуулалтын тухай хууль нь 2008 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Монгол улсын Хот байгуулалтын тухай хуулинд зааснаар	БНХАУ-ын Хот, тосгон байгуулалтын тухай хуулинд зааснаар
Хуулийн бүтэц: Монгол улсын Хот байгуулалтын тухай хууль нь нийт долоон бүлэг, 28 зүйлтэй. Үүнд: • Нэгдүгээр бүлэг - Нийтлэг үндэслэл • Хоёрдугаар бүлэг- Хот байгуулалтын үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх • Гуравдугаар бүлэг- Хот байгуулалтын баримт бичиг, түүнд тавигдах үндсэн шаардлага • Дөрөвдүгээр бүлэг - Хот төлөвлөлтийн үйл ажиллагааны зохицуулалт • Тавдугаар бүлэг- Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах • Зургадугаар бүлэг-Хот байгуулалтын кадастр болон хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналт, шинжилгээ • Долдугаар бүлэг - Бусад зүйл	Хуулийн бүтэц: БНХАУ-ын Хот, тосгон байгуулалтын тухай хууль нь нийт долоон бүлэг, 70 зүйлтэй. Үүнд: • Нэгдүгээр бүлэг - Нийтлэг үндэслэл • Хоёрдугаар бүлэг - Хот, тосгон байгуулалт төлөвлөгөөний тогтолцоо • Гуравдугаар бүлэг - Хот, тосгон байгуулалт төлөвлөгөөний хэрэгжүүлэлт • Дөрөвдүгээр бүлэг - Хот, тосгон байгуулалт төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах • Тавдугаар бүлэг - Хяналт шалгалт • Зургадугаар бүлэг - Хуулийн хариуцлага • Долдугаар бүлэг – Бусад зүйл
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хоорондүүсэх харилцааг зохицуулахад оршино.	1-р зүйл Хот, тосгоны төлөвлөгөөний удирдлагыг сайжруулах, хот, тосгоны хоосон газар талбайн тохижилтыг зохицуулах, хүн амын амьдрах хүрээлэн буй орчныг сайжруулах, хот, тосгоны нийгэм, эдийн засгийн бүх талын хөгжлийг дээшлүүлэх зорилгоор энэхүү хуулийг тогтоосон.

SUDALGAA.MN
СУДАЛГААНЫ САН

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж 2.1.Хот байгуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний зүйлыг дагаж мөрдөнө.	2-р зүйл Хот, тосгоны төлөвлөгөөг гаргах болон хэрэгжүүлэхэд мөн түүнчлэн төлөвлөгөөний бүс дотор барилга барих бол зайлшгүй энэ хуулийг дагаж мөрдөнө. 4-р зүйл Хот, тосгоны төлөвлөгөөний бүс дотор барилга барих бол газрын тухай хууль, байгалийн баялаг, хүрээлэн буй орчны хамгаалалтын тухай хууль зэрэг хууль, эрх зүйн актуудыг дагаж мөрдөнө. 5-р зүйл Хотын ерөнхий төлөвлөгөө, тосгоны ерөнхий төлөвлөгөө мөн сум, дүүргийн ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлт нь үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжилд суурилсан байх ёстой ба түүнчлэн газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөөтэй харилцан уялдах ёстой.
17.1.Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана. 17.2.Хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана.	26- р зүйл Хот төлөвлөлтийн байгууллага нь хот, тосгоны төлөвлөгөөний зөвшөөрөл авахаар хүргүүлэхийн өмнө хуулийн дагуу хотын төлөвлөгөөний төслийг олон нийтэд мэдээлэх ба хэлэлцүүлэг, уулзалт болон бусад аргаар мэргэжилтэн, ард иргэдийн саналыг авна. Нийтэд 30-аас доошгүй өдрийн өмнө мэдээлнэ.

Монгол улсын Хот байгуулалтын тухай хуулинд тусгагдаагүй заалт

Монгол улсын Хот байгуулалтын тухай хуулинд тусгагдаагүй заалт	БНХАУ-ын Хот, тосгон байгуулалтын тухай хуулинд зааснаар
Хотын ерөнхий төлөвлөгөөний хугацааг тодорхой заагаагүй байна.	17- р зүйл Хотын ерөнхий төлөвлөгөө болон тосгоны ерөнхий төлөвлөгөөний хугацаа 20 жил байна. Хотын ерөнхий төлөвлөгөөнд тухайн хотын цаашдын урт хугацааны хөгжлийн талаарх урьдчилсан төлөвлөгөөг мөн гаргана.
16- р зүйл Шинэ хороолол, бичил хорооллыг төлөвлөх болон байгуулах асуудлыг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга санаачилна.	30- р зүйл Хотын ерөнхий төлөвлөгөөнд болон тосгоны ерөнхий төлөвлөгөөнд заасан барилгажуулах газраас бусад газарт өөр төрлийн шинэ хот, барилга байгуулахыг хориглоно.

Ойрын хугацааны барилга байгуулалтын төлөвлөгөөний хугацаа болон бага, дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны барилга байгууламж байгуулах талаар заалт байхгүй.	34- р зүйл Ойрын хугацааны барилга байгуулалтын төлөвлөгөөнд олон нийтийн үйлчилгээний барилга байгууламж, бага дунд орлоготой иргэдэд зориулсан орон сууцны барилга байгууламж болон экологи, байгаль орчин хамгаалах гэсэн чухал үндсэн байгууламжуудыг зайлшгүй тусгана. Түүнчлэн ойрын хугацааны барилга байгууламжын хугацаа, барилгажилтын дараалал, хөгжлийн чиг хандлага болон хоосон газар талбай зэргийн тохижилт орно. Ойрын хугацааны барилга байгуулалтын төлөвлөгөөний хугацаа 5 жил байна.
Хот, тосгоны төлөвлөгөөнд барилга барих байгууллага өөрчлөлт оруулж болох эсэх талаар заалт байхгүй.	43- р зүйл Барилга барих байгууллага нь хотын төлөвлөгөөнд тавигдах шаардлагын дагуу барилга барина. Зайлшгүй өөрчлөх шаардлага гарвал хот, мужийн төрийн захиргааны хотын төлөвлөлтийн газарт /Department of urban and rural planning under the people's government of the city or town/ хүсэлтээ өргөдлөөр гаргана. Хэрэв өөрчлөлт нь хотын нарийвчилсан төлөвлөгөөнд тохирохгүй бол зөвшөөрөл олгож болохгүй. Хот, мужийн төрийн захиргааны хот төлөвлөлтийн яам хуулийн дагуу өөрчлөлт оруулсан хотын төлөвлөгөөг тухай бүр тухайн шатны газрын асуудал хариуцсан яаманд мэдэгдэх ба олон нийтэд зарлана.
Түр барилга барих, түүнийг буулгах талаар энэ хуульд зохицуулсан зүйл заалт байхгүй.	44- р зүйл Хот, тосгон дотор түр барилга барих бол зайлшгүй хот, мужийн төрийн захиргааны хот төлөвлөгөөний яамнаас зөвшөөрөл авна. Хэрэв түр барилга нь хотын ойрын хугацааны төлөвлөгөө, нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилт болон зам тээвэр, хотын өнгө үзэмж, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээр бол зөвшөөрөл олгож болохгүй. Түр барилгыг олгосон зөвшөөрөлд заасан хугацааны дотор түр барилгыг барьсан байгууллага өөрөө буулгана.
	65-р зүйл Барилга барих байгууллага эсвэл хувь хүн дараах аль нэг байдалтай бол тухайн оршин байгаа газрын хот, мужийн төрийн захиргааны газрын төлөвлөгөөний яамнаас буулгуулах шийдвэр гаргах ба мөн түр барилгын төслийн үнийн нэг дахин үнээс багаар торгоно: 1- Зөвшөөрөлгүйгээр түр барилга барьсан бол 2- Зөвшөөрөлд заасны дагуу түр барилга бариагүй бол 3- Түр барилгыг зөвшөөрөлд заасан хугацаанд буулгаагүй бол
Хяналт шалгалт хийсэн байдал болон шийдвэрийн үр дүн нийтэд нээлттэй эсэх талаар заалт байхгүй.	54- р зүйл Хяналт шалгалт хийсэн байдал болон шийдвэрийн үр дүн хуулийн дагуу олон нийтэд нээлттэй байна.
Барилга барих зөвшөөрлийг хүчингүй болгож болох эсэх талаар заалт байхгүй.	57-р зүйл Хот, тосгон байгуулалт төлөвлөгөөний яам энэхүү хуулийг зөрчин захиргааны зөвшөөрөл олгосон бол, дээд шатны төрийн захиргааны хот тосгон төлөвлөлтийн яамнаас тухайн зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргах ба эсвэл шууд хүчингүй болгоно. Зөвшөөрлийг хүчингүй болгосноос шалтгаалан хүний эрх ашигт хохирол учирсан бол хуулийн дагуу хохирлыг нөхөн олгоно.

UIS.MN
СУДАЛГААНЫ САН

Хот, төлөвлөлтийн байгууллагад мэргэшлийн гэрчилгээг шаардах ба тухайн мэргэшлийн гэрчилгээг хүчингүй болгож болох талаар заалт байхгүй.?	59- р зүйл Хот, тосгон төлөвлөлтийн байгууллага нь шаардлага хангасан мэргэшлийн гэрчилгээтэй байгууллагаар хот тосгоны төлөвлөгөөг гаргуулаагүй бол, дээд шатны төрийн захиргааны газраас засаж сайжруулахыг шаардах ба анхааруулга өгнө. Мөн тухайн үйл ажиллагааг гүйцэтгэсэн холбогдох гол хариуцсан этгээд болон бусад шууд хариуцсан этгээдэд арга хэмжээ авна.
	63- р зүйл Хот, тосгон төлөвлөлтийн байгууллага нь мэргэшлийн гэрчилгээ /qualification certificate/ авснаас хойш, мэргэшлийн түвшинг цаашид хангахгүй бол тухайн мэргэшлийн гэрчилгээг олгосон байгууллагаас тодорхой хугацаа өгөн засаж сайжруулахыг шаардах ба, хэрэв хугацаандаа сайжраагүй бол мэргэшлийн гэрчилгээний зэрэглэлийг бууруулах эсвэл мэргэшлийн гэрчилгээг хүчингүй болгоно.
Хот, тосгонд баригдсан зөвшөөрөлгүй, шаардлага хангаагүй барилга байгууламжыг хүчээр буулган нурааж болох тухай заалт байхгүй.	64- р зүйл Тосгоны төлөвлөгөөний бүс дотор хуулийн дагуу тосгон байгуулах төлөвлөгөөний зөвшөөрөлгүйгээр барилга барих эсвэл тосгон байгуулах төлөвлөгөөний зөвшөөрлийн дагуу барилга бариагүй бол тосгоны төрийн захиргааны газраас барилга барихыг зогсоож, тодорхой хугацаа өгөн хуучин байдалд нь оруулахыг шаардах шийдвэр гаргана. Хэрэв заасан хугацаанд хуучин байдалд нь оруулаагүй бол хүчээр буулгаж болно.

2. Бүгд Найрамдах Молдов Улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хууль[70]

Тус хууль нь 1997 онд батлагдсан ба нийт 6 бүлэг 78 зүйлтэй, БНМолУ-ын хот байгуулалт, нутаг дэвсгэрийн тохижолтын үйл ажиллагааны зорилго, хот байгуулалтын баримт бичгийн боловсруулалт, түүнд тавих шаардлага, батлах, барилга барих зөвшөөрөл олгох, барилга барих үйл ажиллагааг зогсоох, хот байгуулалт, тохижолтын ажилд тавих хяналт шалгалтын зарчим, тус хяналтыг хэрэгжүүлэх субъект зэрэг хот байгуулалт, нутаг дэвсгэрийн тохижолтын хүрээний харилцааны үндсийг хуульчилжээ.

Энэхүү хуулийг 2008 онд батлагдсан Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн зүйл заалтуудтай харьцуулан үзэхэд ерөнхий бүтэц, зохицуулж буй харилцааны хувьд зарчмын ялгаа, зөрүү харьцангуй бага хэдий боловч зарим нэг тодорхой, чухал асуудал, тухайлбал, тухайн хуулиар зохицуулагдаж байгаа хот байгуулалтын үйл ажиллагааны зорилго, үүрэг, функци, тодорхой нөхцөлд хот байгуулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах дэг, журам, олон нийтийн саналыг авах, хот төлөвлөлтийн төрөл, агуулга, хот байгуулалтын үйл ажиллагааны төлөө хүлээх хариуцлагыг хуульчилсан байдлаараа Молдов Улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хууль илүү тодорхой, нарийвчлан хуульчилсан байна. Тухайлбал, тус хуулийн 1 дүгээр бүлгийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хот байгуулалтын үйл ажиллагааны зорилгыг дараах байдлаар хуульчилжээ. Үүнд:

- Хүн амын суурьшилд зайлшгүй шаардлагатай нутаг дэвсгэрийн үр ашигтай, тэнцвэртэй ашиглалтыг хангах,
- Хүн амын суурьшлын оновчтой бүтцийг тодорхойлох,

[70] Закон Республики Молдовии “Об основах градоустройства и обустройстве территории” 1997 г. http://www.constructor.md

- Хүн амыг нийгмийн хөгжлийн түвшин, хэрэгцээнд нийцсэн амьдрах нөхцөлөөр хангах,
- Барилгажилт, тохижолтын ажлын засал чимэглэлийн гоо зүйн иж бүрдлыг хангах,
- Хүн амыг хүрээлэн буй орчны бохирдол болон болзошгүй байгалийн болон технологийн аюулт үзэгдлээс хамгаалах,
- Байгалийн ба соёлын хөшөө, дурсгалыг зохих ёсоор хадгалан, хамгаалах зэрэг болно.

Түүнчлэн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт орон нутгийн нийтийн захиргааны байгууллага (органы публичного управления) нь өөрийн эрх мэдлийн хүрээнд дээрхи зорилгыг хэрэгжүүлэх хот байгуулалтын зохион байгуулалт, хүн амын суурьшлын бүсийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхийг хуульчилжээ. Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хуульд хот байгуулалтын үйл ажиллагааны зорилгыг хуульчилсан зүйл, заалт байхгүй харин “Хот байгуулалтын үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх” гэсэн 2 дугаар бүлэгт УИХ, Засгийн газар, засгийг газрын уг асуудлыг хариуцсан байгууллага, бүх шатны Засаг дарга, ИТХ-ын бүрэн эрхийг маш ерөнхий байдлаар хуульчилсан байна.

Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтанд хот байгуулалтын баримт бичиг, түүний төрөл, агуулга, хэрхэн боловсруулах, түүнд тавигдах шаардлага, санхүүжилт зэрэг олон чухал асуудлыг тусган хуульчилдаг ба бидний харьцуулж буй 2 хуульд уг асуудлыг тусгайлсан бүлэгт авч үзсэн ба ерөнхий зарчмын асуудлууд нь ижил хэмжээнд тусгагдан хуульчлагдсан боловч тухайн асуудлыг хэрхэн нарийвчлан хуульчилсаныг хот байгуулалтын баримт бичиг гэсэн бүлгийн задаргаа, зүйл тус бүрийн гарчигийг харьцуулан үзэхэд ч харагдаж байгаа болно. Доор Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн Хот байгуулалтын үндсэн барим бичиг, түүнд тавигдах шаардлага гэсэн 3 дугаар бүлэг болон Молдов Улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийн Хот байгуулалт болон нутаг дэвсгэрийн тохижилтын баримт бичиг гэсэн 2 дугаар бүлгийн хэсэг, зүйлийн гарчгийг харьцуулан харуулав.

Монгол Улсын “Хот байгуулалтын тухай”хуулийн II бүлгийн зүйлийн нэрс	Молдов Улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” III бүлгийн хэсгийн нэрс
• Хот байгуулалтын баримт бичиг • Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага • Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэл • Нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага • Хот байгуулалтын баримт бичиг • боловсруулах ажлын санхүүжилт	Баримт бичгийн агуулга Баримт бичгийн боловсруулалт Баримт бичгийг зөвшилцөх Иргэдтэй зөвлөлдөх Баримт бичгийг батлах Баримт бичигт өөрчлөлт оруулах

Тухайлбал, манай улсын ”Хот байгуулалтын тухай” хуулийн 2 дугаар бүлэгт хот байгуулалтын баримт бичиг нь ямар төсөл, төлөвлөгөө, бусад баримт бичгээс бүрдэх, ямар байгууллага тэдгээрийг боловсруулах, ямар шаардлагыг хангасан байх, баримт бичгийг боловсруулах ажлыг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх зэрэг асуудлыг хуульчилсан бол Молдов улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийн 3 дугаар бүлэгт хот байгуулалтын баримт бичиг нь ямар төрөлтэй байх, төрөл тус бүр ямар агуулгыг тусгасан байх, баримт бичгийг боловсруулах явцад ямар байгууллагууд хоорондоо зөвшилцөх болон хэрхэн иргэдтэй зөвлөлдөн, тэдний саналыг боловсруулж буй баримт бичигт тусгах, батлах, тодорхой, шаардлагатай тохиолдолд баримт бичигт

ITH.MN
СУДАЛГААНЫ САН

хэрхэн өөрчлөлт оруулах зэрэг хот байгуулалтын баримт бичигтэй холбоотой тодорхой асуудлуудыг нарийвчлан хуульчилсан байна.

Молдов улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийн 47 дугаар зүйлд хот байгуулалтын баримт бичигт барилга барих ажиллагааг бүр болон түр хориглох арга хэмжээг тусгаж болохыг хуульчлан ямар тохиолдолд бүр болон түр хориглох шалтгааныг тодорхой заажээ.

Монгол Улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн 23, 24 дүгээр зүйлүүдэд мөн хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах, Хот байгуулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд хориглох зүйлүүдийг хуульчилсан нь үндсэндээ ижил төстэй ба манай улсын хуулийн заалтууд нь энэ асуудлаар зарим талаар илүү нарийвчлалтай, инженер, техник, технологийн нөхцөлийг нь тодорхой зааж, хориглох нөхцөлүүдийг нь хуульчилжээ. Тухайлбал, Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах зүйлийг хориглохоор хуульчилжээ. Үүнд:

- Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлага, үе шатны зорилт, эдэлбэр газрын зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горим зөрчиж газар олгох,
- Техникийн нөхцөлийн зөвшөөрөл, бүрдэлгүй газар олгох,
- Олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулах,
- Инженер-геологийн судалгаа, зураг төсөлгүй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, өргөтгөх, шинэчлэх,
- Холбогдох байгууллагаар хянагдаж баталгаажсан төв, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тэдгээрийг зөрчих, зөвшөөрөлгүй дур мэдэн өөрчлөх,
- Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст барилга байгууламж төлөвлөх, барих зэрэг болно.

Түүнчлэн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шийдвэрт хамрагдсан тухайн газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгох болон хот байгуулалтын бусад үйл ажиллагаа явуулахыг тодорхой хугацаагаар түр зогсоор заажээ.

Дээрхи хоёр хуулийг бүлэг, зүйл, заалт бүрээр харьцуулан үзэхэд аль аль хуульд нь нөгөөгөөсөө ялгагдах давуу болон сул тал байгаа нь харагдаж байна. Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн хувьд дээр дурьдсанаар 24 дүгээр зүйлийн заалтууд илүү тодорхой байгаагийн зэрэгцээ тус хуулийн 20 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц бий болгох талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт болон барилгажилтын шийдэл, зураг төсөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно гэсэн заалттай ижил утга агуулгатай эрх зүйн зохицуулалт Молдов улсын “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуульд үгүй байгаа юм. Мөн онцолбол зохих нэг чухал асуудал бол хот байгуулалт, тохижолтын үйл ажиллагаа, зохион байгуулалт, хот байгуулалтын хууль, тогтоомжийг зөрчсөний төлөө ямар субъект хариуцлага хүлээх тухай асуудал юм.

Монгол улсын “Хот байгуулалтын тухай” хуулийн Хот байгуулалтын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан 28 зүйлд иргэн, байгууллага, аж ахуйн нэгж гэсэн 3 субъектэд зохих хариуцлагыг тооцохоор хуульчилсан бол Молдов улсын

“Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийн 3 дугаар зүйлд нутаг дэвсгэрийг тохижуулах ажлын хариуцлагыг дэвшүүлсэн зорилтоос хамааран нийтийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд хүлээнэ, 19 дүгээр зүйлд хот байгуулалт ба тохижилтын бичиг баримтын боловсруулалт, батлах хариуцлагыг дараах байдлаар хүлээнэ:

а) Нийт улсын хэмжээний хот байгуулалт, төлөвлөлтийн хариуцлагыг Засгийн газар,

б) Бүс нутгийн хот байгуулалт, төлөвлөлтийн хариуцлагыг Засгийн газар, тухайн орон нутгийн нийтийн захиргааны байгууллага,

б) Орон нутгийн хот байгуулалт, тохижилт, төлөвлөлтийн хариуцлагыг, тухайн орон нутгийн нийтийн захиргааны байгууллага тус тус хариуцахыг заасан.

71 дүгээр зүйлд “Хот байгуулалтын үндэс ба нутаг дэвсгэрийн тохижилтын тухай” хуулийг зөрчсөн хариуцлагыг орон нутгийн нийтийн захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтнууд хүлээхийн зэрэгцээ, эдгээр байгууллага, албан тушаалтны батлан гаргасан заавар, журам, хийсэн үйлдлээс үүдсэн хохирлын хариуцлагыг мөн тэд хүлээхээр хуульчилсан болно.

3. Гадаадын зарим орнуудын хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтын зарим тодорхой жишээ

1) Нэгдүгээр түвшний газар төлөвлөлтийн баримт бичгийг Германд газар ашиглах төлөвлөгөө, Их Британид бүтцийн төлөвлөгөө, Францид директив схем, Шведэд ерөнхий төлөвлөгөө, АНУ-д комплекс төлөвлөгөө гэж тус тус нэрлэнэ.

Хоёрдугаар түвшний хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийг Германд барилга байгуулалтын төлөвлөгөө, Их Британид орон нутгийн төлөвлөгөө, Францид газар ашиглах төлөвлөгөө, Шведэд нарийвчилсан төлөвлөгөө, АНУ-д бүсийн төлөвлөгөө гэж нэрлэнэ.

- Германд хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг буюу барилга байгуулалтын төлөвлөгөөг дээд шатны буюу муж улсын захиргааны байгууллагад бүртгүүлэхээр хүргүүлнэ. Дээд шатны захиргааны байгууллага нь гурван сарын хугацаанд уг төлөвлөгөө эрх зүйн процедурыг зөрчсөн эсэхийг хянах бөгөөд хэрэв ямар нэгэн зөрчил байвал батлахаас татгалзаж болно. Гэхдээ уг барилга байгуулалтын төлөвлөгөөний агуулгыг зөвшилцөхгүй. Тогтоосон хугацаанд дээд шатны захиргааны байгууллага эрх зүйн процедурын зөрчил байгаа эсэх талаар мэдэгдээгүй юмуу хугацаанаас өмнө зөрчил байхгүй гэдгийг мэдэгдсэн тохиолдолд барилга байгуулалтын төлөвлөгөө хүчин төгөлдөр болно. Харин газар ашиглах төлөвлөгөөгүй тохиолдолд барилга байгуулалтын төлөвлөгөө гаргасан бол дээд шатны захиргааны байгууллагаар уг төлөвлөгөөг батлуулна.
- Их Британид хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг нь газар төлөвлөлтийн баримт бичигтэй нийцэж буй эсэхийг гүнлэгийн төлөвлөлтийн захиргаа баталгаажуулдаг. Хэрэв энэ асуудлаар санал зөрөлдөөн гарвал Хүрээлэн буй орчны сайд асуудлыг зохицуулна. Ингээд сайд оролцоод ч зөрчилдөөнийг шийдвэрлэж чадаагүй бол уг хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг буюу орон нутгийн төлөвлөгөө хүчин төгөлдөр болно, өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичиг нь газар төлөвлөлтийн баримт бичгээс илүү хүч нөлөөтэй болно. Үүнийг 1986 онд батлагдсан Орон сууц, төлөвлөлтийн хуулиар баталгаажуулсан байна. Хүрээлэн буй орчны сайд хот байгуулалтын бүсчлэлийн баримт бичгийг батлах асуудлыг шууд хариуцахгүй боловч энэ баримт бичгийн хувийг түүнд заавал хүргүүлсэн байх ёстой бөгөөд сайд уг баримт бичгийг дахин нарийвчлан судлан боловсруулахыг шаардах эрхтэй.

Энэ тохиолдолд сайдын томилсон байцаагч тусгайлсан илтгэл бичнэ. Орон нутгийн захиргаа уг илтгэлтэй танилцаад байцаагчын санал болгосон засварыг хүлээн авч баримт бичигт тусгах юмуу хүлээн авах боломжгүй гэдгээ мэдэгдэнэ. Энэ зөрчилдөөнийг Төрийн хяналт шалгалтын сайд зохицуулна.

2. Их Британид 1987 оноос газрын бүсчлэлийн хэлбэрийг тогтоосон байдаг. Газар ашиглалтын 16 хэлбэр байх бөгөөд үүнийг 4 үндсэн бүлэгт хуваадаг. А – худалдааны бүс, Б – аж үйлдвэрийн бүс, В – орон сууцны бүс, Г – нийтийн эзэмшлийн бүс.

   - АНУ-д дараах хэлбэрийн бүсчлэл байна: 1. Орон сууцны бүс, дотроо нэг айлын байшингийн бүс, хоёр айлын блок байшингийн бүс, олон орон сууцтай барилгын бүс, өндөр нягтралтай барих орон сууцны барилгын бүс гэсэн 4 дэд хэлбэртэй. Өндөр нягтралын бүсд 1 га газарт 50-иас дээш орон сууц оногдох барилгатай хэсгийг оруулдаг. 2. Худалдаа, үйлчилгээний бүс, 3. Үйлдвэрлэлийн бүс, 4. Хөдөө аж ахуйн бүс.

   - Германд дараах хэлбэрийн бүсүүд байна: 1. Хотын төв бүс, 2.холимог бүс, 3. Орон сууцны бүс, үүнд олон давхар барилгын (3-аас дээш давхар) бүс, олон давхар блок барилгын (хороолол) бүс, хувийн байшингийн бүс гэж хуваагдана, 4. Үйлдвэрлэл, бизнесийн бүс, 5. Аж үйлдвэрийн бүс, 6. Тусгай бүс.

3. АНУ -д үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнэлгээнийх нь 25% -иас хэтрэхгүй хэмжээтэй эквивалентаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрдөг. Германд барилга барихад зөвшөөрөл авахгүй байж болох 30 гаруй тохиолдлыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, конструкцийн өөрчлөлт оруулахгүйгээр хийх барилгын өөрчлөлт, түүх дурсгалын зүйлсийг хадгалах бүсээс өөр бүст барилгын гадаад хэлбэрийг өөрчлөх, хүн амьдрахад зориулагдаагүй 15 м^3 -ээс хэтрэхгүй байгууламж (гараж, худалдаа хийх зориулалтынх байж болохгүй), барилгажилтын талбайн дэргэд хийх газар шорооны ажил (гэхдээ талбай нь 30 м^2 -аас хэтрэхгүй, овоолгын өндөр нь 1,25 м-ээс хэтрэхгүй, ухах гүн нь 1 м-ээс хэтрэхгүй байх тохиолдолд), 20 м^2 -аас хэтрэхгүй талбайтай, 4 метрээс хэтрэхгүй өндөртэй хүлэмж барих, 100 м^3 -ээс хэтрэхгүй багтаамжтай усан бассейн байгуулах, оршуулгын газар 3 метрээс хэтрэхгүй өндөртэй хөшөө босгох гэх мэт.

4. Их Британид 1981 он хүртэл барилга барих зөвшөөрлийг үнэ төлбөргүй олгодог байсан бол үүнээс хойш ялгавартай хураамжийн систем хэрэгжиж байна. Одоо мөрдөгдөж буй хуулиар барилга барих зөвшөөрөл олгох хураамжийг Хүрээлэн буй орчны сайд тогтоодог. Хураамжийн хэмжээ нь газрын 0,1 га тутамд 66-1650 паунд, шинэ барилгын хувьд 40 м^2 талбайтай орон сууц тутамд 33 паунд, 40-75 м^2 орон сууцанд 66 паунд, үүнээс дээш нэмэлт 75 м^2 тутамд 66 паунд байх бөгөөд нэг орон сууцанд дээд хэмжээ нь 3300 паундын хэмжээтэй байна.

   Францад барилга барих зөвшөөрөл олгохдоо шууд бус хураамжийн систем ашигладаг. Барилга баригчид хот тохижилтын орон нутгийн татвар төлөх замаар хотын газар нутгийн инженерийн байгууламж, нийтийн сүлжээг санхүүжүүлэх ёстой гэж хуульчилсан байдаг. Энэхүү хот тохижилтын татварийн хэмжээг тухайн газар дээр байгаа юмуу баригдах үл хөдлөх хөрөнгийн нийт өртөгт суурьлан тогтооно. Өртгийн үнэлгээг жил бүр шинэчлэнэ. Татварын хэмжээг өртгийн 1%-аар тогтоох боловч тухайн орон нутгийн зөвлөлөөс 5% хүртэл нэмэгдүүлж болдог.

5. Германд барилга барих зөвшөөрөл авалгүй барьсан юмуу зөвшөөрлийн нөхцөлийг зөрчин барьсан байгууламжийг эзэмшигчийн зардлаар нураах бөгөөд нэмж торгууль оноодог. Францад бол зөрчил гаргагчийг шоронд хорих хүртэл шийтгэх ба уг зөрчлөөс үүдэн хохирол амссан хөршүүдийнх нь гомдлыг үндэслэн барилга байгууламжийг нураана. Барилга барих зөвшөөрөлд тусгагдсан нөхцөлийг зөрчсөн зөрчилд мөн

торгууль онооно. Хэрэв дахин давтсан зөрчил гаргавал торгууль оноох шийтгэл дээр нэмж 1-6 сар хүртэл хорих ял оноодог.

6. Их Британид зөвшөөрөл олгогдсоноос хойш 5 жил болоход барилга баригдаж дуусаагүй байвал нутгийн захиргааны байгууллагаас газар эзэмшигчид албан ёсны сануулга өгөх бөгөөд уг сануулгыг хүлээн авснаас хойш 12 сараас хэтрэхгүй хугацаанд барилгыг барьж дуусгасан байх ёстой. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд барилга барих зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдох бөгөөд үүнээс хойш хийгдсэн барилгын бүх ажлыг хууль бус гэж үзнэ.

Барилга барих зөвшөөрөлд заагдсан нөхцөлүүдийг зөрчсөн тохиолдолд мөн үүнтэй адил арга хэмжээ авагдана. Орон нутгийн төлөвлөлтийн захиргааны байгууллагаас зөрчил гаргагчид бичгээр сануулга өгөх бөгөөд уг сануулгад гаргасан зөрчлөө арилгах хугацааг заасан байна. Сануулгад заасан зөрчлийг заагдсан хугацаанд арилгаагүй байвал торгууль оногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ хугацаа хэтэрснээс хойш өдөр тутам нэмэгдэнэ.

* * *

Ашигласан материал

1. “Хот байгуулалтын тухай”. Монгол улсын хууль. 2008 он
2. “Хот, тосгон байгуулалтын тухай” БНХАУ-ын хууль /Urban and Rural Planning Law the People’s Republic of China/ http://www.gov.cn
3. Закон Республики Молдовии “Об основах градоустройства и обустройстве территории” 1997 г. http://www.constructor.md
4. Garner J.F. (ed). Planning Law in Western Europe. N.Y.,
5. Wade H.W.R. Administrative Law. 6th ed. Oxford: Clarendon Press, 1988.
6. . Hagman D.G., Juergensmeyer J.C. Urban Planning and Land Development Control Law. 2nd ed. St. Paul, Minn.: West Publishing Co., 1986.
7. М.Я. Вильнер, Н.И. Наймарк Новый градостроительный кодекс РФ в сопоставлении с соответствующим опытом США, Москва, 2005
8. Э.К. Трутнев и др. Градорегулирование. Основы регулирования градостроительной деятельности в условиях становления рынка недвижимости**,** Москва, 2008

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ОЛИГАРХИЖСАН УЛСТӨРИЙН БҮТЦИЙГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

П. Амаржаргал, Г. Билгээ, Г. Гэрэл, Ч. Онончимэг

Гарчиг

Оршил

Онолын үндэслэл

1. Засаглалд нөлөөлөх сонирхлын бүлгүүд
2. Засаглал олигархижих үйл явц
3. Олигархижсан засаглалын төлөв байдал, үр нөлөө
4. Олигархижсан засаглалыг хязгаарлах арга зам

Хавсралт 1. Нэг танхимтай парламенттай улсууд

Хавсралт 2. Хоёр танхимтай парламенттай улсууд

* * *

Оршил

Энэхүү судалгааг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ц.Цолмонгийн 2012 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 1099 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачид хийж гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг салгах, олигархижсан улс төрийн бүтэц үүсэх нөхцөлийг хаах, хязгаарлах асуудлыг онолын түвшинд хэрхэн авч үздэг болон энэ талаарх бусад орны туршлагыг тодруулан гаргахад чиглэгдэнэ.

Судалгааны зорилгийг хэрэгжүүлэхийн тулд:

- Олигархижсан улс төрийн бүтэц, улс төр эдийн засгийн ашиг сонирхлын зааг ялгааг эрдэмтэд судлаачид хэрхэн тодорхойлсон талаарх онолын асуудлыг авч үзэх;
- Олигархижсан улс төрийн бүтэц үүсэх нөхцлийг хаах, хязгаарлах талаар бусад орнууд ямар бодлого баримталж, хэрхэн зохицуулдаг туршлагыг тодруулах;

Онолын үндэслэл

1. Засаглалд нөлөөлөх сонирхлын бүлгүүд

Улс төрийн үйл ажиллагааны хүрээнд засаглалын эрхийг хэрэгжүүлж байгаа бие хүн, нийгмийн бүлгүүдийг засаглалын нийгмийн субъект гэнэ. Үүнд сонирхолын бүлгүүд, эрх баригч элитүүд, улс төрийн хошуучлагчдыг хамруулдаг. Сонирхолын бүлгүүд нь чухамдаа хувь хүмүүсийн нэгдэл юм. Тэд өөрсдөөө ашигтай шийдвэр гаргуулахын тулд улс төрийн институтэд нөлөөлж байдаг. Тэд ашиг сонирхлоо нэгтгэх, илэрхийлэх, мэдээлэх, улс төрийн элитүүдийг төлөвшүүлэх зорилготой ажиллана. Өөрсдийн төлөөллийг засаг төрийн бүрэлдэхүүнд оруулах явдал гол эрмэлзэл нь байдаг.

Эдгээр сонирхлын бүлгүүдийг дараахь байдлаар ангилж болно. Олигархи – Улс төрийн эрх мэдэл эд баялаг, гэр бүл, зэвсэгт хүчний эрх мэдэл, эсвэл шашин шүтлэгээр холбогдсон нийгмийн цөөнх элит хэсгийн гарт байдаг Засгийн газрын хэлбэр. Иймэрхүү эрх мэдлийн туйлын шинж чанар нь тэрээр нээлттэй илэрдэггүй бөгөөд олигархиуд эдийн засгийн аргаар хяналт тогтоож ‘нууц ноёнтон’ хэлбэрээр оршин тогтнохыг чухалчилдаг.[71]

Өнөө үед ардчилсан легитимээр хүлээн зөвшөөрөгдөөгүй хэрнээ засгийн эрх барьж буй эрх баригчидтай тийм улс төрийн системийг олигархи хэмээн нэрийддэг байна. Цөөн хэдэн хүн тасралтгүйгээр буюу эсхүл хяналтгүйгээр төр барихыг хэлнэ. Олигархи бий болох нөхцөл мөн ардчилсан орнуудад ч байдаг.[72]

1911 онд нэрт социологич Роберт Михельс “олигархийн төмөр хууль” гэгчийг томъёолсон бөгөөд ардчилал нь зарчмын хувьд асуудлыг ард түмнийг төлөөлсөн олонхиороо хэлэлцээд, тэдгээрийн талаас илүү хувь нь санал нэгдэж эцсийн шийдвэр гаргадаг тул ямар ч ардчилсан дэглэм гарцаагүй олигархийг төрүүлж байдаг гэдгийг нотолсон. Тухайлбал, 3 сая хүнтэй улсад 100 гишүүнтэй парламент байна гэж төсөөлөхөд гишүүдийн 51 нь цуглаад асуудал хэлэлцэх боломжтой. Үүнээс 26 нь санал нэгдвэл 3 сая хүний хувь заяаг шийдэх боломжтой.

Үүний жишээ нь коммунист орнуудын номеклатурын засаглал, барууны ихэнхи орнууд дахь корпоратив болон плутокократи засаглал (ялангуяа АНУ), хөгжиж буй орнуудын компрадор хөрөнгөтөн болно.

Лобби бүлэг – Өөрсдийнхөө сонирхлыг хэрэгжүүлэх зорилгоор засаг төрд нөлөө үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахыг Лобби гэдэг. Төр засгийн байгууллагуудад нөлөөллөх хандлагын цаана улс эх орны эрх ашиг гэсэн нэгдсэн бодол санаа байх ёстой. Энэ нь юунаас нөхцөлдөх вэ гэвэл: олон ургалч үзэл (плюрализм) улс төрийн намын шинж чанараас хамаарна. Улс төр, нам хүчирхэг нэр нөлөөтэй байхын хирээр сонирхолын бүлгүүдийн нөлөө бага байна. Нам, улс дорой байх тусам лобби бүлэглэлүүдийн нөлөө хүчтэй болдог. Амьдрал дээр бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшний төрийн байгууллагуудыг лоббидох арга олон янз байдаг.

- Парламентад илтгэл оруулах;
- Хууль санаачлах боловсруулахад оролцох;
- Уулзалт хэлэлцээр зохион байгуулах;
- Орон нутгаас шахалт шаардлага ирүүлэх;
- Социологийн судалгаа хийж парламентад тараах;
- Төрийн байгууллагын доторхи өөрийн хүмүүсийг тодорхой зорилгод нэгтгэх;
- Сонгуулийн компаныг зохион байгуулах;
- Албан тушаалтанд авлига өгөх;

Лобби бүлэглэлүүдийн үйл ажиллагаа нь эдийн засгийн, нийгмийн, нийгэм соёлын шинж чанартай байдаг. Парламентийн доторхи лобби нь сонирхолын бүлгүүдэд шаардлагатай байгаа хуулиудыг батлуулахад чиглэгддэг учир хуулийн төсөл санаачилж боловсруулдаг. Засгийн газар дахь лобби нь гүйцэтгэх засаглалын байгууллагуудад хэрэгтэй хууль тогтоолыг гаргахад анхаардаг.

Лобби нь хууль ёсны байж болох ч хууль бус байх нь бий. Тухайлбал, Корпорациуд эдийн засаг, санхүүгийн ашиг олох зорилгоор улс оронд хохиролтой шийдвэр гаргуулах.

[71] Засаглалын үзэл баримтлал, нэр томьёоны тайлбар толь бичиг. Ц.Даваадулам. 2010 он

[72] http://forum.mn/index.php?sel=content&menu_id=6&obj_id=3216

Тодорхой төрлийн гэмт хэргийг өршөөх тухай шийдвэр гаргуулахаар гэмт бүлэглэлүүд нөлөөлөх гэх мэт.

Үндэсний хөрөнгөтнүүд ба Корпорациуд – Тодорхой нөөц бололцоог ашиглах зорилготой, тодорхой аж ахуй засаг захиргаа, цэрэг улс төр хамт олны эрх ашиг сонирхолыг хамгаалж байдаг хуулиар баталгаажсан явцуу бүлэг юм. Эрх мэдэл нь цөөн тооны элит группт харъяалагддаг. Нийгмийн хөрөнгөлөг олигархууд улсдаа хөрөнгө оруулалт хийх буюу өөрийн өмчийг ашиглан улс орон хөгжин цэцэглэх үндсийг тавих (үйлдвэр, компани, барилга байгууламжуудыг бий болгох) зэргээр улс орноо хөгжүүлэх боломжтой. Гэвч энэ нь үнэн хэрэг дээрээ хэлбэрийн төдий зүйл бөгөөд эцсийн дүндээ зөвхөн өөрсдийн өмч хөрөнгө эрх мэдлийг бататгахын тулд хийж буй зүйл болно.

Ардчилалд суралцаж байгаа улсад ардчиллын үнэт зүйл дээр доргүй итгэл үнэмшил болоогүй, хууль, шударга ёс хэрэгжих, эрх зүйт ёсны зарчим үйлчлэх баталгаа байдаггүй. Ялангуяа, төрд өндөр алба хашиж байгаа, итгэл хүлээлгэсэн, эрх бариулсан хүмүүсийн маань төрд нэг сэтгэлээр зүтгэх, ард түмний сонголтоос гажихгүй байх дархлаа бүрэлдээгүй байдаг учраас ашиг сонирхлын зөрчилд орох нь хамгийн түгээмэл үзэгдэл болдог.

Ялангуяа парламентад төрийн эрх мэдэл хуваарилалт алдагдан холилдсон байвал, түүн рүү хууль тогтоох чадвартай, шударга, боловсролтой, мэдлэгтэй, мэргэшсэн хүмүүс орох үүд хаалга хаагдаж, харин мөнгөтэй болчихсон олигархи хэсэг амархан гүйгээд орно. Эл үзэгдлийг Ф.Бастиа “тонуулсан хүмүүс тонох гэж тэгж байгаа” гэж хэлсэн бол А.Токвиль “хувийн секторт амжилт олохгүй болохоор эсвэл ашиг орлого нь чамлагдахаар төрийн ивээлд орж амьдрах, ашиг орлогоо нэмэгдүүлэх гэсэн оролдлого” гэсэн санааг гаргасан байдаг.

Олигархи хөрөнгөтнүүдээс дорвитой бүтээл үлддэггүй, бүхий л хөрөнгө мөнгөө зөвхөн өөртөө л зарцуулж, төрийн албан тушаалыг зөвхөн өөрийн гэр бүл, бараа бологчиддоо бэлэглэсээр төрийг хувьчилж, улмаар дампуурууллдаг. Гэхдээ шинэ нийгмийн шинэлэг сэтгэлгээтэй үндэсний хөрөнгөтнүүдийг олигархиас ангид ойлгох хэрэгтэй. Тэдний зорилго өөр, анх хөрөнгөжсөн түүх нь ч олигархиудаас ялгаатай. Эрх мэдэл, төрийн албанаас ашиг унагаан байж олигархи мэндэлдэг бол ганзагын наймаа эрхлэн, өр зээл тавин байж үндэсний хөрөнгөтөн төрдөг. Олигархи бол төрийн алба, эрх мэдлийн наймаачин. Тэд тендерт ялуулж, төсөл хөтөлбөр зуучилж өгснийхөө хөлсөнд хөрөнгөждөг.

Тэд чөлөөт зах зээлийн өрсөлдөөнийг боймлогчид. Тэд бизнесийн салбарт өрсөлдөлгүйгээр ашиг ологчид. Өрсөлдөөнөөс тэд үхтлээ эмээдэг, өрсөлдөх нь тэдний байгаль чанар биш. Хувийнхаа эрх ашгийн төлөө эх орноо худалдаж байгаа хүмүүс. Нэг харахад тэд улсдаа маш их татвар төлж ард иргэдийг нуруундаа үүрч яваа мэт боловч үнэн чанартаа бор зүрхээрээ зүтгэж яваа бизнесийн салбарынхан л татвараа төлдөг атлаа төрд ч, ард иргэдэд ч адлуулж явдаг.

Хууль зөвхөн жижиг, дунд бизнесийнхэнд л үйлчилдэг. Олигархийн ноёрхол хаана хамгийн хүчтэй байна вэ? Судлаачдын олж тогтоосноор: Нэгдүгээрт: Байгалийн баялаг ихтэй ядуу буурай улс орнуудад, хоёрдугаарт: Пост - социалист улс орнуудад хүчирхэг олигархи ноёрхож байна. Чөлөөт өрсөлдөөнгүй, олигархижсан засаглал бүхий нийгэмд үндэсний хөрөнгөтнүүд нь эцэстээ бизнес хийж эрсдэлд унахын оронд улс төрд өөрөө орж бизнесээ хамгаалах, эсвэл төрийн том албан тушаалтныг лоббидон тэдэнтэй харилцан ашигтай наймаа үсэргэн хөрөнгө мөнгөө өсгөж арвижуулах, хөрөнгөө баталгаажуулах гэсэн бодолд хүрдэг.

2. Засаглал олигархижих үйл явц

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар парламентад засаг бариулж, бас дээр нь 20-р зүйлээр “төрийн эрх барих дээд байгууллага” гэгч дээд эрхийг эдлүүлэхээр заасан. Энэ заалт манай парламентийг “супер” гэсэн чимэгтэй болгосон. Ийм чимгийг гадаадын судлаачид өгсөн юм.

Алдаатай энэ заалтыг нялх ардчиллын романтик сэтгэлгээ, Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийг хуваарилсан ерөнхий үзэл баримтлал, зарчим нь залруулж ирсэн билээ. Гэтэл шинэ Үндсэн хуулийн эх баригч, профессор Б. Чимидийн онож дүгнэснээр 2000 онд “ард түмний захиалга” нэрийн дор хэдхэн хүний “санал” нийлүүлж, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг устгаж, 1990 оны өмнөх тогтолцооны нэгэн хувилбарт эргүүлэн оруулснаар (Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ, 2006, 75 дахь тал) “төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн нөгөө алдаатай заалт жинхэнэ ёсоор амилж, Үндсэн хууль “дуусгавар” болов.

Үндсэн хууль оршино гэдэг нь Үндсэн хууль гэсэн нэртэй бичвэр байхын нэр биш юм. Бодит үйлчлэлээр түүний байгаа, байхгүйг хэмждэг Үндсэн хууль оршихын баталгаа нь төрийн эрх мэдлийг хуваарилж, аль нэгний дангаар ноёрхох дээд эрхийг зогсоох явдал юм. Тийм учраас Францын алдарт тунхагт Үндсэн хуульт ёсны онолоор төрийн эрх мэдлийг хуваариалаагүй улс оронд Үндсэн хууль хэрэг дээрээ оршдоггүй хэмээн заасан билээ. Энэ үүднээс харвал Монгол улсад амин сүнстэй, бодит үйлчлэлтэй, төр, иргэний хоорондын хууль зүйн гэрээ, хүний эрх, иргэний үндсэн эрх чөлөөг хамгаалсан Үндсэн хууль одоо байхгүй. Харин “төрийн эрх барих дээд байгууллага” төрийн дээд эрхээ дангаар эдэлж байна.

Тэр байгууллага үндсэн, уугуул чиг үүргээ (төлөөлөх, хууль тогтоох) бараг хэрэгжүүлэхгүй нөгөө дээд эрхээ л амтархан хэрэгжүүлж байна. Тэгвэл тэр байгууллага чинь юу хийж байна гэж хэн хүнгүй асуух нь лавтай. Өнгөрсөн он жилүүдийн явцаас харахад парламент юунд их анхаарч ирэв гэвэл хуулийг хууль бүтээдэг арга технологиор бүтээхийн төлөө бус, харин засаг тойрсон асуудлаар зав зайгүй гүйцгээв. Парламент ийм байдалд орсон нь төрийн тогтолцооны гажиг, нөгөө л “дээд эрх”-тэй холбоотой.

Манай улс Засгийн газрын гишүүдийг парламентын гишүүдээс, парламентаас томилохоор хуульчилсан нь парламентыг хууль тогтоох, төлөөлөх үндсэн чиг үүргээс салгасан төдийгүй, парламентын гишүүний суудлын төлөө оюунлаг хэсгийг биш харин мөнгөтэй, улс төрөөр дамжуулж хувийн бизнесээ хөгжүүлэхийг хүсэгчдийг уралдуулж, парламентийн гишүүний суудлыг хэдэн зуун сая төгрөгийн үнэтэй болголоо. Эцэс сүүлдээ парламентын гишүүнээр сонгох, сонгогдох эрх ард түмнээс бүрэн хүнийсч, улс төрийн нам дахь хэдхэн хүний хувийн өмч болон хувирч, социализмын үеийн тулгалтын, дайчилгааны сонгуульд бараг шилжлээ.

1. Олигархижсан засаглалын төлөв байдал, үр нөлөө

Засаг барьсан шилжилтийн орны супер парламент гишүүдийнхээ гарын тоогоор төрийн санд дэгээ оруулж, тойргийн тоогоор тал тал тийш нь хөрөнгө чангааж байдаг учраас хязгаарлагдмал нөөцийг хамгийн үрэлгэн зараад зогсохгүй, мөнгө дагаж эрх хэмжээ нь ихэсч байдаг. Улсыг төлөөл, улсын эрх ашгийн илэрхийлэл бай гэж тэдэнд чөлөөт мандат олгосон юм. Гэтэл улсыг бус дараагийн сонгууль бодоод тойрог, тойрог руугаа хөрөнгө чангаагаад хомсхон нөөцийг үр ашиггүй зарцуулж байна.

Зөвхөн хууль тогтоож, ард түмнийг төлөөлдөг парламенттай болбол эл байдал зогсож, байгаа хөрөнгөө зөв зарцуулах эхлэл бий болж, улс хөгжих нөхцөл бүрэлдэнэ. Тэр үед парламентын гишүүн мөнгө тараах биш, харин Засгийн газар төсвийн хуулиар олгосон

UIT.MN
СУДАЛГААНЫСАН

эрхийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянаж суудаг субъект болно. Дарангуйлал гэхээр л фашизм, 37 оныг л санаад, барих, хорих, мөрдөн мөшгих, буудах, тамлах гэх мэтийг төсөөлөөд байх жишээтэй. Тэгээд манайд тийм зүйл алга учраас бүх зүйл сайн сайхан байна. Юуны чинь дарангуйлал юу яриад байна гэж зарим уурлаад байх маягтай. Орчин үед дарангуйлал ихээхэн “соёлжсон”. Өнгө зүс, арга, хэлбэрээ танигдахын аргагүй маш нарийн болгож өөрчилсөн.

Өөрсдөөр нь зөвшөөрүүлж, үйлдлээр нь дарангуйлдаг аргыг ч олжээ. Сонгуулийн аргаар гарч ирнэ. Гарч ирсэн хойноо ард түмэн гэж их ярина. Номхон зөөлөн дүртэй. Харин ард түмнийг хэрэг дээрээ сонсохгүй, тэднээс авсан мандатыг зөвхөн өөртөө, өөрсдийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхэд л ашиглах хэлбэрээр дарангуйлна. Өөрөөр хэлбэл, дарангуйллын “сонгодог” арга, хэлбэр өдгөө аль хэдийнэ моодноос гарсан гэсэн үг.

Түүнийг зөвшөөрдөг, тэвчдэг орон зай ч алга болсон байна. Тийм учраас дарангуйллыг харах, таних нь бас чухал. Дарангуйлуулж байгаагаа мэдэхгүй байх нь харамсалтай хэрэг болно. Дарангуйлалд дассан хүмүүс түүнийг анзаарахаа больчихсон байх нь олонтаа байдаг гэсэн. Тийм учраас юуг дарангуйлал гэж үзэхийг ард түмэнд ойлгуулах нь чухал байна. Олигархийн дарангуйлал гэдэг бол хэсэг бүлэг хүмүүс ард түмнээс тасарч, өөрсдийн эрх мэдлээ тогтоохыг хэлдэг. Засаг барьсан, намчирхсан, иргэний нийгмийн хяналтгүй, бүрэлдэхүүнд нь олигархиуд давамгайлсан хууль тогтоогчид буюу парламент олигархийн дарангуйллын гол субъект болдог.

Ардчиллын суурь үнэт зүйлс, иргэний нийгэм, зах зээлийн эдийн засгийн харилцаа хөгжөөгүй шилжилтийн улсад олигархийн дарангуйлал тогтоход төрийн удирдлагын парламентын хэлбэр хамгийн шимтэй хөрс суурь болдог. Түүн дээр манай өнөөгийн төрийн тэргүүний Засгийн газрыг байгуулах, хариуцлага тооцоход оролцдог бүрэн эрхийг намчирхсан парламентад, парламентын намуудад ямар нэг саад тотгоргүй, шууд шилжүүлсэн гажгийг, посткоммунист орны марксист сэтгэлгээний эмгэгийг нэмбэл бүүр ч лавширна.

Джефферсоноос Медисонд 1789 онд бичсэн нэгэн захидалдаа: “Манай төрийн байгуулалд миний санааг зовоож байгаа гол асуудал нь гүйцэтгэх эрх мэдэл огт биш ээ. Одоо төдийгүй цаашид ч олон жил байж болох хамгийн гол аюул бол хууль тогтоогчдын дарангуйлал юм. Гүйцэтгэх эрх мэдэл дарангуйлагч болж болох боловч тэр нь хожуу тохиолдоно” (Алексис де Токвиль. Демократия в Америке, М., 1992, с.203) гэж бичсэн байна.

Хэдэн зууны тэртээ засаг бариагүй зөвхөн хууль тогтоодог, төлөөлдөг парламентыг дарангуйлагч болчих аюулыг ийнхүү урьдчилан харж, мэдэрч, сэрэмжилж, олигархийн дарангуйллын гол субъектыг парламент болох хамгийн өндөр магадлалтайг тодруулсан байхад бид энэ тухай тухтай нэг ч бодоогүй, харин ч парламент бол ардчилал хөгжих гол институт, харин нэг хүний дарангуйлал хэцүү гэх ухааны юм яриад бид сууж байтал манай парламент аль хэдийнэ Джефферсоны айгаад, сэрэмжлүүлээд байсан тэр зүйлийн эзэн болжээ.

4. Олигархижсан засаглалыг хязгаарлах арга зам

- Харилцан тэнцвэртэй бие биендээ хяналт тавих бүрэн боломжтой төрийн тогтолцоог бүрдүүлэх: Аль нэг субьектэд хэт их эрх мэдэл төвлөрөхөөс болгоомжлох, засгийн эрх мэдлийг баригч субьектууд өөр хоорондоо хяналт тавих боломжтой тогтолцоог бүрдүүлэх. Энэхүү бодлогыг дийлэнх улсууд баримталдаг бөгөөд учир нь нийгмийн аливаа нэг гишүүнийг хөрөнгө чинээ, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхалгүйгээр хууль бус үйлдэл хийхээс сэргийлэх боломжтой гэж үздэг байна. Судалгааны хавсралт хэсэгт улс орнуудын энэ талаарх жишээг харуулав.

- Хууль бүх нийтэд тэгш үйлчлэх: Шашин шүтлэг, өмч хөрөнгө, эрх мэдэл зэргээс үл хамааран хуулийн өмнө бүх нийт тэгш байх. Хуулийн ноёрхоллыг тогтоож хараат бус шүүх, хараат бус шүүгчтэй байх

- Сонгуулийн хуулийг боловсронгуй болгох: Сонгогдогчийн талаар үнэн зөв мэдээлэл өгөх, хээл хахууль, авилгал, санал худалдаж авах зэргийг таслан зогсоох.

Эдгээр үндсэн арга замуудаас гадна зарим улсууд дараах байдлаар хязгаарлах бодлого баримталж байна.

Япон улсын хувьд энэ талаар баримталж буй гол бодлого нь Улс төрийн намуудын санхүүжилтийн эх үүсвэрийг нээлттэй болгох. Энэ бол олигархийг хязгаарлах гол арга замийн нэгд тооцогдоно. Тухайлбал, 1948 онд батлагдаж, 1994 онд шинэчилсэн “Улс төрийн санхүүжилтыг хянах тухай хууль” (Political Funds Control Law of Japan), 1995 онд батлагдсан “Намын татаасын тухай хууль эсхүл Намыг төрөөс санхүүжүүлэх тухай хууль” (Political Party Subsidy Law of Japan), Сонгуулийн байгууллагын тухай хууль (Public Office Election Law of Japan) улс төрийн нам, сонгуулийн санхүүжилт, төрөөс өгөх санхүүжилтыг зохицуулсан байна.[73]

Улс төрийн санхүүжилтыг хянах тухай хуулийн гол зорилго нь сонгуульд нэр дэвшигчид, намууд, улс төрийн холбоодуудад өгч буй гишүүдийн татвар, хандивлагчдын хандив, сонгуулийн зардлыг хянаад чиглэгдэнэ. Жишээ нь намд хувь хүнээс жилд өгөх хандивийн хэмжээ 2 сая иен, улс төрийн холбоо, компанийн жилд өгөх хандивын дээд хэмжээ 30 сая хүртэл иен байна. Хэрэв уг хуулийн заалтыг зөрчин улс төрчид хуулиас гадуур хандив авах, орлого олбол 5 жил хүртэл хорих ял эсхүл 1 сая хүртэл иен торгууль оногдуулна. Уг хуулийн 5 дугаар бүлэг 21.3 дахь заалт.

Намын татаасын тухай хууль эсхүл Намыг төрөөс санхүүжүүлэх тухай хуулийн гол зорилго нь төрийн татаасыг нэмэгдүүлэх, бизнесийн улс төр дэх нөлөөг хязгаарлах, олигархийг хязгаарлах, улс төрчид рүү чиглэсэн хандив урсгалыг багасгахад чиглэгдэнэ. Ингэхдээ Парламентад (国会 Kokkai) 5 -аас доошгүй суудал авсан байх бөгөөд иргэн бүрээс 250 иен байхаар бодож олгоно.

Сонгуулийн байгууллагын тухай хуулийн зорилого нь нам, нэр дэвшигчийн сонгуулийн компанийн санхүүжилтын орлого, зарлагыг хянах тэдгээрийн хязгаарлалтыг тогтооход оршино. Төлөөлөгчдийн танхимын сонгуульд нэр дэвшигч бүр тухайн нэр дэвшиж буй сонгуулийн тойрогт бүртгэлтэй сонгогч бүрийг 15 иенээр бодож дээр нь 19 сая 100 мянга хүртэл иенийн зардал гаргах, харин Зөвлөхүүдийн танхимын сонгуульд нэр дэвшигч бүр 52 сая иен хүртэл зардал гаргахыг уг хуулиар хүлээн зөвшөөрдөг байна.

Оросын Холбооны Улсын төрийн албанд ашиг сонирхлыг зөрчилдөөнтэй холбоотой харилцааг 2004 онд батлагдсан “Оросын Холбооны Улсын төрийн албаны тухай”[74] хуулийн 19-р зүйлээр Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахаар заасан. Тус хуулийн 19.1-д зааснаар төрийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, төрийн албан тушаалтны хувийн болон бусдын хуулийн ашиг сонирхол хоорондоо харшилдаж байгаа, эсхүл харшилдаж болох, хуулийн ашиг сонирхолд хохирол учруулах болзошгүй нөхцөл байдлыг ашиг сонирхлыг зөрчил хэмээн заажээ.

Төрийн албанд ашиг сонирхлын зөрчлийг тухайн байгууллагын удирдлага болон тусгайлан

[73] http://202.180.216.26/modules.php?name=News&file=article&sid=1184275

[74] Н. Лүндэндорж. Өдрийн сонин 2007/01/08/ “Олигархийн дарангуйлалаас ардчилалд хүрэх зам”

энэ төрлийн асуудлыг зохицуулахаар байгуулагдсан хороо зохицуулна. Зохицуулах хорооны харилцааг ОХУ -ын Ерөнхийлөгчийн 2007 оны “ОХУ-ын төрийн албан тушаалтны албаны зан байдалд тавигдах шаардлагыг хянах болон ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хорооны тухай”[75] зарлигаар зохицуулна. Төрийн албан тушаалтан үндсэн үүрэг бол хэрэв хувийн ашиг сонирхол нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болхоор байвал удирдах албан тушаалтандаа бичгээр заавал мэдэгдэх ёстой.

Харин удирдах тушаалтан ашиг сонирхлын зөрчлийг зогсоох, эсхүл зохицуулах арга хэмжээ авна. Хэрвээ тухайн этгээд удирдах тушаалтаны гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа бол Төрийн албан тушаалтны албаны зан байдалд тавигдах шаардлагыг хянах болон ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хороогоор хянуулна. Хорооны бүрэлдэхүүнд удирдах албан тушаалтан болон /эсхүл/ түүний үүрэг гүйцэтгэгч, хэлтэс албадын дарга нараас гадна эрдэм шинжилгээний, боловсролын болон бусад салбарын төлөөлөл бие даасан экспектын хувьд орно.

“Оросын Холбооны Улсын төрийн албаны тухай” хуулийн 16.1 -д төрийн албанд орж болохгүй, төрийн албан тушаалтан нь төрийн албанд байж болохгүй нийт 9 хориглосон нөхцөлийг заасан байна. Тэдгээрийн нэг нь хэрэв албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл эсхүл садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол иргэнийг төрийн албан тушаалд авч ажиллуулахыг хориглосон нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 16.2.3 -т заасантай адил байна.

Хавсралт 1.

НЭГ ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТТАЙ УЛСУУД

	Улсын нэр	Хууль, тогтоолыг батлах журам	Хяналт тавих субьект
		Парламентад 2 субъект хяналт тавина.	
1.	Вануату	Хуулийн төслийг парламент баталж Ерөнхийлөгч 14 хоногийн дотор батламжилна. Хэрэв тухайн хууль Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл Ерөнхийлөгч Дээд шүүхэд хандах ба Дээд шүүх үндэслэлтэй гэж үзвэл хууль нийтлэгдэхгүй.	Ерөнхийлөгч, Дээд шүүх
2.	Кирибати	Хуулийн төслийн 2 удаагийн хэлэлцүүлгээр ердийн олонхийн саналаар хууль баталж, Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Хэрэв Ерөнхийлөгч хориг тавибал парламент дахин хэлэлцэж шийдвэрлэнэ. Ерөнхийлөгч уг хуулийн төслийг хүлээн зөвшөөрөхгүй бол тухайн хууль Үндсэн хуультай хэрхэн нийцэж байгааг хянуулахаар Дээд шүүхэд мэдүүлнэ. Хэрэв Дээд шүүхээс Үндсэн хуульд нийцэж байгаа тухай шийдвэр гаргавал Ерөнхийлөгч уг хуулийг батламжилна. Үндсэн хуультай эс нийцсэн тохиолдолд парламент дахин хэлэлцэнэ.	Ерөнхийлөгч, Дээд шүүх
3.	Кот-д’Ивуар	Хуулийн төслийг гишүүдийн олонхи нь оролцож, олонхийн саналаар төслийг батална. Органик хуулийн төслийг парламент 2/3-ын саналаар батлах бөгөөд Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийг зөрчөөгүй гэсэн дүгнэлт гарсны дараа хүчин төгөлдөр болно. Үндсэн хуулийн шүүх болон парламенттай урьчилан зөвшилцөж гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон ерөнхийлөгчийн зарлигийг батламжилна.	Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүх
4.	Мали	Өргөн баригдсан хуулийн төслийг жилд 2 удаа болдог ээлжит чуулган, Ерөнхий сайд, гишүүдийн олонхийн хүсэлтээр хийдэг ээлжит бус чуулган, Ерөнхийлөгчийн зарлигаар хийдэг тусгай чуулганы хуралдаанаар хэлэлцэж, олонхийн саналаар батална. Парламентаар хэлэлцэж баталсан органик хууль Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуульд харшлаагүй гэсэн дүгнэлт гарсны дараа хүчин төгөлдөр болно. Улсын төсвийн тухай хуулийг жил бүр 3 сарын туршид хянан хэлэлцэх, засаг захиргааний бүх түвшинд аудитын шалгалт оруулах зэрэг хэлбэрийг ашигладаг.	Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн шүүх
		Парламентад 1 субъект хяналт тавина.	
5.	Бангладеш	Хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэж батална. Парламентаар баталсан хуулийг Ерөнхийлөгч соёрхон батална.	Ерөнхийлөгч
6.	Замби	Парламент хуулийн төсөлд 3 удаагийн хэлэлцүүлэг хийж, олонхийн саналаар баталсны дараа Ерөнхийлөгчид батламжлуулахаар шилжүүлнэ. Ерөнхийлөгч Үндэсний ассамблейн баталсан хуулийг батламжлах эсвэл бүхэлд нь буюу зарим зүйл заалтад нь хориг тавих шийдвэр гаргана. Ерөнхийлөгч хориг тавьж буцаасан төслийг парламент хэлэлцэн хүлээж авсан бол Ерөнхийлөгч батламжлах ба хүлээж аваагүй бол 21 хоногийн дотор хуулийг батламжлах эсвэл Парламентыг тараах шийдвэр гаргана.	Ерөнхийлөгч
7.	Кувейт	Хуулийн төслийг Үндэсний Ассамблейгаар баталж, Эмир соёрхон батална. Гишүүд хууль санаачлах эрхтэй бөгөөд хуулийн төсөл Үндэсний Ассамблейгаас буцаагдсан тохиолдолд түүнийг Үндэсний Ассамблейн уг чуулганаар дахин хэлэлцдэггүй.	Эмир
8.	Люксенбург	Нийт гишүүдийн олонхийн саналаар хуулийн төслийг батлах журамтай. Төрийн зөвлөл парламентад зөвлөх үүрэгтэй ажиллах бөгөөд төслийн талаар парламент төрийн зөвлөлийн санал зөрвөл 3 сарын дараа дахин санал хураалтад оруулах журамтай.	Төрийн зөвлөл
9.	Маршаллын арлууд	Парламент хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлгээр батална. Хэрэв парламент шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийг 2 удаа баталж чадаагүй болон Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа 30 хоногийн дотор Засгийн газрын танхимыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч парламентыг тараах эрхтэй.	Ерөнхийлөгч
10.	Микронезийн улсууд	Конгресс баталсан хуулиа Ерөнхийлөгчид өргөн мэдлүүлнэ. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор уг хуулийг батламжилах ба эсхүл буцаана. Заасан хугацаанд Ерөнхийлөгч хуулийг буцаагаагүй тохиолдолд Конгрессын баталсан хууль хүчин төгөлдөр болно.	Ерөнхийлөгч
11.	Мозамбик	Өргөн барьсан төслийг эхлээд Парламентын байнгын хороо, холбогдох байнгын комиссын хурлаар хэлэлцсэний дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж олонхийн саналаар батална. Парламентын нэгдсэн хуралдаан гишүүдийн олонхи нь оролцсоноор хүчин төгөлдөр байна. Парламентын нэгдсэн хуралдаанаар Ерөнхийлөгч, Парламентын байнгын комисс, Засгийн газар төслийг хэлэлцүүлдэг байна.	Ерөнхийлөгч
12.	Самоа	Хуулийн төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар батална. Хуулийн төслийг парламентаар баталсаны дараа төрийн тэргүүнд өргөмжилнө. Төрийн тэргүүн уг хуулийг батламжилснаар хууль хүчин төгөлдөр болно.	Төрийн тэргүүн
13.	Сингапур	Хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлэг хийж олонхийн саналаар баталдаг. Парламентын баталсан хуулийг Ерөнхийлөгч сайшаасны дараа хүчин төгөлдөр мөрдөнө. Ерөнхийлөгчид хууль шилжүүлсний дараа Ерөнхийлөгчийн дэргэдэх Үндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалах зөвлөл авч хэлэлцэн шийвэр гаргасныг үндэслэн Ерөнхийлөгч хуулийг сайшаах, үл сайшаах шийдвэрийг гаргана.	Ерөнхийлөгч

[75] Япон Улсын Үндсэн хууль. Орчуулсан П.Амаржаргал (2011) х 4

14.	Сьерра-Леоне	Үндсэн хуульд харшлаагүй улс орны хэмжээний ямар ч асуудлаар өргөн баригдсан төслийг анхны хэлэлцүүлгийн дараа хэвлэлд нийтлүүлж байх журамтай бөгөөд хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд 2-3 удаагийн хэлэлцүүлэгт оруулан хэлэлцэж батлах журамтай. Нэгдсэн хуралдаанд гишүүдийн ирц j-ээс дээш ирсэн байвал асуудлыг хэлэлцэж эхлэх бөгөөд гишүүдийн олонхийн саналаар батлагдсанд тооцдог байна. Парламент хэлэлцэж баталсан төслийг ерөнхийлөгч батламжилсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Хуулийг Ерөнхийлөгч дахин хэлэлцүүлэхээр буцаасан тохиолдолд парламентын гишүүдийн 2/3-ын саналаар батлагдвал хууль шууд хүчин төгөлдөр болно.	Ерөнхийлөгч
15.	Швед	Хуулийн төслийг парламентын нэгдсэн хуралдаанаар 2 удаагийн хэлэлцүүлэг хийж батлах журамтай. Хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийн дараа Үндсэн хуулийн хорооноос төсөл Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаархи дүгнэлтийг танилцуулна. Хэрэв Үндсэн хуульд харшилж байвал төслийг Үндсэн хуулийн байнгын хороонд буцаана.	Үндсэн хуулийн шүүх тавина.
16.	Шинэ Зеланд	Хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэж батална. Төлөөлөгчдийн танхимын баталсан хуулийг Хатан хаан болон түүний өргөмжит Амбан захирагч баталснаар хууль хүчин төгөлдөр болно.	Хатан хаан, өргөмжит Амбан захирагч
17.	Экваторын Гвиней улс	Парламентын баталсан хуулийг Ерөнхийлөгч батламжилснаар хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгч хуулийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь дахин 2,3 дугаар хэлэлцүүлэг хийлгэхээр буцааж болно.	Ерөнхийлөгч
		Хуулийн төслийг Парламент дангаараа батлана.	
18.	Болгар	Хэрэв өөр өөр өдөр болсон нийт 3 удаагийн санал хураалтаар бүх ардын төлөөлөгчдийн 3/4-с доошгүй нь дэмжсэн санал өгвөл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. Нэмэлт, өөрчлөлт оруулах санал нь ардын төлөөлөгчдийн 3/4 санал аваагүй боловч түүний төлөө 2 сараас доошгүй, 5 сараас дээшгүй хугацаанд ардын төлөөлөгчдийн дийлэнх олонх нь дахин санал өгвөл хүчин төгөлдөрт тооцогддог.	
19.	Грек	Хуулийн төслийг эхний хэлэлцүүлгээр зүйлчлэн хэлэлцэх ба 2 дахь хэлэлцүүлгээр зарчмын саналаар санал нэг бүрчлэн хурааж, төслийг бүхэлд нь баталдаг. Хуралдааны ирц бүх гишүүдийн 1/4-ээс дээш байх бөгөөд төслийг олонхийн саналаар батлах журамтай.	
20.	Гүрж	Хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлгээр оруулж батлана. Хууль нь батлагдсанаас хойш 15 хоногийн дараа “Парламентын тайлан “ сэтгүүлд хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.	
21.	Дани	Парламент хуулийн төслөөр 3 хэлэлцүүлэг хийх журамтай. Хуралдаан 2/5-ийн ирцтэй бол хүчин төгөлдөр байна. Парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахад хэлэлцэгдээгүй үлдсэн төслийг хууль санаачлагчид татан авах журамтай.	
22.	Израиль	Хуулийн төслийг 3 үе шаттай хэлэлцэн батална. Эхний хэлэлцүүлгээр хуулийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэн холбогдох Байнгын хороонд шилжүүлдэг. 2 дахь шатанд Байнгын хороогоор хэлэлцсэн хуулийн төслийг зүйл дараалан хэлэлцэж санал хураадаг. 3 дахь хэлэлцүүлгээр хуулийн төслийг уншин санал хурааж баталдаг.	
23.	Индонези	Хуулийн төслийг Төлөөлөгчдийн зөвлөл хоёр үе шаттай хэлэлцдэг. 1-р үе шат нь Хорооны үе шат буюу Байнгын болон түр хороо Засгийн газартай хамтран хэлэлцдэг бол 2-р үе шатанд төслийг бүхэлд нь хэлэлцэн баталдаг. Энэ хоёр үе шатнаас өмнө парламент дахь фракцууд хуулийн төслийг хэлэлцдэг байна.	
24.	Ирак	Хуулийн төслүүдийг хэлэлцэж, гишүүдийн олонхи оролцсон санал хураалтаар олонхийн саналаар батлагддаг.	
25.	Иран	Хуулийн төслийг Засгийн газрын хамтын саналаар, парламентын 15-аас доошгүй гишүүн хамтран хуулийн төсөл санаачилж Исламын Зөвлөх Хуралд өргөн барина. Үндсэн хуульд зааснаар хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж болохгүй ч онцгой нөхцөлд тодорхой хязгаартайгаар дотоод комисс хууль гаргах бүрэн эрхтэй гэж заасан байна.	

26.	Кабо-Верде	Засгийн газрын илтгэл мэдээллийг сонсох, парламентын гишүүд, бүлэг, Засгийн газрын боловсруулсан улсын төсвийн зардлыг өсгөх, орлогыг бууруулах асуудал болон хуулийн төслөөр, 10 мянгаас доошгүй иргэдийн шууд санаачлагаар ард нийтийн санал асуулга явуулах асуудлыг хэлэлцэж, парламентын гишүүдийн олонхи нь хуралд оролцсон тохиолдолд 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.	
27.	Киргизстан	Хууль, бусад шийдвэрийг хуралдаанд оролцогчдын олонхиор батлах боловч дэмжсэн гишүүдийн тоо 50-аас бага байж болохгүй. Үндсэн хууль болон үндсэн хуулийн байгууллын тухай хуулиуд, улсын хилийг өөрчлөх тухай хуулийг гурваас доошгүй удаа хэлэлцэж, 2/3 доошгүйн саналаар батлах буюу нэмэлт, өөрчлөлт оруулна.	
28.	Кипр	Хуулийн төслийг эхлээд байнгын хороонд шилжүүлж хэлэлцүүлэн холбогдох дүгнэлт гарсны дараа нэгдсэн хуралдаанаар гишүүдийн 1/3-ийн оролцсоноор хэлэлцүүлэг хийж, хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх журамтай.	
29.	Литва	Сейм хууль болон бусад шийдвэрийг хуралдаанд оролцогчдын ердийн олонхиор батлах бөгөөд нийт гишүүдийн талаас илүү нь ирснээр хуралдаан хүчин төгөлдөр болно.	
30.	Лихтенштейний Вант улс	Парламентын шийдвэр хуралд оролцсон гишүүдийн 2/3-с доошгүйн саналаар хүчин төгөлдөр болох бөгөөд гишүүдийн олонхийн саналаар батлагдах ёстой. Дэмжсэн болон эсэргүүцсэн санал тэнцсэн тохиолдолд парламентын тэргүүний саналаар, сонгуулийн асуудлаар бол санал хураалтын 3 дахь үеийн дараа шийдвэрлэгдэнэ.	
31.	Македон	Хурал нийт гишүүдийн талаас илүү нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэрийг хуралдаанд орлцогчдын ердийн олонхиор батлана. Гэвч эдгээр дэмжигчдийн тоо нь нийт депутатын 2/3-с бага байж болохгүй. Хуулийг 3 удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэж батлана. Хууль батлагдсанаас хойш 7 хоногийн дараа “БН Македон Улсын албан мэдээ” сэтгүүлд хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.	
32.	Мальдив	Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг Үндсэн хуульд заасны дагуу, бусад хууль тогтоомж, тэдгээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг Исламын номлолд нийцүүлэн батлах үүрэгтэй. Парламентын нэгдсэн хуралдааны ирц 25 хувь байна.	
33.	Мальт	Парламент хуулийн төслийг танхимын бүх гишүүдийн 2/3-с доошгүй хувь нь дэмжсэнээр батална. Төлөөлөгчдийн танхимын хурлын ирц 15 гишүүнээс бүрдэх бөгөөд хуралдааны даргалагч хурлын ирцэнд хамаарахгүй.	
34.	Португал	Хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар 2 удаагийн хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлэг тус бүрээр санал хурааж Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн олонхийн саналаар батлана.	
35.	Турк	Хуулийн санаачлах эрх Засгийн газар болон парламентын гишүүдэд хадгалагдах бөгөөд хуулийн төслийг эхлээд мэргэшсэн хороо судлан тайлангаа гаргаад парламентын чуулганаар хуулийн төслийг бүхэлд нь хэлэлцдэг. Чуулганаар бүхэлд нь хэлэлцсэний дараа асуулт, хариулт явуулах ба дараа нь зүйл бүрчлэн хэлэлцэхээр санал хураана. Түүний дараа дахин хуулийн төслөөр бүхэлд нь санал хураана.	
36.	Хойд Солонгос	Засгийн газрын өргөн барих хуулийн төслийг эхлээд Төрийн зөвлөл шүүн хэлэлцдэг. Үндэсний Ассамблейн баталсан хуулийн төслийг Засгийн газарт хүргүүлж, Ерөнхийлөгч уг хуулийг 15 хоногийн дотор зарлан тунхаглана.	

ШУА.MN
СУДАЛГААНЫ САН

37.	Хятад	БХАТИХ нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн биелэлтэнд хяналт тавих, эрүү, иргэн, төрийн төв байгууллагын тухай болон бусад шаардлагатай хууль дүрмийг батлах, Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг сонгох, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд, түүний орлогчид сайд нар, Ерөнхий хянан шалгагч, Төрийн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргыг томилохоор Улсын дарга, Ерөнхий сайдын оруулсан саналыг шийдвэрлэх, Цэргийн төв комисс, болон бусад төв комиссын даргыг сонгох талаар Улсын даргын оруулсан саналыг зөвшөөрөх, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурорыг сонгох, улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, улсын төсөв, гүйцэтгэлийн тайланг батлах, Байнгын хорооноос баталсан шаардлагагүй гэж үзсэн эрхийн актуудыг хүчингүй болгох, төв Засгийн газар шууд хамаарах муж, өөртөө засах эрх бүхий тойрог, хошуу, онцгой эрх бүхий мужийг батлах, дайн ба энхийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийг бүх депутатуудын 2/3-оос дээшхийн саналаар, бусад асуудлыг депутатуудын олонхи нь оролцсон хуралдаанаар олонхийн саналаар батлалдаг.	
38	Сейшелийн арлууд	Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар, Үндэсний ассамблейн гишүүдийн санаачилсан хуулийн төслийг хэлэлцэж батлахаас хэлэлцүүлэгт гишүүдийн олонхи нь оролцох бөгөөд Үндсэн хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд санал хураалтад оролцсон гишүүдийн олонхийн саналаар төслийг батлагдсанд тооцох журамтай.	
39.	Уганда	Парламент нэгдсэн хуралдаанаар Засгийн газраар хэлэлцүүлж, байнгын хорооноос дүгнэлт гаргасан төслийг хэлэлцэж батална. Парламентын хуралдаанд гишүүдийн 1/3 нь ирсэн бол төслийн хэлэлцүүлэг эхлэх бөгөөд санал хураалтаад хэлэлцэж буй асуудлын онцлогоос хамаарч гишүүдийн олонх (2/3, 3/4 гм өөр өөр)-ийн саналаар баталдаг.	
40.	Финланд	Хуулийн төслийг 2 удваагийн хэлэлцүүлэгт оруулж, олонхийн саналаар баталдаг.	
41.	Эритрей	Хууль тогтох чиг үүргээ жил бүр хуралддаг ээлжит чуулган, Ерөнхийлөгч, Парламентын дарга, парламентын гишүүдийн 1/3-ийн саналаар хуралддаг онцгой чуулганы хуралдаанаар өргөн баригдсан төслийг хэлэлцэнэ. Парламентын гишүүдийн олонхи нь оролцсон хуралдаанаар энэхүү хэлэлцүүлгийг хийх бөгөөд Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батлах журамтай.	

* * *

Хавсралт 2.

ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТТАЙ УЛСУУД

№	Улсын нэр	Хууль, тогтоолыг батлах журам	Хяналт тавих субьект
		Ерөнхийлөгч эсхүл Хаан, Парламентын дээд болон доод танхим	
1.	Беларус	Хуулийн төслийг Төлөөлөгчийн танхим, дараа нь Төрийн зөвлөл хэлэлцэх бөгөөд нийт гишүүдийн олонхийн саналаар батлана. Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн олонхийн саналаар батлаж, Төрийн зөвлөлийн олонхи сайшааснаар хууль хүчин төгөлдөр болно. Төрийн зөвлөл хуулийг буцаавал танхимуудын төлөөллөөс бүрдсэн зөвшилцөх комисс хуулийн төслийг дахин боловсруулж хоёр танхимд хүргүүлнэ. Уг төслийг Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн 2/3-оос доошгүй нь дэмжвэл хууль батлагдсанд тооцно. Ингэж батласан болон ердийн журмаар буюу Төлөөлөгчдийн танхимын батлаж, Төрийн зөвлөлийн сайшаасан хуулийг 10 хоногийн дотор Ерөнхийлөгчид гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.	Ерөнхийлөгч Төрийн зөвлөл Төлөөлөгчдийн танхим

2.	Бельги	Бельги улсын Хаан, Төлөөлөгчдийн танхим, Сенат нь тус бүрдээ хууль тогтоох эрх мэдэлтэй. Ингэхдээ хуулийн төслөөс хамаарч дараах дараалаар хэлэлцэнэ: Хааны санаачилсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим хэлэлцээд Сенат руу шилжүүлнэ. Хааны санаачилсан хуулийн төсөл нь олон улсын гэрээтэй холбоотой бол Сенат хэлэлцээд Төлөөлөгчдийн танхим руу шилжүүлнэ. Хуульд заасан зарим тохиолдолд Сенат, Төлөөлөгчидийн танхим хоёр адил тэгш эрхтэй байна. Хуулийн төслийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор 15-аас доошгүй Сенатын гишүүний шаардсанаар. Сенат 60 хоногийн дотор шалгаад хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахгүй тухай, эсхүл хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа батлах тухай гэсэн хоёр шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэрэв Сенат заасан хугацаанд уг хуулийн төсөлд саналаа илэрхийлээгүй, эсхүл Төлөөлөгчдийн танхимын гаргасан шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахгүй тухай шийдвэр гаргасан бол уг хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим Хаанд өргөн барина. Хэрэв Сенат уг хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийн зарим хэсгийг болон бүхэлд нь эсэргүүцэх тухай, эсхүл батлах тухай аль нэг шийдвэрийг гаргуулахаар Төлөөлөгчдийн танхим руу буцаана. Сенатаас нэмэлт өөрчлөлт орж буцаагдсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим дахин хэлэлцэж, нэмэлт өөрчлөлт оруулаад эргүүлээд Сенат руу шилжүүлнэ. Сенат үүнийг хүлээж аваад 50 хоногийн дотор Төлөөлөгчдийн танхимын оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай, эсхүл дахин нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн төслийг батлах тухай шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэрэв Сенат заасан хугацаанд уг хуулийн төслийн талаархи саналаа илэрхийлээгүй, эсхүл Төлөөлөгчдийн танхимын оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн бол Төлөөлөгчдийн танхим уг хуулийн төслийг Хаанд өргөн барина.	Хаан Дээд танхим – Сенат Доод танхим – Төлөөлөгчдийн танхим
3.	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	Хуулийн төслийг парламентын аль ч танхимд өргөн барьж болох боловч практик дээр хуулийн төслийг эхлээд Нийтийн танхимд 3 удаа хэлэлцсэний эцэст баталсан тохиолдолд Лордуудын танхимд хэлэлцүүлэхээр шилжүүлдэг. Аливаа хуулийн төсөл нь парламентын хоёр танхимаар хоёуланг аар нь батлагдах ёстой ба хаан буюу хатан хаан зөвшөөрсний дараа хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг хийхэд танхимын 40-өөс доошгүй гишүүн оролцох ёстой, харин хуулийн төслийг танхимын гишүүдийн олонхийн саналаар баталдаг. Хуулийн төсөл батлагдсаны дараа түүнийг Лордуудын танхимд шилжүүлдэг ба тэнд мөн л ийм журмаар хуулийн төслийг хэлэлцэж батална. Гэхдээ Лордуудын танхимын хууль тогтоох эрх мэдэл нь Нийтийн танхимаас нэлээд хязгаарлагдмал ба энэхүү хязгаарлалтыг 1911 оны Парламентын тухай хуулиар тогтоожээ.	Хаан буюу хатан хаан Дээд танхим буюу Лордуудын танхим Доод танхим буюу Нийтийн танхим
4.	Итали	Хууль нь батлагдсанаас хойш сарын дотор Ерөнхийлөгч ёсчилоны дараа хуулийг зарлана. Хэрвээ хоёр танхимын гишүүдийн туйлийн олонхи нь хуулийг яаралтай тунхаглах ёстой гэж үзвэл хуульд тунхаглагдах эцсийн хугацааг зааж өгнө. Хуулийн хүчин төгөлдөр болсны дараа нэн даруй нийтлэх ёстой бөгөөд хэрвээ хуульд өөрт нь хүчин төгөлдөр болох хугацааг зааж өгөөгүй бол тус хууль нийтлэгдсэнээр хүчин төгөлдөр болно. Засгийн газар нь зөвхөн хязгаартай хугацаанд буюу тусгай зорилгоор хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тусгай асуудлаар аль нэг танхим хуралдаж байх үед нөгөө танхим нь тухайн асуудлыг авч хэлэлцэнэ. Тусгай асуудлаар хуралдахдаа Ерөнхийлөгч, парламентын дарга болон парламентын гишүүний санаачлагаар хуралдана.	Ерөнхийлөгч Дээд танхим буюу Сенат Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим

ШИНЭЧЛЭХ УХААНЫ СЭДВЭГТЭНЦЭР САН

5.	Бүгд Найрамдах Ирланд	Хууль тогтоомжийн өргөн баригдсан төслийг хүлээн авсан танхим нь нэгдсэн хуралдаанаар эхлэн хэлэлцэж, нөгөө танхимдаа шилжүүлэн, 2 танхим дараалан хэлэлцэх журамтай. Төслийг хэлэлцсэн сүүлчийн танхим төсөлд ямар нэг өөрчлөлт оруулбал, түүнийг доод танхим эцэслэн батлана. Парламентын 2 танхим дараалан хэлэлцэж баталсан хуулийг Ерөнхийлөгчид үзэглэж, тунхаглан зарлуулахаар шилжүүлнэ.	Ерөнхийлөгч Дээд танхим буюу Сенат Доод танхим буюу Төлөөлөгчдийн танхим
6.	Испани	Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өргөн баригдсан төслийг Төлөөлөгчдийн конгресс гишүүдийн олонхи нь оролцсон хурлаар Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол олонхийн саналаар баталж, Сенатад шилжүүлнэ. Сенат энэхүү төслийг хэлэлцэж олонхийн саналаар батлах, эсхүл хориг тавина. Төлөөлөгчдийн танхим баталсан хуулийг Эзэн хаанд батламжлуулахаар шилжүүлнэ. Хуулийн төслийн талаар 2 танхим саналын зөрүүтэй асуудлаар нэгдсэн хороо байгуулан ажиллаж, нэгдсэн саналд хүрэхийг эрмэлзэх бөгөөд хориг тавьсан хуулийн төслийг сарын дотор дахин хэлэлцэж, хоригийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүлээн авах эсхүл хоригийг нийт гишүүдийн олонхийн саналаар хүлээн авахгүй байх шийдвэр гаргана.	Эзэн хаан Дээд танхим буюу Сенат Доод танхим буюу Төлөөлөгчдийн Конгресс
7.	Зимбабве	Парламентын доод танхим хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хууль, тогтоомжийн төслийг хэлэлцэж, олонхийн саналаар батлан Сенатад шилжүүлэнэ. Доод танхим батлагдсан хуулийг Ерөнхийлөгчид батламжлуулахаар шилжүүлнэ. Ерөнхийлөгчөөс уг хуулийн төслийг батламжлахгүй буцаасан тохиолдолд төслийг 6 сарын дотор дахин хэлэлцэж батлан Ерөнхийлөгчид батламжлуулахаар дахин хүргүүлнэ. Парламент баталж, Ерөнхийлөгч батламжилсан хуулийг бүх нийтээр мөрдүүлэхээр нийтлүүлнэ.	Ерөнхийлөгч Доод танхим буюу Хурлын танхим Дээд танхим буюу Сенатын танхим
8.	Намиби	Парламентын доод танхим аливаа асуудлыг хэлэлцэхэд 37 ба түүнээс дээш гишүүн /нийт 72 гишүүн/ оролцох бөгөөд олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Доод танхим хэлэлцэж баталсан хуулийн төслийг дээд танхимын даргад шилжүүлнэ. Дээд танхимаар хэлэлцэж, хуулийн төслийг зөвшөөрсөн бол батлагдсан хуулийг Ерөнхийлөгчид зөвшөөрөл авахаар хүргүүлнэ. Дээд танхимаар хэлэлцсэн төслөөр саналын зөрүү гарвал доод танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаана. Дээд танхимаас ирүүлсэн саналыг доод танхимаар хэлэлцэж, баталсан төслийн хувилбарыг дахин дээд танхимд хүргүүлэх шаардлагагүй бөгөөд хууль батлагдсанд тооцож Ерөнхийлөгчид зөвшөөрөл авахаар хүргүүлнэ. Хэрэв Дээд танхимын бүх гишүүдийн 2/3-ын саналаар оруулсан өөрчлөлтийг доод танхимаар хэлэлцүүлэхээр буцаасан бол доод танхим хэлэлцэж гишүүдийн 2/3-ын саналаар баталсан төсөл хүчин төгөлдөр болох ба 2/3-оос доош санал авсан бол энэ төслийг үргэлжлүүлэн хэлэлцэхгүйгээр хууль санаачлагчид буцаана. Парламентын дээд танхим доод танхимаар хэлэлцэн баталж шилжүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхээс гадна бүс нутгийн асуудлаархи хуулийн төслийг доод танхимд санал болгох, Парламентын доод танхимтай санал нийлээгүй асуудлыг 2/3-оос дээшхийн саналаар баталж, энэ тухай илтгэлдээ оруулна. Доод танхим энэ асуудлыг дахин хэлэлцэж 2/3-оос дээшхийн саналаар зөвшөөрвөл уг асуудал дээд танхимын саналаар шийдвэрлэгдсэнд тооцно.	Ерөнхийлөгч Доод танхим - Үндэсний ассамблей Дээд танхим - Үндэстний зөвлөл

9.	Оросын Холбооны Улс	Холбооны хуулиудыг Төрийн Дум батлаж Холбооны Хурлаар хэлэлцүүлэхээр тав хоногийн хугацаанд шилжүүлнэ. Хэрэв Холбооны Хурлын танхимын нийт гишүүдийн талаас илүү нь дэмжсэн буюу 14 хоногийн дотор Холбооны Хурлаар хэлэлцэгдээгүй бол холбооны хууль Холбооны Хурлаар зөвшөөрөгдсөнд тооцогдоно. Харин холбооны хуулийг Холбооны Хурлын танхим буцаасан тохиолдолд үүссэн санал зөрөлдөөнийг арилгахын тулд зохицуулах комиссыг байгуулж ажиллуулсны дараа холбооны хуулийг Төрийн Думаар дахин хэлэлцүүлж болно. Холбооны Хурлын шийдвэртэй Төрийн Дум санал нийлээгүй бол дахин санал хураалтын үед Төрийн Думын нийт депутатуудын 2/3-оос цөөнгүй нь холбооны хуулийг дэмжсэн бол түүнийг батлагдсанд тооцно. Батлагдсан хуулийг 5 хоногийн хугацаанд Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Ерөнхийлөгч хуулийг зөвшөөрсөн тохиолдолд 14 хоногийн дотор баталж, ёсчлох бөгөөд харин буцаавал Төрийн Дум болон Холбооны Хурал уг хуулийг дахин авч хэлэпцэж нийт гишүүдийнхээ 2/3-оос доошгүйн саналаар анхны редакцаар батлагдвал 7 хоногийн хугацаанд Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч түүнийг ёсчлох үүрэгтэй.	Ерөнхийлөгч Холбооны зөвлөл Төрийн Дум
10.	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	Парламентын 2 танхим дараалан хэлэлцэж, олонхийн саналаар баталсны дараа Ерөнхийлөгчид батламжлуулахаар шилжүүлдэг. Санхүүгийн холбогдол бүхий хуулийн төслийг зөвхөн доод танхимд өргөн барина. Хуулийн төслийг батлахад 2 танхим санал зөрсөн тохиолдолд тухайн хууль нь Мужийн Үндэсний Зөвлөлд шилжих бөгөөд Үндэсний зөвлөл нь тухайн хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хуулийн төслийг буцаана. Хэрэв тухайн хууль нэмэлт өөрчлөлт оруулах саналтайгаар батлагдвал уг хуулийг Ерөнхийлөгчөөс зөвшөөрөл авахаар өргөн барина. Хэрэв хуулийг буцаах, нэмэлт өөрчлөлт оруулах саналтайгаар баталвал Үндэсний Ассамблей тухай хуулийг дахин авч хэлэлцэх буюу Мужийн Үндэсний Зөвлөлөөс оруулсан саналыг дахин авч хэлэлцэх буюу эсхүл дахин авч хэлэлцэхгүй байхаар шийдвэрлэж болно. Үндэсний Ассамблейгаас хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүлээн авсан бол Ерөнхийлөгчийн зөвшөөрөлд өргөн барина.	Ерөнхийлөгч Дээд танхим - Үндэсний Ассамблей Доод танхим - Мужийн Үндэсний Зөвлөл
11.	Румын Улс	Батлагдсан хуулийн төслийг батламжлуулахаар Ерөнхийлөгчид хүргүүлэх бөгөөд Ерөнхийлөгч 20 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв батламжлахаас татгалзвал парламентаар дахин хэлэлцүүлэхээр нэг удаа буцааж болно. Ерөнхийлөгч тухайн хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн шүүхэд хандвал тус шүүх хуулийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор дүгнэлт гаргана.	Ерөнхийлөгч Дээд танхим – Сенат Доод танхим – Төлөөлөгчдийн танхим
12.	Сенегал	Парламентын доод танхим хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ ердийн хуулийг олонхийн саналаар, органик хуулийн төслийг гишүүдийн 3/5-ийн саналаар баталж Сенатад шилжүүлэх журамтай. Хууль батлагдсаны дараа хуанлийн 6 хоногт багтаж Ерөнхийлөгч болон гишүүдийн 1/10 нь шаардлагатай гэж үзсэн бол Үндсэн хуулийн зөвлөл түүнийг Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар хянан үзнэ. Сенат Парламентын доод танхим баталсан хуулийн төслийг хэлэлцэж батлан Ерөнхийлөгчид өргөн барихаас гадна Сенатуудын санаачилсан хуулийн төслийг хэлэлцэж, доод танхимд шилжүүлнэ.	Ерөнхийлөгч Дээд танхим-Үндэсний ассамблей Доод танхим – Сенат
13.	Словени	Үндэсний Хурлын чуулганы хуралдаан нийт гишүүдийн талаас илүү нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хууль болон бусад шийдвэрийг хуралдаанд оролцогсдын олонхиор батладаг. Үндэсний Зөвлөл Үндэсний Хурлын баталсан хуулийг дахин хэлэлцүүлэхээр 7 хоногийн дотор буцааж болно. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний Хурлын нийт депутатын олонхи нь дэмжсэн тохиолдолд уг хуулийг батлагдсанд тооцно. Батлагдсан хуулийг 8 хоногийн дотор Ерөнхийлөгчид хүргүүлнэ.	Ерөнхийлөгч Үндэсний Хурал Үндэсний Зөвлөл

UIH.MN
ШИНЖЛЭХ УХААНЫ САН

14.	Тунис	Парламент нь хуулийн төслийг хэлэлцэж, ердийн олонхийн саналаар батлах бөгөөд түүнд Ерөнхийлөгч 15 хоногийн дотор хориг тавьж болно. Хориг тавьсан төслийг Парламент 2/3-оос дээшхийн саналаар хүлээн авсанд тооцдог бөгөөд хууль шууд хүчин төгөлдөр болно. Доод танхим өргөн баригдсан хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж, олонхийн саналаар баталсан тохиолдолд дээд танхимд хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. Дээд танхим хугацаандаа хэлэлцээгүй болон 2 танхим санал зөрсөн асуудлаар нэгдмэл байр сууринд хүрч чадаагүй төслийг доод танхим Ерөнхийлөгчид шууд ёсчлуулахаар өргөн барих эрхтэй. Органик хуулийн төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар, ердийн хуулийн төслийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гэхдээ нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар батална. Хэрэв Парламентын доод танхимаас шилжүүлсэн төсөлд дээд танхим өөрчлөлт оруулан баталсан бол Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн барина. Парламентын дээд танхим органик хуулийн төслийг нийт гишүүдийн олонхийн саналаар, ердийн хуулийн төслийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гэхдээ нийт гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар батална.	Ерөнхийлөгч Дээд танхим – Депутатуу-дын танхим Доод танхим – Зөвлөхүү-дийн танхим
15.	Этиоп	Доод танхим нь хуулийг батлахдаа олонхийн саналаар батлах бөгөөд баталсан хуулийг гарын үсэг зуруулахаар Ерөнхийлөгчид өргөн барина. Ерөнхийлагч өргөн барьсан хуульд 15 хоногт гарын үсэг зурна. Хэрэв Ерөнхийлөгч 15 хоногийн дотор гарын үсэг зураагүй бол түүний гарын үсэгүйгээр тухайн хууль хүчин төгөлдөр болно. Дээд танхим өргөн барьсан төслийг хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хуралдаанд гишүүдийн 2/3-оос дээшхи нь оролцож, олонхийн саналаар шийдвэрлэнэ.	Ерөнхийлөгч Дээд танхим - Холбооны Танхим Доод тан-хим- Ардын Төлөөлөгчдийн Танхим
16.	Бүгд Найрам-дах Франц Улс	Танхимын товчооноос хуулийн төслийг 3 үе шатыг дамжин батлагдана. Хэрэв парламентын аль нэг танхим хуулийн төслийг батлахгүй буцаавал 4-5 дахь хэлэлцүүлгийг хийж болно. Өргөн барьсан төслийн талаар 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал Ерөнхий сайдын хүсэлтээр хамтарсан адил тооны гишүүдээс бүрдсэн комисс байгуулж хэлэлцэх бөгөөд нэгдсэн саналд хүрсэн төслийг 2 танхим дахин хэлэлцэж шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд саналын зөрүү гарвал Ерөнхий сайд Парламентын доод танхимд батлах хүсэлт тавьж тэрээр эцэслэн шийдвэрлэнэ. Хууль батлагдсаны дараа түүнийг Ерөнхийлөгч ёсчилдог ба тэрээр 15 хоногийн дотор уг хуулийг дахин хэлэлцэхийг шаардах эрхтэй байна. Үүний тулд Ерөнхийлөгч тунхаг гаргана.	Ерөнхийлөгч Дээд танхим – Сенат Доод танхим - Үндэсний ассамблей
17.	Чех	Хуулийн төслийг батлахдаа түүнийг хоёр танхим хоёулаа хүлээн зөвшөөрөх учиртай. Эхлээд Депутатуудын танхим дараа нь Сенат төслийг хэлэлцэж нийтлэг журмын дагуу хууль батлахын тулд нийт депутат болон сенатчаас 1/3-ээс доошгүй нь байлцаж депутат болон сенатчдын олонхиор батлах шаардлагатай. Хуулийг Депутатуудын танхим батласны дараа түүнийг батлуулахаар Сенатад хүргүүлнэ. Сенат нь депутатуудын танхимаар батлагдсан хуулийг 30 хоногийн хугацаанд судлан үзэж шийдвэрээ гаргах ёстой. Хэрэв Сенат хуулийг дэмжвэл түүнийг Ерөнхийлөгчид ёсчлуулахаар хүргүүлнэ. Мөн дээрх хугацаанд Сенат хуулийн талаар ямар нэг шийдвэр гаргаагүй бол түүнийг Сенатаар батлагдсанд тооцно. Сенат нь Депутатуудын танхимын батласан хуулийг дэмжихээс татгалзвал Депутатуудын танхим Сенатын хоригийг нийт депутатуудын олонхийн саналаар давж болдог. Сенатаас гадна тус улсын Ерөнхийлөгч парламентын баталсан хуульд 15 хоногийн дотор хориг тавьж болно. Энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн хоригийг давах журам нь Сенатын хоригийг давах журамтай адил байдаг.	Ерөнхийлөгч Депутатуу-дын танхим Сенат
		Парламентын Дээд болон доод танхим	

18.	Конго Улс	Хуулийн төслүүдийг доод, дээд танхим дараалан чуулганы хуралдаанаар хэлэлцэж, гишүүдийн 2/3 нь оролцсон тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар батлах журамтай. 2 танхимын хооронд хэлэлцэж буй асуудлаар саналын зөрүү гарвал доод танхимын гишүүдийн туйлын олонхийн саналаар баталсан шийдвэр давуу эрхтэй байдаг.	Доод танхим - Үндэсний ассамблей Дээд танхим - Сенат
19.	Конго Улс	Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ парламентад хэлэлцүүлэхээр оруулсан хуулийн төслийг 2 танхим дараалан хэлэлцэж батлах журамтай. Парламент Ерөнхийлөгч болон гишүүдийн санаачилсан хуулийн төслийг 20 хоногийн дотор танхимуудын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлсний дараа нэгдсэн хуралдаанд оруулж, олонхийн саналаар батлах журамтай. Хуулийн төслөөр парламентын танхимуудын хооронд саналын зөрүү гарвал Засгийн газраас танхимуудын хамтарсан комисс байгуулж нэгдсэн саналд хүрэх талаар хүсэлт тавина. Үүний дагуу комисс нэгдсэн саналд хүрээгүй бол доод танхим эцэслэн шийдвэрлэх журамтай.	Доод танхим - Үндэсний ассамблей Дээд танхим - Сенат
20.	Лесото Улс	Доод танхим нь хуулийн төслөөр хэлэлцүүлэг хийж олонхийн саналаар батлан Сенатад шилжүүлнэ. Сенатад өөрчилсөн зүйл заалтыг Доод танхим зөвшөөрсөн ч эс зөвшөөрсөн ч тэр парламентын эцсийн шийдвэр байна. Сенат доод танхимын баталсан хуулийг тоймлон хэлэлцэж батлах бөгөөд хууль санаачлах эрх эдлэхгүй.	Доод танхим - Үндэсний ассамблей Дээд танхим – Сенат
21.	Марокко Улс	Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг доод тахим буюу Төлөөлөгчдийн танхим, дээд танхим буюу Зөвлөхүүдийн танхим хоёулаа хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана. Парламентын доод танхим хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэсэн төслийг Парламентын дээд танхимд шилжүүлнэ. Парламентын 2 танхим хуулийн төслийг тус бүр 2 удаа хэлэлцсэн ч саналын зөрүүтэй асуудал гарсан бол уг асуудлаар адил тооны гишүүд оролцсон хамтарсан комисс байгуулж, Засгийн газартай хамтран үндэслэлийг нь сонсож, эцсийн шийдвэр гаргана. Органик хуулийн төслийг 2 танхим заавал хэлэлцэнэ.	Доод танхим - Төлөөлөгчдийн танхим Дээд танхим - Зөвлөхүүдийн танхим
22.	Польш	Сейм хуулийн төслийг гурван удаагийн хэлэлцүүлгээр хэлэлцэж батална. Сенат Сеймийн батласан хуулийг хүлээн авсан өдрөөс эхлэн 30 хоногийн дотор, яаралтай бол 14 хонгийн дотор хэлэлцнэ. Сенат тухайн хуулийг шууд батлах эсвэл засвар оруулах, буцаах эрхтэй. Хуульд засвар оруулах, буцаах тухай тогтоол нь Сенатын нийт гишүүдийн талаас илүү нь хуралдаанд оролцож, 3/4 нь дэмжсэнээр хүчин төгөлдөр болно. Харин улсын төсвийн тухай хуулийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор хэлэлцэж батална. Сеймийн Маршал батлагдсан хуулийг гарын үсэг зуруулахаар Ерөнхийлөгчид хүргүүлнэ.	Сейм Сенат
23.	Швейцарын Холбооны Улс	Өргөн барьсан төслийн талаар 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал, түүнийг хэлэлцэж эхэлсэн танхимд нь буцааж, дахин хэлэлцэхдээ нөгөө танхимын саналыг харгалздаг. Үүний дараа дахин саналын зөрүүтэй тохиолдолд зөвшилцөх бага хурал зохион байгуулж, түүний үр дүнд шийдвэр гаргана. Энэ зөвшилцлийн бага хурлаар нэгдсэн шийдэлд хүрэх боломжгүй бол уг асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтаас хасна.	Доод танхим - Үндэсний Зөвлөл Дээд танхим - Кантонуудын Зөвлөл
		Бусад субъектүүд	

ОНМН
СУДАЛГААНЫ САН

24	Алжир Улс	Үндсэн хуульд заасны дагуу хууль, тогтоомжийн төслийг эхлээд парламентын доод танхим хэлэлцэж, баталсны дараа дээд танхим хэлэлцэж 3/4-ийн саналаар баталснаар Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн барина. Доод танхим нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ ердийн хуулийн төслийг олонхиор, органик хуулийн төслийг 2/3-оос дээшхийн саналаар батална. Үндсэн хуулийн зөвлөл батлагдсан төсөл Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянана. Харин Ерөнхийлөгч 30 хоногийн дотор төслийг дахин хэлэлцүүлэх санал тавих эрхтэй. Энэхүү саналыг доод танхим хүлээн авч хэлэлцээд 2/3-ийн саналаар баталбал хууль батлагдсанд тооцно. Парламентын доод танхимын хэлэлцэж олонхиороо баталсан хуулийн төслийг дээд танхим хэлэлцэх журамтай. Дээд танхим төслийг 3/4-ын саналаар баталсан тохиолдолд уг хууль Ерөнхийлөгчид ёсчлуулахаар өргөн баригдана. Доод танхимын баталсан төслийг дээд танхим 3/4-ын саналаар зөвшөөрөөгүй бол 2 танхимаас тэнцүү тооны гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж холбогдох асуудлаар Засгийн газрын байр суурь, үндэслэлийг сонсож, Засгийн газрын саналтай нийлэхгүй байвал уг заалтыг батлагдаагүйд тооцно.	Ерөнхийлөгч Доод танхим-Үндэсний ардын ассамблей Дээд танхим-Үндэстний зөвлөл Үндсэн хуулийн зөвлөл
25	Австри Улс	Хуулийн төслийг батлахдаа доод танхимын нийт гишүүдийн 1/3-ийн ирцтэйгээр батлах бөгөөд дараа нь дээд танхимд өргөн баригдана. Доод танхим нь гагцхүү Холбооны улсын төсвийг бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй. Дээд танхим нь Доод танхимын баталсан хуулийн саналыг өөрчилж чадахгүй, гэхдээ Доод танхимыг итгүүлэхийн тулд 8 долоо хоног хүртэл хүлээж авахгүй байх боломжтой. Энэ тохиолдолд Доод танхим нь гаргасан шийдвэрээ эргэх харах ёстой. Ингэхдээ доод танхимын нийт гишүүдийн тал хувийн ирцтэй байж шийдвэр хүчинтэй байх журамтай. Хэрэв дээд танхим нь дахин эсэргүүцвэл, энэ удаагийн “вето” нь нийт гишүүдийнх нь тал хувийн ирцтэй, түүнчлэн ирсэн гишүүдийн 2/3 хувийн саналыг авсан байх журамтай. Дээд танхим нь хүлээн авсан, эсвэл доод танхим нь дээд танхимын саналыг хүлээн авахгүй бол хууль хүчин төгөлдөр болж Ерөнхийлөгч хуулийг ёсчлоно. Холбооны улсын Канцлер ч мөн үүнийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсанаар уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөнө.	Ерөнхийлөгч Дээд танхим – Холбооны зөвлөл Доод танхим – Үндэсний зөвлөл Холбооны улсын Канцлер
26	Герман	Холбооны Засгийн газар, Бундесрат, эсвэл зарим тохиолдолд Бундестаг хуулийн төсөл санаачилах эрхтэй. Хэрэв Бундестаг өөрөө хууль саанаачилах бол тус танхимын нийт гишүүдийн 5 хувийн саналыг авах, эсвэл парламентын бүлгийн дэмжлэх авах ёстой. Бундестаг нь хуулийн төслийг нэгдсэн хураалдаанаараа 3 удаа хэлэлцүүлнэ. Сүүлийн хэлэлцүүлэгээр хуулийн төслийг баталсны дараа Бундесратад шилжүүлнэ. Бундесрат хянан үзээд Бундестагийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн, эс хүлээн зөвшөөрсөн, эсвэл Зуучлалын хороо (Mediation Committee)-г хуралдуудах зэрэг шийдвэрийн аль нэгийг гаргана Зуучлалийн хороо нь хоёр танхимын санал зөрөлдөөд байгааг зөвшилцөлд хүргэх зорилготой бөгөөд хуульд ямар нэгэн засвар хийх эрхгүй. Зуучлалын хорооны гаргасан саналыг Бундестаг ба Бундесрат хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Хэрэв Бундесрат нь хуулийг эс зөвшөөрөх бол энэ шийдвэрээ 2 долоо хоногийн дотор гарна. Бундесратын татгазсан шийдвэрийг Бундестаг хяцаалт хийнэ. Бундесрат хуулийн төслийг хүлээн зөвшөөрч парламент дахь ажилласаа дуусна. Гэхдээ тухайн хуулийн төсөлтэй холбоотой салбарын сайд болон Холбооны Канцлер, Холбооны Ерөнхийлөгч ч нар хүлээн зөвшөөрч баталсан тохиолдолд хууль батлагдсан гэж үзнэ.	Дээд танхим буюу Холбооны зөвлөл (Бундесрат) Доод танхим буюу Холбооны хурал (Бундестаг) Зуучлалын хороо Тухайн хуулийн төсөлтэй холбоотой салбарын сайд Холбооны Канцлер Холбооны Ерөнхийлөгч

		ПАРЛАМЕНТАД 1 СУБЪЕКТ ХЯНАЛТ ТАВИНА.
		Танхим тус бүр батлана. Үүний дараа Төрийн тэргүүн хяналт тавьж батлана.

27.	Австрали	Танхим бүрт хуулийн төслийг хэлэлцэх ба уг төсөл парламентын хоёр танхимаар дэмжигдсэн байна. Хэрэв аль нэг танхим төсөлд өөрчлөлт оруулбал нөгөө танхим уг өөрчлөлтийг мөн адил зөвшөөрч батална. Хоёр танхимаар дэмжигдсэн төслийг Амбан захирагчаар батлуулахаар өргөн мэдүүлнэ.
28.	Аргентин	Хуулийн төслийг танхим тус бүрээр хэлэлцэж 2 танхим хоёул дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид танилцуулна. Ерөнхийлөгч дэмжвэл уг хуулийн төсөл хууль болон хэрэгжинэ.
29.	Боливи	Хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцэж гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгчийн соёрхон баталсан хуулийг төрийн хэвлэлд нийтлэснээр хүчин төгөлдөр үйлчилнэ.
30.	Бразил	Хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцүүлж, Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг.
31.	Бутан	Аль нэг танхим хуулийн төслийг хэлэлцээд баталсан тохиолдолд нөгөө танхимдаа хүргүүлдэг. Хэрэв нөгөө танхим нь уг төслийг батлахгүй бол хуулийн төслийн баталсан танхимд буцаан хүргүүлдэг. Танхим хуулийн төслийг дахин хэлэлцээд баталвал Хаанд соёрхон батлуулахаар хүргүүлдэг. Хуулийг Хаан батламжилснаар хүчин төгөлдөр болно.
32.	Казахстан	Мажилисын хүлээн авч хэлэлцээд олонхиороо дэмжсэн хуулийн төслийг Сенат хэлэлцэх бөгөөд Сенатын гишүүдийн олонхийн дэмжлэг авбал хуулийг батлагдсанд тооцон Ерөнхийлөгчид гарын үсэг зуруулахаар танилцуулна. Сенатын нийт гишүүдийн олонхийн дэмжлэг аваагүй хуулийн төслийг Мажилист буцаах бөгөөд Мажилисийн нийт гишүүдийн гуравны хоёр нь уг хуулийн төслийг дахин дэмжвэл Сенатаар хэлэлцүүлж санал хураалгахаар шилжүүлнэ. Хэрэв Сенат дахин буцаавал тухайн чуулганы хугацаанд уг хуулийн төслийг хэлэлцэхгүй.
33.	Камбож	Үндэсний Ассамблейн гишүүд болон Ерөнхий сайд хууль санаачлах эрхтэй. Үндсэний Ассамблейн баталсан хуулийг Хаан соёрхон баталж төрийн сонинд нийтэлснээр хүчин төгөлдөр болдог.
34.	Канад	Нийтийн танхим болон Сенатад хуулийн төслийг 3 удаагийн хэлэлцүүлгээр эцэслэн баталсаны дараа тухайн хуулийг хуульчлан зарлан тунхаглах хүсэлтийг Хатан хаанд хүргүүлдэг. Хааны зөвшөөрлийг авсаны дараа тухайн хуулийн төсөл нь хуульчилагдан батлагдсанд тооцогддог.
35.	Малайз	Хууль парламентын 2 танхимаар орж батлагдах ба Хаан соёрхон баталснаар хүчин төгөлдөр болно. Хууль батлахдаа 2 танхим тус бүр хэлэлцэж, 2 танхимаас батлагдсан хуулийг Хаан соёрхон баталж хэвлэгдсэнээр хүчин төгөлдөр болно.
36.	Мьянмар	Хууль тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тухайн танхимд өргөн барьсан болон тухайн танхимын гишүүдийн санаачилж, холбогдох саналыг авсан төслийг жил бүрийн ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Парламентын 2 танхим Үндсэн хуулиар тогтоосон хуулийн төслөөр хамтарсан хэлэлцүүлэг хийж нэгдсэн саналд хүрэхийг зорино. Парламентын 2 танхим хэлэлцэж баталсан хуулийг Ерөнхийлөгч ёсчилж мөрдүүлэх шийдвэр гаргана.
37.	Тайланд	Хууль болон хуулийн төсөл Үндэсний хурлаар батлагдах бөгөөд эзэн хаан гарын үсэг зурснаар, төрийн хэвлэлд нийтлэгдэж хууль хүчин төгөлдөр болно.
38.	Чили	Хуулийн төслийг танхим тус бүрээр хэлэлцүүлж, нийт гишүүдийн олонхийн дэмжлэг авсан тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг.
		Танхим тус бүр батлана. Үүний дараа Төрийн тэргүүн батлана. Төрийн тэргүүн хориг тавьж болно.
39.	Америкийн Нэгдсэн Улс	Төлөөлөгчдийн танхим ба Сенатын танхим тус бүрээр дэмжигдсэн хуулийн төслийг Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид илгээнэ. Ерөнхийлөгч уг хуулийн төслийг дэмжвэл гарын үсэг зурж хүчин төгөлдөр хэрэгжих ба хэрэв татгалзвал уг хуулийн төслийг эсэргүүцлийн хамт буцаадаг. Уг хуулийн төслийг дахин авч хэлэлцээд 2/3 саналаар хэвээр нь баталбал Ерөнхийлөгчийн эсэргүүцлийн хамт нөгөө танхимдаа шилжүүлнэ. Тус танхим дахин авч хэлэлцээд 2/3 саналаар баталбал уг хуулийн төсөл хүчин төгөлдөр болсон гэсэн үг.

ҮЙЛ ҮЙН
СЭДЭЛГЭЭНЭЭСЭН

40.	Афганистан	Үндэсний Ассамблейн баталсан хуулийг Ерөнхийлөгч соёрхон батлах бөгөөд Ерөнхийлөгч хуульд үндэслэлтэй хориг тавих эрхтэй. Ерөнхийлөгчийн хориг тавьсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим гуравны хоёрын саналаар баталвал хууль хүчин төгөлдөр болно. Засгийн газрын санаачилсан хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд хүргүүлдэг бөгөөд уг танхим хуулийн төслийг хэлэлцээд баталвал Сенатын танхимд хүргэдэг.
41.	Йордан	Хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим баталсны дараагаар Сенатад хүргүүлдэг. Сенат хуулийг баталсны дараагаар Хаанд хүргүүлэн хаан соёрхон батална. Сенатаас хуулийн төсөл буцсан тохиолдолд Төлөөлөгчдийн танхим хуулийн төслийг эргэн хэлэлцдэг байна. Хаан хуулийн төсөлд хориг тавьсан тохиолдолд 2 танхим хоёулаа 2/3-оос доошгүй саналаар хуулийг баталж болдог байна.
42.	Палау	Парламентын хоёр танхим тус бүр хууль батлан гаргана. Парламентын танхим тус бүрийн баталсан хуулийг Ерөнхийлөгч баталснаар хүчин төгөлдөр болно. Хэрэв Ерөнхийлөгч хуулийн төсөлд хориг тавьсан бол парламентын хоёр танхимд буцаана. Танхимууд дахин хэлэлцэж гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батлан Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Ерөнхийлөгч хоёр дахь удаагаа хуулийн төслийг парламентад буцаахгүй.
43.	Парагвай	Хуулийн төслийг Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгчийн хоригийг Үндэсний Конгресс хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол хуулийн төслийг анхны процедураар, санаачилсан буюу анх хүлээн авсан танхим нь 60 хоногийн дотор дахин хэлэлцээд нөгөө танхимдаа шилжүүлнэ. Үндэсний Конгрессын гишүүдийн олонхи буюу 2/3 нь хоригийг хүлээн зөвшөөрөхгүйгээр шийдвэл уг хууль батлагдана.
44.	Уругвай	Парламентын гишүүн, Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй байдаг. Уг хуулийн төслийг Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгч хориг тавих тохиолдолд хоригийг Үндэсний Ассамблей хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхи буюу 3/5 нь хоригийг хүлээн зөвшөөрөхгүйгээр шийдвэл уг хууль батлагдана.
		Дээд танхим нь доод танхимын хэлэлцсэн хуулийн төслийг хянаж батлах ба хэрэв дээд танхим хүлээн зөвшөөрөхгүй бол Ерөнхийлөгчөд шууд өргөн барьж батлуулж болно.
45.	Мексик	Хуулийн төслийг 2 танхимаар хэлэлцүүлж, Холбооны Конгрессийн гишүүдийн олонхи дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгчид батлуулахаар өргөн барьдаг. Хэрэв анх санаачилсан буюу хүлээн авсан танхимаас ирүүлсэн төслийг нөгөө танхим нь дэмжээгүй тохиолдолд засвар өөрчлөлт оруулах шаардлагатай зүйл заалт болон хэрхэн өөрчлөх тухай саналаа оруулж төслийг буцаана. Энэ саналыг хүлээн зөвшөөрч төсөлдөө тусган шинэчлэн боловсруулсан бол нөгөө танхимдаа дахин хэлэлцүүлэлгүйгээр шууд батлуулахаар Ерөнхийлөгчид өргөн барьдаг. Харин төслийг анх санаачилсан буюу хүлээн авсан танхим нь нөгөө танхимаас ирүүлсэн төсөлд оруулах засвар өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол энэ тухай үндэслэл, тайлбараа багтаан төслийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлнэ. Нөгөө танхим энэ тайлбар үндэслэлийг хүлээн зөвшөөрөхгүй, төслийг заавал засч өөрчлөх ёстой байсан гэж үзвэл төслийг хэлэлцэхгүй. Энэ тохиолдолд уг хууль батлагдахгүй. Ерөнхийлөгч 10 хоногийн дотор хориг тавих эсэхээ шийдэх ёстой. Ерөнхийлөгчийн хоригийг Холбооны Конгресс хүлээн авсан бол уг төслийг дахин хэлэлцэхгүй. Хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол хуулийн төслийг анхны процедураар дахин хэлэлцэнэ.
46.	Узбекистан	Хууль тогтоох танхимаар хэлэлцэн батлагдаад Сенат дэмжиж, Ерөнхийлөгч гарын үсэг зурж, албан ёсны хэвлэлд нийтэлснээр хууль хүчин төгөлдөр болно. Сенатын танхим дэмжихгүй бол Хууль тогтоох танхимд хуулийн төсөл эргэн хүргэгдэнэ. 2 дахь удаа буцаж ирсэн тохиолдолд Хууль тогтоох танхимын нийт гишүүдийн 2/3-ын саналаар Ерөнхийлөгчид илгээнэ. Ерөнхийлөгч хуулийн төслийг дэмжиж болно. Татгалзаж буцаасан тохиолдолд татгалзлын бичигтэй буцаадаг байна. Буцаж ирсэн хуулийг аль аль танхим 2/3-оос доошгүй саналаар ирсэн хуулийг Ерөнхийлөгч заавал баталдаг байна.
47.	Фижи	Бүх хуулийн төслүүдийг Төлөөлөгчдийн танхим эхлэн хэлэлцээд дараа Сенатад өгнө. Сенат төслийг засваргүй юмуу засвартайгаар батлах, эсвэл буцааж болно. Хэрэв хуулийн төсөл Төлөөлөгчдийн танхимаар хоёр чуулган дараалан орж батлагдсан, хоёр дахин өргөн барихад Сенат хоёуланд нь хүлээн зөвшөөрөөгүй юмуу засвартайгаар баталсан, үүнтэй нь Төлөөлөгчдийн танхим санал нийлэхгүй байвал хуулийн төсөлд гарын үсэг зуруулахаар шууд ерөнхийлөгчид өргөн барьж болно.

		Танхим тус бүр хуулийн төсөл батлахад оролцоно. Хэрэв санал зөрвөл хоёр танхимын хамтарсан чуулганаар батлана.
48.	Бахрейн	Парламентын доод танхимын баталсан хуулийн төслийг дээд танхим батлаагүй бол доод танхимд дахин хэлэлцүүлэхээр буцаадаг. Хэрэв хуулийн төслийг доод танхим баталвал тус төслийг дээд танхимын дарга Ерөнхий сайдад хүргүүлдэг ба Ерөнхий сайд Хаанд өргөн мэдүүлнэ. Хэрэв хоёр танхим хоёр удаа санал зөрвөл Зөвлөх зөвлөлийн даргын удирдлага доор хамтарсан чуулган явуулах ба үүнд Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
49.	Колумби	Хуулийн төслийг танхим тус бүрээр 2 удаа хэлэлцүүлж, төслийг хоёр танхим дэмжсэн үед Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар өргөн барьдаг. Ерөнхийлөгчийн соёрхон баталсан хуулийн төсөл албаны хэвлэлд нийтлэгдсэнээр хүчин төгөлдөр үйлчилнэ. Хэрэв санаачилсан буюу хүлээн авсан танхимаас ирүүлсэн төслийг нөгөө танхим нь дэмжээгүй тохиолдолд хоёр танхимын гишүүдээс тэнцүү тоотойгоор оролцуулсан төсөл хэлэлцэх холимог хороог байгуулна. Энэ хороо нь төсөл дэх санал зөрөлдөөнтэй зүйл заалтад холбогдох засвар өөрчлөлтийг оруулсны дараа төслийг батлуулахаар Ерөнхийлөгчид өргөн барьдаг. Харин Ерөнхийлөгч хуулийг батлахаас татгалзах буюу эсвэл хориг тавих хугацаа өнгөрсөн ч ямар нэг тодорхой шийдвэр гаргаагүй бол Үндэсний Конгрессын тэргүүн хуулийг батлана.
50.	Пакистан	Хуулийн төслийг аль нэг танхим хэлэлцэн олонхиор батлавал, түүнийг нөгөө танхимдаа хүргүүлдэг. Нөгөө танхим ямар нэг өөрчлөлтгүй хуулийг баталвал хуулийг Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар хүргүүлдэг. Хэрэв аль нэг танхимын баталсан хуулийн төсөл нөгөө танхимдаа ирээд 90 өдрийн дотор батлагдаагүй эсхүл татгалзсан, эсхүл нэмэлт, өөрчлөлт орсон бол анх хуулийн төслийг баталсан танхимын шаардлагаар Ерөнхийлөгч хоёр танхимын хамтарсан хуралдааныг зарлан уг хуулийн төслийг хэлэлцүүлнэ. Хамтарсан хуралдаанаар бүх гишүүний олонхийн саналаар хуулийн төсөл нэмэлт, өөрчлөлтгүй эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулан баталвал Ерөнхийлөгчид соёрхон батлуулахаар хүргүүлдэг.
51.	Энэтхэг	Хуулийн төслийг 2 танхим тус бүрийн нийт гишүүдийн 1/10–ийн ирцтэйгээр хэлэлцэх бөгөөд гишүүдийн олонхийн саналаар төслийг баталдаг. Хуулийн төслийг хэлэлцэх явцад парламентын 2 танхимын хооронд саналын зөрүү гарвал танхимуудын хамтарсан хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар төслийг батлагдсанд тооцдог. Санхүү, мөнгөний холбогдолтой хуулийн төслийг Дээд танхим хэлэлцэхгүй, харин төслийн талаархи саналаа Доод танхимд хүргүүлнэ. Доод танхим уг төсөлд Дээд танхимаас ирүүлсэн саналыг авч үзэх бөгөөд тэдгээрийг тусгасан, эс тусгаснаас үл хамааран төслийг Доод танхим баталснаар хүчин төгөлдөр болно. Батлагдсан хуулийг Ерөнхийлөгч ёсчилно.
		ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ПАРЛАМЕНТ ДАНГААРАА БАТЛАНА.
		Танхим тус бүр батлана.
52.	Йемен	Төлөөлөгчдийн танхимын гишүүн болон Засгийн газар нь хуулийн төслийн санал гаргах эрхтэй бөгөөд Төлөөлөгчдийн танхимд хуулийн төслийг өргөн барьдаг. Зарим тохиолдолд л хуулийн төслийг дээд танхимаар хэлэлцдэг байна.
53.	Япон	Хуулийн төслийг хоёр танхим батална. Төлөөлөгчдийн танхимаар баталсан хуулийн төслийг Зөвлөхүүдийн танхим хүлээн зөвшөөрөхгүй бол уг төслийг Төлөөлөгчдийн танхим дахин хэлэлцээд гишүүдийн гуравны хоёрын дэмжсэн саналаар хууль батлагдсанд тооцдог.
54.	Босни-Герцеговин	Төлөөлөгчдийн танхим нь 42 гишүүнтэй. Ард түмний танхим 15 гишүүнтэй. Парламент нь хууль батлах, хянан шалгах, төсөв болон сайд, Ерөнхий сайдыг батлах зэрэг бүрэн эрхтэй. Хоёр танхимийн ердийн олонхи дэмжсэнээр хууль хүчин төгөлдөр болно.
		Зарим хуулийг зөвхөн доод танхим батална.
55.	Оман	Хуулийн төслийг доод танхим хэлэлцэн өөрсдийн саналыг оруулдаг. Нийтийн эрх ашгийг хөндсөн хуулийг батлах эрх нь Султанд байдаг байна. Дээд танхим нь Султаны батлах хуулинд зөвлөх үүрэгтэй.

56.	Тажикистан	Доод танхим Үндсэн хуулинд өөрөөр заагаагүй бол хуулийг нийт депутатын олонхийн саналаар хуулийг батлана. Доод танхимаас баталсан Улсын төсөв ба өршөөлийн хуулиас бусад бүх хуулийг Дээд танхимд хүргүүлнэ. Хэрэв дээд танхим нийт гишүүдийнхээ олонхиор дэмжвэл хуулийг дээд танхим дэмжлээ гэж үзнэ. Хэрэв дээд танхим хуулийг дэмжээгүй бол доод танхим дахин хэлэлцэнэ. Доод танхим дээд танхимын шийдвэртэй санал нийлээгүй бөгөөд уг төслийг дахин 2/3-аас доошгүйн саналаар батлавал уг хуулийг батлагдсан гэж үзнэ. Үүний дараа хуулийг ёсчлуулахаар ерөнхийлөгчид хүргэнэ. Хэрэв ерөнхийлөгч хууль буюу түүний аль нэг хэсэгтэй санал нийлэхгүй байвал доод танхимд буцаана. Энэ тохиолдолд дээд, доод танхимууд дахин хуулийн төслийг хэлэлцэж аль аль нь нийт гишүүдийн 2/3-аас доошгүйн саналаар батлавал ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурна.
57.	Филиппин	Төрийн мэдэлд өмч хөрөнгө авах, татвар, төлбөрийн хэмжээ тогтоох, орон нутгийн хууль тогтоомж, засгийн газрын өрийг нэмэгдүүлэх, болон тусгай хуулиудыг зөвхөн Төлөөлөгчдийн танхим гаргах бөгөөд Сенат нь түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал оруулж болно.

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БАЙСАН ХҮМҮҮСИЙН ХАНГАМЖ, ХАМГААЛАЛТ, ЭРХ, ҮҮРГИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

УДИРТГАЛ

УИХ -ын гишүүн Г. Уянгын захиалгаар “Гадаадын зарим орны Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалт, эрх, үүргийн талаарх харьцуулсан судалгаа”сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны, тухайлбал, АНУ, Франц, БНЭУ, ОХУ, БНКырУ -ын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт, Зүүн Тимор Улс, Ангол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн зарим эрх, үүргийн талаарх эрх зүйн зохицуулалтыг судалж, туршлагыг харьцуулан гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим орны Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Гадаадын зарим орны Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн эрх, үүргийн талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Дээрх орнуудын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүс бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссаны дараа эрхэлж буй ажлын талаар зарим хүмүүсийн жишээн дээр тулгуурлан материал бэлтгэх зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын Үндсэн хууль, холбогдох бусад хуулийн бүлэг заалт,
- Гадаадын зарим орны Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн бүрэн эрх нь дуусгавар болсны дараа эрхэлж буй ажлын талаар эх сурвалж, баримт материалыг судлах,
- Судалгааны материалыг нэгтгэн тайлан бичих

Хамрах хүрээ:

1. Гадаадын улс орнууд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүстэйгээ хэрхэн ажилладаг талаар холбогдох эх сурвалжуудаас судалж үзсэн боловч энэ талаар тодорхой материал байхгүй, харин тэдний хангамж, хамгаалалт, зарим улсад бүрэн эрх нь дууссаны дараа эрхлэх ажлын талаарх холбогдох эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн болно.
2. АНУ, Франц, БНЭУ, ОХУ, БНКырУ -ын Ерөнхийлөгч байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаарх асуудал,
3. Зүүн Тимор Улс, Ангол Улсын Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн бүрэн эрх нь дууссаны дараа эрхлэх ажил, хэрэгжүүлэх эрх, үүргийн талаарх асуудал,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. Зарим орны Ерөнхийлөгч байсан хүмүүсийн бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссаны дараа явуулсан үйл ажиллагааны талаар мэдээлэл

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн судалгааны тайлан бичсэн

* * *

1. Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаар

Америкийн нэгдсэн Улс

Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл нь 1947 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн (National Security Act of 1947) дагуу байгуулагдсан. 1949 оны Өөрчлөн байгуулалтын төлөвлөгөө №4 (Reorganization Plan No. 4 of 1949) ёсоор Ерөнхийлөгчийн Гүйцэтгэх офист байрлах болсон. УАБЗ -ийг Ерөнхийлөгч даргална. Ерөнхийлөгчөөс гадна Дэд ерөнхийлөгч, Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайд нар байнгын гишүүн нь байна.

Штабын дарга нарын нэгдсэн хорооны дарга буюу АНУ -ын Ерөнхий штабын тэргүүн УАБЗ -ийн цэргийн асуудлын, Тагнуулын ерөнхий газрын дарга тагнуулын асуудлын байнгын зөвлөх байна. Сангийн сайд, НҮБ дахь АНУ-ын байнгын төлөөлөгч, Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын асуудлын туслах, Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын туслах болон Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга нар Зөвлөлийн бүх хуралдаанд уригдана. Ерөнхий Атторней болон Хар тамхины үндэсний хяналтын бодлогын газрын дарга нар хариуцах асуудлынхаа хүрээнд, бусад албаны хүмүүс шаардлагын дагуу Зөвлөлийн хуралдаанд уригдан оролцоно.

УАБЗ нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын бодлогод нөлөөлөх дотоод, гадаад цэрэг, тагнуул болон эдийн засгийн асуудлаар (Үндэсний эдийн засгийн зөвлөлтэй хамтран) ерөнхийлөгчид зөвлөж, туслана. 1958 онд батлагдсан Бүрэн эрх нь дуусан ерөнхийлөгчийн тухай хуулиар (Former Presidents Act) ерөнхийлөгч асан хүмүүсийн тэтгэвэр, ажлын алба, офисийн зардал, эмнэлэгийн үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал, Тусгай албаны хамгаалалтын асуудлыг зохицуулдаг.

Тэтгэвэр. Тэтгэврийг нь Сангийн сайд хариуцана. Тэтгэвэр нь гүйцэтгэх төвшний нэгдүгээр зэргийн буюу яамдын гүйцэтгэх тэргүүн нарын цалинтай тэнцэх бөгөөд татвар ногдуулна. (2012 оны байдлаар 191300 $). Тэтгэврийг ерөнхийлөгчийн бүрэн эрх нь дуусмагц олгож эхлэнэ. Хэрэв ерөнхийлөгч агсны бэлэвсэн эхнэр бусад тогтмол тэтгэвэрээс татгалзсан бол насан туршид нь жилд 20000 $-ын тэтгэвэрийг олгоно.

Шилжилт. Бүрэн эрх нь дуусан ерөнхийлөгчийн офисоос явах шилжилтийн зардлыг мөн улсаас санхүүжүүлнэ. Үүнд офисийн байрны зардал, ерөнхийлөгчийн ажилтнуудын нөхөн олговор, харилцаа, холбооны үйлчилгээ, хэвлэх болон шуудангийн зардлыг 7 сарын турш санхүүжүүлдэг.

Ажилтнууд, офис. Ерөнхийлөгч асны хувийн офис, ажилтнуудын асуудлыг Ерөнхий үйлчилгээний газрын захирал хариуцан, санхүүжүүлнэ. Энэ офисийн ажилтнуудыг ерөнхийлөгч асан өөрөө сонгох бөгөөд тэд ажил, үүргээ зөвхөн түүний өмнө хариуцан тайлагнана. Ерөнхийлөгч асан хүн бүрэн эрхээ хэрэгжүүлж байхад нь ажиллаж байсан өөрийн ажилтнуудад олгох нөхөн олговрын суурь хэмжээг өөрөө тогтоох бөгөөд хэмжээний

хувьд эхний 30 сард жилийн нийлбэр дүнгээрээ 150000$ -оос хэтрэхгүй, түүнээс цааш 96000$ -оос хэтрэхгүй байна.

Эмнэлэг, эрүүл мэндийн даатгал. Ерөнхийлөгч асан цэргийн госпитальд эмчлүүлэх эрхтэй бөгөөд эмчилгээний зардлыг агентлагийн дотоод тарифаар төлнө. Энэ тарифийг Удирдлага, төсвийн товчооноос тогтоосон байдаг. Хоёр удаа ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан хүн Холбооны албан хаагчдын эрүүл мэндийн хөнгөлөлтийн программын хүрээнд эрүүл мэндийн даатгал худалдан авч болдог.

Тусгай албаны хамгаалалт. 1965 - 1996 оны ерөнхийлөгч нар, тэдний эхнэрийг насан туршид нь төрийн тусгай албад хамгаална. Мөн ерөнхийлөгч асны 16 нас хүрээгүй хүүхдийг хамгаална. Харин 1994 онд батлагдсан дүрэм ёсоор 1997 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш тангараг өргөн ажилласан ерөнхийлөгч нарын хамгаалалтын хугацааг 10 жил болгон өөрчилжээ. Энэ дүрмийн дагуу Билл Клинтон насан туршийн хамгаалалттай байх бол Жорж Буш, Барак Обама болон тэднээс хойших ерөнхийлөгч нар бүрэн эрх нь дууссанаас хойш 10 жил хамгаалалтанд байна.

Мөн 2008 онд Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний хамгаалалтын хууль (Former Vice President Protection Act of 2008) батлагдан гарсан байна. Дэд ерөнхийлөгч асан, түүний эхнэр, 16 нас хүрээгүй хүүхдийг нь дэд ерөнхийлөгч бүрэн эрхээ дууссанаас нь хойш 6 хүртэл сарын хугацаанд төрийн тусгай албадаас хамгаалж байхаар Холбооны Эрүүгийн хуульд нэмэлт оруулсныг Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний хамгаалалтын хууль гэдэг. Мөн энэ хугацаа дууссанаас хойш шаардлага гарвал Дэд ерөнхийлөгч асан болон түүний гэр бүлийг тодорхой хугацаагаар хамгаалалтанд авах тухай шийдвэр гаргах эрхийг Дотоодын аюулгүй байдлын сайдад олгосон байна. Энэ хамгаалалт мөн дэд ерөнхийлөгч асны офист хамаарна.

Бүгд Найрамдах Франц Улс

Францын хууль ёсоор Ерөнхийлөгч байсан хүн насан туршдаа Төрийн зөвлөхийн хэмжээний тэтгэвэр авахаас гадна дипломат паспорттай байна. Мөн Францын Үндсэн хуулийн 56 дугаар зүйл ёсоор Францын үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүн байна. (Зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 9 жилийн хугацаагаар Ерөнхийлөгч, Үндэсний хурал болон Сенатын спикерүүд томилно. Зөвлөлд дахин томилогдохгүй. 3 жил тутамд Зөвлөлийн гишүүдийн гуравны нэгийг шинэчлэн Ерөнхийлөгч, Үндэсний хурал болон Сенатын спикерүүд тус бүр нэг нэг гишүүн томилно. Үндсэн хуулийн зөвлөлийн нэг онцлог нь Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч байсан хүн дээрх 9 гишүүн дээр нэмэгдэн гишүүн болох эрхтэй байдаг явдал юм.

Үндсэн хуулийн зөвлөл нь бусад орны үндсэн хуулийн шүүхтэй харьцуулбал бага эрх мэдэлтэй. Тухайлбал, Зөвлөл хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг хүчингүй болгох эрхгүй. Зөвхөн хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулийн төсөл юмуу батлагдсан боловч хүчин төгөлдөр үйлчилж эхлээгүй хуулийн талаар үндсэн хуульд нийцэж буй эсэхэд нь дүгнэлт гаргана. Үндсэн хуулийн Зөвлөлийн гишүүн нь олон нийтэд хандсан мэдэгдэл хийх, тодорхой албан тушаалуудыг хаших болон зарим төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй байдаг.)

Францын ерөнхий сайдын 1985 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн шийдвэрээр Ерөнхийлөгч байсан хүмүүсийн хангамжийг тогтоосон байна. Үүгээр ерөнхийлөгч асан төрийн тусгай хамгаалалт, жолоочтой автомашин, офисийн байр, уг офист үйлчлэх хоёр ажилтантай байх бөгөөд бүх зардлыг нь улсаас хариуцна. Мөн Засгийн газраас байнгын 7 ажилтныг Ерөнхийлөгч асны офист ажиллуулна. Эдгээр ажилтныг Дотоод явдлын яам, Батлан хамгаалах яам, Сангийн яам, Нийгмийн хамгаллын яамнаас санхүүжүүлэн ажиллуулна.

Оросын Холбооны Улс

2001 оны 2 сард ОХУ-ын Төрийн Думаас “Бүрэн эрх нь дууссан ерөнхийлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн баталгааны тухай” хуулийг баталсан ба тус хуульд 2007, 2010 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус хуулийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссан ерөнхийлөгч “Төрийн хамгаалалтын тухай” хуулийн заалт ёсоор насан туршдаа төрийн хамгаалалтанд байх, тээвэр, холбоо, тусгай эмнэлгийн үйлчилгээ авах, нийгэм, эрүүл мэндийн даатгалыг улсын төсвөөс санхүүжүүлэх, идэвхтэй үйл ажиллагаа явуулахад нь зориулж зохих техник хэрэгслээр тоноглосон ажлын байр, туслахуудын аппаратыг ажиллуулахаар хуульчилжээ.

Түүнчлэн ерөнхийлөгч байсан хүнд насан туршид нь ОХУ -ын Ерөнхийлөгчийн цалингийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хангамжийг сар бүр олгох, төрийн зуслангийн аль нэг өргөөг насан туршид нь ашиглуулахаар заасан. Хэрэв ерөнхийлөгч асан хүн дахин төрийн алба хашиж эхлэх /ерөнхий сайд, мужийн захирагч, төрийн албан хаагч зэрэг/ бол мөнгөн хангамжийг зогсооно. Энэхүү хуулиар бүрэн эрх нь дуусгавар болсон ерөнхийлөгчийн халдашгүй байдлыг хуульчилсан ба ерөнхийлөгч байхдаа хийсэн үйлдлийнх нь төлөө эрүүгийн ба захиргааны хариуцлагад татахыг хориглосон. Харин ерөнхийлөгч байх хугацаандаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, эрүүгийн хэрэг үүссэн тохиолдолд энэ хуулиар тогтоосон халдашгүй байдал үйлчлэхгүй юм.

Хуулиар тогтоосон халдашгүй байдал нь ерөнхийлөгч асны орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, хувийн баримт бичиг, харилцаа, холбоо, ачаа тээшинд мөн хамаарна. Ерөнхийлөгч асныг амьд сэрүүн байхад нь гэр бүлийн хүн нь болон ойрын төрлийн хүмүүс нь зуслангийн өргөөнд нь амьдрах ба тэдэнд мөн хамгаалалт гаргаж, урьд нь авч байсан эмнэлгийн үйлчилгээг үзүүлнэ.

Ерөнхийлөгч асныг нас нөхцсөнөөс нь хойш гэр бүлийнх нь хүмүүст түүнийг нас нөхчих үед нь хуулиар мөрдөж байсан өндөр насны тэтгэврийн хэмжээг 6 дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгоно. Мөн гэр бүлийнхэн нь нас нөхчсөнөөс нь хойш 5 жил албаны машин, эмнэлгийн үйлчилгээг авна. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Бүгд Найрамдах Кыргыз Улс

БНКырУ -ын Ерөнхийлөгч Алмазбек Атамбаев 2011 оны 12 дугаар сард “Бүгд Найрамдах Кыргыз Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны баталгааны тухай” хуулийг үндэслэн БНКырУ-ын Ерөнхийлөгч асан Роза Отунбаевагийн хангамжийн талаар зарлиг гаргажээ.

Энэхүү зарлигийн дагуу БНКырУ -ын Ерөнхийлөгч байсан Роза Отунбаевад БНКырУ-ын Ерөнхийлөгчийн цалингийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хангамжийг сар бүр олгох, тус улсын нутаг дэвсгэр дээр засгийн газрын холбоо болон бусад холбооны хэрэгслээр хангах ба мөн хурлын танхим, нисэх болон төмөр замын буудлын VIP танхимаар үнэ төлбөргүй үйлчлүүлэх, Ерөнхийлөгчийн хэрэг эрхлэх газрын харъяа эмнэлгийн нэгдлээс эрүүл мэндийн үйлчилгээ авах, жолоочтой авто машин, зуслангийн өргөөг насан туршид нь ашиглуулах, Улсын аюулгүй байдлыг хангах Хорооноос “Төрийн хамгаалалтын тухай” хуулийн дагуу бүрэн хэмжээгээр Ерөнхийлөгч асныг хамгаалалтанд авна.

Бүгд Найрамдах Энэтхэг Улс

Энэтхэгт Ерөнхийлөгч байсан хүмүүсийн тэтгэвэр, хангамжийг 1951 онд баталж, 1985,1990,1993, 1998, 2003 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Ерөнхийлөгчийн цалин, тэтгэврийн тухай хуулиар (The President’s 1 (emoluments and) pension act, 1951) зохицуулдаг. Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгч нар бүрэн эрхээ дууссанаас хойш ажиллаж байсан

үеийнхээ цалингийн 50% -тай тэнцэх тэтгэвэр авах эрхтэй. 2008 оны 9 дүгээр сарын 11 -нээс Ерөнхийлөгч сард 150000 рупий, Дэд ерөнхийлөгч 125000 рупийн цалин тус тус авч байна. (2012 оны 11 дүгээр сарын 2 -ны байдлаар 1USD = 53,64 рупий) Үүнээс гадна Ерөнхийлөгч асанд ашиглалтын зардлыг нь улсаас даах тавилгатай өргөө, 2 телефон, үндэсний роаминг бүхий үүрэн холбооны утас, автомашин, интернет ашиглах эрх олгоно. Эмнэлэгийн зардлыг улсаас даана. Хоёр хувийн нарийн бичгийн дарга, хувийн туслах болон хоёр үйлчилгээний ажилтантай байх бөгөөд офисийн зардал нь жилд 60000 рупий байна. Энэтхэгийн нутгаар аялахад нь дагалдах нэг хүний хамт онгоцны болон төмөр замын зардлыг нь дээд ангилалаар даана. Эдгээр зардлыг Засгийн газар хариуцна.

Ерөнхийлөгч асан хүн нас барсан тохиолдолд эхнэр (нөхөр) нь тавилгатай орон байр, нарийн бичгийн ажилтан, автомашин, телефон хэрэглэх эрхтэй байх бөгөөд мөн аялал жуулчлалын тодорхой хөнгөлөлт эдлэнэ. Дэд ерөнхийлөгч асан хүн офисийн ажилтантай байх бөгөөд жилд офисийн зардалд нь 60000 рупий олгоно. Нас барсан тохиолдолд нь эхнэрт (нөхөр) нь тавилгатай орон байр олгоно. Дэд ерөнхийлөгч асан хүний тэтгэвэр, хангамжийг Дэд ерөнхийлөгчийн тэтгэврийн хуулиар (The Vice - president’s pension act, 1997) зохицуулдаг.

2. Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байсан хүмүүсийн зарим эрх, үүргийн талаар

Холбогдох эх сурвалжуудаас хайлт хийж үзэхэд Зүүн Тимор Улс, Ангол Улсад бүрэн эрх нь хууль ёсоор дуусгавар болсон Ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчид зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар Үндсэн хуульдаа заасан байна.

Зүүн Тимор Улсын Үндсэн хууль, III бүлэг.

90 дүгээр зүйл. Төрийн зөвлөл.

1. Улсын Ерөнхийлөгчид улс төрийн зөвлөгөө өгөх эрх бүхий Төрийн зөвлөлийг Ерөнхийлөгч өөрөө тэргүүлнэ.
2. Төрийн зөвлөл нь дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:
   а/ Огцорсон, зайлуулагдсанаас бусад бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон улсын Ерөнхийлөгчид;
   в/ Үндэсний парламентын дарга;
   с/ Ерөнхий сайд;
   d/ Тухайн үеийн парламентаас бүрэн эрхийн хугацаандаа парламент дахь төлөөлөлтэй пропорциональ зарчмаар төрийн дээд байгууллагын гишүүн бус 5 иргэнийг томилох;
   е/ Ерөнхийлөгчөөс өөрийн бүрэн эрхийн хугацаандаа төрийн дээд байгууллагын гишүүн бус 5 иргэнийг томилох;

91 дүгээр зүйл. Төрийн зөвлөлийн бүрэн эрх, зохион байгуулалт, чиг үүрэг.

1. Төрийн зөвлөл дор дурдсан үүрэгтэй: Үүнд:
   а/ Үндэсний парламентыг тараах асуудлаар саналаа илэрхийлэх;
   в/ Засгийн газрыг огцруулах асуудлаар саналаа илэрхийлэх;
   с/ Дайн зарлах, энх тайван тогтоох асуудлаар саналаа илэрхийлэх;
   d/ Ерөнхийлөгчийн хүсэлтээр өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдол бүхий Үндсэн хуулиар зөвшөөрсөн аль ч асуудлаар саналаа илэрхийлэх;
   е/ Өөрийн дотоод дүрэм, дэгийн төслийг боловсруулах;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2. Төрийн зөвлөлийн хуралдаан олон нийтэд хаалттай байж болно.
3. Төрийн зөвлөлийн зохион байгуулалт, чиг үүргийг хуулиар тогтооно.

Ангола Улсын Үндсэн хууль, II бүлэг. Бүгд найрамдах улсын зөвлөл.

75 дугаар зүйл.

1. Бүгд найрамдах улсын зөвлөл нь Ерөнхийлөгчид улс төрийн асуудлаар зөвлөх байгууллага бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

   а/ Үндэсний ассамблейг тараах асуудлыг батлах;

   в/ Засгийн газрыг огцруулах асуудлыг батлах;

   с/ Дайн зарлах, энр тайван тогтоох асуудлыг батлах;

   d/ Түр хугацаагаар үүрэг гүйцэтгэж буй ерөнхийлөгчийн Ерөнхий сайдыг томилох, Засгийн газрыг огцруулах, Ерөнхий прокурор, Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга, Зэвсэгт хүчний янз бүрийн салбарын дарга захирагч нарыг томилох, чөлөөлөх асуудлаар гаргасан шийдвэрийг батлах;

   е/ Ерөнхийлөгчийн хүсэлтээр түүнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх;

   f/ Төрийн зөвлөлийн тогтоолыг батлах;

2. Төрийн зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцын тайлангаа гаргаж нийтэд ёслол төгөлдөр тунхаглана

76 дугаар зүйл.

Ерөнхийлөгчийн тэргүүлдэг Төрийн зөвлөл дор дурдсан гишүүдээс бүрдэнэ.Үүнд:
а/ Үндэсний ассамблейн дарга, в/ Ерөнхий сайд, с/Үндсэн хуулийн шүүхийн дарга, d/ Ерөнхий прокурор, е/ Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч, f/ Үндэсний ассамблейд төлөөлөлтэй намуудын дарга нар g/ Ерөнхийлөгч томилдог 10 гишүүн

77 дугаар зүйл.

1. Төрийн зөвлөлийн гишүүд Ерөнхийлөгчийн өмнө тангараг өргөнө.
2. Төрийн зөвлөлийн гишүүд нь Үндэсний ассамблейн гишүүдийн нэгэн адил эрх ямба эдэлнэ.

3. Зарим улс орнуудын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн[76] гишүүн байсан хүмүүс бүрэн эрх нь дуусгавар болсны дараа эрхэлсэн ажил, явуулсан үйл ажиллагааны талаар

АНУ-ын 39 дэх (1977 - 1981) Ерөнхийлөгч Жимми Картер ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж дууссаныхаа дараа дэлхий дахинд зөрчил, мөргөлдөөнийг тайван замаар шийдвэрлэх, хүний эрхийн төлөө идэхтэй үйл ажиллагаа явуулсан ба үүний төлөө 2002 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн байна. АНУ -ын Ерөнхийлөгчийн албан тушаалаа өгснийхөө дараа энэ шагналыг хүртсэн анхны АНУ -ын Ерөнхийлөгч юм. Үүний зэрэгцээ Ж.Картер Африк тивийн улс орнуудад энхийг сахиулах үйлс болон тэнд дэлгэрсэн дракункулёз өвчинтэй тэмцэх үйлсэд хүчин чармайлт гарган ажилладаг ажээ. Тухайлбал, түүний энэ үйл ажиллагааны үр дүнд Африкт энэ өвчнөөр өвчилсөн нийт 3.5 сая хүнээс өнөөдөр 1700 хүн л энэ өвчнөөр өвдөж байгаа гэсэн мэдээлэл байна.

[76] Хуулийг хавсаргав

АНУ -ын 42 дахь (1993 - 2001) Ерөнхийлөгч Билл Клинтон сүүлийн жилүүдэд маш идэвхтэй нийгмийн үйл ажиллагаа явуулж байгаа ба тэрээр олон янзын нийгэм, улс төрийн болон тусламжийн байгууллагын гишүүнээр ажиллаж байна. Тухайлбал, Билл Клинтон дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх зорилго бүхий Гурван талт комиссийн гишүүн ажээ. 2010 оны 1 сард Гайтид болсон хөнөөлт газар хөдлөлтийн дараа хохирсон хүмүүст тусламж үзүүлэх зорилгоор хэд хэдэн удаа тэнд очсон ба 2010 оны 3 сард НҮБ -ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн Билл Клинтоныг Гайтичүүдэд үзүүлэх олон улсын тусламжийн үйл ажиллагааг зохицуулахыг хүсчээ. Мөн тэрээр өөрийн бичсэн “Миний амьдрал” зэрэг номноос гадна бусадтай хамтран хэд хэдэн ном бичжээ[77].

Билл Клинтоны захиргаанд 1993 - 2001 онд АНУ -ын Дэд ерөнхийлөгч байсан Альберт Гор нь 2007 онд хүрээлэн буй орчныг хамгаалах талаар явуулсан үйл ажиллагаа болон цаг агаарын өөрчлөлтийн асуудлаар хийсэн судалгааны ажлынхаа төлөө Нобелийн энх тайвны шагнал хүртсэн байна. Тэрээр америкийн Current телевизийн Ерөнхийлөгчийн албыг хашдаг.

Их Британийн ерөнхий сайд асан Маргарет Тетчер 1992 онд 66 насандаа огцорсныхоо дараа өөрийн нэрэмжит сан байгуулан ажилласан бөгөөд 2002 он хүртэл олон улсын хэмжээнд улс төрийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж байв. Өөрийн улс төрийн карьерийн талаар «The Downing Street Years» (1993), «The Path to Power» (1995) гэсэн дурсамжийн хоёр боть хэвлүүлжээ.

1992 онд Сербийн талаас Боснид үйлдэж байсан харгислалыг зогсооход НАТО чухал үүрэг гүйцэтгэх ёстой талаар уриалсан нь энэ улсад энх тайван тогтооход ихээхэн нөлөөлсөн гэж үздэг. 1990-ээд онуудад барууны орнууд, үндэстэн дамнасан нефтийн компаниуд Каспийн тэнгисийн энергийн эх үүсвэрт холбогдоход Маргарет Тетчерийн Азербайджанд хийсэн айлчлал чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

1993-2000 онд АНУ-ын Вильгельм ба Мариягийн коллежийн, 1992-1999 онд Букингемийн их сургуулийн хүндэт ректороор сонгогдож байв. 2002 онд бичсэн “Statecraft: Strategies for a Changing World” ном нь дэлхийн олон хэл дээр хэвлэгджээ.

1999-2007 онд Бүгд Найрамдах Латви Улсын Ерөнхийлөгч асан Вайра Вике - Фрейберга нь нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ба НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай элч, Европын Холбооны урт хугацааны хөгжлийн асуудлаарх шинжээчдийн Бүлгийн дэд дарга байсан. Одоо Харилцан хүндэтгэх, хүлээцтэй хандах асуудлаарх Европын Зөвлөлийн (European Council on Tolerance and Reconciliation) гишүүнээр ажилладаг. Энэ байгууллага нь олон улсын засгийн газрын бус байгууллага бөгөөд Европ тивд бусдын үзэл бодол, амьдралын хэв маяг, зан заншилд хүлээцтэй хандах асуудлаар санал, санаачлага боловсруулах зорилготой юм.

Вайра Вике - Фрейберга нь Мадридын клуб байгууллагын гишүүнээр мөн ажиллаж байна. Тус байгууллага нь дэлхийн 80 гаруй орны ерөнхийлөгч, ерөнхий сайд байсан хүмүүсийг нэгтгэсэн, ардчилсан удирдлага, манлайлалыг бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бие даасан байгууллага ажээ. Тэрээр мөн Соёлтой Дипломатын Институтийн (ICD) зөвлөлийн гишүүн юм.

Роза Отунбаева Кыргызид 2010 дөрөвдүгээр сард болсон үйл явдлын дараа Кыргызийн Түр засгийн газрын Тэргүүн болсон ба улмаар 2010 - 2011 онд шилжилтийн үеийн Кыргызийн Ерөнхийлөгчийн албыг хашсан болно. 2011 оны 12 дугаар сарын 1 -ний өдрөөс Ерөнхийлөгчийн албаа дараачийн Ерөнхийлөгч Алмазбек Атамбаевт шилжүүлсэн. Үүний

[77] Loi n°55–366 du 3 avril 1955 relative au dйveloppement des crйdits affectйs aux dйpenses du ministиre des finances et des affaires йconomiques pour l’exercice 1955

дараа Роза Отунбаева “Роза Отунбаевагийн санаачлага” нэртэй Кыргызийн ард түмний хөгжилд зориулсан бүтээн байгуулалт хийх зорилготой олон улсын сан байгуулсан ба жил бүр үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ тодорхойлон ажиллах юм байна. 2012 оны үйл ажиллагааны санаачлага нь боловсрол, соёл, урлагийн хөгжил, залуучууд, эмэгтэйчүүдийг дэмжихэд чиглэгдэх юм.

Францын Ерөнхийлөгч байсан хүмүүс Францын Үндсэн хуулийн 56 дугаар зүйл ёсоор Францын үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүн болох эрхтэй байдаг тухай дээр өгүүлсэн. Тухайлбал, Франц улсын ерөнхийлөгч байсан хүмүүс болох Валери Жискар д’Эстен, Жак Ширак, Николя Саркози нар Францын Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Тэд энэ албан тушаалыг насан туршдаа хаших эрх зүйн зохицуулалтай болно.

5. Товч дүгнэлт

- Холбогдох эх сурвалжуудаас үзэхэд ҮАБЗ-ийн гишүүн байсан хүмүүсээс бүрдсэн ҮАБЗ-д зөвлөх үүрэг бүхий бүтэцтэй улс бидний судалгааны явцад олдсонгүй, харин Зүүн Тимор Улс, Ангол Улсад бүрэн эрх нь хууль ёсоор дуусгавар болсон Ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчид зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар Үндсэн хуульдаа заасан байна. Тус Зөвлөлийн гишүүний бүрэн эрх, чиг үүргийг мөн Үндсэн хуулиар хуульчилжээ.
- Францын Ерөнхийлөгч байсан хүмүүс Францын Үндсэн хуулийн 56 дугаар зүйл ёсоор Францын үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүн болох эрхтэй байдаг. Үндсэн хуулийн Зөвлөлийн гишүүн нь олон нийтэд хандсан мэдэгдэл хийх, тодорхой албан тушаалуудыг хаших болон зарим төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй байдаг байна.
- Дэлхийн ихэнх орон төрийн дээд албан хашиж байсан, ҮАБЗ-ийн гишүүн байсан хүмүүсийн хангамж, хамгаалалтын талаар эрх зүйн зохицуулалт хийсэн байдаг.

* * *

Хавсралт - 1

Former Presidents Act

(3 U.S.C. § 102 note)

(a) Each former President shall be entitled for the remainder of his life to receive from the United States a monetary allowance at a rate per annum, payable monthly by the Secretary of the Treasury, which is equal to the annual rate of basic pay, as in effect from time to time, of the head of an executive department, as defined in section 101 of title 5, United States Code [section 101 of Title 5]. However, such allowance shall not be paid for any period during which such former President holds an appointive or elective office or position in or under the Federal Government or the government of the District of Columbia to which is attached a rate of pay other than a nominal rate.

(b) The Administrator of General Services shall, without regard to the civil-service and classification laws, provide for each former President an office staff. Persons employed under this subsection shall be selected by the former President and shall be responsible only to him for the performance of their duties. Each former President shall fix basic rates of compensation for persons employed for him under this paragraph which in the aggregate shall not exceed $96,000 per annum, except that for the first 30-month period during which a former President is entitled to staff assistance under this subsection, such rates of compensation in the aggregate shall not exceed $150,000 per annum. The annual rate of compensation payable to any such person shall not exceed the highest annual rate of basic pay now or hereafter provided by law for positions at level II of the Executive Schedule under section 5313 of title 5. United States Code [section 5313 of Title 5. Government Organization and Employees]. Amounts provided for “Allowances and Office Staff for Former Presidents” may be used to pay fees of an independent contractor who is not a member of the staff of the office of a former President for the

review of Presidential records of a former President in connection with the transfer of such records to the National Archives and Records Administration or a Presidential Library without regard to the limitation on staff compensation set forth herein.

(c) The Administrator of General Services shall furnish for each former President suitable office space appropriately furnished and equipped, as determined by the Administrator, at such place within the United States as the former President shall specify.

(d) [Repealed. Pub. L. 86-682, § 12(c), Sept. 2, 1960, 74 Stat. 730. See sections 3214 and 3216 of Title 39.]

(e) The widow of each former President shall be entitled to receive from the United States a monetary allowance at a rate of $20,000 per annum, payable monthly by the Secretary of the Treasury, if such widow shall waive the right to each other annuity or pension to which she is entitled under any other Act of Congress. The monetary allowance of such widow--

(1) commences on the day after the former President dies;

(2) terminates on the last day of the month before such widow--

(A) dies; or

(B) remarries before becoming 60 years of age; and

(3) is not payable for any period during which such widow holds an appointive or elective office or position in or under the Federal Government or the government of the District of Columbia to which is attached a rate of pay other than a nominal rate.

(f) As used in this section, the term “former President” means a person--

(1) who shall have held the office of President of the United States of America;

(2) whose service in such office shall have terminated other than by removal pursuant to section 4 of article II of the Constitution of the United States of America; and

(3) who does not then currently hold such office.

(g) There are authorized to be appropriated to the Administrator of General Services up to $1,000,000 for each former President and up to $500,000 for the spouse of each former President each fiscal year for security and travel related expenses: Provided, That under the provisions set forth in section 3056, paragraph (a), subparagraph (3) of title 18, United States Code [section 3056(a)(3) of Title 18, Crimes and Criminal Procedure], the former President and/or spouse was not receiving protection for a lifetime provided by the United States Secret Service under section 3056 paragraph (a) subparagraph (3) of title 18, United States Code; the protection provided by the United States Secret Service expired at its designated time; or the protection provided by the United States Secret Service was declined prior to authorized expiration in lieu of these funds.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт - 2

H.R. 5938 (110th): Former Vice President Protection Act of 2008

One Hundred Tenth Congress of the United States of America AT THE SECOND SESSION
Begun and held at the City of Washington on Thursday, the third day of January, two thousand and eight

An Act

To amend title 18, United States Code, to provide secret service protection to former Vice Presidents, and for other purposes. Be it enacted by the Senate and House of Representatives of the United States of America in Congress assembled,

TITLE I--FORMER VICE PRESIDENT PROTECTION ACT SEC. 101. SHORT TITLE.

This title may be cited as the ‘Former Vice President Protection Act of 2008’.SEC. 102. SECRET

SERVICE PROTECTION FOR FORMER VICE PRESIDENTS AND THEIR FAMILIES.

Section 3056(a) of title 18, United States Code, is amended--

(1) by inserting immediately after paragraph (7) the following:

‘(8) Former Vice Presidents, their spouses, and their children who are under 16 years of age, for a period of not more than six months after the date the former Vice President leaves office. The Secretary of Homeland Security shall have the authority to direct the Secret Service to provide temporary protection for any of these individuals at any time thereafter if the Secretary of Homeland Security or designee determines that information or conditions warrant such protection.’; and

(2) in the sentence immediately preceding subsection (b) of section 3056, by striking ‘(7)’ and inserting ‘(8)’.

SEC. 103. EFFECTIVE DATE.

The amendments made by this Act shall apply with respect to any Vice President holding office on or after the date of enactment of the Act.

“ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ” ЗАРИМ АСУУДАЛ

(ОХУ, БНХАУ, АНУ, КАНАД УЛСЫН ЭРХЗҮЙН ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖИШЭЭН ДЭЭР)

Г. Чулуун

Өмнөтгөл

Төрийн өндөр албан тушаалтан [нийгэмд ил үзэгдэх] том эрх мэдэлтэй, хангалттай өргөн бүрэн эрхтэй байдаг. “Бусдаас давуулаг боломжит” энэ эрхэмийн дур зоргод хориг хязгаар тавихгүй бол тэрбээр албан тушаалаа урвуулан ашиглах замаар хувийн сонирхолоо гүйцэлдүүлэх боломжтой; гэж үзнэ. Албаны “бүрэн эрх” –ийн нэр нөлөөгөөр хувийн зорилгоо хэрэгжүүлнэ гэдэг улсын эрх ашигт хохирол учруулна; гэсэнтэй утга дүйх үг юм.

Монголд, төрийн өндөр [дээд] албан тушаалтны хамрах хүрээ УИХ –ын 2002.11.08 –ны өдрийн №73 тогтоолын агуулгаар дам тодорхойлогдсон байдаг. Захиалагчаас[78] ирүүлсэн хүсэлтэд “улстөрийн болон төрийн өндөр албан тушаалтны эрхийг [доорхи 3 чиглэлээр] хязгаарласан гадаадын улс орны[79] эрхзүйн зохицуулт” –ын талаар тухайлан анхаарах талаар дурдсан байв. Үүнд:

1. Төрийн өндөр албан тушаалтны “гадаадад, хадгаламжийн болон харилцах данстай байх” эрхийн хязгаарлалт;
2. Гадаадын харъяат эхнэр [нөхөр] –тэй төрийн албан тушаалтны эрхийн хязгаарлалт;
3. Төрийн өндөр албан тушаалтны гадаад оронд үнэт цаас эзэмших эрхийн

УИХ –ын 2002 оны 73 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад төрийн өндөр албан тушаалыг нэгбүрчлэн нэрлэж заасан ба тэрэн дотор төрийн захиргааны, төрийн тусгай, мөн, төрийн улстөрийн албан тушаалын аль аль нь багтдаг. Төрийн захиргааны болон төрийн тусгай алба [бол, хууль зааснаар] төрийн жинхэнэ албанд хамаарна. Мөн, Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлд, төрийн улстөрийн албан тушаалын нэр, хүрээг тодорхойлсон бөгөөд тэдгээр тушаалтнуудаас, ангилал зэрэглэлийнхээ дагуу төрийн өндөр албан тушаалтанд чухам аль нь хаана хамаарахыг дээрх 73 дугаар тогтоолоор нэгмөр шийдсэн юм.

Харин, гадаадын улс орны холбогдох хууль тогтоомжид, төрийн албан тушаалтны эрхийг [янз бүрээр] хязгаарлахдаа, хязгаарлалтуудыг их төлөв, төрийн албан хаагчийн зэрэг зиндаанаас гэхээсээ илүү, төрийн албаны зарчим, төрийн албаны ёс зүйн үүднээс [бүхэлд нь харж] нийтлэгээр тогтоохыг эрмэлзсэн гэж хэлж болохоор байдаг. Тиймээс, бид “төрийн албан тушаалтны эрхийн хязгаарлалтын асуудал” –ыг, гадаад улс орны хууль тогтоомжийн үзэл санааг “дагасхийн”, тэдгээрийг “нийтлэг өргөн хүрээнд” авч үзлээ.

Төрийн албан хаагчийн, түүний дотор төрийн өндөр албан тушаалтны эрхийн хязгаарлалын асуудал, түүний хамрах хүрээ, дэлхийн улс орнуудын хууль тогтоомжид [ерөнхийдөө, гадаад эхнэр нөхрийн асуулыг эс тооцвол] түгээмэл тусгалтай юм. Тэдгээр нийтлэг “арга хэрэгсэл” хуулийн хэрэгжилтийнхээ талаас хэлбэрэлтгүй байж чадаж гэмээнэ үр дүнгээ дүүрэн өгөх, асуудлыг бүрэн зохицуулах боломжтой гэж үздэг бөгөөд энэ чиг хандлагаар

[78] УИХ –ын гишүүн Ж. Батзандан, албан бичиг №10/3338, 2012.11.23;

[79] ОХУ, БНСУ, ... бусад;

эдүгээ зүүн Европын болон Азийн олон улс орон явж байна. Харин, Англи, Францын туршлагад “тэдний нийгмийн уламжлалт сэтгэлгээ” хэтэрхий гүн тусгалтай; тул бусад улс орнуудад таарамжаар сайн биш гэж үздэг; гэсэн. Тэндэхийн “эрхэм дээдсүүд” хэзээнээсээ “тусгай каст” маягтай явж ирсэн, тэднийг бэлтгэх, “гаргаж ирэх” тогтолцоо нь ч харьцангуй өөр гэдэг. Өөр нэг ажиглагдсан нийтлэг хандлага бол гадаадын улс орнуудад, төрийн албан хаагчийн эрхийн хязгаарлалтыг, голчлон “албан тушаалтны ашиг сонирхлын зөрчил” –ийн талбарт, мөн түүнчлэн, коррупцийн эсрэг бодлого тэмцлийн эрхзүйн хэм хэмжээний ерөнхий голдрилд хамаатуулан зохицуулдаг ажээ.

а) ОХУ –д

Төрийн өндөр албан тушаалтны эрхийг хязгаарлалтын чиглэлд өнөөг хүртэл үйлчилж ирсэн ОХУ –ын хууль эрх зүйн зохицуулалт [нийгмийн] шаардлага хангахгүй болсон, “хоцрогдсон” байна, түүнийг даруй өөрчлөх ёстой гэсэн байр суурьтай ОХУ –ын Төрийн думын хэсэг депутат шинэ хуулийн төсөл [саяхан] өргөн барьсан (2012.8.02) ба тэрхүү төсөл эдүгээ хараахан батлагдаагүй байна.

ОХУ –д хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид [эдгээр төслөөр санал болгож байгаа] асуудлууд тусгалаа огт олоогүй буюу өнөөг хүртэл тодорхой хуулийн зохицуулалтгүй явж ирснийг тэмдэглэн хэлэх нь зөв болов уу..

> Действующее законодательство Российской Федерации не предусматривает предлагаемые законопроектом запреты и ответственность для вышеперечисленных Лиц.

Хуулийн тэрхүү [хүлээгдэж буй] өөрчлөлтөөр, орост, төрийн өндөр тушаалтны “хадгаламжийн болон харилцах дансны асуудал” –ыг хэрхэн зохицуулах чиг төлөвтэй байгааг уг баримт бичийн эхээс шууд харъя. Хууль санаачлагчдын өргөн барьсан төсөл “Зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” гэсэн ерөнхий нэртэй бөгөөд түүний агуулгын холбогдох хэсгийг бид энд утгачилсан орчуулгатайгаар хураангуйлж авав.

Төрийн албаны “чиновник” –уудын ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах, өмч – бизнесийн чиглэлээрх эрх хэмжээг зохицуулах бодлого алхам ОХУ –д шинэ зүйл биш, үргэлж яригдсаар ирсэн хүлээлттэй хуучин асуудал юм. Энд тэрхүү оршсоор ирсэн хуучин асуудлыг “шинээр зохицуулах” тухай ярьж байгаа болно. Орост, “чиновник, сановник” гэж үзэгдэхүйц эрх мэдэл бүхий төрийн өндөр албан тушаалтныг хэлдэг. Энгийн, ардын “яриан хэллэг” юм. Хуулийн хэлэндээ [бол] тоочиж дуусахгүй урт нэр жагсаалтаар илэрхийлэгдэх зарим бэрхшээл үүсгэх тул “төрийн өндөр тушаалтан” гэдэг оноосон тойм нэрийг баримталж өгүүлэмжийг бяцхан хялбаршуулъя.

* * *

“Зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” (ОХУ, фед. закон) **-ийн төсөл**

Төслийн 1 дүгээр зүйлд,

- “Нэр бүхий албан тушаалыг хашиж буй төрийн албан хаагч, түүний эхнэр [нөхөр], мөн, гэр бүлийн насанд хүрээгүй хүүхдийн нэр дээр, гадаадын банкинд, гадаад улсын нутаг дэсвгэрт хадгаламж (депозит) –тай, үл хөдлөх хөрөнгөтэй, гадаадын компанийн үнэт цаастай байхыг хориглоно” [үүнээс гадна тэнд, өөр дэд заалтаар, төрийн өндөр тушаалтнуудад депозит болон харилцах данс нээхийг, мөн, гадаадад үл хөдлөх хөрөнгө, гадаадын компанийн үнэт цаас эзэмшигч болохыг хоригложээ] Дээрх нэмэлтийг “Коррупцийн эсрэг тэмцэх тухай хууль” -д оруулахаар төлөвлөж байгаа болно.

Төслийн 2 дугаар зүйлд,

- дээрх 1 дүгээр зүйлд заасныг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тухай [энд] дурджээ. Хууль зөрчигчийг энэ тохиолдолд “5 – 10 сая рубль – ээр торгох, эсхүл, 5 хүртэлх жилийн хорих ял оноон тодорхой нэр бүхий албан тушаал хаших эрхийг нь 3 хүртэл жилээр хасна” гэсэн байна. Энэ өөрчлөлтийг хууль санаачлагчид ОХУ –ын Эрүүгийн хуульд оруулахаар төлөвлөжээ.

> Хуулийн төсөлд нь «... наказывается штрафом в размере от пяти до десяти миллионов рублей или лишением свободы сроком до пяти лет с лишением права занимать определенные должности на срок до трех лет» гэсэн заалт орсон.

Төслийн 3 дугаар зүйлд,

- Нэр бүхий албан тушаал хашигч төрийн албан хаагчид, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэх үед (2013.01.01) –д [түүнд хамаатаж байсан] хадгаламжийн болон харилцах дансны, мөн түүнчлэн, гадаадад байгаа үл хөдлөх өмч хөрөнгө, гадаадын компанийн үнэт цаасны асуудлаа 2013.6.01 – ний дотор [энэ] хуулийн өөрчлөлтөд нийцүүлэн нэг мөр цэгцэлж дуусгасан байх; -ыг заасан.
- Нэр бүхий албан тушаал хашигч төрийн албан хаагч хэрэв (энд дурдаж буй төрөл зүйлд хамаарах) данс, өмч хөрөнгийг бусдаас өвлөлийн журмаар авсан бол тэдгээрийг өвлөж авсан өдрөөсөө хойш 1 жилийн дотор “отчуждение” хийх замаар хуульд нийсэн арга хэмжээ авна.

> Иргэний эрх зүйд “отчуждение” гэдэг нь, - передача имущества в собственность другого лица; один из способов осуществления собственником правомочия распоряжения своим имуществом. Различаются отчуждение возмездное (купля - продажа) и безвозмездное (дарение)\

- Нэр бүхий албан тушаалд шинээр томилогдсон албан тушаалтан, тухайн ажилд томилогдсоноосоо хойш 6 сарын дотор хадгаламжийн болон харилцах дансны болон гадаадад байгаа үл хөдлөх хөрөнгө, гадаадын компанийн үнэт цаасны асуудлаа хуульд нийцүүлэн цэгцэлж дуусгана.

- Нэр бүхий албан тушаалаас чөлөөлөгдсөн (халагдсан) хүний энэ хуулиар хязгаарлагдаж байсан [эдгээр] эрх, түүнийг халагдсанаас хойш 3 жилийн дотор эргэж сэргэхгүй.

Хуулийн төсөлд, өмнө дурдсан эрхийн хязгаарлалтуудыг “тодорхой нөхцөлд хэрэглэхгүй байх” тохиолдлуудыг ч нэмж зааж өгчээ. Үүнд:

a) алба үүргийн гүйцэтгэлийг хангах зориулалтаар [энд зааж тодорхойлсон] төрийн нэр бүхий өндөр тушаалтан гадаадад харилцах данстай, өмч хөрөнгөтэй байж болно.
b) мөн, нэр бүхий албан тушаал хашигч төрийн албан хаагч, шаардлагатай тохиолдолд зөвхөн боловсролын зориулалтаар ба эмнэлгийн туслалцаа авах зорилгоор гадаадад харилцах данстай байх, түүнийг нээлгэх, ашиглах эрхтэй.

“Зарим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” (ОХУ, фед. закон) -ийн төсөл уртаашаа 4 заалттай цомхон юм. Холбооны хуулийн төсөл [энэ агуулгаараа] өөрчлөлтгүйгээр батлагдвал, хуулийг 2013.01.01 –ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр тусгажээ.

(ОХУ -ын) **Төр засгийн өндөр тушаалтны гадаад дахь үл хөдлөх хөрөнгийн тойм зураг**

Хууль санаачлагч зарим депутатууд (И.Пономарёв, С.Железняк ... нарын зэрэг) -ын ярьж “нотолж” байгаагаар “Төрийн өндөр албан тушаалтан, төрийн Думын депутат (тэдгээрийн гэр бүл) гадаадын банкинд хадгаламжийнхаа 50% -аас дээш хэсгийг хийсэн тохиолдолд Холбооны аюулыг хамгаалах газар (ФСБ) –аас түүнийг “анхаарах”, мөрдөх үүргэтэй. ФСБ хяналын хүрээнд орсон “объект” –ын “гадаадын эрх ашгийн төлөө ажиллаж байгаа эсэх” -ийг болон түүний хамаатан садан гадаадын тагнуул эсэхийг шалгаж тодруулах ёстой.

ОХУ –ын төрийн өндөр албан тушаалтан, улстөрчид гадаад улс оронд өмч хөрөнгөтэй, гадаадын банкинд данс хадгаламжтай байх тэр тохиолдолд, тэд хүссэн хүсээгүй “сэтгэлзүйн хүлээстэй” болно. “Гадаадын агент” гэсэн хэллэг хуулийн төсөлд орох [хэрэглэгдэх] боломжтой. Тэгээд ч ер нь, сонгогч түмэн тийм өмч хөрөнгийн үүсэл гарвалыг нь мэдэх эрхтэй. Энэ бүхэн тунгалаг төрийн төлөө хийх нэг алхам” гэнэ. И.Понамарев нарын энэ аргумент төслийн хэлэлцүүлгийн урьдчилсан шатанд олонхийн дэмжлэг авсан байдаг. Хуулийн энэ төсөл хэлэлцүүлгийн шатандаа яваа юм.

* * *

ОХУ –д, гадаадын харъяат эхнэр (нөхөртэй) хүнийг төрийн албанд ажиллуулахгүй байх чиглэлд бас нэг өөр хуулийн төсөл [өмнөхтэй зэрэгцээд] явж байгаа. Хууль санаачлагчдын тэрхүү төсөлд “ОХУ –ын төрийн албаны өндөр тушаалтан гадаадын хүнтэй гэр бүл болж болохгүй” –г хуульчилахаар тусгажээ. Энэ [төсөл] хууль болж гарсан тохиолдолд, “төрийн өндөр тушаалтны эхнэр (нөхөр) гадаадын харъяат байх ахул, тухайн албыг уг тушаалтан хаших эрхгүй; буюу, гадаад хүнтэй гэр бүл үүсгэвэл тэрхүү төрийн өндөр албан тушаалтан “ажлаасаа чөлөөлөгдөх” юм.

Хууль санаачлагчдын өгүүлснээр, тэд, ийм арга замаар төрийн албаны нууц гадаадад алдагдахаас сэрэмжлүүлж байгаа аж. Гадаадын хүнтэй гэр бүл болсон явдал нь өөрөө тухайн хүний хувьд “гадаадаас хараат” байх [нэг] үндэс мөн; гэж тэд үзсэн байна. Төрд ажиллах хүн сонголтоо өөрөө хийнэ. Гадаад эхнэрээ дагах уу гос-албаа дагах уу гэдэг нь “тухайн хүний өөрийнх нь хэрэг” байх юм.

Энд нэг зүйлийг нэмж дурдах ёстой. ОХУ –ын хувьд, Тусгаар тогтносон хамтын нөхөрлө-

лийн орнууд [СНГ] –ыг бусад улс орнуудаас ялгамжтай авч үзэж байгаа. Үүнийг хууль санаачлагчид “ЗХУ –ын үед буюу бид саяхан болтол үндсэндээ нэг хэл соёлтой нэг улс үндэстэн байсан учраас, СНГ –ийн орнуудад бусдаас “өөрөөр хандах” учир шалтгаан байна; хэмээн тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, СНГ –ийн онуудад оросын төрийн албан хаагчийн хадгаламж, харилцах данс, үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас ... мөн, гадаад эхнэр [нөхөр] –т хамаатах эрхийн хязгаарлалтууд хийгдэхгүй.

- Стоит отметить, что страны СНГ не войдут в реестр зарубежных государств, где непозволительно российским чиновникам, банкирам и госслужащим иметь недвижимость.

Гэвч, хууль санаачлагчдын дээрх төслүүдийг бусад зарим депутатууд “маргаантай, бүтэшгүй” асуудал гэж хатуухан шүүмжилсээр байна. Тиймээс, хуулийн [эдгээр] төслүүд амархан батлагдахааргүй байдал ороод байгаа болно. Эсэргүүцэгч талын сөрөг үндэслэлүүд ихэнхдээ ерөнхий шинжтэй байв. Жишээлбэл,

Хуучин ЗХУ –ын үед зөвлөлтийн хүн гадаадын иргэнтэй гэр бүл болох бүтгүүлэх явдал үндсэндээ “хориотой шахуу” амаргүй асуудал байсан. Хууль санаачлагчдын энэ мэт “глупость” заримдаа эмгэнэлт инээдэмийн хэмжээнд бууж ирж байна. Энэ бол ухралт. Төрийн өндөр албан тушаалтны хилийн чанад дахь өмч хөрөнгийг шалгаж ... тоолж тогтоох нь “технически талаасаа бараг боломжгүй, бүтэшгүй талдаа” ажил юм.

- Асуудлаа хууль санаачлагчид төсөлдөө [бас] буруу томъёолсон байна. Зүй нь, гадаадын харъяат эхнэр нөхөртэй хүнийг төрийн өндөр албан тушаалд томилохыг хязгаарласан зүйл заалт [гэж] ярих хэрэгтэй мэт. Гэтэл төсөлд эсрэгээр нь өгүүлээд байна. Иргэнээ “гадаадын хүнтэй гэрлэхийг хориглоно” гэдэг түгээмэл эрх зүйн үүднээс байж боломгүй алхам ... г. м.

- Бидэнд барьж авч яаралтай шийдүүштэй улс орны ахуулгүй байдал ахуул занал учруулсан “илүү” бодит том том асуудал хангалттай их байна. Бид чоно харахгүй, хулгана зурмаар хөөцөлдөөд байна. (Мы стреляем по воробьям, не замечая бегемотов) Төрийн өндөр тушаалтны гадаадад байгаа хөрөнгө - хадгаламжийн тухайд бол “онц их хэмжээтэй” –г нь хориглож болох юм. Асуудлыг хавтгайруулмааргүй байна. Макро түвшний том юмаар оролдмоор байна.

- Оросын улстөрийн мэдээллийн төв (Москва) -ийн Ерөнхий захирал проф. А. Мухин хууль тогтоогчдын гаргасан энэхүү санал санаачлагыг “Энэ бүхэн хэрээс хэтэрсэн хоосон сүржигнэл. Хэт өргөн хүрээг хамарсан ... [баахан] хатуурхсан ийм олон хориг тээг баруунд боловсрол эзэмшсэн өнөөгийн олон зуун шилдэг удирдагчдыг айлган дайжуулж, тэднийг төрийн албанаас арга буюу дутаахад хүргэнэ” гэж шүүмжлээд, эцсийн бүлэгт, төрийн Думын чуулганы хуралдааны танхимд саруул ухаан ялж [уг асуудал дээр] “бүхнийг хаах, бүгдийг хорих” гэсэн арга хандлагаасаа бид татгалзаж таарах байх. Иргэн хүний конституциар хамгаалагдсан эрхэд халдаж болохгүй. “Чиновники тоже люди” (тэд ч мөн хүн шүү дээ) гэжээ.

b) БНХАУ –д

Хятадын нийгэм улстөрийн тогтолцоо манайхаас эрс өөр. Төрийн өндөр тушаалтны “сахилга бат” –ын асуудлыг тэнд Хятадын коммунист намын “Намын төв комисс” (1970 –аад оноос хойш) хариуцдаг. 2007 онд Авилгын эсрэг байгууллагатай болсныг “хянан шалгахын сайд” удирддаг. Тус байгууллагын нэг чиг үүрэг нь “... асуудалд шууд болон дамаар холбогдсон төрийн түшмэдүүдийг хариуцлагаас мултрах бололцоогүй болгох, хяналтыг эрчимжүүлэн чангатгах” явдал юм.

БНХАУ –ын Төрийн зөвлөлөөс төрийн түшмэдүүдийн эрхийг “энд хөндсөн чиглэл” –ээр хатуу чанга хязгаарласан байдаг. Хятадын төрийн зөвлөлийн циркулярт,

- Төрийн эрх мэдэлтэн биржийн акци бэлгэнд авч болохгүй;
- Байшин ба автомашиныг “эргэлзээ төрүүлэм бага үнээр” хямдхан худалдан авч болохгүй;
- Төрийн албан хаагч мөрийтэй тоглох аваас түүнийг авилгын мөнгөө “угаасан” хэмээн үзнэ;
- Төрийн алба тушаалаас (огцорч) буусны дараа өндөр цалинтай ажил албанд очих талаар хэн нэгэнтэй тохиролцохыг хориглоно; ... гэхчилэнгээр заасан байдаг.

Хятадын авилгын эсрэг тэмцлийн нэг онцлог тактик нь “төрийн эрх мэдэлтнийг нэг ажилд, “нэг газар” удаахгүй байх, тэднийг ротацаар байнга сэлгэн өөрчлөх” явдал юм. Энэ арга “үр дүнтэй” гэдгээ цаг хугацааны уртад хангалтай нотолсон; гэж тэнд үздэг ажээ.

Хятадын авилгын эсрэг кампанит ажлын эрчимжилтийн бас нэг илрэл нь “хөдөөгийн элит” –үүдийн үйл хөдлөлийг хянах явдал; гэнэ. Энэ нь, манай зарим улстөрчдийн сүүлийн үед сөхөж ярих гээд байгаа “орон нутгийн олигархи” –ийн асуудал мөн бололтой. Хятадын, нам төвт улстөрийн тогтолцоо “намын орон нутгийн удирдлагын [өнөөгийн] бие даах гэсэн зарим байдлыг” илт таашаахгүй байгаа бөгөөд, тэднийг, дээрээс, төвөөс шууд “хараат байдалд барьж” байх чиглэлд урьдын адил анхаарсаар байна.

c) Канадад

Канадад төрийн албан хаагчийн ашиг сонирхлын нийтлэг зөрчлийг шийдэхтэй зэрэгцүүлээд “парламентын коррупцийн эсрэг” бодлогын явцуу хүрээг ч давхар анхаардаг байна.

Канадын хууль тогтоомжоор, бизнесийн талбарынханы улстөр хийх боломжийг “байх ёстой үзэгдэл” –ийн хэмжээнд, “тодорхой хүрээ хязгаарын дотор” авч үздэг. Парламентын гишүүдийн бизнесийн ертөнцтэй холбогдох хэм хэмжээг, тэнд, эрхзүйн талаас нь нарийн тохируулахыг эрмэлзсээр иржээ. Энд, хандлагын хэд хэдэн чиг байх бөгөөд, тэдгээрт,

- Парламентын гишүүний ба тухайн хүний бизнесийн менежерийн үүргийн зөрчилдөөнийг шийдэх;
- Парламентын гишүүний үнэт цаас эзэмших эрхийн асуудал;
- Парламентын сонгуулийн кампанийн үед сурталчилгааны зориулалттай санхүүгийн эх үүсвэр олох зарцуулах тухай асуудал ... зэргийг дурдаж болно.

Парламентын гишүүний [улстөрийн] үүрэг хариуцлага тухайн гишүүний эдийн засгийн ашиг сонирхол хоорондоо “зөрчилдөхгүй” байх нэг гол нөхцөл нь ... албан тушаалтны үйл ажиллагааны тайлагнал, ил тод байдал гэж үзнэ. Канадад, парламентын гишүүний эрхийн хязгаарлалтын асуудлыг “конституцийн ба эрүүгийн хууль” –ийн агуулгын хязгаар дотор авч үзэж Норм[80] тогтоожээ. Энэ Норм парламентын 2 танхимын бүх гишүүдэд төдийгүй засгийн газрын гишүүдэд ч хамаарна.

Канадын эрүүгийн хууль парламентын коррупцийн илрэлийн нэг тод хурц хэлбэрт тооцогддог “гишүүний авилгал” -ыг үндсэн хууль зөрчсөн ... бүр, **урвалт** (государственная измена) –ын хэмжээнд авч үздэг байна. Ийм зөрчил гаргасан парламентын гишүүнд 14 жил хүртэл хугацаагаар хорих ял оноох бөгөөд шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон мөчөөс эхлэн тухайн “гишүүний мандат” автоматаар хүчингүй болно.

[80] Собрание законодательства Российской Федерации, 1996, N 25, ст. 2954;

Канадад, [жирийн] парламентын гишүүн үнэт цаас эзэмших, бизнесийн байгууллагадаа пост эзлэх эрхтэй ч, энэ “нээлттэй эрх” нь хуулийн олон “нөхцөл” –үүдээр тодотгогдожээ.

> Все депутаты обязаны ежегодно сообщать в письменном виде подробные данные о компаниях, в которых они являются директорами, менеджерами или служащими, а также о корпорациях или фондах, ценными бумагами которых они владеют.
>
> В связи с существованием указанных ограничений современные канадские парламентарии предпочитают не заниматься предпринимательством после прихода в политику. Лишь некоторые из них сохраняют побочный род занятий - юридическую или медицинскую практику, которая может считаться специфическим видом бизнеса. Часть депутатов владеет небольшими пакетами акций, обычно в семейных фирмах.

1985 онд канадад төрийн албан хаагчийн Эд хөрөнгийн этикийн кодекс (нийтлэг дүрэм) батлагдсан бөгөөд уг дүрмээр ашиг сонирхлын зөрчлийн үед төрийн албан хаагчийн баримтлах байр суурь, ёс зүйн хэм хэмжээг нэгмөр тогтоожээ. Эд хөрөнгийн этикийн дүрмийн агуулга 4 хэсэгтэй бөгөөд түүний 2 дахь хэсэгт, энд бидний тухайлан сонирхоод байгаа “төрийн албан хаагчийн зарим эрхийн хязгаарлалт” –ад холбогдох асуудлууд хөндөгдсөн байна. Төрийн албан хаагчийн Эд хөрөнгийн этикийн дүрэм ёсоор, төрийн албан хаагч доорхи шаардлагыг заавал биелүүлэх үүрэгтэй. Үүнд:

a) Төрийн албанд тохоон томилодсоноосоо хойш 60 хоногийн дотор эрх бүхий байгууллага албан тушаалтанд [өөрийн] Өмч Хөрөнгийн Илтгэл бичиж өгнө. Илтгэлд бичигдвэл зохих өмч хөрөнгийн төрөл болон хүлээх үүрэгт,
   - [эзэмшиж байгаа] корпорац, компанийн акци, облигац;
   - янз бүрийн хувийн компани корпорацийн зүгээс тэдгээрт тавигдах хяналт;
   - газар эзэмших төрөл бүрийн эрх;
   - ашиг орлого өгдөг өмч хөрөнгө, тоног төхөөрөмж;
   - гадаад валют; (хэрэв тэдгээрийг “сэгсэрч хөдөлгөж” ашиг олдог бол)
   - бусдад олгосон зээл;
   - албан үүрэг гүцэтгэх үед ашиг сонирлын зөрчил үүсгэж болох бусад учир шалтгааныг [нэмж] дурдах;

b) Ашиг олох зориулалтгүй, мөн хувийн хэрэглээний эд зүйлс, өмч хөрөнгийг Илтгэлд дурдахгүй. Энэ төрлийн өмчид дараахь эд зүйлс орно. Үүнд:
   - орон сууцны байшин барилга;
   - гэр бүлийн эдлэн газар, зуслан;
   - мебель тавилга;
   - урлагийн бүтээл, хуучны үнэт эдлэл;
   - автомашин түүтэй адилтгах бусад төрлийн хувийн эзэмшлийн техник;
   - үнэт цаас, биет мөнгө; ... г. м.

Төрийн албан хаагч ашиг сонирлын зөрчил үүсгэх боломжтой эд хөрөнгөө худалдах, эс бөгөөс, итгэмжлэгдсэн этгээдийн нэр дээр (томилогдсоноосоо хойш 120 хоноийн дотор) түр шилжүүлэх эрх үүрэгтэй. Энэ зорилгоор, эд хөрөнгөө эхнэр (нөхөр), гэр бүлийн бусад гишүүдийн нэр дээр шилжүүлэхийг хориглоно, ингэж шилжүүлэхийг “хуулийн тодорхой зүйл заалтын үзэл санааг гуйвуулан, түүнийг ёс бусаар тойрох оролдлого” гэж үзнэ.

Канадад төрийн албан хаагч эрхэлсэн ажлынхаа хажуугаар, түүнтэй “ашиг сонирхлын харшилдаан үүсгэхгүй” тийм ажил үйл эрхлэх боломжтой гэж үздэг. Дүрмийн шаардлага биелүүлээгүй түүнийг зөрчсөн албан хаагч эрхэлж буй ажлаасаа халагдах хүртэл шийтгэл хүлээнэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

c) АНУ –д

1990.10.17 –нд АНУ –ын Ерөнхийлэгчийн № 12731 захирамж - тушаал гарч, түүгээр тэнд, төрийн [гүйцэтгэх салаа мөчрийн] өндөр тушаалтны дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг тогтоожээ. Тэнд, “төрийн алба бол дотор нь ажилласан хүн нь санхүүгийн ямар нэгэн ашиг хонжоо харах ба бодох боломжгүй тийм алба” гэж тодорхойлжээ. АНУ –д, төрийн өндөр тушаалтан эрхэлж буй албан тушаалынхаа цалингаас өөр нэмэгдэл орлого боломж хязгаарлагдмал явж ирсэн уламжлалтай. АНУ –ын Ерөнхийлэгчийн томилсон төрийн өндөр албан тушаалтан бүрэн эрхийнхээ хугацаанд өөр бусад ямар ч нэр хэлбэрийн нэмэлт орлого олох эрхгүй юм.

Америкийн төрийн өндөр тушаалтнуудын “ашиг орлого” –ын асуудлыг дээрх захирамжаас гадна, Засгийн газрын ёс зүйн Акт [Акт об этике в правительстве, 1978] –аар зохицуулагддаг. Захирамжлалын тэрхүү Акт анх гарч хэрэгжихдээ Цагаан ордны болон салбарын яамдын бүх түшмэлээс доор дурдсан мэдээллийг “тусгай заавар журмын дагуу” 90 хоногийн дотор багтаан гаргуулж авсан байдаг. Үүнд:

1. Тухайн түшмэл өөрөө шууд болон эхнэр (нөхөр), гэр бүлийн бусад гишүүдээрээ дамжин ямар нэгэн байдлаар [үйл ажиллагаагаар] холбогддог корпорац, компани, пүүс, бусад бизнесийн байгууллага, мөн түүнчлэн ашгийн бус байгууллага, боловсролын байгууллагуудынхаа нэрийн бүрэн жагсаалтыг гаргаж өгнө.

   Энд яригдаж байгаа “ямар нэгэн байдлаар холбогдох” гэдэг нь нилээн өргөн утгатай юм. Под «делом» в данном случае понимается «любой сохраняющийся финансовый интерес и любые связи» чиновника с этими организациями независимо от того, в каком качестве он выступает.

2. Батлагдсан журам ёсоор төрийн түшмэл (чиновник), түүний эхнэр нөхөр, гэр бүлийн хамт амьдардаг гишүүдийнхээ хаанаас зээл авсан [тэдгээр] зээлдүүлэгчдийнхээ жагсаалтыг ч мөн гаргана.

3. Өмнөх пунктүүдэд дурдсан түшмэл, түүний гэр бүл, гэрбүлийн гишүүд өөрсдийн нэр дээр байдаг үл хөдлөх хөрөнгийн талаархи мэдээллээ гаргаж өгнө.

“Журам” –ын хэрэгжилтийн хүрээнд шаардлагатай бол “тухайн төрийн байгууллагын дотоод хяналтын албан ёсны бүтэц” –ээр дамжуулан түшмэдийн “мэдүүлэг” –ийг шалгах тодруулах, “ярилцлагад дуудах”, “нягтлах” замаар нэмэлт мэдээлэл гаргуулж авах боломжтой. Шалгалт явуулсан албан тушаалтан, комисс, групп шаардлагатай гэж үзвэл тухайн албан тушаалтаныг “холбогдох газарт өгч” асуудлыг эцэслэн шийдүүлэх механизм бүхий ажээ.

Америкт, Хууль тогтоогчдын ёс зүйн Дүрэм (1977) бий бөгөөд энэ дүрмийн үйлчлэлийн хүрээ Конгрессийн гишүүдэд төдийгүй түүний аппаратын ажилтнуудад ч хамаатай. Тэндэхийн чиновникуудын ашиг орлогын мэдүүлэгийн дэг харьцангуй өвөрмөц юм. Дээд танхимынханд зориулсан, тогтсон хэв загвар бүхий хавсралт – маягтыг Сенатын ёс зүйн хороо боловсруулна.

Мэдүүлэгийг Сенатын ажлын албанд өгнө, өгөх өрөөнийх нь дугаар (SH - 232) –ыг хүртэл зааж журамласан нарийн процедуртай. Сенатад нэр дэвшигчийн мэдүүлгийг [хүртэл] тэнд авч байгаа нь зарим талаар эргэзээтэй ... сонгуулийн хорооны ажлыг хийгээд байна уу гэмээр. Мэдүүлгийг нэр дэвшигч, дэвшсэн өдрөөсөө хойш 30 хоногийн дотор, сенаторууд болон сенатын ажлын албанхан жил болгон тогтсон хугацаанд гаргадаг.

Подавать декларацию обязаны сенаторы, кандидаты, баллотирующиеся в Сенат (противоречивое, но, надо полагать, эффективное требование), а также чиновники различных рангов, служащие Сената. Подаваться декларация должна ежегодно, а для кандидатов - в течение 30 дней с момента выдвижения кандидатуры.

* * *

Улс үндэстнүүд хоорондоо бие биенээсээ харилцан хамааралтай “байнгын өрсөлдөөний орчинд” оршдог. Хэдий тийм ч төрийн өндөр тушаалтны гадаад дахь өмч хөрөнгө, гадаадын харъяат эхнэр (нөхөр) бол “энэ өрсөлдөөнд” [аль нэг талд] сөргөөр ашиглагдах сэжим болдог гэх үзэл хандлагын зөв эсэх нь маргаантай хэвээр байна. Гэсэн ч, төрийн түшмэлийг “гадаадаас удирдах” –д сөргөөр ашиглагддаг [гэх] эдгээр “механизм” –ыг хуулийн хүрээнд хаах оролдлого улс орнуудад гарсаар байна.

Асуудлыг хаанаас яаж харахаас бүх зүйл хамаарна. Энд, оросын хөрөнгөлөг сановникуудын “эргэлзээт зарим үйлдэл” –ийг, мөн украйны В. Ющенко, гүржийн М. Саакашвили –ийн эхнэрүүдийн “нөлөөлөөгүй нөлөө” –г сонгодог жишээнд дурдах нь элбэг ажээ. Гэхдээ, эдгээр үзэл хандлага ихээхэн субъектив шинжтэй “барьцгүй”[81] гэдгийг зориуд энд тэмдэглэн хэлэх нь зөв болов уу.

Төрийн өндөр тушаалтны эрхийн хязгаарлалтын асуудлыг “ашиг сонирхлын зөрчил, авилга хээл хахуулийн цогц хүрээнд хамаатуулж үздэг; тухай өмнө бид дурдсан. Коррупцийн эсрэг тэмцэл эдүгээ улс дотоодын хүрээнээс хэдийнэ хальж, улам бүр улс гүрэн дамнан хэрэгжих глобаль шинжтэй үйл явц болсоор байна. Тиймээс, Олон улсын хамтын нийгэмлэг улс дамнасан (транснациональ) коррупцийг хазаарлах чиглэлд хүч анхаарлаа чиглүүлж байна. Гэвч, хэдийгээр улс орнуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо энэ чиглэлд бэхжиж байгаа ч гэсэн, төрийн өндөр эрх тушаалтны өмч хөрөнгө данс хадгаламжийн хяналтын тогтолцоонд, мөн түүнчлэн, “төрийн өндөр тушаалтны гадаад эхнэр (нөхөр) –ийн асуудалд учирч байгаа саад бэрхшээл “хүний эрх” –ийн конституциональ шинжтэй учраас олон улсын түвшиндээ нэгмөр шийдэгдэх магадлалаар ч өндөр биш юм.

ОХУ –ын Төрийн Думын спикер Сергей Нарышкины зүгээс “оросын төрийн албан хаагчийн гадаад дахь банкны дансны болон гадаад дахь үл хөдлөх хөрөнгийн эрхийг хязгаарлах, хориглох [гадаад эхнэр нөхийн асуудал ч мөн өөрцгүй] тухай хуулийн төсөл бол авилгатай тэмцэхтэй асуудалтай огт хамаатахгүй, түүнээс тэс өөр асуудал” гэж мэдэгдсэн нь “тухайлсан төсөөт зохицуулалтын хуучин хамаарч ирсэн нийтлэг хил зааглалыг” эргэж харахад хүргэхүйц ... ихээхэн анхаарал татахаар үг юм.

2012.12.03

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[81] М. Саакашвили –ийн эхнэр Сандра Рулофс голландын харъяат, харин, В. Ющенко –ийн эхнэр 2005 онд АНУ –ын харъяатаас татгалзжээ. Хугацааны хувьд илүү холын түүхэн тод жишээ манайд ч мөн бий. Бал даргын эхнэр А. Филатова –ийн зарим үйлдэл “гадаадын тагнуулын шинж бүхий” байсан тухай оросын сэтгүүлчийн монголд хэвлэгдсэн бүтээлд тэмдэглэгдсэн нь бий.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ТАВИХ ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

Б. Нарантуяа

1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

1.1. ОХУ дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай асуудал

ОХУ-ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлыг ярихад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдлага, сэтгүүлчдийн чадвараас гадна улс төрөөс хараат бусаар мэдээлэх, дарамт шахалтгүйгээр ажиллах орчны талаар хөндөх болдог. Оросын хэвлэл мэдээлэлд телевиз, радио, тогтмол хэвлэл болон интернэтийг багтаах ба ОХУ -ын хуулийн дагуу улсын болон хувийн өмч байна. Орчин үеийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний орчин, нөхцөл байдал, үзэл бодол нь олон төрлийн олон улсын байгууллагуудаас шүүмжлэл хүлээсээр байна. Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагаас ОХУ бол Европын улсуудаас сэтгүүлчдэд хамгийн аюултай улс гэж үзжээ[82].

Үндсэн хуулиндаа хэвлэлийн болон үг хэлэх эрх чөлөөг зарлан тунхагласан /**Эрх зүйн орчин хэсгээс үзнэ үү**./ боловч шүүхийн тогтолцоон дахь хээл хахуул болон улс төржих асуудал нь санаа зовоох бөгөөд хэдхэн үлдсэн хараат бус сэтгүүлчдээ мөрдөх, хэрэгт татах зэрэгт албаны хүмүүс хэрэглэж байв. Эрх баригчид засгийг шүүмжлэх, түүний дотор хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид хэт туйлширч байна гэж үзэж байжээ. 2010 онд авлига, хээл хахуул, дотоодын терроризмын халдлага болон улсын эдийн засгийн хямралын хажуугаар ОХУ дахь хэвлэлийн эрх чөлөө тун хангалтгүй, тааруухан хэмжээнд байсаар байна.

2010, 2011 оны байдлаар иргэний болон эрүүгийн хэргүүдийн ихэнх нь сэтгүүлчдийн эсрэг чиглэсэн байв. Тухайлбал, 2010 оны 11 сард Москвагийн Химкийн шүүхэд Михайл Векетов эрүүгийн гүтгэлгийн хэрэгт буруутгагдсан ба Химки хотын дарга Владимир Стрелченко телевизэд өгсөн ярилцлагандаа энэ хэрэг нь санаа зовоосон компанит ажлуудын нэг болсон талаар дурдсан байна.

2008 онд Векетов “Химкинская правда” сонинд Химки тосгоны замын байгууламжийн талаарх төслийн Москва хотын эргэн тойрныг ойжуулах болон хүрээлэн буй орчинд нөлөөлөх хор хөнөөлийн талаар шүүмжлэл бичсэнийхээ дараа зэрлэг хэрцгийгээр зодуулж байсан байна. Ингээд 12 сард Химки хотын шүүх Векетовыг гэм буруутайд тооцсон бөгөөд энэ үед тэрээр 2008 оны халдлагаас болж тахир дутуу хүний тэргэнцэрт суудаг, ярих чадваргүй болж үлдсэн байжээ. Иймэрхүү хэргүүд ар араасаа гарсаар байжээ.

Москвагийн хараат бус “Шинэ сонин” сонинд мэдээлэл холбоо харилцааны бүртгэл хөтлөх тусгай байгууллага Роскомнадзор /Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, технологийн мэдээлэл, телекомын хүрээ дэх удирдлагын улсын алба/ -оос “хэт даврагчид”-ын үзэл санааг агуулсан неофашист удирдагчийн талаарх сурвалжлага, ярилцлагыг албан ёсны сэрэмжлүүлэг болгон хүргүүлж байсан байна.

Роскомнадзор нь олон нийтийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих зорилготой байгууллага бөгөөд 2007 оны 3 сарын 12-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Дмитрий Медведевийн

[82] http://en.wikipedia.org/wiki/Freedom_of_the_press_in_Russia

тушаал[83]-аар байгуулах эх үндсийг тавьж, Засгийн газрын шууд удирдлага[84], тэр дундаа Соёлын сайдын харьяанд ажиллахаар байгуулагджээ.

Эрх баригчид энэхүү хүчтэй улс төржиж байгаа явдлыг зогсоохын тулд эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхийг зорьсоор байв. Ерөнхийлөгч Медведев Холбооны улсын нууц албаны хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуульд гарын үсэг зурсан бөгөөд энэ нь хэвлэл мэдээллийг “хэт даврагчид”-ын үйл ажиллагаанаас холдуулахад нэг хэсэг нь чиглэнэ гэж үзсэн. Олон улсын байгууллагаас явуулсан судалгаагаар ОХУ бол хэвлэл мэдээллийн эрх чөлөөгүй улс төдийгүй, сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэгтнүүдийг ял шийтгэлээс чөлөөлдөг, хууль ёсгүй, журамгүй байдал өргөн тархсан, хэвлэл мэдээллийн хэрэгслийн орчин нь дэлхий дээрх хамгийн аюултай улс[85] гэж тооцогдсон байна**.**

1.2. Эрх зүйн орчин

- Үндсэн хууль
- Эрүүгийн хууль

ОХУ -ЫН ҮНДСЭН ХУУЛИАС /1993.12.12/

2 дугаар бүлэг. Хүний эрх, эрх чөлөө

29 дүгээр зүйл.

1. Хүн бүр үг хэлэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй.
2. Нийгэм, үндэстэн эсхүл шашны тэмцэл, өс хонзон, суртал ухуулга, үймээн самуунд өдөөн хатгахыг хориглоно. Нийгэм, үндэстэн, үндэстний цөөнх, шашин эсхүл хэл шинжлэлийн дээрэнгүй чанарын суртал ухуулга явуулахыг хориглоно.
3. Хэнийг ч өөрийн үзэл бодлоо илэрхийлэхийг албадах болон үзэл бодлоо илэрхийлсэний төлөө гэм буруутайд тооцож, үл тоомсорлож болохгүй.
4. Хүн бүр аливаа мэдээллийг хууль ёсны замаар хүлээн авах, мэдээлэх, дамжуулах, тараах, чөлөөтэй үзэх эрхтэй. Холбооны улсын хуулийн дагуу төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тодорхойлно.
5. Нийтийн мэдээллийн эрх чөлөөг хуулиар баталгаажуулна. Цензур тогтоохыг хориглоно.[86]

ОХУ -ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС /1996.06.13/

129 дүгээр зүйл. Гүтгэх

1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах худал мэдээллийг санаатайгаар гүтгэн тараасан бол 80 мянга хүртэл тэнцэх хэмжээний рублиэр, эсхүл 6 сар хүртэл хугацааны цалин, хөлс, эсхүл түүнтэй адилтгах орлоготой тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 120-180 цагийн албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ. /ойролцоогоор 3,200,000 төгрөгтэй тэнцэнэ./

2. Гүтгэлэг нь нийтийн өмнө эсхүл олон нийтэд тараасан болон олон нийтийн хэвлэл

[83] http://graph.document.kremlin.ru/page.aspx?960206

[84] http://www.rsoc.ru/eng/

[85] http://www.unhcr.org/refworld/docid/4e9bec3013.html [accessed 11 November 2012]

[86] http://www.departments.bucknell.edu/russian/const/constit.html

мэдээллийн хэрэгслийн гүжирдлэг агуулсан бол 120 мянга хүртэл тэнцэх хэмжээний рублиэр, эсхүл 1 жил хүртэл хугацааны цалин, хөлс, эсхүл түүнтэй адилтгах орлоготой тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 120-180 цагийн албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 1-2 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 3-6 сар хүртэл баривчлах ял шийтгэнэ. /ойролцоогоор 4,800,000 төгрөгтэй тэнцэнэ./

3. Хүнийг хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэвэл 100-300 мянга хүртэл тэнцэх хэмжээний рублиэр, эсхүл 1-2 жил хүртэл хугацааны цалин, хөлс, эсхүл түүнтэй адилтгах орлоготой тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорихоор, эсхүл 4-6 сар хүртэл баривчлах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хасах ял шийтгэнэ. /ойролцоогоор 4,000,000-12,000,000 төгрөгтэй тэнцэнэ./

130 дугаар зүйл. Доромжлох

1. Доромжлох нь хүний нэр төр, алдар хүндийг гутаан ёс журамгүй хэлбэрээр илэрхийлэгдсэн бол 40 мянга хүртэл тэнцэх хэмжээний рублиэр, эсхүл 3 сар хүртэл хугацааны цалин, хөлс, эсхүл түүнтэй адилтгах орлоготой тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 120 цаг хүртэл албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ. /ойролцоогоор 1,600,000 төгрөгтэй тэнцэнэ./

2. Нийтийн өмнө эсхүл олон нийтэд тараасан болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол 80 мянга хүртэл тэнцэх хэмжээний рублиэр, эсхүл 6 сар хүртэл хугацааны цалин, хөлс, эсхүл түүнтэй адилтгах орлоготой тэнцэх хэмжээгээр торгох, эсхүл 180 цаг хүртэл албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 1 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.[87] /ойролцоогоор 3,200,000 төгрөгтэй тэнцэнэ/

2. ШВЕДИЙН ВАНТ УЛС

2.1. Шведийн Вант Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай асуудал

Шведийн Вант Улс бол 1766 оноос хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хүрээнд хэвлэлийн эрх чөлөө нь хууль, эрх зүйн хүчтэй хамгаалалтад байдаг улс юм. Дэлхийн Хэвлэлийн эрх чөлөөний хамгийн анхны хууль нь энэ 1766 оны хууль бөгөөд олон улсын эрх чөлөөний байгууллагын явуулсан судалгаагаар Швед улс хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй улс гэж үзсэн байна[88].

Тус улсын парламнетын эрх зүйн актууд /The Riksdag act/-д хариуцлагын талаар тусгахдаа тухайн хэвлэгдсэн мэдээллийг эзэмшигч, зохиогч, эсхүл тогтмол болон тогтмол бус хэвлэлийг хариуцан нийтлэгч хариуцлага хүлээхээр заасан ба торгуулийн хэмжээний талаар тодорхой зүйл заагаагүй бөгөөд нэхэмжлэл дэх хохирлыг барагдуулах, мэдээлэл материалыг хураан авах зэргээр заасан байна. Мөн онц болон дайны байдал зарлагдсан үед өдөөн хатгасан аливаа мэдээлэл тараавал авах арга хэмжээний талаар заасан байна. Эрүүгийн хуульдаа гүтгэх гэмт хэргийн талаар тодорхой заасан бөгөөд 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Мөн уг харилцаатай холбоотой аливаа хяналтыг Хууль зүйн сайд хяналт тавих ба хариуцлагын талаарх аливаа асуудалд мөн түүний шийдвэрээр хандах талаар заасан байна.

[87] http://www.legislationline.org/download/action/download/id/1697/file/0cc1acff8241216090943e97d5b4.htm/preview

[88] http://www.unhcr.org/refworld/country,,FREEHOU,,SWE,4562d8b62,4e9bec251e,0.html

2.2. Эрх зүйн орчин

- Үндсэн хууль
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль
- Эрүүгийн хууль

ШВЕДИЙН ВАНТ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС /1975.01.01/

Үндсэн хуулийн үндсэн дөрвөн зарчимтай. Үүнд:

- Засгийн газрын баримт бичиг
- Тасралтгүй үргэлжлэх байдал
- Хэвлэн нийтлэх эрх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орно.

Хүний үндсэн эрх, эрх чөлөө хэмээх 2 дугаар бүлэгт зааснаар:

1 дүгээр зүйл. Иргэн бүр төрийн захиргаатай харилцах харилцаандаа эдлэх эрхэд:

1. Үгийн эрх чөлөө: үзэл бодол, санал, дүгнэлт, сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэхдээ амаар, бичгээр болон төсөөлөн илэрхийлэх, дүрслэх, эсхүл ямар ч замаар мэдээ мэдээллийг дамжуулах, мэдээлэх эрхтэй.
2. Мэдээллийн эрх чөлөө: өөртөө мэдээлэл олж авахдаа бусдын хэлсэн зүйл, ярианаас олж авах эрхтэй.
3. Нэгдэх /цуглах/ эрх чөлөө: мэдээлэл олж авах, эсхүл санал, дүгнэлтээ илэрхийлэх зэрэг аливаа зорилгоор уран бүтээлч үйл ажиллагаа болон аливаа уулзалтыг зохион байгуулах болон оролцох эрхтэй.
4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой нөхцөл байдалд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг дагаж мөрдөнө[89].

ШВЕДИЙН ВАНТ УЛСЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИАС

8 дугаар бүлэг. Хариуцлага хүлээх нөхцөлүүд

1 дүгээр хэсэг. **Тогтмол хэвлэлийн хариуцлага**

1 дүгээр зүйл.

1. Тогтмол хэвлэл нийтлэгдэх үед хариуцлагатай нийтлэгч бүртгэлтэй байсан хувь хүн тогтмол хэвлэлд хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэний хариуцлагыг хүлээнэ.
2. Хариуцлагатай нийтлэгчээр орлогч бүртгэгдсэн байсан бол орлогч нь хариуцлага хүлээнэ.

2 дугаар зүйл.

1. Тогтмол хэвлэл нийтлэгдэж гарах үед хэвлэлийн лиценз байгаагүй, эсхүл 1.1-д заасан хариуцлагатай нийтлэгч шаардлагад нийцээгүй, үүргээ гүйцэтгэхээр больсон байсан тохиолдолд эзэмшигч хариуцлага хүлээнэ.
2. Эзэмшигч мөн хариуцлагатай нийтлэгчийг дүр төдий томилсон байсан болон 5 дугаар бүлгийн 3 дугаар зүйлд заасан эрх мэдлээ тогтмол хэвлэл нийтлэгдэхэд эдэлж байгаагүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.

[89] http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=11805

ШУА-ИН МОНГОЛЫН СУДАЛГААНЫ САН

3. Хариуцлагатай нийтлэгч байсан орлогч тогтмол хэвлэл хэвлэгдэх үед ажлын шаардлагад нийцээгүй, түүний томилолтын хугацаа дууссан байсан, эсхүл энэ зүйлийн 2 -т заасан нөхцөл байдал орлогчид хамаарч байвал эзэмшигч хариуцлага хүлээнэ.

3 дугаар зүйл.

Тогтмол хэвлэл хэвлэгдэж гарсан үед эзэмшигчийг нь тогтоох боломжгүй бол хэвлэж гаргасан хүн /газар/ түүний оронд хариуцлага хүлээнэ.

4 дүгээр зүйл.

Хэвлэн гаргаж буй хүн /газар/ нь тодорхойгүй тогтмол хэвлэл, эсхүл буруу зүйл гэдгийг тараан түгээгч мэдэж байгаа бол хэвлэн гаргаж буй хүн /газар/ тодорхойгүй тохиолдолд тараан түгээгч хариуцлага хүлээнэ.

2 дугаар хэсэг. **Тогтмол бус хэвлэлийн хариуцлага**

5 дугаар зүйл.

Тогтмол хэвлэлээс бусад хэвлэлд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гарсан бол зохиогч нь 3 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд заасны дагуу мэдэгдэж байвал зохиогч өөрөө хариуцлага хүлээнэ. Зохиогч түүний зөвшөөрөлгүйгээр түүний нэр, хуурамч нэрийг хэвлэж нийтэлсэн зүйлийн төлөө хариуцлага хүлээхгүй.

6 дугаар зүйл.

1.5 дугаар зүйлийн дагуу зохиогч хэд хэдэн зохиогчийн бичсэн зүйлд хувь нэмэр оруулсан ба 3 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд заасны тусгайлан хариуцсан нийтлэгч томилогдсон байсан бол уг нийтлэгч хариуцлага хүлээнэ.

2.1-д зааснаас бусад хэвлэгдсэн материалын хувьд зохиогч нь хэвлэгдэх үед нас барсан байвал хариуцлагатай нийтлэгч хариуцлага хүлээнэ.

3.Хариуцлагатай нийтлэгч түүний нэр, хуурамч нэр түүний зөвшөөрөлгүйгээр ашиглагдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

4.Тогтмол хэвлэлээс бусад хэвлэлийн материалын хариуцлагатай нийтлэгч нь зохиогч нь биш бөгөөд материалыг бэлтгэж хэвлүүлж байгаа хүн байх болно.

7 дугаар зүйл.

1.5,6 дугаар зүйлийн дагуу зохиогч, хариуцлагатай нийтлэгчийн аль нь ч хариуцлага хүлээхгүй, эсхүл материал нийлэгдэж гарах үед нас барсан байвал нийтэлсэн хүн хариуцлага хүлээнэ.

2.Тогтмол хэвлэлээс бусад хэвлэлийн нийтлэгч нь бусдын бичсэн зүйлийг бэлтгэж хэвлүүлж байгаа хүн юм.

8 дугаар зүйл.

Нийтлэгч байгаагүй, эсвэл нэрийг нь тодорхойлох боломжгүй бол хэвлэгч хариуцлага хүлээнэ.

9 дүгээр зүйл.

4 дүгээр зүйлийн нөхцөл мөн тогтмол хэвлэлээс бусад хэвлэлийн материалыг түгээгчийн хариуцлагад хамаарна.

3 дугаар хэсэг. Бүх төрлийн хэвлэлд хамаарах нөхцөлүүд

10 дугаар зүйл.

1.2, 5, 6, 7 дугаар зүйлийн хариуцлага хүлээх байсан хүн материал хэвлэгдэж нийтлэгдэх үед Швед улсад оршиг суугаа газар нь мэдэгдэхгүй, хэргийг шийдвэрлэх үед хаана байгаа нь тогтоогдоогүй тохиолдолд хариуцлагыг дараагийн хариуцлагатай хүн хүлээнэ. Энэ нь 6 дугаар зүйлийн 1-д зааснаас бусад тохиолдолд тогтмол бус хэвлэлийн хариуцлагатай нийтлэгч юм уу, тараан түгээгч хариуцлага хүлээхгүй гэсэн нөхцөлтэй байна.

2.1, 2, 5, 6, 7 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээх байсан этгээдийг шийтгэлээс чөлөөлөх нөхцөл байдал байгаа юм уу, түүний дараа хариуцлага хүлээх хүн энэ нөхцөл байдлын талаар мэдэж байсан, мэдэх ёстой байсан тохиолдолд адил нөхцөл үйлчилнэ.

11 дүгээр зүйл.

Буруутгагдсанаас өөр хүн энэ бүлэгт заасны дагуу хариуцлага хүлээх болох нөхцөл байдлыг зөвхөн шүүх хурлаас өмнө чухал нотолгоо илэрсэн тохиолдолд авч үзнэ.

12 дугаар зүйл.

Энэ бүлэгт заасны дагуу хэвлэмэл материалын төлөө хариуцлага хүлээх хүний хариуцлагыг тодорхойлохдоо материалын агуулгад уг хүний мэдлэг болон зөвшөөрөл шингэсэн, санаа нийлсэн гэж үзнэ.

9 дүгээр бүлэг. Хяналт ба ял шийтгэл

1 дүгээр зүйл.

Одоогийн хууль зүйн актуудад заагдсан хэвлэлийн эрх чөлөөний хязгаар зөрчигдөхгүй байхад Хууль зүйн сайд хяналт тавина.

2 дугаар зүйл.

1.Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт зөвхөн Хууль зүйн сайд яллагч байж болно. Түүнээс өөр хэн ч хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн өмнөх мөрдөн шалгалт /байцаалт/ эхлүүлэх эрхгүй. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн Хууль зүйн сайд болон хариуцсан шүүх уг гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдүүдийн хувьд албадлагын арга хэмжээг хэрэглэхийг зөвшөөрч болно.

2.Засгийн газар эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааг хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэсэн үндэслэлээр эхлүүлэхийн тулд Хууль зүйн сайдад хэвлэлийн материалыг мэдүүлж, гомдол гаргаж болно. Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой олон нийтийн эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааг зөвхөн Засгийн газрын зөвшөөрөлтэйгөөр эхлүүлж болно гэдгийг хуульд зааж өгч болно.

3.Үүнтэй адил зөвхөн Хууль зүйн сайд хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой боловч түүний эсрэг бий болон уг хуулийн бусад нөхцөлийг зөрчиж байгаа хэргүүдэд яллагч байна.

3 дугаар зүйл.

1.Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг дээр тулгуурлан эрүүгийн байцаан шийтгэж үйл ажиллагааг эхлүүлэх эрх тогтмол хэвлэлийн хувьд материал нийтлэгдэх үед хүчинтэй лицензтэй байсан бол зургаан сарын дараа, тогтмол бус хэвлэлийн хувьд нийтлэгдсэн өдрөөс нэг жилийн дараа хүчингүй болно. Хэрэв дээр дурдсан хугацаанд олон нийтийн эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа явагдаж эхэлсэн бол энэ үйл ажиллагаанаас гадна уг хэрэгт хариуцлага хүлээх бусад

этгээдүүдийн эсрэг шинэ үйл ажиллагаа эхлүүлж болно.

2.Хэвлэлийн эрх чөлөөни эсрэг гэмт хэрэгт гэмт хэрэг эрүүгийн ялтай бол шийдэж дуусах хугацаанд хамаатай хуулийн нөхцөлүүд мөн үйлчилнэ.

4 дүгээр зүйл.

Хувираа гомдол мэдүүлэгчийн хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг мэдээлэх, эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа эхлүүлэх эрхийг хуулиар зохицуулна.

5 дугаар зүйл.

8 дугаар бүлэгт заасан нөхцөлөөр хэн ч хариуцлага хүлээхгүй, Хаант улсын хил хязгаар дотор хариуцлагатай хүнд зарлан дуудах хуудас хүргүүлэх боломжгүй бол яллагч юм уу, гомдол гаргагч хэвлэгдсэн материалыг эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны оронд хурааж авах өргөдөл гаргаж болно.

10 дугаар бүлэг. Тусгай албадах арга хэмжээнүүд

1 дүгээр зүйл.

1.Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгтэй холбоотой хэвлэгдсэн материалыг хурааж авч магадгүй гэсэн шалтгаан байгаа бол материалыг шийдвэр гартал хурааж авч болно.

2.7 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд хамаарах шүүхийн шийдвэр хүлээж буй хэргүүдийн хувьд тогтмол хэвлэлийг нийтлэн гаргахад хориг тавьж болно.

2 дугаар зүйл.

Хэрэв зөрчил, гэмт хэрэг нь эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаанд хамаарч байгаа бол Хууль зүйн сайд хэвлэл нийтлэлийг хураан авч, хэвлэлтэнд хориг тавих, шийдвэрийг гаргахаас өмнө, эсхүл шүүхэд хураан авах тухай өргөдөл гаргаж болно. Хуулийн дагуу улсын яллагч өөрийн эрх мэдлийн хүрээн дэх материалыг хураан авах эрх мэдэлтэй байхаар зохицуулж болно.

3 дугаар зүйл.

Улсын яллагч материал хураан авах шийдвэр гаргасан бол энэ тухай нэн даруй Хууль зүйн сайдад мэдэгдэх ёстой. Хууль зүйн сайд цааш нь тушаал хүчин төгөлдөр хэвээр үлдэх эсэхийг шийднэ.

4 дүгээр зүйл.

Хууль зүйн сайд материалыг хураах тушаал гаргасан, улсын яллагчийн тушаалыг баталгаажуулсан бол хууль зүйн шийдвэр гаргаснаас хоёр долоо хоногийн дотор нийтийн эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаа эхлэх юм уу, хэвлэгдсэн материалыг хураан авах тухай өргөдөл гаргаж болно. Эдгээр нөхцөлүүд хангагдаагүй тохиолдолд хураан авах тушаал болон түүнийг дагалдсан хэвлэх хориг бүгд хүчингүй болно.

5 дугаар зүйл.

1.Хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн юм уу, материалыг хураан авах өргөдлийг шүүхэд гаргасны дараа байцаан шийтгэх үйл ажиллагаа эхэлсэн бол шүүх материалыг хураан авах, хэвлэлийн хориг тавих шийдвэр гаргах юм уу, тийм шийдвэрийг хүчингүй болгож болно.

2.Ийм үйлдлийн хувьд шийдвэрт хүрэхдээ шүүх урьд гаргасан тушаал хүчин төгөлдөр үлдэх эсэхийг тодорхойлно. Шүүхийн шаардлагын хэмжээнд байгаагүйгээс

хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл шүүх хэвлэсэн материалыг эрүүгийн шинжтэй эсэхийг тодорхойлохгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон ба материалыг хураан авах тухай өргөдөл тавигдана гэсэн шалтгаан байгаа бол шүүх шүүхээр тогтоосон тодорхой хугацаанд тушаал хүчинтэй байх шийдвэр гаргаж болно. Энэ хугацаанд ямар ч арга хэмжээ аваагүй бол тушаал хүчингүй болно.

6 дугаар зүйл.

Хураан авах тушаалд ямар хэсэг /хэсгүүд/ энэ хураан авах тушаалын шалтгаан болсныг заах ба зөвхөн тэр хэсэг /хэсгүүд/ агуулагдаж байгаа боть, хэсэг, дугаарыг хурааж авна.

7 дугаар зүйл.

Хураан авах тушаалыг цагдаагийн байгууллага хэрэгжүүлнэ. Хураагдсан хэвлэмэл материалыг тараах нь 6 дугаар бүлгийн 3 дугаар зүйлд заасны дагуу хориотой.

8 дугаар зүйл.

1.Зөвхөн тараахад зориулагдсан байсан хэвлэмэл материалыг хураан авна.

2.Хураан авсны баталгааг хураан авах үйл ажиллагаа явагдсан газрын эзэн болон материалыг хэвлэх хүнд хүргэж өгнө. Энэ баталгаа нь хураан авах шалтгаан болсон хэсэг /хэсгүүд/-ийн талаар мэдээлэл агуулсан байх ёстой.

9 дүгээр зүйл.

Хураан авах тушаалыг буцаасан тушаал хүчингүй болсон тохиолдолд хураасан зүйлийг буцааж олгоно.

11 дүгээр зүйл.

1.Улс орон дайны байдалд юм уу, дайны аюултай байдалд байгаа үед 7 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн дагуу шийтгэгдэх, зэвсэгт хүчин өөрийн үүргийг биелүүлэхгүй байхад хүргэх агуулга бүхий хэвлэмэл материал армийн анги нэгтгэлд олдсон бол хууль, эрх зүйн мэдлэг чадвартай уг анги нэтгэлийн ёс зүйн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий офицер уг материалыг хураах тушаал гартал хураан авч болно.

2.Хэрэв удаашрал аюулд хүргэх боломжтой бол хуулийн дагуу өөр офицер дээрх үйлдлийг хийх шийдвэр гаргаж болно. Ингэхдээ энэ тухайгаа 1-д заасан офицерт нэн даруй мэдэгдэх ба уг офицер материал хурааж авсан нь хэвээр байх эсэхийг шийднэ.

12 дугаар зүйл.

11 дүгээр зүйлийн нөхцөлийн дагуу шийдвэр гарсан бол энэ тухайгаа Хууль зүйн сайдад нэн даруй мэдэгдэх ёстой. Хууль зүйн сайд цаашид тушаал хүчин төгөлдөр байх эсэхийг шийднэ.

13 дугаар зүйл.

Торгуулийн дагуу хариуцлагад хамаатай хуулийн ерөнхий нөхцөлүүд хэвлэх хоригийн эсрэг тараагдсан тогтмол хэвлэл, ийм хоригт тусгайлан заагдсан тогтмол хэвлэлийг зарлан тунхаглаж үргэлжлүүлж байгаа тогтмол хэвлэлд мөн адил үйлчилнэ.

14 дүгээр зүйл.

Хэвлэмэл материалын хуулбар хэвлэлийн эрх чөлөөний асуудалтай холбоотой шалгах үйл явцад чухал гэж үзвэл түүнийг хурааж авч болно. Үүнтэй холбоотойгоор 2, 3, 5 /1/, 6, 7

ШШГ MN
СУДАЛГААНЫ САН

/1/ ба 9 дүгээр зүйлийн нөхцөл үйлчилнэ. Мөн чухал хэсгүүдэд хуулийн хураан авах тухай ерөнхий нөхцөл үйлчилнэ.

11 дүгээр бүлэг. Хувийн нэхэмжлэлийн хохирол барагдуулах талаар

1 дүгээр зүйл.

1.Хэвлэлийн эрх чөлөөг буруугаар ашигласан гэдэг үндэслэлээр хохирол барагдуулах нэхэмжлэлийг зөвхөн уг нэхэмжлэлд заагдсан хэвлэмэл материалд хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт агуулагдаж байгаа тохиолдолд гаргаж болно. Өөрөөр заагаагүй бол уг нэхэмжлэлийг 8 дугаар бүлгийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүнд гаргана. 8 дугаар бүлгийн 10 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын улмаас уг хүнд хариуцлага шилжсэн бол нэхэмжлэл мөн түүний өмнө хариуцлагатай байсан хүнд шилжинэ.

2.8 дугаар бүлгийн 12 дугаар зүйлийн хариуцлагатай холбоотой нөхцөл нь хохирол барагдуулах нэхэмжлэлд мөн хамаарна.

3.Хуулийн чухал нөхцөлүүдийг 7 дугаар бүлгийн 2 юм уу, 3 дугаар зүйлд заасан гэмт хэрэг зөрчилд хамааралтай хохирол барагдуулах нэхэмжлэлийг авч үзсэний үндсэн дээр хэрэглэнэ.

2 дугаар зүйл.

Тогтмол хэвлэлийн хариуцлагатай нийтлэгч, түүний орлогчийн эсрэг гаргасан хохирол барагдуулах нэхэмжлэлийг мөн эзэмшигчийнх нь эсрэг гаргаж болно. Хэвлэмэл материалын хувьд зохиогч юм уу, хариуцлагатай нийтлэгчийн эсрэг гаргаж буй нэхэмжлэлийг мөн нийтлэгчийн эсрэг гаргаж болно.

3 дугаар зүйл.

Хэрэв хэн нэгэн хүн хуулийн этгээдийн хууль зүйн төлөөлөгч, итгэмжлэгдсэн хүн, зохицуулагчийн хувиар хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргээс гарсан хохирлын хувьд хариуцлага хүлээх бол хохирол барагдуулах нэхэмжлэлийг тэр хуулийн этгээд, итгэмжлэгдсэн төлөөлөгч, зохицуулагч төлөөлж байгаа хүн гаргаж болно.

4 дүгээр зүйл.

Энэ бүлгийн дагуу хувь хүн өөр хэн нэгэн хүний хамт хариуцлага хүлээх бол уг хүмүүс хамтдаа болон тусдаа хариуцлага хүлээнэ. Хоёр тал хэрхэн хариуцлага хүлээхийг хуулийн нөхцөлийн дагуу шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл.

Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээх хугацаа нь дууссан, эсхүл Эрүүгийн хуулийн дагуу арга хэмжээ авах боломжгүй ч хэвлэлийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн улмаас гарсан хохирлыг барагдуулах нэхэмжлэлийг гаргаж болно[90].

ШВЕДИЙН ВАНТ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИАС /1965.01.01/

5 дугаар бүлэг. Гүтгэх

1 дүгээр хэсэг.

Хэн нэг хүн бусдыг гэмт хэрэгтэн эсвэл буруу зүйл хийж байна гэх эсвэл тухайн хүнийг ямар нэг байдлаар үл хүндэтгэх зорилготой мэдээлэл өгсөн бол гүтгэх шийтгэл хүлээлгэн

[90] http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=267691

торгууль ноогдуулна. Хэрэв тухайн хүн өөрийгөө тийнхүү илэрхийлэх үүрэг хүлээсэн байсан бол тухайн байдлыг харгалзан үзэж, тухайн зүйл дээр өгсөн мэдээлэл зөвтгөж болохуйц байх, эсвэл хэрэв тэрээр тухайн мэдээллийг тодорхой шалтгааны улмаас өгсөн бөгөөд энэ нь унэн зөв гэдгийг баталж чадсан тохиолдолд шийтгэл ноогдуулахгүй.

2 дугаар хэсэг.

Хэрэв 1 дүгээр хэсэг дээр тодорхойлогдсон хэрэг нь зүй зохисгүй гэж тооцогдвол гүтгэсний торгууль, эсвэл 2 жилээс хэтрэхгүй хорих ял ноогдуулна.

Тухайн тараагдсан мэдээлэл хэр их цар хүрээнд тархсан, мөн утга агуулга, хэр ноцтой хор хохиролтой мэдээлэл зэргийг авч хэлэлцсэний үндсэн дээр тухайн хэрэг хэр зүй зохисгүй гэдгийг үнэлэн дүгнэнэ.

3 дугаар хэсэг.

Хэн нэг хүн нь аль нэг хүнийг нэр хоч өгч доромжлох, эсвэл бүрүүшаан гутаасан тохиолдолд шийтгэл ноогдуулна. Хэрэв тухайн хэрэг 1, 2 дугаар хэсэгт хамрагдаж шийтгэгдэхүйц биш бол гаргасан зан аашных нь төлөө торгууль ноогдуулна.

Хэрэв тэрхүү гэмт хэрэг зүй зохисгүй гэж тооцогдвол Ds 1999:36 23 /Гүтгэх гэмт хэргийн бүлгийн дугаар/ дагуу торгууль, эсвэл 6 сар хүртэл хорих ял ноогдуулна.

4 дүгээр хэсэг.

Гүтгүүлсэн хүн нас барсан тохиолдолд энэ нь ард үлдэгсдэд нь гомдолтой бол 1, 2 дугаар хэсэгт заасанчлан хариуцлага хүлээнэ. Энэхүү хэрэг нь түүнийг амьд байх үед нь тайван бус байлгасан бол түүний нэр төрийг сэргээх хэрэгтэй.

5 дугаар хэсэг.

Хохирогчоос өөр тал 1-3 дугаар хэсэгт заагдсан хэргийг шүүх эрхгүй. Хэрэв хохирогч өөрөө гэмт хэргийг ард олны дунд шүүх онцгой шаардлагатай гэж үзвэл шүүгч ёсоор болгож болно:

1. Гүтгэлэг ба зүй зохисгүй гүтгэлэг
2. Хэн нэгний ажлын үүрэг болон ажлын дадал зуршлыг доромжлох
3. Хэн нэгнийг арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, үүсэл гарлыг далд утгаар гутаан доромжлох
4. Хэн нэгнийг бэлгийн чиг хандлагаар нь далд утгаар гутаан доромжлох

Нас барсан хүний шүүх ажиллагааг түүний гэр бүл, эцэг эх, үе залгамжлагч нар оролцон явуулах ба хэрэв тодорхой шалтгаанууд байвал олон нийтэд нээлттэй шүүх хурал зарлана. Хэрэв 1-3 дугаар хэсэгт заасан хэрэг нь Швед улсад байгаа гадны төлөөлөгч болон гадны хүчнийг доромжилсон бол эхний хэсэг дээрх хуулийн заалтын дагуу олон нийтийн шүүгч шүүнэ. Засгийн газар болон Засгийн газрын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр ийнхүү шүүж болохгүй. (Law 1998:393)24 Ds 1999:36[91].

* * *

Ашигласан эх сурвалж:

1. Report of The Freedom House - http://www.unhcr.org/refworld/docid/4e9bec3013.html [accessed 11 November 2012]
2. Constitution of The Russian Federation - http://www.departments.bucknell.edu/russian/const/constit.html

[91] http://www.government.se/sb/d/3926/a/27777

3. The Criminal code of The Russian federation - http://www.legislationline.org/download/action/download/id/1697/file/0cc1acff8241216090943e97d5b4.htm/preview
4. Report of The Freedom House - http://www.unhcr.org/refworld/country,,FREEHOU,,SWE,4562d8b62,4e9bec251e,0.html
5. Constitution of Sweden - http://www.wipo.int/wipolex/en/details.jsp?id=11805
6. The freedom of the press act of Sweden - http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=267691
7. The Swedish Penal code - http://www.government.se/sb/d/3926/a/27777
8. http://graph.document.kremlin.ru/page.aspx?960206
9. http://www.rsoc.ru/eng/
10. http://www.government.se/sb/d/3926/a/27777
11. http://www.freedomhouse.org/report-types/freedom-press

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙРНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батдорж, Г. Чулуун

Агуулга

Оршил

Судалгааны зорилго

1. Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байрны дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт
   1.1. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт:
   1.2. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны өнөөгийн байдал
   1.3. Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байрны дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт
2. Сууц өмчлөгчдийн холбооны гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт
   2.1. Оросын холбооны улс
   2.2. Казакстан улс

* * *

Оршил

Энэхүү судалгааг УИХ -ын гишүүн С. Дэмбэрэлийн 2012.10.30 -ны өдрийн 8/2850 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Судалгааны төвийн судлаач Ц.Батдорж, Г.Чулуун нар гүйцэтгэв.

Судалгааны ажлын явцад “Сууц өмчлөгчдийн холбоо, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрх зүйн байдлын тухай хууль” болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтийн явцад бий болж буй тулгамдсан асуудлуудыг тодруулах, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл болон иргэд оршин суугчдаас гарч буй санал шүүмжүүдийг харьцуулан судлах, бусад сайн туршлага бүхий зарим орнуудын /ОХУ, Казахстан/ орон сууцны нийтийн өмчлөлийн эрх зүйн зохицуулалтын актууд болон төрөөс явуулж буй бодлого зэргийг харьцуулан судалж дүгнэлт гаргах зорилго тавив.

Судалгаанд Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл болон БХБЯ -ны ОСНАА -н Бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн албан ёсны тоо мэдээлэл, өдөр тутмын сонин хэвлэл, вэб сайтуудад гарсан Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай холбоотой санал шүүмжүүд зэргийг эх сурвалж болгон ашигласан ба эдгээр мэдээллийг нэгтгэн дүгнэлт гаргав. Мөн ОХУ, БНКУ -ын холбогдох хууль тогтоомжуудыг ашиглав.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 17,18, 19-р зүйлд заасны дагуу СӨХ-үүдийн үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, хуулийн хэрэгжилтэд

СУДАЛГААНЫ САН

хяналт тавих эрх, үүрэг бүхий субьектууд нь Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам, Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга болон мэргэжлийн байгууллагууд юм. Гэвч эдгээр байгууллагуудын зүгээс СӨХ -үүдийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар удирдан зохион байгуулах, хяналт тавих, дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал хангалтгүй байдгаас зарим СӨХ -үүдийн санаачлагаар 1999 онд Сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл/ СӨХДЗ/ ТББ -ийг байгуулж, мэргэжил арга зүйн туслалцаа авах хэлбэрээр ажиллаж байна. Тус холбооны эрхлэх үйл ажиллагаа, эрх үүрэг нь дээрх хуулийн зохицуулалтанд хамрагдахгүй бөгөөд сайн дурын, гишүүнчлэл бүхий байгууллага тул дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн хэрэгжилтийн явцад СӨХ болон СӨХДЗ -ийн үйл ажиллагаа, төрийн зохицуулалт, хяналтын тогтолцоо, хууль хэрэгжүүлэх механизмтай холбоотой асуудлууд маш их гарч байна. Одоо мөрдөж байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд барилгажилт, хот байгуулалтын хүрээнд оршин суугчдын дундын өмчлөлтэй холбоотой асуудлыг шинээр үүсч буй нөхцөл байдлыг бүрэн зохицуулах боломж хомс байна. Иймд холбогдох мэдээлэл, олон нийтийн шүүмж, бусад орнуудын туршлагыг зэрэгцүүлэн харуулахыг зорив.

* * *

1. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, НИЙТИЙН ЗОРИУЛАЛТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙРНЫ ДУНДЫН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт:

Сууц өмчлөгчдийн холбоо, нийтийн зориулалттай орон сууц, дуднын өмчлөлын тухай бодлогын болон эрх зүйн өргөн хүрээнд тусгагдсан асуудал юм. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль эрх зүйн орчин анх 1996 онд батлагдсан дундын өмчлөлийн орон сууцны тухай хуулиар анх зохицуулагдаж байсан бөгөөд тухайн хуулиар одоо мөрдөгдөж байгаа хуултай агуулгын хувьд ойролцоо байсан байна. 2003 оны 06 сарын 18-ны өдрийн хууль нь Иргэний хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хууль, болон энэ хуульд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актад нийцүүлэн гаргасан байна.

1996 оны хуулийн зорилтод дундын өмчлөлийн орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг сууц, тухайн орон сууцны бус зориулалттай хэсгийг өмчлөгчид дундаа хамтран өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах, орон сууц өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон бол 2003 оны СӨХ-ийн хуулиар сууц өмчлөгчдийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулахаар тодорхойлсон байна.

Сууц өмчлөгч, сууц өмчлөгчдийн холбоо, дундын өмчлөлийн талаар дараах зохицуулалтуудыг бусад хуулиудад дараах байдлаар тусгаж өгсөн байна. Иргэний хуулийн тавдугаар дэд бүлэг буюу 142-149-р зүйлүүдэд Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрх, сууц өмчлөгчдийн холбоо, холбоог татан буулгах, орон сууц дангаар өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох, орон сууцны дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйл, дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах, өмчлөгчийн эрх, үүрэг орон сууц өмчлөгчдийн шаардах эрх зэргийг нарийвчлан тусгаж өгсөн байна.

Барилгын тухай хуульд төрийн бус байгууллагын оролцоо, барилга байгууламжийг

ашиглахтай холбоотой хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангасан, зэргэлдээ барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл байдлыг алдагдуулаагүй байх зэрэг харилцааг зохицуулж өгсөн байна.

Орон сууцны тухай хуульд төрөөс орон сууцны талаар дараахь зарчим баримтална. Үүнд:

- Иргэд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан орон сууцаар өөрсдийгөө хангах нөхцөлийг бүрдүүлж өгөх, орон сууц, түүний дэд бүтцийг хөгжүүлэх бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд зах зээлийн эдийн засгийн үндсэн шаардлагад тулгуурлах, орон сууцны хороолол, бичил хороолол, түүний дэд бүтцийг төлөвлөх, барьж байгуулахыг төрөөс бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодлого баримтлаж ажиллахаар тусгасан
- Мөн хуульд нийтийн зориулалттай орон сууцны байшингийн засвар, үйлчилгээ, орон сууцны байшингийн инженерийн хангамж, орчны тохижилт, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийтийн зориулалттай орон сууц, нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нийтийн зориулалттай орон сууцны байшинд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглохыг заасан байна.

Дээрх хуулиудад сууц өмчлөгч, сууц өмчлөгчдийн холбоо, дундын өмчлөлийн эд хөрөнгийн талаар тодорхой зааж өгсөн байгаа боловч хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар хариуцах байгууллага, албан тушаалтан байдаггүй нь нууц асуудал биш болоод байна.

1.2. Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны өнөөгийн байдал:

Өнөөдрийн байдлаар /2012 оны 12 сарын 01/ улсын хэмжээнд 627 Сууц өмчлөгчдийн холбоод байгаагаас Улаанбаатар хотод 527, орон нутагт 110 нь үйл ажиллагаа явуулж байна. Хот, хөдөөд байгуулагдсан олон тооны СӨХ -д эвлэлдэн нэгдэж нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах, мэргэжлийн чиг удирдлагаар хангах, суугч-иргэдийн эрх ашгийг хамгаалах, төр, засгийн болон бусад байгууллагатай холбож тусламж дэмжлэг авах, Төрөөс явуулж байгаа бодлого арга хэмжээг нэгтгэн зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг, зорилготойгоор Монголын Сууц Өмчлөгчдийн Холбооны Дээд зөвлөлийг (МСӨХДЗ) байгуулсан байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 627 Сууц Өмчлөгчдийн Холбоо /СӨХ/ -ноос 497 СӨХ нь МСӨХДЗ -д гишүүнээр элссэн. Улсын хэмжээний СӨХ -үүдийг нийслэл, орон нутаг дахь 17 салбар зөвлөлөөрөө дамжуулан зохион байгуулалтын удирдлагаар хангаж байгаа бөгөөд аймаг, дүүрэг бүрт тэргүүлэгч гишүүн ажиллуулдаг байна. Өнөөгийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ -дын тоог графикаар харуулбал:

ШИНЖЛЭХ УХААН СУДАЛГААНЫ САН

Эх сурвалж: Эх сурвалж: МСӨХДЗ -ийн ирүүлсэн мэдээлэл, 2012.12.05

СӨХ -ийн тоо сүүлийн үед тогтвортой өсч байгаа нь хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой байж болох юм. Тухайлбал, орон сууцны барилгууд хувьчлагдсан, сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн орчин тодорхой болсон, барилгын салбар дахь орон сууцны нийлүүлэлт нэмэгдсэн гэх мэт.

СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООНЫ САНГИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД

Сууц өмчлөгчдийн холбоодын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх 6 төрлийн эх үүсвэрийг хуульчлан тогтоосон байна. Тухайн жилд гүйцэтгэх засвар, үйлчилгээний зардлыг оршин суугчдаас гаргуулан авч байгаа боловч энэхүү хөрөнгө нь хуучирч муудсан байрны засвар үйлчилгээнд хүрэлцэхгүй болсон тул 2004 - 2011 онд нийт 19,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс гаргуулсанаас дээврийн засварт 9,0 турбум төгрөг, лифтний их засвар шинэчлэлийн үйл ажиллагаанд 10,4 тэрбум төгрөгийг

тус тус зарцуулсан байна. Үүнийг он оноор нь авч үзвэл:



Улс, орон нутгийн төсвөөр хийгдсэн дээврийн ажлууд



Улс орон нутгийн төсвөөр хийгдсэн цахилгаан шатны ажлууд

МСӨХДЗ - өөс ирүүлсэн мэдээллээс үзэхэд, МСӨХДЗ -ийн ерөнхийлөгч, Нийслэлийн Засаг даргын хамтран баталсан удирдамжийн дагуу Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ -үүдын захирлуудын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэгийг 2001 оноос эхлэн хийж эхэлсэн бөгөөд сүүлийн 3 жилийн үзлэгийн дүнгээс үзэхэд Нийслэлд ажиллаж байгаа гишүүн СӨХ -үүдийн 85 хувь нь хангалттай, бүрэн хангалттай үзүүлэлттэй байна.



ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООД

Дээрхи статистик мэдээллүүд нь СӨХДЗ - өөс ирүүлсэн мэдээлэл бөгөөд үзлэг шалгалт хийгдэж, СӨХ -үүдийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө хангалттай түвшинд байна гэж үнэлэгдэж байгаа боловч иргэд, оршин суугчдаас гомдол тасардаггүй, СӨХ-ийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах хандлага түгээмэл байна. Судалгааны явцад СӨХ-ийн эрх зүйн орчны хүрээнд ч хуулийн хэрэгжилтийн шатанд ч анхаарах, засаж залруулах асуудлууд байгаа нь харагдаж байна. Тухайлбал, СӨХ нь оршин суугчдад үйлчилгээ үзүүлдэг дундын үйлчилгээний байгууллага боловч эдгээр байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн дүнг оршин суугчдаар хэлэлцүүлдэггүй, ажлын үр дүнг нь оршин суугчдаас судалгаа авах хэлбэрээр үнэлдэггүй, оршин суугчдаас засвар, үйлчилгээний хураамжинд холбооны санд хуримтлуулсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг ил тод тайлагнадаггүй зэрэг зөрчил, дутагдалууд байна.

1.3. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт:

Манай улсад сууц өмчлөгчдийн холбоо гэх байгууллага үүссэн цагаасаа нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулах зорилттой ажиллах үүрэг хүлээн үйл ажиллагаа явуулаад олон жилийн нүүр үзлээ. Энэ байгууллагын талаар сүүлийн жилүүдэд иргэдийн зүгээс гарах гомдол тасрахгүй байгаа бөгөөд сууц өмчлөгчдийн холбоотой хамааралтай бүхийл үйл ажиллагааг зохицуулахаар 2003 онд Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсан.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилтийг тус хуулийн 17 -р зүйлд орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ханган ажиллах ба биелэлтэнд нь хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй байхаар тусгаж өгсөн байна. Уг хуулийн хэрэгжилтийн талаар мониторинг хийхийн тулд орон сууцны асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллагын тайланд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай болсон юм. Тухайн байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл бага байсан учир хэвлэл мэдээллийн хэрэгслэлд гарсан мэдээ, мэдээлэлд тулгуурлан хуулийн хэрэгжилтийг гаргав.

1.3.1. Сууц өмчлөгчдийн холбоо, холбооны эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шүүмжүүд:

Сууц өмчлөгчдийн холбоо, холбооны эрх барих дээд байгууллагын талаар хуульд заасан эрх, үүрэг түүнтэй холбоотой асуудлаар иргэдээс гарсан гомдол болон сөрөг үр дагаварууд.

- Сууц өмчлөгчдийн холбоо нь иргэдийн эрүүл, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй олон нийтийн байгууллага авч олон нийтийн бус орон тооны хэдхэн хүний эрх ашгийн байгууллага болон хувирч, өөрийн дураар тариф тогтоодог ашгийн байгууллга болсон тухай гомдол тасардаггүй байна.
- Сууц өмчлөгчдийн холбоо нь хуульд заасан эрхийнхээ хүрээнд хувийн эзэмшлийн талбайгаас гаднах орц, хонгил, дээвэр, гадна орчны талбай, газар, тоглоомын талбай зэрэг нь дундын өмчийг харж, хянаж, хариуцаж, оршин суугчдын эрх ашгийг хамгаалж, тав тухтай байдлыг хангаж байх үүрэгтэй байгууллага боловч сууц өмчлөгчдийн холбоодын дарга нар оршин суугчдын эрх ашгийг, дундын эд хөрөнгийг хамгаалах үүргээ биелүүлэхгүй харин ч дундын өмчлөлийг өөрийн юм шиг ашиглаж, орон сууцны подвал, хонгил, орчны газрыг түрээслэж, төлбөрийг нь тодорхой бус зүйлд зарцуулдаг байна. Засвар үйлчилгээ хийх мэргэжлийн байгууллагыг гэрээний үндсэн дээр сууц өмчлөгчдийн холбоо чөлөөтэй сонгох эрхтэй бөгөөд хийж гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ хяналтгүй хийгддэг учир зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэсэн ажлын чанар маш муу хийгддэг тухай иргэдийн гомдол тасардаггүй байна.
- Сууц өмчлөгчдийн холбоо нь иргэдээс авсан мөнгөө юунд зарцуулж, ямар ажил хийснээ оршин суугчиддаа тайлагнадгүй, нөгөө талаас оршин суугчдын эрх зүйн мэдлэг бага байдгаас сууц өмчлөгчдийн холбоо, оршин суугчдын хооронд уялдаа холбоо муу байдаг байна.
- Иргэд өөрсдийн санал, санаачлагаар сууц өмчлөгчдийн холбоог байгуулах татан буулгах хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлбэл дээрх асуудлуудыг цэгцлэх боломжтой юм.
- Сууц өмчлөгчдийн дээд зөвлөл гэх байгууллага сууц өмчлөгчдийн холбоодуудаас 250-300 мянган төгрөгийг татвар нэрийн дор татдаг, улсын төсвөөс орон сууцны засвар үйлчилгээнд зориулж хуваарилж өгдөг мөнгийг захиран зарцуулдаг тухай иргэд гомдол гаргасан байна. Энэ тухай сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлийн ерөнхийлөгч сууц өмчлөгчдийн холбоодуудаас жилдээ орлогы 2 хувь буюу 60-120 мянган төгрөгийн татвар авдаг. Мөн улсын төсвөөс хийгдэх засвар үйлчилгээний зураг төслийг үнэ төлбөргүй сууц өмчлөгчдийн холбоодуудад боловсруулж өгдөг, жилдээ 2.5-2.6 тэрбум төгрөгийг орон сууцны засварт хуваарилдаг хэрэв төсөв зохиож өгөхгүй бол дурын үнээр бараа үйлчилгээ авдаг тухай дурдсан байна. Дээд зөвлөл дээрх авсан татварыг мөнгөөр юу тухайгаа тайлбарладггүй аж.
- Бүх гишүүдийн хурал нь сууц өмчлөгчдийн 50-иас дээш хувь оролцоноор, хэрэв сууц өмчлөгчид ногдох хэсгийн хориос дээш хувь нь нэг өмчлөгчтэй бол бүх гишүүдийн 75-аас дээш хувь оролцоноор хүчин төгөлдөр болно гэж заасан байдаг боловч хуулийн дагуу ирц бүрэн бүрдээгүй байхад хурал хийж хамаарах асуудлын хүрээнд шийдвэр гаргадаг байна. Мөн бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрүүлэх асуудлыг сууц өмчлөгдийн холбооны гүйцэтгэх захирал бие даан шийдвэр гаргаж дундын өмчлөлийн эд хөрөнгийг бусдад ашиглуулдаг зөрчлүүд гардаг байна.
- Сууц өмчлөгчдийн холбооны захирлыг томилдоггүй, харин оршин суугчид итгэл даан ажиллаж чадна гэсэн хүнээ сонгодог. Сайн ажилладаг, оршин суугчдынхаа

эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хамгаалж чадах чадвартай хүнээ зөв сонгох нь оршин суугчдын үүрэг бөгөөд түүний ажлын явц, гүйцэтгэлд хяналтын зөвлөлөөрөө дамжуулан хяналт тавих, шаардлагатай үед тайлан тэнцэлтэй нь биечлэн танилцах, тайлан мэдээг нь тогтмол сонсч байх эрхтэй юм. Хэрэв гүйцэтгэх захирал ажиллаж чадахгүй байгаа бол нэн даруй бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, дахин сонгууль явуулах эрх оршин суугчдад хуулиар олгогдсон. Гэтэл хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхгүй, хэт эрх мэдэлтэй сууц өмчлөгчдийн холбооны захирлууд олон байна.

- Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд суугчид бүрэн хяналт тавьдаггүй ямар үйл ажиллагаа явуулдаг талаар бүрэн мэдээлэл байдаггүй учраас хуульд заасан утгаараа бүрэн дүүрэн үйл ажиллагаагаа явуулж байгаа сууц өмчлөгчдийн холбоо ховорхон байдаг байна. Үүний нэг илрэл нь төсөв тайлан, сан байгуулах, ашиглалт, захиран заруулалттай холбоотой шийдвэр хурлын материал суугчдад тараагддаггүй мөн тус хурал нь хуралддаг эсэх нь тодорхойгүй байдаг байна. Сүүлийн үед гарч байгаа нэг том зөрчил бол шинэ баригдсан орон сууцны сууц өмчлөгчдийн холбоо ямар байдлаар байгуулагдсан эсэх нь тодорхорй бус үнэ тарифыг үндэслэлгүй тогтоох болсон байна.
- Орон сууцны зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барихдаа сууц өмчлөгчдийн холбоо болон мэргэжлийн бусад байгууллагаас зөвшөөрөл авах ёстой байтал сууц өмлөгчид дураараа барилга, байшин барьж орон сууцныхаа зориулалтыг нь өөрчилж байгаад хяналт тавьдаггүй мөн сууц өмчлөгчдийн холбоо уг асуудалд анхаарлаа хандуулан зөвшөөрөл өгдөгч бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэгддэг эсэх нь тодорхой бус зөвшөөрөл аваагүй сууц өмчлөгчид хүлээлгэх хуулийн хариуцлага сул байдаг.
- Сууц өмчлөгчдийн холбоо иргэдээс хуримтлуулсан мөнгө, дундын өмчлөлөөс олсон түрээсийн төлбөр болон бусад орлогыг сан байгуулж хадгалах ёстой байтал хураах авсан мөнгөө зориулалтын бус зүйлд заруулдаг байна. Гэтэл хэдэн жилийн дараа шугам сүлжээ, дээвэр зэрэгт засвар хийх болоход хуримтлалын мөнгө байхгүй учраас суугчдаас засварын мөнгө гэж нэмж авах тохиолдолууд олон байдаг байна. Сүүлийн жилүүдэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийгдэж байгаа боловч сууц өмчлөгчдийн холбоод оршин суугчдаас засвар үйлчилгээний мөнгө болон бусад зардлын мөнгөө тогтмол авсаар байгааг таслан зогсоох хяналтын тогтолцоо хэрэгтэй байна.

1.3.2. Хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал, сууц өмчлөгчтэй холбоотой шүүмжүүд

Сууц өмчлөгчдийн холбоо, хяналтын зөвлөл, холбооны гүйцэтгэх захиралтай холбоотой-гоор практикт үүсээд байгаа асуудлууд болон суугчдын санал гомдолтой холбоотой асуудлууд.

- Хуульд зааснаар хяналтын зөвлөл нь сууц өмчлөгчдийг төлөөлөн сууц өмч-лөгчдийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй боловч хяналтын зөвлөл хуулиар хүлээсэн үүрэгээ биелүүлж байгаа эсэхэд эргэлзэх хүн олон байна. Хяналтын зөвлөл байдаг эсэх талаар мэддэг оршин суугч бараг байдаггүй байна. Хяналтын зөвлөл холбооны үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг арилгуулах талаар шүүх болон холбогдох байгууллагад хандах эрх, үүрэгтэй боловч холбооны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэд өөрсдөө гомдол гаргах тохиолдол элбэг байна.
- Иргэний хуулийн 147, 148 дугаар зүйлд зааснаар дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээнд зориулан төлсөн төлбөрөө хэрхэн зарцуулагдаж байгааг мэдэх, хяналт тавих эрхтэй байдаг. Харин сууц өмчлөгчдийн холбооны “Хяналтын зөвлөлийн гишүүн шалгасан баримт бичиг, тайлан, тэнцлийн нууцыг хадгалах

үүрэгтэй” гэж хуулийн 11.4-д заасан байгаа нь сууц өмчлөгчдийн давхар хяналт тавих эрхийг хязгаарлаж байгаа юм.

- Иргэд өөрийн байрны сууц өмчлөгчдийн холбоог шалгуулах хүсэлтийг сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлд гаргахад тэд тодорхой хэмжээний төлбөр нэхсэн тохиолдол гарсан байна. Тус байгууллага нь төрийн бус байгууллагын статустай. Харин төрийн бус байгууллагыг дотор нь нийгэмд чиглэсэн, гишүүнд чиглэсэн хэмээн хоёр ангилан авч үздэг ч сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулахаар 1999 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Гэтэл уг үйл ажиллагааны чиглэл өнөөдөр өөрчлөгдөж, гишүүн байгууллагын үйл ажиллагааг хянаж, шалгах нэрийдлээр татаас авдаг байгууллага болсон байна. Үүнийг анхаарч үзэх шаардлага гарч байгаа юм.
- Мөн орон сууцны байшингуудын ойролцоо шатахуун түгээх станцуудыг олноор нь барьж байгаа нь оршин суугч, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх ноцтойгоор зөрчигддөг байна.
- Сүүлийн үед шинээр баригдсан барилгын гүйцэтгэгч нь сууц өмчлөгчдийн холбооны үүргийг давхар гүйцэтгэсэн нэртэй суугчдаас засвар үйлчилгээний хөлс 2-3 жил авч ашиглаж байгаад тайлан тооцоо хийхгүй орхин явдагаас дундын өмчлөлийн эд хөрөнгө эзэнгүйдэж эцэст нь суугчид хохирох, гомдол гаргах явдал олноор гарах болсон байна.

  Жишээ дурдахад: Хотын төвд, нийслэлийн Чингэлтэй дүүргийн III хорооны нутаг дэвсгэрт орших “Пума констракшн”-ы барьсан 51 дүгээр байр уг нь аль эрт 2010 онд ашиглалтад орсон байна. Барилгын компани сууц өмчлөгчдийн холбоо байгуулж, иргэдээс сар болгон СӨХ-ны мөнгөнөөс гадна, цахилгаан, халаалт, дулааны мөнгийг хүртэл бэлнээр тооцож авдаг, хэрэглэсэн хэмжээнээс нь их мөнгө суутгах болсонд тус байрны оршин суугчид эсэргүүцэж, энэ тухайгаа СӨХ-ны даргадаа хэлтэл огтхон ч хүлээж аваагүй аж. Мөн айл өрхүүдээс албан газрын тарифаар тооцож, хэрэглэсэн ус, дулааны мөнгийг нь суутгаж авсан байна.
- Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт холбооны өдөр тутмын үйл ажиллагааг холбооны дүрэмд заасан эрх хэмжээ, удирдах зөвлөлтөй байгуулсан гэрээний хүрээнд захирал эрхэлэх тухай хуульд заасан эрх үүрэгээ хэтрүүлэн хэрэглэж дур мэдэн дундын өмчлөлийн эд хөрөнгтэй асуудалд шийдвэр гаргаж суугчдын эрх ашигийг хохироодог байна.
- Сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал холбооны эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаархи бүх гишүүдийн болон удирдах зөвлөлийн хурлаас тогтоосон эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглах зэрэг үйл ажиллагаанаас холбоонд хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр барагдуулна. /хуулийн 12.6-д/ гэж заалттай нягт уялдаатай юм. Сууц өмчлөгчдийн холбооны өмч нь нийтийн өмч болохоос гүйцэтгэх захирлын өмч биш. Иймд бусдын өмнө гүйцэтгэх захирал нь өөрийн хувийн хөрөнгөөрөө хариуцна. Энэхүү асуудлыг хяналтын зөвлөл холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх үүрэгтэй боловч захиралууд хөрөнгө завшсан тухай асуудал гарсаар байна.
- Сууц өмчлөгчдийн холбоо оршин суугчдаас авсан мөнгийг хуримтлуулан тохижилт, зарим засвар үйлчилгээг хийх ёстой ч урсгал зардал нэрийн дор “үрээд” дуусдаг байна. Сууц өмчлөгчдийн холбоодын дунд хийсэн шалгалтаар ихэнх холбоо нь зардлынхаа 70-80 хувийг цалинд зарцуулдаг нь тогтоогджээ. Зарим сууц өмчлөгчдийн холбоо жолоочтой байснаас гадна жижүүр, лифтчиний цалинг өгөөд үлдсэн хэсгийг нь унааны мөнгө гэх мэт урсгал зардалд зарцуулдаг байсан байна.

1.3.3. Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө, дэвсгэр болон орчны газар, дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, хамгаалалт, үйлчилгээний зардлыг хуваарилахтай холбоотой шүүмжүүд:

Дундын өмчлөлийн эд хөрөнгө, дэвсгэр болон орчны газар, дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой багагүй зөрчлүүд гардаг бөгөөд эдгээр асуудлуудыг авч үзвэл.

- Сууц өмчлөгчдийн холбооныхон өөрсдөө дур мэдэн газар “худалддаг” 2011 оны байдлаар нийтийн эзэмшлийн талбайгаа баталгаажуулж авахаар хотын захиргаанд хандаад байгаа 285 сууц өмчлөгдийн холбоо байдаг бөгөөд үүнээс 267 сууц өмчлөгчдийн хүсэлтийн дагуу газрыг нь баталгаажуулах ажлыг нийслэлийн засаг даргын тамгын газар хийгээд байгаа тухай нийслэлийн газрын албанаас мэдээлсэн байна. Эдгээрээс иргэд, аж ахуйн нэгжид олгогдчихсон 50 гаруй газрын зөвшөөрлийг цуцалсан аж.
- Нийтийн эзэмшлийн талбайд нэмж газар олголт явуулаагүй байгаа бөгөөд сууц өмчлөгчдийн холбоонууд өөрсдөө баталгаажуулж авсан газартаа дур мэдэн автомашины граж барих, эсвэл барилгын компаниудад өгөх, газар доорхи граж барих зэргээр хууль зөрчдөг байна.
- Орон сууцны хорооллын ногоон бүсэд амралтын, хүүхдийн тоглоомын, явган замын талбай байх ёстой. Гэхдээ нийт эзлэх талбай нь эдэлбэр газрын талбайн 30 хувиас ихгүй байх байтал энэ нь асуудал бараг шаардалагад нийцэдгүй байна.
- Барилгын нэгдүгээр давхрын сууц өмчлөгчид дураараа хаалга цонх гарган үйлдвэрлэл үйлчилгээ явуулж, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг алдагдуулдаг явдал элбэг тохиолддог байна.
- Орон сууцны нэг давхар, орц подвальд ундааны цех, саун болон угаалгын газар, барилгын материалын дэлгүүр ажиллуулах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээг ихэвчлэн эрхэлж байна.
- Барилгын ашиглалтын хугацаа хэтэрсэн, даацын ханыг нураасан, зориулалтыг өөрчилснөөс болж бусад айлууддаа аюултай байдлыг үүсгэж байна.
- Олон жил ашиглагдсан “дундын өмчлөлийн” шугам хоолойд гарсан эвдрэл гэмтлийг засварлахад цаг хугацаа алдаж оршин суугчдыг чирэгдүүлдэг.
- Сууц өмчлөгчдийн холбоо нь ус, дулаанаар хангагч байгууллагуудаас “дундын өмчлөлийн шугам сүлжээ”-г ашигласны төлбөр шимтгэлийг авч, түүгээрээ шугам хоолойг засварлах ёстой. Гэтэл сууц өмчлөгчдийн холбоонд хамааруулсан инженерийн байгууламжуудад засвар үйлчилгээ хийх зардлыг сууц өмчлөгчөөс гаргуулдаг байна.
- Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл тусламж, бизнесийн байгууллагуудын өөрийн хөрөнгө оруулалтаар жил бүр олон арван нийтийн зориулалттай орон сууцны барилга, хотхон, хорооллууд гадна шугам сүлжээ, ус, дулаан дамжуулах төв, зам талбай, цахилгаан хангамжийн дэд өртөө, автомашины ил, далд зогсоолын хамт цогцолбороор ашиглалтад орсоор байна. Эдгээр цогцолборыг гүйцэтгэгч нэг төсвөөр барьж, гаргасан зардлаа сууц өмчлөгчдөд худалдаж буй үнийн дүндээ оруулан борлуулж байна.

  Зам талбай, автомашины зогсоол, үйлчилгээний хэсгүүдийг барилга угсралтын компаниуд өөрсдөө ашиглан орлого олох, худалдах, гадна шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төв, цахилгаан хангамжийн дэд өртөө зэрэг ашиглалтын зардал өндөр барилга байгууламжуудыг хангагч байгууллагад шилжүүлсэн нэрээр орхих, өмч эзэнгүйдүүлэх, бусдын өмчлөлд хууль бусаар шилжүүлэх, өмчийн болон засвар, ашиглалт үйлчилгээний талаар маргаан гарах зэрэг асуудал байнга гардаг байна.
- Орон сууцны ойролцоох хүүхдийн талбай болон амрах салхилахад зориулан тохижуулсан талбайнуудын ихэнх нь устаж, оронд нь барилга байшин баригдаж байгаа нь оршин суугчид, хүүхэд, хөгшид, нийт оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтойгоор зөрчигддөг байна.

1.3.4. Хуулийн хэрэгжилтийн явцад хуулийн дараахь зүйл, заалтууд ихэвчлэн зөрчигдөж байна. Үүнд:

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр гарч буй ихэнх нийтлэл шүүмжүүд, Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн мэдээлэл зэргээс үзэхэд “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотой дараахь зөрчлүүд гарч байна. Тухайлбал:

- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сууц өмчлөгчийн эрх, үүрэг гэсэн хэсэгт засвар, үйлчилгээний хөлс, зардал үндэслэлтэй эсэхийг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх /13.1.4/ эрхтэйч асуудлыг шийдвэрлэх шатанд төрийн бус байгууллагыг манайх шалгах эрхгүй гэх мэтчилэн асуудлыг шийдвэрлэх байгууллага байдаггүй байна.
- Сууц өмчлөгчид нь Иргэний хуулийн 147, 148 дугаар зүйлд зааснаар дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар үйлчилгээнд зориулан төлсөн төлбөрөө хэрхэн зарцуулагдаж байгааг мэдэх, хяналт тавих эрхтэй юм. Зарцуулалтын тайланг гаргаж өгдөггүй бодитой бус мэдээллээр хангах явдал элбэг байдаг байна.
- “Хяналтын зөвлөлийн гишүүн шалгасан баримт бичиг, тайлан, тэнцлийн нууцыг хадгалах үүрэгтэй” гэж хуулийн 11.4-д заасан байгаа нь сууц өмчлөгчдийн хяналт тавих эрхийг хязгаарлаж байна.
- Орон сууцны байшингийн орчны газрыг СӨХ-ийн хуулийн 12.4.8, 18.1.4-д зааснаар гэрээний дагуу ашиглуулах эрх олгох эрх бүхий этгээд нь газрын тухай хуульд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бөгөөд тухайн шийдвэрийг хууль бус, оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна гэж үзвэл, сууц өмчлөгчид Захиргааны хэргийн шүүхэд хандан, эрх ашгаа хамгаалуулах эрх нь оршин суугчдад нээлттэй байна. Энэ заалтууд мөн хэрэгждэггүй.
- Гүйцэтгэх захирал ажиллаж чадахгүй байгаа бол нэн даруй бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж, дахин сонгууль явуулах эрх оршин суугчдад хуулийн 10.8.2-р заалтаар олгогдсон. Гэтэл хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхгүй, хэт эрх мэдэлтэй сууц өмчлөгчдийн холбооны захирлууд олон байдаг байна.
- Үндсэн хуульд заасан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой зүйл заалтуудыг бусад салбар хуулиудад тусгаж өгсөн юм. Тухайлбал: Монгол улсын Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлд барилга байгууламжид тавигдах шаардлагыг хүний ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан, мөн гудамж талбай, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг зэрэг нийтийн эдэлбэр газрыг чөлөөтэй ашиглах нөхцөлийг хангасан байхаар хуульчилж өгсөн. Дээрх шаардлагад нийцсэн барилга ховорхон болсон тул анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм.
- Сууц өмчлөгчдийн холбооны хуулийн 13.2.7-д сууц өмчлөгч нь сууцныхаа зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтээц, хийц, инженерийн шугам сүлжээг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй байх үүрэгтэй гэж заасан.

Эдгээр заалтууд хэрэгжихгүй байна. Барилгын нэгдүгээр давхрын сууц өмчлөгчид дураараа хаалга цонх гарган үйлдвэрлэл үйлчилгээ явуулж, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг алдагдуулсаар байна.

- Монгол улсын иргэний хуулийн 148.2.2-т “орон сууц өмчлөгч нь сууц, сууцны бус зориулалттай хэсгийг ашиглах, тvvнд засвар өөрчлөлт, шинэчлэл хийхдээ хууль тогтоомж, норм, стандартад заасан шаардлагыг сахин биелvvлэх, бусад өмчлөгчдийн эд юмсад хохирол учруулахгvй, хууль ёсны бусад эрх, ашиг сонирхлыг зөрчихгvй байх vvрэгтэй” гэж заасан ч байнга зөрчигддөг байна.
- Орон сууцны тухай хуулийн Орон сууцны тухай хуулийн 5 дугаар бvлгийн 16 дугаар зvйлийн 1 дэх хэсэгт ”Сууц өмчлөгч нь бусад оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгvйгээр хуульд зааснаас бусад vйлдвэрлэл, vйлчилгээ сууцандаа эрхэлж болно” гэвд нийтийн зориулалттай орон сууцны байшинд барилгын төлөвлөлт, эрvvл ахуй, аюулгvй байдлын норм зөрчсөн, химийн хорт бодистой харьцах, цацраг идэвхт бодис, цахилгаан соронзон vvсгvvр, даралтат сав, уурын тоног төхөөрөмж ашиглах, саун болон угаалгын газар ажиллуулах, согтууруулах ундаа vйлдвэрлэх зэрэг хvний эрvvл мэндэд хортой vйлдвэрлэл, vйлчилгээ эрхлэхийг хориглосон. Гэтэл орон сууцны нэг давхар, орц подвальд ундааны цех, саун болон угаалгын газар, барилгын материалын дэлгvvр ажиллуулах зэрэг vйлдвэрлэл, vйлчилгээг ихэвчлэн эрхэлж байна.
- Нийслэлийн засаг даргын 2001 оны 7 сарын 02-ны 222 тоот захирамжийн дагуу 1950, 1960 оны vед баригдсан тоосгон ханатай, орон сууцны барилгаас бусад орон сууцны нэгдvгээр давхаруудын төлөвлөлт, зориулалтыг өөрчлөн vйлдвэрлэл, vйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг тухайн барилгын бат бэх, аюулгvй байдлыг хангасан нөхцөл бvхий зураг төсөлд vндэслэн хотын ерөнхий менежер олгодог. Эдгээр зөвшөөрлүүд ихэнхдээ хуучны барилгуудад олгогдож өдийг хүртэл үйл ажилагаа явуулсаар байна.
- Барилгын ашиглалтын хугацаа хэтэрсэн, даацын ханыг нураасан, зориулалтыг өөрчилснөөс болж бусад айлууддаа аюултай байдлыг авчрах өндөр магадлалтай болоод байна. Улаанбаатар хот нь газар хөдлөлтийн идэвхитэй бvсэд хамаардаг. Иймээс барилгыг газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг тооцож төлөвлөгдсөн барилгын норм дvрмийг хатуу баримтлах шаардлагатай юм. СӨХ-ийн хуулийн 13.2.7-р заалтыг зөрчиж байна. Мөн хариуцлагын тогтолцоо муу байна.
- Ус, дулаан хангамжийн нэгдсэн системийг хэсэгчлэн хувааж, олон эзэнтэй болгосноос сууц өмчлөгчид инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг дур мэдэн өөрчлөх асуудал хяналтгүй болж, нэгдсэн горим тохируулга хийх боломжгүй болсноос хангагч байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа алдагдах, хэрэглэгчдийг найдвартай ус, дулаанаар хангахад сөргөөр нөлөөлж байна. СӨХ-ийн тухай хуулий 15.6-д сууц өмчлөгчид нь орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх, орон сууцны байшингийн дэвсгэр болон орчны газрыг эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхдээ инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхэлж буй мэргэжлийн байгууллагад саад учруулахыг хориглоно гэж заасан байтал энэ заалт зөрчигдсөн байна.
- Олон жил ашиглагдсан “дундын өмчлөлийн” шугам хоолойд гарсан эвдрэл гэмтлийг засварлахад цаг хугацаа алдах, оршин суугчдыг чирэгдүүлэх, хэрэглэгч хангагчдын хооронд харилцан үл ойлголцол үүсэх, дорвитой хөрөнгө оруулалт хийгдэхгүйгээс орон сууцны ашиглалтад ноцтой нөлөөлөх явдал гарсаар байна.
- Сууц өмчлөгчдийн холбоо нь ус, дулаанаар хангагч байгууллагуудаас “дундын өмчлөлийн шугам сүлжээ”-г ашигласны төлбөр шимтгэлийг авч, түүгээрээ шугам хоолойг засварлах ёстой. Гэтэл сууц өмчлөгчдийн холбоонд хамааруулсан

инженерийн байгууламжуудад засвар үйлчилгээ хийх зардлыг сууц өмчлөгчөөс гаргуулж байгаа нь нэг үйлчилгээг хүртсэнийхээ төлөө сууц өмчлөгч нь тухайн үйлчилгээг үзүүлж буй ганц байгууллагад бус завсрын хоёр эсвэл гурван байгууллагад төлбөр төлдөг системийг өөрчлөх шаардлага зүй ёсоор гарч байна. Энэ байдал нь нөгөө талаас үйлчилгээний төлбөрийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байна.

- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15.1-д заасны дагуу хотхон хорооллын орон сууцны бус зориулалттай автомашины ил, далд зогсоол, техникийн өрөө, нэгдүгээр давхрын үйлчилгээний хэсгүүд нь оршин суугчдын дундын өмчлөлд хамаарах ёстой байтал сүүлийн үед шинээр баригдаж байгаа хотхон, хороололд барилгын компаниуд өөрсдөө ашиглах, эзэнгүйдүүлж орхих явдал гарсаар байна.
- Газар эзэмшvvлэх зөвшөөрөл олгох асуудлыг аймаг, нийслэл, сум, дvvргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргадаг. Ийнхvv газар олгох зөвшөөрлийг хамтын зарчмаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас биш, зөвхөн нэг аппаратад төвлөрvvлснээс алдаатай шийдвэр гарч, оршин суугчид олноор хохирч байна.
- Барилга барихаар олгогдсон зөвшөөрлийг эсэргvvцэн өргөдөл, гомдлыг зохих шатны байгууллага, албан тушаалтанд өгч, хянан шийдвэрлvvлэх хугацаа нь олон шат дамжлагын хvнд суртлаас болж хэт сунжран, тухайн барилга нэгэнт баригдчихдаг. Өөрөөр хэлбэл, тухайн зөвшөөрлийг vндэслэлтэй зөв олгогдсон эсэхийг хянан шийдвэрлэх хvртэл ямар нэг хамгаалалтын арга хэмжээ авах механизм байхгvй байгаагаас иргэдийн эрх ашиг зөрчигдөж байна. Уг асуудлыг шийдвэрлэж дуустал барилгын ажлыг тvр зогсоох, хэрэв барьсан бол оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илvvд vзэн тvvнийг нураах хүртэл арга хэмжээ авдаг хууль зүйн зохицуулалтыг нэн даруй хийх шаардлагатай юм.
- “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18.1.4–д холбоонд орчных нь газрыг тодорхой болзолтойгоор холбооны мэдэлд ашиглуулах боломж олгосон гэж vзэж болохоор заалт байгаа хэдий ч энэ нь иргэдийн хувьд бvрхэг, ойлгомжгvй байгаа юм. Иймд энэхvv заалтыг илvv тодорхой болгон Сууц өмчлөгчдийн холбоо нь өөрийнхөө орон сууцны орчны газрын эзэмшлийн асуудлыг зохицуулах эрх зүйн vндсийг хуульчлах шаардлагатай байна.

* * *

Дүгнэлт

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль хэрэгжих явцад мөн заалтуудаас гадна орон сууцны тухай хууль, газрын тухай хууль, иргэний хууль, барилгын тухай хуулиуд болон холбогдох бусад хуулиуд зөрчигддөг байна.

Эдгээр зөрчлүүдийг анхааралдаа авч хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар бусад хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах шаарлага практикт үүсээд байна. Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга, түүнчлэн мэргэжлийн байгууллагууд “Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангаагүйгээс шалтгаалан сууц өмчлөгчдийн холбоод хуулиас гадуур ажиллах болсон байна. Иймд хуульд заасан

UIH.MN

эрх бүхий байгууллага, албан тушаалтангууд хуульд заасан үүргээ биелүүлж тус хуулийн хэрэгжилтийг хангах нарийвчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тодорхой шат дараалал бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна. Мөн хуульд дундын өмчлөлийн эд хөрөнгийн зааг ялгааг нарийвлан тусгаж нэг байгууллагад хариуцуулах түүнтэй холбоотой маргаан гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, их засвар үйлчилгээтэй холбоотой бодит үр дүнг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож ашиглалтанд авах, дундын өмчлөлтэй холбоотой эд хөрөнгийн зориулалт, төлөвлөлт, үндсэн бүтэц хийцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгах, сууц өмчлөгчдийн холбоодыг мэргэжлийн байгууллагын харъяанд шилжүүлэх зэрэг дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй юм.

ОХУ –ын холбогдох хууль тогтоомжийн нийтлэг агуулга, тэдгээрийн практик хэрэглээний өнөөгийн туршлага сэлтээс харахад, тэнд [мөн казахстанд] байшингийн оршин суугчдын хурлыг нутгийн өөрөө удирдах ёсны [анхдагч] нэг хэлбэр гэж үзэх чиг хандлага ажиглагдах шинж бүхий байна. Энэ нь, жишээ нь, манай монголын “нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага зөвхөн засаг захиргааны нэгжийн хүрээнд оршдог” гэсэн явцуу ойлголтоос өөр байна.

Орост, олон айлт байшингийн ойр тойрны газар тухайн байшингийн оршин суугчдын [хурлын] мэдэлд “харьцангуй бодитойгоор” хил хязгаартайгаар оршин харъяалагдаж байна. Тиймээс тэнд, хаа хамаагүй хүн, байгууллага “дээд газрын зөвшөөрөлтэйгээр” ирэн [шууд] сул зайд барилга барих дур зорго хязгаарлагдсан байна. Манайд ийм хориг байхгүй байгаагаас үүдэн гудамж талбай оршин суугчдад ашиггүйгээр “бусдад эзлэгдсэн” байдалтай болсон байна.

* * *

2. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО НӨХӨРЛӨЛИЙН ТАЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (ОХУ, КАЗАХСТАНЫ ЖИШЭЭН ДЭЭР)

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдалд шууд ба шууд бусаар холбогдох асуудлын хүрээ нь дан гагц энэ холбооны эрхзүйн хэм хэмжээнд хашигдахааргүй өргөн агуулгатай юм. Оршин суугчдын эрх ашиг нь олон байгууллага, олон хуулийн хэрэгжилтээс шууд хамааралтай. Тиймээс, өнөөдрийн манай СӨХ –дын үйл ажиллагаанд гарч байгаа асуудал, бэрхшээлүүд нь их төлөв “өөр хоорондоо уялдаатай багц хуулийн асуудал” мөн тул судалгааны явцад бусад хуулийн агуулгыг ч мөн авч үзэх шаардлагатай болсныг энд тэмдэглэх нь зөв болов уу.

Нөгөөтэйгүүр, кондоминум[62]-ын асуудал бүхэлдээ олон хуулийн агуулгаар тодорхойлогдох учраас гадаадын аль нэг орны ижил төсөөтэй зохицуулалтуудыг аль болохоор хамруулан үзэхийн тулд их хэмжээний материал дээр ажиллах хэрэгцээ үүссэний зэрэгцээ, судлах тодруулах зүйлээ, бид захиалагчаас өгөгдсөн хүрээгээр хязгаарлаж богино[92] хугацаанд нэгтгэн багцалж амжихааргүй байв. Тиймээс, энэ чиглэлийн эрхзүйн зохицуулалтыг нь тухайлан сонирхох улс орны тоог хязгаарлаж зөвхөн ОХУ, БНКазахстан улсыг авч үзсэн болно.

- Кондоминиум (лат. condominium) con - хамтын, dominium - эзэмшил буюу хамтын өмчлөл, нэг том объект (их төлөв барилга байшин, үл хөдлөх хөрөнгө) –ын хамтын удирдлагыг илэрхийлдэг, дэлхийн олон улс оронд нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо юм.

[92] Кондоминиум (лат. con - вместе и dominium - владение) — совместное владение, обладание единым объектом, чаще всего домом, но также и другим недвижимым имуществом. Понятие «кондоминиум» получило большое распространение в ряде государств, в частности в США.

2.1. Оросын Холбооны Улсад

Эдүгэ ОХУ –ын хот суурин газрын хүн амын 90% нь олон оршин суугч бүхий орон сууцанд аж төрдөг гэсэн статистик үзүүлэлттэй. Орост, 2007 онд орон сууц нийтийн аж ахуй (ОСНААК) -н тогтолцоонд реформ хийх үйл явцад туслах зорилготойгоор Сангийн тухай хууль баталж хэрэгжүүлсэн. Энэ хуулийн хүрээнд олон айлт байшингийн капитал засварыг норматив хугацаанд нь тогтмол гүйцэтгэж байх болон элэгдэж муудсан аваарын байдалд орсон амьдрах нөхцөл хангахгүй байр сууцнаас оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх үед гардаг хүндрэл бэрхшээлийг зохицуулах ... гэх мэт иргэдийн эрүүл саруул орчинд амгалан тайван оршихуйн олон асуудлыг төрийн бодлогоор дэмжин зохицуулсан байдаг.

- Олон айлт байшингийн оршин суугчдын зүгээс мэргэжлийн үйлчилгээний компаниудтай хийх “тэмцэлд” 2010 оны 12 дугаар сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн ОХУ –ын Засгийн газрын шинэ тогтоол эрэг нөлөө үзүүлж байна;
- ОХУ –д, удахгүй, 2014. 7. 01 –наас олон айлт байшингийн капитал засварын нэгэнт батлагдсан шинэ хууль мөрдөгдөн үйлчилж эхэлнэ. Тэрхүү хууль ёсоор, айл болгон амьдарч байгаа байрныхаа ам метр бүрт 12 рубл. (~520 төг.) –ээр тооцогдох төлбөрийг төлөхөөр болж байгаа; ... гэх мэт.

Нийгмийн зүгээс ард иргэдэд ирэх дарамтыг бууруулах үүднээс зөвлөлт засгийн [гэх] үед оросод (1993 оныг хүртэл, улсын дунджаар) айл өрх бүр өрхийн орлогынхоо 12% -аас илүүгүй хэсгийг л орон сууцны ашиглалтын зардалд төлдөг - төлүүлдэг байх, үүнээс хэтрүүлэхгүй байх гэсэн дээд газрын албадан зохицуулалт үйлчилж байв. Тэр үед, оршин суугчдын байрны үнэд төлсөн хураамж төлбөр нийлбэр дүнгээрээ улсын нийт орон сууцны фонд ашиглалтын ерөнхий зардлыг бүхэлд нь хааж чадахгүй байсан ч хамаагүй [ө. х.] үлдсэн бүх зардлыг улсаас даан хариуцаж байлаа. Гэвч энэ байдал цааш удаан үргэлжлээгүй, социалист нийгэм [түүний өмөг түшиг ЗХУ] бүхэлдээ хямарсан билээ.

Горбачевын “өөрчлөн байгуулалт” -ын үе өнгөрч, улмаар, 1993 оноос оросын нийгэм төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоондоо оршин тогтнох аргагүй болж, эдийн засаг нийгмийн бүхий л хүрээнд реформист өөрчлөлтүүд өрнөн, нийгмийн амьдрал шинэ дэг - зохицуулалтад орж ... бүр, Үндсэн хууль нь ч өөрчлөгдөв. Шинэ конституцийн үйлчлэлийн хүрээнд эрхзүйн салбарын шинэчлэл явагдаж ... мөн өнөө хир үргэлжилсээр байна.

* * *

ОХУ –д Сууц өмчлөгчдийн нөхөрлөл гэсэн манай монголын СӨХ шиг нэртэй “холбоо” бий бөгөөд түүнээс гадна, үндсэндээ мөн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг өөр хэлбэр нэр [домком, ТОС ... г. м.] -ийн байгууллага ч нэгбус. Тиймээс бид энд оршин суугчдын дундаасаа байгуулсан хамтын нөхөрлөлүүдийн нэр, нэрэнд орсон үг утгаар явцууран хөөцөлдөх нь энд “тархи эргүүлэх” –ээс цаашгүй “зөв биш арга хандлага” гэж санагдсан.

Асуудлын мөн чанар юунд орших вэ гэхээр, нэг талаас ОСНААК, нөгөө талаас “эвлэлдэн нэгдсэн өмчийн эзэн” гэсэн байгууллагуудын хамтын бүтээлч ажиллагааны үр өгөөжийг дээшлүүхэд дэмжлэг үзүүлэх арга механизмын онцлогийг тодруулах явдал юм. Ийм механизмын гол зангилаа цэг нь “оршин суугчдын хурал” болж таарч байгаа нь ОХУ –ын холбогдох хууль тогтоомжийн агуулгаас илт байна.

Гэтэл амьдрал дээр ийм хурлыг байнга бөгөөд чанартай зохион байгуулах боломжгүй, оршин суугчдын ихгэх чадвар сул байдаг нь туршлагаар тогтоогдсон баримттай үнэн юм. Оршин суугчдын хурлаа зохих ёсоор чадваргүй, боломжгүйг “ашиглаад” ... нэгэнт байгуулагдсан СӨХ, нөхөрлөл, байшингийн зөвлөл, түүний үйл ажиллагаа “оршин суугчдынхаа хяналтаас гараад явчих” боломж магадлал өндөр юм байна. Иймийн учир,

сөхүүдэд гэхээсээ илүү, сөхийг байгуулсан оршин суугчдад хуулиар туслах хэрэгцээ үүссэн гэж хэлж болохоор ажээ. Жишээн дээр хэлэхэд, оршин суугчдын хурлын кворумаас эхлүүлээд олон зүйлийг хуулиар нарийн сайн тогтоож өгөхгүй бол СӨХ гэж нэг “дархлагдсан, аюултай” цэг үүсэх нь “зүйн хэрэг” ажээ.

- Но зачастую на практике проводить такие собрания просто невозможно, а проблемы в этой сфере нужно решать регулярно, а иногда и оперативно. Одной стороной выступают организации, оказывающие жилищно-коммунальные или ремонтные услуги, а второй - собственники квартир. По общему правилу при такой схеме решения принимаются жильцами на общем собрании при кворуме в 50%.

ОХУ –ын хууль тогтоомж дахь кондоминиум –ын тухай ойлголт

Гадаадын зарим орны хууль зүйн практикт кондоминиум гэсэн нэр томъёог хамтын эзэмшилт нэг том объектын ашиглалтын явцад гарах эрхзүйн өвөрмөц бөгөөд багц харилцааны ерөнхий агуулгаар хэрэглэдэг.

ОХУ –д энэ ойлголтыг [он цагийн тодорхой зааглалуудад] янз янзаар ухварлаж хэрэглэж ирсэн байна. Тэд, эхэн үедээ кондоминумыг эрхзүйн [бүлэг] харилцаа гэсэн утгаар нь биш, харин, энэ харилцаанд оролцогч “участник” –ыг тийн нэрлэж байв. Тэгснээ сүүлдээ зөвхөн “оролцогчид” –ыг нэрлэж байсан хуучин байдлаасаа татгалзаж, [цаад] барилга – объектоо л тийн нэрлэх болжээ. Тодруулж дурдвал,

[1992]

Кондоминиумын тухай ойлголт ОХУ –д анх “Орон сууцны талаар төрөөс баримтлах бодлого” [Федеральный закон «Об основах федеральной жилищной политики» № 4218-1 от 24 декабря 1992 г.] –ын баримт бичигт орсон байдаг. Тэнд, «Кондоминиум – это товарищество собственников жилых помещений в многоквартирных домах с установлением условий совместного владения и пользования межквартирными лестницами, лифтами, коридорами, крышами, техническими подвалами, внеквартирным инженерным оборудованием, придомовой территорией и другими местами общего пользования» гэж заасан нь бий. Тухайн заалт зөвхөн кондоминиумыг тодорхойлоод зогсохгүй оросын Сууц өмчлөгчдийн нөхөрлөл [СӨХ] –ийн “чухам юу хариуцахыг” дамаар давхар зааж өгсөн гэх үндэстэй мэт.

[1993]

Мөн, “Кондоминиумын [талаархи] түр заавар батлах тухай ОХУ –ын Ерөнхийлэгчийн зарлиг [Об утверждении временного положения о кондоминиуме № 2275 от 23 декабря 1993 г.] –т,«Кондоминиум является объединением собственников в едином комплексе недвижимого имущества в жилищной сфере (далее именуются - домовладельцы), в границах которого каждому из них на праве частной или государственной, муниципальной собственности, иной форме собственности принадлежат в жилых домах жилые (квартиры, комнаты) и / или нежилые помещения, включая пристроенные, а также другое недвижимое имущество, непосредственно связанное с жилым домом, являющееся общей собственностью домовладельцев и следующее судьбе права домовладельца на жилое и / или нежилое помещение» гэж тодотгосон байна.

[1996]

Харин, сүүлд 1996 онд гарсан ОХУ –ын Ерөнхийлэгчийн өөр нэг зарлиг [О новом этапе реализации государственной целевой программы „Жилище“ № 431 от 29 марта 1996 г.] –т кондоминиумын талаар дурдахдаа, түүнийг дээрх шиг эрхзүйн харилцааны “оролцогч” “субъект” гэсэн утгаар бус, зөвхөн “объект” гэдгээр дурдсан байх жишээтэй. ОХУ –ын 1996.6.15 –ны өдрийн хууль [№ 72 – ФЗ] –д энэ талаархи харьцангуй хожуугийн “тодруулга” өгөгдсөн. Уг хуульд, кондоминиумыг “совокупность земельного участка, помещений (включая жилые, нежилые и помещения общего пользования),

ограждающих конструкций и инженерных коммуникаций много квартирного жилого дома или нескольких односемейных домов” гэсэн юм.

[2004 - 2005]

2004.12.29 –нд ОХУ –ын №188 тоот хууль батлагдан, Жилищный кодекс 2005.3.01 –нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хуулийн агуулгад кондоминиум талаархи ойлголт тусаагүй. Энэ нь, тэнд, уг ойлголтоос ерөнхийдөө татгалзаж, түүнийг өөр буюу эх хэлнийхээ “олон квартирт байшин” гэдэг ухагдахуунаар [байшингийн доорхи газар энд хамаарна] дүйцүүлэн сольсон юм байна. Мөн кодексоор, олон айлт байшингийн дундын өмчлөлийн хэсгийн “ашиглалтын удирдлага” гэсэн ойлголт баталгаажсан бөгөөд энэхүү удирдлагын хэлбэр ч тодорхойлогдсон гэж үздэг.

Кондоминиумын [жишээлсэн] ерөнхий төрх

Орост, олон айлт байшингийн удирдлагын хэд хэдэн хэлбэр байдаг бөгөөд тэдгээрээс кондоминиумын “эрхзүйн харилцаа” гэсэн түгээмэл агуулгад хамгийн их дөхөж очсон гэмээр нь Сууц өмчлөгчдийн нөхөрлөл –ийн хэлбэр ажээ. Олон айлт байшингийн “ашиглалтын удирдлага” –ын хэлбэрээс дутуугүй мөн түүний “удирдлагын арга” [способы] –ыг бид сонирхох учиртай мэт. ОХУ –д олон айлт байшингийн [дундын өмчлөлийн зүйлсийн] ашиглалтын удирдлагын [хуульд зааж тусгасан] 3 янзын арга байна. Үүнд:

1) өмчлөгчид өөрснөө шууд удирдах;
2) СӨХ –өөр удирдуулах; [хөдлөнгийн СӨХ маягийн байгууллагаар удирдлагыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх арга энд орно]
3) орон сууцны ашиглалтын үйлчилгээг хариуцаж ирсэн удамжлалт “удирдах газар” [ОСНААК] -аар удирдуулах;

Эдгээр аргаас алийг нь сонгож хэрэглэх гэж байгаагаа оршин суугчдын нийтийн хурал дээр шийднэ. ОХУ –ын Орон сууцны тухай хууль зааж “шахсанаар”, олон айлт байшингуудын дундын хөрөнгийн ашиглагчид, талбайн өмчлөгчид 2007.01.01 –ний дотор “удирдлагын аргаа сонгох асуудал” –ыг шийдсэн байна. Гэтэл, 2009 онд ОХУ –ын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дэд салбарын захирал В. Ефимов анхаарал татахуйц нэгэн мэдэгдэл хийсэн байдаг. Тэрээр хэлэхдээ, удирдлагын арга сонгох асуудлыг эцэслэн шийдсэн олон айлт байшингийн оршин суугчдын нийтийн [нийт] хурлын 95% нь “болоогүй хурал, эсхүл, ганц хоёрхон хүний гарын үсгээр баталгаажсан хууль бус хурал” байсан; гэжээ.

ОХУ –ын Жилищный кодекс

ОХУ –ын орон сууцны тухай хууль (Жилищный кодекс) 2005 онд шинэчлэгдсэн. ОХУ –ын жилищный шинэ кодексийн агуулгад, ерөнхийдөө, сууц өмчлөгчийн нуруунд бүхнийг үүрүүлэхээр буюу “оршин суугч өөрийхөө байрны ашиглалтын зардлыг бүрэн хариуцна” үзэл санаа нэвт шингэсэн; гэж үзэгсэд цөөнгүй ажээ. Үүнийгээ тэд, ОХУ –ын Конституцийн 7 дугаар зүйлд заасан “энэрэнгүй нийгэм [социальное государство] -ийн “тунхаг” –т харшилсан агуулгатай орон сууцны кодекс болсон; гэдгээр тайлбарладаг. Мөн, ОХУ –ын орон сууцны хуулийг өөр бусад олон аспектаар чанар ба зарчмын шаардлага хангаагүй, “сулхан зохицуулалт” болсон гэж шүүмжилдэг юм байна. Үүнд:

- Орон сууцны байшингийн [үнэ нь нэгэнт төлөгдчихсөн гэж үзэх] капитал засварын асуудлыг ор тас үгүйсгэсэн;
- Оршин суугчдыг өөрсөнд нь ашиггүй “сууц өмчлөгчдийн холбоо - СӨХ [товарищества собственников жилья - ТСЖ] –нд, хэрэг дээрээ “хүчээр хөөж оруулсан”;
- Чухамдаа, оршин суугчдын хамтын санхүүжилтээр “амьдардаг” хирнээ “хууль бус гүйцэтгэх засаглалын шинжтэй” болоод хувирчихсан янз бүрийн [ОСК г. м.] нэр хаяг бүхий “зуучлагч маягийн” үйлчилгээний байгууллагуудад оршин суугчдыг “албаар барьж өгсөн”; ... гэх мэт.

> Ийм шүүмжлэл дагуулахуйц зүйл заалт монголын хууль тогтоомжид ч түгээмэл. Жишээ нь, Сууц өмчлөгчдийн холбооны эрхзүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай [Монгол Улсын] хуулийн 16.2. –т, орон сууцны байшингийн нэг буюу хэд хэдэн сууцанд хамаарах дундын өмчлөлийн эд хөрөнгө (инженерийн шугам сүлжээ, салхижуулалтын хоолой, давхрын хаалга болон бусад тоног төхөөрөмж гэх мэт) -ийн засвар, үйлчилгээтэй холбогдсон зардлыг тухайн эд хөрөнгийг ашиглаж байгаа сууц өмчлөгчид хуваах төлнө” гэсэн байдаг.

ОХУ –д [хотын захиргаа] гүйцэтгэх засаглалын байгууллагууд нь ОСНААК –уудаар дамжуулан (дольщикуудын байр худалдан авахдаа төлсөн үнийн дүнд нэгэнт багтсан) иргэдийн дундын хувийн өмчид байнга, чимээгүйхэн, өөрсөнд нь мэдэгдэлгүйгээр

халдсаар ашигласаар ирсэн гэж үзэх зарим үндэслэл байдаг ажээ.

> Эта собственность фактически принадлежит жителям на правах общедолевого владения– гэснийг, энд бид утгачилсан ойлголтоор авч хэрэглэв. Байр сууцны дундын эзэмшлийн жишээ нь, инженерийн холболтууд өмчийнхөө хувьд байр худалдан авагчдын сууц анх авахдаа төлсөн үнэ мөнгөнд орчихсон, товчдоо, ОСНААК –ын биш хөрөнгө юм.

Мөн тэд [гүйцэтгэх засаглалын байгууллагууд], оршин суугчдын зөвшөөрөлгүйгээр дундын өмчлөлийн [суух зориулалтын бус] талбай, гаднах газрыг бусдад янз бүрийн хэлбэрээр бусдад чөлөөтэй эзэмшүүлэх шилжүүлэх үйлдийг байнга хийдэг. Орост, засаг захиргааны зүгээс давтамж ихтэй гаргадаг энэ мэтийн үйл хандлага оршин суугчдын эсэргүүцэлтэй тулгардаг ч, зарга тэмцэл даамжирлаа даамжирлаа гээд шүүх прокурорын шатандаа, эцсийн дүндээ, тэгсхийгээд замхардаг нийтлэг зураг бий болсон буюу хот суурин газрын олон оршин суугч бүхий томхон байшингийн оршин суугчид хаа сайгүй захиргааны зүгээс ирж байгаа элдэв дур зоргын өмнө хүчин мөхөсдөх байдалд орчихсон байдаг ажээ.

Энэ бүхэн, засаж залруулахгүй бол эцсийн дүндээ иргэдийг, мөн нийгмийг бүхэлд нь, төр засгийн эсрэг сэтгэхүйтэй болгох, улмаар, нийтийг хамарсан үймээн самуунд хүргэх аюултай байдлыг нөхцөлдүүлнэ. Тиймээс, олон түмэн, оршин суугчид эвлэлдэн нэгдэх үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэн дуу хоолойгоо нийлүүлэн, нутгийн удирдлагын анхдагч шатанд тухайн асуудлаар удирдлага – санаачилгыг “өөр дээрээ татаж авах” –ыг эрмэлзэхийн чухлыг ил тод уриалах явдал энд тэнд ажиглагдсаар байна.

ОХУ –ын Орон сууцны кодексийн 161.1 –т, “... 4 –өөс дээш айлтай байшинд амьдарч байгаа сууц талбай өмчлөгч байрны нийтийн хурал [общее собрание] -аар [заавал] Оршин суугчдын зөвлөл байгуулна” гэж заажээ. Энэ хурлыг явуулах дэгийн асуудал ч уг хуулиар зохицуулагдсан байдаг.

* * *

ОХУ дахь Сууц өмчлөгчдийн нөхөрлөл [СӨН] **-ийн тухай**

Сууц өмчлөгчдийн нөхөрлөл нь ОХУ –ын хууль тогтоомжиийн зарим заалт, тайлбар ёсоор, нутгийн өөрийн удирдлагын нэг төрөл хэлбэрт тооцогддог юм байна. Олон айлт байшингийн ашиглалтын процессийг хэвийн жигд явуулах үүднээс олон айлт байшингийнхан дундаасаа санаачлагчийн группийг үүсгэн, оршин суугчдын “бүгдийн хурал” –ыг зохих журмын дагуу явуулж, улмаар СӨН –ийг байгуулдаг аж. Ингэх нь байр сууц ашиглалтын тулгамдсан асуудлыг оршин суугчдад ашигтайгаар түргэн шуурхай шийдэх боломжийг нөхцөлдүүлдэг; гэж үзнэ.

ОХУ –д Сууц өмчлөгчдийн нөхөрлөлийн эрхзүйн байдлыг эхлээд нэг хэсэг хугацаанд Иргэний хуулиар болон СӨН –ийн тухай хуулиар [Гражданский кодекс РФ и Федеральным законом от 15 июня 1996 № 72-ФЗ «О товариществах собственников жилья»] зохицуулж байв. Тэгснээ, 2005 онд ОХУ –ын Орон сууцны тухай хууль батлагдсанаар мөн оны 3 сарын 1 –нээс эхлэн СӨН –ийн тухай хуулийн үйлчлэл дуусвар болж уг харилцаа ОХУ –ын Жилищний кодексийн дагуу явах болсон байдаг. СӨН –ийн бүртгэхдээ ашгийн бус байгууллагуудыг бүртгэх журмыг баримталдаг.

Нэмж хэлэхэд, СӨН –ийн асуудал хэсэгхээн хугацаанд буюу 2006.4.18 – 2007.12.15 –ны хооронд ОХУ –ын Ашгийн бус байгууллагын тухай хууль [Федеральный закон от 12.01.1996 № 7 - ФЗ «О некоммерческих организациях»] -иар бас зохицуулагдаж байжээ.

СӨН –ийг олон айлт байшингийн квартируудын өмч эзэмшигч нар байшингийнхаа ашиглалтын хэвийн зохист горимыг хангах, ашиглалтыг сайжруулах, дундын өмчөө “захиран зарцуулах” чиглэлд хамтын удирдлага хэрэгжүүлэхээр байгуулна. Хуульд заасан

ёсоор, СӨН ашиг олох зорилготой байж болохгүй. СӨН –ийг байгуулах, түүний дүрмийг батлахдаа, заавал, олон айлт тухайн байшингийн нийт өмчлөгчийн олонх [зөвхөн хуралд суусан оршин суугчдын олонхиор бус] -ийн саналаар шийднэ. Ер нь, ямар асуудлыг ямар бүрэлдэхүүний ямар хувиар шийдэх ёстойг ОХУ –ын Орон сууцны кодексийн агуулгад заасан байдаг. Олон айлт байшингийн нийт өмчлөгчдийн 2/3 нь дэмжсэнээр батлагдах хэрэгжих шийдвэрүүд ч бий.

СӨХ байгуулагдсанаар тухайн байрны оршин суугчид бүгд автоматаар тэрхүү СӨХ –ийн гишүүн болчихдоггүй гэнэ. СӨХ –ийн гишүүн болохын тулд өмч эзэмшигчид заавал “нэгдэх өргөдөлөө” бичгээр гаргах ёстой ажээ. СӨН –д нэгдсэн гишүүн хүссэн цагтаа өргөдлөө гаргаж болох ба мөн хүссэн цагтаа СӨН –өөс гарч болно. Олон айлт байшингийн СӨН үйл ажиллагааныхаа явцад нэгдсэн гишүүдээ алдсаар ... үлдсэн гишүүд нь нийт оршин суугчдын талаас бага хувийг эзлэх болбол хуульд заасан ёсоор тийм СӨН татан буугдах учиртай аж.

> Орост, “нэг байшинд нэг СӨН” гэсэн зарчмаар СӨН –үүдийг байгуулдаг боловч, газар нэгтэй, мөн инженерийн дэд бүтэц нэгтэй байшингуудыг нэг СӨН –д харъяалахыг зөвшөөрдөг. СӨН –ий удирдах байгууллага нь оршин суугчдын хурал юм. Энэ хурлаас Удирдах зөвлөлийг сонгоно. Удирдах зөвлөл бол байнгын гүйцэтгэх байгууллага. Удирдах зөвлөл өөрийхөө эзлжинд Удирдах зөвлөлийн даргыг сонгоно. Нөхөрлөлийн бүх баримт бичгэн дээр итгэмжлэлгүйгээр гарын үсэг зурах, нөхөрлөлийг төлөөлөх эрхтэй хүн бол Удирдах зөвлөлийн (СӨХ –ийн дарга) юм. Председатель правления ТСЖ не является органом управления ТСЖ, так как статья 144 Жилищного кодекса РФ не относит его к числу таковых. СӨН –ий Хяналтын зөвлөл (Ревизионная комиссия) –ийг мөн нийтийн хурлаас сонгоно. СӨН –ий удирдах зөвлөл, СӨН –ий дарга, Хяналтын зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа 2 жил. Эдгээр албан тушаалд нэг хүнийг ахин дахин сонгож болно, энэ тал дээр хязгаарлалт байхгүй. СӨН –ийн ажиллагсадын нийт орон тоо, бүрэлдэхүүний цалин хөлсний хэмжээг СӨН –ийн Улирдах зөвлөлийн хурлаар баталсан журмын дагуу зохицуулдаг.

а) СӨН –ий хурлын санал тоолох зарим онцлог

ОХУ –ын орон сууцны тухай хуульд олон айлт байшингийн СӨХ –ийн нийт гишүүдийн хурлын санал тоолох аргачлалыг шууд тодорхой заагаагүй. Харин, тухайн байрны сууц өмчлөгчдийн нийтийн хурлын санал тоолох процедур бол тодорхой байдаг. Тэгэхээр, ОХУ –д байшингийн оршин суугчдын нийт өмчлөгчдийн хурал, СӨН –д нэгдсэн гишүүдийн хурал гэсэн 2 өөр ойлголт тодорхой зааг ялгаатай болох нь харагдаж байна. (Порядок подсчёта голосов на общем собрании собственников установлен императивно и изменить его Уставом ТСЖ или иным образом нельзя)

Санал тоолох арга механизмыг ч дотор нь бас ангилж авч үздэг байна. Үүнд:

- Саналын эрх эзэмшиж буй помещений талбайн хэмжээтэй шууд пропорциональ хамааралтай байх тохиолдол байдаг. Энэ нь, квартирын юм уу эсхүл айлд үл тооцогдох талбайн хэмжээ том байх тусмаа түүний эздийн санал харьцангуй илүү жин дарна гэсэн үг. Байрны нийт өмчлөгчдийн хурлын санал тоолох ийм боломжийг Жилищный кодекс (ч.3 ст. 48, ч.1 ст. 37 ЖК РФ) –д дурджээ. Уг аргачлалыг СӨН –ий гишүүдийн нийтийн хуралд төсөөтэй хэрэглэх боломж бүхий аж.
- “Нэг гишүүн – нэг санал” –ын зарчмыг бас хэрэглэж болно. Энэ нь, нэг өмчлөгч хэд хэдэн өрөө – талбайтай байлаа ч гэсэн түүний саналын үнэ цэнэ бусдынхаас ялгамжтай давуу байхыг үл зөвшөөрнө. Харин, эсрэгээр, нэг том талбай хэд хэдэн өмчлөгчтэй байх ахул, тэдгээрийн өмчлөгч болгон саналын эрхтэй байна.
- Хүнээр нь биш квартираар нь тооцож саналын эрх олгох хувилбар бас байна. Энэ нь ерөнхийдөө “нэг айл нэг санал” гэсэн зарчим мөн болов уу. Талбайн хэмжээ энд тооцогдохгүй.

Дурдсан 3 төрөл зүйл аргачлалын аль нэгийг сонгож хэрэгжүүлнэ. Санал тоолох критерийг сонгохдоо хурлын кворумыг тодорхойлоход бэрхшээл үүсэх хандлага буй. Саналын эрхээ нэмэгдүүлэх зорилгоор оршин суугчид ордер бичгээ олон хүний нэр дээр болгох зэрэг “сөрөг үйлдэл” гаргаж болзошгүй байдаг. “Том” ба “жижиг” [метр квадратаар] айлын хүлээх үүрэг хариуцлагыг “саналын жинг тэгшитгэх” замаар тэнцүүлэхэд үйлчилгээний хөлс тарифыг талбайн хэмжээтэй уях бололцоогүй болгох сул тал үүсдэг дутагдалтай байдаг гэнэ.

Орон сууцны оршин суугчдын зөвлөл (Совета жителей дома – СЖД, Москва хотын жишээн дээр)

ОХУ –д сууц өмчлөгдийн холбоо [товарищества собственников жилья - ТСЖ] -ноос гадна “Байрны зөвлөл - БЗ” гэсэн байгууллага манайхны СӨХ –ны чиг үүрэгтэй нилээд хэмжээний давхцал бүхий үйл ажиллагаа өрнүүлдэг туршлага бас байна. Тиймээс, тэрхүү “байрны зөвлөл” – байгууллагын чиг зорилго эрх үүргийг дор тухайлан авч үзье.

- [Олон айлт] Байшингийн зөвлөл (собрания) тухайн байшингийн дэвсгэр нутгийн хувьд нутгийн өөрөө удирдах ёс зарчимд үндэслэсэн, анхдагч шатны, [хот айл, түүний гишүүдийн] хамтын оршихуйн нийтлэг дэг журмын бүх асуудлыг авч хэлэлцэх эрх бүхий өөрийн удирдлагын дээд байгууллага мөн;
- Байшингийн хуралд хамрагдах эрх бүхий оршин суугч нь тухайн байшингийн тодорхой хаалга – хаягаар байнга оршин суух албан ёсны бүртгэлтэй, уг байшингийн харъяалагдах сонгуулийн нутаг дэвсгэрийн хэсэгт саналын эрх бүхий иргэнийг хэлэхээс гадна, тухайн байшингийн “дундын өмчлөлийн байр талбайн албан ёсны түрээслэгчид мөн хамарна;
- Тухайн байшингийн салшгүй бүрдэл хэсэгт ордог орчны газар буюу ойр тойрны газар дээр ашгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг тухайн байрны зарим оршин суугч, тэдний үүсгэсэн нэгдэл – хоршоо нь Байшингийн зөвлөлийн хуралд суух эрхтэй; ... гэх мэт.

Энд, байшингийн ойр тойрны газар буюу “придомовая территория” гэсэн ойлголтыг бяцхан тодруулъя. Байшингийн орчны газар гэдэг нь тухайн байшингийн эргэн тойронд байгаа мэргэжлийн байгууллагын норм нормативаар тогдоогдсон хэмжээ зааг бүхий газрыг хэлж байгаа юм. Энэ газар дээр тухайн байшингийн инженерийн шугам хоолой, нийгэм экологийн болон нийгэм ахуйн бүтэц байршдаг. Байшингийн ойр тойрны газар тогтоогдсон норматив хэмжээнд анхнаасаа хүрэхгүй байдалтай байсан бол түүнийг тухайн байгаа бодит хэмжээгээр нь тооцох ба олон байшин өөрсдийн дундын газраа нийлүүлэн “нутаг дэвсгэрийн хамтлаг” –ийн зохион байгуулалтад орсон тохиолдолд, тухайн нэг байшинд ногдох орчны газрын хэмжээ нэмэгдэх боломж ба тохиолдол байдаг байна.

Москвад, байшингийн зөвлөлүүд байгуулагддаг нийтлэг дүрэмтэй, тэр дүрмийг нь Ассоциация территориальных общин и объединений байгууллагаас боловсруулж батлсан байдаг.

Байшингийн зөвлөлийн үүсэх ба үйл ажиллагаа явуулах эрхзүйн үндэс нь дараахь баримт бичгүүдэд зарчмын тусгалаа олсон гэж үзнэ. Үүнд:

1. Нутгийн өөрөө удирдах ёс зарчмын тухай Европын харти;
2. ОХУ –ын Үндсэн хууль, Орон сууцны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж;
3. Устав территориального общинного самоуправления (территориальной общины) утвержден Советом Ассоциации территориальных общин и объединений от 31.03.2004 г. (АТОО)
4. Устав Ассоциации территориальных общин и объединений Московского совета

местного самоуправления. Утвержден Советом Ассоциации территориальных общин и объединений (АТОО) 24.10.2004 г. (Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд заасан ёсоор “Конституция РФ и федеральные законы имеют верховенство на всей территории РФ”)

ОХУ –ын энэхүү Орон сууцны оршин суугчдын зөвлөл (ОСОСЗ) -ийн чиг зорилгыг ерөнхийд нь товчоор манай [монголын] СӨХ –тэй ижилдүү юм гэж ойлгогдов. Тэнд, “ОСОСЗ нь оршин суугчдын зүгээс амьдарч байгаа байр байшингаа зүй ёсоор ашиглах, додомдон тохижуулах, энэ чиглэлд хүч оролцоогоо нэгтгэн тухайн асуудлаар иргэний болон үндсэн хуулиар олгодсон эрхээ хамтран хамгаалах нэгдэл мөн” гэж[63] заажээ.

Оросын ОСОСЗ –ийн бүрэн эрхийн хүрээнд олон асуудал туссан байдаг. “Дүрэм” –ээ батлах, ОСОСЗ үүсгэх, татан буулгах ... гэхчилэнгийн процедур шинжтэй үйлдлүүдийг энд бүгдийг тоочин дурдах нь илүүц гэж үзнэ. Харин, дурдахгүй орхиж боломгүй зарчмын хэд хэдэн санаа байгааг хэлье. Үүнд:

- байр байшингийн хэвийн байдлыг алдагдуулахгүй байх, мөн, өмчийн ашиглалт түрээслэлт, шилжүүлэлт эзэмшүүлэлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- байшингийн дэргэдэх газрын хил заагийг тогтоох, өөрчлөх;
- тухайн байшингийн зай талбайг бүрэн дүүрэн ашиглахтай холбогдсон асуудлыг оршин суугчдад ашигтайгаар шийдэх, зохицуулах;[64]
- ОСОСЗ нь тухайн байшинд (оршин суугчдад) үйлчилгээ үзүүлэгч ОСНААК –ын үйл ажиллагаанд [үйлчилгээний чанарын] хяналт тавих;[93]
- Тухайн байшингийн урсгал ба их засварын ажлын гүйцэтгэлийг хянах;

ОХУ дахь ОСОСЗ –ийн өмнө өгүүлсэн дүрэм журам, түүний эрх хэмжээний хүрээ заагийг тодорхойлсон заалтуудын агуулгаас харж байхад,[94] ОСОСЗ нь нутгийн өөрөө удирдах ёс зарчмыг эш болгосон, иргэдийн өөрийн зохион байгуулалтын, өөрийн удирдлагын хэлбэртэй, өөрсдийн“аюулгүй орчинд амгалан тайван орчинд амьдрах хууль ёсны эрх ашгаа [хамтын хүчээр] хамгаалахын төлөө оршдог, ашгийн бус үйл ажиллагаа өрнүүлдэг; гэж хэлж болохоор байна.

Байшингийн дарга

ОХУ –ын Орон сууцны тухай хуулийн 164 дүгээр зүйлд олон айлт байшингийн оршин суугчдын хурал, ОСНААК –тай биш, чухамхүү “гэрээт гүйцэтгэгч” ... мэтийн гуравдагч этгээдтэй нийт байшингаа төлөөлж харьцах эрх бүхий бүрэн эрхт төлөөлөгчийг сонгох тухай заасан байна. Энэхүү бүрэн эрхт төлөөлөөлөгчийг жилищный хуульд “байрны ахлагч, байрны дарга” гэсэн байна. Байрны дарга байрны нийт оршин суугчдыг төлөөлөх эрхтэй.

Байшингийн комитет буюу “домком”

Байшингийн комитет нь байрны даргын зөвлөл маягийн өмнөхийн өргөтөгсөн хэлбэр юм. Нэр нь л ондоо болохоос биш ОСОСЗ ба Байшингийн комитет угтаа нэг зүйл гэдэг нь Домкомын эрхлэх заим чиг үүрэг, тодорхойлолтоос харагддаг. Байшингийн комитет бол оршин суугаа газрынхаа харъяаллаар нэгдэж үүсгэсэн олон айлт байшингийн оршин суугчдын [тодорхой асуудлаар] эрх ашгаа хамгаалах **сайн дурын нэгдэл** юм. Байшингийн комитетийн зорилго нь,

- орон сууцны зөв зохист ашиглалтын чиглэлээр тулгарах нийгэм ахуйн аливаа

[93]ст.12, ст. 130 - 132 Конституции РФ;

[94]установление, изменение границ придомовой территории и всех вопросов, связанных с использованием всех помещений дома, технических сооружений и коммуникаций, всех систем жизнеобеспечения.

асуудлыг хамтран хэлэлцэх, шийдвэрлэх, шийдүүлэх;

- нэг байшинд оршин суугч хөршүүдийн эвсэг найрсаг зан харилцааг бэхжүүлэх;
- байшиндаа болон байшингийхаа ойр тойронд амьдралын тааламжтай нөхцөл бүрдүүлэх, бүрдүүлэхийн төлөө ажиллах;
- байшингийнхаа ойр тойрны хүрээлэн байгаа орчныг хамгаалах, олон нийтийн хяналт тавих; ... г. м.

Домком — это общественное объединение граждан, основанное на **добровольных началах** по месту их жительства в многоквартирном доме. Целью комитета является совместное решение социальных проблем в жилищной сфере, развитие доброжелательных отношений между соседями, создание комфортной среды проживания, осуществление общественного контроля за содержанием жилых домов и придомовых территорий, объектов благоустройства и озеленения.

ОХУ –ын орон сууцны тухай хуулийн 161 дүгээр зүйлд, олон айлт олон байшин дундаасаа нэг Домком байгуулж болохгүй тухай буюу нэг байшинг хариуцсан нэг Домком байх тухай заасан байдаг.

Нутгийн өөрийн удирдлагын “олон айлт байшинд суурилсан” анхдагч хэлбэр буюу “территориальное общественное самоуправление (ТОС)

ОХУ дахь энэхүү ТОС –ын эрх үүргийн тодорхойломж, түүний чиг зорилгын хэрэгжилтийг амьдрал дээр гарсан бодит нэгэн шүүмжлэлийн агуулгаар товчхон тодруулж өгүүлье.

Олон айлт байшингийн нэг оршин суугч хөшүүдийнхээ хүсэлт шаардлагаар, нэг нөхөр, 80 айлт 5 давхар хуучин байшингийнхаа оршин суугчдын бүх нийтийн хурлаар ном журмын дагуу “байшингийн дарга” болоотхож. Тэрний болон түүний нөхдийн гол гол зорилго нь холбогдогч ОСНААК –тай “тулж ажиллах”, байшингийхаа айлуудын эрх ашгийг ОСНААК –ын хариуцлагагүй цалгар назгай байдлаас “хамгаалах” явдал байв. Энэ нь, иргэдийн хүсэлт шаардлагыг үйлчилгээний контор хүлээж авахгүй, тоож үзэхгүй байснаас үүдсэн ... арга буюу хийгдсэн зайлшгүй алхам байлаа. Товчхондоо, өөр арга байсангүй.

Тэгээд ирцээ сайн бүрдүүлээд хурлаа хийгээд авчээ. Хурлынхаа протокол тогтоолыг аваад [шинэ дэвшсэн эрч хүчтэй] байрны дарга тухайн байрныхаа харъяалагддаг ОСНААК –т оршин суугчдаа төлөөлөн хүрч очив. Хүсэлт шаардлагаа ч уламжилжээ. Тэгсэн контор – компанийхан “та бүхний хэлээд байгаа тэр ажил үйлчилгээг чинь бид өөрснөө тэртэй тэргүй хийчихнэ” гээд огт цочирсонгүй. 7 хоногийн дараа байшингийн дарга дахиад хүрч очив. Тэглээ гээд түүнийг мөн л “авч хэлэлцэх” янзгүй гэнэ. Тэгэхээр нь, байрны дарга өөрийхөө бүрэн эрхийн талаар харилцагч тал нь чухам ямар ойлголттой байдгийг асууж лавлан, мөн, “байрны дарга” гэсэн үнэмлэх бичиг нэн даруй шийтгэж олгохыг шаардан тэрүүхэндээ бяцхан “чангараад” үзсэн ч тусыг мөн эс олжээ. Нөгөө талаас түүнд ийн хариулжээ: - Та бол байрны дарга мөн, үгүйсгээгүй, тэрнийг нотлох нэмэлт үнэмлэх бичиг ч танд огт хэрэггүй ... таныг ийн ажилласаны төлөө ямарваа нэгэн нэмэлт урамшуулал танд олгогдохгүй. Таны хийх үндсэн ажил [чинь] бол “байрныхаа мөнгийг төлөхгүй байгаа тэр хүмүүстэй тулж ажиллах явдал юм” – гэж элдэгээр сургамжлан зөвлөв гэнэ.

Ийм байх ёсгүй хэмээн сэтгэсэн байрны дарга эргэлзээгээ тайлахаар хотын захиргаа руу харайлгав. Тэнд бичиг баримт протокол тогтоол сэлтийг нь сүрхий үзэж анхааралтайяа сонсоод ... “байрны зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан нэгдсэн дүрэм журам байхгүйг, мөн хэзээ бий болох нь тодорхойгүйг ч нэмж хэлжээ. Харин, удахгүй бид нутгийн өөрийн удирдлагын “олон айлт байшинд суурилсан” анхдагч хэлбэр гэгддэг “территориальное общественное самоуправление (ТОС) –уудыг байгуулна, тэгээд ажил үйлчилгээ сайжирна цэгцэрнэ гэж айлджээ.

Байрны дарга ТОС –ын дүрэмтэй нь танилцсан байна. Тэгээд, ТОС гэдэг нь мөн л сайн дурын “эхлэл санаачилгын” шинжтэй “хүч султай” байгууллага болохыг олж мэджээ. Энэ бүхний дараа байрны дарга олон айлт байшингийн оршин суугчдад ТОС ба ТСЖ хоёрын чухам аль нь илүү хэрэгтэйг тодийлэн сайн ухварласангүй хэвээр үлдэв. Тэгээд зогссонгүй, ер нь, хуучнаараа ОСНААК –аа “гуйгаад” явж байсан ч өлзийтэй байж уу даа гэсэн эргэлзээ хүртэл төрсөн; гэдэг.

Энэ нийтлэгдүү байж мэдэх түүхээс үзэхүл, СӨХ –ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлд оросын талын “оршин суугчдын эхлэл санаачилгад тулгуурласан” эдгээр туршлага бидэнд тус нэмрээр тун бага гэж санагдав. Харин, ОХУ –ын ОСНАА –н [салбарын] удирдлагын институт (Институт управления ЖКХ) –ийн үйл ажиллагаанд авууштай анхаарууштай олон зүйл байгааг С) дэд гарчгийн дор хойно жич дурдана.

2.2. Казахстанд

Сууц өмчлөгчдийн “домком” –т зохион байгуулалт орчин цагийн эерэг агуулгаараа эдүгээ казахстанд ч бас хэрэглэгдэж байна. Үг нэрийн хувьд домком нь эртний хуучин хэллэг юм. Зөвлөлт (ЗХУ) –ийн бүрэлдэхүүнд байсан улс орнуудын ялангуяа хижээл насныханы хувьд энэ тушаалтан нэг тийм до яамны мэдээлэгч матаач, хамар хаяа хөршдөө амар заяа үзүүлдэггүй [дээхнэ үеийн уранзохиолд олонтаа дүрслэгдсэн] өөдгүй шургаач этгээдийн сөрөг дүрээр буух нь элбэг; гэдэг.

Казахстаны “Орон сууцны харилцааны тухай” хуульд домком –ын тухай тодорхойлж заагаагүй. Гэвч орон нутгийн засаг захиргааны байгууллага (районы акимат) -ын зарим мэдээ мэдээлэлээс, тэнд, домкомыг кондомиумын удирдлагын өнөөгийн нэг хэлбэр гэж үздэг нь илт байна. Ер нь оросын, мөн казахстаны Орон сууцны тухай хуульд, орон суугчдын өөрсдийн [дундаасаа] сонгож байгуулдаг тэр хоршоо нөхөрлөлийг оноосон нэрээр бус ерөнхий агуулгаар нь тодорхойлжээ.

Казахстанд домкомыг сонгох огцруулах өөрчлөх нь тухайн байрны сууц өмчлөгчдийн өөрсдийнх нь мэдлийн асуудал байдаг. Ингэхийн тулд, оршин суугчдын нийтийн (общее) хурал дээр квартир өмчлөгчдийн 50 -аас доошгүй хувийн санал хэрэгтэй болдог бөгөөд хурлын шийдвэрт хуралд оролцогсодын нэрийн жагсаалт (оршин суугчийн гарын үсэг бүхий) -ыг заавал хавсаргадаг байна.

Домкомын эрх мэдэл нийтийн хурал түүнд ямар бүрэн эрх олгосохоос хамаарна. Казахстаны домкомын нийтлэг төрх нь үйлчилгээ үзүүлэгч ОСНААК, үйлчилгээ авагч (оршин суугчид) –ын хоорондох “эрх бүхий зуучлагч” (посредник) –ийн шинжтэй байдаг. Хэрэв домком хүлээсэн үүргээ биелүүлэхгүй хариуцлага алдвал яах вэ – мэдээж, энэ нь оршин суугчдын өөсдийн эрх мэдлийн асуудал. Гэхдээ, хүндрүүлж авч үзэх үндэслэл бүхий буюу домкомын зүгээс орон сууцны харилцааны тухай хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн тохиолдолд засаг захиргааны нэгжийн акиматад[95] хандаж болдог.

2.2.1. Орон сууц нийтийн аж ахуйн салбарын удирдлагын институт

ОХУ –ын Москва дахь ОСНАА –н [салбарын] удирдлагын институт (Институт управления ЖКХ) 2011 онд байгуулагдсан. Ашгийн төлөө энэ байгууллагын үйл ажиллагааны гол зорилго нь ОСНАА –н системийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, улмаар тулгамдсан асуудлыг тодорхойлох, хүндрэл бэрхшээлээс ангижрах гарц санал болгох, санал зөвлөмж боловсруулахад чиглэгддэг.

[95] Институтын ректораар “ОСНААК –ийн салбарын тэргүүний ажилтан”, АО «Жилкомаудит» -ийн Ерөнхий захирал, ОХУ –ын Бүс нутгийн хөгжлийн яамны ОСНАА –н экспертийн зөвлөлийн гишүүн, эдийн засгийн ухааны доктор, И. П. Маликова ажилладаг.

ОСНАА –н салбарын удирдлагын институтэд эдийн засаг, санхүү бүртгэл, барилга, эрхзүйн салбарын гаршууд мэргэжилтнүүд шинжээч – экспертээр ажиллаж төрөл бүрийн холбогдох стандарт, дүрэм журмыг боловсруулж ажилладаг. Институтын шинжээчдийн зөвлөлийн дарга нь ОХУ –ын орон сууц нийтийн аж ахуйн салбарын тогтолцооны шинэчлэлд туслах Сангийн **удирдах бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд энэ нь ажлын уялдаа холбоог сайжруулахад эерэгээр нөлөөлдөг байна.**

Институтын үйл ажиллагааны гол зарчимыг тэд, “ОСНАА –н хэмжээний үндсэн зорилтуудыг оновчтой тодорхойлох, [дотоод] салбар хоорондын тулгамдсан аливаа асуудалыг нэг нь нөгөөгөөсөө харилцан хамааралт цогц системийн хүрээнд нэгмөр шийдвэрлэх явдал” гэж үздэг байна.

Дээрх институт нь, хувь хүн хуулийн этгээд, засаг захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагуудад доорхи үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

- Мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгөх;
- ОСНАА –н салбарын тулгамдсан асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулах;
- Үйлчилгээний чанар стандарт, норм норматив, салбарын удирдлагын техник – зохион байгуулалтын болон эрх зүйн зохицуулалтын асуудлаар санал зөвлөмж боловсруулах;
- Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, тэдгээрийн өөрчлөлтийн төсөл боловсронгуй болгох чиглэлээр экспертийн санал дүгнэлт гаргах;
- ОСНАА салбарт мөрдөгдөж буй норм нормативын таарамжийг тодорхойлох, тэдгээрт экспертиз хийх;
- Салбарын мэргэжилтнүүдийн мэргэшил боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт семинар зохион байгуулах; ...

Энэ институт мөн орон сууц өмчлөгчдийн мэргэжлийн байгуулагаас авч байгаа үйлчилгээ, түүний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулагдаж байгаа олон нийтийн хэлэлүүлэг, зөвлөлгөөнд оролцох, тэдгээрийг санаачлан зохион байгуулж, салбарын үйл ажиллагаатай холбогдсон [шинжээчдийн гаргасан] эрх зүйн тайлбар танилцуулга, бусад холбогдох материалыг сэтгүүл брошюр гаргах замаар ОХУ –ын бүх бүс нутаг регионд хэвлэн нийтэлж хүргэдэг байна.

Институтын зүгээс санаачилж олны талархлыг хүлээсэн саяханы нэг багц бүлэг ажил нь ОСНАА –н салбарын үйлчилгээ, олон айлт байшингийн хамтын удирдлагын тогтолцооны үнэ хөлс, тариф, тэдгээрийн өөрчлөлтийг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн 2012.9.01 –ний байдлаар шинэчлэн тооцож гаргасан явдал юм.

Анхаарах зарим санаа

1. ОХУ –д олон айлт байшингийн доторхи квартир өмчлөгчдийн “бүгдийн хурал”, СӨХ –д хамрагдсан гишүүд – өмчлөгчдийн [бүгдийн бус] хурал хоорондоо зарчмын том ялгаатай юм. СӨН үйл ажиллагаагараа нийт оршин суугчдын талаас илүү хувийг өөртөө татаж чадахгүй хэмжээнд сул ажиллавал, хуульд заасан ёсоор, татан буугдах бололцоотой ажээ. Энэ нь СӨН –үүдийн үйл ажиллагааны үр дүнг тооцох нэг төрлийн [хуулиар тавигдсан] “хяналтын механизм” юм байна.

2. Олон айлт байшингийн “бүгдийн хурал”, мөн СӨХ –ийн хурлын аль алиных нь “байнга бүтээлч оршин тогтнох чадамж сул” бөгөөд энэ өвөрмөц байдал [дутагдал] нь, СӨХ –ийг “оршин суугчдын хяналтын гадна орших” бололцоог нөхцөлдүүлдэг.

   Аж амьдрал дээр олон айлт байшингийн нэг квартирын тухайн нэг дундач өмчлөгч өөрийгөө зөвхөн өөрийн “гэр” –ийн эзэн мэтээр “алдаатай” сэтгэж, байшин арчилгааны

4 хананаасаа цаашхи ажил үйлсэд санаа тавих хүсэл зориггүй байдаг байна. Магадгүй энэ нь, ОХУ –д жишээ нь, зарим талаараа, иргэдийн хуучин уламжлалт соц. сэтгэлгээний урхаг ч байж мэдэх юм.

Сууц өмчлөгчдийн дунд СӨН –д нэгдэхийг болон СӨН –ийн хураамж төлөхийг үл хүсэгч хүмүүс байдаг. Тэднээс, хамтач бус хандлага эргэлзээт байр сууриа өөрчлөхийг шахаж шаардах нөлөөллийн механизм байдаггүй. СӨН –ийн гишүүн энэ авир байдлаа өөрчлөөгүйн төлөө түүнийг нийтийн хурлаар СӨН –ийн гишүүнээс хаслаа ч гэсэн “буруутан” этгээд уг байшинд байсаар байх нь дамжиггүй. Шүүхийн журмаар түүнийг байшингаас хөөх асуудал, орост , “онолын хувьд” өнөө хир ямарнэгэн хэмжээгээр оршдог шиг байна. Энэ алхамыг хийжээ гэж бодоход, зардал төлбөрийн талаасаа, СӨН –д өөрт нь бас ашиггүй тусдаг гэх. Хэн нэг иргэнийг өмчөөс нь, амьдралын анхдагч хэрэглээнээс нь албадан салгах утга санаа, энд, ямар нэг байдлаар яригдаж байна гэдэг их аюултай.

3. ОХУ –ын холбогдох хууль тогтоомжийн нийтлэг агуулга, тэдгээрийн практик хэрэглээний өнөөгийн туршлага сэлтээс харахад, тэнд [мөн казахстанд] байшингийн оршин суугчдын хурлыг нутгийн өөрөө удирдах ёсны [анхдагч] нэг хэлбэр гэж үзэх чиг хандлага ажиглагдах шинж бүхий байна. Энэ нь, жишээ нь, манай монголын “нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага зөвхөн засаг захиргааны нэгжийн хүрээнд оршдог” гэсэн явцуу ойлголтоос өөр байна.

   Энэ зарчим жишгийг дагах боломж бий эсэх нь Үндсэн хуулийн үзэл санаа [зүйл заалттай бус] -тай холбоотой эрхзүйн нарийн асуудал юм. Үнэхээр тэгж болдог бол, СӨХ –ийг жинхэнээс нь “удирдах [чиглүүлэх] газар” бараг тодорхой болчих юм ч шиг зэ. Ямар ч байсан, СӨХ –үүдийг [манайд] оршин харъяалагдах хорооны ИТХ –тай ажил төрлийн уялдаатай болгох боломжтой мэт.

4. Орост, олон айлт байшингийн ойр тойрны газар тухайн байшингийн оршин суугчдын [хурлын] мэдэлд “харьцангуй бодитойгоор” хил хязгаартайгаар оршин харъяалагдаж байна. Тиймээс тэнд, хаа хамаагүй хүн, байгууллага “дээд газрын зөвшөөрөлтэйгээр” ирэн [шууд] сул зайд барилга барих дур зорго хязгаарлагдсан байна. Манайд ийм хориг байхгүй байгаагаас үүдэн гудамж талбай оршин суугчдад ашиггүйгээр “бусдад эзлэгдсэн” байдалтай болсон байна.

ЦЭРГИЙН АЛБА ХААХ ХУГАЦААНЫ ТАЛААРХИ ГАДААДЫН УЛС ОРНЫ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Оросын холбооны улс, Америкийн нэгдсэн улс ... бусад улс орны жишээн дээр хийсэн лавлагаа, харьцуулалт)

Р. Хатанбаатар, Г. Чулуун

Цэргийн албаа хаах хугацааг 24 сар болгон өөрчлөх чиглэлд хууль боловсруулах санаачилга төсөл явж байгаатай холбогдуулан, гадаадын улс орнууд дахь хугацаат цэргийн албаны “хугацааны зохицуулалт” ямар байдгийг тодруулах зорилгоор товч лавлагаа, харьцуулалт хийв.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад “цэргийн албаа хаах хугацаа” -г эргэж харах .. өөрчлөх явдал олонтаа гарч байна. Жишээлбэл,

1. **Оросын холбооны улсад** ...

   ОХУ –д [хугацаат] цэргийн албаа хаах хугацаа 12 сар юм. “1 жилийн цэрэгтэй” байх энэ шийдвэрийг 2006 онд гаргажээ.

   ОХУ –ын Төрийн дум дахь коммунист намын бүлгээс санаачлан 2009.4.21 –нд “оросын зэвсэгт хүчний өнөөгийн байдал, түүнийг бэхжүүлэх арга зам, цаашдын зорилт ..” -ын талаар “дугуй ширээ” -ний хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэг, хуралдааны явцад оросын батлан хамгаалах салбарын бэрхшээлт олон асуудал яригдсан бөгөөд бүр цэргийн номлолыг [хүртэл] өөрчлөх тухай хөндөгдөж байлаа. Бидний сонирхож байгаа чиглэлд,

   - нэг жилийн хугацаат албаа цэргийг жинхэнэ ёсоор бэлтгэх шаардлагыг хангахгүй байна. Энэ хугацааг 12 биш 18 сар болгох, мөн, жилд 2 биш 3 удаа цэрэг татдаг байх” –аар хуульчилъя; гэсэн саналыг Думын батлан хамгаалахын асуудал эрхэлсэн хорооны дарга [сүүлд болсон] депутат В. Комоедов [энэ хэлэлцүүлэг дээр] гаргаж байв. Депутат В.Комоедов нь хар-тэнгисийн флотын командлагч байсан [цэргийн мэргэжилтэн, адмирал] хүн бөгөөд “цэргийн албаа хаах одоогийн 1 жилийн хугацаа хэтэрхий бага, оросын армийн бэлэн байдал (боеготовность) –д сөргөөр нөлөөлж байна; гэж үздэг аж. Гарсансан саналаасаа болж тэрээр мэргэжлийн армийн “эсрэг үзэлтэн” гэх зэргээр хэвлэлд шүүмжлүүлсэн нь их ажээ.

ОХУ –ыг Төрийн Дума –ийн батлан хамгаалахын .. асуудал эрхэлсэн хороон дарга, коммунист нам [КПРФ] бүлгийн депутат Владимир Комоедовын “цэргийн албаа хаах хугацааг “одоогийнхоос нь 6 сараар нэмэгдүүлж, 1.5 жил болгох” гэсэн санаачилгыг [эдүгэ] ОХУ –ын Ерөнхийлэгч В. Путин дэмжихгүй байгаа тухай Ерөнхийлөгчийн хэвлэлийн албанаас 2012.11.22 –нд мэдээлжээ. [Болж өнгөрсөн] Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн явцад цэргийн албаны хугацааг нэмэхгүй байх талаар нэр дэвшигч В. Путины амлалт ч байдаг бололтой юм.

Комоедовын саналыг их төлөв цэргийн хүрээний дээгүүр тушаалтнууд дэмждэг, мөн, олон хүн (правозащитники) эсэргүүцдэг аж. ОХУ –ын зэвсэгт хүчний жанжин штаб энэ талаар “цэргийн албаа хаах хугацааг нэмэн өөрчлөх саналгүй” байгаагаа илэрхийлсэн байдаг. Энэ бүхний дараа депутат В. Комоедов “уг санал миний хувийн бодол байсан юм” гэж мэдэгдсэн байна.

2012 оны XI сард ОХУ –ын Батлан хамгаалахын сайд Сердюковыг “элдэв хэл аманд ороцолдсон” шалтгаанаар огцруулсан. Цэргийн зарим экспертийн тэмдэглэсэнээр,

огцорсон хуучин сайдын гол үзэл санаа нь оросын армийг мэргэжлийн арми болгон хувиргах явдал байсан ба энэ байдал нь, нийтийн цэрэг татлагаар буюу “хүнээр зодож” бүрдүүлдэг тийм армиас өөрийг мэдэхгүй [хоцрогдсон] цэргийн эрхтнүүдийн дургүйг ихэд хүргэсэн. “Шинэтгэгч” сайд огцормогц, одоо хуучинсаг үзэлтнүүд яг цагаа олоод шоволзоод гараад ирж байна. Тэд “цэрэг засах зөвлөлтийн модель” –ийг санал болгох биз; гэх зэргээр бичжээ. “Цэргийн эзэжүүдийн хороодын холбоо” ТББ –аас “цэргийн албаа хаах хугацааг нэмэх үндэслэл бүхий шаардлага шалтгаан одоогоор нэг ч байхгүй” хэмээн мэдэгджээ.

Байдал ийм байгаа ч, Оросын холбооны улсад, одоогоор, 2006 оны шийдвэрээ эргэн харж өөрчлөх, ө. х. хугацаат цэргийн албаа хаах хугацааг 18 сар болгож нэмэгдүүлэх чиглэлд хууль санаачлах эрх бүхий улстөрийн зарим зүтгэлтнүүд, ялангуяа холбогдох байнгын хорооны удирдлага (В. Комоедовын орлогч, “нэгдсэн-оросын” депутат Ф. Клинцевич .. г. м.) идэвхтэй ажиллаж байгаа аж.

Төрийн думын депутат, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Байнгын хорооны удирдлагын саналыг оросын Батлан хамгаалах яам дэмжээгүй. Чиглэлийн яамны шинэ сайд (С. Шойгу) –ын байр суурь уг асуудал дээр ямар байгаа нь тодорхой бус байна.

ОХУ –д цэргийн албаа хаах хугацааг багасгаж 1 жил болгохдоо (2006) хууль тогтоочдын зүгээс доорхи тайлбарыг хийж байсныг эдүгээ “эсрэг чиглэлийн өнцгөөс” эргэн санахад сонирхолтой юм. Үүнд:

- энэ бол оросын зэвсэгт хүчний системийн шинэчлэлийн нэг хэсэг;
- орчин цагт гадаад аюул занал дэлхийн II дугаар дайныхтай адилгүй, түүнээс тэс өөр болсон. Зэр зэвсэг, техник технологийн шинэчлэл биднээс хуучнаасаа ялгаатай өөр арга хандлага шаардаж байна; .. г. м.
- надо учитывать, что Россия не может полностью отказаться от призыва. Но сокращение срока службы по призыву необходимо, что и предусмотрено во внесенных изменениях. С 2007 года срок службы будет составлять полтора года, а с 2008 – один год. Этого достаточно, тем более что все больше частей и соединений планируется переводить на профессиональную основу;
- мэргэжлийн армитай байх ба болох европын орнуудын туршлага нь зэвсэгт хүчний системийн шинэ загвар хуучнаас илүү үр дүнтэй, давуулаг тогтолцоо болохыг харуулж байна; .. г. м.

2. Бусад зарим оронд ...

a) 2012 оны II сард **Гүрж**ид хугацаат цэргийн албаны хугацааг нэмсэн. Энэ нэмэлтээр хуучин мөрдөж байсан 12 сарын хугацаа 15 сар болж өөрчлөгджээ. Цэргийн албаа хаах хугацааны талаархи гүржийн хуулийн энэ зүйл заалт нь, тэнд, тухайн асуудлыг сүүлийн 8 жилийн хугацаанд 4 удаагаа авч хэлэлцсэний дүнд хийгдсэн сүүлчийн шинэ өөрчлөлт юм.

b) Киргизүүд тун саяхан, 2012 оны X сард, цэргийн дүйцүүлэх албаны хугацааг 2 дахин хорогдуулж, 1ж.6с. болгосон байна. Өмнө нь уг хугацаа, тэнд – 3ж. байсан юм.

c) Германд бүх нийтийн цэргийн үүргийг 2011 оны VII сараас эхлэн тодорхойгүй хугацаагаар [түр] зогсоосон. Тэнд, эх орноо, сарын 800 – 1100 евро -ийн цалин (дээр нь нэмэгдлүүд бий) -тай сайн дурынхан хамгаалдаг.

d) Финляндид 1998 онд хугацаат цэргийн албаа хаах хугацаа 8 сар байсныг болиулж

багасган 6 сараар тогтоожээ. Гэсэн хэдий ч тэнд цэргийн дүйцүүлэх албаны хугацаа хуучнаараа буюу буюу 13 сараар хэвээр нь үлдээжээ.

e) Сүүлийн 5 - 6 жилд, цэрэг татлагаас татгалзсан зарим орнуудын жагсаалтыг дор дурдъя. Үүнд:

- Серби (2011)
- Польш (2010)
- Швец (2010)
- Хорват (2008)
- Литва (2008)
- Латви (2007)
- Болгар (2007)

f) Унгар улс 1999 онд НАТО –д элссэн. Тэр цагаас цэрэг бүрүүлэх тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлсээр 2005 он гэхэд тус улс гэрээт албан хаагчдаас бүрдсэн мэргэжлийн армитай болжээ. Ингэснээр, өмнө нь 136 жилийн туршид үйлчилж ирсэн “цэрэг татлагат” тогтолцоог халсан юм. Энэ шилжилт явагдсанаар унгарын армийн бие бүрэлдэхүүний тоо “хуучнаасаа” 3 дахин цөөрсөн байдаг.

Унгарын парламент 2004 онд дээрх шилжилтийг бүрэн баталгаажуулж холбогдох хууль эрхзүйн орчныг бүрдүүлж өгчээ. “Татагдаж ирсэн” ирсэн сүүлчийн цэрэг мөн оны намар халагдаж дууссан юм. Энэхүү түүхэн чухал үйл явдлыг тэмдэглэж Будапештийн Баатруудын талбайд тусгай арга хэмжээ зохин байгуулсан байдаг. Тэр цагаас хойш, унгарт цэргийг албадаж татдаггүй .. харин, урьдаг болсон юм. Тэнд, унгарын залуус (охид) ойролцоогоор 1000 долл. цалинтайгаар гэрээт албан хаагч болдог байна. Эрсдэл өндөртэй даалгавар гүйцэтгэх тохиолдолд цалин 2 ба түүнээс илүү дахин нэмэгддэг .. г. м.

g) Францын цэрэг босгох тогтолцоо ерөнхийдөө америкийнхтай төстэй. Францын арми 100% сайн дурын гэрээт албан хаагчдаас бүрдэнэ. Францын цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэлийн явцад “муу юм тохиовол” ар гэрийг нь төр засгаас баталгаатай харж үзнэ гэдэгт итгэл төгс байдаг. Францын зэвсэгт хүчин улс орныхоо хэмжээнд хамгийн том ажил олгогчийн нэг болдог. Францад “цэрэг” гэдэг бол “ажил амьдрал” юм.

Францын армийн байлдагч, эхлээд 3-5 жилийн хугацаатай гэрээ байгуулах, дуусахаар нь хүсвэл, тав таван жилээр сунгуулаад үргэлжлүүлээд явж болдог. Цэргийн үндсэн цалин 1100 - 1300 евро байх ба алба хаасан хугацаанаас хамаараад хэмжээ нь нэмэгддэг. Армийн ахмадын цалин 2400 евро, дэд хурандаагийн 3250 евро байх жишээтэй.

Францын цэргийн албан хаагч (байлдагч) энхийг сахиулах үйлсэд оролцож гадаадад үүрэг гүйцэтгэвэл сарын 2500 евро авна. Түрүүчийн цалийн энэ тохиолдолд 4000 евро г. м. (Бусад нэмэгдүүд энд оруулаагүй юм байна) Байлдаантай халуун цэг рүү явах эсэхээ тухайн цэргийн албан хаагч өөрөө сайн дураараа шийднэ.

* * *

UIH.MN
СУДЛАЛЫН САНГ

3. **Цэргийн алба хааж эхлэх нас ба хаах хугацаа** (Тив тивийн зарим орны жишээн дээр)

	Хойд Солонгос	Израйль	Турк	Дани	Эстони	Чад
Цэрэгт татагдах нас	17 н.	18 н.	20 н.	18 н.	18 н.	18 н.
Цэргийн алба хаах хугацаа (сараар)	120	36 (хүртэл)	6 (дээш)	4 (дээш)	8 (дээш)	36

Дашрамд тэмдэглэхэд, Израйлийн армид “хал цэргийн дэг” гэх гаж үзэгдэл байдаггүй гэнэ. Тэнд цэргийг цэрэг татахаас өмнө сургадаг. Залуу байлдагчийн курсийн сургалт 3 сарын хугацаатай. Цэрэгт татагдсан - эр хүн **3 жил**, - эм хүн **2 жил**ийн хугацаагаар тус тус алба хаана. Израйлийн цэрэг харьцангуй чөлөөт эрхтэй. Тэд сар бүр гэрээдээ хариад ирэх чөлөөгөөр хангагддаг. Израйлийн арми дээд боловсролтой цэрэгт их сонирхолтой. Ирсэн цэрэг нь дээд сургууль элсэх эрхтэй байх ахул, түүний сургалтын төлбөрийн Батлан хамгаалах яамнаас хариуцан төлөх боломжтой. Ингэхийн тулд “нөгөө цэрэг” 7 жил (үүнээс 3 жилийг байлдагчаар, 4 жилийг офицераар) алба хаах нөхцлийн зөвшөөрөх ёстой юм. Израйлийн энгийн цэргийн цалин ~200 долл. –тай дүйнэ.

4. **Америкийн нэгдсэн улсад** ...

Америкт цэргийн албыг сайн дурын үндсэн дээр хаана. Залуухан хархүү (охин) –г цэргийн алба хаасангүй гэж хэн ч буруутгахгүй. (Орост, жишээ нь, цэргийн алба хаагүй бол төрийн албанд, полицайд ажиллуулахгүй .. гэх мэт хязгаарлалтууд байдаг) АНУ цэрэг сайн дураар элсүүлэх улсын хэмжээний байнгын нэгдсэн сүлжээтэй. Хүн хэрэв хүсвэл цэрэг элсүүлэх төвд очоод гэрээ контрактаа байгуулаад л бол оо. Насны хатуу зааг хязгааргүй. Гэхдээ 18 – 34 насныханд “элсэх магадлал хавьгүй илүүтэй” байдаг нь судалгаагаар тогтоогджээ.

Цэрэгт орсон хүнийг бүртгүүлсэн мөчөөс нь эхлэн 250 мянган долл. –р автоматаар даатгалд даатгана. Цэрэгт элссэн хүн нэг сарын цалинтай ээлжийн амралт авах, үнэгүй эмчлүүлэх, үнэгүй (цалинтай) суралцах .. г. м. олон хөнгөлөлт эдэлнэ. Тэнд, цэргийн эрдмийн 150 гаруй мэргэжил буй гэх. Хожмын “генералууд” олон тест шалгууруар орж, амжилттай давсан нь цэргийн академи дүүргэнэ. Хулгай хийх, зодоон цохион үүсгэх .. зэрэг хэрэг зөрчил гаргавал цэргийн албанаас хасагдана.

Даалгавар гүйцэтгэж яваад хохирсон цэрэг ба офицерт материаллиг тусламжийг насан туршид нь олгоно. Энэ тусламж ар гэрийнх нь байдлаас хамаарч 15 мянган долл. ба түүнээс дээш хэмжээтэй байна. Ахмад дайчдын .. янз бүрийн халамжийн байгууллагууд ч их байдаг. Тэр байгууллагууд [мөн хүмүүст] нэмэлт тэтгэж олгодог. Бас төр засгийн зүгээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх тохиолдол мэр сэр гардаг, гэх. Товчдоо, америкт цэргийн алба нь тухайн хүний хувьд, жишээ нь, “ажил мэргэжил сонгохтой” төсөөлиг агуулгатай, чухамдаа “хувь хүний амьдралын замын боломжит нэг сонголт” байсаар иржээ; гэмээр.

5. [Нэмэлт] **зарим санаа**

а) Цэргийн жинхэнэ алба хаах хугацааны харьцуулалтыг нь тухайлан сонирхож үзсэн дээрх хэдэн орны [авагдсан жишээ] жишээ мэдээнээс үзэхэд, гадаадын улс орнууд зэвсэгт хүчнээ цомхон чадварлиг бие бүрэлдэхүүнтэй, мэргэжлийн арми болгон өөрчлөх хандлага чиглэлд явж байгаа нь ажиглагдав. Мөн, цөөнгүй улс

оронд “хугацаат цэргийн алба хаах” хугацааны өөрчлөлт [дээрх жишээнүүдийн хүрээнд яривал] дан гагц багасах буурах чиглэлд тэмүүлж ирсэн; гэж хэлж болохоор байна.

b) ОХУ –ын хувьд бол бидний “сонирхсон асуудал” тэнд, бусдаас нилээн өөр байгаа. Тэнд цэргийн жинхэнэ албаны [хаах] хугацааг нэмэх асуудал “төслийн өмнөх буюу эхлэлийн шатандаа” яваа юм. Цэргийн алба хаах хугацааг нэмэх үзэл санааны гол дэмжигчид, тэнд, думын “коммунист нам” фракцийн зарим депутатууд байх шиг байна.

c) Оросын холбооны улс бол цэргийн их гүрэн. Зэвсэгт хүчний талбар дахь тэдний бодлого зохицуулалт, цэргийн номлол бусад улс оронд тэр бүрий “таалагдахгүй байх” магадлал өндөр гэж үзнэ. Орост, хүн амын нөхөн үйлдвэрлэл уналтын байдалд орсоор удаж байна. Эл байдал эдүгээ, тэндэхийн “армийн бие бүрэлдэхүүний хомсдол” –д ч нөлөөлж байгаа нь дамжиггүй юм .. г. м.

2013.01.30

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГАД ХОЛБОГДОХ ЗАРИМ ЛАВЛАГАА

Р. Хатанбаатар, Г. Чулуун

УИХ –ын гишүүн Д. Эрдэнэбатын ирүүлсэн захиалгын[96] дагуу бид Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тухайлсан зарим заалт, тэдгээрийн [хүлээгдэж байгаа] өөрчлөлтийн талаар лавлагаа тодруулга хийв. Захиалгад доорхи асуултууд оржээ. Үүнд:

1) Монгол Улсад цэргийн алба хаах хугацааг өөрчилж байсан шалтгаан нөхцөл;
2) Цэргийн алба хаах хугацааг 24 сар болгон өөрчилж хуульчилсан тохиолдолд, уг шийдлээс, улсын нийгэм эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөлөл
3) Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7. –д[97] дурдсан “цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах” –ад [өнөөгийн] 12 сарын хугацаа хүрэлцээтэй эсэх;
4) Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь заалт[98] -ыг хүчингүй [болсоноос] үүсэх үр нөлөө;
5) Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тоо; (сүүлийн 5 жилийн байдлаар)
6) Гадаадын улс орнууд дахь цэргийн алба хаах хугацааны талаархи зохицуулалт, харьцуулалт;

Тодруулга шаардсан эдгээр асуудлын сүүлчийн буюу 6) дахь хэсэгт хамааруулж “Гадаадын улс орнууд дахь цэргийн алба хаах хугацааны талаархи зохицуулалт, харьцуулалт” гэсэн жич сэдэвт тусдаа материал бэлдсэн. Тиймээс, энд [үлдсэн] эхний 5 асуултын талаар, дарааллын дагуу өгүүлэв.

Мэдээллийг бэлтгэхдээ, шийдвэрээс гарах үр дагаварын холбогдолтой зарим асуудал дээр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын холбогдох албаны мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажилласан. Мөн, Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг анх [Улсын Бага Хурал, 1992] батлахад, уг хуулийн төслийг хариуцсан парламентын ажлын хэсгийн даргаар, хошууч генерал, д-р. (Ph.D), проф. Н. Жалбажав ажиллажээ.

* * *

[96] УИХ –ын гишүүн Д. Эрдэнэбатын 2013.01.25 –ны өдрийн № - $^{6}/_{253}$ тоот албан бичиг;

[97] Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 5 дугаар зүйл, зүйлийн гарчиг: Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс, зарчим, Зүйлийн доторхи заалт: 5.2. Зэвсэгт хүчний байгуулалт нь дараахь зарчимд тулгуурлана, ... дэдийн дэд заалт: ... 5.2.7. цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах; ... гэж буй.

[98] Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиийн 12 дугаар зүйл, зүйлийн гарчиг “Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх”, заалт 12.8. –д, “Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана. Уг албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг Улсын Их Хурал батална. Мөнгөн төлбөрийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно. Мөнгөн төлбөрийн орлогын 50 хүртэлх хувийг орон нутгийн төсөвт, үлдсэнийг улсын төсөвт төвлөрүүлэн батлан хамгаалах зорилгод зарцуулна” гэжээ.

1) Монгол Улсад цэргийн алба хаах хугацааг [хамгийн сүүлд, 1992 онд] **өөрчилсөн үндэслэл**

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг Улсын Бага Хурал 1992.5.14 –нд баталсан юм. Энэ хуулийн агуулгад өнөөдрийг хүртэл нийт 14 удаа өөрчлөлт орсон байдаг ба хамгийн сүүлийн өөрчлөлт 2012.8.17 –нд хийгджээ. Хугацаат цэргийн албан хаах хугацааг уг хуульд анхнаасаа [л] 12 сараар тогтоосон[99] -ыг, өнөөдрийг хүртэл хэвээр мөрдөж байна.

Монголд цэргийн жинхэнэ алба хаах хугацааг өөрчилж, 1 жилээр тогтоохын өмнө, уг хугацаа 2 жил буюу 24 сар байсан юм. Цэргийн “алба хаах хугацаа” монголд, сүүлийн 75 жилд хэдэнтээ өөрчлөгдөж, доорхи байдлаар, гагцхүү, байнга багасах чиглэлд хувирч иржээ. (Хүснэгт - 1) Социализмын үед 5 ба 3 жилийн хугацаатай байсан цэргийн жинхэнэ албаны хугацаа ийнхүү, үе шаттайгаар, аажим шилжилттэйгээр .. 1 жил болж буурснаас хойш эдүгэ 20 жил болж байна.

(Хүснэгт – 1)

Он жилүүд	1939 – 1948	1948 – 1986	1987 - 1992	1992 – өнөөг хүртэл
Цэргийн хугацаа	5 жил	3 жил	2 жил	1 жил

Цэргийн алба хаах хугацааг багасган бууруулж 1 жил болгосон сүүлчийн өөрчлөлтийн ерөнхий үндэслэлийг, тухайн үеийн Батлан хамгаалахын сайд, генерал Ш. Жадамба (УБХ –д тавьсан илтгэл тайлбартаа) ийн дурджээ. Тэнд,

a) Олон улсын харилцааны чиг хандлага өөрчлөгдөж, болзошгүй цөмийн дайны аюул холдсон;
b) Эх орноо хамгаалах үйл хэргийг бусдын хүчинд дулдуйдах биш, зөвхөн өөрийн хүч боломжид тулгуурлан шийдэх цаг нэгэнт боллоо;
c) Хугацаат цэргийн албаны хугацааг 1 жилээр тогтоохдоо “тухайн үеийн холимог бүтцээ аажимдаа мэргэжлийнхэд шилжүүлэх” үзэл санаанд тулгуурласан;
d) Цэргийн албыг 1 жил болгосоор “залуучуудын идэр насандаа сурч боловсрох, ажиллаж амьдрах, ахуй нийгмийнхээ асуудлыг эртнээс шийдэж төвхнүүлэх” боломжийг нэмэгдүүлнэ;
e) Иргэн бүрийг цэргийн үүрэг биелүүлэхэд адил тэгшээр хамруулах шударга шаардлага хангагдахад дөхөм болно;
f) Өнөөдрийн манай нөхцөл байдал цэргийн алба хаах хугацааг богиносгохыг шаардаж байна. Бид өмнө нь “батлан хамгаалах бүх юмаа улсаас үнэ төлбөргүй авч байсан .. энэ юм өнөөдөр байхгүй” болчихлоо;
g) Хууль бүхэлдээ, өмнөхөөсөө илүү хүнлэг, энэрэнгүй агуулгатай болж байгаа .. энэ бүхэн эцэг эхчүүдийн санаа сэтгэлд нийцнэ;

гэдгээс илүү зүйл хэлээгүй байна. Харин, уг хуулийн төслийн шат шатны хэлэлцүүлгийн явцад зарим санаа нэмж тодорсон байдаг.

Улсын Бага Хурлын Төрийн байгууллагын байнгын хорооноос, хуулийн төслийг

[99] Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйл, Зүйлийн гарчиг: Байлдагч, түрүүчийн алба, Заалт: “Байлдагч, түрүүчийн алба нь хугацаат цэргийн алба, гэрээт цэргийн албанаас бүрдэнэ. Хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар, гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 24 сар байх бөгөөд гэрээний хугацааг цаашид 31 нас хүртэл үргэлжлүүлэн сунгаж болно” гэж буй.

дэмжихдээ, энэ хууль бүхэлдээ цаг хугацааны онцлогийг харгалзсан, нийгмийн амьдралын шаардлагад нийцсэн, мөн, цэргийн сургалтын .. хугацааг богиносгох, зардал төсөв хэмнэх нь тулгамдсан хурц асуудал болсныг дурдсан байв.

Иргэний цэргийн үүргийн ба цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн шатанд,

- Монголын арми зөвлөлтийн армийн хавсарга бүтцээр явж ирсэн;
- Батлан хамгаалах стратеги, цэргийн номлол .. олон юм тодорхойгүй байна, тэдгээрийг гарна удахгүй бий болно гэх мэтийн хоосон төсөөллөөр тайлбарлаад, санал өгөхөд хэцүү байна;
- Монголын арми “цэрэг унтаж байхад алба явж л байдаг” гэсэн .. тэр дүр төрхтэйгээ хэвээр байгаа;
- Зүүнбаянд цэрэг өлсөөд галзуурсан, тэнд, цэргийн баяраар ялзарсан махан хоолтой байсан, нийгмийн байдал цэрэг цуухын төдийгүй .. бүх салбарт хүнд байгаа; (хүн өлсөхөөрөө галзуурдаг эсэх нь тодорхойгүй ч, уурлаж догширдог нь бол биологийн хуулираа үнэн юм)
- Хэн нэгэн этгээд манай руу их хүчээр гэнэт цэрэглэн хөдөлбөл .. тэгээд тосоод байлдаад байлдаад байх юм уу яахын, эсхүл “тулалдахгүй” гэж мэдэгдэхиймуу, буугаад өгөхийм бол армиар яахын ...; гэхчилэнгийн содон үгс ч дуулдаж байв.

Эцсийн дүндээ Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын 1992 оны хууль амжилттай батлагджээ. Хугацаат цэргийн албаны хугацаа - 1 жил [болох ба] болсонтой холбогдож, “цэрэг татах – цэрэг халахад” хамаарал бүхий шуурхай зохицуулалтууд зохих ёсоор хийгдэж, “зарим жил цэрэг татахгүй байх”, “цэргийг хугацаанаас нь өмнө халах” шийдвэрүүдийг ч гаргаж байжээ.

* * *

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай [хүчин төгөлдөр мөрдөж байгаа 1992 оны] хуулийн хэлэлцүүлгийн явцын энэ мэт өгүүлэмжийг протоколын нийт агуулгатай хамтатган тоймлоход,

> 1992 онд цэргийн алба хаах хугацааг 1 жил болгож багасгахдаа, шийдвэр гаргагч нар улс орноо мэргэжлийн армитай болгоно гэхээсээ илүү, зэвсэгт хүчний салбар дахь соц.системийн нийтлэг хямралаас үүдэлтэй материаллиг хомсдол, тулгам учирсан саад бэрхшээлийг нэр төртэй даван туулах [тухайн нөхцөл байдалд тохирсон] хамгийн оптималь хувилбарыг сонгож, бие бүрэлдэхүүнийхээ тоог цөөлөх чиг зорилгод нийцүүлжээ. Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол цэргийн номлол .. зэрэг төрийн бодлогын баримт бичгүүд боловсорч гараагүй .. батлагдаагүй байхад 1 жилийн цэрэгт шилжсэн явдал өөрөө үүнийг дам нотлох мэт.

Үйл явдал эдүгэ нэгэнт түүх болоод хувирчихсан тул, ялангуяа цэргийн түүхчдийн холбогдох сэдэв чигийн бүтээл туурвилд дүгнэлтийн чанартай санаанууд гарсан нь мэдээж бий байх. Цаг хугацааны шахамдуу байдлаас хамааражаад, бид энэ удаад, тэдгээрийг үзэж төдийлэн амжсангүй.

2) Цэргийн алба хаах хугацааг 24 сар болгон өөрчилж хуульчилсан тохиол-долд, уг шийдлээс, улсын нийгэм эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөлөл

Цэргийн албаны хугацааг нэмж, уг хугацааг 2 жил болгон өөрчилсөн тохиолдолд, түүнээс, нийгэм эдийн засгийн нөлөө бүхий олон үр дагавар гарна. Өгүүлэмжийг

аль болох энгийн байлгах үүднээс “2 жилийн цэрэг” гэсэн хэллэг хэрэглэе. 2 жилийн цэрэгтэй болох тохиолдолд, түүнээс гарах нийгэм эдийн засгийн үр нөлөөллийн байж болох дагаварыг бид доорхи 2 багцад хуваалаа. Үүндээ, уг асуудлаар яам .. газрын урьчилан гаргасан санал – дүгнэлтийг эш болгов.

a) [2 жилийн цэрэгтэй болохын] **эерэг талууд**:

- Цэргийн ерөнхий ба, мөн, “төрөл-цэргийн” “бага мэргэжил” эзэмшүүлэх сургалтын чанарт ахиц гарна;
- Цэргийн алба хаагч .. алба хаах хугацаандаа энгийн мэргэжил эзэмшиж, энэ нь эргээд хожим тухайн хүний өөрийнх нь аж амьдрал хэрэг болох боломж нэмэгдэнэ;
- Улс орны томоохон бүтээн байгуулалтад оролцож байгаа цэргийн хөдөлмөрийн хөлсний орлогын тодорхой хувь процентийг монголын зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, цэргийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төвлөрүүлэх боломж бүрдэнэ;
- 2 жилийн цэрэгтэй болсон тохиолдолд, энэ хугацааны тодорхой хэсэгт, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа байгаль орчны хөтөлбөрүүдэд туссан уул уурхайн салбарын нөхөн сэргээлтэд болон цэргийн анги байгууллагуудын орчныг тохижуулахад .. цэргийн албан хаагч оролцох .. товчоор хэлэхэд, тэднийг эх орны бүтээн байгуулалтад оролцуулна;
- Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан “ажлын байраар хангах”, “ажилтай орлоготой монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад [зэвсэгт хүчний байгууллага] дэмжлэг үзүүлэх [боломжтой] болно;
- Цэргийн албан хаагчдыг эх орны бүтээн байгуулалтад оролцуулахын тулд [...] мөнгөн хуримтлал [тэдний хүчээр] бий болно;
- Цэргийн албан хаагчийг цэрэгт эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж, улмаар, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах, их дээд сургууль коллежид хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй суралцах нөхцлийг [урамшууллын механизмаар] бүрдүүлнэ; .. г. м. –ийг дурдсан байна.

b) [2 жилийн цэрэгтэй болоход гарч болзошгүй] **сөрөг талууд**:

- Хугацаат цэргийн алба хаах хугацаа нэмэгдсэнээр, цэрэгт татагдах насныханы “цэрэгт тэмүүлэх” сонирхол буурна. “Ганцхан жилийн цэрэг юүхэн байхав, бушуухан яваад хаагаад ирье, тэгээд дараа дараагийн ажил амьдралаа бодъё“ гэсэн иргэн хүний тэмүүлэлт сэтгэлэгийн тухай энд ярьж буй юм.
- Хугацаат цэргийн албаны хугацааг 2 жил болгон нэмэгдүүлэхэд .. цэргийн дайчилгааны нөөцийн хэмжээ 50% -иар багасч, зэвсэгт хүчний дайчилгааны бэлэн байдалд сөрөг нөлөө үзүүлнэ.

* * *

Цэргийн алба хаах хугацааг 2 жил болгон нэмэгдүүлснээс үүдэж, улс орны нийгэм эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөллийн талаархи дээрх, ялангуяа эерэг талд хамаарах үндэслэлүүд хэт ерөнхий [хангалтгүй] шинжтэй байгааг нэмж тэмдэглэх нь зүйтэй болов уу.

ШУТИС
СУДАЛГААНЫ САН

3) Цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах (сургахад, өнөөгийн) **12 сарын хугацаа хүрэлцээтэй эсэх**

Цэргийн жинхэнэ албыг хаах хугацааг 1 жил болгон багасгах тухай асуудлыг хэлэлцэж байхад (1992) хууль тогтоогч нар энэ асуудал дээр нилээн ярьсан байдаг. Тэднийг товчхон сонсъё. Жишээ нь,

- Цэргийн алба хаах хугацааг 1 жил болгох нь “цэргийн бэлэн байдал” –д сөргөөр нөлөөлж болзошгүй. Яагаад гэхээр, байлдагч хүн цэргийн эрдэмд зохих ёсоор суралцаж дадлагажих боломж [зүгээр л] цаг хугацааныхаа талаас алга болно, алдагдана. (Асуулгын чанартай үг юм)
  - Цэргийн бэлэн байдал гэдэг бол “цаг хугацаа орон зайн хамааралт” ухагдахуун. Олон цэрэгтэй байхаараа цэрэг бэлэн байдаг гэж үзэх сэтгэх нь учир дутагдалтай ойлголт юм. Цэргийн бэлэн байдал, жишээ нь, дайчилгааны асуудалтай ихээхэн холбоотой ... г. м. (генерал Ш. Жадамбаа)
  - Цэргийн нарийн мэргэжлүүдээр шинэ цэргийг 5 – 6 сар сургаад явж байна. (Тухайн цаг 24 сарын цэрэгтэй байсан үе юм) Энийг бид туршаад үзчихлээ. 8 сараас .. цаад зах нь 12 сарын хугацаатай ч сургаж болно; гэж бодож байна. (генерал Р. Гаваа)
- Монголын зэвсэгт хүчний шинэчлэлийн чиг зорилго мэргэжлийн арми руу дөхөх чиг хандлагатай тухай цэргийн дарга нар их ярих юм. Цэргийн алба хаах хугацааг багасгах нь саяын хэлсэн “номлол” зорилготой эсрэгцэх юм биш үү. Цэрэг хүн цэргийн эрдэмдээ сурах нь улам улмаар багасаад ирэхээрээ цэрэг арми харин ч бүр мэргэжлийн-бус [эсрэг] чигрүү тэмүүлмээр санагдах юм. (Асуулт)
  - Мэргэжлийн цэрэг армитай болно гэдгийн ийм хялбархнаар ойлгож ярьж болохгүй. Мэргэжлийн арми гэдэг бол хэрэг дээрээ “хөлсний арми” гэсэн үг. Энэ бол ирээдүйн манай зорилт. Тэр чиглэлд анхны алхамуудыг бид хийж байна. Мэргэжлийн арми руу шилжих шилжилт хэдий чинээ богино хугацаатай байна төдийчинээ сайн. Гэвч, энэ шилжилтийг шуурхай хийх эдийн засгийн боломж чадавхи манайд өнөөдөр (1992) бидэнд алга. Мэргэжлийн арми [гэдэг] өндөр хангамж зардал шаардана. (Генерал Ш. Жадамбаа)
  - Яг дайн байлдаан боллоо гэж бодоход, яаж бид Эх орноо хамгаалах вэ гэсэн нэг асуудал байгаа юм. Монгол хүн ам цөөтэй, уудам дэлгэр нутагтай учраас “эх орноо хамгаалахын тал дээр бол бүх нийтээрээ хамгаалах юм” шиг байгаам. Энэ үүднээс нь авч үзвэл, хүн амыг цэргийн эрдэмд сургах тийм шаардлага бас гарч ирдэг. Монгол онцлогтой, хүн ам цөөн. Байнгын мэргэжлийн армитай том орнууд бол өөр юм. (Генерал Л. Пүрэвдорж)

Цэргийн ерөнхий мэргэжилтнүүдийн эдгээр үгс монголд “цэргийн алба 2 жилийн хугацаатай байх тэр үеийнх. Тэр үед, 2 жилийн цэрэгт 6 – 8, эсхүл 8 – 12 сарын буюу нийт алба хаах хугацааныхаа (25 – 50)% -ийг сургалтад зарцуулах замаар, цэрэг хүн цэргийн эрдэмд мэргэжиж “хангалттай болоод байсан” байна. Энийг тэд “нэг төрлийн туршлага” гэж үзэж, ярьж нотолж байжээ. Туршлага үнэхээр хийгдсэн хэмээвээс .. “туршлагаар үнэнийг тогтоох” боломжтой. Мөн уг туршлага өнөөгийн манай “1 жилийн цэрэгт” ч таарч тохирч байгааг салбарын яам, зэвсэгт хүчний жанжин штабын албаны хүмүүс үгүйсгээгүй болно.

a) Израйлд, цэргийн өмнөх сургалт - 3 сар үргэлжилдэг .. гээд цэрэг сургахтай холбогдсон гадаадын туршлага их байдаг. Хойд солонгост цэргийн алба хаах хугацаа – 10 жил .. г. м. Газар газрын улс орны арга хандлага энд харилцан адилгүй юм байна. Энд, 1 жилийн цэргээс 2 жилийн цэрэгт шилжих өөрчлөлтийн тухай ярьж байгаа болохоор манай “хуучин туршлага” хэрэг болох нь дамжиггүй.

b) Нэг жилийн цэрэгт шилжих асуудлыг бид оросоос 15 жилийн өмнө шийдсэн. Оросын холбооны улс “1 жилийн цэрэг” –т 2007 онд харьцангуй хожуу шилжсэн юм. Харин, цэргийн албаны хугацааны өөрчлөлтийг эсрэг чиглэлд “эргүүлж”, буцааж нэмэх санааг өнөөдөр бид умард хөрштэйгээ бараг зэрэг шахуу хөндөж авч үзэж байгаад хамаарлын ямар нэгэн зүй тогтол үгүй .. энэ санамсаргүй давхцал юм.

ОХУ –ын “хугацаат цэргийн албаны хугацаа” нэмэгдэж гэмээнэ, “18 сар” –аас хэтрэхээргүй байгаа. Мөн, 1 жилд 2 биш 3 удаагийн цэрэг татлагын тухай тэнд ярьдаг. Орост, цэргийг цэргийн эрдэмд 6 – 12 сар сургаад, мэргэшсэн ба мэргэшиж амжаагүй буюу татагдмал цэргийн шинэ хуучин бүрдлүүдийг хэсэг зуур “газар дээрээ хамт суралцах боломж” –ийг хангах үүднээс 3 татлагатай “цэрэг сэлгэх цуваажилт” –ын механизм тавина; хэмээн зарим хууль тогтоогчид нь санал болгож байгаа юм билээ.

> Энэ бүхнийг яагаад дурдав гэхээр, хууль тогтоох төвшиндөө, хугацаат цэргийн албаны хугацааг нэмэх санал санаачилгыг тал талд зэрэг гаргаж байгаагаараа хөршүүд хоорондоо төстэй, бас үүгээрээ гадаадын бусад олон орноос содон ялгарч байгаа юм.

c) Цэргийн хугацаат албыг [нэг зэрэг] хааж байгаа хугацаат цэргийн тоо нэмэгдэж, түүнийг дагаад, цэргүүдийг .. цэргийн эрдэмд сургах энгийн багш мэргэжилтний тоо, төсөв, сургалтын материаллиг баазын зардал анги нэгтгэл бүрээр шинээр нэмэгдэж гарч ирнэ.

* * *

Дэд гарчгийн хүрээнд дүгнэлтийн чанартай нэмж хэлэхэд, цэргийг цэргийн мэргэжилд сургахад 12 сарын хугацаа хангалттай юм. Үүнийг гадаад дотоодын туршлага нотолж байна.

4) Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь заалтыг [хүчингүй болсноор] **үүсэх үр нөлөө**

Дурдсан заалт хүчингүй болсноор, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн “Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх” гэсэн дэд гарчигтай 12 дугаар зүйлийн 8 дахь заалтын үйлчлэл зогсоно. Өөрөөр харуулбал,

> §12. Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх
>
> ~~8. Байлдагч, түрүүчийн албан хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн албан хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана.~~

Анхааралд өртөөд буй энэ заалт [заалт хэрэв ийн дарагдвал (гарчиг дарагдахгүй)] “цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаахыг болиулна. Тиймээс,

ШИНЭ МЭДЭЭ СУДАЛГААНЫ

цэргийн албыг, түүн дотроо цэргийн дүйцүүлэх албыг хаах дэг процедурт анхаарлаа түр хандуулъя.

1. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль дахь, жишээ нь, “цэргийн дүйцүүлэх албыг мөнгөөр орлуулан хаах” гэсэн ухагдахуун .. утга чанарын хувьд “хугацаат цэргийн албыг мөнгөөр хаах” –аас өөр юм биш байна.

2. Үндсэн хууль ёсоор, иргэн цэргийн алба хаах үүрэгтэй. Цэргийн жинхэнэ албанд татагдсан [шинэ цэрэг] саналаа хэлж, хилийн цэрэг, зэвсэгт хүчин, дотоодын цэргийн аль нэгэнд очно.

3. Цэргийн албыг 18 - 26 насанд биеэр, эсхүл мөн, дүйцүүлэн хааж болдог. Хуулиараа ийм юм.
   - Биеэр хаах нь 1 жилийн хугацаатай, үүнийг тайлбарлах шаардлагагүй, ойлгомтой байна.
   - Харин, дүйцүүлэн хаах гэдэг нь 2 жилийн хугацаатай бөгөөд, цэргийн штабт .. [гэрээсээ, мөн] биеэр ирж, биеэрээ [байнга биш, алдаг оног ажиллаж] үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг.

4. Цэргийн алба хаагаагүй [мөртөө] 26 наснаас хэтэрсэн залуус, харин, цэргийн албыг мөнгөөр дүйцүүлж хаана. Зөвхөн 26 нас нас өнгөрч байж ингэнэ. (18 – 26) гэсэн насан дотроо бол, хэн ч байлаа гэсэн, цэргийн албыг мөнгөн хэлбэрээр хаах боломжгүй.
   - Цэргийн албыг биеэр дүйцүүлж хаасан залуус болон цагдаа, шүүх, онцгой байдлын албанд хоёр жил алба хаасан иргэд [энэхүү мөнгөн төлбөрөөс] чөлөөлөгдөнө.
   - 27 нас хүрээгүй байж мөнгө өгч хаах сонирхолтой залуус байдаг, гардаг. Энэ бол буруу юм, тийм юм байхгүй. Харин, 26 наснаас дээш буюу 27 –той болохоороо .. мөнгөн төлбөр төлөх шаардлага цэргийн алба хаагаагүй хүнд хуулийн дагуу тулгарч байгаам. Цэргийн алба хаах үндсэн нас нь хэтэрсэн учраас тэр юм.

5. Мөн, цэргийн алба хаагаагүй хүн бүр мөнгө төлдөг .. бүрэн төлдөг гэж ойлгож болохгүй.
   - Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөгдөж .. явж ирсэн бол төлөх мөнгөний хэмжээ [он оноор, таблицийн дагуу] буурна. Өөрөөр хэлбэл, өөрөө оюутан, эсхүл, эцэг эхийн аль нэг нь хөдөлмөрийн чадваргүй, 2 ба түүнээс дээш хүүхэдтэй, гэр бүлийн хүн нь тахир дутуу .. зэрэг шалтгаанаар, цэрэг татлагын комиссын хурлаар орж чөлөөлөгдөж байсан бол төлбөрийн хэмжээ ийн буурдаг.
   - 18 - 26 насны хүн нийт 8 жил дараалан цэргийн комиссоор орох учиртай. Нэг удаагийн хурлаар, дээр дурдсанаар чөлөөлөгдсөн хүний, төлбөл зохих мөнгөний хэмжээ ~14% -иар бууруад явна гэсэн үг. 8 удаа ингэж чөлөөлөгдсөн бол мөнгө төлөхгүй, нас мултарна, асуудал хаагдана.

6. Шийдвэрээс гарах үр нөлөөний тухайд бол, Батлан хамгаалах яамны .. стратеги төлөвлөлтийн газрын санал дүгнэлтэд “цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулж хаах” –ыг буруушаасан ч, шийдвэрээс гарах үр нөлөөний тухайд тодорхой зүйл дурдаагүй юм.

Цэргийн албыг мөнгөөр “хаалгуулсны” дүнд цугларсан хөрөнгийн 50% нь батлан хамгаалахын төсөвт, нөгөө тал нь орон нутгийн төсөвт тус тус ордог. Мөнгөөр хаахыг болиулснаар энэ хуримтлал төвлөрөхгүй болно. Яамны хэмжээний нийт зардал дотор нь яривал энэ хуримтлал жин дарахаар хэмжээтэй биш, өчүүхэн мөнгө юм. Батлан хамгаалах яам энэ мөнгөөр салбараа сурталчлах, цэргийн албыг биеэр хаах сонирхолтой залуусын хүрээг тэлэх сургалт [энэ-тэр] явуулах .. зэргээр ашигладаг. Батлан хамгаалах яам .. уг хуримтлалын орон нутгийн төсөвт орсон тэр хэсэг яг зориулалтаараа зарцуулагддаг гэдэгт эргэлздэг юм байна.

Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн энэхүү §12.8 заалт хасагдсанаар,

- «цэргийн жинхэнэ алба хаагаагүй 27 нас[100] хүрсэн эрэгтэйчүүд цэргийн жинхэнэ албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах» боломж үгүйсгэгдэнэ.
- Мөн, УИХ –ын 2009 оны 33 дугаар тогтоолоор баталсан,
  a) Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах болзол;
  b) Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах [үед] иргэний төлөх төлбөрийг хэмжээг тогтоосон сүлжээ; -ний хэрэглээ тус тус шаардлагагүй болно.
  c) Бас, цэргийн албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах төлбөрийн хэмжээг хугацаат цэргийн албан хаагчийн хангамж, үйлчилгээний тухайн жилийн дундаж зардлаар тооцож Засгийн газраас жил бүр тогтоож байх шаардлагагүй болно.
  d) Бусад холбогдох олон хууль тогтоомжид өөрчлөлт орно;

5) Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тоо (сүүлийн 5 жилийн байдлаар)

Цэргийн албыг дүйцүүлэн хаах журамд “цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас жил бүрийн 1 дүгээр улиралд .. аймаг, нийслэлээр тогтооно; гэж заасан. Үүнийг, улсын хэмжээнд, сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал,

Он жилүүд	2008	2009	2010	2011	2012
Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тоо	1132	1060	1064	1033	624

Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүний тоо, түүний дээд хязгаарыг .. Засгийн газраас тогтоодог нь “цэргийн мэргэжлийн удирдлагын Төв байгууллага” –ын сонирхол, шаардлагад нийцэхгүй байна гэж үзэх нь бий. Гэвч, үүнийг “хуучин зохицуулалтаараа явж болно” .. түүнчлэн, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрөөр хаадаг байдал зогсож гэмээнэ, дүйцэх алба хаагчдын тооны дээд хязгаарыг нэмэгдүүлэх боломж хэрэгцээ нэмэгдэх үндэстэй. Тэр тохиолд, үүнийг холбогдох яам газрын санал дээр үндэслээд тухай бүр нь шийдээд явахад болохгүй гэх зүйл үгүй юм.

* * *

[100] УИХ –ын 1998 оны 94 дүгээр тогтоолын хавсралтад “... зэвсэгт хүчин, бусад цэргийн аль нэг анги салбарт цэргийн жинхэнэ алба хаагаагүй 27 хүртэлх насны эрэгтэйчүүд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаана” гэж заасан.

Анхаарах зарим санаа

A. Хугацааг цэргийн албаа хаах хугацааг багасгаж хасахад буюу 1 жил болгоход (1992) хэрэглэсэн үндэслэлийн агуулгыг, утга санааных нь хувьд “буруутгах, эргэж харах” шаардлагатай болсон гэхүйц, нийгмийн шинэ нөхцөл байдал өнөө хир үүсээгүй байна, нэгдүгээрт. Хоёрдугаарт, “хугацаа хорогдуулахад” хэрэглэсэн үндэслэлийг “хугацаа нэмэхэд” ашиглахгүй нь мэдээж байх. Тэгэхээр, хугацаат цэргийн албаны “хугацааг нэмэх” –д илүү тодорхой буюу өмнөхтэй [ерөнхийдөө] өрсөлдөхүйц төдийгүй давж гарах аргумент хэрэгтэй болно. «Иргэн бүрийг цэргийн үүрэг биелүүлэхэд адил тэгшээр хамруулах шударга шаардлага хангагдахад дөхөм болно» гэх үндэслэл ч “1 жилийн цэрэгт шилжихэд” хэдийнэ хэрэглэгджээ. Харин, улс орны эдийн засгийн чадавхи нэмэгдсэнийг дурдах нь зөв болов уу.

B. Үйлчилж байгаа хуулийн бичлэг зарим талаар төвөг удах нь бий. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 –ын 8 дахь заалтын оршин буй хэсгийн малгай гарчиг “Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх” тухай юм. Дотроо олон заалттай. Энэ гарчиг агуулгаа дүүрэн илэрхийлээгүй, буруу илэрхийлсэн.

   Энд тухайлан авч үзээд байгаа 12 –ын 8 –д, товчдоо “цэргийн албаа хаагаагүй хүнээс мөнгө авах” тухай[101] л санаа буй. Үүнээс үүдэлтэйгээр буюу зүйлийн гарчигтай холбож ярихад, цэргийн албыг “мөнгөөр хаадагийг нь болиулах” гээд байна уу, аль эсхүл, “мөнгөөр хаахаас чөлөөлдөгийг нь болиулах” гээд байна уу, гэж эргэлзмээр байдал хүртэл үүсч болохоор байгаа юм. Ер нь, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хуулийн доторхи цэргийн дүйцүүлэх албаны холбогдолтой зүйл заалтууд хоорондоо логикийн зөрчил бүхий байна.

C. Цэргийн албыг хаагаагүйнхээ төлөө мөнгө төлж байгаа явдлыг, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөөр хааж байгаа мэтээр ярих нь оновчтой биш юм. Цэргийн албаа хаах үүргийг мөнгөтэй хүн мөнгөө төлөөд амархан зохицуулчихаж байхад, ингэх боломжгүй нь, хүнд хүчир албанд зөвхөн биеэрээ зүтгэхээс өөр гарцгүй байдалд ордог. Энэ нь, хүнийг нийгмийн байдлаар нь, хөрөнгө чинээгээр нь ялгаварласан .. манай үндсэн хуульт ёсны үзэл санаанд харш алхам болсон байж мэдэхээр байгаа юм.

   Монгол Улсын Үндсэн хуулийн,

   - 14 –ийн 1 –т “хүн бүр хуулийн .. өмнө эрх тэгш байна”
   - 14 –ийн 2 –т “хүнийг .. нийгмийн байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”
   - 17.1. –ийн 4 –т “иргэн [бүхэн] шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн .. эх орноо хамгаална .. цэргийн алба хаана” гэсэн байдаг.

D. Хугацаат цэргийн албыг хаах хугацааг нэмэх хасах асуудалд дамаар холбогдох өөр сэдвүүд ч байдаг. Тэдгээрийн нэг нь монголын армид олон жил он удаан үргэлжилсэн, одоог хүртэл амь бөхтэй оршиж ирсэн [оршсоор байгаа] “хал цэргийн дэг” гэгч аюул юм.

   Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хуулийг анх баталж байх үеийн, ялангуяа, цэргийн албаа хаах хугацааг багасгахад

[101] §12.8 - Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх
Байлдагч, түрүүчийн албаа хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн албаа хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана.

холбоотой хэлэлцүүлгийн явцад тухайн үеийн хууль тогтоогч нараас энэ сэдвийг хөндсөн байдал ажиглагдсангүй. Магадгүй тэд, цэргийн албаа хаах хугацаа хангалттай хэмжээгээр бага болж байгаа болохоор “дедовщина” гэх тэрхүү зүй бус үзэгдэл аяндаа нэг-мөр давхар шийдэгдчихнэ, асуудал аяндаа “арилана” гэж бодсон ч байж болох юм. Гэтэл амьдрал дээр “хал цэргийн дэг” өнөөг хүртэл байсаар аж. Энэ үзэгдлийг эрс багасахад “цэргийн албаны 1 жилийн хугацаа” эрэгээр, эрс сайнаар нөлөөлснийг дурсахгүй орхихын аргагүй юм.

Тиймээс, хэрэв бид “2 жилийн цэрэгт” –т эргэж шилжих тохиолдолд, хал цэргийн дэг, мөн хамт “жинхэнээсээ эгж ирэх” боломж бий. Үүнээс сэргийлэх чиглэлд анхаарууштай юм. Захиргаадалтын хатуу нийгэм хүртэл тухайн цагийн дэглэгчдийг “дэглэж дийлэлгүй” “армийг бараг нэргүй шорон” болгочихсон гэсэн үлгэр домог шиг үг-жишээ элбэг байдаг. “3 жилийн цэрэгтэй” байсан гүн социализмын үед цэрэгт яваад эргэж гэртээн ирээгүй .. эсхүл, тахир татуу болоод “хөдөлмөрийн чадвараа алдаад”, “хүний гарт ороод дамнуурган дээр ирсэн” байдагчийн тоо замаа алдсан гашуун түүх буй.

Энэ чиглэлд он оноор гаргасан “яаман дээрх бүртгэл судалгаа,” –г (жишээ нь, сүүлийн хагас зуун жилийн байдлаар, бүр - аймаг сумаар[102] нь) парламентын гишүүний асуулгаар, эсхүл, парламентын хяналтын өөр арга механизмаар, хууль тогтоох байгууллага өөр дээрээ албан шугамаар авч, түүнд анализ хийх шаардлагатай байна. Цэргийн мэргэжилтнүүд харамсалтай нь үүнийг ер ярихгүй байна. Яам бол энэ асуудлыг хэзээ ч өөрөө илээр сөхөж ярьдаггүй нь хугацаагаар нотлогдсон үнэн билээ. Зөвхөн “цэргийн дэглэл” -тэй холбосон эл үндэслэл “2 жилийн цэрэгт шилжихгүй байх” –д хүрэлцээтэй мэт.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын олон жилийн тэртээ (1992) хэлсэн “цэргийн албаны хугацааг 2 жилээс бууруулж - 1 жил болгох нь эцэг эхчүүдийн санаа сэтгэлд нийцнэ” гэсэн үндэслэл яг юуны тухай үг болохыг ч сайтар бодмоор байдаг. Дэлхийн олон улс оронд цэргийн албаа хаах хугацаагаа 1 жил ба түүнээс ч бага байсаар .. болсоор байна.

Ер нь, цэрэг цагдаа .. хүчний байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан алив хуулийг (төслийг) хийхдээ, уг хуулийг хэрэгжүүлэгч [тэр] байгууллагыг өөрийг нь аль болохоор оролцуулахгүй байх нь дээр; гэсэн зарчим хандлага барих шаардлагатай санагддаг. Засгийн газрын хууль санаачлах эрхийг .. энэ мэт зарим чиглэлд хязгаарлах боломжийг ч [үндсэн хуулийн агуулгын хүрээнд] судалж үзүүштэй байгаа юм.

E. Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2 хууль болгож задалж, цэргийн асуудлыг тусад нь тодорхой заагламаар байна.

2013.01.31

₪ ₪ ₪

Ашигласан материал

1. Улсын Бага Хурлын 1992 оны V чуулганы хуралдааны тэмдэглэл, ХН - 245, 246, 252, 253;
2. Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын хууль, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Цэрэг халахыг зөвшөөрсөн тухай УИХ –ын 1992 оны ... тогтоолын хувийн хэрэг, Б-№41;

[102] нэгэнт түүх болоод өнгөрчихсөн юмыг .. ядаж, зөвхөн тоон талаас нь ч болов, дүйлгэж тодруулахад хүртэл амар хялбар байлгах нь чухал;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3. Хугацаат цэргийн алба хаах хугацаанд өөрчлөлт оруулахтай холбогдсон [цэргийн мэргэжилтнүүдийн зарим албан бус] санал дүгнэлт, 2012.01.31;
4. Сэдэвт холбогдох бусад сурвалж;

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Товуусүрэн, Б. Хатантуул

Улсын Их Хурлын гишүүн С. Оюун, С. Дэмбэрэл нарын захиалгаар “Сонгуулийн сурталчилгааны зардлын санхүүжилт, гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Судалгааны төвийн ахлах референт Ц. Товуусүрэн, референт - судлаач Б. Хатантуул нар гүйцэтгэв.

Энэхүү судалгааны зорилго нь Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоо бүхий 7,8 дугаар бүлгийн заалтуудыг улам боловсронгуй болгоход чиглэгдсэн гадаадын улс орнуудын энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад оршино.

Судалгааны зорилтууд.

- Анли, Канад, Японы Сонгуулийн хуулийн сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилттай холбоотой зохицуулалтуудыг судлах;
- Дээрх улс орнуудын сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтын талаар эрдэм шинжилгээний болон, олон улсын байгууллагуудын судалгааны багуудын урьд нь гүйцэтгэсэн судалгааны ажилтай танилцах, холбогдох улс орнуудын улс төрийн намуудын сонгуулийн санхүүжилттэй холбоотой хуулийн сайтуудад байгаа материалтай танилцах;
- Судалж, танилцсан материалуудыг нэгтгэх;

Судалгааны үр дүн.

- Нэр бүхий улс орнуудын сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтын талаар холбогдох эрх зүйн акт, өмнө нь гүйцэтгэсэн бусад газрын судалгааны ажлуудтай танилцаж, холбогдох материалыг түүвэрлэн авч, , шийдвэр гаргагчдад харьцуулалт, сонголт хийх боломжийг бүрдүүлэхийг зорьсон болно.

* * *

Япон

Дэлхийн II дайны дараа Японы улс төрд АНУ-ын нөлөө хүчтэй байсан учраас улс төрийн тогтолцоог ардчилах, олон намын тогтолцоог төлөвшүүлэхэд 1946 онд батлагдаж, 1947 оноос мөрдсөн Үндсэн хууль чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Японы сонгуулийн тогтолцоо нь юуны түрүүнд шалгуур, хязгаарлатынхаа тоогоор өөрийн гэсэн онцлогтой. Сонгох эрхийг 20 наснаас эдэлнэ. Их 8-д л гэхэд ийм насны ийм хожуу хязгаар тогтоосон улс үгүй. Сонгуулийн кампаний хатуу хязгаарлалтад сурталчилгааны самбарууд нь тогтоосон хэмжээ, агуулгатай байх бөгөөд хатуу заасан газарт л байрлуулах журамтай.

Телевизээр явуулах сурталчилгааг хатуу тогтсон журмын дагуу зөвхөн нэг л телевизийн сувгаар явуулна. Сонгуулийн кампаний дүрмээр нэр дэвшигчээс сонгогчдод илгээх ил захидлын тоог хүртэл зааж өгдөг. Сонгуулийн кампаний хандивын хэмжээ, явагдах хугацаа, орон зайг ч хязгаарласан байна. Хэдийгээр ийм хязгаарлалтууд байдаг ч Японы иргэд сонгуулийн ийм тогтолцоондоо хангалттай итгэл үзүүлдэг байна. Японд хувь хүмүүсээс улс төрийн нам, нэр дэвшигчдэд шууд хандив өгөх уламжлал тогтоогүй бөгөөд үүнийг хуулиар хориглодог.

Японд сонгуулийн кампанид оролцож буй улс төрийн бүх намуудад үнэ төлбөргүй сурталчилгааны байж болох хамгийн бага хэвлэлийн талбай, эфирийн цагийг хуваарь олгох бөгөөд үлдсэн хэсгийг нь өмнөх сонгуулийн үр дүн, нэг мандаттай тойрогт нэр дэвшигчдийн тооноос хамааруулан хуваарилдаг байна. Үнэ төлбөргүй явуулах сурталчилгааны зардлыг сонгуулийн тойргийн хорооноос санхүүжүүлэх журамтай. Төрийн болон орон нутгийн засаг захиргааны аль ч байгууллагаас улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилт хийхийг хуулиар хориглодог.

Төрийн албан хаагч, төрийн төв болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг компани, корпораци сонгуулийн компанийг ивээн тэтгэгч байхыг хориглодог байна. Сонгуулийн кампани болон бусад улс төрийн үйл ажиллагааны санхүүжилтэд гадаадын иргэн, гадаадын компани, корпораци оролцох, нэр хаягаа өнгөлөн далдалж хандив өргөхийг хориглодог байна

Сонгуулийн сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалт

Японд 1988 - 1993 онд авилга хээл хахуулийн дуулиан дэгдэж, 1993 оны парламентын сонгуулиар 38 жил тасралтгүй засгийн эрхийг барьсан Либерал Ардчилсан Нам /ЛАН/ засгийн эрхээс бууж, намуудын эвсэлд эрхээ шилжүүлсэн байна. Эвслийн засгийн газар улс төрийн салбар дор дурдсан шинэчлэлийг хийсэн байна. Үүнд:

1. Сонгуулийн шинэ тогтолцоо
2. Улс төрийн хандивын эрх зүйн шинэ зохицуулалт
3. Улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалт
4. Улс төрийн намуудын хууль, эрх зүйн тусгай хэм хэмжээ

Эдгээр шинэчлэлийг хийсний үр дүнд 1948 онд батлагдаж, 1994 онд шинэчлэгдсэн “Улс төрийн санхүүжилтыг хянах тухай” хууль /Political funds control law of Japan/PFCL/, 1995 онд батлагдсан “Намын татаасын тухай” хууль/Намыг төрөөс санхүүжүүлэх тухай” хууль/Political party subsidy law of Japan/PPSL/, “Төрийн байгууллагын сонгуулийн тухай” хууль/Public offices election law/POEL/-ууд Японы улс төрийн намуудын үйл ажиллагаа, сонгуулийн кампаний санхүүжилтын харилцааг зохицуулах болов.

Улс төрийн санхүүжилтийн харилцааг зохицуулж байгаа гол хууль нь “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай” хууль бөгөөд түүний үндсэн зорилго нь сонгуульд нэр дэвшигчид, намууд, улс төрийн эвслүүдэд орж буй гишүүдийн татвар, хандивлагчдын хандив, сонгуулийн зардлыг хянаж, зохицуулахад чиглэгддэг. Энэхүү хуулиар намын орлого нь гишүүдийн татвар, хандивлагчдын хандив, сонгуулийн кампаний үеэр нам, нэр дэвшигчдэд өгсөн хандив, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих төсвийн дэмжлэгзэргээс бүрддэг болсон. 1995 оны “Намын татаасын тухай” хуулиас өмнө улсын төсвөөс намуудыг санхүүжүүлэх харилцаа байгаагүй. Харин “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай” хуулиар байгууллага, хувь хүмүүсээс улс төрчдөд шууд улс төрийн хандив өгөхийг хориглосон бөгөөд зөвхөн нам, эвслээр дамжин хандив өгөхөөр зохицуулсан.

Орон нутгийн улс төрийн эвсэл, байгууллагуудаас бие даан нэр дэвшигчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хуулиар зөвшөөрсөн байна. Бие даан нэр дэвшигчдэд аж ахуйн нэгжүүд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудаас хандив өргөхийг зөвшөөрдөг бөгөөд тэд сонгуулийн үеэр энэхүү хандив /koenkai/-ыг босгоход ихээхэн чармайлт гаргадаг байна. Намууд, нэр дэвшигчид хандивлагчдаас хандив, тусламж үзүүлэхийг ямар нэг хэлбэрээр уриалах, шахах, санал тавихыг хориглодог.

Улс төрийн намын санхүүжилт, түүний хязгаарлалт

“Улс төрийн санхүүжилтыг хянах тухай”, “Намын татаасын тухай”, “Сонгуулийн байгуул-

лагын тухай” хуулиудаар намын санхүүжилтийн эх үүсвэр нь:

- хуульд нийцүүлэн намын дүрэм бусад эрх зүйн актуудаар тогтоосон гишүүдийн татвар байх бөгөөд намуудын хувьд харилцан адилгүй байдаг ч ерөнхийдөө ойролцоо байхаар зохицуулсан байна.
- Хандивын тухайд “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай” хуулиар нэлээд тодорхой зохицуулсан байна.

Улс төрийн намд хувь хүнээс өргөх хандивын дээд хэмжээг 2 сая иен, улс төрийн холбоодоос өргөх хандивын дээд хэмжээг “Улс төрийн санхүүжилтыг хянах тухай” хуулиар дор дурдсанаар зохицуулсан байна. Үүнд:

1. 100 мянгаас дээш гишүүнтэй бол 30 сая иен
2. 50 - 100 мянган гишүүнтэй бол 15 сая иен
3. 50 хүртэл мянган гишүүнтэй бол 7 сая 500 иен гэж тогтоожээ.

Хэрэв хуулийн энэ заалтыг зөрчиж, хуулиас гадуур хандив, орлого олсон тохиолдолд холбогдох этгээдийг 5 жил хүртэл хорих ялаар шийтгэх буюу 1 сая иений торгууль ногдуулахаар хуульчилжээ. Харин компани, корпорациудаас өргөх хандивын дээд хэмжээг “Улс төрийн санхүүжилтыг хянах тухай” хуулиар дор дурдсанаар зтогтоосон байна. Үүнд: Компаний дүрмийн сан нь:

1. 50 тэрбум иенээс дээш бол 30 сая иен
2. 10-50 тэрбум иен бол 15 сая иен
3. 10 тэрбум хүртэл иен бол 7 сая 500 иен байхаар тогтоожээ.

Намыг төрөөс санхүүжүүлэх эрх зүйн үндсийг Либерал Ардчилсан Намын 1993 оны санхүүгийн будлиан, дуулиан шуугианы дараа 1995 онд батлагдсан “Намыг төрөөс санхүүжүүлэх тухай” хулиар тодорхойлжээ. Энэ хуулийн гол зорилго нь төрийн татаасыг нэмэгдүүлж, бизнесийн улс төр дэх нөлөөг хязгаарлах, хуулийн цоорхойг нөхөх, улс төрчид рүү чиглэсэн хандив өглөгийн урсгалыг хязгаарлахад чиглэгдсэн учраас маш чухал ач холбогдолтой хууль гэж үздэг. Энэ хуулиар төрөөс улс төрийн намд олгох санхүүжилтийн нөхцлийг дор дурдсанаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Улс төрийн нам парламентад 5-аас доошгүй суудал авсан. байх
2. Парламентын Төлөөлөгчдийн болон Зөвлөхүүдийн танхимын өмнөх сонгуульд 2 хувиас доошгүй сонгогчдын санал авсан байх

Дээрх нөхцлийг хангасан тохиолдолд дор дурдсан шалгуурыг харгалзан санхүүжүүлэх журам тогтоожээ. Үүнд:

1. Төлөөлөгчдийн танхимын сүүлчийн сонгуульд сонгогдсон төлөөлөгчдийн тоо
2. Төлөөлөгчдийн танхимын сүүлчийн сонгуульд хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгогдсон төлөөлөгчдийн тоо
3. Зөвлөхүүдийн танхимын сүүлийн сонгуулиар орон нутгаас сонгогдсон зөвлөхүүдийн тоо
4. Зөвлөхүүдийн танхимын сүүлийн сонгуулиар орон нутгаас сонгогдсон зөвлөхүүдийн тоо
5. Зөвлөхүүдийн танхимын сүүлийн сонгуулиар хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгогдсон зөвлөхүүдийн тоог шалгуур болгон төрийн санхүүжилтийг хуваарилдаг байна.

Улс төрийн намд төрөөс санхүүжилт олгохдоо хүн амын сүүлчийн тооллогын дүнг үндэслэн иргэн бүрт 250 иенээр тооцож, төсөвт суулгаад түүнээс дээр дурдсан нөхцөл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

журмын дагуу намуудыг санхүүжүүлдэг байна. “Улс төрийн санхүүжилтийг хянах тухай”, ““Намын татаасын тухай”” тухай хуулиудаас гадна “Төрийн байгуллагуудын сонгуулийн тухай” хууль нь улс төрийн нам, срнгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн кампаний санхүүжилтийн орлого, зарлагыг хянах, тэдгээрийн хязгаарлалтыг тогтоох эрх зүйн үндэс нь болдог байна.

Сонгуулийн кампаний үеэр нэр дэвшигчдийн сонгуулийн тойрогт зарцуулах зардлын хэмжээг Төлөөлөгчдийн болон Зөвлөхүүдийн танхимын алинд нь нэр дэвшиж байгаагаас хамааруулан ялгаатай тогтоодог. Төлөөлөгчдийн танхимын сонгуульд нэр дэшигчид уг тойрогт бүртгэлтэй сонгогч бүрт 15 иенээр бодож, дээр нь 19 сая 100 иен хүртэл зардлыг нэмж гаргахыг хуулиар зөвшөөрсөн байна. Зөвлөхүүдийн танхимын сонгуульд нэр дэвшигч бүрт 52 сая иений зардал гаргахыг хуульчилжээ.

Санхүүжүүлэх нөхцөл, журам.

Японы сонгуулийн тогтолцооны 1994 оны шинэчлэл нь сонгуулийн үеэрх мөнгөний урсгалыг цэвэршүүлсэн төдийгүй орон нутгийн намын байгууллагын нэр хүндийг нэр хүнд бүхий улс төрчдөөр дамжуулан өсгөж чадсан зэрэг олон талын эерэг зүйлийг авчирсан гэж судлаачид дүгнэсэн байна. Японы сонгуулийн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд улс төрийн санхүүжилтийн хувьд дор дурдсан хоёр шинэчлэлийн асуудлыг шийдэж чадсан гэж үздэг. Үүнд:

- Улс төрийн санхүүжилтийн менежментийн хүрээнд улс төрийн хандивыг улс төрийн нам, эвсэл, дэмжигчдийн холбоодоор дамжуулан авах болсноос гадна тэдгээрийг бэлнээр бус банкин дахь дансаар шилжүүлж авах болсон нь хяналт тавих боломжийг нээж өгсөн.
- Улс төрийн санхүүжилтийг тайлагнах тогтолцоог нарийвчилж, хариуцлагатай болгож чадсан.

Японд улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар тодорхой алхмууд хийгдсээр ирсэн ч бизнес эрхлэгчдээс улс төрчдөд хуулиас гадуур өглөг хандив өргөх явдал гардаг, түүнийг нь намууд мэдсээр байж хүлээн авдаг, энэ нь орон нутаг, бүс нутгийн намын фракцуудын санхүүгийн эх үүсвэр болох нь түгээмэл байсан байна. Энэ талаарх шүүмжлэл, улс төрийн эрэлт шаардлагын дагуу 1995 онд “Намыг төрөөс санхүүжүүлэх тухай” хуулийг батлан мөрдүүлсэн байна.

Намыг төрөөс санхүүжүүлэх хуулийн дагуу олгох татаасыг жилд дөрөв хуваж олгодог байна. Үүнд:

- IYсард жилийн нийт санхүүжилтийн j-ийг олгох;
- YII сард жилийн нийт санхүүжилтийн 1/3 -ийг олгох;
- X сард жилийн нийт санхүүжилтийн S -ийг олгох;
- XII сард үлдсэн хэсгийг нь олгох бөгөөд энэ санхүүжилт банкаар дамжин намуудын дансанд ордог байна. Харин сонгуулийн жилд сонгууль дууссаны дараа шинэ санхүүжилт хэлэхээр зохицуулсан байна.

Санхүүжилтын ил тод байдал, тайлагнах журам.

“Улс төрийн санхүүжилтыг хянах тухай” хуулийн бас нэг зорилго нь улс төрчид, улс төрийн нам, эвслийн орлогыг ил тод, нээлттэй байлгахад чиглэгддэг. Энэ хуулийн дагуу улс төрийн нам, эвслүүд жилд нэг удаа тайлангаа гаргаж, хүлээн авсан хандив, санхүүжилтийн эх үүсвэр, зардлын төрөл тус бүрээр нь олон нийтэд мэдээлэлх үүрэг хүлээдэг байна. Санхүүгийн тайлан гаргах журмыг дор дурдсанаар зохицуулсан байна. Үүнд:

1. Улс төрийн бүх нам, эвсэл санхүүгийн орлого, зарлагын тайлангаа Ерөнхий асуудал эрхэлсэн яамны Сонгуулийн удирдлагын газарт албан ёсоор хүргүүлнэ.
2. Сонгуульд нэр дэвшигч бүр орлого, зарлагын тайлангаа өөрийн дүүргийн Сонгуулийн хороонд гаргаж өгөх үүрэг хүлээдэг.

Улс төрийн нам, эвслийн санхүүгийн тайлангаа мэдээлж байх энэхүү үүрэг нь тэдгээрт хувь хүмүүс, албан байгууллага, компаниуудаас өргөх хандивын эх үүсвэрийг хязгаарлаха хөшүүрэг болдог байна. Улс төрийн намууд, тэдгээрийн бүсийн болон орон нутгийн нэгжүүдэд бизнес эрхэгчид, хандивлагчдаас өргөх хандивыг намуудыг дэмжигч холбоодуудаар дамжуулж өргөхөөр зохицуулсан байгаа нь онцлог юм.

Хандив хүлээн авсан тал хандивын зорулалтаа ил тод мэдээлсэн тохиолдолд 50000 иений татаасыг төрөөс олгохоор зохицуулсныг эс тооцвол улс төрчид хандивын орлогын талаарх мэдүүлгээ ил тод мэдээлэх талын зохицуулалт бүдэг байгааг шүүмжилдэг. Төрөөс санхүүжилт авсан нам мөнгөний зарцуулалтын тайлангаа Төрийн удирдлагын яаманд албан ёсоор гаргаж өгөх бөгөөд олон нийтэд мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх үүрэг хүлээдэг бөгөөд тайланг мэдээлсэн өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд тус яамны цахим хуудсанд байршуулах журамтай.

Мөнгөн хандивын зэрэгцээ, улс төрийн нам, улс төрчдөд унаа хөсөг, жолооч , албан тасалгаа гаргаж өгөх зэрэг бусад үйлчилгээний хэлбэрээр үзүүлдэг дэмжлэг тусламжийг хуулиар хориглоогүй байгааг шүүмжилсээр байгаа юм байна.

Канад

Канадад 2000, 2003 онуудад сонгуулийн хуульд сонгуулийн зардал, сурталчилгааны зохицуулалттай холбоотой шинэчлэл хийгдсэн. Үүгээрээ өмнөх хуулиудын цоорхой, дутагдалтай талуудыг сайжруулан зохицуулсан ба бүртгэлтэй, сонгуульд өрсөлдөгч намуудын санхүүгийн дэмжлэг, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт, гуравдагч этгээдийн сонгуулийн сурталчилгаанд зориулах хөрөнгийн хэмжээ зэргийг зохицуулсан байна.

Сонгуулийн харилцаатай тэр тусмаа түүний санхүүгийн холбогдолтой харилцааг Канадын сонгуулийн тухай хууль \Canada elections act 2000\, Нэвтрүүлгийн тухай хууль \ Broadcasting law 1968\, Холбооны бүртгэлийн тухай хууль \Federal accountability act 2006\ зэрэг эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Улс төрийн намын санхүүжилт, түүний хязгаарлалт

Намын санхүүжилт болон сонгуульд өрсөлдөж буй үеийн зардалтай холбоотой харилцааг дараах актуудаар зохицуулдаг. Үүнд: Канадын сонгуулийн тухай хууль, Холбооны сонгуулийн санхүүжилтын тухай хууль. Хууль тогтоомжийн дагуу дараах байдлаар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна.

- хуульд нийцүүлэн гаргасан намын дүрэм бусад эрх зүйн актуудаар тогтоосон гишүүдийн татвар,
- Хуульд заасан эрх бүхий этгээдээс олгож буй хандив, ивээн тэтгэлэг, бусад төрлийн бэлэглэсэн эд зүйл,
- Улсын нэгдсэн хөрөнгийн сангаас олгож буй татаас зэрэг болно.

Хандивийн эрх зүйн зохицуулалт

Өмнөх эрх зүйн актуудад холбооны сонгуулийн нийт зардлын хязгаартай холбоотой харилцааг зохицуулах зорилготой байсан бол 2003 онд шинэчлэсэн Канадын сонгуулийн

тухай хууль, 2006 онд батлагдсан Холбооны бүртгэлийн тухай хууль зэрэг эрх зүйн актуудаар сонгуулийн хандивын харилцаатай холбоотой нилээд гол түлхүүр асуудлуулыг зохицуулсан байна. Үүнд:

- Зөвхөн албан ёсоор байнга оршин сууж буй Канадын иргэд нь бүртгэгдсэн нам эвсэл, нэр дэвшигчид, дүүргийн сонгуулийн хороодод хандив өгнө.
- Сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигч болон намуудад 1000$ \инфляцитай уялдуулан бодсон\ жилд хандивлах эрхтэй байхаар заасан.
- Мөн хувь хандивлагчид нь 1000$ \инфляцитай уялдуулан бодсон\–оос хэтрүүлэхгүйгээр бүртгэгдсэн нам эвсэл, нэр дэвшигчидэд хэдэн ч удаа хамаагүй хандивлаж болно.
- Корпораци, худалдааны холбоо, бусад хуулийн этгээдүүд нь бүртгэгдсэн нам эвсэл, нэр дэвшигчид, дүүргийн сонгуулийн хороодод ямар нэг хандив өгөх эрхгүй байхаар тус тус зохицуулжээ.

Дээрх зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд улсын ерөнхий прокурор асуудлыг хянан шалгаж түүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эсэх, шүүхэд шилжүүлэх эсэхийг шийдвэрлэж хуульд заасан арга хэмжээг авах эрхтэй байхаар хуульчлан зохицуулжээ.

Улс төрийн нам нь тухайн сонгууль дуусгавар болсны дараа Сонгуулийн хороонд хүсэлт гаргаж сонгуулийн зардлын 50, нэр дэвшигч нь 60 хүртэлх хувийг татаасын хэлбэрээр нэгдсэн хөрөнгийн сангаас буцаан авах боломжтой байдаг. Дараах нөхцлүүдийг хангасан тохиолдолд хүсэлт гаргаж болно. Үүнд:

- Нийт сонгуулийн саналын 2 хувиас дээш санал авсан байх
- Эсвэл тухайн өрсөлдсөн тойргийн 5 хувиас дээш санал авсан байх

Дээрх нөхцлийг хангасан тохиолдолд дор дурдсан шалгуурыг харгалзан санхүүжүүлэх журам тогтоожээ. Үүнд: Канадын сонгуулийн тухай хуулий 429 - 434 дүгээр заалтуудад заасны дагуу дараах шаардлагуудыг хангах ёстой гэж заажээ. Үүнд:

- Зөрчил гаргаагүй
- Уг намын сонгуулиар авсан саналын эрхийн тоо
- Өрсөлдөж буй нэр дэвшигчдийн тоо зэрэг болно.

Канадын сонгуулийн тухай хууль, Холбооны сонгуулийн санхүүжилтын тухай хууль, Холбооны бүртгэлийн тухай хууль, зэрэг хуулиудаар нэр дэвшигчид болон намын сонгуульд зарцуулах нийт зардлын дээд хэмжээг нэр дэвшиж буй тойргийн хүн амын тоонос хамааруулан зохицуулсан байдаг.

- Тухайн өрсөлдөж буй тойргийн нэрсийн жагсаалтад бүртгэлтэй санал өгөх эрх бүхий сонгогчдийн тоог 0.70$-оор үржүүлэн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтооно.

Санхүүжүүлэх нөхцөл, журам

Нэр дэвшигч болон улс төрийн намын сонгуулийн сурталчилгааны санхүүжилтэд олон нийтийн хандивын хөрөнгийг ашиглах боломжтой байдаг. Нэр дэвшигч болон улс төрийн нам нь өмнөх сонгуулийн дүнд үндэслэж улсаас санхүүжилт авдаг байна. 2003 оны сонгуулийн санхүүжилтын тухай хуульд зааснаар нэг санал тус бүр 1,75 канад доллар байхаар зохицуулсан бөгөөд энэ нь санхүүжилтын гол эх үүсвэр болдог. Харин 2012.04.01-ний өдрөөс 2015.04.01 -ний өдөр хүртэл дээрх хэмжээг 1,53 канад доллар болгож бууруулах тухай эрх зүйн акт гарсан байна.

Дээрх санхүүжилтыг авахдаа дараах нөхцөлийг хангасан байх ёстой.

- Нийт сонгуулийн саналын 2 хувиас дээш санал авсан байх
- Эсвэл тухайн өрсөлдсөн тойрогийн 5 хувиас дээш санал авсан байх

Канадын сонгуулийн тухай хуулийн дагуу өмнөх сонгуулиар авсан саналын тоотой уялдуулан дараах байдлаар намуудад татаасыг олгодог байна.

- Эхний жилийн 4 дүгээр сарын 1-нд 0.3825$
- Дараагийн жил 0.255$
- Сүүлийн жил 0.1275$ тус тус нийт авсан сонгуулийн саналтай харьцуулан улсаас олгодог байна.

Санхүүжилтын ил тод байдал, тайлагнах журам.

Канадын сонгуулийн тухай хуульд бусдаас авсан аливаа хандив, мөнгөн хөрөнгө, эд зүйлийг бүгдийг бүртгэж нэгдсэн тайлан гаргаж өгөх мөн нийт сонгуулийн явцад гарсан санхүүжилт болон мөнгөн гүйлгээтэй холбоотой бүхий л үйл ажиллагааны нэгдсэн тайлан гаргаж өгөхөөр хуульчилсан нь сонгуулийн санхүүжилт тэдгээрийн ил тод байдлыг хангахад чиглэгдсэн байдаг.

Сонгуулийн хандивийн хувьд 200 канад доллароос дээш хэмжээтэй тохиолдолд баримт үйлдэж нэгдсэн тайланд хавсаргахыг шаарддаг байна. Канадын сонгуулийн тухай хуульд зааснаар санхүүгийн ажилтан нь санхүүгийн үе шат бүрд сонгуулийн удирдах газарт дараах ажил гүйлгээтэй холбоотой тайланг гаргаж өгнө гэж заажээ. Үүнд:

- Тухайн үед гарсан мөнгөн гүйлгээ
- Хандивийн нэгдсэн тайлан
- Хандивлагчидийн тоо
- Хандивийн журмаар орж ирсэн хөрөнгө тэдгээрийн үнэлгээ
- Өр зээл

Санхүүгийн ажилтан нь сонгууль дууссанаас 5 сарын дотор энэ тайланг гаргаж өгөх ёстой ба үүнийг бие даасан аудиторын дүгнэлттэй цуг хавсаргаж өгөх ёстой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх сурталчилгааны зохицуулалт

Нэр дэвшигчийг дэмжин сурталчлах ажлын уулзалт, хурал, цуглаан хийх, сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэл хийх зэрэг болно. Нэвтрүүлгийн тухай хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр явуулах сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгүүдийн асуудлыг зохицуулдаг. Ингэхдээ хэд хэдэн үндсэн зарчмын дагуу үйл ажиллагаа нь явагдах ёстой. Үүнд эрх тэгш байх буюу бүх нэр дэвшигчтэй адил тэгш хандаж бүх нэр дэвшигчидэд сурталчилгаагаа хийлгэх тэгш боломжоор хангах, аль нэг нэр дэвшигчийн талд үйлчлэх нь хориотой байх ёстой.

Мэдээллийн хэрэгсэл нь 6.5 цагийг сонгуулийн сурталчилгаа хийлгэхээр бэлтгэх ёстой ба энэ нь бүх нэр дэвшигчидэд хамаарна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хийх сурталчилгаа нь үндсэн 4 хэсэгт хуваагддаг. Үүнд:

- Төлбөртэй мэдээллийн цаг - Нэр дэвшигчийн тухайн хэвлэл мэдээллийн байгууллагаас гэрээний дагуу худалдаж авсан цаг. Худалдаж авч болох цагийн дээд хэмжээ нь 39 минут байна.
- Төлбөргүй мэдээллийн цаг - Нам эсхүл нэр дэвшигчэд үнэгүй олгож буй сурталчилгааны хугацаа

- Мэдээний хугацаа - Тухайн нэр дэвшигч эсхүл улс төрийн намын талаарх дүгнэлт, танилцуулгуудыг ихэвчлэн тухайн байгууллага өөрөө мэдээг голчлон бэлтгэдэг.
- Олон нийтийн арга хэмжээ-Нэр дэвшигчдийн нээлттэй хэлэлцүүлэг, мэтгэлцээн, олон нийтийн санал бодлыг тандах зорилготой шууд санал хураалт зэрэг.

Их Британи

1883 оноос эхлэн Их Британи нь сонгуульд нэр дэвшигчдийн зардал болоод мөнгөн урсгалд хууль эрх зүйн хүрээнд хяналт тавьж эхэлсэн байна. Их Британий сонгуулийн санхүүжилтийн зохицуулалтын гол зарчим нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн зардлыг хязгаарлах, хуулийн дагуу орж ирж буй хандив тусламжыг хязгаарлахад оршдог байна.

1883 онд батлагдсан Авилга болон хууль бус үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх \Corrupt and Illegal Practices Prevention Act 1883\ тухай хуулиар анхлан сонгуулийн санхүүжилтын харилцааг зохицуулж байсан ба одоо Ард түмний төлөөллийн тухай акт \Representation of the People Act 1983 (RPA)\, Улс төрийн намын сонгууль болон референдумын тухай акт\ Political Parties Elections and Referendums Act 2000 (PPERA)\ зэрэг эрх зүйн актуудаар зохицуулж байна. Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн зардлыг дотор нь 3 төрөлд ангилж авч үзсэн байна. Үүнд

- Сонгуулийн сурталчилгааны зардал,
- Удирдлагийн зардал
- Бусад зардал.

Улс төрийн намын санхүүжилт, түүний хязгаарлалт

Сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээг хуулиар тогтоосон байдаг. Сонгуулийн зардалтай холбоотой орсон, гарсан бүх мөнгөн урсгалыг бүртгэж мэдэгдэх ёстой ба сонгуулийн хандив тусламжыг мөн давхар мэдэгдэж мэдэгдэл бичиж сонгуулийн хороонд хүргүүлэх ёстой. Хуулийн дагуу сонгуулийн сурталчилгааны зардалд дараах зардлуудыг оруулахаар заасан байна: Сонгуулийн мэдээ, зар сурталчилгаа, сонгогчидод тарааж буй ухуулах материал, намын болон нэр дэвшигчийн бодлогийн талаархи бичиг баримт, тунхаглалууд, сонгуультай холбоотой зах зээлийн судалгаа тэдгээрийн санхүүгийн зураглалууд зэрэгтэй холбоотой гарсан зардлууд ордог байна.

Улс төрийн намын сонгууль болон референдумын тухай хуульд улс төрийн намуудын санхүүжилтыг бүрдүүлэх арга хэлбэрийг зохицуулахаас илүүтэйгээр сонгуулийн хандив тусламжын ил тод байдлыг хангахад чиглэсэн байна. Хуульд зааснаар намууд дараахь санхүүжилтийг ашиглаж болно.

- Намын гишүүдээс авч буй татвар
- Хандив тусламжаар орж ирж буй орлого

Хуулийн дагуу нэр дэвшигчидийн авах хандивт дээд хязгаар байхгүй ба хуулийн зорилт нь дээр хэлсэнчлэн хандивын ил тод байдлыг хангахад чиглэдэг ба 500J-аас дээш хэмжээний хандивыг хуульд заасан хандивлах эрх бүхий этгээдээс авна гэж заажээ. Хуульд зааснаар сонгуульд оролцох эрх бүхий сонгогч, Компаний тухай хуульд\Companies act 2006\ заасны дагуу бүртгэгдсэн компани, бүртгэгдсэн нам, барилгын нийгэмлэг, худалдааны нийгэмлэг зэрэг байна гэж зааж өгжээ. 5000J дээш хэмжээний мөнгөн тусламж, ивээн тэтгэлэг, эд барааны тусламж хандивийг авсан нам эвсэл, 1000J дээш хэмжээний тусламжыг авсан нэр дэвшигч нь сонгуулийн хороонд 7 хоногийн дотор мэдэгдэх ёстой.

Санхүүжүүлэх нөхцөл, журам.

Жил бүр 2 сая фунт стерлинг /J/ -ийг намуудад нэгдсэн хөрөнгийн сангаас үйл ажилла-гаандаа зарцуулахаар парламентад суудал авсан байдлаас хамааруулан Short Money аргаар олгодог байна.

Улс төрийн намууд, сонгуулийн референдумын тухай хуулийн 12 -р хэсэгт зааснаар мөрийн хөтөлбөр болон бодлого тэдгээрийн шинэчлэл, өөрчлөн сайжруулалт тэдгээрийг хэрэгжүүлэхэд зориулж ашиглаж болохоор заажээ. Энэ санхүүжилтыг авахийн тулд багаар бодоход парламентын Доод танхимд 1 суудал авсан байх ёстой. Мөн богино хөрөнгө\ Short Money\ буюу намуудын үйл ажиллагааны зардалд зориулан өмнөх сонгуулийн дүнтэй хамааралтайгаар олгодог. Энэ нь намууд нэг суудал бүрт 14,351J мөн авсан 200 санал бүрт нэмэгдэх 28.66J -ийг тус тус санхүүжилт болгон авдаг байна.

Санхүүжилтын ил тод байдал, тайлагнах журам.

Ард түмний төлөөллийн т ухай хуулийн дагуу сонгуульд өрсөлдсөн бүртгэлтэй нам эвсэл, нэр дэвшигчид нь сонгуультай холбоотой гарсан бүх зардал, сонгуулийн хандив тусламж зэрэг бүхий л орсон гарсан орлого, зарагыг нэгтгэсэн тайланг сонгуулийн удирдах газарт гаргаж өгөх ёстой байдаг байна. Үүнийг сонгууль дууссанаас хойш 3 сарын дотор гүйцэтгэх ба уг тайланд мөнгөөр үнэлэгдэхгүй эд зүйлсийг мөн хамааруулах бөгөөд энэ нь 250,000J хүртэлх мөнгөн дүнд багтсан байна. Харин 250,000J дээших хэмжээний нийт мөнгөн дүн бүхий тайлангийн хувьд сонгууль дууссанаас 6 сарын дотор гаргаж өгөх ба бие даасан аудитрын гаргасан дүгнэлтийг хавсаргаж өгөх ёстой.

Сонгуулийн сурталчилгааны эрх зүйн зохицуулалт

Сурталчилгааны зардлын эрх зүйн зохицуулалт

Намын зардлын хязгаарлалт нь Улс төрийн намын сонгууль болон референдумын тухай хуульд заасны дагуу өрсөлдөж буй тойргийн тоо хэмжээнээс шалтгаалж хязгаарыг тогтоодог байна.

- Сонгуулийн нэг тойрог тутам 30,000J-ийн зарцуулах эрхтэй,
- 540,000J-ийг намын сонгуульд ашиглах хөрөнгийн дээд хэмжээ гэж заажээ.

Сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээ нь намуудад нэр дэвшигчдтэй харьцуулвал илүү их боломжыг олгосон буюу харьцангуй өндөр тогтоож өгсөн байна.

Төлбөргүй хийгдэх сонгуулийн сурталчилгааны төрөл

Их Британий хувьд нэр дэвшигчдийг зурагт, радио буюу хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр төлбөртэй мэдээлэл цацахыг хориглосон байдаг ба сонгуулийн сурталчилгаагаа үнэ төлбөргүй хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цацах эрхийг олгосон байдаг. Сурталчилгааны хэмжээ, давталт, хувиарлалт зэргийг Ofcom \Office Communication\ буюу Мэдээ харилцаа холбооны газар шийдвэрлэдэг. Ингэхдээ ихэнхи том намууд нь шууд мэдээний цагийг хүлээн авдаг ба бусад бүртгэлтэй намууд нь Ofcom-ийн журмын дагуу зохицуулагддаг.

British Broadcasting Corporation буюу Британий Нэвтрүүлгийн Корпораци нь бие даасан дээрхи байгууллагаас хараат бус ажилладаг боловч улс төрийн холбоотой сурталчилгаа хийх асуудлаар Мэдээ харилцаа холбооны газраас гаргасан дүрмийн дагуу ажилладаг байна. Мөн түүнчлэн нэр дэвшигчэд нь улсын төсвөөс санхүүждэг, улсын өмчийн газрууд буюу сургууль олон нийттэй харилцах боломж бүхий газруудыг үнэ төлбөргүйгээр сонгуулийн сурталчилгааны зорилгоор ашиглах боломжтой байхаар хуульд зааж өгсөн байна.

Эх сурвалж:

- “Улс төрийн санжүүжилт ба намын хөгжлийн хандлага” судалгааны тайлан
- http://www.loc.gov/law/help/campaign-finance/uk.php
- http://www.electoralcommission.org.uk/guidance/resources-for-those-we-regulate/campaigners-in-referendums
- http://www.electoralcommission.org.uk/guidance/resources-for-those-we-regulate/candidates-and-agents
- http://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/section/50
- http://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/section/37
- http://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/section/125
- http://www.legislation.gov.uk/ukpga/2006/22/section/30
- http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/E-2.01/page-90.html#docCont
- http://www.elections.ca/content.aspx?section=res&dir=loi/fel/cea&document=index&lang=e
- http://www.crtc.gc.ca/eng/archive/2011/2011-218.htm
- http://en.wikipedia.org/wiki/Campaign_finance
- http://www.mapleleafweb.com/features/federal-campaign-finance-laws-canada
- www.lexadin.nl

”ЧИНГИС ХААН” НЭР, “ЧИНГИС ХААНЫ ХӨРӨГ”-ИЙГ ГАДААД УЛСАД ХЭРЭГЛЭХ, АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

П. Амаржаргал

Улсын Их Хурлын гишүүн Д. Ганбатын № 9/793 тоот албан бичгийн дагуу “Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг” -ийг гадаад улсад хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал, Олон улсын гэрээ, конвенцийн эрх зүйн зохицуулалт” сэдвээр референт - шинжээч П.Амаржаргал уг судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгаанд Монгол Улсын нэгдэн орсон дараах олон улсын гэрээ, конвенц, протокол, хэлэлцээрийг хамруулан авч үзэв. Үүнд:

- “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр” 1891 онд гарын үсэг зурж, Монгол улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан (Madrid Agreement Concerning the International Registration of Marks.)
- “Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол” 1989 онд гарын үсэг зурж, Монгол улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан (Protocol Relating to the Madrid Agreement Concerning the International Registration of Marks.)
- “Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц” 1967 онд гарын үсэг зурж, Монгол улс 1978 оны 10 дугаар сарын 10 ны өдөр соёрхон баталсан (Convention Establishing the World Intellectual Property Organization)
- “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц” 1970 онд хүчин төгөлдөр болж, Монгол улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан (Paris Convention for the Protection of Industrial Property.)

Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай “Мадридын хэлэлцээр” -ийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хэлэлцэн тохирогч орнуудын харьяатууд гарлын орны холбогдох байгууллагаар дамжуулан гарлын оронд бүртгүүлсэн бараа, үйлчилгээний тэмдгийн талаар Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенцид дурдсан Оюуны өмчийн олон улсын товчоонд мэдүүлэг өгөх замаар дээрх барааны буюу үйлчилгээний тэмдгийг энэхүү хэлэлцээрт оролцогч бусад бүх оронд хамгаалуулж болно” гэж заажээ.

Уг Мадридын хэлэлцээрт Барааны тэмдгийн олон улсын бүртгэл эрхэлсэн тусгай хороо байгуулах, барааны тэмдгийг бүртгэх, гарлын орныг тодорхойлох, олон улсын бүртгэлийн мэдүүлгийн бүрдэл, олон улсын бүртгэлийн үйлчлэл, барааны тэмдгийн бүрдэл хэсгийн хууль ёсны ашиглалтыг нотлох баримт, олон улсын бүртгэлийн хүчинтэй хугацаа болон хугацааг сунгах, гарлын оронд эрхийн хамгаалалт дуусгавар болох, хураамж зэрэг шаардлага, эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна.

“Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц”-ийн 2 дугаар зүйлд “оюуны өмч” гэж...бүтээгдэхүүний загвар, бараа болон үйлчилгээний тэмдэг...орно гэж заажээ. Үүнээс үзэхэд, “Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг” нь барааны тэмдэг болж орохоор байна.

“Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр”-ийн протоколд заасны дагуу барааны тэмдгийг бүртгүүлэхэд холбооны гишүүнчлэл, олон улсын мэдүүлэг, бүртгэл, нотлох баримт, бүртгэлийн хугацаа, хураамж зэрэг шалгууруудтавигдаж байна.

“Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц”- ийн 6 дугаар зүйлд заасан “Тэмдэг: Бүртгэх нөхцөл; өөр өөр оронд нэг тэмдгийн хамгааллын, үл хамгааллын, үл

хамаарал” гэсэн заалт, хэсгүүд уг асуудалд хамаарахаар байна. Жишээ нь , уг конвенцийн 6 дугаар зүйлийн 1 (а) дахь хэсэгт заасан “Холбооны гишүүн бусад орны төрийн бэлгэ тэмдэг, далбаа, сүлд, тэдгээр улсын баталгаажуулж, хяналтын тэмдэглэл, тусгай тэмдэг тавих, түүнчлэн сүлдний үүсэл, дүрслэлийн талаас авч үзэхэд дууриалгасан тэмдгийг барааны тэмдгээр буюу түүний ямар нэгэн бүрдэл хэсгээр эрх бүхий засаглалын зөвшөөрөлгүй ашиглаж байгааг зохих арга хэмжээ авах замаар хориглох, бүртгэлийг хүчингүй болгох, бүртгэхээс татгалзах талаар холбооны гишүүн орнууд харилцан тохиролцоно” гэж заажээ.

Эндээс дүгнэж үзэхэд “Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг”-ийг “төрийн бэлэг тэмдэг”-ийн түвшинд хуульчлан баталгаажуулсан /жишээ нь: Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг, ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийн илэрхийлэл болгон “Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг”-ийг албан ёсоор баталгаажуулан Монгол Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах/ тохиолдолд гадаад улсад хэрэглэх, ашиглахтай холбоотой олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Оюуны өмчийн олон улсын товчооны шаардлагыг хангасан нөхцөлд бүртгүүлэх, хамгаалагдах нь дээр заасан “Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийн” 6 дугаар зүйлд заасан боломж үүснэ.

Өөрөөр хэлбэл, эхэлж “Чингис хаан” нэр, хөргийг Монгол улсад аль нэгэн байдлаар төрийн бэлэг тэмдэгийн түвшинд хуульчлан баталгаажуулсаны дараагаар олон улсын гэрээ, конвенцийн дээр дурьдсан зүйл заалтыг баримталж бүртгүүлэх тохиолдолд гишүүн орнуудын дэмжлэг авах, бүртгүүлэн хамгаалагдах илүү боломж үүсэх магадлалтай юм. Мөн судалгааны явцад “Чингис хаан” нэр, “Чингис хааны хөрөг”-ийн тухай Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Оюуны өмчийн олон улсын товчоонд бүртгүүлэх явцад дараах зүйлийг харгалзан үзэх, давхардал бий болохыг үгүйсгэхгүй. Үүнд:

1. Chinggis Khaan
2. Chingis Khan
3. Genghis Khan
4. Chinghis Khaan
5. Chingiz Khan

(“Чингис хаан” нэрний хувьд англи хэлээр дэлхийн улс орнууд харилцан адилгүй үсэг, дуудлагаар бичиж байна. Үүнд хамгийн түгээмэл хэрэглэгдэх таван хэлбэрийг дараалуулан бичлээ)

“Чингис хааны хөрөг”-ийн тухайд хамгийн өргөн хэрэглэгддэг, Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн дэвсгэртэнд байгаа хөрөг, мөн Тайваны Үндэсний музейд хадгалагдаж байгаа хөрөг зургийг харьцуулан анхаарч үзэх, давхардлыг арилгах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Чингис хааны хөрөг”-ийн сүүлийн хувилбарыг албан ёсоор баталгаажуулж Оюуны өмчийн олон улсын товчоонд бүртгүүлэх нь зүйтэй болов уу.

* * *

Хавсралт.

Оюуны өмчийн эрх зүйтэй холбоотой Монгол улсын соёрхон баталсан Олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр, протоколын нэр, он

№	Олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр, протоколын нэр	Гарын үсэг зурсан он	Монгол улс соёрхон баталсан огноо	Эх сурвалж	Албан ёсны хэл.
1.	Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр	1891 онд гарын үсэг	Монгол улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан	http://www.wipo.int/madrid/en/legal_texts/trtdocs_wo015.html Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. III боть (2006)	Madrid Agreement Concerning the International Registration of Marks. April 14, 1891, as revised
2.	Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол	1989 онд гарын үсэг	Монгол улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр соёрхон баталсан	http://www.wipo.int/madrid/en/legal_texts/trtdocs_wo016.html Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. III боть (2006)	Protocol Relating to the Madrid Agreement Concerning the International Registration of Marks. Adopted at Madrid. On June 27, 1989
3.	Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц	1967 онд гарын үсэг	Монгол улс 1978 оны 10 дугаар сарын 10 ны өдөр соёрхон баталсан	http://www.wipo.int/treaties/en/convention/trtdocs_wo029.html Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. III боть (2006)	Convention Establishing the World Intellectual Property Organization. Signed at Stockholm. On July 14, 1967
4.	Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц	1883 онд гарын үсэг	Монгол улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан	http://www.wipo.int/treaties/en/ip/paris/trtdocs_wo020.html Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. III боть (2006)	Paris Convention for the Protection of Industrial Property. Of March 20, 1883

* * *

Ашигласан материал:

Монгол хэл дээр:

1. Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. III боть (2006)
2. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр (1891)
3. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц (1967)
4. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протокол (1989)
5. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц (1970)
6. Патентын тухай хууль. Төрийн мэдээлэл. № 7 (2006)
7. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль. Төрийн мэдээлэл. № 7 (2006)
8. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль. Төрийн мэдээлэл. № 26 (2010)
9. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль. Төрийн мэдээлэл. № 6 (1994)
10. http://www.ipom.gov.mn Оюуны өмчийн газар
11. Хуулийн нэр томъёоны дагалга. ХЗҮТ (2004)

Англи хэл дээр:

1. Madrid Agreement Concerning the International Registration of Marks. of April 14, 1891, as revised http://www.wipo.int/madrid/en/legal_texts/trtdocs_wo015.html
2. Protocol Relating to the Madrid Agreement Concerning the International Registration of Marks.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Adopted at Madrid on June 27, 1989 http://www.wipo.int/madrid/en/legal_texts/trtdocs_wo016.html

3. Paris Convention for the Protection of Industrial Property. of March 20, 1883, http://www.wipo.int/treaties/en/ip/paris/trtdocs_wo020.html
4. Convention Establishing the World Intellectual Property Organization. Signed at Stockholm on July 14, 1967, http://www.wipo.int/treaties/en/convention/trtdocs_wo029.html
5. http://www.wipo.int/portal/index.html.en World Intellectual Property Organization
6. http://www.wipo.int/tools/en/gsearch.html?cx=000395567151317721298%3Aaqrs59qtjb0&cof=FORID%3A11&q=chinggis+khaan
7. http://en.wikipedia.org/wiki/Genghis_Khan

5
БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ПАРЛАМЕНТ СУДЛАЛЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“ТӨРИЙН АЛБАНЫ ТОГТОЛЦОО, ШИНЭТГЭЛИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ”

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн, Ө. Мөнхтунгалаг, Ц. Болормаа, Б. Нарантуяа

Агуулга

Оршил
Судалгааны ажлын зорилго, тойм

1. Төрийн албаны шинэчлэлийн загвар
   - Төрийн иргэний албаны “хаалттай” загвар
   - Төрийн иргэний албаны “нээлттэй” загвар
2. Гадаадын зарим орнуудын төрийн албаны тогтолцоо,
3. Эрх зүйн орчин, шинэтгэл
   Бүгд Найрамдах Унгар Улс
   - БНУУ-ын төрийн албаны тогтолцоо, бүтэц
   - Төрийн албаны менежментийн загвар
   - Төрийн албаны эрх зүйн орчин
   - Төрийн албаны шинэчлэлийн туршлага, хэрэгжилт, үр дүн, нутгийн удирдлага

   Бүгд Найрамдах Латви Улс
   - Төрийн албаны бүтэц
   - Төрийн албаны эрх зүйн орчин
   - Төрийн албаны шинэчлэлийн туршлага, хэрэгжилт, үр дүн, нутгийн удирдлага

   Тайланд Улс
   - Төрийн албаны бүтэц, тогтолцоо, эрх зүйн орчин
   - Төрийн албаны менежмент
   - Төрийн албаны шинэтгэл, туршлага, хэрэгжилт, үр дүн

   Ботсван Улс
   - Төрийн албаны бүтэц
   - Нутгийн өөрийн удирдлага
4. Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, эрх зүйн орчин, шинэтгэл /нөхцөл байдлын шинжилгээ/
   - Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, бүтцийн схем
   - Монгол Улсын төрийн албаны эрх зүйн орчин
   - Монгол Улсын төрийн албаны шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн
5. Төрийн албаны шинэчлэлийн өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох нь
6. Төрийн албаны шинэчлэлийн талаарх бодлогын хувилбарууд, эерэг, сөрөг талууд
7. Эх сурвалж

* * *

Оршил

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А. Бакейгийн 2012 оны 8 дугаар сарын 28 -ны өдрийн 1077 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу “Төрийн албаны шинэчлэл” харьцуулсан судалгааны ажлыг Судалгааны төвийн судлаачдын баг хийж гүйцэтгэв. Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу дор дурдсан улс орнуудыг хамруулав. Үүнд:

- Ази тивээс Тайландын Вант Улс - Ө. Мөнхтунгалаг
- Европ тивээс Унгар улс, Латви улс - Б.Нарантуяа
- Африк тивээс Ботсван Улс - Ц.Товуусүрэн
- Монгол Улс – Ц. Болормаа

Судалгааны зорилго

Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, бүтцийн схемийг гадаадын зарим орнуудынхтай харьцуулж, төрийн албаны шинэтгэлийн бодлого, хууль, эрх зүйн орчны ижил төсөөтэй болон ялгаатай байдлын талаар дүн шинжилгээ хийж тулгамдсан асуудлыг тодруулах, цаашид төрийн албаны шинэтгэлийг оновчтой явуулах бодлогын хувилбаруудын эерэг сөрөг талыг гаргаж тавин хууль тогтоогчдод сонголт хийх боломж олгох зорилго тавин ажиллав.

Судалгааны ажлын тойм

Төрийн албаны тогтолцооны хувьд судалгаанд хамрагдсан улс орнуудаас гадна хөгжингүй орнуудад төрийн албаны бие даасан тогтолцоотой байгаа бөгөөд энэ нь манайх шиг харьцангуй хараат бус ажилладаг бол Тайланд зэрэг зарим улсад Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд зарим холбооны улсуудад холбооны канцлерийн, Европын холбооны гишүүн зарим улсуудад Дотоод хэргийн сайд, сангийн сайд, хүний нөөцийн асуудал хариуцсан сайд, төрийн захиргааны шинэтгэлийн асуудал хариуцсан сайдын эрхлэх хүрээнд багтдаг байна. Төрийн албаны төв болон яам агентлагийн салбар алба ажиладгаас гадна мужийн болон орон нутгийн нэгжийн түвшний төрийн албаны нэгж/ажилтан/-тэй байна.

Төрийн албаны бүтэц нь судалгаанд хамрагдсан орнуудын хүрээнд ажиглахад төрийн хүний цөөцийн удирдлага, боловсон хүчний асуудал, нөхөн олговор, хөнгөлөлт, тэтгэмжийн асуудал, төрийн үйлчилгээний асуудал, төрийн албаны хөгжил, сургалтын асуудал хариуцсан нэгжүүдтэй байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хүрээнд Төрийн иргэний албан хаагчдын эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Засгийн газрын бүтцийн тухай, Авилгатай тэмцэх тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиуд болон бусад хууль, хууль тогтоомжийн актууд, бодлогын баримт бичгүүд нь төрийн албаны эрх зүйн орчныг бүрдүүлдэг жишиг нийтлэг байна.

Төрийн албаны шинэчлэл нь 1980-1990 -ээд онуудад төр засгийн үүргийг хамгийн бага байлгах гэсэн неолиберал хандлагатай байсан бол сүүлийн жилүүдэд төрийн байгууллагуудыг ардчилсан, шударга ажиллагаатай, төрийн эх үүсвэрүүдийг үр ашигтай зарцуулдаг, иргэдэд үйлчилгээг үр нөлөөтэй хүргэдэг байхын зэрэгцээ дэлхий нийтийн нөлөөллийн хүчийг сөрөн зогсох чадвартай, хүчирхэг байлгахыг эрмэлзэх болжээ. Төрийн албаны шинэчлэлийг судалгаанд хамрагдсан улс орнуудын тухайд хэрхэн хэрэгжүүлж байгааг ажиглах аваас төрийн албаны нээлттэй буюу англо-саксоны загвар хаалттай руугаа ойртох, хаалттай буюу эх газрын европын орнуудын загвар нээлттэй руугаа ойртох чиг хандлага давамгайлж байна.

ШУТИС
СУДАЛГААНЫ

“Хөгжингүй орнуудын клуб” буюу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/ ЭЗХАХБ/ -ын гишүүн орнуудад хийсэн захиргааны шинэтгэлийг гурван үе шатанд авч үзэж байна. Үүнд:

I шат. Дэлхийн II дайны дараа үеэс 1970 -аад оны эхэн үе хүртэл Засгийн газрууд хэт томорч, зардал нь үлэмж өсөж, эдийн засаг дахь оролцоо нь хэт ихэсч, харин иргэд хангалттай үйлчилгээ авч чадахгүй болсон нь шүүмжлэл дагуулах болсон тул 1970-аад оны дунд үеэс 1980-аад оны сүүлч хүртэл төрийн албаны шинэтгэлийн эхний үе шат болох захиргааны өөрчлөлтүүдийг хийхдээ төсвийн алдагдлыг багасгах, орон тоог цомотгох, өмч хувьчлахад чиглэгдэж байв. Австрали, Их Британи, Шинэ Зеландад энэ шатны шинэчлэлийг эхлүүлсэн байна.

II шат. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэнд ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын төсвийн алдагдал мэдэгдэхүйц буурч, улмаар Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд, төрийн зохицуулалтыг уян хатан болгох, орон нутагт эрх мэдэл шилжүүлэх замаар иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх алхмуудыг хийсэн байна.

Их Британи, АНУ, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнуудад 1980 -аад оноос улсын салбарт хувийн хэвшлийн менежментийн зарчмуудыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн шинэтгэл хийж, түүнийгээ Төрийн шинэ менежмент гэж нэрлэжээ. Энэ хүрээнд төрийн албыг илүү уян хатан, үр ашигтай болгох, төрийн албанд өрсөлдөөний зарчим, гүйцэтгэлийн менежментийг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, түүнд нь тохирсон цалин, урамшуулал олгох, удирдлагын төвлөрсөн хяналтыг агентлагуудад шилжүүлэх, төрийн хэвшлийн аж ахуйн үйл ажиллагаанд гэрээний хэлбэрийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх зэрэг шинэтгэлийн хэлбэрүүдийг санал болгосон байна.

Энэхүү Төрийн шинэ менежменийн үр дүнд төрийн албан хаагчдын чадвхи дээшилсэн боловч төрийн томилгоот албан тушаалтнуудын өмнө төрийн захиргааны албадын хүлээх хариуцлагыг хэт чухалчилснаар төрийн албыг улс төржүүлэх, нийтийн өмнө хүлээх хариуцлагыг нь сулруулж, төрийн албаны ёс зүйг бэхжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлсэн байна гэж зарим эх сурвалжууд/The impact of new public management on the Auctralian Public Service/ -ад тэмдэглэсэн байна.

III шат. 1990-ээд оны сүүлчээс төрийн захиргаанд урьд нь хийсэн шинэтгэлүүдийн сөрөг үр дагаврыг арилгах, олсон амжилтыг бататгах, төрийн албаны ёс зүйг сайжруулах шатандаа ороод байна.

Дээр дурдсан шинэтгэлүүд нь тухайн орны түүхэн нөхцөл байдал, соёлын түвшингээс хамааран өөр өөрийн загвар, хурд, амжилтанд нөлөөлсөн хүчин зүйлүүдтэй байна. Тухайлбал Шинэ Зеландад илүү хурдтай радикал замыг сонгосон бол, зарим улсуудад илүү урт хугацааны асуудлыг шийдвэрлэх алгуур замыг сонгосон байна.

Дэлхийн банкны ерөнхий эдийн засагчаар ажиллаж байсан Аллен Шик “ Шинэ Зеландын шинэтгэлийг хөгжиж буй ихэнх улс орон яагаад тушиж болохгүй вэ” гэсэн нийтлэлдээ “Монгол зэрэг цөөн улсад энэхүү загварын зарим элементийг авч хэрэгжүүлэх ажил эхний шатандаа явж байна. Гэхдээ үндсэн номлол, зарчмыг хүлээн аваад хэр зэрэг хол явах талаар үнэлгээ өгөхөд эрт байна. Бүхэлдээ энэ өөрчлөлт тэдний хэрээс давсан, эсвэл өнөөгийн хэрэгцээнд тохирохгүй байгаа учраас аж үйлдвэржсэн болон хөгжиж буй орнууд хийгээгүй байна” хэмээсэн нь анхаарч үзэх асуудал юм.

Төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дор дурдсан нийтлэг сургамжийг үлдээсэн гэж экспертүүд үзэж байна. Үүнд:

- Хувь хүний ажлын үр дүнг үнэлэх, урамшуулах нь үзэл баримтлалын хувьд ойлгомжтой, хялбархан мэт боловч, практикт хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болохыг олон орны туршлага харуулжээ. Төрийн албан хаагчдыг ажлын үр дүнтэй эь холбон урамшуулах систем нэвтрүүлэх оролдлого бүтэлгүй болсон учраас байгууллагаар нь, багаар нь урамшуулах журам тогтсон байна.

Ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зэрэг хувийн хэвшлийн практикийг төрийн байгууллагуудад хэрэглэх тохиолдолд төрийн албаны ёс зүйг бэхжүүлэх асуудлыг онцгойлон анхаарахгүй бол авилга, хээл хахууль өсөх боломжийг бүрдүүлдэг байна. Төрийн албан хаагчид бага зүйлээр ихийг хийх, үүний зэрэгцээгээр албан тушаал нь баталгаагүй болох, байнгын халаа сэлгээнээс залхаж, урам зориг нь буурах хандлагатай болсон байна.

Нэг. Төрийн албаны шинэчлэлийн загвар

Гадаадын улс орнуудад хэрэгжүүлсэн Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийн үзэл баримтлалаас чухам аль нь тухайн улсын онцлогт илүү тохирох, илүү нутагших, төрийн албаны бүтээмжийг илүү дээшлүүлж чадах вэ гэдгийг нэн тэргүүнд анхаарах ёстой гэж судлаачид үздэг болжээ.

Гадаадын улс орнуудын төрийн албаны өөрчлөлтийн давалгаа 1990 онд эхэлсэн бөгөөд хөгжиж байгаа орнуудад илүү эрчтэй явагдсан байна. Тэдгээр улс орнуудад төрийн албаны өөрчлөлтийг хэрэгжүүлэхдээ хөгжингүй орнуудын загварыг өөрийн орны онцлогт тохируулан буулгах аргыг түлхүү баримталжээ. Манай улсад мөн адил Шинэ Зеландынхыг загвар болгосон билээ.

Шинжээчдийн үзэж байгаагаар төрийн албаны шинэчлэл хийсэн ихэнх орнуудад дараах асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн албаны шинэчлэлээ чиглүүлдэг байна. Үүнд:

1. Төрийн иргэний албаны системд улс төрийн томилгоог нам бус мэргэжлийн бюрократтай зөв хослуулах, тэнцвэржүүлэхийг хичээх
2. Төрийн албаны тогтвортой болоод эрч хүчтэй байдлын тэнцлийг хангах
3. Төрийн иргэний албаны нээлттэй ардчилсан байх, олон нийт, иргэний хэрэгцээнд нийцсэн эелдэг хөнгөн шуурхай байдлыг хүчтэй болгох
4. Төрийн иргэний албаны менежментыг сайжруулах, төрийн албаны системд зах зээлийн зарчмыг нэвтрүүлэх/Их Британи, Нидерланд, Итали, Шинэ Зеланд г.м./, төрийн зарим чиг үүрэг, төрд үйлчилгээ үзүүлэх ажлыг шалгаруулалтын үндсэн дээр Засгийн газартай гэрээ байгуулан гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн бус бүтцийг буй болгох
5. Төрийн албанд элсэн орох, албан тушаалд дэвшүүлэх шалгаруулалтын хүрээг өргөтгөх
6. Төрийн иргэний албан тушаалтны орон тоог цомотгох, хөнгөлөлт давуу байдал, цалин хөлсийг өсгөхийг хязгаарлах, ажлын үр дүнгээс хамаарсан цалин хөлсний өсөлтийн илүү боловсронгуй хуваарийг нэвтрүүлэх/Их Британи, Нилерланд, БНСУ, АНУ/

Төрийн албаны өөрчлөн байгуулалт/реформ/ тодорхой хэмжээнд амжилттай байгаа ч шилжилтийн үед байгаа орнууд/бүр илүү өндөр хөгжилтэй Бразил, БНСУ-д ч/-аас нэгд нь ч төгс амжилттай болж чадаагүй гэж шинжээчид дүгнэжээ. Олонх экспертүүд Их Британий төрийн албаны шинэчлэлд сөрөг үнэлгээ өгч байна. Энд төрийн албаны нэгдмэл тогтолцоо алдарч, төрийн албанд татагдах сонирхол буурсан байна.

Шинжээчид төрийн албаны шинэчлэл нь тухайн улсын хөгжлийн жинхэнэ бодит өнөөгийн түвшингээс түрүүлж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Өнөөгийн байдлаар шинжлэх

ухааны хүрээнд, хуульчид, эрдэмтдийн дунд төрийн иргэний албаны 2 үндсэн загвар байна гэх үзэл баримтлал давамгайлж байна. Үүнд:

1. Нээлттэй буюу англо- саксоны загвар/ төрийн шинэ менежмент/
2. Хаалттай буюу эх газрын Европын орнуудын загвар

Энэхүү 2 загвар нь улс орнуудын төрийн байгууллын хэлбэрээс хамаарч холбооны улсын, нэгдмэл улсынхаар тус тусдаа 2 хуваагдана гэж үзэж байна. Энэ маягаар төрийн иргэний албаны дээр дурдсан 4 загварыг:

- Нэгдмэл улсуудад хэрэгжиж байгаа төвлөрсөн удирдлага бүхий, хаалттай загвар
- Холбооны улсуудад хэрэгжиж байгаа удирдлагын төвлөрлийг харьцангуй сааруулсан хаалттай загвар
- Нэгдмэл улсуудад хэрэгжиж байгаа удирдлагын төвлөрлийг харьцангуй сааруулсан нээлттэй загвар
- Холбооны улсуудад хэрэгжиж байгаа удирдлагын төвлөрлийг сааруулсан нээлттэй загвар гэж нэрлэж болохоор байна.

1. Төрийн иргэний албаны “хаалттай” загвар

Энэхүү загварыг Европын эх газрын олонх улс орнуудын төрийн албанд хэрэгжүүлдэг бөгөөд дор дурдсан нийтлэг шинжтэй байна:

1. Төрийн албаны түвшин тус бүрт зориулсан дүрэмтэй, захирч захирагдах дэглэм илүү ноёрхсон төрийн албаны тогтолцоотой байх
2. Төрийн албанд боловсон хүчнийг шилж сонгох хаалттай систем үйлчлэх
3. Төрийн албан хаагчдын эрх зүй, нийгмийн баталгаа сайтай байхын зэрэгцээ албан тушаал дэвших, цалин хөлс, хөнгөлөлтийн өсөлт нь ажилласан жилээс ихэвчлэн хамаарах
4. Төрийн иргэний албан хаагчийг ажлаас халахад төвөгтэй дэг журам үйлчлэх

Энэхүү хаалттай загварын нэгдмэл улсын төлөөлөл болгож **Франц,** холбооны улсын төлөөлөл болгож **Германыг** авч үзье:

1.1 Францын төрийн албаны загвар

Наполеон -1 ийн хувьсгалын үеэс Францад энэ загварын эх тавигдсан. Төрийн алба нээлттэй байх, нийтийн ашиг сонирхолд үйлчлэх зарчмыг тунхаглаж, албан хаагчдыг шалгаруулалтаар шилж сонгох систем тогтоож, төрийн албан хаагчдыг бэлтгэх тусгай сургалтын байгууллага буй болгосон байна. Түүний зэрэгцээ төрийн албаны төвлөрөл, сахилга бат, үйлчилгээний хүрээг явцуурууллах хандлага давамгайлдаг. Францын орчин үеийн төрийн алба 1945 онд эцсийн хэлбэрээ олж, тэр даруйдаа “Төрийн албаны өөрчлөн байгуулалтын тусгай хороо”-г байгуулсан байна.

Энэхүү хорооны гол зорилго нь төрийн албыг нээлттэй, ардчилсан болгоход чиглэгдэж байв. 1946 онд “Түшмэдүүдийн ерөнхий эрх зүйн байдлын тухай”хуулийг баталж, түүгээр төрийн албаны шинэ бүтцийг тогтоож, нийгмийн болон эрх зүйн баталгааг нэмэгдүүлсэн байна. Төрийн албан хаагч бослогод оролцох эрхтэй, тэдгээрийг зөвхөн орон тоог хорогдуулсан тусгай хуулийн дагуу л ажлаас халж байхаар тогтоосон байна. Төрийн аппаратын мэргэжлийн ангиллын түвшин аажмаар задарч, орон тоо нэмэгдэж., төрийн албан хаагчдын мөнгөн орлогын хэжээ төрийн бус секторынхоос илэрхий хоцорч ирсэн нь төрийн албаны нэр хүнд унахад хүргэсэн байна.

1981 - 1983 оны өөрчлөн байгуулалт удирдлагын төвлөрлийг сааруулах, төрийн аппаратын бүтээмж, үр ашгийг өсгөхөд чиглэгдэв. Энэхүү өөрчлөлтийн дагуу 1983 оны 6 дугаар сарын 13 -нд “Төрийн албан хаагчдын эрх, үүргийн тухай”, 1984 оны 11 дүгээр сарын 14-нд “Төрийн төвлөрсөн албаны ерөнхий дүрмийн тухай” хуулийг баталжээ. Францад хэрэгжүүлж байгаа төрийн албаны хаалттай зарчмын үндсэн агуулгад дор дурдсан нэмэлт баяжуулалт орсон байна:

1. Мужийн түвшний төрийн албан хагчдын үйл ажиллагаанд төвөөс хатуу хяналттай хүчирхэг төвлөрсөн тогтолцоо
2. Төрийн иргэний албан хаагчдыг шалгаруулалтаар сонгон шалгаруулах тогтолцоотой
3. Төрийн албаны шигшмэл байдлыг шалгаруулалтын үед төрийн албан хаагчдыг бэлтгэдэг цөөн хэдэн сургалтын монопол байгууллагаас хангахыг дэмждэг;

1.2. Германы төрийн албаны орчин үеийн загвар

Германы төрийн албаны орчин үеийн загварын хамгийн гол онцлог нь боловсон хүчний асуудалд улс төрийн намын оролцоо, улс төрийн томилгоог өргөжүүлсэнд оршиж байгаа юм. Нэг үгээр хэлбэл намын ивээл, хамгаалалтын зарчим үйлчилдэг.

Төрийн албаны хүрээн дэх эрх зүйн үндсэн нормчилсон актууд 1957-1985 онуудад батлагдсан байна. Тэдгээр актуудад 1953 оны 6 дугаар сарын 14-ний “Холбооны түшмэдүүдийн тухай” хууль, түүний 1985 оны 2 дугаар сарын 27 –ны шинэчилсэн найруулга, 1957 оны 6 дугаар сарын 1-ний “Түшмэдүүдийн эрхийн ерөнхий зарчмын тухай” хууль, түүний 1985 оны 2 дугаар сарын 27-ны шинэчилсэн редакци, “Холбооны албан хаагчдын цалингийн тухай” 1957 оны 6 дугаар сарын 27-ны хууль, түүний 1985 оны 12 дугаар сарын 03 -ны шинэчилсэн редакци хамрагдаж байна.

Германы төрийн албаны орчин үеийн загварын онцлог нь:

1. Төрийн иргэний албаны тогтолцоонд улс төрийн хүчин зүйлийн оролцоо өндөр байна.
2. Төрийн иргэний албаны байгууллагуудыг удирдлагын түвшингээр эрх хэмжээг нь ялгаж өгсөн.
3. Төрийн албаны боловсон хүчнийг хамгийн тэргүүний дээд боловсролын байгууллагаас шилж сонгох олон шаттай системтэй.
4. Төрийн иргэний албан хаагчид өндөр түвшний нийгмийн эрх хэмжээтэй, хүндэт түшмэдийн институци байдаг.
5. Албан хаагчийн насан туршийн томилгооны зарчим болон эрх зүй, нийгмийн хамгаллын баталгааны төгс тогтолцоотой

2. Төрийн иргэний албаны “нээлттэй” загвар

Энэхүү загвар нь англосаксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудад зонхилон хэрэгждэг бөгөөд дор дурдсан нийтлэг шинжтэй байна:

1. Төрийн албаны харилцаанд хатуу тогтоосон норматив, эрх зүйн зохицуулалтын хатуу зохион байгуулалт бүхий тогтолцоогүй
2. Төрийн иргэний албанд боловсон хүчин авах нээлттэй шалгаруулалтын тогтолцоотой
3. Төрийн иргэний албан хаагчийн ажлын үр дүнгээс хамаарсан хөдөлмөрийн хөлс, албан тушаал дэвшүүлэх нөхцөлтэй
4. Ажлаас халах хялбаршуулсан дэг журамтай

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Энэхүү “нээлттэй” загварын хувилбараас төрийн албаны удирдлагын төвлөрлийг харьцангуй саруулсан загвар бүхий, нэгдмэл улсын төлөөлөл болгож Их Британыг, холбооны улсын төлөөлөл болгож АНУ -ыг авч үзье.

2.1. Их Британий төрийн албаны загвар

Тус улсын төрийн албаны нүсэр өөрчлөн байгуулалт нь 1854 онд парламентад тавьсан Норткот - Тревельяны илтгэлээс эхтэй гэж үздэг. Энэхүү өөрчлөлтийн явцад төрийн албаны тогтолцоонд захирагчид, гүйцэтгэгчид, ажлын алба гэсэн 3 ангиллыг нэг мөр болгон тогтоож, төрийн албанд өндөр мэргэжлийн хүмүүс ирсэн байна. Төрийн албаны энэхүү өөрчлөлт 1870 онд шалгаруулалтын төв комисс/Төрийн иргэний албаны асуудал хариуцсан хороо/-ын хяналт дор зохион байгуулагдсан ажилтан шалгаруулах шалгалт явагдсанаар дуусгавар болжээ.

Шалгалтын хөтөлбөрийг Оксфорд, Кембриджийн их сургуулийн арга зүйд үндэслэн зохиосон байна. Энэ өөрчлөлт нь эх газрын загварын хүмүүнлигийн ухааны ерөнхий боловсролтой албан хаагчид шиг явцуу мэргэжлийнхний бус ноёрхлыг тогтоож, төрийн албыг өөрийг нь явцуу шинж чанартай болгоход хүргэсэн байна.

1979 оноос Ерөнхий сайд М. Тетчер яам, газруудын зардлыг багасган, төрийн албан хаагчдын зарим хэсгийг ажлаас халах замаар захиргааны өөрчлөн байгуулалтыг эхлүүлжээ. 1988 онд “Дараагийн алхмууд” нэртэй, Төр засгийн бүх байгууллагуудыг төрийн бодлогыг тодорхойлох төв байгууллагууд, шийдвэрийн гүйцэтгэлийг хариуцах байгууллагууд гэж хуваагаад, шийдвэрийн гүйцэтгэлийг хариуцах байгууллагыг бодлого тодорхойлох төв байгууллагуудтай гэрээний үндсэн дээр ажиллах засгийн газрын бус байгууллага/GUANGO/ болгон өөрчилжээ.

GUANGO-г шалгаруулалтын дүрэм журмын дагуу шийдвэрийн гүйцэтгэлийг хангахад хамгийн тохиромжтой байгууллага гэж сонгожээ. Үүний дараа, цалин хөлсний тариф , тэтгэвэр, хөнгөлөлт, давуу байдлын нэгдсэн сүлжээ зөвхөн төрийн бодлогыг тодорхойлох төв байгууллагуудын хүрэээнд хадгалагдан үлдэж, харин GUANGO-д гэрээгээр гүйцэтгэх ажлын хүрээ өргөжин тэлжээ.

Энэхүү өөрчлөн байгуулалт нь нэг талаас төрийн албан хаагчдын тоог цомотгох, хөнгөлөлт, давуу байдлын хэмжээг хорогдуулах, захиргааны ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд түлхэц өгсөн ч нөгөө талаас төрийн албаны нэгдмэл тогтолцоог алдагдуулан, төрийн албанд татагдах сонирхлыг бууруулахад нөлөөлсөн байна. Харин GUANGO -д цалин хөлс нь хувийн секторынхаас хавьгүй доогуур үлдсэн байна. Хэдийгээр ийм байсан ч Тетчерийн хөтөлбөр Нидерланд, Шинэ Зеландад дэмжигдэж, хуулбарлагдсан боловч эцсийн дүгнэлт хийлгүйгээр зах зээлийн энэхүү механизмыг зах зээлийн бус төрийн албаны үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь одоохондоо эртэднэ гэж экспертүүд дүгнэсэн байна.

2.2. АНУ -ын загвар

1860 -аад оны үед АНУ-д холбооны түвшинд европийнхний ойлголтоор мэргэжлийн бюрократ гэсэн ойлголт үндсэндээ байгаагүй. 1829 онд Ерөнхийлөгч Э.Жексоны нэвтрүүлсэн “victors spoils system” буюу сонгуульд ялсан намын төлөөлөл албан тушаалд томилогддог тогтолцоо хэрэгжиж байв.

XIX зууны эцэс, XX зууны эхээр АНУ-д европын төрийн албаны боловсронгуй загварын тухай үзэл санаа өргөн хүрээнд яригдах болсон байна. 1883 онд батлагдсан Пендлтоны хуулиар “Төрийн дийлэнх албан хаагчдын албан тушаал, цалин хөлс, мэргэжлийн шалгаруулалтын нэгдмэл тогтолцоо”-г хэрэгжүүлж эхэлснээр “victors spoils system”-д

цохилт өгсөн байна. Төрийн албан хаагчдаас улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг шууд хязгаарласан хууль бол 1939 онд Конгрессоор батлагдсан Хэтчийн хууль бөгөөд түүгээр төрийн албан хаагчид аль ч шатны сонгуулийн кампанит ажилд оролцох, өөрийн албан тушаалын байдлаа аль нэг улс төрийн намын ашиг сонирхолд ашиглахыг хориглосон байна. 1960 - 1970 онуудад төрийн албыг улс төржүүлэх хандлага дахин зонхилж байв.

1978 - 1979 онуудад хийгдсэн төрийн албаны өөрчлөн байгуулалтаар төрийн албанд “merit system” буюу “ажлын үр дүнгийн систем”, төрийн албан хаагчдын байнгын аттестатчлал, ажлын үр дүнгийн хяналтыг нэвтрүүлснээр хуучин ситемийг үндсээр эргүүлсэн байна. Төрийн албаны удирдах байгууллагуудыг эмхлэн байгуулсаны дотор Холбооны боловсон хүчний удирдах газар, Ажлын үр дүнгийн тогтолцоог хамгаалах зөвлөлийг байгуулсан байна. Т

үүнчлэн улс төрийн болоод албан тушаалд дэвших боловсон хүчний нөөц/1994 онд тэтгээрийн тоо 7560-д хүрсэн/ -ийг бүрдүүлэх зорилгоор дээд түвшний захиргаа-улс төрийн элитүүдийн эмхэлэн байгуулах тогтолцоо/Дээд түвшний удирдагчдын алба/-г байгуулжээ. 1978 онд энэхүү өөрчлөлтийг бататгах үүднээс төрийн иргэний албаны тухай хуулийг баталсан байна.

АНУ -ын төрийн иргэний албаны орчин үеийн загварын онцог нь:

1. Төрийн иргэний албаны тогтолцоонд улс төрийн томилгоо зонхилох байр суурьтай
2. Төрийн иргэний албан тушаалтны цалингийн хэмжээ, албан тушаалд дэвших нь ажлын үр дүнгээс хамаарах “ажлын үр дүнгийн систем”-тэй
3. Төрийн иргэний албан тушаалтныг ажлаас халах хялбаршуулсан журамтай
4. Холбооны төрийн алба, Холбооны субъектуудын төрийн алба/ Холбооны субъектуудын төрийн албаны тухай хууль нь хоорондоо болон холбооны хуультайгаа бараг адил/-тай учраас төвлөрлийг өндөр түвшинд сааруулж чадсан
5. Төрийн иргэний албаны ангилал тогтоохдоо:
   - АНУ -ын байгууллагуудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэний нийтийн албан хаагч,
   - дээд түвшний улс төрийн томилгооныхон-төр засгийн албан хаагч
   - төрийн албан хаагчдын 60 %-ийг эзлэх иргэний албан хаагч - мэргэжлийн өөрчлөгдөшгүй түшмэдүүд гэж ангилжээ.

1993 - 1999 онд АНУ-д төрийн албаны дараагийн өөрчлөлтийг хийсэн бөгөөд түүнийг ердийн төрийн албан хаагчид бус улс төрийн томилгооныхон удирдсан байна. 1992 онд явуулсан үндэсний хэмжээний ажлын үр дүнгийн шалгалтын үндсэн дээр 1993 онд “Төр засгийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн тухай хууль” батлагдаж, түүний дагуу төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, холбооны төрийн албан хаагчдын тоог 17%-иар цомотгосон байна.

2. Гадаадын зарим орнуудын төрийн албаны тогтолцоо, эрх зүйн орчин, шинэтгэл

Дээр дурдсан загваруудын төлөөлөл болгож, Европ тивийн хуучин социалист орнуудаас Унгар, ЗХУ -ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас Латви, Ази тивийн хөгжиж буй улсуудаас Тайланд, Африк тивийн хурдацтай хөгжиж буй Ботсван зэрэг гадаадын зарим улс орны төрийн албаны тогтолцоо, бүтэц, менежментын загвар, эрх зүйн орчин, шинэчлэлийн туршлага, хэрэгжилтийн талаар товч авч үзье.

ШУТИС
СУДАЛГААНЫ САН

Бүгд Найрамдах Унгар Улс

Унгар Улс Социалист хөгжлийн чиг хандлагаас татгалзаж, төрийн албаны шинэчлэлээ, хөрш зэргэлдээ хөгжингүй улсууд болон Европын холбооны улсуудын эрх зүйн орчинд нийцүүлэн өөрийн орны түүх, соёлын уламжлалд тулгуурлан хийж, төрийн албаны загварын хувьд Англиийн загварт ойртуулан шинэчилсэн улс юм.

- Төрийн албаны тогтолцоо, бүтэц

Унгар Улс /Парламентын бүгд найрамдах/-ын төрийн албаны тогтолцоо нь төрийн алба болон төрийн албан хаагчийн бүрдэл юм. Үүнд:

a) Төрийн захиргаа
b) Мужийн түвшний төрийн захиргаа
c) Орон нутгийн түвшний төрийн захиргаа
d) Орон нутгийн удирдлагын байгууллага /орон нутгийн өөрийн удирдлага/

Төрийн албан хаагчид нь төрийн төв болон орон нутгийн албан хаагчдаас бүрдэнэ.

a) Зэвсэгт хүчний албан хаагчид /цагдаа, хил хамгаалах гэх мэт/
b) Төрийн албан хаагчид-олон нийтэд үйлчилдэг нийгмийн ажилтан /эрүүл мэндийн салбарын ажилтан болон багш гэх мэт/ Эмч, багш, сувилагч бол төрийн албан хаагч гэхээсээ илүү иргэний нийтийн албан хаагч гэдэгтээ хамаарна.

Төрийн албан хаагчдын тоо

№	Салбар	Ажилчдын тоо
1	Төрийн иргэний албан хаагчид / Civil servants /	110.000
2	Зэвсэгт хүчний албан хаагчид	90.000
3	Иргэний нийтийн албан хаагчид / Public servants /	550.000

Яамдын тоо

Ерөнхий сайдын ажлын албанаас гадна 14 яамтай. Үүнд:

- Хөдөө аж ахуйн болон хөдөөгийн хөгжлийн яам
- Соёлын өв уламжлалын яам
- Батлан хамгаалах яам
- Эдийн засаг болон зам тээврийн яам
- Боловсролын яам
- Хөдөлмөр болон хөдөлмөр эрхлэлтийн яам
- Хүрээлэн буй орчин болон усны яам
- Сангийн яам
- Гадаад хэргийн яам
- Дотоод явдлын яам
- Эрүүл мэндийн яам
- Мэдээлэл, харилцаа холбооны яам
- Хууль зүйн яам
- Залуучууд, гэр бүл, нийгмийн хамгааллын яам

Портфель /Сайдын суудалгүй/ -гүй 2 яам байдаг. Үүнд:

- Европын холбоонд үүрэг хүлээх яам
- Барилга, орон сууц, барилга байгууламж болон аялал жуулчлал, бүс нутгийн асуудалд үүрэг хүлээх яам

Яамны бүтэц



Парламент /хууль тогтоох байгууллага/ нь олонхиос Ерөнхийлөгчөө сонгодог. Парламентад нь 386 гишүүн байна. Үүнээс 176 нь нэг мандаттай тойргоос сонгогддог. 152 нь олон мандаттай 20 тойргоос намуудын жагсаалт /5 хувийн барьертай/-аас сонгогддог. Үлдсэн 58 нь шууд пропорциональ төлөөллийг хангах зорилгоор сонгогддог. Хууль, тогтоол хэлбэрээр шийдвэрээ гаргана. Тогтоол нь зөвхөн парламентдаа чиглэж гарна.

Засгийн газар нь кабинетийн зарчмаар үйл ажиллагаа явуулна. 7 хоног болгон хуралдана. Ерөнхий сайд толгойлно. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлснээр парламент сонгоно. Сайдуудыг Ерөнхий сайд нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно. Засгийн газар нь Ерөнхий сайд болон бусад сайдуудаас бүрдэнэ. Сайдууд нь парламентын гишүүн байх албагүй. 4 хэлбэрээр шийдвэр гарна. Үүнд: Хуулийн төсөл, Засгийн газрын тушаал/хууль хэрэгжүүлэхийн тулд гадагшаа чиглэсэн/, сайдын тушаал, ЗГ-н тогтоол /зөвхөн төвлөрсөн ЗГ-ын байгууллагуудад хэрэгжих ёстой. Холбогдох сайдуудын хэрэгжүүлэх дотогшоо чиглэсэн/.

Парламент Засгийн газрын бүтцийг тогтооно. Яамны хариуцах асуудал, сайдуудын эрх хэмжээний талаар Засгийн газар тогтооно. Засгийн газарт кабинетийн хороо байх бөгөөд тэдгээр нь шийдвэрүүдийг бэлтгэнэ. Засгийн газар нь байнгын хороо болон бусад хороог үүсгэж болдог.

1.2. Төрийн албаны менежментийн загвар

Албан хаагчдыг хийсэн ажил ажлын үр дүнгээр цалинжуулж, улс төрөөс хараат бус байх, улс төрийн нөлөөллөөс хамгаалах, боловсон хүчнийг урамшуулах болон сургалтанд хамруулахын зэрэгцээ хүчирхэг хариуцлагын тогтолцоотой хосолсон удирдлагын уян

хатан байдал шаардлагатай гэж үзэж байна. /шинэчилсэн менежментийн загвар/ (New Public Management)

1.3. Төрийн албаны эрх зүйн орчин

БНУУ -ын одоогийн Үндсэн хууль нь 1989 оны 10 сард батлагдсан. Шинэ Үндсэн хууль нь 1949 оны Үндсэн хуулийг шинэчлэн найруулж, нэмэлт, өөрчлөлт оруулсан юм. Парламентын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байна. Төрийн иргэний албаны тухай хууль /the Civil Service Act/ нь 1992 онд батлагдсан. Энэ хууль нь албан хаагчдыг хийсэн ажил ажлын үр дүнгээр цалинжуулах тогтолцооны эх үүсвэрийг бий болгосон бөгөөд улс төрөөс хараат бус байх, улс төрийн нөлөөллөөс хамгаалах, яг тодорхой заасан албан тушаалын цалин хөлсний тогтолцоо, боловсон хүчнийг урамшуулах болон сургалтад хамруулах тогтолцоог энэ хуулиар хэрэгжүүлсэн. 1992 оноос хойш хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Харин 2001 онд их томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсан.

1.4. Төрийн албаны шинэчлэлийн туршлага, хэрэгжилт, үр дүн

Ойролцоогоор хоёр жил тутамд Засгийн газраас сүүлийн үед авч хэрэгжүүлэх бодлого болон хийх шаардлагатай дараагийн алхмуудын талаар тогтоол гаргадаг бөгөөд түүнийгээ Унгарын Засгийн газрын мэдээллийн хуудсанд нийтэлдэг. 1990-1992 он, 1996-1997 он болон 2001 онуудад шинэчлэл хийж байсан. 1992 оны Төрийн албаны хууль нь хийсэн ажил үр дүнгээр цалинжуулах тогтолцоог бий болгож, улс төрөөс хараат бус байх, улс төрийн нөлөөллөөс хамгаалах, албан тушаалын цалин хөлсний тогтолцоо, боловсон хүчнийг урамшуулах болон сургалтад хамруулах тогтолцоог энэ хуулиар хэрэгжүүлсэн. 1992 оноос хойш хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Унгарт төвлөрлийг сааруулах талаар маш хүчтэй шинэчлэл хийж байгаа. 1990 онд орон нутгийн захиргаа болон хотын захиргааны жижиг нэгжүүдэд илүү их бие даасан эрх мэдлийг өгснөөр төрийн үйлчилгээ сайжирсан. Мөн улсын төсөв дэх орон нутгийн төсөв багассан. 1998 оны сонгуулиас төвлөрсөн агентлагуудын үүрэг өргөжсөн байна. Мөн төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх оролдлогыг олон хийж байсан. 1996-1997 онд 3 хувиар цомотгосон. 1995 онд яамдад ажиллаж байгаа албан хаагчдаа 15 хувиар цомотгох тушаал гаргасан боловч бодит байдал дээр сайн бууруулж чадаагүй. Эргээд өссөн байна. Орон нутгийн засаг захиргааны хувьд ажиллагчдын тоог бууруулах шаардлага байгаагүй.

Засгийн газраас нийтийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, нийтийн тээвэр гэсэн дөрвөн чиглэлээр иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл өгөх төвүүд / Англиин PUMA 1998b гэсэн дүрмээс туршлага авч хэрэгжүүлэхээр бэлдсэн/-ийг байгуулан ажиллуулж эхэлжээ. Үйл ажиллагааг улам өргөжүүлэхийн тулд өндөржүүлсэн, сайжруулсан хариуцлагын тогтолцоотой хосолсон удирдлагын уян хатан байдал шаардлагатай байна гэж үзсэн бөгөөд энэ нь хуучин эрх зүйн тогтолцоотой таарахгүй байсан. Төрийн өндөр албан тушаалтнуудын ил тод байдлыг бий болгох үүднээс хөрөнгө орлогын мэдүүлгийг шаардаж эхэлсэн байна.

Төрийн албаны хуульдаа 2001 онд нэмэлт, өөрчлөлт оруулах хүртэл төрийн албан хаагчдыг 4 ангилж үздэг байсан. Бакалаврын түвшний зэрэгтэй нь 1-р төрөл, бүрэн дунд боловсролын түвшинд 2-р төрөл, бичиг хэргийн ажилчид 3-р төрөл, биеийн хөдөлмөр эрхлэх ажилчид 4-р төрөлд гэж хуваж байсан. Энэ анги дотроо зэрэглэлүүд байгаа. 3 жил төрийн албанд ажиллахаар дараагийн зэрэглэл рүү дэвшиж явдаг байна. 2001 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн 1, 2 -р төрөлд хамаарах хүмүүсийг л төрийн албан хаагчид гэж үзэх болж тэдгээр хүмүүс Төрийн албаны хуульд хамаардаг болсон.

112 мянган төрийн албан хаагч байснаас 2001 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт бүрэн

хэрэгжиж эхэлсэнээр 3, 4-р ангиллын ажилтнууд хасагдсанаар 14 мянгаар буурч байсан. 1995 онд 15 хувиар бууруулах гэж оролдоод амжилттай болоогүйгээс хойш ямар нэгэн өөрчлөлт хийгээгүй байна. Түүнээс хойш Европын холбоонд орохын тулд шаардлага биелүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын тоо бага багаар нэмэгдэж байсан байна. 3000 гаруй байгууллагад нийт төсөв хуваарилагдаж байна.

Төрөл	Тоо	Хүн амын эзлэх хувь
Тосгон	2 899	36.5%
Хот	214	26%
Мужийн төв хот	22	19.9%
Будапешт /23 дүүрэгтэй, хууль зүйн тусгай статустай/	1	17.6%

Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ хувийн секторт ажиллагсдын авдаг цалингийн дунджаас 10 хувиар бага байсан. Орон нутгийн ажилчдын цалингийн хэмжээ бол улсын нийт цалингийн дундаас 40 хувиар бага байна. 2001 оны нэмэлт, өөрчлөлтөөр төрийн албан хаагчдын амжилтын тогтолцоог хаалттай болгосон.

Энэ нь ажил албандаа тогтвор суурьшилтай ажиллаад, насан турш төрийн албандаа зүтгэх боломжийг олгож өгсөн. Энийгээ амьдралын, бүх насны амжилт /life career/ гэж нэрлэдэг. Ингэснээр төрийн албан хаагчид хэдэн жил ажиллахад цалин урамшуулал хэзээ, хэрхэн нэмэгдэх, болон ямар сургалтанд хэзээ хамрагдах гэдэг асуудлыг тогтвортой болгож өгсөн. Энэ нь төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэхэд чиглэгдсэн байна. Боловсон хүчний ахлах албан тушаалд хүмүүсийг авахад хувь хүн дур зоргоороо шийдээд авах асуудлыг хязгаарлаж, өрсөлдөөний журмаар шалгаруулалтад суурилах аргуудыг хэрэглэж байна.

Шинэчлэлийн үр дүн

Удирдлагын хуулиудыг илүү боловсронгуй оновчтой болгоход чиглэсэн хоорондоо уялдаа бүхий хэд хэдэн хуулиудыг хэрэгжүүлсэн. Өөрчлөлт шинэчлэлтийн гол зорилго бол улс төрийн ардчилсан тогтолцоо болон хуулийн орчныг бий болгох салбарын удирдах байгууллага байгуулах/гүйцэтгэх засаглалын салаа мөчир бий болгох/ зорилготой байсан. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд зориулсан удирдлага бий болгох зорилт тавьсан. Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар социализмаас зах зээлд шилжиж байгаа 20 орны дотор Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр дүнгээр нэгдүгээр байранд орж байсан.

1989 - 1990 онд ардчилсан улс төрийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн юм. Улс төрийн том хүчнүүдийн хооронд харилцан ойлголцол байсны ачаар ийм том өөрчлөлтүүдийг хийж чадсан. Одоогийн байдлаар өмнө хийсэн шинэчлэлүүдээс гарсан өөрчлөлтүүдийг яаж шийдэх вэ гэдэг дээр төвлөрч ажиллаж байна.

Нутгийн удирдлага

Унгар улсын ерөнхий нутаг дэвсгэрийн хуваарилалтыг Үндсэн хуульд зохицуулж өгсөн. Ингэхдээ мужууд /бүс нутгийн түвшний/ болон хот, тосгод /орон нутгийн түвшний/ гэзд нутгийн өөрийн удирдлага эдгээр нэгжүүд дээр үндэслэдэг. Унгарын төрийн захиргаа нь хүнд суртлын болон ардчилсан шалгаруулалтаар томилогддог гэсэн үндсэн хоёр суурь бүтэцтэй. Эхнийх нь төрийн захиргааны төв байгууллагууд, тэр дундаа орон

нутгийн ерөнхий түвшний /төвлөрсөн байгууллагууд/ төрийн захиргаанд захирагддаг байгууллагууд, хоёр дахь нь өөрөө удирдах систем ба нэмэлт зарчимд үндэслэсэн нутгийн өөрийн удирдлагын тогтолцооны бүтэц юм. Нутгийн өөрийн удирдлагын тогтолцоо нь орон нутгийн болон бүс нутгийн түвшин гэж хуваагддаг байна.

Унгарын нутгийн өөрөө удирдах байгууллага нь зохион байгуулалт үйл ажиллагааны дүрэм журмаа өөрөө бие даан шийдвэрлэх эрхтэй байдаг. Тиймээс төлөөлөгчид нь өөрсдийн оффис, газар, хэлтсийн зохион байгуулалтаа хийх ажлыг хариуцдаг. Орон нутгийн засаг захиргааны бүтэц нь ихэвчлэн ИТХ-ын хууль, журам, Засаг дарга болон Ерөнхий Захирагчийн шийдвэрээр тогтоогддог. Өөрөө удирдах байгууллага нь өөрийн үүрэг эрх мэдлээ оффисийн (тамгын газар) албан хаагчдаар бус харин ИТХ-аар дамжуулан хэрэгжүүлдэг. Харин төрийн удирдлагын эрх мэдлийг ихэвчлэн Ерөнхий захирагч болон зарим тохиолдолд Засаг дарга хэрэгжүүлдэг. Иймээс оффис (тамгын газар) нь зөвхөн захиргааны болон арын албаны үүрэг функцийг гүйцэтгэдэг.

Оффисийн (тамгын газар)-ийн менежментийг засаг дарга болон ерөнхий захирагч гүйцэтгэдэг. Ихэвчлэн засаг дарга ерөнхийд нь чиглүүлж харин ерөнхий захирагч удирдан зохион байгуулдаг. Засаг дарга нь засаг даргын орлогч, ерөнхий захирагч болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын тэргүүнүүдийг томилдог. Ажиллагсадыг ажилд авах, халах, шагналд тодорхойлох зэрэг засаг даргын ажил үүрэгт хамаарах асуудлаар гаргасан Ерөнхий захирагчийн шийдвэрүүдийг засаг дарга батлах шаардлагатай байдаг.

Иргэдийн Төлөөлөгчдийн байгууллагын ажиллагсад нь төрийн албан хаагчид юм. Унгарт төрийн үйлчилгээний удирдлага нь төвлөрсөн үү, эсвэл орон нутгийнх уу гэдгээс үл хамааран 1992 оны “Төрийн албан хаагчийн статус” тухай хуулиар зохицуулдаг. Хэдийгээр энэхүү хууль нь төрийн албаны бүх түвшинг хамаардаг ч орон нутгийн түвшинд албан хаагчидтай холбоотой зарим ялгааг зөвшөөрдөг. Орон нутгийн засаг захиргааны хамгийн чухал байгууллага нь Иргэдийн төлөөлөгчдийн байгуулага ба засаг дарга бөгөөд аль аль нь иргэдээс сонгуулиар сонгогддог. Бүх хүмүүс сонгуульд оролцох тэгш эрхтэй бөгөөд саналын хуудсаар нууцаар саналаа өгдөг. Тухайн нутагт тогтмол оршин суугаа сонгуулийн насанд хүрсэн Унгарын Улсын бүх иргэд орон нутгийн сонгуульд оролцох эрхтэй.

Унгарын иргэн биш боловч Унгарт тогтмол амьдарч байгаа хүмүүс ч бас сонгууль өгөх эрхтэй. ИТХ-ыг сонгох тогтолцоо нь том болон жижиг суурин газруудад ялгаатай байдаг бөгөөд “богино тасалбар” болон “холимог” системийн аль алийг нь ашигладаг. 10000 хүртлэх хүн амтай суурин газрыг нэг тойрог болгон хүн амын тооноос хамааран 3-13 төлөөлөгчийг сонгодог. Иргэн бүр ИТХ-ын гишүүдийн тоогоор санал өгч болох ба төлөөлөгчид дийлэнхи олонхийн саналаар сонгогддог. Нийслэлийн дүүргүүдийг оролцуулан 10000-аас дээш хүн амтай хот суурин газруудад холимог системээр сонгууль явуулдаг. Энэ системээр төлөөлөгчдийн зарим хэсэг нь бие даасан тойргуудаас, үлдсэн нь намын жагсаалтаар сонгогддог. Мандатын тоог хуулиар тогтоож өгдөг.

- Бүгд Найрамдах Латви Улс

Латви Улс ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарч тусгаар улс болсныхоо дараа төрийн албаны шинэчлэлээ эх газрын загварыг чиг баримжаа болгон хэрэгжүүлж , улмаар Европын холбооны улсуудтай хамтран ажиллахад эвтэй хэн байх үүднээс энэ орон зайд тохируулан өөрийн орны түүх, соёлын давтагдагдашгүй онцлогт нийцүүлэн шинэчлэл хийж удирдлагын төвлөрлийг харьцангуй сааруулж чадсан улс юм.

Төрийн албаны бүтэц

Латви улсын төрийн албанд /public service/:

a) төрийн иргэний алба /civil service/,
b) Засаг захиргааны шууд байгууллага институцийн албан хаагчид / яамд болон тэдгээрт харьяалагддаг байгууллагууд/
c) орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад шууд харъяалагддаггүй албан хаагчид: Орон нутгийн захиргаа нь төрийн алба /civil service/ -нд хамаардаггүй.

Төрийн иргэний алба /civil service/-нд яамдын албан хаагчид, мэргэшсэн дипломатч, цагдаагийн албан хаагч, гал сөнөөгч, хил хамгаалагч, татварын байцаагчид болон бусад улсын төсвийн байгууллагын үйлчилгээний ажилчид хамаарна.

Төрийн албан хаагчдын тоо

	Институтын тоо	Албан тушаа-лын тоо	Төрийн албан хааг-чдын тоо	Ажилтнуу-дын тоо	Боловсон хүчний тоо	Нийтийн захиргааны ажилчдаас төрийн албан хаагчдын эзлэх хувь
Төрийн иргэний алба	78	8111	6858	6230	10388	52%
Мэргэш-сэн төрийн алба	9	23380	21633	3786	25419	86%
Нийт	87	31491	28491	10016	38507	74%

Яамдын тоо

Хэрэг эрхлэх газар – Цахим засаглалын тусгай санхүүжилт хариуцсан болон Нийгэм дэх ашиг сонирхолыг нэгтгэх сайдуудтай. 15 яамтай. Үүнд:

- Гадаад хэргийн яам
- Батлан хамгаалахын яам
- Хууль зүйн яам
- Сангийн яам
- Дотоод явдлын яам
- Эрүүл мэндийн яам
- Нийгмийн хангамжийн яам
- Зам тээвэр болон харилцаа холбооны яам
- Бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн засаг захиргааны яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам
- Хүрээлэн буй орчны яам
- Соёлын яам
- Хөдөө аж ахуйн яам
- Эдийн засгийн яам
- Хүүхэд болон гэр бүлийн асуудал хариуцсан яам

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Төрийн албаны эрх зүйн орчин

БНЛатУ -ын Үндсэн хуулийг Үндсэн хуулийн хурал /the Constitutional Assembly/-аас 1922.02.15 -нд баталсан. Төрийн үйлчилгээний тогтолцоог Латви улсын Парламент анх 1994.04.21 -нд Төрийн иргэний албаны тухай /the Law on State Civil Service/ хуулиар баталгаажуулсан. 2001 оны 01 сараас мөрдөж эхэлсэн Төрийн албаны тухай хууль, түүнд оруулсан нэмэлтийн тухай хууль нь төрийн албаны эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. Энэхүү хуулийн зүйл заалтаар бол төрийн алба нь төрийн эрх барих байгууллагуудын хянан шалгах, бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болж хяналт тавихаас гадна хууль тогтоомжийн төсөл бэлтгэх зэрэгт түлхүү анхаарч ажиллах үүрэгтэй.

Төрийн алба нь засаг захиргааны байгууллагаар хязгаарлагдахгүй бөгөөд үүнд тусгай албад, дипломат болон консулын алба, төсвийн ажилтан, цагдаа, хилийн цэрэг зэрэг багтана. Түүнчлэн төрийн тусгай албаны бүлгүүдэд зориулсан нэмэлт хууль тогтоомжууд байдаг ба төрийн албанд хамааралтай бусад хууль тогтоомжууд болох Авилгын эсрэг болон Засан хүмүүжүүлэх хууль зэрэг багтана. Дээр дурдсан хууль тогтоомжууд нь Ерөнхий сайд, сайдууд, дэд сайдууд, парламентийн нарийн бичгийн дарга зэрэг бусад хуульд захирагддаг улс төрийн алба тушаалтнуудад үйлчилдэггүй. Зөвлөхүүд болон туслахууд зэрэг дээд албан тушаалтай албан хаагчид болон түүнчлэн төрийн дээд байгууллагуудыг дэмжиж ажилладаг байгуулагуудад ч дээрх хууль үйлчилдэггүй.

2002 оны 6 сард төрийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, хяналт шалгалт, хариуцлагын болон төсвийн зохицуулалт зэргийг хянах үүрэг бүхий Төрийн захиргааны тухай хууль / Law on Public Administration/-ийг баталсан.

Төрийн албаны шинэчлэлийн туршлага, хэрэгжилт, үр дүн

Латви улсад 1993 онд мэргэжлийн төрийн албыг бэхжүүлэх болон төрийн захиргааны талаар улс төрийн шийдвэр шаардагдаж байсан тэр үед төрийн захиргааны шинэтгэлийн

бэлтгэл эхэлсэн. Тус улсын төрийн захиргааны /Төрийн удирдлагын/ шинэтгэлийн хөтөлбөр /Сайд нарын кабинетаас 1995.03.28 -.д баталсан/ -ийг Латвийн төрийн захиргаа дарангуйлагч дэглэмээс хууль, дүрэмд тулгуурласан, эрх зүйт ардчилсан төр рүү шилжих үед тодорхойлсон байна. Үндсэн хуулиар төрийн захиргааны байгууллага болон төрийн эрх мэдэл, чиг үүрэг иргэдэд чиглэсэн шууд, үр ашигтай байх ба, шударга байх ёстойг тогтоосон байна.

Төрийн удирдлагын шинэчлэлийн эхний хөтөлбөр нь 1995 онд төрийн албаны бүтэц, гүйцэтгэх үүрэг, зарчим дээр төвлөрсөн. Эхэн үедээ шинэчлэлийн хөтөлбөр нь байгууллагууд /институт/, түүний боловсон хүчний үйл ажиллагаа удирдлагын шинэчлэлээс хэтрэхгүй байсан. Энэ нь шинэчлэлийн хөтөлбөр бүрэн хэрэгжихэд чигрэгдэл учруулж байжээ. Учир нь энэ олж авсан мэдээлэл дээр үндэслэн тойм төлөвлөгөө хийн төгс хэлбэрийг тооцоолоход хангалтгүй байсан. Захиргааны бодит бүтэц болон боловсон хүчний бодлого нь захиргааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, биелүүлэх, боловсонгуй болгох ба төрийн албаны үйлчилгээний чанар, үр ашиг, хүчин чадал, төрийн албаны шинэчлэлийг нэвтрүүлэхэд чигглэгдэж байв.

Хөтөлбөр дэх шинэчлэлийн стратегийн заавар:

- Нийгэм болон төр хоорондын харилцааны шинэчлэл
- Төрийн удирдлагын гүйцэтгэх үүргийн шинэчлэл
- Төрийн захиргааны бүтцийн шинэчлэл
- Төрийн удирдлагын зарчим дахь шинэчлэл
- Төрийн удирдлагын гол хэрэгслийн шинэчлэл

  -Төрийн санхүүгийн удирдлага
  -Боловсон хүчний удирдлага
  -Хэм хэмжээний актын боловсруулалт ба хэрэгжүүлэлт

Хөтөлбөрт дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна:

-эрх зүйн акт гаргах;
-судалгаа шинжилгээний тогтолцоо буй болгох;
-удирдлагын өөрчлөлт хийх;
-санхүүгийн нөөц бүрдүүлэх;
-боловсон хүчнийu сургаж боловсуулах;
-нийгэм болон төрийн албан хаагчдын төлөвшүүлэх;

Төрийн үйлчилгээний тогтолцоог Латви улсын Парламент анх 1994.04.21 -нд Төрийн иргэний албаны /the Law on State Civil Service/ тухай хуулиар баталгаажуулсан. Энэ хууль нь төрийн захиргааны төв болон шилжилтийн дараах орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын албан хаагчдын зэрэг дэвийг тогтоох үндсийг тавьж өгсөн. Энэхүү хуулиар төрийн улс төрийн болон төрийн захиргааны байгууллагуудын ялгааг тусгасан байдаг. Төрийн албан хаагчдыг нээлттэй өрсөлдөөн болон ажлын чанарын үзүүлэлтээр шилж сонгох ба сонгон шалгаруулалтад мэргэжлийн ангилал, боловсрол, үүсгэн байгуулагдсан төр засгийн хууль дүрэм сахих чадвар, Латвийн шилжилтийн дараах хаагдсан байгууллагууд болон бусад улс орнуудын байгууллагуудын ажил, үйлчилгээний байгууллагуудад бүртгэлгүй байх зэрэг шалгууруудыг багтсан.

1994 онд үйлчилж байсан тогтолцооноос Төрийн иргэний албаны тухай хууль /the Civil Service Law/-д шилжих шилжилтийг хийхийн тулд засаг төрийн байгууллагад ажиллаж байсан бүх иргэнийг төрийн албанд нэр дэвшүүлэхэд зайлшгүй шаардлагатай шалгуурт

тэнцэж байгаа эсэхийг шалгах мэргэжлийн шалгалтанд хамруулсан байна. 1994-1996 онуудад яамдын ахлах албан тушаалд ажиллаж байсан бүх хүмүүс энэ мэргэжлийн шалгалтанд хамрагджээ. Шалгалтанд тэнцсэн ажилтнууд төрийн албанд иргэний үйлчилгээний ажилтан гэсэн статустайгаар нэр дэвшиж байсан.

1994-1998 онуудад Төрийн захиргаанд ажиллаж байсан ажилтнуудыг болон төрийн алба горилогчдыг Төрийн засаг захиргааны сургуулиас боловсруулсан зайлшгүй хамрагдах шаардлагатай цогц сургалтын хөтөлбөрт хамруулсан байна. Сургалтын тусгай курсын хөтөлбөрийн гол агуулгад комьпютерын технологийн чадвар, олон нийттэй харилцах асуудал, засаг захиргааны хууль, зах зээлийн эдийн засгийн үндэс, оффисийн болон бичиг хэргийн удирдлага, сэтгэл судлал, ёс зүй, төрийн худалдан авалтын асуудал, удирдлагын орчин үеийн шинэчлэгдсэн онолын гол чухал мэдлэг болон практик ур чадвараа хөгжүүлэх зэрэг зориуд бэлтгэсэн хөтөлбөрүүдийг багтаасан байдаг. Дээрх сургууль нь мөн Европын холбооны байгууллагуудад ажиллах ажилтнуудад зориулсан гадаад хэлний сургалт явуулдаг.

Төрийн иргэний дээд түвшний байгууллагын менежерүүдэд (Төрийн нарийн бичгийн дарга болон иргэний үйлчилгээний байгууллагын тэргүүн) бусадтай нь харьцуулбал өөр агуулга бүхий сургалттай байдаг. 240 төрийн дээд албан тушаалтнуудад гадаадын төрийн захиргааны удирдлагаар мэргэшсэн мэргэжилтнүүдээр бусдаас тусгайлан сургалт явуулсан байна.

Үндсэн танилцуулах сургалт нь 1994-1996 оны Төрийн удирдлагын шинэчлэлийн хөтөлбөр /Public Administration Reform Program (1994–1996)/-ийн захиргааны шинэчлэлийн хөтөлбөртэй давхцах ба энэ нь сургалтын өгөөжийг сайжруулахад онцгойлон анхаарахад зориулагдсан байдаг. Дунд болон бага түвшний ажилтнуудыг /12000 хүн/ сургахын тулд дээрх сургууль нь сургагчийг сургах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ба үүгээрээ Латвийн сургагч нарыг сургах, сургалтын материалын загварыг гаргах, 23 бүсийн төвүүдэд зайлшгүй сургах сургалт явуулж байсан байна.

2001–2006 оны Төрийн албаны шинэчлэлийн стратегийн хэрэгжилтийн төлөвлөгөөг 2001 оны 12 сард Засгийн газраас батлсан бөгөөд хэрэгжилтийг хянахын тулд Зохицуулах хороог байгуулсан байна. Улсын канцлерийн газар гол үүрэг гүйцэтгэдэг ба тэрээр зөвхөн боловсон хүчний бодлогын хөгжлөөр зогсохгүй, мөн цаашлаад Төрийн албаны хуулийн хэрэгжилт, цалингийн нэгдсэн тогтолцооны хөгжилт төрийн агентлагийн хуулийн хэрэгжилт мөн дээр нь Төрийн захиргааны сургуулийн сургалтуудыг удирдан чиглүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг.

2002 оны 6 сард төрийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, хяналт шалгалт, хариуцлагын болон төсвийн зохицуулалт зэргийг хянах үүрэг бүхий Төрийн захиргааны тухай хууль / Law on Public Administration/-ийг батлсан ба 2003 оны 01 сараас эхлэн мөрдөж, 2005 оны 01 сар гэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Төрийн албаны хуульд шинээр ажилтан элсүүлэх болон тушаал дэвшүүлэх зэргийг зохицуулж өгсөн байдаг. Төрийн албаны бүхий л орон тоог нийтэд ил зарлан шалгаруулж авах ба хуулинд шинээр ажилтан авахдаа ил тод байх бүх л нөхцөл, горим журмыг заасан. Төрийн алба нь шинээр ажилтан элсүүлэх журмыг мөрдүүлэх ёстой бөгөөд Төрийн алба нь дүрэм журмыг баталж төрийн албанд хэрхэн зөв хэрэгжүүлж байгааг хянаж хариуцах ёстой.

Төрийн дээд албан тушаалыг хуулинд нэрлэн жагсааснаар төвлөрсөн сонголтын журмаар сонгон шалгаруулдаг. Хашиж буй албан тушаалаасаа хамаарч тухайн байгууллагын тэргүүн эсвэл сайд, Ерөнхий сайд нь үнэлгээний комиссын санал болгосноор албан тушаалд томилогдох эрх үүснэ. Төрийн дээд албан тушаалтны томилгоог Сайд нарын

зөвлөл баталдаг. Томилгоог туршилтын хугацааг нааштайгаар гүйцэтгэсэн гэдэг үндэслэлээр тодорхой хугацаагүйгээр хийдэг. Яамдын хоорондох шилжилт хөдөлгөөнийг хийх боломжтой ба үүнд ажлын шалтгаанаар тохиролцон өөр албанд шилжих ч багтана.

Шинэчлэлийн үр дүн

1990 онд тусгаар тогтнолоо зарласан ч албан ёсоор Зөвлөлт Холбоот Улсын нэг субъект хэвээр байсан Латви улс нь маш ихээр өөрчлөгдсөн. Тэрээр хуучнаа эргэлт буцалтгүйгээр халж зах зээлийн эдийн засагтай ардчилсан улс болох сууриа тавьсан. Нийгмийн аж амьдралыг удирдаж байдаг төрийн байгуулагуудын үйл ажиллагаа нь сайжран бүтээмж нь дээшилж байсан ч зохицуулалт дутагдсанаас үүссэн хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар л байжээ. Хуучны улс төрийн соёл нь өнөөг хүртэл оршсоноор хөгжил дэвшилд хортойгоор нөлөөлсөн.

Латви нь Европын холбоо, Дэлхийн банк, гишүүн улсууд болон бусад байгууллагуудаас тусламж дэмжлэг авч ардчилсан засаглалд суралцсаар байна. Шинэчлэлийн явц удаашралтай байгаа ба энэ нь шинэ зүйлд дасах, шинэ үзэл онолыг хүлээж авах мөн шинэ сэтгэлгээнд шилжих зэргийг шаардсан. Өөрөөр хэлбэл, өөрчлөлт шинэчлэлтэд нийтийг хамарсан сургалт хэрэгтэй. Латви нь бүтэц, зохион байгуулалт болон нийгмийн харилцаандаа туршилт хийж үзсэн болохоор өөрсдийн туулж өнгөрүүлсэн туршлагаас сургамж авч байгаа юм. Латвийн төрийн байгууллагын загвар нь барууны ардчиллынх хэдий ч өөр өөр орчинд сайн судалгаа хийлгүйгээр бэлэн загварыг ул суурьгүй хуулбарласныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Бүх л төрийн байгууллагууд нь үндэсний соёл болон түүхийн давтагдашгүй байдлаас болж өөр өөр байдаг болохоор ямарваа бэлэн загварыг шууд хуулах ямар ч боломжгүй байдаг учраас сайн засаглалын зарчим дээр тулгуурлан өөрийн гэсэн загварыг бий болгох нь чухал.

Дээрх зарчмууд нь ардчиллын үнэт зүйлс дээр тогтдог ба орчин үеийн ардчилсан орнууд энэхүү зарчимд нийцүүлэн оршдог. Европын холбооны гишүүн орнуудтай хамтарч ажиллахын тулд Латви улсын бүтэц, зохион байгуулалт болон дүрэм журмаа Европын төрийн байгууллагуудын орон зайд нийцүүлэх шаардлагатай болсон. Ур чадвар эзэмших, бусадтай харьцуулах болон бусдын хөгжил дэвшил алдаа оноог үнэлснээр өөрийн улсыг дэлхийд өрсөлдөхүйц чадвартай болгох мөн төрийн байгууллагаа нийгмийн эрх ашгийн төлөө үйлчилдэг болгон хөгжүүлэхийг зорьсоор байна.

Нутгийн удирдлага

Латвийн Орон нутгийн удирдлагын тухай хуульд орон нутгийн удирдлагын бүтцийг бүрдүүлэх талаар ямарваа нэг хязгаарлалт байдаггүй бөгөөд харин орон нутаг засаг захиргааны нэгж тус бүрийн хууль нь үүнийг тодорхойлдог. Энэ бүтцийн загварыг доорх зурагт харуулав. Том хот суурин газруудын удирдах байгууллагууд ихэвчлэн газар, хэлтэсүүдэд хуваагддаг бол харин хөдөө, орон нутагт ихэвчлэн тийм хуваагдал байдаггүй. Яагаад гэвэл ердөө 5-7 ажилтантай байдаг. Орон нутгийн нэгж бүрийн засаг захиргааны байгууллагууд өөрийн дотоод удирдлагын бүтэцтэй байдаг.

СУДАЛГААНЫ

Латви улсын орон нутгийн захиргааны зохион байгуулалтын бүтцийн загвар

1994 онд батлагдсан хуулийн дагуу орон нутгийн удирдлагын байгууллагууд нь төрийн иргэний үйлчилгээний албан тушаалын зэрэглэлд багтсан байдаг. Гэвч орон нутгийн захиргааны ажилтнууд мэргэжлийн шалгалт өгдөггүй ба төрийн албаны сургалтад хамрагддаггүй байна. Орон нутгийн захиргааны хууль журамд тухайн засаг захиргааны бүс нутаг бүрт гүйцэтгэх захирлын албан тушаал байх эсэхийг заасан байдаг. Гүйцэтгэх захирал байдаггүй орон нутгийн засаг захиргаанд түүний үүрэг функцийг захиргааны зөвлөлийн хурлаар шийддэг.

1994 оны 01 сарын 13 -нд Saeima “Хот суурин газар, бүс нутаг болон хөдөө, орон нутгийн захиргааны зөвлөлийн сонгуулийн тухай хууль”-ийг баталж гаргасан. Сонгууль 4 жил тутам 3 сарын 13-ны өдөр болдог. Европын орон нутгийн өөрөө удирдах ёсны дүрмийн шаардлагын дагуу нутгийн захиргааны зөвлөлийг сонгуулийн тэгш, шууд, нууц сонгох эрхийн үндсэн дээр пропорциональ системээр сонгодог. Латвид өнөөдөр орон нутгийн зөвлөл дэх иргэдийн төлөөлөгчдийн дундаж тоо баруун европын орнуудынхтай харцуулахад бага.

Орон нутгийн удирдах зөвлөлийн төлөөлөгчдийн тоо нь тухайн нутгийн хүн амын тоотой шууд хамааралтай байдаг.

- 2000 хүртэлх хүн ам – 7 төлөөлөгч
- 2001-5000 хүн ам – 9 төлөөлөгч
- 5001-50000 – 11 төлөөлөгч
- 50000-аас дээш – 15 төлөөлөгч
- Рига хотын зөвлөлд 6 иргэдийн төлөөлөгч байдаг.

Орон нутгийн сонгуулийн хуулиар мөн сонгох эрхийн талаар өөрчлөлт оруулсан. 1989 оны сонгуульд тухайн үеийн Латви ССР-ийн бүх иргэд сонгох эрхтэй байсан. Шинэ хуулиар сонгуулийн өдөр 18 нас хүрсэн доор дурдсанаас бусад Латви Улсын иргэд сонгууль өгөх эрхтэй болсон:

- гэмт хэрэгт сэжиглэгдэн түр хоригдон, шалгагдаж байгаа хүмүүс
- Хуулиар сонгох эрхийн чадамжгүй гэж тодорхойлогдсон хүмүүс
- Иргэн өөрийн хууль ёсоор амьдран суугаа газраа эсвэл өөрийнх нь үл хөдлөх хөрөнгө хууль ёсоор бүртгэгдсэн газраа сонгууль өгөх эрхтэй.

Орон нутгийн зөвлөлийн төлөөлөгчид нэр дэвшигч нь сонгуулийн өдөр 21 нас хүрсэн Лавти Улсын иргэн байх ёстой бөгөөд (1) сонгууль эхлэхээс доод тал нь 12 сарын өмнө тухайн нутагтаа албөн ёсоор оршин суугчаар бүртгүүлсэн байх, эсвэл (2) сонгуулийн өдрөөс өмнө дор хаяж 6 сарын турш тухайн нутагт ажилласан байх, эсвэл (3) тухайн нутагт үл хөдлөх хөрөнгөтэй байх ёстой бөгөөд дараах нөхцөлүүдээс бусад тохиолдолд нэр дэвшиж болно:

- Хоригдож байгаа хүмүүс
- хуулиар нэр дэвшиж болохгүй гэж тусгайлан заасан хүмүүс
- засрашгүй онц ноцтой гэмт хэрэг үйлдсэний улмаас ял эдэлж байсан хүмүүс
- урьд нь КГБ -д ажиллаж байсан эсвэл ЗХУ -ын Батлан хамгаалах яаманд ажиллаж байсан хүмүүс
- Төрийн албан ёсны хэлийг дээд түвшинд (3-р) эзэмшиж чадаагүй хүмүүс

Тайланд Улс

Тайланд Улс харилцагч гадаадын улс орнуудынхаа орон зайд төрийн албаны тогтолцоогоо нийцүүлэх шаардлагыг үндэс болгон төрийн албаны эх газрын загварыг англо-саксоны эрх зүйн загварын зарим элементээр баяжуулан хэрэгжүүлж, удирдлагын төвлөрлийг мэдэгдэхүйц сааруулж чадсан улс юм

Төрийн албаны бүтэц, тогтолцоо эрх зүйн орчин

Тайландын иргэдэд үйлчлэх төрийн байгууллагууд нь бүтцийн хувьд нь хэт төвлөрсөн бус үүрэг чиглэлтэй нутгийн захиргааны болон засгийн газрын төв байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг дараах хуулиудаар зохицуулдаг.

- “Төрийн захиргааны байгууллагын тухай хууль” /Organization of State Administration Act,
- “Засгийн газрын байгууллагын тухай хууль” / The Government Organization Act/,
- “Төрийн иргэний албаны тухай” The Civil Service Act.

“Төрийн захиргааны байгууллагын тухай” хуулиараа яамдуудын нэр тоо болон яам бүрийн нэгж, хэлтэс албадуудыг тодорхойлж өгсөн бөгөөд тэдгээрийн үүрэг чиглэлүүд нь тухайн хуулинд тодорхойлогдсон байдаг. 1991 оны “Төрийн захиргааны байгууллагуудын тухай” хуулиар иргэний 14, батлан хамгаалах 1, нийт 15 яамтай байхаар тусгагдсан. Эдгээр нь 125 агентлагуудтай байна.

“Төрийн иргэний албаны тухай ” хуулинд төрийн албан хаагчдын эрх, нөхөн олговор, албан тушаал дэвших, үүрэг, хариуцлагыг тодорхойлж өгсөн байдаг. Мөн ирээдүйд төрийн алба хаагчдын учирч болох эрсдэл, зайлшгүй хийгдэх ажиллагаа, сургалт, боловсрол зэрэг ирээдүйг харж хийсэн заалтууд тусгагдсан. Тус хуулинд төрийн албан хаагчдын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төрийн албанд ажиллагсдын удирдан зохион байгуулах

UIH.MN
ЭРҮҮЛГЭЭНИЙ ИХСАН

чадвар, удирдах ажилтнуудын эрх үүргийг тодорхой тусгаж өгснөөр албан хаагчдын эрх үүргийн нэгдлийг хангаж, эрх зүйн болон ажил үүрэг, хариуцлагын хийдэл гаргахгүй байх боломжыг бүрдүүлж өгсөн байна. Мөн хуулиар иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааны менежмент, төрийн үйлчилгээний концепци, байгууллагуудын ажилтнуудын хүний нөөц, албан тушаал зэргийг хуульчилсан байна.

Нийгэм, эдийн засаг, олон улсын шинэчлэлт өөрчлөлтийг дагаад энэ хуулинд байнгын өөрчлөлт шинэчлэлт, засвар оруулж ирсэн байна. Хуулийн хэрэгжилт, алба хагчдын хууль дээдлэх сахилга бат нь тухайн улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдахаас гадна, иргэд олон нийтийн зан заншил, соёлын үнэт зүйлд тулгуурласан ёс суртхууны хэм хэмжээ голлох байр суурьтай. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тухай энэхүү хуулиуд нь тус байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах, авилга хээл хахууль, хүнд суртал гаргахгүйгээр иргэдэд үйлчлэх тухай тодорхой хэм хэмжээнүүдийг тусгасан байдаг.

Төрийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны хувьд тодорхойлсоныг үзвэл:

Засгийн газрын төв байгууллагууд нь 14 яам 125 агентлагаас бүрдэх бөгөөд бүх яамдууд байнгын нарийн бичгийн даргын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулна. Улсын нийслэл Бангкокт төв аппаратуудын байр нь байрлах ба төвлөрсөн удирдлагаар хангана.

Бүсийн засаг захиргаа буюу энэ байгууллагыг бүс нутгийн захирагч удирдах бөгөөд төвлөрсөн бус бодлого үйл ажиллагаатай. Улсын нэгдсэн бодлого, хөтөлбөрүүд Засгийн газрын төв байгууллагууддаа боловсруулагдаж түүний дагуу ямар шийдвэрийг тухайн бүсийнхээ онцлогт тохируулан гаргах нь бүсийн засаг захиргааны шийдвэрлэх асуудал бөгөөд энэ эрхэнд нь хөндлөнгийн ямар нэгэн нөлөөлөл байхгүй. Нутгийн захиргааны байгууллага буюу нутгийн өөрийн удиодлагын байгууллага нь нутаг дэвсгэртээ төрийн эрх мэдлийг бие даан, хараат бусаар хэрэгжүүлнэ. Энэ нь үндсэн 2 төрөлтэй байдаг.

1. Орон нутаг, хотын захиргаа
2. Бангкок зэрэг томоохон хотууд болон Паттаяа хотын гэх мэт.

Төрийн эдгээр байгууллагууд нь өөр хоорондоо ямар ч нөлөөлөлгүйгээр бие даасан/ санхүүгийн болон эрх мэдлийн хувьд/ үйл ажиллагаа явуулдаг. Засгийн газрын төв байгууллагаас бодлого боловсруулах, хууль батлан гаргах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, тухайн гаргасан эрх зүйн хэм хэмжээний хүрээнд бүс нутгийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөр өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэртээ зохих шийдвэрүүдийг хуулийн хүрээнд гаргаж түүнийгээ нийт харьяа нутаг дэвсгэртээ дагаж мөрдүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй. Бүс нутгийн засаг захиргааны байгууллагыг тухайн бүсэд хамаарах хот, тосгод, орон нутгийн иргэдийн шууд санал хураалтаар, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг тухайн хот, тосгон, орон нутгийн нийт иргэдийн шууд санал хураалтаар тус тус сонгоно.

Төрийн албаны менежмент

Тус улсын төрийн албаны байгууллагууд болох “Төрийн иргэний албаны комисс” /Civil Service Commission/, “Үндэсний нийгэм эдийн засгийн хөгжлийн газар” /National Economic and Social Development Board (NESDB)/, “Төсвийн товчоо” /Bureau of the Budget (BoB)/ нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд түүний удирдлага дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд дээрхи 3 байгууллагын тэргүүнүүд нь ажлаа шууд Ерөнхий сайдад тайлагнана.

Эдгээр 3 төв байгууллагын үүрэг нь бодлого боловсруулах, хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг хийх болон төсвийн удирдлага зохион байгуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Энэ байгууллагуудаас бусад бүх байгууллагууд мэргэшсэн тогтвортой байж харьяа яам, агентлагуудын дарга нарт ажлаа тайлагнана. Төрийн байгууллагын үйл

ажиллагаа ямагт төрийн улс төрийн албан тушаалаас хараат бусаар оршин тогтнож, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байх ёстой.

“Төрийн иргэний албаны комисс”-ын чиг үүрэг:

- Засгийн газрын кабинетийн гишүүдэд төрийн албан хаагчдын бие бүрэлдэхүүн, орон тоо, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой асуудлууд, төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, байгууллагуудын хөгжил, хүнд суртлыг арилгах болон нөхөн олговор, нийгмийн хамгааллын талаар зөвлөх
- Иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх бодлогыг боловсронгуй болгож хүний нөөцийг хөгжүүлэх
- Хүний нөөцийн удирдлагыг зохион байгуулах хүрээнд үйл ажиллагаандаа удирдлага болгох эрх зүйн хэм хэмжээнүүдийг боловсруулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, албан хаагчдын алдааг засаж, ололтыг хөгжүүлэх, албан тушаалын зэрэг дэв, цалинг тогтоох, төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах, ажиллуулах, алба хаагчдын эрхийг хангах, гомдлыг шийдвэрлэх, хариуцлага тооцох, тэднийг урамшуулах, хөхиүлэн дэмжих мэдлэг чадварыг дээшлүүлэх бүхий л арга хэмжээг авах
- Төрийн алба хаагчдыг ялгаварлан гадуурах явдлаас сэргийлж, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах, төрийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмж, нэмэгдэл цалин, хангамж, нөхөн олговорын асуудлыг хариуцан шийдвэрлэх
- Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг аль болох чирэгдэлгүй, хөнгөн шуурхай соёлч боловсон үйлчлэх талаар анхаарч ажиллах гэх мэт үүргийг хүлээдэг. Энэ алба нь нарийн бичгийн даргын удирдлага доор үйл ажиллагаагаа явуулна.

“Нийгэм эдийн засгийн хөгжлийн алба”-ны чиг үүрэг:

- Улсын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж Үндэсний нийгэм эдийн засгийн хөгжлийн хороонд тайлангаа хүргүүлэх, тэдэнд эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах талаар санал дэвшүүлэх
- Засгийн газрын агентлагуудын болон төрийн өмчит аж ахуйн байгууллагуудын эдийн засгийн хөгжлийг хангахтай холбоотой авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээнүүдийг үзэж судлан үнэлэлт, дүгнэлт өгөх бөгөөд эдийн засгийн хөгжлийн бодлого нь ерөнхийдөө үндэсний баялаг, чухал хүчин зүйлсийг багтаасан эсэх талаар хянан магадлана.
- Төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн байгууллагуудын тухайн жилийн төсвийн хүрээнд хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, гадаадын зээл тусламж авах зэргээр хамтын ажиллагааг хангах
- Улс орны хөгжлийн зэрэгцээ нөхөн сэргээгдэхгүй баялагыг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх эрэл хайгуул хийх
- Төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн байгууллагуудын гадаадын зээл, тусламж авах ажилд дэмжлэг үзүүлэх шаардлагатай тохиолдолд баталгаа гаргаж өгөх.
- Төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн байгууллагуудын хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх.

“Төсвийн товчоо”-ны чиг үүрэг:

- Төсвийн бодлого төлөвлөгөөг боловсронгуй болгох
- Засгийн газрын төсвийг боловсруулах, түүнд санал оруулах
- Төрийн байгууллагуудын төсөв түүний гүйцэтгэлд хяналт тавьж энэ талаархи

мэдээллээр Засгийн газар болон кабинетийн гишүүдэд мэдээлэх

- Кабинетийн гишүүдийн шаардлагаар санхүү, төсөвтэй холбоотой саналаа гаргах гэх мэт.

Төрийн албаны шинэтгэл, туршлага, хэрэгжилт, үр дүн

Тайланд улс дэлхийн олон улс үндэстнүүдийн нэгэн адил техник, технологийн хөгжил дэвшилд хөл нийлүүлэн оролцож тэдний нөлөөлөлд орсон улс мөн. Гадаад харилцаа, худалдаа хамтын ажиллагааны хувьд тус улс нь нээлттэй өргөн хүрээтэй бодлого баримталдаг бөгөөд харилцагч орнуудаас нийгмийн интеграцичлал, ёс суртахууны асуудлаар болон, хүнд суртлыг багасгаж, улмаар арилгах талаар зөвөлгөө, санууулга олон удаа өгч байсан. Тиймээс ч улс төр, эдийн засаг, нийгмийн шинэ шинэ харилцааг зохицуулах, зохион байгуулах шаардлагаар төрийн албаны шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлага урган гарч байдаг.

Нийгэм эдийн засгийн үйл явц дахь төрийн оролцоо, төрийн үйлчилгээний хүнд суртал зэрэг нь тус улсыг бусад орнуудтай олон улсын түвшинд харилцах явдалд сөргөлдөөн рүү түлхэж байгааг гүнээ ухамсарлан, дээрхи байдлыг засан сайжруулах зорилгоор тохиромжтой шинэтгэлийн хувилбарыг дэвшүүлэн хэрэгжүүлэх ажил нь цаашдын хөгжил дэвшилд ахиц болно гэж үзэн, эдийн засгийг хөгжүүлэх, хувийн секторын цэцэглэн хөгжих боломжийг бүрдүүлэх зорилтыг өмнөө тавьж шинэтгэлийг хийхийг зорьж байна.

Тайланд улсын тухайд төрийн албаны шинэчлэлийг байнга хийж ирсэн бөгөөд хамгийн том гэж хэлж болох шинэчлэлийг 4-р Рама хааны үед буюу 1868-1910 оны хооронд хийсэнгэж үздэг. Тухайн үед төр барьж байсан засгийн газрын бодлого шийдвэрэр шинэчлэлийн бодлого хэрэгжиж байжээ. Тухайн үеийн засгийн газрын цэвэр бус байдал, хаалттай тогтолцооноос улбаатайгаар шинэчлэл нь олны нүдэнд ил харагдахуйц өөрчлөлтийг авчраагүй ба энэ нь шинэчлэлийн утга агуулгад үл тохирох систем байжээ.

Шинэ үеийн Засгийн газрын шинэчлэлийн бодлогод төрийн албаны өөрчлөлт шинэчлэл нь тэргүүлэх байр суурьтай байж ирсэн. Энэ нь ерөнхийдөө хүнд суртлыг арилгах, түүнтэй тэмцэх албаны бүтэц зохион байгуулалтыг тодорхойлж үйл ажиллагааг нь жигдрүүлэхэээс эхэлсэн гэж үзэж болно. Энэ албыг Ерөнхий сайдын орлогч толгойлдог бөгөөд Төрийн иргэний албаны нарийн бичгийн дарга нь тус хорооны нарийн бичгийн даргын албыг давхар хашдаг байна. 1991 онд нийт иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн Төрийн иргэний албаны шинэчлэлд томоохон хувьсгал хийсэн гэж болно. Энэ нь тухайн үед Ерөнхий сайдын албыг хашиж байсан Анан Паниракуны удирдлага дор хийгджээ.

- **Ботсван Улс.**

Ботсван Улсын төрийн албаны загвар нь эх газрын Францын загварыг өөрийн орны нөхцөлд тохируулан буулгасан хувилбар юм. Ботсван Улсын Төрийн албыг Төрийн албаны удирдлагын газар /Directorate of public service management DRSM/ гэдэг. Төрийн албаны удирлагын газар нь дор дурдсан бүтэцтэй байна.

Төрийн албаны бүтцийн схем

Мэдээлэл холбооны технологийн хэлтэс нь Төрийн үйлчилгээний удирдлагын газарт мэдээллийн технологийн эрдэл дагуулсан хэд хэдэн үйл ажиллагааг нэвтрүүлж, тэдгээр нь төрийн албаны удирлагынг хэрэглэгчид шуурхай хүргэхэд эргэлт авчирсан. Түүнд ажиллагдын удирдлагын компьютержүүлсэн систем, мэдээллийн технологийн тусламжийн ширээ/IT-Help Desk/ хамрагдана.

Хүний нөөцийн удирдлагын хэлтэс нь төрийн албаны үр дүн бүхий удирпдлагыг тогтовортой байлгах, ажлын нөхцлийг бүрдүүлэх, төрийн албаны нэгдмэл цул байдлыг хангах, албан хаагчдын оюун санааны бэлэн байдлыг хангаснаар бүтээмжийг өндөр байлгах Үйлчилгээний удирдлагын хэлтэс нь төрийн албанд тасралтгүй, удаан жил ажиллах нь ашигтай бөгөөд бүхий л түвшинд дасч зохицох боломжтой гэдгийг итгүүлэх үүрэгтэй. Хүний нөөцийн төлөвлөлт, төсөв, судалгааны хэлтэс нь Төрийн секторыг ажиллах хүчнээр хангах, хөгжүүлэх,яам агентлагуудын төрийн захиргааны ажлын чиг үүргийг биелүүлж чадахуйц ажиллах хүчнээр бэхжүүлэх, хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгдсэн үйлчилгээний хэлтэс нь Төрийн үйлчилгээг захиргааны удирдлагаар хангах, Төрийн үйлчилгээний удирдах газрын хөдөлмөрийн болон санхүүгийн нөөцийн үнэлгээг гаргах Төрийн албаны хөгжил, сургалтын хэлтэс нь Төрийн албан хаагчдын сургалтын бодлогыг боловсруулах, хөдөлмөрийн нөөцийн хөгжил, сургалтыг зохион байгуулна. Төрийн албаны удирдлага нь хүний нөөцийг хөгжүүлэх техникийн үйлчилгээг хүлээн авахаас гадна, гадаад хамтрагчдын талаарх үйлчилгээг хүлээн авна.

Үйлдвэрлэлийн хүний нөөцийн хэлтэс нь хөдөлмөрийн харилцааны асуудал нь төрийн үйлчилгээтэй нийлэмжтэй үйлдвэрлэлийн ажиллагчдаар зохих дүрэм журмын дагуу хангах үүрэгтэй. Нөхөн олговор, хөнгөлөлтийн хэлтэс нь Төрийн албан хаачдын нөхөн олговор хөнгөлөлтын асуудлыг хариуцна. Боловсон хүчнийг ажилд авах, байршуулах хэлтэс нь боловсон хүчний бодлогыг хөгжүүлэхэд чиглүүлж, боловсон хүчнийг ажилд авах, байршуулах яам агентлагуудад төрийн албаны батлагдсан орон тоонд юуны өмнө төрийн албаны үр ашигтайг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийг элсүүлэх нөхцлийг ханган тохирсон мэргэжлийн чиглэлийн хүмүүсээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан хэлтсүүдээс заримынх нь дэлгэрэнгүй чиг үүргийг дурдвал:

Мэдээлэл холбооны технологийн газар нь Хүний нөөцийн мэдээллийн технологийн бодлогыг боловсруулахдаа дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн технологийн дэвшилтэт бодлого,

стратегийг нэвтрүүлэх;

- Системийн өгөгдлүүдэд нэвтрэх боломж, түүний аюуулгүй байдлын хяналттай холбоо бүхий дэг журмыг боловсруулах, хэрэгжүүлэх;
- Хүний хөгжлийн удирдлагын үр өгөөж бүхий системийг ашиглаж, хөгжүүлэхдээ түүний чанарын шаардлагыг хангаж, баталгаажуулахын тулд Хүний хөгжлийн удирдлагын ашиглагч нь бодлого боловсруулах чанартай өгөгдлүүдтэй байх нөхцлийг бүрдүүлэх, цаашид өргөжүүлэх;
- Техник хангамжийг зохицуулах ;

Дэд бүтцэд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх хүрээнд; - Сүлжээний дэд бүтцийг үр ашигтай, тогтвортой ажиллуулахын тулд байнга хянан шалгах хүрээнд;

- Толгой компьютер болон тооцоолон бодох системийн ажлын машин, түүний туслах төхөөрөмжүүдийн хэвийн ажиллуулах
- Төрийн албаны удирдах газраас яамдын хүний нөөцийн удирдлагын системд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой интернет протоколын LAN, WAN –ны удирдлагыг хэрэгжүүлэх;
- Яамдад хүний нөөцийн хүний нөөцийн удирдлагын системтэй холбоотой дэмжлэгийг газар дээр нь үзүүлэх;

Бусад дэмжлэгийн хүрээнд;

Software программ хангамжийг дэмжих, шинэ төхөөрөмжийг нэвтрүүлж жигдрүүлэх болон бусад; Тухайлбал

- хүний нөөцийн удирдлагын инфинум дүрэм журмыг хэрэгжүүлэх
- шинэ мэдээлэл суулгах
- эцсийн хэрэглэгчдэд туслах
- тайлан гаргах

Шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг худалдан авах, хуваарилахдаа:

- -Хүний нөөцийн удирдлагын системийн ашиглалтын нөхцөл, дэд бүтцийн байдлын дүн шинжилгээ хийх;
- -Тоног төхөөрөмжийг хайх, олж авахдаа Засгийн газрын компьютерийн товчоо, Төрийн худалдан авалтын газар, Үл хөдлөх хөрөнгийн захиран зарцуулалтын газартай зөвлөлдөх;
- -Засгийн газрын компьютерийн товчоотой хамтарч гадаад системийн зөвлөхүүдийн асуудлыг шийдвэрлэх,
- Эцсийн хэрэглэгчдийн сургалт, хөгжлийн асуудлыг зохион байгуулах:
- -Засгийн газрын компьютерийн товчооны зөвлөмжийн дагуу Хүний хөгжлийн удирдлагын эцсийн хэрэглэгчдийн сургалтын зарчим, дэгийг Хүний хөгжлийн удирлагын газар, яам, агентлагийнхтай нэгэн адил боловсруулах;
- бүх шатны Хүний нөөцийн удирдлагын эцсийн хэрэглэгчдийн сургалтыг хүний нөөцийн системд ашиглагддаг эрх мэдлийн хөгжлийг хангахуйцаар байнга зохион байгуулах
- Сураглт явуулсан тренер-сургагч багшийн ажлын хөлсийг сургалтын чанар, удирдлагын мэдлэгийн түвшин г харгалзан үнэлж тогтоох
- Хүний нөөцийн бодлого, мэдээллийн бүх архив, бичиг баримт, өгөгдлийн дата бааын удирдлагын системийг боловсруулах
- Протоколын хайлт, аюулгүй байдлын системийн өгөгдлүүдийн шинжилгээ хийх

- Дэд бүтцийн үйл ажиллагааны практик дахь холбоо, мэдлэг, мэдээлэл солилцох, хамтран ажиллах бололцоог группчилсэн системийн интеллектуаль хуанлийн тусламжтайгаар хөгжүүлэх г.м.

Нөхөн олговор, тэтгэмжийн хэлтэс нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ Чиглэл, төсөөлөл, зохицуулалтын захиргааны цалингийн бодлогын хүрээнд;

- Хүний нөөцийн бодлогыг дэмжих, хөгжүүлэх, цалингийн бүтэц, захиргааны удирлагын талаар шуурхай чиглэл өгөх
- Батлагдсан цалин хөлсний бүтцийг мөрдүүлэхийн тулд түүнийг зохицуулах, удирдах, хянаж шалгах, шинжилгээ хийх, үнэлэлт өгөх
- Төрийн цалин хөлсний бүтцэд нөлөөлөхүйц өөрчлөлтийн талаарх найдвартай эх сурвалжийг цуглуулахын тулд нөхөн олговрын судалгаа хийх
- Үйлчилгээний ажлын хөлс, цалин хөлсний тавилт, хөнгөлөлт, тусламж олголтын нийгмийн бүтэцтэй холбоо бүхий асуудлын чиг хандлага, мэргэжлийн чиг баримжааг хангах, цалин хөлсний тоймын чиглэлээр засгийн газраас байгуулагдсан комисст тусламж үзүүлэх

б/ үйлчилгээний үр дүнгийн талаарх нийгмийн үнэлгээний хүрээнд

- Үнэлгээний тогтолцооны талаар хэлэлцүүлэг , боловсруулалт, томъёолол боловсруулах
- Үйлчилгээний удирдлагын хэлтэстэй хамтран төрийн үйлчилгээний ажлын байр тус бүрээр бүтээмжийн тоон болон чанарын стандартыг боловсруулах
- Яамдад төрийн албаны ажлын байрны бүтээмжийг стандарт боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Аттестатчлын системийг оновчтой, өгөөжтэй байлгахын тулд үе үе шинэчилж байх
- Яам агентлагуудад үнэлгээний системийн талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх
- Аттестатчлын системийн үр өгөөжийн үнэлгээ, хяналт шалгалт хийх

Тэтгэмжийн хэсэг

- Удирдлагын терминалуудын төрийн үйлчилгээний бодлого түүнчлэн удирдлагын шуурхай байх зарчмыг боловсруулах, зохицуулах
- Яам, агентлагуудаас нийтийн үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжлийн чиг баримжаа болон тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг хангах,
- Төрийн тэтгэврийн үйлчилгээ, тэтгэврийн сан, тэтгэврийн нөөц сангийн хууль дүрмийн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Тэтгэврийн сангийн захиргаатай хамтран ажиллах, төсөл, үнэлгээнд дүн шинжилгээ хийх
- Төрийн албаны батлагдсан орон тоо, ажлын байрны агуулга, шаардлагыг системтэй шинжилгээний арга зүйн үндсэн дээр боловсруулах
- Төрийн албаны албан тушаалын заавар, ангиллын стандартыг боловсруулах, төрийн үйлчилгээний ажлын агуулгын шинжилгээ хийх
- Албан тушаалын хамгийн сүүлд батлагдсан ангилал, зааврыг дэмжиж, мөрдлөг болгох
- Үйлчилж байгаа албан тушаалын зааврыг тодорхой хугацаанд задлан шинжилж, илүү үр ашигтай системийг боловсруулах, нэвтрүүлэх
- Төрийн албаны үнэлгээний найдвартай системийг боловсруулах, нэвтрүүлэх

UIP.MN
СУДАЛГААНЫ САН

- Мөрдөж байгаа ажлын байрны зэрэглэлийг тогтоохдоо батлагдсан үнэлгээний аргыг хэрэглэх
- Төрийн албыг давтан ангилах, зэрэглэхдээ үнэлгээний системийг баримтлах
- Төрийн албаны мөрдөгдөж байгаа цалин хөлсний бүтэц, сүлжээний бодитой эсэх асуудлаар техникийн зөвлөгөө өгөх

Хүний нөөцийн удирлагын хэлтэс нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүний нөөцийн удирдлагын хүрээнд:

- Захиргааны боловсон хүчний бодлого, удирдлагын шуурхай байх зарчимтай холбоо бүхий асуудлаар арга зүйн зөвлөгөө, удирлагаар хангах, энэ чиглэлээр зохицуулах, боловсруулах
- Бүх нийтийн ерөнхий үйлчилгээтэй холбоотой боловсон хүчний удирдлагын асуудлыг ерөнхий удирлагаар хангах

Үйлчилгээний нөхцлийн удирдлагын хүрээнд:

- Төрийн албаны тухай хуулийн боловсон хүчний удирдлагатай холбогдох заалтуудыг оновчтой хэрэглэх, тайлбарлах нөхцөл,
- Төрийн албаны боловсон хүчний хөдөлмөрийн нөхцөл, гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх
- Төрийн албаны тухай хууль, хүний нөөцийн талаарх чиглэл гэх мэт ерөнхий дүрэм журам болон төрийн албаны тухай хуулийг тайлбарлах
- Төрийн үйлчилгээний дүрэм журам түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт зэргийг сурталчлах, тайлбарлах зааварчлах чиглэлээр боловсон хүчин бэлтгэх
- Хүний нөөцийн удирдлагын хэлтсээс яам, газруудад тодорхой үүрэг гүйцэтгэх бүрэн эрхэт төлөөлөгчийг томилон ажиллуулах
- Төрийн үйлчилгээний хүрээнд хүний нөөцийн удирдлагын шинэ чиглэлийг практикт нэвтрүүлэх

Хүний нөөцийн удирдлагын боловсон хүчнийг сонгох, судлах хүрээнд:

- Боловсон хүчний бодлогын ерөнхий байдал, удирдлагын зарчим, дүрэм нь үр дүнтэй, ач холбогдолтой хэвээр байх нөхцлийг бүрдүүлэх
- Яам, агентлагуудтай боловсон хүчний бодлого, систем, дүрэм журмыг хэрэгжүүлэх хүрээнд байнгын идэвхитэй эргэх холбоотой ажиллах
- Төрийн албыг идэвхитэй, гүйцэтгэх чадамжтай, үр ашигтай байлгахад чиглэсэн судалгаа явуулах

Нийгмийн халамж, үйлчилгээ, аюулгүй ажиллагааны хүрээнд:

- Төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг практикт хэрэгжүүлэх
- Төрийн албаны ажилтнуудын ая тухтай ажиллах, нийгмийн хангамжийн шаардлагыг иж бүрэн хангахуйц нөхцлийг бүрдүүлэх
- Ажиллагчдын биеийн эрүүл мэндийн байдал нь дүрэм журамд заасан нөхцлийг хангах
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах
- Төрийн албаны харьцааны дүрмийн хүрээнд:
- Төрийн албанд үнэнч шударга хандах зорилгыг хангахын тулд харьцааны тухай хууль дүрмийг боловсруулах, мөрдүүлэх, зохицуулах

- Төрийн албаны сахилга дэг журмын хэрэгжилтийг шалгах, үр дүнг үнэлэх, харьцааны тухай хуулийг хянаж үзэх
- Яам, агентлагуудад төрийн албаны нийтлэг харилцааны бүхий л асуудлаар чиглэл, зааварчлага өгөх
- Яам, агентлагуудад төрийн албаны тухай хууль, сахилга, өргөдөл гомдолтой холбоотой дүрэм, чиглэл, ерөнхий журам зэргийг хэрэглэх, хэлэлцүүлэг явуулахад тусламж үзүүлэх
- Өргөдөл гомдлыг задлан шинжлэх, шаардлагатай үед нэмэлт мэдээлэл авах
- Дарга нараас оногдуулж байгаа сахилгын шийтгэлд зөвлөгөө өгөх
- Ерөнхийлөгчөөс зарим чиглэлээр уучлал үзүүлэх асуудлаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт болон яамдад зөвлөгөө өгөх
- Төрийн албаны тухай хууль/дүрэм, ерөнхий журам/-ийг хэрэглэх, хэлэлцүүлэг хийхэд Төрийн албаны комисст зөвлөгөө өгөх
- Давж заалдсан тохиолдолд Төрийн албаны комисст нарийн бичгийн даргын үйлчилгээ үзүүлэх
- Хөдөлмөрийн харилцааны хүрээнд:
- Төрийн албаны зөвлөх нэгжийн ажилтнуудыг дэмжих, удирдах, зохицуулах болон Ботсваны иргэний албаны холбоо(BCSA), Зөвлөх зөвлөлийн нэгдсэн төв штаб(CJSCC)-тай холбоотой ажиллах
- Үйлдвэрлэлийн харилцаа, үйлчилгээний бүх түвшин дэх асуудлаар мэргэжлийн удирдлага чиглэлээр хангах
- Зөвлөх зөвлөлийн нэгдсэн төв штаб(CJSCC)-т нарийн бичгийн даргын үйлчилгээ үзүүлэх, төрийн албаны хөдөлмөрийн харилцааны нэгдмэл байдлыг хангах
- Төрийн албаны аттестатчлалын хүрээнд:
- Албаны аттестатчлалын системийг боловсруулах, дэмжих, удирдах
- Төрийн албаны ажлын байр тус бүрээр тоон болон чанарын стандартын талаар Удирдах газрын үйлчилгээний удирдлагын хэлтэстэй нягт хамтран ажиллаж цаашид хөгжүүлэх
- Төрийн албаны ажлын байрны бүтээмжийн стандартууд нь батлагдахдаа сайтар боловсруулагдсан байх шаардлагыг хангах, аттестатчлалын дүн нь үр дүнд хүрэхүйц байх
- Төрийн албаны албан тушаал дэвшүүлэх төлөвлөгөөний хүрээнд:
- Төрийн албаны боловсон хүчний ажлын байр тус бүрээр батлагдсан ажлын байрны ангилал, зааврын үндсэн дээр албан тушаал дэвшүүлэх үндэслэлтэй төлөвлөгөө боловсруулах
- Албан тушаалд дэвшүүлэх төлөвлөгөөг баталгаажуулж, бүх хэрэглэгчдээд ил тод мэдээлэх
- Мэргэжлийн чиг баримжаа олгох, төрийн албаны албан тушаал дэвших төлөвлөгөө түүнийг үр дүнтэй хэрэгжүүхтэй холбоотой бүх асуудлыг чиглүүлэн дүн шинжилгээ хийх, зохицуулах

Төрийн албаны терминал ба тэтгэврийн асуудлын хүрээнд:

- Төрийн албаны терминал ба тэтгэвэр хөнгөлөлт, шуурхай удирдлагын зарчмуудыг зохицуулах бодлогыг боловсруулах, удирдлагаар хангах, зохицуулах
- Яам, агентлагуудад алба хаахыг зогсоох, огцруулах, гэрээний хугацаа дуусгавар болох, тэтгэвэрт гарах, ажлаас халагдах, албан тушаалыг үгүй болгох зэрэгтэй холбоо бүхий асуудлаар чиглэл, мэргэжлийн чиг баримжаагаар хангах
- Төрийн албаны цалингийн бүтэц, цалин хөлсний удирдлагын асуудлаар:

ОНЕ.MN
СУДАЛГААНЫ САН

- Захиргаа, цалингийн бүтцийн шуурхай удирлагатай холбоотой төрийн бодлогыг дэмжиж, хөгжүүлэх
- Батлагдсан цалингийн бүтэц нь шаарлага хангаж байга эсэхийг зохицуулах, удирдах, хянан шалгах, дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт гаогах
- Төрийн цалин хөлсний бүтэц, удирдлагад нөлөөлөхүйц өөрлөлтийн талаарх найдвартай баримт өгөгдлийг цуглуулж, задлан шинжилж, нөхөн олговор олгох
- Цалин хөлсийг өөрчлөх үүрэг бүхий Засгийн газрын комиист тусламж үзүүлэх, цалингийн бүтэц, цалин тавилт, хөнгөлөлт, тусламжийн мөнгөний олголттой холбоотой асуудлаар мэргэжлийн чиглэл өгөх, чиг баримжаагаар хангах

Ботсван Улсын нутгийн өөрийн удирдлага Ботсван Улсын нутгийн өөрийн удирдлагыг 10 дүүргийн зөвлөл, Габороне, Франкстоун/Francistown/, Лобаце/Lobatse/, Селеби-Пикве / Selebi - Pikwe/ гэсэн 4 хотын зөвлөл хэрэгжүүлдэг..

Дүүргийн гүйцэтгэх эрх мэдлийг төв Засгийн газраас томилогдсон дүүргийн комиссар дүүрэг тус бүрт хэрэгжүүлдэг.Бүрэн эрхэт төлөөлөгч нь дүүргийн зөвлөл, Дүүргийн хөгжлийн хороотой хамтран чиг үүргээ хэрэгжүүлдэг байна. Дүүргийн хөгжлийн хорооны гишүүдийн зарим нь сонгогдох ба зарим нь томилогддог байна. Ботсванд уламжлалын дагуу “Кготла” гэж нэрлэгдэх тосгоны/омгийн/ зөвлөл ажиллаж нийтийн хурал зохион байгуулан оршин суугчдын саналыг сонсдог байна.

Монгол Улсын төрийн албаны тогтолцоо, эрх зүйн орчин, шинэтгэл
/Нөхцөл байдлын шинжилгээ/

Монгол улсын төрийн албаны тогтолцоо, бүтцийн схем

Монгол улсын төрийн албаны тогтолцоо нь Үндсэн хууль болон Төрийн албаны тухай хууль, түүнд холбогдох төрийн засаглалын салаа мөчирт хамаарагдах салбарын 40 гаруй бие даасан хууль болон тэдгээрийн үндсэн дээр баталсан хуульчилсан актуудаар тодорхойлогдох нь гарцаагүй. Харин Төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүд “төрийн алба улс төрөөс хараат, төрийн албан хаагчид улс төрчдийн ивээлд ажилладаг SPOIL тогтолцоо хэвээр хадгалагдсаар байна”[103] гэснээс үзэхэд төрийн албан дахь томилгоогоор төрийн албаны тогтолцоог авч үздэг хандлага бас байдаг бололтой.

Үүгээр бол дээд шатны байгууллагадаа захирагдах, дээрээс доош чиглэсэн буюу босоо удирлагын тогтолцоотой улс орон бол Монгол Улс мөн юм. Энэ нь төрийн албаны тухай болон салбарын бусад бие даасан хуулийн зохицуулалтаас ч харагддаг. Харин судлаач миний зүгээс Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж Монгол улсын төрийн албаны бүтэц, тогтолцоог тодорхойлохыг зорив.

Тиймээс төрийн албаны тогтолцоо болон бүтцийн схемийг нарийвчлан гаргахын тулд “Монгол улсын төрийн албаны тухай” /цаашид Төрийн албаны тухай гэх/ хууль болон холбогдох бусад хуулийг сайтар шинжлэн судлах шаардлага тулгарч байна. Юуны өмнө, төрийн албаны тогтолцоо болон бүтцийн ерөнхий бүдүүвчийг гаргахын тулд “төрийн алба” гэдэг ойлголт болоод “төрийн албаны хамрах хүрээ”-г тодорхойлох нь чухал. Төрийн албаны тухай хуулийн 3.1-т “Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ” гэж томъёолсон байдаг. Энгийнээр тайлбарлавал:

[103] Салбарын хууль тогтоомжийг оролцуулан

Холбогдох хууль тогтоомжоор эрх олгосон субьект нь хуулиар өөрт нь олгосон бүрэн эрхийн хүрээнд мөн хууль, хуульчилсан актаар тогтоосон журмын дагуу төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааг ТӨРИЙН АЛБА гэжээ.

Төрийн албаны хамрах хүрээг хуульд зааснаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- төрийн улс төрийн алба
- төрийн захиргааны алба
- төрийн тусгай алба
- төрийн үйлчилгээний алба.

Өөрөөр хэлбэл, хуульд заасан дээрх төрийн албаны ангилал нь төрийн албаны хамрах хүрээг илэрхийлэх бөгөөд маш товчхондоо төрөөс бүрэн санхүүжих болон санхүүгийн дэмжлэг аван төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүхий л салбар нь төрийн албаны хамрах хүрээг бүрдүүлж байна.

Үүнд төрийн:

- Хууль тогтоох
- Гүйцэтгэх
- Шүүх эрх мэдэлд хамаарах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч бүхий л субьект нь “төрийн алба” хэмээх үндсэн ойлголтыг бүрдүүлэх бөгөөд дээрх 3 эрх мэдэлд хамрагдах бүх л субьект нь төрийн албаны тогтолцоог бүрдүүлж байна.

Төрийн албаны бүтцийг бүдүүвчлэн үзэж бүтцийн схемийг гаргах бол дараахь 2 байдлаар схемчилж болохоор байна. Үүнд:

- ✓ Төрийн албаны ангилалаар нь авч үзсэн ерөнхий бүдүүвч
- ✓ Төрийн алба гүйцэтгэх эрх бүхий субьектээр авч үзсэн төрийн албаны бүтцийн бүдүүвч гэсэн 2 хэлбэрээр гаргаж болохоор байна.

Төрийн албаны ангилалаар нь авч үзсэн тогтолцооны ерөнхий бүдүүвч

Зураг 1-ээр үзүүлсэн төрийн албаны бүтцийн ерөнхий бүдүүвч нь төрийн албыг ангилалаар нь харуулсан бүтцийн хамгийн энгийн зураглал юм. Түүнчлэн төрийн албыг засаглалын 3 салаа мөчирт ангилагдах байдлаар нь зураглан үзүүлж болох хэдий ч энэ нь хамгийн ойлгомжтой зураглал тул хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй субьектээр нь нарийвчлан үзүүлсэн бүтцийн зураглалийг /Зураг 2-оор/ үзүүлэв.

UIH MN
СУДАЛГААНЫ САН

Аль ч улс орны хувьд төрийн алба, төрийн албаны бүтэц, тогтолцоо гэдэг нь нүсэр бүтэцтэй байдаг нь энэ судалгааг хийх явцад ажиглагдаж байлаа. Тухайлбал бусад улс орны төрийн албаны тогтолцоо болоод түүний бүтцийн схемийг хайх бүрт нарийвчилсан бүтцийн схем төдийлөн олдоогүй бөгөөд ихэвчлэн Төрийн захиргааны төв байгууллагын дотоод бүтцийн схем тааралдаж байв. Түүнчлэн хэрэв аль нэг улс нь төрийн албаны тогтолцоогоо тодорхойлохдоо нутаг дэвсгэрийн байдлаар буюу тодруулбал:

- Төрийн алба
- Мужийн төрийн алба
- Орон нутгийн төрийн алба гэх мэтээр нутаг дэвсгэрийн байдлаар нь эсвэл төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарагдах байдлаар нь төрийн албаны бүтцийг илэрхийлсэн байдал цөөнгүй харагдаж байв.

Зураг 2 -т байгаа бүтцийн схемээс төрийн албаны босоо тогтолцоог олж харах бөгөөд төрийн албаны бүтцийг субьектээр нь харуулсан зураглал юм. Төрийн албаны бүтцэд хамрагдаж байгаа субьектын хувьд судлаач мэргэжилтнүүд “...улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний ангилалд хамрагдаж байгаа бүлэг хүмүүс бүгд төрийн албан хаагчид гэж төөрөлдөж байна ” гэсэн шүүмжлэл байдаг.

Хуулиндаа төрийн албыг тодорхойлсон байдлаас харахад улс төрийн албан хаагчид хэдийгээр мэргэшсэн тогтвортой биш, сонгуульт хугацаанд байдаг хэдий ч хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа, үйлчилгээний албан хаагчид мөн л салбарын хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд төрийн чиг үүргийг тухайн салбарт хэрэгжүүлж байгаа өнөөгийн хуулийн тодорхойлолтын дагуу төрийн албанд хамрагдах нь маргаангүй юм. Үүнээс үзэхэд Монгол улсын төрийн албаны тухай хууль болон онолын асуудлын хооронд тодорхой зөрчилдөөн бий гэдэг нь харагдаж байна.

Монгол улсын төрийн албаны эрх зүйн орчин

Юуны өмнө төрийн албаны эрх зүйн орчин гэсэн энэ хэсэгт төрийн албаны тухай хууль хэдийд, ямар нөхцөл байдалд батлагдсан, хэд хэдэн онд ямар өөрчлөлт орж байсан зэрэг түүхэн товчооны шинжтэй асуудал бичихийг зорьсонгүй. Харин одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид сайжруулбал зохих, өөрчилбөл зохих зарчмын шинжтэй ямар асуудал байна, хуулийн заалт бодит байдалтай зөрчилдөж байгаа эсэх, хуулийн зохицуулалт нь амьдралд хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа эсэх зэрэг бодлогын шинжтэй асуудлыг тодруулан гаргахыг зорин ажиллаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төрийн албаны тухай хууль болон төрд олон жил ажилласан туршлагатай улс төрч, төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүд, эрдэмтэд судлаачдын үзэл, хандлага хоорондоо зөрчилдөж буй зарчмын нэг том асуудал байгаа нь судалгааны явцад тодорхой болсон юм.

Нэгдүгээр асуудал:

Энэ нь судалгааны энэ бүлгийн өмнөх хэсгүүдэд дурьдсанчлан улс төрийн болоод үйлчилгээний албаны албан тушаалтнуудыг төрийн албанд хамруулах эсэх тухай асуудал. Өнөөдөр хуулиар эдгээр албан тушаалтан нь яах аргагүй төрийн албан хаагчид мөн бөгөөд төрийн албаны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Гэтэл бодит байдал дээр хуулийн энэ зохицуулалт нь төрийн албыг мэргэшсэн, хараат бус, тогтвортой байх мэрит зарчмаар ажиллах боломжийг хаах төдийгүй эрх мэдлийг орон нутаг шилжүүлэх, бие даалгах, гэрээгээр гүйцэтгүүлэх зэргээр шийдэж болох

үйл-чилгээний албыг төрд харъяалуулснаар төрийн алба хэтэрхий нүсэрдэх нэг гол шалтгаан болж байна. Үүнээсээ болж улсын төсөв ачааллаа даахгүй хүртэж ядсан төсөв төлөвлөдөгөөс эрүүл мэндийн, боловсролын, соёл урлагын, үйлчилгээний ажил эрхлэдэг олон үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ нь хүртээмжгүй, чанаргүй, байхаас гадна бусад олон шүүмжлэлийг араасаа дагуулах гол шалтгаан болж байна.

Төрийн алба гүйцэтгэх эрх бүхий субьектээр авч үзсэн төрийн албаны тогтолцооны нарийвчилсан бүдүүвч



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хоёрдугаар асуудал:

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27-р зүйл буюу “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа” гэдэг зүйлд:

> 27.2.2. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх

гэсэн заалт бий. Гэвч энэ заалтад дээр нэр дурьдагдсан субьектүүд өөрийн ажлын алба болоод харъяаны төрийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх боломжийг хориглоогүй хязгаарлаагүй заалт юм. Тиймээс энэ заалт нь тунхаглалын шинжтэй заалт болж хувирах бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчдын хувьд баталгаа болж чадахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, аливаа улс төрийн хүчин сонгуульт хугацаандаа бүтцийн өөрчлөлт, баг бүрдүүлэлт нэрийн дор төрийн жинхэнэ албан хаагчдыг халж, сольж, ажиллах боломжгүй болгодог нь нууц биш.

Энэ нь ХУУЛИАР ХОРИГЛООГҮЙ БҮХНИЙГ ХИЙЖ БОЛНО гэсэн эрх зүйн зарчмыг урьдаа барин төрийн жинхэнэ албыг тогтворгүйжүүлэх, чадваргүйжүүлэх, мэргэших боломжийг бодитоор хаадаг нь харагдаж байна. Төрийн албаны эрх зүйн орчны бүрдэлд Төрийн албаны тухай хууль тогтоомж болон хууль зүйн баримт бичгүүдийг багтаасан байдаг. Үүнд:

Монгол улсын хууль:

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
4. Хөдөлмөрийн хууль
5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль

УИХ -ын тогтоол:

1. Дугаар 87. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм
2. Дугаар 14.Төрийн байгууллага болон төрийн албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх тухай
3. Дугаар 13. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам
4. Дугаар 70. Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай

Засгийн газрын тогтоол:

1. Дугаар 62. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам
2. Дугаар 288. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм
3. Дугаар 112. Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журам

Төрийн албаны шийдвэр, зөвлөмж:

1. “Төрийн албаны зөвлөлийн 2011 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2012 онд

дэвшүүлэх зорилтын тухай”
2. Тогтоол 129.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам
3. Тогтоол 99. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам
4. Тогтоол 43. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах аргачлал
5. Тогтоол 61. Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам
6. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас ажиллуулах журам
7. Тогтоол 45. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах тухай
8. Тогтоол 126. Төрийн албан зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай
9. Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам
10. Тогтоол 02. Төрийн жинхэнэ албанд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам
11. Тогтоол 34. Ажлын байр(албан тушаал)-ны тодорхойлолт,Ажлын байр(албан тушаал)-ны тодорхойлолт боловсруулах заавар
12. Тогтоол 47. Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам
13. Тогтоол 48. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээний биелэлт) -г үнэлэх журам
14. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах загвар
15. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэх загвар
16. Тогтоол 187. Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежертэй, Ерөнхий менежер менежер (нэгжийн дарга)-тэй үр дүнгийн гэрээ байгуулах заавар болон тэдгээрийн биелэлтийг дүгнэх журмыг шинэчлэн батлах тухай
17. Тогтоол 18. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам
18. Тогтоол 13. Төсвийн байгууллагын ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэх дарга (захирал, эрхлэгч)-ыг сонгон шалгаруулах журам

Харин судлаач миний үзэж байгаагаар төрийн албыг бүрдүүлж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж буй субьектийн эрх зүйн статус, чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагааны үндсэн чиглэл болоод төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа харилцааг зохицуулсан гол хууль болон баримт бичгүүд мөн үүнд хамаарагдана гэж үзээд 40 гаруй хууль хэмээн иш татсан билээ.

Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн бодлого, хэрэгжилт, үр дүн

Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн бодлогыг үндсэн нь 4 үе шатад авч үзсэн байдаг. Харин цаг хугацааны хувьд судлаач болоод салбарын удирдлагууд өөр өөр он цагийг баримтдах боловч энэ нь төдийлөн хол зөрүүгүй тул онц ач холбогдол өгсөнгүй. Монгол Улсын төрийн албаны шинэтгэл нь 1990 оноос эхэлж өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа гэж салбарын мэргэжилтнүүд болон эрдэмтэд санал нэгддэг нь харагдаж байна. Төрийн албаны зөвлөлийн удирдлагаас өгч буй мэдээллээр Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн үйл явц 4 үе шатыг дамжин хэрэгжиж байна. Үүнд:

Нэг дэх үе.

Энэ үе нь 1990-1995 оныг хамарсан бөгөөд тус шинэтгэлийн эхний үе шатны гол онцлог нь Монгол улсын төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байжээ. Энэ үе шатанд ардчиллын үнэт зүйлсийг шингээсэн Үндсэн хуулийг боловсруулж батлсан бөгөөд энэхүү гол хуулийн үзэл санаанд нийцүүлж төрийн эрх мэдлийг тэнцвэртэйгээр хуваарилан хэрэгжүүлэх онолын дагуу төрийн байгууламжийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салаанд хуваарилах нэн чухал ажил хийгдсэн[104] гэж салбарын мэргэжилтнүүд үзэж байна.

Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулиуд батлагдан мөрдөгдөж төрийн байгууллагуудыг чиг үүргийн дагуу өөрчлөн байгуулах үйл явц өрнөсөн байна. Үр дүнд нь төрийн албаны өнөөгийн дүр төрх бүрэлдэх суурь тавигдсан нь энэ үе шатны гол үр дүн гэж үздэг байна. Түүнчлэн 1993 онд Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн “Удирдлагын хөгжлийн хөтөлбөр” нь төрийн албаны шинэтгэлийг урагшлуулахад багагүй үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Хоёр дахь үе.

Төрийн албаны шинэтгэлийн хоёр дахь үе шат нь 1995 - 2002 оныг хамран үргэлжилсэн байна**.** 1995 онд Төрийн албаны тухай хуулийг баталж, манай улсад анх удаа төрийн албаны гол харилцааг зохицуулсан төрөлжсөн хуультай болсон. Энэ хуулиар төрийн албаны ангилал, албан тушаалын ангилал зэрэглэл, төрийн албанд баримтлах зарчим, төрийн албан хаагчийн эрх үүрэг, хариуцлага гэх зэрэг гол асуудлуудыг тусган төрийн албаны хэмжээнд нийтлэг мөрдөж эхэлсэн байна.

Төрийн албаны хууль батлагдсанаар стандартын шинжтэй 20 гаруй дүрэм, журам хуулийг даган батлагдсан бөгөөд төрийн албаны хэмжээнд мөрдөх эрх зүйн зохицуулалтыг иж бүрэн болгох үйл ажиллагаанууд дэс дараалан хийгдсэн байна. Мөн тухайн хууль тогтоомжийн дагуу төрийн албыг цэгцлэх ажил энэ үе шатанд явагдаж одоогийн төрийн албаны тогтолцоо, бүтэц бүрэлдэхүүнийг бий болгох суурийг тавьжээ. Энэ үе шатанд хийсэн олон ажлуудаас анхаарал татсан гол ажил нь төрийн албаны стандартын удирдлагыг хариуцсан “Төрийн албаны төв байгууллага” буюу “Төрийн захиргааны албаны зөвлөл”-ийг байгуулсан явдал гэж салбарынхан нь дүгнэсэн байна.

Энэ байгууллагыг байгуулах зорилго нь:

- улс төрөөс ангид,
- мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэх явдал байсан бөгөөд ийм байгууллага байгуулж үр дүнд хүрсэн гадаадын зарим орны туршлагыг нутагшуулан хэрэглэсэн байдаг.
- 2 дахь шатанд УИХ-ын 1996 оны 38 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийн талаар баримтлах бодлого”- ын баримт бичгийг баталсан байна.

Гуравдахь үе.

Энэ үе шат нь 2002-2008 оныг хамарсан. Учир нь 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдан мөрдөгдөж, Төрийн албаны тухай хуульд ч үүнтэй холбоотой нэмэлт өөрчлөлт орсон байдаг. Тус хуульд төрийн албаны үйл ажиллагааг төлөвлөхдөө хийх ажлыг бүтээгдэхүүнд шилжүүлж, өртөг зардлыг тооцон түүний үндсэн дээр төрийн албаны хийж гүйцэтгэх ажлын төсөв босгох арга замыг тусгаснаас гадна, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн ерөнхий

104

менежерүүдийн эрх хэмжээг ялгавартай тогтоож, зарим удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зарчмыг тодорхойлж, төрийн албаны удирдлагын хэв шинж, ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр нь тооцох аргачлалыг нарийвчлан хуульчилсан зэрэг нь шинэтгэлийн 3 дахь үе шатны гол үр дүн байжээ.

Төлөвлөлт, гүйцэтгэлийн стандартыг тогтоон, дагаж мөрдвөл зохих олон баримт бичиг гарч тэдгээр нь өнөө хүртэл үйлчилж байна. Эдгээр бодлогын баримт бичгийн дагуу:

- Стратеги төлөвлөлт,
- Бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөржүүлэх, зохицуулах,
- Мониторинг хийх, үнэлж дүгнэх чиг үүрэгтэй төвлөрсөн чиг үүргийн болон чиглэлийн яамд, хууль тогтоомж, стандартыг сахиулах чиг үүрэгтэй Засгийн газрын тохируулагч агентлаг, бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй хэрэгжүүлэгч агентлагууд байгуулагдаж, төсөвт байгууллагын шинэ тогтолцоог бүрдүүлсэн.

Энэ үе шат бол төрийн албаны удирдлага, санхүүжилт, төлөвлөлт, гүйцэтгэл, үнэлгээний орчин үеийн хэв шинжийг бүрдүүлэхэд ахиц гаргасан үе гэж тус салбарын мэргэжилтнүүд дүгнэсэн байна. Энэ үе шатанд Төрийн захиргааны албаны зөвлөлийг “Төрийн Албаны Зөвлөл” болгон өргөтгөж, бие даасан хараат бус байгууллагын статусыг нь баталгаажуулсан байна.

Гурав дахь үе шатанд төрийн албаны шинэтгэлийг урагшлуулахад гол үүрэг гүйцэтгэж байсан баримт бичиг бол 2004 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги” гэх бодлогын баримт бичиг юм. Мөн 2008 онд УИХ-аас “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг баталж түүнд Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг нэмэгдүүлж, хараат бус байдлыг нь улам баталгаажуулж, төрийн албыг мэргэшсэн тогтвортой байх эрх зүйн үндсийг тогтоосон байна.

Дөрөв дэх үе.

Төрийн албаны шинэтгэлийн дөрөв дэх үе шат 2008 оноос эхлэн өнөөг хүртэл үргэлжилж байна. 2008 онд Төрийн албаны тухай хуульд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулсан. Тухайлбал, улс төрийнхөөс бусад төрийн албан хаагчдыг улс төрийн намын харьяалалгүй байлгах, намын харьяалалгүй төрийн албан хаагчид улс төрийн сонгуулийн сурталчилгаанд ямар нэгэн хэлбэрээр оролцохгүй байх, төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр халах, чөлөөлөхийг хатуу хориглох, Төрийн албаны төв байгууллагаас төрийн албаны удирдах албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хариуцлага тооцох, сонгон шалгаруулалтаас хамгийн шаардлага хангасан нэг хүнийг шалгаруулан нэр дэвшүүлэх зэрэг төрийн албанд шудрага ёсыг хэвшүүлэх, хүний нөөцийн замбараагүй томилгоо, хөдөлгөөнийг зогсоож, улс төрийн зүй бус нөлөөллөөс ангид болгох, төрийн мэргэшсэн, тогтвортой албыг цаашид төлөвшүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн өөрчлөлтүүд тусгагдсан гэж ТАЗ-өөс дүгнэсэн байна[105].

Төрийн албаны шинэтгэлийн 4 дэхь үе шатанд Төрийн албаны зөвлөлийн эрх хэмжээг нэмэгдүүлж, түүний төрийн албаны шинэтгэлийн талаар гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна. Энэ үед төрийн албаны шинэтгэлд нэг чухал баримт бичиг батлагдсан нь 2010 онд Улсын Их Хурлаас баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” хэмээх бодлогын баримт бичиг байна. Тус бодлогын баримт бичигт төрийн

105 Мөн тэнд

залгамж чанар, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдал, хууль ёсыг дээдэлсэн авлигагүй төрийн алба, төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмжийн талаар тусгаж шинэ үеийн төрийн албаны хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон байна. Тодруулбал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын:

> 3.3.2. Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх гэдэгт:
>
> 3.3.2.1. Иргэдэд адил тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтална. Цахим засгийг хөгжүүлэх замаар төрийн алба, үйлчилгээг иргэндээ хандсан, үр нөлөөтэй, шуурхай, хэмнэлттэй болгоно.
>
> 3.3.2.3. Төрийн бодлогын залгамж чанарыг хангах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлнэ.
>
> 3.3.2.4. Бодлогын оновчтой арга, хэрэгслээр дамжуулан эдийн засгийн зохицуулалт хийх төрийн удирдлагын чадавхыг сайжруулна.
>
> 3.3.2.6. Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
>
> 3.3.2.7. Төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана.

гэж тус тус заасан нь төрийн албаны шинэтгэлийн 4 дэхь үед хийсэн алхам бөгөөд үүний үр дүнд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль 2012 оны 1 сард батлагдсан байна.

Дөрөв. Төрийн албаны шинэчлэлийн өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох нь

1. Монгол Улсын шинэхэн үе/1990 оноос хойшхи/-ийн төрийн албаны хөгжил, шинэтгэлийн эхний үе шат нь 1990-1993 /зарим судлаачид, албаны хүмүүс 1990-1995 он гэдэг/ онуудад хийгдсэн төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байв.

2. Хоёр дах үе шат нь Төрийн захиргаа, төрийн албаны шинэ тогтолцоог бүрдүүлэх үе шат бөгөөд 1994 - 2001 оныг хамарч байна. 1994 оны 12 дугаар 30 “Төрийн албаны тухай” хууль батлагдаж, төрийн мэргэшсэн тогтвортой албыг бүрдүүлэх эрх зүйн үндэс тавигдсан байна 1996 онд Улсын Их Хурлын 38 дугаар тогтоол гарч “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, хэргжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудыг өөрчлөн зохион байгуулжээ.
3. Гурав дах үе шат нь Төрийн албаны чадавхи, үйл ажиллагааных нь үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд 2002 - 2007 оныг хамарч байна. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хууль/2003.01.01-нээс/, “Монгол улсын төрийн албаны дунд хугацааны стратегийн баримт бичиг”/УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоол/-ийг баталж мөрдүүлжээ.
4. Дөрөв дэх үе шат нь 2008 оноос өнөөг хүртэл улс төрийн нөлөөллөөс ангид төрийн мэргэшсэн, тогтвортой албыг төлөвшүүлэх хүрээний зорилтыг хэрэгжүүлэх явдал байв.

Монгол улсын Үндсэн хуулийн эх газрын эрх зүйн тогтолцоог үндэс болгон авч үзвэл манайд төрийн албаны /Шинэ Зеланд/ удирдлагын төвлөрлийг сааруулсан нээлттэй

загвар төдийлөн тохиромжгүй бөгөөд харин нэгдмэл улсуудад хэрэгжүүлж байгаа төвлөрлийг харьцангуй сааруулсан хаалттай загвар тохирч болох юм. Өөрөөр хэлбэл Францын эх газрын тогтолцоог үндэс болгон, сүүлийн үед ОХУ, пост социалист улсууд, Прибалтикийн орнуудад хэрэгжүүлж эхэлж байгаа төрийн албаны эх газрын хаалттай зарчмыг төрийн абаны нээлттэй байх, төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулдаг, төрийн албан хаагчдын ажлын үр дүнг мерит зарчмаар үнэлдэг англо-саксоны эрх зүйн элементээр баяжуулан хэрэглэх хувилбар байж болох юм.

Шийдвэрлэвэл зохих асуудал

Төрийн албаны хуульд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулан Төрийн улс төрийн албан хаагчдаас бусад төрийн албан хаагчдын улс төрийн намын харъяаллыг тодгэлзүүлж, төрийн захиргааны алба мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баталгаажуулан төрийн албаны залгамж чанарыг хадгалах, төрийн албаны гүйцэтгэлийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төрийн албаны нэр хүндийг дээшлүүлэхэд томоохон алхам болно гэж үзсэн байна.

Улс төрчид бол сонгуулийн үр дүнгээр тодорхой хугацаанд эрх ямба эдэлж, үүрэг хүлээдэг бол төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг. Харин төрийн албан хаагчид мэргэжлийн шалгалт өгч, тангараг өргөөд ажлын үр дүн, ур чадвараараа албан тушаал ахиж, насан туршдаа төр, түмний төлөө зүтгэдэг болох нь улс орнуудад түгээмэл болсон бөгөөд эдгээр ангилалд хамаарах албан хаагчдийн хөдөлмөрийн харилцааг тус тусдаа бие даасан хуулиар зохицуулагддагдаг. Иймд үүнийг залруулж нэг мөр ойлгомжтой болгон “Төрийн албаны тухай” хуулийг шинэчилж, “Төрийн албан хаагчдийн эрх зүйн байдлын тухай” хууль боловсруулж батлан мөрдөж зохицуулалтыг зөв болгох шаардлагатай гэж энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид үзэж байна.

Төрийн алба улс төрөөс хараат, төрийни албан хаагчид улс төрчдийн ивээлд ажилладаг /spoil/ тогтолцоо хэвээр хадгалагдсаар байна. “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн үндсэн үзэл санааны нэг нь захиргааг төрөөс тусгаарлах явдал байв. Өөрөөр хэлбэл улс төрийн түвшинд юу хийхийг нь шийдэж, түүнийг нь захиргааны байгууллагууд хэрхэн хэрэгжүүлэхээ бие даан шийдэх боломжийг бүрдүүлсэн юм. Харамсалтай нь энэ бодлого тууштай хэрэгжихгүй, бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа хоорондоо хутгалдаж, эргэж буцах төлөвтэй байна.

Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдал, ажлын үр дүнг үнэлэх зарчим бүрэн хангагдаагүй байна. Төрийн албан хаагчдыг ажлыг үр дүнгээр нь үнэлэх зарчим ажлын байр тус бүрээр хийх нь аятайхан, амархан мэт боловч, гадаадын улс орнуудад энэ нь амаргүй болох нь тогтоогдож, хүн тус бүрээр бус багаар нь үнэлэх хандлага буй болж байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын ангилалд тохирсон сургалтын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай гэж үзэх болжээ.

Төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөх, цаашилбал улс орны хөгжлийн хурдыг түргэсгэх чухал алхам бол төрийн албан хаагч авилга, хээл хахуулиас ангид байх явдал юм. Үүний тулд улс орнуудад авилга хээл хахуулийг багасгаж чадсан бэлэн туршлагыг авч төгс хэрэгжүүлэх шаардлагатай.

Тав. Төрийн албаны шинэчлэлийн талаарх бодлогын хувилбарууд, эерэг, сөрөг талууд

1. Төрийн алба уу? Нийтийн алба уу?

Public service гэдгийг орос хэл рүү “Государственная служба” гэж хөрвүүлсэн байх бөгөөд түүнийг Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв нарын “Орос Монгол толь” -ийн 95 дугаар хуудсанд “гүрэн”, “засаг төр”, “төр” гэж хөрвүүлснээс үзвэл манай Үндсэн хуулийн бүлэг,

зүйл, заалтуудад “төр” гэж зөв томъёологдсон байна гэж үзэж болохоор байна.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төрийн албанаас нийт иргэдэд хандсан үйлчилгээнд түлхүү анхаарах, цаашид төрийн албаны шинэчлэлийг өөрийн орны онцлогт тохируулан гүнзгийрүүлэх, илүү зөв гольдролд оруулах гэж байгаа бол иргэд, олон нийт, мэргэжлийнхний зүгээс маргах зүйлгүй нь ажиглагдаж байна. Монгол Улсын Төрийн албыг Нийтийн алба болгон өөрчлөх санаачлага гарч, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль 2012 онд батлагдаж, Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй нэр томъёотой хуультай болов.

Үндсэн хуульд төр гэдэг нэр томъёо нэг мөр тодорхойлогдсон билээ. Үндсэн хуулийн оршил хэсгийн 3 дахь зурааснаас “төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг надиган өвлөж”, 1 дүгээр зүйлийн 2 -т”Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 2 дугаар зүйлийн 1 -д “Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, 3 дугаар зүйлийн 1 -д “... Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”, Мөн зүйлийн 2 -т “Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.”, 5 дугаар зүйлийн 2 -т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, мөн зүйлийн 4 -т Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, мөн зүйлийн 5 -д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.” 6 дугаар зүйлийн 1 -д Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” Мөн зүйлийн 2-т “Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.”, мөн зүйлийн 3 -т ... түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.”, мөн зүйлийн 4 -т Төр газрын эзэнд...”мөн зүйлийн 5 -д “төрөөс гадаадын иргэн...”, 7 дугаар зүйлийн 1 -д “..., оюуны өв төрийн хамгаалалтад байна.”, 8 дугаар зүйлд “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн.”, 9 дүгээр зүйлийн 1-д “...төр нь шашнаа хүндэтгэж,...”, мөн зүйлийн 2 -т Төрийн байгууллага шашны,...”, 3 -т “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна. ”11 дүгээр зүйлийн 1 -д “... хангах нь төрийн үүрэг мөн.”, 12 дугаар зүйлийн 1 -д “... Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.” 2 -т “Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал нь...”, 3 -т “Төрийн сүлд нь...”, 4 -т “ Монголын нэгдсэн улсын төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын Төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн.”, 5-д “Монгол Улсын төрийн далбаа нь ... ”6 -д “Төрийн тамга нь...”, 7 -д “Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх журам, төрийн дууллын үг, аяыг хуулиар бататгана.”, 13 дугаар зүйлийн 1 -д Монгол Улсын төрийн дээд байгууллага оршдог хотыг нийслэл гэнэ....” гэх мэтээр Монгол Улсын Үндсэн хуулийн 70 зүйлээс 28 зүйлд нь, 202 хэсгийн заалтаас 48 –д нь, 72 дэд заалтаас 17 дэд заалтад нь төр гэсэн нэр томъёо орсон байна. Үүний дотроос Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийг ТӨРИЙН БАЙГУУЛАЛ гэж нэрлэсэн байх бөгөөд энэ бүлгийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, 23дугаар зүйлийн 1 -д “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” 38 дугаар зүйлийн 1 -д “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.”, мөн зүйлийн 2 -т “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гэж заасан байхад 46 дугаар зүйлийн 1 -д Монгол Улсын яам төрийн бусад албан газрыг хуулийн дагуу байгуулна.”, мөн зүйлийн 2 -т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана.” гэж

зааснаас дүгнэлт хийж үзвэл:

1. Улсын Их Хурлын гишүүд нь нийт иргэний эрх ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах
2. Улсын Их Хурал нь нийт иргэний эрх ашиг сонирхлыг эрхэмлэн баримталсан хууль тогтоох онцгой эрх эдлэх
3. Засгийн газар нь төрийн хуулийг биелүүлэх
4. Төрийн жинхэнэ албан хаагч нь Үндсэн хууль, бусад хуулийг баримталж, ард түмнийхээ тусын тулд, төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах учиртай гэж ойлговоос төрийн албыг нийтийн алба гэж нэрлэхэд хүрвэл Үндсэн хуулийг бүхэлд нь эргэж харах асуудлыг эхэлж шийдэхэд хүрэхээр байна.

2. Төрийн албаны эх газрын /Европын Франц гэх мэт олонх улсуудын/ загвар уу?

Англо - саксоны загвар уу? Эсвэл дундынх уу?

Эх газрын загварын тухайд:

Монгол Улсын Үндсэн хууль эх газрын эрх зүйн загварт тухайлбал Францын загварт илүү ойрхон. Гэвч удирдлагын босоо тогтолцоо, төвөөсөө хамааралтай байдал нь манай төвлөрлийг сааруулах бодлоготой зөрчилдөх болно. Герман мэтийн улсуудад үйлчилдэг төрийн албан хаагчид нь намын хамааралтай, түүний ивээлд байхыг манайд өнөөдөр үйлчилж байгаа хуулиар дэмжпэггүй, цаашид ч энэ бодлого хэвээр байх болов уу.

Англо-саксоны загварын тухайд:

Үндсэн хуулийн хүрээнд авч үзвэл манайд тохиромж муутай. Төрийн албаны төвлөрөл уламжлагдаж ирсэн манай орны тухайд Их Британи, Шинэ Зеланд болон холбооны улсуудын жишгээр орон нутгийн бүрэн бие даасан байдлыг тогтоох, эсэх талаар бодолцох шаардлагатай. Төрийн албан хаагчдыг гүйцэтгэсэн ажлын үр дүнгээр нь үнэлэх өнөөгийн шаардлагыг хангахын тулд оновчтой хувилбар/ хүн тус бүрээр эсвэл багаар/-ыг сонгох шаардлага тавигдана.

Дундын хувилбарын тухайд:

Улс орнуудад төрийн албаны шинэчлэл хийсэн замналыг авч үзвэл нээлттэй загвар хаалттай руугаа ойртох, хаалттай загвар нээлттэй руугаа ойртох чиг хандлага давамгайлж байна.Төрийн албаны эх газрын загварын удирдлагын төвлөрлийг сааруулж, Үндсэн хуульд заасны дагуу орон нутагт нутгийн өөрийн удирдлагыг төрийн удирлагатай зөв хослуулах механизмыг тогтоохын тулд орон нутгийн удирдлагын аль түвшинд, ямар албан тушаалд төрийн албан хаагч байхыг оновчтой тогтоох

- Төрийн албаны хаалттай загварт түгээмэл байдаг төрийн албаны улс төрийн хамаарлыг төрийн мэргэшсэн бюрократтай зөв хослуулах
- Төрийн албаны нээлттэй загварт түгээмэл үйлчилдэг, төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтын өнөөгийн үйлчилж байгаа журмыг болвсронгуй болгох
- Төрийн үйлчилгээний албан тушаалыг бүхэлд нь хөдөлмөрийн гэрээнд шилжүүлэх

Дээр дурдсан гурван зарчим бол дэлхийн улс орнуудын төрийн албаны шинэчлэлийн практикт хэрэллэж байгаа загварууд бөгөөд аль аль нь сайн болоод саар дутагдалтай талтай ч социалст чиг баримжаатай байсан нэлээд орнууд, БНСУ, Сингапур, Африкийн Ботсван зэрэг улсуудад дундын хувилбарыг амжилттай хэрэгжиж байгааг судлаачид тэмдэглэжээ. Аль ч загварыг хэрэгжүүлэхэд гадаад орнуудын туршлага, ялангуяа хөгжиж буй шилжилтийн эдийн засагтай орнуудын түвшинд үлдээсэн дараах сургамжийг

харгалзан үзэхийг экспертүүд зөвлөсөн байна. Үүнд:

1. Хөрс сууриа зөв тавь. Амжилттай хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх
2. Цаасан дээр буулгасан зүйлийнхээ цаадах бодит практикийг нягталж үз. Хууль, албан ёсны дүрэм журмаас илүү төрийн захиргаан дах байгууллагын болон хүний хүчин зүйлс хэрхэн үйлчилж байгааг анхаарч судлах
3. Хуулбарлахаас татгалз. Хаана нэг хэрэгжүүлсэн шинэтгэл, туршлагыг шууд авч хэрэглэхээс татгалзан, дотоодын нийгэм, эдийн засгийн зорилтод нийцсэн үндэсний загварыг боловсруулах.
4. Ижил алдааг бүү давт. Улс орнуудын сайн, муу загварын аль алиныг судалж харцуулснаар үндэсний өөрийн гэсэн загварыг сонгох
5. Бүү яар, дөт замыг бүү хай. Төрийн албаны шинэтгэл нь интитуцийн хамааралтай гүнзгий агуулгатай байдаг учраас харьцангуй их хугацаа шаардана. Зөвхөн техникийн шийдлээс хамаарахгүй улс төрийн шийдвэрээс шалтгаалдаг тул ойлгож мэдрэх, итгэл үнэмшилтэй болоход цаг хугацаа шаардагдана.
6. Лавла, судал, бас дахин лавла, судал. Янз бүрийн эх сурвалжаас мэдээлэл, зөвлөгөө авснаар муу хувилбарыг шүүн тунгаах боломж бүрдэнэ.

* * *

Эх сурвалж:

1. Төрийн захиргаа онол, арга зүйн сэтгүүл, 2011/тусгай дугаар (18), 26-р тал
2. http://www.gov.bw/en/Ministries--Authorities/Ministries/State-President/The-Directorate-of-Public-Service-Management-DPSM1/Recruitment--Placement-Division/Compensation-and-Terminal-Benefits-Division/
3. АНАЛИЗ МОДЕЛЕЙ ГОСУДАРСТВЕННОЙ ГРАЖДАНСКОЙ СЛУЖБЫ В ЗАРУБЕЖНЫХ СТРАНАХ Малышкин А.П, Михайлова М.В 2010 г
4. Литвинцева Е.А. Реформирование государственной гражданской службы в зарубежных странах // Государственная служба. 2007. № 6.
5. Санхүүгийн төвлөрөл, нутгийн өөрөө удирдах ёсфорумд “Төрийн удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоо” илтгэл Ц. Даваадулам
6. Нийгэм эдийн засгийн хөгжил- төрийн захиргааны шинэчлэл сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүд
7. http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un/unpan000233.pdf ADMINISTRATIVE REFORM EFFORTS IN THAILAND: CURRENT EXPERIENCES AND SUCCESSES
8. http://www.dgaep.gov.pt/media/0601010000/austria/Structure%20of%20the%20Civil.pdf
9. http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un/unpan023216.pdf
10. http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/NISPAcee/UNPAN007217.pdf
11. http://www.oecd.org/site/sigma/publicationsdocuments/1850010.pdf
12. http://www.humanrights.lv/doc/latlik/satver~1.htm
13. http://lgi.osi.hu/publications/books/decentralization/Chapter%203.pdf
14. http://lgi.osi.hu/publications/2000/25/Chapter_8.PDF

ХУУЛИАР ТОГТООСОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ БА БУСАД ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

П. Амаржаргал

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей гишүүний 8/1872 тоот захиалгын дагуу энэхүү харьцуулсан судалгааг үндсэн хоёр асуудлын хүрээнд гүйцэтгэв. Нэгдүгээрт, Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх чиг үүргийн шинжилгээ, Хоёрдугаарт, Парламентын дотоод ажил хариуцсан байнгын хорооны эрх зүйн зохицуулалтын талаархи дэлхийн 6 орны харьцуулсан судалгааг гүйцэтгэв. Мөн ашигласан материалыг хавсаргав.

Судалгааны нэг дэх хэсэгт Улсын Их Хурлын төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлэн авч үзэв. Монгол Улсын Үндсэн хуулийн 25.4, 27.6 дахь заалтууд болон Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дах хэсэгт заасан Төрийн байгуулалтын байнгын хорооны чиг үүрэг нь бусад хууль тогтоомжийн зохицуулалттай хэрхэн холбогдож байгааг авч үзэхэд, Хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Их Хурал түүнээс томилогддог байгууллага болох Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, Монгол Улсын Төв банк /Монголбанк/, Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны төв байгууллага /Төрийн албаны зөвлөл/, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Олон нийтийн радио телевиз, Сонгуулийн Ерөнхий хороо болон ард түмнээс сонгогдсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын хүрээнд үйл ажиллагааны үндсэн чиглэлээр тодорхой хуулийн зохицуулалтууд тусгагдсан байна.

Судалгааны хоёр дахь хэсэгт Польш, Их Британи, Энэтхэг, Япон, ХБНГУ, Австри зэрэг 6 улсын парламентын үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм журмуудаас дотоод ажил хариуцсан байнгын хорооны эрх зүйн зохицуулалтыг түүвэрлэн орчуулж судаллаа. Улс орон бүрт Парламентын дотоод асуудал хариуцсан байнгын хороо нь өөр өөрөөр нэрлэгдэх боловч тухайн орныхоо Үндсэн хуулийн холбогдолтой дотоод асуудал, төрийн байгууллагатай холбогдох дотоод асуудал, өдөр тутмын асуудлыг хамаарч байгаа нь харагдаж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны үйл ажиллагааны чиглэл түүнд холбогдох хуулийн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 25.4, 27.6 дахь заалтууд болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дараахь асуудлууд хамаарч байна. Үүнд:

- 20.5.1. Төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;
- 20.5.2. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль;
- 20.5.3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс;
- 20.5.4. Төрийн алба;
- 20.5.5. Төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;
- 20.5.6. Ард нийтийн санал асуулга;
- 20.5.7. Төр, сүм хийдийн харилцаа;

UHL.MN
СУДАЛГААНЫ САН

- 20.5 8. Хэвлэл мэдээллийн хараат бус байдал;
- 20.5.9. Төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай харилцах;
- 20.5.10. Гишүүний бүрэн эрхийн асуудал;
- 20.5.11. Гишүүний ёс зүй;
- 20.5.12. Гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал;
- 20.5.13. Улсын Их Хурал, гишүүний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт;
- 20.5.14. Гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;
- 20.5.15. Чуулганы хуралдааны дэгийн асуудал гэсэн арван таван хүрээг хамарч байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байгаа, УИХ-аар шийдвэр гаргаж, үйл ажиллагааг нь зохицуулж, хяналт тавих үүрэгтэй байгууллагуудын одоо мөрдөж байгаа хууль эрх зүйн актуудад тусгасан Улсын Их Хуралд холбогдох зохицуулалтуудыг түүвэрлэн авч харуулав

1. Монгол Улсын Засгийн газар

Үндсэн хууль (1992)

Монгол Улсын Үндсэн хуулийн 27.6 дахь хэсэг “Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ”.

Засгийн газрын тухай хууль (1993)

18 дугаар зүйл. Монгол Улсын яам

2. Монгол Улсын яамыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн, Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн хуулиар байгуулж, татан буулгана.

18[3] дугаар зүйл. Засгийн газрын агентлаг

1. Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн бүдүүвчийн дагуу байгуулан ажиллуулж болно.

25 дугаар зүйл. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

6/ түүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно;

26 дугаар зүйл. Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах

1. Засгийн газар нь Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино. Улсын Их Хурал Засгийн газарт итгэл хүлээлгэхгүй байгаа тухай шийдвэр гаргавал Засгийн газар огцорно.

2. Засгийн газрын үйл ажиллагааны талаархи олон нийтийн санаа бодол, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн байр суурийг харгалзан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч холбогдох тогтоолын төслийг Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

3. Итгэл хүлээлгэж байгаа эсэх тухай тогтоолын төсөл, түүнчлэн Засгийн газар огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Ерөнхий сайдын бэлтгэсэн мэдэгдлийн төслийг Засгийн газрын гишүүдийн дөрөвний гурваас доошгүйн ирцтэй

хуралдаанаар хэлэлцсэн байвал зохино.

4. Улсын Их Хурал өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Засгийн газар уг асуудлыг өөрөө санаачлан авч хэлэлцэхгүй.

5. Засгийн газраас Улсын Их Хуралтай өдөр тутам шууд харилцах асуудлыг Ерөнхий сайд, эсхүл ажил үүргийн хуваарь бүхий Засгийн газрын гишүүн эрхэлнэ.

6. Засгийн газар Улсын Их Хуралд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг тавьж, цаг үеийн асуудлаар тогтмол мэдээлэл хийж байна.

7. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 6О хоногийн дотор, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд түүнд өргөн мэдүүлнэ

8. Засгийн газар хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлынхаас өөр саналтай байгаа бол Ерөнхий сайд уг саналаа дахин хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд тавьж болох бөгөөд түүнийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж хариу өгнө.

9. Засгийн газар хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Ерөнхий сайд, түүний даалгавраар Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын даргад зохих журмын дагуу өргөн мэдүүлнэ.

10. Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийн өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон тухайн төслийг хариуцан боловсруулсан Засгийн газрын гишүүний албан ёсны зөвшөөрлийг авсан байна.

11. Засгийн газрын гишүүн нь Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариуг хууль тогтоомжид заасан журмын дагуу өгөх үүрэгтэй.

29 дүгээр зүйл. Засгийн газрын хуралдаан

1. Засгийн газар энэ хууль, бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан, Ерөнхийлөгчөөс санал болгосон асуудлыг хуралдаанаараа хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ. Түүний дотор дор дурдсан асуудлыг хуралдаанаараа заавал хэлэлцэнэ:

30 дугаар зүйл. Засгийн газрын шийдвэр

2. Засгийн газар нь Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно. Энэ эрхийн акт нь тогтоол хэлбэрээр байна.

Агентлагын хүрээнд

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль хууль (2004)

5 дугаар зүйл. Агентлаг байгуулах

5.1. Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн дагуу тухайн үйл ажиллагааны зохих хүрээ, Ерөнхий сайд, сайд /цаашид “сайд”гэх/-ын саналыг үндэслэн Засгийн газар байгуулна.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч

Ерөнхийлөгчийн тухай хууль (1993)

5 дугаар зүйл. Ерөнхийлөгч тангараг өргөх

1. Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч нь Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргаснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд Үндсэн хуулиар тогтоосон тангараг өргөнө.

2. Ерөнхийлөгч тангараг өргөх өдрийг Улсын Их Хурал товлон тогтооно.

3. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг Улсын Их Хурал тогтооно.

7 дугаар зүйл. Ерөнхийлөгч ажлаа хариуцах

1. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцаж жил тутам үйл ажиллагааныхаа талаар танилцуулж байна.

2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.

3. Үндсэн хуулийн цэц

Үндсэн хуулийн цэцийн тухай хууль (1992)

3 дугаар зүйл. Цэцийг байгуулах журам

1. Цэцийн есөн гишүүний гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Цэцийн гишүүнээр томилох хүний тухай Улсын Их Хуралд санал болгохдоо Улсын Их Хурлын дарга зохих байгууллагын хороодын санал дүгнэлтийг үндэслэн захирамж, Ерөнхийлөгч захирамж, Улсын Дээд шүүх гишүүдийнхээ олонхийн саналыг үндэслэн зохих шийдвэр гаргана.

4 дүгээр зүйлийн 3. Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийг Улсын Их Хурлаас дараагийн гишүүнийг томилсноор дуусгавар болно.

5 дугаар зүйлийн 3. Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно.

7 дугаар зүйл. Цэцийн үйл ажиллагааны нөхцөл

1. Цэц нь ажлын албатай байна. Түүний орон тоог Улсын Их Хурлаас батлагдсан төсөвт багтаан Цэцийн ажлын албаны дарга тогтооно.

3. Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож батална.

8 дугаар зүйл. Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналт

3. Цэц Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараахь маргааныг хянан үзэж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулна:

1/ Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх;

2/ Улсын Их Хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх;

3/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/ Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

5/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах хуульд заасан үндэслэл байгаа эсэх.

Дөрөв. Төв банк /Монголбанк/

Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (1996)

26 дугаар зүйл. Монголбанкны удирдлага

1. Монголбанкийг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

2. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

5. Монголбанкны Ерөнхийлөгчийн цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

6. Улсын Их Хурал Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг дор дурдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ:

1/ арилжааны банкны хувьцаа эзэмшигч болсон;

2/ Монголбанкны эрх ашигт харш үйлдэл /эс үйлдэл/ гаргасан;

3/ биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг албан тушаалаас чөлөөлж өгөхийг хүссэн;

4/ үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

5/ гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;

6/ ашиг сонирхлын бусад зөрчил үүссэн.

8. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийг томилсон өдрөөс эхэлж, Улсын Их Хурлаас дараагийн Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийг томилсноор дуусгавар болно.

30 дугаар зүйл. Монголбанк Улсын Их Хуралтай харилцах

1. Монголбанк төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаар Улсын Их Хуралд улирал тутам танилцуулна.

2. Төрийн мөнгөний бодлогод тодорхойлсон үзүүлэлт нь Монголбанкны үйл ажиллагаанаас үл шалтгаалан эдийн засагт бий болсон нөхцөл байдлаас хамааран хэрэгжээгүй тохиолдолд энэ талаар Улсын Их Хуралд танилцуулна.

3. Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна.

Тав. Төрийн албаны төв байгууллагын хүрээнд /Төрийн албаны зөвлөл/

Төрийн албаны тухай хууль (2002)

5 дугаар зүйл. Төрийн албан тушаалын ангилал, төрөл5.4. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.\

5.5. Энэ хуулийн 5.4-т заасан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

33.1. Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлага хэрэгжүүлэх Улсын Их Хурал

34.2. Төрийн албаны зөвлөлын үйл ажиллагааны хараат бус, бие даасан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнах.

34.4. Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 40 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

34.5. Улсын Их Хурал Зөвлөлийн орон тооны гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно.

34.7. Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын дадлага, туршлагатай, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

34.10. Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Улсын Их Хурал батална.

34.11. Зөвлөлийн орон тооны гишүүн нь гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль ноцтой зөрчсөн бол түүнийг уг албан тушаалаас нь эгүүлэн татах тухай асуудлыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

39.3. Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг Улсын Их Хурал тогтооно.

Зургаа. Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)

4.2. Хорооны дүрмийг Улсын Их Хурал батална

9 дүгээр зүйл. Хороо Улсын Их Хуралтай харилцах

9.1. Хороо хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнана.

9.2. Хорооны үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд Улсын Их Хурал зохих бүтцээрээ дамжуулан хяналт тавина.

11.2. Хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хоёр хүний, Хууль зүйн болон Төсвийн байнгын хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр нэг хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас томилно.

Долоо. Үндэсний аудитын газар

Төрийн аудитын тухай хууль (2003)

13 дугаар зүйл. Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч

13.1. Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно.

13.7. Ерөнхий аудиторын орлогчийг Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурал томилж чөлөөлнө. Ерөнхий аудиторын орлогчид нэр дэвшигч нь энэ хуулийн 13.2-т заасан Монгол Улсын Ерөнхий аудиторт тавигдах шаардлагуудыг нэгэн адил хангасан байна. Хэрэв Улсын Их Хурал санал болгосон хүнийг нь томилох боломжгүй гэж үзсэн бол Монгол Улсын Ерөнхий аудитор дахин нэр дэвшүүлнэ.

13.8. Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд гаргаж болно.

13.9. Албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй болон биеийн эрүүл мэндийн улмаас албан үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийг Улсын Их Хурал үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

13.10. Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч гэмт хэрэгт сэжиглэгдсэн бол шүүхийн шийдвэр гарах хүртэл Улсын Их Хурал албан тушаалаас нь түдгэлзүүлэх ба гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол албан тушаалаас нь огцруулна.

13.11.Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийн цалин, зэрэг зиндааг Улсын Их Хурал тогтооно.

13.12. Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд тэдгээрийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

13.13. Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогч орон гарсан тохиолдолд 15 хоногийн дотор, Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт дараагийн чуулган эхэлснээс хойш 15 хоногийн дотор тэдгээрийг нөхөн томилно.

16 дугаар зүйл. Аудитын төлөвлөлт

16.2. Үндэсний аудитын газар аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа дараахь зүйлийг харгалзан үзнэ:

16.2.1. Улсын Их Хурал, түүний Байнгын хороодоос ирүүлсэн санал;

20 дугаар зүйл. Санал, зөвлөмж, мэдээлэл

20.2.Монгол Улсын Ерөнхий аудитор улс орны эрх ашгийн төлөө гэж үзсэн аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулж болно.

26 дугаар зүйл. Үндэсний аудитын газрын үйл ажиллагааны тайлан

26.1. Үндэсний аудитын газар үйл ажиллагаагаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнана. Үндэсний аудитын газрын жилийн тайланд тухайн жилийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тайлан болон санхүүгийн тайлан тусгагдана.

Найм. Олон нийтийн радио, телевиз

Олон нийтийн радио, телевизийн тухай хууль (2005)

21 дүгээр зүйлийн 5.2. Монгол Улсын Их Хурал 7 хүн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ.

21.5. Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:

21.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн;

21.5.2. Монгол Улсын Их Хурал 7 хүн;

21.5.3. Монгол Улсын Засгийн газар 4 хүн.

21.7. Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

21.8. Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Ес. Сонгуулийн Ерөнхий хороо

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)

4 дүгээр зүйл. Хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журам

4.2.Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.

4.3.Хорооны дарга, нарийн бичгийн даргыг Хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно.

4.5.Хорооны гишүүний бүрэн эрх нь түүнийг томилсон тухай Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно.

6 дугаар зүйл. Хорооны гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болох

6.6. Хорооны гишүүн огцрох тухай хүсэлтээ Улсын Их Хуралд бичгээр гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Улсын Их Хурлын чуулганы үед гаргасан бол 21 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт гаргасан бол чуулган эхэлснээс хойш 21 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.7. Хорооны гишүүн гэмт хэрэгт холбогдсон, түүнчлэн энэ хуулийн 11.7-д заасны дагуу баривчлагдсан бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын гаргасан санал, шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.8. Хорооны гишүүн гэмт хэрэгт холбогдолгүй, гэм буруугүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн түүний бүрэн эрхийг сэргээж, Улсын Их Хурал тогтоол гаргана.

7 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

7.1.11. ард нийтийн санал асуулга болон сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал, Засгийн газарт санал оруулах;

7.3.1.Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, түүнийг өөрчлөх талаархи саналыг Улсын Их Хуралд оруулах;

7.3.9. сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, сонгогдсон Улсын Их Хурлын нийт гишүүний нэрийн жагсаалтыг үйлдэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган мэдүүлэх, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, нийтэд мэдээлэх;

* * *

Судалгааны үр дүн

Төрийн байгуулалтын байнгын хорооны үйл ажиллагааны чиглэл нь хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, эрхлэх асуудлын хүрээнд төрийн бодлого, Улсын Их Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Мөн түүнчлэн дээр дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Их Хурал түүнээс томилогддог байгууллага болох Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, Монгол Улсын Төв банк /Монголбанк/, Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны төв байгууллага /Төрийн албаны зөвлөл/, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний аудитын газар, Олон нийтийн радио телевиз, Сонгуулийн Ерөнхий хороо болон ард түмнээс сонгогдсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын хүрээнд үйл ажиллагааны үндсэн чиглэлээр тодорхой хуулийн зохицуулалттай ажиллаж байна.

Энэхүү хууль тогтоомжийн хамаарлын хүрээнд **Нэг.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн институтын хүрээнд; түүнийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн тухай хууль гаргах, огцруулах эсэхийг шийдвэрлэх /5,7 дугаар зүйл/

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн хүрээнд; цэцийн гишүүдийг томилох, эгүүлэн татах, төсвийг нь батлах, гаргасан дүгнэлтийг хэлэлцэх **Гурав**. Монгол Улсын Засгийн газрын хүрээнд; Ерөнхий сайд, гишүүдийг нэг бүрчлэн хэлэлцэн томилох, Засгийн газрыг огцруулах, үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, Монгол Улсын яамыг хэлэлцэн хуулиар байгуулж, татан буулгах, агентлагийн ерөнхий бүдүүвчийг батлах

Дөрөв. Улсын Төв банкны /Монголбанк/ хүрээнд; Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарыг зургаан жилийн хугацаатай томилох,албан тушаалаас нь чөлөөлөх, төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө зээлийн байдлын талаар улирал тутам мэдээлж танилцуулах

Тав. Төрийн албаны төв байгууллагын /Төрийн албаны зөвлөл/ хүрээнд; Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох, орон тооны гишүүдийг зургаан жилийн хугацаатай томилох, эгүүлэн татах, зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг батлах, төрийн албатай холбоотой гарсан төрийн албаны маргааны журмыг тогтоох **Зургаа**. Санхүүгийн зохицуулах хорооны хүрээнд; Хорооны дүрмийг батлах, хорооны гишүүдийг томилох, хорооны хуулийн хэрэгжилт, түүнчлэн өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааныхаа талаар жил тутам тайлагнах **Долоо.** Үндэсний аудитын газрын хүрээнд; Монгол Улсын Ерөнхий аудитор болон орлогчийг зургаан жилийн хугацаатай томилж чөлөөлөх, Үндэсний аудитын газар хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа УИХ, түүний байнгын хорооны санлыг харгалзах, үйл ажиллагаагаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнах

Найм. Олон нийтийн радио телевизийн хүрээнд; Олон нийтийн радио телевизийн зөвлөлийн гишүүнийг зургаан жилийн хугацаатай томилж чөлөөлөх

Ес. Сонгуулийн ерөнхий хорооны хүрээнд; гишүүдийг зургаан жилийн хугацаатай томилж чөлөөлөх, ард нийтийн санал асуулга болон сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд санал оруулах, Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, түүнийг өөрчлөх талаархи саналыг Улсын Их Хуралд оруулах, сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, сонгогдсон Улсын Их Хурлын нийт гишүүний нэрийн жагсаалтыг үйлдэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган мэдүүлэх, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зэрэг эрх зүйн зохицуулалтууд тусгагдсан байна.

Улсын Их Хурлын хүрээнд /Улсын Их Хурлын тухай хуулийн 6.13. дахь хэсэг/ гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг гишүүдийн олонхийн саналаар санал дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргахыг хэлэлцэх /мөн хуулийн 11.1.21 дахь хэсэг/ хуулийн зохицуулалт байна.

Парламентын дотоод ажил хариуцсан байнгын хорооны эрх зүйн зохицуулалт

1. Бүгд Найрамдах Польш Улс

Бүгд Найрамдах Польш Улсын Төлөөлөгчдийн танхимын байнгын дүрэм /The Standing Orders of the Sejm of the Republic of Poland/-йн 18.1 дэх хэсэг болон 18.3 дахь хэсэгт Захиргаа, дотоод хэргийн байнгын хороо болон Үндсэн хуулийн тайлагналын байнгын

хороотой байхаар заажээ. Захиргаа, дотоод хэргийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төрийн захиргаа болон аюулгүй байдал, нийгмийн дэг журам болон аюулгүй орчны үйл ажиллагааны журам хамаарна. Харин Үндсэн хуулийн тайлагналын байнгын хороо нь Үндсэн хуулийн дагуу байгуулагдах байгууллагуудын үйл ажиллагааны шудрага байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд энэ талаар тогтоол гаргах, үр дүнгийн талаар танилцуулах чиг үүрэгтэй.

2. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Төлөөлөгчдийн танхимын байнгын дүрэм /Standing Orders of the House of Commons/ 152 дугаар хэсэгт хороодын эрхлэх асуудлын хүрээг тодорхойлжээ. Англи Улсын хувьд төрийн дээд болон засгийн газрын байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагаа, болон парламентын дотоод асуудлыг цаг үеийн шаардлага, өөрчлөлттэй холбоотойгоор хэд хэдэн хороодод харьяалуулсан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн хороо нь хуулиудыг Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс хянаж Үндсэн хуулийн асуудлаар өргөн хэмжээний судалгаа явуулах чиг үүрэгтэй. Энэ хороо нь хуулийн төслөөс гарах үр нөлөөнд үнэлгээ хийх, төслийн талаархи мэдээллийг танхимд өгнө. Байнгын хороо нь Үндсэн хуулийн асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах бөгөөд голлон Засгийн газарт хандсан зөвлөмж бүхий мэдээллийг хүргүүлнэ. Лордын танхимын даргаас жил бүр нотлох баримт хүлээн авч Үндсэн хуулийн асуудлаархи Засгийн газрын байр суурийг тодорхойлно.

Дотоод хэргийн байнгын хороо нь 11 гишүүнээс бүрдэх бөгөөд улс төрийн гурван том намаас энэ хороонд ордог. Дотоод хэргийн яам /хууль зүйн яам/ түүнтэй холбоотой бусад төрийн байгууллагын бодлого, захиргаа болон зардлыг хянах зорилгоор байгуулсан. Уг хороо нь олон нийт болон бүлгээс үндэслэл, нотолгоо бүхий хүсэлт цуглуулж, уг хүсэлтэд үндэслэн дүгнэлт хийж Засгийн газарт хандсан зөвлөмж гаргадаг. Засгийн газар нь энэхүү зөвлөмж нийтлэгдсэнээс хойш хоёр сарын дотор уг зөвлөмжийн талаар хариу тайлбар өгнө. Түүнчлэн Дотоод хэргийн хороо нь Парламентын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна.

Захиргааны хороо нь Их Британи Улсын Парламентын Нийтийн танхимын тусгай хороо /select committee/ бөгөөд 2005 оны 7 дугаар сард өмнөх дотоодын 5 хороог өөрчлөн байгуулсан бол, Арын суудлын ажил хэргийн хороог 2010 оны 6 дугаар сард шинэ байгуулсан. Хороо нь арын суудлын гишүүд (жишээлбэл, Эзэн хааны эсхүл сүүдрийн сайд)-ийг төлөөлөн долоо хоногийн нэг өдөрт ажил хэргээ танилцуулдаг байна. Хороо нь чуулганы эхэнд сонгогдсон 7 гишүүн, даргаас бүрдэнэ. Дарга нь сөрөг хүчний гишүүн байх бөгөөд бусад хороодын гишүүдийн адил журмаар сонгогдоно.

Санхүү ба үйлчилгээний хороо мөн тусгай хороо бөгөөд Танхимын үйлчилгээний төсвийг хянах ба танхимын төсөвт нарийвчилсан судалгаа хийх үүрэгтэй. Гишүүдийн зардлын /The Members' Expenses Committee/ нь 2011 оны 7 дугаар сар хүртэл Гишүүдийн урамшууллын хороо гэж нэрлэгдэж байсан бөгөөд Их Британи Улсын Парламентын Нийтийн танхимын тусгай хороо юм. Нийтийн танхимын гишүүдийн цалин урамшууллын талаар танхимын тэргүүн болон Гишүүдийн үнэлгээний хороонд зөвлөгөө өгнө.

2009 оны 1 сард байгуулагдсан ба Мэдээллийн эрх чөлөөний хуулийн дагуу Гишүүдийн зардлыг нийтэд мэдээлэхтэй холбогдуулан авсан арга хэмжээний хүрээнд байгуулагдсан. 2009 оны гишүүдийн цалин, урамшууллын талаархи хэрүүлийн дараа гишүүдийн зардал, урамшууллын талаархи түр арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж байсан. 2011 оны 5-7 сард сонгуультай холбоотойгоор бараг үйл ажиллагаа явуулаагүй ба хороог шинээр нэрлэн гишүүдийг нь шинээр томилж Парламентын стандартын тухай 2009 оны хуулийн хэрэгжилтийн талаар дараахь асуудлаар тайлан гаргах үүрэгтэй болсон. Үүнд:

1. Татвар төлөгчдийн төлж буй мөнгөний үнэ цэнэ
2. тайлагнал
3. олон нийтийн парламентад итгэх итгэл
4. гишүүд өөрсдийн үүргээ үр ашигтайгаар биелүүлэх чадвар
5. гэр бүлтэй болон дутуу хангамж эдэлсэн гишүүдэд шударга ёс хэрхэн үйлчлэх
6. гишүүдийн хууль ёсны нэхэмжлэл гаргах нь хязгаарлагдсан эсэх. Эдгээр зургаан асуудлаар тайлан гаргана.

Стандарт ба дархан эрхийн хороо /Standards and Privileges Committee/ нь 1995 онд Дархан эрхийн хорооны оронд байгуулагдсан. Парламентын дархан эрх зөрчсөн талаархи гомдлыг хэлэлцэж Танхимд зөвлөмж гаргах 10 гишүүнтэй. Парламентын стадартын комиссарын үйл ажиллагаанд хяналт тавихаар томилогдсон. Гишүүдийн ашиг сонирхлын бүртгэлийг цуглуулах, хадгалах, хүртээмжтэй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд гишүүдийн ашиг соирхлын бүртгэлтэй холбоотой гомдлыг авч хэлэлцэх, гишүүний үйл аижллагааны дүрэмж журмыг зөрчсөн талаархи гомдлыг шалгана.

Журмын хороо /Procedure Committee/ нь мөн тусгай хороо бөгөөд нийтийн үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх журам, практикийг авч хэлэлцдэг. Сонгох хороо /Committee of Selection / нь тусгай хороо боловч бусад хороодтой адилгүй Дотоод үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг бөгөөд онцгой байгууллага, хувь хүнд хамаарна. Энэхүү Сонгох хороо, Стандарт, дархан эрхийн хороо, Хамтын ажиллагааны хороод нь шинэ гишүүн томилох, гишүүнээс чөлөөлөхийг одоо байгаа гишүүд нь шийддэг. Тусгай хороодын гишүүдийг нийтийн танхимд санал оруулах замаар шийддэг бол нийтлэг чиг үүргийн хороо (нийтийн хуулийн төслийн хороо) зэргийг хороо нь өөрийн эрх мэдлийн хүрээнд томилдог.

3. Энэтхэг Улс.

Энэтхэг Улсын Лок Сабха үйл ажиллагааны дүрэм /Rules of Procedure and conduct of business in Lok Sabha/ буюу Төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааны дүрмийн 26 дугаар бүлгийн 253-331 зүйлд Байнгын хороод нь нийлэг чиг үүргийн болон яамд хариуцсан төрөлтэй байхаар заасан. Нийтлэг чиг үүргийн байнгын хороо нь Засгийн газрын баталгааны байнгын хороо байх бөгөөд энэ нь сайд нарын өгсөн амлалт, баталгаа, үйл ажиллагааг судлаж танхимд дараахь мэдээллийг гаргаж өгнө.

1. Засгийн газрын баталгаа, үйл ажиллагааны хэрэгжилтын хүрээ хэмжээ
2. Хэрвээ хэрэгжсэн бол уг хэрэгжилт нь зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай хамгийн бага хугацаанд хэрэгжсэн эсэх

Ийнхүү хоёр мэдээллийн үр дүнд гарсан санал хураалтын дүнгээ танхимд мэдэгдэнэ.

4. Япон Улс.

Япон Улсын Парламентын тухай хууль /The Diet Law/-ийн 41-54 дүгээр зүйлд заасны дагуу "Үндэсний суурь бодлогын хороо /Committee on Fundamental National policy/ гэсэн байнгын хороо үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар Танхим бүрийн байнгын хороо нь тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ / шийдвэрийг оролцуулан/, гомдол болон бусад асуудлыг авч хэлэлцэнэ.

Үндэсний суурь бодлогын хороо нь төрийн үндсэн бодлогыг хэлэлцэх үүрэгтэй. Энэ хороо нь Зөвлөхүүдийн танхимын ижил нэртэй ийм хороотой хамтран хуралддаг ба Ерөнхий сайд ба сөрөг намын удирдагчдын хооронд үндэсний суурь бодлого болон бусад чухал асуудлаар хэлэлцүүлэг хийхэд голлох үүрэгтэй оролцоно. Нэг онцлог нь мөн хуулийн 43 дугаар зүйлд Байнгын хороо бүр мэргэжлийн мэдлэгтэй ажилтан, /Сэнмон

UIH.MN

буюу мэргэжлийн зөвлөх/ болон судлаачидтай байхаар заасан байна. Уг хуулийн 48, 53 дугаар зүйлд зааснаар хорооны дарга нь хорооны ажил хэргийг эмхэлж, хорооны үйл ажиллагааны журмыг сахиулж. хорооны хурлын үйл явц, үр дүнгийн талаар танхимд мэдээлнэ.

5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Парламентын процессын дүрэм /Rules of Procedure of the German Bundestag/-ийн 54-74 зүйлд байнгын хорооны эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Ахмадуудын зөвлөл нь Парламентын дотоод асуудлыг хэлэлцэхэд оролцдог байна. Ахмадуудын зөвлөл нь Германы Бундестагийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, болон бусад 23 гишүүнээс бүрдэнэ. Тус зөвлөлийн гишүүн байхад заавал насаар хамгийн ахмад байх шаардлагагүй, харин улс төрийн амьдралын арвин туршлагатай байх шаардлагатай. Ахмадуудын зөвлөл нь Бундестагийн Ерөнхийлөгчид туслах ба ингэхдээ Бундестагийн үйл ажиллагаа нь аль болох үр ашигтай, хэвийн явагдах боломжийг хангахад туслана. Жишээлбэл долоо хоногийн хуралдааны өдрүүдийг урьдчилан тогтоож хурлаар хэлэлцэх асуудлыг гаргана. Цаашлаад энэхүү зөвлөл нь үүссэн маргааныг хэлэлцэх, эвлэрүүлэх форум болдог. Ахмадуудын зөвлөл нь өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах тул өөрт нь тусгай дэмжлэг үзүүлэх коммиссуудыг томилдог.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Парламентын процессын дүрмийн /Rules of Procedure of the German Bundestag/ долоодугаар бүлгийн 54-74 дүгээр зүйлд заасан байнгын хорооны эрх зүйн зохицуулалт нь Япон Улсын Парламентын байнгын хороотой ижил, төсөөтэй зохицуулалттай байгааг дурдаж байна.

6. Австри Улс

Австри Улсын холбооны хуулийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм /Federal Law on the Rules of Procedure of the National Council/-ийн 29-41 дүгээр зүйлд Гол байнгын хорооны тухай зохицуулсан байна.

Гол хороо /Main committee/ нь Үндэсний зөвлөлийн гурав дахь чиг үүрэг болох холбооны түвшний гүйцэтгэх чиг үүргэгт оролцох үүргээ дамжуулан гүйцэтгэх байгууллага юм. (эхний нэг, хоёр дахь чиг үүрэг нь хууль тогтоох ба хяналтын чиг үүрэг байна). Ийм учраас энэхүү хорооны чиг үүргийг хуулиар хатуу зохицуулсан байдаг. Үндэсний зөвлөлийн Гол хороонд гишүүд тодорхой шийдвэрүүдийг эрх бүхий засгийн газрын гишүүдтэй хамт хэлэлцэнэ. Гол хорооноос баталсан бол шийдвэр гарсанд тооцно.

Энэ нь өөрөө Парламентын байнгын хороо байх бөгөөд дуртай цагтаа хуралдана. Ихэвчлэн Үндэсний зөвлөлийн ерөнхийлөгч эсхүл түүний дэд ерөнхийлөгч энэ хороог даргална. Парламентын бүлгүүдийн дарга нар нь энэ хорооны орон тооны бус гишүүд байна.

Энэхүү гүйцэтгэх захиргааны ажилд оролцсон шинжтэй чиг үүрэг нь бүгд найрамдах улсын үеэс үргэлжлэн шинээр байгуулагдсан төрийн хувьд үргэлжүүлэх парламентад хамаарах зарчмын гол чиг үүрэг болж орж ирсэн. Гэхдээ Холбооны Засгийн газар нь парламентад захирагддаг байсан ба парламент нь холбооны захиргааны үйл ажиллагаанд маш олон төрлийн хяналт болон оролцоотой байсан. Үндсэн хуулийн 1929 оны шинэчлэлээр Холбооны Ерөнхийлөгч, Холбооны Засгийн газрын байр суурийг бэхжүүлсэн бөгөөд парламентад байх эрх мэдлийг цөөрүүлсэн ч гэсэн шийдвэр гаргахад оролцоно гэдэг нь хариуцлагыг хуваан авч байна гэсэн утгаараа энэ хорооны шийдэх асуудлууд нь ихэвчлэн улс орны маш чухал асуудлууд байдаг.

Зарим зохицуулалтууд энэхүү Гол хороогоор батлагдсан байх ёстой, жишээлбэл Засгийн газраас батлах сонгуулийн журам. Хорооны зөвшөөрлийг үндэслэн цэргийг гадаадад илгээх, энх тайвныг сахиулах үйл ажиллагаанд оролцуулах, экспортыг дэмжих, төрийн өмчийг худалдах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд авдаг. Түүнчлэн уг хороо нь дараахь гол бус чиг үүргүүдийг гүйцэтгэдэг:

- Европын холбооны улс төрийн ажилд оролцох Холбооны Үндсэн хуулиар энэ чиг үүргийг Гол хороонд даалгасан байдаг ба энэ нь өөрөө дэд хороодыг байгуулж болно. Энэ төрлийн асуудлыг Үндэсний зөвлөлөөс түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг энэ хороо олгодог.
- Хяналтын шүүхийн Ерөнхийлөгчийг томилох, Омбудсманы гишүүн, Зэвсэгт хүчний комиссийн даргад нэр дэвшүүлэх;
- Үндэсний социализмийн хохирогчдод зориулсан АБНУ -ын үндсэний сангийн удирдах зөвлөлийн гишүүдийг шууд сонгох
- Европын шударга ёсны шүүхийн Австри шүүгч болон Европын холбоон дахь Австри гишүүнийг хэлэлцэх, томилох.

* * *

Судалгааны үр дүн

Бусад орнуудын парламентын дотоод ажил хариуцсан байнгын хорооны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Парламентын тухай хууль болон Хурлын танхимын дүрмээр хэрхэн тусгагдсаныг түүвэрлэн орчуулж судлахад улс орон бүр өөрийн онцлогт тохирсон өөр өөр зохицуулалттай байх ба байнгын хорооны нэршил нь ч мөн өөр өөр байна.

Зарим улсын хувьд парламентын дотоод ажил, Үндсэн хуулиар байгуулагдах төрийн чиг үүргийг гүйцэтгэх байгууллагын асуудлуудыг хуваан хоёр байнгын хороонд хариуцуулсан байхад зарим газар нэг хороонд харьяалагдаж байна. Түүнчлэн энэхүү дотоод асуудал хариуцсан эсхүл Үндсэн хуулийн суурь бодлого хариуцсан хорооны гишүүдийг сонгох, томилохдоо онцлог журамтайгаар зохицуулсан улс орон байх бөгөөд харин бусад хороодтой адил журмаар сонгож томилдог улс орныг тусгайлан бичээгүй юм.

Дээрх зохицуулалтаас үзэхэд тухайн улс орны төрийн бодлого, тулгамдаж буй асуудал, Үндсэн хуульт байгууламжийн онцлогоос хамааран дотоод ажил хариуцсан болон Үндсэн хуулийн хэрэгжилт, төрийн дээд болон Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг эрхлэх хороодыг тус тусад нь байгуулах хандлага ажиглагдаж байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006)
3. Засгийн газрын тухай хууль (1993)
4. Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хууль (2004)
5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль (1993)
6. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль (1992)
7. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (1996)
8. Төрийн албаны тухай хууль (2002)
9. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)
10. Төрийн аудитын тухай хууль (2003)
11. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль (2005)

12. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)
13. Япон Улсын Үндсэн хууль. Орч: П.Амаржаргал Адмон хэвлэл 2011
14. The Diet Law /Парламентын тухай хууль/
15. http://www.shugiin.go.jp/index.nsf/html/index_e.htm
16. http://www.sangiin.go.jp/eng/index.htm
17. Дэлхийн Улс орнуудын парламентын ажлын алба. Адмон хэвлэл 2012
18. Polish Constitutional Law: The Constitution and selected statutory materials. Chancellery of Sejm Warsaw 2009
19. The Standing Orders of the Sejm of the Republic of Poland
20. Магна Харт. Орч: П.Амаржаргал. Ред: Н.Лүндэндорж Мөнхийн үсэг хэвлэл 2012
21. http:/parliament.uk/business/committee
22. Standing Orders of the House of Commons. Published by The House of Commons 2012
23. Rules of Procedure and conduct of business in Lok Sabha. Secretariat 2010
24. Rules of Procedure of the German Bundestag as published in the Notification of 2 July 1980 (Federal Law Gazette I, p. 1237) and as amended by the Notification of 20 August 2008
25. Federal Law on the Rules of Procedure of the National Council. Promulgations: BGBl. [Federal Law Gazette] No. 410/1975 as amended in BGBl.
26. http://www.parlament.gv.at/ENGL/PERK/RGES/
27. http://www.bundestag.de/htdocs_e/documents/legal/index.html

ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨДЛИЙН ХОРООНЫ ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Р. Хатанбаатар, Г. Алтан - Оч (Ph.D), А. Пагма,
Ө. Мөнхтунгалаг, Б. Нарантуяа

УДИРТГАЛ

УИХ-ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р.Бурмаагийн захиалгаар “Гадаадын зарим орны парламентын Өргөдлийн хороодын талаархи харьцуулсан судалгаа”сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв. Үүний өмнө 2011 онд Төрийн байгуулалтын Байнгын хорооны даргын захиалгаар “Гадаадын зарим орны парламентын Өргөдлийн хороодын талаархи харьцуулсан судалгаа” хийсэн бөгөөд тус судалгаанд Европын Парламент, ХБНГУ, Австрали, Энэтхэгийн парламентын Өргөдлийн хорооны үйл ажиллагааны талаар харьцуулан судалсан болно.

Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагууд иргэд, олон нийтийн зүгээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг өөрийн аль нэг бүтцээр дамжуулан хүлээх авч шийдвэрлэдэг ба харин парламентын Өргөдлийн Байнгын хороогоор дамжуулан шийдвэрлэдэг нь бидний авч үзсэн дээрхи хэдэн улс орнууд байгаа болно.

Энэ удаагийн судалгаанд бид өмнөх судалгааны зарим материалыг захиалгын дагуу дэлгэрүүлэн судалж нээлттэй хэлэлцүүлэг, гэрч болон бүрдүүлсэн материалыг хамгаалах, парламентыг үл хүндэтгэх гэмт хэрэг, түүнд хэрхэн шийтгэл ногдуулах, өргөдлийн байгнын хорооноос өргөдлийг судлан ангилж, зохих газруудад шилжүүлэн шийдвэрлүүлэх, эргэж мэдээлэх зэрэг асуудал, түүнчлэн асуудлыг нарийвчан үзэхэд дөхөм болгон ХБНГУ-ын Бундестагын “Өргөдлийн Байнгын хорооны бүрэн эрхийн тухай” хууль, Өргөдлийн хорооны дүрэм зэрэг баримт бичгийг албан бусаар орчуулан хавсаргасан болно.

Судалгааны зорилго:

Гадаадын зарим орны, тухайлбал, Австрали, ХБНГУ, БНЭУ-ын Өргөдлийн хороодын чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг судалж, туршлагыг харьцуулан гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Гадаадын зарим орны парламентын Өргөдлийн байнгын хорооны дүрэм, чиг үүргийн зохицуулалтыг харьцуулан судлах,
- Гадаадын зарим орны парламентын нээлттэй сонсголын зохион байгуулалт, зохицуулалтыг харьцуулан судлах,
- Дээрх орнуудын парламентын Өргөдлийн байнгын хороодын чиг үүргийн талаар харьцуулан дэлгэрэнгүй материал бэлтгэх зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын Үндсэн хууль, парламентын Дэгийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны парламентын нээлттэй сонсголын зохион байгуулалт, зохицуулалтыг харьцуулах
- Судалгааны материалыг нэгтгэн тайлан бичих

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

Хамрах хүрээ:

1. Австрали, ХБНГУ, БНЭУ-ын Өргөдлийн байнгын хороодын дүрэм, чиг үүрэг
2. Парламентын нээлттэй сонсголыг зохион байгуулах журам
3. Гэрч болон бүрдүүлсэн материалыг хамгаалах асуудал
4. Парламентын эсрэг гэмт хэрэг, парламентыг үл хүндэтгэх гэмт хэрэг, тэдгээрт ногдуулах шийтгэлийн эрх зүйн зохицуулалт

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р.Хатанбаатар ахалж, ХБНГУ -ын парламентын талаар ахлах референт Г.А лтан-Оч, Австралийн парламентын талаар референт-шинжээч А. Пагма, БНЭУ -ын парламентын талаар референт - судлаач Б. Нарантуяа, ХБНГУ -ын Өргөдлийн байнгын хорооны эрх зүйн баримт бичгүүдийг референт - судлаач Ө. Мөнхтунгалаг нар тус тус хийж гүйцэтгэв.

* * *

1. АВСТРАЛИ УЛС

1.1. Австралийн Парламентын Төлөөлөгчдийн Танхимын Өргөдлийн байнгын хорооны чиг үүрэг /Standing Committee on Petitions/

Австралийн Парламентын доод танхим болох Төлөөлөгчдийн Танхим нь 15 байнгын хороотой бөгөөд Өргөдөл, хүсэлтийн байнгын хороо нь 2008 оны 12 дугаар сард батлагдсан Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн дагуу байгуулагдсан байна. Тус Дэгийн 16 дугаар хэсгийн 220 дугаар зүйлд Төлөөлөгчдийн Танхимын Өргөдлийн байнгын хорооны чиг үүргийг “Аливаа асуудлаар Төлөөлөгчдын Танхимд хандсан өргөдөл, хүсэлт, гомдлыг хүлээн авч барагдуулах явдал мөн” гэж тодорхойлжээ. Тус Байнгын хороо нь 10 гишүүнтэй байх ба 6 Засгийн газрын гишүүн депутат, 4 Засгийн газрын гишүүн бус депутатаас бүрдэнэ гэдгийг мөн Дэгд заажээ. Түүнчлэн Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн 15 дугаар хэсгийн 204-209 дэх зүйлд өргөдөл, гомдол гаргах журмыг тодорхойлсон байна[106]. Одоо үүнийг авч үзье.

Өргөдлийн хэлбэр, агуулга

1. Өргөдөл нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:
   - Төлөөлөгчдийн Танхимд хандсан байх,
   - Танхимын эрх хэмжээнд хамааралтай асуудлаар өргөдөл, хүсэлтийг гаргах,
   - Хүсэлт гаргаж буй шалтгааныг тодорхой дурьдах,
   - Танхимын зүгээс ямар үйлдэл хийх хүсэлтийг агуулах,
2. Өргөдлийн үг хэллэг, нэр томъёо нь хоёрдмол утгагүй байх ба өргөдөл нь 250 үгээс хэтрэхгүй байна. Нэр томъёоны ойлголтыг өргөдлийн нэгдүгээр хуудасны дээд талд бичих ба харин хүсэлтийг өргөдлийн нэг хуудас алгасан дээд талд нь бичнэ.

[106] House of Representatives Standing and Sessional Orders. http://www.aph.gov.au/

3. Өргөдөл, хүсэлтийн үг хэллэг, агуулга нь хууль бус байж болохгүй ба хууль бус үйлдлийг дэмжсэн байж болохгүй. Хэллэг нь аядуу байх,
4. Өргөдөл, хүсэлт англи хэл дээр байх ба эсхүл албан ёсны орчуулгатай байна. Орчуулагчийн нэр, хаягыг бичнэ.
5. Өргөдөлд ямар нэгэн баримт, захидал хавсаргах шаардлагагүй. Хавсаргасан тохиолдолд Танхимд танилцуулахын өмнө тэдгээрийг өргөдлөөс хасна.
6. Компаниас гаргасан өргөдөл дээр тухайн компаний тамгыг дарсан байх ёстой. Компаний тамгагүй тохиолдолд хүсэлтийг гарын үсэг зурсан хувь хүмүүсийн хүсэлт гэж ойлгоно.

Гарын үсэг зурах журам

- Өргөдлийн эхний хуудсан дээр гол хүсэлт гаргагчийн гарын үсэг, нэр, хаягийг бичнэ.
- Өргөдөлд хүн бүхэн өөрөө гарын үсгээ зурна. Зөвхөн өөрөө гарын үсгээ зурах боломжгүй хүн бусдаар өөрийн нэрийн өмнөөс гарын үсэг зуруулах боломжтой.
- Гарын үсэг нь хувилсан, хуулсан, наасан, хуудасны ар талд болон хоосон хуудсан дээр зурсан байж болохгүй.
- Парламентын гишүүн өргөдлийн гол хүсэлт гаргагч болон гарын үсэн зурагч байж болохгүй.

Өргөдөл гаргах танилцуулах

- Өргөдөл, хүсэлтийг шууд Байнгын хороонд болон парламентын гишүүнээр дамжуулан гаргаж болно.
- Өргөдөл, хүсэлтийн Байнгын хороо өргөдлийг журмын дагуу шалгаж, шаардлага хангасан өргөдлийг Танхимд танилцуулахаар хүлээн авна.

Өргөдлийг танилцуулах

- Өргөдлийг хоёр замаар танилцуулж болно. Үүнд:

  1. Чуулган дээр Өргөдлийн Байнгын хорооны дарга танилцуулах мөн Байнгын хорооны өөр нэг гишүүн энэ асуудлаар танилцуулга хийж болно. Танилцуулах хугацаа 10 минут.

  2. Тус Байнгын хорооны бусад гишүүд Чуулганы хуралдаан, Ерөнхий хорооны (Main Commitee) хуралдаан дээр болон хэлэлцүүлгийн завсарлагаанаар Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн зохих заалтын дагуу танилцуулна. Үүнд:

  a. Дэгийн 43 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөгчдийн Танхимын Даргын нэр цохсон гишүүд үг хэлэх үедээ 90 секундээс илүүгүй хугацаанд өргөдөл, хүсэлтийг танилцуулна
  b. Дэгийн 193 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхий хорооны хуралдаанд гишүүд сонгогчдын нэрийн өмнөөс (constituency statements) үг хэлэхдээ 3 минутын хугацаанд өргөдөл, хүсэлтийг танилцуулна
  c. Дэгийн 31 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлгийн завсарлагааны үеэр (adjournment debate) өргөдөл, хүсэлтийг танилцуулна
  d. Дэгийн 192B- д заасны дагуу Ерөнхий хорооны хуралдаанд гомдлыг хянан хэлэлцэх (Grievance debate) үеэр өргөдөл, хүсэлтийг танилцуулна

UHL.MN
СУДАЛГААНЫ САН

Өргөдлийн талаар шийдвэр гаргах

Төлөөлөгчдийн танхимаас авах арга хэмжээ

- Өргөдөл, хүсэлтийн хэлэлцүүлгийг танилцуулагын үед Дэгийн 207 б-д заасны дагуу явуулна.
- Байнгын хорооноос тэр дор нь буцаасан өргөдөл, хүсэлтээс бусад өргөдөл, хүсэлт Танхимаар хэлэлцэгдэн шийдвэрлэгдэнэ.
- Өөр бусад Байнгын хорооны хамаарах асуудлаарх өргөдөл, хүсэлтийг зохих хороонд шилжүүлнэ.
- Өргөдөл, хүсэлтийн Байнгын хороо Төлөөлөгчдын Танхимын нэрийн өмнөөс хүсэлт гаргагчид хариуг өгч, энэ талаар Танхимд тайлагнана.

Өргөдлийг хариу авахаар сайдуудад шилжүүлж болно

- Өргөдөл, хүсэлтийг Танхимд танилцуулсаны дараа өргөдөлд хөндөгдсөн асуудлыг хариуцсан сайдад хуулбарыг илгээж болно.
- Сайд өргөдлийг хүлээн авч 90 хоногийн дотор Байнгын хороонд бичгээр хариуг ирүүлнэ.
- Байнгын хорооны дарга сайдын ирүүлсэн өргөдлийн хариуг мэдээлнэ. Үүний дараа энэ хариуг Танхимын хуралдааны тэмдэглэлд (Hansard) хэвлэх ба вебсайтад байршуулна.
- Өргөдлийн Байнгын хороо нь мөн Засгийн газрын албан тушаалтан болон гол өргөдөл гаргагчийг урьж өргөдлийн асуудлаар ярилцлага хийх эсэхийг шийднэ.

1.2. Нээлттэй сонсгол зохион байгуулах журам

Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн 235 дугаар зүйлд[107] Байнгын хороо, дэд хороо нь хуралдаан болон сонсголыг хаалттай хурал (private meeting), гэрчүүдийг сонсох (hearing witnesses), ингэхдээ нээлттэй болон хаалттай хэлбэрээр, бусад Танхимын практикт хэрэглэдэг уулзалт, хэлэлцүүлэг, хяналт шалгалтын хэлбэрээр явуулна гэж заажээ. Байнгын хорооноос нээлттэй сонсгол зохион байгуулах журмын талаар авч үзье.

Дээр дурьдсанчилан Дэгийн дагуу нээлттэй сонсгол хийх үед гаднаас хүмүүсийг хүлээн авна. Сонсголд олон нийт болон хэвлэлийнхэн өргөн оролцдог ба Байнгын хорооны нарийн бичгийн дарга нарын газраас нээлттэй хэлэлцүүлгийн талаар урьдчилан олон нийт, хэвлэлийнхэн, энэ талаар сонирхсон хувь хүмүүс, байгууллагуудад мэдэгдддэг.

Хурал даргалагч ба хурлыг ахалж байгаа гишүүн сонсголыг нээж товч мэдээлэл хийн, сонсголын зорилго, дэгийг танилцуулна. Дараа нь гэрчийг дуудан суулгах ба гэрч нь үнэн зөв мэдүүлэг өгөх тухайгаа батлан хэлнэ. Үүний дараа Хурлын дарга асуух, гэрч хариулт өгөх хэлбэрээр өөрийн бүтэн нэр, тус сонсголд ямар үүрэгтэй оролцож байгаа, хэнийг төлөөлж байгаагаа тайлбарлана. Мөн өргөдөлд дахин нэмэлт оруулах хүсэлтэй эсэхээ илэрхийлнэ. Хорооны гишүүд гэрчээс асуулт асууж эхлэхээс өмнө хурал даргалагч түүнийг товч үг хэлэхийг урина.

Байнгын хорооны хуралдаан дээр гэрчүүдээс мэдүүлэг авах нь журмын дагуу явагдах ба бүх асуулт хариулт нь хурал даргалагчаар дамжина, мөн байнгын хорооны бүх гишүүдэд асуулт асуух ижил боломж олгогдоно. Гол төлөв гэрчийн бичгээр өгсөн өргөдөлдөө хөндсөн асуудлын дагуу асуулт тавигдана, гэхдээ энэ нь зөвхөн өргөдлийн дагуу асууна гэсэн үг

[107] Rules for form and content of petitions. House of Representatives Standing and Sessional Orders http://www.aph.gov.au/

бас биш юм. Хорооны гишүүн болон гэрч асуултыг эсэргүүцэж болно, харин гэрч асуултанд хариулт өгөх эсэхийг хурал даргалагч шийднэ. Харин хурал даргалагчийн шийдвэртэй байнгын хорооны гишүүн санал нийлэхгүй тохиолдолд сонсголыг завсарлуулан байнгын хороо энэ асуудлыг хаалттай хэлэлцэх эсэхийг шийднэ. Шаардлагатай бол энэ асуудлыг санал хураалт явуулж шийдэж болно.

1989 онд Дэгийн хорооноос дараах заалтуудыг бүх хороод мөрдлөгө болгохоор заасан байна. Үүнд:

- Байнгын хорооны дарга нь гэрчид тавигдах бүх асуултууд өргөдөлтэй холбоотой байх, танилцуулагдаж буй мэдээлэл нь асуулгын зорилготой нийцсэн байх асуудлыг хариуцах ёстой,
- Гэрч асуусан асуултанд хариулахаас татгалзвал түүний нэр төрд халдаж болохгүй. Харин ийм тохиолдолд яагаад хариулахыг хүсэхгүй байгаа талаараа үндэслэлээ гаргавал хаалттай хэлэлцүүлэг хийж болно.
- Хаалттай хэлэлцүүлэгт заавал хариулт авахыг шаардах боловч байнгын хороо шийдвэрээ гаргах үедээ олон нийтийн нээлттэй хэлэцүүлэгээр хариулт авах шаардлагаггүй бол хаалттай хийнэ.
- Гэрчээс нээлттэй хэлэлцүүлгийн үед хариулт өгөхийг шаардах боловч гэрч хүсэхгүй бол энэ тухай Танхимд мэдээлнэ.

Дээрх заалтуудаас гадна нээлттэй сонсголын талаар дараах гурван чухал заалт бий. Үүнд:

1. Нээлттэй сонсголын талаар гэрчид урьдчилан мэдэгдэх ёстой. Гэрч хуралдааны өмнө ирж хэлэлцэгдэх асуудалтай танилцан, хуулбарыг авах, шаардлагатай бол олон нийтэд ил болсон холбогдох баримтыг авч болно.
2. Гэрч нь амаар мэдүүлэг өгөхөөс өмнө бичгээр мэдүүлэг өгөх боломжоор хангагдсан байх ёстой.
3. Гэрч нь байнгын хороонд гаргаж өгсөн баримт бичиг, баримтуудтай өөрөө зохих ёсоор танилцсан байх ёстой зэрэг болно.

Нээлттэй сонсгол дээр гэрчээс зөвхөн байнгын хорооны гишүүд асуулт асууна. Гэрч өөрөө байнгын хорооны гишүүд бусад хүмүүсээс асуулт асуухгүй, зөвхөн тодруулах зорилгоор асууж болно. Байнгын хорооны ажилтан, зөвлөхүүд гэрчээс асуулт асуух, нээлттэй сонсгол явагдаж байх үед ямар нэг тайлбар хийх, хэлэлцүүлгийн албан ёсны үйл ажиллагаанд оролцох эрхгүй. Гэрчүүд хурлын протоколтой танилцан бага зэрэг өөрчлөлт оруулж болох боловч утгын хувьд өөрчлөлт оруулахыг хориглодог байна.

1.3. Тодорхой өргөдлийг шийдвэрлэсэн байдал

Өргөдлийн байнгын хороо өргөдлийг Танхимд танилцуулсны дараа зохих байнгын хороодод шилжүүлдэг ба тухайлбал, Төлөөлөгчдийн Танхимын Эрүүл мэнд, наслалтын (Health and Ageing) байнгын хороонд шилжүүлсэн нэгэн өргөдөлд Парламентын гишүүн, Эрүүл мэндийн сайд хариу өгсөн байна.

Австралийн хэсэг иргэд эрүүл мэндийн хувийн даатгалын тогтолцоог туршиж байгаатай холбогдуулан туршилтын явцад зарим хүмүүс одоо байгаа эрүүл мэндийн даатгалаа багасгах, зогсоох шийдвэр гаргасны улмаас ачааллаа даахгүй байгаа одоогийн эрүүл мэндийн тогтолцоонд дарамт учирч магадгүй байгааг шалгаж өгөхийг хүсч Төлөөлөгчдийн Танхимын дарга, гишүүдэд өргөдөл гаргасан байна.

Энэхүү өргөдөлд дээр дурдсанчилан Эрүүл мэндийн сайд хариу өгсөн ба тэрээр 2012 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар эрүүл мэндийн хувийн даатгалын нөхөн төлбөр ба

эрүүл мэндийн заавал даатгалын нэмэгдэл шимтгэлийн харьцааг нас насаар нь, түвшин, түвшингээр нь тооцон гаргаад эрүүл мэндийн хувийн даатгалын тогтолцооны улмаас эрүүл мэндийн тогтолцоонд дарамт ирж болзошгүй тухай Та бүхний өргөдлийн дагуу тооцоо хийж үзэхэд уг асуудал Австралийн 10 айлын 9-д нь ямар ч нөлөө үзүүлэхгүй, иргэдийн 99.7 хувь нь клиник эмнэлгийн даатгалаа хэвээр хадгална. Зөвхөн 27000 хүн одоогийн эрүүл мэндийн даатгалаа зогсоосон байна. Гэтэл зөвхөн өнгөрсөн жил 10,11,12 сард 50000 хүн хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь энэ салбар хүчтэй бөгөөд улам хөгжиж өсч байна гэж хэлж болно. Хувийн эрүүл мэндийн даатгалаас татгалзсан цөөн тооны хүмүүс улсын клиникийн эмнэлгүүдэд мэдэгдэхүйц ачаалал өгөхгүй ба нөхөн төлбөр нэмэгдэхгүй гэжээ[108].

1.4. Парламентын эсрэг гэмт хэрэг, парламентыг үл хүндэтгэх гэж ямар үйлдлийг үзэх вэ?

Австралийн парламентын 1987 онд баталсан “Парламентын эрх ямбын тухай хууль”-иар (Parliamentary Privileges Act 1987) парламентын танхимууд, гишүүд болон хоёр танхимын хороодын бүрэн эрх, эрх ямба, халдашгүй байдлыг тогтоосон бөгөөд парламентын танхимууд юмуу гишүүдийн эрх ямба, халдашгүй байдлыг зөрчих болон үл хүндэтгэхийг **парламентын эсрэг гэмт хэрэг** гэж үздэг байна.

Тус хуулийн 3А заалт ёсоор энэ хуулийн эсрэг бүх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэгт зааснаар ангилна. (Тайлбар: Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэг нь эрүүгийн хариуцлага оногдуулах ерөнхий зарчмыг тогтооно). Гэхдээ тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлэн парламентын танхимын эсрэг гэмт хэрэгт Эрүүгийн хуулиар шийтгэл оноохгүй. Хуулийн 7 дугаар зүйлд парламентын эсрэг гэмт хэрэгт оноох шийтгэлийг заасан байна:

1. Хэн нэг этгээд парламентын эсрэг гэмт хэрэг хийсэн гэдгийг парламентын танхимаас тогтоосон бол 6 сар хүртэл хугацаагаар хорих ял оноож болно.
2. Парламент завсарласан, парламентыг тараасан болон парламентын бүрэн эрхийн хугацаа дууссан зэрэг тохиолдол нь оноосон хорих ялыг цуцлах үндэслэл болохгүй.
3. Парламентын танхим нь энэ хуулинд заагдсанаас өөр тохиолдолд хорих ял оноохыг шаардах эрх байхгүй.
4. Аливаа этгээд парламентын эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэдгийг парламентын танхимаас тогтоосон тохиолдолд:
   - а. Хувь хүн бол 5000 австрали доллараас хэтрэхгүй
   - б. Корпораци бол 25000 австрали доллараас хэтрэхгүй хэмжээний торгууль оноож болно.
5. Хорих ялаар шийтгэгдсэн этгээдэд торгууль оноохгүй гэсэн шийтгэлүүдийг ногдуулдаг байна.

Дээр дурдагдсан нээлттэй болон хаалттай сонсголд мэдүүлэг өгдөг гэрчүүдийг хамгаалах үүднээс Парламентын эрх ямбын тухай хуулийн 12(1) дугаар заалтыг зөрчсөн хууран мэхлэх, айлгах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр сүрдүүлэх ямарваа ашиг, урамшуулал өгөхөөр санал тавих, амлах, бусад хууль бус арга хэрэгслээр хэн нэг этгээдийг парламент, хороодод гэрчийн мэдүүлэг өгөх, эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзуулах зэргээр нөлөөлөх зэрэг үйлдлийг **парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг** гэж үзнэ.

Хэн нэгнийг парламент болон хороодод мэдүүлэг өгөх болон өгөхгүй байх, баталгаа, нотолгоо гаргах болон гаргахгүй байхад албадан аливаа шийтгэл оноосон, биед нь гэмтэл

[108] Standing and Sessional Orders.As at 20 october 2010. . http://www.aph.gov.au

учруулсан, мөн тухайн этгээдийн олох ашиг, тэтгэмж, эрх мэдлийг хассан этгээдийг мөн хуулийн 12(2) заалт ёсоор парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр хуульчилжээ. Эдгээр парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэгт мөн дараах шиитгэлийг ногдуулна:

- Хувь хүн бол 5000 австрали доллараас хэтрэхгүй эсвэл 6 сар хүртэл хорих,
- Корпораци бол 25000 австрали доллараас хэтрэхгүй хэмжээний торгууль оноож болно.

Парламентын эрх ямбын тухай хуулийн 12 дугаар заалт нь парламентыг үл хүндэт-гэсэн этгээдэд парламентын зүгээс өөр арга хэмжээ авахад нөлөөлөхгүй. Парламентын танхим болон хороодын зөвшөөрөлгүйгээр парламент болон хороодод зориулан бэлтгэсэн ба танилцуулсан, парламент болон хороодоос баримт нотолгоо болгон авсан баримт бичиг, парламент болон хороодоос баримт нотолгоо болгон авсан аман мэдүүлгийн тайланг хэвлэсэн буюу задласан этгээд мөн дээрхийн адил шийтгэл хүлээнэ.

2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

2.1. ХБНГУ -ын Бундэстагын Өргөдлийн байнгын хороо

Германы Бундэстаг нь ХБНГУ-ын парламент юм. Чухал салбар бүрээр бундэстагт байнгын хороод ажилладаг. Байнгын хороо нь 15-42 гишүүнтэй байх бөгөөд чуулган дахь фракцуудын (бүлгийн) бүтцийг хадгалсан байдаг. Гадаад хэрэг, Европын холбоо, Батлан хамгаалах болон **Өргөдөл (петицион)** гэсэн дөрвөн байнгын хороог ХБНГУ-ын Үндсэн хуулиар тогтоосон байдаг. Харин бусад бүх хороог парламентын бүрэн эрхийн хугацаа эхлэхэд тоог нь тогтоож, бүрэлдэхүүнийг нь баталдаг.[109]

Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо 26 гишүүнтэй ба Бундэстагийн нэр дээр иргэнээс өргөдөл (петицион)-өөр гаргасан хүсэлт болон гомдлыг хариуцах хороо юм. Иргэн бүр Бундэстагт хандаж өргөдөл гаргах үндсэн эрх нь Германы Үндсэн хуулийн 17-р зүйлд тусгагдан баталгаажсан байдаг.[110] Тус байнгын хорооны статусыг Үндсэн хуулийн 45с дэх зүйлд заасан хуулиар зохицуулна гэж тусгайлан онцгойлж тодорхойлсон байна[111]:

45с дэх зүйл

(1) Бундэстаг нь 17 дахь заалтанд тусгагдсаны дагуу иргэнээс Бундэстагт хандаж гаргасан хүсэлт, гомдлыг барагдуулах Өргөдлийн байнгын хороог байгуулж ажиллуулна.

(2) Гомдлыг шалгаж барагдуулахад Байнгын хорооны эдлэх эрх үүргийг холбооны хуулиар зохицуулна.

Байнгын хорооны энэхүү эрх нь, баримт бичиг гаргуулах эрх, мэдээлэл олж авах, төрийн захиргааны байранд нэвтрэх зэрэг үйл ажиллагаатайгаа холбоотой нотлох баримтыг олж авах баталгааг хангаж өгдөг. Үүнийг зөвхөн хуулийн дагуу үйл явцыг нууцлах шаардлагатай, эсвэл бусад хүчээр нууцлах нөхцөл байдалд л татгалзаж болно.

Шүүх болон төрийн захиргааны байгууллага нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй

[109] House of Representatives Practice (6th Edition). September 2012. http://www.aph.gov.au

[110] Австралийн парламентын доод танхимын Өргөдлийн байнгын хорооны нээлттэй сонсголуудын протоколтой тус байнгын хорооны вебхуудаснаас танилцаж болно. http://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House_of_Representatives_Committees?url=petitions/

[111] Өргөдөл болон түүнд өгсөн хариуг хавсаргав.

байдаг. Өргөдлийн байнгын хороо нь өргөдөл гаргагч, гэрч болон мэргэжилтнийг урьж авчран байцааж (мэдүүлэг авах) болно. 2009 оны тайлангийн жилд 18,881 өргөдөл ирсэн нь өмнөх оноос даруй 800 гаруйгаар их байна. Байнгын хороо 17,217 өргөдлийг барагдуулсан байна. Үүнээс 10,478 өргөдлийг парламентын хуралдаанаар оруулалгүй шийдсэн байна. Үүнээс 38%-ийг зөвлөлгөө, мэдээлэл, зааварчилгаа, материал илгээх г.м. арга замаар шийдвэрлэсэн. 14.3% нь аноним, доромжилсон, эсвэл гутаасан шинжтэй сэтгэгдлээ илэрхийлсэн байдалтай байв. 8.5%-ийг нь холбогдох холбооны муж улсад шилжүүлсэн байна.

Парламентын хуралдаанд 6,739 өргөдлийг оруулан хэлэлцүүлжээ. Үүнээс 4,731 (27.5%) нь “үгүй”, 1.316 (7,6 %) нь асуудалд эерэг, 692 (4.1%)-ийг холбогдох байгууллага руу нь шилжүүлж шийдсэнээр хариу гаргасан байна. Уламжлал ёсоор, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхэлсэн ажилтай холбоотой өргөдөл хамгийн олон буюу 3,930 өргөдөл иржээ. Харин Хуульзүйн яамтай холбоотой өргөдөл мэдэгдэхүйц өсөж 2,399 болсон байна.[112]

2009 онд дараахь өргөдлүүд хамгийн их олон нийтийн санал авчээ:[113]

1. Интернэтийн сайтуудыг эс индексжүүлэх болон хориглох (134,015 хүн үзэглэсэн)
2. Хөгжмийн урлагийн тоглолтын болон механикаар олшруулах эрхийн нийгэмлэг (106,575)
3. Компьютерийн тоглоомыг хориглохын эсрэг (73,002) г.м.

Өргөдлийн тоо 2002 оноос хойш байнга өсөх хандлагатай байна.[114] Иргэн хувийн асуудлаар ганцаарчилсан өргөдөл гаргаж болно. Харин ерөнхий асуудлаар олон нийтийн өргөдөл гаргана. 2005 оноос хойш онлайнаар өргөдөл ирүүлэх боломжтой болсон. Үүнийг **цахим-өргөдөл** гэж нэрлэдэг.

Олон нийтийн өргөдөл гаргаж байгаа үед өргөдлийн текстийг эхлээд 6 долоо хоногийн турш онлайн байршуулдаг (өргөдөл гаргагч хүсвэл өөр хугацаа тавьж болно) ба энэ хугацаанд хэн ч танилцаад өөрийн нэрийг бичиж үзэглэж болдог. Үйл ажиллагааны үндсэн зарчим бол бүх өргөдлийг тэгш үзэхэд оршино. 2008 оноос хойш Бундэстагийн шинэ вэбсайт ажиллаж эхэлсэн ба форумаар дамжуулан иргэд санал хүсэлтээ гаргах, мэтгэлцээнд оролцох боломжтой болсон. Өргөдлийн хариуг иргэн эмайлээр авах буюу хэрэв олон нийтийн өргөдөл бол Интернэтэд нийтэлнэ.

Хичнээн өргөдлийн дагуу өөрчлөлт оруулсан эсэхийг мэдэх боломж хараахан байхгүй. Хүсэлт ихэвчлэн хууль, эрзүйн актуудтай холбоотой санал (хүчингүй болгох, нэмэлт оруулах эсвэл өөрчлөх) зонхилдог. Иргэдээс гаргадаг гомдол ихэнхдээ хууль юмуу захиргааны байгууллагын шийдвэрийн эсрэг чиглэсэн байдаг. Бундэстагийн дарга өргөдлийг хүлээж аваад Өргөдлийн байнгын хороонд шилжүүлдэг. Хэрэв өргөдлийн утга нь мэргэжлийн зөвлөлгөө авах шаардлагатай бол холбогдох байнгын хорооны саналыг авдаг.[115]

Өргөдлийн байнгын хороо нь хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган

[112] Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо/Petitionsasusschuss des Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Petitionsausschuss_des_Deutschen_Bundestages

[113] Мөн тэнд

[114] Мөн тэнд

[115] Бундэстагийн дүрэм/Geschdftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311

жагсаалтаар сар бүр Бундэстагийн чуулганд оруулж тайлагнана. Үүнээс гадна тус байнгын хороо нь жил бүр Бундэстагт бичгээр тайлангаа тавьдаг. Тайлангуудыг хэвлэж тараах ба чуулганы үед тайлагнагч амаар тодруулга хийж болно. Зөвхөн аль нэг бүлгээс юмуу чуулганд оролцогч гишүүдийн 5% шаардсан тохиолдолд амаар тайлагнаж болно. Өнөөдрийг болтол, шийдвэрийн төслийг дэмжихгүй байсан тохиолдол Бундэстагт огт гараагүй. Өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэнэ. Ингэхдээ шалтгаануудыг заавал заасан байна.

Бундэстагийн өргөдлийн байнгын хороонд 80 гаруй хүн өндөр ачаалалтайгаар ажилладаг. Хоёр Герман нэгдсэнээс хойш өргөдлийн тоо эрс өссөн ба жилд дунджаар 20 мянга гаруй болдог. Ийнхүү өргөдлийн хороо нь ажиллах явцдаа олонхи өргөдөл гаргагчид зөвлөлгөө өгч, туслалцаа үзүүлэхээс гадна Бундэстагт гаргасан хууль болон захиргааны шийдвэр нь алдаатай, орхигдуулсан (*хуулийн цоорхой* [ГА]), шударга бус байсныг илрүүлж, эрхзүйн орчныг сайжруулахад чухал үүрэгтэй юм.

Өргөдлийн хороо ирсэн өргөдөлд хариу өгөхгүй байж болох тохиолдол бий. Жишээ нь, аноним, будлиантай (учир нь олдохгүй [ГА]), эсвэл шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй байгаа асуудлаар өгсөн өргөдөл хамаарна. Ирсэн нийт өргөдлийн нилээд их (ойролцоогоор 25%) хувь л өөрт хамаарах тул Бундэстагийн өргөдлийн байнгын хороо шийдвэрлэдэг.[116]

ГУРАВ. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

3.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Парламентын Өргөдлийн байнгын хороо

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хууль тогтоох дээд байгууллага нь парламент бөгөөд хоёр танхимтай. Үүнд:

A. Дээд танхим буюу Төрийн зөвлөл /Council of States/
B. Доод танхим буюу Ард түмний танхим /House of The People/

Өргөдлийн хороо

Ард түмний танхим /Lok Sabha/-ын Өргөдлийн байнгын хороо нь танхимын ууган хороо юм. Анх 1924.02.20-нд Ерөнхийлөгчийн Төв хууль тогтоох хурал /ассемблей/-аас байгуулж байсан. Анхны өргөдлийг тус ассемблейд 1922.09.14-нд гаргасан байна. Байнгын хорооны анхны тайлан мэдээг 1925.02.19-нд Ассемблейд Дэд Ерөнхийлөгч танилцуулж байсан бөгөөд өргөдлийн утга нь Энэтхэгийн Эрүүгийн хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал байжээ. Байнгын хорооны нэр нь 1933 оныг хүртэл “Олон нийтийн өргөдлийн хороо” /”Committee on Public Petitions”/ гэж байсан ба түүнээс хойш Өргөдлийн хороо /”Committee on Petitions”/ гэж өөрчилсөн.

Хороог Ард түмний танхим /Lok Sabha/-ын ажил хэргийн /үйл ажиллагааны/ дүрмийн 306 дугаар зүйлээр Спикер байгуулсан. Хорооны үйл ажиллагааны хамрах хүрээ ба үүргийг дүрмийн 307 дугаар зүйл болон Спикер /танхимын дарга/-ийн 95 дугаар захирамжаар Хороонд хандаж ирүүлсэн бүх өргөдлийг авч үзэх гэж заасан[117].

[116] Бундэстагийн дүрэм/Geschdftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311

[117] Rules of Procedure and Conduct of Business in the House of the People . http://rajyasabha.nic.in/rsnew/rs_rule

Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх ерөнхий процедур

Байнгын хороодын ангилал гэсэн хүснэгтээс үзэхэд танхимууд хоёулаа Өргөдлийн хороотой бөгөөд тус тусын үйл ажиллагааны дүрмээр зохицуулна. Дээд танхимын Өргөдлийн хороо нь 10, Доод танхимын Өргөдлийн хороо нь 15 гишүүнтэй байна. Ингээд танхимуудын дүрмээс танилцуулж байна.

3.2. Дээд танхим буюу Төрийн зөвлөлийн Өргөдлийн хороо

Өргөдлийн хорооны үүрэг бол:

- Хорооны нэр дээр ирүүлсэн өргөдөл бүрийг шалгаж, дүрэмтэй нийцэж байгаа тохиолдолд нэг бол бүтнээр нь эсвэл товчилсон хэлбэрээр танилцуулах
- Өргөдөлд дурдсан тодорхой гомдлуудын талаар зохих нотолгоо, баримтын хамт Танхимд мэдээлэхийн хамт авах арга хэмжээг тухайн гомдлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээний хэлбэрээр, эсвэл тиймэрхүү зүйл дахин гарахаас сэргийлсэн арга хэмжээний хэлбэрээр санал болгоно. Хорооны тайланг Танхимд Хорооны дарга эсвэл түүний эзгүйд хорооны аль нэг гишүүн танилцуулна.

Өргөдөл

Эдгээр дүрмийн дагуу даргын зөвшөөрснөөр өргөдлийг Зөвлөлд танилцуулж эсвэл өргөн барьж болно.

Хамрах хүрээ

Өргөдөл дараах асуудлуудыг хамаарсан байж болно:

- Танхимын дүрмийн 61 дүгээр зүйлийн хүрээнд нийтлэгдсэн хуулийн төсөл, эсвэл эдгээр дүрмийн хүрээнд танилцуулагдсан хуулийн төсөл, эсвэл хуулийн төсөлтэй холбогдуулан шүүхэд бичгээр хандсан асуудлаар,\
- Зөвлөлөөр шийдлээ хүлээж буй аливаа ажил хэргийн асуудлаар,
- Олон нийтийн эрх ашгийг хөндсөн, доорхийн аль нэгд хамаарахгүй асуудлаар:
  - Энэтхэгийн нутаг дэвсгэрийн хаана ч үйлчлэх эрх бүхий шүүхийн эрх мэдлийн хүрээний асуудал, эсвэл бусад шүүх, түүнтэй адилтгах эрх бүхий байгууллагуудын эрх мэдлийн асуудлууд
  - Энэтхэгийн Засгийн газрын нэн тэргүүнд анхаарал тавих шаардлагагүй асуудалтай холбогдон үүссэн асуудлууд
  - Бие даан тусад нь шийдвэр гаргаж болох асуудлууд
  - Тухайн орон нутаг, байгуулага, корпорацийн өөрийн хууль, журмын хүрээнд зохицуулж болох асуудлууд

Ерөнхий хэлбэр

1. Өргөдөл нь зааж өгсөн ерөнхий хэлбэрийг (маягтыг) хэрэглэж болох бөгөөд хэрэглэсэн бол хангалттай болно.
2. Өргөдөл бүр хүндэтгэлтэй /аядуу/, соёлтой үг хэллэгээр илэрхийлсэн байх.
3. Өргөдлийг Хинди эсвэл Англи хэл дээр гаргана. Хэрэв өргөдөл нь өөр ямар нэгэн хэл дээр бичигдсэн бол Хинди, эсвэл Англи хэлээр орчуулж хавсарган, өргөдөл гаргагч гарын үсгээ зурсан байна.

Гарын үсгийн баталгаа

Өргөдөлд гарын үсэг зурсан бүх талууд бүтэн нэр болон хаягаа гарын үсгээр баталгаажуулсан байх ба хэрэв бичиг үсэг мэддэг хүн бол түүний гарын үсэг, мэддэггүй хүн бол түүний эрхий хуруугны хээгээ дарсан байна.

Хавсаргах ёсгүй баримт бичгүүд

Өргөдөлд захидал, гэрчийн мэдүүлэг болон бусад баримт бичиг хавсаргаж болохгүй.

Хүлээн авсан гарын үсэг

Өргөдөл бүр хэрэв гишүүнээр дамжуулан гаргасан бол гишүүн гарын үсэг зурсан байна.

Өргөдлийг хэнд гаргах ба хэрхэн төгсгөх

Өргөдөл бүр Зөвлөлд хаяглагдсан байх бөгөөд тодорхой хүсэлтээ ойлгомжтойгоор илэрхийлж өргөдлөө төгсгөнө.

Өргөдлийг танилцуулах тухай мэдэгдэл

Гишүүн өргөдөл танилцуулах тухай мэдэгдлээ Ерөнхий нарийн бичгийн даргад урьдчилан гаргана.

Өргөдлийн танилцуулга

Өргөдлийг гишүүнээр эсвэл Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан гаргах ба Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан гаргасан тохиолдолд болсон хэрэг явдлын

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

талаар Ерөнхий нарийн бичгийн дарга Зөвлөлд илтгэх бөгөөд илтгэх асуудлаар аливаа маргааныг хүлээж авахгүй.

Танилцуулгын хэлбэр

Гишүүн өргөдлийг танилцуулахдаа дараах хэлбэрийг чанд баримтална:

> “Би өргөдөл гаргагч ..... -ны гарын үсэгтэй ..... тухай өргөдлийг танилцуулахыг хичээнгүйлэн хүсэж байгаа бөгөөд энэ хүсэлтийн талаар аливаа маргаан гаргахыг хүлээн зөвшөөрөхгүй”

Өргөдлийн байнгын хорооны бүрэлдэхүүн

1. Дарга нь 10 гишүүнээс бүрдсэн Өргөдлийн хороог томилно.
2. Шинэ Хороог томилтол дүрмийн дагуу томилогдсон хороо албыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
3. Хорооны гишүүдийн сул орон тоонд Танхимын дарга гишүүнийг нөхөн томилно.

Кворум

Хорооны хурлыг хүчинтэй болгох гишүүдийн хамгийн бага ирц 5 байна.

Хорооны дарга

1. Хорооны даргыг хорооны гишүүдийн дундаас томилно. Хэрэв орлогч дарга нь хорооны гишүүн бол түүнийг даргаар томилно.
2. Хэрэв ямар нэг шалтгаанаар хорооны дарга үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд хорооны дарга өөр хорооны даргыг өөрийн оронд томилж болно.
3. Хэрэв Хорооны дарга аливаа уулзалт дээр байхгүй байх юм бол Хорооноос тухайн уулзалтад зориулан өөр гишүүнийг Хорооны даргаар сонгоно.

Өргөдлийг хороонд шилжүүлэх

Өргөдлийг гишүүнээр болон Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан танилцуулсаны дараа Өргөдлийн хороонд шилжүүлнэ.

Өргөдлийг судлах ба шалгах

1. Хорооны нэр дээр ирсэн өргөдөл бүрийг хороо нягтлан үзээд хэрэв дүрэмд нийцэж байвал хороо өөрийн эрх мэдлийн хүрээнд өргөдлийг хүлээн авч судлах шийдвэр гаргаж болно. Хүлээн авах шийдвэр гараагүй өргөдлийг дарга хүлээн авах шийдвэрийг хэзээ ч гаргаж болно.
2. Өргөдлийг бүтэн эхээр нь эсвэл товчилсон хэлбэрээр хороо эсвэл дарга шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

Өргөдөлд гаргах хорооны зөвлөгөө

Ямар ч өргөдлийг гишүүн эсвэл Ерөнхий нарийн бичгийн дарга танилцуулсны дараагаар өргөдөлд хорооныхон зөвлөгөө өгөх болно.

Тайлан

1. Хороо Зөвлөлд өргөдлийн агуулга, гарын үсэг зурсан хүмүүсийн тоо, өргөдөл дүрэмд нийцэж байгаа эсэх болон өргөдлийг тойруулах шийдвэр гарсан эсэх талаар тайлагнана.

2. Мөн өргөдөлд дурдсан тодорхой гомдлын талаар холбогдох нотлох баримтын хамт Зөвлөлд мэдээлж, авах арга хэмжээг тухайн хэрэг явдлыг шийдвэрлэхэд чиглэсэн, эсвэл цаашид тийм зүйл давтан гаргахаас сэргийлсэн хэлбэрээр санал оруулах нь Хорооны үүрэг юм.

Тайлангийн танилцуулга

Байнгын хорооны тайланг Зөвлөлд Хорооны дарга эсвэл түүний эзгүйд аль нэг гишүүн танилцуулна.

Өргөдлийн хэлбэр

Өргөдлийг Хинди эсвэл Англи хэл дээр доорхи хэлбэрээр хийж өргөдөл гаргагч гарын үсэг зурсан байна.

> Төрийн зөвлөл /Rajya Sabha/-д
>
> Өргөдлийг ..... /Энд өргөдөл гаргагч эсвэл өргөдөл гаргагч нарын нэр болон түүнийг тодорхойлох тайлбар/ “А, Б ба бусад” эсвэл “.....-н оршин суугчид” эсвэл “.....-н хотын захиргааны г.м”
> ..... /өргөдлийн утга/
> ба тийм учраас өргөдөл гаргагч нь ..... хүсэж байна.

Өргөдөл гаргагчийн нэр	Хаяг	Гарын үсэг, эсвэл эрхий хуруугны хээ

..... /Гишүүний гарын үсэг/

Өргөдлийн шийдвэр

- Өргөдлийн ач холбогдлын талаар анхааралдаа авах дүгнэлт бичих
- Өргөдлийг буцаах
- Өргөдөлд хөндсөн асуудал нь тохирохгүй байгаа талаар өргөдөл гаргагчид албан ёсоор танилцуулах, хүргүүлэх
- Албан ёсны хэвлэлд өргөдлийн хариуг нийтлэх[118].

Тайлангийн загвар

Тухайлбал, иргэн Шри К.Санжай Прабхугийн 2010.10.29-нд цэргийн албан хаагчид олгох тэтгэлгийн асуудлаар гаргасан өргөдөлд Өргөдлийн хорооноос гаргасан тайлангийн загвар

Дээд танхимын Өргөдлийн байнгын хороо

Зэвсэгт хүчний бие бүрэлдэрүүний ажилтны тэтгэлэг тогтоох ангиллын талаарх өргөдлийн тайлан /2011.12.19/

1. Хорооны бүрэлдэхүүн /Хорооны дарга, гишүүдийн нэрс болон албаны ажилтнуудын нэрс/

[118] Rules of Procedure and Conduct of Business in the House of the People . http://rajyasabha.nic.in/rsnew/rs_rule

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2. Удиртгал
3. Тайлан
   - Нэг цол, нэг тэтгэлгийн зарчим
   - Өргөдөл гаргагчийн аман танилцуулга /2011.05.04/
   - Хуучин цэргийн албан хаагчийн нийгмийн халамж г.м
   - Хорооны судалгааны үр дүн
   - Хорооноос гаргах санал, зөвлөмж
4. Хавсралт гэсэн бүтэцтэй байна.

3.3. Доод танхим буюу Ард түмний танхимын Өргөдлийн хороо

Байнгын хорооны үйл ажиллагааны хамрах хүрээ ба эрх хэмжээ /үүрэг/

Хорооны үүрэг бол:

i. Хороо нь өөрт нь хандан гаргасан бүх өргөдөл, гомдлыг хянан хэлэлцэх ба хэрэв дүрэмтэй нийцэж байвал хорооноос өргөдөл, гомдлыг цааш нь танилцуулах талаар чиглэл өгнө. Өргөдөл, гомдлын талаар чиглэл өгөөгүй бол өгөх, хурлын дарга өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаар хэдийд ч чиглэл өгч болно.

ii. Ирүүлсэн өргөдөл баримтад үндэслэсэн тодорхой санал гаргаж Танхимд танилцуулах.

iii. Тухайн хэрэг явдалд чиглэсэн эсвэл цаашид тийм хэрэг дахин гаргахаас сэргийлсэн хэлбэрээр авах арга хэмжээний санал оруулах.

Танхимын даргын 95 дугаар захирамжийн хэсэгт хувь хүмүүс, нийгэмлэг болон бусад газраас ирүүлсэн төрөл бүрийн өргөдөлтэй холбоотой дүрмээр зохицуулагдаагүй захиа, цахилгааныг авч хэлэлцэн цаашид хэрхэх тухай чиглэл өгөх эрхийг олгосон. Гэхдээ доорхи тохиолдлуудад захидлыг Хороо авч хэлэлцэхгүй бөгөөд зөвхөн бичиг хэрэгт бүртгэгдэнэ:

a) Тодорхой нэргүй захидал эсвэл нэр, хаяг нь ойлгомжгүй, гаргац муутай;

b) Спикер эсвэл Их Хурлаас бусад эрх бүхий байгууллагад хаяглагдсан захидлын баталгаажсан хуулбар, хэрэв хуулбар дээр буруу шударга бус зүйлийг засах тухай хүсэлт байхгүй бол;

Дүрэм болон дээр дурдсан Лок Сабха-д үйл ажиллагаа явуулах дүрмийн бусад заалтын дагуу олгогдсон эрхийнхээ хүрээнд гаргасан спикерийн захирамжууд эдгээр дүрмүүдийг цаашид баяжуулна.

Өргөдөл

Өргөдөл бүрийг Парламентад танилцуулахаас өмнө үйл ажиллагааны дүрэмд нийцэж байгаа эсэхийг Байнгын хорооны нарийн бичгийн дарга нарын газраас шалгана. Өргөдлийг хүлээж авах асуудлаар холбогдох яамнаас болсон нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж үзсэн үед Спикерийн захирамжийн 40.2-т заасны дагуу тухайн яаманд хандан мэдээллүүдийг цуглуулж болно. Парламентад гишүүний танилцуулсан өргөдөл бүрийг Өргөдлийн хороонд шилжүүлнэ.

Өргөдлийн агуулга дараах зүйлүүдийн алинтай ч хамаатай байж болно:

i. Албан ёсны хэвлэлд хэвлэгдсэн Парламентаас гаргасан аливаа хууль
ii. Их Хурлаас шийдлээ хүлээж буй үйл ажиллагаатай холбоо бүхий аливаа асуудал
iii. Олон нийтийн нийтлэг эрх ашгийг хөндсөн аливаа асуудал

Дараах асуудлуудын талаарх өргөдлийг хүлээж авах боломжгүй:

1. Энэтхэгийн нутаг дэвсгэрийн хаана ч үйлчлэх эрх бүхий шүүхийн эрх мэдлийн хүрээний асуудал, эсвэл бусад шүүх, түүнтэй адилтгах эрх бүхий байгууллагуудын эрх мэдлийн асуудал
2. Төрийн хууль тогтоомжийн дагуу сөхөгдөх асуудал
3. Бие даан тусад нь шийдвэр гаргаж болох асуудал
4. Тухайн орон нутаг, байгууллага, корпорацийн өөрийн хууль, журмын хүрээнд зохицуулж болох асуудал
5. Үндсэн хуулийн 110 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн a-f хүртэлх заалтууд эсвэл Ерөнхийлөгч тусгайлан зөвлөмж гаргаагүй Энэтхэгийн Нэгдсэн Сангийн зарлагатай холбоотой асуудал
6. Хувь хүний гомдолтой холбоотой асуудал
7. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хүссэн асуудал

Хорооны дарга

Хорооны даргыг хорооны дарга болон парламентын даргын шийдвэрээр томилно. Хэрэв даргын албан тушаалтан ямар нэгэн шалтгаанаар тэнцэхгүй бол парламентын дарга өөр хэн нэгнийг даргын албан тушаалд томилно. Хэрэв дарга ямар нэгэн шалтгаангүйгээр албан үүргээ гүйцэтгэхгүй байвал өөр нэгэн гишүүнийг даргын нэрд дэвшүүлж болно.

Хорооны хурлын ирц

Хорооны гишүүдийн ирц хорооны нийт гишүүдийн гуравны нэгт хүрсэн байх ёстой. Хэрэв хорооны хурлын ирц хүрэлцэхгүй бол хурлыг тодорхой хугацаагаар хойшлуулна. Хурал ямар нэгэн байдлаар хойшлогдсон тохиолдолд хорооны дарга дараагийн хурлын товыг гарган танхимд мэдэгдэх шаардлагатай. Хэрэв хорооны гишүүн хорооны хуралд даргын зөвшөөрөлгүй хоёроос дээш удаа суугаагүй бол хорооны гишүүний асуудлыг Танхимд мэдэгдэх болно.

Хорооны тогтоол, шийдвэр

Хорооны ямар ч асуудлын талаарх шийдвэрүүд гишүүдийн дийлэнхийн санал асуулгаар шийдвэрлэгдэнэ.

Хороогоор өргөдлийг хэрхэх талаар шийдвэрлэх үйл ажиллагааны процедур

- Олон нийтийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудлаарх өргөдлийн тухайд холбогдох яам газруудаас тайлбарыг авч хороонд хэлэлцүүлэхээр оруулна. Шаардлагатай гэж үзвэл Хороо өргөдөл гаргагч эсвэл яамдын холбогдох хүнийг байлцуулан тайлбар сонсож болно.
- Түүний дараа Нарийн бичгийн дарга нарийн газраас Хорооноос гаргасан зөвлөмж болон дүгнэлтийг үндэслэн тайлангийн төслийг бэлтгэнэ. Даргаар батлуулсаны дараа тайлангийн төслийг Хорооны гишүүдэд тарааж, хурлаар асуудлыг авч хэлэлцэнэ.
- Хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргасан шийдвэрийг Хорооноос өөрчлөлт оруулах эсвэл эс оруулах замаар батламжилна. Хорооноос гаргасан шийдвэрүүд бүх гишүүдийнх бөгөөд тайланд ямарваа нэг зөрүүтэй санал тусгагдахгүй.

Хэрэв яам эсвэл агентлаг хорооноос гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжгүй эсвэл

хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үзвэл яам Лок Сабха /Ард түмний танхим/-гийн Тамгын газарт уг асуудлын талаарх өөрийн байр суурийг танилцуулах Хороонд дахин хандана. Хороо асуудлыг дахин хэлэлцсэний дараа хэрэв шаардлагатай гэж үзвэл Их Хуралд танилцуулж мэдээлэл хийнэ.

Тайлан

Танхим ямар нэгэн байдлаар тайлангийн танилцуулгыг хийх цаг байгаагүй бол хороо нэг сарын дотор шүүн хэлэлцэж яаралтай танилцуулна. Танхим ямар ч хугацаанд хамаарахгүй хэлэлцэн үзэх учиртай. Тайланг урьдчилан хэлэлцэж болно. Хорооны тайлан заавал даргын гарын үсэгтэй байх шаардлагатай. Хэрэв тухайн үед дарга ямар нэгэн байдлаар байхгүй байгаа тохиолдолд хорооны өөр нэгэн ахлах гишүүнээр гарын үсэг зуруулна.

Дэд хороо томилох

Хороо нь нэг эсвэл хэд хэдэн дэд хороо томилох боломжтой. Тухайн томилогдсон хороо тус бүрнээ нэгдмэл чанартай байна.

Хорооны хуралдаан

Хуралдааны өдөр, цагийг Хорооны дарга захицуулна. Хэрвээ хорооны дарга ямар нэгэн байдлаар ирж чадахааргүй тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга өдөр болон цагийг тодорхойлно. Хорооны хуралдаан хэрэв Танхимын парламентын чуулганаас гадуур зохион байгуулагдах чухал шаардлагатай бол заавал парламентын даргын зөвшөөрөл гарсны дараагаар хуралдах болно.

Бичиг баримт гаргуулах, нотолгоо шаардах

Хороонд шаардлагатай гэсэн тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газарт харъяалагдах үндэслэлээр нэмэлт материалыг шаардах эрхтэй. Холбогдох яам байгууллагаас тодруулах шаардлагатай бол мэдээлэл авч болно. Хороо нь өмнө гаргасан нууц болон шаардлагатай баримтыг болгоомжтой хянуур нягтлан үзэх хэрэгтэй.

Хүмүүст бичиг баримт тайлан илгээх

Хороо хүмүүст бичиг баримт илгээх эрхтэй. Баримт бичигт ямар нэгэн асуудал гарвал Парламентын даргын эцсийн шийдвэрээр шийдвэрлэгдэнэ.

Гэрчийн мэдүүлэг дэх хэлэлцүүлэг

Парламентын даргын удирдлаган дор хороо гэрчийн мэдүүлэг дэх хэлэлцүүлгийг хийх ба эцэст нь хороо батална.

Тангаргын бичиг дэх баталгаа

Хороо тангараг бичиг хэрэгжүүлэх эсвэл өмнө нь шалгаж баталгаа олгоно. Тангараг бичигт баталгаа олгохдоо: “I,A.B., бурханы нэрээр андгайлж байна. Уг нотлох баримтыг би ямар ч нөхцөлд үнэн зөвөөр батлах болно. Ямар нэгэн байдлаар өөрийн хувийн ашиг сонирхолдоо ашиглахгүй болно.”

Нотолгоонд хийх шалгалт

Хорооны нотолгоонд хийх судалгаа шинжилгээ дараах байдлаар явагдана: (i) Хорооныхон нотолгоонд судалгаа хийх ёстой бөгөөд гэрчийн этгээдээс асуулт асууж болно.

(ii)Хорооны дарга нотолгоонд шаардлагатай асуултыг хамгийн эхэнд (i)-д заасны дагуу асуух эрхтэй.

(iii) Парламентын дарга хороодын бусад гишүүдийг нэг нэгээр нь дуудаж шаардлагатай гэсэн асуултуудыг асуух эрхтэй.

(iv) Гэрчийн этгээд мөн хорооны даргын өмнө шаардлагатай асуултад хариулах хэрэгтэй.

(v) Хорооны үйл ажиллагааны үгчлэн гаргасан баримтыг гэрч шаардах эрхтэй.

(vi) Хороонд нотлох баримт болгон өгсөн бичиг нь хороодын бүх гишүүдээр баталгаажсан байх ёстой.

Шийдвэрийн баримт

Хорооны шийдвэрийн баримт нь Парламентын даргын удирдлаган дор хороодын гишүүдээр батлагдсан байх ёстой.

Төлөөлөл

Өргөдөлтэй холбоотой дүрмээр зохицуулагдаагүй төрөл бүрийн хувь хүмүүс, нийгэмлэгүүдээс ирсэн захидал, цахилгааныг авч хэлэлцэх бөгөөд Хороогоор батлагдсан үйл ажиллагааны журмын дагуу тэдгээрийг цаашид хэрхэх талаар чиглэл өгнө. Жинхэнэ гомдол, саналыг тусгасан төлөөллийн захидлуудыг хүлээн авч холбогдох Газруудаас авсан баримтуудын хамт Хороогоор хэлэлцүүлэхээр өгнө. Тэдгээрийг цаашид хэрхэхийг өргөлтэй адилаар Хорооноос шийдвэрлэнэ.

14 дэх Лок Сабхагийн /Ард түмний танхим/ Өргөдлийн хорооны ажил [119]

Хуралдааны тоо	Тайлангийн мэдээллийн тоо	Хүлээн авсан болон тайлагнасан өргөдлийн тоо	Төлөөлөгчөөр дамжуулсан гомдлын тоо	Судалгаа хийсэн тоо
103	50	22 өргөдөл ирснээс 15 өргөдлийг хүлээн авч болохыг авч Танхимд танилцуулсан	1630 ирснээс 98 хүлээн авч Танхимд танилцуулсан	8

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. House of Representatives Standing and Sessional Orders. http://www.aph.gov.au/
2. Rules for form and content of petitions. House of Representatives Standing and Sessional Orders http://www.aph.gov.au/
3. Бундэстагийн Өргөдлийн байнгын хороо/Petitionsausschuss des Deutschen Bundestages (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Petitionsausschuss_des_Deutschen_Bundestages
4. Германы Бундэстагийн Хороонууд/German Bundestag-Committees, Partnership for Democratic Governance and Security http://www.pdgs.org/Archivo/bund-comm2.htm#1
5. Бундэстагийн дүрэм/Geschdftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311
6. Германы Бундэстар/Deutscher Bundestag (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Aussch.C3.BCsse

[119] Rules of Procedure and Conduct of Business in the House of the People . http://rajyasabha.nic.in/rsnew/rs_rule

7. Ажлын хуудас 7-Бундэстагийн сонгууль, Хичээлийн сэдэв: Германы ардчилал/Arbeitsblatt 7- Wahlen zum Bundestag, Thema im Unterricht: Die deutsche Demokratie _files_RZN5F9.doc
8. 17 дахь Бундэстагийн Байнгын хороод/Bundestagsausschьsse des 17. Deutschen Bundestages (Wikipedia)
9. The Constitution of India, Lok Sabha Secretariat November, 2006
10. Энэтхэг Улсын Парламентын " Доод танхимын /Lok Sabha/ үйл ажилгаатай холбогдох үйл ажилгааны дүрэм" 2010 он, Тамгын газар Шинэ Дэли, 14 дахь хэвлэл
11. Rules of Rajya Sabha. http://rajyasabha.nic.in/rsnew/rs_rule/rules7th.pdf
12. Rules of Lok Sabha. http://parliamentofindia.nic.in/ls/rules/rules.html
13. Parliament of India. http://rajyasabha.nic.in/rsnew/Parliament_of_India.pdf
14. Committee on Petitions of Rajya Sabha. http://164.100.47.5/webcom/MainPage.aspx
15. Committee on Petitions of Lok Sabha. http://164.100.47.134/committee/committee_informations.aspx

* * *

ХАВСРАЛТ

Германы Бундестагийн Өргөдлийн хорооны бүрэн эрхийн тухай хууль, 1975

Зүйл 1

Үндсэн хуулийн 17 дугаар заалтын дагуу Германы Бундестагийн Өргөдлийн хороо ирсэн өргөдлийн дагуу шийдвэр гаргахад нь Холбооны Засгийн газар болон холбооны төрийн байгууллагууд шаардагдах баримт бичгийг гаргаж өгөх, мэдээллээр хангах ёстой бөгөөд тэдний байранд нь нэвтрэн орж ажиллах бол нөхцлийг нь хангах ёстой.

Зүйл 2

Зүйл 1-ийн заалт нь Холбооны улсын бусад байгууллагууд болон нийтийн эрх зүйн хүрээний институц, сангуудад мөн хамаарах бөгөөд Холбооны Засгийн газрын зүгээс хэрэгжилтэнд нь хяналт тавих үүрэгтэй.

Зүйл 3

(1) Зөвхөн хуульд заасан үндэслэлээр нууцыг хадгалах болон нууцлах гарцаагүй шалтгаантай үед баримт бичиг гарган өгөх, мэдээллээр хангах болон орон байранд нь нэвтрэхээс татгалзаж болно.

(2) Татгалзах шийдвэрийг зөвхөн Холбооны холбогдох хамгийн дээд хяналтын байгууллага гаргана. Шийдвэр гаргасан үндэслэлээ тайлбарлах ёстой.

Зүйл 4

Өргөдлийн хороо нь өргөдөл гаргагч, гэрч, экспертүүдийг сонсох эрхтэй.

Зүйл 5

Өргөдлийн хороонд дуудагдан ирсэн өргөдөл гаргагч, гэрч болон экспертүүд "Гэрч болон экспертүүдийг урамшуулах тухай хууль" болон "Шүүхийн үйл ажиллагааг хялбарчлах болон эрх зүйн үйл ажиллагааны бичлэгийг хялбарчлах хууль"-ийн дагуу шагнал, урамшуулал авна.

Зүйл 6

Германы Бундестагийн Процедурын дүрмийн дагуу Өргөдлийн хороо нь тодорхой тохиолдолд өөрт хуулиар оногдсон эрх мэдлийг өөрийн хорооны нэг буюу хэд хэдэн гишүүнд шилжүүлж болно.

Зүйл 7

Шүүх болон захиргааны байгууллагууд Өргөдлийн хороо болон түүний гишүүдэд шаардлагын дагуу туслах үүрэгтэй.

Зүйл 8

1952 оны Сэргээн босголтын гуравдугаар хуулийн 13 дугаар зүйлийн (1) параграф ёсоор энэ хууль Берлинд хүчинтэй.

Зүйл 9

Энэ хууль хэвлэлд нийтлэгдсэн өдрөөс хүчинтэй.

Германы Бундестагийн процедурын дүрэм

X. Өргөдлийн журам

Дүрэм108. Өргөдлийн хорооны эрх мэдэл

(1) Өргөдлийн хороог Үндсэн хуулийн 45с заалтын дагуу Бундестагт байгуулах бөгөөд Үндсэн хуулийн 7 дугаар заалтын дагуу Бундестагт гаргасан өргөдөл, гомдлыг хариуцан ажиллана...

(2) Хэрэв Германы Бундестагийн Өргөдлийн хорооны эрх мэдлийн тухай хуульд өөрөөр заагаагүй бол өргөдлийг доор заасан журмаар авч үзнэ.

Дүрэм 109. Өргөдлийг шилжүүлэх

(1) Бундестагийн ерөнхийлөгч өргөдлийг Өргөдлийн хороонд шилжүүлнэ. Хэрэв өргөдөлд дурдагдсан асуудал бусад байгууллын хороодын хамрах хүрээнд орж байвал Өргөдлийн хорооны зүгээс холбогдох хороонд хандана.

(2) Уг өргөдөлтэй холбоотой асуудлыг сонирхсон Бундестагийн гишүүд өөрсдийн хүсэлтээр Өргөдлийн хорооны хэлэлцүүлэгт таслах эрхгүйгээр оролцоно.

Дүрэм 110. Өргөдлийн хорооны эрх

(1) Өргөдлийн хороо нь гомдол, хүсэлтийг авч хэлэлцэх үндсэн зарчмыг тодорхойлж, өргөдөлтэй холбоотой шийдвэр гаргах бүрдээ уг зарчмыг ашиглана.

(2) Хэрэв хүсэлтийн дагуу аливаа мэдээлэл, баримт бичиг авах буюу Холбооны төрийн болон бусад байгууллага, нийтийн эрх зүйн хүрээний институц, сангуудын байранд нэвтрэх шаардлагатай бол холбогдох Холбооны засгийн газрын гишүүнд мэдэгдсэн байх ёстой.

(3) Холбогдох Холбооны засгийн газрын гишүүнд мөн өргөдөл гаргагч, гэрч, экспертүүдийг сонсох хугацааг мэдэгдэнэ.

Дүрэм 111. Өргөдлийн хорооны гишүүнд эрх шилжүүлэх

Өргөдлийн хороо нь тодорхой тохиолдолд Үндсэн хуулийн 45с заалтаар өөрт нь оногдсон эрх мэдлийг өөрийн хорооны нэг буюу хэд хэдэн гишүүнд шилжүүлэх шийдвэр гаргаж болно. Уг шийдвэрт шилжүүлж буй эрх мэдлийн хүрээ, онцлогийг тодорхойлсон байна.

Дүрэм 112. Өргөдлийн хорооны зөвлөмж, тайлан

(1) Өргөдлийн хороо нь хэлэлцсэн өргөдлийн талаарх тайлангаа харгалзах зөвлөмжийн хамт Бундестагт жагсаалтаар хүргэнэ. Тайланг сар тутам хүргэнэ. Мөн өөрийн хийсэн ажлын тайланг жил бүр Бундестагт гаргана.

(2) Чуулганы хугацаанд тайланг хүргэснээс хойш гурван долоо хоногийн дотор тайланг хэвлэж, тараах бөгөөд чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулсан байна. Илтгэгч амаар нэмэлт тайлбар хийж болно. Тайлангийн талаарх хэлэлцүүлгийг зөвхөн парламентын бүлгүүд дээр болон Бундестагийн гишүүдийн 5-аас доошгүй хувийн ирцтэй үед хийнэ.

(3) Өргөдөл гаргагчид түүний хүсэлтийг хэрхэн хэлэлцсэн талаар мэдээлнэ.

UIH.MN
ШИНЖЛЭХ УХААНЫ САН

Өргөдлийн Хорооны дүрэм (Үйл ажиллагааны дүрэм)

Германы Бундестагын 1989 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн шийдвэр, түүний 1991 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн нэмэлт найруулга, 1991 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн нэмэлт, 2005 оны 11 дүгээр сарын 30-ны шийдвэрээр 16 дахь сонгуулийн хугацаанд хэрэгжүүлсэн, Германы Бундестагын Үйл ажиллагааны 110 дугаар дүрмийн эхний хэсгийн дагуу Өргөдлийн Хороо нь санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэхдээ дараах дүрмийг баримтална:

1. Холбогдох хууль эрхзүйн заалтууд

(1) Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн дагуу хэн нэгэн дангаараа буюу бусадтай хамтран Бундестагт хандан санал хүсэлт, гомдол гаргах эрхтэй.

(2) Үндсэн хуулийн 45 с зүйлийн 1 дүгээр хэсэгт зааснаар, Бундестагт ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хариуцан шийдвэрлэх Өргөдлийн Хороог Бундестагаас томилно.

(3) Өргөдлийн Хорооноос өргөдлийн талаархи шийдвэр гаргах эрх мэдэл нь Үндсэн хуулийн 17 дугаар зүйл болон Германы Бундестагын Өргөдлийн Хорооны бүрэн эрхийн тухай хуульд үндэслэнэ. (Үндсэн хуулийн 45с зүйлийн дагуу тус хууль хэрэгжиж эхэлсэн).

2. Өргөдлийн мэдүүлэг

2.1. Өргөдөл

(1) **Өргөдөл нь** санал хүсэлт болон гомдлын хэлбэрээр хэн нэгэн өөрөө, гуравдагч этгээдийн өмнөөс эсвэл нийтийн эрх ашгийн төлөөлөн өргөн мэдүүлэгдэнэ.

(2) **Санал хүсэлт нь** төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх ашгийг хөндөн ажиллах байгууллагын үйл ажиллагаа болон хариуцлагагүй байдалд гаргаж буй шаардах хүсэлт болон авах арга хэмжээний санал орно. Үүнд хууль эрх зүйд өөрчлөлт оруулах төслийн санал мөн багтана

(3) **Гомдол нь** төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх ашгийг хөндөн ажиллах байгууллагын үйл ажиллагаа болон хариуцлагагүй байдлын эсэргүүцэл багтана.

2.2. Давхар өргөдөл, хамтын өргөдөл, олон нийтийн өргөдөл

(1) Давхар өргөдөл нь ижил асуудлын талаар тус бүрдээ бичгээр гаргана.

(2) Хамтын өргөдөл нь ижил асуудлын талаар олон этгээдийн гарын үсэг бүхий байна.

(3) Олон нийтийн өргөдөл нь ижил асуудлын талаар утгын хувьд адил эсвэл төстэй маш олон тоогоор гаргасан байна.

2.3. Бусад өргөн мэдүүлэг

Өргөдөл нь мэдээлэл авах хүсэлт, ердийн асуудал, шүүмжлэл, буруушаал, хүлээн зөвшөөрөл эсвэл тодорхой санал хүсэлтгүй бусад хэлбэрийн үзэл бодлын илэрхийлэл байж болохгүй.

3. Өргөдөл гаргагч

(1) Герман улсад оршин суугаа байнгын болон хууль ёсны оршин суугч нь Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заагдсан эрхийг эдлэнэ.

(2) Өргөдөл гаргах эрхээ эдлэхэд хууль эрхзүйн чадамж шаардлагагүй бөгөөд өргөдөл гаргагч нь өөрийн хөндсөн асуудлыг тодорхой илэрхийлж чадахуйц байхад хангалттай. Өргөдөл гаргах эрх нь өргөдөл гаргагчийн оршин суугаа газар эсвэл харъяалал гэх мэт түүний хувийн нөхцөл байдлаас хамаарахгүй.

(3) Хэрэв өргөдөл гуравдагч этгээдийн өмнөөс өргөн баригдсан бол хууль ёсны зөвшөөрөл шаардагдаж болно. Хэрэв гуравдагч этгээд өргөдөлтэй санал нийлэхгүй бол уг өргөдлийг цаашид авч хэлэлцэхгүй.

4. Бичгээр илэрхийлэх

(1) Өргөдөл нь бичгээр өргөн мэдүүлэгдэнэ. Өргөдлийн гарын үсэг баталгаажих тохиолдолд өргөдөл нь тогтоосон маягтын дагуу бичигдсэн байна.

(2) Өргөдлийг амаар гаргах аль эсвэл биеэр өргөн барих шаардлагагүй.

5. Өргөдөлийн Хорооны бүрэн эрх

(1) Өргөдлийн Хороо нь Бундестагын хүрээнд шийдвэрлэгдэх асуудлыг тэр дундаа Холбооны хууль эрх зүйн талаарх өргөдлийг хүлээн авч хэлэлцэнэ.

(2) Өргөдлийн Хороо нь Холбооны засгийн газар, холбооны бусад байгууллага, төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч институтын хариуцах үйл ажиллагааны хүрээнд дэх өргөдлийг авч хэлэлцэнэ. Үүнд тухайн байгуулага аль Холбооны засгийн газрын харъяанд байх нь ач холбогдолтой бус юм.

(3) Үндсэн хуулиар тогтоогдсон эрх хэмжээний хүрээнд Өргөдлийн Хороо нь Холбооны бусад бүтэц бүрэлдэхүүний талаарх өргөдлийг хянан хэлэлцэнэ.

(4) Өргөдлийн Хороо авч хэлэлцэх өргөдөлд Холбооны хууль, Европын Комиссын /EC/ хууль тогтоомж /Laender/ хэрэгжилт, (Үндсэн хуулийн 83, 84 дүгээр зүйлс)-тэй холбоотой асуудлууд, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих Холбооны төлөөлөл (Үндсэн хуулийн 85 дугаар зүйл) мөн Холбооны хууль Европын Комиссын /EC/ хууль тогтоомжтой холбоотой асуудлыг хөндсөн байна.

(5) Тус хороо нь зөвхөн Холбооны түвшин дэх эрх зүйн харилцаатай холбогдох өргөдлийг авч хэлэлцэнэ.

- Хууль тогтоомж хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагууд хуулийн тодорхой арга хэмжээг авах шаардлагатай;
- Эрх бүхий байгууллагууд өөрсдийн эрх ашгийн үүднээс шийдвэр гаргахгүй байх.
- Шүүгчийн бусдаас хамааралгүй байх байдлыг зөрчсөн өргөдлийг хүлээн авч хэлэлцэхгүй.

6. Өргөдлийн талаар мэдээлэл авах, өргөдлийг цааш шилжүүлэх эрх

6.1. Мэдээлэл авах эрх

(1) Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн дагуу санал хүсэлт, гомдлын талаар мэдээлэл авах эрхтэй.

(2) Холбооны засаг захиргаатай холбогдох асуудлын талаарх мэдээллийг Холбооны Засгийн газарт хандан авах эрхтэй. Хэрэв тус асуудал Холбооны хариуцах асуудалтай холбоогүй тохиолдолд уг эрхийг Холбооны бусад эрх бүхий олон нийтийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага ханган ажиллана.

6.2. Холбооны Засгийн газарт мэдээлэх

Баримт бичиг өргөн барих, мэдээлэл авах, төрийн өмчид нэвтрэн орохтой холбоотой санал хүсэлт нийтийн хуулийн дагуу Холбооны засаг захиргааны байгууллага, түүний хамтрагч байгууллага болон институт, сангуудад ирсэн тохиолдолд Холбооны Засгийн газрын хариуцсан гишүүнд (Германы Бундестагын үйл ажиллагааны дүрэм дэхь 110 дүрмийн (2) дугаар хэсгийн дагуу) мэдээлнэ.

6.3. Цааш шилжүүлэх эрх

(1) Өргөдлийн Хороо нь Бундестагын бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргуулахаар санал болгон Холбооны Засгийн газар эсвэл Холбооны бусад байгууллагад хүлээн

СУДАЛГААНЫ САН

авсан өргөдлөө шилжүүлэн өгч болно.

(2) Хэрэв уг асуудал Холбооны Засгийн газрын эрхлэх хэрэг биш бол өргөдлийг Холбооны засаг захиргааны агентлаг эсвэл олон нийтийн асуудал хариуцах байгууллагад шууд шилжүүлнэ.

7. Хорооноос өргөдөл хүлээн авах үе шат

7.1. Өргөдлийг бүртгэн авах

(1) Өргөдөл тус бүрийг бүртгэн авна.

(2) Давхар өргөдлийн хувьд аль нэг өргөдлийг гол өргөдөл болгон бүртгэнэ.

(3) Олон нийтийн өргөдлийн хувьд нэг өргөдөл **(голлох өргөдөл)** хэмээн тооцон авч хэлэлцэнэ. Өргөдөл тус бүрийг хүлээн авч дугаарыг тэмдэглэнэ.

7.2. Өргөдлөөс бусад зүйлийг хүлээн авах

Өргөдлөөс бусад зүйлсийг **(2, 3)** хүлээн авсан тохиолдолд зөвлөгөө, мэдээлэл өгөх эсвэл холбогдох байгууллагад шилжүүлсэн талаар бичгээр заавал мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд тэдгээрийг буцаах болно.

7.3. Бүрэн бус өргөдөл

(1) Дүрэм ёсоор Хорооны ажлын алба нь хүлээн авсан өргөдлийг дараах нөхцөлд авч Хорооны хурлаар хэлэлцүүлэхгүй:

- Агуулгын хувьд ойлгомжгүй;
- Хууль ёсны бус;
- Өргөдөл гаргагчийн хаяг эсвэл гарын үсэг алдаатай эсвэл хуурамч;
- Өргөдөл гаргагчийн хаяг эсвэл гарын үсэг бүхэлдээ буюу зарим хэсэгт дутуу;
- Өргөдөлд хэрэгжүүлэх боломжгүй, гэмт хэргийн шинжтэй, захиргааны хууль зөрчсөн, эсвэл хуулийн тогтоосон дэг журам ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн зүйлийг шаардсан;
- Агуулгын хувьд бусдыг доромжилсон, дарамталсан эсвэл хүчилсэн шинжтэй байх.

(2) Өргөдлийн бүрэн бус байдлыг тогтоосон хугацаанд багтаан өргөдөл гаргагч эсвэл Хорооны ажлын алба залруулаагүй тохиолдолд ажлын алба нь Хорооны даргатай зөвлөсний үндсэн дээр буцаах болно.

7.4. Өргөдлийг хянан шалгах эрхийн хязгаарлалт

Өргөдөл гаргагч ижил асуудлаар өмнө нь өргөдөл гаргаж холбогдох шийдвэр гарч байсан, тэрхүү шийдвэртэй холбоотой одоо дахин шинэ баримт мэдээлэлгүй бол түүний гаргасан өргөдлийг дахин авч хэлэлцэхгүй.

7.5. Өргөдлийг шилжүүлэх

Холбооны хууль тогтоох байгууллага эсвэл бусад институт нь өргөдөл хянан шийдвэрлэх үүргийг хүлээдэг бол өргөдлийг тэдгээр байгууллагад шилжүүлнэ.

7.6. Төрийн албан хаагчийн талаарх өргөдөл

Төрийн албан хаагчийн талаарх өргөдлийг Өргөдлийн Хороо, Зэвсэгт Хүчнийг хариуцсан Парламентын эрх бүхий албан тушаалтны хамран ажиллах дүрмийг баримтлан хэлэлцэнэ.

7.7. Санал авах хүсэлт

Өргөдлийн Хороо өргөдөл авч хэлэлцэх үед Хорооны ажлын хэсгээс Холбооны Засгийн газраас санал авах эсвэл бусад байгууллагаас мэдээлэл авахаар хүсэх боломжтой.

7.8. Бундестагын тусгай хороо хэлэлцэж буй ижил төрлийн асуудлын тухай өргөдөл

Хэрэв өргөдөл нь тусгай хороо хэлэлцэж буй ижил асуудлын талаар дурьдсан бол (109 дүгээр дүрмийн 1 дүгээр хэсэг болон Германы Бундестагын үйл ажиллагааны дүрмийн 62 дугаар дүрмийн эхний хэсгийн дагуу) тусгай хорооноос санал авах боломжтой.

7.9. Өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу шийдвэрлэгдэх

Хэрэв асуудал өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу шийдвэрлэгдвэл түүнд энэ тухай мэдэгдэнэ. Хорооны ажлын алба нь уг өргөдлийн шийдвэртэй холбогдох өргөдлийн жагсаалтыг гаргана (8.5.).

7.10. Үр дүнд хүрэхээргүй өргөдөл

Хэрэв хорооны ажлын алба нь тухайн өргөдлийг цаашид шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн ч үр дүнд хүрэхээргүй хэмээн үзвэл өргөдөл гаргагчид шалтгааныг тайлбараар өгч хэрэв зургаан долоон хоногийн дотор өргөдөл гаргагч эсэргүүцэл гаргаагүй тохиолдолд түүний өргөдөл үр дүнд хүрэхээргүй болохыг мэдэгдэнэ. Хэрэв өргөдөл гаргагч заасан хугацаанд эсэргүүцэл гаргаагүй бол хорооны ажлын алба өргөдлийг шийдвэрлэгдсэн өргөдлийн жагсаалтад оруулна (8.5.).

7.11. Илтгэгч

Тус дүрмийн 7.9, 7.10 хэсгийн дагуу авч хэлэлцээгүй өргөдлийн талаар Хорооны ажлын алба нь парламентын өөр бүлгүүдэд хамаарах Хорооны хоёр гишүүнийг илтгэгчээр томилох санал тавина. Хороо дахь Парламентын бусад бүлгийн төлөөлөл нь өөрсдийн илтгэгчийг томилохыг шаардах эрхтэй. Хэрэв Бундестаг өргөдөлтэй холбоотой асуудлыг авч хэлэлцэн шийдвэрлэх боломжтой бол өргөдлийн талаар тус Хороонд төлөөлөлтэй Парламентын бүлгүүдэд мэдээлж хүсвэл бүлгийн илтгэгчийг ажиллуулах боломжтой.

7.12. Хорооны ажлын албаны санал

Хорооны ажлын албанаас (7.13.1.) дугаарын заалтын дагуу асуудлыг тодруулах, (7.13.2.) дугаарын заалтын дагуу урьдчилсан байдлаар шийдвэр гаргах эсвэл (7.14.) дугаарын заалтын дагуу өргөдлийг шийдвэрлэх мөн тэдгээрийг илтгэгчид шилжүүлэх талаар тус бүрд санал гаргана.

7.13.1. Асуудлыг тодруулах санал

Асуудлыг тодруулах талаар дараах төрлийн саналыг гаргах боломжтой:

- Нэмэлт санал авахыг хүсэх;
- Холбооны Засгийн газрын төлөөлөгчийг уулзалтанд дуудах;
- Гомдлын хувьд Өргөдлийн Хорооны бүрэн эрхийн хуульд заагдсан дараах эрх хэмжээ Хороонд хадгалагдана:
  - Баримт бичгийг өргөн барихыг хүсэх;
  - Өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох;
  - Орон байранд нэгжлэг хийх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

7.13.2. Шийдвэрийн урьдчилсан санал

Холбогдох арга хэмжээний саналд эсэргүүцэл учирсан тохиолдолд Холбооны Засгийн газар болон бусад хариуцсан байгууллагууд (5) арга хэмжээ авах явдлыг Өргөдлийн Хорооноос тухайн гомдлын талаарх эцсийн шийдвэр гарах хүртэл түр хойшлуулна.

7.14. Өргөдлийг эцэслэн шийдвэрлэх тухай санал

Бундестаг өргөдлийг хэрхэн эцэслэн шийдвэрлэх санал дараах хэлбэртэй байна:

7.14.1. Холбооны Засгийн газарт асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор шилжүүлэх

Өргөдлийг Холбооны Засгийн газарт шилжүүлж хэрэв уг өргөдөлд тусгагдсан зүйлс нь бодитой бөгөөд залруулах шаардлагатай бол арга хэмжээ авахыг хүсэх.

7.14.2. Холбооны Засгийн газарт асуудлыг дахин хянуулахаар шилжүүлэх

Өргөдлийг дахин хянуулах зорилгоор Холбооны Засгийн газарт өргөн барьж бодит байдлыг дахин харгалзан залруулах боломжтой бусад арга хэмжээ авахыг хүсэх.

7.14.3. Үндсэн мэдээллийн зорилгоор шилжүүлэх

Холбооны Засгийн газарт өргөдлийг хуулийн төсөл, тогтоолын боловсруулалт, санаачилга болон судалгаанд ашиглах зорилгоор өргөн барих.

7.14.4. Энгийн шилжүүлэг

Өргөдлийг Холбооны Засгийн газарт дараах тохиолдолд шилжүүлнэ:

- Бундестагаас гаргах шийдвэрийн шалтгаан болгох зорилгоор,
- Өргөдөл гаргагчийн дэвшүүлсэн асуудалд анхаарлыг хандуулах.

7.14.5. Парламентын бүлгүүдэд мэдээлэл өгөх зорилгоор өргөн мэдүүлэх

Өргөдлийг дараах нөхцөлд Бундестагын парламентын бүлэгт шилжүүлнэ:

- Өргөдлийн хөндсөн асуудлыг парламентад оруулах санаачилга болгох;
- Өргөдөл гаргагчийн хөндсөн асуудалд парламентын бүлгийн анхаарлыг татах.

7.14.6. Европын Парламентад өргөн мэдүүлэх

Өргөдлийг Европын Парламентад түүний бүрэн эрхэд нөлөөлөхүйц бол өргөн мэдүүлнэ.

7.14.7. Хянан хэлэлцэхийг дуусгавар болгох

Өргөдлийг хянан хэлэлцэх ажиллагаа дараах нөхцөлд дуусгавар болно.

- Одоогийн сонгуулийн хугацаанд уг асуудлыг аль хэдийн авч хэлэлцсэн;
- Уг асуудал өргөдөл гаргагчийн хүсэлтээр өмнө нь шийдвэрлэгдсэн;
- Ямар нэгэн хуулийн заалт өөрчлөгдөхгүй эсвэл нэмэгдэхгүй бол;
- Санал хүсэлт, гомдол гаргагчийн дэвшүүлсэн асуудлыг түүний хүссэнээр шийдвэрлэх боломжгүй;
- Өргөдөлд тусгагдсан захиргааны агентлагын үйл ажиллагаа нь шүүмжлэгдэх шалтгаан болохгүй;
- Өргөдөлд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

7.15. Шалтгаан гаргах бусад санал/үүрэг хариуцлага

Тус дүрмийн 7.14.-д заасан санал нь тухайн өргөдөл яаж шийдвэрлэгдэж болох, мөн хаашаа шилжүүлэх талаархи жишээ байна. Энэ талаар бичгээр мэдэгдэнэ.

8. Өргөдлийн Хорооноос өргөдлийг шийдвэрлэх нь

8.1. Илтгэгчийн үйл ажиллагаа

(1) Илтгэгч нь (7.13.1., 7.13.2., 7.14. дугаар заалтуудын дагуу) Хорооны ажлын албаны санал, өргөдлийн хянан хэлэлцэх ажиллагааг шалган, асуудлын дараалыг тогтоон ажиллана. Тус дүрмийн 7.13.2 дугаар заалттай холбоотой саналыг шуурхай харин бусад саналыг гурван долоо хоногийн дотор шалгана. Хороо нь асуудлын талаар тодруулах ажлыг илтгэгчийн тогтоосон дарааллын дагуу гүйцэтгэнэ. Дараалалд өөрчлөлт орсон тохиолдолд шалтгааныг бичих шаардлагатай.

(2) Олон нийтийн болон давхар өргөдлийн хувьд гол өргөдлийн хэлэлцэх дараалал уг асуудлын талаарх бусад өргөдөлд мөн хамаарна.

8.2.1. Өргөдлийг тусад нь авч үзэх, өргөдөлд санал хураах

Хорооны хуралдаанаар өргөдөл тус бүрийг дараах байдлаар авч үзнэ:

- Өргөдлийг Холбооны Засгийн газарт уламжлан өргөдөлд тусгагдсан асуудлыг эерэгээр шийдвэрлэх, шалгах, асуудлыг шийдвэрлэх арга замыг хайх хүсэлтийг гаргах;
- Бундестаг дахь парламентын бүлэг, Европын парламентад мэдээлэх зорилгоор өргөдлийг шилжүүлэх;
- Илтгэгчийн тогтоосон үйл ажиллагааны дараалал болон Хорооны ажлын албаны санал; тус бүрээр нь авч үзэхийг дэмжих;
- Холбооны Засгийн газрын төлөөлөгчийг Хорооны хуралдаанд оролцуулах;
- Өргөдөл гаргах үед доод тал нь 50,000 хүний дэмжлэгийг авч хорооны гишүүдийн гуравны хоёр дэмжвэл өргөдөл гаргаснаас хойш гурван долоон хоногийн дараа өргөн баригдана. (8.4 (4)).

8.2.2. Шийдвэр гаргах, зөвөлгөө өгч шийдвэрлэх

Өргөдөл гаргагчид гаргасан шийдвэрийг мэдэгдэнэ. Татгалзсан бол шалтгаануудыг заавал заасан байна. Өргөдлийн хороо нь онцгой тохиолдолд буюу нэн чухал гэж үзсэн өргөдлийг хэлэлцэх асуудлын жагсаалтад бүртгэн хэлэлцүүлж болно.

8.4. Хамтын болон олон нийтийн өргөдлийг зохицуулах тусгайлсан дүрэм журмууд.

(1) Өргөдлийн Хорооноос үндсэн өргөдлийг нь судлаж үзэж шийдвэрлэх арга хэмжээ авахаар шийдсэний дараа нэгэн ижил асуудлаар олон өргөдөл ирсээр байвал тэдгээрийг жагсаалт гарган бүртгэн үндсэн өргөдөлтэй хамтатган санал асуулга, сонгуульд оруулна.

(2) Олон нийтийн өргөдлийг (2.2., догол мөр (3)) тухайн хорооноос гаргасан шийдвэрийг дагалдан нэгэн ижил асуудлаар өргөдөл ирсээр байвал тэдгээрийг зөвхөн цуглуулж авах ёстой ба тоог нь тэмдэглэж авна. Хорооноос тэдгээрийн тухайд улирал тутамд мэдээлэл хийнэ.

(3) Догол мөр (1) ба (2)-ын дагуух үйл явц нь гагцхүү хүлээн авсан үндсэн өргөдлийг шийдвэрлэх үүднээс санал асуулга, сонгууль явуулж буй үед хэрэглэгдэнэ. Хэрвээ тухайн нэг хэргийн баримтууд эсвэл хуулийн нөхцөл байдал, Хорооны үзэл бодол, үндсэн өргөдлийн дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх тухайд зэргээр гол үндэслэлд санал асуулга, сонгуулийн үеэр өөрчлөлт гарваас энэхүү үйл явцыг хэрэглэхгүй.

(4) Хэрвээ хамтын буюу олон нийтийн өргөдлийг 50 000 хүн дэмжвэл (8.2.1, 7th bullet point) нээлттэй хорооны хуралд нэг буюу түүнээс дээш өргөдөл гаргагчийн үгийг сонсож танилцах ёстой. Үүний эсрэг шийдвэрийг хороо нь хуралд оролцсон гишүүдийнхээ гуравны хоёрын буюу дийлэнх олонхийн саналаар гаргаж болно. Эдгээр үйл явцыг санал хүсэлт болон гомдлын тухайд хэрэглэнэ. Хувийн нууцыг хадгалах үүднээс, гагцхүү холбогдох хувь хүн зөвшөөрсөн нөхцөлд л нээлттэй хурлыг зохион байгуулна.

8.5. Шийдвэрлэгдсэн өргөдлийн жагсаалт

Шийдвэрлэгдсэн өргөдлийн жагсаалт нь:

- Тус дүрмийн 7.9. болон 7.10.;
- Тус дүрмийн (9.1.2.);
- Өргөдлийн хорооны хуралдаанаар хэлэлцэгдэж өргөдөл гаргагч заасан хугацаанд эсэргүүцэл гаргаагүй өргөдлийг шийдвэрлэгдсэн өргөдлийн жагсаалтад оруулна.

8.6. Өргөдлийн хороо хэлэлцсэн өргөдлийн талаарх тайлан болон зөвлөмжийг хэлэлцүүлэхээр өргөн барих

(1) Өргөдлийн хороо нь хэлэлцсэн өргөдлийн талаарх тайлангаа зохих зөвлөмжийн хамт Бундестагт жагсаалтаар хүргэнэ. (Германы Бундестагийн процедурын дүрэм 112, (1)).

(2) Илтгэгч амаар нэмэлт тайлбар хийж болно. Тайлангийн талаарх хэлэлцүүлгийг зөвхөн парламентын бүлгүүд дээр болон Бундестагийн гишүүдийн 5-аас доошгүй хувийн ирцтэй үед хийнэ.

9. Шийдвэр

9.1.Өргөдөл гаргагчид мэдэгдэх

9.1.1. Шийдвэрийн агуулга ба хугацаа

Бундэстагийн дарга өргөдлийг хүлээж аваад Өргөдлийн байнгын хороонд шилжүүлдэг. Хэрэв өргөдлийн утга нь мэргэжлийн зөвлөлгөө авах шаардлагатай бол холбогдох байнгын хорооны саналыг авдаг. Өргөдлийн байнгын хороо нь хүлээж авсан өргөдлийг шийдвэрийн төсөлтэй нь хамтатган жагсаалтаар сар бүр Бундэстагийн чуулганд оруулж тайлагнана. Үүнээс гадна тус байнгын хороо нь жил бүр Бундэстагт бичгээр тайлангаа тавьдаг.

9.1.2. Шийдвэр парламентын завсарлагын үеэр шийдвэрийг танилцуулах

(1) Бундестагийн хуралдаан хоёр долоо хоногоос илүү хугацаагаар завсарласан үед илтгэгчийн болон хорооны ажлын албаны санал адил байвал Бундестаг шийдвэрээ албан ёсоор гаргаагүй байсан ч өргөдөл гаргагчид гарах шийдвэрийг мэдэгдэж болно.

(2) Тус дүрмийн (8.2.1.) -ийн дагуу ирсэн өргөдлийг хэлэлцэж байх хугацаанд тус хорооны бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол шинэ парламентын өргөдлийн хороо үргэлжлүүлэн авч хэлэлцэнэ.

9.1.3.Шийдвэрийг мэдэгдэх/ нийтэд мэдээлэх

(1) Өргөдөл гаргасан иргэнд гэрийн хаягаар, давхар өргөдөл гаргасан бол гол өргөдөл болгон бүртгэсэн хүний хаягаар шийдвэрийг хүргүүлнэ.

(2) Олон нийтийн болон хамтын өргөдөлд мөн хамаарна.

(4) Хэрэв өргөдөл гаргагчид хамтын нэгдсэн хаяг байхгүй бол олон нийтэд мэдээлнэ. Өргөдлийн хороо шийдвэрийг олон нийтэд хүргэх талаар шийдвэр гаргана.

9.2. Шийдвэрийг Холбооны Засгийн газар харъяа байгууллагууд мэдэгдэх

9.2.1. Шийдвэрийг хүргэх хариуцлага/хүргэх хугацаа

(1) Холбооны Засгийн газарт өргөдлийг шилжүүлж, холбогдох арга хэмжээ авахуулах тухай Бундестагийн шийдвэрийг Бундестагийн ерөнхийлөгч Холбооны Канцлерт мэдэгдэнэ. Өргөдлийг Холбооны Засгийн газарт шилжүүлж, асуудлыг дахин хянан үзэх, үүсэн нөхцөл байдлыг залруулах боломжийг судлуулах тухай Бундестагийн шийдвэрийг

Өргөдлийн хорооны дарга холбогдох Холбооны сайдад мэдэгдэнэ.

(2) Холбооны засгийн газар зургаан долоо хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

(3) Хэрэв өргөдөлд дурдагдсан асуудлыг шийдэх арга хэмжээ авах, дахин хянан үзэх, асуудлыг шийдвэрлэх арга замыг олуулахаар өргөдлийг Холбооны Засгийн

газраас өөр байгууллагад шилжүүлж байгаа бол (1) ба (2) заалт шаардлагатай өөрчлөлттэйгээр хүчинтэй.

(4) Хэрэв өргөдлийг Европын парламентад шилжүүлэхээр Бундестагаас шийдвэрлэсэн бол уг шийдвэрийн тухай Бундестагийн Ерөнхийлөгч Европын парламентын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

9.2.2. Холбооны Засгийн газар Холбооны бусад байгууллагуудаас хариу ирүүлэх

Тус дүрмийн (6.3.)-т зааснаар шилжүүлсэн бол бичгээр хариу мэдэгдэнэ.

10. Өргөдлийн хорооны зөвлөмж, тайлан

(1) Өргөдлийн хороо нь хэлэлцсэн өргөдлийн талаарх тайлангаа зохих зөвлөмжийн хамт Бундестагт жагсаалтаар хүргэнэ. Тайланг сар тутам хүргэнэ. Мөн өөрийн хийсэн ажлын тайланг жил бүр Бундестагт гаргана.

(2) Чуулганы хугацаанд тайланг хүргэснээс хойш гурван долоо хоногийн дотор тайланг хэвлэж, тараах бөгөөд чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд оруулсан байна. Илтгэгч амаар нэмэлт тайлбар хийж болно. Тайлангийн талаарх хэлэлцүүлгийг зөвхөн парламентын бүлгүүд дээр болон Бундестагийн гишүүдийн 5 -аас доошгүй хувийн ирцтэй үед хийнэ.

(3) Өргөдөл гаргагчид түүний хүсэлтийг хэрхэн хэлэлцсэн талаар мэдээлнэ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ ДЭХ БАЙНГЫН ХОРООДЫН АЖЛЫН АЛБА (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

Парламентын Тамгын газрын бүтэц дэх Байнгын хороодын ажлын алба

Байнгын хороодын ажлын алба нь байнгын болон дэд, түр хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцлөөр хангах үүрэг бүхий Тамгын газрын нэгж юм. Энэхүү алба нь парламентад өргөн баригдсан хуулийн төслийг хянаж, зохих журмын дагуу хэлэлцүүлэгт бэлтгэх, хороод, ажлын хэсэг, гишүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, гишүүдээс хуулийн төсөл санаачлах ажилд судалгаа, шинжилгээ, мэдээллээр хангахад туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхдээ парламентын ажлын албаны эрх зүйн үйлчилгээний болон судалгааны албадтай нягт хамтран ажилладаг.

Хууль тогтоомжийн төслийг хороодоор хэлэлцэх явцад хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдаан, хэлэлцүүлгийн зохион байгуулах, хэлэлцүүлгийн явцад гарсан саналын зөрүүг арилгахад чиглэсэн эрх зүй, дүн шинжилгээ, мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ. Парламентын хууль тогтоох үйл явцад Байнгын хороодын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үүргийг дээшлүүлэх нь нэн чухал бөгөөд үүний тулд нэг талаас, хууль тогтоох үйл явцад оролцох байнгын хороодын эрх, үүргийг илүү нарийвчлах, нөгөө талаас байнгын хороодын ажлын албаны чиг үүргийг илүү тодорхой болгох, мэргэшүүлэх, чадавхийг сайжруулах асуудал чухлаар тавигддаг байна.

Дээрх асуудлын хүрээнд Байнгын хороодын ажлын албаны түвшинд дараахь асуудлуудыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Хороодоор хэлэлцэгдэх асуудал нь улсын төсөв болон нийгэм, эдийн засгийн салбарт хэрхэн нөлөөлөх үр дагаврын талаар мэргэжлийн дүгнэлт гаргадаг байх,
- Өргөн баригдсан хуулийн төслийг байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцэх, батлан гаргах бүхий л үе шатанд байнгын хорооны зөвлөх нь салбарын бодлогын зөвлөхийн хувьд, харин эрх зүй хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх нь хуулийн зөвлөхийн хувьд хамтран хариуцан ажиллах,
- Байнгын хороодын ажлын албаны салбар чиглэлийг дагнан хариуцах зөвлөхүүдийн орон тоог нэмэгдүүлж, мэргэшүүлэх зэрэг болно.

Өнөөгийн байдлаар хуулийн төслийн хэлэлцүүлгийг Байнгын хорооны шатанд Байнгын хорооны ажлын албаны зөвлөх, нэгдсэн хуралдааны шатанд Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх хувааж хариуцаж байна. Зүй нь Байнгын хорооны зөвлөх нь салбарын бодлогын зөвлөх, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх нь хуулийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэх ёстой.

Дэлхийн улс орнуудын парламентын Ажлын албанд байнгын болон бусад хороодын үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг нийтлэг байна. Харин энэхүү чиг үүргийг Тамгын газрын янз бүрийн нэгжээр дамжуулан хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Тамгын газрын байнгын хороодын ажлын албадаар дамжуулан парламентын байнгын хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлдэг зарим улс орны тус албаны бүтэц, үйл ажиллагааны талаар товч танилцуулгыг бэлтгэв.

Швейцар

Байнгын хороодын ажлын алба нь хууль тогтоох хороодын нарийн бичгийн даргын газраас бүрдэнэ. Парламентын гишүүдэд хуулийн төсөл, мөн нарийн төвөгтэй хэлэлцээрүүд, тоо баримтыг нарийвчлан судлахад туслах үүрэгтэй. Хороо бүр өөрийн ажлын албатай. Ажлын албад хороодын үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, техник зохион байгуулалт, захиргааны туслалцаа үзүүлэх, парламентын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөгөө өгнө.



Нидерландын Төлөөлөгчдийн танхим

- Хороодод туслах департментууд

Төлөөлөгчдийн танхимын гишүүд байнгын хороод дээр тогтмол хуралддаг. Байнгын хороо бүрт Клерк болон түүний хэд хэдэн орлогч байх бөгөөд байнгын хорооны бүх үйл ажиллагаа, уулзалт, томилолт зэргийг зохион байгуулна. Мөн хуулийн төсөл, бусад шаардлагатай асуудлаар зөвлөгөө өгч, байнгын хорооны дарга үүргээ гүйцэтгэхэд нь туслана. Департмент парламентын хэлэлцүүлгийн үед Танхимын ерөнхийлөгчид туслана.





- Байнгын хороодын ажлын алба (Standing Committees Secretariat)

Тус албаны бүтцэд Байнгын хороодын нарийн бичгийн дарга нарын газар ба Байнгын хороодын архив байна. Байнгын хороодын нарийн бичгийн даргын газар нь хороодын хурал, сонсгол зэргийг зохион байгуулах, хэвлэл, олон нийтэд зориулсан мэдээллийг бэлтгэх, хороодын өдөр тутмын ажилд бодитой туслалцааг үзүүлэх үүрэгтэй. Байнгын хорооны архив нь хороодын үйл ажиллагааны тайлан мэдээг хадгалах, хороодын архивыг Стортингийн архив руу явуулахад бэлтгэх ажлыг хариуцна.

- Хороодын ажлын алба (Committee Secretaries)

Хороодоор хуулийн төсөл хэлэлцүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах ба үйл ажиллагаанд нь мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

Серби улс

- Байнгын хороодын асуудал хариуцсан сектор

Тус сектор нь холбогдох шийдвэрт заасан дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Байнгын хороодын хуралдааныг бэлтгэх, зохион байгуулах;

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

- Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэгдсэн асуудлуудтай холбоотой баримт бичиг, мэдээ бэлтгэх, тайлан бичих;
- Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж буй асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, хуулийн төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлтийг томъёолон бэлтгэх;
- Байнгын хороодоос гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Иргэд, байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авах;
- Үндэсний ассамблейгаас баталсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын танилцуулга, тайлан бичих;
- Санаачилсан хууль тогтоомжийн төсөл Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлт гаргахад зориулан санал, тайлбар бэлтгэх, холбогдох мэдээллийг харьцуулах;
- Иргэд, байгууллагуудаас гаргасан өргөдөл, санал, хүсэлтэд хариу өгөхөд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- Хууль тогтоомж болон хуулийн төсөлд анализ хийх;
- Үндэсний ассамблей, түүний байнгын хороод болон гишүүдэд шаардлагатай бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Байнгын хороодын асуудал хариуцсан сектор нь дараах 4 хэлтэстэй байна. Үүнд:

- Хууль зүйн хэлтэс
- Эдийн засгийн харилцаа, санхүүгийн хэлтэс
- Батлан хамгаалах, Үндэстний асуудлын хэлтэс
- Нийгмийн бодлогын хэлтэс

Хууль зүйн хэлтэс нь Үндсэн хуулийн байнгын хороо, Хууль тогтоомжийн хороо, Захиргааны хороо, Эрх зүй, захиргааны хороо, Нутгийн өөрөө удирдах байгууллагын хороо болон Өргөдөл, саналын хорооны эрх мэдлийн хүрээн дэх үүргийг гүйцэтгэнэ. Эдийн засгийн харилцаа, санхүүгийн хэлтэс нь Санхүүгийн хороо, Өмч хувьчлалын хороо, Аж үйлдвэрийн хороо, Хөдөө аж ахуйн хороо, Худалдаа, аялал жуулчлалын хороо, Тээвэр, харилцаа холбооны хороо болон Хот төлөвлөлт, барилга, эдийн засгийн шинэчлэлийн хороодын эрх мэдлийн хүрээн дэх асуудлуудыг хариуцан ажиллана.

Батлан хамгаалах, Үндэстний асуудлын хэлтэс нь Батлан хамгаалах, аюулгүй байдлын хороо, Үндэстэн хоорондын харилцааны хороо, Косово - Метохияагийн асуудал хариуцсан хороо, Гадаадад оршин сууж буй сербүүдийн асуудал хариуцах хороо болон Аюулгүй байдлын албадын хяналтын хороодын эрх мэдлийн хүрээн дэх асуудлуудыг хариуцан ажиллах үүрэгтэй. Нийгмийн бодлогын хэлтэс нь Эрүүл мэнд, гэр бүлийн хороо, Ядуурлыг бууруулах хороо, Соёл, мэдээллийн хороо, Боловсролын хороо, Шинжлэх ухаан технологийн хөгжлийн хороо, Хөдөлмөр, цэргийн алба хаагсад болон нийгмийн асуудлын хороо,Байгаль орчны хороо, Залуучууд, спортын хороо болон Жендерийн эрх тэгш байдлын хороодын эрх мэдлийн хүрээний асуудлуудыг хариуцаж ажиллана.


Үндэсний Ассамблейн дарга
Төрийн Ахлагчийн ажлын алба
Хэвлэл мэдээлэл, төрийн ба нийтийн сектор
Хэвлэл мэдээлэл, төрийн ба нийтийн сектор
Хэвлэл мэдээлэл, төрийн ба нийтийн сектор
Төрийн Ахлагчийн ажлын алба
Хэвлэл мэдээлэл, төрийн ба нийтийн сектор
Төрийн Ахлагчийн ажлын алба
Төрийн Ахлагчийн ажлын алба
Төрийн Ахлагчийн ажлын алба

Аргентин Улс

Аргентин улсын Парламентын ажлын алба нь Удирдлагын газар, Байнгын хороодын газар, Стенографийн газар, Хүний нөөцийн газар, Гадаад харилцаа, ёслолын газар, Санхүүгийн газар, Парламентын офисын газар, Хэвлэл, мэдээлэл, архив, музейн газар, Өв соёлын газар, Парламентын үйлчилгээний газар, хэлтэс, албадтай. Аргентины парламент нь 2 танхимтай, хоёр танхим тус бүрийн Тамгын газар нь Байнгын хороодын газартай юм.

Байнгын хороодын газар

Тус газар нь хуралдааныг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, дотоод ажлын зохион байгуулалтыг хангах, Хорооны дарга, гишүүдэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, ажлын алба, ажилтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, шуурхай удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Байнгын хороодын ерөнхий газар

Тус газар нь Сенатын танхимын Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах болон техник үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Узбек Улс

Узбекстан Улсын парламентын доод танхим болох Хууль тогтоох танхимын үйл ажиллагаанд мэдээлэл, материал-техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Тамгын газар ажилладаг. Тамгын газар нь хуулийн хэлтэс, байнгын хороодын ажлын алба, хяналт, мэдээллийн хэлтэс, гадаад харилцааны хэлтэс, хэвлэл, орчуулгын хэлтэс, ерөнхий хэлтэс гэсэн зургаан хэлтэстэй.

Тамгын газрын бүтэц:

Байнгын хороодын ажлын алба

Тус алба нь Байнгын хороодоор хуулийн төсөл хэлэлцэх, санал, дүгнэлт гаргах, хянах зэрэг үйл ажиллагаанд зохион байгуулалт, арга зүй, мэдээллийн болон шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөгөө өгнө. Түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, байнгын хороодоос зохион байгуулж буй арга хэмжээ болон ажлын хэсэг байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

Швейцар улс

Байнгын хороодын ажлын алба нь хууль тогтоох хороодын нарийн бичгийн даргын газраас бүрдэнэ. Парламентын гишүүдэд хуулийн төсөл, мөн нарийн төвөгтэй хэлэлцээрүүд, тоо баримтыг нарийвчлан судлахад туслах үүрэгтэй. Хороо бүр өөрийн ажлын албатай. Ажлын албад хороодын үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, техник зохион байгуулалт, захиргааны туслалцаа үзүүлэх, парламентын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар зөвлөгөө өгнө.

UHLMN
СУДАЛГААНЫ



Австралийн Сенатын Департмент

Сенатын Департмент нь Сенат, түүний байнгын хороод, сенатын ерөнхийлөгч, сенатын гишүүдэд хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөх болон туслах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Сенатын департмент нь Сенатын Клеркийн газар, Баримт бичгийн газар (Table office), Процедурын газар, Байнгын хороодын газар, Блейк Родын газар (Black Rod's office) гэсэн 5 газартай.

- Байнгын хороодын газар

Энэ газар нь парламентын байнгын хороод, тусгай хороод болон хоёр танхимын хамтарсан хороодод зориулан судалгаа хийх, захиргааны болон нарийн бичгийн даргын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Газрын дарга нь Сенатын Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент байх бөгөөд мөн Баримт бичгийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэж, байнгын хороод болон хороодын ажлын албадад процедурын холбоотой зөвлөгөө, удирдамж өгнө.

Байнгын хороодын газар нь хууль тогтоох найман хороо, Ерөнхий үүргийн байнгын хороо, хамтарсан дүрмийн гурван хороо болон Сенатаас байгуулсан тусгай хороодод үйлчилнэ. Хууль тогтоох болон Ерөнхий үүргийн байнгын хороодын ажлын алба нь байнгын хороодын газрын ажилтнуудаас бүрдэнэ. Ажлын алба нь Клеркийн байнгын хороод хариуцсан ассистент, байнгын хорооны нарийн бичгийн дарга болон судалгааны асуудал хариуцсан ажилтнуудаас бүрдэнэ. Судлаачдын тоог хариуцах ажлаас хамааран тогтооно.



Финланд улс

Парламентын ажлын алба нь Төв алба, Захиргааны газар, Хороодын ажлын алба, Гадаад харилцааны газар, Мэдээлэл холбооны газар, Санхүү, бүртгэлийн алба, Аюулгүйн алба гэсэн нэгжүүдтэй.

- Хороодын ажлын алба нь Ерөнхий хорооны, Байнгын хороодын, Европын холбооны / EU Secretariat/ хорооны гэсэн ажлын албадтай.

Хороодын ажлын алба нь хорооны хурлын зохион байгуулалт, бэлтгэл ажлыг хариуцна. Хорооны ажлын алба нь Байнгын хороод болон Ерөнхий хорооны ажилтнуудаас бүрдэнэ. Ерөнхий хорооны ажлын алба /Secretariat of the Grand Committee/ нь Үндсэн хуулиар олгогдсон тусгай чиг үүрэгтэй бөгөөд Европын холбоон дээр шийдэгдэх хууль эрх зүйн актууд, төсөв, гэрээ хэлэлцээрийн талаарх парламентын байр суурийг нэгтгэн бэлтгэх, шүүх эрх мэдэл, дотоод бодлого, Европын холбооны үйл ажиллагаанд оролцох зохион байгуулалт, төсвийн асуудал зэргийг хариуцдаг. Ерөнхий хороо нь дээр дурдсан чиглэлээр өргөн баригдсан төслийн талаар парламентын анхны хэлэлцүүлэг хийсний дараа хэлэлцэх журамтай. Ерөнхий хороо нь Европын холбооны хорооны ажлын албатай ижил төрлийн үйлчилгээг үзүүлнэ.

15 Байнгын хорооны ажлын алба /15 special Committees/ нь Засгийн газраас санаачилсан хуулийн төсөл, санал, засгийн газрын тайлан мэдээ, хуралдааны бусад асуудлуудыг бэлтгэх ажлыг хариуцан хэрэгжүүлнэ. Хороод бүр холбогдох яамдтай тодорхой асуудлаар хамтран ажиллана.

Европын холбооны хорооны ажлын алба /EU Secretariat/ нь Европын холбоотой харилцан, түүнд хамааралтай ажлуудыг хариуцна. Европын холбооны хорооны ажлын алба нь Ерөнхий хороо, Гадаад хэргийн хорооны ажилтнууд, европын холбооны мэдээллийн төв дэх Парламентын тусгай зөвлөх /Parliament's special adviser in Brussels and the EU information officer/ зэрэг албаны хүмүүсээс бүрдэнэ.



Швед Улс

Швед Улсын парламент Риксдагийн захиргааг Ерөнхий нарийн бичгийн дарга толгойлох бөгөөд тус захиргаа нь Танхимын нарийн бичгийн даргын газар, Парламентын хороод ба Европын холбооны асуудлын хорооны нарийн бичгийн даргын газрууд, Захиргааны газар, Харилцаа холбооны газар, Гадаад харилцааны департментаас бүрдэнэ.

- Хороодын нарийн бичгийн даргын газрууд

Риксдагт 15 парламентын хороо байдаг. Хороо бүр өөрийн нарийн бичгийн даргын газартай бөгөөд эдгээр газрууд нь хорооны нэг ахлах нарийн бичгийн дарга болон таваас

арван ажилтантай байдаг. Хорооны нарийн бичгийн даргын газар нь гишүүдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд шаардлагатай материал бэлтгэх, Европын холбооны зарим материалд дүгнэлт бичих, үүний дагуу Риксдагийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй. Мөн судалгаа, төлөвлөлттэй холбоотой ажилд нь туслана.

- Европын холбооны асуудлын хорооны нарийн бичгийн даргын газар

Засгийн газар Европын холбоотой холбогдох ажлынхаа талаар Риксдагийн Европын холбооны асуудлын хороотой заавал зөвлөлдөнө. Энэ хороо нь парламентын бусад хороодтой адил 17 гишүүнтэй байна. Нарийн бичгийн даргын газар нь нэг нарийн бичгийн дарга, таван ажилтантай.

* * *

Ашигласан материал

1. Дэлхийн улс орнуудын парламент. УБ., 2010
2. Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УБ., 2012
3. www.ipu.org

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ҮНДЭСНИЙ АССАМБЛЕЙН АЖЛЫН АЛБАДЫН ТУХАЙ (ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ)

Р. Хатанбаатар, Ц. Товуусүрэн, А. Пагма

Нэг. БНСУ -ын Үндэсний ассамблей

Үндэсний ассамблейн эрх мэдэл

Үндэсний ассамблейн зохион байгуулалт



Хууль санаачлагч

Хууль тогтоох үйл ажиллагааны урьдчилсан шат



UIS.MN
СУДАЛГААНЫ САН

Хуулийн төслийг Хороодоор хэлэлцэх

Хууль санаачлагч төслөө танилцуулах
Хорооны экспертийн албанаас төсөлд шинжилгээ хийсэн тайлан
Ерөнхий хэлэлцүүлэг
Ерөнхий хэлэлцүүлэг
Дэд хороодоор
Нэмэлт санал
Хэлэлцүүлэг
Санал хураалт

Нэгдсэн чуулганаар хуулийн төсөл хэлэлцэх

Хуулийн төсөл хэлэлцэх
Төслийн танилцуулга
Байнгын хорооны даргын илтгэл
Асуулт, хариулт, хэлэлцүүлэг
Санал хураах
Ерөнхийлөгчид өргөн барих (15 хоногийн дотор)
Нэмэлт, өөрчлөлт оруулах
30 гишүүний санал авсан байх (төсөвтэй холбоотой бол 50 гишүүн)
Нэмэлтийг холбогдох хороогоор хэлэлцүүлсэн байх.

Үндэсний ассамблейн дарга
Үндэсний ассамблейн даргын ажлын алба
Үндэсний ассамблейн дэд дарга
Хүний нөөцийн дарга
Хороод
Үндэсний ассамблейн дэд дарга
Тамгын газар
Ерөнхий хянан шалгагч
Олон нийттэй харилцах албаны Ерөнхий захирал
Ерөнхий нарийн бичгийн дарга
Хууль зүйн асуудал эрхэлсэн ЕНБД-ын орлогч
Захиргааны асуудал эрхэлсэн ЕНБД-ын орлогч
Радио, ТВ-ийн мэдээллийг төлөвлөх
Дэгийн товчоо
Хуулийн зөвлөхийн алба
Парламентын үйл ажиллагааг дэмжих төв
Үйл ажиллагааг дэмжих хэлтэс
Хүний нөөцийн хэлтэс
Парламентын сургалтын алба
Парламент хоорондын харилцааны товчоо
Ордны ашиглалтын товчоо
Төлөвлөлт, зохицуулалтын алба
Үндэсний ассамблейн номын сан
Үндэсний ассамблейн номын сан
Төлөвлөлт, удирдлагын офис
Парламентын мэдээллийн офис
Мэдээллийн үйлчилгээний товчоо
Мэдээллийн удирдлагын товчоо
Үндэсний хурлын архив
Үндэсний ассамблейн төсвийн газар
Төсвийн газрын дарга
Төлөвлөлт, удирдлагын хэлтэс
Төсвийн шинжилгээний хэлтэс
Эдийн засгийн шинжилгээний хэлтэс
Хөтөлбөрийн үнэлгээний хэлтэс
Үндэсний ассамблейн судалгааны газар
Судалгааны газрын захирал
Төлөвлөлт, удирдлагын офис
Улс төр, захиргааны судалгааны офис
Эдийн засаг, аж үйлдвэрийн судалгааны алба
Нийгэм, соёлын судалгааны алба

UNI.MN
СУДАЛГААНЫ САН

Хоёр. БНСУ-ын Үндэсний ассамблейн ажлын албад

Үндэсний Ассамблейн даргын удирдлаганд ажилладаг парламентын ажлын албад:

I. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн Тамгын газар

Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төсөв, бүртгэл тооцоог хянах, зохион байгуулах болон захиргааны үйл ажиллагааг удирдан явуулах зорилгоор Үндэсний Ассамблейд Тамгын газрыг байгуулна. (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйл)

Ерөнхий нарийн бичгийн даргыг Үндэсний Ассамблейн анхдугаар чуулганаар Үндэсний Ассамблейн дарга намын бүлгүүдтэй зөвшилцөн томилно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Тамгын газрыг удирдах ба Үндэсний Ассамблейн даргын хяналт дор Үндэсний Ассамблейн Дэгийн мөрдөлтөд хяналт тавина. (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйл)

Ерөнхий нарийн бичгийн дарга нь хоёр орлогчтой байна. Ерөнхий нарийн бичгийн даргын нэг орлогч нь нь хууль тогтоох үйл ажиллагааны эрхлэх асуудлын хүрээнд танхим, хороод, гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нөгөө орлогч нь захиргааны үйл ажиллагааг эрхлэх асуудлын хүрээнд төлөвлөлт, төсөв, хүний нөөц, парламент хоорондын харилцаа, сургалт, олон нийтэд мэдээлэл өгөх, ерөнхий үйлчилгээний зэрэг асуудлыг тус тус хариуцна.

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйл. Үндэсний Ассамблейн Тамгын газар

1) Хууль тогтоох, төсвийн хяналт шалгалтыг гүйцэтгэх, санхүүгийн төлбөр тооцоо хийх зэрэг үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, түүнчлэн Үндэсний Ассамблейн захиргааны ажлыг удирдан явуулах зорилгоор Үндэсний Ассамблейд Үндэсний Ассамблейн Тамгын газрыг байгуулна.
2) Үндэсний Ассамблейн Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүлэх бөгөөд бусад шаардлагатай төрийн албан хаагчид ажиллана.
3) Ерөнхий нарийн бичгийн даргыг нам, бүлгүүдийн төлөөлөгч гишүүдтэй зөвлөлдөн, Үндэсний хурлын чуулганаар хэлэлцүүлэн Үндэсний хурлын дарга томилж, чөлөөлнө.
4) Үндэсний Ассамблейн даргын хяналт дор Ерөнхий нарийн бичгийн дарга Үндэсний Ассамблейн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудад хяналт тавьж, Тамгын газрын албан хаагчдыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.
5) Үндэсний Ассамблейн Тамгын газар нь Үндэсний Ассамблейн гишүүд болон хороодын хүсэлтийн дагуу хууль тогтоох, төсвийн хяналт шалгалт, санхүүгийн төлбөр тооцоо хийх зэрэг Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд шаардлагатай үйлчилгээ болон материал хэрэгслээр ханган ажиллана.

6) Ерөнхий нарийн бичгийн дарга болон түүний эрх олгосон албан хаагчид нь 5 дахь хэсэгт заасан хороодын хүсэлтийн дагуу аливаа асуудалд Ерөнхий нарийн бичгийн даргын хяналт дор тайлан, тайлбар хийнэ. Түүнчлэн Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний Ассамблейн даргын зөвшөөрөлтэйгөөр Засгийн газар, захиргааны агентлагууд болон бусад газруудаас шаардлагатай баримт материалыг гаргуулан авч болно.

Энэ хуульд зааснаас бусад Үндэсний Ассамблейн Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

II. Парламентын төсвийн шинжилгээний алба

Судалгаанаас үзэхэд, сүүлийн үед парламентын төсөв хэлэлцэх чадавхийг сайжруулахад бусад орнууд ихээхэн анхаарч байгаа нь харагдаж байна. Хууль тогтоох байгууллагын зүгээс шаардлагатай бол өргөн барьсан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, эрх бүхий зарим байгууллагыг төсвийн хувьд Засгийн газраас хараат бус байлгах, улс орныхоо хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэх үүднээс төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, төсвийн судалгаа шинжилгээ болон хэлэлцүүлэгт бэлтгэх үйл ажиллагаа, төсөв батлагдсаны дараахь хяналт шинжилгээ зэрэг функциональ үйл ажиллагаануудыг тодорхой бүтцийн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, парламентыг төсвийн талаар хараат бус мэдээлэл, шинжилгээгээр хангах чиг үүрэг бүхий бие даасан албад нь Бельги, Канад, Унгар, Солонгос, Нидерландад Парламентын төсвийн алба (PBO - Parliamentary Budget office), Австри, Шведэд Fiscal Council, АНУ-д Конгрессийн төсвийн алба (CBO- Congressional budget office) зэрэг нэртэйгээр, томоохон бүтэцтэйгээр ажилладаг байна. Эдгээр төсвийн шинжилгээний байгууллагуудад макро эдийн засгийн шинжээч, татварын шинжээч, төсвийн шинжээч, Засгийн газар хариуцсан шинжээч, тойрог хариуцсан шинжээч, аналитик шинжээчид, программ хангамж, мэдээлэл технологи хариуцсан ажилтан зэрэг төрөл бүрийн мэргэжилтнүүд ажилладаг.

Парламентын төсвийн алба (Parliamentary Budget office) нь парламентыг төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэгтэй. Парламентын төсвийн алба нь Засгийн газрын төсөвт хяналт тавих, парламентыг үндэслэл тооцоо бүхий мэдээллээр хангахуйц хэмжээний чадавхи нөөцтэй, хараат бус байх ёстой. Бүтэц, харьяалалын хувьд парламентын ажлын албаны бүтцэд, судалгааны албаны бүтцэд, эсхүл ажлын албанаас тусдаа бие даасан хэлбэртэй байна. (PBO, CBO, Fiscal council)

БНСУ -ын парламентын Төсвийн алба нь Үндэсний ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл, Үндэсний ассамблейн Төсвийн албаны тухай хуулийн дагуу 2003 онд байгуулагдсан. Үндэсний ассамблейн Төсвийн алба нь Үндэсний ассамблейн даргын шууд удирдлаган дор ажилладаг. Тус газар нь төсөв, төрийн сан, санхүүгийн менежмент, санхүү, бүртгэлийн асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй. (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

Төсвийн газар нь төсвийн тухай хуулийн төслийг судлах, анализ хийх, төсвийн болон сангуудын хөрөнгийг зарцуулахтай холбоотой хуулиудын төслийн нэгдсэн дүнд анализ хийх, төрийн болон макро эдийн засгийн талаарх санхүүгийн чиг хандлагыг судлах, мэдээ гаргах, задлан шинжилгээ хийх, томоохон хэмжээний нийтийн төслүүдэд үнэлгээ өгөх, төрийн урт болон дунд хугацааны санхүүгийн үнэлгээ хийх, Үндэсний хурлын гишүүд болон хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу дүн шинжилгээ хийх зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Үндэсний Ассамблейн

СУДАЛГААНЫ

Төсвийн газар

1) Төсвийн төлбөр тооцоо, улсын сан, санхүүгийн менежменттэй холбогдох асуудалд судалгаа, анализ, үнэлгээ хийх, түүнчлэн парламентын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилготойгоор Үндэсний Ассамблейн Төсвийн газрыг байгуулна.
2) Үндэсний Ассамблейн Төсвийн газар нь дарга, бусад шаардлагатай төрийн албан хаагчидтай байна.
3) Үндэсний Ассамблейн Төсвийн газрын даргыг Танхимын Удирдлагын хороо / House Steering Committee/-той зөвшилцсөнөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.

Энэ хуульд зааснаас бусад Үндэсний Ассамблейн Төсвийн газрын үйл ажиллагаатай холбогдох асуудлыг хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна. Үндэсний ассамблейн Төсвийн алба нь Үндэсний ассамблейн Төсвийн албаны тухай хууль болон Төсвийн албаны дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулдаг.

Чиг үүрэг: Төсвийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн алба нь улсын төсвийн тайлан гаргаж, мөнгөн хуримтлал болон төсөв санхүүгийн зарцуулалттай холбоотой дараах ажил үүргийг гүйцэтгэнэ:

- Төсвийн төсөл, тайлан гаргах, мөнгөн хуримтлалын хэрэглээний төлөвлөгөөний төсөл болон мөнгөн хөрөнгийн тайлан гаргахад шаардлагатай судалгаа, анализ хийх
- Төсөв болон мөнгөн хөрөнгийн хэлбэр, арга хэмжээ, дагалдах дүрэм журмын төсөл, хуулийн төсөлд холбогдох хэрэгцээт зардлыг тооцох
- Улсын эдийн засгийн байдал, макро эдийн засгийн чиг хандлагын анализ болон хэтийн төлөвийг прогнозлох
- Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн хэрэгцээ шаардлагын талаар анализ хийх

Үндэсний ассамблейн хороо болон Үндэсний ассамблейн гишүүдийн хүсэлтээр судалгаа, анализ хийх.

БНСУ-ын Үндэсний ассамблейн Төсвийн албаны бүтэц



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Төлөвлөлт, менежментын хэлтэс:

Тус хэлтэс нь Төсвийн албаны бусад хэлтсүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг бөгөөд төсөв болон санхүү, хүний нөөц, мэдээллийн нөөцийн менежмент, номын сангийн үйлчилгээг

гүйцэтгэдэг. Төсвийн анализын хэлтэс: Тус хэлтэс нь дотроо зургаан хэсэгт хуваагдана. Хэлтэс нь:

- Төсвийн төлөвлөгөө болон нөөцийн үйл явцын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн үр дүн болон нөөцийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх
- Төсөв болон нөөцийн тооцоонд зориулан үнийн үнэлгээ болон дүгнэлт гаргах зэрэг чиг үүрэгтэй.

Эдийн засгийн анализын хэлтэс:

Хэлтэс нь 5 хэсэгт хуваагдах бөгөөд татварын анализын зөвлөх туслалцаа үзүүлнэ. Хэлтэс нь:

- Макро эдийн засаг, худалдаа болон үндэсний санхүүгийн бодлогод анализ хийх, урьдчилсан таамаглал гаргах
- Эдийн засгийн бодлогын анализ, санхүүгийн нэгдсэн тайлан гаргах
- Үндэсний өр зээл, орлого болон татварын системд дүн шинжилгээ хийх
- Орон нутгийн болон олон улсын санхүүгийн системийн судалгаа хийх зэрэг чиг үүрэгтэй.

Программын үнэлгээ анализын хэлтэс:

Хэлтэс нь 5 хэсэгт хуваагдана. Хэлтэс нь:

- Үндэсний чухал программуудын үнэлгээ болон анализ
- Үндэсний чухал программуудын хэрэгжилтийн үнэлгээ, мониторинг
- Үндэсний чухал программ болон дунд хугацааны санхүүгийн эрэлт хэрэгцээний үнэлгээ, анализ
- Төсвийн илүүдэл зардлын төлөв байдлын үнэлгээ, анализ
- Олон нийтийн байгууллагуудын менежмент болон гүйцэтгэлийн программ, төсвийн тайлан, Засгийн газраас олон нийтийн байгууллагуудад олгосон төсвийн үнэлгээ, анализ хийх зэрэг чиг үүрэгтэй.

III. Үндэсний Ассамблейн номын сан

Үндэсний ассамблейн номын сан нь 1952 онд байгуулагдсан ба 1988 онд Үндэсний ассамблейн номын сангийн тухай хууль дахин шинээр батлагдан тус номын сан Үндэсний ассамблейн бие даасан нэгж болсон байна.

Номын сан нь ном, хэвлэл, байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны эх сурвалжуудыг цуглуулах, парламентын хууль тогтоох болон хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай тоо баримтуудыг гаргах, задлан шинжлэх, эмхэтгэх, цуглуулах ажлыг гүйцэтгэхээс гадна эдгээр эх сурвалжийг олон нийтэд хүртээмжтэй байлгах үүрэгтэй.

Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн номын сан

1) Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай ном товхимол, хууль тогтоомжийн талаарх материалаар хангах зорилгоор Үндэсний Ассамблейн номын санг байгуулна.
2) Үндэсний Ассамблейн номын сан нь дарга болон номын сангийн бусад албан хаагчидтай байна.
3) Үндэсний Ассамблейн номын сангийн даргыг Танхимын Удирдлагын хороо / House Steering Committee/-той зөвшилцсөнөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.
4) Үндэсний Ассамблейн номын сан нь ном товхимол, номын санд хэрэгцээтэй

бусад материалыг цуглуулж, ангилан хадгалах ба Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд номын сангийн үйлчилгээ үзүүлнэ.

Энэ хуульд зааснаас бусад Үндэсний Ассамблейн номын сангийн үйл ажиллагаанд холбогдох асуудлыг хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна. Хэдийгээр номын сан нь хууль тогтоох байгууллагын бие даасан нэгж боловч номын сангийн дарга нь номын сангийн төсвийн зарцуулалтын талаар Удирдлагын хороонд тайлагнах ёстой байдаг. Номын сан нь төлөвлөлт, удирдлагын офис, парламентын мэдээллийн офис, хуулийн номын сан, мэдээллийн үйлчилгээний товчоо, мэдээллийн удирдлагын товчоо, Үндэсний ассамблейн архив гэсэн хэсэгтэй ба эдгээр нь дотроо хэлтэс, албадтай юм.

Номын сан нь нийт 300 орчим ажилтантай, эдгээрийн тал хувь нь ахлах, туслах номын санчид, бусад нь судлаачид, захиргааны ажилтнууд, компьютерийн программист, конторын техник ажилтнууд ажилладаг. Түүнчлэн тус номын сан нь сонирхсон ажилтнуудад зориулан гадаад хэлний, компьютерийн сургалт, төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар семинар зохион байгуулдаг байна.

Үндэсний ассамблейн номын сан нь баялаг номын фондтой, нийт 3.453.050 нэгж ном, 4.798.753 дижитал фонд, 24.043 нэгж тогтмол хэвлэл, 1.002 сонингийн фондтой. Номын сан нь хэлэлцүүлгийн танхим, гишүүдийн уншлагын зал, сонин уншлагын зал, тогтмол хэвлэлийн зал гэх мэт нийт 15 уншлагын танхимтай.

IV. Үндэсний Ассамблейн судалгааны алба

2006 оны 12 дугаар сарын 26 -нд Үндэсний ассамблейн судалгааны тухай хууль батлагдаж, 2007 онд Судалгааны алба байгуулагджээ. 2010 онд тус албыг судалгааны 3 офис, удирдлагын 1 офис, 12 хэлтэс, 101 орон тоотойгоор өөрчлөн байгуулсан байна. Парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор хууль тогтоох болон бодлогын үйл ажиллагааны талаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох мэдээлэл хайх, боловсруулах үүрэгтэй.

Судалгааны алба нь гишүүд, хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаа, шинжилгээ хийнэ. Үндэсний Ассамблейн Судалгааны албаны үйл ажиллагааны журмыг Үндэсний Ассамблейн Судалгааны Албаны тухай хууль болон Үндэсний Ассамблейн хуулийн 22 - 3 дугаар хэсэгт зааснаар зохицуулдаг.

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны гол үйлчилгээ:

- Хороод болон парламентын гишүүдийн захиалгаар судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх
- Хууль тогтоох болон бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, холбогдох мэдээллээр хангах
- Хууль тогтоох болон бодлогын асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, хүргэх
- Гишүүдийн судалгааны хэсгүүдийг мэдээллээр хангах
- Бусад улсуудын хууль тогтоох үйл ажиллагааны чиг хандлагад шинжилгээ хийж, холбогдох мэдээллээр хангана.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь гишүүдийн болон хороодын захиалгаар судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ:

- ✓ Гишүүд болон хороодын хэрэгцээнд суурилан цаг хугацаанд нь, захиалагчийн шаардлагыг хангахуйц мэдээллийг бэлтгэж, хамгийн тохиромжтой хэлбэрээр захилагчид хүргэх,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- ✓ Чанар сайтай мэдээллээр хангахын тулд үйл ажиллагааны процессийг стандартчилах, бусад экспертүүдтэй хамтран ажиллах, шинжлэх ухааны аргачлалыг ашиглах,
- ✓ Бүтээгдэхүүний үнэн зөв, бодит байдлыг хангахын тулд хяналтын хэвтээ болон босоо тогтолцоог ашиглах,
- ✓ Судалгааны нууцлалыг хангана.



Төлөвлөлт, удирдлагын офис.

1. Ерөнхий хэрэг эрхлэх баг. Боловсон хүчин, санхүү, ерөнхий асуудал, удирдлага, нийгмийн үйлчилгээний асуудлыг хариуцан ажиллана.
2. Төлөвлөлт, хамтын ажиллагааны баг. Төлөвлөлт, төсөв, олон нийттэй харилцах, сургалт, мэдээллийн удирдлага, судалгааны захиалгын бүртгэлийн асуудлыг хариуцан ажиллана.

Улс төр, захиргааны судалгааны офис.

1. Улс төр, парламентын судалгааны баг. Үндсэн хууль, парламент, улс төрийн нам, сонгууль, улс төрийн сангуудын судалгааг хариуцан ажиллана.
2. Шүүх, хууль тогтоомжийн судалгааны баг. Шүүх эрх мэдлийн асуудал, авилгатай тэмцэх, хүний эрх, шүүхүүд, эрх зүй, Үндсэн хуулийн шүүх, аудит , хяналт шалгалт, шударга өрсөлдөөний асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
3. Гадаад хэрэг, үндэсний аюулгүй байдлын баг. Гадаад хэрэг, гадаад худалдаа, үндэстний дахин нэгдэх, үндэсний батлан хамгаалах, ахмадын асуудал болон хүний аюулгүй байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

4. Төрийн захиргаа, аюулгүй байдлын баг. Төрийн захиргаа, орон нутгийн өөрийн удирдлага, орон нутгийн санхүү/татвар/, цагдаа, гал түймэртэй тэмцэх, гамшгийн удирдлага, сонирхлын бүлгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Эдийн засаг, аж үйлдвэрийн судалгааны офис**.**

1. Төрийн санхүү, эдийн засгийн баг. Төрийн санхүү, төсөв, үндэсний татвар, эдийн засгийн бодлого, төрийн худалдан авалт, статистикийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. Санхүү, валютын харилцааны баг. Банк, даатгал, санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн хоршилт, гадаад санхүү,гадаад валютын харилцааны асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
3. Аж үйлдвэр, байгалийн нөөцийн баг. Аж үйлдвэр, үйлдвэржүүлэх бодлого, жижиг дунд бизнес, хөдөө аж ахуй, ой мод, загас агнуур, хүнс, худалдаа, оюуны өмч, эрчим хүч, байгалийн баялгийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. Газар, тээвэр, далайн асуудлын баг. Үндэсний газрын хөгжил, хот төлөвлөлт, газар нутаг, орон сууцжуулалт, барилгажуулалт, усны нөөц, тээвэр, төмөр зам, агаарын тээвэр, далай тэнгисийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

Нийгэм, соёлын судалгааны офис.

1. Боловсрол, шинжлэх ухааны баг. Боловсрол, хүний нөөцийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
2. Соёл, мэдээлэл, харилцаа холбооны баг. Соёл, спорт, аялал жуулчлал, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны сүлжээ, мэдээллийн хэрэгсэл, интернэт, мэдээллийн аюулгүй байдлын талаарх судалгааг хариуцан ажиллана.
3. Эрүүл мэнд,гэр бүл, нийгмийн халамж, жендэрийн баг. Эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлгийн тусламж, нийгмийн халамж, нийгмийн даатгал, гэр бүл, хүйсийн тэгш байдлын асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.
4. Хүрээлэн байгаа орчин, хөдөлмөрийн асуудлын баг. Хүрээлэн байгаа орчин, цаг уурын өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааг хариуцан ажиллана.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТ ДАХЬ НАМЫН БҮЛЭГ УДАА ДАРАА ИРЦ БҮРДҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД НАМЫН БҮЛГИЙГ ТАРААХ АСУУДЛААР БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

(ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)

Р. Хатанбаатар, Б. Хатантуул

Монгол Улсын Их Хурлын гишүүн, ТББХ -ны дарга А.Бакейн утсаар өгсөн хүсэлтийн дагуу Парламент дахь намын бүлэг удаа дараа ирц бүрдүүлээгүй тохиолдолд намын бүлгийг тараах асуудлаар бусад орны туршлагыг харьцуулан гүйцэтгэв. Уг асуудлын хүрээнд Казахстан, Узбекстан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани, Аргентин, ОХУ, Франц, Серби улсуудыг судалсан болно.

- Казахстан, Узбекстан, Молдова, Киргиз, Армен, Шинэ Зеланд, Испани улсуудын хувьд бүлгийн гишүүдийн тоо нь бүлгийг бүртгэх тоонд хүрэхгүй болсон тохиолдолд бүлэг үйл ажиллагааг зогсоодог.
- Узбекстан, Киргиз улсын хувьд мөн түүнчлэн өөрийн санаачлагаар эсвэл хууль тогтоох танхимын бүрэн эрхийн хугацаа дууссан үед бүлгийн үйл ажиллагаа зогсдог.
- Аргентин Улсын Депутатуудын Танхимын дүрэм, Үндэсний Конгрессын Акт, ОХУ-н Төрийн Думын Регламент, Францын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг, Сербийн Үндэсний ассамблейн дэг болон Үндэсний ассамблейн хуульд намын бүлгийг тараах асуудлаар нарийвчлан тусгаагүй байна.

* * *

1. Бүгд Найрамдах Казахстан улсын парламентын дэг

120 дугаар заалт. Депутатын бүлгээс хэн нэг депутат гарснаар бүлгийн гишүүдийн тоо нь бүлгийг бүртгэх тоонд хүрэхгүй болсон тохиолдолд депутатын бүлэг үйл ажиллагаагаа зогсооно.

2. Бүгд Найрамдах Узбекстан улсын Олий Мажилисийн Хууль тогтоох танхимийн тухай хууль

   26 дугаар зүйл.Фракц, депутатын бүлгийн үйл ажиллагааг зогсоох

   Дараах тохиолдолд фракц, депутатын бүлгийг үйл ажиллагаа зогсоно:

   1. Фракц болон депутатын бүлгийн өөрийн санаачлагаар
   2. Хууль тогтоох танхимын бүрэн эрхийн хугацаа дууссан
   3. Фракц болон депутатын бүлгийн депутатын тоо цөөрч фракц, депутатын бүлгийг байгуулах тоонд хүрэхгүй болсон.

   Энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт заасан тохиолдлуудаас гадна харьяалагдах улс төрийн нам нь үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд фракцийг тараана.

3. Молдова улсын парламентын дэг

   5 дугаар зүйл. Парламентын фракцийн үйл ажиллагааг зогсоох

   1. Фракцийн бүрэлдэхүүнд таваас доош гишүүн үлдсэн бол фракцийн үйл ажиллагааг зогсооно.

4. Бүгд Найрамдах Киргиз улсын Жогорку Кенешийн дэг

   10 дугаар зүйл. Парламентын фракц

   7. Фракцийн үйл ажиллагаа дараах тохиолдолд зогсоно:

      1. Жогорку Кенеш бүрэн эрхийг зогсоосон
      2. Жогорку Кенеш өөрөө тарсан.

5. Бүгд Найрамдах Армен улсын Үндэсний хурлын дэг

   4.Хэрэв бүх гишүүд нь фракцаасаа гарвал фракцийн үйл ажиллагааг зогсоох ба фракцид орох эрх бүхий ядаж ганц депутат эргэн орвол фракцийн үйл ажиллагааг сэргээнэ.

6. Шинэ Зеландын Төлөөлөгчдийн танхимын дэг

   36 дугаар зүйл 3 дугаар заалт. парламентад байгуулагдсан бүлгийн гишүүдийн тоо 6 -д хүрэхгүй болсон тохиолдолд бүлэг татан буугдана.

7. Испанийн Вант Улсын Депутатуудын танхимын дэг

   27 дугаар зүйл. бүлгийн гишүүдийн тоо нь бүлгийг бүртгэх тоонд хүрэхгүй болсон тохиолдолд бүлгийн үйл ажиллагааг зогсооно.

* * *

Ашигласан материал:

1. www.assemblee-nationale.fr
2. http://www.parliament.nz/NR/rdonlyres/65E97824-9EED-447E-832A-E4A4418EAEA2/252153/standingorders2011_5.pdf
3. http://www.diputados.gov.ar/frames.jsp?mActivo=institucional&p=http://www1.hcdn.gov.ar/dependencias/dip/congreso/regladip.pdf
4. Л.Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй., 2010 он
5. www.parlam.kz/ru/Home/status
6. www.lex.uz/
7. old.parlament.md/legalfoundation/regulations/ru.html
8. www.kenesh.kg/RU/Articles/1099-Reglament.aspx
9. www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=rus
10. http://www.congreso.es/portal/page/portal/Congreso/Congreso/Hist_Normas/Norm/standing_orders_02.pdf

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫГ ҮЛ ХҮНДЭТГЭХ ҮЙЛДЭЛ: АГУУЛГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Р. Хатанбаатар, А. Пагма

УДИРТГАЛ

УИХ -ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р.Бурмаагийн захиалгаар “Парламентыг үл хүндэтгэх үйлдэл, агуулга, эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачид гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Парламентыг үл хүндэтгэх үйлдлийн агуулгыг тодорхойлж, зарим орны тухайлбал, Австрали, АНУ, Их Британи, ХБНГУ, ОХУ-ын жишээн дээр энэхүү үйлдлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

- Судалгаанд хамрагдсан улс орнуудад парламентыг үл хүндэтгэх үйлдлийг хэрхэн тодорхойлдог талаар харьцуулан судлах,
- Дээрхи орнуудад парламентыг үл хүндэтгэх үйлдлийг эрх зүйн хувьд хэрхэн зохицуулдаг, ямар шийтгэл ногдуулдаг талаар харьцуулан судлах,
- Дээрхи орнуудад парламентыг үл хүндэтгэх үйлдэл, түүний агуулга, эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан дэлгэрэнгүй материал бэлтгэх зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын Үндсэн хууль, парламентын Дэгийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны парламентын гишүүний эрх зүйн байдал, эрх ямбын тухай, захиргааны зөрчлийн тухай болон эрүүгийн хуулийн холбогдох заалт,
- Судалгааны материалыг нэгтгэн тайлан бичих зэрэг болно.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р. Хатанбаатар, референт - шинжээч А. Пагма нар хийж гүйцэтгэв.

* * *

Парламентыг үл хүндэтгэх үйлдэл

Парламентын засаглалтай нэлээд олон улс оронд парламент болон парламентын гишүүн эрх мэдлээ хэрэгжүүлэх, чиг үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд нь саад учруулсан үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж үздэг байна. Парламентыг үл хүндэтгэсэн байдлыг илэрхийлэх үйлдлүүд нь олон янз байж болох авч ерөнхийдөө дараах үндсэн 3 зүйлийг хамруулдаг байна. Үүнд:

- Парламент болон түүний хороодыг санаатайгаар хуурах, төөрөгдөлд оруулах
- Парламент болон түүний хороодод гэрчийн мэдүүлэг өгөх, баримт гаргаж өгөхөөс татгалзах
- Парламентын гишүүнд ямар нэг байдлаар нөлөөлөхийг оролдох, жишээ нь, авилга өгөх, заналхийлэх гэх мэт болно.

Зарим оронд парламент нь өөрийн үйл ажиллагаанд саад учруулсан аливаа үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэн хэрэг хэмээн үзэж шийтгэл оноосон бол түүнийг шүүхээр авч үзэх боломжгүй байдаг. Харин зарим улс оронд парламентыг үл хүндэтгэсэн хэрэг нь хууль, тогтоомжоор тодорхойлогддог ба парламент нь үл хүндэтгэсэн хэргээр шийтгэх эсэх талаар анхны шийдвэрээ гаргаж байх хооронд тухайн хүн эсвэл байгууллага нь шүүхэд хандаж болдог ажээ. Түүнчлэн парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Танхимыг үзэн ядах, үл хүндлэх, тохуурхах байдлыг үүсгэн, түүний нэр хүндийг унагасан” нийтлэл, материал мэдээлэгдсэн, хэвлэгдсэн тохиолдолд парламентыг доромжилсон үйлдэл гэж үзэн шийтгэл оноодог практик Их Британи, Австрали зэрэг оронд байдаг[120].

Австралид парламентын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан аливаа нийтлэлийг парламентыг үл хүндэтгэсэн гэж үздэг байна. Үүнд дараах төрлийн материалууд хамрагдана:

- Танхим болон хороодын хэлэлцүүлэг, сонсголын талаар буруу, ташаа мэдээлсэн
- Танхимын үйл ажиллагааг харлуулсан
- Хороодод явагдсан сонсголын талаар Төлөөлөгчдийн танхимд хэлэлцэгдэхээс нь өмнө нийтэлсэн
- Гэрчийг мэдүүлэг өгөхөөс татгалзах байдалд хүргэх мэдээлэл зэрэг болно.

Доор зарим улсын жишээн дээр парламентыг үл хүндэтгэх байдлыг хэрхэн үздэг, ямар эрх зүйн зохицуулалт байдаг талаар авч үзье.

Австрали

Австралийн парламентын 1987 онд баталсан “Парламентын эрх ямбын тухай хууль” -иар (Parliamentary Privileges Act 1987) парламентын танхимууд, гишүүд болон хоёр танхимын хороодын бүрэн эрх, эрх ямба, халдашгүй байдлыг тогтоосон бөгөөд парламентын танхимууд юмуу гишүүдийн эрх ямба, халдашгүй байдлыг зөрчих болон үл хүндэтгэхийг парламентын эсрэг гэмт хэрэг гэж үздэг байна[121].

Тус хуулийн 3А заалт ёсоор энэ хуулийн эсрэг бүх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэгт зааснаар ангилна. (Тайлбар: Эрүүгийн хуулийн 2 дугаар бүлэг нь эрүүгийн хариуцлага оногдуулах ерөнхий зарчмыг тогтооно). Гэхдээ тодорхойгүй байдал үүсэхээс сэргийлэн парламентын танхимын эсрэг гэмт хэрэгт Эрүүгийн хуулиар шийтгэл оноохгүй.

Хуулийн 7 дугаар зүйлд парламентын эсрэг гэмт хэрэгт оноох шийтгэлийг заасан байна:

1. Хэн нэг этгээд парламентын эсрэг гэмт хэрэг хийсэн гэдгийг парламентын танхимаас тогтоосон бол 6 сар хүртэл хугацаагаар хорих ял оноож болно.
2. Парламент завсарласан, парламентыг тараасан болон парламентын бүрэн эрхийн хугацаа дууссан зэрэг тохиолдол нь оноосон хорих ялыг цуцлах үндэслэл болохгүй.
3. Парламентын танхим нь энэ хуулинд заагдсанаас өөр тохиолдолд хорих ял оноохыг

[120] Contempt of Parliament, by Kieron Wood (Clarus Press, 2012)

[121] Егоров В.В. Телевидение: Страницы истории. ГЛАВА VIII. www. evartist.narod.ru

шаардах эрх байхгүй.

4. Аливаа этгээд парламентын эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэдгийг парламентын танхимаас тогтоосон тохиолдолд:
   - Хувь хүн бол 5000 австрали доллараас хэтрэхгүй
   - Корпораци бол 25000 австрали доллараас хэтрэхгүй хэмжээний торгууль оноож болно.
5. Хорих ялаар шийтгэгдсэн этгээдэд торгууль оноохгүй гэсэн шийтгэлүүдийг ногдуулдаг байна.

Дээр дурдагдсан нээлттэй болон хаалттай сонсголд мэдүүлэг өгдөг гэрчүүдийг хамгаалах үүднээс Парламентын эрх ямбын тухай хуулийн 12(1) дугаар заалтыг зөрчсөн хууран мэхлэх, айлгах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр сүрдүүлэх ямарваа ашиг, урамшуулал өгөхөөр санал тавих, амлах, бусад хууль бус арга хэрэгслээр хэн нэг этгээдийг парламент, хороодод гэрчийн мэдүүлэг өгөх, эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзуулах зэргээр нөлөөлөх зэрэг үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг гэж үзнэ.

Хэн нэгнийг парламент болон хороодод мэдүүлэг өгөх болон өгөхгүй байх, баталгаа, нотолгоо гаргах болон гаргахгүй байхад албадан аливаа шийтгэл оноосон, биед нь гэмтэл учруулсан, мөн тухайн этгээдийн олох ашиг, тэтгэмж, эрх мэдлийг хассан этгээдийг мөн хуулийн 12(2) заалт ёсоор парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр хуульчилжээ. Эдгээр парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэгт мөн дараах шийтгэлийг ногдуулна:

- Хувь хүн бол 5000 австрали доллараас хэтрэхгүй эсвэл 6 сар хүртэл хорих,
- Корпораци бол 25000 австрали доллараас хэтрэхгүй хэмжээний торгууль оноож болно.

Парламентын эрх ямбын тухай хуулийн 12 дугаар заалт нь парламентыг үл хүндэтгэсэн этгээдэд парламентын зүгээс өөр арга хэмжээ авахад нөлөөлөхгүй. Парламентын танхим болон хороодын зөвшөөрөлгүйгээр парламент болон хороодод зориулан бэлтгэсэн ба танилцуулсан, парламент болон хороодоос баримт нотолгоо болгон авсан баримт бичиг, парламент болон хороодоос баримт нотолгоо болгон авсан аман мэдүүлгийн тайланг хэвлэсэн буюу задласан этгээд мөн дээрхийн адил шийтгэл хүлээнэ.

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Конгресс ба түүний аль нэг хорооны үйл ажиллагаанд саад болсон үйлдлийг Конгрессийг үл хүндэтгэсэн хэрэг гэж үзнэ. Түүхийн хувьд сенатч юмуу Төлөөлөгчдийн танхимын гишүүнд авилга өгч худалдан авахыг оролдох үйлдлийг Конгрессийг үл хүндэтгэсэн хэрэг гэж үздэг байжээ. Орчин үед голлон Конгрессийн хороо, дэд хороодоос хэн нэгэн этгээдийг гэрчийн мэдүүлэг өгүүлэх аль эсхүл баримт гаргуулахаар дуудахад хүрэлцэн ирэхгүй тохиолдлыг Конгрессийг үл хүндэтгэсэн хэрэг гэж үзэх болжээ. 1857 онд Конгрессийг үл хүндэтгэх үйлдлийг АНУ -ын эсрэг гэмт хэрэг хэмээн хуульчилсан байдаг.

Конгрессийн дэг ёсоор байнгын хороод хуулийн этгээдээс гэрчийн мэдүүлэг авах ба баримт гаргуулан авах эрхтэй байдаг. Энэ эрхээ хэрэгжүүлэхийн тулд Конгрессийн Хороодын дүрэм ёсоор хороо, дэд хороо болон хорооны дарга гэрчийг зарлан дуудах эрхтэй. Конгрессийн хороодоос явуулах энэхүү зарлан дуудах нь эрх зүйн үүднээс дараах гурван шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Хороодын мөрдөн шалгах үйл ажиллагааны хүрээ нь Танхимаас тодорхойлогдсон байх,

- Мөрдөн шалгах ажиллагаа хууль тогтоох үйл ажиллагааны бодитой зорилгоор хийгдэх,
- Зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны зөвшөөрөгдсөн хүрээнд асуулт тавигдсан байх зэрэг болно.

Гэрч мэдүүлэг өгөх болон баримт гарган өгөхөөс татгалзсан тохиолдолд Хороо энэхүү Конгрессийг үл хүндэтгэсэн үйлдлийн тухай мэдээллийг өөрийн харьяалагдах Танхимд өгөх ёстой. Хороо мөн Конгрессийг үл хүндэтгэсэн этгээдийг шүүхэд өгч болох ба энэ тухайгаа Танхимд тэр даруй мэдэгдсэн байх ёстой. Дэд хорооны хувьд бол Конгрессийг үл хүндэтгэсэн үйлдлийн талаар харьяалагдах хороондоо мэдээлэх ба энэ мэдээллийг цаашид Танхимд хүргүүлэх эсэх талаар ямар шийдвэр гаргах нь тухайн хорооны эрх мэдлийн асуудал болно. Хэрэв Төлөөлөгчдийн танхим юмуу Сенатаас конгрессийг үл хүндэтгэсэн үйлдлийн талаарх Хорооны тайланг үндэслэлтэй гэж үзээд энэ бол конгрессийг үл хүндэтгэсэн хэрэг гэсэн шийдвэр гаргавал тухайн Танхимаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэд хэдэн үндсэн арга зам бий[122]. Үүнд:

1. Өөрөө шийдвэрлэх (Inherent contempt

   Энэ тохиолдолд Конгрессийг үл хүндэтгэсэн этгээдтэй холбоотой асуудлыг зөвхөн Конгрессийн тухайн танхим өөрөө шийдвэрлэнэ. Тухайн этгээдийг зарлан дуудаж Төлөөлөгчдийн танхимын ба Сенатын Гүйцэтгэгч (Sergeant-at-Arms) баривчлан Танхимд авчирна. Танхимын тэргүүлэх албан тушаалтан уг этгээдийг хариуцлагад татаж буйг мэдэгдэх бөгөөд Танхимын зүгээс шийтгэл оноох юмуу хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана.

   Шийтгэл нь гол төлөв тодорхой хугацаагаар хорих юмуу албадан хөдөлмөр эрхлүүлж хорих хэлбэртэй байна. Гэхдээ Конгресс ийнхүү өөрөө шийдвэрлэх процесс нь их хугацаа шаарддаг, шийдвэрлэхэд бэрхшээл их тохиолддогоос гадна зөвхөн Конгрессийн тухайн чуулганы хугацаанд л хэрэгжүүлж болох тул өргөн хэрэглэгддэггүй. Түүхийн хувьд хамгийн сүүлд 1934 онд Сенатад ийнхүү шийдвэрлэсэн тохиолдол гарсан байна.

2. Шүүхээр шийдвэрлүүлэх

   Конгрессийг үл хүндэтгэсэн хэргийг тухайн Танхимын тэргүүлэх албан тушаалтны шийдвэрээр Колумбия дүүргийн Атторнейд шилжүүлэх бөгөөд хуулийн дагуу Атторней хэргийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлэх үүрэгтэй.

   Конгрессийг үл хүндэтгэсэн хэрэгт эрүүгийн шийтгэл оноох бөгөөд шийтгэл нь нэг сараас доошгүй, арван хоёр сараас дээшгүй хугацаагаар хорих юмуу 100-гаас доошгүй, 1000-аас илүүгүй долларaар торгоно.

3. Иргэний хэргийн журмаар шийдвэрлэх

   Сенатын зүгээс Сенатын Хуулийн зөвлөхийн товчоонд Конгрессийг үл хүндэтгэсэн хувь хүний эсрэг иргэний хэргийн нэхэмжлэл гаргахыг даалгаж болно. Сенатын нэхэмжлэлийн дагуу Холбооны дүүргийн шүүх тухайн этгээдийг Сенатын процедурыг хүндэтгэн биелүүлэхийг шаардана. Хэрэв этгээд шүүхийн энэ шийдвэрийг биелүүлэхээс татгалзвал тухайн этгээдийг шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэж, энэ зүйлийн дагуу шийтгэл онооно.

Их Британи

Парламент эрх ямбаа эдлэх болон парламентын танхимууд, гишүүдийн зүгээс үйл ажиллагаагаа явуулахад нь аливаа хэлбэрээр саад болсон үйл ажиллагаа, үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэн хэрэг гэж үздэг. Парламентыг үл хүндэтгэхтэй холбоотой

[122] Parliamentary Privileges Act 1987. http://www.aph.gov.au/

асуудлыг Нийтийн танхим болон Лордуудын танхимд үндсэндээ адил журмаар зохицуулдаг. Парламентыг үл хүндэтгэсэн хэргийг Нийтийн танхимд Стандарт ба эрх ямбын байнгын хороо хариуцах боловч аливаа шийдвэр гаргахдаа Танхимтай зөвшилцсөн байх ёстой.

Парламентын эрх ямба нь Танхим ба хороодын хуралдааны танхимд үг хэлэх эрх, халдашгүй байх эрх, гишүүнчлэлийн зохицуулалт, дотоод асуудлаарх онцгой эрхээс бүрдэнэ. Эрх ямба нь мөн Танхимын зүгээс хансард болон бусад тайлан, баримтыг хэвлэн нийтлэхэд хамаарна.

Халдашгүй эрх нь анх түүхийн хувьд гишүүн, түүний эд хөрөнгө, ажилтнууд нь эрүүгийн болон иргэний аливаа асуудлаар баривчлагдахгүй байх эрх байсан бол 18 дугаар зуунд эхэлж тэдний эд хөрөнгө, ажилтнуудынх нь хувьд энэ эрх үйлчлэхгүй болж, дараа нь гишүүдийн хувьд ч эрүүгийн хэргээр баривчлагдахгүй байх эрх нь цуцлагдсан юм. Одоогийн байдлаар парламентын гишүүдийн халдашгүй эрх нь гишүүд иргэний хэрэг болон шүүхийг үл хүндэтгэсэн асуудлаар л баривчлагдахгүй байх эрх болсон юм.

Гишүүнчлэлийн зохицуулалт гэдэг нь парламентын гишүүнээр хэн сонгогдов, гишүүний суудлыг хэн эзлэх вэ гэдгийг тодорхойлох асуудал юм. Сонгуулийн үр дүнтэй холбоотой аливаа асуудлыг Дээд шүүхийн шүүгчдээс бүрдсэн Сонгуулийн шүүх хариуцдаг. Сонгуулийн үр дүнтэй холбоотой маргааныг уг шүүх шийдвэрлэж, сонгогдсон хүнд сертификат олгон парламентын спикерт хүргүүлдэг. Парламентын танхим нь сонгогдон ирсэн хүмүүс нь парламентын гишүүний суудлыг эзэлж болох уу, гишүүний тангараг өргөх эрхтэй юу гэдгийг өөрөө тодорхойлох онцгой эрхтэй.

Дотоод асуудлаарх онцгой эрх гэдэг нь гишүүдийн өргөх тангарагийг тодорхойлох, хэн Нийтийн танхимын эрх, боломжийг ашиглах, шүүхийн өмнө хамгаалагдах вэ гэдгийг парламент өөрөө тогтоох онцгой эрх юм. Хэдийгээр парламентын гишүүн эрүүгийн хэргээр баривчлагдахгүй байх эрхийг нь 18 дугаар зуунд цуцалсан боловч Их Британид парламентын гишүүнийг албан үүргээ хэрэгжүүлж байх үед нь баривчилбал энэ үйлдэл нь парламентыг үл хүндэтгэсэн хэрэг гэж тооцогдоно.

Парламентыг үл хүндэтгэсэн хэрэгт мөн дараах үйлдэл орно. Үүнд:

- Парламентын гишүүнд авлига өгсөн юмуу өгөхийг завдсан, эсвэл аль нэг гишүүн авлига авах юмуу авлига нэхсэн
- Танхимын болон хорооны хуралдааныг тасалдуулсан\
- Хороонд мэдүүлэг өгөхөөр ирэхээс татгалзсан
- Хорооны хуралдаан дээр тавигдсан асуултанд хариулахаас татгалзсан
- Хороонд худал мэдүүлэг өгсөн
- Хорооны хуралдаанд мэдүүлэг өгөхийн өмнө тангараг өгөхөөс татгалзсан
- Бусад хэлбэрээр Танхимын үйл ажиллагааг тасалдуулсан зэрэг хэрэг орно.

Парламентыг үл хүндэтгэсэн парламентын гишүүнийг түр хугацаагаар хуралдаанд оролцох эрхийг нь хасах, хуралдаанаас хөөн гаргах зэргээр шийтгэнэ. Парламентын гишүүн биш хүн парламентыг үл хүндэтгэсэн бол уг этгээдийг тухайн парламентын бүрэн эрхийн хугацааны турш юмуу тухайн чуулган дуустал шоронд хорих ялаар шийтгэж болно. Лордуудын танхимын хувьд бол уг этгээдийг торгох шийтгэл оноох эрхтэйгээс гадна хэдэн ч жилийн хугацаагаар, гэхдээ хязгаартайгаар шоронд хорихыг шаардаж болно. Хоёр танхимаас оноосон шийтгэлийг аль ч шатны шүүхэд давж заалдах эрх байхгүй.

* * *

ХБНГУ

ХБНГУ -д парламентыг үл хүндэтгэх гэдэг асуудлыг гол төлөв Засгийн газрын байгууллага, албан тушаалтны хувьд авч үздэг байна. Тухайлбал, Засгийн газар тодорхой шийдвэр гаргах, гадаадын улс орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулахдаа Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг мөрдөн ажиллахыг шаарддаг.

ХБНГУ -ын Үндсэн хууль

59-р зүйл

(2) Холбооны улс төрийн харилцааг зохицуулдаг болон Холбооны хууль тогтоомжтой холбоотой асуудлаар байгуулах гэрээ нь Холбооны хууль тогтоох эрх бүхий байгууллагаас Холбооны хууль батлан гаргах хэлбэрээр зөвшөөрөгдөж, дэмжигдсэн байх шаардлагатай. Захиргааны гэрээний хувьд Холбооны захиргаанд хамаарах заалтыг жишиж хэрэглэнэ

Зарим жишээ дурдвал: 2011 оны 2 дугаар сард Холбооны канцлер А.Меркель Европын холбооны саммитад оролцон еврогийн өрсөлдөх чадварыг сайжруулах асуудлаар Герман улсын бодлогыг илэрхийлэхдээ энэ асуудлаар Бундестагтай зөвлөлдөөгүй, 2012 онд онц аюултай неонацист байгууллагын талаарх цэргийн тагнуулын байгууллагын мэдээллийг Бундестагийн холбогдох хороонд мэдээлэлгүй удсан, 2009 оноос Саудын Араб улсад зэвсэг нийлүүлэх гэрээ байгуулахдаа Бундестагаар зохих хууль батлуулан зөвшөөрөл авалгүй ажилласан зэрэг үйлдлүүдийг парламентыг үл хүндэтгэсэн хэрэг гэж үзэж парламентын зарим гишүүд, фракцуудын шаардлагаар Бундестагт хэлэлцэж байжээ.

Оросын Холбооны Улс

ОХУ-д парламентыг үл хүндэтгэх, парламентын гишүүний үйл ажиллагаанд саад учруулахад хариуцлага тооцох тухай асуудлыг ОХУ -ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын эрх, үүрэг, хариуцлага, тэдгээрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх зүй, нийгмийн баталгааг хуульчилан тогтоосон “Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын эрх зүйн байдлын тухай” Холбооны хуулиар тодорхойлж, хуульчилсан байна.

Тус хуулийн 3 дугаар бүлгийн 41 дүгээр зүйлд Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын үйл ажиллагаанд саад учруулсан үйлдэлд хариуцлага тооцох талаар “Төрийн байгууллага, сонгуулийн комисс, ард нийтийн санал асуулгын комисс, нутгийн удирдлагын байгууллага, олон нийтийн байгууллага, нэгдлийн албан тушаалтан, ажил-танууд энэ хуулийн заалтууд, түүний дотор илт худал мэдээлэл өгөх, хуулиар тогтоосон мэдээлэл өгөх дэг журам, хугацааг зөрчсөн, Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын халдашгүй байдлын талаарх Холбооны хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон захиргааны хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно” гэж заажээ. Түүнчлэн дээрхи хуулийн 43 дугаар зүйлд “Холбооны Хурлыг илт үл тоомсорлосон байдлын илэрхийлэл болсон Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатыг үл хүндэтгэсэн хэний ч үйлдэл болон энэ хуулиар тогтоосон дэг журмыг зөрчсөн үйлдэлд захиргааны хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно” гэж заасан.

ОХУ -ын “Захиргааны зөрчлийн тухай” хуулийн Төрийн байгууллагын эрхэнд халдсан захиргааны зөрчил гэсэн 17 дугаар бүлгийн Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн гэсэн 1 дэх хэсэгт Төрийн байгууллага, сонгуулийн комисс, ард нийтийн санал асуулгын комисс, нутгийн удирдлагын байгууллага, олон нийтийн байгууллага, нэгдлийн албан тушаалтан, ажилтануудын зүгээс Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн болон тэдгээрийн үйл ажиллагаанд саад учруулсан бол 1000 -аас 3000 хүртэл рублийн

захиргааны торгууль ногдуулахаар хуульчилжээ. Мөн 17 дугаар бүлгийн нэгийн 2 дах хэсэгт албан тушаалтан Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын депутатын хүсэлтийн дагуу мэдээллийг (баримт бичиг, материал, хүсэлтийн хариу) тогтоосон хугацаанд ирүүлээгүй тохиолдолд түүнд 1000-аас 2000 хүртэл рублийн захиргааны торгууль ногдуулахаар хуульчилсан байна[123].

ОХУ -ын “Эрүүгийн хууль” -ийн Төрийн эрх мэдлийн эсрэг гэмт хэрэг гэсэн 10 дугаар бүлгийн Оросын Холбооны Улсын Холбооны Хурал ба Оросын Холбооны Улсын Аудитын Газарт мэдээлэл өгөхөөс татгалзах гэсэн 287 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт албан тушаалтан Холбооны Хурлын Холбооны Зөвлөл, Төрийн Дум болон Аудитын Газарт мэдээлэл (баримт бичиг, материал) гаргаж өгөхөөс татгалзах, зайлсхийх эсхүл илт бүрэн бус, худал мэдээлэл гаргасан тохиолдолд хоёр зуун мянга хүртэл рубль эсхүл шийтгэл хүлээсэн хүний 18 сарын цалин ба бусад орлоготой тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулах, эсхүл тодорхой албан тушаал ба тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хоёроос таван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл 6 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ[124].

Тус хуулийн 287 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт яг дээрхийн адил үйлдэлд холбогдсон Оросын Холбооны Улсын төрийн албан тушаалтан болон Оросын Холбооны Улсын субъектын төрийн албан тушаалтныг нэг зуун мянгаас гурван зуун мянга хүртэл рубль эсхүл шийтгэл хүлээсэн хүний нэгээс хоёр жил хүртэл хугацааны цалин ба бусад орлоготой тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулах, эсхүл тодорхой албан тушаал ба тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасч, эсхүл эрхийг нь ийнхүү хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл тодорхой албан тушаал ба тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасч, эсхүл эрхийг нь ийнхүү хасахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 287 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан гэмт үйлдлүүд нь:

a. төрийн албан тушаалтны гаргасан зөрчлийг нуун дарагдуулсан,
b. урьдчилан тохирч, үгсэн хуйвалдаж, зохион байгуулалттайгаар бүлэглэн үйлдсэн,
c. ноцтой үр дагаварт хүргэсэн тохиолдолд тодорхой албан тушаал ба тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасч, эсхүл эрхийг нь ийнхүү хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл тодорхой албан тушаал ба тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь гурван жил хүртэл хугацаагаар хасч, эсхүл эрхийг нь ийнхүү хасахгүйгээр 8 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ.

* * *

Судалгааны товч дүгнэлт

1. Судалгааны үр дүнгээс үзэхэд тухайн улс эрх зүйн ямар тогтолцоонд харъяалагдаж байгаагаас хамааран парламентыг үл хүндэтгэх үйлдлийг хэрхэн авч үзэж байгаа нь ялгаатай болох нь харагдаж байна.

[123] 2 USC § 194 - Certification of failure to testify or produce; grand jury action (Хавсралтаас үзнэ үү)

[124] Федеральный закон “О статусе члена Совета Федерации и статусе депутата Государственной Думы Федерального Собрания Российской Федерации”, www. council.gov.ru

2. Англи - саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад, тухайлбал, Австрали, Их Британи, АНУ -д парламентыг үл хүндэтгэх үйлдлийг гэмт үйлдэл, парламентын эсрэг гэмт хэрэг гэж үзэн парламент өөрөө болон шүүхэд нэхэмжлэл гаргаж шийтгэл ногдуулдаг байна. Шийтгэл нь торгууль ногдуулах, тодорхой хугацаагаар хорих хэлбэртэй байна.
3. Ром - Германы буюу эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад парламентыг үл хүндэтгэх үйлдлийн тухай ойлголт байгаа боловч англи-саксоны эрх зүйн системтэй орнуудын адил хатуугаар гэмт үйлдэл гэж үзэх уламжлал байхгүйгээс үүдэн эрх зүйн зохицуулалт нь улс оронуудад ялгаатай байна.
4. Манай улсын хувьд парламентыг үл хүндэтгэх үйлдлийн талаар эрх зүйн ойлголт байхгүй байна. Энэ байдал нь парламентын үйл ажиллагаанд хүндрэл учруулах үр дагавартай байж болох учир парламентыг үл хүндлэх үйлдлийн талаарх ойлголтыг практик эргэлтэнд оруулж, эрх зүйн талаар зохицуулалт бий болгох шаардлага байгаа нь харагдаж байна. Ингэхдээ юуны өмнө, a) засгийн байгууллага, албан тушаалтууд, b) хувь хүн, ялангуяа гэрч, c) нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтнууд, d) хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтнууд, e) аливаа хуулийн этгээдүүдийг хамруулах боломжтой.
5. АНУ -д Конгрессийг үл хүндэтгэх үйлдлийг эрх зүйн хувьд шийдвэрлэх нэг хэлбэр нь иргэний хэргийн журмаар шийдвэрлэх явдал юм. Ингэхдээ Сенатын зүгээс Сенатын Хуулийн зөвлөхийн товчоонд Конгрессийг үл хүндэтгэсэн хувь хүний эсрэг иргэний хэргийн нэхэмжлэл гаргахыг даалгаж болно. Сенатын нэхэмжлэлийн дагуу Холбооны дүүргийн шүүх тухайн этгээдийг Сенатын процедурыг хүндэтгэн биелүүлэхийг шаардана. Хэрэв этгээд шүүхийн энэ шийдвэрийг биелүүлэхээс татгалзвал тухайн этгээдийг шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэж, энэ зүйлийн дагуу шийтгэл оноодог нь харгалзаж үзүүштэй хувилбар байж болох юм.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Parliamentary Privileges Act 1987. http://www.aph.gov.au/
2. House of Representatives Standing and Sessional Orders. http://www.aph.gov.au/
3. Бундэстагийн дүрэм/Geschdftsordnung des Deutschen Bundestages http://bundesrecht.juris.de/btgo_1980/BJNR012380980.html#BJNR012380980BJNG000900311
4. Германы Бундэстаг/Deutscher Bundestag (Wikipedia) http://de.wikipedia.org/wiki/Deutscher_Bundestag#Aussch.C3.BCsse
5. Todd Garvey, Alissa M. Dolan. Congress’s Contempt Power and the Enforcement of Congressional Subpoenas: Law, History, Practice, and Procedure. Congressional Research Service, 2012
6. USC § 194 - Certification of failure to testify or produce; grand jury action
7. 2 USC § 192 - Refusal of witness to testify or produce papers
8. The Code of Conduct together with The Guide to the Rules Relating to the Conduct of Members, House of Commons Publications, 12 March 2012, http://www.publications.parliament.uk
9. Федеральный закон “О статусе члена Совета Федерации и статусе депутата Государственной Думы Федерального Собрания Российской Федерации”, www. council.gov.ru
10. Кодекс Российской Федерации об административных правонарушениях. http://www.consultant.ru
11. Угловный Кодекс РФ, www.garant.ru
12. Егоров В.В. Телевидение: Страницы истории. ГЛАВА VIII. www. evartist.narod.ru

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ

USC › Title 2 › Chapter 6

2 USC § 192 - Refusal of witness to testify or produce papers

> Every person who having been summoned as a witness by the authority of either House of Congress to give testimony or to produce papers upon any matter under inquiry before either House, or any joint committee established by a joint or concurrent resolution of the two Houses of Congress, or any committee of either House of Congress, willfully makes default, or who, having appeared, refuses to answer any question pertinent to the question under inquiry, shall be deemed guilty of a misdemeanor, punishable by a fine of not more than $1,000 nor less than $100 and imprisonment in a common jail for not less than one month nor more than twelve months.

USC › Title 2 › Chapter 6 ›

2 USC § 194 - Certification of failure to testify or produce; grand jury action

> Whenever a witness summoned as mentioned in section 192 of this title fails to appear to testify or fails to produce any books, papers, records, or documents, as required, or whenever any witness so summoned refuses to answer any question pertinent to the subject under inquiry before either House, or any joint committee established by a joint or concurrent resolution of the two Houses of Congress, or any committee or subcommittee of either House of Congress, and the fact of such failure or failures is reported to either House while Congress is in session or when Congress is not in session, a statement of fact constituting such failure is reported to and filed with the President of the Senate or the Speaker of the House, it shall be the duty of the said President of the Senate or Speaker of the House, as the case may be, to certify, and he shall so certify, the statement of facts aforesaid under the seal of the Senate or House, as the case may be, to the appropriate United States attorney, whose duty it shall be to bring the matter before the grand jury for its action.

ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА
(ЛАВЛАГАА - МЭДЭЭЛЭЛ)

Ц. Болормаа

Парламентын нээлттэй сонсголд оролцогчдын үүрэг, хариуцлага

- Оршил
- Нээлттэй сонсгол ба түүний төрлийн тухай ерөнхий ойлголт
- Нээлттэй сонсголд оролцогчдын үүрэг, хариуцлага

Оршил

Улсын Их Хурлын эрхэм гишүүн М.Батчимэгийн ирүүлсэн захиалгын дагуу судалгааны төвийн судлаач Ц.Болормаа энэхүү мэдээллийг гүйцэтгэв. Захиалагч гадаад орнуудын парламентын тухай хуулиуд болон бусад холбогдох хуулиудад нээлттэй сонсголд оролцогчдын үүрэг хариуцлагыг хэрхэн хуульчилдаг талаарх харьцуулсан судалгааг хүссэн билээ.

Тус хүсэлтийн дагуу парламентын нээлттэй сонсголын олон жилийн туршлагатай АНУ, Их Британи болон Европын холбооны зарим орны парламентын тухай хуулиуд, парламентын дэг буюу Standing order \Rules of procedure of the National Assambley\, Төлөөлөгчдийн танхим болон Сенатын журам \Rules of the House of Representatives, Rules of the Senate\ болон Парламентын хороодын журам, парламентын танхимуудын гарын авлага \ Congressional Handbook, US Senate Handbook\, Сенатын сонсголын гарын авлага \Senate Hearing Guide\ гэх мэтчилэн боломжтой бүхий л бичиг баримтуудаас хайлт хийн судалсан боловч Парламентын сонсголд оролцогчид тодруулбал гэрч нарт хуулиар тусгайлан үүрэг хүлээлгээгүй байх нь дийлэнхи байна. Өөрөөр хэлбэл, гэрч нар сонсголын урилга хүлээн авахаас татгалзах, сонсголд хүрэлцэн ирээгүйн төлөө ямар нэгэн хуулийн хариуцлага хүлээхгүй байх зарчим үйлчилдэг нь харагдлаа.

Харин Англо-Саксоны эрх зүйн бүл бүхий улс орнууд тухайлбал АНУ, Австралийн хамтын нөхөрлөлийн орнуудад гэрч Сонсголд оролцохдоо тангараг өргөх тохиолдол байх ба энэ нь агуулгын хувьд үнэнийг хэлэх хуулийн үүрэг хүлээсэн байна гэж ойлгогдохоор байна. Түүнчлэн Хяналтын сонсголын үед гэрч тангараг өргөх тохиолдол байдаг байна. Харин нээлттэй сонсголыг зохион байгуулагч буюу сонсгол даргалагч, эсвэл аль нэгэн байгын хорооны дарга нар хууль болон журмийн дагуу тодорхой хэмжээний үүрэг хүлээдгийг судалгааны үндсэн тайлангаас харна уу.

Дээрх баримт бичгүүдээр парламентын сонсголын төрөл, сонсголд хэрхэн бэлтгэх, гэрчийг хэрхэн сонгох, урих, гэрчийн мэдүүлгийн төрөл хэлбэр, сонсголын ирц, хаалттай сонсгол, гэрчийн эрх, гэрчийг байцаах хугацаа, гэрчийг байцаах журам, нотдлох баримт болон сонсголыг хэвлэл, олон нийтэд мэдээлэх гэх мэт нарийвчилсан харилцааг зохицуулсан байна.

НЭГ. ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛ БОЛОН ТҮҮНИЙ ТӨРӨЛ

Сонсгол гэж юу вэ?

> Нээлттэй сонсгол бол парламентын хороодын бодлого боловсруулах, хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд ашигладаг мэдээлэл цуглуулах механизм юм.

Нээлттэй сонсгол нь ихэнхдээ хуулийн төслийг хянах, хэлэлцэх зорилгоор хийгддэг байна.

Сонсгол нь парламентийн гишүүд, парламентийн албан хаагчид, уригдсан мэргэжлийн экспертүүд, сонирхогч талууд болон олон нийтэд тулгамдаж буй асуудлуудыг авч хэлэлцэн, шүүн тунгаах боломж олгодог парламентын бодлого боловсруулах үйл явцын гол хэрэгсэл юм.

Сонсгол нь сонгогдсон парламентын гишүүдэд ямар нэгэн хуулийг боловсруулах, батлах, өөрчилхөд эсхүл Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулахад тусалдаг. Мөн парламентийн гишүүд болон парламентад олон нийт тухайн хууль болон хуулийн төслийн талаар ямар санаа бодолтой байгаа, хэр дэмжиж байгаа зэргийг харахад гол хэрэглүүр болдог бөгөөд иргэдэд төрийн бодлогыг хөгжүүлэхэд оролцох боломж олгодогоороо ач холбогдолтой юм.

Сонсголын төрөл

Улс орнуудын хэмжээнд парламентын сонсголын төрлүүдийг судалж үзэхэд нийтлэг гурван төрлийн сонсгол байдаг байна. Харин Их Британи, АНУ зэрэг англо-саксоны эрх зүйн бүл бүхий улс оронд тогтсон жишиг бүхий гурван төрөл дээр нэмээд нотлох болон талбайн гэсэн парламентын сонсголын төрөл байдаг байна. Эдгээр таван төрлийг авч үзвэл:

1) Хууль тогтоох сонсгол
2) Хяналтын сонсгол
3) Мөрдөн байцаах сонсгол
4) Нотлох сонсгол
5) Талбайн сонсгол

Хууль тогтоох сонсгол - Legislative Hearings

Парламентийн хороод /байнгын хороод/ нь аливаа хуулийн төсөлтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэх, эсхүл шинээр хууль батлах шаардлагатай эсэхийг тогтоох зорилгоор хууль тогтоох сонсгол зарлаж болно. Ихэнх тохиолдолд хууль тогтоох сонсгол нь хуулийн төслийг олон нийтийн ашиг сонирхолд улам нийцтэй болгох, тухайн хуулийн агуулгатай холбоотой мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт, зөвлөгөөг авах зорилгоор хийгддэг.

Хууль тогтоох сонсгол нь тухайн сонсголд уригдсан гэрчүүдийн хэлэлцэж буй хуультай холбоотой баримт мэдээлэл, хуульд оруулах санал болон үзэл бодлоо өөр хороондоо танилцуулах форум хэлбэрээр явагдана. Сонсголд өөрийн эрх ашиг нь тухайн хуультай хамаарал бүхий гэрчүүд, эсхүл хэлэлцэгдэж буй хуулийн талаар үзэл бодлоо илэрхийлэх хүсэл, боломжтой парламентийн гишүүн, төрийн албан хаагч, аль нэг ашиг сонирхлын бүлгийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэд гэх мэтчилэн аль ч салбар мэргэжлийн хүмүүс байж болно. Хууль тогтоох сонсголд оролцогчдын нийтлэг зорилго нь тухайн хуулийг хэрхэн хамгийн сайнаар хуульчлахыг тодорхойлох явдал юм.

Хяналтын сонсгол- Oversight Hearings

Хяналтын сонсгол нь Засгийн газрын ажлыг хянах, ялангуяа батлагдсан хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, төрийн эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэл зэргийг хянах зорилгоор хийгддэг. Парламентийн гишүүд Засгийн газрын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн зорилго, мөн чанарт нийцэж буй эсэхийг шалгах ба тодруулбал Засгийн газрын үйл ажиллагаа нь олон нийтийн ашиг сонирхолд үйлчилж чадаж байгаа эсэхийг хянана. Хяналтын сонсгол нь үр дүнтэй, бүтээмжтэй засаглалыг бий болгох гол түлхэц болох бөгөөд үр дүнтэй хэрэгсэл юм. АНУ-д парламентийн хороод энэ төрлийн

сонсголыг явуулах явдал түгээмэл байдаг ба энэ нь ихэвчлэн Засгийн газрын ямарваа нэг хөтөлбөрийг санхүүжүүлэх, шинэ хөтөлбөр батлах эсхүл Засгийн газрын агентлаг байгуулах зэрэг тохиолдолд хийгддэг байна. Харин бусад орны хувьд тухайлбал, Македон, Өмнөд Африк болон зэрэг улсуудад парламентад Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг Хяналтын хороо \Public Account Committee\ ажилладаг.

Мөрдөн байцаах сонсгол **-** Investigative Hearings

Энэхүү сонсгол нь хууль тогтоох болон хяналтын сонсголтой төстэй боловч тодорхой нэг үйл ажиллагааг шалгах зорилгоор явагддагаараа онцлогтой. Одоогоор БНМакедони Улсын Ассамблей нь Ассамблейтэй хамаатай асуудлуудыг шалгалтын тусгай комиссууд байгуулан хэлэлцдэг ба мөрдөн байцаах сонсгол заавал хийдэггүй. Хэрэв төрийн аливаа албан тушаалтан буюу төрийн аль нэг байгууллагын зүгээс олон нийт болон иргэдэд хохирол учруулсан шийдвэр болон үйл ажиллагаа явуулсан эсэх, эсхүл хувийн болон төрийн өмчийн аливаа компани төрийн байгууллага, албан тушаалтантай харьцахдаа зүй бус хандсан зэрэг тохиолдолд энэ төрлийн сонсголыг явуулдаг. Зарим парламент нь тусгай шалган сурвалжлах хороо байгуулан тодорхой үйл явдал, хэрэг зөрчлийг шалгадаг ба ардчилсан уламжлалтай улсуудад парламентийн хувьд энэхүү шалгах сурвалжлах хороодын үйл ажиллагаа нь тогтсон байнгын үйл ажиллагаа байдаг.

Энэ төрлийн сонсголыг quasi-judicial буюу хагас шүүхийн шинжтэй сонсгол гэж үздэг байна. Энэ төрлийн сонсголд гэрч нь Сонсгол даргалагчийн удирдлагаар заавал үнэнийг өгүүлэх тангараг өргөдөг байна.

Нотлох сонсгол - Confirmation hearings

Энэ сонсгол АНУ-ын Конгресст хийгддэг сонсгол бөгөөд Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлэх талаархи нотлох сонсголыг Үндсэн хуулиар Сенатад олгогдсон “зөвлөх ба зөвшилцөх” үүргийн биелэлтийг хангах үүднээс зохин байгуулдаг байна. Сенатын бүх хороо хуулийн хүрээнд Ерөнхийлөгчийг нэр дэвшүүлэх талаархи нотлох сонсголыг хийхдээ гүйцэтгэх болон шүүх засаглалын байр сууринаас хийж болно.

Талбайн Сонсгол – Field Hearings

Энэ төрлийн сонсгол нь Вашингтоноос гадуур болдог Конгрессийн сонсгол юм. Өөрөөр хэлбэл энэ нь Вашингтон дах Конгрессийн байранд болохгүй харин хэлэлцэх гэж буй үйл явдал болсон тухайн газарт нь очиж хийдэг сонсгол юм. Сонсгол хийх албан ёсны үндэслэл нь танхимын дүрмийн дагуу явагдана. Сенатын 26-р дүрмийн 1-р бүлэгт /догол мөрөнд зааснаар хороо нь:

- “Сонгол хийх эрхтэй ... Сенатын хуралдааны үеэр, завсарласан үеэр, мөн хуралдааныг завсарлуулж” гэж аль шаардлагатай үеэр хийх боломжтой байдгийг заажээ. Жишээлбэл, 106 дахь Конгрессийн үеэр Худалдааны хороо нь Вашингтоны Беллингхэм дэх дамжуулах хоолойнд дэлбэрэлт болсон талаар тухайн газарт нь, мөн Эрчим хүч, байгалийн нөөцийн хороо Нью-Мексикогийн Альбукеркед Эрчим хүчний стандартын яамны үйл ажиллагаанд нийцсэн Үндэсний Лаборторийг байгуулах тухай хуулийн төслийн талаар тус тус сонсгол тухайн газрын сонсгол хийсэн байдаг[125].

* * *

[125] Service and Accountibility: public hearing manual, USAID, November 2009.

ХОЁР. ПАРЛАМЕНТЫН НЭЭЛТТЭЙ СОНСГОЛД ОРОЛЦОГЧДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Нээлттэй сонсголд оролцогч гэж хэн бэ?

- Сонсгол даргалагч
- Гэрчүүд: Парламентийн гишүүд, төрийн албан хаагчид, уригдсан мэргэжлийн экспертүүд, сонирхогч талууд, иргэний нийгмийн байгууллага, иргэд

1. Сонсгол даргалагчийн үүрэг

   a) ХБНГУ -д Сонсголыг даргалагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

      - Сонсголын явцад эмх журам, дэг ёсыг сахиулах
      - Аль гишүүн хэзээ ярих, асуулт асуух процедурыг танилцуулах,
      - Гишүүдийн үйлдэл нь процедурын хувьд зөв зохимжтой эсэхийг сануулах үүрэгтэй.

Сонсгол даргалагч хэн байх вэ?

Байнгын хорооны дарга сонсголыг даргалах ба, түүний эзгүйд дэд буюу орлогч дарга даргална. Дэд дарга мөн эзгүй бол хорооны хамгийн ахмад гишүүн нь сонсголыг даргална. Олон нийтийн сонсголыг эхлүүлэхдээ сонсголыг даргалагч танилцуулга хийх бөгөөд тухайн сонсголын зорилго, сонсгол хийхэд хүргэсэн үйл явдлуудыг дурдана. Үүний дараагаар танилцуулах яриа хийх хүсэлтэй хорооны гишүүдийг тогтоох ба хэрэв хугацаа хүрэлцэхгүй бол танилцуулга хийх хугацааг 5 минутаар тогтооно. Мөн аман танилцуулгаас гадна хорооны гишүүдээс бичгээр танилцуулга, санал авч болно.

   b) АНУ болон Их Британи дахь Сонсгол даргалагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

      Сонсгол эхлэхээс өмнө:

      - Сонсголын сэдвийг батлах, хэвлэх (эсхүл энэхүү үүргийг гүйцэтгэх төлөөний хүн томилох)
      - Гэрчийн мэдүүлэгт өгөх, сонсголын дэг, дүрмийн талаар гэрчид заавар өгөх
      - Олон нийтийг оролцуулж, нээлттэй, ил тод байдлыг бий болгох
      - Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй холбоо тогтоож, ярилцлагын цагийг тохируулах

      Сонсголын үеэр:

      - Сонсголыг танилцуулах, сонсголын хугацааг тогтоох
      - Үндсэн дүрмүүдийг танилцуулах
      - Гэрч нарыг танилцуулах
      - Хугацааны хязгаарт захирагдах явдлыг хянах, хангах, сонсголыг хянах, хугацаанд нь тохируулах
      - Хуралдааныг удирдах, илтгэгчдийг сэдвийн хүрээнд байлгах
      - Маргаан үүсгэж сонсголд саад болон, тасалдуулж байгаа хүмүүс байвал тэдгээрийг зохицуулах, зөрчилдөөнийг зогсоох, шийдвэрлэх
      - Асуулт тавигчдыг тогтоож, шаардлагатай бол дахин давтан асуулт асуух
      - Завсарлагаануудын дараа сонсголд дуудах, оролцогчдыг дахин цуглуулах

      Сонсголыг хаах:

      - Сонсголыг нэгтгэн дүгнэх, цаашид авах төлөвлөгөөг танилцуулах
      - Хаалтын үед тэмдэглүүштэй зүйлсийг тэмдэглэх
      - Асуултанд хариулж, сонсголын төгсгөлд оролцогчдын санал гомдлыг хүлээн авч сонсох
      - Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй уулзаж албан ёсны тайлбар, ярилцлага өгөх

2. Сонсголд оролцох гэрчийн үүрэг

ХБНГУ -д гэрч нь:

Гэрч нь ямар нэгэн удирдах үүрэг байхгүй ч нээлттэй сонсголд оруулах тэдний хувь нэмэр нь маш чухал байдаг. ХБНГ-ад гэрчүүд нь сонсголд оролцох урилгыг хүлээж авах хуулиар хүлээсэн үүрэг байхгүй.

Гэвч гэрч болон уригдсан хувь хүн, байгууллагын төлөөлөгч урилга хүлээж аваагүй тохиолдол бараг байдаггүй байна.

Мэдүүлэг өгч буй гэрч нь шүүхийн өмнө эсвэл Бундестагийн байцаах хорооны өмнө шүүх засаглал дахь гэрчийн адил үүрэг хүлээхгүй. Тодруулбал, бүх асуултад хариулах, заавал үнэнийг хэлэх гэсэн үүрэг байхгүй.

Сонсголыг явуулж буй албан тушаалтан гэрчүүдтэй олон нийтийн өмнө диалоги, харилцан ярианд орох явдал мөрдөн байцаах /эрэн сурвалжлах/ сонсголоос бусад сонсголд бараг байдаггүй. Энэ төрлийн сонсгол буюу мөрдөн байцаах сонсголд гэрч нь хорооны зөвлөлийн зүгээс байцаагдахыг зөвшөөрч, асуултуудад үнэн зөв хариулахаа андгайлдаг. Эдгээр нь хууль тогтоох сонсголоос өөр дүрэм журмын дагуу явагддаг.

Хууль тогтоох сонсголд гэрчүүд нь үнэнийг хэлэх үүргийг хуулиар хүлээдэггүй бөгөөд зөвхөн өөрийн үзэл бодлыг илэрхийлдэг байна.

Бүгд Найрамдах Македони улсад гэрч нь:

Нээлттэй сонсголд мэдүүлэг өгөхөөр уригдсан гэрчүүд нь сонсголд оролцох хуулиар хүлээсэн үүрэг байхгүй боловч ихэнх тохиолдолд оролцдог. Гэрчүүд нь тангараг өргөдөггүй бөгөөд энэ нь хуулиар зөвхөн үнэнийг хэлэх үүрэг хүлээдэггүй.

Гэвч гэрчүүд худал мэдүүлэг өгөхгүй байх нэгэн хөшүүргэ бол сонсголоор хэлэлцэж буй хуулийн төсөл буюу асуудалтай холбоотойгоор гэрчийн өгсөн мэдүүлэгт эсрэг байр суурьтай хороодын гишүүдийн эсэргүүцэл болон олон нийтийн төлөөллийн эсэргүүцэл нь тухайн гэрчийн мэдүүлгийн худал болохыг илчилж олон нийтийн өмнө нэр төрийг нь унагаах явдал байдаг. Тиймээс худал мэдүүлэг өгөх нь хорооны гишүүдэд сөрөг сэтгэгдэл төрүүлэн хэлэлцэгдэж буй асуудал дээрх тухайн хүний байр суурийг ганхуулах учир энэ нь гэрч үнэн зөв мэдүүлэг өгөх баталгаа болдог байна.

Харин мэргэжлийн зүгээс мэдүүлэг өгч байгаа хүмүүс нь бусад гэрчийн адил өргөн эрх эдлэхгүй. Учир нь тэдний өгсөн мэдүүлгийг, тэднийг урьсан парламентийн гишүүний байр суурьтай холбогдон улс төржүүлэх магадлал өндөртэй байдаг. Мэргэжлийн экспертүүд ихэнх тохиолдолд эсрэг байр суурь бүхий хорооны гишүүдээс маш хүнд бөгөөд нөхөрсөг бус, давшилсан асуултуудтай тулгардаг байна.

Харин сонсголыг даргалагч нь энэ асуулт хариулт буюу мэдүүлэг авах процессийг хэрээс нь хэтрүүлэлгүй, удирдан явуулах үүрэгтэй байдаг.

АНУ -ын парламентын нээлттэй сонсголын гэрч нь:

АНУ-ын Сенатын Сонсголын гарын авлага болон парламентын дэгд тусгагдсанаар

Гэрч нь мөн адил Сонсголд заавал оролцох хуулиар хүлээсэн үүрэг байхгүй.

Гэвч оролцохгүй тохиолдол тун цөөхөн байсан байна. АНУ-д Сонсголд оролцогч гэрч нь тангараг өргөдөг зохицуулалт үйлчилдэг байна. Гэхдээ хууль тогтоохоос бусад сонсгол буюу хагас шүүхийн шинж бүхий Хяналтын сонсгол, Мөрдөн байцаах сонсгол, Нотлох сонсголд оролцож буй гэрч нь тангараг өргөнө. Тухайлбал, АНУ-ын Вашингтон мужын холбогдох журам -д зааснаар хагас шүүхийн шинжтэй Сонсгол даргалагч нь сонсголд ирсэн гэрчүүдээс дараах зүйлийг асууна. Үүнд:

“Өнөөдөр та бүхэн үнэн зөв мэдүүлэг өгөхөө андгайлж байна уу? Хэрэв тийм бол андгайлж байна гэж хэлнэ үү” гэж хөтлөх ба гэрчүүд андгайлж байгаагаа илэрхийлсэн тохиолдолд гэрчээс мэдүүлэг авдаг байна. Энэ нь тохиолдолд гэрч хэрэв тангараг өргөсөн бол энэ нь нөгөө талаас хуулиар хүлээсэн үүрэг болох юм.

Мөн АНУ-ын парламентын сонсголд оролцож буй гэрчийн хувьд холбогдох дүрэм журамд гэрчийн эрх, мэдүүлэг өгөх хэлбэр, мэдүүлэг өгөх хугацаа болон мэдүүлэг өгөх журмын талаар тодорхой зохицуулалт байгаагаас биш үүрэг хариуцлага гэж тусгайлан заагаагүй байна.

Австрали улсын нээлттэй Сонсголын гэрч нь:

Австрали улсын хувьд Сонсголын үеэр гэрчийг дуудахдаа гэрчээр тангараг өргүүлж болохоор заасан байдаг.[126] Гэвч гэрч заавал тангараг өргөх зохицуулалт байхгүй байна. Тодруулбал, сонсголыг даргалагч нь Хорооны нарийн бичгийн дарга болон Хорооны гишүүдээс тангараг өргүүлэхийг хүсч болно гэж заасан байна. Мөн энэ улсын хувьд “Парламентын гишүүний онцгой эрхийн тухай хууль”-ийн зохицуулалт нь Нээлттэй сонсголд оролцож буй гэрч нь үнэн зөв мэдүүлэг өгөх үүрэг хүлээх нэг хөшүүргэ болж байна. Өөрөөр хэлбэл, сонсголд оролцож буй гэрч тангараг өргөсөн эс өргөсөн байдлаас үл шалтгаалан худал мэдүүлэг өгөх нь парламентыг үл хүндэтгэсэн асуудал болох бөгөөд ийм тохиолдол гарвал тус хуульд зааснаар хариуцлага хүлээлгэдэг байна. Иймд нээлттэй сонсголд оролцож буй гэрч үнэн зөв мэдүүлэг өгөх нь зайлшгүй гэж үздэг байна.

Эцэст нь судалгааны материалд хамруулсан АНУ, Австрали ХБНГУ, БНМУ зэрэг гадаадын улс орон дахь парламентын нээлттэй сонсголд оролцох гэрчид хуулиар тусгайлан үүрэг оноож, хариуцлага хүлээлгэх зохицуулалт байхгүй байна. Харин Сонсгол даргалагчийн үүргийг тусгайлан заасан бөгөөд гэрчүүдийн хувьд тэдний эрх, мэдүүлэг өгөх журам, мэдүүлэг өгөх хугацаа болон гэрчийн мэдүүлгийн төрлүүдийг журам болон дэгээр тусгайлан заасан байсныг онцлон хэлье.

[126] http://www.rules.senate.gov/public/index.cfm?p=RuleXXVI

ХБНГУ -ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Захиалагч: УИХ -ын гишүүн М. Батчимэг
Гүйцэтгэгч: Ахлах референт Г. Алтан - Оч
Огноо: 2012 оны 10 дугаар сар 25

Strafgesetz	ХБНГУ-ын Эрүүгийн хуулиас
§ 53 (1) Zur Verweigerung des Zeugnisses sind ferner berechtigt 1. Geistliche ьber das, was ihnen in ihrer Eigenschaft als Seelsorger anvertraut worden oder bekanntgeworden ist; 2. Verteidiger des Beschuldigten ьber das, was ihnen in dieser Eigenschaft anvertraut worden oder bekanntgeworden ist; 3. Rechtsanwдlte, Patentanwдlte, Notare, Wirtschaftsprьfer, vereidigte Buchprьfer, Steuerberater und Steuerbevollmдchtigte, Дrzte, Zahnдrzte, Psychologische Psychotherapeuten, Kinder- und Jugendlichenpsychotherapeuten, Apotheker und Hebammen ьber das, was ihnen in dieser Eigenschaft anvertraut worden oder bekanntgeworden ist, Rechtsanwдlten stehen dabei sonstige Mitglieder einer Rechtsanwaltskammer gleich; 3a. Mitglieder oder Beauftragte einer anerkannten Beratungsstelle nach den §§ 3 und 8 des Schwangerschaftskonfliktgesetzes ьber das, was ihnen in dieser Eigenschaft anvertraut worden oder bekanntgeworden ist; 3b. Berater fьr Fragen der Betдubungsmittelabhдngigkeit in einer Beratungsstelle, die eine Behцrde oder eine Kцrperschaft, Anstalt oder Stiftung des цffentlichen Rechts anerkannt oder bei sich eingerichtet hat, ьber das, was ihnen in dieser Eigenschaft anvertraut worden oder bekanntgeworden ist; 4. Mitglieder des Deutschen Bundestages, der Bundesversammlung, des Europдischen Parlaments aus der Bundesrepublik Deutschland oder eines Landtages ьber Personen, die ihnen in ihrer Eigenschaft als Mitglieder dieser Organe oder denen sie in dieser Eigenschaft Tatsachen anvertraut haben, sowie ьber diese Tatsachen selbst; 5. Personen, die bei der Vorbereitung, Herstellung oder Verbreitung von Druckwerken, Rundfunksendungen, Filmberichten oder der Unterrichtung oder Meinungsbildung dienenden Informations- und Kommunikationsdiensten berufsmдЯig mitwirken oder mitgewirkt haben.	53 дугаар зүйл (1) Түүнчлэн доорх хүмүүс гэрчээ нууцлах эрхтэй: ... 4. Бундэстаг (Холбооны парламент)-ийн, Холбооны хурал (холбооны зөвлөлийн)-ын, ХБНГУ-аас Европын парламентад суугаа, эсвэл Улсын парламентын гишүүд өөрт нь гишүүний хувиар итгэсэн хүн, эсвэл үйлдэл, мөн тухайн үйлдлийн талаар; ...

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Erster Abschnitt Erteilung von Auskьnften und Akteneinsicht, sonstige Verwendung von Daten fьr verfahrensьbergreifende Zwecke § 474 (1) Gerichte, Staatsanwaltschaften und andere Justizbehцrden erhalten Akteneinsicht, wenn dies fьr Zwecke der Rechtspflege erforderlich ist. (2) Im Ьbrigen sind Auskьnfte aus Akten an цffentliche Stellen zuldssig, soweit 1. die Auskьnfte zur Feststellung, Durchsetzung oder zur Abwehr von Rechtsansprьchen im Zusammenhang mit der Straftat erforderlich sind, 2. diesen Stellen in sonstigen Fдllen auf Grund einer besonderen Vorschrift von Amts wegen personenbezogene Daten aus Strafverfahren ьbermittelt werden dьrfen oder soweit nach einer Ьbermittlung von Amts wegen die Ьbermittlung weiterer personenbezogener Daten zur Aufgabenerfьllung erforderlich ist oder 3. die Auskьnfte zur Vorbereitung von MaЯnahmen erforderlich sind, nach deren Erlass auf Grund einer besonderen Vorschrift von Amts wegen personenbezogene Daten aus Strafverfahren an diese Stellen ьbermittelt werden dьrfen. Die Erteilung von Auskьnften an die Nachrichtendienste richtet sich nach § 18 des Bundesverfassungsschutzgesetzes, § 10 des MAD-Gesetzes und § 8 des BND-Gesetzes sowie den entsprechenden landesrechtlichen Vorschriften. (3) Unter den Voraussetzungen des Absatzes 2 kann Akteneinsicht gewдhrt werden, wenn die Erteilung von Auskьnften einen unverhдltnismдЯigen Aufwand erfordern wьrde oder die Akteneinsicht begehrende Stelle unter Angabe von Grьnden erklдrt, dass die Erteilung einer Auskunft zur Erfьllung ihrer Aufgabe nicht ausreichen wьrde. (4) Unter den Voraussetzungen der Absдtze 1 oder 3 kцnnen amtlich verwahrte Beweisstьcke besichtigt werden. (5) Akten kцnnen in den Fдllen der Absдtze 1 und 3 zur Einsichtnahme ьbersandt werden. (6) Landesgesetzliche Regelungen, die parlamentarischen Ausschьssen ein Recht auf Akteneinsicht einrдumen, bleiben unberьhrt.	Эхний хэсэг Хавтаст хэргээс мэдээлэл олгох, түүнтэй танилцах, гүйцэтгэх ажлаас хэтийдхүйц зорилгоор өгөгдлийг тусгайлан ашиглах 474 дүгээр зүйл ... 2 дахь заалт. Түүнээс гадна доорх тохиолдлуудад хавтаст хэргийн мэдээллийг олон нийтийн газарт өгөхийг зөвшөөрнө: ... Өргөн нэвтрүүлгийн албанд мэдээлэл олгоход Холбооны үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Мэдээллийн нууцлалын[1] тухай хуулийн 10 дугаар зүйл, Холбооны өргөн нэвтрүүлгийн[2] тухай хуулийн 8 дугаар зүйл болон улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно. ... 6 дахь заалт. Парламентын байнгын хороонд хавтаст хэрэгтэй танилцах эрх олгох талаарх улсын хууль тогтоомжуудыг үл хөндөнө.

* * *

(Footnotes)

[1] Militдrischer Abschirmdienst des Bundesministeriums der Verteidigung - гэдгийг үгчилж орчуулбал: Батлан хамгаалах яамны Цэрэгжсэн хамгаалах (“нийгмийг аюулаас хамгаалах” гэж ойлгож болно) албаны тухай хууль

[2] Bundesnachrichtendienst – гэдгийг үгчилбэл: Холбооны мэдээний алба

ПАРЛАМЕНТЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СОНСГОЛЫН ГЭРЧИЙГ ХАМГААЛАХ, УРАМШУУЛАХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Р. Хатанбаатар, А. Пагма, Д. Жигвагүнсэл

УДИРТГАЛ

УИХ -ын Өргөдлийн Байнгын хорооны дарга Р. Бурмаагийн захиалгаар “Парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудлын эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачид гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудлын эрх зүйн зохицуулалтыг зарим орны тухайлбал, Австрали, АНУ, Канадын жишээн дээр харьцуулан гаргахад оршино.

Судалгааны зорилтууд:

Австрали, АНУ, Канадад парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах,

- Дээрхи орнуудад парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийн замын зардал, байр, буудлын зардлыг хэрхэн шийдвэрлэдэг талаар харьцуулан судлах,
- Дээрхи орнуудад парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудлын эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан дэлгэрэнгүй материал бэлтгэх зэрэг болно.

Судалгааны аргачлал:

- Гадаадын зарим орнуудын Үндсэн хууль, парламентын Дэгийн холбогдох бүлэг заалт,
- Гадаадын зарим орны парламентын байнгын хороодын дэг, журам,тогтоолын холбогдох заалт,
- Судалгааны материалыг нэгтгэн тайлан бичих зэрэг болно.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Хууль, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын Газрын Судалгааны төвийн ахлах референт Р.Хатанбаатар, референт-шинжээч А. Пагма, референт - судлаач Д. Жигвагүнсэл нар хийж гүйцэтгэв.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг хамгаалах, урамшуулах асуудал

Австрали

Парламентын хэлэлцүүлгийн гэрчийг хамгаалах

Төлөөлөгчдийн танхимын Дэгийн 256 -д заасан ёсоор “Танхим болон танхимын аль нэг хороонд мэдүүлэг өгсөн гэрч нь өөрийн өгсөн мэдүүлэгтэй холбоотойгоор хамгаалагдах эрхтэй”. Гэрчийн хамгаалагдах эрх нь мөн Эрхийн Тунхаглалын (Article 9 of the Bill of Rights) “Парламентын хэлэлцүүлгийн явцад хэлсэн үгний төлөө аль ч шатны шүүх хэрэг үүсгэх эрхгүй” гэсэн заалтаас үүдэн гарна. Энэ заалт нь мөн Үндсэн хуулийн 49 дүгээр зүйл болон Парламентын эрх ямбын хуулиар баталгаажсан байдаг.

Парламентын хороонд аман мэдүүлэг өгсөн гэрчийн хамгаалагдах эрх нь мөн нотлох баримт гаргаж өгсөн гэрчийн хувьд адил хүчинтэй[]. Парламентын эрх ямбын хуулиар энэ хамгаалагдах эрх нь сайн дурааараа мэдүүлэг өгсөн гэрч болон шүүхээс албадан ирүүлж мэдүүлэг авсан гэрчүүдийн хувьд, мөн тангараг өргөсөн болон өргөөгүй гэрчийн хувьд ч адил хүчинтэй байдаг байна.

Эрхийн Тунхаглал болон Парламентын эрх ямбын хуулиас үүдэн гарах парламентын аливаа хэлэлцүүлгийн явцад хэлсэн үг болон бичгээр гаргасан саналыг хамгаалах абсолют эрх мөн холбогдох зарим тохиолдолд хүчинтэй байдаг. Тухайлбал, Парламентын баримт бичгийн хууль ёсоор (The Parliamentary Papers Act) Танхим болон хороодоос хэвлэхийг зөвшөөрсөн баримт бичиг, танилцуулга, протоколыг хэвлэсэн хэвлэн нийтлэгч мөн хамгаалагдах эрхтэй.

Хөндлөнгийн оролцоо, баривчлах, дарамтлахаас хамгаалах

Гэрч нь баривчлах (эрүүгийн хэрэг үйлдснээс бусад тохиолдолд), дарамтлах, хөндлөнгөөс нөлөөлөх болон парламент, хороодод мэдүүлэг өгөхөөс нь татгалзуулахын тулд бусад хэлбэрээр нөлөөлөхөөс хамгаалагдана. Мөн өгсөн мэдүүлэгтэй нь холбогдуулан шийтгэх, торгохоос (парламентыг үл хүндэтгэсэн хэргийн төлөө парламентаас шийтгэл оноох асуудал орохгүй) хамгаалагдана. Энэ талаар Парламентын эрх ямбын тухай хуулийн 12 дугаар зүйлд тодорхой заасан байна (энэ заалт доор тодорхой дурдагдсан байгаа). Мөн хуулийн 14 дүгээр зүйл ёсоор Танхим болон хороонд ирж мэдүүлэг өгөх өдөр нь тодорхой болсон гэрчийг тухайн өдөр нь шүүхэд дуудах, баривчлах, иргэний асуудлаар саатуулахыг хориглоно.

Гэрчийг хамгаалах үүднээс Парламентын эрх ямбын тухай хуулийн 12(1) дугаар заалтыг зөрчсөн хууран мэхлэх, айлгах, хүч хэрэглэх буюу хэрэглэхээр сүрдүүлэх ямарваа ашиг, урамшуулал өгөхөөр санал тавих, амлах, бусад хууль бус арга хэрэгслээр хэн нэг этгээдийг парламент, хороодод гэрчийн мэдүүлэг өгөх, эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзуулах зэргээр нөлөөлөх зэрэг үйлдлийг парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг гэж үзнэ.

Хэн нэгнийг парламент болон хороодод мэдүүлэг өгөх болон өгөхгүй байх, баталгаа, нотолгоо гаргах болон гаргахгүй байхад албадан аливаа шийтгэл оноосон, биед нь гэмтэл учруулсан, мөн тухайн этгээдийн олох ашиг, тэтгэмж, эрх мэдлийг хассан этгээдийг мөн хуулийн 12(2) заалт ёсоор парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр хуульчилжээ. Эдгээр парламентыг үл хүндэтгэсэн гэмт хэрэгт мөн дараах шиитгэлийг ногдуулна:

- Хувь хүн бол 5000 австрали доллараас хэтрэхгүй эсвэл 6 сар хүртэл хорих,
- Корпораци бол 25000 австрали доллараас хэтрэхгүй хэмжээний торгууль оноож болно.

Парламентын эрх ямбын тухай хуулийн 12 дугаар заалт нь парламентыг үл хүндэтгэсэн этгээдэд парламентын зүгээс өөр арга хэмжээ авахад нөлөөлөхгүй.

Мэдүүлэгт нэр дурдагдсан хүмүүсийг хамгаалах

Төлөөлөгчдийн танхимын Процедурын хорооноос мэдүүлэгт нэр дурдагдсан хүмүүсийг хамгаалах, тэдэнд туслах үүднээс дараах нөхцөлүүдийг харгалзаж үзэхийг зөвлөмж болгосон. Үүнд:

- Мэдүүлэг өгсөн хүнд энэхүү асуудал нь эргээд нөлөөлж болзошгүй үндэслэл байна гэж хороо үзвэл тус мэдүүлгийг хаалттай сонсголоор сонсох,
- Байнгын хорооны хуралдаанаас өмнө гэрчийн мэдүүлэгт нэр дурдагдсан хүмүүс мэдүүлэгтэй танилцах болон бичгээр хариу өгөх, хороон дээр ирэх боломжоор хангагдсан байх зэрэг болно.

Хэдийгээр Процедурын хорооны дээрхи зөвлөмжүүд нь албан ёсоор Танхимаар батлагдаагүй ч гэсэн Танхимын нээлттэй сонсголын практикт хэрэглэгддэг байна.

Нэгдсэн хороод дээр гэрчийг хамгаалах

Сенат 1988 онд Сенатын байнгын хороо гэрчийг хамгаалах асуудлаар хэрхэх талаар дараах нарийвчилсан заалттай тогтоолыг баталсан. Үүнд:

- Мэдүүлэг өгөх гэрчийг урих,
- Гэрч нь сонсгол болохоос өмнө мэдүүлгээ бичгээр өгөх боломжоор хангагдсан байх,
- Гэрч нь сонсгол болохоос өмнө хорооноос сонирхсон асуултаа асуух, тодруулах, лавлагаа авах боломжоор хангагдах,
- Шаардлагатай тохиолдолд хаалттайгаар мэдүүлэг өгөх,
- Гэрчийн зүгээс зарим асуултад хариулахгүй байх боломжоор хангагдах,
- Гэрч нь зөвлөхтэй байх, дагалдуулах боломжоор хангагдах зэрэг болно.

Гэрчийн зардал

Хорооны саналаар гэрчид замын зардал болон байрлах зардлыг боломжийн үнээр тооцож олгоно.

АНУ

АНУ-ын Сенатын Сонсголын гарын авлага[127]болон Сенатын дэгийн тухай хуулийн[128] XXVI бүлэгт гэрчийг урих, хамгаалах, санхүүжүүлэх талаар заасан байдаг байна. Сонсгол дээр гэрчээс мэдүүлэг авахын тулд тухайн хороо нь гэрчийг урих ёстой. Гэрчийг албан ёсоор урихаас өмнө хорооны ажилтнууд боломжит гэрчийг судалж мэдэх, тодорхойлох үүднээс ихэнх тохиолдолд ярилцлага авдаг байна. Шаардлагатай бол гэрч нь өөрийн намтар, гэрчийн мэдүүлгийг бичгээр явуулна. Сенатын журмын дагуу гэрч болгон сонсгол болохоос 24-72 цагийн өмнө урьдчилсан мэдүүлгээ бичгээр өгөх ёстой (Rule XXVI, paragraph 4(b)). Энэ цаг нь сонсгол явуулах хорооноос хамаарч ялгаатай байна. Тухайлбал, Гадаад харилцааны хороо сонсгол болохоос 48 цагийн өмнө, Хяналтын хороо (Select Committee

[127] Parliamentary Privileges Act 1987, s. 16(2).

[128] Parliamentary committees: powers over and protection afforded to witnesses, Paper prepared by I. J. Greenwood and R. J. Ellicott, PP 168 (1972) 31.

on Intelligence) нь 72 цагийн өмнө урьдчилсан мэдүүлгийг бичгээр авна гэж заасан байдаг байна.

Мөн хэрэгтэй гэрч хэмээн үзвэл хорооноос бичгээр албан ёсны урилга явуулна. Гэрч нь уг урилгаас оролцох сонсголынхоо зорилго, сэдэв, огноо болон сонсгол болох газар зэрэг үндсэн мэдээллийг мэдэж авах боломжтой. Үүнээс гадна гэрчээс асуух асуудал болон гэрчийн аман мэдүүлэг өгөх хугацааны хязгаарыг заасан байна. Мөн хорооны зүгээс хорооны гишүүдийн нэрсийн жагсаалт, Хорооны хуралдааны процедурын журам, асуудалтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ зэрэг нэмэлт мэдээллийг өгч болно. Хорооны ажилтантай холбоо барих мэдээллийг өгсөн байна. Зарим тохиолдолд хорооныхон гэрчтэй сонсгол болохоос өмнө уулзаж асуултуудад хариу авч, процедурыг тоймлон үзэж болно.

Сонсголд мэдүүлэг өгч байгаа гэрч нь үндсэндээ Үндсэн хуулийн эрхээр хамгаалагдсан бөгөөд Үндсэн хуулийн 1, 4, 5-дахь нэмэлт өөрчлөлтөөр хэрэгжинэ. Тухайлбал, 1-дэх нэмэлтээр хэрэв хороо гэрчийн үг хэлэх, цуглаанд оролцох эрхийг зөрчсөн гэж үзэн сонсголд ирэхээс татгалзсан гэрчийн эрхийг хамгаалах бол 4-дэх нэмэлтээр мэдээлэл авахын тулд үндэслэлгүйгээр нэгжих, баривчлахыг хориглоно. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг хамгаалсан 5-дахь нэмэлтээр зөвхөн халдашгүй байдлаар хамгаалагдаагүй тохиолдолд гэрчүүд өөрсдийн эсрэг гэрч баримт албан хүчээр өгөхгүй байж болдог байна.

Сенатын дэгийн 26.5 /Senate Rule XXVI, paragraph 5/-д зааснаар гэрчийг хамгаалахын тулд сонсголыг олон нийтэд хаалттай хийх эсэх талаар хорооны гишүүдийн саналыг хурааж болно гэсэн байна.

Хороод тус тусдаа өөрсдийн дэгтэй бөгөөд дэгээрээ гэрчийг хамгаалах асуудлыг зохицуулсан байдаг. Зарим хороод тухайлбал, Төрийн хэргийн хорооны дэгийн дагуу гэрч өөрийн өмгөөлөгчтэй хамт оролцож, өөрийн эрхийн талаар зөвлөгөө авч болно. Санхүүгийн хорооны дэгээр гэрч хүсвэл мэдүүлгээ өгөх явц нь олон нийтийн хэрэгслэлээр гаргахгүй гэж хүсвэл хаалттай хуралдахыг шаардах эрхтэй байдаг ажээ.

Гэрчийн зардал

Сенатын дэгийн дагуу гэрчийн зардлыг төлөх, эсхүл нөхөн олгоно (S.Res. 259, 100th Congress). Төлөгдөх, эсхүл нөхөн олгогдох зардлын суурь нь Дэг, захиргааны хороо (Committee on Rules and Administration)-ноос тогтоосон хоногийн зардлын хэмжээнээс хэтэрч болохгүй боловч тус Хороо нь онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд тогтоосон хоногийн зардлыг эргэн харж үзэж болно. Хороо нь мөн мэдүүлэг өгөх гэрчийн замын зардлыг төлөх, эсхүл нөхөн олгоно. Гол төлөв зөвхөн бэрхшээл, зовлон үүссэн нөхцөл байдалд байгаа гэрч, түүнчлэн зөвхөн гэрчийн оршин суугаа газраас сонсгол болох газар хүртэлх, түүнээс буцах замын зардлыг олгодог байна. Харин гэрчийг шүүхэд зарлан дуудсан тохиолдолд зардлыг төлөхгүй.

Канад

Гэрчийн эрх, үүрэг

Канадын парламентын хороодод мэдүүлэг өгч буй гэрч нь парламентын гишүүдтэй адил үг хэлэх, баривчлагдахгүй байх болон дарамтаас ангид байх эрхтэй. Нэгэнт ийнхүү гэрчийн эрх хамгаалагдсан тул хэрэв гэрч хорооны өмнө ямарваа мэдүүлэг өгөөгүй бол шүүхэд шилжүүлж болно. Мөн гэрч нь өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй гэсэн үндэслэлээр мэдүүлэг өгөхөөс татгалзаж болохгүй. Өөрөөр хэлбэл, гэрч нь мэдүүлэг өгөх, эсвэл шүүхээр хэлэлцэгдэн шийтгэгдэх гэсэн хоёрхон сонголттой тулгарна.

Хэрэв гэрч улсын нууцтай холбоотой юмуу бизнесийн ноцтой мэдээлэлтэй холбоотой асуудлаар мэдүүлэг өгөх бол хорооны шийдвэрээр хаалттай сонсголоор мэдүүлэг өгч болно. Онцгой тохиолдолд гэрч нэрээ нууцлан мэдүүлэг өгөхийг зөвшөөрнө. Гэрч мэдүүлэг өгөхдөө өмгөөлөгчийн туслалцаа авахыг хүсвэл энэ тухайгаа хороонд мэдэгдэн хүсэлт гаргаж болно. Өмгөөлөгч нь зөвхөн зөвлөх эрхтэй байх бөгөөд асуулт тавих болон гэрчийн өмнөөс хариулах эрхгүй.

Гэрчийг мэдүүлэг өгүүлэхгүй байх гэсэн аливаа оролдлогыг парламентын бүрэн эрхэнд халдсан үйлдэл гэж үзнэ. Мөн парламентад мэдүүлэг өгсөн гэрчийг айлган сүрдүүлэх болон бусад хэлбэрээр дарамтлахыг парламентын бүрэн эрхэнд халдсан хэрэг гэж үздэг. Хороонд мэдүүлэг өгч буй гэрчид тавигдаж болох асуултыг зохицуулсан ямар нэг дүрэм байхгүй бөгөөд гэрч хорооны сонсгол дээр тавигдсан ямарч асуултанд хариулах ёстой. Нөгөө талаас гэрч хорооны аль нэг гишүүний тавьсан асуултанд хариулахаас татгалзаж болно. Гэхдээ хороо тавигдсан асуултанд хариулах хэрэгтэй гэж үзвэл хорооноос тавигдсан асуулт гэж үзээд гэрч хариулах ёстой болдог. Ингэснээр Хороо тавигдсан асуултанд гэрчээс заавал хариу авах болон гэрчийг хамгаалах гэсэн хоёр сонголтын дундаас шийдвэр гаргах гарцтай болно.

Гэрчийн эрх, үүргийг ийнхүү хатуу хэлбэрээр томьёолсон байдаг учир Канадын парламентын Нийтийн танхимаас Гэрчид зориулсан гарын авлагыг гаргасан байдаг[129].

Гэрчийн мэдүүлэг авахыг шийдэх

Хэрэв парламентын аль нэг гишүүн тодорхой хэн нэгэн этгээдээс гэрчийн мэдүүлэг авах шаардлагатай гэж үзвэл энэ тухайгаа Хорооны даргад мэдэгдэнэ. Энэ талаар Нийтийн танхимын дэгд тусгасан байдаг.

STANDING ORDERS OF THE HOUSE OF COMMONS

CHAPTER XIII. 122. If any Member files a certificate with the Chair of a committee of the House, stating that the evidence to be obtained from a particular person is, in his or her opinion, material and important, the Chair shall apprise the committee thereof.

Худал мэдүүлэг

Канадын Парламентын хуулиар[130] гэрч парламентад мэдүүлэг өгөхдөө тангараг өргөх ёстой бөгөөд ийнхүү тангараг өргөсөн боловч худал мэдүүлэг өгсөн бол Эрүүгийн хуулиар шийтгэл хүлээнэ, тухайлбал шүүхээс Эрүүгийн хуулийн худал мэдүүлэг өгсөн этгээдийг шийтгэх тухай заалтын дагуу ял онооно.

Судалгааны товч дүгнэлт

- Манай судалгаанаас үзэхэд англи-саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад парламентын хэлэлцүүлэг, сонсголд оролцогчид, үүний дотор гэрчийг хамгаалах асуудлыг Тухайн орны Үндсэн хууль, парламентын хууль, парламентын эрх, ямбын хууль, парламентын дэг, хороодын дүрэм болон холбогдох бусад журмуудаар зохицуулсан байна.
- Парламентын сонсголын гэрчийг урих, ирүүлэх, шаардлагатай тохиолдолд албадан ирүүлэх журмыг нарийвчлан тогтоосон байдаг.
- Мөн парламентын хэлэлцүүлэг, сонсголын үед мэдүүлэг өгч байгаа гэрч нь

[129] Parliamentary privileges act 1987, s.12, Commonwealth Consolidated Acts, http://www.austlii.edu.au

[130] SENATE HEARING GUIDE. Hearings in the U.S. Senate: A Guide for Preparation and Procedure, CRS Report for Congress. 19 July 2004.

парламентын гишүүдийн нэгэн адил үг хэлэх, баривчлагдахгүй байх, дарамтаас ангид байх, хамгаалагдах эрхтэй ба ийнхүү эрхийг нь хамгаалсанаар гэрч нь мэдүүлэг заавар өгөх, үнэн зөв мэдүүлэг өгөх шаардлагатай бөгөөд хэрэв тодорхой асуудлаар мэдүүлэг өгөхөөс татгалзах, худал мэдүүлэг өгөх тохиолдолд парламентаас болон шүүхээс шийтгэл хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай байна.

- Түүнчлэн парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчийг өгсөн мэдүүлэгтэй нь холбоотойгоор айлган сүрдүүлэх, дарамтлах, шүүхээр мөрдөн шалгах нь хуулиар хориотой.
- Эдгээр орнуудад парламентын хэлэлцүүлэг, сонсголын гэрчид зориулсан гарын авлагыг дэлгэрэнгүй, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэн гаргадаг байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Parliamentary Privileges Act 1987. http://www.aph.gov.au/
2. House of Representatives Standing and Sessional Orders. http://www.aph.gov.au/
3. House of Representatives Practice (6th Edition). http://www.aph.gov.au/
4. Parliamentary committees: powers over and protection afforded to witnesses, Paper prepared by I. J. Greenwood and R. J. Ellicott, PP 168 (1972)
5. Senate hearing guides. Hearings in the U.S. Senate: A Guide for Preparation and Procedure, CRS Report for Congress. 19 July 2004. http://www.gpo.gov/fdsys/pkg
6. Guide for Witnesses appearing before committees of the House of Commons, http://www.parl.gc.ca/
7. Standing orders of the House of Commons, http://www.parl.gc.ca
8. Parliament of Canada Act, http://laws-lois.justice.gc.ca

* * *

ХАВСРАЛТ

Parliament of Canada Act
Examination of Witnesses

Examination of witnesses under oath

10. (1) The Senate or the House of Commons may administer an oath to any witness examined at the bar of the Senate or the House.

Examination before committee

(2) The Senate or the House of Commons may order witnesses to be examined on oath before any committee.

Committee may administer oath

(3) Any committee of the Senate or the House of Commons may administer an oath to any witness examined before the committee.

R.S., c. S-8, ss. 25 to 27.

Affirmation 11. (1) Where any witness to be examined under this Part conscientiously objects to take an oath, the witness may make a solemn affirmation and declaration.

affirmation

(2) Any solemn affirmation and declaration made under subsection (1) has the same force and effect, and entails the same consequences, as an oath taken in the usual form.

R.S., c. S-8, ss. 28, 29.

(Perjury 12. Any person examined under this Part who wilfully gives false evidence is liable to such punishment as may be imposed for perjury.

R.S., c. S-8, s. 31.

13. (1) Any oath or solemn affirmation and declaration under this Part may be administered by

(a) the Speaker of the Senate or the House of Commons;

(b) the chairman of any committee of the Senate or the House of Commons; or

(c) such person or persons as may be appointed for that purpose either by the Speaker

of the Senate or by the Speaker of the House of Commons or by standing or other

order of the Senate or the House.

Form (2) Every oath and solemn affirmation and declaration under this Part shall be in the Forms 1 and 2 in the schedule.

R.S., c. S-8, ss. 30, 32.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЫН ТАНХИМД ГИШҮҮДИЙГ СУУЛГАХ ДАРААЛАЛ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

(ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)

Р. Хатанбаатар, Б. Хатантуул

Улсын Их Хурлын Тамгын Газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Болдбаатарын захиалгаар Парламентын Танхимд гишүүдийг суулгах дараалал болон түүнтэй холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэх талаарх бусад орны туршлагыг харьцуулан гүйцэтгэв. Уг асуудлын хүрээнд Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, ОХУ, Солонгос, Канад, Сингапур, Финланд, Испани улсуудыг судалсан болно.

Судалгаанаас үзэхэд:

- Австрали, Шинэ Зеланд, Солонгос, Энэтхэг улсын хувьд бол Спикер суудал хуваарилах болон дарааллын асуудлыг шийдвэрлэдэг байна.
- ОХУ хувьд түр ажлын хэсэг байгуулан, гишүүдийг Танхимд суух суудлын дарааллыг тогтоодог байна.
- Норвеги улсын хувьд бол сонгогдсон тойргийнхоо нэрийн цагаан толгойн дарааллаар Танхимд суудаг.
- Канад, Сингапур, Финланд, Испани улсуудын хувьд Парламентын дэгийн тухай хууль болон Парламентын дүрэмдээ нарийвчлан тусгаагүй.

Австралийн Хамтын Нөхөрлөл

Төлөөлөгчдийн танхимын дүрмийн 24 дүгээр зүйлийн А-д заасны дагуу удирдлагын хэлбэр /government/[131] солигдоогүй тохиолдолд шинэ Парламентад улиран сонгогдсон гишүүн урьдах Парламентын Танхим дахь суудлаа хадгалж болно. Мөн тус дэгийн 24 дүгээр зүйлийн Б -д заасны дагуу Танхимд суудал хуваарилах асуудлаар маргаан гарах тохиолдолд Спикер асуудлыг шийдвэрлэнэ.

> Жич: Гишүүн суудал хуваарилахтай холбоотой хүсэлтээ Парламентын Гүйцэтгэгч /Serjeant at Arms/-д[132] гаргаж болно. Суудал хуваарилахтай холбоотой маргааныг 24 дүгээр зүйлийн Б-д заасны дагуу шийдвэрлэнэ.

Seating

The Chamber has a horse-shoe shaped seating arrangement, with Members from the governing party or parties sitting on the right of the Chair and the Members from the opposition parties and other non-government Members on the left. The front bench seats

131 Л. Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй., 2010 он 46 -р талд Парламентын дэгээр зохицуулаагүй асуудлын тухайд юуны өмнө спикерт байнгын буюу онцгой тохиолдолд дэгд асуудлыг шийдвэрлэхээр өөрчлөлт оруулах эрх олгох замаар тулгарсан асуудлыг шийдэх боломжтой байдаг байна.

1. Бодит зохицуулалт - дэгээр зохицуулагдаагүй асуудлыг нөхөх зорилго бүхий Спикерийн шийдвэр,
2. Процедурын зохицуулалт-дэгэр аль хэдийн зохицуулсан зохицуулалтыг илүү уян хатан, зохистой үр дүнтэй болгож өөрчлөх зорилго бүхий Спикерийн шийдвэрээр зохицуулж болдог ба түүнчлэн Парламентад тогтсон уламжлалт ёсоор асуудлыг шийдвэрлэж болдог.

132 Standing orders of the House of Representatives

on the right hand of the Speaker are reserved for Ministers (S.O. 23). Similarly, the front bench seats on the left hand of the Speaker are reserved for the Opposition Executive (shadow ministers'). The two chairs on the right of the Table are, by practice, reserved for the Prime Minister and the Deputy Prime Minister but are also occupied by other Ministers or Parliamentary Secretaries when they are in charge of the business before the House. Similarly, the two chairs on the left of the Table are reserved for the Leader and Deputy Leader of the Opposition but may be occupied by Members leading for the Opposition in the business before the House.

Other Members have allotted seats. A Member's request for the allocation of a seat should be made to the Serjeant-at-Arms but any question arising regarding the seats to be occupied by Members is determined by the Speaker (S.O. 24(b)). A Member is entitled to retain the seat occupied at the end of the previous Parliament (S.O. 24(a)) (except when a change of government necessitates a change of sides).

Шинэ Зеланд

Төлөөлөгчдийн танхимын дүрмийн [133] 37 дугаар зүйлд зааснаар уламжлал болж тогтсоны дагуу нам тус бүр Танхимд өөрийн хэсэгтэй байх бөгөөд Спикер Танхим дахь гишүүдийн суудлын талаарх аливаа маргааныг шийдвэрлэнэ гэжээ.
Seating in the Chamber

The Prime Minister, Deputy Prime Minister, Leader of the Opposition and deputy to the Leader of the Opposition sit facing each other in recognised front bench seats. Their respective whips are seated immediately behind them. Other Ministers and members are allocated seats within the area of the Chamber occupied by the party to which they belong on a basis determined by the party. As far as practicable, each party occupies a block of seats in the Chamber, so that its members are seated contiguously. [16] A member who is under suspension from his or her party continues to be seated within the area of seating allocated to that party. [17] It is also a recognised practice that, if at all possible, every party leader should have a front-bench seat.

The Speaker resolves any disputes about seating that may arise. [18] This generally involves the Speaker determining which area of the Chamber particular parties are to have allocated to them if the parties themselves cannot agree on this. Within these areas the allocation of seats to individual members of each party is left to the party leaders and their whips, and the Speaker does not intervene. [19]

Энэтхэг

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Парламентын Лок Сабха /доод танхим / танхимын Процедурын болон үйл ажиллагааг удирдлагаар хангах дүрмийн[134] 2 дугаар бүлгийн 4 -т

133 Тухайн Парламентад олонхи болсон улс төрийн нам, эвсэл Спикерийн баруун талд харин цөөнхи болон бусад гишүүд зүүн талд суудаг. Иймээс тухайн улиран сонгогдож байгаа гишүүний намын харьяалалаас шалтгаалж хуучин суудалдаа сууж болох үгүй нь хамаарна.

134 Уламжлал, түүхийн үүднээс Парламентын гүйцэтгэгчийн гол үүрэг нь парламентын танхимын ёслол, аюулгүй байдал болон аж ахуйг хэвийн байлгах байсан бол одоо үед үүрэг нь илүү өргөн болж Төлөөлөгчдийн танхимын бүх хэрэгцээг хангах орчин үеийн ажлын аппарат болон хөгжсөн байна.

Парламентын гүйцэтгэгчийн гол үүрэг бол парламентын хуралдааны үед эмх журам сахиулах, Дэгийн хуулийг мөрдүүлэхэд спикерт туслах юм. Гүйцэтгэгч ба түүний ажилтнууд нь эмх замбараагүй байдал үүсгэсэн хүмүүсийг танхимаас гаргах, албаны хүмүүс болон хэвлэл мэдээллийнхнийг танхимд байхыг зохицуулна. Парламентын гүйцэтгэгч мөн гишүүдийг бүртгэх,

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

зааснаар гишүүд Спикерийн тогтоосон дарааллаар Танхимд суудалд сууна.

ОХУ

Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламентын Төрийн Думын ажлын ерөнхий журмын 32 дугаар зүйлийн 2 ийн 1 -т зааснаар Депутатын түр ажлын хэсэг нь шинээр сонгогдсон гишүүдийг Төрийн Думын хуралдааны танхимд хуваарилан суулгах схемийг батална.

НОРВЕГ

Норвегийн Парламентын процедурын дүрмийн[135] 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд зааснаар гишүүд Стортингийн танхимд[136] сонгогдсон тойргийнхоо нэрийн цагаан толгойн дарааллаар суудалд сууна.

> 4. How the Members are seated in the Storting Chamber.
> In the Storting Chamber, Members shall be seated in the alphabetical order of their constituencies.

СОЛОНГОС

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн Актын 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлд: Спикер Үндэсний Ассамблейд суудал авсан намын төлөөлөлтэй зөвлөж, Үндэсний Ассамблейн гишүүдийн танхимд суух суудлын дарааллыг гаргах бөгөөд хэрэв зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Спикер эцэслэн шийдвэрлэнэ.

> Article3 (Arrangement of Seats)
>
> The seats of the members of the National Assembly (hereinafter referred to as “National Assembly member”) shall be determined by the Speaker in consultation with representative members of each negotiating party: Provided, That if they do not reach agreement, the Speaker shall make the determination.

* * *

Ашигласан эх сурвалж:

1. http://www.legco.gov.hk/general/english/library/internet_rop.html
2. http://www.aph.gov.au/
3. http://www.parliament.nz/en-NZ/PB/Rules/
4. http://www.congreso.es/portal/page/portal/Congreso/Congreso/Hist_Normas/Norm
5. http://www.stortinget.no/en/In-English/About-the-Storting/Parliamentary-procedure/
6. http://web.eduskunta.fi/dman/Document.phx?documentId=yt31112122225889&cmd=download
7. http://www.parl.gc.ca/ProceduralReference.aspx?Language=E
8. http://www.parliament.gov.sg/standing-orders-parliament-singapore
9. http://korea.assembly.go.kr/res/low_02_read.jsp?boardid=1000000036
10. Л. Өлзийсайхан. Парламентын хуралдааны дэгийн онол, арга зүй., 2010 он

танхим дотор гишүүдэд суудал хуваарилах, Төлөөлөгчдийн танхимаас Сенатад албан мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Гишүүд, ажилтнуудад мэдээлэл, зөвлөлгөө болон бусад тусламж бас үзүүлнэ. Тухайлбал, гишүүд ба өмнө байсан гишүүдийн талаархи мэдээллийн баазыг бий болгох, хадгалах, тодорхой мэдээллийг хэвлэн нийтлэх, автомашины үйлчилгээг хариуцах, нарийн бичгийн даргын үйлчилгээ, хурдан бичлэгийн үйлчилгээ зэрэг орно.

Гүйцэтгэгч спикерт радио, телевизийн нэвтрүүлгийн талаар барих бодлогоор зөвлөлгөө өгөхөөс гадна, парламентын танхимд кино, фото зураг авахыг зохицуулна, парламент, гишүүдийн үйл ажиллагааны талаар радио, телевизийн сурвалжлага, нэвтрүүлэгт хяналт тавина.

[135] Rules of Procedure and Conduct of Business in Lok Sabha

[136] Оросын Холбооны Улсын Төрийн Думын Регламентад зааснаар Төрийн Думын хуралдаан эхлэхээс хоёр долоо хоногоос доошгүй хоногийн өмнө хэрэв Ерөнхийлөгч өмнө нь хуралдахаар зарласан бол тухайн шийдвэр гарсны маргааш өдөр Төрийн Думын хуралдааныг зохион байгуулж явуулах депутатуудын түр ажлын хэсгийг шинээр сонгогдсон депутатуудаас байгуулна гэж заасан байдаг. Тухайн түр ажлын хэсэг нь анхны хуралдаанаар Төрийн Думын зохион байгуулалтын нэгжүүдийг томилсоноор үйл ажиллагаа нь дуусна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ПАРЛАМЕНТЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БҮЛГИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Ц. Товуусүрэн, А. Пагма

2012 оны IX сарын 30-ны байдлаар дэлхийн 150 улс орнуудын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь Руанда Улсад хамгийн өндөр буюу 56,25% байна[137]. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог анхлан дэмжиж ирсэн Шведэд эмэгтэй парламентчдын эзлэх хувь 44,7% буюу 4 дүгээр байранд, Финландад 42,5% буюу 7 дугаар байранд, Норвегид 39,6% буюу 11 дүгээр байранд байна. Нийт 30 улсад энэ хувь 30%-иас дээш байгаа бөгөөд манай улсад 12,7% буюу 100 дугаар байранд байна. Йемен, Микронезийн арлууд, Соломоны арлууд Науру, Палау, Катар, Саудын Араб зэрэг улсуудад эмэгтэй парламентачид 0,0-0,3 %-тай сүүлийн байруудад байна.

Улс орнуудын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэхийн хэрээр парламетч-эмэгтэйчүүдийн хамтран ажиллах арга механизмд зарим өөрчлөлт орсоор байна. Гадаад орнуудын парламентад эмэгтэй парламентчдын албан ёсны бүлэг байдаг эсэх талаар холбогдох эх сурвалжуудаас үзэхэд Швейцари, Финланд, Литви зэрэг улсуудад байдаг боловч тэдгээр нь албан бусаар ажилладаг юм байна. Харин эдгээр бүлгийн ажиллах дэг журмын талаар мэдээлэл бараг олдохгүй байгаа бөгөөд хууль тогтоомжид эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангуулах нийтлэг зорилготой болох нь харагдаж байна. Тухайлбал, Швейцарийн парламентад улс төрийн намын харъяаллаас үл хамаарах эмэгтэй парламентчдын албан ёсны бус, үл санхүүжих бүлэг байдаг бөгөөд дээд доод танхимын эмэгтэй парламентчид энэ бүлгийг бүрдүүлдэг байна.

Энэхүү бүлэг нь албан ёсны бус учраас бүлгийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын товыг сонирхогч этгээдүүд нь парламентын ажлын албаар дамжуулан зарлаж хуралдуулдаг байна. Энэхүү бүлэг нь үндэсний хэмжээний эмэгтэйчүүдийн байгууллагууд оролцсон хурлыг жилд нэг удаа хуралдуулах бөгөөд хүйсийн тэгш байдал, Швейцари дахь мусульман шашинтай эмэгтэйчүүдийн байдлыг судалдаг байна.

Олон улсын парламентын холбоо, парламентын хамтын ажиллагааны байгууллагуудын түвшинд эмэгтэй парламентчдын бүлэг байгуулагдан үйл ажиллагаа явуулдаг туршлага байна. Олон улсын парламентын холбоо үндэсний парламентууд дахь эмэгтэй парламентчдын тоо, эзлэх хувийн талаар статистик мэдээлэлийг тухай бүр нь гаргаж байна. Олон улсын парламентын холбооны бага хурлын үеэр эмэгтэй парламентчдын уулзалт яриа зохиогдож, хэлэлцэж байгаа асуудлаас гадна Олон улсын парламентын холбоон дахь харьцааг тэнцвэржүүлэх асуудал яригддаг байна.

Олон Улсын парламентын холбооны Гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүнд Хүйсийн тэгш байдлын түншлэлийн бүлэг байдаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд Гүйцэтгэх хорооны гишүүн 2 эрэгтэй, 2 эмэгтэй парламентч ордог байна. Чухамхүү энэ бүлэг хүйсийн тэгш байдлын аль ч асуудлаарх дүрмийн шаардлагыг үндэсний парламентууд хэрхэн биелүүлж байгааг хянадаг байна . Түүнчлэн Үндэсний парламентууд Олон Улсын Парламентын холбооны хороодын ажилд гишүүдээ хэлбэрийн төдий оролцуулснаар хязгаарлахгүй, төрөл бүрийн мэдэгдэл, илгээлт, тунхаглалд эмэгтэйчүүдийн холбогдолтой сэдэв, асуудлыг хэрхэн тусгаж буйг хянадаг байна.

Америк тивийн улс орнуудын парламентын холбоо/*ParlAmericas*/-ны 2003 оны Панама-

[137] http://www.ipu.org/wmn-e/classif.htm

Ситид болсон II нэгдсэн хуралдааны завсарлагаар эмэгтэй парламентчид улс төр, парламент, түүний байгууллагуудад дахь тэдгээрийн оролцооны талаар хэлэлцэж, Аргентины парламентч Маргарита Столбизар Эмэгтэй парламентчдын бүлэг байгуулах санал дэвшүүлж, тэр даруй Холбооны ассамблейн нэгдсэн хуралдаанаар байнгын байгууллага байхаар санал нэгтэй дэмжсэн байна.

2009 оноос Эмэгтэй парламентчдын бүлгийн Гүйцэтгэх хороог сонгон ажиллуулж байна. Дэлхийн улс орнуудын үндэсний парламентад эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хүйсийн тэгш байдлыг хангах асуудлыг ихэвчлэн парламентын хороодоор дамжуулан хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч байна. Тухайлбал: Белгийн парламентын Төлөөлөгчдийн танхимын Нийгмийн тэгш байдлын талаар зөвлөх тусгай хороо нь хууль тогтоомжийн төсөлд нийгмийн тэр дундаа эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудлыг тусгайлан авч хэлэлцдэг байна. Төлөөлөгчдийн танхимын дэгийн 69 дүгээр зүйлд энэхүү хорооны бүрэлдэхүүнд улс төрийн бүлэг тус бүрээс пропорциональ төлөөлөлтэй байх бөгөөд 13 гишүүнээс 11 нь эмэгтэй гишүүн байхаар заасан байна[138].

Зөвлөх тусгай хорооны үйл ажиллагааны дэг нь бүтцийн бусад хороодынхтой адил байна. Тусгай хороо нь парламентын гаднах эмэгтэйчүүдийн болон тэгш байдлын асуудал эрхэлдэг байгууллагууд болон Засгийн газрын саналын талаар нээлттэй хэлэлцүүлэг явуулдаг байна.

Шведийн парламент/ Рикстаг/-д хүйсийн тэгш байдлын асуудлаар бүх байнгын хороод үүрэг хариуцлага хүлээх бөгөөд хөдөлмөрийн зах зээлд хүйсийн тэгш байдлыг хангах асуудлыг Хөдөлмөрийн зах зээлийн байнгын хороо хариуцдаг. Тус Байнгын хороо нь 17 гишүүнтэйгээс 11 нь эмэгтэй гишүүн заасан байна[139].

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[138] http://www.ipu.org/wmn-e/classif.htm

[139] http://www.ipu.org/parline-e/reports/instance/2_179.htm?chambername=Chambre des Repr‡sentants (House of Representatives)&chamberid=2029

ISBN 978-99962-1-743-2

УИХ -ын Тамгын газар ©
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»
(Судалгааны эмхтгэл, XIV боть)

УИХ -ын Тамгын газрын хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэд шилжүүлсэн 2013.3.15
Тираж 300, Хэвлэлийн хуудас 35
Цаасны хэмжээ 176 * 250 $^{1}/_{10}$
(Анхны хэвлэл)

УБ, 2013

UIH.MN
СУДАЛГААНЫ САН